ҮГ НЬ
МАХБОДООР ИЛЭРСЭН

II БОТЬ

БУРХАНЫГ МЭДЭХ ТУХАЙ

ТӨГС ХҮЧИТ БУРХАНЫ ЧУУЛГАН

Зохиогчийн эрх © 2023 Төгс Хүчит Бурханы Чуулган

ҮГ НЬ
МАХБОДООР ИЛЭРСЭН
II БОТЬ
БУРХАНЫГ МЭДЭХ ТУХАЙ

Эцсийн өдрүүдийн Христ, Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн “Үг нь махбодоор илэрсэн” (товчоор Үг гэх) ном нь одоогийн байдлаар I Боть: Бурханы илрэлт ба ажил; II Боть: Бурханыг мэдэх тухай; III Боть: Эцсийн өдрүүдийн Христийн яриа; IV Боть: Антихристүүдийг илчлэх нь; V Боть: Удирдагч, ажилчдын үүрэг хариуцлага; VI Боть: Үнэний эрэл хайгуулын тухай гэсэн зургаан ботиос бүрддэг.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Зохиогчийн эрх эзэмшигчийн бичгээр үйлдсэн тодорхой зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийн аль нэг хэсгийг хэвлэн олшруулах, бичлэг хийх, мэдээлэл хадгалах, хайх системд оруулах зэргээр цахим эсвэл механик аливаа хэлбэрээр хуулбарлах, дамжуулахыг хориглоно.

Мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу:
contact.mn@kingdomsalvation.org

Энэхүү номын агуулгыг бүхэлд нь мэргэжлийн орчуулагчид орчуулж, хянан тохиолдуулсан хэдий ч бага зэргийн алдаа мадаг гарч болзошгүй. Хэрвээ та тийм алдаа олж харвал хятад хэл дээрх эх бичвэрээс лавлана уу. Дахин хэвлэх үед нь уг номыг шинэчлэх боломжтой тул бидэнтэй мөн холбоо бариарай.

Төгс Хүчит Бурханы Чуулган Хэвлэв
https://mn.godfootsteps.org

ӨМНӨХ ҮГ

Та нар дор бүрнээ Бурханыг дагах үйл явцдаа Бурханыг үнэхээр ойлгож, үнэхээр ухаарч, үнэхээр мэдэж авсан эсэхээ, янз бүрийн хүмүүст Бурхан ямар хандлага баримталдгийг үнэхээр мэддэг эсэхээ, мөн Бурхан чам дээр юу хийж байгааг болон үйлдэл бүрийг чинь Бурхан хэрхэн тодорхойлдгийг үнэхээр ойлгож байгаа эсэхээ харахын тулд амьдралынхаа туршид Бурханд хэрхэн итгэснээ шинээр шинжлэн шалгах ёстой. Хажууд чинь байж, урагшлах чиглэлийг чинь залж чиглүүлж, хувь заяаг чинь захирч, хэрэгцээг чинь хангадаг энэ Бурханыг чи чухамдаа хэр их ойлгож, хэр их мэддэг вэ? Тэр өдөр бүр чам дээр юу хийдгийг чи мэдэх үү? Түүний үйлдэл бүр ямар зарчим, зорилгод үндэслэдгийг мэдэх үү? Тэр чамайг хэрхэн залж чиглүүлдгийг мэдэх үү? Чамайг хангадаг Түүний арга барилыг мэдэх үү? Чамайг удирддаг Түүний арга замыг мэдэх үү? Тэр чамаас юу олж авахыг хүсдэгийг болон Тэр чамд юу гүйцэтгэхийг хүсдэгийг чи мэдэх үү? Чиний гаргаж байгаа олон төрлийн аашинд Тэр ямар хандлага баримталдгийг чи мэдэх үү? Чи Түүний хайртай хүн мөн эсэхээ мэдэх үү? Түүний баяр баясгалан, уур хилэн, уй гуниг, баяр хөөрийн уг сурвалж, тэдгээрийн ар дахь бодол, санаа болон Түүний мөн чанарын талаар чи мэдэх үү? Эцсийн эцэст итгэдэг энэ Бурхан чинь ямар Бурхан бэ гэдгийг мэдэх үү? Гэх мэт эдгээр асуулт нь чиний хэзээ ч ойлгож эсвэл бодож байгаагүй зүйл мөн үү? Бурханд итгэх үйл явцдаа чи Бурханы үгийг бодитоор мэдэрч, туулах замаар Түүний талаарх буруу ойлголтоо арилгасан уу? Бурханы сахилгажуулалт, цохилтыг хүртсэнийхээ дараа чи Бурханд жинхэнээсээ дуулгавартай байж, анхаарал тавьж эхэлсэн үү? Бурханы гэсгээлт, шүүлтийн дунд чи, хүний тэрслүү байдал болон сатанлаг уг чанарыг танин мэдэхээр дамжуулан Бурханы ариун байдлын талаар өчүүхэн ч гэсэн ойлгож авсан уу? Бурханы үгийн удирдамж болон гэгээрлийн дор чи амьдралыг үзэх шинэ үзэл бодолтой болсон уу? Бурханы илгээсэн шалгалтын дунд чи, хүний халдахыг Тэр тэвчдэггүй гэдгийг, түүнчлэн Тэр чамаас юу шаарддагийг болон Тэр чамайг хэрхэн аварч буйг мэдэрсэн үү? Бурханыг буруугаар ойлгох гэж юу болохыг, эсвэл энэ буруу ойлголтыг хэрхэн залруулахыг мэддэггүй бол чамайг хэзээ ч Бурхантай жинхэнээсээ харилцаагүй, хэзээ ч Бурханыг ойлгож байгаагүй гэж хэлж болно, эсвэл чи наад зах нь хэзээ ч Түүнийг ойлгохыг хүсээгүй гэж хэлж болно. Хэрвээ чи Бурханы сахилгажуулалт, цохилт гэж юу болохыг мэддэггүй бол дуулгавартай байх болон анхаарал тавих гэдэг нь юу болохыг мэддэггүй нь лавтай, эсвэл чи наад зах нь хэзээ ч Бурханд үнэхээр дуулгавартай байж, анхаарал тавьж байгаагүй юм байна. Хэрвээ чи Бурханы гэсгээлт, шүүлтийг хэзээ ч туулж байгаагүй бол Түүний ариун байдлыг мэдэхгүй нь лавтай бөгөөд хүний тэрслүү байдал юу болох талаар бүр ч мэдэхгүй. Хэрвээ чамд амьдралыг үзэх зөв үзэл бодол юм уу амьдралын зөв зорилго хэзээ ч байгаагүй, харин урагшаа явахаас ч эргэлзэх хүртэл хэмжээнд амьдралынхаа ирээдүйн замд тээнэгэлзэж, тэвдсээр байгаа бол Бурханы гэгээрэл, удирдамжийг

хэзээ ч хүлээн авч байгаагүй чинь илэрхий юм; чамайг үнэхээр хэзээ ч Бурханы үгээр хангагдаж, нөхөгдөж байгаагүй гэж хэлж болно. Хэрвээ чи Бурханы шалгалтыг хараахан туулаагүй бол Бурхан хүний халдахыг тэвчдэггүй гэж юу болохыг мэдэхгүй нь лавтай, мөн Бурхан чамаас эцсийн эцэст юу шаарддагийг ойлгохгүй, хүнийг удирдаж, аврах Түүний ажил юу болохыг бүр ч ойлгохгүй нь тодорхой юм. Хүн Бурханд хэчнээн олон жил итгэсэн байх нь хамаагүй, Бурханы үгээс хэзээ ч, юу ч мэдэрч ойлгоогүй бол тэр хүн авралын зам руу мэдээж алхаагүй, Бурханд итгэх итгэл нь мэдээж ямар ч бодитой агуулгагүй, Бурханы талаарх мэдлэг нь ч гэсэн мэдээж хоосон бөгөөд Бурханыг хүндлэх гэж юу болохыг огт мэддэггүй нь илэрхий юм.

Бурханд юу байгаа, Тэр юу болох, Бурханы мөн чанар, Бурханы зан чанар нь бүгд Түүний үгээр дамжин хүн төрөлхтөнд илэрхийлэгдсэн. Хүн Бурханы үгийг туулж байхдаа тэдгээрийг хэрэгжүүлэх явцад Бурханы хэлдэг үгийн цаад зорилгыг ойлгож, Бурханы үгийн эх сурвалж болон цаад шалтгааныг ойлгож, Бурханы үгийн зорьсон үр нөлөөг ойлгож, мэдэрнэ. Хүмүүсийн хувьд, үнэн болон амийг олж авч, Бурханы хүслийг ухаарч, зан чанараа өөрчилж, Бурханы дээд эрх, зохицуулалтыг дуулгавартай дагаж чаддаг болохын тулд туулж, ухаарч, олж авах ёстой бүх зүйл бол энэ юм. Хүн эдгээр зүйлийг туулж, ухаарч, олж авах зуураа Бурханы талаарх ойлголтыг аажмаар олж авсан байх бөгөөд энэ үедээ бас Түүний талаарх өөр өөр түвшний мэдлэгийг олж авсан байх болно. Энэхүү ойлголт, мэдлэг нь хүний төсөөлж зохиосон зүйлээс гарч ирдэггүй, харин ч өөрийнхөө дотор ухамсарлаж, мэдэрч, туулж, баталж байгаа зүйлээс нь гарч ирдэг. Эдгээр зүйлийг ухамсарлаж, туулж, мэдэрч, баталсны дараа л Бурханы талаарх хүний мэдлэг агуулгатай болдог; энэ үед л хүний олж авсан мэдлэг үнэн, бодитой, алдаа мадаггүй байх бөгөөд Бурханы үгийг ухамсарлаж, туулж, мэдэрч, батлах замаар Бурханы тухай жинхэнэ ойлголт, мэдлэгийг олж авах энэ үйл явц бол Бурхан, хүн хоёрын хоорондох жинхэнэ харилцаа юм. Ийм төрлийн харилцаан дунд хүн Бурханы санаа зорилгыг үнэхээр ойлгож, ухаарч эхэлдэг ба Бурханд юу байгаа, Тэр юу болохыг, Бурханы мөн чанарыг үнэхээр ойлгож, мэдэж, Бурханы зан чанарыг аажмаар ойлгож, мэдэж, Бурхан бүх зүйлийг захирдаг баримтын талаар жинхэнэ үнэмшил болон зөв тодорхойлолттой болдог бөгөөд Бурханы ялгамж чанар, байр суурийн тухайд бодитой танин мэдэхүй, мэдлэгтэй болдог. Ийм төрлийн харилцаан дунд хүн Бурханы тухай санаа бодлоо алхам алхмаар өөрчилж, Түүнийг үндэслэлгүйгээр төсөөлж, Түүний талаар дураараа сэжиглэж, Түүнийг буруугаар ойлгож, яллаж, Түүнд шүүлт оноож, Түүнд эргэлзэхээ больдог. Тийнхүү Бурхантай маргах нь багасаж, зөрчилдөх нь багасаж, Бурханы эсрэг тэрслэх нь цөөрдөг. Эсрэгээрээ, хүн Бурханд анхаарал тавьж, дуулгавартай байх нь ихсэж, Бурханыг хүндлэх хүндлэл нь улам бодитой, улам гүн гүнзгий болдог. Ийм төрлийн харилцаан дунд хүн үнэний хангалт болон амийн баптисмыг олж аваад зогсохгүй, үүний зэрэгцээ бас Бурханы талаарх жинхэнэ мэдлэгт хүрдэг. Ийм төрлийн

харилцаан дунд хүн зан чанараа өөрчилж, аврал хүртээд зогсохгүй, үүний зэрэгцээ бүтээгдсэн зүйлээс Бурханд хандах жинхэнэ хүндлэл болон шүтлэгийг олж авдаг. Ийм төрлийн харилцаатай байснаар Бурханд итгэх итгэл нь хоосон цаас, хий дэмий амлалт юм уу сохор эрэл хайгуул, сохор шүтлэг байхаа больдог; ийм төрлийн харилцаатай байснаар л хүний амь өдөр өдрөөр боловсрон өсөх ба энэ үед л хүний зан чанар аажмаар өөрчлөгдөж, Бурханд итгэх итгэл нь бүдэг бадаг, тодорхойгүй итгэлээс жинхэнэ дуулгавартай байдал, анхаарал халамж руу, бодит хүндлэл рүү алхам алхмаар шилждэг, түүнчлэн хүн Бурханыг дагах үйл явцдаа идэвхгүй байснаа идэвхтэй байдалтай болж, сөрөг байснаа эерэг болж аажмаар ахин дэвшдэг; ийм харилцаатай байснаар л хүн Бурханы талаарх жинхэнэ ойлголт, ухаарал, мөн Бурханы талаарх жинхэнэ мэдлэгт хүрдэг. Хүмүүсийн дийлэнх нь хэзээ ч Бурхантай жинхэнээсээ харилцаж байгаагүй учраас Бурханы талаарх мэдлэг нь онолын түвшинд, бичиг үсэг, хоосон сургаалын түвшинд хүрээд зогсдог. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн дийлэнх нь Бурханд хэчнээн олон жил итгэсэн байх нь хамаагүй, Бурханыг мэдэхийн тухайд бол одоо ч эхлэлийн цэг дээрээ байж, феодалын мухар сүсэг болон романтик өнгө аястай холбоотой уламжлалт бишрэл хүндэтгэлийн хэлбэрийн суурин дээр гацаж байдаг. Бурханы талаарх хүний мэдлэг эхлэлийн цэг дээрээ гацна гэдэг бол бараг байхгүй гэсэн үг. Бурханы байр суурь, ялгамж чанарын талаарх хүний баталгаанаас бусдаар бол хүний Бурханд итгэх итгэл нь мөн л бүдэг бадаг тодорхойгүй байдалд байдаг. Ийм болохоор хүнд Бурханыг гэх жинхэнэ хүндлэл хэр их байдаг вэ?

Чи Бурханы оршин тогтнолд хэчнээн бат итгэдэг нь хамаагүй, энэ нь Бурханы талаарх мэдлэгийг чинь ч, Бурханыг хүндлэх хүндлэлийг чинь ч орлож чадахгүй. Чи Бурханы ерөөл, нигүүлслийг хэчнээн их эдэлсэн ч бай, энэ нь Бурханы талаарх мэдлэгийг чинь орлож чадахгүй. Бурханы төлөө бүхнээ зориулж, бүхнээ зарлагадахыг хэчнээн их хүсэх чинь хамаагүй, энэ нь Бурханы талаарх мэдлэгийг чинь орлож чадахгүй. Магадгүй чи Бурханы хэлсэн үгийг маш сайн мэддэг болж, тэдгээрийг цээжилж, дуржигнатал уншиж чадаж байлаа ч гэсэн, энэ нь Бурханы талаарх чиний мэдлэгийг орлож чадахгүй. Бурханыг дагахдаа хүн хэчнээн шийдэмгий байлаа ч гэсэн, Бурхантай хэзээ ч жинхэнээсээ харилцаж байгаагүй бол, Бурханы үгийг жинхэнээсээ туулаагүй бол Бурханы талаарх мэдлэг нь хий хоосон, эцэс төгсгөлгүй мөрөөдөл байх болно; чи зөрж өнгөрөхдөө Бурхантай мөр шүргэлцэж, Түүнтэй нүүр тулан уулзсан ч бай, Түүний талаарх мэдлэг чинь хоосон хэвээр байх ба Бурханыг гэх хүндлэл чинь хий хоосон уриа лоозон, хүслэнт үзэл баримтлалаас өөрцгүй байх юм.

Олон хүн Бурханы үгийг бариад өдөр бүр уншдаг, бүр тэнд байгаа бүх сонгодог эшлэлийг өөрсдийн хамгийн эрхэм эрдэнэ шиг анхааралтай цээжлэхэд хүрдэг төдийгүй Бурханы үгийг хаа сайгүй номлож, Бурханы үгээр бусдыг хангаж, тусалж байдаг. Ингэх нь Бурханыг гэрчилж байгаа, Түүний үгийг гэрчилж байгаа хэрэг бөгөөд ингэх нь Бурханы замыг дагаж байна гэж тэд боддог; ингэх нь Бурханы үгээр

амьдарч байна, ингэх нь Түүний үгийг бодит амьдралдаа авчирч байна, мөн ингэвэл Бурханы сайшаалыг хүртэж, аврагдаж, төгс болгуулах боломжтой гэж тэд боддог. Гэвч, тэд Бурханы үгийг номлож байхдаа ч гэсэн, хэрэгжүүлэхдээ хэзээ ч Бурханы үгийг дагаж мөрддөггүй, мөн Бурханы үгэнд илчлэгдсэн зүйлтэй өөрсдийгөө нийцүүлэхээр хичээдэггүй. Үүний оронд тэд Бурханы үгийг ашиглан бусдын хүндлэл, итгэлийг мэхлэн авч, өөрсдийн удирдлагыг эрхэлж, Бурханы алдрыг завшиж, хулгайлдаг. Тэд Бурханы ажил болон сайшаалаар шагнуулахын тулд Бурханы үгийг түгээх боломжийг ашиглах гэж хий дэмий найддаг. Хэчнээн олон жил өнгөрсөн ч гэлээ, энэ хүмүүс Бурханы үгийг номлох явцдаа Бурханы сайшаалыг хүртэж чадаагүйгээр үл барам, Бурханы үгийг гэрчлэх явцад өөрсдийн дагах ёстой замыг олж нээж чадаагүйгээр барахгүй, Бурханы үгээр бусдыг хангаж, туслах явцдаа өөрсдөдөө тусалж, өөрсдийгөө дэмжиж чадаагүйгээс гадна, энэ бүх зүйлийг хийх явцдаа Бурханыг мэдэж, Бурханыг хүндлэх жинхэнэ хүндлэлд хүрч чадаагүйгээр зогсохгүй; харин ч Бурханы талаарх буруу ойлголт нь улам бүр гүнзгийрч, Түүнийг сэжиглэх нь улам ч ноцтой болж, Түүний талаарх төсөөлөл нь бүр их хэтрүүлэгтэй болдог. Бурханы үгийн тухай онолын хангалт болон удирдлага дор тэд загас усанд орсон мэт, өөрсдийн ур чадварыг ядах юмгүй хялбархан ашиглаж байгаа мэт, өөрсдийн амьдралын зорилго, үүрэг даалгаврыг олсон мэт, шинэ амийг олж аваад, аврагдсан мэт, Бурханы үгийг цээжээр урсган уншихынхаа хамтаар үнэнийг олж авч, Бурханы хүслийг ухаарч, Бурханыг мэдэх замыг нээн олсон мэт, Бурханы үгийг номлох явцдаа Бурхантай дандаа нүүр тулан уулзсан мэт харагддаг. Мөн, тэд үргэлж цурхиран уйлтлаа “сэтгэл нь хөдөлдөг” ба Бурханы үгэн дэх “Бурханаар” байнга удирдуулснаар, Түүний чин сэтгэлийн анхаарал, сайн санаа зорилгыг нь тасралтгүй ухаарч байгаа мэт харагддагийн зэрэгцээ хүнийг аврах Бурханы аврал болон Түүний удирдлагыг ухаарч, Түүний мөн чанарыг мэдэж авч, Түүний зөвт зан чанарыг ойлгосон мэт харагддаг. Энэ сууринд үндэслэн тэд Бурханы оршин тогтнолд улам бүр бат итгэж, Түүний эрхэм дээд байдлын талаар улам бүр ухаарч, Түүний агуу, ер бусын байдлыг бүр ч гүнзгий мэдэрч байх шиг санагддаг. Тэд Бурханы үгийн тухай өнгөц мэдлэгт автан, итгэл нь өсөж, зовлон туулах шийдэмгий байдал нь батжиж, Бурханы талаарх мэдлэг нь гүнзгийрсэн мэт харагддаг. Тэд Бурханы үгийг үнэхээр туулахаас нааш Бурханы талаарх бүх мэдлэг, бодол санаа нь өөрсдийнх нь хий хоосон төсөөлөл, таамаглалаас гарч ирдэг гэдгийг хэрхэн мэдэх билээ. Тэдний итгэл Бурханаас ирсэн ямар ч туршилтыг дийлэхгүй, тэдний сүнслэг байдал болон биеийн хэмжээ гэгддэг зүйл нь Бурханы шалгалт юм уу үзлэгийг ердөө даахгүй, тэдний шийдвэр элсэн дээр баригдсан цайзтай адил бөгөөд тэдний хэлдэг Бурханы талаарх мэдлэг нь санаанаасаа зохиосон төсөөллөөс цаашгүй. Үнэндээ, Бурханы үгэнд “их хэмжээний хүчин чармайлт” гаргасан энэ хүмүүс жинхэнэ итгэл гэж юу болох, жинхэнэ дуулгавартай байдал гэж юу болох, жинхэнэ анхаарал халамж гэж юу болох, Бурханы талаарх жинхэнэ мэдлэг гэж юу болохыг хэзээ ч ухаараагүй. Тэд онол, төсөөлөл, мэдлэг,

авьяас билиг, уламжлал, мухар сүсэг, тэр ч бүү хэл хүний ёс суртахууныг хүртэл аваад, тэдгээрийг Бурханд итгэх болон Түүнийг дагах “хөрөнгө”, “зэр зэвсэг” болгон, тэр ч байтугай тэдгээрийг Бурханд итгэх итгэл, Түүнийг дагах үндэс сууриа болгодог. Үүний зэрэгцээ, тэд бас энэ хөрөнгө, зэр зэвсгийг аваад, Бурханыг мэдэж, Бурханы хяналт, шалгалт, гэсгээлт, шүүлттэй нүүр тулж, харьцах шидэт сахиус болгодог. Эцэст нь, тэдний цуглуулсан зүйл шашны өнгө аяс, феодалын мухар сүсэг нэвчиж, романтик, хачин жигтэй, учир битүүлэг бүхэн шингэсэн Бурханы талаарх дүгнэлтээс цаашгүй зүйлээс бүрддэг. Бурханы талаарх тэдний мэдлэг, тодорхойлолт нь зөвхөн Дээд Тэнгэр, эсвэл Тэнгэр Эцэгт итгэдэг хүмүүсийнхтэй нэг хэвд цутгагдсан байдаг бол Бурханы бодитой байдал, мөн чанар, зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох гэх зэрэг бодитой Бурхантай Өөртэй нь хамаатай юм бүхэн тэдний ухаарч ойлгож чадаагүй зүйлс бөгөөд тэдний мэдлэг үүнтэй огт хамааралгүй, бүр хойд, өмнөд туйл шиг хол байдаг. Ийм маягаар хэдий тэд Бурханы үгийн хангалт, тэжээл дор амьдардаг ч гэсэн Бурханаас эмээж, муугаас зайлах замаар алхаж үнэхээр чаддаггүй. Үүний жинхэнэ шалтгаан нь тэд хэзээ ч Бурханыг мэдэж аваагүй, мөн хэзээ ч Түүнтэй жинхэнээсээ холбогдож, ярилцаж байгаагүй. Иймээс тэдний хувьд Бурхантай харилцан ойлголцолд хүрч, Бурханд үнэхээр итгэж, Бурханыг дагаж, шүтэн мөргөх боломжгүй юм. Бурханы үгийг ийнхүү үзэж, Бурханыг ийнхүү үздэг тэдний харах өнцөг, хандлага нь тэднийг гар хоосон буцахад хүргэсэн бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлах замаар мөнхөд алхаж чадахааргүй болоход хүргэсэн. Тэдний зорьж буй зорилго болон явж байгаа чиглэл нь тэд бол мөнхөд Бурханы дайсан, үүрд мөнхөд хэзээ ч аврал хүртэж чадахгүй гэдгийг илтгэдэг.

Бурханыг олон жилийн турш дагаж, Түүний үгийн хангалтыг олон жил эдэлсэн хүний хувьд, Бурханы талаарх түүний тодорхойлолт нь мөн чанартаа хуурамч шүтээний өмнө хүндэтгэн мөргөдөг хүнийхтэй адил бол тухайн хүн Бурханы үгийн бодит байдлыг олж аваагүй гэдгийг энэ нь илтгэнэ. Учир нь тэр Бурханы үгийн бодит байдалд ердөө ороогүй бөгөөд энэ шалтгааны улмаас Бурханы үгэнд угаасаа байдаг бодит байдал, үнэн, санаа зорилго, хүн төрөлхтөнд тавьсан шаардлага зэрэг нь бүгд тэр хүнтэй огт хамаагүй байдаг. Өөрөөр хэлбэл, ийм хүн Бурханы үгийн өнгөц утгын талаар хэчнээн хүчин чармайлт гаргалаа ч энэ бүхэн нь нэмэргүй юм: Учир нь тэр ердөө үг үсгийг л эрэлхийлдэг тул түүний олж авах зүйл мөн л үг үсэг төдий байх болно. Бурханы хэлдэг үг гаднаа энгийн ч бай, гүн гүнзгий ч бай, амь руу ороход хүнд шаардлагатай бүх үнэн юм; тэдгээр нь сүнсээрээ болон махан биеэрээ амьд үлдэх боломжийг хүнд олгодог амийн усны эх булаг билээ. Тэдгээр нь хүнийг амьд үлдэхэд хэрэгтэй зүйлээр; өдөр тутмын амьдралдаа биеэ авч явахад нь зориулсан зарчим, итгэл үнэмшлээр; авралд хүрэхийн тулд явах ёстой зам, зорилго болон чиглэлээр; Бурханы өмнө бүтээгдсэн зүйл нь болохын хувьд эзэмших ёстой бүх үнэнээр; Бурханыг хэрхэн дуулгавартай дагаж, шүтэн мөргөх тухай бүх үнэнээр хангадаг. Тэр нь хүний амьд үлдэх баталгаа, хүний өдөр

тутмын талх төдийгүй, хүнийг хүчтэй, тэсвэртэй болгодог бат бөх дэмжлэг юм. Тэр нь бүтээгдсэн хүн төрөлхтөн хэвийн хүн чанарыг амьдран харуулдаг үнэн-бодит байдлаар баялаг, хүн төрөлхтнийг завхралаас чөлөөлж, Сатаны урхинаас мултлах үнэнээр баялаг, Бүтээгчээс бүтээгдсэн хүмүүст өгсөн чин сэтгэлийн сургаал, сануулга, зоригжуулалт болон тайтгарлаар баялаг байдаг. Тэр нь бүхий л эерэг зүйлийг ойлгоход хүмүүсийг удирдан гэгээрүүлдэг гэрэлт цамхаг, зөв шударга, сайн бүхнийг амьдран харуулж, эзэмшихэд хүнийг хүргэдэг баталгаа, хүмүүс, үйл явдлууд болон эд зүйлсийг бүгдийг нь хэмждэг хэмжүүр, мөн түүнчлэн хүмүүсийг аврал болон гэрлийн зам руу хөтөлдөг жолоодлогын тэмдэг юм. Бурханы үгийн бодит туршлага дунд л хүн үнэн болон амиар хангагдаж чадна; эндээс л хүн хэвийн хүн чанар гэж юу болох, утга учиртай амьдрал гэж юу болох, жинхэнэ бүтээгдсэн зүйл гэж юу болох, Бурханд үнэхээр дуулгавартай байх гэж юу болохыг ойлгож авч чадна; эндээс л Бурханыг хэрхэн анхаарч халамжлах ёстойг, бүтээгдсэн зүйлийн үүргээ хэрхэн биелүүлэх ёстойг, хэрхэн жинхэнэ хүний дүртэй болох ёстойг ойлгож авч чадна; эндээс л жинхэнэ итгэл, жинхэнэ шүтлэг мөргөл гэж юу гэсэн үг болохыг ойлгож авч чадна; тэнгэр, газар бүх зүйлийн Захирагч хэн болохыг ойлгож авч чадна; бүхнийг захирагч Нэгний бүх зүйлийг захирч, удирдаж, хангадаг арга барилыг ойлгож авч чадна; бүхнийг захирагч Нэгний оршин тогтнож, үзэгдэж, ажилладаг арга барилыг ухаарч ойлгож авч чадна. Бурханы үгийг бодитоор туулахаас өөрөөр хүнд Бурханы үг болон үнэний талаарх ямар ч жинхэнэ мэдлэг, ойлголт байдаггүй. Ийм хүн бол чухамдаа амьд үхдэл, бүрэн цогцос бөгөөд Бүтээгчтэй хамаатай бүх мэдлэг түүнтэй огтхон ч хамаагүй байдаг. Бурханы нүдээр ийм хүн хэзээ ч Түүнд итгээгүй, мөн хэзээ ч Түүнийг дагаж байгаагүй, иймээс Бурхан ийм хүнийг жинхэнэ бүтээгдсэн зүйл гэх нь байтугай Өөрийн итгэгч, дагалдагч гэж хэзээ ч үздэггүй.

Жинхэнэ бүтээл болохын хувьд, Бүтээгч гэж хэн болох, хүнийг бүтээсэн нь юуны төлөө болох, бүтээгдсэн зүйлийн үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлэх, бүтээлийн Эзэнийг хэрхэн шүтэн мөргөхийг мэдэх ёстой бөгөөд Бүтээгчийн хүсэл, сэтгэлийн үг, шаардлагыг ойлгож, ухаарч, мэдэж, анхаарч, Бүтээгчийн үгийг даган мөрдөж—Бурханаас эмээж, муугаас зайлах ёстой.

Бурханаас эмээх гэж юу вэ? Хүн яаж муугаас зайлах вэ?

“Бурханаас эмээх” гэдэг нь хэлэхийн аргагүй айдас болон аймшгийг хэлдэггүй, булtан зугтах, зайгаа барих, бишрэн шүтэх, мухар сүсэг гэсэн үг ч биш. Харин энэ нь бишрэл, хүндлэл, итгэл, ойлголцол, анхаарал халамж, дуулгавартай байдал, зориулалт, хайр, түүнчлэн болзол тавихгүйгээр, гомдоллохгүйгээр шүтэн мөргөх, ач хариулах болон захирагдах гэсэн үг юм. Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр, хүмүүст жинхэнэ бишрэл, жинхэнэ итгэл, жинхэнэ ойлголт, жинхэнэ анхаарал халамж юм уу дуулгавартай байдал гэж байхгүй, харин зөвхөн айдас, түгшүүр, эргэлзээ, үл ойлголцол, булталт, зайлсхийлт л байх болно; Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр хүмүүс жинхэнээсээ зориулж, ач хариулна гэж байхгүй;

Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр хүмүүс жинхэнээсээ шүтэн мөргөж, захирагдана гэж байхгүй, сохор шүтлэг, мухар сүсэг л байх болно; Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр хүмүүс Бурханы үгийг даган мөрдөж, Бурханаас эмээж, муугаас зайлж яавч чадахгүй. Эсрэгээр нь хүмүүсийн хийдэг үйл ажиллагаа, гаргадаг зан авир болгон нь тэрслүү, эсэргүүцэл, Бурханы тухай гүжирдсэн зэмлэл, гутаасан шүүлт, үнэн болон Бурханы үгийн жинхэнэ утга учрыг зөрчсөн муу үйлээр дүүрнэ.

Хүмүүс Бурханд үнэхээр итгэх үедээ Түүнийг жинхэнээсээ дагаж, Түүнд найдна; Бурханд үнэхээр итгэж, найдсанаар л хүмүүс жинхэнэ ойлголт, ухааралтай болж чаддаг; Бурханы талаар бодит ухааралтай болсноор л Түүнийг бодитоор анхаарч халамжилдаг; Бурханыг жинхэнээсээ анхаарч халамжилдаг байснаар л хүмүүс үнэхээр дуулгавартай болно; Бурханд жинхэнээсээ дуулгавартай байснаар л хүмүүс жинхэнээсээ зориулна; Бурханд жинхэнээсээ зориулснаар л хүмүүс болзол тавьж, гомдоллолгүй ач хариулна; жинхэнэ итгэл найдвар, жинхэнэ ойлголт, анхаарал халамж, жинхэнэ дуулгавартай байдал, жинхэнэ зориулалт, ач хариулалт байснаар л хүмүүс Бурханы зан чанар, мөн чанарыг үнэхээр мэдэж, Бүтээгчийн ялгамж чанарыг мэдэж авч чадна; Бүтээгчийг үнэхээр мэдэж авсан үедээ л хүмүүс жинхэнээсээ шүтэн мөргөж, захирагдаж чадна; Бүтээгчид жинхэнээсээ шүтэн мөргөж, захирагдах үедээ л хүмүүс муу арга замаа үнэхээр хойш тавих буюу муугаас зайлж чадна.

Эдгээр нь “Бурханаас эмээж, муугаас зайлах” бүхий л үйл явцыг бүрдүүлдэг төдийгүй Бурханаас эмээж, муугаас зайлах бүхий л агуулга юм. Түүнчлэн Бурханаас эмээж, муугаас зайлахын тулд явах ёстой зам юм.

“Бурханаас эмээж, муугаас зайлах” болон Бурханыг мэдэх нь тоо томшгүй олон уялдаагаар салшгүй холбогддог ба тэдгээрийн хоорондох холбоо илэрхий юм. Хэрвээ хүн муугаас зайлахыг хүсвэл эхлээд Бурханаас үнэхээр эмээх ёстой; хэрвээ хүн Бурханаас үнэхээр эмээхийг хүсвэл эхлээд Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй байх ёстой; хэрвээ хүн Бурханы талаар мэдлэгтэй болохыг хүсвэл Бурханы үгийг туулж, Бурханы үгийн бодит байдалд орж, Бурханы цохилт, сахилгажуулалт, гэсгээлт, шүүлтийг туулах ёстой; хэрвээ хүн Бурханы үгийг туулахыг хүсвэл эхлээд Бурханы үгтэй нүүр тулж, Бурхантай нүүр тулж, хүмүүс, үйл явдал, эд зүйлтэй холбоотой төрөл бүрийн орчинд Бурханы үгийг туулах боломжоор хангахыг Бурханаас гуйх ёстой; хэрвээ хүн Бурхан болон Бурханы үгтэй нүүр тулахыг хүсвэл эхлээд цайлган, үнэнч зүрх сэтгэл, үнэнийг хүлээн авахад бэлэн байдал, зовлон бэрхшээл туулах хүсэл, муугаас зайлах шийдвэр, эр зориг болон жинхэнэ бүтээгдсэн зүйл болох хүсэл эрмэлзэлтэй байх ёстой… Ийм маягаар алхам алхмаар урагшилснаар чи Бурхантай улам бүр ойртож, зүрх сэтгэл чинь илүү ариун болж, чиний амьдрал болон амьд байхын үнэ цэн Бурханыг мэдэж авснаас чинь үүдэн улам бүр утга учиртай, улам бүр гэрэл гэгээтэй болно. Нэг л өдөр чи Бүтээгч оньсого байхаа больсныг болон Бүтээгч хэзээ ч чамаас нуугдаагүй, Бүтээгч хэзээ

ч нүүрээ чамаас нуугаагүй, Бүтээгч чамаас огтхон ч хол байдаггүй, мөн Бүтээгч чиний цаг үргэлж боддог ч мэдрэмжээрээ хүрч чаддаггүй Нэгэн байхаа больж, үнэхээр баруун зүүн талд чинь хамгаалан зогсож, чиний амийг хангаж, хувь заяаг чинь хянаж байдаг гэдгийг мэдэрнэ. Тэрээр алс хол тэнгэрийн хаяанд байдаггүй, мөн Өөрийгөө өндөрт үүлэн дунд ч нуугаагүй. Тэр чиний яг хажууд, бүх зүйлийг чинь захирч байдаг, Тэр бол чиний бүх зүйл, чамд байгаа цорын ганц зүйл юм. Тийм Бурхан л зүрх сэтгэлээсээ Түүнийг хайрлаж, Түүнээс зүүгдэж, Түүнд ойр байж, Түүнийг биширч, Түүнийг алдахаас айж, Түүнээс татгалзах, Түүнд дуулгаваргүй байх, Түүнээс холдох, Түүнээс булталх хүсэлгүй болох боломжийг чамд олгодог. Түүнд анхаарал тавьж, Түүнийг дуулгавартай дагаж, чамд өгсөн бүхнийх нь ачийг хариулж, Түүний эрх мэдэлд захирагдахыг л чи хүсдэг. Чи цаашид Түүгээр удирдуулж, хангагдаж, халамжлуулж, хамгаалагдахаас татгалзахгүй, мөн чиний төлөөх Түүний захиралт, зохицуулалтаас цаашид татгалзахгүй. Түүнийг л дагаж, Түүний хажууд Түүнтэй хамт байхыг л чи хүсэх бөгөөд Түүнийг өөрийн цорын ганц амь гэж хүлээн авах, Түүнийг өөрийн цорын ганц Эзэн, өөрийн цорын ганц Бурхан гэж хүлээн авахыг л чи хүсдэг билээ.

2014 оны 8 дугаар сарын 18

ГАРЧИГ

Бурханы зан чанар болон Түүний ажлаар хүрэх үр дүнг хэрхэн мэдэх вэ? 1
Хүмүүсийн төгсгөл зүрх сэтгэлд нь хэр хүнд дардаг бол 2
Хүмүүсийн итгэл үнэмшил үнэнийг орлож чадахгүй 4
Хүмүүсийн төгсгөлийг тодорхойлдог Бурханы стандартын талаар олон санал бодол байдаг 6
Бурханы замаар алх: Бурханаас эмээж, муугаас зайл 8
Хүмүүс Бурханаас эмээж, муугаас зайлж байгаа эсэхийг туршихын тулд Бурхан янзын бүрийн шалгалт ашигладаг 9
Бурханаас эмээхгүй, муугаас зайлахгүй байх нь Бурханыг эсэргүүцэж байгаа хэрэг 14
Бурхан хүмүүсийн төгсгөлийг хэрхэн тодорхойлдог болон хүмүүсийн төгсгөлийг тодорхойлдог Түүний стандарт 17
Нэгэн бодитой асуулт хүмүүсийн янз бүрийн ичгүүртэй байдлыг ил болгодог 21
Бурханы хандлагыг ойлгож, Бурханы талаарх бүх буруу төсөөллийг хая 26
Хүмүүсийн төгсгөлийг хэн тодорхойлдог вэ? 28
Хүмүүс туршлага дээр тулгуурлан Бурханыг тодорхойлох хандлагатай байдаг 30
Ажлынх нь явцад зугтсан хүмүүст хандах Бурханы хандлага 32
Бурханы ажлын үеэр зугтсан хүмүүс бол үнэн замыг хаядаг хүмүүс юм 33
Хүмүүсийн хувь заяаг Бурханд хандах хандлагаар нь шийддэг 35
Бурханаас эмээж эхлэх цэг нь Түүнд Бурхан шиг хандах юм 38
Бурханы хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс 41
Санууулах үгс 42

Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурхан Өөрөө I 43
I. Адам, Ева хоёр 52
1. Адамд өгсөн Бурханы тушаал 52
2. Бурхан Еваг бүтээсэн нь 54
3. Бурхан Адам, Ева хоёрт арьсан дээл хийж өгөв 56
II. Ноа 59
1. Бурхан дэлхийг үерээр устгахаар төлөвлөж, Ноад бүхээг барих заавар өгсөн нь 59
2. Үерийн дараа Ноад өгсөн Бурханы ерөөл 65
3. Бурхан солонгыг хүмүүстэй хийсэн Өөрийн гэрээний тэмдэг болгосон нь 67

Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурхан Өөрөө II 79
I. Абрахам 82
1. Бурхан Абрахамд хүү өгөхөөр амлав 82
Бурханы хийхээр шийдсэн ажилд хэн ч саад учруулж чадахгүй 82
2. Абрахам Исаакийг өргөсөн нь 84
Бурханы удирдлагын ажил болон хүн төрөлхтнийг аврах ажил нь Абрахам, Исаакийг тахил болгосноор эхэлдэг 84
Бурхан хүнийг мунхаг байсан ч тоодоггүй—Тэр хүнээс үнэнч байхыг л шаарддаг 84
3. Бурханы Абрахамд өгсөн амлалт 86
Хүн чин сэтгэл болон дуулгавартай байдлынхаа үрээр Бурханы ерөөлийг олж авдаг 86
Бурханыг мэддэг болон Түүнийг гэрчлэх чадвартай хүмүүсийг олж авах нь Бурханы хувиршгүй хүсэл юм 88
II. Бурхан Содомыг устгахаар шийдсэн нь 90
Бурхан зөвхөн Түүний үгэнд дуулгавартай орж, Түүний тушаалыг дагаж чаддаг хүмүүст санаа тавьдаг 90
Бурхан санаа тавьдаг хүмүүстээ асар их өршөөнгүй байдаг ба Өөрийнхөө жигшиж, голдог хүмүүст гүнээ хилэгнэдэг 93
Эцсийн өдрүүдийн хүмүүс Бурханы уур хилэнг үгээс нь л хардаг бөгөөд Бурханы уур хилэнг жинхэнээсээ амсаагүй 95
Бурханы зан чанар хэзээ ч хүнээс нуугдаж байгаагүй—хүний зүрх сэтгэл Бурханаас хөндийрсөн 97
III. Иов 99
1. Иовын талаарх Бурханы болон Библи дэх үнэлгээ 99
Иов өдөр тутмын амьдралдаа Бурханаас эмээж, муугаас зайлсны гойд илрэлүүд 100
2. Сатан Иовыг анх удаа уруу татсан нь (малаа хулгайд алдаж, хүүхдүүдэд нь гай зовлон тохиолдов) 101
а. Бурханы хэлсэн үгс 101
б. Сатаны хариу 102
Иовыг уруу татахыг Бурхан Сатанд зөвшөөрсөн нь Иовын итгэлийг төгс болгохын төлөө байв 102
в. Иовын хариу үйлдэл 104
Иов эзэмшдэг бүхнээ буцааж өгсөн нь түүний Бурханаас эмээдэг байдлаас үүдсэн 104
Иовын гуйвшгүй зарчимч чанар Сатанд ичгүүр авчирсан ба түүнийг самгардан зугтахад хүргэсэн 107
3. Сатан Иовыг дахин нэг удаа сорьсон нь (Иовын бүх бие яр хатгинд баригдав) 108

а. Бурханы хэлсэн үгс 108
б. Сатаны хэлсэн үг 108
в. Иов шалгалтад хэрхэн хандсан тухай 108
Бурханы замыг хайрлах Иовын хайр бүхнийг ялан дийлсэн 109
Хүн төрөлхтнийг гэх Бурханы анхаарал халамжийг Иов асар их зовлон дунд үнэхээр ойлгожээ 111
Иов Бурханаас эмээж, муугаас зайлдаг байсны бас нэг илрэл нь тэрээр бүх зүйл дээр Бурханы нэрийг дээдлэн магтаж байсан 112
Иовын талаарх олон буруу ойлголт 114
Өөрөөсөө болж Бурханыг шаналгахыг хүсээгүй учраас Иов төрсөн өдрөө хараав 116
Иов Сатаныг ялж, Бурханы нүдэнд жинхэнэ хүн болсон 118
Иовын тухай 120
Иовын өдөр тутмын амьдралаас бид түүний төгс, шулуун шударга байдал, Бурханаас эмээж, муугаас зайлдгийг нь харж болно 120
Шалгалтын үеийн Иовын хүн чанарын илрэл (Шалгалтын үеийн Иовын төгс, шулуун шударга байдал, Бурханаас эмээж, муугаас зайлдаг байдлыг ойлгох нь) 122
Иовын ухаалаг байдал 124
Иовын үнэн дүр төрх: Хуурамч зангүй бөгөөд үнэн, цэвэр ариун 125
Иов хайр, хорслыг ялгадаг нь 126
Иовын зөөлөн сэтгэл ба чин сэтгэл 126
Бурхан Иовыг Сатаны гарт өгсөн явдал болон Бурханы ажлын зорилгын хоорондох харилцаа 127
Бурханы туршилтыг хүлээн ав, Сатаны сорилтыг дав, мөн бүхий л оршихуйг чинь авахыг Бурханд зөвшөөр 129
Иовын гэрчлэл хойч үеийнхэнд өгсөн анхааруулга ба сэнхрүүлэл 130
Иовын гэрчлэл Бурханд тайтгарал авчирдаг 131
4. Иов Бурханыг чихээрээ сонссон нь 131
Бурхан Өөрийгөө Иовд харуулаагүй боловч Иов Бурханы дээд эрхэд итгэдэг 132
Бурхан өөрөөс нь нуугдаж байснаас болж Бурханд итгэх Иовын итгэл ганхаагүй 133
Иов Бурханы нэрийг алдаршуулдаг бөгөөд ерөөл, гай зовлонгийн талаар боддоггүй 134
Бурхан хэдийгээр хүнээс нуугддаг боловч бүх зүйлийн дундах үйл хэрэг нь Түүнийг мэдэхэд хүнд хангалттай юм 135
Зүрх сэтгэл нь Бурхантай дайсагнадаг бол хүн яаж Бурханаас эмээж, муугаас зайлж чадах билээ? 137
Бурханы шалгалтын тухай бүү эргэлз 139

5. Шалгалтын дараах Иов 141
Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүмүүсийг Бурхан нандигнадаг, харин мунхаг хүмүүсийг Бурхан дорд үздэг 141
Бурхан Иовд эрх мэдэл олгосон нь 143
Иов дахин нэг удаа Бурханд ерөөгдөж, Сатанд дахин хэзээ ч буруушаагдаагүй 143
Иов амьдралынхаа сүүлийн хагасыг Бурханы ерөөл дунд өнгөрөөжээ 144
Бүхий л амьдралдаа Иовын амьдран харуулсан үнэ цэн 145
IV. Хуулийн эрин үеийн хуулиуд 146
Хуулийн эрин үеийн хуулиуд нь Бурхан бүх хүн төрөлхтнийг удирдан чиглүүлдгийн бодит нотолгоо юм 147
Хүн төрөлхтөн Бурханы сургаал болон хангамжаас мөнхөд салшгүй 148
Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурхан Өөрөө III 151
Дэлхийг бүтээснээс хойших Бурханы бодол, санаа, үйлдлийн тойм 152
Бурхан анхны амьд хүнийг биечлэн бүтээв 153
Хуулийн эрин үеийн хавьцаа Бурхан урьд хожид хийгдээгүй хэд хэдэн ажлыг хийв 154
Бурхан ажил хийхээр анх удаа бие махбодтой болов 158
1. Есүс Амралтын өдөр тариан түрүү шувтран идэв 159
2. Хүний Хүү бол Амралтын өдрийн Эзэн мөн 159
3. Алдагдсан хонины тухай сургаалт зүйрлэл 169
4. Дал дахин долоон удаа уучлах 171
5. Эзэний Хайр 171
6. Уулан дээрх Сургаал 176
7. Эзэн Есүсийн сургаалт зүйрлэлүүд 176
8. Тушаалууд 177
9. Есүс гайхамшиг үзүүлсэн нь 184
а. Есүс таван мянган хүнийг хооллосон нь 184
б. Лазарын амилал Бурханыг алдаршуулсан нь 184
10. Есүсийн талаарх фарисайчуудын шүүлт 192
11. Есүс фарисайчуудыг зэмлэсэн нь 192
12. Өөрийн амиллын дараа шавь нартаа хэлсэн Есүсийн үг 196
13. Есүс дахин амилсныхаа дараа талх идэж, судрыг тайлбарласан нь 203
14. Шавь нар нь Есүст хайрсан загас өгсөн нь 203

Цор ганц Бурхан Өөрөө I

Бурханы эрх мэдэл (I) 209

1. Бурхан бүх зүйлийг бүтээхдээ үг ашигладаг 212

Эхний өдөр, Бурханы эрх мэдлийн ачаар хүн төрөлхтний өдөр, шөнө бий болж, бат зогсов 213

Хоёр дахь өдөр, Бурханы эрх мэдэл нь усыг зохицуулж, огторгуйг бүтээсэн ба хүмүүсийн амьдрах хамгийн үндсэн орон зай гарч ирсэн 214

Гурав дахь өдөр, Бурханы үг газар болон тэнгисийг бий болгосон ба Бурханы эрх мэдэл нь дэлхий ертөнцийг амиар бялхахад хүргэсэн 216

Дөрөв дэх өдөр, Бурханыг эрх мэдлээ дахин нэг удаа хэрэгжүүлэхэд хүн төрөлхтний улирал, өдөр, жил бий болжээ 218

Тав дахь өдөр, янз бүрийн хэлбэртэй амь Бүтээгчийн эрх мэдлийг өөр өөр байдлаар харуулсан 220

Зургаа дахь өдөр, Бүтээгчийг үгээ хэлмэгц Түүний оюун санаан дахь төрөл бүрийн амьтад ээлж дараалан гарч ирсэн 223

Бүтээгчийн эрх мэдлийн дор бүх зүйл төгс байдаг 225

Бүтээгдсэн болон бүтээгдсэн бус зүйлсийн юу ч Бүтээгчийн ялгамж чанарыг орлож чадахгүй 227

2. Хүнтэй гэрээ байгуулахын тулд Бурхан Өөрийн үгийг ашигласан 228

Бүх зүйлийг бүтээснийх нь дараа Бүтээгчийн эрх мэдэл солонгон гэрээнд дахин нэг удаа батлагдаж, харагдсан юм 229

3. Бурханы ерөөлүүд 231

Бүтээгчийн айлдварын өвөрмөц байдал болон шинж чанар нь Бүтээгчийн цор ганц ялгамж чанар болон эрх мэдлийн бэлгэ тэмдэг юм 231

Бүтээгчийн эрх мэдэл нь цаг хугацаа, орон зай, эсвэл газар зүйд хязгаарлагддаггүй ба Бүтээгчийн эрх мэдэл хэмжээлшгүй 236

Бүх зүйл болон амьтдыг Бүтээгч хянаж, захирдаг баримт нь Бүтээгчийн эрх мэдлийн жинхэнэ оршин тогтнолыг илтгэдэг 240

Бүтээгчийн эрх мэдэл хувиршгүй ба халдашгүй 242

4. Бурханы Сатанд өгсөн тушаал 243

Сатан хэзээ ч Бүтээгчийн эрх мэдлийг зөрчиж зүрхлээгүй ба үүний ачаар бүх зүйл дэг журамтай амьдардаг 243

Бүтээгчийн ялгамж чанартай Бурханд л цор ганц эрх мэдэл байдаг 245

Бүтээгчийн ялгамж чанар цор ганц бөгөөд чи олон бурхан шүтэх үзэл санааг баримтлах ёсгүй 251

Хүн төрөлхтөн хэдий ялзарсан ч гэсэн Бүтээгчийн эрх мэдлийн дээд эрх дор амьдарсаар байдаг 251

Цор ганц Бурхан Өөрөө II

Бурханы зөвт зан чанар 254
Бурханыг зөрүүдлэн эсэргүүцсэнийхээ төлөө хүн Бурханы уур хилэнд сүйрдэг 254
Содомын завхрал: Хүний уурыг хүргэж, Бурханыг хилэгнүүлэв 255
Бурханы уур хилэнг хүргэснийхээ төлөө Содом бүр мөсөн газрын хөрснөөс арчигджээ 257
Содом Өөрт нь ахин дахин дайсагнаж, эсэргүүцсэний дараа Бурхан бүрмөсөн газрын хөрснөөс арчсан 258
Бурханы уур хилэн нуугдмал агаад хүнд мэдэгддэггүй боловч халдахыг тэвчдэггүй 260
Бурханы уур хилэн бол бүх шударга хүч, бүх эерэг зүйлийн баталгаа 261
Сатан энэрэнгүй, шударга, журамтай мэт харагддаг ч мөн чанартаа харгис агаад ёрын муу билээ 265
Бурханы зөвт зан чанарыг мэдэхийн тулд хүн туршлага болон төсөөлөлдөө найдах ёсгүй 266
Хүмүүс чин сэтгэлээсээ гэмшсэнээр Бурханы өршөөл, хүлээцтэй байдлыг хүртэнэ 268
Ниневегийн түүхийн тойм 269
Ехова Бурханы анхааруулга Ниневед хүрэв 269
Ехова Бурханы анхааруулгад үзүүлсэн Ниневе болон Содомын хариу үйлдлийн эрс тэс ялгаа 270
Ниневегийн хааны гэмшил Ехова Бурханы сайшаалыг хүртсэн 271
Бурхан Ниневе хотынхны зүрх сэтгэлийн гүн дэх чин сэтгэлийн гэмшлийг харсан нь 272
Бурханд итгэх итгэл чинь жинхэнэ бол чи Түүний халамжийг үргэлж хүртэнэ 273
Ниневе хотынхон үнэн сэтгэлээсээ гэмшсэнээр Бурханы өршөөлийг хүртэж, төгсгөлөө өөрчилсөн 274
Бурханы өршөөл, хүлээцтэй байдал ховор биш, хүний жинхэнэ гэмшил л ховор юм 275
Бүтээгчийн зөвт зан чанар нь жинхэнэ агаад тод томруун 275
Хүн төрөлхтөнд хандах Бүтээгчийн үнэн сэтгэл 278
Бүтээгч хүн төрөлхтөнд зориулж үнэн сэтгэлээ илэрхийлдэг 280
Таван төрлийн хүн 282
Нэг дэх төрөл: Өлгийтэй нярай үе шат 282
Хоёр дахь төрөл: Хөхүүл хүүхдийн үе шат 283
Гурав дахь төрөл: Хөхнөөс гарч буй буюу жаахан хүүхдийн үе шат 283

Дөрөв дэх төрөл: Торниж байгаа хүүхэд буюу хүүхэд насны үе шат 285
Тав дахь төрөл: Амь нь боловсрох үе шат буюу насанд хүрэгчийн үе шат 288

Цор ганц Бурхан Өөрөө III
Бурханы эрх мэдэл (II) 290
Бурханы эрх мэдлийг макро болон микро өнцгөөс ойлгох нь 290
Хүн төрөлхтний болон орчлон ертөнцийн хувь заяа Бүтээгчийн дээд эрхтэй салшгүй холбоотой 293
Хүний амьдралын зургаан онцгой үе 295
Эхний онцгой үе: Төрөлт 295
1) Бүтээгчийн төлөвлөгөөнөөс шинэ амь төрдөг 296
2) Яагаад өөр өөр хүмүүс өөр өөр нөхцөлд төрдөг вэ 297
Хоёр дахь онцгой үе: Өсөж торних 298
1) Хүн болгоны өсөж том болох тогтсон нөхцөл байдлыг Бүтээгч төлөвлөсөн 298
2) Хүмүүсийн өсөж торнидог янз бүрийн нөхцөл байдал нь өөр өөр үүргийг бий болгодог 298
Гурав дахь онцгой үе: Биеэ даах 299
1) Биеэ даасныхаа дараа хүн Бүтээгчийн дээд эрхийг мэдэрч эхэлдэг 299
2) Эцэг эхээ орхин явж, амьдралын театрт жинхэнээсээ дүрдээ орж тоглож эхлэх нь 301
Дөрөв дэх онцгой үе: Гэрлэлт 301
1) Гэрлэлтэд хувь хүний сонголт хамаарахгүй 302
2) Гэрлэлт хань ижлүүдийн хоёулынх нь хувь заяанаас төрдөг 303
Тав дахь онцгой үе: Үр удам 303
1) Хүний үр хүүхэд ямар болохыг хэн ч хянах боломжгүй 304
2) Дараагийн үеэ өсгөн хүмүүжүүлсний дараа хүмүүс хувь заяаны талаар шинэ ойлголт олж авдаг 305
3) Хувь заяанд итгэх нь Бүтээгчийн дээд эрхийн тухай мэдлэгийг орлохгүй 306
4) Бүтээгчийн дээд эрхэд захирагддаг хүмүүс л жинхэнэ эрх чөлөөг олж авч чадна 307
Зургаа дахь онцгой үе: Үхэл 309
1) Хүний амьдрал, үхлийг хянах эрх гагцхүү Бүтээгчид бий 309
2) Бүтээгчийн дээд эрхийг мэддэггүй хүн үхлийн айдаст автана 310
3) Алдар нэр, эд баялаг хөөцөлдөж өнгөрүүлсэн амьдрал хүнийг үхэлтэй тулгарахад барьц алдуулна 311
4) Бүтээгчийн ноёрхол дор орж, үхэлтэй тайвнаар нүүр тул 313

5) Иовын амьдралын эрэл хайгуул, олж авсан зүйл нь үхэлтэй тайвнаар нүүр тулах боломжийг түүнд олгосон 315
6) Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрснөөр л хүн Түүний хажууд эргэн очиж чадна 316
Бүтээгчийн дээд эрхийг мэдэх боломжийг бүү алд 317
Бурханд хүний хувь заяаг захирах дээд эрх байдаг гэсэн бодит үнэнийг хэн ч өөрчилж чадахгүй 319
Бурханы эрх мэдэлд захирагдахыг хүсдэг хүний зөв хандлага ба хэрэгжүүлэлт 320
Бурханыг цор ганц Эзэнээ гэдгийг хүлээн зөвшөөрөх нь авралд хүрэх эхний алхам юм 321

Цор ганц Бурхан Өөрөө IV
Бурханы ариун байдал (I) 324
1. Хүнд өгсөн Ехова Бурханы тушаал 326
2. Могой, эмэгтэйг уруу татсан нь 326
3. Сатан, Ехова Бурхан хоёрын харилцан яриа 329

Цор ганц Бурхан Өөрөө V
Бурханы ариун байдал (II) 342
Сатаны сорилт 347
Сатан хүнийг завхруулдаг таван арга зам 354
а. Сатан хүнийг завхруулахад эрдэм мэдлэгийг хэрхэн ашигладаг тухай 355
б. Сатан хүнийг завхруулахад шинжлэх ухааныг хэрхэн ашигладаг тухай 357
в. Сатан хүнийг завхруулахад уламжлалт соёлыг хэрхэн ашигладаг тухай 359
г. Сатан хүнийг завхруулахын тулд мухар сүсгийг хэрхэн ашигладаг тухай 361
д. Сатан хүнийг завхруулахад нийгмийн чиг хандлагыг хэрхэн ашигладаг тухай 363

Цор ганц Бурхан Өөрөө VI
Бурханы ариун байдал (III) 372
Сатан хүнийг завхруулдаг таван арга зам 372
а. Сатан хүнийг завхруулахдаа эрдэм мэдлэгийг ашиглаж, хүнийг хянахдаа алдар нэр, ашиг хонжоог ашигладаг 372
б. Сатан хүнийг завхруулахдаа шинжлэх ухааныг ашигладаг 376
в. Сатан хүнийг завхруулахдаа уламжлалт соёлыг ашигладаг 378
г. Сатан хүнийг завхруулахдаа нийгмийн чиг хандлагыг ашигладаг 380

Хүнд хийдэг зүйлээс нь Бурханы ариун байдлыг ойлгох нь 383
Хүнийг завхруулахдаа Сатаны хэрэглэдэг заль мэх..... 392
Хүнийг завхруулахдаа Сатаны хэрэглэдэг зургаан үндсэн заль мэх бий..... 393

Цор ганц Бурхан Өөрөө VII

Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж (I)..... 400
Бурханы эрх мэдэл, Бурханы зөвт зан чанар, Бурханы ариун байдлын тухай тойм..... 400
I Түүх: Үр, газар, мод, нарны гэрэл, шувууд ба хүн..... 405
II Түүх: Өндөр уул, жаахан горхи, хүчит салхи ба аварга давлагаа..... 410

Цор ганц Бурхан Өөрөө VIII

Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж (II)..... 421
Хүн төрөлхтөнд зориулан Бурханы бүтээсэн амьдралын үндсэн орчин..... 423
а. Агаар 424
б. Температур 425
в. Дуу чимээ 428
г. Гэрэл 429
д. Агаарын урсгал..... 431
Хүн төрөлхтөнд зориулан Бурханы бэлддэг өдөр тутмын хоол, унд..... 434

Цор ганц Бурхан Өөрөө IX

Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж (III)..... 446
Бурхан бүх хүн төрөлхтнийг тэжээн тэтгэхийн тулд бүх зүйлд хил хязгаар тогтоодог 447
Нэгдүгээр хэсэг: Бурхан янз бүрийн нутаг дэвсгэрт хил хязгаар тогтоосон 447
Хоёрдугаар хэсэг: Бурхан бүх амьд зүйлд хил хязгаар тогтоосон ... 450
Гуравдугаар хэсэг: Бурхан хүн төрөлхтнийг тэтгэх байгаль орчин, экологийг хадгалсан..... 451
Дөрөвдүгээр хэсэг: Бурхан өөр өөр арьс өнгөний хүмүүсийн дунд хил хязгаар татсан 454
Бүхнийг захирч, бүгдийг хангадаг Бурхан бол бүх зүйлийн Бурхан юм 458
Хүн төрөлхтөнд амьдрах тогтвортой орчныг өгөхийн тулд Бурхан бүх зүйлийн хоорондох харилцааг тэнцвэржүүлдэг 462

Цор ганц Бурхан Өөрөө X

Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж (IV) 470
Бурхан сүнсний ертөнцийг хэрхэн захирч, удирддаг вэ 472
а. Үл итгэгчдийн амьдрал, үхлийн мөчлөг..... 475

б. Итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүсийн амьдрал, үхлийн мөчлөг 483
в. Бурханыг дагагчдын амьдрал, үхлийн мөчлөг 487
Хүн төрөлхтөнд тавих Бурханы шаардлага 495
а. Бурханы Өөрийнх нь ялгамж чанар, байр суурь 495
б. Бурханд хандах хүн төрөлхтний янз бүрийн хандлага 496
в. Хүн төрөлхтнөөс Бурханы шаарддаг Өөрт нь хандвал зохих хандлага 499

БУРХАНЫ ЗАН ЧАНАР БОЛОН ТҮҮНИЙ АЖЛААР ХҮРЭХ ҮР ДҮНГ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

Эхлээд магтан дуу дуулцгаая: Хаанчлалын сүлд дуулал (I) Хаанчлал дэлхий дээр бууж ирлээ.

Дагаж дуулах: Үй түмэн хүн Намайг уухайлдаг, үй олон хүн Намайг магтдаг; бүх ам нэгэн жинхэнэ Бурханыг дууддаг. Хаанчлал хүний ертөнцөд бууж ирлээ.

1 Үй түмэн хүн Намайг уухайлдаг, үй олон хүн Намайг магтдаг; бүх ам нэгэн жинхэнэ Бурханыг дуудаж, бүх хүн Миний үйл хэргийг харахаар хараагаа бэлчээдэг. Хаанчлал хүний ертөнцөд бууж ирлээ, Миний үнэн бие баялаг агаад элбэг дэлбэг. Үүнд баясахгүй хэн байх билээ? Баяр хөөртэйгөөр бүжихгүй хэн байх билээ? Өө, Сион! Намайг тэмдэглэхийн тулд ялгуусан тугаа өргө! Ялалтын ялгуусан дуугаа дуулж, Миний ариун нэрийг түгээ!

2 Газар дэлхийн зах хязгаар дахь бүх бүтээл ээ! Миний төлөө тахил болохоор өөрсдийгөө яаран цэвэрлэ! Тэнгэр дэх одод оо! Даруйхан байрандаа эргэн очиж огторгуйд Миний сүр хүчийг харуул! Намайг гэх дундаршгүй хайр хүндлэлээ шингээсэн газар дээрх хүмүүсийн дууг Би чих тавин сонсож байна! Бүх бүтээл эргэн амилах энэ өдөр, Би хүний ертөнцөд буун ирсэн. Энэ мөчид, яг энэ үед бүх цэцэг цоморлогоо дэлгэж, бүх шувуу нэгэн өнгөөр жиргэж, бүх зүйл баяр хөөрөөр цалгидаг! Хаанчлалын ёслолын буудлагын дуунаар Сатаны хаанчлал нуран унаж, хаанчлалын сүлд дууллын нүргээнд дахин хэзээ ч өндийхгүйгээр устан үгүй болдог!

3 Газар дээр хэн өндийн босож, эсэргүүцэж зүрхлэх билээ? Газар луу буухдаа Би шатаалт, уур хилэн, бүх гай гамшиг авчирдаг. Газар дээрх хаанчлалууд одоо Миний хаанчлал болсон! Тэнгэрт үүлс хөлбөрөн нүүгэлтдэг; тэнгэрийн дор гол нуурууд долгилж, сэтгэл уярам аялгууг баясалтайгаар урсгадаг. Ичсэн амьтад үүрнээсээ гарч, бүх хүнийг Би зүүд нойрноос нь сэрээдэг. Түмэн олон ардын хүсэн хүлээсэн өдөр эцэстээ ирлээ! Тэд хамгийн сайхан дууг Надад өргөн барьдаг!

Хургыг дагаж шинэ дуу дуулъя

Та нар энэ дууг дуулах болгондоо юуны тухай боддог вэ? (Сэтгэл маш их хөөрч, догдлон, хаанчлалын гоо үзэмж хэчнээн гайхалтай сайхныг, мөн хүн төрөлхтөн болон Бурхан хэрхэн үүрд хамт байх тухай боддог.) Бурхантай хамт байхын тулд хүн ямар болох ёстой талаар бодож үзсэн хүн байна уу? Бурхантай нэгдэж, хаанчлалд үргэлжлэх гайхалтай сайхан амьдралыг эдлэхийн тулд хүн ямар байх ёстой гэж та нар төсөөлдөг вэ? (Тэдний зан чанар өөрчлөгдөх ёстой.) Тэдний зан чанар өөрчлөгдөхдөө харин ямар хэмжээгээр өөрчлөгдөх ёстой вэ? Зан чанар нь өөрчлөгдсөний дараа тэд ямар болох вэ? (Тэд ариун болно.) Ариун байдлын шалгуур юу вэ? (Хүний бүх бодол, эргэцүүлэл Христтэй нийцэх ёстой.) Тийм нийцэл хэрхэн илэрдэг вэ? (Хүн Бурханы эсэргүүцэж, Түүнээс урвадаггүй, Бурханд бүрэн захирагдаж чаддаг, зүрх сэтгэлдээ Бурханаас эмээн хүндэтгэдэг.) Та нарын

зарим хариулт дөхөж байна. Та нар бүгдээрээ зүрх сэтгэлээ нээж, хэлэхийг хүссэн зүйлээ хэл. (Бурхантай хамт хаанчлалд амьдардаг хүмүүс үнэнийг эрэлхийлж, аливаа хүн, үйл явдал, эд зүйлд баригдалгүйгээр үүргээ үнэнчээр биелүүлж чаддаг байх ёстой. Ингэснээр харанхуйн нөлөөнөөс ангижирч, зүрх сэтгэлээ Бурхантай нийцүүлж, Бурханаас эмээж, муугаас зайлах боломжтой болдог.) (Аливааг харах бидний өнцөг Бурхантай нийцдэг болж, бид харанхуйн нөлөөнөөс ангижирч чадна. Ядаж л бид Сатанд ашиглуулахаа больж, аливаа ялзарсан зан чанарыг хаяж, Бурханд захирагдаж чадна. Хүмүүс харанхуйн нөлөөнөөс ангижрах нь нэн чухал гэдэгт бид итгэдэг. Харанхуйн нөлөөнөөс ангижирч, Сатаны хүлээснээс мултарч чадахгүй хүмүүс Бурханы авралыг хүртээгүй байдаг.) (Бурханаар төгс болгуулах стандартад нийцэхийн тулд хүмүүс Түүнтэй нэгэн зүрх сэтгэл, санаа бодолтой байж, Түүнийг эсэргүүцэхээ болих ёстой. Тэд өөрсдийгөө мэдэж, үнэнийг хэрэгжүүлж, Бурханы тухай ойлголттой болж, Бурханыг хайрлаж, Бурхантай нийцтэй болж чадах ёстой. Үүнийг л хийх хэрэгтэй.)

Хүмүүсийн төгсгөл зүрх сэтгэлд нь хэр хүнд дардаг бол

Баримтлах ёстой замынхаа талаар та нар бага зэрэг боддог юм шиг харагддаг бөгөөд энэ талаар жаахан ойлголттой болж, үнэлдэг болсон. Гэвч хэлсэн бүх үг чинь хий хоосон, эсвэл бодитой болох эсэх нь та нар өдөр тутмын хэрэгжүүлэлтдээ анхаарал хандуулахаас хамаарна. Олон жилийн туршид та нар бүгд сургаал номлол болон үнэний бодит агуулгын аль алиных нь хувьд үнэний тал болгоноос тодорхой хэмжээний үр дүнд хүрсэн. Өнөө үед хүмүүс үнэнийг эрмэлзэхэд ихээхэн анхаардгийг энэ нь баталдаг бөгөөд үүний үр дүнд үнэний тал болон хэсэг бүр зарим хүний зүрх сэтгэлд гарцаагүй үндэс сууриа тавьсан. Гэвч Миний хамгийн их айдаг зүйл юу вэ? Хэдийгээр үнэний эдгээр сэдэв болон онол та нарын зүрх сэтгэлд үндэс сууриа тавьсан ч гэсэн бодит агуулга нь чухал биш байдаг. Асуудалтай тулгарч, шалгалт, сонголттой нүүр тулах үед эдгээр үнэний бодит байдлыг та нар хэр зэрэг бодитойгоор ашиглах вэ? Бурханы хүслийг хангаж чаддаг болохын тулд хүндрэл бэрхшээлээ даван гарч, өөрийн шалгалтаас гарч ирэхэд энэ нь та нарт тусалж чадах уу? Та нар шалгалтынхаа дунд бат зогсож, Бурханд цангинасан гэрчлэл хийх үү? Та нар ер нь эдгээр асуудлыг анхаарч байсан уу? Би та нараас асууя: Зүрх сэтгэлд чинь, өдөр бүрийн бүх бодол, эргэцүүлэлд чинь та нарын хувьд хамгийн чухал нь юу вэ? Та нар ер нь энэ талаар дүгнэлтэд хүрч байсан уу? Та нар юуг хамгийн чухал гэж итгэдэг вэ? Зарим хүн “мэдээж, үнэнийг хэрэгжүүлэх” гэдэг байхад зарим нь “мэдээж, Бурханы үгийг өдөр бүр унших” гэж хэлдэг. Зарим хүн “мэдээж, Бурханы өмнө очиж, Бурханд өдөр бүр залбирах” гэдэг бөгөөд “мэдээж, энэ бол өдөр бүр үүргээ зохих ёсоор биелүүлэх” гэж хэлдэг хүмүүс бий. Бурханыг хэрхэн сэтгэл хангалуун байлгаж, бүх зүйл дээр Түүнд хэрхэн дуулгавартай байж, Түүний хүсэлд хэрхэн нийцүүлж үйлдэх тухай л боддог гэж хэлдэг зарим хүн ч байдаг. Энэ зөв үү? Энэ нь бүх зүйл үү? Жишээ нь, “Би Бурханд захирагдахыг л

хүсдэг боловч асуудал тулгарах болгонд би тэгж чаддаггүй” гэж зарим нь хэлдэг. Нөгөө хэсэг нь “Би зөвхөн Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг л хүсдэг, би ганцхан л удаа Түүнийг сэтгэл хангалуун болгож чадвал болох нь тэр, гэхдээ би Түүнийг хэзээ ч сэтгэл хангалуун болгож чадахгүй” гэж хэлдэг. Зарим нь “Би Бурханд захирагдахыг л хүсдэг. Шалгалтын үед би ямар нэгэн гомдол, хүсэлтгүйгээр Түүний зохион байгуулалт, дээд эрх, зохицуулалтад захирагдахыг л хүсдэг. Гэсэн ч би бараг дандаа л захирагдаж чаддаггүй” гэдэг. Гэвч зарим нь “Шийдвэр гаргах болохдоо би хэзээ ч үнэнийг хэрэгжүүлэхээр сонгож чаддаггүй. Би махан биеийг хангахыг үргэлж хүсэж, хувийн, аминчхан хүслээ хангахыг хүсдэг” гэж хэлдэг. Үүний шалтгаан нь юу вэ? Бурханы туршилт ирэхээс өмнө та нар өөрсдийгөө аль хэдийн олон удаа сорьж, ахин дахин туршиж, шалгаад үзчихсэн байх уу? Та нар Бурханд үнэхээр захирагдаж, Түүнийг үнэхээр сэтгэл хангалуун болгож, Түүнээс урвахгүй гэдгээ баталж чадах эсэхээ үз; өөрсдийгөө сэтгэл хангалуун байлгахгүй, өөрсдийн аминчхан хүслийг хангалгүй, харин зөвхөн Бурханыг сэтгэл хангалуун байлгаж, хувийн сонголт хийхгүй байж чадах эсэхээ үз. Ингэдэг хүн байна уу? Үнэндээ, яг нүдний чинь өмнө тавьсан цорын ганц баримт л байгаа, та нар дор бүрнээ үүнийг хамгийн их сонирхож, мэдэхийг хамгийн их хүсдэг бөгөөд энэ бол хүн бүрийн төгсгөл, хүрэх газрын тухай асуудал юм. Та нар үүнийг ухаараагүй байж магадгүй боловч хэн ч үүнийг үгүйсгэж чадахгүй билээ. Хүний төгсгөлийн тухай үнэн, хүн төрөлхтөнд өгсөн Бурханы амлалт, Бурхан хүмүүсийг ямар хүрэх газарт аваачих санаатай байгаа тухайд, энэ сэдвээр Бурханы үгийг аль хэдийн хэдэнтээ судалчихсан зарим хүн байдаг гэдгийг Би мэднэ. Тэгтэл хариултыг удаа дараа хайж, оюун санаандаа эргэцүүлэн бодож байгаа хэр нь юунд ч хүрдэггүй, эсвэл магадгүй зарим нэг тодорхойгүй дүгнэлтэд хүрч дуусдаг хүмүүс байдаг. Эцэст нь тэд ямар төгсгөл өөрсдийг нь хүлээж байгаа талаар сайн мэдэхгүй хэвээр үлддэг. Үүргээ биелүүлэхдээ, ихэнх хүн дараах асуултын эцсийн хариултыг мэдэхийг хүсэх хандлагатай байдаг: “Миний төгсгөл ямар байх вэ? Би энэ замаар бүр төгсгөлд нь хүртэл алхаж чадах болов уу? Хүн төрөлхтөнд хандах Бурханы хандлага ямар вэ?” Зарим хүн: “Урьд нь би зарим нэг юмыг хийж, хэлсэн; би Бурханд дуулгаваргүй байсан, Бурханаас урвасан үйлдэл хийсэн, би Бурханыг сэтгэл хангалуун болгож чадахгүй, Бурханы сэтгэлийг шархлуулж, Бурханы урмыг хугалж, намайг үзэн ядаж, жигшихэд Бурханыг хүргэсэн удаа ч байсан. Магадгүй ийм учраас миний төгсгөл тодорхойгүй байгаа байх” гэж хүртэл санаа зовдог. Ихэнх хүн өөрийнхөө төгсгөлийн талаар түгшдэг гэж хэлэх нь зүйтэй болов уу. “Би амьд үлдэнэ гэдэгтээ зуун хувь итгэлтэй байна; би Бурханы хүслийг хангаж чадна гэдэгтээ зуун хувь итгэлтэй байна; би бол Бурханы зүрх сэтгэлд нийцдэг хүн; би бол Бурханы магтан сайшаадаг хүн” гэж хэлж хэн ч зүрхэлдэггүй. Бурханы замыг дагах нь нэн хэцүү, үнэнийг хэрэгжүүлэх нь бүхнээс хэцүү гэж зарим хүн боддог. Иймд ийм хүмүүс өөрсдийгөө тусыг олохоос өнгөрсөн гэдэгт итгэж, сайн төгсгөлд хүрэх талаар найдаж зүрхэлдэггүй; эсвэл магадгүй тэд Бурханы хүслийг хангаж чадахгүй учраас

амьд үлдэж чадахгүй гэж итгэдэг байх. Үүнээсээ болж тэд, өөрсдөд нь төгсгөл байхгүй, сайн хүрэх газарт хүрч чадахгүй гэж мэтгэдэг. Хүмүүс яг яаж бодохоос үл хамааран, бүгд л өөрийнхөө төгсгөлийн талаар олонтоо бодсон байдаг. Өөрсдийн ирээдүй болон Бурхан ажлаа дуусмагц юу хүртэх тухай асуултуудын талаар тэд байнга тооцоолж, төлөвлөж байдаг. Зарим нь төлөөсийг хоёр нугалж төлдөг; зарим нь гэр бүл, ажлаа орхидог; зарим хүн гэрлэлтээсээ татгалздаг; зарим нь Бурханы төлөө өөрсдийгөө зарлагдахын тулд албан тушаалаасаа огцордог; зарим нь үүргээ биелүүлэхийн тулд гэр орноосоо явдаг; зарим нь зовлон бэрхшээлийг сонгож, хамгийн шаналгаатай, ядаргаатай даалгаврыг үүрч эхэлдэг; зарим нь эд хөрөнгөө зориулж, байгаа бүхнээ зориулахыг сонгодог; гэсэн ч нөгөө хэсэг нь үнэнийг эрэлхийлж, Бурханыг мэдэхээр эрмэлзэхийг сонгодог. Та нар хэрхэн хэрэгжүүлэхээр сонгох нь хамаагүй, хэрэгжүүлэх арга барил чинь чухал уу, үгүй юу? (Чухал биш.) Тэгвэл энэхүү “чухал биш байдлыг” бид хэрхэн тайлбарлах вэ? Хэрэгжүүлэлтийн арга барил чухал биш юм бол, юу чухал вэ? (Гаднах сайхан зан авир бол үнэнийг хэрэгжүүлэхийн илэрхийлэл биш.) (Хувь хүн бүрийн бодол чухал биш; бид үнэнийг хэрэгжүүлсэн эсэх, мөн бид Бурханыг хайрладаг эсэх нь энд гол нь.) (Антихристүүд болон хуурамч удирдагчдын уналт нь гадаад зан авир хамгийн чухал зүйл биш гэдгийг ойлгоход бидэнд тусалдаг. Тэд өнгөн дээрээ ихийг хаясан мэт, төлөөс төлөхөд бэлэн байгаа мэт санагддаг боловч ойроос шалгаж үзвэл тэд Бурханыг зүгээр л хүндэтгэдэггүй, харин ч Түүнийг бүхий л талаар эсэргүүцдэгийг нь бид харж болно. Шийдвэрлэх мөчид тэд үргэлж Сатаны талд зогсож, Бурханы ажилд саад хийдэг. Тиймээс цаг нь ирэхэд бид аль талд зогсох вэ, аливааг үзэх бидний үзэл бодол ямар байх вэ гэдгийг гол нь энд авч үздэг.) Та нар бүгд сайхан ярьдаг, үнэнийг хэрэгжүүлэх, Бурханы санаа зорилго, Бурхан хүн төрөлхтнөөс юу шаарддаг тухайд аль хэдийн үндсэн ойлголттой болж, хэрэгжүүлэх стандарттай болсон юм шиг байна. Та нар ингэж ярьж чадаж байгаа нь тун сэтгэл хөдлөм юм. Хэдийгээр та нарын зарим хэлдэг зүйл тийм ч үнэн зөв биш боловч үнэний тухай зүй ёсны тайлбартай болоход хэдийн дөхөж очсон байна. Та нар эргэн тойрныхоо хүмүүс, үйл явдал болон юмсын талаар, Бурханы зохицуулсан хүрээлэн буй орчин, харж чадах бүх зүйлийнхээ талаар өөрийн гэсэн бодитой ойлголтыг бий болгосныг энэ нь баталдаг. Энэ бол үнэнд дөхсөн ойлголт юм. Та нарын хэлсэн зүйл бүрэн ойлгомжтой биш, цөөн хэдэн үг нь тийм ч зохимжтой биш байгаа ч ойлгох чадвар чинь үнэний бодит байдалд аль хэдийн дөхөж байна. Та нарын ингэж ярихыг сонсоход Надад маш сайхан санагдаж байна.

Хүмүүсийн итгэл үнэмшил үнэнийг орлож чадахгүй

Зарим хүн зовлон бэрхшээлийг дааж чаддаг, төлөөс төлж чаддаг, гаднаа маш сайхан зан авиртай, ихээхэн хүндлэгддэг, бусдын бишрэлийг хүлээсэн байдаг. Ийм гаднах зан авирыг үнэнийг хэрэгжүүлж байна хэмээн үзэж болно гэж та нар хэлэх үү? Ийм хүмүүс Бурханы хүслийг хангаж байна гэж тодорхойлж болох уу? Хүмүүс

ийм хүмүүсийг хараад, тэд Бурханыг сэтгэл хангалуун байлгаж, үнэнийг хэрэгжүүлэх замаар алхаж, Бурханы замаар явж байна гэж яагаад дандаа боддог юм бэ? Зарим хүн яагаад ингэж боддог юм бэ? Үүнд ганцхан тайлбар бий. Тэр нь ямар тайлбар вэ? Асар олон хүний хувьд, үнэнийг хэрэгжүүлнэ гэдэг юу гэсэн үг болох, Бурханыг сэтгэл хангалуун байлгана гэж юу гэсэн үг болох, жинхэнээсээ үнэн-бодит байдалтай болно гэж юу гэсэн үг болох гэх мэт зарим асуултыг тийм ч сайн ойлгодоггүй. Тиймээс гаднаа сүнслэг, эрхэмсэг, сүрлэг, агуу мэт санагддаг хүмүүст байнга хууртдаг зарим хүн байдаг. Үсэг, хоосон сургаалын тухай цэцэн цэлмэг ярьж чаддаг, үг яриа, үйлдэл нь бахдан бишрүүштэй юм шиг санагддаг хүмүүсийн тухайд гэвэл, тэдэнд мэхлэгдэгсэд үйлдлийнх нь мөн чанар, үйл хэргийнх нь цаад зарчим, тэдний зорилго юу болохыг хэзээ ч харж байгаагүй. Түүнчлэн энэ хүмүүс Бурханд үнэхээр захирагддаг эсэхийг нь хэзээ ч харж байгаагүй, үнэхээр Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүн мөн эсэхийг нь бас хэзээ ч тодорхойлж байгаагүй. Тэд энэ хүмүүсийн хүн чанар-мөн чанарыг хэзээ ч ялган таньж байгаагүй. Харин ч тэдэнтэй танилцах эхний алхмаасаа л эхлээд тэд бага багаар энэ хүмүүсийг биширч, дээдлэн хүндлэх болж, эцэстээ энэ хүмүүс шүтээн нь болдог. Түүнчлэн зарим хүний бодлоор бол өөрсдийнх нь гэр бүл, ажлаа орхиж чадна гэж боддог, өнгөн талдаа төлөөс төлж чаддаг мэт санагддаг, шүтэн биширдэг шүтээнүүд нь Бурханыг үнэхээр сэтгэл хангалуун байлгадаг, сайн төгсгөл болоод сайн хүрэх газарт үнэхээр хүрч чадах хүмүүс байдаг. Тэдний бодлоор бол эдгээр шүтээн нь Бурханы магтдаг хүмүүс юм. Юунаас болж тэд ингэж боддог вэ? Энэ асуудлын мөн чанар юу вэ? Энэ нь ямар үр дагаварт хүргэж болох вэ? Эхлээд үүний мөн чанарын асуудлыг хэлэлцье.

Хүмүүсийн үзэл бодол, хэрэгжүүлэлтийн арга барил, тэд хэрэгжүүлэлтийн аль зарчмыг авч хэрэгжүүлэхээр сонгодог, дор бүрнээ юунд анхаарлаа төвлөрүүлэх хандлагатай байдаг тухай эдгээр асуудал нь хүн төрөлхтөнд тавих Бурханы шаардлагатай үндсэндээ ямар ч хамаагүй байдаг. Хүмүүс өнгөц хэрэг явдал, эсвэл гүнзгий асуудал, үсэг, сургаал номлол, эсвэл бодит байдлыг анхаардаг ч байсан гэсэн өөрсдийн хамгийн их баримталбал зохих зүйлээ баримталдаггүй, өөрсдийн хамгийн их мэдэх ёстой зүйлээ ч мэддэггүй. Үүний шалтгаан бол хүмүүс үнэнд огт дургүй; тиймээс тэд Бурханы айлдвар дахь хэрэгжүүлэлтийн зарчмуудыг эрж хайж, хэрэгжүүлэхэд цаг зав, хүчин чармайлт гаргахыг хүсдэггүй. Үүний оронд тэд дөт зам ашиглан, өөрсдийн сайн хэрэгжүүлэлт, сайн зан авир гэж ойлгож, мэддэгээ нэгтгэн дүгнэхийг илүүд үздэг; энэхүү дүгнэлт нь хожим өөрсдийнх нь эрэлхийлэх зорилго болдог бөгөөд үүнийгээ тэд хэрэгжүүлэх үнэн гэж үздэг. Үүний шууд үр дагавар нь хүмүүс үнэнийг хэрэгжүүлэх явдлыг хүний сайн зан авираар орлуулан ашигладаг ба энэ нь бас хүмүүсийн Бурханд тал олж авах гэсэн хүслийг хангадаг. Энэ нь тэдэнд үнэнтэй тэмцэлдэх хөрөнгийг өгдөг, үүнийг ашиглан тэд бас Бурхантай маргаж, Бурхантай өрсөлддөг. Үүний зэрэгцээ хүмүүс бас Бурханыг эрээ цээргүйгээр хаяж, шүтэн биширдэг шүтээнээ Түүний оронд тавьдаг. Хүмүүсийг ийм

харанхуй бүдүүлэг үйлдэл, үзэл бодол, өрөөсгөл бодол, хэрэгжүүлэлттэй болоход хүргэдэг цорын ганц үндсэн шалтгаан байдаг бөгөөд өнөөдөр Би та нарт энэ тухай ярьж өгнө: Шалтгаан нь, хүмүүс хэдийгээр Бурханыг дагаж, Түүнд өдөр бүр залбирч, Түүний айлдварыг өдөр бүр уншдаг боловч үнэндээ Бурханы хүслийг ойлгодоггүй. Асуудлын үндэс энд байдаг. Хэрвээ хэн нэгэн Бурханы зүрх сэтгэлийг ойлгож, Тэр юунд дуртай, юуг жигшдэг, юу хүсдэг, юуг голдог, ямар хүнийг Тэр хайрладаг, ямар хүнд дургүй байдаг, хүмүүст шаардлага тавиҳдаа Тэр ямар стандарт хэрэглэдэг, тэднийг төгс болгохдоо Тэр ямар арга зам баримталдгийг мэддэг бол тэр хүн өөрийн хувийн бодлыг тээсэн хэвээр байж чадах уу? Ийм хүмүүс зүгээр л явж очоод, өөр нэг хүнийг шүтэж чадах уу? Энгийн нэг хүн тэдний шүтээн болж чадах уу? Бурханы хүслийг ойлгодог хүмүүс үүнээс арай илүү ухаалаг үзэл бодолтой байдаг. Тэд ялзарсан хүнийг зоргоороо шүтэхгүй, мөн үнэнийг хэрэгжүүлэх замаар алхах зууpаа хэдхэн энгийн дүрэм, зарчмыг сохроор дагаж мөрдөх нь үнэнийг хэрэгжүүлэхтэй адилхан гэдэгт ч итгэхгүй.

Хүмүүсийн төгсгөлийг тодорхойлдог Бурханы стандартын талаар олон санал бодол байдаг

Энэ сэдэвтээ буцаж ороод төгсгөлийн тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье.

Хүн болгон өөрийн төгсгөлийн талаар санаа зовнидгоос хойш Бурхан тэр төгсгөлийг хэрхэн тодорхойлдгийг та нар мэдэх үү? Бурхан ямар аргаар хүний төгсгөлийг тодорхойлдог вэ? Түүнчлэн үүнийг тодорхойлохдоо Тэр ямар стандарт хэрэглэдэг вэ? Хүний төгсгөл хараахан тодорхойлогдоогүй байх үед үүнийг ил болгохын тулд Бурхан юу хийдэг вэ? Үүнийг мэдэх хүн байна уу? Хүмүүсийн төгсгөл, эдгээр төгсгөлийн хуваагддаг ангиллууд, өөр өөр төрлийн хүмүүсийг хүлээж байдаг янз бүрийн төгсгөлийн талаарх сэжүүрийг эрж хайхыг чармайж Бурханы үгийг судлахад аль хэдийн маш урт хугацааг зарцуулсан зарим хүн байдаг гэж Би хормын өмнө хэлсэн. Тэд бас Бурханы үг хэрхэн хүний төгсгөлийг удирддаг, Тэр ямар стандарт хэрэглэдэг, хүний төгсгөлийг Тэр яг яаж тодорхойлдгийг олж мэдэх гэж найддаг. Гэсэн ч эцэстээ энэ хүмүүс хариултыг нь хэзээ ч олж чаддаггүй. Үнэндээ энэ асуудлын талаар Бурханы айлдварт тун цөөхөн дурдсан байдаг. Яагаад тэр вэ? Хүний төгсгөл хараахан ил болох болоогүй цагт Бурхан эцэст нь юу болохыг хэнд ч хэлэхийг хүсдэггүй, мөн цаг нь болоогүй байхад хүрэх газрынх нь талаар хэнд ч мэдэгдэхийг хүсдэггүй—учир нь, ингэх нь хүн төрөлхтөнд ямар ч ашиггүй байх болно. Яг одоо Би Бурхан ямар арга замаар хүний төгсгөлийг тодорхойлдог, эдгээр төгслийг тодорхойлж, ил болгохдоо Түүний ажилдаа баримталдаг зарчим, хүн амьд үлдэж чадах эсэхийг тодорхойлохдоо Түүний ашигладаг стандартын тухай та нарт хэлэхийг л хүсэж байна. Эдгээр нь та нарын хамгийн их санаа зовниж буй асуулт бус уу? Тэгвэл Бурхан хүмүүсийн төгсгөлийг хэрхэн тодорхойлдог гэж хүмүүс боддог вэ? Та нар зарим хэсгийг нь дөнгөж сая дурдлаа: Бурханы төлөө зарлагадаж, үүргээ үнэнчээр биелүүлэхтэй энэ хамаатай гэж та

нарын зарим нь хэлсэн; энэ бол Бурханд захирагдаж, Түүнийг сэтгэл хангалуун байлгах тухай гэж зарим нь хэлсэн; Бурханы зохион байгуулалтад захирагдах нь нөлөөлөх хүчин зүйл болно гэж зарим хүн хэлсэн; хамгийн гол нь даруухан байх гэж зарим хүн хэлсэн… Та нар эдгээр үнэнийг хэрэгжүүлж, өөрсдийн зөв гэж итгэдэг зарчмын дагуу хэрэгжүүлэхдээ Бурхан юу бодож байгааг мэддэг үү? Энэ чигээрээ яваад л байх нь Түүний хүслийг хангаж байна уу, үгүй юу гэдгийг та нар эргэцүүлж үзсэн үү? Энэ нь Түүний стандартад нийцдэг үү? Түүний шаардлагыг хангаж байна уу? Ихэнх хүн үнэндээ энэ асуултыг нэг их эргэцүүлж боддоггүй гэж Би бодож байна. Тэд Бурханы үгийн хэсэг, номлолын хэсэг, эсвэл өөрсдийн шүтэн бишрдэг тодорхой сүнслэг хүмүүсийн стандартыг зүгээр л бодох юмгүйгээр хэрэглэж, энэ тэрийг хийх гэж өөрсдийгөө хүчилдэг. Ингэж хийх нь зөв гэж тэд итгэдэг учраас эцсийн дүнд юу болох нь хамаагүй, үүнийгээ баримталсаар, хийсээр байдаг. Зарим хүн “Би маш олон жил итгэсэн; би үргэлж ийм байдлаар хэрэгжүүлсэн. Бурханыг үнэхээр сэтгэл хангалуун байлгасан, мөн би үүнээс их зүйл олж авсан гэж надад санагдаж байна. Учир нь энэ хугацаанд би олон үнэнээс гадна өмнө нь ойлгож байгаагүй олон зүйлийг ойлгож авсан. Тухайлбал миний олон үзэл санаа, үзэл бодол өөрчлөгдсөн, миний амьдралын үнэт зүйл маш их өөрчлөгдсөн, одоо би энэ хорвоогийн талаар нэлээд сайн ойлголттой болсон” гэж боддог. Тийм хүмүүс, энэ бол үр өгөөж, энэ бол хүн төрөлхтний төлөө хийсэн Бурханы ажлын эцсийн үр дүн гэж итгэдэг. Та нарын бодлоор бол эдгээр стандарт болон та нарын бүх хэрэгжүүлэлтийг хамтад нь авч үзвэл та нар Бурханы хүслийг хангаж байна уу? Та нарын зарим нь тун итгэлтэйгээр “Мэдээж! Бид Бурханы үгийн дагуу хэрэгжүүлж байна; бид Дээрхийн номлож, ярилцсан зүйлийн дагуу хэрэгжүүлж байна. Бид үргэлж үүргээ биелүүлж, Бурханыг үргэлж дагаж байна, бид Түүнийг хэзээ ч орхиогүй. Тиймээс бид Бурханыг сэтгэл хангалуун байлгаж байна гэдгээ бүрэн итгэлтэйгээр хэлж чадна. Бид Бурханы санаа зорилгыг хэр зэрэг ойлгож, Бурханы үгийг хэр зэрэг ухаарч ойлгох нь хамаагүй, бид Бурхантай нийцтэй байхыг эрж хайх зам дээр үргэлж байж ирсэн. Бид зөв үйлдэж, зөв хэрэгжүүлж байгаа цагт зөв үр дүнд хүрэх нь дамжиггүй” гэж хэлнэ. Та нар энэ үзэл бодлын талаар юу гэж бодож байна? Энэ зөв үү? “Би эдгээр зүйлийн талаар өмнө нь хэзээ ч бодож байгаагүй юм байна. Би үүргээ биелүүлж, Бурханы айлдварын шаардлагын дагуу үйлдсээр байвал амьд үлдэж чадна гэж л боддог. Би Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгаж чадах эсэх, Түүний тавьсан стандартад би нийцэж байгаа эсэх тухай асуултыг хэзээ ч бодож үзээгүй. Бурхан надад хэзээ ч ямар нэг тодорхой заавар хэлж өгөөгүй хойно, намайг зогсохгүй ажилласаар байгаа цагт Бурхан сэтгэл ханаж, надад ямар нэгэн нэмэлт шаардлага тавих ёсгүй гэдэгт би итгэдэг” гэж хэлэх хүмүүс бас байж магадгүй. Ийм итгэл нь зөв үү? Миний хувьд бол, ийм маягийн хэрэгжүүлэлт, ийм бодол, эдгээр үзэл бодол нь бүгд хий мөрөөдлөөс гадна бага зэргийн харалган байдал юм. Намайг ингэж хэлэхэд та нарын зарим нь бага зэрэг урам хугарч: “Харалган байдал аа? Хэрвээ энэ харалган байдал юм бол бидний

аврагдах, амьд үлдэх найдвар маш бага, тодорхойгүй юм байна, тийм үү? Ингэж хэлснээрээ Та бидэн дээр хүйтэн ус асгаж байгаа хэрэг бус уу?” гэж бодож магадгүй. Та нар юу гэж итгэх нь хамаагүй, Миний хэлдэг, хийдэг зүйлс та нар дээр хүйтэн ус асгаж байгаа мэт санагдуулах гээгүй юм. Харин ч Бурханы санаа зорилгын талаарх ойлголтыг чинь сайжруулж, Тэр юу бодож байгаа, юу биелүүлэхийг хүсдэг, ямар хүнийг таалдаг, юуг жигшдэг, юуг үзэн яддаг, ямар төрлийн хүнийг олж авахыг хүсдэг, ямар төрлийн хүнийг зэвүүцэн голдог талаарх та нарын ойлголтыг нэмэгдүүлэх гэсэн юм. Тэдгээр нь та нарын оюун санааг саруул болгож, та нарын нэг бүрийн чинь үйлдэл, бодол Бурханы шаардсан стандартаас чухам хэр хол хадуурсан талаар тодорхой ойлголт өгөхийн тулд юм. Эдгээр сэдвийг хэлэлцэх тун шаардлагатай юу? Учир нь та нар маш урт удаан хугацаанд итгэж, маш их номлол сонссон боловч эдгээр нь та нарт хамгийн их дутагдаж байгаа яг тэр зүйлс гэдгийг Би мэднэ. Та нар бүх үнэнийг дэвтэртээ тэмдэглэж, өөрөө чухал гэж итгэдэг зарим зүйлээ зүрх сэтгэлдээ цээжилж, тогтоосон хэдий ч, мөн хэрэгжүүлэлтийнхээ үеэр Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд эдгээрийг ашиглаж, хэрэгтэй үедээ үүнийгээ ашиглаж, өмнө чинь байгаа хүнд хэцүү цаг үеийг туулахын тулд үүнийгээ ашиглаж, эсвэл амьдрах хугацаандаа эдгээр зүйлийг өөрийнхөө араас зүгээр л дагуулахаар төлөвлөдөг хэдий ч, Миний хувьд бол, яаж хийх чинь хамаагүй, та нар үүнийг хийж л байгаа бол энэ нь тийм ч чухал биш. Тэгвэл юу маш чухал юм бэ? Хэрэгжүүлж байхдаа хийж байгаа бүхэн чинь, үйл хэрэг бүр чинь Бурханы хүсэлтэй нийцэж байгаа эсэх, чиний бүх үйлдэл, бүх бодол, хүрэхийг хүсдэг үр дүн, зорилго чинь Бурханы хүсэлд нийцэж, Түүний шаардлагыг хангаж байгаа эсэх, мөн Бурхан тэдгээрийг сайшааж байгаа эсэхийг чи сэтгэлийнхээ гүнд үнэхээр баттай мэдэж байх ёстой. Эдгээр нь маш чухал зүйл юм.

Бурханы замаар алх: Бурханаас эмээж, муугаас зайл

Та нарын тэмдэглэж авах ёстой хэллэг байдаг. Энэхүү хэллэг нь маш чухал гэж Би итгэдэг, учир нь Миний хувьд энэ үг өдөр бүр тоо томшгүй олон удаа санаанд орж ирдэг. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, Би хэн нэгэнтэй нүүр тулах бүрд, хэн нэгний түүхийг сонсох бүрд, хэн нэгний Бурханд итгэсэн тухай туршлага, гэрчлэлийг сонсох бүрдээ энэ хүн Бурханы хүсдэг, Бурханд таалагддаг төрлийн хүн мөн үү, биш үү гэдгийг зүрх сэтгэлдээ тодорхойлохын тулд энэ хэллэгийг үргэлж ашигладаг. Тэгэхээр энэ юу гэсэн хэллэг вэ? Одоо Би та бүгдийг суудал дээр чинь өндөлзүүлж байна. Намайг энэ хэллэгийг хэлэх үед та нарын урам хугарч магадгүй, учир нь олон жилийн турш үүнийг ярихаас цаашгүй байж ирсэн хүмүүс бий. Гэхдээ Би нэг ч удаа үүнийг ярихаас цаашгүй байгаагүй. Энэ хэллэг Миний зүрх сэтгэлд оршдог. Тэгэхээр энэхүү хэллэг нь юу вэ? Энэ нь: “Бурханы замаар алх: Бурханаас эмээж, муугаас зайл” юм. Энэ хэтэрхий энгийн хэллэг бус уу? Гэхдээ энэхүү хэллэг нь хэдий энгийн ч гэсэн энэхүү үгийн талаарх жинхэнэ гүнзгий ойлголттой хүмүүс

энэ нь асар их жинтэй, энэхүү хэллэг нь хэрэгжүүлэлтэд маш үнэ цэнтэй, үнэн-бодит байдлыг агуулсан амийн хэлний нэг мөр, Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эрж хайдаг хүмүүсийн хувьд насан туршийнх нь зорилго, Бурханы санаа зорилгыг анхаардаг хэн хүний дагах ёстой насан туршийн зам гэдгийг мэдэрнэ. Тэгэхээр та нар юу гэж бодож байна: Энэхүү хэллэг үнэн бус уу? Энэ нь ийм чухал юу, үгүй юү? Мөн магадгүй та нарын зарим нь энэ хэллэгийн талаар бодоод учрыг нь олохоор оролдож байхад: Энэ хэллэг маш чухал уу? Тун чухал уу? Үүнийг тийм их онцлох шаардлагатай юу? гээд эргэлздэг зарим хүн ч байх. Та нарын зарим нь бас энэ хэллэгт тийм ч их дуртай биш байх, учир нь Бурханы замыг аваад, энэ нэг хэллэгт багтаах нь хэтэрхий хялбарчилсан хэрэг гэж та нар боддог. Бурханы хэлсэн бүхнийг авч, ганц хэллэг болгон багасгах нь Бурханыг арай дэндүү өчүүхэн болгож байгаа бус уу? Тийм биш гэж үү? Эдгээр үгийн цаадах гүн гүнзгий утга учрыг та нарын ихэнх нь бүрэн ойлгохгүй байж болох юм. Та нар бүгд үүнийг тэмдэглэж авсан ч гэсэн энэ хэллэгийг зүрх сэтгэлдээ хадгалах санаагүй байгаа; та нар завтай цагтаа дахин харж, эргэцүүлэн бодохын тулд үүнийг зүгээр л тэмдэглэлийн дэвтэртээ бичиж авсан. Та нарын зарим нь энэ хэллэгийг сайн ашиглах гэж хичээх нь байтугай цээжилье гэж оролдох ч үгүй. Гэвч Би яагаад энэхүү хэллэгийг дурдахыг хүсдэг вэ? Та нарын харах өнцгөөс үл хамааран, та нар юу ч гэж боддог байсан, энэ хэллэгийг Би дурдах ёстой байсан, учир нь Бурхан хүмүүсийн төгсгөлийг хэрхэн тодорхойлдогтой энэ туйлын их хамаатай. Энэ хэллэгийн талаарх одоогийн ойлголт чинь ямар байх, эсвэл та нар үүнд хэрхэн хандах нь хамаагүй, Би та нарт үүнийг хэлнэ: Хэрвээ хүмүүс энэ хэллэгийг хэрэгжүүлж, туулан, Бурханаас эмээж, муугаас зайлах стандартад хүрч чадвал амьд үлдэх нь гарцаагүй бөгөөд сайн төгсгөлтэй байх нь лавтай. Гэвч хэрвээ чи энэ хэллэгийн тавьсан стандартад хүрч чадахгүй бол төгсгөл чинь тодорхойгүй гэж хэлж болно. Тиймээс Би сэтгэл зүйг чинь бэлдэх гэж энэ хэллэгийн тухай та нарт хэлж байна, ингэснээр та нарыг хэмжихдээ Бурхан ямар стандарт ашигладгийг та нар мэдэх болно. Миний дөнгөж сая хэлсэнчлэн энэхүү хэллэг нь Бурхан хүн төрөлхтнийг аврах болон хүний төгсгөлийг Тэр хэрхэн тодорхойлдогтой туйлын их хамаатай. Энэ нь ямар байдлаар хамаатай вэ? Та нар үнэхээр мэдэхийг хүсэх учраас бид өнөөдөр энэ тухай ярилцана.

Хүмүүс Бурханаас эмээж, муугаас зайлж байгаа эсэхийг туршихын тулд Бурхан янзын бүрийн шалгалт ашигладаг

Өөрийнхөө ажлын эрин үе болгонд Бурхан хүмүүст зарим үгийг хайрлаж, зарим үнэнийг хэлдэг. Эдгээр үнэн нь хүмүүсийн баримтлах ёстой зам, тэдний алхах ёстой зам, тэднийг Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаг болгох зам, амьдралдаа болон амьдралынхаа явцад хүмүүсийн хэрэгжүүлж, баримталбал зохих зам болдог. Ийм шалтгааны улмаас Бурхан эдгээр айлдварыг хүн төрөлхтөнд илэрхийлдэг. Бурханаас ирдэг эдгээр үгийг хүмүүс баримтлах ёстой бөгөөд тэдгээрийг баримтлах нь

амь хүртэхийн тулд юм. Хэрвээ хүн тэдгээрийг баримталдаггүй, хэрэгжүүлдэггүй, Бурханы үгийг амьдралдаа амьдран харуулдаггүй бол энэ хүн үнэнийг хэрэгжүүлдэггүй юм байна. Түүнчлэн хэрвээ хүмүүс үнэнийг хэрэгжүүлэхгүй бол Бурханаас эмээж, муугаас зайлахгүй байна, мөн Бурханыг сэтгэл хангалуун байлгаж ч чадахгүй. Бурханыг сэтгэл хангалуун байлгах чадваргүй хүмүүс Бурханы сайшаалыг хүртэж чадахгүй, ийм хүмүүст төгсгөл байхгүй. Тэгвэл Бурхан Өөрийнхөө ажлын явцад хүний төгсгөлийг хэрхэн тодорхойлдог вэ? Хүний төгсгөлийг тодорхойлохын тулд Бурхан ямар арга хэрэглэдэг вэ? Одоогоор та нар энэ талаар сайн мэдэхгүй хэвээр байж магадгүй ч Би та нарт процессыг нь хэлэх үед нэлээд тодорхой болно, яагаад гэвэл, та нараас олонх нь үүнийг аль хэдийн өөрсдөө туулсан.

Өөрийн ажлын явцад, эхнээсээ л Бурхан хүн бүхэнд, өөрөөр хэлбэл Өөрийг нь дагадаг хүн бүхэнд зориулж шалгалт тавьсан бөгөөд энэхүү шалгалт нь янз бүрийн хэмжээтэй байдаг. Гэрийнхэндээ гологдох шалгалт, хатуу ширүүн орчны шалгалт, баривчлагдаж, тамлагдах шалгалт, сонголттой тулгарах шалгалт, мөн мөнгө, байр суурийн шалгалт туулсан хүмүүс байдаг. Ерөнхийд нь хэлбэл, та нар дор бүрнээ бүх төрлийн шалгалттай тулгарсан. Бурхан яагаад ингэж ажилладаг вэ? Тэр яагаад хүн бүхэнд ингэж ханддаг вэ? Тэр ямар үр дүн харахаар эрж хайдаг вэ? Миний та нарт хэлэхийг хүсдэг санаа энэ байна: Энэ хүн Бурханаас эмээж, муугаас зайлдаг төрлийн хүн мөн эсэхийг Бурхан харахыг хүсдэг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, Бурхан чамайг шалгаж, чамайг энэ тэр зарим нэг нөхцөл байдалтай тулгараад Өөрөөс нь эмээж, муугаас зайлдаг хүн мөн үү, биш үү гэдгийг турших санаатай байдаг. Хэрвээ хэн нэгэнд тахил хамгаалах үүрэг тулгарч, энэхүү үүргийнхээ улмаас Бурханы тахилд хүрсэн бол энэ нь Бурханы зохицуулсан зүйл гэж чи хэлэх байсан уу? Эргэлзээгүй тийм! Чамд тулгардаг бүхэн Бурханы зохицуулсан зүйл байдаг. Ийм асуудалтай тулгарах үед Бурхан чамайг нууцаар ажиглаж, ямар сонголт хийх, хэрхэн хэрэгжүүлэх, ямар бодолтой байгааг чинь харах болно. Бурхан эцсийн үр дүнг хамгаас их анхаардаг, учир нь яг тухайн шалгалтад Түүний стандартад хүрсэн эсэхийг чинь хэмжихэд энэхүү үр дүн Түүнд тусална. Гэхдээ хүмүүс асуудалтай тулгарах болгондоо яагаад үүнтэй тулгарч байгаа, ямар стандартад нийцэхийг Бурхан тэднээс шаарддаг, Тэр тэднээс юу харахыг хүсдэг, юу олж авахыг хүсдэг талаар тэд ихэнхдээ боддоггүй. Энэ асуудалтай тулгарах үедээ ийм хүмүүс ердөө л “Энэ надад тулгарсан зүйл; би болгоомжгүй биш, болгоомжтой байх ёстой! Ямар ч байсан энэ бол Бурханы тахил бөгөөд би үүнд хүрч болохгүй” гэж боддог. Ийм энгийн бодолтой хүмүүс үүргээ биелүүлсэн гэж итгэдэг. Энэ шалгалтын үр дүнд Бурхан сэтгэл хангалуун байх уу, үгүй юу? Энэ талаар ярилцаарай. (Хэрвээ хүмүүс зүрх сэтгэлдээ Бурханаас эмээдэг бол Бурханы тахилд хүрэх боломж олгох үүрэгтэй тулгарах үедээ Бурханы зан чанарт халдах нь хэчнээн амархан байх талаар бодож үзэх бөгөөд энэ нь тэднийг гарцаагүй болгоомжтой ханддаг болгоно.) Хариулт чинь дөхөж байна, гэхдээ хараахан болоогүй байна. Бурханы замаар алхах нь гаднаа дүрэм журам мөрдөх явдал биш; харин ч чамд асуудал тулгарах

үед чи үүнийг Бурханы зохицуулсан нөхцөл байдал, Түүнээс чамд хайрласан хариуцлага, эсвэл Түүний чамд даалгасан даалгавар гэж юуны түрүүнд үзнэ гэсэн үг юм. Энэ асуудалтай тулгарах үедээ чи үүнийг бүр Бурханы чамд тавьсан шалгалт ч гэж үзэх ёстой. Энэ асуудалтай тулгарах үед чи зүрх сэтгэлдээ стандарттай болж, энэ хэрэг явдал Бурханаас ирсэн гэж бодох ёстой. Чи Бурханд үнэнч байхын зэрэгцээ үүргээ биелүүлж чадахуйц байдлаар үүнийг хэрхэн шийдэх талаар, мөн Түүнийг хилэгнүүлж, Түүний зан чанарт халдалгүйгээр хэрхэн үүнийг хийх талаар бодох ёстой. Тахилыг хамгаалах талаар бид дөнгөж сая ярилаа. Энэ хэрэг явдал тахилтай хамаатай, бас чиний үүрэг, хариуцлагыг хөнддөг. Чи энэхүү хариуцлагыг хүлээх үүрэгтэй. Гэхдээ энэ асуудалтай тулгарсан үед ямар нэгэн уруу таталт байдаг уу? Байдаг. Энэ уруу таталт хаанаас гардаг вэ? Энэхүү уруу таталт Сатанаас гардаг, мөн энэ нь хүний ёрын муу, завхарсан зан чанараас гардаг. Уруу таталт байдаг болохоор энэ асуудал нь хүмүүсийн хийх учиртай гэрчлэлд зогсох явдлыг хамардаг бөгөөд энэ нь мөн чиний үүрэг, хариуцлага юм. Зарим хүн “Энэ бол маш жижиг асуудал; үүнийг ийм сүртэй юм болгох үнэхээр хэрэгтэй гэж үү?” гэдэг. Үнэхээр их хэрэгтэй! Учир нь, Бурханы замаар явахын тулд бид өөрсдөд маань, эсвэл бидний эргэн тойронд болж байгаа юуг ч, бүр өчүүхэн зүйлсийг ч зүгээр орхиж болохгүй; бид үүнд анхаарал хандуулах ёстой юу, үгүй юу гэж боддог ч байсан бай, ямар нэгэн асуудал тулгарсан л бол бид үүнийг зүгээр орхиж болохгүй. Болж буй бүхнийг Бурханы бидэнд өгсөн туршилт гэж харах ёстой. Юмыг ингэж харах талаар чи юу гэж бодож байна? Хэрвээ чи ийм хандлагатай бол энэ нь: Чи сэтгэлийнхээ гүнд Бурханаас эмээдэг бөгөөд муугаас зайлахад бэлэн гэсэн нэг баримтыг баталдаг. Хэрвээ чамд Бурханыг сэтгэл хангалуун байлгах энэ хүсэл байгаа бол чиний хэрэгжүүлж байгаа зүйл Бурханаас эмээж, муугаас зайлах стандартаас тийм ч холгүй байна.

Хүмүүсийн нэг их анхаардаггүй, ер нь дурддаггүй асуудлууд нь үнэнийг хэрэгжүүлэхтэй ямар ч хамаагүй, ялихгүй аар саар зүйл гэж итгэдэг хүмүүс нэлээд их байдаг. Тийм асуудал тулгарахад энэ хүмүүс үүнийг нэг их бодож үзэлгүй, тэгээд зүгээр өнгөрөөдөг. Гэвч үнэндээ энэ асуудал нь чиний сурах ёстой сургамж, Бурханаас хэрхэн эмээж, муугаас хэрхэн зайлах тухай сургамж байсан юм. Түүнчлэн, чиний бүр ч илүү санаа зовних хэрэгтэй зүйл бол энэ асуудал чамд тулгарахаар гарч ирэх үед Бурхан юу хийж байгааг мэдэх явдал билээ. Бурхан яг хажууд чинь үг, үйлдэл бүрийг чинь ажиглаж, хийж буй юм болгоныг чинь, бодол санаанд чинь ямар өөрчлөлт гарч байгааг хардаг—энэ бол Бурханы ажил. Зарим хүн “Энэ хэрвээ үнэн юм бол би яагаад үүнийг мэдрээгүй юм бэ?” гэж асуудаг. Бурханаас эмээж, муугаас зайлах замыг чи гол замаа болгож баримтлаагүй учраас үүнийг мэдрээгүй; тиймээс, хүмүүст хийдэг Бурханы нарийн ажлыг, хүмүүсийн янз бүрийн бодол, үйлдлийн дагуу өөрөө илэрдэг тэр ажлыг чи мэдэрч чаддаггүй. Чи хөнгөн хийсвэр юм! Томоохон асуудал нь юу вэ? Жижиг асуудал нь юу вэ? Бурханы замаар алхахтай хамаатай асуудлуудыг том, жижиг гэж хуваадаггүй, бүгдээрээ л

том асуудал—та нар үүнийг хүлээн зөвшөөрч чадах уу? (Бид үүнийг хүлээн зөвшөөрч чадна.) Өдөр тутмын асуудлуудын тухайд, хүмүүсийн маш том, ач холбогдолтой гэж үздэг зарим асуудал, ялихгүй аар саар зүйл гэж үздэг өөр хэсэг асуудал байдаг. Хүмүүс эдгээр том асуудлыг маш чухал гэж үздэг бөгөөд тэдгээрийг Бурхан илгээсэн гэж тооцдог. Гэвч энэ том асуудлуудыг шийдвэрлэх явцад дутуу дулимаг биеийн хэмжээ, дорд муу хэв чанарынхаа улмаас хүмүүс Бурханы хүслийг дандаа биелүүлж, ямар ч илчлэл олж авч, үнэ цэнтэй ямар ч бодит мэдлэг эзэмшиж чаддаггүй. Жижиг асуудлуудын тухайд гэвэл, тэдгээрийг хүмүүс зүгээр л анзаарахгүй үлдээж, бага багаар алга болгодог. Тиймээс Бурханы өмнө шинжлүүлэх, Түүгээр туршигдах олон боломжийг хүмүүс алдсан. Бурханы чамд зориулж зохицуулсан хүмүүс, үйл явдал, юмс, нөхцөлүүдийг чи үргэлж анзаардаггүй бол юу гэсэн үг вэ? Энэ нь өдөр бүр, цаашлаад мөч бүрд Бурхан чамайг төгс болгохоос, мөн Бурханы манлайллаас чи байнга татгалзаж байна гэсэн үг юм. Бурхан чамд зориулан нөхцөл байдал зохицуулах бүрдээ нууцаар харж, зүрх сэтгэлийг чинь харж, бодол, эргэцүүллийг чинь ажиглаж, хэрхэн бодож байгааг чинь харж, хэрхэн үйлдэхийг чинь харахаар хүлээж байгаа. Хэрвээ чи хайхрамжгүй хүн бол—Бурханы зам, Түүний үг, эсвэл үнэнд хэзээ ч нухацтай хандаж байгаагүй хүн бол—Бурхан чамд зориулан тодорхой орчин зохицуулахдаа Тэр ямар шаардлагад нийцэхийг чамаас шаарддаг, Тэр юу гүйцэлдүүлэхийг хүсэж байгааг чи хайхарч, анхаарал хандуулахгүй. Чамд тохиосон хүмүүс, үйл явдал, юмс нь үнэн, эсвэл Бурханы хүсэлтэй ямар холбоотойг чи бас мэдэхгүй. Иймэрхүү олон удаагийн нөхцөл байдал болон шалгалттай тулгарсны дараа Бурхан чамаас ямар ч үр дүн олж харахгүй бол Тэр яах вэ? Чи шалгалттай удаа дараа нүүр тулсны дараа зүрх сэтгэлдээ Бурханыг өсгөөгүй, бас чамд зориулан Бурханы зохицуулсан нөхцөл байдлыг ч байгаагаар нь, Бурханы шалгалт, туршилт гэж хараагүй. Харин ч Бурханы чамд хайрласан боломжуудаас ээлж дараалан татгалзаж, тэдгээрийг ахин дахин алдсан. Энэ бол хүмүүсийн харуулдаг туйлын дуулгаваргүй байдал бус уу? (Мөн.) Үүнээс болж Бурхан гомдох уу? (Тэгнэ.) Буруу, Бурхан гомдохгүй! Миний ингэж хэлэхийг сонсоод та нар дахин нэг удаа цочирдлоо. “Бурханд үргэлж гомдолтой санагддаг гэж өмнө нь хэлээгүй бил үү? Тиймээс Бурхан гомдохгүй гэж үү? Тэгвэл Бурханд хэзээ гомдолтой санагддаг вэ?” гэж та нар бодож байж магадгүй. Товчхондоо Бурхан энэ нөхцөлд гомдохгүй. Тэгвэл дээр дурдсан зан авирт хандах Бурханы хандлага юу вэ? Хүмүүс Бурханы илгээдэг шалгалт, туршилтыг голж, тэдгээрээс зайлсхийх үед ийм хүмүүст хандах цорын ганц хандлага Бурханд байдаг. Энэ ямар хандлага вэ? Бурхан ийм хүмүүсийг зүрх сэтгэлийнхээ гүнээс зэвүүцэн голдог. “Зэвүүцэн голох” гэдэг үгэнд давхар утга бий. Би үүнийг Өөрийнхөө өнцгөөс хэрхэн тайлбарлах хэрэгтэй вэ? Гүн утгаараа “зэвүүцэн голох” гэдэг үг нь жигших, үзэн ядах гэсэн утгатай байдаг. Нөгөө нэг утга нь юу вэ? Тэр нь ямар нэг зүйлээс татгалзах гэсэн санааг агуулдаг хэсэг юм. “Татгалзах” гэдэг нь юу гэсэн үг болохыг та нар бүгд мэднэ, тийм үү? Товчоор

хэлбэл, “зэвүүцэн голох” гэдэг нь иймэрхүү байдлаар авирлаж байгаа тэр хүмүүст хандах Бурханы эцсийн хандлага, хариу үйлдлийг илэрхийлдэг үг юм; энэ бол тэдэнд хандах туйлын үзэн ядалт, зэвүүцэл, улмаар энэ нь тэднийг орхих шийдвэрт хүргэдэг. Энэ бол Бурханы замаар хэзээ ч алхаагүй, хэзээ ч Бурханаас эмээж, муугаас зайлаагүй хүнд чиглэсэн Бурханы эцсийн шийдвэр билээ. Миний өмнө нь дурдсан энэхүү хэллэгийн чухал ач холбогдлыг та нар одоо бүгд харж чадаж байна уу?

Хүний төгсгөлийг тодорхойлохын тулд Бурханы хэрэглэдэг аргуудыг одоо та нар ойлгож байна уу? (Тэр өдөр бүр өөр өөр нөхцөл байдлыг зохицуулдаг.) Тэр өөр өөр нөхцөл байдлыг зохицуулдаг—энэ нь хүмүүсийн мэдэрч, хүрч чаддаг зүйл юм. Тэгвэл үүнийг хийх Бурханы сэдэл юу вэ? Тэр хүн нэг бүрд өөр өөр арга замаар, өөр өөр цагт, өөр өөр газарт шалгалт өгөх санаа зорилготой байдаг. Шалгалтын үеэр хүний ямар талуудыг туршдаг вэ? Өөрт тулгардаг, сонсож, харж, биечлэн туулдаг асуудал бүрдээ чи Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүн мөн үү, биш үү гэдгийг чинь шалгалт тодорхойлдог. Хүн бүхэн ийм шалгалттай тулгарна, учир нь Бурхан бүх хүнд шударга ханддаг. Та нарын зарим нь “Би Бурханд олон жилийн турш итгэсэн; тэгэхээр би яагаад ямар ч шалгалттай тулгараагүй юм бол?” гэж хэлдэг. Бурхан чамд зориулан нөхцөл байдлыг зохицуулах болгонд чи тэдгээрийг нухацтайгаар авч үзээгүй, Бурханы замаар алхахыг хүсээгүй учраас чамд шалгалт тулгараагүй гэж санагддаг. Иймээс чи зүгээр л Бурханы шалгалтыг огт мэдэрдэггүй. Зарим хүн “Би цөөн хэдэн шалгалттай тулгарч байсан боловч хэрхэн зүй зохистой хэрэгжүүлэхээ мэдэхгүй. Хэрэгжүүлсэн үедээ ч гэсэн Бурханы шалгалтын үеэр бат зогссон эсэхээ мэдэхгүй л байна” гэдэг. Ийм байдалтай хүмүүс гарцаагүй цөөнх биш. Тэгвэл хүмүүсийг хэмждэг Бурханы стандарт юу вэ? Хэдхэн хормын өмнө яг л Миний хэлсэнчлэн: Чи хийж, бодож, илэрхийлж байгаа юм бүхэндээ Бурханаас эмээж, муугаас зайлж байна уу, үгүй юу гэдэг чинь юм. Чамайг Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүн мөн үү, биш үү гэдгийг ингэж тодорхойлдог. Энэ ухагдахуун энгийн байна уу? Үүнийг хэлэхэд бишгүй амархан, харин хэрэгжүүлэхэд амархан уу? (Тийм ч амархан биш.) Яагаад тийм ч амархан биш вэ? (Яагаад гэвэл, хүмүүс Бурханыг мэддэггүй, Бурхан хүмүүсийг хэрхэн төгс болгодгийг мэддэггүй учраас асуудалтай тулгарах үедээ тэд асуудлаа шийдвэрлэхийн тулд үнэнийг хэрхэн эрж хайхаа мэддэггүй. Тэд Бурханаас эмээх бодит байдалтай болж чадахаасаа өмнө янз бүрийн шалгалт, цэвэршүүлэлт, гэсгээлт, шүүлтийг туулах ёстой.) Та нар ингэж хэлж болох ч та нарын хувьд Бурханаас эмээж, муугаас зайлах нь яг одоо амархан хийж болохуйц санагддаг. Яагаад Би ингэж хэлж байна вэ? Яагаад гэвэл, та нар маш их номлол сонсож, үнэн-бодит байдлаас багагүй хэмжээний усалгаа хүлээн авсан; энэ нь Бурханаас эмээж, муугаас зайлах талаар онолын болон оюун санааны хувьд ойлгох боломжийг та нарт олгосон. Бурханаас эмээж, муугаас зайлахыг хэрхэн бодитоор хэрэгжүүлэх тухайд бол энэ мэдлэг бүгд тун тустай байсан бөгөөд тийм зүйлийг амархан биелүүлж болмоор юм шиг та нарт

санагдуулдаг. Тэгвэл хүмүүс яагаад үүнийг бодитоор биелүүлж чаддаггүй вэ? Яагаад гэвэл, хүмүүсийн уг чанар-мөн чанар нь Бурханаас эмээдэггүй бөгөөд мууд дуртай байдаг. Жинхэнэ шалтгаан нь энэ юм.

Бурханаас эмээхгүй, муугаас зайлахгүй байх нь Бурханыг эсэргүүцэж байгаа хэрэг

“Бурханаас эмээж, муугаас зайлах” гэсэн энэ хэллэг хаанаас үүссэнийг Би та нараас асууж эхэлмээр байна. (Иовын ном.) Бид Иовыг дурдсан болохоор түүний талаар хэлэлцье. Иовын цаг үед Бурхан хүн төрөлхтнийг байлдан дагуулж, аврахын төлөө ажиллаж байсан уу? Үгүй. Тийм биз дээ? Иовын хувьд бол, тухайн үед тэр Бурханы талаар хэр их мэдлэгтэй байсан бэ? (Тийм ч их биш.) Иов Бурханы талаар яг одоо та нарын мэддэгээс ихийг мэддэг байсан уу, багыг мэддэг байсан уу? Та нар яагаад хариулж зүрхлэхгүй байна вэ? Энэ бол хариулахад маш хялбар асуулт. Бага! Мэдээжийн хэрэг! Та нар одоо Бурхантай, Бурханы үгтэй нүүр тулсан байдаг; Бурханы талаарх та нарын мэдлэг Иовынхоос хавьгүй илүү. Би яагаад үүнийг сөхөж байна вэ? Ингэж хэлсний минь зорилго юу вэ? Би та нарт нэгэн баримтыг тайлбарлахыг хүсэж байна, гэхдээ тэгэхээсээ өмнө та нараас нэг асуулт асуумаар байна: Иов Бурханы тухай маш бага мэддэг байсан ч Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаг байсан; өнөөгийн хүмүүс яагаад ингэж чаддаггүй юм бэ? (Тэд гүн завхарсан байдаг.) Тэд гүн завхарсан гэдэг нь уг асуудлыг үүсгэж буй өнгөцхөн үзэгдэл боловч Би үүнийг хэзээ ч ингэж харахгүй. Та нар “гүн завхрал”, “Бурханы эсрэг тэрслэх”, “Бурханд үнэнч бус байх”, “дуулгаваргүй байдал”, “үнэнд дургүй байх” гэх мэт сургаал, нэр томьёог авч, асуудал бүрийн мөн чанарыг тайлбарлахдаа эдгээр хэлц үгийг ашигладаг. Энэ бол хэрэгжүүлэх өө сэвтэй арга юм. Өөр өөр шинж чанартай асуудлуудыг тайлбарлахдаа нэг хариулт ашиглах нь үнэн болон Бурханыг доромжилж байна гэсэн сэжгийг зайлшгүй төрүүлдэг; Би иймэрхүү хариулт сонсох дургүй. Энэ тухай нухацтай бодоод үз! Та нарын хэн нь ч энэ асуудлын талаар бодож байгаагүй боловч Би өдөр бүр үүнийг харж, мэдэрч чадна. Тиймээс та нарыг үйлдэж байхад Би харж байдаг. Ямар нэгэн зүйл хийж байхдаа та нар мөн чанарыг нь мэдэрч чаддаггүй, харин Би үүнийг харахдаа мөн чанарыг нь харж, бас мэдэрч чаддаг. Тэгэхээр энэ мөн чанар нь юу вэ? Өнөө үед хүмүүс яагаад Бурханаас эмээж, муугаас зайлах чадваргүй байдаг вэ? Та нарын хариулт энэ асуудлын мөн чанарыг тайлбарлаж огт чадахгүй, бас шийдвэрлэж ч чадахгүй. Яагаад гэвэл, та нарын мэддэггүй эх сурвалж үүнд байдаг. Энэ эх сурвалж нь юу вэ? Та нар энэ талаар сонсмоор байгааг Би мэдэж байна, иймээс Би энэ асуудлын эх сурвалжийг та нарт хэлье.

Бурхан ажил хийж эхэлснээс хойш хүнийг хэрхэн үздэг байсан бэ? Бурхан тэднийг аварсан; Тэр хүмүүсийг Өөрийн гэр бүлийн гишүүн, Өөрийн ажлын зорилго, Өөрөө байлдан дагуулж, аврахыг хүссэн хүмүүс, Өөрөө төгс болгохыг хүссэн хүмүүс гэж үзэж байсан. Өөрийн ажлын эхнээс л Бурхан хүнд ингэж хандаж байв.

Харин тэр үед хүн төрөлхтөн Бурханд ямар хандаж байсан бэ? Бурхан хүмүүсийн хувьд үл таних нэгэн байсан бөгөөд тэд Бурханыг танихгүй нэгэн шиг үзсэн. Бурханд хандах тэдний хандлага зөв үр дүнд хүрээгүй, тэд Бурханд хэрхэн хандах ёстой талаар тодорхой ойлголтгүй байсан гэж хэлж болно. Тиймээс тэд Түүнтэй хүссэнээрээ харьцаж, юу дуртайгаа хийсэн. Тэдэнд Бурханы талаар ямар нэгэн үзэл бодол байсан уу? Эхэндээ тэдэнд байгаагүй; тэдний санаа бодол, таамаглал гэгч нь Түүний тухай тодорхой нэг үзэл, таамаглалаас бүрдэх төдий байсан. Өөрсдийнх нь үзэлд нийцсэн зүйлсийг нь тэд хүлээн зөвшөөрсөн бөгөөд, ямар нэг зүйл үзэлтэй нь нийцэхгүй үед тэд өнгөн дээрээ дуулгавартай дагасан боловч зүрх сэтгэлийнхээ гүнд үүнтэй хүчтэй зөрчилдөж, эсэргүүцсэн. Эхэндээ хүн, Бурхан хоёр хоорондоо ийм харилцаатай байв: Бурхан тэдийг гэр бүлийн гишүүнээ гэж харж байхад, хүн Бурханд танихгүй нэгэн шиг хандсан. Гэхдээ Бурхан хэсэг ажилласны дараа Бурхан юунд хүрэхээр хичээж байгааг хүмүүс ойлгож авч, Бурхан бол жинхэнэ Бурхан юм гэдгийг тэд мэдсэн; тэд мөн Бурханаас юу олж авч болохыг мэдэж авсан. Энэ үед хүмүүс Бурханыг юу гэж үзсэн бэ? Тэд Түүнийг аврах татлага хэмээн харж, Түүний нигүүлсэл, ерөөл, амлалтыг хүртэх гэж найдсан. Энэ үед Бурхан хүнийг юу гэж үздэг байсан бэ? Тэр тэднийг байлдан дагуулалтынхаа бай гэж харж байсан. Бурхан үг ашиглан тэднийг шүүж, туршиж, тэднээр шалгалт туулуулахыг хүссэн. Гэхдээ тэр үеийн хүмүүсийн хувьд Бурхан бол өөрийн гэсэн зорилгодоо хүрэхэд ашиглаж болох объект л байсан. Бурханы гаргасан үнэн өөрсдийг нь байлдан дагуулж, аварч чадна, Бурханаас хүссэн зүйлээ авахаас гадна, хүссэн хүрэх газартаа хүрэх боломж тэдэнд байна гэдгийг хүмүүс харсан. Үүнээс болж тэдний зүрх сэтгэлд өчүүхэн төдий чин сэтгэл бүрэлдэж, Бурханыг дагахад бэлэн болсон. Цаг хугацаа өнгөрч тэд Бурханы талаар өнгөцхөн, хоосон онолын бага зэрэг мэдлэг олж авсан учраас Бурхан, Түүний хэлсэн үг, Түүний номлол, Түүний гаргасан үнэн, Түүний ажилтай “танил” болж эхэлсэн гэж хүртэл хэлж болно. Иймээс өөрсдөд нь Бурхан танихгүй нэгэн байхаа больж, өөрсдийгөө аль хэдийн Бурхантай нийцтэй болох замд хөл тавьсан гэж тэд эндүүрэх болсон. Одоо бол хүмүүс үнэний талаар маш их номлол сонсож, Бурханы ихээхэн ажлыг туулсан. Гэсэн ч олон янзын хүчин зүйлс, нөхцөл байдлаас үүдсэн хөндлөнгийн оролцоо, саад бартааны улмаас ихэнх хүн үнэнийг амжилттай хэрэгжүүлж чаддаггүй, бас Бурханыг сэтгэл хангалуун байлгаж ч чаддаггүй. Хүмүүс улам их хойрго болж, улам итгэлгүй болсон. Өөрсдийнх нь төгсгөл тодорхойгүй юм шиг санагдах нь улам нэмэгдсэн. Тэд хэрээс хэтэрсэн санаа гаргаж зүрхэлдэггүй, ахиц дэвшил гаргах гэж тэмүүлдэггүй; тэд зүгээр л дуртай дургүй дагаж, алхам алхмаар урагшилдаг. Хүмүүсийн өнөөгийн байдлын тухайд, тэдэнд хандах Бурханы хандлага ямар вэ? Тэр эдгээр үнэнийг тэдэнд хайрлаж, Өөрийн замыг тэдэнд суулгаж өгч, дараа нь тэднийг өөр өөр арга замаар шалгахын тулд өөр өөр орчин нөхцөл зохицуулдаг. Түүний зорилго нь эдгээр үг, эдгээр үнэн болон Өөрийн ажлыг авч, хүн Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаг болох төгсгөлийг авчрах явдал

билээ. Миний харсан ихэнх хүн Бурханы үгийг хоосон сургаал, цаасан дээрх зүгээр нэг үсэг, сахин мөрдөх журам гэж үздэг. Тэд үйлдэж, ярихдаа, эсвэл шалгалттай тулгарахдаа Бурханы замыг өөрсдийн мөрдөх ёстой зам гэж үздэггүй. Хүмүүс ялангуяа томоохон шалгалттай тулгарахад энэ үнэн байдаг; Бурханаас эмээж, муугаас зайлахаар хэрэгжүүлж байгаа ямар ч хүнийг Би хараагүй. Тиймээс хүмүүст хандах Бурханы хандлага нь туйлын их жигшил, зэвүүцлээр дүүрэн байдаг! Тэр тэднийг удаа дараа, бүр хэдэн зуун удаа шалгасан ч гэсэн, “Би Бурханаас эмээж, муугаас зайлахыг хүсэж байна!” хэмээн шийдсэнээ харуулах ямар ч тодорхой хандлага байхгүй хэвээр байдаг. Хүмүүст ийм шийдэмгий байдал нэгэнт байхгүй, ингэж харагддаггүйгээс хойш тэдэнд хандах Бурханы өнөөгийн хандлага нь, өршөөл үзүүлж, хүлээцтэй байж, хүлцэн тэвчиж, тэвчээр гаргаж байсан өнгөрсөн үеийнхтэй нь адил байхаа больсон. Харин ч Тэр хүн төрөлхтөнд туйлын их урам хугарсан. Хэнээс болж ийнхүү урам хугарсан бэ? Хүмүүст хандах Бурханы хандлага хэнээс хамаардаг вэ? Энэ нь Түүнийг дагадаг хүн нэг бүрээс хамаардаг. Олон жилийн ажлынхаа замналын явцад Бурхан хүмүүст олон шаардлага тавьж, тэдэнд зориулж олон нөхцөл байдлыг зохицуулсан. Гэхдээ хэрхэн гүйцэтгэснээс нь үл хамааран, Бурханд хандах хандлага нь ямар ч байсан, хүмүүс Бурханаас эмээж, муугаас зайлах зорилгод тодорхой нийцүүлэн хэрэгжүүлж чадаагүй. Тиймээс Би үүнийг нэг хэллэгээр дүгнэн хэлж, хүмүүс яагаад Бурханаас эмээж, муугаас зайлах Бурханы замаар алхаж чаддаггүй талаар бидний дөнгөж сая ярьсан бүхнийг тайлбарлахад энэ хэллэгийг ашиглана. Энэ ямар хэллэг вэ? Энэ бол: Бурхан хүмүүсийг Өөрийн аврах объект, Өөрийн ажиллах объект гэж үздэг; хүмүүс Бурханыг өөрийн дайсан, өөрийн эсрэгцэл гэж үздэг. Одоо чи энэ асуудлын талаар тодорхой ойлголттой болсон уу? Хүн төрөлхтний хандлага ямар болох, Бурханы хандлага ямар болох, хүн, Бурхан хоёрын хоорондын харилцаа ямар болох нь маш тодорхой байна. Та нар хэчнээн ч их номлол сонссон ч гэсэн, Бурханд үнэнч байж, Бурханд захирагдаж, Бурхантай нийцтэй байх замыг эрж хайж, бүхий л амьдралаа Бурханд зарлагадахыг, Бурханы төлөө амьдрахыг хүсэх гээд өөрийн гэсэн дүгнэлтээ гаргасан тэдгээр зүйл нь Надад бол, Бурханаас эмээж, муугаас зайлах Бурханы замаар ухамсартайгаар алхаж байгаагийн жишээ биш, харин ч тэдгээр нь тодорхой зорилгод хүрэхдээ ашиглаж болох зүгээр нэг сувгууд юм. Тэдгээрт хүрэхийн тулд та нар зарим дүрэм журмыг дурамжхан мөрддөг бөгөөд Яг энэ дүрэм журмууд л Бурханаас эмээж, муугаас зайлах замаас хүмүүсийг улам илүү холдуулж, Бурханыг дахин нэгэнтээ хүн төрөлхтний эсрэг болгодог.

Өнөөдрийн сэдэв бага зэрэг хүнд боловч ямар ч байсан хожмын туршлага, хожмын цаг хугацааг туулахдаа Миний дөнгөж сая та нарт хэлсэн зүйлийг хийж чадна гэж Би найдсаар л байна. Чамд хэрэг болсон үед Бурхан оршин байдаг, харин хэрэггүй үед Тэр оршин байдаггүй юм шиг Түүнийг хоосон агаар мэт бүү үз. Дотоод ухамсартаа ийм бодол тээмэгцээ чи Бурханыг аль хэдийн хилэгнүүлсэн байдаг. “Би Бурханыг хий хоосон агаар төдий гэж үздэггүй. Би үргэлж Түүнд

залбирч, Түүнийг сэтгэл хангалуун байлгахыг хичээдэг, миний хийдэг бүхэн Бурханы шаардсан цар хүрээ, стандарт, зарчмын дотор байдаг. Би гарцаагүй өөрийн санаа бодлын дагуу үйлдэхгүй байгаа" гэж хэлэх хүн байж магадгүй. Тийм ээ, чиний хэрэгжүүлж байгаа арга зам зөв. Гэсэн ч чи асуудалтай тулгарах үедээ юу гэж боддог вэ? Чамд асуудал тулгарах үед чи хэрхэн хэрэгжүүлдэг вэ? Зарим хүн Бурханд залбирч, Түүнээс гуйх үедээ л Бурхан оршин байгааг мэдэрдэг боловч асуудал тулгарах болгонд, өөрийн санааг гаргаж, түүнийгээ дагахыг хүсдэг. Энэ нь тэд Бурханыг ердөө л хоосон агаар гэж үздэг гэсэн үг бөгөөд ийм нөхцөл байдлын улмаас оюун санаандаа тэд Бурханыг оршин байхгүй болгодог. Хэрэгтэй үед нь Бурхан орших ёстой, харин хэрэггүй үед Тэр орших ёсгүй гэж хүмүүс итгэдэг. Өөрсдийнхөө санаанд үндэслэж хэрэгжүүлэх нь хангалттай гэж хүмүүс боддог. Тэд хүссэн болгоноо хийж болно гэж итгэдэг; Бурханы замыг эрж хайх хэрэг тэдэнд байхгүй гэж тэд гагцхүү итгэдэг. Одоо ийм нөхцөлд байгаа, ийм байдалд гацсан хүмүүсийн тухайд тэд аюул дуудаж байгаа бус уу? Зарим хүн "Аюул дуудаж байгаа, үгүйн аль нь ч бай, би маш олон жилийн туршид итгэж ирсэн, Бурхан намайг орхиж тэвчихгүй учраас намайг орхихгүй гэдэгт би итгэдэг" гэдэг. Нөгөө хэсэг нь "Би бүр эхийнхээ хэвлийд байсан цагаас Эзэнд итгэж ирсэн. Дөч, тавин жил болсон учраас цаг хугацаагаар бол би Бурханаар аврагдаж, амьд үлдэхэд хамгийн тохирно. Энэхүү дөч, тавин жилийн хугацаанд гэр бүл, ажил төрлөө орхиж, мөнгө, байр суурь, зугаа цэнгэл, гэр бүлтэйгээ байх цаг гээд өөрт байсан бүхнийг би хаясан. Би олон амттай хоол идэж, их зугаа цэнгэлийг эдлээгүй, олон сонирхолтой газраар яваагүй, энгийн хүний дааж чадахааргүй зовлонг хүртэл туулсан. Хэрвээ Бурхан энэ бүхний төлөө намайг аварч чадахгүй юм бол надад шударга бус хандаж байна, би ийм Бурханд итгэж чадахгүй" гэдэг. Ийм үзэл бодолтой хүн олон байдаг уу? (Олон байдаг.) Тэгвэл өнөөдөр Би нэг баримтыг ойлгоход чинь та нарт тусалъя: Ийм үзэл бодолтой хүмүүс бүгд өөрсдийгөө баллаж байна. Яагаад гэвэл, тэд өөрсдийнхөө төсөөллөөр нүдээ таглаж байна. Яг эдгээр төсөөлөл, мөн өөрсдийнх нь дүгнэлт нь хүмүүсээс хүрэхийг шаарддаг Бурханы стандартыг орлож, Бурханы жинхэнэ санаа зорилгыг хүлээн зөвшөөрөхөөс тэднийг хойш татдаг. Энэ нь Түүний жинхэнэ оршин тогтнолыг мэдэрч чадахгүй болгож, мөн Бурханаар төгс болгуулах боломжоо алдаж, Бурханы амлалтад оролцох аливаа оролцоогоо хаяхад хүргэдэг.

Бурхан хүмүүсийн төгсгөлийг хэрхэн тодорхойлдог болон хүмүүсийн төгсгөлийг тодорхойлдог Түүний стандарт

Чи аливаа үзэл бодол, дүгнэлт дээр тогтохоосоо өмнө чамд хандах Бурханы хандлага ямар болохыг, Тэр юу бодож байгааг ойлгох хэрэгтэй, тэгвэл чи өөрийнхөө бодлыг зөв эсэхийг шийдэж чадна. Хүний төгсгөлийг тодорхойлохдоо, Бурхан хэзээ ч цаг хугацааг, хэмжих нэгж болгож ашиглаж байгаагүй, ийнхүү тодорхойлохдоо, хүний хэр их зовлон зүдүүр амссанд нь бас хэзээ ч үндэслэж байгаагүй. Тэгвэл Бурхан хүний төгсгөлийг тодорхойлохдоо юуг стандарт болгож

ашигладаг вэ? Цаг хугацаанд үндэслэж тодорхойлох нь хүмүүсийн үзэлтэй хамгийн их нийцэх болно. Түүнчлэн, нэгэн үе үлэмж ихийг зориулж, ихийг зарлагадаж, асар том төлөөс төлж, үлэмж ихээр зовж байсныг нь та нар байнга хардаг хүмүүс байдаг. Та нарын бодлоор бол тэд Бурханы аварч болох хүмүүс юм. Энэ хүмүүсийн үзүүлж, амьдран харуулдаг бүхэн нь хүний төгсгөлийг тодорхойлох Бурханы стандартын талаарх хүмүүсийн үзэлтэй яг таг нийцдэг. Та нар юунд ч итгэдэг байсан, Би эдгээр жишээг нэг нэгээр нь нэрлэхгүй. Товчоор хэлбэл, Бурханы бодсон стандарт биш л бол хүний төсөөллөөс гардаг бөгөөд иймэрхүү бүх зүйл хүний үзэл юм. Хэрвээ чи өөрийн үзэл, хоосон төсөөлөлдөө сохроор зүтгэвэл ямар үр дагавар гарах вэ? Бурхан чамайг зэвүүцэн голох үр дагавар л байж болно гэдэг нь тун илэрхий байна. Учир нь чи Бурханы өмнө үргэлж чадвараа гайхуулж, Түүнтэй өрсөлдөж, маргалдаж байдгийн дээр Түүний бодлыг үнэхээр ухаарч ойлгох гэж хичээдэггүй, бас Түүний хүсэл болон хүн төрөлхтөнд хандах Түүний хандлагыг ухаарч ойлгох гэж ч хичээдэггүй. Ийм маягаар авирлах нь Бурханыг алдаршуулахгүй, харин өөрийгөө бүхнээс дээгүүр өргөмжилж байгаа хэрэг юм. Чи өөртөө итгэдэг; чи Бурханд итгэдэггүй. Бурхан ийм хүмүүсийг хүсдэггүй, бас тэдэнд аврал авчрах ч үгүй. Хэрвээ чи ийм үзэл бодлоо хаяж, урьд нь чамд байсан тэдгээр буруу үзэл бодлыг залруулж чадвал, чи Бурханы шаардлагын дагуу байж чадвал, энэ мөчөөс эхлэн Бурханаас эмээж, муугаас зайлах замыг хэрэгжүүлж чадвал, Бурханыг бүх зүйл дээр агуу Нэгэн хэмээн дээдэлж, өөрийгөө болон Бурханыг тодорхойлохдоо өөрийн хоосон төсөөлөл, үзэл бодол, итгэл үнэмшлийг ашиглахаас татгалзаж хүчрээд, оронд нь Бурханы санаа зорилгыг бүхий л талаар эрж хайж, хүн төрөлхтөнд хандах Түүний хандлагыг ухааран, ойлгож авч, Түүний стандартад нийцсэнээрээ Түүнийг сэтгэл хангалуун болгож чадвал—тэгвэл гайхалтай байх болно! Энэ нь чамайг Бурханаас эмээж, муугаас зайлах замд орох гэж байгааг илтгэн харуулна.

Бурхан хүмүүсийн янз бүрийн бодол, санаа, үзэл бодлыг төгсгөлийг нь тодорхойлох стандарт болгож ашигладаггүй бол, Тэр хүмүүсийн төгсгөлийг тодорхойлохдоо ямар стандарт ашигладаг вэ? Тэр төгсгөлийг нь тодорхойлохдоо шалгалт ашигладаг. Бурхан хүмүүсийн төгсгөлийг тодорхойлохдоо шалгалт ашигладаг хоёр стандарт бий: Эхнийх нь хүмүүсийн туулдаг шалгалтын тоо, хоёр дахь нь эдгээр шалгалтын хүмүүст үзүүлсэн үр дүн. Энэ хоёр үзүүлэлт нь хүний төгсгөлийг тогтоодог. Тэгвэл одоо энэ хоёр стандартыг дэлгэрэнгүй тайлбарлацгаая.

Эхлээд, хүн Бурханаас ирсэн шалгалттай тулгарах үед (энэ шалгалт нь чиний хувьд багахан, дурдахын ч хэрэггүй байж болно), Түүний гар чам дээр байгаа, энэ нөхцөл байдлыг Тэр чамд зориулж зохицуулсан гэдгийг Тэр чамд тов тодорхой мэдүүлнэ. Биеийн хэмжээ чинь дутуу дулимаг хэвээр байхад Бурхан чамайг туршихаар шалгалт зохицуулах бөгөөд эдгээр шалгалт нь чиний биеийн хэмжээ, чиний ухаарч ойлгож, тэсвэрлэж чадах зүйлд тохирсон байна. Чиний аль хэсгийг турших вэ? Бурханд хандах хандлагыг чинь. Энэ хандлага маш чухал уу? Мэдээж, чухал! Энэ бол онцгой чухал! Хүний энэ хандлага бол Бурханы хүсэж байгаа үр дүн

учраас Түүний хувьд, энэ бол бүхнээс хамгийн чухал зүйл юм. Эс бөгөөс Бурхан ийм ажил хийж, хүчин чармайлтаа хүмүүст зарцуулахгүй байх байсан. Эдгээр шалгалтын аргаар Бурхан Өөрт нь хандах чиний хандлагыг харахыг хүсдэг; чамайг зөв зам дээр байгаа эсэхийг харахыг Тэр хүсдэг. Мөн Бурханаас эмээж, муугаас зайлж байгаа эсэхийг чинь харахыг Тэр хүсдэг. Тиймээс тодорхой нэг цаг үед үнэнийг их ч ойлгосон, бага ч ойлгосон бай, чи Бурханы шалгалттай тулгарсаар байх болно, чиний ойлгосон үнэний хэмжээ ихсэхийн хэрээр Бурхан чамд таарах шалгалтуудыг үргэлжлүүлэн зохицуулсаар байх болно. Чи шалгалттай дахин нэг удаа тулгарах үед чиний үзэл бодол, бодол санаа, мөн Түүнд хандах хандлага чинь энэ хооронд ямар нэгэн өсөлт туулсан эсэхийг Бурхан харахыг хүснэ. Зарим хүн “Яагаад Бурхан дандаа хүмүүсийн хандлагыг харахыг хүсдэг юм бэ? Үнэнийг хэрхэн хэрэгжүүлж байгааг нь Тэр аль хэдийн харсан бус уу? Яагаад бас хүмүүсийн хандлагыг харах гэж?” хэмээн гайхдаг. Энэ бол утгагүй дэмий яриа! Бурхан ийм маягаар ажилладаг болохоор Түүний хүсэл тэнд байх л ёстой. Бурхан хүмүүсийг байнга хөндлөнгөөс ажиж, үг үйлдэл бүр, үйл хэрэг, хөдөлгөөн бүрийг нь ажигладаг; тэр ч бүү хэл тэдний бодол, санаа бүрийг Тэр аждаг. Бурхан хүмүүст тохиолддог бүхнийг, тэдний сайн үйлс, тэдний алдаа, гэм буруу, бүр урвалт, эсэргүүцлийг нь хүртэл тэдний төгсгөлийг тодорхойлох нотолгоо болгож тэмдэглэж авдаг. Бурханы ажил алхам алхмаар өргөгдөхийн хэрээр чи улам их үнэнийг сонсож, улам их эрэг зүйл, эерэг мэдээллийг хүлээн авдаг болж, илүү их үнэний бодит байдлыг олж авна. Энэ үйл явцын туршид чамд тавих Бурханы шаардлага ч мөн нэмэгдэж, ийнхүү нэмэгдэхийн хэрээр, Тэр чамд зориулж илүү чухал шалгалтыг зохицуулна. Энэ хугацаанд Түүнд хандах чиний хандлага сайжирсан эсэхийг ажиглах нь Түүний зорилго юм. Мэдээж, ийм зүйл болох үед Бурханы чамаас шаарддаг үзэл бодол, үнэн-бодит байдлын талаарх ойлголттой чинь нийцэх болно.

Биеийн хэмжээ чинь аажмаар өсөн нэмэгдэхэд чамаас шаарддаг Бурханы стандарт мөн адил өснө. Чамайг дутуу дулимаг байхад Тэр чамд маш доогуур стандарт тогтооно; биеийн хэмжээ чинь арай их болоход Тэр чиний стандартыг арай өндөр болгоно. Гэхдээ, бүх үнэний талаарх ойлголтыг олж авсны дараа Бурхан яах вэ? Тэр чамайг бүр ч илүү том шалгалттай тулгаруулна. Эдгээр шалгалтын дундаас Бурхан чамаас олж авахыг хүсдэг, чамаас харахыг хүсдэг зүйл бол Түүнийг илүү гүнзгий мэддэг болж, Түүнийг жинхэнээсээ хүндэтгэдэг болох явдал юм. Энэ үед, чамд тавих Түүний шаардлага нь, биеийн хэмжээ чинь дутуу дулимаг байсан үеийнхээс илүү өндөр, “илүү хатуу ширүүн” байх болно (хүмүүс тэдгээрийг хатуу ширүүн гэж үзэж магадгүй боловч Бурхан үнэндээ тэдгээрийг боломжийн гэж үздэг). Бурхан хүмүүсийг шалгахдаа ямар бодит байдлыг бүтээхийг хүсдэг вэ? Тэр хүмүүсээс зүрх сэтгэлээ Өөрт нь өгөхийг үргэлж шаардаж байна. Зарим хүн “Би яаж үүнийг өгөх юм бэ? Би үүргээ биелүүлсэн; би гэр орон, ахуй амьдралаа орхиж, өөрийгөө зарлагадсан. Эдгээр нь бүгд миний зүрх сэтгэлээ Бурханд өгөхийн жишээ бус уу? Өөрөөр би яаж зүрх сэтгэлээ Бурханд өгч болох

юм бэ? Эдгээр нь үнэндээ миний Түүнд зүрх сэтгэлээ өгөх арга зам биш байсан байж болох уу? Бурханы тодорхой шаардлага юу вэ?” гэж хэлнэ. Шаардлага нь тун энгийн. Үнэндээ, шалгалтынхаа янз бүрийн үе шатанд, зүрх сэтгэлээ Бурханд янз бүрийн хэмжээгээр аль хэдийн өгчихсөн зарим хүн байдаг боловч хүмүүсийн дийлэнх олонх нь зүрх сэтгэлээ Бурханд хэзээ ч өгдөггүй. Бурхан чамайг шалгахдаа зүрх сэтгэл чинь Түүнтэй, махан биетэй, эсвэл Сатантай байгаа эсэхийг хардаг. Бурхан чамайг шалгахдаа Түүнийг эсэргүүцэн зогсож байна уу, эсвэл Өөртэй нь нийцсэн байр сууринд байна уу гэдгийг чинь харж, зүрх сэтгэл чинь Өөрийнх нь талд байгаа эсэхийг хардаг. Чи төлөвшөөгүй байхдаа шалгалттай тулгахдаа итгэл багатай байдаг бөгөөд үнэний талаар хязгаарлагдмал ойлголттой байдаг учраас Бурханы санаа зорилгыг биелүүлэхийн тулд чухам юу хийх хэрэгтэйгээ мэдэж чадахгүй. Гэвч хэрэв чи үнэнээсээ, чин сэтгэлээсээ Бурханд залбирч чаддаг хэвээр байвал, зүрх сэтгэлээ Түүнд өгч, Түүнийг өөрийн эзэн болгож, хамгийн эрхэм дээд гэж итгэдэг зүйлсээ Түүнд өргөн барихад бэлэн байж чадвал, чи зүрх сэтгэлээ Бурханд аль хэдийн өгчихсөн байх болно. Чи илүү их номлол сонсож, үнэнийг илүү их ойлгох тусам биеийн хэмжээ чинь бас аажмаар өснө. Энэ үед Бурханы шаардлагын стандарт нь чиний дутуу дулимаг байсан үеийнхтэй адилгүй байна; Тэр чамаас илүү өндөр стандарт шаардана. Хүмүүс зүрх сэтгэлээ Бурханд аажмаар өгөхийн хэрээр зүрх сэтгэл нь Бурханд аажмаар улам ойртсоор байдаг; хүмүүс Бурханд жинхэнээсээ ойртож чадах тусам зүрх сэтгэл нь Түүнийг улам их хүндэтгэнэ. Бурхан чухам ийм л зүрх сэтгэлийг хүсдэг.

Бурхан хэн нэгний зүрх сэтгэлийг олж авахыг хүсэх үедээ тухайн хүнийг олон тооны шалгалт туулуулна. Эдгээр шалгалтын үеэр хэрвээ Бурхан тухайн хүний зүрх сэтгэлийг олж аваагүй, эсвэл энэ хүнд ямар нэг хандлага байгааг нь харвал, өөрөөр хэлбэл, энэ хүн Түүнд хүндэтгэл үзүүлсэн байдлаар хэрэгжүүлэх буюу авирлахыг нь Бурхан хараагүй, мөн энэ хүнээс Тэр муугаас зайлах хандлага, шийдэмгий байдлыг хараагүй бол, зөндөө олон шалгалтын дараа түүнд гаргасан тэвчээрээ Бурхан буцаан авч, түүнийг цаашид хүлцэхээ болино. Энэ хүнийг Тэр цаашид шалгахаа больж, түүн дээр ажиллахаа болино. Тэгэхээр энэ хүний төгсгөлийн тухайд энэ нь юуг илтгэн харуулж байна вэ? Энэ нь түүнд ямар ч төгсгөл байхгүй гэсэн үг юм. Магадгүй энэ хүн ямар ч муу зүйл хийгээгүй байж болно; магадгүй тэр ямар ч бусниулах зүйл хийж, ямар ч үймээн үүсгээгүй байж болно. Магадгүй тэр Бурханыг илт эсэргүүцээгүй байж болно. Гэвч энэ хүний зүрх сэтгэл Бурханаас далд хэвээр байна; тэр хэзээ ч Бурханд хандах тодорхой хандлага, үзэл бодолтой байгаагүй бөгөөд зүрх сэтгэлээ Өөрт нь өгч, Өөрөөс нь эмээж, муугаас зайлахаар эрж хайж байгааг нь Бурхан тодорхой харж чаддаггүй. Бурхан ийм хүмүүсийг тэвчихээ больж, тэдний төлөө ямар нэг төлөөс төлж, тэдэнд ямар нэг өршөөл үзүүлж, тэдэн дээр ажиллахаа болино. Ийм хүний Бурханд итгэх итгэлийн амьдрал аль хэдийн дууссан. Учир нь түүнд өгсөн олон шалгалтаас бүгдээс нь Бурхан Өөрийн хүссэн үр дүнг олж аваагүй. Тиймээс өөрсдөөс нь Ариун Сүнсний

гэгээрэл, гэрэлтүүлэлтийг Би хэзээ ч олж хараагүй олон хүн байдаг. Үүнийг хэрхэн харж болох вэ? Энэ хүмүүс олон жил Бурханд итгэсэн байж болно, өнгөн дээрээ маш эрч хүчтэйгээр авирлаж байсан; тэд олон ном уншиж, олон ажил хэргийг зохицуулж, арван хэдэн тэмдэглэлийн дэвтэр дүүргэж, үлэмж олон үг, хоосон сургаал эзэмшсэн. Гэвч тэдэнд ямар ч харагдахуйц өсөлт ер байгаагүй, Бурханы талаарх үзэл бодол нь үл мэдэгдэх хэвээр, хандлага нь тодорхойгүй байсаар байдаг. Өөрөөр хэлбэл, тэдний зүрх сэтгэлийг харах боломжгүй байна; тэдгээр нь үргэлж боодолтой, битүүмжлэгдсэн байдаг—Бурханаас битүүмжлэгдсэн байдаг. Ийм учраас тэдний үнэн зүрх сэтгэлийг Тэр хараагүй, энэ хүмүүсээс Өөрийг нь гэсэн жинхэнэ хүндлэлийг Тэр хараагүй, түүнээс гадна, энэ хүмүүс Өөрийнх нь замаар хэрхэн алхаж байгааг Тэр хараагүй. Хэрвээ одоог хүртэл Бурхан ийм хүмүүсийг олж аваагүй бол ирээдүйд Тэр тэднийг олж авч чадах уу? Чадахгүй! Тэр олж авч чадахгүй зүйлээ авах гэж зүтгээд л байх уу? Тэгэхгүй! Тэгвэл ийм хүмүүст хандах Бурханы одоогийн хандлага ямар вэ? (Тэр тэднийг зэвүүцэн голж, үл ойшоодог.) Тэр тэднийг үл ойшоодог! Бурхан ийм хүмүүсийг анхаарч үздэггүй; Тэр тэднийг зэвүүцэн голдог. Та нар эдгээр үгийг маш хурдан, маш үнэн зөв цээжилсэн. Та нар сонссон зүйлээ ойлгосон мэт байна!

Бурханыг дагаж эхлэхдээ дутуу дулимаг, харанхуй бүдүүлэг зарим хүн байдаг; тэд Түүний хүслийг ойлгодоггүй, бас Түүнд итгэх гэдэг юу болохыг ч мэддэггүй. Тэд хүний үүсгэсэн, андуу ташаа арга замаар Бурханд итгэж, Бурханыг дагадаг. Ийм хүмүүс шалгалттай тулгарах үедээ үүнийг мэддэггүй; Бурханы удирдамж, гэгээрэлд хөшүүн хэвээр байдаг. Бурханд зүрх сэтгэлээ өгнө гэж юу болох, шалгалтын үеэр бат зогсох гэж юу болохыг тэд мэдэхгүй. Бурхан ийм хүмүүст хязгаарлагдмал хугацаа өгөөд энэ хугацаанд Бурханы шалгалт гэж юу болох, Бурханы санаа зорилго юу болохыг ойлгуулна. Дараа нь энэ хүмүүс үзэл бодлоо харуулах ёстой. Энэ үе шатанд байгаа хүмүүсийг Бурхан хүлээсээр л байна. Зарим нэг үзэл бодолтой боловч тээнэгэлзсээр байгаа, Бурханд зүрх сэтгэлээ өгөхийг хүсдэг боловч үүнтэй эвлэрээгүй байгаа, хэдийгээр зарим энгийн үнэнийг хэрэгжүүлдэг ч томоохон шалгалт тулгарахад нуугдаж, бууж өгөхийг оролддог хүмүүсийн тухайд—тэдэнд хандах Бурханы хандлага ямар вэ? Тэр одоо ч гэсэн тэднээс жаахныг хүлээдэг бөгөөд үр дүн нь тэдний хандлага болон гүйцэтгэлээс хамаардаг. Хэрвээ хүмүүс ахиц дэвшил гаргахдаа идэвхтэй биш бол Бурхан яадаг вэ? Тэр тэднийг хаядаг. Учир нь Бурхан чамайг хаяхаас өмнө чи аль хэдийн өөрийгөө хаячихсан байдаг. Тиймээс ингэснийх нь төлөө чи Бурханыг буруутгаж болохгүй. Бурханд гомдоллох чинь буруу.

Нэгэн бодитой асуулт хүмүүсийн янз бүрийн ичгүүртэй байдлыг ил болгодог

Бүгдээс хамгийн эмгэнэлт төгсгөлтэй өөр нэг төрлийн хүн байдаг; энэ бол Миний хамгийн дурдах дургүй төрлийн хүн юм. Тэд Бурханы шийтгэлийг хүртэж

байгаа, эсвэл тэдэнд тавих Бурханы шаардлага хатуу ширүүн учраас эмгэнэлт төгсгөлтэй болохоороо тэд эмгэнэлтэй биш юм; харин ч энэ нь өөрсдөөс болдог учраас тэд эмгэнэлтэй юм. Ердийн хэлц үгэнд өгүүлдэгчлэн тэд булшныхаа нүхийг өөрсдөө ухдаг. Ямар хүн ингэдэг вэ? Энэ хүмүүс зөв замаар алхдаггүй, тэдний төгсгөл урьдаас ил болдог. Бурханы нүдэнд, ийм хүмүүс бол Түүний жигшил зэвүүцлийн хамгийн том объект юм. Хүмүүсийн хувьд ийм хүмүүс хамгийн хөөрхийлөлтэй нь юм. Ийм хүмүүс Бурханыг дагаж эхлэхдээ маш урам зоригтой байдаг; тэд олон төлөөс төлж, Бурханы ажлын хэтийн төлөвийн талаар санал бодол сайтай, өөрсдийнхөө ирээдүйн тухайд арвин их мөрөөдөлтэй байдаг. Тэд мөн Бурханд нэн итгэлтэй байж, Тэр хүмүүсийг бүрэн төгс болгож, тэднийг гайхалтай сайхан хүрэх газарт аваачиж чадна гэж итгэдэг. Гэсэн ч ямар нэг шалтгаанаар энэ хүмүүс дараа нь Бурханы ажлын явцад зугтдаг. “Зугтах” гэдэг нь энд юу гэсэн үг вэ? Энэ нь тэд салах ёс хийлгүй, дуу ч гаргалгүйгээр алга болдог гэсэн үг юм; Тэд үг дуугүй явдаг. Хэдийгээр ийм хүмүүс Бурханд итгэдэг гэж хэлдэг боловч үнэндээ Бурханд итгэх замд үндэс сууриа ерөөсөө тавиагүй байдаг. Тиймээс тэд Бурханд хэчнээн удаан итгэсэн ч байсан, Бурханаас нүүр буруулж чадсаар байдаг. Зарим хүн бизнест орохоор, зарим нь өөрийнхөөрөө амьдрахаар, зарим нь баяжихаар, зарим нь гэрлэж, хүүхэдтэй болохоор явдаг… Явж буй хүмүүсийн дунд хожим мөс чанар нь гэнэт сэргэж буцаж ирэхийг хүсдэг зарим хүн байдаг бөгөөд тэсэж үлдэхэд маш хэцүү байдаг, өчнөөн олон жилийн турш энэ хорвоод урсгал даган хөвж дуусдаг нөгөө хэсэг хүн байдаг. Энэхүү зорилгогүй амьдрагчид нь маш их зовлон зүдүүр туулдаг бөгөөд энэ хорвоод амьдрах нь хэтэрхий зовуурьтай, Бурханаас салж чадахгүй гэж тэд итгэдэг. Тэд гай гамшгаас зугтаж, авралыг олж, сайхан хүрэх газарт хүрэхийн тулд Бурханы гэрт буцаж очиж, тайтгарал, амар амгалан, баяр хөөрийг олж авч, Бурханд үргэлжлүүлэн итгэхийг хүсдэг. Учир нь, энэ хүмүүс Бурханы хайр бол хязгааргүй бөгөөд Бурханы нигүүлсэл дундаршгүй гэдэгт итгэдэг. Хүн юу хийсэн байх нь хамаагүй, Бурхан тэднийг уучилж, өнгөрснийг нь тэвчих ёстой гэж боддог. Энэ хүмүүс буцаж ирээд үүргээ биелүүлэхийг хүсэж байгаагаа ахин дахин хэлдэг. Өөрсдийн зарим эд зүйлийг чуулганд өгч, ингэвэл Бурханы гэрт буцаж очих замаа засна гэж найддаг хүмүүс хүртэл байдаг. Ийм хүмүүст хандах Бурханы хандлага ямар байдаг вэ? Тэр тэдний төгсгөлийг хэрхэн тодорхойлох хэрэгтэй вэ? Чөлөөтэй ярьцгаа. (Бурхан ийм хүнийг хүлээж авна гэж бодож байсан, гэхдээ дөнгөж сая үүнийг сонссоны дараа Тэр тэгэхгүй байж магадгүй гэж санагдлаа.) Шалтгаанаа хэл. (Ийм хүмүүс үхлийг өөрийн төгсгөл байлгахгүйн тулд л Бурханы өмнө ирдэг. Тэд үнэхээр чин сэтгэлээсээ Бурханд итгэхээр ирдэггүй; Бурханы ажил удахгүй дуусна гэдгийг мэддэг учраас тэд ирдэг, тиймээс тэд хүрч ирээд ерөөл хүртэж чадна гэж эндүүрдэг.) Чиний хэлж байгаагаар, энэ хүмүүс Бурханд чин сэтгэлээсээ итгэдэггүй учраас Тэр тэднийг хүлээн авч болохгүй, тийм үү? (Тийм.) (Миний ойлгож байгаагаар, ийм хүмүүс нь ашиг хонжоо хайгчид бөгөөд Бурханд чин сэтгэлээсээ

итгэдэггүй.) Тэд Бурханд итгэх гэж ирээгүй; тэд бол ашиг хонжоо хайгчид. Сайхан хэллээ! Энэ ашиг хонжоо хайгчид бол хүн болгоны үзэн яддаг төрлийн хүмүүс юм. Тэд салхи үлээсэн зүгт хийсэж, өөрт нь ашиггүй л бол юуг ч хийе гэж боддоггүй, тэгэхээр мэдээж, тэд жигшмээр! Өөр ах, эгч нарт хуваалцмаар санал бодол байна уу? (Бурхан тэднийг цаашид хүлээж авахгүй, учир нь Түүний ажил дуусах гэж байгаа бөгөөд одоо бол хүмүүсийн төгсгөлийг тогтоох үе юм. Чухам энэ үед л энэ хүмүүс эргэж ирэхийг хүсдэг—тэд үнэхээр үнэнийг эрэлхийлэхийг хүссэндээ биш, харин гай гамшиг ирж буйг харсан, эсвэл гаднын хүчин зүйлс нөлөөлсөн учраас тэр юм. Хэрвээ тэдэнд үнэнийг эрэлхийлэх санаа зорилго үнэхээр байсан бол хэзээ ч Бурханы ажлын дундаас зугтахгүй л байсан.) Өөр санал бодол байна уу? (Тэднийг хүлээж авахгүй. Бурхан үнэндээ тэдэнд аль хэдийн боломж өгсөн боловч тэд Бурханд хайхрамжгүй хандах гэж зүтгэсээр байсан. Энэ хүмүүсийн санаа зорилго ямар байх нь хамаагүй, тэд үнэхээр гэмшиж байсан ч гэсэн Бурхан тэднийг мөн л буцаж ирэхийг нь зөвшөөрөхгүй. Учир нь Тэр тэдэнд маш олон боломж өгсөн атал тэд аль хэдийн өөрсдийн хандлагыг харуулсан: Тэд Бурханыг орхихыг хүссэн. Энэ шалтгааны улмаас одоо тэд буцаж ирэхийг оролдвол Бурхан тэднийг хүлээж авахгүй.) (Бурхан ийм хүнийг хүлээж авахгүй гэдэгтэй би санал нэг байна, учир нь хэрвээ хүн үнэн замыг харж, Бурханы ажлыг маш урт хугацааны турш туулсан байтлаа дэлхий рүү, Сатаны тэвэрт буцаж очиж чадаж байвал энэ нь Бурханаас айхтар урвасан хэрэг юм. Бурханы мөн чанар нь өршөөл, хайр гэдэг нь бодит үнэн боловч энэхүү мөн чанар нь ямар хүнд чиглэж байгаагаас хамаардаг. Хэрвээ энэ хүн тайтгарал хайж, найдаж болох ямар нэгэн зүйл хайж Бурханы өмнө ирвэл, тэр ердөө л Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг төрлийн хүмүүс биш бөгөөд ийм хүмүүст үзүүлэх Бурханы өршөөл энэ хүрээд дуусна.) Хэрэв Бурханы мөн чанар нь өршөөл юм бол, Тэр яагаад ийм хүнд арай жаахан илүүг өгөхгүй байгаа юм бэ? Арай жаахан илүү өршөөл хүртвэл энэ хүнд боломж гарах бус уу? Урьд нь хүмүүс Бурхан хүн бүрийг аврагдаасай гэж хүсдэг бөгөөд хэнийг ч мөхөөсэй гэж хүсдэггүй гэж дандаа хэлдэг байсан; Хэрвээ зуун хониноос нэг нь төөрвөл Бурхан ерэн есийг нь орхиод алга болсон нэгийг нь хайна. Одоо энэ хүмүүсийнхээр бол, тэд чин сэтгэлээсээ итгэх учраас Бурхан тэднийг хүлээж авч, хоёр дахь боломж олгох ёстой юу? Энэ үнэндээ хэцүү асуулт биш; маш энгийн! Хэрвээ та нар Бурханыг үнэхээр ойлгож, Түүний талаар бодит мэдлэгтэй бол нэг их тайлбар хэрэггүй—нэг их таамаг ч бас хэрэггүй, тийм үү? Та нарын хариулт дөхөж байгаа боловч Бурханы хандлагаас хол зөрүүтэй байсаар байна.

Дөнгөж сая та нарын зарим нь Бурхан ийм хүнийг хүлээж авах боломжгүй гэдэгт эргэлзэхгүй байгаагаа илэрхийлсэн. Бусад нь тийм ч баттай байгаагүй ба Бурхан тэднийг хүлээж авч ч магадгүй, үгүй ч байж магадгүй гэж бодож байсан—энэ хандлага бол арай дундыг баримталсан хандлага. Бурхан ийм хүнийг хүлээж авна байх гэж найдсан үзэл бодолтой хүмүүс бас байсан—энэ бол илүү тодорхойгүй хандлага юм. Бодож буй зүйлдээ итгэлтэй байдаг та нар шиг хүмүүс, Бурхан маш

удаан ажиллаж, Түүний ажил дууссан учраас Тэр энэ хүмүүсийг хүлцэх хэрэггүй гэж итгэдэг; тиймээс Тэр тэднийг дахин хүлээж авахгүй гэж боддог. Та нарын дундаас арай дундыг баримталдаг нь эдгээр асуудлыг нөхцөл байдал тус бүрээр нь шийдэх хэрэгтэй гэж итгэдэг; хэрвээ энэ хүмүүсийн зүрх сэтгэл Бурхантай салшгүй холбоотой, тэд Бурханд үнэхээр итгэж, үнэнийг эрэлхийлдэг бол Бурхан урьдын сул тал, алдааг нь мартах хэрэгтэй—Тэр энэ хүмүүсийг уучилж, дахин нэг боломж олгон, Түүний гэрт эргэн ирж, Түүний авралыг хүртэхийг нь зөвшөөрөх хэрэгтэй. Гэхдээ хэрвээ энэ хүмүүс хожим дахиад зугтах юм бол Бурхан тэднийг хүсэхээ болих бөгөөд энэ хүмүүсийг хаяхыг шударга бус хандсанд тооцож болохгүй. Бурхан ийм хүнийг хүлээж авч чадна гэж найддаг өөр бүлэг хүн байдаг. Энэхүү бүлэг нь Бурхан үнэхээр тэгэх эсэхэд тийм ч итгэлтэй биш байдаг. Хэрвээ Тэр ийм хүнийг хүлээж авах хэрэгтэй гэж тэд итгэж байтал Тэр тэгэхгүй бол энэхүү үзэл бодол нь Бурханы харах өнцөгтэй бага зэрэг нийцэхгүй байгаа мэт санагдана. Хэрвээ Бурхан ийм хүнийг хүлээж авах хэрэггүй гэж тэд итгэж байтал Бурхан, хүнийг гэсэн Өөрийнх нь хайр хязгааргүй бөгөөд ийм хүнд дахин нэг боломж олгохыг хүсэж байна гэж хэлж таарвал энэ нь хүний харанхуй бүдүүлэг байдлыг ил болгож байгаагийн жишээ болох бус уу? Ямар ч байсан та нар бүгд өөрийн гэсэн үзэл бодолтой. Эдгээр үзэл бодол нь та нарын өөрсдийн чинь бодол дахь мэдлэгийг төлөөлдөг; тэдгээр нь мөн үнэн болон Бурханы хүслийн талаарх та нарын ойлголтын гүний тусгал юм. Ингэж хэлэх нь зөв, тийм үү? Энэ асуудал дээр та нарт санал бодол байгаа нь гайхалтай. Гэхдээ та нарын санал бодол зөв эсэх тухай асуулт байсаар байна. Та нар бүгдээрээ бага зэрэг санаа зовж байна, тийм үү? “Тэгвэл юу зөв юм бэ? Бурхан чухам юу бодож байгааг би сайн харахгүй, бас мэдэхгүй байгаа бөгөөд Тэр надад юу ч хэлээгүй. Түүний юу бодож байгааг би яаж мэдэж чадах юм бэ? Бурханы хүн төрөлхтөнд хандах хандлага нь хайр. Урьд нь ханддаг байсан хандлагаараа явбал Тэр ийм хүнийг хүлээж авах ёстой боловч би Бурханы одоогийн хандлагын талаар тийм ч сайн мэдэхгүй байна; Тэр энэ хүнийг хүлээж авч ч магадгүй, авахгүй ч байж магадгүй гэж би хэлж л чадна.” Энэ бол инээдтэй юм, тийм үү? Энэ асуулт та нарыг үнэхээр мухардалд оруулчихлаа. Хэрвээ та нарт энэ асуудлын талаар зүй зохистой үзэл бодол байхгүй бол танай чуулган ийм хүнтэй үнэхээр тулгарвал та нар яах вэ? Хэрвээ та нар нөхцөл байдлыг зөв шийдэхгүй бол Бурханд халдаж болно. Энэ нь аюултай хэрэг явдал бус уу?

Дөнгөж сая Миний гаргаж тавьсан асуудалтай холбогдуулан Би яагаад та нарын үзэл бодлыг асуухыг хүссэн бэ? Би та нарын үзэл бодлыг, Бурханы талаар хэр их мэдлэгтэйг чинь, Түүний санаа зорилго, хандлагын талаар хэр их ойлгож байгааг чинь туршихыг хүссэн юм. Хариулт нь юу вэ? Хариулт нь та нарын үзэл бодол юм. Та нарын зарим нь маш хуучинсаг үзэлтэй, зарим нь төсөөллөө ашиглаж тааж байна. “Таах” гэж юу вэ? Энэ нь та нар Бурхан хэрхэн боддогийг ялган таньж чадахгүй болохоор Бурхан ямар нэгэн байдлаар бодох ёстой гэсэн ор үндэсгүй

таамаглал бодож олдог гэсэн үг юм; өөрийнхөө зөв, бурууг та нар өөрсдөө үнэндээ мэдэхгүй учраас тодорхойгүй үзэл бодол илэрхийлдэг. Ийм баримттай тулгараад та нар юу харсан бэ? Хүмүүс Бурханыг дагахдаа Түүний хүсэлд бараг анхаарал хандуулдаггүй, Түүний бодол, хүмүүст хандах Түүний хандлагыг ховорхон анхаарч үздэг. Хүмүүс Бурханы бодлыг ойлгодоггүй тул Түүний санаа зорилго, зан чанарын тухай асуулт асуухад та нар будилдаг; та нар гүн эргэлзээнд автдаг, тэгээд нэг бол тааж, эсвэл аз туршдаг. Энэ ямар гээч сэтгэлгээ вэ? Энэ нь нэг баримтыг баталдаг: Бурханд итгэдэг ихэнх хүн Түүнийг хоосон агаар шиг, нэг хоромд оршин тогтноод дараагийн хоромд үгүй болдог юм шиг санагддаг зүйл шиг үздэг. Яагаад Би ингэж хэлж байна вэ? Учир нь, асуудалтай тулгарах бүрдээ та нар Бурханы хүслийг мэддэггүй. Та нар Түүний хүслийг яагаад мэддэггүй вэ? Та нар яг одоо л мэдэхгүй байгаа юм биш, харин ч эхнээсээ эцсээ хүртэл та нар энэ асуудлын талаарх Бурханы хандлага юу болохыг мэддэггүй. Чи үүнийг ойлгож чадахгүй, Бурханы хандлагыг ямар болохыг мэдэхгүй боловч энэ талаар сайн бодож байсан уу? Чи үүнийг мэдэхээр эрж хайсан уу? Чи энэ талаар нөхөрлөсөн үү? Үгүй! Энэ нь нэг баримтыг баталж байна: Чиний итгэж үнэмшдэг Бурхан бодит байдлын Бурхантай ямар ч холбоогүй. Чи Бурханд итгэхдээ зөвхөн өөрийн болон удирдагч нарынхаа санаа зорилгыг л эргэцүүлдэг; чи Бурханы хүслийг үнэхээр мэдэж, эрж хайх гэж огтхон ч оролдохгүйгээр, ердөө л Бурханы үгийн өнгөц, онолын утгыг л эргэцүүлдэг. Тийм биш гэж үү? Энэ асуудлын мөн чанар нь тун аймшигтай! Маш олон жилийн дараа Би Бурханд итгэдэг олон хүнийг харсан. Тэдний итгэл Бурханыг оюун санаанд нь юу болгож хувиргасан бэ? Зарим хүн Бурханыг зүгээр нэг хоосон агаар мэт үзэж Түүнд итгэдэг. Энэ хүмүүс Бурханы байгаа, байхгүйг мэдэрч, мэдэж чаддаггүй, тэр ч бүү хэл, тодорхой харж, эсвэл ойлгож чаддаггүй учраас Бурханы оршин тогтнолын талаарх асуултад өгөх хариулт тэдэнд байдаггүй. Дотоод ухамсартаа энэ хүмүүс Бурханыг оршдоггүй гэж боддог. Зарим хүн Бурханыг хүн мэтээр үзэж Түүнд итгэдэг. Өөрсдийнх нь хийж чаддаггүй бүх зүйлийг Тэр бас хийж чадахгүй, Тэр өөрсөд шиг нь бодох ёстой гэж энэ хүмүүс боддог. Тэд Бурханыг “үл үзэгдэх, хүршгүй хүн” тодорхойлдог. Бурханыг хүүхэлдэй мэтээр итгэдэг бүлэг хүн бас байдаг; энэ хүмүүс Бурханд ямар ч сэтгэл хөдлөл байхгүй гэж итгэдэг. Бурхан бол шавар хөшөө, асуудалтай тулгарах үедээ Бурханд ямар ч хандлага, үзэл бодол, санаа байдаггүй гэж тэд боддог; Түүнийг хүн төрөлхтний эрхшээлд байдаг гэж тэд итгэдэг. Хүмүүс ердөө л хүссэнээрээ итгэдэг. Түүнийг тэд агуу болговол Тэр агуу; тэд Түүнийг жижиг болговол Тэр жижиг байдаг. Хүмүүс нүгэл үйлдээд, Бурханы өршөөл, хүлээцтэй байдал, хайр хэрэгтэй болоход Бурхан өршөөлөө үзүүлэх ёстой гэж тэд боддог. Энэ хүмүүс “Бурханыг” оюун ухаандаа зохиож, энэхүү “Бурханаар” хэрэгцээгээ гүйцэлдүүлж, бүх хүслээ хангуулдаг. Хаана, хэзээ гэдэг нь хамаагүй, мөн ийм хүмүүс юу хийдэг нь хамаагүй, тэд Бурхантай харьцаж, Бурханд итгэхдээ энэхүү хоосон төсөөллөө ашигладаг. Бурханы хайр хязгааргүй, Түүний зан чанар зөвт, хүн Түүнд хэчнээн халдах нь хамаагүй, Тэр алийг нь ч санахгүй гэж

боддог учраас Бурханы зан чанарыг хилэгнүүлсэн атлаа өөрсдийг нь Тэр аварч чадна гэж итгэдэг хүмүүс ч бас байдаг. Хүний алдаа, гэм нүгэл, дуулгаваргүй байдал нь тэр хүний зан чанарын түр зуурын илэрхийлэл учраас Бурхан хүмүүст боломж олгож, тэдэнд тэвчээртэй, хүлээцтэй хандана гэж тэд боддог; Бурхан тэднийг урьдын адил хайрласаар байна гэж тэд итгэдэг. Иймээс тэдний аврагдах ихээхэн найдвар тээсээр байдаг. Үнэндээ, хүмүүс Бурханд яаж итгэдэг байх нь хамаагүй, үнэнийг эрэлхийлэхгүй байгаа цагт Тэр тэдэнд сөрөг хандлага баримтална. Учир нь чи Бурханд итгэх явцдаа Бурханы үгийн номыг авч, эрдэнэ мэт үзэж, өдөр бүр судалж, уншдаг атлаа жинхэнэ Бурханыг үл тоомсорлодог. Чи Түүнийг ердөө л нэг хоосон агаар мэт, яг л хүн шиг үздэг—та нарын зарим нь Түүнийг хүүхэлдэйнээс хэтрэхгүй зүйл мэт үздэг. Би яагаад ингэж хэлж байна вэ? Яагаад гэвэл Миний харж байгаагаар, та нар асуудалтай нүүр тулсан ч бай, эсвэл зарим нэг нөхцөл байдалтай тулгарсан ч бай дотоод ухамсарт чинь оршиж байгаа тэдгээр зүйл, дотроос чинь гарсан тэдгээр зүйл Бурханы үг болон үнэнийг эрэлхийлэхтэй хэзээ ч ямар ч холбоотой байгаагүй. Чи юу бодож байгаа, чиний үзэл бодол юу болохыг чи өөрөө л мэддэг, тэгээд өөрийн бодол санаа, үзэл бодлыг Бурханд хүчээр тулгадаг. Чи оюун санаандаа тэдгээрийг Бурханы үзэл бодол болгодгийн дээр эдгээр үзэл бодлыг стандарт болгон тууштай баримталдаг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр, ингэж авирлах нь чамайг Бурханаас улам бүр холдуулдаг.

Бурханы хандлагыг ойлгож, Бурханы талаарх бүх буруу төсөөллийг хая

Та нарын одоо итгэж байгаа энэ Бурхан чухам ямар Бурхан юм бэ? Та нар ер нь энэ талаар бодож үзсэн үү? Муу хүн муу үйл үйлдэж буйг хараад Тэр үзэн яддаг уу? (Тиймээ, Тэр тэгдэг.) Харанхуй бүдүүлэг хүмүүс алдаа гаргахыг хараад Түүний хандлага ямар байдаг вэ? (Гунигтай.) Тахилыг нь хүмүүс хулгайлж байгааг хараад Тэр ямар хандлагатай байдаг вэ? (Тэр тэднийг үзэн яддаг.) Энэ бүгд маш ойлгомжтой. Хүн Өөрт нь итгэх итгэлдээ төөрөлдөж, үнэнийг яагаад ч эрэлхийлэхгүй байгааг нь хараад Бурхан ямар хандлагатай байдаг вэ? Та нар тийм ч итгэлтэй биш байна, тийм үү? “Төөрөгдөл” гэдэг бол хандлага болохын хувьд нүгэл биш, бас Бурханд халдаж байгаа ч хэрэг биш бөгөөд энэ нь нэг төрлийн томоохон алдаа биш гэж хүмүүст санагддаг. Тэгэхээр энэ тохиолдолд Бурханы хандлага ямар байхыг Надад хэлээч? (Тэр үүнийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй.) “Хүлээн зөвшөөрөх хүсэлгүй байх”—энэ ямар хандлага вэ? Энэ нь Бурхан энэ хүмүүсийг дорд үзэж, үл тоомсорлодог гэсэн үг юм! Тэр энэ хүмүүстэй харьцаж байгаа байдал нь хүйтэн хөндий хандлага байдаг. Гэгээрэл, гэрэлтүүлэлт, цээрлүүлэлт, сахилгажуулалтын ажил зэрэг ямар ч ажлыг тэдэн дээр хийлгүйгээр үл тоомсорлох нь Бурханы арга барил юм. Ийм хүмүүсийг ердөө л Бурханы ажилд оруулдаггүй. Түүний зан чанарыг хилэгнүүлж, захиргааны зарлигийг нь зөрчдөг

хүмүүст хандах Бурханы хандлага ямар байдаг вэ? Туйлын их жигшил зэвүүцэл! Түүний зан чанарыг хилэгнүүлсэндээ гэмшдэггүй хүмүүст Бурхан туйлын их хилэгнэдэг. “Хилэгнэсэн” гэдэг нь зөвхөн мэдрэмж, сэтгэлийн байдал юм; энэ нь тодорхой хандлагатай холбоогүй. Гэхдээ иймэрхүү мэдрэмж, сэтгэлийн байдал нь ийм хүмүүст төгсгөл авчирна: Энэ нь Бурханыг туйлын их жигшлээр дүүргэнэ! Энэхүү туйлын их жигшлийн үр дагавар нь юу вэ? Бурхан энэ хүмүүсийг үл тоомсорлож, хэсэг хугацаанд хариу өгөхгүй. Тэгээд Тэр “намрын улирлын дараа” тэднийг ялгахаар хүлээнэ. Энэ нь ямар санааг агуулж байна вэ? Энэ хүмүүст төгсгөл байсаар байх уу? Бурхан ийм хүмүүст төгсгөл өгөхийг хэзээ ч зориогүй! Иймээс Бурхан ийм хүмүүст одоо хариу өгөхгүй байгаа нь тун хэвийн хэрэг бус уу? (Тийм, энэ бол хэвийн.) Ийм хүмүүс одоо юу хийхээр бэлдэж байх ёстой вэ? Тэд өөрсдийн зан авир болон үйлдсэн муу үйлийнхээ сөрөг үр дагаврыг үүрэхэд бэлдэх хэрэгтэй. Энэ бол ийм хүнд барьж буй Бурханы хариу юм. Иймээс Би одоо ийм хүмүүст: Эндүүрэлтэйгээ зууралдахаа боль, бүтэшгүй мөрөөдөл бүү өвөрлө хэмээн тодорхой хэлж байна. Бурхан хүмүүст үргэлж хүлээцтэй хандахгүй; Тэр тэдний гэм буруу, дуулгаваргүй байдлыг үргэлж тэсвэрлэхгүй. Зарим хүн: “Би ч бас иймэрхүү цөөн хэдэн хүн харж байсан, залбирах үед нь Бурхан тэдний сэтгэлийг онцгойлон хөдөлгөж, тэд гашуунаар уйлдаг. Ер нь тэд бас маш их аз жаргалтай байдаг; Бурхан тэдэнтэй хамт байгаа мэт, Бурханы удирдамж тэдэнд байгаа мэт санагддаг” гэж хэлнэ. Ийм дэмий юм бүү ярь! Гашуунаар уйлж байгаа нь заавал Бурхан сэтгэлийг нь хөдөлгөсөн юм уу, эсвэл Бурхан түүнтэй хамт байгаа гэсэн үг биш, Бурханы удирдамж байна гэсэн үг бүр ч биш. Хэрвээ хүмүүс Бурханыг хилэгнүүлбэл Бурхан тэднийг удирдан чиглүүлсээр байх уу? Товчхондоо, Бурхан хэн нэгнийг таягдан хаяж, орхихоор шийдсэн бол тэр хүний төгсгөл аль хэдийн үгүй болдог. Залбирах үед нь тэдэнд хэчнээн таатай санагдах, зүрх сэтгэлдээ Бурханд хэчнээн их итгэдэг байх нь хамаагүй энэ нь чухал биш болсон байдаг. Чухал зүйл нь Бурханд ийм итгэл хэрэггүй; Бурхан энэ хүмүүсийг аль хэдийн зэвүүцэн голсон. Ирээдүйд тэдэнтэй хэрхэн харьцах нь ч бас чухал биш. Чухал зүйл нь гэвэл, энэ хүмүүс Бурханыг уурлуулах яг тэр мөчид төгсгөл нь тогтоогддог. Хэрвээ Бурхан ийм хүмүүсийг аврахгүй гэж шийдсэн бол тэд шийтгүүлэхээр үлдэнэ. Бурханы хандлага энэ билээ.

Хэдийгээр Бурханы мөн чанар хайр агуулдаг бөгөөд Тэр хүн болгонд өршөөнгүй ханддаг боловч Түүний мөн чанар нь бас нэр хүнд гэдгийг хүмүүс анзаардаггүй, мартсан байдаг. Түүнд хайр бий гэдэг нь хүмүүс Түүнд дурааараа халдаж болдог, Тэр ямар ч мэдрэмж, хариу үйлдэл гаргахгүй гэсэн үг биш, түүнд өршөөл бий гэдэг нь хүмүүст хэрхэн хандах талаар Түүнд ямар ч зарчим байхгүй гэсэн үг бас биш билээ. Бурхан амьд; Тэр үнэхээр оршдог. Тэр бол төсөөллийн хүүхэлдэй, эсвэл өөр ямар нэг эд зүйлийн аль нь ч биш. Тэр оршдог болохоор бид Түүний зүрх сэтгэлийн дуу хоолойг цаг үргэлж анхааралтай сонсож, Түүний хандлагад нухацтай анхаарал хандуулж, Түүний мэдрэмжийг ойлгож авах хэрэгтэй. Бурханыг тодорхойлохдоо

бид хүмүүсийн төсөөллийг ашиглах ёсгүй, бас хүмүүний бодол, хүслийг Түүнд тулган, Бурханыг хүний төсөөлөлд үндэслэсэн хүний арга барилаар хүнд ханддаг болгох ёсгүй. Хэрвээ тэгвэл чи Бурханыг уурлуулж, Бурханы уур хилэнг төрүүлж, Бурханы эрхэм чанарыг сорьж байна! Тиймээс энэ асуудал хэр хүнд болохыг та нар ойлгож авмагцаа өөрийнхөө үйлдэлд анхаарал болгоомжтой бай гэж Би та нарын хүн нэг бүрээс шаардаж байна. Хэлж ярихдаа ч мөн анхаарал болгоомжтой бай—чи Бурханд хэрхэн хандах тухайд бол анхаарал болгоомжтой байх тусмаа сайн! Бурханы хандлага ямар болохыг ойлгохгүй байхдаа хайхрамжгүй бүү ярь, хайхрамжгүй үйлдэл бүү хий, хайнга нэр хоч бүү зүүлгэ. Түүнээс ч чухал нь, дур зоргоороо дүгнэлт бүү хий. Үүний оронд чи хүлээж, эрж хайх ёстой; ийм үйлдэл нь бас Бурханаас эмээж, муугаас зайлахын илрэл юм. Юуны түрүүнд, хэрвээ чи үүнд хүрч чадвал, юуны түрүүнд, чи ийм хандлагатай бол тэнэглэл, харанхуй бүдүүлэг байдал болон аливаа юмсын цаад учир шалтгааныг ойлгодоггүй гээд Бурхан чамайг буруутгахгүй. Харин ч Бурханд халдахаас айдаг, Түүний санаа зорилгыг хүндэлдэг, Түүнийг дуулгавартай дагахад бэлэн хандлагын чинь ачаар Бурхан чамайг санаж, чамайг удирдан чиглүүлж, гэгээрүүлж, дутуу дулимаг, харанхуй бүдүүлэг байдлыг чинь тэвчих болно. Эсрэгээрээ, Түүнд хандах хандлага чинь хүндэтгэлгүй—Түүнийг хүссэнээрээ шүүж, Түүний санаа бодлыг дур зоргоороо таамаглаж, тодорхойлж байвал—Бурхан чамайг яллаж, сахилгажуулж, бүр шийтгэнэ; эсвэл Тэр чиний талаар санал шүүмж хэлж магад. Тэрхүү санал шүүмж нь чиний төгсгөлтэй хамаатай байж ч болох юм. Тиймээс Би үүнийг дахин нэг удаа цохон тэмдэглэмээр байна: Та нар дор бүрнээ Бурханаас ирдэг бүхэнд анхаарал, болгоомжтой байх ёстой. Хайхрамжгүй бүү ярь, мөн хайхрамжгүй үйлдэл бүү хий. Чи ямар нэгэн зүйл хэлэхээсээ өмнө зогсоод бодох ёстой: Миний энэ үйлдвэл Бурханыг уурлуулах болов уу? Ингэснээрээ би Бурханыг хүндэлж байна уу? Энгийн асуудал дээр ч гэсэн чи эдгээр асуултыг ойлгох гэж оролдон, тэдгээрийг бодож үзэхэд илүү их хугацаа зарцуулах хэрэгтэй. Хэрвээ чи бүхий л талаар, бүх зүйл дээр, цаг ямагт эдгээр зарчмын дагуу үнэхээр хэрэгжүүлж, ялангуяа ямар нэг зүйлийг ойлгохгүй байх үедээ ийм хандлага баримталбал Бурхан чамайг үргэлж залж чиглүүлж, дагах замаар хангана. Хүмүүс ямар дүр үзүүлэх нь хамаагүй, Бурхан тэднийг тун тодорхой, ил тод хардаг бөгөөд ийнхүү үзүүлсэнд чинь үнэн зөв, тохирох үнэлгээг өгнө. Сүүлчийн шалгалтыг туулсны чинь дараа Бурхан чиний төгсгөлийг тодорхойлохын тулд бүх зан авирыг чинь авч бүрэн нэгтгэж дүгнэнэ. Энэхүү үр дүн нь хүн нэг бүрийг ямар ч эргэлзээгүйгээр итгүүлнэ. Би энд та нарт юу хэлэхийг хүсэж байна вэ гэвэл: Та нарын үйл хэрэг, үйлдэл бүр, бодол болгон хувь заяаг чинь шийднэ.

Хүмүүсийн төгсгөлийг хэн тодорхойлдог вэ?

Хэлэлцэх ёстой хамгийн чухал бас нэг асуудал байгаа бөгөөд тэр нь Бурханд хандах та нарын хандлага юм. Энэ хандлага бол туйлын чухал! Энэ нь та нарыг эцэстээ сүйрэл рүү явах уу, эсвэл та нарт зориулж Бурханы бэлдсэн гайхалтай

сайхан хүрэх газар луу явах уу гэдгийг шийддэг. Хаанчлалын эрин үед Бурхан хэдийнээ 20 гаруй жил ажилласан бөгөөд магадгүй энэ 20 жилийн хугацаанд та нар ямар байсан талаараа сэтгэлийнхээ гүнд бага зэрэг итгэлгүй байж ирсэн байх. Гэвч Бурхан зүрх сэтгэлдээ та нарын хүн нэг бүрийн талаар бодит, үнэн зөв бүртгэл хийчихсэн. Хүн болгон Түүнийг дагаж, Түүний номлолыг сонсож, үнэнийг аажмаар улам их ойлгож эхэлсэн үеэс нь эхлээд, хүн болгон үүргээ биелүүлж эхэлсэн хүртэлх хүн бүрд хамаарах бүх зан төлөвийн байдлын бүртгэлийг Бурхан хөтөлсөн. Үүргээ гүйцэтгэж, бүх төрлийн орчин нөхцөл, шалгалттай тулгарч байхдаа хүмүүсийн хандлага ямар байдаг вэ? Тэд хэрхэн биелүүлдэг вэ? Зүрх сэтгэлд нь Бурханы талаар ямар мэдрэмж төрдөг вэ?… Бурханд энэ бүгдийн данс, бүртгэл бий; Тэд бүгдийнх нь бүртгэлийг хөтөлдөг. Та нарын бодлоор эдгээр асуудал толгой эргэмээр байж магад. Гэвч Бурханы үзэж байгаагаар бол тэдгээр нь бүгд тов тодорхой, хайнга байдлын өчүүхэн төдий ч ул мөр байдаггүй. Энэ бол хүн нэг бүрийн төгсгөлтэй хамаатай, тэдний хувь заяа болон хэтийн ирээдүйг хөндсөн асуудал, тэр ч байтугай, Бурхан уйгагүй хүчин чармайлтаа энд л зарцуулдаг; иймд Бурхан үүнийг хэзээ ч өчүүхэн төдий ч үл ойшоож тэвчихгүй, бас ямар ч хайнга байдлыг тэвчихгүй. Бурхан хүн төрөлхтний энэхүү дансны бүртгэлийг хөтөлж, Бурханыг дагасан хүмүүсийн замналыг эхнээс нь төгсгөл хүртэл бүгдийг нь тэмдэглэж авдаг. Энэ хугацаанд Бурханд хандах чиний хандлага хувь заяаг чинь тодорхойлдог. Энэ үнэн бус уу? Одоо чи Бурхан зөвт гэдэгт итгэж байна уу? Түүний үйлдэл зохистой юу? Та нарын толгойд Бурханы талаар өөр ямар нэгэн төсөөлөл байсаар байна уу? (Үгүй.) Тэгэхээр та нар хүний төгсгөл бол Бурханы тодорхойлдог зүйл гэж хэлэх үү, эсвэл хүмүүс өөрсдөө тодорхойлдог зүйл гэж хэлэх үү? (Энэ бол Бурханы тодорхойлох зүйл.) Хэн эдгээрийг тодорхойлдог вэ? (Бурхан.) Та нар итгэлгүй байна, тийм үү? Хонконгийн ах, эгч нар аа, хэлээч—хэн тэдгээрийг тодорхойлдог вэ? (Хүмүүс өөрсдөө тэдгээрийг тодорхойлдог.) Хүмүүс өөрсдөө тодорхойлдог гэж үү? Тэгвэл хүмүүсийн төгсгөл Бурхантай ямар ч хамаагүй гэсэн үг болох бус уу? Өмнөд Солонгосын ах, эгч нар хэлээч. (Бурхан хүмүүсийн бүх үйлдэл, үйл хэрэг дээр үндэслэж, мөн явж байгаа замынх нь дагуу төгсгөлийг нь тодорхойлдог.) Энэ маш бодитой хариулт байна. Миний та бүхэнд мэдэгдэх ёстой нэг баримт бий: Бурхан авралын ажлынхаа явцад хүмүүст зориулж стандарт тогтоосон. Тэд Бурханы үгийг сонсож, Бурханы замаар алхах ёстой байх нь энэхүү стандарт билээ. Энэ стандартыг хүмүүсийн төгсгөлийг дэнслэхэд ашигладаг. Чи Бурханы энэ стандартын дагуу хэрэгжүүлбэл сайн төгсгөл олж авч чадна; тэгэхгүй бол чи сайн төгсгөл олж авч чадахгүй. Тэгэхээр энэ төгсгөлийг хэн тодорхойлдог гэж чи хэлэх вэ? Бурхан ганцаараа биш, харин Бурхан, хүн хоёр хамтдаа үүнийг тодорхойлдог. Энэ зөв үү? (Зөв.) Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, Бурхан хүн төрөлхтнийг аврах ажил хийж, хүн төрөлхтөнд үзэсгэлэнтэй сайхан хүрэх газрыг бэлдэхийг идэвхийлэн хүсдэг; хүмүүс бол Бурханы ажлын объект бөгөөд энэ төгсгөл, энэхүү хүрэх газрыг Бурхан тэдэнд бэлдэж өгдөг. Хэрвээ Түүнд ажиллах

объект байгаагүй бол Тэр энэ ажлыг хийх хэрэггүй байх байв; Бурхан энэ ажлыг хийгээгүй бол хүмүүст аврал хүртэх боломж үгүй байх байлаа. Хүмүүс бол аврагдах хүмүүс, хэдийгээр аврагдах нь энэхүү процессын идэвхгүй тал нь боловч энэ үүргийг гүйцэтгэж байгаа хүмүүсийн хандлага нь хүн төрөлхтнийг аврах ажилдаа Бурхан амжилттай байх уу, үгүй юу гэдгийг тодорхойлдог. Бурхан чамайг залж чиглүүлдэггүй байсан бол чи Түүний стандартыг мэдэхгүй, бас зорилгогүй байх байсан. Чамд энэ стандарт, энэ зорилго байсан ч, чи хамтран ажилладаггүй, үүнийг хэрэгжүүлдэггүй, төлөөс төлдөггүй хэвээр байвал энэ төгсгөлийг олж авахгүй. Ийм учраас хүний төгсгөлийг Бурханаас салгаж болохгүй, бас хүнээс салгаж болохгүй гэж Би хэлдэг. Одоо тэгэхээр та нар хүмүүсийн төгсгөлийг хэн тодорхойлдгийг мэдэж авлаа.

Хүмүүс туршлага дээр тулгуурлан Бурханыг тодорхойлох хандлагатай байдаг

Бурханыг мэдэх тухай сэдвийг хэлэлцэж байх үед та нар нэг зүйлийг анзаарсан уу? Бурханы хандлага сүүлийн үед өөрчлөгдсөнийг та нар анзаарсан уу? Хүмүүст хандах Түүний хандлага хувиршгүй юу? Бурхан үргэлж ингэж тэвчиж, бүх хайр, өршөөлөө хүмүүст үүрд үзүүлсээр байх уу? Энэ асуудалд Бурханы мөн чанар бас хамаардаг. Өмнө нь дурдсан үрэлгэн хүү гэгчийн асуулт руу буцаж очицгооё. Энэ асуултыг асуусны дараа та нарын хариулт тийм ч тодорхой байгаагүй; өөрөөр хэлбэл, та нар Бурханы санаа зорилгыг баттай сайн ойлгоогүй байна. Бурхан хүн төрөлхтнийг хайрладгийг мэдээд тэд Түүнийг хайрын бэлгэ тэмдэг гэж тодорхойлдог: Хүмүүс юу хийж, хэрхэн авирлаж, Бурханд яаж хандаж, хэчнээн дуулгаваргүй байсан ч бай, Бурханд хайр байдаг учраас, Бурханы хайр хязгааргүй агаад хэмжээлшгүй учраас эдгээрийн аль нь ч үнэндээ хамаагүй; Бурханд хайр байдаг учраас Тэр хүмүүст хүлээцтэй хандаж чаддаг; Бурханд хайр байдаг учраас Тэр хүмүүст, тэдний дутуу дулимаг, харанхуй бүдүүлэг, дуулгаваргүй байдалд өршөөнгүй хандаж чаддаг гэж тэд итгэдэг. Энэ үнэхээр ийм байдаг уу? Зарим хүний хувьд, тэд Бурханы тэвчээрийг нэг удаа, эсвэл хэдэнтээ мэдэрснийхээ дараа энэхүү туршлагаа Бурхан талаарх ойлголтынхоо хөрөнгө мэт үзэж Тэр өөрсдөд нь үүрд тэвчээртэй, өршөөнгүй хандана гэж итгээд амьдралынхаа явцад Бурханы энэхүү тэвчээрийг өөрсдөд нь хандах Түүний стандарт болгож үздэг. Бурханы хүлээцтэй байдлын нэг удаа мэдэрснийхээ дараа Бурханыг хүлээцтэй, тэдний бодлоор бол энэхүү хүлээцтэй байдал нь хязгааргүй, хариу нэхдэггүй, бүр ямар ч зарчимгүй гэж үүрд тодорхойлох хүмүүс бас байдаг. Ийм итгэл үнэмшил зөв үү? Бурханы мөн чанар, Бурханы зан чанарын тухай асуудлыг хэлэлцэх бүрд та нар гайхширсан мэт харагддаг. Та нарын ийм байгааг харах нь Намайг тун их түгшээдэг. Та нар Бурханы мөн чанартай холбоотой олон үнэнийг сонссон; мөн Түүний зан чанартай холбоотой нэлээд олон хэлэлцүүлгийг сонссон. Гэвч та нарын оюун санаанд эдгээр асуудал болон үнэний энэ талууд нь зүгээр л онол болон

бичигдсэн үгс дээр үндэслэсэн ой санамжууд юм; та нарын хэн нь ч өдөр тутмын амьдралдаа Бурханы зан чанар гэж чухамхүү юу болохыг хэзээ ч мэдэрч, харж чадаагүй. Тиймээс та нар бүгд итгэхдээ мунгинуу байдаг; Бурханд хүндэтгэлгүй хандаж, бүр Түүнийг үл тоомсорлох хүртлээ та нар бүгд сохроор итгэж байна. Та нар Бурханд ийм хандлагатай байх нь юунд хүргэдэг вэ? Энэ нь та нарыг үргэлж Бурханы талаар дүгнэлт хийхэд хүргэдэг. Та нар өчүүхэн төдий мэдлэг олж авмагцаа маш их сэтгэл ханаж, Бурханыг бүхэлд нь олж авсан мэт санагддаг. Дараа нь Бурхан ийм л байдаг гэж дүгнэх бөгөөд Түүнийг чөлөөтэй хөдөлгөдөггүй. Түүнчлэн Бурхан ямар нэгэн шинэ зүйл хийх болгонд Түүнийг Бурхан гэдгийг нь та нар хүлээн зөвшөөрч чаддаггүй. Нэг л өдөр Бурхан “Би хүн төрөлхтнийг хайрлахаа болино; Би хүмүүст өршөөл үзүүлэхээ болино; хүмүүст гаргах Миний тэсвэр, тэвчээр барагдлаа; Би тэднийг туйлаас жигших жигшил, дургүйцлээр дүүрэн боллоо” гэж хэлэх үед хүмүүс энэхүү мэдэгдлээс болж сэтгэлийнхээ гүнд зөрчилдөнө. Тэдний зарим нь бүр “Та миний Бурхан байхаа больсон; Та миний дагахыг хүссэн Бурхан байхаа хэдийнээ больсон. Хэрвээ Та ингэж хэлж байгаа бол, Та цаашид миний Бурхан байхад тохирохгүй бөгөөд би Таныг цаашид дагах хэрэггүй. Хэрвээ Та надад өршөөл үзүүлж, намайг хайрлаж, надад хүлээцтэй хандахгүй юм бол би Таныг дагахаа болино. Та намайг хязгааргүй тэвчиж, надад үргэлж хүлээцтэй хандаж, Та бол хайр, тэвчээр, хүлээцтэй байдал гэдгээ надад харуулах юм бол л би Таныг дагаж чадна, зөвхөн тэр үед л би эцсээ хүртэл Таныг дагах итгэлтэй болно. Би нэгэнт Таны тэвчээр, өршөөлийг хүртсэнээс хойш миний дуулгаваргүй байдал болон гэм нүгэл үүрд өршөөгдөж, уучлагдаж болохын дээр би хэдийд ч, хаана ч нүгэл үйлдэж, улайж, өршөөгдөж, мөн Таныг уурлуулж болно. Та миний талаар сэтгэгдэлтэй байх, эсвэл дүгнэлт хийх ёсгүй” гэж хэлдэг. Хэдийгээр магадгүй та нарын нэг нь ч ийм асуудлын талаар субьектив байдлаар, санаатайгаар бодохгүй ч гэсэн Бурханыг нүглийг чинь уучлах хэрэгсэл, гайхалтай сайхан хүрэх газар олж авахад ашиглах объект гэж үзэх болгондоо, чи амьд Бурханыг чадамгайгаар өөрийнхөө эсрэг, өөрийн дайсан болгосон байдаг. Надад ингэж харагддаг. “Би Бурханд итгэдэг”, “Би үнэнийг эрэлхийлдэг”, “Би зан чанараа өөрчлөхийг хүсэж байна”, “Би харанхуйн нөлөөнөөс чөлөөлөгдөхийг хүсэж байна”, “Би Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг хүсэж байна”, “Би Бурханд дуулгавартай байхыг хүсэж байна”, “Би Бурханд үнэнч байж, үүргээ сайн гүйцэтгэхийг хүсэж байна” гэх мэт зүйлсийг чи хэлсээр байж магадгүй юм. Гэхдээ чиний үг хэчнээн сайхан сонсогддог, чи хэдий их онол мэддэг, тэр онол хэдий сүржин, хүндэлмээр байх нь хамаагүй бодит үнэн гэвэл одоо та нарын ихэнх нь Бурханы талаар дүгнэлт хийхдээ эзэмшсэн дүрэм журам, хоосон сургаал, онолоо хэрхэн ашиглахыг аль хэдийн сурсан учраас Түүнийг хар аяндаа л өөрсдийнхөө эсрэг тавьдаг. Хэдийгээр чи үсэг, хоосон сургаал эзэмшсэн боловч үнэний бодит байдалд жинхэнээсээ ороогүй учраас чиний хувьд Бурхантай ойр болж, Түүнийг мэдэж, ойлгох нь маш хэцүү байдаг. Энэ бол тун эмгэнэлтэй явдал юм!

Би дараах дүр зургийг видеоноос үзлээ: Хэдэн эгчид “Үг нь махбодоор илэрсэн” ном байх бөгөөд тэд үүнийг маш өндөрт өргөн барьж байсан; тэд энэхүү номыг дундаа, толгойноосоо өндөрт өргөж байсан. Хэдийгээр энэ нь зүгээр л нэг дүрс боловч Миний дотор төрсөн зүйл нь дүрс биш, харин хүн бүр зүрх сэтгэлдээ өндөрт тээдэг зүйл бол Бурханы үг биш, харин Бурханы үгийн ном гэж Надад бодогдсон. Энэ бол туйлын гунигтай хэрэг. Ийм үйлдэл нь Бурханыг өндөрт өргөж байгаатай огтхон ч адилгүй, учир нь та нарт Бурханы талаарх ойлголт байхгүй болохоор мэдээжийн асуулт, өчүүхэн жижиг асуудал хүртэл та нарыг өөрсдийн гэсэн үзэлтэй болгодог. Би та нараас нухацтайгаар юм асуухад, таамаглал, өөрсдийн төсөөллөөрөө хариулдаг; та нарын зарим нь бүр эргэлзсэн өнгөтэй болж, Миний асуултыг асуултаар хариулдаг. Та нарын итгэдэг Бурхан чинь жинхэнэ Бурхан биш гэдгийг энэ нь Надад улам тодорхой хэлж өгдөг. Бурханы үгийг ийм олон жилийн турш уншсаныхаа дараа та нар дахиад л тэдгээрийг, Бурханы ажил болон илүү их хоосон сургаалыг ашиглан Түүний талаар дүгнэлт хийдэг. Түүнчлэн, та нар Бурханыг ойлгох гэж хэзээ ч оролддоггүй; Түүний санаа зорилгыг ухаарч, хүмүүст хандах Түүний хандлагыг ойлгож, эсвэл Бурхан хэрхэн боддог, Тэр яагаад гунигтай, ууртай байдаг, Тэр яагаад хүмүүсийг зэвүүцэн голдог болон иймэрхүү бусад асуултыг ухаарч ойлгох гэж хэзээ ч хичээдэггүй. Түүнээс гадна, Бурхан хүн төрөлхтний талаар хандлага, санаа бодолгүйгээр, тэдний янз бүрийн үйлдлийг нь зүгээр л ажиглаж байдаг учраас Бурхан үргэлж дуугүй байсаар ирсэн гэж бүр ч олон хүн итгэдэг. Гэтэл өөр нэг бүлэг хүн Бурхан үг дуугүй хүлээн зөвшөөрсөн учраас дуу гаргадаггүй, Тэр хүлээж байгаа, эсвэл ямар ч хандлагагүй учраас Тэр чимээгүй байгаа гэж итгэдэг; Бурханы хандлагыг хэдийнээ номд бүрэн дэлгэрэнгүй өгүүлсэн, хүн төрөлхтөнд бүрэн дүүрэн илэрхийлсэн учраас хүмүүст ахин дахин давтан хэлэх хэрэггүй гэж тэд боддог. Бурхан хэдийгээр чимээгүй байгаа ч Түүнд хандлага, үзэл бодлоос гадна хүмүүсээс хүрэхийг шаарддаг стандарт байсаар байдаг. Хэдийгээр хүмүүс Түүнийг ойлгох гэж, эрж хайх гэж хичээдэггүй боловч Бурханы хандлага маш тодорхой байдаг. Нэгэн үе маш их урам зоригтойгоор Бурханыг дагаж байсан атлаа хэзээ нэгэн цагт Түүнийг хаяж, орхиод явсан хүнийг аваад үзье. Энэ хүн одоо буцаж ирэхийг хүслээ гэхэд, гайхалтай нь та нар Бурханы үзэл бодол, Бурханы хандлага ямар байхыг мэддэггүй. Энэ бол туйлын гунигтай хэрэг бус уу? Үнэндээ энэ бол нэлээд өнгөцхөн асуудал юм. Хэрвээ та нар Бурханы зүрх сэтгэлийг үнэхээр ойлгосон бол, ийм хүнд хандах Түүний хандлагыг мэдэх байсан бөгөөд тодорхойгүй хариулт өгөхгүй байсан. Та нар мэдэхгүй байгаа учраас Би хэлж өгье.

Ажлынх нь явцад зугтсан хүмүүст хандах Бурханы хандлага

Ийм хүмүүс хаа сайгүй байдаг: Тэд Бурханы замын талаар итгэлтэй байдаг байснаа янз бүрийн шалтгаанаар гарч явж, юу хүссэнээ хийх гээд баяртай ч гэж хэлэлгүй чимээгүйхэн явдаг. Энэ хүмүүсийн явдаг шалтгааныг бид одоохондоо ярилцахгүй; эхлээд бид ийм хүнд хандах Бурханы хандлага ямар байдгийг авч үзэх

болно. Энэ маш тодорхой байна. Бурханы нүдэнд бол, энэ хүмүүс явсан тэр мөчөөс Бурханд итгэх хугацаа нь дуусдаг. Үүнийг хувь хүн өөрөө биш, харин Бурхан дуусгасан. Энэ хүн Бурханыг орхиж явсан нь Бурханыг хэдийн голж, Түүнийг хүсэхээ больж, Бурханы авралыг хүлээн авахаа больсон гэсэн үг юм. Ийм хүн Бурханыг хүсэхгүй байгаагаас хойш Бурхан түүнийг хүсэж болно гэж үү? Түүнчлэн ийм хүмүүс ийм хандлага, ийм үзэл бодолтойн дээр Бурханыг орхиж явахаар шийдэхдээ Бурханы зан чанарыг аль хэдийн хилэгнүүлсэн байдаг. Хэдийгээр тэд уурсаж, Бурханыг хараагаагүй, аливаа балиар, дэндсэн авир гаргаагүй ч гэсэн, мөн хэдийгээр энэ хүмүүс “Би гадаа ханатал зугаацаж, эсвэл ямар нэгэн зүйлийн улмаас Бурхан надад хэрэгтэй хэвээр байх өдөр ирвэл би эргэж ирнэ. Эсвэл Бурхан намайг дуудвал би эргэж ирнэ” хэмээн бодож эсвэл “Би гаднаа гомдож, эсвэл гадаад ертөнц хэтэрхий харанхуй, хэтэрхий хорон муухай гэдгийг хараад урсгалаараа явахыг хүсэхээ болих үедээ Бурханд эргэж очно” гэж хэлдэг ч гэсэн тийм байдаг. Хэдийгээр энэ хүмүүс яг хэзээ буцаж очихоо дотроо тооцоолсон ч гэсэн, буцаж ирэх хаалгаа онгорхой орхихыг хичээсэн ч гэсэн тэд юунд итгэж, хэрхэн төлөвлөх нь хамаагүй, энэ бүгд зүгээр л хий хоосон мөрөөдөл гэдгийг тэд ухаардаггүй. Тэдний явахыг хүсэж байгаа нь Бурханд ямар санагдахыг мэддэггүй нь тэдний хамгийн том алдаа юм. Тэд Бурханыг орхиж явахаар шийдсэн тэр мөчөөс Тэр тэднийг бүрмөсөн хаядаг; тэр үед Тэрээр ийм хүний төгсгөлийг зүрх сэтгэлдээ аль хэдийн тодорхойлсон байдаг. Тэр нь ямар төгсгөл вэ? Тэр нь энэ хүн хулгануудын нэг учраас тэдэнтэй хамт мөхөх болно. Тиймээс хүмүүс хэн нэгэн Бурханыг хаясан боловч шийтгэл хүртэхгүй байх иймэрхүү нөхцөлийг дандаа хардаг. Бурхан зарчмынхаа дагуу ажилладаг. Зарим зүйлийг харж болдог байхад заримыг нь Бурхан зөвхөн зүрх сэтгэлдээ шийдвэрлэдэг учраас хүмүүс үр дүнг нь харж чаддаггүй. Хүмүүст харагддаг тал нь аливаа юмны жинхэнэ тал байх албагүй, харин чиний хардаггүй нөгөө тал нь үнэндээ Бурханы жинхэнэ чин сэтгэлийн бодол, дүгнэлтийг агуулдаг.

Бурханы ажлын үеэр зугтсан хүмүүс бол үнэн замыг хаядаг хүмүүс юм

Ажлынх нь үеэр зугтсан хүмүүст Бурхан яагаад тийм ноцтой шийтгэл өгдөг вэ? Яагаад Тэр тэдэнд маш их уурладаг вэ? Юуны өмнө Бурханы зан чанар бол сүр жавхлан, уур хилэн гэдгийг бид мэднэ; Тэр бол хэн нэгэнд нядлуулах хонь биш, хүмүүсийн хүссэнээрээ удирдах хүүхэлдэй бүр ч биш. Тэрээр мөн захируулдаг хоосон агаар ч биш. Хэрвээ чи Бурхан оршдог гэдэгт үнэхээр итгэдэг бол Бурханаас эмээдэг зүрх сэтгэлтэй байж, Түүний мөн чанарыг уурлуулах учиргүй гэдгийг мэдэх ёстой. Энэхүү уур хилэн нь нэг үгээс, нэг бодлоос, магадгүй зарим төрлийн өөдгүй зан авираас, эсвэл бүр нэг төрлийн аядуу зөөлөн зан авираас, хүмүүсийн нүдээр, хүний ёс зүйгээр зүгээр өнгөрөөж болох зан авираас үүдсэн юм уу магадгүй хоосон сургаал, онолоос үүдэлтэй байж ч болно. Гэхдээ нэгэнт

Бурханыг уурлуулсан бол чи боломжоо алдаж, төгсгөлийн өдрүүд чинь ирсэн байна. Энэ бол аймшигтай зүйл! Хэрвээ чи Бурханд халдаж болохгүй гэдгийг ойлгодоггүй бол Бурханаас айдаггүй, магадгүй Түүнд тогтмол халддаг байж болзошгүй юм. Хэрвээ чи Бурханаас хэрхэн эмээхээ мэддэггүй бол Бурханаас эмээж чадахгүй бөгөөд Бурханы замаар алхах—Бурханаас эмээж, муугаас зайлах зам дээр хэрхэн өөрөө гарахыг мэдэхгүй. Чи үүнийг мэддэг болж, Бурханд халдаж болохгүй гэдгийг ухаарч ойлгомогц, Бурханаас эмээж, муугаас зайлах гэж юу болохыг мэдэх болно.

Бурханаас эмээж, муугаас зайлах замаар алхах нь чи хэр их үнэнийг мэддэг, хэр их шалгалт туулсан, эсвэл хэр их сахилгажсан тухай байх албагүй юм. Харин ч энэ нь зүрх сэтгэлдээ Бурханд хандах хандлагаас чинь болон ямар мөн чанарыг илэрхийлдгээс чинь хамаардаг. Хүмүүсийн мөн чанар болон тэдний субьектив хандлага маш чухал, гол түлхүүр нь юм. Бурханаас татгалзаж, орхиж явсан хүмүүсийн тухайд гэвэл, Түүнд хандах тэдний жигшмээр хандлага, үнэнийг үзэн яддаг зүрх сэтгэл нь хэдийнээ Түүний зан чанарыг уурлуулсан учраас Түүний хувьд тэд хэзээ ч уучлагдахгүй. Тэд Бурханы оршин тогтнолын тухай мэддэг, Тэр аль хэдийн ирчихсэн гэдэг мэдээлэл тэдэнд байсан, бүр Бурханы шинэ ажлыг ч туулсан. Тэдний явсан нь төөрөгдөлд орсон эсвэл мунгинасан хэрэг биш, тэднийг албадсан хэрэг бүр ч биш. Харин ч тэд ухамсартайгаар, саруул ухаанаар Бурханыг орхиж явахыг сонгосон. Тэдний явсан нь замаа алдсан явдал биш, тэд хаягдсан хэрэг ч бас биш. Тиймээс Бурханы нүдэнд тэд бол замаа алдсан үрэлгэн хүү байх нь байтугай, сүргээсээ төөрсөн хурга ч биш юм. Тэд аймшиггүйгээр явсан бөгөөд ийм нөхцөл, ийм байдал нь Бурханы зан чанарыг хилэгнүүлдэг бөгөөд ийнхүү хилэгнэсэн учраас Тэр тэдэнд горь тасрам төгсгөл өгдөг. Ийм төгсгөл аймшигтай бус уу? Иймээс, хэрвээ хүмүүс Бурханыг мэддэггүй бол Бурханд халдаж болно. Энэ бол жижиг асуудал биш! Хэрвээ хүмүүс Бурханы хандлагыг нухацтай авч үздэггүй, мөн тэд бол Бурханы зарим төөрсөн хурганууд бөгөөд зүрх сэтгэлээ өөрчлөхийг нь Бурхан хүлээсээр байгаа учраас буцаж ирэхийг нь Бурхан тэсэн ядан хүлээж байгаа гэж итгэсээр байдаг бол тэд шийтгэгдэх өдрөөсөө тийм ч холгүй байна. Бурхан тэднийг хүлээж авахаас зүгээр ч нэг татгалзахгүй. Тэд Түүний зан чанарыг хоёр дахь удаагаа хилэгнүүлж байгаа тул хэрэг явдал бүр ч илүү аймшигтай! Энэ хүмүүсийн хүндэтгэлгүй хандлага Бурханы захиргааны зарлигийг хэдийнээ зөрчсөн байдаг. Тэр тэднийг одоо ч хүлээж авах уу? Энэ асуудлын талаарх Түүний зүрх сэтгэл дэх зарчим бол, хүн үнэн замын тодорхой мэдлэгийг олж авсныхаа дараа ч ухамсартайгаар, саруул ухаанаар Бурханыг голж, Бурханаас явж чадаж л байвал Бурхан тийм хүний аврал хүрэх замыг нь хааж, хойшид энэ хүний хаанчлалд орох хаалга нь хаагдана. Энэ хүн дахин нэг ирж хаалга тогшиход Бурхан хаалгаа нээж өгөхгүй; энэ хүн үүрд хаалганы цаана үлдэнэ. Магадгүй та нарын зарим нь Библи дэх Мосегийн түүхийг уншсан байх. Бурхан Мосег мялаасны дараа 250 удирдагч Мосегийн үйлдэл болон өөр янз бүрийн шалтгааны улмаас дуулгаваргүй байдлаа

түүнд илэрхийлсэн. Тэд хэнд захирагдахаас татгалзсан бэ? Энэ нь Мосе байгаагүй. Тэд Бурханы зохицуулалтад захирагдахаас татгалзсан; тэд энэ асуудал дээр Бурханы ажилд захирагдахаас татгалзсан. Тэд дараах зүйлийг хэлсэн: “Та нар арай дэндэж байна. Чуулсан олон түмэн, хүн бүр нь ариун бөгөөд Ехова тэдний дунд байна.” Хүний үзэл бодлоор бол эдгээр үг, мөр маш ноцтой юу? Тэдгээр нь ноцтой биш. Ядаж л эдгээр үгийн үгчилсэн утга нь ноцтой биш. Хуулийн үүднээс тэд ямар ч хууль зөрчөөгүй, учир нь, энэ нь гадна өнгөндөө дайсагнасан үг хэлтэй биш, доромжилсон өнгө аяс бүр ч байхгүй. Эдгээр нь жирийн л өгүүлбэр, өөр юу ч биш. Тэгвэл яагаад эдгээр үг Бурханы уур хилэнг тэгж их өдөөж чаддаг вэ? Яагаад гэвэл, тэдгээрийг хүмүүст биш, харин Бурханд хэлсэн юм. Тэдний илэрхийлсэн хандлага, зан чанар нь Бурханы зан чанарыг хилэгнүүлдэг яг тэр зүйл бөгөөд тэд Бурханы халдаж болохгүй зан чанарт халддаг. Тэдгээр удирдагчийн төгсгөл эцэстээ ямар байсныг бид бүгд мэднэ. Бурханыг хаясан хүмүүсийн тухайд тэд ямар үзэл бодолтой вэ? Тэдний хандлага ямар вэ? Мөн яагаад тэдний үзэл бодол, хандлага нь Бурхан тэдэнтэй ингэж харьцахад хүргэдэг вэ? Үүний шалтгаан нь, Түүнийг Бурхан гэдгийг тэд сайн мэдэж байсан ч гэсэн Түүнээс урвах замыг сонгосон, тийм учраас тэд аврагдах боломжоо бүрэн алдсан. Библид: “Учир нь үнэний мэдлэгийг хүлээн авсныхаа дараа хэрвээ бид санаатайгаар нүгэл үйлдвэл нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй” (Еврей 10:26) гэж хэлсэнтэй яг адилхан. Та нар одоо энэ асуудлын талаар тодорхой ойлгосон уу?

Хүмүүсийн хувь заяаг Бурханд хандах хандлагаар нь шийддэг

Бурхан бол амьд Бурхан бөгөөд хүмүүс өөр өөр нөхцөл байдалд өөр өөрөөр авирладагтай яг л адил эдгээр авирт хандах Түүний хандлага өөр өөр байдаг, учир нь Тэр хүүхэлдэй биш, хоосон агаар ч биш. Хүн төрөлхтөн Бурханы хандлагыг мэдэж авахаар эрэлхийлбэл зохино. Хүмүүс Бурханы хандлагыг мэдсэнээрээ Бурханы зан чанарыг хэрхэн бага багаар мэдэж, Түүний зүрх сэтгэлийг ойлгож авч болохыг сурах ёстой. Бурханы зүрх сэтгэлийг бага багаар ойлгоод ирэхийн цагт Бурханаас эмээж, муугаас зайлах нь биелүүлэхэд тийм ч хэцүү зүйл гэж чамд санагдахгүй. Түүнчлэн, чи Бурханыг ойлгох үед Түүний талаар дүгнэлт хийх магадлал бага болно. Чи Бурханы талаар дүгнэлт хийхээ боливол Бурханд халдах магадлал бүр л бага болж, чамайг мэдээгүй байхад Бурхан чамайг Өөрийнх нь талаар мэдлэг олж авахад хөтөлнө; энэ нь зүрх сэтгэлийг чинь Бурханыг хүндлэх сэтгэлээр дүүргэнэ. Тэгээд чи өөрийн эзэмшсэн хоосон сургаал, үсэг, онолын аргаар Бурханыг тодорхойлохоо болино. Харин ч бүх зүйлээс үргэлж Бурханы санаа зорилгыг эрж хайснаар, чи өөрийн мэдэлгүй Бурханы зүрх сэтгэлийн дагуу хүн болно.

Бурханы ажил нь хүмүүст харагддаггүй, хүршгүй боловч Бурханы хувьд, хүн болгоны үйлдлийг, Өөрт нь хандах тэдний хандлагын хамт Тэр ойлгодог төдийгүй, бас Өөрт нь илэрхий байдаг. Үүнийг хүн бүр танин мэдэж, тодорхой ойлгосон байх

ёстой. Чи өөрөөсөө үргэлж “Миний энд хийж байгааг зүйлийг Бурхан мэддэг болов уу? Яг одоо миний юу бодож байгааг Тэр мэддэг болов уу? Тэр мэддэг ч байж магадгүй, мэддэггүй ч байж магадгүй” хэмээн асууж байж магад. Хэрвээ чи ийм үзэл бодолтой байж, Бурханыг дагаж, Түүнд итгэдэг боловч, Түүний ажил, Түүний оршин тогтнолд эргэлзэж байвал эрт орой хэзээ нэгэн цагт чи Түүний уур хилэнг хүргэх өдөр ирнэ, учир нь, чи аль хэдийн аюулт хавцлын ирмэг дээр дэнжгэнэж байна. Бурханд олон жил итгэсэн ч гэсэн Бурханы хүслийг ойлгох нь байтугай үнэн-бодит байдлыг олж аваагүй хүмүүсийг Би харж байсан. Энэ хүмүүс амь болон биеийн хэмжээндээ ямар ч ахиц гаргахгүй, гагцхүү хамгийн өнгөц хоосон сургаалыг баримталж байдаг. Учир нь, энэ хүмүүс Бурханы үг нь өөрөө амь гэж хэзээ ч үзэж байгаагүй, хэзээ ч Түүний оршин тогтнолтой нүүр тулж, хүлээн авч байгаагүй. Бурхан тийм хүмүүсийг хараад баяр хөөрөөр дүүрдэг гэж чи бодож байна уу? Тэд Түүнийг тайтгаруулдаг уу? Тиймээс хүмүүс Бурханд хэрхэн итгэх нь тэдний хувь заяаг шийддэг. Хүмүүс Бурханыг хэрхэн эрж хайж, Түүнд хэрхэн хандах тухайд бол хүмүүсийн хандлага хамгийн чухал юм. Бодлын чинь мухарт эргэлдэж буй хоосон агаар мэт Бурханыг бүү үл тоомсорло; өөрийн итгэдэг Бурханыг үргэлж амьд, жинхэнэ Бурхан гэж бод. Тэр гурав дахь тэнгэрт хийх юмгүй сууж байгаа юм биш. Харин ч Тэр хүн бүрийн зүрх сэтгэл рүү байнга өнгийж, юу хийх гэж байгааг чинь ажиж, жижиг сажиг үг, үйл хэрэг бүрийг чинь харж, хэрхэн авирлаж байгаа, Түүнд хандах хандлага чинь ямар болохыг байнга харж байдаг. Чи өөрийгөө Бурханд өгөх хүсэлтэй ч бай, үгүй ч бай, бүхий л үйлдэл, сэтгэлийн гүн дэх бодол, санаа чинь Бурханы өмнө илхэн, Түүнд харагдаж байдаг. Чиний зан авир, үйл хэрэг, Түүнд хандах чиний хандлагаас шалтгаалж чиний талаарх Түүний санаа бодол, чамд хандах Түүний хандлага байнга өөрчлөгдөж байдаг. Би зарим хүнд бага зэрэг зөвлөгөө өгмөөр байна: Бурхан чамайг ухаангүй хайрлах ёстой юм шиг, чамайг хэзээ ч орхиод явж чадахгүй юм шиг, чамд хандах Түүний хандлага хувиршгүй, хэзээ ч өөрчлөгдөж чадахгүй юм шиг өөрсдийгөө Бурханы гар дээр нялх хүүхэд шиг бүү тавь, мөн мөрөөдөхөө боль гэж Би зөвлөе! Бурхан хүн болгонд зөвт ханддаг, Тэрээр хүмүүсийг байлдан дагуулж, аврах ажилд чин сэтгэлээсээ ханддаг. Энэ бол Түүний удирдлага юм. Тэрээр хүн болгонд нухацтай ханддаг бөгөөд тоглож наадах гэрийн тэжээвэр амьтан шиг үздэггүй. Хүмүүсийг гэх Бурханы хайр бөөцийлж, эрхлүүлэх хайр биш, хүн төрөлхтөнд үзүүлдэг Түүний өршөөл, хүлээцтэй байдал нь ч бас өөгшүүлсэн, зоргоор нь тавьсан биш байдаг. Эсрэгээрээ хүмүүсийг гэх Бурханы хайранд амийг энхрийлж, өрөвдөж, хүндлэх багтдаг; Түүний өршөөл, хүлээцтэй байдал тэдэнд тавьсан Түүний итгэл найдварыг илэрхийлдэг бөгөөд хүн төрөлхтөнд амьд үлдэхэд хэрэгтэй зүйл юм. Бурхан амьд бөгөөд үнэхээр оршин тогтнодог; хүн төрөлхтөнд хандах Түүний хандлага зарчимтайн дээр ягшмал бөөн дүрэм огтхон ч биш, бас энэ нь өөрчлөгдөх боломжтой. Хүн төрөлхтний төлөөх Түүний санаа зорилго цаг хугацааны эрхээр, үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж, хүн нэг бүрийн хандлагатай хамт аажмаар хувьсан, өөрчлөгдөж байдаг. Иймээс

Бурханы мөн чанар хувиршгүй, Түүний зан чанар өөр өөр үед, өөр өөр нөхцөл байдлаас гардаг гэдгийг чи зүрх сэтгэлдээ тов тодорхой мэдэж байх ёстой. Энэ бол ноцтой асуудал гэж чи бодохгүй байж болно, Бурхан юмыг хэрхэн хийх ёстойг төсөөлөхдөө чи үзлээ ашиглаж магадгүй. Гэхдээ үзэл бодлын чинь яг эсрэг нь үнэн байх үе байдаг бөгөөд үзлээ ашиглан Бурханыг хэмжих гэж оролдсоноороо чи Түүнийг хэдийнээ уурлуулсан. Учир нь, Бурхан чиний боддог шиг ажилладаггүй, чиний хэлдэг шигээр энэ асуудалд ханддаггүй. Иймээс чи өөрийн эргэн тойрондоо байгаа юм болгонд хандахдаа болгоомжтой, хянамгай байж, бүх зүйл дээр Бурханы замаар алхах—Бурханаас эмээж, муугаас зайлах зарчмыг дагах талаар суралц гэж Би чамд сануулж байна. Чи Бурханы хүсэл, Бурханы хандлагын асуудал дээр бат ойлголттой болж, энэ талаар чамтай хэлэлцэх гэгээрсэн хүмүүсийг олж, хичээнгүйлэн эрж хайх ёстой. Өөрийн итгэдэг Бурханыг хүүхэлдэй шиг үзэж, дур зоргоороо шүүж, Түүний талаар дурааараа дүгнэлт хийж, Түүнд зохих ёсоор хүндэтгэлтэй хандахгүй байж болохгүй. Бурхан чамайг аварч, төгсгөлийг чинь тодорхойлох зуураа чамд өршөөл, хүлээцтэй байдал, эсвэл шүүлт, гэсгээлт хүртээж магадгүй боловч ямар ч тохиолдолд чамд хандах Түүний хандлага өөрчлөгдөшгүй биш юм. Түүнд хандах чиний хандлагаас гадна Түүний талаарх ойлголтоос чинь энэ нь хамаардаг. Бурханы талаарх түрхэн зуурын өрөөсгөл мэдлэг, ойлголтоороо Түүнийг үүрд мөнхөд тодорхойлж болохгүй. Үхсэн Бурханд бүү итгэ; амьд Бурханд итгэ. Үүнийг санаж яв! Хэдийгээр Би та нарын сонсох хэрэгтэй байсан зарим үнэнийг энд хэлэлцсэн боловч та нарын одоогийн байдал, биеийн хэмжээнээс шалтгаалан урам зоригийг чинь мохоохгүйн тулд одоохондоо та нарт илүү их шаардлага тавихгүй. Тэгэх нь зүрх сэтгэлийг чинь хэтэрхий их уйтгараар дүүргэж, Бурханд дэндүү их урам хугарахад хүргэж болно. Үүний оронд, та нар урдах замаараа алхахдаа зүрх сэтгэлдээ байгаа Бурханыг гэх хайр, Бурханыг хүндэлдэг хандлагаа ашиглаж чадна гэж Би найдаж байна. Бурханд хэрхэн итгэх тухай энэ асуудлыг бүү аргацаа; үүнийг байж болох хамгийн том асуултуудын нэг гэж үз. Үүнийг зүрх сэтгэлдээ тээж, хэрэгжүүлж, бодит амьдралтай холбо; зүгээр нэг бүү дүр үзүүл. Учир нь, энэ бол амьдрал, үхлийн асуудал, чиний хувь заяаг тодорхойлох асуудал билээ. Үүнд тоглоом, наргиан шиг бүү ханд! Өнөөдөр та нартай эдгээр үгийг хуваалцсаныхаа дараа та нар толгойдоо хэчнээн их зүйлийг нь ойлгож авсан бол гэж Би гайхаж байна. Өнөөдөр энд Миний ярьсан зүйлийн талаар асуух асуулт та нарт байна уу?

Хэдий эдгээр сэдэв нь бага зэрэг шинэ, та нарын үзэл бодол, ер нь та нарын эрэлхийлж, анхаардаг зүйлсээс бага зэрэг холдсон боловч эдгээрийг та нар хэсэг хугацаанд нөхөрлөвөл Миний энд хэлсэн бүхний талаар та нар нийтлэг ойлголттой болно. Эдгээр сэдэв нь бүгд маш шинэ, та нарын урьд өмнө хэзээ ч эргэцүүлж үзэж байгаагүй сэдвүүд болохоор ямар нэгэн байдлаар та нарын ачааг нэмэхгүй гэж Би найдаж байна. Би өнөөдөр эдгээр үгийг та нарыг айлгахын тулд хэлж байгаа юм биш, бас тэдгээрийг Би та нартай харьцах арга зам болгож ашиглаж байгаа ч юм

биш; харин ч Миний зорилго бол бодит үнэний тухай бодит баримтыг ойлгоход та нарт туслах явдал юм. Хүн, Бурханы хоёр хоорондоо ялгаатай учраас хэдийгээр хүмүүс Бурханд итгэдэг ч гэсэн Түүнийг хэзээ ч ойлгож, хандлагыг нь мэдэж байгаагүй. Түүнчлэн хүмүүс Бурханы хандлагад санаа тавихдаа хэзээ ч нэг их урам зоригтой байгаагүй. Харин ч тэд сохроор итгэж, явсан бөгөөд Бурханы талаарх мэдлэг, ойлголтдоо хайхрамжгүй байж ирсэн. Тиймээс Би эдгээр асуудлыг та нарт ойлгомжтой болгож, та нарын итгэдэг энэ Бурхан чинь чухам ямар төрлийн Бурхан бэ, мөн Тэр юу бодож байгаа, янз бүрийн хүмүүст хандахдаа Түүний хандлага ямар байдаг, та нар Түүний шаардлагыг биелүүлэхээс хэр хол байгаа, та нарын үйлдэл болон Түүний шаарддаг стандарт хоёрын хоорондох зөрүү хэр их байгааг ойлгоход та нарт туслахыг хичээж байна. Ийм зүйлсийг та нарт мэдүүлэх нь та нарт өөрсдийгөө хэмжих хэмжүүр өгөх зорилготой бөгөөд ингэснээр явж байгаа зам чинь ямар үр дүн рүү хөтөлж байгааг, энэ зам дээр юу олж аваагүйг, ямар салбарт огт оролцож байгаагүйгээ та нар мэднэ. Та нар өөр хоорондоо хэлэлцэхдээ цар хүрээний хувьд тун явцуу, өнгөцхөн агуулгатай цөөн хэдэн түгээмэл хэлэлцдэг сэдвийн талаар ихэвчлэн ярьдаг. Та нарын хэлэлцдэг зүйл, Бурханы санаа зорилго хоёрын хооронд, мөн та нарын хэлэлцүүлэг болон Бурханы шаардлагын цар хүрээ, стандартын хооронд зай, завсар байдаг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр ийнхүү үргэлжлүүлэх нь та нарыг Бурханы замаас улам л хол хазайхад хүргэнэ. Та нар ердөө л Бурханы одоогийн айлдварыг авч, шүтэн мөргөх объект болгож, тэдгээрийг зан үйл, дүрэм журам гэж хардаг. Та нар үүнийг л хийж байгаа! Үнэндээ, та нарын зүрх сэтгэлд Бурханы орон зай байхгүй, Тэр та нарын зүрх сэтгэлийг үнэндээ хэзээ ч олж аваагүй. Бурханыг мэдэх маш хэцүү гэж зарим хүн боддог—энэ үнэн. Энэ хэцүү. Хэрвээ хүмүүсээс үүргээ биелүүлж, гаднаа аливаа зүйлсийг хийж, шаргуу ажилла гэвэл Бурханд итгэх маш амархан юм байна гэж тэд бодно, учир нь энэ бүхэн хүний хийж чадах хэмжээнд байдаг. Гэхдээ сэдэв нь Бурханы санаа зорилго болон хүнд хандах Түүний хандлага руу шилжих мөчид хүн болгоны бодлоор юм үнэхээр арай илүү хэцүү болдог. Яагаад гэвэл, үүнд үнэний тухай хүмүүсийн ойлголт, тэдний бодит байдлын оролт хамаардаг, тэгэхээр мэдээж, тодорхой хэмжээгээр хүндрэлтэй байна! Гэсэн ч эхний хаалгаар нэвтэрч, оролтыг олж авч эхэлсний чинь дараа юм аажмаар улам бүр хялбар болдог.

Бурханаас эмээж эхлэх цэг нь Түүнд Бурхан шиг хандах юм

Нэг хүн саяхан нэг асуулт дэвшүүлсэн байна: Бид Бурханыг Иовын мэдэж байснаас илүү сайн мэддэг мөртөө Түүнийг яагаад яагаад хүндэлж чаддаггүй юм бэ? Бид энэ асуудлыг өмнө нь бага зэрэг хөндсөн. Үнэндээ, энэ асуудлын мөн чанарыг ч бас өмнө нь хэлэлцсэн, Иов тухайн үед Бурханыг мэддэггүй байсан ч гэсэн Түүнд Бурхан шиг хандаж, Түүнийг тэнгэр, газар, бүх зүйлийн Эзэн гэж үздэг байсан. Иов Бурханыг дайснаа гэж үзээгүй; харин Түүнийг бүх зүйлийг Бүтээгч хэмээн шүтэн мөргөдөг байсан. Өнөө үед хүмүүс яагаад Бурханыг ийм их

эсэргүүцдэг вэ? Тэд яагаад Бурханыг хүндэлж чаддаггүй вэ? Нэг шалтгаан нь тэд Сатанаар гүн завхруулагдсан бөгөөд сатанлаг уг чанар тэдэнд гүн шингэсэн болохоор тэд Бурханы дайсан болсон юм. Тиймээс тэд хэдийгээр Бурханд итгэж, Бурханыг хүлээн зөвшөөрдөг боловч Түүнийг эсэргүүцэж, өөрсдийгөө Түүний эсрэг тавьж чадсан хэвээр байдаг. Хүний уг чанар үүнийг тодорхойлдог. Нөгөө нэг шалтгаан нь хүмүүс Бурханд итгэдэг ч гэсэн ердөө л Түүнд Бурхан шиг ханддаггүй. Харин ч Түүнийг өөрсдийн дайсан гэж үзээд хүн төрөлхтний эсрэг тавьж, Бурхантай эвлэршгүй гэж санагддаг. Ийм л энгийн юм. Энэ асуудал өмнөх хэлэлцүүлэгт хөндөгдсөн бус уу? Үүнийг бодоод үз: Энэ шалтгаан нь бус уу? Бурханы талаар бага зэрэг мэдлэг чамд байдаг боловч энэ мэдлэг чинь яг юунд хүргэх вэ? Хүн бүрийн яриад байгаа зүйл энэ бус уу? Бурханы чамд хэлсэн зүйл энэ бус уу? Чи үүний онолын болон сургаалын талыг нь л мэддэг, гэвч чи Бурханы жинхэнэ царайг ойлгож байсан уу? Чамд субьектив мэдлэг бий юу? Чамд бодитой мэдлэг, туршлага бий юу? Бурхан чамд хэлээгүй бол чи мэдэж чадах байсан уу? Онолын мэдлэг чинь жинхэнэ мэдлэгийг төлөөлдөггүй. Товчхондоо, хэр их мэддэг, үүнийг хэрхэн мэдэж авсан чинь хамаагүй, Бурханы талаар жинхэнэ ойлголт олж авах хүртэл Тэр чиний дайсан байна, Бурханд үнэхээр Бурхан шиг хандах хүртэл Тэр чамайг эсэргүүцнэ, учир нь чи бол Сатаны биелэл билээ.

Чи Христтэй хамт байхдаа магадгүй чи Түүнд өдрийн гурван хоолоор үйлчилж, цайгаар үйлчилж, Түүний амьдралын хэрэгцээнд санаа тавьж чадах байх; чи Христэд Бурхан шиг хандаж байгаа юм шиг байна. Ямар нэг зүйл тохиолдох бүрд хүмүүсийн үзэл бодол үргэлж Бурханы үзэл бодлын эсрэг байдаг; хүмүүс үргэлж Бурханы үзэл бодлыг ойлгож, хүлээн зөвшөөрч чаддаггүй. Хүмүүс өнгөн дээрээ Бурхантай сайн харилцаатай байдаг хэдий ч энэ нь тэд Түүнтэй нийцтэй байдаг гэсэн үг биш. Ямар нэгэн зүйл тохиолдмогц хүн төрөлхтний дуулгаваргүй байдлын үнэн төрх ил гарч, ингэснээр хүн болон Бурханы хооронд оршдог дайсагналыг баталдаг. Энэхүү дайсагнал нь Бурхан хүнийг эсэргүүцэж, хүнд дайсагнахыг хүсэж байгаа хэрэг биш, мөн Тэр тэднийг Өөрийнхөө эсрэг тавьж, тэдэнд тэгж хандаж байгаа хэрэг ч бас биш юм. Харин ч Бурханы эсрэг энэхүү мөн чанар нь хүний субьектив хүсэлд, хүний далд ухамсарт нуугдаж байгаа хэрэг юм. Хүмүүс Бурханаас ирдэг бүхнийг өөрсдийн судалгааны объект гэж үздэг болохоор Бурханаас ирдэг зүйлд, Бурхантай хамаатай зүйлд хандах хариу үйлдэл нь юун түрүүнд таамаглаж, эргэлзэн, дараа нь Бурхантай зөрчилдөж, Түүнийг эсэргүүцсэн хандлага сонгох байдаг. Үүний дараа удалгүй тэд сөрөг ааш авир тээн Бурхантай маргалдаж, тэмцэлдэхэд хүрч, бүр ийм Бурханыг дагавал зохих эсэх талаар эргэлзэх хүртлээ дэнддэг. Эрүүл ухаан нь тэдэнд ийм байдлаар үргэлжлүүлж болохгүй гэдгийг хэлдэг боловч тэд өөрийн эрхгүй ингэхээр сонгож, эцсээ хүртэл ямар ч эргэлзээгүйгээр үргэлжлүүлэх болно. Жишээлбэл, Бурханы тухай цуу яриа, гүтгэлэг сонсоод зарим хүний эхний хариу үйлдэл ямар байдаг вэ? Тэдний хамгийн түрүүнд үзүүлдэг хариу үйлдэл нь энэ цуу яриа үнэн, худал эсэх, ийм цуур яриа

байдаг эсэх талаар гайхширч, тэгээд харзнах хандлага сонгох байдаг. Тэгээд тэд “Үүнийг магадлах арга алга. Үнэхээр ийм явдал болсон болов уу? Энэ үнэн болов уу, үгүй болов уу?” хэмээн бодож эхэлдэг. Хэдийгээр ийм хүмүүс өнгөн дээрээ харуулдаггүй ч гэсэн зүрх сэтгэлдээ аль хэдийн эргэлзэж, Бурханыг аль хэдийн үгүйсгээд эхэлсэн байдаг. Ийм хандлага, ийм үзэл бодлын мөн чанар нь юу вэ? Энэ нь урвалт бус уу? Тэдэнд ийм асуудал тулгарах хүртэл энэ хүмүүсийн үзэл бодол юу болохыг чи харж чадахгүй; тэд Бурхантай зөрчилддөггүй, Түүнийг дайсан гэж үздэггүй мэт харагддаг. Гэвч асуудал тулгармагц тэд даруй Сатантай хамт зогсож, Бурханыг эсэргүүцдэг. Энэ нь юуг харуулж байна вэ? Энэ нь хүн, Бурхан хоёр бол эсрэг тэсрэг гэдгийг харуулж байна! Бурхан хүн төрөлхтнийг дайснаа гэж үздэг биш, харин хүн төрөлхтний мөн чанар өөрөө Бурханд дайсагнаж байдгаас тэр юм. Хүн Бурханыг хэчнээн удаан дагаж, хэр их төлөөс төлсөн нь хамаагүй, хүн Түүнийг хэрхэн магтаж, Түүнийг хэрхэн эсэргүүцэхээс тэвчиж, бүр Бурханыг хайрлах гэж хэчнээн өөрсдийгөө хүчилдэг ч бай, тэд Бурханд хэзээ ч Бурхан шиг хандаж чадахгүй. Үүнийг хүмүүсийн мөн чанар тодорхойлдог бус уу? Хэрвээ чи Түүнд Бурхан шиг хандаж, Тэр бол Бурхан гэж жинхэнээсээ итгэдэг бол Түүнд эргэлзэж чадна гэж үү? Чи зүрх сэтгэлдээ Түүний тухай ямар нэгэн асуултын тэмдэг тээсээр байж чадна гэж үү? Чадахгүй, тийм үү? Энэ хорвоогийн чиг хандлага маш ёрын муу, энэ хүн төрөлхтөн ч мөн адил; тиймээс чамд яахаараа тэдгээрийн талаар ямар ч үзэл байхгүй байж болох юм бэ? Чи өөрөө тун хорон муу, тиймээс яахаараа чи тэр талаар ямар ч үзэлгүй байдаг юм бэ? Гэтэл хэдхэн цуу яриа, зарим нэг гүтгэлэг л Бурханы тухай тийм том үзлийг бий болгож, маш олон зүйлийг төсөөлөхөд хүргэж чадаж байгаа нь биеийн хэмжээ чинь хэчнээн дутуу дулимаг болохыг харуулж байна! Ердөө л хэдхэн шумуул, хэдхэн балиар ялааны “шунгинаан” чамайг мэхлэхэд хангалттай гэж үү? Энэ ямар гээч хүн бэ? Бурхан ийм хүмүүсийн талаар юу боддогийг чи мэдэх үү? Тэдэнд хандах Бурханы хандлага үнэндээ маш тодорхой. Ийм хүмүүст хандах Бурханы хандлага нь тэдэнд хүйтэн хөндий хандах—тэдэнд ямар ч анхаарал тавихгүй, энэхүү харанхуй бүдүүлэг хүмүүсийг нухацтай авч үзэхгүй байх нь Түүний хандлага юм. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, Түүнд эцсээ хүртэл дайсагнахаар амлалт өгсөн, Түүнтэй нийцтэй байх замыг эрж хайхаар хэзээ ч төлөвлөөгүй тэр хүмүүсийг олж авна гэж Бурхан зүрх сэтгэлдээ хэзээ ч төлөвлөөгүй билээ. Миний хэлсэн эдгээр үг хэдэн хүнийг гомдоож магадгүй юм. Тэгвэл та нарыг үргэлж ингэж гомдоохыг минь та нар хүсэж байна уу? Та нар хүссэн, хүсээгүй, Миний хэлж байгаа бүхэн бодит үнэн! Хэрвээ Би та нарыг үргэлж ингэж гомдоож, шархыг чинь ил болговол зүрх сэтгэлдээ тээдэг та нарын эрхэм дээд Бурханы дүр төрхөд нөлөөлөх үү? (Нөлөөлөхгүй.) Тэгэхгүй гэдэгтэй Би санал нийлж байна, учир нь, та нарын зүрх сэтгэлд Бурхан огт байхгүй. Та нарын зүрх сэтгэлд оршдог, та нарын жигтэйхэн өмгөөлж, хамгаалдаг Бурхан бол ердөө л Бурхан биш. Харин хүний төсөөллөөс гарсан зүйл; тэр ердөө оршдоггүй. Иймээс энэ оньсогын хариуг Би ил болгох нь хамаагүй илүү дээр; энэ

нь бодит үнэнийг ил болгож байгаа хэрэг бус уу? Жинхэнэ Бурхан бол хүний төсөөлдөг тэр зүйл биш. Та бүхэн энэ бодит байдалтай нүүр тулж чадахын дээр энэ нь Бурханы талаарх мэдлэгт чинь тус болно гэж Би найдаж байна.

Бурханы хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс

Бурхан итгэлийг нь зүрх сэтгэлдээ хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй зарим хүн байдаг. Өөрөөр хэлбэл, Бурхан итгэлийг нь сайшаадаггүй учраас энэ хүмүүсийг Өөрийнхөө дагалдагч гэж хүлээн зөвшөөрдөггүй. Энэ хүмүүсийн хувьд, Бурханыг хэчнээн жил дагасан ч гэсэн, тэдний санаа, үзэл бодол хэзээ ч өөрчлөгдөөгүй; тэд шүтлэггүй хүмүүс шиг шүтлэггүй хүмүүсийн бусад хүмүүстэй харилцах зарчим, арга барил, тэдний амьд үлдэх хууль болон итгэлийг баримталдаг. Тэд хэзээ ч Бурханы үгийг хүлээн авч амиа болгодоггүй, Бурханы үг бол үнэн гэж хэзээ ч итгээгүй, хэзээ ч Бурханы авралыг хүлээн авах гэж зориогүй, Бурханыг хэзээ ч өөрсдийн Бурхан гэж хүлээн зөвшөөрөөгүй. Тэд Бурханд итгэхийг нэг төрлийн сонирхогчдын хобби хэмээн харж, ердөө л сүнслэг тэжээл мэт Түүнд ханддаг болохоор Бурханы зан чанар, эсвэл мөн чанарыг ойлгох гэж хичээвэл зохилтой гэж боддоггүй. Жинхэнэ Бурхантай холбоотой бүхэн энэ хүмүүст ямар ч хамаагүй гэж хэлж болно; тэд сонирхдоггүй, анхаарал тавья гэж боддог ч үгүй. Учир нь, зүрх сэтгэлийнх нь гүнд тэдэнд “Бурхан бол харагддаггүй, хүршгүй бөгөөд оршдоггүй” гэж үргэлж хэлж байдаг хүчтэй дуу хоолой байдаг. Ийм Бурханыг ойлгохыг хичээж хүчин чармайлт гаргах хэрэггүй, ингэх нь өөрсдийгөө хуурсан хэрэг болно гэж тэд итгэдэг. Ямар ч бодитой үзэл бодол баримталж, аливаа бодит үйлдэлд өөрсдийгөө зориулахгүйгээр, ердөө л үгээр Бурханыг хүлээн зөвшөөрснөөрөө өөрсдийгөө сүрхий ухаалаг байна гэж тэд итгэдэг. Бурхан энэ хүмүүсийг юу гэж хардаг вэ? Тэр тэднийг үл итгэгчид гэж хардаг. Зарим хүн “Үл итгэгчид Бурханы үгийг уншиж чадах уу? Тэд өөрсдийн үүргийг биелүүлж чадах уу? ‘Би Бурханы төлөө амьдарна’ гэдэг үгийг хэлж чадах уу?” гэж асуудаг. Тэдний өнгөн дээрээ үзүүлдэг зүйлийг хүмүүс дандаа хардаг; тэд хүмүүсийн мөн чанарыг хардаггүй. Гэтэл Бурхан эдгээр өнгөн талын үзүүлэх байдлыг хардаггүй; Тэр зөвхөн дотоод мөн чанарыг нь л хардаг. Тиймээс энэ хүмүүст Бурхан ингэж хандаж, ингэж тодорхойлдог. Энэ хүмүүс “Бурхан яагаад ингэдэг вэ? Бурхан яагаад тэгдэг вэ? Би энийг ойлгож чадахгүй байна; би тэрийг ойлгож чадахгүй байна; энэ хүний үзэлтэй нийцэхгүй байна; Та надад үүнийг тайлбарлах ёстой …” гэж хэлдэг. Үүний хариуд Би ингэж асуудаг: Эдгээр асуудлыг Би үнэхээр чамд тайлбарлах шаардлагатай юу? Эдгээр асуудал үнэндээ чамд хамаатай юу? Чи өөрийгөө хэн гэж бодоо вэ? Чи хаанаас ирсэн юм бэ? Чи үнэхээр Бурханд заах шаардлага хангасан уу? Чи Түүнд итгэдэг үү? Тэр чиний итгэлийг хүлээн зөвшөөрдөг үү? Нэгэнт чиний итгэл Бурхантай ямар ч хамаагүйгээс хойш, Түүний хийж буй зүйл чамд ямар хамаатай юм бэ? Чи Бурханы зүрх сэтгэлд хаана нь зогсож байгаагаа мэдэхгүй учраас Бурхантай ярилцах шаардлага хангасан байж чи яаж чадах юм бэ?

Сануулах үгс

Эдгээр сургамжийг сонсоод та нарт таагүй байгаа бус уу? Хэдийгээр та нар эдгээрийг сонсох, хүлээн зөвшөөрөх хүсэлгүй байж болох ч тэдгээр нь бүгд бодит баримт юм. Ажлын энэ үе шатыг Бурхан гүйцэтгэх учраас хэрвээ чи Түүний санаа зорилгод сэтгэл тавьдаггүй, Түүний хандлагыг хайхардаггүй, Түүний мөн чанар, зан чанарыг ойлгодоггүй бол эцэст нь хохирох хүн бол чи байна. Миний үгийг сонсоход хэцүү байна, мөн урам зоригийг чинь хугалсан гэж бүү буруушаа. Би үнэнийг ярьдаг; Би та нарын урмыг хугалах гээгүй юм шүү. Би та нараас юу шаардах, үүнийг та нар хэрхэн хийх шаардлагатай нь хамаагүй, та нар зөв замаар алхаж, Бурханы замыг дагаж, зөв замаас хазайхгүй гэж найдаж байна. Хэрвээ чи Бурханы үгийн дагуу хийхгүй, Түүний замыг дагахгүй бол Бурханы эсрэг тэрсэлж, зөв замаас төөрсөн гэдэгт чинь эргэлзэхгүй байж болно. Тиймээс та нарт тодруулж өгөх ёстой зарим асуудал байгаа бөгөөд та нарыг ойлгомжтой, тодорхой, өчүүхэн төдий ч тээнэгэлзэхгүйгээр итгэдэг болгож, Бурханы хандлага, Түүний санаа зорилго, Тэр хүнийг хэрхэн төгс болгож, хүний төгсгөлийг ямар арга замаар тодорхойлдог талаар тодорхой ойлголттой болоход чинь туслах ёстой гэж Надад санагддаг. Хэрвээ чи энэ зам дээр гарч чадахгүй байх өдөр ирвэл Би ямар ч хариуцлага үүрэхгүй, учир нь эдгээр үгийг чамд аль хэдийн маш тодорхой хэлчихсэн. Өөрийнхөө төгсгөлийг чи хэрхэн зохицуулах тухайд, энэ асуудал нь бүхэлдээ чамаас хамаарна. Янз бүрийн хүмүүсийн төгсгөлийн тухайд Бурхан өөр өөр хандлагатай байдаг, Түүнд тэдгээрийг дэнслэх Өөрийн гэсэн арга замаас гадна тэдэнд зориулсан Өөрийн гэсэн шаардлагын стандарт байдаг. Хүмүүсийн төгсгөлийг дэнслэх Түүний стандарт нь бүх хүнд шударга байдаг—үүнд эргэлзэх юмгүй! Тиймээс зарим хүн эмээх шаардлагагүй юм. Одоо та нарын сэтгэл амрав уу? Өнөөдрийн хувьд ингээд дууслаа. Баяртай!

2013 оны 10 дугаар сарын 17

БУРХАНЫ АЖИЛ, БУРХАНЫ ЗАН ЧАНАР БА БУРХАН ӨӨРӨӨ I

Өнөөдөр бид нэг чухал сэдвийг нөхөрлөх гэж байна. Энэ нь Бурханы ажил эхэлснээс хойш одоо хүртэл хэлэлцэж байгаа сэдэв бөгөөд хүн нэг бүрд тун чухал юм. Өөрөөр хэлбэл, энэ нь хүн бүрийн Бурханд итгэх итгэлийн явцад тааралдах асуудал; энэ бол тааралдах ёстой асуудал юм. Энэ бол хүн төрөлхтөн холдож эс чадах чухал, зайлшгүй асуудал мөн. Чухал гэснээс, Бурханд итгэгч хүн бүрийн хувьд хамгийн чухал зүйл юу вэ? Зарим хүн хамгийн чухал зүйл бол Бурханы хүслийг ойлгох гэж боддог; зарим нь Бурханы үгээс улам их идэж уух нь хамгийн чухал гэж итгэдэг; зарим нь хамгийн чухал зүйл бол өөрсдийгөө мэдэх гэж боддог; бусад нь хамгийн чухал зүйл бол Бурханаар дамжуулан яаж аврал олохыг, Бурханыг хэрхэн дагахыг, Бурханы хүслийг хэрхэн биелүүлэхийг мэдэх явдал гэсэн бодолтой байдаг. Бид өнөөдөртөө энэ бүх сэдвийг хойш тавья. Тэгэхээр бид юуны тухай хэлэлцэх вэ? Сэдэв нь Бурхан Энэ нь хүн бүрд хамгийн чухал сэдэв мөн үү? Бурханы тухай сэдэвт юу багтах вэ? Мэдээж, үүнийг Бурханы зан чанар, Бурханы мөн чанар болон Бурханы ажлаас салгаж болохгүй нь лавтай юм. Иймд өнөөдөр бид “Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханы Өөрийн тухай” ярилцъя.

Хүн Бурханд итгэж эхэлсэн үеэсээ эхлээд Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханы Өөрийнх нь тухай сэдвүүдтэй тааралдсаар ирсэн. Бурханы ажлын тухайд гэвэл, зарим хүн: “Бурханы ажил бидэн дээр хийгддэг; бид үүнийг өдөр бүр туулдаг болохоор бидэнд танил юм” гэж хэлнэ. Бурханы зан чанарын тухайд гэвэл, зарим хүн: “Бурханы зан чанар нь насан туршдаа бидний судалж, шинжилж, анхаардаг сэдэв тул бид мэдэх ёстой л доо” гэж хэлнэ. Бурханы Өөрийнх нь тухайд зарим хүн: “Бурхан Өөрөө бол бидний дагадаг, итгэдэг, эрэлхийлдэг Нэгэн; бид Түүний тухай мэддэггүй ч юм биш” гэж хэлнэ. Бүтээсэн цагаас хойш Бурхан Өөрийн ажлыг хэзээ ч зогсоогоогүй; Өөрийн ажлын турш Тэр Өөрийн зан чанарыг үргэлжлүүлэн илэрхийлж, Өөрийн үгийг илэрхийлэхийн тулд янз бүрийн арга хэрэглэсэн. Үүний зэрэгцээ Тэр хүн төрөлхтөнд Өөрийгөө болон Өөрийн мөн чанарыг илэрхийлэхээ, бас хүн төрөлхтөнд хандсан Өөрийн хүсэл болон тэдэнд тавьсан шаардлагыг илэрхийлэхээ хэзээ ч болиогүй. Иймд шууд утгаараа эдгээр сэдэв нь хэнд ч танил бус биш юм. Гэтэл өнөөдөр Бурханыг дагадаг хүмүүст бол Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурхан Өөрөө үнэндээ огтмэдэхгүй зүйл юм. Яагаад ийм байна вэ? Хүн Бурханы ажлыг туулах үедээ Бурхантай бас холбоотой болдог нь тэдэнд Бурханы зан чанарыг ойлгодог, эсвэл ямар байдаг талаар зарим нэг мэдлэгтэй мэт санагдуулдаг. Ийм болохоор хүн өөрийгөө Бурханы ажил болон Бурханы зан чанарын талаар мэддэггүй гэж боддоггүй. Харин ч өөрийгөө Бурханыг маш сайн мэддэг ба Бурханы тухай ихийг ойлгодог гэж боддог. Гэвч одоогийн байдлаар Бурханы тухай энэ ойлголт нь олон хүний хувьд номоос уншсан зүйлээс нь хэтрээгүй, тэдний хувийн туршлагын цар хүрээнд

боогдсон, төсөөлөлд нь баригдсан бөгөөд юуны өмнө, нүдээрээ харж чадах баримтуудаар хязгаарлагдсан—бүгд жинхэнэ Бурханаас Өөрөөс нь маш хол байдаг. Энэ “хол” гэдэг нь яг хэр хол юм бэ? Хүн өөрөө эргэлзэж байж магадгүй, жаахан мэдрэмж, жаахан таамаглалтай байж магадгүй боловч Бурханы Өөрийн тухайд бол Түүний тухай хүний ойлголт нь жинхэнэ Бурханы Өөрийн мөн чанараас хэтэрхий хол байдаг. Ийм учраас “Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурхан Өөрөө” гэсэн сэдвийг системтэй, тодорхой байдлаар нөхөрлөх нь бидэнд маш чухал юм.

Үнэн хэрэгтээ Бурханы зан чанар хүн бүрд нээлттэй байдаг ба нуугдмал байдаггүй, учир нь Бурхан аливаа хүнээс хэзээ ч санаатайгаар зайлсхийгээгүй ба хүмүүс Өөрийг нь мэдэх, Өөрийг нь ойлгоход саад хийх гэж Өөрийгөө хэзээ ч зориуд нуух гээгүй. Бурханы зан чанар үргэлж нээлттэй байсаар ирсэн бөгөөд хүн тус бүртэй үргэлж илэн далангүй нүүр тулдаг. Бурханы удирдлагад Бурхан хүн бүхэнтэй нүүр тулан Өөрийн ажлыг хийдэг бөгөөд Түүний ажил хүн нэг бүр дээр хийгддэг. Тэрээр энэ ажлыг хийхдээ зан чанараа тасралтгүй илэрхийлж, хүн нэг бүрийг удирдан чиглүүлж, хангахын тулд Өөрийн мөн чанарыг болон Түүнд юу байгаа, Тэр юу болохоо тасралтгүй ашиглаж байна. Эрин үе болгонд, үе шат бүрд нөхцөл байдал сайн эсвэл, муу байгааг үл харгалзан Түүний амь хүнийг байнга, зогсолтгүйгээр хангаж, дэмжиж байдгийн адил Бурханы зан чанар хувь хүн бүрд үргэлж нээлттэй байдаг бөгөөд Түүний эзэмшил болон оршихуй нь хувь хүн бүрд үргэлж нээлттэй байдаг. Гэхдээ зарим хүний хувьд Бурханы зан чанар далд хэвээр үлддэг. Яагаад? Учир нь, энэ хүмүүс Бурханы ажил дотор амьдарч, Бурханыг дагадаг атлаа Бурханд ойртох гэх нь байтугай Бурханыг ойлгох гэж хэзээ ч оролдоогүй, Бурханыг мэдэхийг ч хүсээгүй. Энэ хүмүүсийн хувьд Бурханы зан чанарыг ойлгоно гэдэг нь тэдний төгсгөл ойртсоныг ёрлодог; тэд Бурханы зан чанараар шүүгдэж, яллагдах гэж байна гэсэн үг юм. Ийм учраас тэд Бурханыг болон Түүний зан чанарыг ойлгохыг хэзээ ч хүсээгүй, Бурханы хүслийг илүү гүнзгий ойлгож, мэдэх гэж ер шимтээгүй. Тэд ухамсартай хамтын ажиллагаагаар Бурханы хүслийг ойлгох гэж эрэлхийлдэггүй—тэд зөвхөн хүссэн юмаа цуцалтгүй хийж, түүндээ үүрд сэтгэл хангалуун байдаг; итгэхийг хүсдэг Бурхандаа л итгэдэг; зөвхөн өөрсдийнх нь төсөөлөлд оршдог Бурханд, зөвхөн өөрсдийнх нь үзэлд оршдог Бурханд итгэдэг; мөн өдөр тутмынх нь амьдралд өөрсдөөс нь салшгүй нэгэн Бурханд итгэдэг. Үнэн Бурханы Өөрийн тухайд болохоор тэд огт тоосон шинжгүй байдаг бөгөөд Түүнийг ойлгох, Түүнд анхаарал хандуулах байтугай Түүнд улам ойртох хүсэл тэдэнд бүр ч хомсхон байдаг. Тэд Бурханы илэрхийлдэг үгийг зөвхөн өөрсдийгөө гоёж, сайхан харагдуулахын тулд л ашигладаг. Энэ нь тэднийг аль хэдийн амжилттай итгэгчид, Бурханд зүрх сэтгэл дотроо итгэдэг хүмүүс болгосон гэж тэд боддог. Тэд зүрх сэтгэлдээ өөрсдийн төсөөлөл, өөрсдийн үзэл болон Бурханы тухай өөрсдийн хувийн тодорхойлолтод хүртэл хөтлөгддөг. Нөгөө талаас бол, үнэн Бурханд Өөрт нь тэд огт хамаагүй байдаг. Учир нь, тэд үнэн Бурханыг

Өөрийг нь ойлгож, Бурханы жинхэнэ зан чанарыг ойлгон, Бурханд юу байгаа болон Бурхан юу болохыг ойлгосон цагт тэдний үйлдэл, тэдний итгэл, тэдний эрэл хайгуул яллагдана гэсэн үг юм. Ийм учраас тэд Бурханы мөн чанарыг ойлгох дургүй, Бурханыг илүү сайн ойлгох, Бурханы хүслийг илүү сайн мэдэх, Бурханы зан чанарыг илүү сайн ойлгохын тулд идэвхтэйгээр эрж хайх, залбирах дургүй, хүсэлгүй байдаг. Тэд Бурханыг зохиомол, хоосон хөндий, тодорхойгүй зүйл байгаасай гэж хүсдэг. Тэд Бурханыг яг л өөрсдийнх нь төсөөлсөнтэй адилхан нэгэн, далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гардаг нэгэн, дуусашгүй нөөцтэй, үргэлж бэлэн байдаг нэгэн байхыг хүсдэг. Тэдэнд Бурханы нигүүлсэл хэрэгтэй болоход тэрхүү нигүүлсэл нь байгаач гэж тэд Бурханаас гуйдаг. Тэдэнд Бурханы ерөөл хэрэгтэй болоход тэрхүү ерөөл нь байгаач гэж Бурханаас гуйдаг. Бэрхшээлтэй тулгарахдаа тэднийг зоригжуулж, арын хамгаалалт болооч гэж Бурханаас гуйдаг. Энэ хүмүүсийн Бурханы тухай мэдлэг нь нигүүлсэл болон ерөөлийн хүрээн дотор гацсан байдаг. Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханы тухай тэдний ойлголт нь төсөөлөл, бичиг үсэг, хоосон сургаал төдийхнөөр хязгаарлагдаж байдаг. Гэвч Бурханы зан чанарыг ойлгохыг эрмэлздэг, Бурханыг Өөрийг нь жинхэнээсээ харж, Бурханы зан чанарыг болон Бурханд юу байгаа, Бурхан юу болохыг үнэхээр ойлгохыг хүсдэг зарим хүн бий. Энэ хүмүүс үнэний бодит байдал болон Бурханы авралын араас хөөцөлдөж, Бурханы байлдан дагуулалт, аврал, төгс болголтыг хүлээн авахаар эрж хайж байдаг. Тэд Бурханы үгийг уншихдаа зүрх сэтгэлээ ашигладаг, мөн тэдэнд зориулан Бурханы бэлтгэсэн хүн, үйл явдал, юм бүрийг биечлэн мэдрэхэд зүрх сэтгэлээ ашигладаг бөгөөд үнэнчээр залбиран эрж хайдаг. Мэдэх сэн гэж хамгийн их хүсдэг зүйл нь бол Бурханы хүсэл бөгөөд ойлгохыг хамгийн их хүсдэг зүйл нь Бурханы жинхэнэ зан чанар болон мөн чанар юм, тэгснээрээ тэд Бурханыг гомдоохоо больж, Бурханы хайр татам байдал болон Түүний үнэн талыг туршлагаараа дамжуулан илүү их харж болох юм. Мөн ингэснээр тэдний зүрх сэтгэлд жинхэнэ бодит Бурхан оршин тогтнох ба ингэснээр Бурхан тэдний зүрхэнд байраа эзэлж, тэд цаашид төсөөлөл, үзэл, тодорхой бус байдлын дунд амьдрахаа болино. Энэ хүмүүс Бурханы зан чанар болон Түүний мөн чанарыг ойлгох тулгамдсан хүсэлтэй байдгийн шалтгаан бол Бурханы зан чанар, мөн чанар нь хүн төрөлхтний туршлагын турш мөчөөс мөчид хэрэгтэй учраас тэр юм; Түүний зан чанар, мөн чанар хүнийг насан туршид нь амиар тэтгэх зүйл юм. Бурханы зан чанарыг нэгэнт ойлгохоороо тэд Бурханыг илүү хүндэтгэн, Бурханы ажилд илүү сайн хамтран ажиллаж, Бурханы хүсэлд илүү анхааралтай болж чадах ба үүргээ чадлынхаа хэрээр сайн биелүүлнэ. Бурханы зан чанарт хандах хоёр төрлийн хүмүүсийн хандлага ийм юм. Эхнийх нь Бурханы зан чанарыг ойлгохыг хүсдэггүй. Тэд Бурханы зан чанарыг ойлгож, Бурханыг Өөрийг нь мэдэж, Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг харахыг хүсдэг, Бурханы хүслийг үнэхээр үнэлдэг гэцгээдэг боловч сэтгэлийнхээ гүнд Бурхан байдаггүй нь дээр гэж боддог. Яагаад гэвэл, энэ төрлийн хүмүүс байнга Бурханд дуулгаваргүй байж,

эсэргүүцдэг; тэд өөрийн зүрх сэтгэл дэх байр суурийн төлөө Бурхантай тэмцэлдэж, Бурханы оршин тогтнолыг үргэлж сэжиглэж, бүр үгүйсгэдэг. Тэд зүрх сэтгэлээ Бурханы зан чанарт буюу бодит Бурханд нь эзлүүлэх хүсэлгүй байдаг. Тэд өөрсдийн хүсэл, төсөөлөл болон санаархлыг хангахыг л хүсдэг. Тиймээс энэ хүмүүс Бурханд итгэдэг, Бурханыг дагаж, мөн Түүний төлөө гэр бүл, ажлаа орхиж болох боловч муу замаа орхидоггүй. Зарим нь бүр тахил хулгайлж, эсвэл үрэн таран хийнэ, зарим нь Бурханыг нууцаар хараж байхад бусад нь өөрсдийгөө ахин дахин гэрчилж, өөрсдийгөө дөвийлгөж, хүмүүс болон байр суурийн төлөө Бурхантай тэмцэлдэхийн тулд байр сууриа ашиглаж байж магадгүй. Тэд өөрсдийгөө шүтүүлэхийн тулд хүмүүсийн сэтгэлийг татаж, хяналтдаа оруулахыг үргэлж хичээн янз бүрийн арга саам хэрэглэдэг. Зарим нь бүр хүмүүсийг санаатайгаар төөрөгдүүлэн өөрсдийгөө Бурхан, тиймээс өөрт нь Бурхан шиг үзэж болно гэж хүмүүст бодуулдаг. Тэд хүнд ялзарсан байна гэдгийг нь, өөрсдийгөө бас ялзарсан, биеэ тоосон гэдгээ, өөрсдийг нь битгий шүт, тэд хэчнээн ч мандаж байх нь хамаагүй, энэ нь Бурханы өргөмжлөлөөс болдог бөгөөд хийх ёстой юмаа хийж байна гэдгээ ямар ч гэсэн хэнд ч ерөөсөө хэлэхгүй л дээ. Тэд эдгээр зүйлийг яагаад хэлдэггүй вэ? Яагаад гэвэл, тэд хүмүүсийн зүрх сэтгэл дэх байр сууриа алдахаас маш их айдаг. Ийм хүмүүс Бурханыг хэзээ ч өргөмжилдөггүй, Бурханд хэзээ ч гэрчлэл хийдэггүй. Тэд Бурханыг ойлголгүйгээр Бурханыг мэдэж чадах уу? Тэгэх боломжгүй! Иймд “Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурхан Өөрөө” гэх сэдвийн үгс энгийн байж магадгүй боловч хүн бүрд утга учир нь өөр өөр юм. Бурханд үргэлж дуулгаваргүй байдаг, Бурханыг эсэргүүцдэг, Бурханд дайсагнадаг хүний хувьд тэр үгс нь ял зэмийг ёрлодог; харин үнэн-бодит байдлыг эрэлхийлдэг, Бурханы хүслийг эрж хайх гэж үргэлж Бурханы өмнө ирдэг хүн тийм үгсийг усанд орсон загас мэт авч үзнэ. Тэгэхээр, Бурханы зан чанар, Бурханы ажлын тухай яриаг сонсоод толгой нь өвдөж, зүрх нь эсэргүүцлээр дүүрч, жигтэйхэн тавгүйтдэг хүмүүс та нарын дунд бий. Гэвч та нарын дунд, энэ сэдэв өөрсдөд нь маш ашиг тустай учраас яг өөрсдөд нь хэрэгтэй зүйл, өөрсдийнх нь амийн туршлагаас салшгүй зүйл; энэ бол хамгийн гол чухал зүйл, Бурханд итгэх итгэлийн үндэс бөгөөд хүн төрөлхтний орхиж болохгүй зүйл гэж боддог зарим хүн бий. Та бүгдийн хувьд энэ сэдэв ойрхон бөгөөд хол, мэдэхгүй боловч танил санагддаг байж болно. Гэхдээ ямартай ч энэ нь хүн бүрийн сонсох ёстой, мэдэх ёстой, ойлгох ёстой сэдэв юм. Чи үүнд яаж хандах, үүнийг яаж харах, хэрхэн хүлээж авахаас үл хамааран энэ сэдвийн чухал ач холбогдлыг тоохгүй байж болохгүй.

Бурхан хүн төрөлхтнийг бүтээсэн цагаасаа эхлэн Өөрийн ажлыг хийсээр байна. Эхэндээ энэ нь маш энгийн ажил байсан боловч энгийн мөртөө Бурханы мөн чанар болон зан чанарын илэрхийллийг агуулж байв. Хэдийгээр өнөөдрийг хүртэл Эдүгээ Бурханы ажил илүү өргөгдөж, Өөрийг нь дагагч хүн бүр дээрх энэ ажил нь Түүний үгийн агуу илэрхийллийн хамт асар том бөгөөд бодитой болсон байхад Бурханы үнэн бие хүн төрөлхтнөөс тувт нуугдсаар байна. Хэдийгээр Тэр хоёр удаа бие

махбодтой болсон боловч Библид тэмдэглэгдсэн үйл явдлын үеэс орчин үеийг хүртэл Бурханы үнэн биеийг хэн ер нь харсан юм бэ? Та нарын ойлголт дээр үндэслэвэл, Бурханы үнэн биеийг харсан хүн ер нь байна уу? Байхгүй. Хэн ч Бурханы үнэн биеийг хараагүй, хэн ч Бурханы жинхэнэ төрхийг үзээгүй гэсэн үг. Энэ бол хүн бүрийн хүлээн зөвшөөрдөг зүйл юм. Өөрөөр хэлбэл, Бурханы үнэн бие буюу Бурханы Сүнс нь Түүний бүтээсэн Адам, Ева болон Түүний хүлээн зөвшөөрсөн зөв шударга хүн Иовыг оролцуулаад бүх хүнээс нуугдмал байдаг. Тэдний хэн нь ч Бурханы үнэн биеийг хараагүй юм. Харин Бурхан Өөрийн үнэн биеийг яагаад зориуд далдалдаг вэ? Зарим хүн: “Бурхан хүмүүсийг айлгахаасаа эмээдэг” гэнэ. Зарим нь: “Хүн дэндүү жижигхэн, Бурхан дэндүү агуу учраас Бурхан Өөрийн үнэн биеийг нуудаг; хүмүүс Бурханыг харж болохгүй байх, эс бөгөөс тэд үхнэ” гэдэг. Бас “Бурхан Өөрийн ажлыг өдөр бүр удирдаад завгүй байдаг, хүмүүст Өөрийгөө харуулахаар гарч ирэх цаг Түүнд байдаггүй байх” гэж хэлэх хүмүүс ч бий. Та нар алинд нь ч итгэдэг бай хамаагүй, Надад нэг дүгнэлт байна. Энэ дүгнэлт нь юу вэ? Энэ бол Бурхан зүгээр л үнэн биеэ хүмүүст харуулъя гэж хүсдэггүй гэсэн дүгнэлт юм. Хүмүүсээс нуугдмал байх нь Бурханы зориуд хийдэг зүйл. Өөрөөр хэлбэл, Түүний үнэн бие хүмүүст харагддаггүй нь Бурханы санаа юм. Үүнийг одоо бүгд ойлгосон байх. Бурхан Өөрийн үнэн биеийг хэзээ ч хэнд ч илчлээгүй юм бол Бурханы үнэн бие оршин байдаг гэж та нар боддог уу? (Тэр оршин байдаг.) Мэдээж, Тэр байдаг. Бурханы үнэн бие оршин байдаг нь огт эргэлзээгүй юм. Гэвч Бурханы үнэн бие хэр агуу болох, эсвэл ямар харагддаг тухайд гэвэл, эдгээр асуултыг хүн төрөлхтөн судлах хэрэгтэй юу? Үгүй. Үгүйсгэсэн хариу байна. Бурханы үнэн бие нь бидний судлах хэрэгтэй сэдэв биш бол юу байх юм бэ? (Бурханы зан чанар.) (Бурханы ажил.) Гэвч албан ёсны сэдвийн талаар нөхөрлөхийн өмнө дөнгөж сая хэлэлцэж байсан зүйлдээ буцаж оръё: Бурхан яагаад Өөрийн үнэн биеийг хүн төрөлхтөнд хэзээ ч харуулаагүй вэ? Яагаад Бурхан Өөрийн үнэн биеийг хүн төрөлхтнөөс зориуд нуудаг вэ? Үүнд зөвхөн ганц л шалтгаан бий, тэр нь бол: Бурханы бүтээсэн хүн Түүний ажлын хэдэн мянган жилийг туулсан хэдий боловч Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханы мөн чанарыг мэддэг ганц ч хүн байхгүй. Ийм хүмүүс Бурханы нүдэнд Өөрийнх нь эсрэг байдаг ба Өөрт нь дайсагнадаг хүмүүст Бурхан Өөрийгөө харуулахгүй. Энэ бол Бурхан хүн төрөлхтөнд Өөрийн үнэн биеийг хэзээ ч харуулаагүй, яагаад Өөрийн үнэн биеийг тэднээс зориуд халхалдгийн цорын ганц шалтгаан юм. Бурханы зан чанарыг мэдэхийн ач холбогдлыг та нар одоо ойлгов уу?

Бурханы удирдлага байсан цагаас эхлэн Бурхан Өөрийн ажлыг гүйцэтгэхэд үргэлж бүх анхаарлаа хандуулж иржээ. Хүнээс Өөрийн үнэн биеийг нуудаг хэдий ч Тэр үргэлж хүний дэргэд байж, хүн дээр ажиллаж, Өөрийн зан чанарыг илэрхийлэн, Өөрийн мөн чанараар бүх хүн төрөлхтнийг залан чиглүүлж, Өөрийн агуу хүч чадал, мэргэн ухаан, эрх мэдлээр хүн бүр дээр ажилласнаар Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе болон өнөөгийн Хаанчлалын эрин үеийг авчирсан. Бурхан

хүнээс Өөрийн үнэн биеийг нуудаг боловч Түүний зан чанар, Түүний оршихуй болон эзэмшил, хүн төрөлхтний төлөөх Түүний хүсэл нь хүмүүсийг харж, мэдрэг гэж нээлттэй ил байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс Бурханыг харж, Түүнд хүрч чадахгүй боловч хүн төрөлхтөнд харагдсан Бурханы зан чанар болон мөн чанар нь Бурханы Өөрийнх нь цэвэр илэрхийлэл мөн билээ. Энэ үнэн биш гэж үү? Бурхан Өөрийн ажилд ямар арга, эсвэл ямар өнцөг сонгохыг нь үл харгалзан, Тэр хүмүүст үргэлж Өөрийн жинхэнэ ялгамж чанараар хандаж, Өөрт оногдсон ажлыг хийж, хэлэх ёстой үгийг хэлдэг. Бурхан ямар ч өнцгөөс яривч—гуравдагч тэнгэрт зогсож байсан ч, эсвэл махбодод орших юм уу, бүр энгийн хүний байдлаар байсан ч—Тэр хүмүүст үргэлж Өөрийн бүх сэтгэл зүрхнээс, Өөрийн бүх оюун ухаанаар, хуурч мэхлэхгүй, нууж далдлахгүй ярьдаг. Өөрийн ажлыг явуулж байхдаа Бурхан Өөрийн үг болон зан чанарыг илэрхийлж, мөн Түүнд юу байгаа, Тэр юу болохоо юу ч үлдээлгүй илэрхийлдэг. Тэр хүн төрөлхтнийг Өөрийн амь, Өөрийн оршихуй болон эзэмшлээр залж чиглүүлдэг. “Харагддаггүй, баригддаггүй” Бурханы удирдамж дор хүн төрөлхтний өлгий эрин болох Хуулийн эрин үеийг хүн ийнхүү туулсан юм.

Хуулийн эрин үеийн дараа Бурхан анх удаа махбод болсон, бие махбодтой болсон нь гучин гурван жил хагас үргэлжилсэн билээ. Хүний хувьд гучин гурван жил хагас гэдэг урт хугацаа юу? (Урт биш.) Хүний насны хэмжээ гучин хэдэн жилээс ер нь хавьгүй урт байдаг тул энэ нь хүний хувьд нэг их урт цаг хугацаа биш. Гэхдээ бие махбодтой болсон Бурханы хувьд энэ гучин гурван жил хагас бол үнэндээ маш урт байсан юм. Тэр Бурханы ажил, Бурханы даалгаврыг үүрсэн хүн—энгийн хүн болсон. Энэ нь, Тэрээр энгийн хүний хийж чадахгүй ажлыг хариуцахын зэрэгцээ бас энгийн хүний тэсвэрлэж чадахгүй зовлонг давах болсон гэсэн үг юм. Нигүүлслийн эрин үед, ажлынх нь эхлэлээс загалмайд цовдлогдох хүртэлх хугацаанд Эзэн Есүсийн амссан зовлонгийн хэмжээг өнөөдрийн хүмүүс нүдээр үзэж чадахгүй байж болох боловч Библийн түүхээс үүний талаар та нарт бага зэрэг ч гэсэн төсөөлөл авч чадах уу? Эдгээр тэмдэглэсэн баримтад хэчнээн олон нарийн зүйл байдгийг харгалзахгүйгээр ерөнхийдөө, энэ хугацаанд Бурханы ажил бэрхшээл, зовлонгоор дүүрэн байлаа. Ялзарсан хүний хувьд, гучин гурван жил хагас нь урт хугацаа биш; бага зэрэг зовлон амсах нь жижиг асуудал. Гэвч бүх хүн төрөлхтний нүглийг үүрэх, мөн нүгэлтнүүдтэй хамт хооллож, хонож, амьдрах ёстой болсон нь ямар ч өө сэвгүй, ариун Бурханы хувьд бол итгэхийн аргагүй их шаналал байв. Тэрээр Бүтээгч, бүх зүйлийн Захирагч, бүх юмны Эзэн атал энэ ертөнцөд ирж, ялзарсан хүмүүсийн дарлал, харгислалыг тэсвэрлэх хэрэгтэй болсон. Өөрийн ажлыг дуусгаж, хүн төрөлхтнийг тоо томшгүй зовлонгоос аврахын тулд хүнд яллагдаж, бүх хүн төрөлхтний нүглийг үүрэх ёстой байлаа. Түүний туулсан зовлонгийн хэмжээг жирийн хүн төсөөлж, мэдрэх боломжгүй юм. Энэ зовлон юуг төлөөлдөг вэ? Энэ нь хүн төрөлхтнийг гэх Бурханы чин зүрхний хайрыг төлөөлдөг. Энэ нь хүмүүсийг нүглээс золин аврахын тулд, Өөрийн ажлын энэ шатыг дуусгахын тулд Түүний тэвчсэн доромжлол, хүнийг аврахын төлөө Түүний төлсөн төлөөсийг

илтгэдэг. Энэ нь бас Бурхан хүн төрөлхтнийг загалмайгаас золин аврах байсан гэсэн үг. Энэ нь бүтээгдсэн амьтан төлж чадашгүй, цусаар, амиар төлсөн төлөөс юм. Учир нь, Түүнд Бурханы мөн чанар байдаг ба Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг эзэмшдэг тул Тэр ийм төрлийн зовлонг дааж, ийм төрлийн ажлыг хариуцаж чадах юм. Энэ бол бүтээгдсэн ямар ч амьтан Түүний оронд хийж чадахгүй байсан зүйл юм. Энэ нь Нигүүлслийн эрин үед Бурханы хийсэн ажил ба Түүний зан чанарын илчлэл билээ. Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг энэ нь илчилж байна уу? Хүн төрөлхтний мэдүүштэй зүйл энэ мөн үү? Тэрхүү эрин үед хүмүүс Бурханы үнэн биеийг хараагүй боловч Бурханы нүглийн тахилыг хүлээн авч, загалмайгаас Бурханаар золин аврагдсан. Нигүүлслийн эрин үед Бурханы хийсэн ажлын талаар хүмүүс мэдэж магадгүй боловч энэ хугацаанд Бурханы илэрхийлсэн зан чанар болон хүслийн талаар мэддэг хүн бий юу? Хүмүүс ердөө л өөр өөр эрин үед хийсэн Бурханы ажлын нарийн ширийнийг янз бүрийн сувгаар дамжуулан мэддэг, эсвэл Бурханыг ажлаа хийж байх үед гарсан Бурхантай холбоотой түүхүүдийг л мэддэг. Эдгээр баримт, түүх нь Бурханы тухай зүгээр л нэг мэдээлэл, эсвэл домгоос цаашгүй байдаг ба Бурханы зан чанар болон мөн чанарт ямар ч хамаагүй. Иймд хүмүүс Бурханы тухай хэдэн чтүүх мэддэг байвч энэ нь тэднийг Бурханы зан чанар, Түүний мөн чанарын тухай гүнзгий ойлголт, мэдлэгтэй гэсэн үг биш юм. Хуулийн эрин үетэй адилаар, Нигүүлслийн эрин үеийн хүмүүс махбодтой Бурхантай шууд, ойр учирдаг байсан боловч Бурханы зан чанар болон Бурханы мөн чанарын тухай тэдний мэдлэг Хуулийн эрин үед байсан шиг нь бараг үгүй байжээ.

Хаанчлалын эрин үед Бурхан эхний удаа болсон шигээ дахиж бие махбодтой болсон. Ажлынхаа энэ хугацаанд Бурхан Өөрийн үгийг юу ч үлдээлгүй илэрхийлсээр, хийх ёстой ажлаа хийж, Өөртөө юу байгааг болон Өөрийгөө юу болохыг илэрхийлдэг. Үүний зэрэгцээ Тэр хүний дуулгаваргүй, мунхаг байдлыг тэсэн тэвчсээр байна. Бурхан ажлынхаа энэ хугацаанд ч гэсэн үргэлж Өөрийн зан чанарыг харуулж, Өөрийн хүслийг илэрхийлж байгаагүй гэж үү? Иймд хүнийг бүтээснээс эхлээд одоог хүртэл Бурханы зан чанар, Түүний оршихуй болон эзэмшил, Түүний хүсэл нь хүн бүрд үргэлж нээлттэй байсаар байдаг. Бурхан Өөрийн мөн чанар, зан чанар, эсвэл Өөрийн хүслийг хэзээ ч зориуд нууж байгаагүй. Бурханы юу хийж байгааг, Түүний хүсэл юу болохыг хүн төрөлхтөн тоохгүй байгаа л хэрэг, тийм учраас л Бурханы тухай хүний ойлголт ийм өрөвдөлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийн үнэн биеийг нуудаг атлаа Өөрийн хүсэл, зан чанар болон мөн чанарыг үргэлж ил үзүүлэн хором тутамд хүн төрөлхтний дэргэд байж байдаг. Зарим талаар, Бурханы үнэн бие хүмүүст бас нээлттэй байдаг боловч сохор, дуулгаваргүй байдлаасаа болоод тэд Бурханы илрэлтийг харж хэзээ ч чаддаггүй. Иймээс хэрвээ асуудал нь энэ бол Бурханы зан чанарыг болон Бурханыг Өөрийг нь ойлгоход хүн бүрд хялбар биш байх биз дээ? Энэ бол хариулахад маш хэцүү асуулт байгаа биз? Та нар үүнийг хялбар гэж хэлж болно, гэхдээ зарим хүн Бурханыг мэдэхээр эрэлхийлдэг атлаа Түүнийг хэзээ ч мэдэж,

эсвэл Түүний талаар тодорхой ойлголттой болж чаддаггүй—энэ нь үргэлж бүдэг бадаг, бүрхэг байдаг. Харин та нар үүнийг тийм ч амаргүй гэж хэлбэл энэ нь ч бас буруу юм. Ийм урт хугацаанд Бурханы ажлын субьект байж ирсэн учир хүн бүр туршлагаараа дамжуулан Бурхантай жинхэнэ харьцаатай байсан байх ёстой. Тэд ядаж л Бурханыг зүрх сэтгэлдээ зарим нэгэн хэмжээгээр мэдэрсэн, эсвэл Бурхантай сүнслэг түвшинд хальт учирсан байх ёстой бөгөөд Бурханы зан чанарын талаар ядаж л бага зэрэг ухварлан мэдсэн буюу Түүний тухай зарим ойлголт олж авсан байх ёстой. Бурханыг дагаж эхэлсэн цагаас одоог хүртэл хүн төрөлхтөн хэтэрхий ихийг хүртсэн боловч хүний муу хэв чанар, мунхаглал, дуулгаваргүй байдал болон төрөл бүрийн санаа зорилго гэсэн олон шалтгааны улмаас хүн төрөлхтөн бас үүнээс дэндүү ихийг нь алдсан. Бурхан хүнд хангалттай ихийг аль хэдийн өгчихөөгүй гэж үү? Бурхан хүнээс Өөрийн үнэн биеийг нуудаг ч, Түүнд юу байгаа болон Тэр юу болохоор, тэр ч байтугай Өөрийн амиар тэднийг хангадаг; Бурханы тухай хүмүүсийн мэдлэг нь зөвхөн одоогийнх шигээ байх ёсгүй юм. Ийм учраас Би Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханы Өөрийн тухай сэдвээр та бүхэнтэй цаашид нөхөрлөх хэрэгтэй гэж бодож байна. Үүний зорилго нь бол, ингэснээр мянга мянган жилийн турш хүнд хүртээсэн Бурханы халамж, анхаарал дэмий өнгөрөхгүй, ингэснээр өөрсдийнх нь төлөөх Бурханы хүслийг хүн төрөлхтөн үнэнээсээ ойлгож, үнэлж чаддаг болгох явдал юм. Ингэснээр Бурханы тухай хүмүүсийн мэдлэг шинээр нэг алхам урагшилж чадна. Энэ нь бас Бурханыг хүмүүсийн зүрх сэтгэл дэх жинхэнэ байранд нь буцаана; өөрөөр хэлбэл, Түүнийг зөв үнэлэх болно.

Бурханы зан чанар болон Бурханыг Өөрийг нь ойлгохын тулд багаар эхлэх ёстой. Гэвч хаанаас багаар эхлэх вэ? Юуны өмнө, Би Библиэс хэдэн бүлгийг сонгож авсан. Доорх мэдээлэл нь бүгд Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханы Өөрийнх нь тухай сэдэвт холбоотой Библийн мөрүүдийг агуулдаг. Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханыг Өөрийг нь мэдэхэд туслах лавлах материал болгохын тулд Би эдгээр эшлэлийг тусгайлан олсон юм. Эдгээрийг хуваалцсанаар Бурхан урьдын ажлаараа ямар зан чанар илэрхийлсэн ба Түүний боловч хүмүүсийн мэддэггүй зан чанар болон мөн чанарын аль талуудыг хүн мэддэггүй гэдгийг бид ойлгож чадна. Энэ бүлгүүд хуучин байж болох боловч бидний нөхөрлөж байгаа сэдэв бол хүмүүст байхгүй, ер сонсоогүй шинэ зүйл юм. Та нарын заримд нь үүнийг ойлгоход бэрх байж магадгүй—Адам, Еваг дурсаж, Ноа руу эргэж очих нь гишгэсэн мөрөөрөө буцаж яваа хэрэг биш үү? Та нар юу ч гэж бодсон хамаагүй, эдгээр бүлэг нь энэ сэдвийн талаар нөхөрлөхөд маш тустай бөгөөд өнөөдрийн нөхөрлөлийн сургалтын бичвэр эх материал болж чадна. Намайг энэ нөхөрлөлийг дуусгах үед эдгээр бүлгийг сонгосон Миний цаад санааг та нар ойлгоно. Өмнө нь Библийг уншсан хүмүүс энэ цөөн хэдэн мөрийг уншсан байж болох ч жинхэнээсээ ойлгоогүй байж магадгүй. Тэдгээрийг эхлээд товчхон хэлэлцээд дараа нь нөхөрлөлөөрөө нэг бүрчлэн дэлгэрэнгүй авч үзье.

Адам, Ева хоёр хүн төрөлхтний элэнц хуланц юм. Бид Библийн дүрүүдийг дурдах гэж байгаа бол тэр хоёроос эхлэх ёстой. Дараагийнх нь хүн төрөлхтний хоёр дахь өвөг Ноа юм. Гурав дахь дүр нь хэн бэ? (Абрахам.) Та нар бүгдээрээ Абрахамын түүхийг мэдэх үү? Та нарын зарим нь үүнийг мэднэ байх, гэхдээ бусад нь сайн мэдэхгүй байж магадгүй. Дөрөв дэх дүр нь хэн бэ? Содомын сүйрлийн түүхэнд хэнийг дурдсан бэ? (Лотыг.) Гэвч энд Лотыг дурдаагүй байна. Хэний тухай өгүүлдэг вэ? (Абрахамын тухай.) Абрахамын тухай түүхэнд дурдсан гол зүйл бол Ехова Бурханы хэлсэн зүйл юм. Та нар үүнийг харж байна уу? Тав дахь дүр нь хэн бэ? (Иов.) Бурхан ажлынхаа энэ үе шатанд Иовын түүхийг ихэд дурддаггүй гэж үү? Тэгвэл та нар энэ түүхийг маш их тоодог уу? Та нар их тоодог юм бол Библи дэх Иовын түүхийг анхааралтай уншсан уу? Иов юу хэлж, юу хийснийг та нар мэдэх үү? Та нарын хамгийн олон уншсан нь хэдэн удаа уншсан бэ? Та нар үүнийг үргэлж уншдаг уу? Хонконгийн эгч нар аа, бидэнд хэлнэ үү. (Өмнө нь Нигүүлслийн эрин үед байхдаа би ганц хоёр удаа уншсан.) Тэрнээс хойш дахин уншаагүй юу? Харамсалтай байна. Би та нарт хэлье: Бурханы ажлын энэ үе шатанд Тэр Иовыг олон удаа дурдсан нь Түүний санаа зорилгын тусгал байсан юм. Тэрээр Иовыг олон удаа дурдсан боловч та нарын анхаарлыг татаагүй нь дараах баримтын нотолгоо: Та нар Бурханаас эмээж, муугаас зайлдаг сайн хүмүүс байх сонирхолгүй байна. Учир нь, та нар Иовын тухай Бурханы эш татсан түүхийн талаар бүдүүн тойм ойлгосондоо сэтгэл хангалуун байдаг. Та нар уг түүхийг ойлгосон төдийхөндөө сэтгэл хангалуун байдаг, харин Иов хэн болох тухай нарийн ширийнийг, мөн Бурхан яагаад тийм олон тохиолдолд Иовыг эш татдагийн цаад зорилгыг тоодоггүй, ойлгох гэж оролддоггүй. Хэрвээ та нар Бурханы магтсан ийм хүнийг сонирхохгүй байгаа юм бол яг юунд анхаарлаа хандуулж байна вэ? Та нар Бурханы дурдсан ийм чухал хүнийг тоохгүй, түүнийг ойлгох гэж оролдохгүй байгаа юм бол Бурханы үгэнд та нарыг ямар хандлагатай гэх вэ? Энэ нь эмгэнэлтэй хэрэг биш гэж үү? Та нарын ихэнх нь бодитой зүйлд оролцдоггүй, бүгдээрээ үнэнийг эрж хайдаггүйг батлахгүй гэж үү? Хэрвээ чи үнэнийг эрж хайдаг бол Бурханы сайшаадаг хүмүүс болон Бурханы дурссан хүмүүсийн түүхэнд хангалттай анхаарал хандуулна. Тэдний дайтай болж, эсвэл тэдний түүхийг мэдэрч чадах эсэх чинь хамаагүй, хурдан явж тэдний тухай уншиж, тэдгээрийг ойлгож, тэдний үлгэр жишээг дагах арга зам олохыг хичээж, чадах бүхнээ чадлынхаа хэрээр хий. Үнэнийг эгээрэн хүсдэг хүн ингэх ёстой юм. Харин үнэндээ бол энд сууж байгаа та нарын ихэнх нь Иовын түүхийг огт уншаагүй, энэ чинь нэгийг хэлээд байна.

Миний саяхан ярьж байсан сэдэв рүү буцаж оръё. Хуучин Гэрээний Хуулийн эрин үед холбоотой Библийн энэ хэсэгт нь Би Библийг уншсан хүмүүсийн дийлэнх олонх нь мэдэх маш үлгэр жишээч дүрүүдийн тухай хэдэн түүхийг голлон сонголоо. Хэн ч эдгээр дүрийн тухай түүхийг уншаад тэдэн дээр Бурханы хийсэн ажил болон тэдэнд хэлсэн Бурханы үг одоогийн хүмүүст ч бас бодитой, ойлгомжтой гэдгийг мэдэрч чадна. Чи эдгээр түүхийг, Библийн тэмдэглэлийг уншихдаа түүхийн тэр цаг

үед Бурхан Өөрийн ажлыг хэрхэн хийж, хүмүүст яаж хандаж байсан талаар илүү сайн ойлгож чадна. Гэхдээ өнөөдөр эдгээр бүлгийг хэлэлцэхээр шийдсэн шалтгаан бол чамайг эдгээр түүх дээр, эсвэл доторх дүрүүд дээр нь анхаарлаа төвлөрүүлэх гэж оролд гэсэнд биш. Харин ч ингэснээр та нар энэ дүрүүдийн түүхээр дамжуулан Бурханы үйлс болон Түүний зан чанарыг харж чадна. Та нар Бурханыг мэдэж, ойлгох, Түүний бодит талыг харахад илүү хялбар болгоно; энэ нь Түүний тухай төсөөлөл, үзлийг чинь сарниулж, бүрэг бараг байдлаар хүрээлэгдсэн итгэлээс чамайг холдуулж туслах юм. Баттай суурьгүй бол Бурханы зан чанарыг ойлгох гэж, мөн Бурханыг Өөрийг нь мэдэх гэж оролдох нь арчаагүй, арга мөхөс, хаанаас эхлэхээ ч мэдэхгүй байдалд байнга оруулж болно. Бурханыг илүү сайн ойлгох, Бурханы хүслийг илүү бодитоор үнэлэх, Бурханы зан чанарыг болон Бурханыг Өөрийг нь мэдэх, мөн Бурханы оршин тогтнолыг жинхэнээсээ мэдрэх ба хүн төрөлхтний төлөөх хүслийг нь үнэлэхэд чинь туслах арга, барилыг хөгжүүлэхэд энэ Надад түлхэц болсон юм. Энэ та бүгдэд ашигтай бус уу? Одоо эдгээр түүх болон Библийн хэсгүүдийг дахиж хараад та нар зүрх сэтгэл дотроо юу мэдэрч байна вэ? Библиэс Миний сонгож авсан хэсгүүдийг та нар илүүц гэж бодож байна уу? Би сая та нарт хэлсэн зүйлээ дахин онцлох ёстой: Та бүхнээр энэ хүмүүсийн түүхийг уншуулах гэсэн нь Бурхан Өөрийн ажлыг хүмүүс дээр яаж хийдгийг болон хүн төрөлхтөнд хандах Түүний хандлагыг илүү сайн ойлгоход чинь туслах зорилготой юм. Үүнийг ойлгоход та нарт юу туслах вэ? Бурханы урьд нь хийсэн ажлыг ойлгох ба түүнийг нь яг одоо хийж буй ажилтай нь холбох—Бурханы тоолшгүй олон талыг ойлгоход энэ чамд тусална. Эдгээр тоолшгүй олон тал нь үнэн бодитой бөгөөд Бурханыг таньж мэдэхийг хүсдэг бүхэн тэдгээрийг мэдэж, ойлгох ёстой.

Одоо бид Адам, Ева хоёрын тухай түүхээс эхэлье. Эхлээд Библиэс уншицгаая.

I. Адам, Ева хоёр

1. Адамд өгсөн Бурханы тушаал

Эхлэл 2:15–17 Ехова Бурхан хүнийг авч, Еден цэцэрлэгийг арчлуулан мануулахын тулд тэнд суулгажээ. Ехова Бурхан хүнд тушааж, “Цэцэрлэгийн бүх модны жимсээс чөлөөтэй идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс л идэж болохгүй, учир нь идсэн тэр өдөртөө л чи гарцаагүй үхнэ” хэмээв.

Та нар энэ мөрүүдээс ямар нэг зүйл ойлгов уу? Библийн энэ хэсэг та нарт ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ? Би яагаад Адамд өгсөн Бурханы тушаалын тухай ярья гэж шийдсэн бэ? Бурхан, Адам хоёрын дүр зураг та бүгдийн санаанд байна уу? Та нар ингэж төсөөлөөд үз: Хэрвээ та нар тэнд байсан бол сэтгэлийнхээ гүнд та нар Бурханыг ямар байх байсан гэж боддог вэ? Энэ тухай бодохоор ямар санагдаж байна вэ? Энэ бол сэтгэл хөдөлгөн сэргээх зураглал юм. Энд зөвхөн Бурхан, хүн хоёр л байгаа боловч тэдний ойр дотно харилцаа нь чамд дүүрэн бахдал төрүүлнэ:

Бурханы бялхам хайр хүнд харамгүй хүрч, хүнийг хүрээлж байна; хүн гэмгүй, ариун, санаа зовох зүйлгүй байж, Бурханы харцан дор баяр цэнгэлээр дүүрэн амьдарч байна; Бурхан хүнд санаа тавьж, хүн Бурханы хамгаалалт, ерөөл дор амьдарч, хүний хийж, хэлж буй бүхэн Бурхантай нягт холбоотой, салшгүй байна.

Үүнийг Бурхан хүнийг бүтээснийхээ дараа түүнд өгсөн анхны тушаал гэж болно. Энэ тушаал юу тээдэг вэ? Энэ нь Бурханы хүслийг, мөн хүн төрөлхтний төлөөх Түүний сэтгэлийн зовнилыг тээдэг. Энэ бол Бурханы анхны тушаал байсан ба бас хүний төлөө санаа зовдгоо Бурхан анх удаа илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг бүтээсэн мөчөөсөө эхлэн хүний төлөө хариуцлага үүрэхээ мэдэрсэн. Түүний хариуцлага юу вэ? Тэр хүнийг хамгаалж, харж хандах ёстой. Хүн Өөрт нь итгэж, үгийг нь дагаж чадна гэж Тэр найддаг. Энэ нь мөн л хүнд тавьж буй Бурханы анхны найдвар юм. Бурхан тийм найдвартайгаар дараах зүйлийг хэлдэг: “Цэцэрлэгийн бүх модны жимснээс чөлөөтэй идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимсээс л идэж болохгүй, учир нь идсэн тэр өдөртөө л чи гарцаагүй үхнэ.” Эдгээр энгийн үг Бурханы хүслийг төлөөлдөг. Эдгээр нь мөн Бурхан зүрх сэтгэлдээ аль хэдийн хүнд санаа тавьж эхэлснийг илчилдэг. Бүх зүйлийн дотроос зөвхөн Адам л Бурханы дүрээр бүтээгдсэн; Адам бол Бурханы амийн амьсгаатай цорын ганц амьд зүйл байсан; тэр Бурхантай хамт алхаж, Бурхантай ярилцаж чаддаг байв. Тийм учраас Бурхан түүнд ийм тушаал өгсөн. Бурхан энэ тушаалаараа хүн юу хийж болох, юу хийж болохгүйг маш тодорхой зааж өгчээ.

Энэ энгийн хэдэн үгээс бид Бурханы зүрх сэтгэлийг хардаг. Харин Бурханы ямар зүрх сэтгэл харагддаг вэ? Бурханы зүрх сэтгэлд хайр байдаг уу? Зовнил байдаг уу? Эдгээр мөрд байгаа Бурханы хайр, зовнилыг хүмүүс үнэлээд зогсохгүй гүнзгий мэдэрч чадна. Зөвшөөрч байна уу? Намайг ингэж хэлсний дараа та нар эдгээрийг зүгээр л хэдэн энгийн үг гэж бодож байна уу? Ер нь тийм ч энгийн биш байгаа биз дээ? Та нар үүнийг өмнө нь мэдэж байсан уу? Хэрвээ Бурхан чамд энэ цөөн хэдэн үгийг биечлэн хэлсэн бол чамд ямар санагдах байсан бэ? Хэрвээ чи хүн чанартай хүн биш байсан бол, хэрвээ чиний сэтгэл цэвдэг байсан бол чи юу ч мэдрэхгүй, Бурханы хайрыг үнэлэхгүй бөгөөд Бурханы зүрх сэтгэлийг ойлгох гэж оролдохгүй байсан. Хэрвээ чи мөс сайтай, хүн чанарын мэдрэхүйтэй хүн байсан бол өөрөөр мэдрэх байсан. Чи дулаан илч мэдэрч, халамжлуулж, хайрлуулж байгаагаа мэдрэх ба аз жаргалыг мэдрэх байсан. Тийм биш гэж үү? Чи эдгээр зүйлийг мэдрэхээрээ Бурханд хэрхэн хандах вэ? Бурханд ээнэгшин дассан мэт санагдах болов уу? Чи зүрх сэтгэлийнхээ угаас Бурханыг хайрлан хүндэтгэх болов уу? Зүрх сэтгэл чинь Бурханд улам ойртох болов уу? Чи үүнээс Бурханы хайр хүнд яг хэр чухал болохыг харж болно. Гэвч хүмүүс Бурханы хайрыг үнэлж, ойлгох нь бүр ч илүү чухал юм. Үнэндээ, Бурхан Өөрийн ажлын энэ үе шатанд иймэрхүү зүйлийг олон хэлдэггүй гэж үү? Бурханы зүрх сэтгэлийг үнэлж үздэг хүн өнөөдөр байна уу? Миний дөнгөж сая ярьсан Бурханы хүслийг та нар ойлгож чадах уу? Бурханы хүсэл ийм тодорхой, бодитой, жинхэнэ байхад та нар үнэлж үнэндээ

чаддаггүй. Ийм учраас Би та бүхнийг Бурханы талаар бодитой мэдлэг, ойлголтгүй гэж хэлдэг. Энэ үнэн биш гэж үү? Харин одоохондоо ингээд орхиё.

2. Бурхан Еваг бүтээсэн нь

Эхлэл 2:18–20 Ехова Бурхан, “Хүн ганцаараа байх нь сайн зүйл биш; Би түүнд тохирсон туслагчийг бүтээх болно” гэв. Тэгээд Ехова Бурхан хээрийн бүх араатан амьтан, мөн огторгуйн бүх жигүүртэн шувуудыг шороогоор бүтээн; тэднийг хэрхэн нэрлэхийг нь үзэхээр Адамд авчирч өгөв. Адам амьтан бүрийг нэрлэсэн нь тийнхүү тэдний нэр болжээ. Тэгээд Адам бүх мал амьтад, огторгуйн жигүүртэн шувууд, мөн хээрийн бүх араатанд нэр өгөв; гэвч Адамын хувьд түүнд тохирох туслагч олдсонгүй.

Эхлэл 2:22–23 Ехова Бурхан эрэгтэй хүнээс авсан хавиргаараа эмэгтэй хүнийг бүтээж, түүнийг эрэгтэй хүнд аваачиж өгөв. Ингээд Адам, “Энэ бол одоо миний яснаас авсан яс, махнаас авсан мах юм, түүнийг Эрэгтэй хүнээс гаргаж авсан учраас Эмэгтэй хүн гэж нэрлэх болно” гэжээ.

Библийн энэ хэсэгт нэг чухал мөр бий: “Адам амьтан бүрийг нэрлэсэн нь тийнхүү тэдний нэр болжээ.” Тэгэхээр, бүх амьд амьтанд хэн нэр өгсөн бэ? Бурхан биш, харин Адам. Энэхүү мөр нь хүн төрөлхтөнд нэг баримтыг хэлж байна: Бурхан хүнийг бүтээхдээ түүнд оюун ухаан өгсөн. Иймд хүний оюун ухаан Бурханаас ирсэн байна. Энэ бол мадаггүй юм. Гэхдээ яагаад? Бурхан Адамыг бүтээсний дараа Адам сургуульд явсан уу? Тэр уншиж чаддаг байсан уу? Бурхан төрөл бүрийн амьд амьтан бүтээсний дараа Адам тэр бүх амьтныг таньж байсан уу? Тэднийг юу гэж нэрлэдгийг Бурхан түүнд хэлж өгсөн үү? Мэдээж, Бурхан түүнд эдгээр амьтныг яаж нэрлэхийг зааж өгөөгүй. Энэ бол жинхэнэ баримт! Тэгвэл тэр эдгээр амьтанд яаж нэр өгөхийг болон ямар нэр өгөхийг яаж мэдсэн бэ? Энэ нь Адамыг бүтээхдээ Бурхан түүнд юу нэмсэн бэ гэдэг асуултад хамаарах юм. Бурхан хүнийг бүтээхдээ Өөрийн оюун ухааныг түүнд нэмсэн гэдгийг уг баримтууд баталж байна. Энэ бол гол чухал зүйл юм, тиймээс анхааралтай сонс. Энд та бүхний ойлгох ёстой бас нэг чухал зүйл байна: Адам эдгээр амьтанд нэр өгсний дараа тэр нэрс нь Бурханы үгсийн санд байршсан. Би яагаад үүнийг дурдаж байна вэ? Яагаад гэвэл, энэ нь мөн Бурханы зан чанарыг агуулдаг ба үүнийг Би цааш нь дэлгэрэнгүй тайлбарлах ёстой.

Бурхан хүнийг бүтээж, түүнд амийн амьсгал үлээж оруулаад, Өөрийнхөө оюун ухаан, Өөрийн чадвар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохоосоо заримыг нь өгсөн. Бурхан хүнд энэ бүх зүйлийг өгсний дараа хүн бие даан зарим нэг юм хийж, өөрөө бодож сэтгэж чаддаг болсон. Хэрвээ хүний бодож, хийж байгаа зүйл Бурханы нүдэнд сайн харагдаж байвал Бурхан түүнийг зөвшөөрч, саад болдоггүй. Хүний хийж байгаа зүйл зөв бол Бурхан зүгээр орхидог. Иймээс “Адам амьтан бүрийг нэрлэсэн нь тийнхүү тэдний нэр болжээ” гэсэн өгүүлбэр юуг илтгэдэг вэ? Энэ нь, төрөл бүрийн амьтанд өгсөн нэрээс алийг нь ч өөрчлөх хэрэггүй гэж үзсэнийг

илтгэж байна. Адам амьтныг ямраар нэрлэхэд нь Бурхан тухайн амьтны нэрийг батлан “Тийм болог” гэж хэлж байжээ. Тэр хэрэг дээр Бурхан ямар нэг санал бодол илэрхийлсэн үү? Үгүй, Тэр мэдээж тэгээгүй. Та нар эндээс юу олж мэдэв? Бурхан хүнд оюун ухаан өгсөн ба хүн юм хийхдээ Бурханаас заясан оюун ухаанаа ашигласан. Хэрвээ хүний хийдэг зүйл Бурханы нүдэнд эерэг бол Бурхан ямар ч шүүлт, шүүмжлэлгүйгээр баталж, зөвшөөрч, хүлээн авдаг. Энэ нь ямар ч хүн, ямар ч муу ёрын сүнс юм уу, Сатаны хийж чадахгүй зүйл юм. Та нар эндээс Бурханы зан чанарын илэрхийллийг харж байна уу? Хүн төрөлтөн, нэг ялзарсан этгээд, эсвэл Сатан өөрийнх нь өмнөөс яг хамар дор нь юм хийхийг бусдад зөвшөөрөх байсан уу? Мэдээж, үгүй! Тэд өөрсдөөс нь ялгаатай өөр хүн юм уу, өөр хүчтэй энэ байр суурийн төлөө тэмцэх байсан уу? Мэдээж, тэгэх байсан! Хэрвээ тухайн мөчид нэг ялзарсан этгээд юм уу, Сатан Адамтай хамт байсан бол Адамын хийж байсан зүйлийг лав зөвшөөрөхгүй байх байсан. Тэдэнд бие даан бодох чадвар болон өөрийн онцлог ухвар байгаа гэдгийг батлахын тулд тэд Адамын хийсэн бүхнийг ор тас үгүйсгэн, “Чи үүнийг ингэж нэрлэмээр байна уу? Гэхдээ би энийг ингэж нэрлэхгүй, би үүнийг тэгж нэрлэнэ; чи үүнийг Том гэж нэрлэлээ, харин би Харри гэж нэрлэнэ. Би хэчнээн ухаалаг гэдгээ үзүүлэх хэрэгтэй” гэх байлаа. Энэ ямархуу уг чанар вэ? Энэ нь учиргүй биеэ тоосон зан биш гэж үү? Харин Бурхан ямар вэ? Түүнд тийм зан чанар бий юу? Бурхан Адамын хийж байсан зүйлийг хачин байдлаар эсэргүүцсэн үү? Хариулт нь маргаангүй “Үгүй”! Бурханы илчилдэг зан чанарт маргааныч, биеэ тоосон, эсвэл өөрийгөө зөвтгөдөг зан өчүүхэн төдий ч байдаггүй. Энд энэ нь маш тодорхой байна. Хэдийгээр энэ нь ялимгүй зүйл мэт боловч хэрвээ чи Бурханы мөн чанарыг ойлгохгүй бол, хэрвээ зүрх сэтгэл чинь Бурхан яаж ажилладгийг болон Бурханы хандлага юу болохыг ухаарах гэж хичээхгүй бол чи Бурханы зан чанарыг мэдэхгүй, эсвэл Бурханы зан чанарын илэрхийлэл болон илчлэлийг харж чадахгүй. Тийм биш гэж үү? Миний сая тайлбарласан зүйлтэй та нар санал нийлж байна уу? Адамын хийсэн үйлдлийн хариуд Бурхан “Сайн байна. Чи зөв хийлээ. Би зөвшөөрч байна!” гэж чангаар тунхаглаагүй. Гэвч Бурхан зүрх сэтгэл дотроо Адамын хийсэн зүйлийг сайшааж, үнэлж, магтаж байсан. Энэ бол бүтээлийн цаг үеэс хойш Бурханы төлөө Түүний зааврааар хүний хийсэн анхны зүйл байв. Энэ бол Бурханы оронд, Бурханы нэрийн өмнөөс хүний хийсэн зүйл байлаа. Бурханы нүдэнд бол энэ нь Түүний хүнд бэлэглэсэн оюун ухаанаас урган гарсан зүйл байв. Бурхан үүнийг сайн зүйл, эерэг зүйл гэж харсан. Адамын тэр үед хийсэн зүйл нь хүнд байсан Бурханы оюун ухааны анхны илрэл байсан юм. Бурханы үзэл бодлоор бол энэ нь сайн илрэл байлаа. Түүнд юу байгаа, Тэр юу болох болон Өөрийн оюун ухаанаас Бурхан хүнд бага сага шингээсэн нь хүнийг Өөрийг нь илэрхийлэн харуулж чадах амьд бүтээл болгох зорилготой байсан юм гэдгийг Би энд та нарт хэлэхийг хүсэж байна. Учир нь, ийм амьд биет Өөрийнх нь нэрийн өмнөөс юм хийх нь Бурханы хүсэн хүлээсэн яг тэр зүйл байлаа.

3. Бурхан Адам, Ева хоёрт арьсан дээл хийж өгөв

Эхлэл 3:20–21 Адам эхнэрээ Ева гэж нэрлэсэн; учир нь тэр амьд бүхний эх байсан юм. Адам ба түүний эхнэрт Ехова Бурхан арьсан дээл хийж, тэднийг хувцаслав.

Гурав дахь эшлэлийг харцгаая, Адамын Евад өгсөн нэр нь цаанаа үнэхээр утга учиртай гэдгийг энэ нь харуулдаг. Адам бүтээгдсэнийхээ дараа өөрийн гэсэн бодолтой болж, олон зүйлийг ойлгосныг энэ нь харуулдаг. Гэвч одоохондоо бид, тэр юу ойлгосныг болон хэр их юм ойлгосныг судалж шинжлэхгүй, учир нь гурав дахь эшлэлийг хэлэлцэх Миний гол зорилго энэ биш юм. Тэгэхээр Миний онцлон тэмдэглэхийг хүсч буй гол зүйл юу вэ? “Адам ба түүний эхнэрт Ехова Бурхан арьсан дээл хийж, тэднийг хувцаслав” гэсэн мөрийг авч үзье. Хэрвээ бид өнөөдрийн нөхөрлөлөөр бичвэрийн энэ мөрийн талаар хэлэлцэхгүй бол та бүхэн эдгээр үгийн цаад илүү гүн утга учрыг хэзээ ч ойлгохгүй байж магадгүй. Эхлээд Би та нарт зарим нэг сэжүүр өгье. Адам, Ева хоёрын амьдарч байгаа Еден цэцэрлэгийг төсөөлөөд үз. Бурхан тэдэн дээр очиход тэд харин нүцгэн байсан тул нуугддаг. Бурхан тэднийг олж хардаггүй, тэгээд тэднийг дуудахад “Бид нүцгэн байгаа учир Таныг харж зүрхэлсэнгүй” гэж хэлдэг. Тэд нүцгэн байсан учир Бурханыг харж зүрхэлдэггүй. Тэгээд Ехова Бурхан тэдэнд зориулж юу хийдэг вэ? Эх бичвэрт “Адам ба түүний эхнэрт Ехова Бурхан арьсан дээл хийж, тэднийг хувцаслав” гэдэг. Бурхан тэдний хувцсыг юугаар хийснийг та нар үүнээс ойлгов уу? Бурхан тэдний хувцсыг амьтны арьсаар хийсэн. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнд өмсгөхөөр хийсэн хувцас нь арьсан дээл байжээ. Энэ бол хүнд зориулж Бурханы хийсэн анхны хувцас байв. Арьсан дээл гэдэг нь өнөөдрийн стандартаар хээнцэр эд бөгөөд хүн болгоны аваад өмсөж чадах эд биш. Хэрвээ хэн нэгэн чамаас “Манай өвөг дээдсийн өмссөн анхны хувцас нь юу байсан бэ?” гэж асуувал чи: “Арьсан дээл байсан” гэж хариулна. “Энэ арьсан дээлийг хэн хийсэн юм бэ?” Тэгэхэд нь чи: “Бурхан хийсэн!” гэж хариулж чадна. Энэ хувцсыг Бурхан хийсэн гэдэг нь энд гол зүйл юм. Энэ нь ярилцууштай зүй биш гэж үү? Миний дүрсэлснийг сонсоод та нарын оюун санаанд дүр зураг буув уу? Ядаж бүдүүвч зураг ч болтугай байх ёстой. Үүнийг өнөөдөр та нарт хэлсний учир нь хүний анхны хувцас юу байсныг мэдэгдэх гэсэн юм биш. Тэгвэл гол зүйл нь юу вэ? Гол зүйл нь арьсан дээл биш, харин Бурханы илэрхийлсэн зан чанар, Бурханд юу байгаа болон Бурхан юу болохыг Түүний юу хийснээс хүмүүс хэрхэн мэдэж авах явдал юм.

“Адам ба түүний эхнэрт Ехова Бурхан арьсан дээл хийж, тэднийг хувцаслав.” Энэ үзэгдэлд Адам, Ева хоёртой хамт байх үедээ Бурхан ямар үүрэг гүйцэтгэхийг нь бид харж байна вэ? Зөвхөн хоёр хүн амьдардаг ертөнцөд Бурхан Өөрийгөө ямар байдлаар үзүүлсэн бэ? Бурханы үүрэгтэй үзүүлсэн үү? Хонконгийн ах, эгч нар аа, хариулагтун. (Эцэг эхийн үүрэгтэй.) Өмнөд Солонгосын ах, эгч нар аа, Бурхан ямар үүрэгтэй гарч ирсэн гэж та нар бодож байна вэ? (Өрхийн тэргүүний.) Тайваний ах, эгч нар аа, та нар юу гэж бодож байна вэ? (Адам, Евагийн гэр бүлийн гишүүний

дүрээр, гэр бүлийн гишүүний дүрээр.) Та нарын зарим нь Бурханыг Адам, Евагийн гэр бүлийн гишүүн, зарим нь Бурханыг өрхийн тэргүүн, бусад нь эцэг эхийн хувиар гарч ирсэн гэж байна. Эдгээр нь бүгд тун тохиромжтой. Гэвч Би юу гэх гээд байгааг та нар ойлгож байна уу? Бурхан энэ хоёр хүнийг бүтээгээд тэднийг Өөрийн нөхөд гэж үзсэн байна. Тэдний гэр бүлийн ганц гишүүний хувиар Бурхан тэдний амьдралыг анхаарч, хоол, хувцас, оромжинд нь санаа тавьж байлаа. Энд Бурхан Адам, Ева хоёрын эцэг эх болон гарч ирсэн. Бурхан үүнийг хийхэд Бурхан хэр сүрлэг байдгийг нь хүн хардаггүй; Бурханы дээд чанар, Түүний нууцыг болон ялангуяа Түүний уур хилэн, сүр жавхланг хардаггүй. Хүний хардаг нь ердөө л Бурханы даруу байдал, Түүний хайр, хүнд тавих анхаарал, хүний төлөөх хариуцлага, халамж юм. Бурханы Адам, Ева хоёрт хандсан хандлага болон арга зам нь эцэг, эхчүүд хүүхдэдээ хэрхэн анхаарал тавьдагтай ижил билээ. Энэ нь мөн эцэг эх хөвгүүд, охидоо хэрхэн хайрлаж, халамжилж, санаа тавьдагтай адилхан—үнэн бодитой, харагдахуйц, мэдрэгдэхүйц байдаг. Өөрийгөө өндөр, сүр хүчирхэг байр сууринд өргөхийн оронд Бурхан хүнд хувцас хийх гэж Өөрийн гараар арьс хэрэглэсэн. Энэ арьсан дээл нь тэдний ичингүйрлийг далдлах, эсвэл тэднийг хүйтнээс хамгаалахад зориулсан эсэх нь огт хамаагүй. Юу хамаатай гэвэл, хүний биед нөмөргөсөн энэ хувцсыг Бурхан Өөрийн гараар хийсэн явдал юм. Хүмүүс Бурханыг тэгсэн биз гэж төсөөлдөг байж магадгүй шиг зүгээр л бодоод, эсвэл ид шидийн хүчээр хувцас бий болгохын оронд Бурхан хийхгүй, хийх ёсгүй гэж хүн бодох байсан зүйлийг жинхэнээсээ хийсэн байна. Энэ нь шалихгүй юм шиг санагдаж магадгүй—зарим хүн үүнийг дурдах шаардлагагүй гэж үздэг ч байж болзошгүй—гэвч энэ нь Бурханыг дагадаг хэрнээ Түүний талаар бүдэг бадаг санаа бодлоор дүүрсэн аливаа хүнд Түүний жинхэнэ агаад хайр татам байдлыг ухаарах, мөн Түүний үнэнч, даруу байдлыг харах боломж олгодог юм. Энэ нь өөрсдийгөө өндөр бөгөөд агуу гэж боддог тэвчихийн аргагүй биеэ тоосон хүмүүсийг Бурханы үнэн бодитой агаад даруу байдлын өмнө ичсэндээ бардам толгойгоо гудайлгахад хүргэдэг. Энд Бурханы үнэн бодитой агаад даруу байдал нь Түүнийг хэчнээн хайр татам болохыг харах боломжийг хүмүүст улам их олгодог. Эсрэгээрээ хүмүүс зүрх сэтгэлдээ агуулдаг “агуу” Бурхан, “хайр татам” Бурхан ба “бүхнийг чадагч” Бурхан нь маш өчүүхэн, муухай, хүрэх төдийд нурж унахаар болсон юм. Чи энэ мөрийг харж, энэ түүхийг сонсоод ийм юм хийснийх нь төлөө Бурханыг дорд үзэх үү? Зарим хүн тэгж магадгүй, гэхдээ бусдынх нь хувьд тэс ондоо байх болно. Тэд Бурханыг жинхэнэ, хайр татам гэж бодох ба Бурханы чухамхүү энэ жинхэнэ байдал болон хайр татам байдал тэднийг хөдөлгөдөг юм. Тэд Бурханы бодит талыг харах тусмаа Бурханы хайр үнэхээр оршин байгааг, тэдний зүрх сэтгэл дэх Бурханы нөлөөг, Тэр мөч бүрд тэдний хажууд байдгийг төдий чинээ их ойлгож чадна.

Одоо бид хэлэлцүүлгээ өнөө үетэй холбоё. Бурхан бүр эхэндээ Өөрийн бүтээсэн хүмүүсийн төлөө ийм янз бүрийн жижиг сажиг зүйлийг, тэр ч байтугай хүмүүсийн бодож ч зүрхлэхгүй, эсвэл хийнэ гэж ч санахааргүй зарим нэг зүйл хийж

чадсан юм бол өнөөдрийн хүмүүсийн төлөө ийм зүйл хийж чадах болов уу? Зарим хүн “Тийм!” гэж хэлнэ. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, Бурханы мөн чанар хуурамч биш, Түүний хайр татам байдал хуурамч биш. Учир нь, Бурханы мөн чанар үнэхээр оршин байдаг бөгөөд бусдын нэмсэн зүйл биш, өөр өөр цаг хугацаа, газар нутаг, эрин үетэй хамт өөрчлөгддөг зүйл лав биш юм. Бурханы жинхэнэ агаад хайр татам байдал нь үнэндээ хүмүүсийн огт сонирхолгүй, шалихгүй гэж үздэг—Бурхан ер нь хийнэ гэж хүмүүс бодох ч үгүй маш өчүүхэн зүйлсийг хийснээр л илрэн гарч чадна. Бурхан дүр үзүүлдэггүй. Түүний зан чанар болон мөн чанарт ямар ч хэтрүүлэг, хуурамч дүр, бардамнал, биеэ тоосон зан байдаггүй. Тэр хэзээ ч сайрхдаггүй, харин Өөрийнхөө бүтээсэн хүмүүсийг үнэнч байдал, чин сэтгэлээрээ хайрлаж, анхаарал тавьж, халамжилж, залж чиглүүлж байдаг. Хүмүүс үүнээс хэр ихийг нь үнэлж, мэдэрч, ойлгож чадах нь хамаагүй, Бурхан үүнийг хийж байгаа нь огтхон ч эргэлзээгүй билээ. Бурхан ийм мөн чанартай гэдгийг мэдэх нь Бурханыг хайрлах хүмүүсийн хайранд нөлөөлөх үү? Бурханаас эмээхэд нь нөлөөлөх үү? Чи Бурханы бодит талыг ойлгохоороо Түүнд улам ойртон, Түүний хайр, хүн төрөлхтнийг гэх халамжийг илүү үнэнээсээ үнэлж чаддаг болохын зэрэгцээ зүрх сэтгэлээ Бурханд өгч, Түүний талаар элдэв сэжиг, эргэлзээ тээхээ болино гэж Би найдаж байна. Бурхан бүхнийг хүний төлөө дуугүйхэн хийж, энэ бүхнийгээ Өөрийн чин сэтгэл, итгэмжит байдал, хайраар чимээгүйхэн хийж байдаг. Гэвч хийдэг аливаа зүйлдээ зовниж, харамсах явдал Түүнд ер байдаггүй, Түүнд хэн ч, хэзээ ч ямар нэгэн хэлбэрээр хариу төлөх хэрэггүй, бөгөөд эсвэл хүн төрөлхтнөөс ямар ч юм авах санаа Түүнд огт байхгүй. Түүний хийсэн бүх зүйлийн цорын ганц зорилго бол хүн төрөлхтний жинхэнэ итгэл, хайрыг хүлээн авах явдал юм. Эхний сэдвийг үүгээр дуусгая.

Эдгээр хэлэлцүүлэг та нарт тус болов уу? Хэр их тус болов? (Бурханы хайрын тухай илүү их ойлголт, мэдлэгтэй боллоо.) (Нөхөрлөлийн энэ арга цаашид Бурханы үгийг илүү сайн үнэлэхэд, үг хэлж байх үеийнх нь сэтгэл хөдлөл ба хэлсэн зүйлийнх нь утга учрыг ойлгоход болон яг тэр үед юу мэдэрч байсныг нь мэдрэхэд бидэнд тусалж чадна.) Эдгээр үгийг уншсаны дараа та нарын дундаас Бурханы бодит оршин тогтнолыг илүү их мэдэрсэн хүн байна уу? Бурханы оршин тогтнол нь хоосон хөндий, бүдэг бадаг биш гэдгийг мэдэрч байна уу? Та нар нэгэнт ийм мэдрэмжтэй болоод Бурхан яг хажууд чинь байгааг мэдэрч чаддаг уу? Уг мэдрэмж яг одоо тийм ч илт бус, эсвэл та нар үүнийг хараахан мэдэрч чадахгүй байж магадгүй. Гэвч нэг л өдөр та нар зүрх сэтгэлдээ Бурханы зан чанар болон мөн чанарыг үнэнээсээ ихэд үнэлж, бодитой мэдлэгтэй болохдоо Бурхан яг хажууд чинь байгааг мэдэрнэ—чи л Бурханыг зүрх сэтгэлдээ хэзээ ч жинхэнээсээ хүлээн авааагүй. Энэ нь үнэн юм.

Та нар нөхөрлөлийн энэ аргын талаар юу гэж бодож байна? Та нар хоцроогүй биз? Бурханы ажил болон Бурханы зан чанарын талаарх ийм нөхөрлөл маш хүнд гэж та нар бодож байна уу? Та нарт ямар санагдсан бэ? (Маш сайхан, баяртай байна.) Та нарт юу нь сайхан санагдав? Та нар яагаад баярлав? (Еден цэцэрлэгт

буцаад очсон юм шиг, Бурханы хажууд очсон юм шиг байлаа.) “Бурханы зан чанар” гэдэг нь үнэндээ хүмүүст нэг их танил бус сэдэв, учир нь, чиний төсөөлдөг зүйл, номоос уншиж, нөхөрлөлөөс сонссон зүйл чинь сохор хүн заанд хүрч байгаа шиг санагдуулах хандлагатай байдаг—чи гараараа л тэмтчих боловч үнэндээ юу ч дүрслэн харж чаддаггүй. Сохроор тэмтчээд Бурханы тухай тодорхой санаа байтугай бүдүүн тойм ойлголт ч өгч чадахгүй; энэ нь чиний төсөөллийг улам лөдөөж, Бурханы зан чанар болон мөн чанар яг юу болохыг нарийн тодорхойлоход чинь саад хийх бөгөөд чиний төсөөллөөс урган гарах тодорхойгүй зүйлс зүрх сэтгэлийг чинь эргэлзээгээр тогтмол дүүргэнэ. Чи ямар нэгэн зүйлийн талаар итгэлтэй байж чадахгүй атлаа бас ойлгох гэж оролдоход зүрх сэтгэлд чинь үргэлж зөрчил, тэмцэл, бүр түгшүүр төрүүлэн баримжаа алдуулж, будлиулдаг. Чи Бурханыг хайхыг, Бурханыг мэдэхийг, Түүнийг тодхон харахыг хүсэж байгаа боловч үргэлж хариуг нь олж чадахгүй байвал маш зовлонтой хэрэг биш үү? Мэдээж, эдгээр үг нь зөвхөн Бурханыг эмээн хүндэлж, Бурханыг хангалуун байлгахыг хүсдэг хүмүүст чиглэсэн. Ийм зүйлд ямар ч анхаарал хандуулдаггүй хүмүүст энэ үнэндээ хамаагүй, учир нь, тэд Бурханы бодит байдал болон оршин тогтнол нь домог юм уу, санааны зохиол төдий байгаасай л гэж найддаг, тэгвэл тэд юу дуртайгаа хийж чадна, тэгвэл хамгийн том, хамгийн чухал хүмүүс болж чадна, тэгвэл үр дагаврыг нь тоолгүйгээр муу үйл үйлдэж чадна, тэгээд ямар ч шийтгэл хүлээхгүй, ямар ч хариуцлага үүрэхгүй, тэр ч бүү хэл, мууг үйлдэгчдийн тухай Бурханы хэлсэн зүйлс тэдэнд хамаарахгүй. Энэ хүмүүс Бурханы зан чанарыг ойлгохыг хүсдэггүй. Бурханыг болон Түүний тухай бүхнийг мэдэх гэж оролдохоос үхтэлээ залхдаг. Тэд Бурхан оршдоггүй байсан нь дээр гэж үздэг. Энэ хүмүүс Бурханыг эсэргүүцдэг бөгөөд таягдан хаягдах хүмүүсийн тоонд багтдаг юм.

Дараа нь бид Ноагийн түүх болон энэ нь Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурханы Өөрийнх нь тухай сэдэвт хэрхэн холбогддог тухай хэлэлцэнэ.

Бичвэрийн энэ хэсэгт Бурхан Ноад юу хийж байгааг та нар харж байна вэ? Энд сууж байгаа хүн бүр уг бичвэрийг уншаад энэ талаар зарим нэг зүйлийг мэдэж авсан байх: Бурхан Ноагаар бүхээг бариулаад дараа нь үерээр дэлхийг устгасан. Бурхан Ноад найман хүнтэй гэр бүлээ аврах бүхээг барьж, тэднийг амьд үлдээд хүн төрөлхтний дараагийн үеийн өвөг дээдэс болохыг зөвшөөрсөн юм. Одоо Библиэс уншицгаая.

II. Ноа

1. Бурхан дэлхийг үерээр устгахаар төлөвлөж, Ноад бүхээг барих заавар өгсөн нь

Эхлэл 6:9–14 Ноагийн үр удам энэ билээ: Ноа бол зөв шударга хүн, үеийнхнийхээ дунд төгс бөгөөд Бурхантай хамт явдаг байв. Ноа Шем, Хам, Иафет хэмээх гурван хүү төрүүлсэн. Газар дэлхий бас Бурханы өмнө завхарч, дэлхий хүчирхийллээр дүүрчээ. Бурхан ажиглаж харахад дэлхий завхарсан байлаа; учир нь газар дэлхий дээрх мах цустай

бүхний зам завхарсан байв. Бурхан Ноад хандан: “Мах цустай бүхний төгсгөл Миний өмнө ирлээ; тэднээс болж газар дэлхий хүчирхийллээр дүүрч байгаа учир Би тэднийг газартай нь сүйрүүлнэ. Чи говор модоор өөртөө бүхээг хий; бүхээг дотроо тасалгаанууд гаргаж, дотор гаднагүй давирхайгаар давирхайд” гэв.

Эхлэл 6:18–22 “Харин Би чамтай гэрээ байгуулна; чи өөрийн эхнээр, хөвгүүд, бэрүүдтэй цуг тэр бүхээгт орно. Мөн өөртэйгөө хамт амьд үлдээхийн тулд чи мах цустай амьтан бүрээс эр, эмийг хосоор нь бүхээгт оруул. Амьд үлдээхийн тулд жигүүртэн шувуудын төрөл төрлөөс, адгуус амьтдын төрөл төрлөөс, газраар мөлхдөг бүхний төрөл төрлөөс хосоороо чам дээр очно. Чи идэх бүх хоол хүнсээ өөртөө авч цуглуул; энэ нь чиний болон тэдний хоол болно” гэв. Ноа тийнхүү үйлдэв; тэрээр Бурханы өөрт нь тушаасан бүхнийг ёсоор нь гүйцэтгэжээ.

Энэ хоёр хэсгийг уншсаны дараа та нар Ноа гэж хэн болох талаар ерөнхий ойлголттой болов уу? Ноа ямар хүн бэ? Эх бичигт “Ноа бол зөв шударга хүн, үеийнхнийхээ дунд төгс” гэж байна. Орчин үеийн хүмүүсийн ойлголтоор бол тэр үед “шударга” хүн гэж ямар хүн байсан бэ? Шударга хүн бол төгс хүн байх учиртай. Энэ төгс хүн нь хүмүүсийн нүдэнд төгс хүн үү, эсвэл Бурханы нүдэнд төгс үү гэдгийг та нар мэдэх үү? Энэ төгс хүн нь хүмүүсийн нүдэнд биш, харин Бурханы нүдэнд төгс хүн байх нь эргэлзээгүй. Энэ бол гарцаагүй! Учир нь, хүн сохор бөгөөд харж чадахгүй, зөвхөн Бурхан л газар дэлхийг бүхлээр нь, мөн хүн нэг бүрийг ажиглаж байдаг тул Ноа төгс хүн гэдгийг зөвхөн Бурхан л мэднэ. Иймд дэлхийг үерээр устгах Бурханы төлөвлөгөө нь Ноаг дуудсан мөчөөс эхэлсэн.

Тэр эрин үед Бурхан маш чухал нэг зүйл хийхийн тулд Ноаг дуудах гэсэн. Энэ ажлыг яагаад хийх хэрэгтэй болсон бэ? Яагаад гэвэл, тухайн мөчид Бурханы зүрх сэтгэлд нэгэн төлөвлөгөө байлаа. Тэр дэлхийг үерээр устгах төлөвлөгөөтэй байв. Яагаад дэлхийг устгана гэж? Энд ингэж хэлсэн байна: “Газар дэлхий бас Бурханы өмнө завхарч, дэлхий хүчирхийллээр дүүрчээ.” “Дэлхий хүчирхийллээр дүүрчээ” гэсэн өгүүлбэрээс та нар юу ойлгож байна вэ? Энэ нь дэлхий болон түүний хүмүүс хэтэртлээ ялзрахад тохиолддог үзэгдэл юм; үүнээс үүдэн “дэлхий хүчирхийллээр дүүрчээ” гэжээ. Өнөөдрийн хэлээр “хүчирхийллээр дүүрчээ” гэдэг нь бүх юм эмх замбараагүй байна гэсэн үг юм. Хүний хувьд энэ нь нийгмийн бүх анги давхаргад дэг журам байхгүй, юмс бүгд замбараагүй бөгөөд удирдах аргагүй болсон гэсэн утгатай. Бурханы нүдэнд бол дэлхийн хүмүүс дэндүү ялзарсан гэсэн үг байв. Харин ямар хэмжээнд хүртэл ялзарсан бэ? Бурхан цаашид харж тэвчихгүй, энэ талаар цаашид хүлцэж чадахаа болих хүртэл хэмжээнд ялзарсан. Бурхан тэднийг устгахаар зорих хэмжээнд хүртлээ ялзарсан юм. Бурхан дэлхийг устгахаар шийдэхдээ нэгэн бүхээг барих хүн олохоор төлөвлөсөн. Бурхан энэ ажлыг гүйцэтгүүлэхээр Ноаг сонгосон; Ноагаар бүхээг бариулах гэсэн. Яагаад Ноаг сонгосон бэ? Бурханы нүдэнд Ноа бол зөв шударга хүн байсан; Бурхан юу ч гэж зааварласан бай, Ноа ёсоор нь хийжээ. Өөрөөр хэлбэл, Бурханы юу хий гэснийг нь

Ноа хийхэд бэлэн байжээ. Өөртэй нь хамт ажиллаж, Өөрийнх нь даалгасныг гүйцээж—газар дээрх ажлыг нь гүйцээх ийм хүн олохыг Бурхан хүссэн. Тэр үед ийм ажлыг гүйцээж чадах хүн Ноагаас өөр байсан уу? Огтхон ч үгүй! Ноа бол Бурханы даалгасан зүйлийг гүйцээж чадах цорын ганц тохирох хүн байсан тул Бурхан түүнийг сонгосон. Гэхдээ тэр үед хүмүүсийг аврах Бурханы стандарт, хязгаар нь өнөөгийнхтэй адил байсан уу? Хариулт нь гэвэл, мэдээж ялгаа бий! Би яагаад үүнийг асууж байна вэ? Тэр үед Ноа бол Бурханы үзэхэд, цорын ганц зөв шударга хүн байсан ба харин эхнэр нь ч, хөвгүүд ба бэрүүдийн аль нь ч зөв шударга хүмүүс байгаагүй боловч Ноаг бодоод Бурхан энэ хүмүүсийг зүгээр орхисон. Бурхан тэдэнд шаардлага тавихдаа одоогийнх шиг байдлаараа тавиагүй, харин Ноагийн гэрийн бүх найман гишүүнийг амьд үлдээсэн. Тэд Ноагийн зөвт байдлын ачаар Бурханы ерөөлийг хүртсэн юм. Ноа байгаагүй бол тэдний хэн нь ч Бурханы даалгасан зүйлийг гүйцээж чадахгүй байсан билээ. Иймд Ноа бол тэр үеийн дэлхийн сүйрлээс амьд гарах ёстой цорын ганц хүн байсан бөгөөд бусад нь зүгээр л хөндлөнгийн завшаантнууд юм. Бурхан Өөрийн удирдлагын ажлыг албан ёсоор эхлэхээс өмнөх эринд хүмүүст хандаж, тэднээс шаардаж байсан зарчим ба стандарт нь харьцангуй зөөлөн байсан гэдгийг энэ харуулдаг. Ноагийн гэрийн найман хүнд хандсан Бурханы байдал өнөөгийн хүмүүст “шударга ёсоор” дутмаг мэт харагддаг. Гэвч одоо хүмүүс дээр Түүний хийдэг ажлын далайц, Түүний дамжуулдаг үгийнх нь хэмжээтэй харьцуулахад Ноагийн гэрийн найман хүнд хандсан Бурханы хандлага нь тухайн үеийн Түүний ажлын цаад шалтгааныг авч үзэхэд ердөө л ажлын зарчим байсан юм. Харьцуулбал, найман хүнтэй Ноагийнх, Бурханаас илүү ихийг авсан уу, эсвэл одоогийн хүмүүс ихийг авдаг уу?

Ноа дуудагдсан нь энгийн нэг баримт боловч бидний ярих гэж байгаа гол зүйл болох энэ тэмдэглэл дэх Бурханы зан чанар, Түүний хүсэл, Түүний мөн чанар нь тйим ч энгийн биш. Бурханы энэ хэдэн талыг ойлгохын тулд бид эхлээд Бурхан ямар төрлийн хүнийг дуудахыг хүсдэг вэ гэдгийг ойлгоод, үүгээрээ Түүний зан чанар, Түүний хүсэл болон мөн чанарыг ойлгох ёстой. Энэ бол маш чухал. Тэгэхээр Бурханы дууддаг хүн Бурханы нүдэнд чухам ямар төрлийн хүн байдаг вэ? Энэ нь Түүний үгийг сонсож, Түүний зааврыг дагаж чаддаг хүн байх ёстой. Үүний зэрэгцээ энэ нь хариуцлагатай агаад Бурханы үгийг биелүүлэхээр хүлээсэн хариуцлага, үүрэг гэж үзэн гүйцэтгэх хүн байх ёстой. Тэгвэл ийм хүн Бурханыг мэддэг хүн байх хэрэгтэй юу? Үгүй. Тэр үед Ноа Бурханы сургаалыг тийм ч их сонсоогүй ба Бурханы ямар ч ажлыг мэдрээгүй байсан. Иймд Ноа Бурханы тухай маш бага мэдлэгтэй байв. Энд Ноаг Бурхантай хамт явдаг байсан гэж бичсэн боловч тэр Бурханы үнэн биеийг ер нь харсан уу? Хариулт нь, яавч үгүй! Яагаад гэвэл, тэр үед зөвхөн Бурханы элч нар л хүмүүсийн дунд ирдэг байсан. Тэд аливааг хэлж, хийхдээ Бурханыг төлөөлдөг байсан ч Бурханы хүсэл, санаа зорилгыг дамжуулдаг төдий байсан юм. Бурхан хүнтэй нүүр тулан үнэн биеэ илчлээгүй. Бичвэрийн энэ хэсгээс бид үндсэндээ энэ Ноа гэдэг хүн юу хийх ёстой байсан, мөн түүнд өгсөн Бурханы

заавар юу байсныг хардаг. Тэгэхээр энд Бурханы илэрхийлсэн мөн чанар нь юу байсан бэ? Бурханы хийдэг бүхэн чамбай төлөвлөгддөг. Тэр ямар нэгэн зүйл, үйл явдал үүсэхийг харахдаа Түүний нүдэнд үүнийг хэмжих стандарт байдаг ба энэ стандарт нь үүнийг шийдэх төлөвлөгөө эхлүүлэх эсэхийг, эсвэл энэ зүйл, үйл явдлыг шийдэхдээ ямар арга барилаар хандахыг нь тодорхойлдог. Тэр бүх зүйлд тоомжиргүй, эсвэл хайхрамжгүй байдаггүй. Үнэндээ бүр эсрэгээрээ байдаг. Бурханы Ноад хэлсэн нэг мөр энд байна: “Мах цустай бүхний төгсгөл Миний өмнө ирлээ; тэднээс болж газар дэлхий хүчирхийллээр дүүрч байгаа учир Би тэднийг газартай нь сүйрүүлнэ.” Бурхан үүнийг хэлэхдээ Тэр зөвхөн хүмүүсийг устгана гэсэн үү? Үгүй! Бурхан мах цустай амьд бүхнийг устгана гэж хэлсэн. Бурхан яагаад сүйрэл хүссэн бэ? Бурханы зан чанарын бас нэг илэрхийлэл энд байна: Бурханы нүдэнд бол, хүний ялзрал, мах цустай бүхний бузар булай, хүчирхийлэл, дуулгаваргүй байдалд хандах Түүний тэвчээрт хязгаар байдаг. Түүний хязгаар юу вэ? Бурханы хэлснээр “Бурхан ажиглаж харахад дэлхий завхарсан байлаа; учир нь газар дэлхий дээрх мах цустай бүхний зам завхарсан байв.” “Учир нь газар дэлхий дээрх мах цустай бүхний зам завхарсан байв” гэсэн хэллэг ямар утгатай вэ? Энэ нь Бурханыг дагаж байсан, Бурханы нэрийг дуудсан, Бурханд нэгэнтээ шатаалт тахил өргөсөн, Бурханыг үгээр хүлээн зөвшөөрсөн, бүр Бурханыг магтаж байсан хүмүүсийг оролцуулаад бүх амьд амьтан гэсэн үг—нэгэнт тэдний үйлдэл ялзралаар дүүрч, Бурханы нүдэнд өртсөн тул Тэр тэднийг устгах хэрэгтэй болсон юм. Тэр нь Бурханы хязгаар байлаа. Тэгэхээр хүнийг болон мах цустай бүхний ялзралыг Бурхан ямар хэмжээнд хүртэл тэвчсэн бэ? Бурханыг дагагчид ч бай, эсвэл үл итгэгчид ч бай бүх хүн бүгдээрээ зөв замаар явахаа болих хүртэл нь. Хүн зүгээр нэг ёс суртахууны хувьд ялзарч, ёрын муу бүхнээр дүүрснээр үл барам ертөнцийг Бурхан захирдаг, Бурхан хүмүүст гэрэл гэгээ болон зөв замыг авчирч чадна гэдэгт итгэдэг хүн байтугай, Бурханы оршин тогтнолд итгэдэг хүн байхгүй болох хүртэл нь. Хүн Бурханы оршин тогтнолд зэвүүцэж, Бурханы оршин тогтнолыг зөвшөөрөхгүй болох хүртэл нь. Хүн төрөлхтний ялзрал энэ цэгт хүрэхэд Бурхан цаашид тэвчиж чадахаа больсон. Үүнийг нь юу орлох вэ? Бурханы уур хилэн ба Бурханы шийтгэл. Энэ нь Бурханы зан чанарын илчлэлийн нэг хэсэг биш байсан гэж үү? Одоогийн энэ эрин үед Бурханы нүдэнд зөв шударга хүн бас л бий юу? Бурханы нүдэнд төгс хүн бас л бий юу? Энэ эрин үе нь Бурханы нүдэнд бол, газар дээрх мах цустай бүхний үйлдэл ялзарсан үе мөн үү? Эдүгээ Бурханы бүрэн төгс болгохыг хүсдэг хүмүүсээс, Бурханыг дагаж, Түүний авралыг хүлээн авч чадах хүмүүсээс бусад мах цуснаас бүрдсэн бүх хүн Бурханы тэвчээрийн хязгаарыг сорьж байгаа биш гэж үү? Өдөр бүр энэ ертөнц дээр та нарын хажууд тохиолддог, та нарын нүдээрээ харж, чихээрээ сонсдож, биеэрээ амсдаг бүхэн хүчирхийллээр дүүрэн биш гэж үү? Бурханы үзэхэд, ийм ертөнц, ийм эрин үеийг дуусгавал зохилтой бус уу? Одоогийн эрин үеийн цаад нөхцөл нь Ноагийн үеийн цаад нөхцөл байдлаас огт өөр боловч хүний ялзралд хандах Бурханы мэдрэмж болон уур хилэн

нь яг тэр үеийнхтэйгээ адилхан хэвээрээ. Бурхан Өөрийн ажлаас болоод тэвчиж чаддаг боловч бүхий л төрлийн нөхцөл, байдалд бол Бурханы нүдэнд энэ ертөнц аль хэдийн устгагдах ёстой байсан. Нөхцөл байдал нь дэлхийг үерээр устгасан тэр үеийнхээс ч долоон дор байна. Гэхдээ ялгаа нь юу вэ? Энэ нь бас Бурханы зүрх сэтгэлийг хамгийн их гуниглуулдаг зүйл бөгөөд та нарын хэн нь ч үүнийг ухамсарлаж чадахгүй зүйл байж магадгүй.

Бурхан дэлхийг үерээр устгахдаа Ноаг бүхээг барих болон зарим бэлтгэл ажил хийлгэхээр дуудаж чадсан. Бурхан Өөртөө энэ олон зүйлийг хийлгэхээр Ноа хэмээх нэг хүнийг дуудаж чадсан юм. Гэвч одоогийн энэ эрин үед Бурханд дуудах хүн үгүй болжээ. Яагаад ийм байна вэ? Энд сууж байгаа хүн нэг бүр уг шалтгааныг сайн мэдэж, тодорхой ойлгодог байх. Би үүнийг та нарт хэлэх хэрэгтэй юу? Үүнийг чанга хэлбэл та бүхний нүүрийг улайлгаж, хүн бүрийг хямрааж магадгүй. Зарим хүн: “Хэдийгээр бид Бурханы нүдэнд зөв шударга бус, төгс бус хүмүүс боловч хэрвээ Бурхан бидэнд ямар нэг зүйл хий гэж зааварчилбал бид түүнийг нь хийж чадах л юм. Өмнө нь, сүйдтэй гамшиг ирж байгаа тухай Түүнийг хэлэхэд бид гамшгийн үед хэрэг болох хүнс болон бусад зүйлсийг бэлдэж эхэлсэн. Энэ бүхэн нь Бурханы шаардлагын дагуу хийгдээгүй гэж үү? Бид Бурханы ажилтай үнэхээр хамтран ажиллаагүй гэж үү? Бидний хийсэн эдгээр зүйлийг Ноагийн хийсэнтэй харьцуулж болохгүй юм гэж үү? Бидний тэгж хийж байсан нь жинхэнэ дуулгавартай байдал биш гэж үү? Бид Бурханы зааврыг дагаж байгаагүй гэж үү? Бид Бурханы үгэнд итгэдэг учраас л Бурханы хэлснийг хийгээгүй гэж үү? Тэгвэл яагаад Бурхан гунигласаар байна вэ? Дуудах хүн нэг ч алга гэж Бурхан яагаад хэлдэг вэ?” Та нарын үйлдэл болон Ноагийн үйлдлийн хооронд ялгаа байна уу? Ялгаа нь юу вэ? (Өнөөдөр гамшигт зориулж хүнс бэлдэх нь бидний өөрсдийн санаа байсан.) (Бидний үйлдэл “зөв шударга”, байж чаддаггүй байхад Ноа бол Бурханы нүдэнд зөв шударга хүн юм.) Та нарын хэлсэн зүйл нэг их хол зөрсөнгүй. Ноагийн хийсэн зүйл нь одоогийн хүмүүсийн хийж байгаа зүйлээс эрс ялгаатай юм. Ноа Бурханы зааврыг дагаж байхдаа Бурханы санаа зорилго юу байсныг мэдээгүй. Бурхан юу биелүүлэхийг хүсэж байгааг тэр мэдээгүй. Бурхан түүнд зөвхөн тушаал өгч, их тайлбарлалгүйгээр нэг юм хий гэж зааварласан бөгөөд Ноа ёсоор болгож, түүнийг нь хийсэн. Тэрээр дотроо Бурханы санаа зорилгын учрыг олох гэж оролдоо ч үгүй, Бурханыг эсэргүүцээ ч үгүй, мөн хуурамч зан гаргаа ч үгүй. Тэр явж очоод л цайлган, эгэл сэтгэлээр зохих ёсоор нь хийсэн. Бурханы юу л хий гэснийг хийсэн бөгөөд дуулгавартай байж, Бурханы үгийг сонссон нь түүний аливааг хийх итгэл үнэмшил байлаа. Бурханы даалгасан зүйлийг тэр ингэж шулуухан, энгийнээр хариуцаж авсан юм. Түүний мөн чанар—түүний үйлдлүүдийн мөн чанар нь, таамаглах, эсэргүүцэх, түүнчлэн хувийн ашиг сонирхлыг болон өөрийн олз, гарзын талаар бодох явдал биш, харин дуулгавартай байдал байсан юм. Цаашлаад, Бурхан дэлхийг үерээр устгана гэж хэлэхэд Ноа хэзээ гэдгийг нь асуугаагүй, эсвэл юу тохиолдохыг асуугаагүй, мөн Бурханаас дэлхийг хэрхэн устгах гэж байгааг лав

асуугаагүй. Тэр зүгээр л Бурханы зааварласнаар хийсэн. Бурхан яаж хийхийг, юугаар хийхийг хүссэнчлэн бүхнийг яг Бурханы хэлснээр хийсэн бөгөөд бас даруйхан ажлаа эхэлсэн. Тэр Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг хүссэн хандлагатайгаар Бурханы зааврын дагуу үйлдсэн. Тэр өөрийгөө гамшгаас зайлуулахын тулд үүнийг хийсэн үү? Үгүй. Бурханаас ертөнцийг сөнөөх хүртэл хэр хугацаа үлдсэнийг асуусан уу? Асуугаагүй. Тэр бүхээг барихад хэр удахыг Бурханаас асуусан уу, эсвэл өөрөө мэдэж байсан уу? Тэр үүнийг бас мэдээгүй. Тэр зүгээр л дуулгавартай байж, сонсож, ёсоор нь хийсэн. Одоогийн хүмүүс ийм биш юм: Бурханы үгээс жаахан л мэдээлэл цухалзмагц, салхинд навчис сэржигнэх төдийхнийг мэдэрмэгцээ хүмүүс юу ч хамаагүй, ямар ч үнээр хамаагүй хожим идэж, уух, хэрэглэх зүйлээ, тэр ч байтугай гамшиг тохиолдоход зугтах замаа ч төлөвлөх гэж гэнэт ирмүүн ажилладаг. Үүнээс ч илүү сонирхолтой нь, энэ чухал мөчид “ажил амжуулахдаа” хүний тархи маш сайн байдаг. Бурхан ямар ч заавар өгөөгүй нөхцөлд хүн юм бүхнийг маш тохиромжтойгоор төлөвлөж чаддаг. Та нар ийм төлөвлөгөөг дүрслэхдээ “төгс” гэдэг үгийг хэрэглэж болох юм. Харин Бурханы хэлдэг зүйл, Бурханы санаа зорилго, Бурханы хүсэж буй зүйлийн талаар бол хэн ч хайхардаггүй ба ойлгох гэж оролддоггүй. Энэ нь одоогийн хүмүүс болон Ноагийн хоорондох хамгийн том ялгаа биш гэж үү?

Ноагийн түүхийн тухай энэ тэмдэглэлээс та нар Бурханы зан чанарын нэг хэсгийг харав уу? Хүний ялзрал, бузар булай, хүчирхийлэлд хандах Бурханы тэвчээрт хязгаар байдаг. Тэрхүү хязгаарт хүрэхэд Тэр цаашид тэвчихээ больж, харин шинэ удирдлага, шинэ төлөвлөгөөгөө эхлэх ба хийх ёстой зүйлээ хийж, Өөрийн үйл хэргийг болон Өөрийн зан чанарын нөгөө талыг илчилж эхэлдэг. Түүний энэ үйлдэл нь Түүнд хүмүүс хэзээ ч халдаж болохгүй гэдгийг юм уу, эсвэл Тэр эрх мэдэл, уур хилэнгээр дүүрэн гэдгийг харуулахын тулд биш бөгөөд хүн төрөлхтнийг устгаж чадна гэдгийг харуулахын тулд ч биш юм. Энэ нь, Түүний зан чанар болон Түүний ариун мөн чанар нь иймэрхүү хүн төрөлхтнийг Түүний өмнө, Түүний эрх мэдэл дор цаашид амьдрахыг зөвшөөрч, тэвчээд байж чадахгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн бүгдээрээ Түүний эсрэг байж, бүхий л дэлхий дээр Түүний аварч чадах нэг ч хүн байхгүй болоход Тэр ийм хүн төрөлхтнийг цаашид тэвчихээ болих ба ийм хүн төрөлхтнийг устгах Өөрийн төлөвлөгөөг эргэлзэж тээнэгэлзэлгүй хэрэгжүүлнэ. Бурханы энэ үйл нь Түүний зан чанараар тодорхойлогддог. Энэ бол зайлшгүй үр дагавар бөгөөд Бурханы эрх мэдэл дор байгаа бүтээгдсэн зүйл бүрийн үүрэх ёстой үр дагавар юм. Энэ нь, одоогийн эрин үед Бурхан Өөрийн төлөвлөгөөг дуусгаж, Өөрийн аврахыг хүсэж байгаа хүмүүсийг аврахаар тэсэн яддагийг харуулахгүй байна гэж үү? Ийм нөхцөлд Бурхан юунд хамгийн их санаа тавьдаг вэ? Түүнийг огт дагадаггүй хүмүүс, эсвэл Түүнийг юу ч гэсэн эсэргүүцдэг хүмүүс Түүнд яаж хандаж, Түүнтэй яаж мөчөөрхдөг, эсвэл хүн төрөлхтөн Түүнийг яаж гүжирдэж байгаад биш. Зөвхөн Өөрийг нь дагадаг хүмүүс буюу Түүний удирдлагын төлөвлөгөөн дэх авралын бай нь Түүгээр бүрэн төгс

болгуулсан эсэх, мөн тэд Түүний сэтгэл ханамжид хүрсэн эсэх талаар л санаа тавьдаг. Түүнийг дагадгаас бусад хүмүүсийн тухайд бол Тэр Өөрийн уур хилэнг илэрхийлэхийн тулд хаяа нэг бага зэрэг шийтгэл үзүүлдэг төдий. Жишээ нь: цунами, газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт гэх мэт. Үүний зэрэгцээ Тэр бас Өөрийг нь дагадаг ба Өөрөө аврах гэж байгаа хүмүүсийг хүчтэй хамгаалж, харж ханддаг. Бурханы зан чанар бол энэ: Нэг талаар, Тэр бүрэн гүйцэд болгох гэж байгаа хүмүүстээ туйлын их тэвчээр, хүлээцтэй байж, тэднийг чадах чинээгээрээ удаан хүлээдэг; нөгөө талаар, Өөрийг нь дагадаггүй, Өөрийг нь эсэргүүцдэг Сатаны төрлийн хүмүүсийг туйлгүй үзэн ядаж, жигшдэг. Сатаны төрлийн энэ хүмүүс Өөрийг нь дагаж, Өөрийг нь шүтэн мөргөдөг эсэхийг Тэр тоодоггүй хэдий боловч зүрх сэтгэлдээ тэднийг тэвчихийн хамт тэднийг мөн л зэвүүцдэг бөгөөд Сатаны төрлийн энэ хүмүүсийн төгсгөлийг шийдэнгээ Өөрийн удирдлагын төлөвлөгөөний алхмууд ирэхийг бас хүлээж байна.

Дараагийн хэсгийг харцгаая.

2. Үерийн дараа Ноад өгсөн Бурханы ерөөл

Эхлэл 9:1–6 Бурхан Ноа болон түүний хөвгүүдийг ерөөж, “Өсөн үржиж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ. Газар дэлхий дээрх бүх араатан амьтан, огторгуйн бүх жигүүртэн шувууд та нараас айж, та нараас эмээнэ; газар дээрх шавьж бүхэн, далайн бүх загасыг та нарын гарт өгнө. Амьд амьтад та нарын хоол болно; та нарт хүнсний ногоо өгсөн шигээ Би бүх зүйлийг та нарт өгсөн. Гэхдээ та нар тэдний махыг амьтай нь буюу цустай нь идэж болохгүй. Та нарын цусыг урсгаж, амийг хөнөөсөн араатан бүрээс, мөн хүний гараас Би амийн цусыг гарцаагүй нэхнэ; хүний ах дүү бүрийн гараас ч Би хүний амийг нэхнэ. Хүний цус урсгасан хэний ч цус хүний гараар урсана: учир нь Бурхан хүнийг Өөрийн дүрээр бүтээсэн билээ” гэв.

Та нар энэ хэсгээс юу юу ойлгож байна вэ? Би яагаад эдгээр эшлэлийг сонгосон бэ? Би яагаад Ноа ба түүний гэр бүлийн бүхээг дээр байсан үеийнх нь амьдралын тухай эшлэл сонгоогүй вэ? Яагаад гэвэл, тэрхүү мэдээлэл нь бидний өнөөдрийн ярилцаж буй сэдэвтэй нэг их холбоогүй. Бидний анхаарах зүйл бол Бурханы зан чанар юм. Хэрвээ та нар тэр тухай дэлгэрэнгүй мэдмээр байвал Библи аваад өөрсдөө уншаарай. Бид тэр тухай энд ярихгүй. Өнөөдрийн бидний ярилцах хамгийн гол сэдэв бол Бурханы үйл хэргийг хэрхэн мэдэх тухай юм.

Ноа Бурханы зааврыг хүлээн авч, бүхээг барьж, Бурхан дэлхийг үерээр сөнөөж байсан өдрүүдэд амь зогоож, найман хүнтэй гэр бүл нь бүтнээрээ амьд гарсан. Найман ам бүлтэй Ноагийнхаас бусад бүх хүн төрөлхтөн устсан, газар дэлхий дээрх бүх амьд юм устсан. Ноад Бурхан ерөөлөө хайрлаад түүнд болон хөвгүүдэд нь хэдэн үг хэлсэн. Эдгээр үг нь Бурханы түүнд хайрлаж байсан зүйлс, мөн Бурханы түүнд өгсөн ерөөл байсан юм. Энэ бол Түүнийг сонсож, Түүний зааврыг хүлээн авч чаддаг хүнд өгдөг Бурханы ерөөл, амлалт бөгөөд энэ нь бас хүмүүсийг шагнадаг

Бурханы арга юм. Өөрөөр хэлбэл, Бурханы нүдэнд Ноа төгс хүн, эсвэл зөв шударга хүн байсан эсэхээс үл хамааран, Бурханы талаар хэр зэрэг мэддэг байснаас үл хамааран, товчхондоо, Ноа ба түүний гурван хүү бүгдээрээ Бурханы үгийг сонсож, Бурханы ажилд хамтарч, Бурханы зааврын дагуу хийх ёстой зүйлээ хийсэн. Үр дүнд нь тэд Бурханы удирдлагын төлөвлөгөөний дараагийн алхамд асар их хувь нэмэр оруулж, дэлхий үерт сүйрсний яг дараа Бурханы төлөө хүмүүс болон төрөл бүрийн амьд зүйлийг эсэн мэнд авч үлдсэн. Хийсэн бүхнийх нь төлөө Бурхан түүнийг ерөөжээ. Өнөөдрийн хүмүүсийн хувьд Ноагийн хийсэн зүйл дурдахын ч хэрэггүй юм байж магадгүй. Тэр ч байтугай “Ноа юу ч хийгээгүй, Бурхан түүнийг үлдээхээр шийдсэн болохоор тэр мэдээж үлдэх байсан. Ололт амжилтынхаа ачаар тэр амь гарсан биш. Бурхан ийм юм болохыг хүссэн, учир нь хүн бол идэвхгүй” гэж зарим хүн бодож магадгүй. Гэвч энэ нь Бурханы бодож байсан юм биш билээ. Хүн агуу, эсвэл өчүүхэн байх нь Бурханд хамаагүй, Түүнийг сонсож, тэд Түүний заавар, Түүний даалгасан зүйлд дуулгавартай хандаж, Түүний ажил, Түүний хүсэл, Түүний төлөвлөгөөтэй хамтран ажиллаж чаддаг ба тэгснээр Түүний хүсэл болон Түүний төлөвлөгөө төвөггүй хэрэгжиж байх л юм бол тэдний тийм зан төлөв Түүнд дурсагдахуйц, Түүний ерөөлийг хүртэхүйц байх юм. Бурхан тийм хүмүүсийг эрхэмлэдэг ба тэдний үйлдэл, Өөрийг нь гэсэн тэдний хайр, сэтгэлийг нандигнадаг. Энэ бол Бурханы хандлага юм. Тэгэхээр Бурхан яагаад Ноаг ерөөсөн бэ? Яагаад гэвэл, хүний тийм үйлдэл, дуулгавартай байдалд Бурхан ингэж ханддаг юм.

Бурхан Ноаг ерөөсөн тухайд зарим хүн: “Хэрвээ хүн Бурханыг сонсож, Бурханыг хангалуун болгож байвал Бурхан хүнийг ерөөх ёстой. Энэ нь зүй ёсны хэрэг биш гэж үү?” гэж хэлнэ. Бид ингэж хэлж болох уу? Зарим хүн: “Болохгүй” гэдэг. Бид яагаад тэгж хэлж болохгүй вэ? Зарим хүн: “Хүн бол Бурханы ерөөлийг эдлэхэд зохисгүй” гэж хэлдэг. Энэ яг зөв биш юм. Яагаад гэвэл, хүн Бурханы даалгасан зүйлийг хүлээн авах үед тэр хүний үйлдлийн сайн, муу эсэхийг, түүний дуулгавартай байсан эсэхийг, Бурханы хүслийг хангалуун байлгасан эсэхийг болон түүний хийдэг зүйл тэнцэх эсэхийг шүүх стандарт Бурханд байдаг. Бурханы анхаардаг зүйл нь хүний гадна талын үйлдэл биш, харин хүний зүрх сэтгэл юм. Хүн яаж хийхийг үл харгалзан ямар нэг зүйл хийж л байвал Бурхан хүнийг ерөөх ёстой гэсэн үг биш. Энэ бол Бурханы тухай хүмүүст байдаг буруу ойлголт юм. Бурхан юмны зөвхөн эцсийн үр дүнг хардаггүй, харин аливаа зүйл явагдах хугацаанд хүний зүрх сэтгэл ямар байгааг болон хүний хандлага ямар байгааг илүү онцлон анхаардаг ба тэдний зүрх сэтгэлд дуулгавартай байдал, тоомсор болон Бурханыг хангалуун байлгах хүсэл байгаа эсэхийг хардаг. Тэр үед Ноа Бурханы талаар хэр их мэддэг байсан бэ? Одоо та нарын мэддэг сургаал шиг их байсан уу? Бурханы тухай ухагдахуун болон мэдлэг гэх мэт үнэний талын хувьд тэрээр та нартай адил хэмжээний усалгаа, хариулга хүлээн авсан уу? Үгүй ээ, тэгээгүй! Гэвч энд үгүйсгэхийн аргагүй нэг баримт байна: Одоогийн хүмүүсийн ухамсар, оюун санаа, зүрх сэтгэлийнх нь гүнд байгаа Бурханы тухай ухагдахуун болон хандлага бүдэг

бадаг бөгөөд тодорхойгүй. Хүмүүсийн нэг хэсэг нь Бурханы оршин тогтнолд үгүйсгэсэн хандлагаар ханддаг гэж ч хэлж болно. Харин Ноа зүрх сэтгэл, ухамсартаа Бурханы оршин тогтнолд бүрэн дүүрэн, өчүүхэн ч эргэлзээгүй итгэдэг байсан тул түүний дуулгавартай байдал хольцгүй байсан ба туршилтыг тэсвэрлэж чадсан. Түүний зүрх сэтгэл цэвэр бөгөөд Бурханд нээлттэй байсан. Бурханы үг бүрийг дагахад өөрийгөө итгүүлэхийн тулд түүнд онолын нэг их мэдлэг хэрэггүй байсан ба Бурханы даалгасныг хүлээн авч чадахын тулд, мөн Бурханы хий гэсэн бүхнийг хийх чадвартай байхын тулд Бурханы оршин тогтнолыг батлах олон баримт ч хэрэггүй байсан. Энэ бол Ноа болон өнөөдрийн хүмүүсийн хоорондын мөн чанарын ялгаа ба Бурханы нүдэнд төгс хүн чухам ямар байх тухай жинхэнэ тодорхойлолт юм. Бурхан Ноа шиг хүмүүсийг хүсдэг. Тэр бол Бурханы магтдаг, мөн Бурханы ерөөдөг чухам тийм төрлийн хүн юм. Та нар үүнээс гэгээрэл олж авав уу? Хүмүүс хүмүүсийг гаднаас нь хардаг байхад Бурханы хардаг зүйл нь хүний зүрх сэтгэл, мөн чанар юм. Өөрт нь дурамжхан, эргэлзсэн байдлаар хандахыг Бурхан хэнд ч зөвшөөрдөггүй ба мөн Өөрийг нь ямар ч байдлаар сэжиглэх юм уу, туршихыг хүмүүст зөвшөөрдөггүй. Иймээс өнөөдрийн хүмүүс Бурханы үгтэй нүүр тулдаг—Бурхантай нүүр учирдаг гэж хэлж ч болох атал зүрх сэтгэлийнх нь гүнд байдаг ямар нэг зүйлээс, завхарсан мөн чанар байдгаас, Бурханд дайсагнадаг хандлагаасаа болоод Бурханд итгэх жинхэнэ итгэл нь боогдож, Түүнд дуулгавартай байх нь хаагддаг. Үүнээс болоод Бурханы Ноад хайрласантай адил ерөөлийг олох нь тэдний хувьд маш хэцүү юм.

Одоо бид Бурхан солонгыг хүмүүстэй хийсэн Өөрийн гэрээний тэмдэг болгосон тухай хэсгийг бичвэрээс харцгаая.

3. Бурхан солонгыг хүмүүстэй хийсэн Өөрийн гэрээний тэмдэг болгосон нь

Эхлэл 9:11–13 Би та нартай гэрээ байгуулах ба мах цустай бүхнийг дахиж үерийн усаар устгахгүй; газар дэлхийг сүйрүүлэх үер дахиад болохгүй. Тэгээд Бурхан: “Миний та нартай болон та нартай хамт байгаа амьд амьтан болгонтой үеийн үед хийх гэрээний тэмдэг нь энэ: Би үүлэнд солонго татуулах ба энэ нь дэлхий бид хоёрын хоорондын гэрээний тэмдэг байх болно” гэв.

Ихэнх хүн солонго гэж юу болохыг мэддэг ба солонготой холбоотой зарим түүх сонссон. Библи дэх солонгын тухай түүхийн хувьд гэвэл, зарим хүн үүнд итгэж, зарим нь үүнийг домог гэж үздэг байхад бусад нь ерөөсөө итгэдэггүй. Ямар ч байсан солонготой холбоотой тохиолдсон бүх үйл явдал нь Бурханы ажил бөгөөд хүнийг удирдах Бурханы удирдлагын үйл явцад болсон билээ. Эдгээр зүйлийг Библид яг нарийн тэмдэглэсэн байдаг. Эдгээр тэмдэглэл нь тэр үед Бурханы ааш аяг ямар байсныг, эсвэл Бурханы хэлсэн эдгээр үгийн цаана ямар санаа зорилго байсныг бидэнд хэлдэггүй. Түүнчлэн Бурхан эдгээр үгийг хэлж байхдаа ямар

мэдрэмжтэй байсныг хэн ч мэдэж чаддаггүй. Гэвч энэ бүхэл үйл явдлын талаар Бурханы сэтгэл санааны байдал нь бичвэрийн цаад утгаас илэрч байна. Бурханы тэр үеийн бодол нь Түүний айлдварын үг, хэллэг бүрээр дамжин хуудаснаас даруй тодрон гарч ирэх мэт байдаг.

Бурханы сэтгэл бодол бол хүмүүсийн хамгийн их анхаарах ёстой зүйл бөгөөд мэдэж авах гэж хичээвэл зохих зүйл юм. Учир нь Бурханы бодол нь Бурханы талаарх хүний ойлголттой салшгүй холбоотой бөгөөд Бурханы тухай хүний ойлголт нь хүний амийн оролтод зайлшгүй чухал зангилаа юм. Тэгвэл эдгээр үйл явдал тохиолдох үед Бурхан юу бодож байсан бэ?

Анх Бурхан Өөрийнхөө үзлээр маш сайн бөгөөд Өөртөө ойр хүн төрөлхтөн бүтээсэн боловч тэд Түүний эсрэг боссоны дараа тэднийг үерээр устгасан. Ийм хүн төрөлхтөн хоромхон зуур ингэж алга болсон нь Бурханыг шаналгасан уу? Мэдээж, шаналгасан! Тэгвэл Тэр энэ зовнилоо юугаар илэрхийлсэн бэ? Энэ нь Библид хэрхэн тэмдэглэгдсэн бэ? Энэ нь Библид ийнхүү тэмдэглэгджээ: “Би та нартай гэрээ байгуулах ба мах цустай бүхнийг дахиж үерийн усаар устгахгүй; газар дэлхийг сүйрүүлэх үер дахиад болохгүй.” Энэ энгийн өгүүлбэр нь Бурханы бодлыг илчилж байна. Дэлхийн энэ сүйрэл Түүнийг маш их шаналгасан. Хүний үгээр бол Тэр маш гунигтай байсан юм. Бид ингэж төсөөлж болно: Нэгэнтээ амиар дүүрэн байсан дэлхий үерт устсаны дараа ямархуу харагдаж байсан бол? Нэгэнтээ хүн төрөлхтнөөр дүүрэн байсан дэлхий тэр үед ямархуу харагдаж байсан бол? Хүний суурьшил үгүй, амьд зүйл үгүй, хаа сайгүй ус, усны гадаргуу дээр жинхэнэ сүйрэл байсан. Бурхан дэлхий ертөнцийг бүтээх үед иймэрхүү дүр зураг Түүний анхдагч санаа зорилго байсан уу? Мэдээж үгүй! Бурханы анхдагч санаа бол бүх газар нутаг даяар амьдрал цэцэглэхийг харах, Түүнийг шүтэн мөргөдөг ганц хүн нь, эсвэл Түүний дуудлагад хариу өгч, даалгасан зүйлийг нь гүйцээдэг ганц хүн нь Ноа биш, харин Өөрийнх нь бүтээсэн хүмүүс Өөрт нь шүтэн мөргөж байхыг харах явдал байлаа. Хүн төрөлхтөн алга болоход Бурхан Өөрийн анх төлөвлөж байсан зүйлийг бус, харин шал эсрэг зүйлийг харсан. Түүний зүрх яаж шаналахгүй байж чадах юм бэ? Иймд Өөрийн зан чанарыг илчилж, Өөрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлж байх үедээ Бурхан шийдвэр гаргасан. Тэр ямар шийдвэр гаргасан бэ? Бурхан дахиж хүн төрөлхтнийг үерээр устгахгүй хэмээн амлаж, хүнтэй байгуулсан гэрээ болгон үүлэнд нум (өөрөөр хэлбэл, бидний хардаг солонго) хийх шийдвэр. Мөн үүний зэрэгцээ энэ нь хүмүүст Бурхан нэгэн цагт дэлхийг үерээр сөнөөсөн гэдгийг хэлж, Бурхан яагаад ийм зүйл хийснийг хүнд үүрд сануулахын тулд байсан.

Тэр удаа дэлхийг устгах нь Бурханы хүссэн зүйл байсан уу? Бурханы хүссэн зүйл огт биш байсан нь дамжиггүй. Бид дэлхийн сүйрлийн дараа газар дэлхий ямар эмгэнэлтэй байсны өчүүхэн хэсгийг төсөөлөн бодож чадах боловч тэр үед Бурханы нүдэнд ямар дүр зураг харагдаж байсныг дөхүүлэн төсөөлж чадахгүй юм. Дэлхийг үерээр сөнөөсний дараах дүр зургийг хараад Бурханы сэтгэл санаа ямар байсныг одоогийн ч юм уу, эсвэл тэр үеийн хүмүүсээс хэн нь ч төсөөлж, ойлгох чадваргүй

гэхэд болно. Хүний дуулгаваргүй байдал Бурханыг ийм юм хийхэд хүргэсэн боловч үерт устсан дэлхийн энэ сүйрлээс болж Бурханы амссан сэтгэлийн шаналал нь нэг ч хүний ойлгож үнэлж эс чадах бодит үнэн юм. Тийм учраас Бурхан нэгэнтээ иймэрхүү юм хийсэн гэдгийг хүмүүст сануулах гэж, мөн Бурхан дахиж ийм маягаар дэлхийг хэзээ ч сөнөөхгүй гэж тэдэнд амлахаар зорьж хүн төрөлхтөнтэй гэрээ байгуулжээ. Энэ гэрээнээс бид Бурханы зүрх сэтгэлийг хардаг ба хүн төрөлхтнийг устгах үед Бурханы зүрх сэтгэл шаналж байсныг хардаг. Хүний хэлээр бол, Бурхан хүн төрөлхтнийг устгах үедээ, хүн төрөлхтөн алга болж байгааг харах үедээ зүрх нь шимширч, элэг нь эмтэрч байсан. Бид үүнээс илүү дүрсэлж чадна гэж үү? Эдгээр үгийг хүмүүс хүний сэтгэл хөдлөлийг дүрслэхэд хэрэглэдэг ба хүний хэл дэндүү хомсдох боловч Бурханы мэдрэмж, сэтгэл хөдлөлийг дүрслэхэд Надад бол тийм ч муугүй, бас дэндүү хэтрүүлээгүй санагдаж байна. Энэ нь та нарт дор хаяж Бурханы сэтгэл санаа тэр үед ямар байсан тухай маш бодитой, маш тохиромжтой ойлголт өгч байна. Одоо та нар дахиж солонго харахаараа юу бодох вэ? Ядаж л та нар Бурхан нэгэнтээ дэлхийг үерээр сөнөөсөндөө гунигтай байсныг санана. Бурхан энэ дэлхийг үзэн ядаж, хүн төрөлхтөнд зэвүүцэж байсан ч Өөрийн гараар бүтээсэн хүн төрөлтнийг устгах үедээ Түүний зүрх сэтгэл зовуурилж, зөнд нь хаяж ядан дурамжхан, тэсвэрлэхийн аргагүй болж байсныг та нар санах болно. Түүний цорын ганц тайтгарал нь найман хүнтэй Ноагийн гэр бүл байв. Ноагийн хамтын ажиллагаа нь Түүний бүх зүйлийг бүтээсэн уйгагүй зүтгэлийг талаар болгоогүй юм. Бурханыг зовж байх үед энэ нь л Түүний зовуурийг намдаах ганц зүйл байв. Тэр үеэс Бурхан хүн төрөлхтөнд зориулсан бүх найдвараа Ноагийн гэр бүлд тавьж, тэднийг Түүний хараал дор биш, Түүний ерөөл дор амьдарч чадна гэж найдан, дэлхийг Бурхан дахиж үерээр устгахыг тэд хэзээ ч харахгүй, бас өөрсдөө ч устгагдахгүй гэж найджээ.

Эндээс бид Бурханы зан чанарын аль хэсгийг ойлгох хэрэгтэй вэ? Хүн Түүнтэй дайсагнадаг тул Бурхан хүнийг үзэн ядсан боловч Түүний зүрх сэтгэлд хүн төрөлхтөнд зориулсан анхаарал, халамж, өршөөл нь өөрчлөгдөлгүй үлдсэн. Тэрээр хүн төрөлхтнийг устгасан хэдий ч Түүний зүрх сэтгэл хувиралгүй хэвээр үлдсэн. Хүн төрөлхтөн ялзралаар дүүрч, Бурханд ноцтой хэмжээгээр дуулгаваргүй хандахад Бурхан Өөрийн зан чанар, мөн чанараас үүдэж, мөн Өөрийн зарчмын дагуу энэхүү хүн төрөлхтнийг устгах хэрэгтэй болсон. Гэвч Өөрийнхөө мөн чанараас үүдэн Бурхан хүн төрөлхтнийг бас өрөвдсөн бөгөөд хүн төрөлхтнийг цаашид амьдруулахын тулд тэднийг золин аврах янз бүрийн арга зам хэрэглэхийг хүртэл хүсэж байв. Гэтэл хүн Бурханыг эсэргүүцэж, Бурханд дуулгаваргүй байсаар, Бурханы авралыг хүлээн авахаас татгалзсан; өөрөөр хэлбэл, Түүний сайн санааг хүлээн авахаас татгалзсан. Бурхан тэднийг яаж ч дуудаад, тэдэнд яаж ч сануулж, тэднийг хангаж, тусалж, тэдэнд хүлээцтэй хандсан ч хамаагүй, хүмүүс үүнийг нь ойлгоогүй, үнэлээгүй бөгөөд ямар ч анхаарал хандуулаагүй. Бурхан шаналж байхдаа хүний ухаарч өөрчлөгдөхийг хүлээн хүнд Өөрийн дээд зэргийн тэвчээрийг

хайрлахаа бас л мартаагүй билээ. Тэр Өөрийн хязгаарт хүрснийхээ дараа хийх ёстой зүйлээ ямар ч эргэлзээгүйгээр хийжээ. Өөрөөр хэлбэл, Бурхан хүн төрөлхтнийг устгахаар төлөвлөсөн мөчөөс хүн төрөлхтнийг устгах Түүний ажлын албан ёсны эхлэл хүртэл тодорхой цаг хугацаа, үйл явц байсан. Энэ үйл явц нь хүнд ухаарч өөрчлөгдөх боломж олгох зорилготой байсан ба энэ нь Бурханы хүнд өгсөн сүүлчийн боломж байв. Тэгвэл Бурхан хүн төрөлхтнийг устгахын өмнөх энэ хугацаанд юу хийсэн бэ? Бурхан ихээхэн хэмжээний санuулах, ятгах ажил хийсэн. Түүний зүрх сэтгэл хэчнээн их шаналж, гуньж байсан ч Тэрээр хүмүүст анхаарал, халамж, өгөөмөр өршөөлөө хайрласаар л байсан. Бид үүнээс юу ойлгож байна вэ? Эргэлзээгүйгээр, хүн төрөлхтнийг гэх Бурханы хайр нь зүгээр нэг дэмжсэн дүр үзүүлэх явдал биш, харин үнэн бодитой гэдгийг ойлгож байна. Энэ нь бодитой, мэдрэгдэхүйц, мэдэгдэхүйц бөгөөд бачтай, хуурамч, мэхэлсэн, эсвэл дүр үзүүлсэн зүйл биш юм. Бурхан хайр татам гэдгээ хүмүүст харуулахын тулд хэзээ ч, ямар ч заль мэх хэрэглэж, хуурамч дүр зураглал бүтээдэггүй. Тэр Өөрийн хайр татам байдлыг хүмүүст харуулахын тулд, эсвэл Өөрийн хайр татам болон ариун байдлыг гайхуулахын тулд хэзээ ч хуурамч гэрчлэл хэрэглэдэггүй. Бурханы зан чанарын эдгээр тал нь хүний хайрыг хүртүүштэй бус уу? Тэдгээрийг шүтэн мөргүүштэй биш гэж үү? Тэдгээрийг нандигнууштай биш гэж үү? Одоо Би та нараас ингэж асуумаар байна: Эдгээр үгийг сонссоныхоо дараа та нар Бурханы агуу байдлыг зүгээр л цаасан дээрх үгс гэж бодож байна уу? Бурханы хайр татам байдал нь зүгээр л хоосон үг юм уу? Үгүй! Мэдээж үгүй! Бурханы дээдийн дээд байдал, агуу, ариун байдал, хүлээц, хайр гэх зэрэг—Бурханы зан чанар болон мөн чанарын олон янзын тал нэг бүрийн нарийн ширийн нь ажлаа хийх бүрд нь бодитоор илэрхийлэгдэж, хүнд хандсан Түүний хүсэлд шингэсэн ба хүн нэг бүр дээр хэрэгжиж, тусагдаж байдаг. Чи үүнийг өмнө нь мэдэрч байсан эсэхийг үл харгалзан Бурхан хүн бүрийн сэтгэлийг дулаацуулж, сүнсийг сэргээхийн тулд Өөрийн чин зүрх сэтгэл, мэргэн ухаан болон янз бүрийн аргыг хэрэглэн, хүн бүрийг боломжийн бүх аргаар халамжилж байна. Энэ бол маргаангүй үнэн юм. Энд хэдэн ч хүн сууж байгаа нь хамаагүй, хүн бүр Бурханы хүлээц, тэвчээр болон хайр татам байдлын талаар өөр өөр туршлага, мэдрэмжтэй байгаа. Бурханы тухай эдгээр туршлага, эдгээр мэдрэмж, эсвэл Түүний тухай ойлголт—товчхондоо, энэ бүх эерэг зүйл Бурханаас үүдэлтэй. Тэгэхээр Бурханы тухай хүн бүрийн туршлага, мэдлэгийг нэгтгэн, өнөөдөр Библиэс уншсан зүйлтэйгээ нийлүүлэхээр та нар одоо Бурханы талаар илүү үнэн бодитой, зүй зохистой ойлголттой болж байна уу?

Энэ түүхийг уншиж, энэ үйл явдал дээр Бурханы харуулсан зарим зан чанарыг ойлгоод та нар Бурханы талаар ямар шинэ мэдлэгтэй болсон бэ? Энэ нь та нарт Бурхан болон Түүний зүрх сэтгэлийн талаар илүү гүнзгий ойлголт өгсөн үү? Одоо та нар Ноагийн түүхийг дахин харахдаа өөрөөр үздэг үү? Та нарын бодлоор бол Библийн энэ мөрүүдийг нөхөрлөх хэрэггүй байсан уу? Одоо бид үүнийг нөхөрлөсний дараа та нар тэгэх шаардлагагүй гэж бодож байна уу? Гарцаагүй

шаардлагатай байсан! Бидний уншсан зүйл хэдийгээр нэг түүх боловч энэ нь Бурханы нэгэнтээ хийсэн ажлын тухай үнэн тэмдэглэл юм. Миний зорилго бол та нарт эдгээр түүхийн нарийн ширийнийг, эсвэл энэ дүрийг дэлгэрэнгүй ойлгуулах гэсэн биш, та нараар энэ дүрийг судлуулах гэсэн биш, мөн та нараар Библийг дахиад судлуулах гэсэн юм огт биш. Та нар ойлгож байна уу? Тэгээд Бурханы тухай та нарын мэдлэгт эдгээр түүх тус болов уу? Энэ түүх Бурханы тухай та нарын мэдлэгт юу нэмэрлэсэн бэ? Хонконгийн ах, эгч нар аа, бидэнд хэлээч. (Бурханы хайр бол бидэн шиг ялзарсан хүмүүсийн эзэмшдэг зүйл биш гэдгийг бид ойлгосон.) Өмнөд Солонгосын ах, эгч нар аа, бидэнд хэлээч. (Хүнийг гэсэн Бурханы хайр үнэн бодитой. Хүнийг гэсэн Бурханы хайр нь Түүний зан чанар болон Түүний агуу, ариун байдал, дээдийн дээд байдал болон Түүний хүлээцийг агуулдаг. Бид энэ талаар илүү гүнзгий ойлгох гэж оролдууштай.) (Нөхөрлөлөөр яг тэр үедээ нэг талаас би Бурханы зөвт бөгөөд ариун зан чанарыг харж чаддаг ба мөн хүн төрөлхтний төлөөх Бурханы санаа зовнил, хүнийг өршөөх Бурханы өршөөл болон Бурханы хийж байгаа бүхэн, Түүний бодол санаа бүхэн нь хүн төрөлхтнийг гэсэн Түүний хайр, санаа зовнилын илэрхийлэл гэдгийг харж чаддаг.) (Хүн төрөлхтөн ноцтой хэмжээнд хүртэл муу ёрын болсны улмаас Бурхан дэлхийг үерээр сөнөөсөн ба Бурхан тэднийг үзэн яддаг байсан тул хүн төрөлхтнийг устгасан гэж урьд нь би ойлгодог байсан. Өнөөдөр Бурхан Ноагийн тухай түүхийг ярьж, Бурханы элэг эмтэрч байсан гэж хэлсний дараа л би Бурхан тэр хүмүүсийг зөнд нь хаяхдаа үнэндээ дурамжхан байсан гэдгийг ухаарлаа. Хүн төрөлхтөн хэтэрхий дуулгаваргүй байсан учраас л Бурхан тэднийг устгахаас өөр аргагүй болсон юм байна. Үнэндээ, тэр үед Бурханы зүрх сэтгэл маш гунигтай байжээ. Эндээс би Бурханы зан чанар дахь хүн төрөлхтнийг гэсэн халамж, санаа зовнилыг ойлгож байна. Үүнийг би өмнө нь мэдээгүй.) Маш сайн байна! Дараа нь та нар ярьж болно. (Үүнийг сонссоны дараа миний сэтгэл их хөдөллөө. Урьд би Библийг уншсан боловч бидэнд Өөрийгөө мэдүүлэхийн тулд Бурхан эдгээр зүйлийг шууд задлан шинжилж байсныг би өнөөдрийнх шиг хэзээ ч мэдрээгүй. Бурхан Библийг ойлгуулахын тулд биднийг ийнхүү хөтлөн залсан нь хүний ялзралаас өмнөх Бурханы мөн чанар нь хүн төрөлхтнийг гэсэн хайр, халамж байсан гэдгийг надад мэдүүлж чадлаа. Хүн төрөлхтөн ялзарснаас эхлээд одоогийн эцсийн өдрүүд хүртэл Бурхан зөвт зан чанартай хэвээр хэдий боловч Түүний хайр, халамж нь өөрчлөгдөөгүй. Энэ нь хүн ялзарсан эсэхээс үл хамааран бүтээлийн цаг үеэс одоог хүртэл Бурханы хайрын мөн чанар хэзээ ч өөрчлөгдөөгүйг харуулдаг.) (Өнөөдөр би Бурханы мөн чанар нь цаг хугацаа болон Түүний ажлын байрлал өөрчлөгдсөнөөс үүдэн хувирч өөрчлөгддөггүй гэдгийг харлаа. Бурхан дэлхий ертөнцийг бүтээж байгаа, эсвэл хүнийг ялзарсны дараа үүнийг устгаж байгаа нь хамаагүй, Түүний хийсэн бүхэн утга учиртай бөгөөд Түүний зан чанарыг агуулдаг гэдгийг бас харлаа. Тиймээс би Бурханы хайр хязгааргүй бөгөөд хэмжээлшгүй гэдгийг, мөн бусад ах, эгч нарын дөнгөж сая дурдсанчлан дэлхийг устгах үедээ хүн төрөлхтөнд өгсөн Бурханы

анхаарал халамж болон өршөөлийг ч бас харлаа.) (Эдгээр нь үнэндээ миний мэддэггүй байсан зүйлс юм. Өнөөдөр сонсоод би Бурхан бол үнэхээр итгэл хүлээсэн, үнэхээр найдвартай, итгүүштэй бөгөөд Тэр үнэхээр оршин байдаг гэдгийг мэдэрч байна. Бурханы зан чанар болон хайр үнэхээр ийм бодитой гэдгийг би зүрх сэтгэлдээ жинхэнээсээ ойлгож чадна. Энэ бол өнөөдөр үүнийг сонссоны дараах миний сэтгэгдэл юм.) Онц сайн! Та нар сонссон бүхнээ зүрх сэтгэлдээ хүлээн авсан юм шиг байна.

Та нар өнөөдрийн нөхөрлөсөн Библийн бүх түүхийг оролцуулаад Библийн бүх эшлэлээс нэг юм анзаарав уу? Бурхан хэзээ нэг цагт Өөрийн бодлыг, эсвэл хүн төрөлхтнийг гэсэн Өөрийн хайр, халамжийг илэрхийлэх гэж Өөрийнхөө хэлийг ер нь хэрэглэж байсан уу? Тэрээр энгийн хэл хэрэглэн хүн төрөлхтөнд хэр их санаа тавьж, хайрладаг гэдгээ хэлснийг батлах тэмдэглэл бий юу? Үгүй. Үгүй биз дээ? Та бүхний дунд Библийг болон Библиэс өөр ном уншсан хүмүүс олон бий. Та нарын дунд ийм үг харсан хүн байна уу? Хариулт нь мэдээж үгүй! Учир нь, Бурханы үг болон Бурханы ажлын баримтыг агуулсан Библийн тэмдэглэлд Бурхан, Өөрийн сэтгэлийг дүрслэх, эсвэл хүн төрөлхтнийг гэсэн Өөрийн хайр, халамжийг илэрхийлэх гэж ямар ч эринд, ямар ч цаг үед Өөрийн арга барилыг ашиглаж байгаагүй ба Өөрийн сэтгэл санаа болон сэтгэл хөдлөлийг илэрхийлэхдээ Бурхан, яриа буюу ямар нэгэн үйлдлийг хэзээ ч ашиглаагүй—энэ нь баримт биш гэж үү? Би яагаад ингэж хэлж байна вэ? Би яагаад үүнийг дурдах хэрэгтэй вэ? Яагаад гэвэл, үүнд бас Бурханы хайр татам байдал болон Түүний зан чанар илэрдэг.

Бурхан хүн төрөлхтнийг бүтээсэн; тэд ялзарсан эсэхээс, эсвэл Түүнийг дагадаг эсэхийг үл харгалзан Бурхан, хүн төрөлхтнийг Өөрийн хамгийн их нандигнадаг хайртай хүмүүс—буюу хүмүүсийн хэлдгээр Түүний хувьд энхрий дотно хүмүүс—гэж үздэг болохоос биш, Өөрийн тоглоом шиг үздэггүй. Бурхан Өөрийгөө Бүтээгч, хүнийг Өөрийн бүтээл гэж хэлдэг нь тэдний хооронд зэрэг зиндааны жаахан ялгаа байгаа мэт сонсогдож болох боловч бодит байдал дээр хүн төрөлхтний төлөө Бурханы хийсэн бүхэн нь ийм чанарт харилцаанаас хавьгүй илүү давсан байдаг. Бурхан хүн төрөлхтнийг хайрлаж, хүн төрөлхтнийг халамжилж, тэдэнд санаа тавьдгаа үзүүлдгээс гадна мөн хүн төрөлхтнийг тасралтгүй, тогтмол хангадаг. Зүрх сэтгэлдээ Тэр үүнийгээ хэзээ ч нэмэлт ажил, эсвэл маш их гавьяатай зүйл гэж боддоггүй. Мөн Тэр хүн төрөлхтнийг аварч, тэднийг хангаж, тэдэнд бүх зүйлийг өгч байгаагаа хүн төрөлхтөнд асар их хувь нэмэр оруулж байна гэж ч боддоггүй. Тэр зүгээр л хүн төрөлхтнийг Өөрийн арга замаар, Өөрийн мөн чанар болон Түүнд юу байгаа, Тэр юу болохоороо дамжуулан чимээгүйхэн, дуугүй хангаж байдаг. Хүн Түүнээс хэчнээн их хангалт, хэр их тусламж авч байдаг нь хамаагүй, Бурхан хэзээ ч гавьяа гэж боддог ч үгүй, гавъяа болгох гэж оролддог ч үгүй. Энэ нь Бурханы мөн чанараар тодорхойлогддог ба Бурханы зан чанарын жинхэнэ илэрхийлэл юм. Ийм учраас бид, Бурхан Өөрийн бодлыг илэрхийлснийг Библиэс ч, эсвэл өөр аливаа номоос ч ерөөсөө олж үзэхгүй, түүнчлэн Бурхан эдгээр зүйлийг яагаад хийдэг,

эсвэл хүн төрөлхтний төлөө яагаад ингэж их санаа тавьдаг гэдгээ Өөртөө талархуулж, Өөрийгөө магтуулах гэсэн зорилгоор хүмүүст тайлбарласныг нь юм уу, зарласныг нь ерөөсөө олж үзэхгүй. Тэр гомдож, зүрх сэтгэл нь туйлын их шимширч байхдаа ч гэсэн хүн төрөлхтний өмнө хүлээсэн хариуцлагаа, хүн төрөлхтний төлөөх халамжаа хэзээ ч мартдаггүй; энэ бүх зовуурь, шаналгааг Тэр ганцаараа чимээгүйхэн тэсвэрлэж байдаг. Харин ч Бурхан хүн төрөлхтнийг үргэлж хангасан шигээ хангасаар байдаг. Хүн төрөлхтөн Бурханыг байнга магтаж, эсвэл Түүнд гэрчлэл хийдэг ч гэсэн эдгээр явдлын алийг нь ч Бурхан шаардаагүй юм. Учир нь, хүн төрөлхтөнд зориулан хийдэг сайн зүйлсийнхээ нэгийг нь ч талархлаар солих, эсвэл хариу төлөөс авах гэсэн санаа Бурханд ерөөсөө байдаггүй. Нөгөө талаар, Бурханаас эмээж, муугаас зайлдаг, Бурханыг чин сэтгэлээсээ дагадаг, Түүнийг сонсож, Түүнд үнэнч байдаг болон Түүнд дуулгавартай байдаг хүмүүс Бурханы ерөөлийг байнга хүртэх бөгөөд Бурхан ийм ерөөлийг харамгүй хайрлана. Түүнчлэн хүмүүсийн Бурханаас хүртдэг ерөөл нь тэдний төсөөллөөс байнга давсан байдаг ба мөн хүмүүс хийсэн зүйлээрээ, эсвэл төлсөн төлөөсөөрөө сольж чадахааргүй байдаг. Хүн төрөлхтөн Бурханы ерөөлийг эдэлж байхад Бурхан юу хийж байгаа талаар анхаардаг хүн байна уу? Бурханы сэтгэл ямар байгаад санаа тавьдаг хүн байдаг уу? Бурханы шаналлыг ойлгох гэж хичээдэг хүн байдаг уу? Эдгээр асуултын хариулт нь: Хэрхэвч үгүй! Тэр үед Бурханы мэдэрч байсан шаналлыг Ноаг оролцуулаад ямар ч хүн ойлгож чадах уу? Бурхан яагаад тийм гэрээ байгуулсныг хүн ойлгож чадах уу? Чадахгүй! Хүн төрөлхтөн Бурханы шаналлыг үнэлдэггүй нь Бурханы шаналлыг ойлгож чаддаггүйгээс болдог бус, мөн Бурхан хүн хоёрын хоорондын зайнаас юм уу, тэдний байр суурийн ялгаанаас ч болдог юм биш; харин хүн төрөлхтөн Бурханы ямар ч мэдрэмжийг огт тоодоггүйгээс болдог. Бурхан бол бие даасан тул хүмүүс Түүнд санаа тавих, Түүнийг ойлгох юм уу, Түүнийг анхаардгаа харуулах нь Бурханд хэрэггүй гэж хүн төрөлхтөн боддог. Бурхан бол Бурхан, иймээс Тэр өвддөггүй, сэтгэлийн хөдөлгөөнгүй; Тэр гуниглахгүй, уй гашууг мэдэрдэггүй, Тэр бүр уйлдаг ч үгүй. Бурхан бол Бурхан, иймээс Түүнд сэтгэл хөдлөлийн ямар ч илэрхийлэл хэрэггүй бөгөөд Түүнд сэтгэл санааны тайтгарал хэрэггүй. Хэрвээ ямар нэг нөхцөлд эдгээр нь Түүнд хэрэгтэй болбол Тэр үүнийг Өөрөө шийдвэрлэх ба хүн төрөлхтнөөс ямар ч тусламж шаардахгүй. Харин ч “сул дорой, төлөвшөөгүй” хүмүүст л Бурханы тайтгарал, хангалт, зоригжуулалт хэрэгтэй байдаг ба Бурхан тэдний сэтгэл хөдлөлийг цаг үргэлж, хаана ч байсан тайвшруулах хэрэгтэй байдаг. Хүн төрөлхтний сэтгэлийн гүнд ийм юм бүгж байдаг: Хүн бол сул дорой; тэднийг Бурхан бүх талаар харж хандах ёстой, Бурханаас авдаг бүх халамжийг тэд хүртэж, өөрсдийнх нь гэж бодож байгаа бүхнээ Бурханаас шаардах ёстой. Бурхан бол хүч чадалтай; Түүнд бүх юм бий, Тэрээр хүн төрөлхтний хамгаалагч, мөн ерөөл хүртээгч байх учиртай. Тэрээр хэдийний Бурхан бөгөөд бүхнийг чадагч учраас хүн төрөлхтнөөс Түүнд хэзээ ч юу ч хэрэггүй байдаг.

Хүн Бурханы ямар ч илэрхийлэлд анхаарал хандуулдаггүй болохоороо Бурханы гуниг, шаналал, баяр баясгаланг хэзээ ч мэдэрч байгаагүй. Тэгэхэд харин Бурхан хүний бүх зан төлөвийг алган дээрээ тавьсан юм шиг мэддэг. Бурхан хүн бүрийн хэрэгцээг цаг үргэлж, хаана ч хангаж, хүн бүрийн хувиран өөрчлөгдөх бодлыг ажиглаж, ингэснээр тэднийг тайтгаруулан ухуулж, чиглүүлэн гэрэлтүүлдэг. Хүн төрөлхтөнд Бурханы хийсэн бүх зүйл, тэдний төлөө Түүний төлсөн бүх төлөөсийг авч үзвэл, Бурхан хүнээс ямар нэгэн юм шаардана гэж тодорхой илтгэсэн нэг хэсгийг Библиэс юм уу, эсвэл эдүгээг хүртэл Бурханы хэлсэн үгээс хүмүүс олж чадах уу? Үгүй! Харин ч хүмүүс Бурханы бодлыг хэчнээн ч үл тоож байсан Тэрээр хүн төрөлхтнийг мөн л ахин дахин замчилж, байн байн хангаж, тэдэнд тусалж, тэдэнд зориулан Өөрийн бэлтгэсэн гайхалтай сайхан хүрэх газарт очиж чадахад нь туслахын тулд Бурханы замыг дагах боломжийг тэдэнд өгдөг. Бурханы тухайд бол, Түүнд юу байгаа болон Тэр юу болох, Түүний нигүүлсэл, Түүний өршөөл, Түүний бүх шагнал нь Түүнийг хайрладаг, дагадаг хүмүүст харамгүй хүртэнэ. Гэвч Тэр Өөрийн амссан шаналал, Өөрийн сэтгэл санааны байдлыг хэнд ч, хэзээ ч харуулдаггүй ба Түүнийг тоохгүй байна гэж, эсвэл Түүний хүслийг мэдэхгүй байна гэж хэнд ч, хэзээ ч гомдоллодоггүй. Тэрээр хүн төрөлхтөн үүнийг ойлгож чадах өдрийг хүлээн энэ бүгдийг зүгээр л чимээгүйхэн тэсэж байдаг.

Би яагаад энд эдгээр зүйлийг хэлж байна вэ? Миний хэлсэн зүйлээс та нар юу ойлгосон бэ? Бурханы мөн чанар болон зан чанарт анзааралгүй өнгөрөхөд дэндүү амархан нэг зүйл буюу агуу хүмүүс, сайн хүмүүс гэж бусдын боддог ямар ч хүн, эсвэл өөрсдийнх нь төсөөллийн Бурханы эзэмшдэггүй, харин гагцхүү Бурханы эзэмшдэг нэг зүйл байдаг. Энэ зүйл юу вэ? Энэ бол Бурханы аминч бус чанар юм. Аминч бус чанарын талаар ярихад чи өөрийгөө ч бас их аминч бус гэж бодож магадгүй, яагаад гэвэл, чи хүүхэдтэйгээ хэзээ ч үнэ хэлэлцэж, наймаалцдаггүй, бас эцэг, эхдээ маш их аминч бус байдаг гэж боддог. Чи юу ч гэж бодож байсан чамд дор хаяж “аминч бус” гэдэг үгийн тухай ухагдахуун байдаг ба чи үүнийг эерэг үг гэж боддог, мөн аминч бус хүн байх нь их бахдам хэрэг гэж боддог. Чи аминч бус байхдаа өөрийгөө дээгүүр үнэлдэг. Гэвч бүх зүйл, хүмүүс, үйл явдлууд, юмсын дунд болон Бурханы ажлаас Бурханы аминч бус чанарыг олж харж чадах нэг ч хүн байхгүй. Яагаад ийм байна вэ? Яагаад гэвэл, хүн хэтэрхий аминчхан! Би яагаад үүнийг хэлж байна вэ? Хүн төрөлхтөн материаллаг ертөнцөд амьдардаг. Чи Бурханыг дагадаг байж болох боловч Бурхан яаж чамайг хангаж, чамайг хайрлаж, чамд анхаарал тавьдгийг хэзээ ч харж, үнэлдэггүй. Чи юу хардаг вэ? Чамайг хайрладаг, эсвэл жигтэйхэн энхрийлдэг төрөл төрөгсдөө хардаг. Чи өөрийн бие махбодод хэрэгтэй зүйлсийг хардаг ба өөрийн хайрладаг хүмүүс болон зүйлсэд л санаа тавьдаг. Энэ бол хүний аминч бус чанар гэгч нь юм. Гэхдээ ийм “аминч бус” хүмүүс өөрсдөд нь амь хайрладаг Бурханыг хэзээ ч анхаардаггүй. Бурханыхтай харьцуулахад, хүний аминч бус чанар нь нь аминчхан, жигшүүртэй болдог. Хүмүүсийн итгэдэг аминч бус байдал нь хоосон, бодит бус, хуурамч, Бурхантай

зохицолгүй, Бурхантай холбоогүй. Хүний аминч бус байдал нь өөрийнхөө төлөө байдаг бол Бурханы аминч бус чанар нь Түүний мөн чанарын жинхэнэ илрэл юм. Бурханы аминч бус чанарын үрээр л хүн Түүнээс тасралтгүй урсах хангалт хүртэж байдаг. Та нарт Миний өнөөдрийн ярьж буй энэ сэдэв тийм ч гүн нөлөөлөөгүй, толгой дохих төдийхөн л зөвшөөрдөг байгаа боловч чи зүрх сэтгэлдээ Бурханы зүрх сэтгэлийг мэдрэх гэж оролдоход өөрийн мэдэлгүй дараах зүйлийг олж мэднэ: Энэ ертөнцөд чиний мэдэрч чадах бүх хүн, үйл хэрэг болон юмсын дундаас гагцхүү Бурханы аминч бус чанар л жинхэнэ агаад бодитой, учир нь чамайг гэсэн Бурханы хайр л ямар нэгэн болзол тавьдаггүй бөгөөд өө сэвгүй байдаг. Бурханыхаас өөр хэний ч аминч бус чанар гэгч нь бүгд хуурамч, өнгөцхөн, жинхэнэ биш; энэ нь нэг зорилго, зарим санаархалтай, нэг тохиролцоо агуулдаг ба шалгуур давж чаддаггүй. Үүнийг бүр бохир, жигшүүртэй гэж хэлж ч болох юм. Та нар зөвшөөрч байна уу?

Та бүхэн эдгээр сэдвийн талаар сайн мэдэхгүй бөгөөд жинхэнээсээ ойлгохын өмнө бага зэрэг бодох хугацаа хэрэгтэй гэдгийг Би мэдэж байна. Эдгээр асуудал болон сэдвийн талаар та нар хэдий их мэдэхгүй байх тусам эдгээр сэдэв нь та нарын зүрх сэтгэлд дутагдаж байгааг төдий чинээ баталж байгаа юм. Би эдгээр сэдвийн талаар хэзээ ч дурдаагүй бол та нарын дундаас тэр талаар бага ч атугай мэдэх хүн байх байсан болов уу? Та нар хэзээ ч мэдэхгүй байх байсан биз. Энэ бол баттай. Та нар хэр ихийг ухаарч, мэдэж чадахаас үл хамааран товчхондоо, Миний ярьдаг энэ сэдвүүд хүмүүст хамгийн их дутагддаг бөгөөд тэдний хамгийн сайн мэдэж байвал зохих зүйл юм. Эдгээр сэдэв нь хүн бүрийн хувьд маш чухал—тэдгээр нь эрхэм нандин ба тэдгээр нь амь, тэдгээр нь өмнө чинь байгаа замд зориулж та нарын эзэмших ёстой зүйлс юм. Энэ үгсээр удирдамж хийхгүй бол, Бурханы зан чанар болон мөн чанарыг ойлгохгүй бол чи Бурханы тухайд үргэлж эргэлзэж явах болно. Чи Бурханыг ойлгож ч чадахгүй бол Түүнд яаж зохих ёсоор итгэж чадах юм бэ? Чи Бурханы сэтгэл хөдлөл, Түүний хүсэл, Түүний сэтгэл санаа, Тэр юу бодож байгааг болон Түүнийг юу гуниглуулдгийг, юу баярлуулдгийг огт мэддэггүй, тэгэхээр Бурханы зүрх сэтгэлд яаж анхаарал тавьж чадах юм бэ?

Бурхан сэтгэлээр зовох бүрдээ Өөрт нь огт анхаарал хандуулдаггүй, Өөрийг нь дагадаг, Өөрийг нь хайрладаг гэдэг мөртөө Өөрийнх нь мэдрэмжийг өчүүхэн ч тоодоггүй хүн төрөлхтөнтэй нүүр тулдаг. Түүний зүрх сэтгэл яаж шархлахгүй байх юм бэ? Өөрийн удирдлагын ажилд Бурхан Өөрийн ажлыг чин сэтгэлээсээ хэрэгжүүлж, хүн бүртэй ярьж, юу ч нууж хаалгүй нүүр тулдаг байтал харин Түүнийг дагадаг хүн бүр Түүнд хаалттай байж, хэн ч Түүнд идэвхтэй ойртож, Түүний зүрх сэтгэлийг ойлгож, Түүний сэтгэлийг анхаарахыг хүсдэггүй. Бурханы дотны хүн болохыг хүсдэг хүмүүс хүртэл Түүнд ойртож, Түүний зүрх сэтгэлийг анхааран тоож, эсвэл Түүнийг ойлгох гэж оролдохыг хүсдэггүй. Бурханыг хөгжилтэй, баяртай байхад аз жаргалыг нь хуваалцах хэн ч байдаггүй. Хүмүүс Бурханыг буруугаар ойлгох үед Түүний шархалсан зүрх сэтгэлийг тайтгаруулах хэн ч байдаггүй. Түүний зүрх сэтгэл шархалж байх үед уужиртлаа ярихыг нь сонсохыг хүсэх ганц ч хүн

байдаггүй. Бурханы удирдлагын ажлын энэ хэдэн мянган жилийн туршид Бурханы хажууд байж, баяр гунигийг нь хуваалцах хүн байтугай Бурханы сэтгэл хөдлөлийг ойлгох нэг ч хүн байгаагүй, мөн тэдгээрийг ухаарч, мэдрэх хэн ч байгаагүй юм. Бурхан ганцаардаж байна. Тэр ганцаардаж байна! Завхарсан хүн төрөлхтөн Түүнийг эсэргүүцдэгээс болж Бурхан ганцаардаж байгаа юм биш, харин сүнслэг байхыг эрэлхийлдэг, Бурханыг мэдэхийг, Түүнийг ойлгохыг хүсдэг хүмүүс, мөн өөрийн бүх амьдралыг Түүнд зориулахыг хүсэж буй хүмүүс хүртэл Түүний бодлыг мэддэггүй ба Түүний зан чанар, сэтгэл хөдлөлийг ойлгодоггүйгээс болдог.

Ноагийн түүхийн төгсгөлд Бурхан тухайн үеийн Өөрийн сэтгэлийг илэрхийлэхийн тулд ер бусын арга хэрэглэснийг бид хардаг. Энэ бол маш онцгой арга байсан: тэр нь. Бурхан дэлхийг үерээр устгахаа зогсоосныг тунхагласан гэрээ хүнтэй хийх арга байв. Гаднаа бол гэрээ хийх нь маш энгийн зүйл мэт харагддаг. Энэ нь хоёулангийнх нь ашиг сонирхлыг хамгаалахын тулд хоёр талд үүрэг хүлээлгэж, гэрээгээ зөрчихөөс урьдчилан сэргийлэх гэж л үг үсэг ашигласан хэрэг билээ. Хэлбэрээрээ бол энэ нь маш энгийн зүйл боловч Бурхан ийм юм хийж байгаагийн цаад шалтгаан, утга учраас үзвэл, энэ нь Бурханы зан чанар болон сэтгэл санааны жинхэнэ илрэл юм. Хэрвээ чи эдгээр үгийг хойш тавьж, тоохгүй өнгөрвөл, хэрвээ Би та бүхэнд юмсын үнэнийг хэзээ ч хэлэхгүй бол хүн төрөлхтөн Бурханы бодлыг хэзээ ч мэдэхгүй. Чиний төсөөллөөр бол Бурхан энэ гэрээг хийх үедээ инээмсэглэж байсан, эсвэл сүрхий буурьтай дүртэй байсан байж магадгүй, гэвч Бурханы царайд хамгийн энгийн ямар илрэл байсан гэж хүмүүсийн төсөөлөхийг үл харгалзан Бурханы ганцаардлыг байтугай Бурханы зүрх сэтгэлийг, мөн Түүний шаналлыг хэн ч харж чадахгүй байсан билээ. Хэн ч Бурханыг өөртөө итгүүлж чадаагүй буюу Бурханы итгэлийг олж чадахуйц биш, эсвэл Бурхан Өөрийн бодлыг илэрхийлж, Өөрийн шаналлыг уужиртал хэлэх нэгэн болж чадахгүй юм. Тийм учраас Бурхан ийм зүйл хийхээс өөр замгүй болсон. Гадна талдаа Бурхан урьдын хүн төрөлхтнөөс хагацахдаа өнгөрсөн асуудлыг шийдвэрлэж, дэлхийг үерээр устгах явдлаа төгс гүйцэлдүүлэн хялбар зүйл хийсэн. Гэвч Бурхан энэ үеийн шаналанг зүрх сэтгэлийнхээ гүнд булсан юм. Бурхан итгэмжлэх нэг ч хүнгүй байхдаа дэлхийг дахин хэзээ ч үерээр устгахгүй гэж хэлэн хүнтэй гэрээ хийсэн. Солонго татсан нь ийм нэгэн зүйл тохиолдсон гэдгийг хүмүүст сануулж, муу зүйл хийхгүй байхыг тэдэнд анхааруулахын тулд байлаа. Ийм шаналалтай байдалд ч Бурхан хүн төрөлхтнийг мартаагүй ба тэдэнд маш их анхаарал тавьсаар байсан. Энэ нь Бурханы хайр, аминч бус чанар биш гэж үү? Гэтэл хүмүүс зовох үедээ юуны тухай боддог вэ? Энэ нь тэдэнд Бурхан хамгийн хэрэгтэй болдог үе биш гэж үү? Иймэрхүү үед хүмүүс Бурханаар өөрсдийгөө тайтгаруулах гээд Бурханыг үргэлж татан авчирдаг. Хэдийд ч байсан Бурхан хүмүүсийн итгэлийг хэзээ ч хөсөрдүүлэхгүй ба хүмүүсийг хэцүү байдлаас нь үргэлж гаргаж, гэрэлд амьдруулна. Бурхан хүнийг ингэж хангаж байдаг боловч хүний зүрх сэтгэлд Бурхан бол зөвхөн тайвшруулах эм, тайтгаруулах ундаа юм. Зовж байхад нь, зүрх сэтгэл нь шархалсан үед Өөрт нь

хань болж, эсвэл Өөрийг нь тайтгаруулах нэг бүтээл юм уу, нэг хүнтэй байна гэдэг бол Бурханы хувьд хэтэрхий сайхан хүсэл юм. Хүн Бурханы сэтгэлийг хэзээ ч анхаардаггүй тул Бурхан Өөрийг нь тайтгаруулж чаддаг хүн байгаач гэж хэнээс ч асуудаггүй, тийм хүн бий гэж боддог ч үгүй. Тэр Өөрийн ааш занг илэрхийлэхийн тулд зүгээр л Өөрийн аргуудыг хэрэглэдэг. Зарим нэг зовлон туулах нь Бурханд сүртэй юм биш гэж хүмүүс үздэг боловч чи үнэхээр Бурханыг ойлгох гэж оролдох үедээ л, Түүний хийж байгаа бүхнээс Бурханы чин сэтгэлийн хүчин чармайлтыг жинхэнээсээ ухаарах үедээ л Бурханы агуу байдал, аминч бус чанарыг мэдэрч чадна. Хэдийгээр Бурхан солонго хэрэглэн хүн төрөлхтөнтэй гэрээ хийсэн боловч Тэр үүнийг яагаад хийснээ болон яагаад энэ гэрээг байгуулснаа Тэр хэнд ч хэлээгүй. Энэ нь Тэр хэнд ч Өөрийн жинхэнэ бодлыг хэлээгүй гэсэн үг юм. Учир нь, Өөрийн гараар бүтээсэн хүн төрөлхтөндөө Бурхан ямар их хайртайг ойлгож чадах нэг ч хүн байхгүй ба мөн хүн төрөлхтнийг устгах үедээ Түүний зүрх хэчнээн их шимширснийг ухаарч чадах нэг ч хүн байхгүй юм. Тиймээс Тэр хүмүүст юу мэдэрч байгаагаа хэлсэн ч гэсэн тэд энэ итгэлийг нь дааж чадахгүй. Шаналж байгаагаа үл харгалзан Тэр Өөрийн ажлын дараагийн алхмыг үргэлжлүүлсээр байна. Бурхан үргэлж Өөрийн хамгийн сайн тал, хамгийн сайн зүйлийг хүн төрөлхтөнд өгөөд Өөрөө бүх зовлонг чимээгүйхэн үүрдэг. Бурхан эдгээр зовлонг хэзээ ч ил дэлгэдэггүй. Тэгэхийн оронд тэдгээрийг тэсвэрлэж, чимээгүй хүлээдэг. Бурханы тэвчээр нь хүйтэн цэвдэг, хөшүүн, арчаагүй ч биш, мөн сул доройн шинж ч биш юм. Харин Бурханы хайр болон мөн чанар нь үргэлж аминч бус байсаар байна. Энэ нь Түүний мөн чанар болон зан чанарын төрөлхийн илрэл бөгөөд жинхэнэ Бүтээгч болох Бурханы ялгамж чанарын үнэн бодитой биелэл билээ.

Үүнийг хэлсний дараа зарим хүн Миний юу гэснийг буруу ойлгож, “Бурханы сэтгэлийг ийм дэлгэрэнгүй, ийм их дуулиантайгаар дүрслэх нь хүмүүсээр Бурханыг өрөвдүүлэх зорилготой байсан уу?” хэмээн бодож магадгүй. Ийм санаа зорилготой байдаг уу? (Үгүй.) Эдгээр зүйлийг хэлсэн Миний цорын ганц зорилго бол та бүхэнд Бурханыг илүү сайн мэдүүлэх, Түүний асар олон талыг ойлгуулах, Түүний сэтгэл хөдлөлийг ойлгуулах, Бурханы мөн чанар, зан чанар нь хүний хоосон үгээр, бичиг үсэг, номлол болон төсөөллөөр дүрслэгддэг бус, харин Түүний ажлаар дамжин үнэн бодитоор, бага багаар илэрхийлэгдэж байдаг гэдгийг ухааруулах явдал юм. Өөрөөр хэлбэл, Бурхан болон Бурханы мөн чанар нь үнэхээр оршин байдаг—тэдгээр нь зураг биш, төсөөлөл биш, мөн хүний гараар бүтээгдээгүй бөгөөд хүний санаанаасаа зохиосон зүйл лав биш юм. Та нар үүнийг одоо ухамсарлаж байна уу? Хэрэв та нар үүнийг ухамсарласан бол өнөөдөр Миний үг зорилгодоо хүрчээ.

Бид өнөөдөр гурван сэдвийг хэлэлцлээ. Хүн бүр энэ гурван сэдвийн тухай нөхөрлөлөөс маш их зүйл олж авсан гэж Би итгэж байна. Энэ гурван сэдвээр дамжуулан Миний ярьсан Бурханы бодол, эсвэл Миний дурдсан Бурханы зан чанар, мөн чанар нь Бурханы тухай зарим хүний төсөөлөл, ойлголтыг өөрчилж, тэр ч бүү хэл, хүн бүрийн Бурханд итгэх итгэлийг өөрчилж, түүнчлэн хүн бүрийн зүрх

сэтгэлдээ гайхан биширч байсан Бурханы дүр төрхийг өөрчилсөн гэдэгт Би үнэхээр итгэлтэй байна. Ямар ч атугай Библийн энэ хоёр хэсгээс Бурханы зан чанарын талаар мэдсэн зүйл чинь та нарт ашиг тустай гэж Би найдаж байна, мөн та нар буцаж очоод энэ тухай илүү их тунгаан бодох гэж оролдоно гэдэгт найдаж байна. Өнөөдрийн цуглаанаа ингээд дуусгая. Баяртай!

2013 оны 11 дүгээр сарын 4

БУРХАНЫ АЖИЛ, БУРХАНЫ ЗАН ЧАНАР БА БУРХАН ӨӨРӨӨ II

Сүүлийн цуглааныхаа үеэр бид маш чухал сэдвийн талаар нөхөрлөсөн. Тэр юу байсныг та нар санаж байна уу? Би давтаж хэлье. Бидний сүүлийн нөхөрлөлийн сэдэв бол: Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурхан Өөрөө байсан. Энэ сэдэв та нарт чухал уу? Үүний аль хэсэг нь та нарт хамгийн чухал вэ? Бурханы ажил уу, Бурханы зан чанар уу, эсвэл Бурхан Өөрөө юу? Алийг нь та нар хамгийн их сонирхож байна вэ? Аль хэсгийг нь та нар хамгийн их сонсмоор байна вэ? Тэр асуултад хариулах нь та нарт хэцүү гэдгийг Би мэднэ, учир нь Бурханы зан чанарыг Түүний ажлын бүх талаас харж болох бөгөөд Түүний зан чанар Түүний ажилд үргэлж газар сайгүй илэрдэг ба үнэндээ Бурханыг Өөрийг нь төлөөлдөг; Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөнд Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурхан Өөрөө бүгд салшгүй холбоотой.

Бурханы ажлын талаарх бидний сүүлчийн нөхөрлөлийн агуулга нь олон жилийн өмнө тохиолдсон үйл явдлын талаарх Библийн тэмдэглэлүүдээс бүрдэж байсан. Тэдгээр нь бүгд хүн болон Бурханы тухай түүх байсан бөгөөд хүнд тохиолдсон зүйлсийн тухай байхын зэрэгцээ Бурханы оролцоо болон илэрхийллийг ч бас багтаадаг, иймээс эдгээр түүх нь Бурханыг мэдэхэд онцгой үнэ цэн, ач холбогдолтой байдаг. Хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараахан Бурхан хүнтэй харьцаж, хүнтэй ярилцаж эхэлсэн бөгөөд Түүний зан чанар хүнд илэрхийлэгдэж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнтэй анх харилцсан цагаасаа Өөрийн мөн чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохоо хүнд тасралтгүй мэдэгдэж эхэлсэн. Урьдын хүмүүс, эсвэл өнөөгийн хүмүүс үүнийг харж, ойлгож чадах эсэхээс үл хамааран Бурхан Өөрийн зан чанарыг илчилж, Өөрийн мөн чанарыг илэрхийлэн хүнтэй ярьж, хүмүүсийн дунд ажилладаг—энэ бол баримт бөгөөд хэн ч үгүйсгэж чадахгүй юм. Энэ нь бас Бурханы зан чанар, Бурханы мөн чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болох нь Түүнийг хүнтэй ажиллаж, харилцах явцад байнга ил гарч, илчлэгдэж байдаг гэсэн үг юм. Тэр хүнээс хэзээ ч, юу ч нууж, далдлаагүй, харин юу ч үлдээлгүйгээр Өөрийн зан чанарыг нийтэд мэдэгдэж, ил гаргадаг. Ингэж хүн Өөрийг нь мэдэж, бас Түүний зан чанар, мөн чанарыг ойлгож чадна гэж Бурхан найддаг. Түүний зан чанар болон мөн чанарыг хүн мөнхийн нууц гэж үзэхийг Тэр хүсдэггүй, мөн хүн төрөлхтөн Бурханыг хэзээ ч тайлагдашгүй таавар гэж үзэхийг Тэр хүсдэггүй. Хүн төрөлхтөн Бурханыг мэддэг болсон үедээ л урагшлах замаа мэдэж, Бурханы удирдамжийг хүлээн зөвшөөрөх ба ийм хүн төрөлхтөн л үнэхээр Бурханы ноёрхол дор амьдарч чадах бөгөөд гэрэлд, Бурханы ерөөл дунд амьдарна.

Бурханы гаргаж, илэрхийлсэн үгс болон зан чанар нь Түүний хүслийг төлөөлдөг, бас Түүний мөн чанарыг төлөөлдөг. Бурхан хүнтэй харилцах үедээ юу ч хэлж, хийж, эсвэл ямар зан чанар харуулах нь хамаагүй, мөн Бурханы мөн чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох талаар хүн юу харах нь хамаагүй, тэдгээр нь бүгд

хүний төлөөх Бурханы хүслийг төлөөлдөг. Хүн хэр ихийг ухаарч, ухамсарлаж, ойлгож чадахаас үл хамааран энэ нь бүгд Бурханы хүслийг—хүний төлөөх Бурханы хүслийг төлөөлдөг. Энэ нь маргаангүй юм! Хүн төрөлхтний төлөөх Бурханы хүсэл бол хүмүүсээс ямар байхыг, юу хийхийг, мөн хэрхэн амьдрахыг болон яаж Бурханы хүслийг биелүүлэх чадвартай байхыг шаарддаг явдал юм. Эдгээр зүйл Бурханы мөн чанараас салшгүй юу? Өөрөөр хэлбэл, Бурхан хүнд шаардлага тавихын зэрэгцээ Өөрийн зан чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохоо гаргаж байдаг. Тэнд ямар ч худал хуурмаг, дүр эсгэлт, нуун далдлалт, гоёж чимэглэсэн зүйл байдаггүй. Гэсэн ч хүн яагаад мэдэх чадваргүй байдаг вэ, мөн хүн яагаад Бурханы зан чанарыг хэзээ ч тодорхой ойлгож чадахгүй байсаар байна вэ? Хүн яагаад Бурханы хүслийг хэзээ ч ухаараагүй вэ? Бурханы илчилж, гаргадаг зүйл бол Бурханд Өөрт нь юу байгаа болон Өөрөө хэн болох нь; мөн Түүний жинхэнэ зан чанарын хэсэг, тал бүр юм—тэгээд хүн яагаад харж чаддаггүй юм бэ? Яагаад хүн бүрэн төгс мэдлэгтэй болж чаддаггүй юм бэ? Үүнд нэг чухал шалтгаан байдаг. Тэгвэл энэ шалтгаан нь юу вэ? Бүтээгдсэн цагаасаа хойш хүн хэзээ ч Бурханыг Бурхан шиг үзэж хандаагүй. Хамгийн эртний цаг үед дөнгөж бүтээгдсэн хүний тухайд Бурхан юу хийсэн нь хамаагүй, хүн Түүнийг зүгээр л найз нөхөр, түшиглэж болох нэгэн гэж үзсэн бөгөөд Бурханы талаар ямар ч мэдлэг, ойлголтгүй байсан. Өөрөөр хэлбэл, өөрийнх нь түшиглэж, найз нөхрөө гэж үзэж байсан Нэгэний илэрхийлсэн зүйл Бурханы мөн чанар байсныг хүн мэдээгүй, мөн Тэр бол бүх зүйлийг захирдаг Нэгэн гэдгийг ч мэдээгүй. Энгийнээр хэлбэл, тэр үеийн хүмүүс Бурханыг огтхон ч таньж мэдээгүй. Тэнгэр, газар болон бүх зүйлийг Тэр хийсэн гэдгийг тэд мэдээгүй бөгөөд Тэр хаанаас ирсэн, түүнчлэн Тэр хэн байсан гэдгийг мэдэхгүй байсан. Мэдээж, тэр үед Өөрийг нь мэдэхийг, эсвэл ухаарахыг, эсвэл Өөрийнх нь хийсэн бүхнийг ойлгохыг, эсвэл Өөрийнх нь хүслийн талаар мэддэг байхыг Бурхан хүнээс шаардаагүй, учир нь энэ бол хүн төрөлхтнийг бүтээсний дараах хамгийн эртний цаг үе байсан юм. Хуулийн эрин үеийн ажилд бэлтгэж эхлэх үедээ Бурхан хүнд зарим нэг зүйлийг хийсэн бөгөөд мөн Бурханд хэрхэн тахил өргөж, шүтэн мөргөж байхыг хүнд хэлж, хүнээс зарим зүйлийг шаардаж эхэлсэн. Зөвхөн тэр үед л хүн Бурханы тухай цөөн хэдэн энгийн төсөөлөлтэй болж, зөвхөн тэр үед л хүн ба Бурханы хоорондын ялгааг, бас Бурхан бол хүн төрөлхтнийг бүтээсэн Нэгэн байсан гэдгийг мэдэж авчээ. Бурхан бол Бурхан, хүн бол хүн гэдгийг хүн мэдсэн үед Бурхан тэр хоёрын дунд тодорхой зай бий болсон, гэсэн ч Түүний талаар асар их мэдлэг буюу гүн ойлголттой болооч гэж Бурхан хүнээс хүсээгүй. Тийнхүү Бурхан Өөрийн ажлын үе шат, нөхцөл байдалд үндэслэн хүнд өөр өөр шаардлага тавьдаг. Та нар эндээс юу харж байна вэ? Бурханы зан чанарын ямар талыг та нар ойлгож байна вэ? Бурхан бодитой юу? Хүнээс шаардах Бурханы шаардлагууд тохиромжтой юу? Бурхан хүн төрөлхтнийг бүтээсний дараах хамгийн эртний цаг үед, Бурхан хүнийг байлдан дагуулж, төгс болгох ажлыг хараахан хэрэгжүүлээгүй, тийм ч олон үг хэлээгүй байхдаа хүнээс багыг шаардаж байсан.

Хүн юу хийсэн, хэрхэн авирласнаас үл хамааран—Бурханд халдсан зарим нэг зүйл хийсэн ч гэсэн—Бурхан бүгдийг нь уучилж, өнгөрөөсөн юм. Яагаад гэвэл, Бурхан хүнд юу өгснөө, мөн хүний дотор юу байгааг мэдэж байсан, иймээс хүнд тавих ёстой Өөрийн шаардлагын стандартыг мэдэж байлаа. Хэдийгээр тэр үед Түүний шаардлагын стандарт маш бага байсан ч гэсэн Түүний зан чанар агуу байгаагүй, эсвэл мэргэн ухаан болон төгс хүчин нь хоосон үгээс цаашгүй байсан гэсэн үг биш юм. Хүнд Бурханы зан чанар болон Бурханыг Өөрийг нь мэдэх цорын ганц зам байдаг нь: хүн төрөлхтнийг удирдаж, аврах Бурханы ажлын алхмуудыг дагаж, хүн төрөлхтөнд Бурханы хэлдэг үгийг хүлээн зөвшөөрөх явдал юм. Хүн Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг мэдэж, Бурханы зан чанарыг мэдмэгцээ Өөрийн үнэн биеийг харуулаач гэж Бурханаас мөн л гуйх уу? Үгүй, хүн гуйхгүй, гуйж ч зүрхлэхгүй, учир нь Бурханы зан чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохыг ойлгож ухаарснаар хүн жинхэнэ Бурханыг Өөрийг нь болон Түүний үнэн биеийг аль хэдийн харсан байх болно. Энэ бол зайлшгүй үр дүн билээ.

Бурханы ажил болон төлөвлөгөө зогсолтгүй урагшлахын хэрээр, мөн энэ дэлхийг дахин хэзээ ч үерийн ус ашиглан сөнөөхгүйн тэмдэг болгон хүнтэй солонгын гэрээ байгуулсныхаа дараа Бурхан, Өөртэй нь нэг санаатай байж чадах хүмүүсийг олж авах улам их шаргуу хүсэлтэй болсон юм. Мөн газар дээр Өөрийнх нь хүслийг биелүүлж чадах хүмүүсийг олж авах, цаашлаад харанхуйн хүчнээс мултарч, Сатанд хүлэгдэхгүй байж чадах, газар дэлхий дээр Түүнд гэрчлэл хийж чадах бүлэг хүнийг олж авах бүр ч илүү яаралтай хүсэл Түүнд байсан. Тийм бүлэг хүн олж авах нь Бурханд удтал байсан хүсэл буюу бүтээлийн цагаас хойш Түүний хүлээсээр ирсэн зүйл байлаа. Тийнхүү дэлхийг сөнөөхийн тулд Бурхан үер ашигласныг, эсвэл хүнтэй байгуулсан Түүний гэрээг үл харгалзан Бурханы хүсэл, сэтгэл санааны байдал, төлөвлөгөө, итгэл найдвар нь бүгд хэвээр үлдсэн. Түүний хийхийг хүссэн зүйл буюу Бүтээлийн цагаас өмнө удтал хүсэн эрмэлзсэн зүйл бол хүн төрөлхтний дундаас Өөрийн олж авахыг хүссэн хүмүүсийг олж авах—Түүний зан чанарыг ухамсарлан мэдэж, Түүний хүслийг ойлгож чадах бүлэг хүмүүс, Түүнийг шүтэн мөргөж чадах бүлгийг олж авах явдал байсан юм. Тийм бүлэг хүмүүс нь Түүнд гэрчлэл хийж лавтай чадах бөгөөд тэд бол Түүний итгэлийг хүлээсэн хүмүүс гэж хэлж болно.

Өнөөдөр бүгдээрээ Бурханы мөрөөр буцан явж, Түүний ажлын алхмуудыг үргэлжлүүлэн дагацгаая, ингэснээр бид Бурханы бодол, санаа болон Бурхантай хамаатай бүх төрлийн нарийн ширийнийг, маш урт хугацаанд “битүүмжлэгдсэн” бүхнийг нээн илрүүлж магадгүй юм. Эдгээр зүйлээр дамжуулан бид Бурханы зан чанарыг мэдэж, Бурханы мөн чанарыг ойлгож эхлэх бөгөөд дор бүрнээ Бурханыг зүрх сэтгэлдээ оруулж, Бурханд хүрэх зайгаа багасган Бурханд аажмаар ойртож очно.

Бидний сүүлд ярьсан зүйлийн нэг хэсэг нь Бурхан яагаад хүнтэй гэрээ байгуулсан тухай байсан. Энэ удаа бид Библийн доорх хэсгүүдийн тухай нөхөрлөх болно. Эхлээд Библиэс уншицгаая.

I. Абрахам

1. Бурхан Абрахамд хүү өгөхөөр амлав

Эхлэл 17:15–17 Бурхан Абрахамд, “Чиний эхнэр Сараин тухайд гэвэл, чи түүнийг Сараи гэж дуудаж болохгүй, харин түүний нэр Сара байх болно. Тэгээд Би түүнийг ерөөж, түүгээр чамд хүү өгнө: Тийм ээ, Би түүнийг ерөөх болно, тэгээд тэр үндэстнүүдийн эх болж; хүмүүсийн хаад түүнээс гарах болно” гэв. Тэгэхэд нь Абрахам нүүрээрээ газар унан, инээж, зуун настай надад хүү төрнө гэж үү? Бас ерэн настай Сара хүүхэд төрүүлнэ гэж үү? хэмээн дотроо бодов.

Эхлэл 17:21–22 “Гэхдээ Би гэрээгээ ирэх жилийн өдийд Сарагийн чамд төрүүлж өгөх Исаактай байгуулна” гэв. Тэгээд түүнтэй яриагаа дуусгасан ба Бурхан Абрахамаас холдон дээш одов.

Бурханы хийхээр шийдсэн ажилд хэн ч саад учруулж чадахгүй

Ингээд та бүгд Абрахамын түүхийг дөнгөж сая сонслоо, тийм үү? Үер дэлхийг сөнөөсний дараа түүнийг Бурхан сонгосон, түүний нэрийг Абрахам гэдэг байсан бөгөөд түүнийг зуун настай, эхнэр Сара нь ерэн настай байхад Бурханы амлалт түүнд ирсэн. Бурхан түүнд юу амласан бэ? Бурхан Библид дурдсан зүйлийг амласан: “Тэгээд Би түүнийг ерөөж, түүгээр чамд хүү өгнө.” Бурхан түүнд хүү өгнө гэсэн амлалтын цаана юу байсан бэ? Библид дараах тэмдэглэл байдаг: “Тэгэхэд нь Абрахам нүүрээрээ газар унан, инээж, зуун настай надад хүү төрнө гэж үү? Бас ерэн настай Сара хүүхэд төрүүлнэ гэж үү? хэмээн дотроо бодов.” Өөрөөр хэлбэл, өтөл насны энэ хос хүүхэдтэй болоход хэтэрхий хөгшин байв. Бурханыг амлалт өгсний дараа Абрахам юу хийсэн бэ? Тэр нүүрээрээ газар унан инээж, “Зуун настай надад хүү төрнө гэж үү?” хэмээн өөртөө хэлсэн. Абрахам энэ нь боломжгүй гэж итгэж байсан—түүнд өгсөн Бурханы амлалт нь тоглоом тохуунаас өөр юу ч биш гэж итгэсэн гэсэн үг. Хүний үзлээр бол, энэ нь хүний биелүүлж чадашгүй зүйл бөгөөд Бурхан ч ялгаагүй биелүүлж чадашгүй, боломжгүй зүйл байлаа. Абрахамд энэ нь инээдтэй байсан байх: “Бурхан хүнийг бүтээсэн атлаа ийм хөгшин хүн хүүхэдтэй болж чадахгүй гэдгийг яагаад ч юм мэддэггүй юм шиг байна; Бурхан надад хүүхэдтэй болох боломж олгож чадна гэж бодоод, надад хүү өгнө гэнэ—огт боломжгүй зүйл!” Иймээс Абрахам нүүрээрээ газар унан: “Боломжгүй зүйл—Бурхан надаар тоглож байна, энэ үнэн байж таарахгүй!” хэмээн дотроо бодон инээж байсан. Тэр Бурханы үгийг нухацтай хүлээж аваагүй. Тэгвэл, Бурханы нүдэнд Абрахам ямар хүн байсан бэ? (Зөв шударга.) Түүний зөв шударга хүн байсныг хаана хэлсэн байна вэ? Бурханы дуудсан бүх хүн зөв шударга, төгс бөгөөд Бурхантай хамт алхдаг хүмүүс байсан гэж та нар боддог. Та нар номлол дагадаг! Бурхан хэн нэгнийг тодорхойлохдоо зоргоороо хийдэггүй гэдгийг та нар тодорхой ойлгох ёстой. Энд, Абрахам зөв шударга хүн байсан гэж Бурхан хэлээгүй. Бурханы зүрх сэтгэлд хүн бүрийг хэмжих стандарт байдаг. Абрахам ямар төрлийн хүн байсныг Бурхан хэдийгээр хэлээгүй ч гэсэн биеэ авч явах байдлаас нь үзэхэд

Бурханд итгэх Абрахамын итгэл ямар байсан бэ? Энэ нь жаахан хийсвэр байсан уу? Эсвэл тэр их итгэлтэй байсан уу? Үгүй, тэр тийм байгаагүй! Түүний инээд болон бодлууд хэн байсан бэ гэдгийг нь харуулсан, иймээс тэр зөв шударга байсан гэсэн та нарын итгэл бол зөвхөн та нарын төсөөллийн хоосон бодол, номлол сургаал сохроор хэрэглэсэн хэрэг бөгөөд хөнгөн хуумгай үнэлгээ юм. Бурхан, Абрахамын инээд болон жаахан илэрхийллийг харсан уу? Тэдгээрийг мэдсэн үү? Бурхан мэдсэн. Гэхдээ Бурхан хийхээр шийдсэн зүйлээ өөрчлөх байсан уу? Үгүй! Бурхан энэ хүнийг сонгоно гэж төлөвлөж, шийдсэн үед энэ нь аль хэдийн биелсэн. Хүний бодол юм уу, биеэ авч явах байдлын аль нь ч Бурханд өчүүхэн төдий ч нөлөөлж, саад болохгүй; Бурхан Өөрийн төлөвлөгөөг зоргоороо өөрчлөхгүй, мөн хүний биеэ авч явах байдал хэдий мунхаг байж болох ч тэрнээс нь болж Өөрийн төлөвлөгөөг цочмог өөрчлөх юм уу, нураахгүй байсан. Тэгвэл Эхлэл 17:21–22 дээр юу гэж бичсэн байдаг вэ? “‘Гэхдээ Би гэрээгээ ирэх жилийн өдийд Сарагийн чамд төрүүлж өгөх Исаактай байгуулна’ гэв. Тэгээд түүнтэй яриагаа дуусгасан ба Бурхан Абрахамаас холдон дээш одов.” Абрахамын бодсон, эсвэл хэлсэн зүйлд Бурхан өчүүхэн төдий ч анхаарал хандуулаагүй. Түүний үл тоомсорлосон шалтгаан юу байсан бэ? Үүний учир нь, тэр үед Бурхан, хүнээс агуу итгэлтэй байгаач, Бурханы талаар ихийг мэддэг чадвартай болооч гэх юм уу, тэр ч байтугай, Бурханы хийсэн, хэлсэн зүйлийг ойлгож чаддаг байгаач гэж шаарддаггүй байсан юм. Тиймээс, Түүний хийхээр шийдсэн зүйлийг, Түүний сонгохоор шийдсэн хүмүүсийг, эсвэл Түүний үйлдлүүдийн зарчмыг бүрэн ойлгооч гэж Тэр хүнээс шаардаагүй, учир нь хүний биеийн хэмжээ зүгээр л тохирохгүй байсан билээ. Тэр үед Абрахамын юу ч хийж, яаж ч авирласныг Бурхан хэвийн гэж үзсэн. Тэр яллаж, зэмлээгүй, харин ердөө л “Сара чамд дараа жилийн энэ цагт Исаакийг төрүүлж өгнө” гэж хэлсэн юм. Бурханы хувьд эдгээр үгийг тунхагласных нь дараа энэ хэрэг алхам алхмаар биелж эхэлсэн; Бурханы нүдэнд бол Түүний төлөвлөгөөгөөр бүтэх ёстой байсан зүйл аль хэдийн биелсэн. Үүнийг зохицуулсныхаа дараа Бурхан явсан. Хүн юу хийж, юу бодох, хүн юу ойлгох нь, мөн хүний төлөвлөгөө—эдгээрийн аль нь ч Бурханд ямар ч хамаагүй. Бүх зүйл Бурханы тогтоосон цаг хугацаа болон үе шатыг баримтлан Бурханы төлөвлөгөөний дагуу явагддаг. Бурханы ажлын зарчим ийм юм. Хүн юу ч бодож юм уу, мэдэхэд нь Бурхан хөндлөнгөөс оролцдоггүй, гэхдээ бас хүн итгэхгүй юм уу ойлгохгүйгээс болоод л Өөрийн төлөвлөгөөнөөс няцаж, Өөрийн ажлыг хаядаггүй. Тиймээс хэрэг явдлууд Бурханы төлөвлөгөө болон бодлын дагуу бүтдэг. Энэ нь бидний Библиэс хардаг яг тэр зүйл юм: Бурхан Исаакийг Өөрийнхөө тогтоосон хугацаанд төрүүлсэн. Хүний биеэ авч явах байдал, зан авир Бурханы ажилд саад учруулсан гэдгийг баримтууд нотолдог уу? Тэдгээр нь Бурханы ажилд саад учруулаагүй! Бурханд итгэх хүний өчүүхэн итгэл болон Бурханы талаарх үзэл, төсөөлөл нь Бурханы ажилд нөлөөлсөн үү? Үгүй, нөлөөлөөгүй! Огтхон ч үгүй! Бурханы удирдлагын төлөвлөгөөнд ямар ч хүн, хэрэг явдал, эсвэл орчин нөлөөлдөггүй. Түүний хийхээр шийдсэн бүхэн Түүний төлөвлөгөөний дагуу зохих

цагтаа биелж, гүйцэлдэх бөгөөд Түүний ажилд ямар ч хүн саад учруулж чадахгүй. Бурхан, хүний тэнэглэл болон мунхаглалын зарим талыг, тэр ч байтугай, Түүнд хандах хүний эсэргүүцэл болон үзлийн зарим талыг үл хэрэгсдэг ба Өөрийн хийх ёстой ажлыг тоолгүй хийдэг. Энэ бол Бурханы зан чанар бөгөөд энэ нь Түүний бүхнийг чадагч байдлын илрэл юм.

2. Абрахам Исаакийг өргөсөн нь

Эхлэл 22:2–3 Тэр: “Одоо чи өөрийн цорын ганц хайртай хүү болох Исаакийг авч, Мориагийн нутагт оч; Миний хэлж өгөх нэгэн уулан дээр түүнийг шатаалт тахил болгон өргө” гэв. Абрахам өглөө эртлэн босож, илжгээ эмээллээд, өөрийнхөө хүмүүсээс хоёр залууг, хүү Исаакийн хамт дагуулан явж, шатаалт тахилд хэрэглэх мод хагалаад босож, Бурханы хэлсэн газар луу явцгаав.

Эхлэл 22:9–10 Тэд Бурханы хэлсэн газарт иржээ; тэгээд Абрахам тэнд тахилын ширээ босгож, мод өрөөд өөрийн хүү Исаакийг хүлж, тахилын ширээн дээрх модон дээр тавив. Тэгээд Абрахам гараа урагш сунган хүүгээ алахаар хутга авлаа.

Бурханы удирдлагын ажил болон хүн төрөлхтнийг аврах ажил нь Абрахам, Исаакийг тахил болгосноор эхэлдэг

Абрахамд хүү хайрласнаар Абрахамд Бурханы хэлсэн үг биелсэн. Энэ нь Бурханы төлөвлөгөө энд зогссон гэсэн үг биш; харин ч хүн төрөлхтнийг удирдах болон аврах Бурханы сүр жавхлант төлөвлөгөө дөнгөж эхэлсэн бөгөөд Абрахамд хүү өгсөн Түүний ерөөл бол Түүний бүхий л удирдлагын төлөвлөгөөний зөвхөн оршил байсан. Тэр үед, Абрахам Исаакийг тахил болгон өргөх мөчид Сатантай хийх Бурханы тулаан чимээгүйхэн эхэлсэн гэдгийг хэн мэдэх билээ?

Бурхан хүнийг мунхаг байсан ч тоодоггүй—Тэр хүнээс үнэнч байхыг л шаарддаг

Дараа нь Бурхан Абрахамд юу хийснийг харцгаая. Эхлэл 22:2-т Бурхан Абрахамд дараах тушаалыг өгсөн: “Одоо чи өөрийн цорын ганц хайртай хүү болох Исаакийг авч, Мориагийн нутагт оч; Миний хэлж өгөх нэгэн уулан дээр түүнийг шатаалт тахил болгон өргө.” Бурханы санаа тодорхой байсан: Хайртай, цорын ганц хүү Исаакаа шатаалт тахил болго гэж Абрахамд хэлж байсан. Үүнийг өнөөдөр харахад, Бурханы тушаал хүний үзэлтэй мөн л зөрчилдөж байна уу? Тийм ээ! Тэр үед Бурханы хийсэн бүхэн нь хүний үзэлтэй нэлээд харшилддаг; энэ нь хүн ойлгохын аргагүй юм. Өөрсдийнхөө үзэлд хүмүүс дараах зүйлд итгэдэг: Хүн итгэхгүй, мөн боломжгүй гэж бодоход нь Бурхан түүнд хүү өгсөн бөгөөд түүнийг хүүтэй болсны дараа Бурхан түүнээс хүүгээ тахил болго гэж шаардсан. Энэ нь үнэхээр итгэхийн аргагүй бус уу! Бурхан чухам юу хийх санаатай байсан бэ? Бурханы жинхэнэ санаа зорилго юу байсан бэ? Тэр ямар ч болзолгүйгээр Абрахамд хүү өгсөн атлаа үг дуугүй тахил өргөхийг Абрахамаас бас хүссэн. Энэ нь хэтэрхий байсан уу? Гуравдагч этгээдийн үзлээр харвал, энэ нь хэтэрснээр үл

барам бас юу ч гэсэн “шалтгаангүйгээр асуудал үүсгэж байгаа” хэрэг байлаа. Гэхдээ Абрахам өөрөө Бурханыг хэтэрхий их зүйл шаардаж байна гэж үзээгүй. Хэдийгээр тэр энэ талаар өөрийн гэсэн цөөн хэдэн, багахан санаа бодолтой, мөн Бурханыг бага зэрэг сэжиглэж байсан боловч Исаакийг тахил болгон өргөхөөр бэлтгэсэн. Энэ мөчид, Абрахам өөрийн хүүг өргөл болгоход бэлэн байсан гэдгийг нотлох юу харагдаж байна вэ? Эдгээр өгүүлбэрт юу хэлсэн байна вэ? Эх бичвэрт дараах тэмдэглэлийг дурджээ: “Абрахам өглөө эртлэн босож, илжгээ эмээллээд, өөрийнхөө хүмүүсээс хоёр залууг, хүү Исаакийн хамт дагуулан явж, шатаалт тахилд хэрэглэх мод хагалаад босож, Бурханы хэлсэн газар луу явцгаав” (Эхлэл 22:3). “Тэд Бурханы хэлсэн газарт иржээ; тэгээд Абрахам тэнд тахилын ширээ босгож, мод өрөөд өөрийн хүү Исаакийг хүлж, тахилын ширээн дээрх модон дээр тавив. Тэгээд Абрахам гараа урагш сунган хүүгээ алахаар хутга авлаа” (Эхлэл 22:9–10). Абрахам гараа сунган хүүгээ алахаар хутга авах үед түүний үйлдэл Бурханд харагдсан уу? Тэгсэн. Бурхан Исаакийг золиосол гэж Абрахамаас хүссэн үеэс эхлээд Абрахам хүүгээ алахаар хутгаа өргөх үеийг хүртэлх бүхий л үйл явц нь Бурханд Абрахамын зүрх сэтгэлийг харуулсан бөгөөд тэр үед өмнөх тэнэглэл, мунхаглал, Бурханы талаарх буруу ойлголтыг нь үл харгалзан Бурханы төлөө гэсэн Абрахамын зүрх сэтгэл үнэн, шударга байсан, мөн өөрт нь Бурханы өгсөн хүү Исаакийг тэр Бурханд үнэхээр эргүүлэн өгөх гэж байв. Түүнээс Бурхан дуулгавартай байдлыг—Өөрийн хүссэн яг тэр дуулгавартай байдлыг харсан юм.

Хүний хувьд Бурхан ойлгомжгүй, бүр итгэхээргүй зүйлсийг их хийдэг. Бурхан хэн нэгнийг зохион байгуулахыг хүсэх үед энэхүү зохион байгуулалт нь ихэвчлэн хүний үзэлтэй зөрчилдөж, түүнд ойлгомжгүй байдаг, гэсэн ч чухамхүү энэ үл нийцэх болон ойлгомжгүй байдал нь хүнийг шалгах Бурханы шалгалт, туршилт юм. Абрахам тэр зуур өөрийн доторх дуулгавартай байдлыг Бурханд харуулж чадсан бөгөөд энэ нь Бурханы шаардлагыг хангаж чадах хамгийн үндсэн нөхцөл байсан билээ. Абрахам Бурханы шаардлагыг дуулгавартай дагаж чадахад, Исаакийг өргөл болгоход, зөвхөн тэр үед л Бурхан хүн төрөлхтөнд буюу Өөрийн сонгосон Абрахамд итгэх, сайшаах сэтгэлийг үнэхээр мэдэрсэн. Зөвхөн тэр үед л Өөрийнх нь сонгосон энэ хүн Түүний амлалтыг болон Түүний дараагийн удирдлагын төлөвлөгөөг үүрч чадах зайлшгүй чухал удирдагч юм гэдэгт Бурхан итгэжээ. Хэдийгээр энэ нь зөвхөн шалгалт, туршилт байсан боловч Бурхан баярлаж, Түүнийг гэх хүний хайрыг мэдэрсэн бөгөөд хүн Түүнд урьд өмнө үзээгүй тайтгарал өгөхийг мэдэрсэн. Абрахам Исаакийг алахаар хутгаа дээш өргөх мөчид Бурхан түүнийг зогсоосон уу? Бурхан Исаакийг тахилд өргүүлээгүй, учир нь Исаакийн амийг авах санаа Бурханд ердөө байгаагүй. Тиймээс Бурхан Абрахамыг яг цагт нь зогсоосон. Бурханы хувьд, Абрахамын дуулгавартай байдал нь аль хэдийн туршилтад тэнцсэн, түүний хийсэн зүйл хангалттай байсан бөгөөд Бурхан хийхээр зорьсон зүйлийнхээ үр дүнг аль хэдийн харчихсан байв. Энэхүү үр дүн нь Бурханд хангалттай байсан уу? Энэ үр дүн Бурханд хангалттай байсан, тэр нь Бурханы

хүссэн зүйл байсан ба Бурханы харахыг эгээрэн хүсэж байсан зүйл байсан гэж хэлж болно. Энэ үнэн үү? Хэдийгээр өөр өөр байдалд Бурхан хүн бүрийг шалгах өөр өөр арга хэрэглэдэг боловч Бурхан Абрахамаас Өөрийн хүссэн зүйлийг харсан, Абрахамын зүрх сэтгэл үнэнч болохыг, түүний дуулгавартай байдал ямар ч болзолгүй болохыг харсан. Яг л энэ “болзолгүй” байдлыг Бурхан хүсэж байсан юм. “Би аль хэдийн үүнийг өргөл болгосон, би аль хэдийн тийм зүйлээс татгалзсан—Бурхан яагаад надад бас л сэтгэл хангалуун биш байдаг юм бэ? Тэр яагаад намайг шалгаад л байдаг юм бэ? Тэр яагаад намайг туршаад л байдаг юм бэ?” гэж хүмүүс дандаа хэлдэг. Энэ нь нэг баримтыг харуулдаг: Бурхан чиний зүрх сэтгэлийг хараагүй ба чиний зүрх сэтгэлийг олж аваагүй. Өөрөөр хэлбэл, Абрахам хүүгээ өөрийн гараар хөнөөж, түүнийг Бурханд өргөл болгохоор хутгаа далайж чадаж байсан шиг тийм чин сэтгэлийг Тэр хараагүй. Тэр чиний ямар ч болзолгүй дуулгавартай байдлыг хараагүй бөгөөд чамаас тайтгарал аваагүй. Тэгэхээр Бурхан чамайг шалгасаар байх нь хэвийн зүйл юм. Энэ үнэн биш гэж үү? Энэ сэдвийг ингээд орхиё. Дараа нь бид “Бурханы Абрахамд өгсөн амлалтыг” уншина.

3. Бурханы Абрахамд өгсөн амлалт

Эхлэл 22:16–18 Ехова: “Чи энэ зүйлийг хийж, цорын ганц хүүгээ харамлаагүй учраас Би Өөртөө тангараглаж байна: Би чамайг ерөөж, чиний үр удмыг тэнгэрийн од, далайн эрэг дээрх элс шиг олшруулна; чиний үр удам дайснуудынхаа үүд хаалгыг эзэгнэнэ; чи Миний дуу хоолойг дуулгавартай дагасан учир үр удмаар чинь газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөнө” гэлээ.

Энэ бол Бурхан Абрахамыг ерөөсөн тухай бүрэн тэмдэглэл юм. Хэдий товч боловч агуулга нь баялаг: Энэ нь Бурханы Абрахамд өгсөн бэлгийн учир шалтгаан, цаад үндэслэл болон Түүний Абрахамд өгсөн зүйл юу байсныг багтаадаг. Энэ нь бас, Бурхан эдгээр үгийг хэлэхдээ баярлаж, догдолж байсныг, түүнчлэн Өөрийнх нь үгийг сонсож чадах хүмүүсийг олж авах Түүний хүсэл тэмүүллийн яаралтай байдлыг шингээсэн. Үүнээс бид Түүний үгэнд дуулгавартай хандаж, Түүний тушаалыг дагадаг хүмүүст хандах Бурханы хайр энхрийлэл, зөөлөн харьцааг харна. Иймээс, хүмүүсийг олж авахын тулд Түүний төлдөг төлөөс болон тэднийг олж авахад Түүний зориулдаг анхаарал халамж, бодлыг ч бид бас харна. Цаашлаад, “Би Өөртөө тангараглаж байна” гэдэг үгийг агуулсан хэсэг нь Өөрийн удирдлагын төлөвлөгөөний ажлын цаана Бурханы ганцаараа үүрсэн гашуун зовлон, шаналлын хүчтэй мэдрэмжийг бидэнд өгдөг юм. Энэ нь тунгааж бодууштай, мөн дараагийн хүмүүст онцгой ач холбогдолтой бөгөөд гүн гүнзгий нөлөөтэй хэсэг билээ.

Хүн чин сэтгэл болон дуулгавартай байдлынхаа үрээр Бурханы ерөөлийг олж авдаг

Бидний энд уншсан, Бурханаас Абрахамд хүртээсэн ерөөл агуу байсан уу? Яг хэр зэрэг агуу байв? Энд “үр удмаар чинь газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөнө”

гэсэн нэг чухал өгүүлбэр байна. Урьд хожид хэнд ч хүртээгээгүй ерөөлийг Абрахам хүртсэн гэдгийг энэ өгүүлбэр харуулдаг. Бурханыг хүсэхэд Абрахам өөрийн ганц хүүг—хайртай ганц хүүгээ—Бурханд буцааж өгсөн (энд бид “өргөл болгосон” гэдэг үгийг хэрэглэж болохгүй; тэр өөрийн хүүг Бурханд эргүүлэн өгсөн гэж хэлэх ёстой), Бурхан Исаакийг өргөл болгохыг Абрахамд зөвшөөрөөгүйгээр үл барам харин ч түүнийг ерөөсөн. Тэр Абрахамыг ямар амлалтаар ерөөсөн бэ? Түүний үр удмыг үржүүлнэ гэсэн амлалтаар ерөөсөн. Тэд хэр их үржих байсан бэ? Библид дараах тэмдэглэл бий: “тэнгэрийн од, далайн эрэг дээрх элс шиг чиний үр удам дайснуудынхаа үүд хаалгыг эзэгнэнэ; чи Миний дуу хоолойг дуулгавартай дагасан учир үр удмаар чинь газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөнө.” Бурхан эдгээр үгийг ямар нөхцөлд хэлсэн бэ? Өөрөөр хэлбэл, Абрахам Бурханы ерөөлийг хэрхэн хүлээж авсан бэ? Библид “чи Миний дуу хоолойг дуулгавартай дагасан учир” гэж яг л Бурханы хэлснээр хүлээн авсан. Өөрөөр хэлбэл, Абрахам, Бурханы тушаалыг дагасан учраас, Бурханы хэлсэн, хүссэн, тушаасан бүхнийг өчүүхэн ч гомдолгүйгээр хийсэн учраас Бурхан түүнд ийм амлалт өгсөн. Энэ амлалтад Бурханы тухайн үеийн бодлыг хөндсөн нэг чухал өгүүлбэр бий. Та нар харсан уу? “Би Өөртөө тангараглаж байна” гэсэн Бурханы үгэнд та нар нэг их анхаарал хандуулаагүй байх. Энэ нь ямар утгатай вэ гэхээр, Бурхан эдгээр үгийг хэлэхдээ Өөрөөрөө тангараглаж байсан юм. Хүмүүс андгай тавихдаа юугаар тангарагладаг вэ? Тэд Тэнгэрээр тангарагладаг, өөрөөр хэлбэл, тэд Бурханд андгай тавьж, Бурханаар тангарагладаг. Бурхан Өөрөөрөө тангарагласан үзэгдлийн талаар хүмүүс нэг их ойлголттой биш байж магад боловч Би та нарт зөв тайлбар өгөхөөр та нар ойлгож чадна. Түүний үгийг сонсож л чадахаас биш, Түүний зүрх сэтгэлийг ойлгодоггүй хүнтэй тулгараад Бурхан дахин ганцаардаж, барьц алдах шиг болсон. Аргаа барсандаа—дотоод ухамсраараа гэж хэлж болно—Бурхан тун энгийн зүйл хийсэн: Бурхан зүрхэн дээрээ гараа тавиад энэ амлалтаа Абрахамд хүртээх үедээ Өөртөө хандсан ба Бурхан, “Би Өөртөө тангараглаж байна” гэж хэлэхийг хүн сонссон. Бурханы үйлдлээр дамжуулан чи өөрийнхөө тухай бодож болох юм. Чи зүрхэн дээрээ гараа тавиад өөртэйгөө ярь, юу хэлж байгаагаа сайн мэддэг үү? Чиний хандлага чин үнэн үү? Чи зүрх сэтгэлтэйгээ илэн далангүй ярьдаг уу? Тиймээс Бурхан, Абрахамтай ярих үедээ нухацтай, үнэнч шударга байсан гэдгийг бид эндээс харж болно. Абрахамтай ярьж, түүнийг ерөөхийн зэрэгцээ Бурхан мөн Өөртэйгээ ярьж байсан. Тэр Өөртөө: Би Абрахамыг ерөөж, түүний үр удмыг тэнгэрийн од мэт, далайн эрэг дээрх элс мэт олшруулна, учир нь тэр Миний үгийг дуулгавартай дагадаг ба тэр бол Миний сонгосон нэгэн хэмээн хэлж байсан. Бурхан “Би Өөртөө тангараглаж байна” гэж хэлэх үедээ Израилийн сонгогдсон хүмүүсийг Абрахамаас төрүүлж, дараа нь Өөрөө тэр хүмүүсийг Өөрийн ажилтай хөл нийлүүлэн урагш хөтөлнө гэж шийдсэн. Өөрөөр хэлбэл, Бурхан Абрахамын үр удамд Өөрийн удирдлагын ажлыг үүрүүлж, Бурханы ажил ба Бурханы илэрхийлсэн зүйл Абрахамаар эхэлж, Абрахамын үр удамд үргэлжлэн улмаар хүнийг аврах

Бурханы хүслийг биелүүлэх байсан юм. Энэ нь ерөөгдсөн зүйл биш гэж үү? Хүнд үүнээс илүү агуу ерөөл гэж үгүй; энэ нь хамгийн их ерөөлтэй зүйл гэж хэлж болно. Абрахамын олж авсан ерөөл нь түүний үр удмыг үржүүлэх явдал биш байсан, харин Абрахамын үр удам дахь Бурханы удирдлага, Түүний даалгавар болон Түүний ажлын биелэлт байсан юм. Абрахамын авсан ерөөл нь түр зуурынх биш, харин Бурханы удирдлагын төлөвлөгөө ахихын хэрээр үргэлжилнэ гэсэн үг юм. Бурхан үүнийг ярих үедээ, мөн Бурхан Өөрөөрөө тангараглах үедээ аль хэдийн шийдвэр гаргачихсан байлаа. Энэ шийдвэрийн үйл явц үнэн байсан уу? Энэ нь бодитой байсан уу? Тэр үеэс эхлээд Түүний хүчин чармайлт, Түүний төлсөн төлөөс, Түүнд юу байгаа болон Тэр юу болох, Түүний бүх зүйл, Түүний амь хүртэл Абрахамд, Абрахамын үр удамд өгөгдөнө гэж Бурхан шийдсэн. Мөн түүнчлэн энэ бүлэг хүмүүсээс эхлэн Тэр Өөрийн үйл хэргийг харуулж, Түүний мэргэн ухаан, эрх мэдэл болон хүч чадлыг харах боломжийг хүнд олгоно гэж Бурхан шийдсэн юм.

Бурханыг мэддэг болон Түүнийг гэрчлэх чадвартай хүмүүсийг олж авах нь Бурханы хувиршгүй хүсэл юм

Бурхан Өөртэйгөө ярихын зэрэгцээ Абрахамтай бас ярьсан, гэхдээ өөрт нь өгсөн Бурханы ерөөлийг сонсохоос гадна тэр мөчид Бурханы бүх үгэн дэх Бурханы жинхэнэ хүслийг Абрахам ойлгож чадсан уу? Тэр чадаагүй! Иймээс Өөрөөрөө тангараглах тэр мөчид Бурханы зүрх сэтгэл ганцаардмал, гунигтай хэвээр байсан. Түүний зорьсон, төлөвлөсөн зүйлийг ойлгож, ухаарч чадах нэг ч хүн байгаагүй. Тэр мөчид, Абрахамыг оролцуулаад хэн ч Түүнтэй итгэмжлэн ярилцаж чадахгүй, тэр ч бүү хэл, хийх ёстой ажлаа хийхэд нь Түүнтэй хамтран ажиллаж чадах хэн ч байгаагүй. Гадна талдаа бол Бурхан Абрахамыг, Өөрийнх нь үгийг дуулгавартай дагаж чадах хүнийг олж авсан. Гэвч үнэндээ, Бурханы талаарх энэ хүний мэдлэг нь бараг л оргүй хоосон байсан. Хэдийгээр Бурхан Абрахамыг ерөөсөн боловч Бурханы зүрх сэтгэл хангалуун болоогүй л байсан. Бурхан сэтгэл хангалуун биш байсан гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь, Түүний удирдлага дөнгөж л эхэлсэн гэсэн үг, Түүний олж авахыг хүссэн хүмүүс, Түүний харахыг эгээрэн хүссэн хүмүүс, Түүний хайрласан хүмүүс Түүнээс хол хэвээр байсан гэсэн үг; Түүнд цаг хугацаа хэрэгтэй байсан, Тэр хүлээх, тэвчээртэй байх хэрэгтэй байв. Учир нь, тэр үед Түүнд юу хэрэгтэй, Тэр юу олж авахыг хүсдэг, эсвэл Тэр юу хүсэн эрмэлздэгийг Бурханаас Өөрөөс нь өөр мэддэг хүн байгаагүй. Иймээс Бурханы сэтгэл ихэд хөөрөхийн зэрэгцээ бас сэтгэл нь хүнд оргиж байсан. Гэсэн ч Тэр алхаагаа зогсоолгүй хийх ёстой зүйлийнхээ дараагийн алхмыг үргэлжлүүлэн төлөвлөсөн юм.

Абрахамд өгсөн Бурханы амлалтаас та нар юу харж байна вэ? Абрахам ердөө л Бурханы үгийг дуулгавартай дагасан учраас Бурхан түүнд агуу ерөөл хайрласан. Хэдийгээр энэ нь гаднаа хэвийн, мэдээжийн хэрэг мэт харагддаг боловч үүнээс бид Бурханы зүрх сэтгэлийг хардаг: хүн Өөрт нь дуулгавартай байхыг Бурхан онцгойлон эрхэмлэж, Өөрийнх нь талаарх хүний ойлголт болон Өөрт нь хандах чин

сэтгэлийг нандигнадаг. Энэ чин сэтгэлийг Бурхан хэр их нандигнадаг вэ? Тэр үүнийг хэр их нандигнадгийг та нар ойлгохгүй байж магадгүй, мөн үүнийг ухаарч ойлгох нэг ч хүн байхгүй байж ч магадгүй юм. Бурхан Абрахамд хүү хайрласан ба тэр хүүг өсөж том болоход нь хүүгээ Бурханд өргөл болго гэж Абрахамаас шаардсан. Абрахам Бурханы тушаалыг үгчлэн дагаж, Бурханы үгийг дуулгавартай дагасан бөгөөд түүний чин сэтгэл Бурханыг уярааж, Бурханд эрхэмлэгдсэн. Бурхан үүнийг хэр их эрхэмлэсэн бэ? Тэр үүнийг яагаад эрхэмлэсэн бэ? Хэн ч Бурханы үгийг ухаарч, Түүний зүрх сэтгэлийг ойлгоогүй байхад Абрахам тэнгэрийг донсолгож, газрыг доргиосон зүйл хийсэн бөгөөд энэ нь Бурханд урьд өмнө үзээгүй сэтгэл ханамжийг мэдрүүлж, Өөрийнх нь үгийг дуулгавартай дагаж чадах хүнийг олж авахын баяр баясгаланг Бурханд авчирсан юм. Энэхүү сэтгэлийн ханамж, баяр баясгалан Бурханы өөрийнх нь гараар бүтээгдсэн зүйлээс ирсэн бөгөөд энэ бол хүнээс Бурханд өргөсөн хамгийн анхны “тахил”, мөн хүнийг бүтээснээс хойш Бурханы хамгийн их эрхэмлэсэн зүйл байв. Бурхан энэхүү тахилыг хүлээн хэцүү бэрх цагийг туулсан бөгөөд үүнийг Тэр Өөрийн бүтээсэн хүнээс авсан хамгийн чухал анхны бэлэг гэж үзсэн. Энэ нь Өөрийнх нь хүчин чармайлт болон Өөрийнх нь төлсөн төлөөсний анхны үр дүнг Бурханд харуулж, хүн төрөлхтөнд найдвар бий гэдгийг харах боломжийг Түүнд олгосон юм. Дараа нь Бурхан Түүнтэй хамт байж, Түүнд чин сэтгэлээсээ хандаж, Түүнд чин сэтгэлээсээ анхаарал тавих тийм бүлэг хүнийг бүр ч илүү ихээр эгээрэн хүсэх болсон. Тэр ч бүү хэл, Бурхан Абрахамыг амьдарсаар байна гэж найдсан, учир нь Өөрийн удирдлагыг үргэлжлүүлэхэд Абрахамынх шиг тийм зүрх сэтгэл Өөрийг нь дагаж, Өөртэй нь хамт байгаасай гэж Тэр хүссэн юм. Бурхан юу хүсэж байсан нь хамаагүй, энэ бол зүгээр л нэг хүсэл, зүгээр л нэг санаа байсан—учир нь, Абрахам бол ердөө л Түүнийг дуулгавартай дагаж чадах хүн байсан, түүнд Бурханы талаар өчүүхэн төдий ч ойлголт, мэдлэг байгаагүй. Абрахам бол Бурханыг мэдэх, Бурханыг гэрчилж чадах, Бурхантай нэгэн санаатай байх хэмээх хүнээс Бурханы шаарддаг стандартын хаана нь ч хүрээгүй нэгэн байлаа. Иймээс Абрахам, Бурхантай хамт алхаж чадаагүй. Абрахам Исаакийг өргөл болгосноос Бурхан Абрахамын чин сэтгэл, дуулгавартай байдлыг харж, Бурханы шалгалтыг давсан гэдгийг нь харсан. Бурхан түүний чин сэтгэл, дуулгавартай байдлыг хүлээн зөвшөөрсөн хэдий боловч тэр Бурханы итгэлийг хүлээсэн, Бурханыг мэддэг, Бурханыг ойлгодог хүн болох, мөн Бурханы зан чанарыг мэддэг хүн байх гавьяагүй хэвээр байв; тэр Бурхантай нэг санаатай байж, Бурханы хүслийг биелүүлэх хүн огт биш байсан. Иймээс Бурхан зүрх сэтгэлдээ ганцаардмал, санаа зовсон хэвээр байсан юм. Бурхан ганцаардаж, санаа зовох тусмаа Өөрийн удирдлагыг аль болох хурдан үргэлжлүүлж, Өөрийн удирдлагын төлөвлөгөөг биелүүлж, Өөрийн хүсэлд аль болох хурдан хүрэхийн тулд бүлэг хүмүүсийг сонгон олж авч чаддаг байх нь улам их хэрэгтэй болсон. Энэ бол Бурханы их хүслэн бөгөөд бүр эхнээсээ өнөөдрийг хүртэл өөрчлөгдөлгүй үлдсэн юм. Бурхан анх хүнийг бүтээснээсээ хойш бүлэг ялагчдыг, Түүнтэй хамт алхаж,

Түүний зан чанарыг ойлгож, мэдэж, ухаарч чадах бүлгийг эгээрэн хүссэн билээ. Бурханы энэхүү хүсэл хэзээ ч өөрчлөгдөөгүй. Тэр хэчнээн удаан хүлээх хэрэгтэй болсон ч, өмнөх зам нь хэчнээн хүнд хэцүү байж магадгүй ч, хүсэн эрмэлзсэн зорилтууд нь хэчнээн хол байсан ч, Бурхан хүнд тавьсан найдлагаа хэзээ ч өөрчлөөгүй, хэзээ ч орхиогүй. Одоо Би үүнийг хэлсэн болохоор та нар Бурханы хүслээс зарим нэг зүйлийг ухаарав уу? Та нарын ухаарсан зүйл тийм ч гүн гүнзгий биш байх—гэхдээ аажмаар ухаарна!

Абрахамыг амьдарч байх үед Бурхан нэг хотыг бас устгасан. Энэ хотыг Содом гэдэг байлаа. Олон хүн Содомын түүхийг мэддэг нь эргэлзээгүй, гэхдээ энэ хотыг устгахын үндэс болсон Бурханы бодол санааг хэн ч мэдэхгүй.

Иймээс Абрахамтай ярилцсан Бурханы дараах ярианаас өнөөдөр бид Түүний зан чанарыг мэдэхийн зэрэгцээ тухайн үеийн Түүний бодлыг мэдэх болно. Тэгээд дараах Библийн хэсгүүдийг уншицгаая.

II. Бурхан Содомыг устгахаар шийдсэн нь

Эхлэл 18:26 Тэгээд Ехова: “Хэрвээ Би Содом хотынхон дотроос тавин зөв шударга хүнийг олох аваас тэднийг бодоод тэр газрыг бүхэлд нь өршөөнө” гэж хэлэв.

Эхлэл 18:29 Абрахам дахин Түүнтэй ярьж, “Тэндээс дөчин хүн олдож болох шүү дээ” гэж хэлэхэд Тэрээр: “Би тэрийг устгахгүй” гэв.

Эхлэл 18:30 Абрахам Түүнд “Тэндээс гучин хүн олдож болох шүү дээ” гэж хэлэхэд Тэрээр: “Би тэрийг устгахгүй” гэв.

Эхлэл 18:31 Абрахам Түүнд “Тэндээс хорь олдож болох шүү дээ” гэж хэлэхэд Тэрээр: “Би хотыг устгахгүй” гэв.

Эхлэл 18:32 Абрахам дахин Түүнд “Тэнд арав олдож болох шүү дээ” гэлээ. Тэр: “Би тэр хотыг устгахгүй” гэв.

Энд Библиэс Миний сонгосон хэдэн эшлэл байна. Эдгээр нь бүрэн эх хувь биш. Хэрвээ та нар эхийг нь үзмээр байвал Библиэс өөрсдөө харж болно; цаг хэмнэхийн тулд Би эх бичвэрийн зарим хэсгийг орхисон. Энд Би зөвхөн хэдэн гол эшлэл болон өгүүлбэрийг сонгож, бидний өнөөдрийн нөхөрлөлд үл нөлөөлөх хэдэн өгүүлбэрийг орхилоо. Бидний нөхөрлөх бүх хэсэг болон агуулгад эдгээр түүхийн нарийн ширийнийг, мөн эдгээр түүхэн дэх хүний зан төлвийг анхааралгүй алгасана; харин тэр үед Бурханы бодол, санаа ямар байсан тухай л ярина. Бурханы бодол, санаанаас бид Бурханы зан чанарыг харах ба Бурханы хийсэн бүхнээс жинхэнэ Бурханыг Өөрийг нь харна—ингэж бид зорилгодоо хүрнэ.

Бурхан зөвхөн Түүний үгэнд дуулгавартай орж, Түүний тушаалыг дагаж чаддаг хүмүүст санаа тавьдаг

Дээрх хэсгүүд нь хэд хэдэн чухал үгийг буюу тоог агуулсан. Эхлээд Ехова тухайн хотоос тавин зөв шударга хүн олбол энэ газрыг бүхэлд нь өршөөнө гэж, өөрөөр хэлбэл, тэр хотыг устгахгүй гэж хэлсэн. Тэгвэл үнэн хэрэг дээрээ Содом

хотод тавин зөв шударга хүн байсан уу? Байгаагүй. Үүний дараахан Абрахам Бурханд юу гэж хэлсэн бэ? Тэрээр тэнд дөчин хүн олдож болох шүү дээ гэж хэлсэн. Тэгэхэд Бурхан Би үүнийг хийхгүй гэсэн. Дараа нь Абрахам тэндээс гучин хүн олдож болох шүү дээ гэж хэлсэн. Бурхан, Би үүнийг хийхгүй гэсэн. Тэгвэл хорин хүн олдох аваас? Би үүнийг хийхгүй. Арван хүн? Би үүнийг хийхгүй. Яг үнэндээ арван зөв шударга хүн тэр хотод байсан уу? Арав байгаагүй—харин нэг хүн байсан. Энэ нэг хүн нь хэн байсан бэ? Лот байсан. Тэр үед Содомд ганц зөв шударга хүн байсан, гэхдээ ийм тоонд хүрэхэд Бурхан маш хатуу чанд, эсвэл их шаардлагатай байсан уу? Үгүй, Тэр тийм байгаагүй! Иймээс хүн “Дөч байвал яах вэ?”, “Гуч байвал яах вэ?” гэж асуусаар “Арав байвал яах вэ?” гэхэд Бурхан: “Тэнд ердөө арван хүн байсан ч Би энэ хотыг устгахгүй; Би үүнийг өршөөж, энэ арваас гадна бусад хүмүүсийг уучилна” гэсэн. Арав нь өчүүхэн тоо байсан боловч үнэндээ Содомд ядаж тийм тооны ч зөв шударга хүн байгаагүй болж таарсан. Тэгэхээр Бурханы бодлоор энэ хотын хүмүүсийн нүгэл хилэнц болон хорон муу нь тэднийг устгахаас өөр аргагүй байдалд Бурханыг хүргэсэн байгаа биз дээ. Тэнд тавин зөв шударга хүн байвал энэ хотыг устгахгүй гэж Бурхан хэлсэн нь ямар утгатай байсан бэ? Эдгээр тоо нь Бурханд чухал биш байсан. Юу чухал байсан бэ гэвэл, энэ хотод Өөрийнх нь хүссэн зөв шударга хүн байсан эсэх нь чухал байсан. Хэрвээ уг хотод ганцхан зөв шударга хүн байвал уг хотыг устгасны улмаас тэр хүн аюулд өртөхийг Бурхан зөвшөөрөхгүй байв. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, Бурхан энэ хотыг устгах эсэх нь хамаагүй, тэнд хэдэн зөв шударга хүн байгаа нь хамаагүй, Бурханы хувьд энэ нүгэлт хот хараагдаж, зүхэгдэх ёстой бөгөөд устгагдах ёстой, Бурханы нүднээс арилах ёстой, харин зөв шударга хүмүүс үлдэх ёстой байсан юм. Эрин үеийг үл харгалзан, хүн төрөлхтний хөгжлийн үе шатыг үл харгалзан Бурханы хандлага өөрчлөгддөггүй: Тэрээр мууг үзэн ядаж, Өөрийн нүдэнд зөв шударга хүмүүст анхаарал тавьдаг. Бурханы энэ тодорхой хандлага нь басхүү Бурханы мөн чанарын жинхэнэ илчлэл юм. Хот дотор ганцхан л зөв шударга хүн байсан учраас Бурхан цаашид тээнэгэлзээгүй. Эцсийн үр дүнд Содом зайлшгүй устгагдах байсан. Та нар үүнээс юу харж байна вэ? Тэр үед тэнд тавин зөв шударга хүн байсан бол, эсвэл арван хүн байсан бол Бурхан хотыг устгахгүй байсан, энэ нь, Түүнийг хүндэлж, шүтэн мөргөж чадах цөөхөн хүнийг бодоод Бурхан хүн төрөлхтнийг уучилж, тэдэнд хүлцэхээр шийдэх байсан, эсвэл залж чиглүүлэх ажил хийх байсан гэсэн үг юм. Бурхан хүний зөв шударга үйлсэд асар их итгэдэг, Түүнийг шүтэн мөргөж чадах хүмүүст асар их итгэдэг ба Түүний өмнө сайн үйлс хийж чадах хүмүүст Тэр асар их итгэдэг.

Хамгийн эртний үеэс өнөөдрийг хүртэл Бурхан хэн нэгэн хүнд үнэнийг хэлж, эсвэл Бурханы замын талаар ярьж байсан тухай та нар ер нь Библиэс уншсан уу? Үгүй, хэзээ ч үгүй. Хүнд хэлсэн Бурханы үгийг уншихад хүмүүст юу хийхийг л хэлж байсан. Зарим нь үүнийг хийж гүйцэлдүүлсэн, зарим нь үгүй; зарим нь итгэсэн, зарим нь итгээгүй. Ийм л байсан. Тиймээс тухайн эрин үеийн зөв шударга хүмүүс—Бурханы бодлоор зөв шударга байсан хүмүүс нь ердөө л Бурханы үгийг сонсож,

Бурханы тушаалыг дагаж чаддаг хүмүүс байв. Тэд бол Бурханы үгийг хүмүүсийн дунд биелүүлдэг зарц нар байлаа. Тийм хүмүүсийг Бурханыг мэддэг хүмүүс гэж болох байсан уу? Тэднийг Бурханы төгс болгосон хүмүүс гэж хэлж болох байсан уу? Үгүй, болохгүй байсан. Тэгэхээр, тэдний тоог үл харгалзан, Бурханы бодлоор бол эдгээр зөв шударга хүмүүсийг Бурханы итгэмжлэгдсэн хүн гэж нэрлэвэл таарах байсан уу? Тэднийг Бурханы гэрчүүд гэж нэрлэж болох байсан уу? Мэдээж үгүй! Тэд лав Бурханы итгэмжлэгдсэн хүн болон гэрчүүд гэж нэрлэгдэж таарахгүй байсан. Тэгвэл тийм хүмүүсийг Бурхан юу гэж нэрлэсэн бэ? Библийн Хуучин Гэрээнд Бурхан тэднийг “Миний зарц” гэж нэрлэсэн олон тохиолдол байдаг. Өөрөөр хэлбэл, тэр үед Бурханы нүдэнд эдгээр зөв шударга хүмүүс нь Бурханы зарц нар байсан, тэд газар дээр Бурханд үйлчилдэг хүмүүс байсан юм. Энэ нэршлийн тухай Бурхан юу гэж бодож байсан бэ? Тэр тэднийг яагаад ингэж нэрлэсэн бэ? Бурханы зүрх сэтгэлд хүмүүсийг юу гэж нэрлэх тухай стандарт байдаг уу? Гарцаагүй байдаг. Бурхан хүмүүсийг зөв шударга, төгс, чигч, эсвэл зарц нар гэж хэлэх нь хамаагүй, Түүнд стандарт байдаг. Тэр хэн нэгнийг Өөрийн зарц гэж хэлэхдээ энэ хүн Түүний элч нарыг хүлээж авч чадна, Түүний тушаалыг дагаж чадна, мөн элч нарын тушаасан зүйлийг гүйцэтгэж чадна гэдэгт бат итгэлтэй байдаг. Энэ хүн юу гүйцэтгэдэг вэ? Газар дээр хийж, гүйцэтгэ гэж Бурхан хүнд тушаасан зүйлийг гүйцэтгэдэг. Тэр үед, газар дэлхий дээр хийж, гүйцэтгэ гэж хүнээс Бурханы шаардсан зүйлийг Бурханы зам гэж болох байсан уу? Үгүй, болохгүй байсан. Учир нь, тэр үед Бурхан хүнээс зөвхөн цөөн хэдэн энгийн зүйл хийхийг хүссэн; Тэр хүнд зөвхөн энийг, эсвэл тэрийг хий гэснээс өөр юм хэлэлгүй цөөн хэдэн энгийн тушаал өгсөн. Бурхан Өөрийн төлөвлөгөөний дагуу ажиллаж байсан. Учир нь, тэр үед олон нөхцөл байдал хараахан бүрдээгүй, цаг нь хараахан болоогүй байсан бөгөөд Бурханы замыг баримтлах нь хүн төрөлхтөнд хэцүү байсан, тиймээс Бурханы зам Бурханы зүрх сэтгэлээс хараахан гарч эхлээгүй байлаа. Бурханы дурдаж байсан, бидний энд харж байгаа—хорь, эсвэл гуч ч юм уу—зөв шударга хүмүүсийг Бурхан Өөрийнхөө зарц гэж үздэг байсан. Бурханы элч нар эдгээр зарц дээр ирэхэд тэд элч нарыг хүлээн авч, тэдний тушаалуудыг дагаж, тэдний үгээр үйлдэж чаддаг байв. Энэ нь Бурханы үзэхэд, зарц нарын хийх, хүрэх ёстой яг тэр зүйл байсан юм. Бурхан хүмүүсийг нэрлэхдээ бодолтой байдаг. Тэд одоо та нарын байгаа шиг ихээхэн номлол сонссон, Бурхан юу хийх гэж байсныг мэддэг, Бурханы хүслийн талаар их ойлгодог, Түүний удирдлагын төлөвлөгөөг ухаардаг байсан болохоор нь Тэр тэднийг Өөрийн зарц гэж нэрлээгүй, харин тэд хүн чанараараа үнэнч шударга бөгөөд Бурханы үгийг дагаж чаддаг байсан учраас тэгсэн юм; Бурханыг тушаахад тэд хийж байснаа хойш тавьж, Бурханы тушаасныг гүйцэтгэж чаддаг байв. Иймээс Бурханы хувьд зарц гэдэг цолын утга учрын өөр нэг тал нь тэд газар дэлхий дээрх Түүний ажилд хамтран ажилладаг ба хэдийгээр Бурханы элч биш байсан ч гэсэн тэд бол Бурханы үгийг газар дээр гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч байсан. Тэгэхээр энэ зарц нар буюу зөв шударга хүмүүс нь Бурханы

зүрх сэтгэлд их чухал байгаа биз дээ. Дэлхий дээр Бурханы эхлэх гэж байсан ажил, Түүнтэй хамтран ажиллах хүмүүсгүйгээр байж чадахгүй байсан бөгөөд Бурханы зарц нарын хүлээсэн үүргийг Бурханы элч нараар орлуулшгүй байсан. Энэ зарц нарт Бурханы тушаасан даалгавар бүр Түүнд асар их ач холбогдолтой байсан тул Тэр тэднийг алдаж болохгүй байв. Эдгээр зарц нарын Бурхантай ажилласан хамтын ажиллагаагүйгээр хүн төрөлхтний дундах Бурханы ажил зогсоход хүрч, түүний уршгаар Бурханы удирдлагын төлөвлөгөө болон Бурханы итгэл найдвар талаар болох байлаа.

Бурхан санаа тавьдаг хүмүүстээ асар их өршөөнгүй байдаг ба Өөрийнхөө жигшиж, голдог хүмүүст гүнээ хилэгнэдэг

Библийн тэмдэглэлүүд дээр Содомд Бурханы арван зарц байсан уу? Үгүй, байгаагүй! Уг хот Бурханд өршөөгдөхүйц байсан уу? Тус хотод зөвхөн нэг хүн—Лот—Бурханы элчүүдийг хүлээн авсан. Үүний цаад утга нь гэвэл, тус хотод Бурханы ганц зарц л байсан бөгөөд тиймээс Лотыг авраад Содом хотыг устгахаас өөр зам Бурханд байгаагүй гэсэн үг. Дээр эш татсан Абрахам болон Бурханы хоорондын яриа энгийн мэт санагдаж болох ч маш гүн гүнзгий зүйлийг харуулдаг: Бурханы үйлдлүүдэд зарчим байдаг ба шийдвэр гаргахаасаа өмнө Тэр ажиглаж, сайтар бодож, урт хугацаа зарцуулдаг; цаг нь болохоос өмнө Тэр лав ямар нэгэн шийдвэр гаргахгүй, эсвэл аливаа дүгнэлт яаран хийхгүй. Содомыг устгах Бурханы шийдвэр өчүүхэн төдий ч буруу байгаагүй гэдгийг Абрахам болон Бурханы хоорондын яриа бидэнд харуулдаг, учир нь энэ хотод дөчин зөв шударга хүн байхгүй, гучин ч зөв шударга хүн байхгүй, хорь ч байхгүй гэдгийг Бурхан аль хэдийн мэдэж байв. Тэнд бүр арав ч байгаагүй. Тус хотод Лот л цорын ганц зөв шударга хүн байсан юм. Содомд тохиолдсон бүхнийг, тэндхийн нөхцөл байдлыг Бурхан ажиглаж байсан бөгөөд гарын арван хуруу шигээ мэддэг байлаа. Тиймээс Түүний шийдвэр буруу байж таарахгүй. Харин ч Бурханы төгс хүчит байдалтай харьцуулбал хүн маш хөшүүн, маш тэнэг ба мунхаг, маш харалган. Үүнийг бид Бурхан болон Абрахамын хоорондоо ярилцсан үгээс харж болно. Бурхан анхнаасаа эхлээд өнөөдрийг хүртэл Өөрийн зан чанарыг гаргасаар ирсэн. Түүнчлэн бидний харвал зохих Бурханы зан чанар энд ч бас байна. Тоонууд бол энгийн бөгөөд юуг ч илэрхийлдэггүй, харин энд Бурханы зан чанарын маш чухал илэрхийлэл бий. Бурхан тавин зөв шударга хүнийг бодоод тус хотыг устгахгүй байсан. Бурханы өршөөл энэрлээс болоод уу? Түүний хайр, хүлээцээс болоод уу? Та нар Бурханы зан чанарын энэ талыг харсан уу? Тэнд аравхан зөв шударга хүн байсан ч Бурхан тэр арван зөв шударга хүнийг бодоод тус хотыг устгахгүй байх байв. Энэ нь Бурханы хүлээц, хайр биш гэж үү? Бурханы өршөөл, хүлээц, мөн тэрхүү зөв шударга хүмүүст санаа тавих учраас Тэрээр тус хотыг устгахгүй байх байсан юм. Энэ бол Бурханы хүлээцтэй байдал. Эцэст нь бид ямар үр дүнг харж байна вэ? Абрахам: “Тэнд арав олдож болох шүү дээ” гэлээ. Бурхан: “Би тэр хотыг

устгахгүй” гэв. Түүний дараа Абрахам өөр юу ч хэлээгүй—учир нь Содомд түүний хэлсэн арван зөв шударга хүн байгаагүй, түүнд өөр хэлэх үг ч байгаагүй бөгөөд тэр үед Бурхан яагаад Содомыг устгахаар шийдсэнийг ойлгосон юм. Үүнээс Бурханы ямар зан чанар харагдаж байна вэ? Бурхан ямар шийдвэр гаргасан бэ? Өөрөөр хэлбэл, хэрвээ энэ хотод арван зөв шударга хүн байхгүй бол Бурхан үүний оршин тогтнохыг зөвшөөрөхгүй байсан ба үүнийг лавтайяа устгах байсан. Энэ нь Бурханы уур хилэн биш гэж үү? Энэ уур хилэн нь Бурханы зан чанарыг төлөөлөхгүй гэж үү? Энэ зан чанар нь Бурханы ариун мөн чанарын илчлэл биш гэж үү? Энэ нь хүн халдах ёсгүй Бурханы зөвт мөн чанарын илчлэл биш гэж үү? Содомд арван зөв шударга хүн байхгүй гэдгийг нотлоод Бурхан тус хотыг устгах нь мадаггүй болж, тэр хотод байсан хүмүүсийг хатуу шийтгэх гэж байсан, яагаад гэвэл, тэд Бурханыг эсэргүүцсэн ба маш бохир, ялзарсан байсан юм.

Яагаад бид эдгээр хэсгийг ийм маягаар задлан шинжилсэн бэ? Яагаад гэвэл, эдгээр энгийн цөөхөн өгүүлбэр нь Бурханы өгөөмөр энэрэлт зан чанар болон айхтар уур хилэнг бүрэн илэрхийлж өгдөг. Зөв шударга хүмүүсийг эрхэмлэж, өршөөн энэрч, хүлээцтэй хандаж, тэдэнд санаа тавихын зэрэгцээ Бурхан зүрх сэтгэлдээ Содомд байсан ялзарсан хүмүүсийг бүгдийг гүнээ жигшиж байв. Энэ нь өгөөмөр өршөөл болон айхтар уур хилэн байсан уу, үгүй юу? Бурхан уг хотыг ямар аргаар устгасан бэ? Галаар. Тэр яагаад тус хотыг гал хэрэглэж устгасан бэ? Ямар нэг зүйл галд шатаж байхыг хараад, эсвэл ямар нэг зүйлийг шатаах гэж байхдаа чамд ямар мэдрэмж төрдөг вэ? Яагаад чи тэр юмыг шатаамаар байдаг вэ? Тэр юм чамд цаашид хэрэггүй, тэрийг дахиж харахыг ч хүсэхгүй гэж боддог уу? Чи тэр юмыг огоорохыг хүсдэг үү? Бурхан гал хэрэглэсэн нь огоорох, үзэн ядах гэсэн утгатай байсан бөгөөд Тэр Содомыг дахин харахыг хүсээгүй. Энэ бол Содомыг галаар устгах болсон Бурханы сэтгэлийн хөдөлгөөн байсан юм. Гал хэрэглэсэн нь Бурханы хэр их ууртай байсныг харуулдаг. Бурханд өршөөл энэрэл, хүлээц үнэхээр байдаг боловч Өөрийн уур хилэнг сул тавих үед Бурханы ариун байдал болон зөвт байдал нь ямар ч халдлагыг тэвчдэггүй талыг нь хүнд бас үзүүлдэг. Хүн Бурханы тушаалыг дуулгавартай дагах бүрэн чадвартай байж, Бурханы шаардлагын дагуу ажиллахад хүнийг гэсэн Бурханы өршөөл энэрэл элбэг дэлбэг байдаг; хүн ялзрал, үзэн ядалт болон Өөрийнх нь эсрэг дайсагналаар дүүрэн байхад Бурхан ихэд уурладаг. Тэр хэр их хэмжээнд хүртэл уурладаг вэ? Бурхан цаашид хүний эсэргүүцэл болон муу үйлийг харахаа болих хүртэл, тэдгээр нь Түүний нүдний өмнө цаашид байхаа болих хүртэл Түүний уур хилэн үргэлжилнэ. Зөвхөн тэр үед л Бурханы уур арилна. Өөрөөр хэлбэл, тухайн хүн хэн байх нь хамаагүй, хэрвээ зүрх сэтгэл нь Бурханаас холдож, хэзээ ч эргэж ирэхгүйгээр Бурханаас нүүр буруулсан бол, харваас буюу тэдний хийсвэр хүслийн хувьд, тэд биеэрээ, эсвэл бодол санаагаараа Бурханд шүтэн мөргөж, дагаж, дуулгавартай байя гэж хүсэхийг нь үл тоомсорлон Бурханы уур хилэн зогсолтгүй ундарна. Бурхан хүнд өргөн боломж өгчихөөд уураа айхтар ноцтой гаргахад энэ нь нэгэнт суларвал буцаах аргагүй

болох бөгөөд Тэр тийм хүн төрөлхтөнд дахин хэзээ ч өршөөнгүй, хүлээцтэй хандахгүй. Энэ бол ямар ч зөрчлийг тэвчдэггүй Бурханы зан чанарын нэг тал юм. Энд, Бурхан нэг хотыг устгах нь хүмүүст хэвийн мэт санагддаг, учир нь Бурханы бодлоор бол нүглээр дүүрэн хот оршин тогтнож, хэвээр үлдэж болохгүй бөгөөд түүнийг Бурхан устгах нь ухаалаг явдал байсан. Гэсэн ч Содомыг устгахаас өмнө болон дараа тохиолдсон зүйлээс бид Бурханы зан чанарыг бүхэлд нь харж болно. Тэрээр нинжин, сайхан, сайн зүйлсэд хүлээцтэй, өршөөнгүй байдаг; муу, нүгэлтэй, хорон зүйлсэд гүнээ хилэгнэж, уур хилэнгээ зогсолтгүй илгээдэг. Эдгээр нь Бурханы зан чанарын хоёр үндсэн, хамгийн чухал тал бөгөөд түүнчлэн, тэдгээрийг Бурхан эхнээс нь эцсийг нь хүртэл ил харуулсан: өгөөмөр өршөөл ба айхтар уур хилэн. Та бүхний ихэнх нь Бурханы өршөөлөөс юм үзэж мэдэрсэн боловч та нараас тун цөөхөн нь Бурханы уур хилэнг ойлгосон. Бурханы өршөөл, хайр энэрлийг хүн бүрээс харж болно; өөрөөр хэлбэл, Бурхан хүн бүрт маш их өршөөнгүй байж ирсэн. Гэсэн ч Бурхан та нарын дундах ямар нэг хүнд юм уу, аль нэг хэсэгт айхтар уурлаж байсан удаа тун ховорхон эсвэл хэзээ ч уурлаж байгаагүй гэж хэлж болно. Тайвшир! Эрт, орой хэзээ нэгэн цагт Бурханы уур хилэн хүн бүхэнд харагдаж, мэдрэгдэх болно, харин одоо цаг нь хараахан болоогүй байна. Яагаад энэ вэ? Яагаад гэвэл, Бурхан хэн нэгэнд байнга уурлах үед, өөрөөр хэлбэл, Бурхан айхтар уур хилэнгээ түүн дээр буулгах үед энэ нь Тэр уг хүнийг удтал жигшиж, голсон, тэр хүний оршин тогтнолыг үзэн ядаж, оршин тогтнолыг нь тэвчиж чадахаа больсныг харуулж байгаа юм; Түүний уур хилэн тэдэн дээр буумагц тэд үгүй болно. Өнөөдөр Бурханы ажил тэр цэгт хараахан хүрээгүй байна. Бурхан айхтар уурлах л юм бол та нарын хэн нь ч үүнийг дааж чадахгүй. Тэгэх үед Бурхан та нарт бүгдэд нь асар их өршөөнгүй байсан бөгөөд Түүний айхтар уурыг хараахан хараагүй гэдгээ та нар ойлгоно. Хэрвээ итгэхгүй байгаа хүмүүс байвал Бурханы уур хилэнг өөрсөд дээрээ буугаач гэж гуй, ингэснээр та нар Бурханы уур хилэн болон хүний халдлагыг тэвчдэггүй Түүний зан чанар үнэхээр оршин байдаг эсэхийг мэдэрч болох юм. Та нар тэгж зүрхлэх үү?

Эцсийн өдрүүдийн хүмүүс Бурханы уур хилэнг үгээс нь л хардаг бөгөөд Бурханы уур хилэнг жинхэнээсээ амсаагүй

Библийн эдгээр хэсгээс харж болох Бурханы зан чанарын хоёр талыг нөхөрлөвөл зохих уу? Энэ түүхийг сонсоод та нар Бурханы талаар шинэчлэгдсэн ойлголттой болсон уу? Ямар ойлголттой байна вэ? Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл, Бурханы нигүүлсэл, өршөөл, хайр энэрлийг энэ сүүлчийн бүлгийнхэн шиг хэмжээгээр эдэлсэн бүлэг байхгүй гэж хэлж болно. Хэдийгээр сүүлчийн үе шатанд Бурхан шүүлт, гэсгээлтийн ажлыг хийж, Өөрийн ажлыг сүр жавхлан, уур хилэнтэйгээр хийсэн боловч Бурхан ажлаа хэрэгжүүлэхийн тулд голдуу зөвхөн үг хэрэглэдэг; Тэрээр зааж сургах, услах, хангах, тэжээхийн тулд үг хэрэглэдэг. Ингэх зуур Бурханы уур хилэн үргэлж далд нуугдаж байдаг бөгөөд Бурханы хилэнт зан

чанарыг Түүний үгээс мэдрэхээс гадна тун цөөхөн хүн Түүний уур хилэнг биечлэн үзсэн юм. Юу гэсэн үг вэ гэхээр, Бурханы шүүлт, гэсгээлтийн ажлын үеэр Бурханы үгэнд илэрсэн уур хилэн хэдийгээр Бурханы сүр жавхлан болон халдашгүй байдлыг үзэх боломжийг хүмүүст олгодог боловч энэхүү уур хилэн нь Түүний үгээс цааш хэтэрдэггүй. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг зэмлэх, хүнийг илчлэх, хүнийг шүүх, хүнийг гэсгээх болон хүнийг яллахдаа ч үг хэрэглэдэг—гэхдээ Бурхан хүнд хараахан айхтар их уурлаагүй байгаа бөгөөд хүнд Өөрийн уур хилэнг Өөрийн үгээс гадна бараг гаргаагүй. Тиймээс энэ эрин үед хүний мэдэрсэн Бурханы өршөөл, хайр энэрэл нь Бурханы жинхэнэ зан чанарын илчлэл байдаг байхад хүний үзэж амссан Бурханы уур хилэн нь ердөө л Түүний айлдваруудын өнгө, уур амьсгалын үр нөлөө юм. Олон хүн энэ үр нөлөөг Бурханы уур хилэнгийн жинхэнэ туршлага ба жинхэнэ мэдлэг хэмээн буруугаар ойлгодог. Иймд Бурханы үгээс өршөөл, өгөөмөр сэтгэлийг нь харсан, мөн хүний халдлагыг тэвчдэггүйг нь харсан гэж ихэнх хүн итгэдэг, мөн тэдний ихэнх нь Бурхан хүнд өршөөлтэй, хүлээцтэй ханддагийг мэдсэн нь ч бий. Гэхдээ хүний явдал хэчнээн муу муухай, зан чанар нь хэчнээн ялзармал байсан ч хамаагүй, Бурхан үргэлж тэвчсэн. Тэвчихдээ Түүний зорилго нь Өөрийн хэлсэн үг, гаргасан чармайлт, төлсөн төлөөс нь, Түүний олж авахыг хүссэн хүмүүст үр нөлөө үзүүлэхийг хүлээх явдал юм. Ийм үр дүн хүлээхэд цаг орох бөгөөд энэ нь хүмүүс дөнгөж төрөнгүүтээ насанд хүрэгч болдоггүйтэй адил хүнд зориулсан өөр өөр орчныг бүтээхийг шаарддаг; тэр нь арван найм, эсвэл арван есөн жилийг зарцуулдаг ба зарим хүний хувьд жинхэнэ том хүн болж нас биед хүрэхэд хорь, гучин жил ч хэрэгтэй байдаг. Бурхан энэ үйл явц гүйцэхийг хүлээдэг, Тэр тийм цаг ирэхийг хүлээдэг бөгөөд энэхүү үр дүн гарахыг нь хүлээдэг. Хүлээх хугацаандаа Бурхан асар өршөөнгүй байдаг. Гэхдээ Бурханы ажлын хугацаанд туйлын цөөн тооны хүн цохигдон унадаг ба зарим нь Бурханыг ихэд эсэргүүцсэний улмаас шийтгэгддэг. Тийм жишээнүүд нь хүний халдлагыг тэвчдэггүй Бурханы зан чанарын бүр ч илүү том нотолгоо бөгөөд сонгогдсон хүмүүст хандах Бурханы хүлээцтэй байдал, тэвчээрийн бодит оршин тогтнолыг бүрэн баталдаг. Мэдээж, эдгээр ердийн жишээн дэх энэ хүмүүст гарсан Бурханы зан чанарын нэг хэсгийн илчлэл нь Бурханы нийт удирдлагын төлөвлөгөөнд нөлөөлдөггүй. Үнэн хэрэгтээ Бурханы ажлын энэхүү сүүлчийн үе шатанд, хүлээж байх хугацааныхаа турш Бурхан тэвчсэн ба Өөрийг нь дагадаг хүмүүсийг аврахын төлөө Өөрийн тэвчээр болон амийг зольсон. Та нар үүнийг харж байна уу? Бурхан Өөрийн төлөвлөгөөг шалтгаангүйгээр нураахгүй. Тэр Өөрийн уур хилэнг сул тавьж чадна, бас өршөөнгүй байж чадна; энэ нь Бурханы зан чанарын хоёр үндсэн хэсгийн илчлэл юм. Энэ маш ойлгомжтой байна уу, үгүй юу? Өөрөөр хэлбэл, Бурханы тухайд гэвэл, зөв ба буруу, шударга ба шударга бус, эерэг ба сөрөг—энэ бүхэн нь хүнд тодорхой харагддаг. Тэр юу хийх вэ, Тэр юунд дуртай вэ, Тэр юуг үзэн яддаг вэ—энэ бүхэн Түүний зан чанарт шууд тусгагдаж чаддаг. Тийм зүйлсийг мөн Бурханы ажлаас маш илэрхий, тодорхой харж болдог ба тэдгээр нь бүдэг бадаг, эсвэл ерөнхий биш; харин тэдгээр нь

Бурханы зан чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохыг гойд илэрхий, жинхэнэ, бодит байдлаар харах боломжийг хүмүүст олгодог. Энэ бол жинхэнэ Бурхан Өөрөө билээ.

Бурханы зан чанар хэзээ ч хүнээс нуугдаж байгаагүй—хүний зүрх сэтгэл Бурханаас хөндийрсөн

Хэрвээ Би эдгээр зүйлийн талаар нөхөрлөөгүй бол та нарын хэн нь ч Библийн түүхүүдээс Бурханы жинхэнэ зан чанарыг харж чадахгүй байх байлаа. Энэ бол баримт. Яагаад гэвэл, хэдийгээр Библийн эдгээр түүх Бурханы хийсэн зарим зүйлийн талаар тэмдэглэсэн байдаг боловч Бурхан цөөн хэдэн үг хэлсэн ба хүнд Өөрийн зан чанарыг шууд танилцуулаагүй, эсвэл Өөрийн хүслийг ил тод гаргаагүй. Дараагийн үеийнхэн эдгээр тэмдэглэлийг үлгэр түүхээс өөрцгүй үзсэн тул Бурхан Өөрийгөө хүнээс нуудаг юм шиг, мөн Бурханы үнэн бие биш, харин Түүний зан чанар болон хүсэл хүнээс нуугддаг юм шиг хүмүүст санагддаг. Миний өнөөдрийн нөхөрлөлийн дараа ч Бурхан хүнээс бүрэн нуугдсан байдаг гэж та нар бас л бодож байна уу? Бурханы зан чанар хүнээс нуугдмал байдаг гэж та нар бас л итгэж байна уу?

Бүтээлийн цаг үеэс хойш Бурханы зан чанар Түүний ажилтай зэрэгцэн оршсоор ирсэн. Энэ нь хэзээ ч хүнээс нуугдмал байгаагүй, харин олон түмэнд бүрэн мэдэгдэж, хүнд ил байсан. Гэсэн ч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүний зүрх сэтгэл Бурханаас улам их холдсон бөгөөд хүний ялзрал илүү гүнзгий болохын хэрээр хүн, Бурхан хоёрын зай улам бүр ихэссэн юм. Хүн Бурханы нүднээс аажмаар, баараггүй алга болсон. Хүн Бурханыг “олж харж” чадахаа больсон нь түүнийг Бурханы талаарх ямар ч “мэдээлэлгүй” болгож орхисон; тийнхүү тэр Бурхан оршин байдаг эсэхийг мэддэггүй ба бүр Бурханы оршин тогтнолыг бүрэн үгүйсгэхдээ тулсан байна. Иймд Бурханы зан чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болох талаар хүн мэдэхгүй байх нь Бурхан хүнээс нуугддагаас болоогүй, харин хүний зүрх сэтгэл Бурханаас холдсоны уршиг юм. Хэдийгээр хүн Бурханд итгэдэг боловч зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй, Бурханыг хэрхэн хайрлахаа мэддэггүй, Бурханыг хайрлахыг ч хүсдэггүй, учир нь түүний зүрх сэтгэл хэзээ ч Бурханд ойртоогүй бөгөөд хүн, Бурханаас үргэлж зайлсхийдэг билээ. Үр дүнд нь, хүний зүрх сэтгэл Бурханаас хол хөндий байдаг. Тэгвэл түүний зүрх сэтгэл хаана байдаг вэ? Үнэн хэрэг дээрээ хүний зүрх сэтгэл хаашаа ч яваагүй: Үүнийг Бурханд өгч, эсвэл Бурханд харуулахаар илчлэхийн оронд хүн өөртөө хадгалсан. Зарим хүн Бурханд үргэлж залбирч, “Өө Бурхан минь, миний зүрх сэтгэлийг хараач, миний боддог бүхнийг Та мэднэ” гэж хэлдэг ба зарим нь бүр Бурханд өөрсдийгөө харуулж, хэрвээ тангаргаа зөрчвөл тэднийг шийтгэж болно гэж амладаг мөртлөө шүү. Хэдийгээр хүн зүрх сэтгэл доторхыг нь харахыг Бурханд зөвшөөрдөг боловч энэ нь хүн, Бурханы зохион байгуулалт болон зохицуулалтыг дуулгавартай дагах чадвартай гэсэн үг биш, мөн өөрийн хувь заяа, ирээдүй болон бүх зүйлийг Бурханы хяналт дор орхисон гэсэн үг

ч биш. Тиймээс Бурханд өргөдөг чиний тангараг, эсвэл Түүнд чи юу амладгийг үл харгалзан, Бурханы бодлоор бол чиний зүрх сэтгэл одоо ч Түүнд хаалттай байдаг, учир нь чи зүрх сэтгэлийг чинь харахыг л Бурханд зөвшөөрдөг, харин хянахыг зөвшөөрдөггүй. Өөрөөр хэлбэл, чи зүрх сэтгэлээ Бурханд огтхон ч өгөөгүй бөгөөд Бурханд сонсгохын тулд чихэнд чимэгтэй үг л хэлдэг; тэгэх зуураа чи олон янзын зальхай санаагаа, нууц сэдэл, далд явуулга, төлөвлөгөөнийхөө хамт Бурханаас нуудаг ба өөрийн ирээдүй, хувь заяаг гартаа атгаж, тэдгээрийг Бурхан булаан авах вий гэдгээс их айдаг. Тиймээс Өөрт нь хандах хүний чин сэтгэлийг Бурхан хэзээ ч хардаггүй. Хэдийгээр Бурхан хүний зүрх сэтгэлийн гүнийг ажиглаж, хүн зүрх сэтгэлдээ юу бодож байгааг, юу хийхийг хүсдэгийг, мөн зүрх сэтгэлдээ юу хадгалж байгааг харж чаддаг боловч хүний зүрх сэтгэл Бурханд харьяалагддаггүй, тэр үүнийгээ Бурханы хяналтад өгөөгүй. Өөрөөр хэлбэл, Бурханд ажиглах эрх байдаг боловч хянах эрх байдаггүй. Хүн өөрийн ухамсарт Бурханы зохицуулалтад өөрийгөө өгөхийг хүсдэггүй, эсвэл зорьдоггүй. Хүн өөрийгөө Бурханаас хаасан төдийгүй, Бурханы итгэлийг олж авах ба хуурмаг сэтгэгдэл төрүүлэхийн тулд зусар яриа, бялдуучлал ашиглах, жинхэнэ дүр төрхөө Бурханы нүднээс нуун зүрх сэтгэлээ хааж, далдлах арга зам боддог хүмүүс ч байна. Бурханд харуулахгүй байх тэдний зорилго бол тэд чухамдаа ямар вэ гэдгийг ойлгохыг Бурханд зөвшөөрөхгүй байх явдал юм. Тэд өөрсдийн зүрх сэтгэлийг Бурханд өгөхийг хүсдэггүй, харин өөрсдөдөө хадгалахыг хүсдэг. Үүнийг тайлбарлавал, хүн юу хийдэг, юу хүсдэг нь бүгд өөрийнх нь төлөвлөж, тооцоолж, шийдсэн зүйл байдаг; түүнд Бурханы оролцоо буюу хөндлөнгийн оролцоо шаардлагагүй, тэр ч бүү хэл, Бурханы зохион байгуулалт, зохицуулалт хэрэггүй гэсэн үг. Тиймээс Бурханы тушаал, Түүний даалгавар, эсвэл хүнд тавьдаг Бурханы шаардлагын тухайд гэвэл, хүний шийдвэр нь түүний өөрийн санаархал, сонирхол дээр, тухайн үеийн өөрийнх нь байдал, орчин нөхцөл дээр тулгуурладаг. Хүн өөрийн явах ёстой замыг дүгнэж, сонгохын тулд өөрийн мэддэг мэдлэг, ухаарал болон өөрийн оюун ухааныг үргэлж ашигладаг бөгөөд Бурханы хөндлөнгийн оролцоо, хяналтыг зөвшөөрдөггүй. Энэ бол Бурханы хардаг хүний зүрх сэтгэл билээ.

Анхнаасаа өнөөдрийг хүртэл зөвхөн хүн л Бурхантай ярилцах чадвартай байсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, бүх амьд зүйл ба бүтээлийн дундаас хүнээс өөр юу ч Бурхантай ярилцаж чадахгүй. Хүнд сонсох чих, харах нүд бий; тэр хэл яриатай бөгөөд өөрийн санаа бодол, хүсэл зоригтой. Тэр Бурханы ярихыг сонсож, Бурханы хүслийг ойлгож, Бурханы даалгаврыг хүлээн авахад шаардлагатай бүхнийг эзэмшдэг, иймээс Бурхан хүнийг Өөртэйгөө адилхан санаатай, Өөртэй нь хамт алхаж чадах түнш болгохыг хүсэж, Өөрийн бүх хүслийг хүнд найддаг. Удирдаж эхэлснээсээ хойш Бурхан, хүнийг зүрх сэтгэлээ Өөрт нь өгч, Бурханаар ариусгуулж, хангуулан, Бурханаар хайрлуулж, Бурханд таалагддаг болж, Бурханаас эмээж, муугаас зайлдаг болохыг нь хүлээсээр байна. Бурхан энэхүү үр дүнг үргэлж тэсгэлгүй хүсэн хүлээсэн. Библийн тэмдэглэлүүд дотор тийм хүмүүс байдаг уу?

Бурханд зүрх сэтгэлээ өгөх чадвартай хүн Библид байдаг уу? Энэ эрин үеэс өмнө тохиолдсон урьдын жишээ бий юу? Өнөөдөр, Библийн тэмдэглэлүүдийг үргэлжлүүлэн уншиж, Иов хэмээх энэ хүний хийсэн зүйл нь өнөөдрийн бидний ярьж байгаа “Бурханд зүрх сэтгэлээ өгөх” тухай сэдэвт холбоотой эсэхийг харцгаая. Иов Бурханд таалагдаж, Бурханд хайрлуулж байсан эсэхийг харцгаая.

Иовын талаарх та нарын сэтгэгдэл юу вэ? Зарим хүн судраас эш татаж, Иов “Бурханаас эмээж, муугаас зайлсан” гэдэг. “Бурханаас эмээж, муугаас зайлсан”: энэ нь Иовын талаарх Бурханы үнэлгээ юм. Хэрвээ та нар өөрийн үгийг ашиглавал Иовыг хэрхэн дүгнэх байсан бэ? Зарим хүн Иовыг сайн, ухаалаг хүн байсан гэж хэлдэг; зарим нь түүнийг Бурханд жинхэнэ итгэлтэй байсан гэж хэлдэг; зарим нь Иовыг зөв шударга, хүн чанартай хүн байсан гэж хэлдэг. Та нар Иовын итгэлийг харсан, өөрөөр хэлбэл, зүрх сэтгэлдээ та нар үүнд их ач холбогдол өгч, Иовын итгэлд атаархдаг. Тэгвэл өнөөдөр, Иов Бурханд ингэж таалагдах юу эзэмшдэг байсныг харцгаая. Дараа нь доорх бичвэрүүдийг уншицгаая.

III. Иов

1. Иовын талаарх Бурханы болон Библи дэх үнэлгээ

Иов 1:1 Узын нутагт Иов нэртэй нэгэн эр байв; тэр хүн бол төгс, шулуун шударга бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн байв.

Иов 1:5 Тэгээд тэдний найрлах өдрүүд өнгөрөхөд Иов хүн явуулан тэдэнд өөрсдийгөө ариусга гэв. Тэрээр өглөө эрт босож, бүгдийнх нь тоогоор шатаалт тахил өргөв: Яагаад гэвэл, Иов: “Хөвгүүд минь нүгэл үйлдэж, Бурханыг зүрх сэтгэлдээ хараасан байж магадгүй” гэж хэлсэн. Иов тийнхүү тасралтгүй үйлддэг байв.

Иов 1:8 Тэгээд Ехова Сатанд, “Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй” хэмээв.

Эдгээр хэсгээс та нар ямар гол зүйлийг харж байна вэ? Библийн энэ гурван товчхон хэсэг бүгд Иовд хамаатай. Хэдий богино боловч тэдгээр нь тэр ямар хүн байсныг тодорхой өгүүлдэг. Иовын өдөр тутмын ааш авир, зан төлвийн тухай дүрслэлээр дамжуулан Иовын талаарх Бурханы үнэлгээ оргүй биш, харин ч үндэслэл сайтай байсан гэдгийг хүн бүхэнд хэлдэг. Тэдгээр нь, Иовын талаарх хүний үнэлгээ (Иов 1:1) ч тэр, эсвэл түүний талаарх Бурханы үнэлгээ (Иов 1:8) ч тэр, аль аль нь Бурхан болон хүний өмнө гүйцэтгэсэн Иовын үйл хэргийн үр дүн (Иов 1:5) юм гэдгийг бидэнд хэлдэг.

Эхлээд бүгдээрээ нэг дэх хэсгийг уншицгаая: “Узын нутагт Иов нэртэй нэгэн эр байв; тэр хүн бол төгс, шулуун шударга бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн байв.” Энэ бол Библи дэх Иовын талаарх эхний үнэлгээ бөгөөд энэ өгүүлбэр нь Иовын талаарх зохиогчийн үнэлэлт юм. Энэ нь “Тэр хүн бол төгс, шулуун шударга бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн байв” гэж Иовыг үнэлэх

хүний үнэлгээг төлөөлдөг нь зүйн хэрэг. Дараа нь Иовын талаарх Бурханы үнэлгээг уншицгаая: “Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй.” Хоёр үнэлгээний нэг нь хүнээс гарсан ба нөгөө нь Бурханаас үүсэлтэй; тэдгээр нь адилхан агуулгатай хоёр үнэлгээ юм. Иовын ааш авир, зан төлөв нь хүмүүст танигдсан бөгөөд мөн Бурханд магтагдсан гэдгийг харж болно. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн өмнө гаргадаг Иовын зан төлөвболон Бурханы өмнө гаргадаг зан төлөв нь адилхан байсан; тэр өөрийн ааш авир, сэдлийг Бурханы өмнө цаг ямагт дэлгэдэг, ингэснээр Бурхан тэдгээрийг нь ажиглаж болох байсан ба тэр бол Бурханаас эмээж, муугаас зайлсан нэгэн байсан. Тиймээс Бурханы бодлоор бол дэлхий дээрх хүмүүсээс зөвхөн Иов л төгс, шулуун шударга бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн байлаа.

Иов өдөр тутмын амьдралдаа Бурханаас эмээж, муугаас зайлсны гойд илрэлүүд

Дараа нь, Иов өдөр тутмын амьдралдаа Бурханаас эмээж муугаас зайлсны гойд илрэлүүдийг харцгаая. Үүний өмнөх болон дараах хэсэг дээр нэмээд, мөн Иовын Бурханаас эмээж, муугаас зайлсны гойд илрэлийн нэг болох Иов 1:5-ыг уншицгаая. Энэ нь өдөр тутмын амьдралдаа тэр хэрхэн Бурханаас эмээж, муугаас зайлж байсантай холбоотой; хамгийн чухал нь тэр өөрөө Бурханаас эмээж, муугаас зайлахын тулд хийх ёстойгоо хийсэн төдийгүй бас хөвгүүдийнхээ өмнөөс Бурханы өмнө шатаалт тахил байнга өргөдөг байлаа. Найрлаж байхдаа тэд үргэлж “нүгэл үйлдэж, Бурханыг зүрх сэтгэлдээ хараасан байж магадгүй” гэж Иов айдаг байсан. Энэ явдал дээр Иовын илрэл юу байсан бэ? Эх бичвэрт дараах тэмдэглэл байдаг: “Тэгээд тэдний найрлах өдрүүд өнгөрөхөд Иов хүн явуулан тэдэнд өөрсдийгөө ариусга гэв. Тэрээр өглөө эрт босож, бүгдийнх нь тоогоор шатаалт тахил өргөв.” Бурханаас эмээх нь түүний гадаад талын ааш авирт илрэхээсээ илүүгээр зүрх сэтгэлээс нь гарч байсныг, тэр өөрөө муугаас зайлаад зогсоогүй, мөн хөвгүүдийнхээ өмнөөс байнга шатаалт тахил өргөж байсан учраас мөн Бурханаас эмээх нь цаг ямагт, өдөр тутмын амьдралынх нь бүх талаас олж болохыг Иовын ийм зан төлөв бидэнд харуулдаг билээ. Өөрөөр хэлбэл, Иов Бурханы эсрэг нүгэл үйлдэж, зүрх сэтгэлдээ Бурханаас татгалзахаас ихэд айгаад зогсохгүй, хөвгүүд нь Бурханы эсрэг нүгэл үйлдэж, зүрх сэтгэлдээ Бурханаас татгалзах вий гэж бас санаа нь зовдог байв. Бурханаас эмээх Иовын үнэн чанар нарийвчилсан шалгалтыг давна гэдгийг үүнээс харж болох бөгөөд энэ нь ямар ч хүн эргэлзэх аргагүй зүйл юм. Тэр тэгж хааяа хийдэг байсан уу, эсвэл байнга хийдэг байсан уу? Бичвэрийн сүүлийн өгүүлбэрт “Иов тийнхүү тасралтгүй үйлддэг байв” гэсэн юм. Эдгээр үгийн утга нь, Иов хөвгүүдээ хааяа нэг, эсвэл өөрт нь тааламжтай санагдсан үед л эргэж тойрдоггүй байсан, мөн залбирлаар дамжуулж Бурханд нүглээ наманчлаагүй гэсэн үг юм. Үүний оронд тэр хөвгүүдээ тогтмол илгээж, ариусгаж, тэдний төлөө шатаалт тахил өргөж байсан билээ. Энд “тасралтгүй” гэж байгаа нь тэр ингэж ганц хоёр

өдөр, эсвэл түр зуур хийсэн гэсэн үг биш. Энэ нь Иовын Бурханаас эмээдгийн илэрхийлэл түр зуурынх байгаагүй бөгөөд зөвхөн мэдлэг юм уу, хэлсэн үгээр хязгаарлагдаагүй гэдгийг хэлж байна; үүний оронд Бурханаас эмээж, муугаас зайлах зам нь түүний зүрх сэтгэлийг хөтөлж, түүний үйлдлийг удирдаж байсан бөгөөд энэ нь түүний зүрх сэтгэлд оршин тогтнолынх нь үндэс байсан. Тэр тасралтгүй ингэж хийсэн гэдэг нь зүрх сэтгэлдээ тэр, Бурханы эсрэг нүгэл үйлдэхээс дандаа эмээдэг байсан бөгөөд мөн түүнчлэн хөвгүүд, охид нь Бурханы эсрэг нүгэл үйлдэхээс айдаг байсныг харуулдаг. Энэ нь Бурханаас эмээх, муугаас зайлах зам нь түүний зүрх сэтгэлд хэр зэрэг чухал байсныг үзүүлдэг. Тэр тэгж тасралтгүй хийсэн, учир нь зүрх сэтгэлдээ тэр түгшиж, айж байсан—муу юм хийчихлээ, Бурханы эсрэг нүгэл үйлдчихлээ, Бурханы замаас хазайчихлаа, тэгээд Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадахгүй боллоо гэж айж байсан юм. Үүний зэрэгцээ охид, хөвгүүд нь Бурханд халдах зүйл хийчихлээ гэж айж, тэдэнд бас санаа нь зовдог байсан. Иовын өдөр тутмын амьдралын ердийн зан төлөв ийм байв. Яг энэ ердийн зан төлөв нь Иовын Бурханаас эмээдэг, муугаас зайлдаг нь хоосон үг байгаагүй бөгөөд Иов үүнийг бодит байдал дээр амьдран харуулсан гэдгийг нотолдог. “Иов тийнхүү тасралтгүй үйлддэг байв”: Эдгээр үг нь бидэнд Бурханы өмнө Иовын хийсэн өдөр тутмын үйл хэргийг хэлж өгдөг. Тэр тийнхүү тасралтгүй үйлдэхэд түүний үйлдэл болон зүрх сэтгэл Бурханы өмнө хүрдэг байсан уу? Өөрөөр хэлбэл, түүний зүрх сэтгэл, түүний ааш авирт Бурхан байнга сэтгэл ханамжтай байсан уу? Тэгвэл ямар байдалд, мөн ямар орчинд Иов тийнхүү тасралтгүй үйлдсэн бэ? Зарим хүн: “Бурхан Иовд байн байн харагддаг байсан учраас Иов тийнхүү тасралтгүй үйлдсэн” гэж хэлдэг. “Иов муугаас зайлах хүсэлтэй байсан учраас тийнхүү тасралтгүй үйлдсэн” гэж зарим нь хэлдэг. “Иов өөрийнх нь эд хөрөнгө хялбар олдоогүй гэж бодож, үүнийг Бурхан хайрласан гэдгийг мэддэг байсан болохоор Бурханыг гомдоож, халдсаны уршгаар эд хөрөнгөө алдана гэж маш их айсан байх” гэж зарим хүн хэлдэг. Эдгээр үгийн аль нэг нь үнэн үү? Мэдээж үгүй. Учир нь Бурханы бодлоор бол, Иовын тухайд Бурханы хүлээн зөвшөөрч, хамгийн их хайрласан зүйл нь зөвхөн түүний тийнхүү тасралтгүй үйлдсэн явдал биш байсан; харин үүнээс ч илүүтэйгээр, Сатаны гарт өгөгдөж, уруу татагдаж байх үедээ Бурхан, хүн, Сатан гурвын өмнө түүний гаргасан зан төлөв байсан билээ. Доорх хэсгүүд нь Иовын талаарх Бурханы үнэлгээ үнэн гэдгийг бидэнд харуулдаг хамгийн үнэмшилтэй баримтыг өгдөг юм. Дараа нь Библийн дараах хэсгүүдийг уншицгаая.

2. Сатан Иовыг анх удаа уруу татсан нь (малаа хулгайд алдаж, хүүхдүүдэд нь гай зовлон тохиолдов)

а. Бурханы хэлсэн үгс

Иов 1:8 Тэгээд Ехова Сатанд, “Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй” хэмээв.

Иов 1:12 Тэгээд Ехова Сатанд, “Харагтун, түүнд буй бүхэн чиний мэдэлд байна; харин чи түүнд л битгий хүр” гэв. Тэгэхэд нь Сатан Еховагийн дэргэдээс явав.

б. Сатаны хариу

Иов 1:9–11 Дараа нь Сатан Еховад хариулж, “Иов Бурханаас учир шалтгаангүйгээр эмээдэг гэж үү? Чи түүнийг, түүний байшинг тойруулж, түүнд буй бүхнийг нь тойруулж хашаалаагүй гэж үү? Чи түүний гарын ажлыг ерөөсөн, тэгээд түүний эд хөрөнгө энэ нутагт олширсон. Харин одоо гараа сунган түүнд буй бүхэнд хүр, тэгээд тэр Чиний өөдөөс хараах болно” гэв.

Иовыг уруу татахыг Бурхан Сатанд зөвшөөрсөн нь Иовын итгэлийг төгс болгохын төлөө байв

Иов 1:8 бол Ехова Бурхан, Сатан хоёрын яриаг Библиэс харж болох хамгийн эхний тэмдэглэл юм. Бурхан юу гэж хэлсэн бэ? Эх бичигт дараах зүйлийг дурджээ: Тэгээд Ехова Сатанд хандан, “Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй” хэмээв. Энэ бол Иовын талаар Сатанд хэлсэн Бурханы үнэлгээ байсан; тэр бол төгс, шулуун шударга агаад Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн гэж Бурхан хэлсэн. Бурхан, Сатан хоёр хоорондоо ийм үг солихоос өмнө Бурхан, Иовыг уруу татахад Сатаныг ашиглана—Иовыг Сатаны гарт өгнө гэдгээ шийдчихсэн байсан. Нэг талаар энэ нь Иовын талаарх Бурханы ажиглалт болон үнэлгээ алдаагүй, чамбай байсныг баталж, мөн Иовын гэрчлэлээр дамжуулан Сатаныг шившиглэх байсан; нөгөө талаар энэ нь, Бурханд итгэх Иовын итгэлийг нь, Бурханаас эмээхийг нь төгс болгох байсан юм. Тиймээс Сатаныг Бурханы өмнө ирэхэд Бурхан хоёрдмол утгаар яриагүй. Тэр шууд гол зүйлдээ орж, Сатанаас “Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй” гэсэн. Бурханы асуултад дараах утга байсан: Сатан хаа сайгүй хэсүүчлэн явсан бөгөөд Бурханы зарц байсан Иовыг дандаа тагнадаг байсныг Бурхан мэдэж байв. Иовын итгэл болон Бурханаас эмээдэг нь баттай байж чадахгүй гэдгийг батлахын тулд Сатан, Иовд сүйрэл авчрах арга зам олох гэж оролдон Иовыг дандаа сорьж, дайран довтолж байсан. Түүнчлэн Иовыг Бурханаас татгалзаж магадгүй, өөрөө Иовыг Бурханы гараас булаан авч магадгүй гэсэндээ Сатан Иовыг хорлох боломжуудыг дуртайяа хайж байлаа. Гэсэн ч Бурхан, Иовын зүрх сэтгэл доторхыг ажиглаж, тэр бол төгс, шулуун шударга агаад Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүн гэдгийг харсан. Иов бол Бурханаас эмээж, муугаас зайлдаг, төгс, шулуун шударга хүн бөгөөд хэзээ ч Бурханаас татгалзаж, Сатаныг дагахгүй гэдгийг Сатанд хэлэхийн тулд Бурхан асуулт ашиглажээ. Иовын талаарх Бурханы үнэлэлтийг сонсоод доромжлогдсондоо Сатаны уур хүрсэн ба Иовыг булаан авах гэж улам их уурлаж, улам их тэвчээргүй болсон, учир нь хэн нэгэн хүн төгс, шулуун шударга байж чадна,

эсвэл Бурханаас эмээж, муугаас зайлж чадна гэдэгт Сатан хэзээ ч итгээгүй юм. Үүний зэрэгцээ Сатан бас хүний төгс байдал болон шударга занд зэвүүцсэн бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаг хүмүүсийг үзэн ядсан. Иймээс Иов 1:9–11-т ийн бичжээ: “Дараа нь Сатан Еховад хариулж, ‘Иов Бурханаас учир шалтгаангүйгээр эмээдэг гэж үү? Чи түүнийг, түүний байшинг тойруулж, түүнд буй бүхнийг нь тойруулж хашаалаагүй гэж үү? Чи түүний гарын ажлыг ерөөсөн, тэгээд түүний эд хөрөнгө энэ нутагт олширсон. Харин одоо гараа сунган түүнд буй бүхэнд хүр, тэгээд тэр Чиний өөдөөс хараах болно’ гэв.” Бурхан, Сатаны хорлонтой уг чанарыг туйлын сайн мэддэг байсан ба Сатан, Иовд сүйрэл авчрахаар аль хэдийн төлөвлөсөн гэдгийг тун сайн мэдэж байсан, иймээс Иов бол төгс, шулуун шударга агаад Бурханаас эмээж, муугаас зайлдаг гэдгийг Сатанд дахин нэг удаа хэлснээрээ Бурхан үүнийг Сатаныг номхруулан дарж, мөн Сатаныг үнэн нүүр царайгаа харуулан, Иовыг дайрч, уруу татаг гэж хүссэн юм. Өөрөөр хэлбэл, Иов бол төгс, шулуун шударга агаад Бурханаас эмээж муугаас зайлсан нэгэн гэдгийг Бурхан зориуд онцолсон бөгөөд энэ аргаар Сатаныг, Иовынтөгс, шулуун шударга байдал, Бурханаас эмээж, муугаас зайлдгийг үзэн ядаж, уурладгаасаа болоод Иов руу дайрахад хүргэсэн. Үүний үр дүнд Иов төгс, шулуун шударга хүн бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн гэдэг бодит баримтаар дамжуулан Бурхан Сатанд ичгүүр авчрах байсан ба Сатан бүрмөсөн шившиг болж, ялагдах байсан юм. Үүний дараа Сатан, Иовын төгс, шулуун шударга, Бурханаас эмээж, муугаас зайлдагт нь дахин хэзээ ч эргэлзэж, буруушаан чичлэхээ болих байсан. Ийм байдлаар Бурханы шалгалт болон Сатаны сорилт нь бараг зайлшгүй байсан билээ. Бурханы шалгалт болон Сатаны сорилтыг даван гарч чадах цорын ганц хүн нь Иов байв. Энэ ярианы дараа Иовыг уруу татах зөвшөөрөл Сатанд өгөгдсөн. Тиймээс Сатаны дайралтуудын эхний үе эхэлсэн. Энэ дайралтуудын бай нь Иовын эд хөрөнгө байсан ба учир нь Сатан дараах буруушаалтыг Иовын эсрэг хийсэн билээ: “Иов Бурханаас учир шалтгаангүйгээр эмээдэг гэж үү?… Чи түүний гарын ажлыг ерөөсөн, тэгээд түүний эд хөрөнгө энэ нутагт олширсон.” Үүний үр дүнд Бурхан Иовд байгаа бүхнийг авахыг Сатанд зөвшөөрсөн—энэ нь Бурхан Сатантай ярьсны гол зорилго байсан юм. Гэсэн хэдий ч Бурхан Сатанд, “Т үүнд буй бүхэн чиний мэдэлд байна; харин чи түүнд л битгий хүр” (Иов 1:12) гэсэн нэг шаардлага тавьсан. Энэ бол Иовыг уруу татахыг Сатанд зөвшөөрч, Иовыг Сатаны гарт өгснийхөө дараа Бурханы Сатанд тавьсан нэг болзол байсан бөгөөд Сатанд тогтоосон хязгаар байв: Иовыг хорлохгүй байхыг Тэрээр Сатанд тушаасан. Яагаад гэвэл, Иов бол төгс, шулуун шударга хүн байсан гэдгийг Бурхан хүлээн зөвшөөрсөн бөгөөд Өөрийнх нь өмнө гаргадаг Иовын төгс байдал, шулуун шударга занд эргэлзэхийн аргагүй, Иов шалгалтыг давж чадна гэдэгт итгэлтэй байсан тул Бурхан Иовыг уруу татахыг Сатанд зөвшөөрсөн боловч Сатанд хязгаарлалт тавьсан: Иовын бүх эд хөрөнгийг авахыг Сатанд зөвшөөрсөн боловч тэр Иовд хуруу ч хүргэж болохгүй байв. Энэ юу гэсэн үг вэ? Тухайн үед Бурхан Иовыг Сатанд бүрэн өгөөгүй гэсэн үг юм. Сатан,

Иовыг хүссэн ямар ч аргаараа уруу татаж болох боловч Иовыг өөрийг нь—толгойнх нь нэг үсийг ч—гэмтээж болохгүй байсан, яагаад гэвэл, хүний бүх юмыг Бурхан хянадаг, хүн амьдрах уу, үхэх үү гэдгийг Бурхан шийддэг. Сатанд тийм эрх байдаггүй. Бурхан эдгээр үгийг Сатанд хэлсний дараа Сатан хүлээж ч тэвчилгүй эхэлсэн. Тэр Иовыг уруу татахын тулд бүх аргыг ашигласан ба тун удалгүй Иов үй олон хонь, үхэр болон Бурханы өгсөн бүх эд хөрөнгийг алдсан… Тийнхүү Бурханы шалгалт түүн дээр ирсэн юм.

Хэдийгээр Библи бидэнд Иовын сорилтын эх сурвалжийг хэлдэг ч эдгээр сорилтод өртсөн Иов юу болоод байгааг өөрөө мэдэж байсан уу? Иов зөвхөн ердийн нэг хүн байсан; мэдээж түүний эргэн тойронд юу болж буй талаар тэр огт мэдээгүй. Гэсэн хэдий ч түүний Бурханаас эмээдэг нь, төгс байдал болон шулуун шударга зан нь Бурханы шалгалт түүн дээр ирсэн гэдгийг түүнд ухааруулсан. Тэрээр сүнсний ертөнцөд юу болсныг ч, мөн эдгээр шалгалтын ард Бурханы ямар санаа зорилго байсныг ч мэдээгүй. Гэхдээ түүнд юу тохиолдсон ч хамаагүй төгс байдал, шулуун шударга зангаа чанд хадгалах ёстой бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлах замыг баримтлах ёстой гэдгээ мэдэж байсан. Эдгээр асуудалд хандсан Иовын хандлага болон хариу үйлдлийг Бурхан тодорхой харжээ. Бурхан юу харсан бэ? Бурханаас эмээдэг Иовын зүрх сэтгэлийг олж харсан, учир нь эхнээсээ л шалгагдаж дуусан дуустлаа Иовын зүрх сэтгэл Бурханд нээлттэй хэвээр үлдэж, Бурханы өмнө дэлгээтэй байсан бөгөөд Иов төгс байдал, шулуун шударга зангаа орхиогүй, мөн Бурханаас эмээж, муугаас зайлах замаа хаяагүй буюу эргэж буцаагүй—үүнээс илүү тааламжтай зүйл Бурханд байгаагүй юм. Дараа нь, Иов ямар сорилт туулж, эдгээр шалгалтад хэрхэн хандсан тухай бид үзэх болно. Библиэс уншицгаая.

в. Иовын хариу үйлдэл

Иов 1:20–21 Тэгээд Иов босож, нөмрөгөө урж, толгойн үсээ хусаж, газар унан мөргөөд, “Би эхийнхээ хэвлийгээс нүцгэн ирсэн, тийшээ нүцгэн буцах болно: Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг” гэв.

Иов эзэмшдэг бүхнээ буцааж өгсөн нь түүний Бурханаас эмээдэг байдлаас үүдсэн

Бурхан, Сатанд “Т үүнд буй бүхэн чиний мэдэлд байна; харин чи түүнд л битгий хүр” гэж хэлсний дараа Сатан явсан, дараахан нь Иов гэнэтийн, хатуу ширүүн дайралтад өртсөн: Эхлээд түүний үхэр, илжгийг дээрэмдэж, зарим зарцыг нь алсан; дараа нь түүний хонь болон бас хэдэн зарцыг шатааж сүйрүүлсэн; тэгсний дараа тэмээг нь булаан авч, дахиад хэдэн зарцыг нь хөнөөсөн; эцэст нь түүний охид, хөвгүүдийн амийг авсан. Энэ цуврал дайралт бол эхний сорилтын үеэр Иовын туулсан зовлон шаналал байсан юм. Эдгээр дайралтын туршид Сатан Бурханы тушааснаар зөвхөн Иовын эд хөрөнгө болон хүүхдүүдийг онилсон ба

Иовыг өөрийг нь гэмтээгээгүй. Ямар боловч Иов асар их эд баялагтай баян байснаа хоромхон зуурт юу ч үгүй хоосон нэгэн болж хувирсан. Хэн ч энэ хачирхалтай гэнэтийн цохилтыг тэсвэрлэж, эсвэл хариуд нь зохистой үйлдэл хийж чадахгүй байх байсан, харин Иов өөрийн ер бусын талыг харуулжээ. Библид дараах явдлыг дурджээ: “Тэгээд Иов босож, нөмрөгөө урж, толгойн үсээ хусаж, газар унан мөргөв.” Энэ бол үр хүүхдүүдээ болон бүх эд хөрөнгөө алдсан гэдгээ сонсоод Иовын үзүүлсэн эхний хариу үйлдэл байсан. Юуны өмнө тэр гайхсан, мэгдэж сандарсан шинжгүй байсан ба уурласан, үзэн ядсан байдлыг бүр ч илэрхийлээгүй. Тэгэхээр эдгээр гай гамшиг нь санаандгүй явдал, эсвэл хүний гараар хийгдсэн зүйл биш төдийгүй залхаан цээрлүүлэлт юм уу, шийтгэл ирж байгаа явдал бүр ч биш гэдгийг тэр зүрх сэтгэлдээ аль хэдийн хүлээн зөвшөөрсөн байгаа биз дээ. Харин Еховагийн шалгалтууд түүн дээр ирсэн; түүний эд хөрөнгө, үр хүүхдийг авахыг хүссэн нэгэн бол Ехова байсан. Тэр үед Иов маш тайван, сэргэг ухаантай байсан юм. Түүний төгс, шулуун шударга хүн чанар нь түүнд тохиолдсон гай гамшгуудын талаар ухаалаг, зүй зохистойгоор нарийн чамбай шүүж, шийдвэр гаргах боломжийг түүнд олгосон ба үүний үр дүнд тэр ер бусын тайван загнасан: “Тэгээд Иов босож, нөмрөгөө урж, толгойн үсээ хусаж, газар унан мөргөв.” “Нөмрөгөө урж” гэдэг нь хувцасгүй бөгөөд юу ч авч яваагүй байсан гэсэн үг; “толгойн үсээ хусаж” гэдэг нь дөнгөж төрсөн нярай хүүхэд шиг болоод Бурханы өмнө эргэж очсон гэсэн утгатай; “газар унан мөргөсөн” гэдэг нь тэр энэ дэлхийд нүцгэн ирсэн, өнөөдөр ч юу ч үгүй байгаа бөгөөд дөнгөж төрсөн нярай хүүхэд болж Бурханд буцаж очсон гэсэн үг юм. Өөрт нь тохиолдсон бүхэнд Иовын хандсан хандлагыг Бурханы ямар ч амьтан гаргаж чадахгүй байх байсан билээ. Еховад итгэх түүний итгэл нь итгэлийн хүрээнээс даван гарсан; энэ нь түүний Бурханаас эмээдэг, Бурханы өмнө дуулгавартай байдаг чанар нь байсан бөгөөд түүнд юм өгсөнд нь төдийгүй, мөн түүнээс буцааж авахад нь ч Бурханд талархаж чадаж байсан. Түүнчлэн тэр өөрийн амийг оролцуулаад өөртөө байсан бүхнийг Бурханд буцаан өгөх чадвартай байлаа.

Иовын Бурханаас эмээдэг, дуулгавартай байдал нь хүн төрөлхтөнд үлгэр болох жишээ бөгөөд түүний төгс, шулуун шударга зан нь хүний эзэмшвэл зохих хүн чанарын оргилд хүрсэн юм. Тэр хэдийгээр Бурханыг хараагүй ч гэсэн Бурхан үнэхээр оршин байдаг гэдгийг ухаарсан, ийнхүү ухаарсан учраас Бурханаас эмээсэн ба Бурханаас эмээдэг болохоороо Бурханы өмнө дуулгавартай байж чадсан юм. Түүнд байгаа бүхнийг нь авах боломжийг тэр Бурханд олгосон, гэхдээ тэр ямар ч гомдолгүй байсан ба Бурханы өмнө унаж, яг энэ мөчид Бурхан түүний бие махбодыг авах байлаа ч гэсэн тэгэхийг нь ямар ч гомдолгүйгээр баяртайгаар зөвшөөрнө гэдгээ Бурханд хэлсэн. Түүний зан авир бүхэлдээ түүний төгс, шулуун шударга хүн чанараас болсон байсан. Өөрөөр хэлбэл, өөрийн гэнэн цайлган сэтгэл, шударга зан болон сайн санааныхаа үрээр Иов, Бурханы оршин тогтнолын тухай ухаарал болон амссан туршлагадаа тээнэгэлзээгүй. Энэ үндсэн дээр өөртөө шаардлага тавьж, Бурханы өмнө өөрийн бодол, биеэ авч явах байдал, зан төлөв,

үйлдлийн зарчмыг өөрт нь өгсөн Бурханы удирдамжийн дагуу, мөн бүх зүйлийн дотроос олж харсан Бурханы үйл хэргийн дагуу жигдэлсэн. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр түүний туршлага нь Бурханаас эмээх үнэн, бодитой айдсыг түүнд бий болгож, түүнийг муугаас зайлахад нөлөөлсөн. Энэ бол Иовын хатуу баримталдаг зарчимч чанарын эх сурвалж байсан юм. Иов үнэнч шударга, гэнэн цайлган, сайхан хүн чанарыг эзэмшсэн байсан ба Бурханаас эмээх, Бурханы өмнө дуулгавартай байх, муугаас зайлах бодит туршлагатай, түүнчлэн “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа” гэдгийг мэдэж байсан. Зөвхөн эдгээр зүйлийн ачаар л тэр Сатаны тийм харгис балмад дайралтын үеэр гэрчлэлдээ бат зогсож чадсан бөгөөд Бурханы шалгалтууд ирэхэд Бурханы урмыг хугалахгүй байж, Бурханы сэтгэлд нийцэх хариулт өгч чадсан юм. Эхний уруу таталтын үед Иовын зан төлөв маш гүндүүгүй байсан хэдий боловч насан туршаа хичээж чармайгаад ч тийм гүндүүгүй болох найдвар хойчийн үр удамд байгаагүй, мөн дээр дүрсэлсэн Иовын зан төлөвийг эзэмшсэн байх нь зайлшгүй байсангүй. Өнөөдөр Иовын цэгц шулуун зан төлөвтэй тулгараад та нар, Бурханд итгэдэг, эсвэл Бурханыг дагадаг гэж хэлдэг хүмүүсийн Бурханд харуулсан “туйлын дуулгавартай, үхэн үхтэлээ үнэнч байна” гэсэн хашхираан, шийдмэг байдалтай үүнийг харьцуулан үзээд ихэд ичиж байна уу, эсвэл үгүй юу?

Иов болон түүний гэр бүлийн амссан зовлон бүхнийг Библиэс унших үед чамд ямар санагддаг вэ? Чи гүн бодолд дарагддаг уу? Чи гайхшаа бардаг уу? Иовд тохиолдсон шалгалтуудыг “аймшигтай” гэж дүрсэлж болох уу? Өөрөөр хэлбэл, Библид дүрсэлсэн Иовын шалгалтуудыг уншихад хангалттай аймаар бөгөөд бодит амьдрал дээр ямар байх байсныг хэлэхийн ч аргагүй билээ. Үүнээс харахад Иовд тохиолдсон болгон “дасгал сургуулилт” байгаагүй, харин жинхэнэ “буу”, “сум” ашигласан жинхэнэ “тулаан” байсан юм. Харин тэр хэний гараар энэхүү шалгалтад өртсөн бэ? Тэдгээр нь мэдээж Сатаны ажил байсан, Сатан эдгээр зүйлийг өөрийн гараар хийсэн. Гэвч эдгээр зүйлийг Бурхан зөвшөөрсөн байлаа. Ямар аргаар Иовыг уруу татахыг Бурхан Сатанд хэлсэн үү? Тэр хэлээгүй. Бурхан, Сатанд заавал дагах ёстой зүгээр л нэг болзол тавьсан бөгөөд үүний дараа Иовд сорилт ирсэн. Иовд сорилт ирэх үед Сатаны ёрын муу, муу муухай, хорон санааг болон хүнийг жигшин зэвүүцэж, Бурханд дайсагнадгийг нь хүмүүс мэдэрсэн. Энэхүү сорилт хэчнээн хэрцгий байсныг үгээр дүрслэхийн аргагүй гэдгийг үүнээс бид харж чадна. Хүнийг хүчирхийлдэг Сатаны хорлонтой уг чанар болон түүний муухай нүүр царай энэ мөчид илчлэгдсэн гэж хэлж болно. Иовд улайрсан, хайр найргүй хүчирхийлэл учруулахын тулд Сатан энэ боломжийг, Бурханы зөвшөөрлөөр өгөгдсөн боломжийг ашигласан бөгөөд түүний харгислалын арга барил болон түвшний аль аль нь өнөөгийн хүмүүсийн хувьд төсөөлөхийн аргагүй, огт тэсвэрлэшгүй юм. Сатан Иовыг сорьсон бөгөөд Иов энэхүү сорилтын үеэр өөрийн гэрчлэлд бат зогссон гэж хэлэхийн оронд өөрт нь зориулж Бурханы тогтоосон шалгалтаар Иов өөрийн төгс, шулуун шударга занг хамгаалж, Бурханаас эмээж,

муугаас зайлдаг замыг хамгаалахын тулд Сатантай хийх тэмцлийг эхлүүлсэн гэж хэлсэн нь дээр юм. Энэ тэмцэлд Иов асар их үнэтэй хонь, үхрээ алдаж, бүх эд хөрөнгөө алдсан бөгөөд хөвгүүд, охидоо алдсан. Гэхдээ л төгс, шулуун шударга зангаа, эсвэл Бурханаас эмээдгээ болиогүй. Өөрөөр хэлбэл, Сатантай хийсэн энэ тэмцэлд Иов өөрийн төгс байдал, шулуун шударга зан болон Бурханаас эмээх байдлыг алдсанаас эд хөрөнгө, үр хүүхдээсээ салсан нь дээр гэж үзсэн. Тэрээр хүн байхын үндсийг хадгалахыг илүүд үзсэн. Библид Иовын эд хөрөнгөө алдсан бүхий л үйл явцыг товч өгүүлдэг ба түүнчлэн Иовын ааш авир, хандлагыг тэмдэглэсэн. Эдгээр товч, тодорхой тэмдэглэл нь Иов энэ сорилттой нүүр тулахдаа бараг тайван байсан гэдэг санаа төрүүлдэг, гэхдээ Сатаны хорлонтой уг чанартай гэдгийг бас харгалзаж, яг юу болсныг дахин сэргээж үзэх юм бол, тэр зүйлс эдгээр өгүүлбэрт дүрсэлсэн шиг тийм ч энгийн, хялбар биш байх байв. Бодит байдал нь хамаагүй илүү хэрцгий байсан. Хүн төрөлхтөнд болон Бурханы сайшаасан бүх хүнд ханддаг Сатаны сүйрэл, үзэн ядалтын түвшин ийм байдаг ажээ. Хэрвээ Бурхан Иовыг бүү гэмтээ гэж Сатанаас шаардаагүй байсан бол Сатан түүнийг жишим ч үгүй хөнөөх байсан нь эргэлзээгүй. Сатан хэнийг ч Бурханд шүтэн мөргөөсэй гэдэггүй, мөн Бурханы нүдэнд зөв шударга хүмүүсийг болон төгс, шулуун шударга хүмүүсийг Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаг хэвээр байгаасай гэж ч хүсдэггүй. Яагаад гэвэл, хүмүүс Бурханаас эмээж муугаас зайлна гэдэг нь тэд Сатанаас зайлж, түүнийг хаяна гэсэн үг юм, иймээс Сатан өөрийн бүх уур хилэн, үзэн ядалтыг Иов дээр ямар ч өршөөлгүйгээр гаргахын тулд Бурханы зөвшөөрлийг ашиглажээ. Тэгэхээр Иов сэтгэл санаанаас махбод руу, гаднаас дотогш хүртэл асар их зовлон шаналал амссан байгаа биз дээ. Тэр үед энэ нь ямар байсныг өнөөдөр бид ойлгохгүй ба тухайн үед зовлон шаналалд өртөж байхдаа Иовын сэтгэлийн хөдөлгөөнийг Библийн тэмдэглэлүүдээс хальтхан л олж харж чадна.

Иовын гуйвшгүй зарчимч чанар Сатанд ичгүүр авчирсан ба түүнийг самгардан зугтахад хүргэсэн

Тэгвэл, Иовыг ийм зовлон шаналалд унасан үед Бурхан юу хийсэн бэ? Бурхан ажиглаж, харан үр дүнг нь хүлээсэн. Бурхан ажиглаж, харж байхдаа юу мэдэрсэн бол? Мэдээжээр, шаналж байсан. Гэхдээ тийн шаналлаа гээд Бурхан, Иовыг уруу татахыг Сатанд зөвшөөрсөндөө харамссан байж болох уу? Хариулт нь бол Үгүй, Тэр тэгж харамссан байж таарахгүй. Учир нь, Иов бол төгс, шулуун шударга агаад Бурханаас эмээж, муугаас зайлдаг гэдэгт Тэр бат итгэж байсан. Бурхан зүгээр л Иовын зөв шударга байдлыг Бурханы өмнө баталж, мөн өөрийн ёрын муу болон жигшүүрт байдлыг илчлэх боломжийг Сатанд өгсөн. Түүнээс гадна энэ нь Иовын хувьд энэ дэлхийн хүмүүс, Сатаны өмнө төдийгүй Бурханыг дагадаг бүх хүний өмнө ч өөрийн зөв шударга байдал болон Бурханаас эмээж, муугаас зайлдаг байдлыг гэрчлэх боломж байсан юм. Эцсийн үр дүн нь Иовын талаарх Бурханы үнэлгээ зөв бөгөөд алдаагүй байсныг баталсан уу? Иов Сатаныг үнэхээр ялан дийлсэн үү? Энд

бид Иовын хэлсэн үлгэр жишээ үг буюу тэр Сатаныг ялсан гэдгийн баталгаа болсон үгийг уншина. Тэр: “Би эхийнхээ хэвлийгээс нүцгэн ирсэн, тийшээ нүцгэн буцах болно” гэж хэлсэн. Энэ бол Иовын Бурханд дуулгавартай ханддаг хандлага юм. Дараа нь тэр: “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг” гэсэн. Иовын хэлсэн эдгээр үг нь Бурхан хүний зүрх сэтгэлийн гүнийг ажигладаг бөгөөд хүний санаа бодлыг харж чаддаг гэдгийг баталдаг, мөн тэдгээр нь Иовын талаарх Түүний үнэлгээ ямар ч алдаагүй байсан ба Бурханд сайшаагдсан энэ хүн зөв шударга байсан гэдгийг баталдаг. “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг.” Эдгээр үг нь Бурханыг гэрчилсэн Иовын гэрчлэл юм. Сатаныг сүрдүүлж, шившгийг нь тарьсан, тэрийг самгардан зугтахад хүргэсэн ба цаашлаад Сатаныг гинжилж, ямар ч арга чаргагүй болгож орхисон зүйл нь эдгээр энгийн үг байсан юм. Иймээс эдгээр үг нь мөн Ехова Бурханы үйл хэргийн гайхалтай байдал болон сүр хүчийг Сатанд мэдрүүлж, Бурханы замаар зүрх сэтгэлээ удирдуулсан хүний ер бусын чадварыг ойлгох боломжийг Сатанд олгосон. Цаашлаад тэдгээр нь, Бурханаас эмээж, муугаас зайлах замыг баримталж байгаа өчүүхэн жижиг хүний үзүүлсэн хүчирхэг амийн эрч хүчийг Сатанд харуулсан. Тийнхүү Сатан эхний тэмцэлд ялагджээ. Сатан “үүнээс сургамж авснаа” үл харгалзан Иовыг зүгээр орхих бодолгүй байсан ба түүний хорлонтой уг чанарт ямар ч өөрчлөлт гараагүй. Сатан, Иов руу үргэлжлүүлэн дайралт хийх гэж оролдсон тул дахин нэг удаа Бурханы өмнө ирсэн…

Дараа нь, Иов хоёр дахь удаагаа соригдсон талаар Библиэс уншицгаая.

3. Сатан Иовыг дахин нэг удаа сорьсон нь (Иовын бүх бие яр хатгинд баригдав)

а. Бурханы хэлсэн үгс

Иов 2:3 Ехова Сатанд хандан, “Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй. Түүнийг шалтгаангүйгээр устгахын тулд чи Намайг түүний эсрэг турхирсан ч тэр үнэнч шударга байдлаа гуйвалтгүй хадгалж байна” хэмээв.

Иов 2:6 Тэгээд Ехова Сатанд хандан, “Харагтун, тэр чиний гарт байна; харин түүний аминд л бүү хүр” гэв.

б. Сатаны хэлсэн үг

Иов 2:4–5 Мөн Сатан Еховад хариулж, “Арьсыг арьсаар, тийм ээ, хүн өөртөө байгаа бүхнийг амийнхаа төлөө өгөх л болно. Харин Чи одоо гараа сунгаад түүний яс, маханд нь хүр, тэр Чиний өөдөөс хараах болно” гэв.

в. Иов шалгалтад хэрхэн хандсан тухай

Иов 2:9–10 Тэгэхэд эхнэр нь түүнд, “Чи одоо ч гэсэн үнэнч шударга байдлаа хадгалж байна уу? Бурханыг хараа, тэгээд үх” гэв. Харин тэр түүнд “Чи мунхаг эм шиг ярьж байна.

Юу гэнэ ээ? Бид Бурханы гараас сайныг хүлээн аваад мууг хүлээн авахгүй юу?” гэв. Энэ бүгдэд Иов уруулаараа нүгэл үйлдсэнгүй.

Иов 3:3–4 Миний төрсөн тэр өдөр, мөн нэгэн хөвгүүн хэвлийд бүрэлдлээ гэсэн тэр шөнө ч сөнөг. Тэр өдөр харанхуйлаг, Дээр буй Бурхан түүнийг бүү хараг. Тэр өдөр гэрэл ч бүү гэрэлтэг.

Бурханы замыг хайрлах Иовын хайр бүхнийг ялан дийлсэн

Библид Бурхан болон Сатаны хоорондын дараах яриаг тэмдэглэжээ: “Ехова Сатанд хандан, ‘Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй. Түүнийг шалтгаангүйгээр устгахын тулд чи Намайг түүний эсрэг турхирсан ч тэр үнэнч шударга байдлаа гуйвалтгүй хадгалж байна’ хэмээв” (Иов 2:3). Энэхүү ярианд Бурхан Сатанд адилхан асуулт дахин тавьсан. Энэ нь, эхний шалгалтын үеэр Иовын илэрхийлж, амьдран харуулсан зүйлийн талаарх Ехова Бурханы нааштай үнэлгээг бидэнд үзүүлсэн асуулт бөгөөд Сатаны сорилтыг туулахаас өмнөх Иовын тухай Бурханы үнэлгээнээс огтхон ч өөр байгаагүй. Өөрөөр хэлбэл, түүнд сорилт ирэхээс өмнө Бурханы нүдэнд Иов бол төгс байсан, тиймээс Бурхан түүнийг болон түүний гэр бүлийг хамгаалж, түүнийг ерөөсөн; Бурханы нүдэнд бол тэр ерөөгдөхүйц үнэ цэнтэй байсан. Сорилтын дараа Иов эд хөрөнгө, үр хүүхдээ алдсанаас болж хэлээр нүгэл үйлдээгүй, харин Еховагийн нэрийг магтсаар байсан. Түүний жинхэнэ зан төлөвийг хараад Бурхан түүнийг магтсан ба тэр учраас түүнд онц дүн тавьсан юм. Учир нь, Иовын бодлоор бол түүний үр хүүхэд, эсвэл эд хөрөнгө нь түүнийг Бурханаас татгалзуулахад хангалтгүй байсан. Өөрөөр хэлбэл, түүний зүрх сэтгэл дэх Бурханы байрыг түүний хүүхдүүд эсвэл, ямар ч эд хөрөнгөөр орлуулж чадахгүй байв. Иовын эхний сорилтын үеэр Бурханыг хайрлах түүний хайр болон Бурханаас эмээж, муугаас зайлах замыг хайрлах хайр нь бүхнийг ялан дийлдэг гэдгийг тэр Бурханд харуулсан. Энэ шалгалт нь Ехова Бурханаас шагнал хүлээж авах болон эд хөрөнгө, үр хүүхдүүдээ Түүнд булаалгах тохиолдлыг Иовд амсуулсан төдий байв.

Иовын хувьд энэ нь түүний сүнсийг цэвэрлэж угаасан жинхэнэ туршлага болсон, энэ нь түүний амьдралыг бүрэн дүүрэн болгосон амийн баптисм байсан, түүнчлэн энэ нь түүний дуулгавартай байдал болоод Бурханаас эмээх байдлыг туршсан тансаг найр байсан юм. Энэ сорилт нь Иовын байр суурийг баян хүнээс юу ч үгүй нэгэн болгон хувиргасан ба энэ нь мөн хүн төрөлхтөнд чиглэсэн Сатаны хүчирхийллийг түүнд амсуулсан. Зовлон гачигдал нь түүнийг Сатаныг жигшихэд хүргээгүй; харин ч Сатаны зэвүүн үйлдлээс тэр Сатаны бузар муухайг болон жигшүүрт байдлыг, түүнчлэн Бурханд хандах Сатаны дайсагнал, эсэргүүцлийг харсан бөгөөд энэ нь Бурханаас эмээж, муугаас зайлах замыг мөнхөд тууштай баримтлахад түүнийг улам зоригжуулсан юм. Тэрээр эд хөрөнгө, хүүхдүүд, хамаатан садан зэрэг гадны хүчин зүйлсээс болж хэзээ ч Бурханыг хаяхгүй,

Бурханы замаас буруулахгүй, мөн хэзээ ч Сатан, эд хөрөнгө, ямар нэг хүний боол болохгүй; Ехова Бурханаас өөр хэн ч түүний Эзэн буюу түүний Бурхан байж чадахгүй гэж тангараглажээ. Иовын хүсэл эрмэлзэл ийм байсан юм. Нөгөө талаар, Иов бас энэ сорилтоос ямар нэг зүйлийг олж авсан: Бурханаас түүнд өгсөн шалгалтуудын дундаас тэр асар баялаг олж авсан юм.

Иов амьдралынхаа өнгөрсөн хэдэн арван жилийн турш Еховагийн үйл хэргийг харж, түүнд зориулсан Ехова Бурханы ерөөлийг олж авсан. Тэдгээр ерөөл нь түүнийг ихэд тавгүйтүүлж, өртэй гэж санагдуулдаг болсон, учир нь тэр Бурханы төлөө юу ч хийгээгүй мөртөө тийм агуу ерөөлийг хүртэж, маш их нигүүлслийг эдэллээ гэж итгэдэг байсан юм. Энэ шалтгаанаас болж, Бурханы ачийг хариулж чадна хэмээн найдаж, Бурханы үйл хэрэг, агуу байдлыг гэрчлэх боломжтой болно хэмээн найдаж, дуулгавартай байдал болон итгэл нь Бурханаар хүлээн зөвшөөрөгдөх хүртэл Бурхан түүний дуулгавартай байдлыг шалгах ба түүнээс гадна итгэл нь ариусна гэж найдан зүрх сэтгэлдээ үргэлж залбирдаг байв. Тэгээд Иов дээр шалгалт ирэхэд Бурхан түүний залбирлыг сонсжээ гэдэгт итгэсэн юм. Иов энэ боломжийг юм бүхнээс илүү нандигнан хайрласан ба тийнхүү насан туршийнх нь хамгийн агуу хүсэл биелж болох байсан учраас үүнд хуумгай хандаж зүрхлээгүй. Энэ боломж ирсэн нь түүний дуулгавартай байдал болон Бурханаас эмээх байдал туршигдаж, ариусгагдаж болзошгүй гэсэн үг байсан юм. Цаашлаад, Иов, Бурханы сайшаалыг хүртэх бололцоотой болсон, тийнхүү түүнийг Бурханд илүү ойр аваачна гэсэн үг байв. Ийм итгэл, эрэл хайгуул нь шалгалтын явцад улам төгс болж, Бурханы хүслийн талаар илүү их ойлгох боломжийг түүнд олгосон юм. Иов бас Бурханы ерөөл болон нигүүлсэлд улам их талархдаг болсон ба зүрх сэтгэлдээ Бурханы үйл хэргийг улам их магтаж, Бурханаас илүү их эмээж, Бурханыг улам хүндэтгэдэг болсон бөгөөд Бурханы хайр татам, агуу, ариун байдлыг илүү ихээр эгээрэн хүссэн. Энэ үед Иов хэдийгээр Бурханы бодлоор бол мөн л Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн байсан боловч мэдэрч туулсан зүйлийнх нь тухайд гэвэл, Иовын итгэл үнэмшил болон мэдлэг нь түргэн ахисан: Түүний итгэл үнэмшил ихэссэн, дуулгавартай байдал нь бат бөх болсон ба Бурханаас эмээх нь илүү гүнзгийрсэн. Хэдийгээр энэхүү шалгалт Иовын сүнс болон амийг өөрчилсөн боловч энэ өөрчлөлтөд Иов сэтгэл хангалуун байгаагүй, мөн энэ нь түүний ахиц дэвшлийг удаашруулаагүй. Энэ шалгалтаас юу олж авснаа тооцоолж, дутагдлаа эргэцүүлж бодонгоо тэрээр дараагийн шалгалт ирэхийг хүлээн чимээгүйхэн залбирсан, учир нь Бурханы дараагийн шалгалтын явцад итгэл, дуулгавартай байдал, Бурханаас эмээх байдал нь дээшлээсэй гэж хүсэн хүлээж байсан юм.

Бурхан хүний хэлж, хийж байгаа бүхнийг болон зүрх сэтгэлийн гүнд байгаа бодлуудыг нь ажигладаг. Иовын бодол Ехова Бурханы чихэнд хүрч, Бурхан залбирлыг нь сонссон, ийм байдлаар хүлээж байсных нь дагуу Бурханы дараагийн шалгалт Иовд ирсэн юм.

Хүн төрөлхтнийг гэх Бурханы анхаарал халамжийг Иов асар их зовлон дунд үнэхээр ойлгожээ

Ехова Бурханы Сатанд тавьсан асуултын дараа Сатан нууцхан баярласан. Яагаад гэвэл, Бурханы нүдэнд төгс байсан хүн рүү дайрахыг дахин нэг удаа зөвшөөрнө гэдгийг Сатан мэдэж байв—энэ нь Сатаны хувьд ховор боломж байлаа. Сатан энэ боломжийг ашиглан Иовын итгэл үнэмшлийг бүрмөсөн бусниулж, Бурханд итгэх итгэлийг нь алдуулж, тэгснээр Бурханаас эмээж, Еховагийн нэрийг магтдагийг нь болиулахыг хүссэн. Энэ нь Сатанд завшаан болох байв: ямар ч газар, ямар ч үед Сатан Иовыг захирч, тоглоом болгож чадах байлаа. Сатан хорон төлөвлөгөөгөө ор мөргүй нууж байсан боловч ёрын муу уг чанараа хянаж дийлээгүй. Энэ үнэн нь Ехова Бурханы үгэнд хариулсан хариултаас нь цухалздаг ба Библид бичсэнээр: “Мөн Сатан Еховад хариулж, ‘Арьсыг арьсаар, тийм ээ, хүн өөртөө байгаа бүхнийг амийнхаа төлөө өгөх л болно. Харин Чи одоо гараа сунгаад түүний яс, маханд нь хүр, тэр Чиний өөдөөс хараах болно’ гэв” (Иов 2:4–5). Бурхан, Сатан хоёрын энэ ярианаас Сатаны хорон муу санааны талаар мөн чанарт хамаарах мэдлэг болон санаа олж авахгүй байхын аргагүй юм. Сатаны эдгээр төөрөгдлийг сонсоод үнэнийг хайрлаж, мууг жигшдэг бүх хүн Сатаны жигшүүрт, ичгүүргүй байдлыг улам их үзэн ядах нь эргэлзээгүй бөгөөд Сатаны төөрөгдөлд хиртхийн зэвүүцэхийн зэрэгцээ энэхүү зөв шударга хүн төгс төгөлдөрт хүрээсэй хэмээн залбирч, Бурханаас эмээж, муугаас зайлдаг энэ хүн Сатаны сорилтыг мөнхөд даван гарч, гэрэлд амьдарч, Бурханы удирдамж, ерөөл дунд амьдраасай гэж хүсэн Иовын төлөө гүн гүнзгий залбирал, чин сэтгэлийн хүслээ өргөн барина; иймээс тэд бас Иовын шударга үйл хэрэг нь Бурханаас эмээж, муугаас зайлах замаар замнаж байгаа тэр бүх хүнийг мөнхөд зоригжуулж, урам хайрлаж чадаасай гэж хүсэх болно. Хэдийгээр Сатаны хорт санаархлыг энэ тунхаглалаас харж болох боловч Бурхан Сатаны “хүсэлтийг” амархан зөвшөөрсөн—гэхдээ Тэр бас “тэр чиний гарт байна; харин түүний аминд л бүү хүр” (Иов 2:6) гэдэг нэг болзол тавьсан. Учир нь, энэ удаа Сатан Иовын яс махыг гэмтээхийн тулд гараа урагш сунгая гэж гуйсан, Бурхан “харин түүний аминд л бүү хүр” гэж хэлсэн. Энэ үг нь Тэрээр Иовын махан биеийг Сатанд өгсөн боловч Иовын амь Бурханы мэдэлд үлдсэн ба Сатан Иовын амийг авч болохгүй, үүнээс бусдаар бол Иовын эсрэг ямар ч арга, хэрэгсэл ашиглаж болно гэсэн утгатай байлаа.

Бурханы зөвшөөрлийг авсныхаа дараа Сатан Иов руу яаран очиж, түүний арьсыг өвтгөхөөр гараа сунгаж, бүх биеэр нь яр хатги гаргасан ба Иов арьсан дээрх өвчнөө мэдэрсэн. Иов Ехова Бурханы гайхалтай, ариун байдлыг магтсан нь Сатаны балмад омгийг улам гааруулжээ. Хүнийг хорлохын баяр баяслыг мэдэрсэн учраас Сатан гараа сунгаж, Иовын бие махбодыг сийчин яр хатгийг нь идээлүүлжээ. Иов тэр даруй юутай ч зүйрлэшгүй их шаналал, тарчилгааг бие махбодоороо мэдэрсэн бөгөөд махбодын энэ өвчний улмаас сүнсэнд нь ирсэн

цохилтыг намжааж болох юм шиг л хамаг биеийн арьс махаа өөрийн эрхгүй нухалсан юм. Бурхан өөрийг нь хараад дэргэд нь байгаа гэдгийг тэр ухаарсан бөгөөд өөрийгөө хатуужуулах гэж чадлаараа хичээсэн. Тэрээр дахин нэг удаа газар сөхөрч, “Та хүний зүрх сэтгэл доторхыг хардаг, Та хүний гаслан зовлонг ажигладаг; хүний сул дорой байдал яагаад Таны санааг зовооно вэ? Ехова Бурханы нэр магтагдах болтугай” гэжээ. Сатан Иовын тэсэшгүй бэрх өвчин шаналлыг харсан боловч Еховагийн нэрийг орхиж байхыг нь харсангүй. Тиймээс тэр Иовыг мөч мөчөөр нь салгах гэж байж ядан ясыг нь өвтгөхөөр гараа яаран сунгажээ. Төдхөн Иов урьд өмнө үзээгүйгээр тарчилсан; түүний махыг яснаас нь тасар татан салгах мэт, ясыг нь хэсэг хэсгээр нь бяцалж байгаа мэт байжээ. Энэхүү шаналгаат тарчилгаанаас болж, ингэснээс үхсэн нь дээр гэж түүнд бодогдсон юм… Энэ өвчнийг тэсэх чадвар нь хязгаартаа хүрсэн… Тэр хашхирахыг хүссэн, өвдөлтөө намдаахын тулд биеийнхээ арьсыг урж тасдахыг хүссэн—гэхдээ Сатанд сул талаа харуулахыг хүсээгүй учраас орилохоо тэвчиж, биеийнхээ арьсыг урж тасдаагүй билээ. Ингээд Иов дахин нэг сөгдсөн боловч энэ удаад Ехова Бурханы байгааг мэдрээгүй. Ехова Бурхан үргэлж түүний өмнө, түүний ард юм уу, аль нэг талд нь байдгийг тэр мэддэг байв. Гэсэн ч түүнийг өвдөж шаналах үед Бурхан нэг ч удаа хараагүй; Бурхан нүүрээ дараад нуугдаж байсан, учир нь, хүнд зовлон шаналал авчрах нь хүнийг бүтээснийх нь утга учир биш байсан билээ. Энэ удаа Иов мэгшин уйлж, энэхүү бие махбодын тарчилгааг тэвчихийн тулд чадах бүхнээ хийж байхдаа ч гэсэн Бурханд талархахгүй байж чадаагүй: “Хүн анхны цохилтод л унана, тэр сул дорой агаад хүч чадалгүй, балчир агаад мунхаг—яагаад Та түүнд тийм их халамжтай, эелдэг зөөлөн хандахыг хүсдэг юм бэ? Та намайг цохидог, гэхдээ ингэх нь Таныг ч бас өвтгөдөг. Хүний юу нь Таны халамж, анхаарлыг хүртэхүйц юм бэ?” Иовын залбирал Бурханы чихэнд хүрсэн бөгөөд Бурхан дуугүйхэн, ямар ч чимээ гаргалгүй харж л байв… Сатан есөн шидийн аргаар үзээд бүтэлгүйтээд чимээгүйхэн явж одсон, гэвч Иовыг шалгах Бурханы шалгалт үүгээр төгсөөгүй. Учир нь Иовд илчлэгдсэн Бурханы хүч чадал олон нийтэд ил болоогүй, Иовын түүх Сатаны ухралтаар дуусаагүй. Бусад дүр орж ирснээр илүү сонирхол татам үйл явдлууд тохиолдох гэж байсан.

Иов Бурханаас эмээж, муугаас зайлдаг байсны бас нэг илрэл нь тэрээр бүх зүйл дээр Бурханы нэрийг дээдлэн магтаж байсан

Иов Сатаны хөнөөл сүйтгэлд зовсон атлаа Ехова Бурханы нэрийг орхиогүй л байсан. Түүний эхнэр анх эхэлж, хүний нүдэнд харагдах дүрээр Сатаны үүргийг гүйцэтгэн Иов руу дайрч давшилсан. Эх бичвэрт үүнийг ингэж дүрсэлсэн байна: “Тэгэхэд эхнэр нь түүнд, ‘Чи одоо ч гэсэн үнэнч шударга байдлаа хадгалж байна уу? Бурханыг хараа, тэгээд үх’ гэв” (Иов 2:9). Эдгээр нь хүний дүрээр хэлсэн Сатаны үг байсан юм. Тэдгээр нь дайралт, буруушаалт, түүнчлэн уруу таталт, сорилт, гүтгэлэг байлаа. Сатан Иовын бие махбод руу дайрч бүтэлгүйтчихээд Иовын

зарчимч чанар руу шууд дайрсан ба үүнийг ашиглан Иовын зарчимч чанарыг хаяулж, Бурханаас татгалзуулж, цаашид амьдрахыг нь болиулах гэж хүсэж байв. Иймээс ч Сатан Иовыг уруу татахын тулд ийм үгсийг ашиглахыг хүсжээ: Хэрвээ Иов Еховагийн нэрийг орхивол энэ бүх зовлон шаналлыг туулах хэрэггүй; тэр өөрийгөө махан биеийн өвчин шаналлаас чөлөөлж чадах юм. Эхнэрийнхээ зөвлөгөөтэй тулгараад Иов: “Чи мунхаг эм шиг ярьж байна. Юу гэнэ ээ? Бид Бурханы гараас сайныг хүлээн аваад мууг хүлээн авахгүй юу?” (Иов 2:10) гэж түүнийг загнасан. Иов эдгээр үгийг эртнээс мэддэг байсан боловч энэ удаад тэдгээрийн талаарх Иовын үнэнхүү мэдлэг батлагджээ.

Эхнэр нь түүнд Бурханыг хараа, тэгээд үх гэж зөвлөсөн нь дараах утгатай байлаа: “Чиний Бурхан чамтай ингэж харьцаж байхад чи яагаад Түүнийг хараахгүй байгаа юм бэ? Одоо хүртэл юугаа хийж амьдарч байгаа юм бэ? Бурхан чинь чамд тийм шударга бус байхад чи одоо ч ‘Еховагийн нэр алдаршиг’ гэж хэлсээр л байна. Чи Түүний нэрийг алдаршуулж байхад Тэр чамд яаж гай гамшиг авчирч чадаж байна вэ? Хурдал, Бурханы нэрийг хая, тэгээд Түүнийг цаашид бүү дага. Тэгээд чиний бэрхшээл эцэс болно.” Энэ мөчид Бурхан, Иовоос харахыг хүссэн гэрчлэл бий болсон. Ямар ч энгийн хүн тийм гэрчлэл хийж чадаагүй бөгөөд бид ч бас үүнийг Библийн ямар ч түүхээс уншихгүй—гэхдээ Иов эдгээр үгийг хэлэхээс ч өмнө Бурхан үүнийг аль хэдийнээ харчихсан байсан. Бурханы зөв гэдгийг бүгдэд батлахыг Иовд зөвшөөрөх гэж л Бурхан энэ боломжийг ашиглахыг хүссэн юм. Эхнэрийнхээ зөвлөгөөтэй нүүр тулаад Иов өөрийн зарчимч чанарыг орхиж, Бурханаас татгалзаагүйгээр үл барам эхнэртээ бас ингэж хэлсэн: “Бид Бурханы гараас сайныг хүлээн аваад мууг хүлээн авахгүй юу?” Эдгээр үг ихээхэн жинтэй юу? Энд эдгээр үгийн жинг баталж чадах ганцхан баримт байна. Эдгээр үгийн жин гэвэл, тэдгээрийг Бурхан зүрх сэтгэлдээ хүлээн зөвшөөрсөн ба тэдгээр нь Бурханы хүсэмжилсэн зүйл, Бурханы сонсохыг хүссэн зүйл, харахыг эгээрэн хүссэн үр дүн юм; эдгээр үг нь бас Иовын гэрчлэлийн охь манлай билээ. Үүгээр Иовын төгс, зөв шударга байдал, мөн Бурханаас эмээж, муугаас зайлдаг байдал бүгд нотлогдсон. Тэр соригдож байх үедээ, бүр бүх бие нь яр хатгинд баригдсан байхдаа хүртэл, дээд зэргийн тарчилгаа амсаж байхдаа, эхнэр болон хамаатнууд нь түүнд зөвлөж байх үед ч бас л ийм үгийг хэлж байсанд Иовын эрхэм нандин чанар оршино. Өөрөөр хэлбэл, ямар ч сорилт байсан, зовлон зүдүүр, тарчлаан хэчнээн хүнд бэрх байсан ч, үхэл хүртэл ирэх байсан ч хамаагүй, тэрээр Бурханаас татгалзах юм уу, Бурханаас эмээж, муугаас зайлах замаас няцахгүй гэдэгтээ зүрх сэтгэлдээ итгэж байсан. Тэгэхээр Бурхан түүний зүрх сэтгэлд хамгийн чухал байр суурь эзэлж байсан ба зүрх сэтгэлд нь зөвхөн Бурхан л байсныг харж болно. Ийм учраас бид Библид түүний тухай ийн дүрсэлснийг уншдаг: Энэ бүгдэд Иов уруулаараа нүгэл үйлдсэнгүй. Тэр хэлээр нүгэл үйлдээгүйгээр үл барам зүрх сэтгэлдээ ч Бурханы талаар гомдоллоогүй. Тэр Бурханы зүрх сэтгэлийг шархлуулсан үг хэлээгүй, Бурханыг гомдоосон зүйл ч хийгээгүй. Тэр амаараа Бурханы нэрийг алдаршуулсан

төдийгүй, зүрх сэтгэлдээ ч Бурханы нэрийг алдаршуулсан; түүний ам, зүрх сэтгэл нэг байв. Энэ бол Бурханы харсан жинхэнэ Иов байсан бөгөөд Бурхан, Иовыг эрхэмлэн хайрласан чухамхүү шалтгаан энэ байсан юм.

Иовын талаарх олон буруу ойлголт

Иовын туулсан зовлон зүдгүүр нь Бурханы илгээсэн элчүүдийн ажил байгаагүй, мөн Бурханы гараар ч хийгдээгүй. Харин үүнийг Бурханы дайсан Сатан биечлэн учруулсан юм. Үүний уршгаар Иовын туулсан зовлон зүдгүүрийн хэмжээ маш ноцтой байв. Гэсэн ч энэ мөчид Иов зүрх сэтгэлд нь байсан Бурханы талаарх өдөр тутмын мэдлэг, өдөр тутмынхаа үйлдлийн зарчим болон Бурханд хандах хандлагаа бүгдийг үлдээлгүй илэрхийлсэн—энэ нь үнэн юм. Хэрвээ Иовыг сориогүй бол, хэрвээ Бурхан Иов дээр шалгалт буулгаагүй бол Иовыг “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг” гэж хэлэхэд нь чи Иовыг хоёр нүүртэн гэж хэлэх байсан; Бурхан түүнд маш их эд хөрөнгө өгсөн, иймээс тэр Еховагийн нэрийг мэдээжээр алдаршуулж байсан. Хэрвээ шалгалтад өртөхөөсөө өмнө Иов, “Бид Бурханы гараас сайныг хүлээн авааД мууг хүлээн авахгүй юу?” гэж хэлсэн бол чи, Иов хэтрүүлж байгаа ба тэр Бурханы гараар байнга ерөөгддөг тул Бурханы нэрийг орхихгүй гэх байсан. Хэрвээ Бурхан түүнд гай гамшиг авчирсан бол тэр Бурханы нэрийг лав орхих байсан гэж чи хэлэх байсан. Харин өөрт нь тохиолдох вий гэдгээс хүмүүсийн айдаг, хэний ч хүсэхгүй, эсвэл харахыг ч хүсэхгүй, хэн ч өөрт нь тохиолдоосой гэж хүсэхгүй тийм нөхцөл байдалд, бүр Бурхан ч харж тэвчихгүй нөхцөл байдалд орохдоо Иов: “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг”, мөн “Бид Бурханы гараас сайныг хүлээн авааД мууг хүлээн авахгүй юу?” хэмээх зарчимч чанараа хадгалсаар байж чадсан. Тухайн үед Иовын гаргасанзан төлөвтөй тулгараад сүржин үг ярих дуртай хүмүүс болон чамирхаж, номчирхох дуртай хүмүүс хэлэх үггүй болдог. Бурханы нэрийг үг яриагаараа л магтдаг боловч Бурханы шалгалтуудыг хэзээ ч хүлээн зөвшөөрөөгүй хүмүүс нь Иовын хатуу баримталж байсан зарчимч чанараар яллагдаж, хүн Бурханы замыг хатуу баримталж чадна гэж хэзээ ч итгэж байгаагүй хүмүүс Иовын гэрчлэлээр шүүгддэг. Эдгээр шалгалтын үеийн Иовын зан төлөв болон хэлсэн үгтэй нь тулгараад зарим хүн будилна, зарим нь атаархана, зарим нь эргэлзэнэ, мөн зарим нь Иовын гэрчлэлийг үл тоомсорлон бүр сонирхсон ч шинжгүй харагдана, яагаад гэвэл, тэд шалгалтуудын үеэр Иовд тохиолдсон зовлон шаналлыг харж, Иовын хэлсэн үгийг уншдаг төдийгүй шалгалт ирэхэд Иовын өөрийн эрхгүй харуулсан хүний “сул талыг” мөн хардаг. Энэ “сул тал” нь Иовын төгс байдлын өө сэв, Бурханы нүдэнд төгс харагддаг хүний дутагдал юм гэж тэд итгэдэг. Өөрөөр хэлбэл, төгс хүмүүс нь өө сэвгүй, ямар ч хир толбогүй, ямар ч дутагдалгүй, ямар ч өвдөлтийг мэддэггүй, хэзээ ч гуниглаж, гутардаггүй бөгөөд үзэн яддаггүй, гаднаа ямар ч хурц ааш авир гаргадаггүй гэж итгэцгээдэг; үүний үр дүнд хүмүүсийн асар олонх нь Иовыг үнэхээр төгс байсан гэдэгт итгэдэггүй. Шалгалтын үеэр

гаргасан түүний ааш авирын ихэнхийг хүмүүс зөвтгөдөггүй. Жишээлбэл, Иов эд хөрөнгө, үр хүүхдээ алдах үедээ хүмүүсийн төсөөлж байсан шигээр уйлж унжаагүй юм. “Жудаг муутай байдал” нь түүнийг хүйтэн хөндий гэж хүмүүст бодогдуулсан, учир нь түүнд ямар ч нулимс, гэр бүлээ гэсэн хайр байгаагүй. Энэ нь Иовын бусдад төрүүлсэн эхний муу сэтгэгдэл юм. Үүний дараа гаргасан ааш авир тэдэнд бүр ч илүү адармаатай санагддаг: “Нөмрөгөө урж” гэдгийг хүмүүс Бурханыг үл хүндэлсэн гэж тайлбарладаг бөгөөд “толгойн үсээ хусаж” гэдэг нь Иов Бурханыг доромжилж, эсэргүүцсэн гэсэн үг хэмээн эндүүрдэг. “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг” хэмээх Иовын үгээс гадна, Бурханы магтсан Иовын зөв шударга байдлын алийг нь ч хүмүүс олж хардаггүй ба тиймээс Иовын талаарх тэдний ихэнхийн үнэлгээ нь үл ойлгосон, эндүүрсэн, эргэлзсэн, буруушаасан болон зөвхөн онолоор хүлээн зөвшөөрөхөөс цаашгүй байдаг. Иов бол төгс, шулуун шударга хүн агаад Бурханаас эмээж, муугаас зайлсан нэгэн гэсэн Ехова Бурханы үгийг тэдний хэн нь ч үнэхээр ойлгож, үнэлж чаддаггүй.

Иовын талаарх өөрсдийн сэтгэгдэл дээр тулгуурлан хүмүүс түүний зөв шударга байдлын талаар улам их эргэлзэх болсон, учир нь Библид тэмдэглэгдсэн Иовын үйлдэл болон зан авир нь хүмүүсийн төсөөлдөг шиг гойд сэтгэл хөдөлгөм байгаагүй. Тэр ямар ч агуу гавьяа байгуулаагүйгээр үл барам бас үнс нурман дунд сууж байхдаа өөрийгөө маажих гэж ваарны хэлтэрхий авсан. Энэ үйлдэл нь мөн хүмүүсийг гайхашруулж, тэднийг Иовын зөвт байдалд эргэлзэхэд—бүр үгүйсгэхэд—хүргэдэг, учир нь өөрийгөө маажиж байх зуураа Иов Бурханд залбираагүй, эсвэл амлалт өгөөгүй; цаашлаад тэр шаналлын нулимс ч урсгаж харагдаагүй. Энэ үед хүмүүс Иовын зөвхөн сул талаас өөр юу ч хардаггүй тул Иовын “Бид Бурханы гараас сайныг хүлээн авааД мууг хүлээн авахгүй юу?” гэж хэлэхийг сонссон ч гэсэн тэдний сэтгэл огт хөдлөхгүй, эргэлзсээр байдаг бөгөөд түүний үгээс Иовын зөв шударга байдлыг олж харж мөн л чаддаггүй. Сорилтынхоо зовлон шаналлын үеэр Иов айж хавчганасан ч биш, биеэ тоосон ч биш байсан гэдэг нь хүмүүст төрүүлсэн үндсэн сэтгэгдэл юм. Түүний ааш авирын цаана зүрх сэтгэлийнх нь гүнд явагдсан түүхийг хүмүүс хардаггүй, мөн түүний зүрх сэтгэл дэх Бурханаас эмээх байдлыг, эсвэл муугаас зайлах замын зарчмыг баримталж байгааг нь ч хардаггүй. Түүний уужуу тайван байдлаас болж хүмүүс түүний төгс, шулуун шударга байдал бол хоосон үг, Бурханаас эмээдэг нь ердөө л цуу яриа юм байна гэж боддог; нөгөө талаар, түүний гаднаа илчлэн харуулсан “сул тал” нь Бурханы төгс ба шулуун шударга гэж тодорхойлдог тэр хүнд хандах “шинэ өнцөг”, бүр “шинэ ойлголтыг” тэдэнд өгч, гүн гүнзгий сэтгэгдэл үлдээдэг. Иов ам нээж, өөрийнхөө төрсөн өдрийг хараахад тэрхүү “шинэ өнцөг” болон “шинэ ойлголт” батлагддаг байна.

Хэдийгээр туулсан зовлон шаналлынх нь хэмжээ ямар ч хүн төсөөлшгүй, ойлгошгүй байсан ч гэсэн Иов ямар ч тэрслүү үг хэлээгүй, харин өөрийнхөө аргаар биеийнхээ өвдөлтийг л багасгасан юм. Библид тэмдэглэснээр тэр ингэж хэлсэн:

“Миний төрсөн тэр өдөр, мөн нэгэн хөвгүүн хэвлийд бүрэлдлээ гэсэн тэр шөнө ч сөнөг” (Иов 3:3). Ер нь хэн ч эдгээр үгийг чухал гэж үзээгүй байх, тэдгээр үгэнд анхаарал хандуулсан хүмүүс ч байдаг л байх. Та нарын бодлоор, тэдгээр нь Иов Бурханыг эсэргүүцсэн гэсэн утгатай юу? Тэдгээр нь Бурханы эсрэг гомдол уу? Та нараас олон хүн Иовын хэлсэн эдгээр үгийн талаар зарим нэгэн бодол санаатай байгаа бөгөөд хэрвээ Иов төгс, шулуун шударга байсан юм бол ямар нэгэн сул тал, эсвэл уй гашуу харуулах ёсгүй байсан ба харин ч Сатанаас ирсэн аливаа дайралттай эерэгээр нүүр тулж, бүр Сатаны сорилтыг инээмсэглэн угтах учиртай байсан гэж итгэдэг гэдгийг Би мэднэ. Түүний биед Сатаны учруулсан ямар ч тарчилгаанд өчүүхэн төдий ч хариу үйлдэл үзүүлэх ёсгүй байсан, мөн зүрх сэтгэлийнхээ доторх аливаа мэдрэмжийг харуулах ч ёсгүй байсан. Тэр ч бүү хэл, энэ шалгалтуудыг бүр илүү хатуу ширүүн болгооч гэж Бурханаас хүсэх байсан юм. Энэ бол Бурханаас үнэхээр эмээж, муугаас зайлдаг, тууштай хүний харуулах, эзэмшвэл зохих зүйл. Энэ асар их зовлонгийн дунд Иов өөрийн төрсөн өдрийг л хараасан. Тэр Бурханы талаар гомдоллоогүй, тэр ч бүү хэл Бурханыг эсэргүүцэх өчүүхэн ч бодол түүнд байгаагүй юм. Үүнийг хэлэхэд амархан, хийхэд хэцүү, учир нь эрт үеэс өнөөг хүртэл хэн ч, хэзээ ч тийм сорилтыг амсаагүй, эсвэл Иовд тохиолдсон зовлонг туулаагүй. Тэгвэл яагаад хэн ч Иовынхтай адил төрлийн сорилтод ер өртөөгүй юм бэ? Яагаад гэвэл, Бурханы үздэгээр, хэн ч тийм хариуцлага, эсвэл даалгавар үүрч чадахгүй, хэн ч Иов шиг байж чадахгүй, цаашлаад тийм их зовлон шаналал тохиолдох үед Иов шиг тэгж өөрийн төрсөн өдрийг хараахаас гадна Бурханы нэрийг орхилгүй Ехова Бурханы нэрийг үргэлжлүүлэн алдаршуулсаар байж хэн ч чадахгүй. Өөр хүн ингэж чадах уу? Бид Иовын талаар ингэж ярихдаа түүний ааш авирыг сайшаан магтаж байна уу? Тэр бол зөв шударга ба Бурханыг гэрчилж чадах хүн байсан бөгөөд Сатаныг гараараа толгойгоо бариад зугтахад хүргэх чадвартай байсан, ингэснээр Сатан түүнийг буруушаах гэж Бурханы өмнө дахиж очоогүй—иймд түүнийг сайшаан магтахад юу нь буруудаад байна? Та нар Бурханаас илүү өндөр стандарттай байдаг болохоор уу? Та нар дээр шалгалт ирэх үед Иовоос хамаагүй илүү байх байсан болохоор уу? Иовыг Бурхан магтсан—та нарт юу байж болох вэ?

Өөрөөсөө болж Бурханыг шаналгахыг хүсээгүй учраас Иов төрсөн өдрөө хараав

Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлийн доторхыг хардаг байхад хүмүүс хүний гадна талыг хардаг гэж Би үргэлж хэлдэг. Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлийн доторхыг хардаг учраас мөн чанарыг нь ойлгодог, харин тэгэхэд хүмүүс бусдын гадна талд үндэслэн мөн чанарыг нь тодорхойлдог. Иов ам нээж, өөрийн төрсөн өдрийг хараах үед энэ үйлдэл нь Иовын гурван найзыг оролцуулаад бүх сүнслэг хүнийг гайхшируулсан. Хүн Бурханаас ирсэн бөгөөд Бурханаас хайрласан амь нас болон бие махбоддоо, түүнчлэн өөрийн төрсөн өдөрт талархвал зохих ба тэдгээрийг

хараах ёсгүй. Энэ нь жирийн хүмүүсийн ойлгож, ухамсарлаж чадах зүйл юм. Бурханыг дагаж буй хэний ч хувьд энэ ойлголт нь ариун бөгөөд халдашгүй, хэзээ ч өөрчлөгдөхгүй үнэн юм. Харин Иов дүрэм зөрчсөн: Тэр төрсөн өдрөө хараасан. Энэ нь хориотой бүсэд нэвтэрсэн гэж жирийн хүмүүсийн үздэг үйлдэл юм. Иов хүмүүсээр ойлгуулж, өрөвдүүлэх ч эрхгүйгээр үл барам Бурханы уучлалыг ч хүртэх эрхгүй. Үүний зэрэгцээ улам олон хүн Иовын зөв шударга байдалд эргэлзэх болдог, учир нь Бурхан ивээсэн нь Иовыг өөгшүүлсэн юм шиг байв; түүнийг цадиггүй, хэнэггүй болгож, өөрийг нь ерөөж, насан туршид нь халамжилсных нь төлөө Бурханд талархаагүй тодийгүй өөрийн төрсөн өдрийг сүйрэг гэж зүхсэн байдаг. Бурханыг эсэргүүцсэн явдал биш юм бол энэ юу юм бэ? Тийм өнгөц байдал нь хүмүүсийг Иовын үйлдлийг буруушаах нотолгоогоор хангадаг, гэхдээ тухайн үед Иов үнэхээр юу бодож байсныг хэн мэдэх юм бэ? Иов яагаад ингэсний шалтгааныг хэн мэдэх юм бэ? Зөвхөн Бурхан болон Иов өөрөө л дотоод түүх, учир шалтгааныг нь мэддэг.

Сатан Иовын ясыг өвтгөхөөр гараа сунгахад Иов зугтах аргагүйгээр, эсвэл эсэргүүцэх чадалгүйгээр түүний саварт оржээ. Түүний бие, сэтгэл асар их өвдөж шаналсан ба энэ өвдөлт нь махан биед амьдардаг хүний өчүүхэн, эмзэг, хүч чадалгүй байдлыг түүнд гүн гүнзгий мэдүүлсэн. Үүний зэрэгцээ, тэр бас Бурхан яагаад хүн төрөлхтнийг анхаарч, халамжилдагийг ул үндэстэй ойлгож, үнэлэх болсон юм. Сатаны саварт байхдаа Иов мах, цуснаас бүрдсэн хүн бол үнэндээ огт хүч чадалгүй, сул дорой байдгийг ухаарсан. Түүнийг өвдөг сөхрөн унаж, Бурханд залбирах үед Бурхан нүүрээ халхалж, нуугдаж байгаа мэт түүнд санагдсан, учир нь Бурхан түүнийг Сатаны гарт бүрэн өгсөн билээ. Тэгэхийн зэрэгцээ Бурхан бас түүний төлөө уйлж, түүнчлэн түүний төлөө зовж шаналж байсан; Бурхан түүнийг өвдөхөд нь өвдөж, шаналахад нь шаналж байв… Бурханы өвдөхийг, түүнчлэн энэ нь Бурханд хэчнээн тэвчихийн аргагүй байсныг Иов мэдэрч байсан юм… Иов, Бурханд илүү их уй гашуу авчрахыг хүсээгүй, өөрийнхөө төлөө Бурханыг уйлуулахыг ч хүсээгүй, түүгээр ч зогсохгүй өөрөөс нь болж Бурханы зовж шаналахыг харахыг хүсээгүй билээ. Энэ мөчид Иов бие махбодынхоо өвчнийг цаашдаа амсахгүйн тулд зөвхөн өөрийн махан биеийг л хаяхыг хүсэж байсан, учир нь ингэж л тэрээр өөрийнх нь өвдөлтөөс болж Бурханы шаналж байгааг болиулах байсан—гэсэн ч тэр тэгж чадаагүй бөгөөд зөвхөн бие махбодын өвдөлтийг тодийгүй мөн Бурханы санааг зовоохгүйг хүссэн шаналлыг бас туулах хэрэгтэй болсон. Энэ хоёр—нэг нь бие махбодын, нөгөө нь сүнсний—өвдөлт нь Иовд зүрх зүсэм, дотор бачуурам өвдөлтийг авчирсан ба мах цуснаас бүтсэн хүний хязгаарлагдмал байдал хүнд арга мөхөс, арчаагүй санагдуулдгийг түүнд мэдрүүлсэн юм. Эдгээр нөхцөл байдалд Бурханыг эгээрэн хүсэх түүний тэмүүлэл улам ирмүүн болж, Сатаныг жигших нь улам их болсон. Энэ үед Иов, өөрийнх нь төлөө Бурханы уйлж, шаналж байгааг харсны оронд хүний ертөнцөд хэзээ ч төрөөгүй байсан нь дээр байж, байгаагүй байсан нь дээр байж гэж үзэх байсан юм. Тэр өөрийн бие

махбодыг гүнээ жигшиж, өөрөөсөө, өөрийнхөө төрсөн өдрөөс, бүр өөртэйгээ холбоотой юм бүхнээс залхаж, дургүйцэж эхэлсэн. Тэр өөрийнхөө төрсөн өдрийг, эсвэл үүнтэй холбоотой бүхнийг цаашид дурдахыг хүсээгүй, иймээс ам нээж, “Миний төрсөн тэр өдөр, мөн нэгэн хөвгүүн хэвлийд бүрэлдлээ гэсэн тэр шөнө ч сөнөг. Тэр өдөр харанхуйлаг, Дээр буй Бурхан түүнийг бүү хараг. Тэр өдөр гэрэл ч бүү гэрэлтэг” (Иов 3:3–4) хэмээн төрсөн өдрөө хараажээ. “Миний төрсөн тэр өдөр, мөн нэгэн хөвгүүн хэвлийд бүрэлдлээ гэсэн тэр шөнө ч сөнөг” гэсэн Иовын үгс өөрийгөө жигшиж байгааг нь, түүнчлэн “Тэр өдөр харанхуйлаг, Дээр буй Бурхан түүнийг бүү хараг. Тэр өдөр гэрэл ч бүү гэрэлтэг” гэсэн нь Бурханд шаналал учруулсанд гэж өөрийгөө буруутгасныг, мөн өртэй болсноо ухаарсныг нь харуулдаг. Энэ хоёр хэсэг нь Иовд тэр үед ямар санагдаж байсны бүрэн илэрхийлэл бөгөөд түүний төгс, шулуун шударга байдлыг бүгдэд бүрэн дүүрэн харуулдаг. Үүний зэрэгцээ, Иовын хүсэж байсанчлан түүний Бурханд итгэх итгэл, дуулгавартай байдал, түүнчлэн Бурханаас эмээх нь үнэхээр дээшилсэн. Мэдээжээр, энэхүү дээшлэлт нь Бурханы хүлээж байсан яг тэр үр нөлөө юм.

Иов Сатаныг ялж, Бурханы нүдэнд жинхэнэ хүн болсон

Иов эхний шалгалтыг амсах үедээ бүх эд хөрөнгө, үр хүүхдээ алдсан боловч үүний дүнд тэр балраагүй, эсвэл Бурханы эсрэг гомдоллосон ямар нэг зүйлийг хэлээгүй. Тэр Сатаны уруу таталтыг давж гарсан, өөрийн эд агуурс, үр хүүхдийг давж, өөртөө байгаа бүх өмч хөрөнгийг алдах шалгалтыг давж гарсан, өөрөөр хэлбэл, Бурхан юмсыг нь буцаан авахад тэр дуулгавартай байж чадсан ба Бурханы хийсэн зүйлээс болж Бурханд талархал, магтаал өргөж чадсан. Сатаны эхний сорилтын үеэр Иовын зан төлөв ийм байсан, мөн Бурханы эхний шалгалтын үед Иовын гэрчлэл ийм байсан юм. Хоёр дахь шалгалтаар Сатан Иовыг зовоохын тулд гараа сунгаж, Иов урьд өмнө үзээгүй айхтар их өвдөлтийг мэдэрсэн боловч түүний гэрчлэл нь хүмүүсийг гайхшируулж орхиход хангалттай байв. Тэр Сатаныг дахин нэг ялахын тулд сэтгэлийн тэнхээ, итгэл үнэмшил, Бурханд дуулгавартай байдал, Бурханаас эмээх байдлаа ашигласан бөгөөд түүний зан төлөв болон гэрчлэлийг Бурхан бас дахин сайшааж, ивээсэн юм. Энэ сорилтын үеэр Иов, бие махбодын өвдөлт нь Бурханд итгэх итгэл болоод дуулгавартай байдлыг нь өөрчилж чадахгүй, мөн Бурханд үнэнч зүтгэдгийг нь болон Бурханаас эмээдгийг нь үгүй болгож чадахгүй гэдгийг Сатанд харуулахын тулд бодит зан төлөвөө ашигласан; тэрээр үхэлтэй нүүр тулснаас болоод Бурханаас татгалзахгүй, өөрийн төгс, шулуун шударга байдлыг хаяхгүй байх байсан. Иовын шийдэмгий байдал нь Сатаныг хулчийлгаж, итгэл нь Сатаныг түгшээж, бэмбэгнүүр болгосон, үхэл, амьдралын тулааны үеэр Сатаны эсрэг тулалдсан хэр чинээ нь Сатанд гүн гүнзгий үзэн ядалт, хорсол төрүүлж, түүний төгс, шулуун шударга байдал Сатаныг өөр юу ч хийж чадахгүй болгосон болохоор Сатан түүний эсрэг дайралтуудаа орхисон бөгөөд Ехова Бурханы өмнө Иовыг буруушааж байснаа больсон. Энэ нь, Иов дэлхийг ялан

дийлсэн, махан биеийг ялан дийлсэн, Сатаныг ялан дийлсэн, үхлийг ялан дийлсэн гэсэн үг юм; тэр бол Бурханд бүрэн дүүрэн, үнэхээр харьяалагддаг хүн байлаа. Энэ хоёр шалгалтын үеэр Иов гэрчлэлдээ бат зогсож, төгс, шулуун шударга байдлаа амьдран харуулж, Бурханаас эмээж, муугаас зайлдаг амьдралын зарчмынхаа цар хүрээг өргөжүүлжээ. Энэ хоёр шалгалтыг туулснаар Иовд илүү баялаг туршлага хуримтлагдаж, энэхүү туршлага нь түүнийг улам боловсорсон, хашир хүн болгосон, мөн илүү хүчтэй, илүү агуу итгэл үнэмшилтэй болгосон ба энэ нь түүнийг хатуу баримталдаг шулуун шударга байдлынхаа үнэн зөв, үнэ цэнтэй байдалд улам илүү итгэдэг болгосон юм. Ехова Бурхан Иовыг шалгасан нь хүнийг гэх Бурханы анхаарал халамжийн талаар гүн ойлголт, мэдрэмжийг түүнд өгсөн ба Бурханы хайрын үнэ цэнтэй байдлыг мэдрэх боломжийг олгосон, энэ үеэс эхлээд Бурханаас эмээдэг байдалд нь Бурханыг анхаарах, хайрлах нэмэгдсэн. Ехова Бурханы шалгалтууд нь Иовыг Түүнээс холдуулаагүйгээр үл барам, харин түүний зүрх сэтгэлийг Бурханд илүү ойртуулсан. Иовын амссан махан биеийн өвдөлт нь дээд цэгт хүрэх үед Ехова Бурханы халамжийг мэдэрсэн түүнийг нь төрсөн өдрөө хараахаас өөр аргагүйд хүргэсэн юм. Тийм зан авир нь эртнээс төлөвлөсөн зүйл байгаагүй, харин түүний зүрх сэтгэлээс гарсан Бурханыг анхаарах, хайрлах төрөлхийн илчлэл байсан, энэ нь Бурханыг бодож, хайрлахаас нь гарсан төрөлхийн илчлэл байсан. Өөрөөр хэлбэл, тэр өөрийгөө жигшиж байсан учраас, Бурханыг зовоохыг хүсээгүй, бас зовоож тэвчихгүй байсан учраас түүний халамж, хайр нь өөрийгөө үл хайрлах цэгт хүрсэн. Энэ үед Иов Бурханыг гэсэн удаан хугацааны хүндлэл, хүсэл тэмүүлэл ба дассан сэтгэлээ дээшлүүлж, анхаарал тавих болон хайрлах түвшинд аваачсан. Үүний зэрэгцээ мөн Бурханд итгэх өөрийн итгэл, дуулгавартай байдал болон Бурханаас эмээх байдлыг дээшлүүлж, анхаарал тавих, хайрлах түвшинд аваачсан. Бурханд хор учруулах ямар нэг зүйл хийхийг тэр өөртөө зөвшөөрөөгүй, Бурханыг гомдоох байдлаар авирлахыг өөртөө зөвшөөрөөгүй бөгөөд өөрийнхөө учир шалтгааны улмаас Бурханд ямар нэг уй гашуу, ганцрал, гуниглал учруулахыг ч өөртөө зөвшөөрөөгүй юм. Бурханы нүдэнд Иов хэдийгээр урьдын Иов хэвээрээ байсан ч Иовын итгэл, дуулгавартай байдал, Бурханаас эмээх байдал нь Бурханд бүрэн дүүрэн сэтгэл ханамж, таашаал авчирсан. Энэ үед Бурханы түүнээс хүлээж байсан төгс байдалд Иов хүрсэн ба тэрээр Бурханы нүдэнд “төгс ба шулуун шударга” гэж дуудаж үнэхээр болохуйц хүн болсон байв. Түүний зөв шударга үйл хэрэг нь Сатаныг ялан дийлж, Бурханд хийх гэрчлэлдээ бат зогсох боломжийг түүнд олгосон. Иймээс зөв шударга үйл хэрэг нь түүнийг төгс болгож, түүний амийн үнэ цэн дээшлэн, хэзээ хэзээнээс илүү давамгайлах боломжийг олгосон бөгөөд цаашид Сатан сорьж, довтлохгүй анхны хүн болгосон билээ. Иов зөв шударга байсан учраас Сатанд буруушаагдаж, соригдсон; Иов зөв шударга байсан учраас Сатаны гарт өгөгдсөн; Иов зөв шударга байсан учраас Сатаныг даван гарч, ялсан бөгөөд өөрийн гэрчлэлд бат зогссон. Энэ үеэс хойш Иов хэзээ ч Сатаны гарт орохгүй анхны хүн болж, үнэхээр Бурханы сэнтийн өмнө ирж,

гэрлийн дор, Бурханы ерөөлийн дор Сатаны мөрдлөг, хорлолгүйгээр амьдарчээ… Тэрээр Бурханы нүдэнд жинхэнэ хүн болсон; тэр чөлөөлөгдсөн…

Иовын тухай

Иов шалгалтуудыг хэрхэн туулсныг мэдээд та нарын олонх нь Иовын өөрийнх нь тухай, ялангуяа Бурханы магтаалыг олж авсан нууцынх нь талаар илүү дэлгэрэнгүй мэдэхийг хүсэх биз ээ. Иймээс өнөөдөр Иовын тухай ярьцгаая!

Иовын өдөр тутмын амьдралаас бид түүний төгс, шулуун шударга байдал, Бурханаас эмээж, муугаас зайлдгийг нь харж болно

Хэрвээ бид Иовын тухай хэлэлцье гэвэл түүний талаар Бурханы амнаас гарсан: “Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй” хэмээх үнэлгээнээс эхлэх хэрэгтэй.

Эхлээд Иовын төгс, шулуун шударга байдлын талаар үзэцгээе.

“Төгс” болон “шулуун шударга” гэсэн үгийг та нар юу гэж ойлгож байна вэ? Иов бол зэмлэх зүйлгүй, шударга үнэнч хүн байсан гэж та нар итгэдэг үү? Энэ нь мэдээжээр “төгс” болон “шулуун шударга” гэдгийн үгчилсэн тайлбар, ойлголт байх юм. Гэвч бодит амьдралын агуулга нь Иовын талаарх жинхэнэ ойлголтын салшгүй хэсэг—үг, ном, онол нь дангаараа ямар ч хариулт өгөхгүй. Бид Иовын гэр бүлийн амьдралыг болон амьдралынхаа явцад хэвийн зан төлөв нь ямар байсныг харснаар эхэлье. Энэ нь бидэнд түүний амьдралын зарчим, зорилгын талаар, түүнчлэн зан чанар болон эрэл хайгуулын талаар хэлэх болно. Одоо Иов 1:3-ын хамгийн сүүлчийн үгийг уншицгаая: “Энэ хүн дорнын бүх хүнээс хамгийн агуу нь байв.” Эдгээр үг юу хэлж байна вэ гэвэл, Иовын байр суурь, нэр хүнд маш өндөр байсан бөгөөд тэр элбэг дэлбэг эд хөрөнгөтэй болохоороо юм уу, эсвэл төгс, шулуун шударга агаад Бурханаас эмээж, муугаас зайлдаг учраас дорнын бүх хүний дундаас хамгийн агуу нь байсан уу гэдгийг хэдийгээр бидэнд хэлээгүй ч гэсэн ерөнхийдөө Иовын байр суурь, нэр хүнд нь ихэд үнэлэгдэж байсныг бид мэднэ. Библид бичигдсэнээр Иов төгс байсан, Бурханаас эмээж, муугаас зайлдаг байсан, их эд баялаг эзэмшиж, хүндтэй байр суурь эзэлсэн хүн байсан гэдэг нь Иовын талаарх хүмүүсийн анхны сэтгэгдэл юм. Тийм орчинд, тийм нөхцөлд амьдарч байсан жирийн хүний хувьд Иовын хоол хүнс, амьдралын чанар, хувийн амьдралын янз бүрийн талууд нь ихэнх хүний анхаарлын төвд байж таарна; тиймээс бид Библийг үргэлжлүүлэн унших ёстой: “Түүний хөвгүүд явж, өдөр бүр гэр гэртээ ээлжлэн найрлаж байв; бас гурван эгч дүүгээ хамт хооллож, ууцгаая хэмээн дуудуулдаг байв. Тэгээд тэдний найрлах өдрүүд өнгөрөхөд Иов хүн явуулан тэдэнд өөрсдийгөө ариусга гэв. Тэрээр өглөө эрт босож, бүгдийнх нь тоогоор шатаалт тахил өргөв: Яагаад гэвэл, Иов ‘Хөвгүүд минь нүгэл үйлдэж, Бурханыг зүрх сэтгэлдээ хараасан байж магадгүй’ гэж хэлсэн. Иов тийнхүү тасралтгүй үйлддэг байв” (Иов 1:4–5). Энэ эшлэл бидэнд хоёр зүйлийг хэлж байна: Эхнийх нь Иовын

хөвгүүд, охид ихэд идэж, уун үргэлж найрладаг байсан; хоёр дахь нь Иов тэдний төлөө ямагт санаа зовж, тэд нүгэл үйлдэж, сэтгэлдээ Бурханаас татгалзсан байж магадгүй гэдгээс айж байнга шатаалт тахил өргөдөг байсан. Энд хоёр өөр төрлийн хүний амьдралыг дүрсэлсэн. Эхнийх нь Иовын хөвгүүд, охид хангалуун амьдралтай учраас дандаа найрладаг байсан, тэд хэтэрхий үрэлгэн амьдарч, ханатлаа дарс ууж, хооллож, материаллаг эд баялгаас бий болсон өндөр чанарын амьдралыг эдэлж байсан. Ийм амьдралаар амьдарснаар тэд үргэлж нүгэл үйлдэж, Бурханыг гомдоох нь гарцаагүй байв—гэтэл тэд өөрсдийгөө ариусгаагүй, эсвэл шатаалт тахил өргөөгүй. Тэдний зүрх сэтгэлд Бурханы зай байгаагүй, тэд Бурханы нигүүлслийг бодож үзээгүй, Бурханыг гомдоохоос ч айгаагүй, тэр ч бүү, хэл зүрх сэтгэлдээ Бурханыг орхихоос ч айгаагүй байгаа биз дээ. Мэдээжээр, бид Иовын хүүхдүүдэд биш, харин тийм зүйлтэй тулгараад Иов юу хийсэнд анхаарлаа төвлөрүүлэх юм; энэ нь эшлэлд дүрслэгдсэн өөр хэрэг бөгөөд Иовын хүн чанар-мөн чанар болон өдөр тутмын амьдралыг агуулдаг. Библид Иовын хөвгүүд, охидын найр наадмын талаар дүрслэхдээ Иовыг ер дурддаггүй; зөвхөн түүний хөвгүүд, охид дандаа хамт идэж, ууж байсан гэдэг. Өөрөөр хэлбэл, Иов найр наадам хийгээ ч үгүй, мөн хөвгүүд, охид нь үрэлгэн байдлаар идэхэд нь оролцоо ч үгүй. Хэдий баян чинээлэг, их эд хөрөнгө, олон зарцтай байсан ч гэсэн Иовын амьдрал тансаг байгаагүй. Тэр дээд зэргийн амьдрах орчиндоо автаагүй, эд хөрөнгөнийхөө улмаас махан биеийн зугаа цэнгэлд шунаагүй, эсвэл шатаалт тахил өргөхөө ч мартаагүй, тэр тусмаа энэ нь зүрх сэтгэлдээ Бурханаас аажмаар холдоход хүргээгүй. Тэгэхээр Иов амьдралдаа сахилга баттай байсан бөгөөд Бурхан түүнийг ерөөсний үр дүнд шунал, таашаалыг чухалчилж байгаагүй, бас амьдралын чанарт анхаарлаа төвлөрүүлээгүй нь илэрхий. Харин хүлцэнгүй, даруухан байж, сайрхаж бардамнаагүй бөгөөд Бурханы өмнө болгоомжтой, хянуур байв. Бурханы нигүүлсэл болон ерөөлийг байнга бодож, Бурханаас үргэлж эмээж байсан юм. Өдөр тутмын амьдралдаа Иов хөвгүүд, охидынхоо төлөө шатаалт тахил өргөхийн тулд эртлэн босдог байв. Өөрөөр хэлбэл, Иов зөвхөн өөрөө Бурханаас эмээгээд зогсохгүй, мөн хүүхдүүд нь өөрийнх нь адилаар Бурханаас эмээж, Бурханы эсрэг нүгэл үйлдэхгүй байх гэж найддаг байсан юм. Иовын эд баялаг зүрх сэтгэлд нь ямар ч зай эзлээгүй, Бурханы эзэлсэн байр суурийг ч орлоогүй; өөрийнхөө төлөө хийсэн ч бай, эсвэл хүүхдүүдийнхээ төлөө хийсэн ч бай, Иовын өдөр тутмын үйлдэл нь бүгд Бурханаас эмээж, муугаас зайлахтай холбоотой байв. Ехова Бурханаас эмээх нь зөвхөн түүний яриагаар хязгаарлагдаагүй, харин үйлдэлд нь хэрэгжсэн зүйл байсан ба өдөр тутмын амьдралынх нь хэсэг бүрд тусгагдаж байлаа. Иовын энэ жинхэнэ зан төлөв нь, тэрээр үнэнч байсан бөгөөд шударга ёс болон эерэг бүхнийг хайрлах мөн чанарыг эзэмшсэн байсан гэдгийг бидэнд харуулдаг. Иов дандаа хөвгүүд, охидоо явуулж, ариусгуулж байсан нь хүүхдүүдийнхээ үйлдлийг сайшааж, зөвшөөрөөгүй гэсэн үг; харин ч зүрх сэтгэлдээ тэдний ааш авирт сэтгэл гонсойж, тэднийг яллаж байсан юм. Хөвгүүд, охидынх нь ааш авир Ехова Бурханы дургүйг

хүргэмээр байна гэж тэр дүгнэсэн, тиймээс тэдийг Ехова Бурханы өмнө очиж, нүглээ наманчил гэж үргэлж хэлдэг байв. Иовын энэхүү үйлдэл нь түүний хүн чанарын өөр нэг талыг бидэнд харуулдаг: тэр нүгэл үйлдэж, Бурханыг гомдоосон хүмүүстэй хэзээ ч хамт алхаагүй, харин тэднээс зайлсхийж, нүүр буруулж байсан. Хэдийгээр энэ хүмүүс хөвгүүд, охид нь байсан ч гэсэн өөрийнх нь цусан төрөл байсан учраас зан төлөвийн зарчмаасаа няцаагүй, мөн уян сэтгэлээсээ болж тэдний нүглийг өөгшүүлээгүй. Үүний оронд тэр, тэднээс наманчилж, Ехова Бурханы өршөөлийг олж ав гэж шаардсан ба өөрсдийн шунахай зугаа цэнгэлийн төлөө Бурханыг орхихгүй байхыг тэдэнд анхааруулж байсан. Иовын бусдад ханддаг зарчим нь Бурханаас эмээх болон муугаас зайлах зарчимтай нь салшгүй холбоотой. Тэр Бурханы хүлээн авсан зүйлсийг хайрладаг бөгөөд Бурханы дургүйг хүргэдэг зүйлийг жигшдэг байсан, тэрээр зүрх сэтгэлдээ Бурханаас эмээдэг хүмүүсийг хайрлаж, мууг үйлдэж, эсвэл Бурханы эсрэг нүгэл үйлдсэн хүмүүсийг жигшдэг байжээ. Ийм хайр болон жигшил түүний өдөр тутмын амьдралд харагдаж байсан ба тэр нь Бурханы нүдээр харсан Иовын шулуун шударга байдал юм. Мэдээж, энэ нь Иовын өдөр тутам бусадтай харилцдаг жинхэнэ хүн чанарын илэрхийлэл, амьдран харуулалт бөгөөд бидний мэдэж авах ёстой зүйл билээ.

Шалгалтын үеийн Иовын хүн чанарын илрэл (Шалгалтын үеийн Иовын төгс, шулуун шударга байдал, Бурханаас эмээж, муугаас зайлдаг байдлыг ойлгох нь)

Бидний дээр хуваалцсан зүйл бол туршилтаас өмнө өдөр тутмын амьдралдаа харуулж байсан Иовын хүн чанарын янз бүрийн тал юм. Энэ олон янзын илэрхийлэл нь ямар ч эргэлзээгүйгээр Иовын шулуун шударга байдал, Бурханаас эмээж, муугаас зайлдаг талаарх анхны мэдлэг, ойлголтыг өгч, аяндаа анхны нотолгоогоор хангадаг. Яагаад Би “анхны” гэж хэлсний шалтгаан бол ихэнх хүн одоо ч гэсэн Иовын хүн чанар болон Бурханд дуулгавартай байж, Түүнээс эмээх замыг эрж хайсан түвшний талаар үнэн зөв ойлголтгүй байдаг. Өөрөөр хэлбэл, Иовын талаарх ихэнх хүний ойлголт нь “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг”, мөн “Бид Бурханы гараас сайныг хүлээн аваад мууг хүлээн авахгүй юу?” гэсэн түүний үгийг агуулсан Библийн хоёр хэсгээс үүссэн түүний талаарх таатайхан сэтгэгдлээс илүү гүнзгийрдэггүй. Тиймээс бидний хувьд Бурханы шалгалтыг хүлээж авч байхдаа Иов хүн чанараа хэрхэн амьдран харуулсныг ойлгох нь бидэнд маш их хэрэгтэй юм; ийм байдлаар Иовын жинхэнэ хүн чанар нь бүх хүнд бүхэлдээ харагдана.

Эд хөрөнгийг нь дээрэмдсэн, хөвгүүд, охид нь амиа алдаж, зарц нар нь алагдсаныг сонсоод Иов дараах хариу үйлдэл хийсэн: “Тэгээд Иов босож, нөмрөгөө урж, толгойн үсээ хусаж, газар унан мөргөв” (Иов 1:20). Эдгээр үг бидэнд нэгэн баримтыг хэлж байгаа юм: Энэ мэдээг сонссоны дараа Иов тэвдэж балмагдаагүй,

уйлаагүй, эсвэл энэ мэдээг дуулгасан зарц нараа буруутгаагүй, тэр ч бүү хэл, нарийн ширийнийг нь мөрдөж, тодруулан яг юу тохиолдсоныг олж мэдэх гэж гэмт хэрэг болсон газрыг шалгаагүй. Тэр эд хөрөнгөө алдсандаа ямар ч шаналал, харуусал харуулаагүй, мөн хүүхдүүдээ, хайртай хүмүүсээ алдсандаа уйлж унжаагүй. Харин ч нөмрөгөө урж, толгойн үсээ хусаад газар унаж, шүтэн мөргөсөн. Иовын үйлдлүүд ямар ч энгийн хүнийхээс өөр байв. Тэдгээр нь олон хүнийг будилуулж, “хүйтэн хөндий” байсных нь төлөө Иовыг зүрх сэтгэлдээ зэмлэхэд хүргэсэн. Эд хөрөнгөө гэнэт алдах үедээ жирийн хүмүүс уй гашууд дарагдаж, цөхөрсөн мэт байдаг—эсвэл зарим хүн сэтгэлийн гүн хямралд орж ч магадгүй байдаг. Яагаад гэвэл, тэдний зүрх сэтгэлд эд хөрөнгө нь насан туршийнх нь хичээл чармайлтыг төлөөлдөг, тэдний амьд үлдэх нь үүнээс хамаардаг, энэ нь тэдний амьд явах итгэл найдвар болдог; эд хөрөнгөө алдана гэдэг бол хичээл чармайлт нь талаар өнгөрч, горьдлого найдваргүй, бүр ирээдүй ч байхгүй боллоо гэсэн үг юм. Энэ бол ямар ч жирийн хүний өөрийн өмч хөрөнгөд хандах хандлага ба үүнтэй харилцах ойр дотно харилцаа нь юм, мөн хүмүүсийн үзлээр бол энэ нь эд хөрөнгийн ач холбогдол билээ. Тиймээс хүмүүсийн асар олонх нь Иов хөрөнгөө алдчихаад хайхрамжгүй хандсанд гайхаж будилсан. Өнөөдөр бид Иовын зүрх сэтгэлд юу болж байсныг тайлбарласнаар энэ бүх хүний төөрөгдлийг арилгах гэж байна.

Эрүүл ухаанаар бол, тийм арвин их хөрөнгийг Бурханаас хүртсэн болохоор эдгээр хөрөнгийг алдсандаа Иов Бурханаас ичих ёстой, учир нь тэр тэдгээрийг харж хандаж, анхаарал тавиагүй; Бурханы өгсөн хөрөнгийг хадгалаагүй. Тиймээс өмч хөрөнгийг нь дээрэмдсэн гэдгийг сонсоод түүний анхны хариу үйлдэл нь хэрэг болсон газарт очиж, алдагдсан бүхнийг бүртгэж, дараа нь Бурханд өчих ёстой байсан, тэгснээр тэр Бурханы ерөөлийг дахин нэг удаа хүртэж магадгүй байсан юм. Харин Иов тэгээгүй—үнэндээ түүнд тэгэхгүй байх хувийн шалтгаан байсан билээ. Түүний эзэмшдэг бүхнийг Бурхан түүнд хайрласан бөгөөд өөрийнх нь хөдөлмөрийн үр шим биш гэж Иов зүрх сэтгэлдээ гүнээ итгэдэг байсан. Тиймээс тэр эдгээр ерөөлийг дээр нь дөрөөлж хөрөнгөжих зүйл гэж үзээгүй, харин баримтлах ёстой замаас хамаг хүчээрээ зуурч, амьдралынхаа зарчим болгох хэрэгтэй гэж үзсэн. Тэр Бурханы ерөөлийг эрхэмлэн дээдэлж, тэдгээрт талархдаг байсан, гэхдээ ерөөлд сэтгэл татагдаагүй, мөн илүү их ерөөлийг ч эрэлхийлээгүй. Өмч хөрөнгийн талаарх түүний хандлага ийм байв. Тэр ерөөл олж авах гэж юу ч хийгээгүй, мөн Бурханы ерөөлөөр дутлаа, эсвэл алдлаа гэж санаа нь зовж, шаналаагүй; Бурханы ерөөлийг хүртсэндээ сүйдтэй, ухаангүй ихээр баярлаагүй, мөн байнга ерөөл хүртдэг гээд Бурханы замыг үл тоогоогүй, Бурханы нигүүлслийг ч мартаагүй юм. Өөрийн эд хөрөнгийн талаарх Иовын хандлага хүмүүст түүний жинхэнэ хүн чанарыг илчилдэг: Нэгдүгээрт, Иов шунахай хүн байгаагүй ба материаллаг амьдралдаа ихийг шаарддаггүй байсан. Хоёрдугаарт, Бурхан түүнээс байгаа бүхнийг нь авна гэдгээс Иов хэзээ ч айж, санаа зовж байгаагүй, энэ нь зүрх сэтгэлдээ Бурханд

дуулгавартай байх түүний хандлага байсан; өөрөөр хэлбэл, Бурхан хэзээ түүнээс авчих бол гэж, эсвэл авах болов уу, яах бол гэдэг талаар түүнд ямар ч шаардлага, гомдол байгаагүй ба яагаад гэдэг шалтгааныг ч асуугаагүй, харин зөвхөн Бурханы зохицуулалтад дуулгавартай байхыг зорьсон. Гуравдугаарт, түүний хөрөнгө өөрийнх нь хөдөлмөрөөс бий болсон гэж тэр хэзээ ч итгээгүй, харин тэдгээрийг түүнд Бурхан хайрласан гэж итгэдэг байв. Энэ нь Иовын Бурханд итгэх итгэл, бат үнэмшлийн үзүүлэлт байсан. Иовын хүн чанар болон өдөр тутмын жинхэнэ мэрийлт нь түүний талаарх энэ гурван талын дүгнэлтээр тодорхой болсон уу? Эд хөрөнгөө алдаад тайван байсных нь салшгүй хэсэг бол Иовын хүн чанар болон мэрийлт байлаа. Өөрөө өдөр тутам мэрийсний ачаар л Иов Бурханы шалгалтуудын үеэр “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг” гэж хэлэх биеийн хэмжээ болон итгэл үнэмшилтэй байсан билээ. Эдгээр үгийг нэг шөнийн дотор олж аваагүй, мөн тэдгээр нь Иовын толгойд гэнэтхэн орж ирээгүй, харин олон жилийн амьдралыг туулахдаа түүний харж, олж авсан зүйл байсан. Зөвхөн Бурханы ерөөлийг эрж хайдаг, Бурхан буцааж авна гэж айдаг, үүнийг үзэн ядаж, гомдоллодог бүх хүнтэй харьцуулахад Иовын дуулгавартай байдал маш бодитой биш гэж үү? Бурхан байдаг гэдэгт итгэдэг боловч Бурхан бүх зүйлийг захирдаг гэдэгт хэзээ ч итгэдэггүй хүмүүстэй харьцуулахад Иов тун үнэнч, шулуун шударга биш гэж үү?

Иовын ухаалаг байдал

Иовд бодит туршлага, шулуун шударга, үнэнч хүн чанар байсан болохоор эд хөрөнгө, үр хүүхдээ алдсан үедээ хамгийн ухаалаг шийд болон сонголт хийсэн юм. Тийм ухаалаг сонголт нь түүний байнгын эрэл хайгуул болон өдөр тутмын амьдралдаа мэдэж авсан Бурханы үйл хэрэгтэй салшгүй холбоотой байв. Иовын үнэнч байдал нь Еховагийн гар бүх зүйлийг удирддаг гэдэгт түүнийг итгэж чаддаг болгосон; түүний итгэл нь бүх зүйлийг захирах Ехова Бурханы дээд эрхийн бодит баримтыг мэдэх боломжийг түүнд олгосон; мэдлэг нь түүнийг Ехова Бурханы дээд эрх болон зохицуулалтыг дуулгавартай дагахад бэлэн, мөн дагаж чаддаг болгосон; дуулгавартай байдал нь түүнийг Ехова Бурханаас эмээхдээ улам илүү үнэнч болгосон; эмээдэг байдал нь муугаас зайлахдаа улам илүү бодитой болгосон; эцэстээ Иов Бурханаас эмээж, муугаас зайлсан учраас төгс болсон; төгс байдал нь түүнийг цэцэн болгож, мөн хамгийн ухаалаг үйлдэл өгсөн юм.

“Ухаалаг” гэдэг үгийг бид хэрхэн ойлгох ёстой вэ? Үгчилсэн тайлбар нь гэвэл, эрүүл ухаантай, аливааг бодохдоо учир зүйтэй, зохистой агаад эрүүл зөв үг яриа, үйлдэл болон шийдтэй байж, эрүүл саруул, энгийн ёс суртахууны стандартыг эзэмшсэн гэсэн үг юм. Гэсэн ч Иовын ухаалаг байдлыг тайлбарлахад тийм ч хялбар биш. Иовыг туйлын ухаалаг хүн байсан гэж хэлэх үед түүний хүн чанар болон Бурханы өмнө авирласантай нь холбоотой хэлдэг юм. Иов үнэнч байсан учраас Бурханы дээд эрхэд итгэж, дуулгавартай дагаж чадсан, энэ нь түүнд бусдын олж

авч чадахааргүй мэдлэгийг өгч, энэхүү мэдлэг нь өөрт тохиолдсон зүйлийг илүү нарийн зөв танин мэдэж, магадлаж, тодорхойлох боломжийг олгосон, энэ нь түүнд юу хийх, юуг чанд баримтлахаа илүү нарийн, хэрсүү сонгох боломжийг өгсөн. Өөрөөр хэлбэл, түүний үг, ааш авир, түүний үйлдлийн цаадах зарчмууд, аливааг үйлдэхдээ дагадаг дүрэм журам нь энгийн, тодорхой, бодит байсан бөгөөд харалган, ойворгон, эсвэл сэтгэлийн хөдөлгөөнийх байгаагүй. Түүнд тохиолдсон аливаа зүйлд хэрхэн хандахаа тэр мэдэж байсан, төвөгтэй үйл явдлуудын хоорондын харилцааг хэрхэн тэнцвэржүүлж, зохицуулахаа тэр мэдэж байсан, өөрийн чанд баримтлах ёстой замыг хэрхэн чанд баримтлахаа тэр мэддэг байсан бөгөөд цаашлаад, Ехова Бурханы өгөх ба авахад хэрхэн хандахаа мэдэж байсан юм. Иовын ухаалаг байдал яг энэ байсан. Чухамхүү ийм ухаалаг байдлаар зэвсэглэсэн учраас л Иов өмч хөрөнгө, хүү охидоо алдах үедээ “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг” гэж хэлсэн юм.

Иов бие махбодын асар их өвдөлт, хамаатан садан, найз нөхдийнхөө эсэргүүцэлтэй тулгарах үедээ, мөн үхэлтэй нүүр тулах үедээ биеэ авч явсан бодит байдал нь түүний жинхэнэ нүүр царайг дахин нэг удаа бүх хүнд харуулсан.

Иовын үнэн дүр төрх: Хуурамч зангүй бөгөөд үнэн, цэвэр ариун

Иов 2:7–8-ыг уншицгаая: “Тэгээд Сатан Еховагийн дэргэдээс явж, Иовыг хөлийнх нь улнаас толгойн оройг нь хүртэл яр хатгинд бариулж зовоов. Тэр өөрийгөө хусах ваарны хэлтэрхий авч, үнсэн дунд суув.” Энэ бол яр хатги түүний биеэр тархаж байсан үед Иовын биеэ авч явсан байдлын нэг дүрслэл юм. Энэ үед Иов өвдөлтийг тэвчингээ үнс нурам дунд сууж байсан. Хэн ч түүнийг эмчлээгүй, биеийнх нь өвдөлтийг намдаах гэж хэн ч туслаагүй; харин тэр яр хатгиныхаа гадрыг хусахдаа ваарны хэлтэрхий ашигласан. Өнгөц үзэхэд, энэ нь Иовын зовлонгийн нэг л үе шат төдий байсан ба түүний хүн чанар болон Бурханаас эмээх байдалтай ямар ч холбоогүй, учир нь тэр үед Иов өөрийн санаа сэтгэл, үзэл бодлыг илэрхийлэх ямар ч үг хэлээгүй билээ. Гэсэн ч Иовын үйлдэл болон зан төлөв нь түүний хүн чанарын жинхэнэ илэрхийлэл хэвээр юм. Өмнөх нэгдүгээр бүлгийн тэмдэглэлээс, Иов бол дорнын бүх хүний дундаас хамгийн агуу нь байжээ гэдгийг бид уншсан. Харин хоёр дахь бүлгийн энэ эшлэл нь, энэхүү дорнын хамгийн агуу хүн үнэндээ үнс нурам дунд суугаад өөрийгөө маажихаар ваарны хэлтэрхий авсныг бидэнд харуулсан. Энэ хоёр дүрслэлийн хооронд илэрхий ялгаа байхгүй гэж үү? Энэ ялгаа нь бидэнд Иовын үнэн дүр төрхийг харуулсан юм: Өөрийн эрх ямбат байр суурь, зэрэг дэвийг үл харгалзан тэр эдгээр зүйлийг хэзээ ч хайрлаж, анхаарч байгаагүй; бусад хүн түүний байр суурийг хэрхэн үзэж байсныг тоогоогүй, мөн үйлдэл юм уу, зан төлөв нь түүний байр сууринд сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар ч санаа зовоогүй; мөн байр суурийн ашиг тусад шунаагүй, байр суурь, зэрэг дэвийнх нь хамт ирсэн алдар сууг ч эдлээгүй. Тэр зөвхөн Ехова Бурханы нүдэнд өөрийн үнэ цэн болон амьдрахын утга учир ямар байхыг л тоодог байсан. Иовын жинхэнэ төрх

нь түүний мөн чанар байсан: Тэр алдар нэр, эд баялгийг хайрлаагүй, алдар нэр, баян чинээлэг байдлын төлөө амьдраагүй; тэрээр хуурамч зангүй бөгөөд үнэн, цэвэр ариун байсан юм.

Иов хайр, хорслыг ялгадаг нь

Иовын хүн чанарын өөр нэг тал нь түүний эхнэртэйгээ ярилцсан энэ үгээс харагддаг: “Тэгэхэд эхнэр нь түүнд, ‘Чи одоо ч гэсэн үнэнч шударга байдлаа хадгалж байна уу? Бурханыг хараа, тэгээд үх’ гэв. Харин тэр түүнд, ‘Чи мунхаг эм шиг ярьж байна. Юу гэнэ ээ? Бид Бурханы гараас сайныг хүлээн аваад мууг хүлээн авахгүй юу?’ гэв” (Иов 2:9–10). Иовын эхнэр түүний тарчилж байгааг хараад зовлонгоосоо зайлахад нь туслахын тулд зөвлөгөө өгөхөөр оролдсон—гэвч “сайн санааг” нь Иов сайшаагаагүй; харин ч энэ нь түүний уурыг хүргэсэн, яагаад гэвэл, эхнэр нь түүний Ехова Бурханд итгэх итгэл болон дуулгавартай байдлыг үгүйсгэсэн бөгөөд түүнчлэн Ехова Бурханы оршин тогтнолыг үгүйсгэсэн билээ. Энэ нь Иовд тэвчихийн аргагүй байсан, учир нь тэр Бурханыг эсэргүүцэх, эсвэл гомдоох ямар нэг зүйл хийхийг бусдад байтугай өөртөө хэзээ ч зөвшөөрч байгаагүй юм. Бусад хүмүүс Бурханыг гүтгэн доромжилсон үг хэлж байхад тэр хайхрахгүй байж хэрхэн чадах билээ? Тиймээс тэр эхнэрээ “мунхаг эм” гэж дуудсан. Иов эхнэртээ уурлаж, үзэн ядсан, түүнчлэн зэмлэж буруушаасан. Энэ нь хайр, хорслыг хооронд нь ялгах Иовын хүн чанарын ердийн илэрхийлэл байсан бөгөөд түүний шулуун шударга хүн чанарын жинхэнэ төлөөлөл байсан юм. Иов шударга ёсны мэдрэмжтэй хүн байсан—энэ нь, хорон муу уур амьсгал, урсгалыг үзэн ядаж, гаж буруу тэрс үзэл, хөгийн маргаан болон утга учиргүй нотлохыг жигшин, яллаж, няцаадаг болгосон ба олон нийтэд адлагдаж, ойр дотны хүмүүстээ хаягдах үедээ өөрийн зөв зарчим, үзэл баримтлалд үнэнч байх боломжийг түүнд олгожээ.

Иовын зөөлөн сэтгэл ба чин сэтгэл

Нэгэнт бид Иовын зан төлөвөөс түүний хүн чанарын өөр өөр талын илэрхийллийг харж чадаж байгаа болохоор өөрийн төрсөн өдрийг хараахаар амаа нээхэд нь Иовын ямар хүн чанарыг хардаг вэ? Энэ бол бидний доор хуваалцах сэдэв юм.

Иов өөрийн төрсөн өдрийг хараасан шалтгааны талаар Би дээр ярьсан. Үүнээс та нар юу харж байна вэ? Хэрвээ Иов хатуу сэтгэлтэй, хайр энэрэлгүй байсан бол, хэрвээ хүйтэн хөндий, хэнэггүй, хүн чанаргүй байсан бол Бурханы хүслийг анхаарч чадах байсан уу? Тэгээд Бурханы зүрх сэтгэлийг анхаарсан болохоороо өөрийн төрсөн өдрийг жигшиж чадах байсан уу? Өөрөөр хэлбэл, хэрвээ Иов хатуу сэтгэлтэй, хүн чанаргүй байсан бол Бурханыг шаналахад нь зовох байсан гэж үү? Бурхан өөрөөс нь болж зовж шаналсан учраас өөрийн төрсөн өдрийг хараах байсан гэж үү? Хариулт нь бол: Огтхон ч үгүй! Иов зөөлөн сэтгэлтэй байсан учраас Бурханы зүрх сэтгэлийг анхаарсан; Иов Бурханы зүрх сэтгэлийг анхаарч байсан

учраас Бурханы шаналлыг мэдэрсэн; тэр зөөлөн сэтгэлтэй байсан учраас Бурханы өвдөлтийг мэдэрч, илүү их зовлон шаналал амссан; тэр Бурханы өвдөлтийг мэдэрсэн учраас өөрийн төрсөн өдрийг жигшиж, тиймээс өөрийн төрсөн өдрийг хараасан билээ. Гаднын хүмүүст бол шалгалтуудын үеэр Иовын зан төрх бүхэлдээ үлгэр жишээч байсан гэж хэлж болно. Гагцхүү өөрийн төрсөн өдрийг хараасан нь түүний төгс, шулуун шударга байдалд асуултын тэмдэг тавьж, эсвэл өөр үнэлгээ өгдөг юм. Үнэндээ, энэ нь Иовын хүн чанар-мөн чанарын хамгийн жинхэнэ илэрхийлэл байлаа. Түүний хүн чанар-мөн чанар нуугдаж, баглагдаагүй, эсвэл түүнийг нь өөр хүн засварлаагүй. Өөрийн төрсөн өдрийг хараах үедээ тэр зүрх сэтгэлийнхээ гүн дэх өр нимгэн, чин сэтгэлээ ил харуулсан; тэрээр яг л ёроол нь харагдах булгийн ус мэт цэвэр, тунгалаг байсан юм.

Иовын талаар энэ бүхнийг мэдсэнээр ихэнх хүмүүс Иовын хүн чанар-мөн чанарын талаар нэлээд үнэн зөв, бодитой үнэлгээтэй болох нь гарцаагүй. Тэд мөн Бурханы хэлсэн Иовын төгс, шулуун шударга байдлын талаар гүн гүнзгий, бодит, илүү дэвшилтэт ойлголт, ухааралтай болсон байх ёстой. Энэхүү ойлголт болон ухаарал нь Бурханаас эмээж, муугаас зайлах замд ороход нь хүмүүст туслах болно гэж найдаж байна.

Бурхан Иовыг Сатаны гарт өгсөн явдал болон Бурханы ажлын зорилгын хоорондох харилцаа

Иов төгс, шулуун шударга байсан ба Бурханаас эмээж, муугаас зайлдаг байсан гэдгийг ихэнх хүн одоо хүлээн зөвшөөрдөг ч, ийнхүү хүлээн зөвшөөрөх нь тэдэнд Бурханы санаа зорилгын талаар илүү их ойлголт өгдөггүй. Иовын хүн чанар, эрэл хайгуулд атаархахын зэрэгцээ тэд дараах асуултыг Бурханаас асуудаг: Иов тийм төгс, шулуун шударга байсан, хүмүүс түүнийг тэгж их шагширдаг, гэхдээ Бурхан яагаад түүнийг Сатаны гарт өгч, түүнд тийм их зовлон учруулсан юм бэ? Ийм асуулт олон хүний зүрх сэтгэлд оршдог нь дамжиггүй—эсвэл харин ч энэхүү эргэлзээ нь олон хүний зүрх сэтгэл дэх асуулт юм. Нэгэнт энэ нь маш олон хүнийг будилуулсан болохоор бид энэ асуултыг ил тавьж, зүй зохистойгоор тайлбарлах ёстой.

Бурханы хийдэг бүхэн чухал шаардлагатай бөгөөд онцгой ач холбогдол агуулдаг, учир нь Түүний хүнд хийдэг бүхэн Түүний удирдлага болон хүн төрөлхтний авралтай холбоотой байдаг. Мэдээж, Иов хэдийгээр Бурханы нүдэнд төгс, шулуун шударга байсан ч гэсэн Иовд хийсэн Бурханы ажил өөр байгаагүй. Өөрөөр хэлбэл, Бурхан юу хийдэг, ямар аргаар хийдгийг үл харгалзан, төлөөс, зорилтыг нь ь үл харгалзан Түүний үйлдлийн зорилго өөрчлөгддөггүй. Түүний зорилго бол Бурханы үг, Бурханы шаардлага ба түүнчлэн, хүний төлөө гэсэн Бурханы хүслийг хүний дотор оруулах явдал; өөрөөр хэлбэл, Бурханы эерэг гэж боддог юм бүхнийг Бурханы алхмуудын дагуу хүнд оруулж, хүнд Бурханы зүрх сэтгэлийг ойлгуулан, Бурханы мөн чанарыг ухааруулах, Бурханы дээд эрх болон зохицуулалтыг дуулгавартай дагах боломж олгох, улмаар хүнийг Бурханаас эмээж,

муугаас зайлдаг болгох зорилготой—энэ бүхэн нь Бурханы хийдэг бүх зүйлийн зорилгын нэг тал юм. Нөгөө нэг тал нь, Сатан бол Бурханы ажил дахь товойлгогч, үйлчлэл үзүүлэгч учраас хүнийг үргэлж Сатанд өгдөг; энэ нь Сатаны сорилт, дайралтуудаас Сатаны хорон муу, бузар, жигшмээр байдлыг харах боломжийг хүмүүст олгохын тулд Бурханы ашигладаг арга бөгөөд тэгснээр хүмүүсийг Сатаныг үзэн ядаж, сөрөг зүйлийг мэдэж, ялгаж чаддаг болгодог. Энэ үйл явц нь Бурханы үг, Бурханы талаарх мэдлэг болон Бурханд дуулгавартай байх, Бурханд итгэх итгэл, Түүнээс эмээх байдлын ачаар тэд Сатаны дайралтуудыг ялж, Сатаны буруушаалтыг ялах хүртлээ өөрсдийгөө Сатаны хяналтаас, Сатаны буруушаалт, хөндлөнгийн оролцоо болон дайралтуудаас аажмаар чөлөөлөх боломжийг тэдэнд олгодог; зөвхөн тэр үед л тэд Сатаны эзэмшлээс бүрэн чөлөөлөгдсөн байх болно. Хүмүүс чөлөөлөгдөх нь Сатан ялагдсан гэсэн үг, тэд цаашид Сатаны аманд хоол байхаа больж, тэднийг залгихын оронд Сатан тэднийг сулласан гэсэн үг. Ийм хүмүүс шулуун шударга байдаг учраас, Бурханд итгэлтэй, дуулгавартай бөгөөд Түүнээс эмээдэг учраас, мөн тэд Сатанаас бүрмөсөн салдаг учраас энэ. Тэд Сатаныг шившиглэдэг, Сатаныг хулчийлгадаг ба Сатаныг бүрэн дүүрэн ялдаг. Бурханыг дагах тэдний итгэл үнэмшил, Бурханд дуулгавартай байж, Түүнээс эмээдэг нь Сатаныг ялдаг бөгөөд Сатан тэднийг бүрмөсөн орхиход хүргэдэг. Зөвхөн ийм хүмүүсийг л Бурхан үнэхээр авах ба энэ нь хүнийг аврах Бурханы эцсийн зорилго юм. Хэрвээ тэд аврагдахыг хүсэж, Бурхан тэднийг бүрэн аваасай гэж хүсэж байвал Бурханыг дагадаг бүх хүн Сатаны их, бага сорилт, дайралтын аль алинтай тулгарах ёстой. Эдгээр сорилт, дайралтаас гарч ирсэн хүмүүс Сатаныг бүрэн ялж чаддаг бөгөөд Бурханаар авруулсан хүмүүс юм. Өөрөөр хэлбэл, Бурханаар авруулсан хүмүүс нь Бурханы шалгалтыг туулж, тоо томшгүй олон удаа Сатанд соригдож, түүний дайралтад өртсөн хүмүүс юм. Бурханаар авруулсан хүмүүс Бурханы хүсэл, шаардлагыг ойлгож, Бурханы дээд эрх, зохицуулалтыг дуулгавартай дагаж чаддаг бөгөөд Сатаны сорилт дунд Бурханаас эмээж, муугаас зайлах замыг хаядаггүй. Бурханаар авруулсан хүмүүс үнэнч, зөөлөн сэтгэлтэй байдаг ба хайр, хорслыг хооронд нь ялгадаг, шударга ёсны мэдрэмжтэй, ухаалаг байдаг бөгөөд Бурханд анхаарал тавьж, Бурханы юм бүхнийг эрхэмлэн дээдэлж чаддаг. Тийм хүмүүс Сатанд баригдаж, тандуулж, буруушаагдаж, эсвэл хүчирхийлэлд нь ордоггүй; тэд бүрэн эрх чөлөөтэй байдаг, бүрэн чөлөөлөгдөж, суллагдсан байдаг юм. Иов бол яг тийм эрх чөлөөтэй хүн байсан, Бурхан яагаад түүнийг Сатанд гардуулан өгсөн чухам учир нь энэ билээ.

Иовыг Сатан хүчирхийлж байсан боловч Иов бас мөнхийн эрх чөлөө, чөлөөлөлтийг олж авсан ба хэзээ ч дахин Сатаны ялзруулалт, хүчирхийлэл, буруушаалтад өртөхгүй болж, үүний оронд Бурханы сайшаалын гэрэлд эрх чөлөөтэй, саад тотгоргүй амьдарч, өөрт нь өгсөн Бурханы ерөөлүүдийн дунд амьдрах эрхийг олж авсан. Энэ эрхийг хэн ч түүнээс салгаж, устгаж, булаан авч чадахгүй. Үүнийг Иовд итгэл, шийдэмгий байдал, Бурханд дуулгавартай байж,

Бурханаас эмээдгийнх нь хариуд өгсөн юм; Иов газар дээр баяр хөөр, аз жаргал хүртэхийн тулд, тун жам ёсны, үндэслэлтэй эрх ямбыг хүртэхийн тулд, Бурханы жинхэнэ бүтээл болохынхоо хувьд Бүтээгчийг ямар ч хөндлөнгийн оролцоогүйгээр газар дээр шүтэн мөргөхийн тулд амиараа төлөөс төлсөн юм. Иовын туулж амссан сорилтын хамгийн агуу үр дүн бас энэ байсан билээ.

Хүмүүс хараахан аврагдаагүй байх үед тэдний амьдралд Сатан үргэлж оролцож, бүр хянаж байсан. Өөрөөр хэлбэл, аврагдаагүй хүмүүс бол Сатаны хоригдлууд бөгөөд тэд эрх чөлөөгүй, Сатан тэднийг суллаагүй, тэд Бурханыг шүтэн мөргөх шаардлага хангаагүй, эсвэл тэгэх эрхгүй байдаг бөгөөд тэднийг Сатан ойрхон мөшгин хөөж, хайр найргүй дайрч байдаг. Тийм хүмүүст яриад байх аз жаргал байдаггүй, яриад байх хэвийн оршин тогтнох ямар ч эрх байхгүй, түүнчлэн яриад байх ямар ч нэр төр байдаггүй. Чи зөвхөн өндийн босож, Сатантай тэмцэл хийж, Бурханд итгэдгээ, Түүнд дуулгавартай байдгаа, Бурханаас эмээдэг байдлаа Сатантай үхэх сэхэхээ үзэх тулааныхаа зэвсэг болгон ашиглах л юм бол Сатаныг бүрэн ялж, чамайг хараад л сүүлээ хавчин зугтаж, хулчийдаг болгоно, ингэснээр тэр чиний эсрэг өөрийн дайралт, буруушаалтуудыг бүрэн орхино—зөвхөн тэр үед л чи аврагдаж, эрх чөлөөтэй болно. Хэрвээ чи Сатанаас бүрэн салахаар шийдсэн ч Сатаныг ялахад туслах зэвсгээр зэвсэглээгүй бол аюулд орсон хэвээр байх болно. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр, Сатанд маш их тамлагдсанаас болоод чамд өчүүхэн төдий ч хүч чадал үлдээгүй байх үед чи мөн л гэрчлэл хийх чадваргүй, өөрийгөө Сатаны буруушаалт, дайралтаас бүрэн чөлөөлөөгүй байгаа бол аврагдах найдвар чамд бага байх болно. Эцэст нь, Бурханы ажлын төгсгөл тунхаглагдах үед чи бас л Сатаны атганд хэвээр байж, өөрийгөө чөлөөлж чадахгүй, тиймээс чамд боломж, эсвэл найдвар хэзээ ч байхгүй байх юм. Тэгэхээр, ийм хүмүүс Сатанд бүрэн олзлогдсон байх болно гэсэн үг.

Бурханы туршилтыг хүлээн ав, Сатаны сорилтыг дав, мөн бүхий л оршихуйг чинь авахыг Бурханд зөвшөөр

Хүнийг хангах, дэмжих байнгын ажлынхаа үеэр Бурхан хүнд Өөрийн хүсэл болон шаардлагыг бүхэлд нь хэлж, Өөрийн үйл хэрэг, зан чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохоо харуулдаг. Зорилго нь, хүнийг биеийн хэмжээгээр зэвсэглэж, Бурханыг дагах зуураа Бурханаас олон янзын үнэнийг—Сатантай хийх тулалдаанд Бурханаас хүнд өгсөн зэвсэг болох үнэнийг олж авах боломжийг хүнд олгох явдал юм. Тэгж зэвсэглээд хүн Бурханы туршилттай нүүр тулах ёстой. Бурханд хүнийг турших олон арга барил, арга зам байдаг боловч тэр бүхэн нь Бурханы дайсан болох Сатаны “хамтын ажиллагааг” шаарддаг. Өөрөөр хэлбэл, Сатантай тулалдах зэвсгийг хүнд өгснөөр Бурхан хүнийг Сатанд өгч, хүний биеийн хэмжээг “турших” боломжийг Сатанд олгодог. Хэрвээ хүн Сатаны тулалдааны эгнээг сэтлэн гарч, Сатаны бүслэлтээс зугтаан амьд гарч чадвал уг туршилтыг давсан байх юм. Гэвч хэрвээ хүн Сатаны тулалдааны эгнээг орхин явж чадалгүй, Сатанд бууж өгөх юм

бол уг туршилтыг даваагүй байх болно. Хүний ямар ч талыг Бурхан шалгалаа гэсэн, Түүний шалгалтын шалгуур бол Сатаны дайралтад өртөх үедээ хүн гэрчлэлдээ бат зогсож байна уу, үгүй юу, мөн Сатанд урхидуулсан үедээ Бурханыг хаяж, Сатанд бууж өгөн, захирагдсан уу, үгүй юу гэдэг юм. Хүн аврагдах уу, үгүй юу гэдэг нь Сатаныг даван гарч, ялж чадах эсэхээс хамаардаг ба эрх чөлөөг олж авч чадах уу, үгүй юу гэдэг нь Бурханы түүнд өгсөн зэвсгийг ганцаараа өргөж, Сатаны боолчлолыг ялж, Сатаны найдварыг бүрэн алдуулж, өөрийгөө орхиулж чадах эсэхээс хамаардаг гэж хэлж болно. Хэрвээ Сатан найдвараа орхиж, хэн нэгнийг суллавал, энэ нь Сатан энэ хүнийг Бурханаас авах гэж дахин хэзээ ч оролдохгүй, энэ хүнийг дахин хэзээ ч буруушааж, түүнд саад болохгүй, дахин хэзээ ч түүнийг хэрцгийгээр тарчлаахгүй, дайрахгүй гэсэн үг юм; зөвхөн ийм хүнийг л Бурхан үнэхээр авах болно. Энэ нь Бурхан хүмүүсийг олж авдаг бүхий л үйл явц юм.

Иовын гэрчлэл хойч үеийнхэнд өгсөн анхааруулга ба сэнхрүүлэл

Бурхан хүнийг бүрмөсөн олж авдаг үйл явцыг ойлгохын зэрэгцээ бас Бурхан Иовыг Сатанд шилжүүлэн өгсний зорилго болон ач холбогдлыг хүмүүс ойлгох болно. Хүмүүс Иовын зовлон шаналлаас болж зовнидоггүй болсон бөгөөд үүний ач холбогдлын талаар цоо шинэ ойлголттой болсон юм. Тэд Иовынхтай адил сорилтыг туулах эсэхэд санаа зовдоггүй болсон бөгөөд Бурханы шалгалт ирэхийг эсэргүүцэж, үгүйсгэдгээ больсон. Иовын итгэл, дуулгавартай байдал болон Сатаныг ялан дийлсэн гэрчлэл нь хүмүүсийг асар их дэмжиж, зоригжуулах эх сурвалж болдог. Тэд Иовоос авралынхаа найдварыг олж хардаг, мөн итгэл, дуулгавартай байдал болон Бурханаас эмээх байдлаар дамжуулан Сатаныг дийлж, Сатаныг ялах нь бүрэн боломжтой юм гэдгийг хардаг. Бурханы дээд эрх болон зохицуулалтыг үг дуугүй хүлээн зөвшөөрч, бүх зүйлээ алдсаны дараа ч Бурханыг орхихгүй гэсэн шийдвэр, итгэлтэй байгаа цагт Сатанд ичгүүр, ялагдал авчирч чадах бөгөөд Сатаныг айлгаж, яаран зугтаалгахын тулд—амиа алдах байсан ч хамаагүй—зөвхөн гэрчлэлдээ бат зогсох шийдвэр болон тэвчээрийг эзэмших хэрэгтэй гэдгийг тэд хардаг. Иовын гэрчлэл нь хойч үеийнхэнд өгсөн анхааруулга бөгөөд хэрвээ тэд Сатаныг ялахгүй юм бол Сатаны буруушаалт болон хөндлөнгийн оролцооноос хэзээ ч ангижирч чадахгүй, мөн Сатаны хүчирхийлэл, дайралтаас хэзээ ч зугтаж чадахгүй гэдгийг энэхүү анхааруулга тэдэнд хэлдэг билээ. Иовын гэрчлэл хойч үеийнхнийг гэгээрүүлсэн юм. Энэ гэгээрэл нь хүмүүст, тэд зөвхөн төгс, шулуун шударга байсан цагт л Бурханаас эмээж, муугаас зайлж чадна гэдгийг сургадаг; Бурханаас эмээж, муугаас зайлж чадах л юм бол Бурханд хүчтэй, жинтэй гэрчлэл хийж чадна гэдгийг сургадаг; Бурханд хүчтэй, жинтэй гэрчлэл хийж чадах л юм бол Сатанд хэзээ ч захирагдахгүй бөгөөд Бурханы удирдамж, хамгаалалт дор амьдарна—зөвхөн тэр үед л тэд үнэхээр аврагдсан байх болно. Иовын хүн чанар, түүний амьдралын эрэл хайгуулыг аврал эрж хайдаг хүн бүр дуурайх ёстой. Бүхий л амьдралынхаа туршид түүний амьдран харуулсан

зүйл болон шалгалтуудын үеэр биеэ авч явсан байдал нь Бурханаас эмээж, муугаас зайлах замыг эрж хайдаг тэр бүх хүний хувьд үнэт эрдэнэ билээ.

Иовын гэрчлэл Бурханд тайтгарал авчирдаг

Хэрвээ одоо Би та нарт Иов бол хайр татам хүн байсан гэж хэлбэл, та нар энэ үгийн утга учрыг үнэлж чадахгүй байж магад, мөн Би яагаад энэ бүх зүйлийг хэлсний цаад санааг ухаарч чадахгүй байж магад; гэхдээ та нар Иовынхтай адил юм уу, төстэй шалгалтуудыг туулсан байх, гай зовлон амсаж, та нарт зориулан Бурханы биечлэн бэлтгэсэн шалгалтуудыг туулсанбайх, уруу таталт дунд Сатаныг дийлж, Бурханд гэрчлэл хийхийн тулд өөрийн бүх хүчин чармайлтыг зориулж, доромжлол, зовлон шаналалыг тэвчсэн байх тэр өдрийг иртэл хүлээ—тэгэхэд л чи Миний хэлсэн эдгээр үгийн утга учрыг үнэлж чаддаг болно. Тэр үед чи Иовоос хамаагүй дор гэдгээ мэдэрнэ, Иов ямар хайр татам гэдгийг, түүнийг дуурайх нь зүйтэй гэдгийг мэдэрнэ. Тэр цаг ирэхэд Иовын хэлсэн тэдгээр сонгодог үг одоо үед амьдарч байгаа завхарсан хүнд хэчнээн чухал болохыг чи ухаарах ба мөн Иовын хийсэн зүйлийг хийх нь өнөөгийн хүмүүст хэчнээн хэцүү болохыг ухаарах болно. Энэ нь хэцүү юм гэдгийг мэдрэх үедээ чи Бурханы зүрх сэтгэл хэчнээн их түгшиж, зовниж байсныг үнэлэх бөгөөд тийм хүмүүсийг олж авахын тулд Бурханы төлсөн төлөөс хэчнээн өндөр болохыг, мөн хүн төрөлхтний төлөө Бурханы хийдэг, зарцуулдаг зүйл хэчнээн эрхэм болохыг үнэлэх болно. Одоо та нар эдгээр үгийг сонсоод Иовын талаар үнэн зөв ойлголт, алдаагүй үнэлгээтэй болж байна уу? Та нарын үзэхэд, Иов үнэхээр Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс, шулуун шударга хүн байсан уу? Ихэнх хүн мэдээж “Тийм” гэж хэлнэ биз ээ. Учир нь, Иовын үйлдэж, илчилж байсан зүйлсийн баримтыг ямар ч хүн, эсвэл Сатан үгүйсгэж чадахгүй билээ. Тэдгээр нь Иов, Сатаныг ялсны хамгийн хүчтэй нотолгоо юм. Энэ нотолгоог Иов бий болгосон бөгөөд Бурханы хүлээн авсан анхны гэрчлэл байв. Тиймээс Иов Сатаны сорилтыг ялж, Бурханд гэрчлэл хийхэд Бурхан Иовоос найдвар олж харсан бөгөөд Түүний зүрх сэтгэлийг Иов тайтгаруулсан. Бүтээлийн цаг үеэс Иовын цаг үеийг хүртэл тайтгарал гэж юу байдгийг, хүнээс тайтгарал хүлээн авна гэж юу гэсэн үг болохыг Бурхан анх удаа үнэхээр мэдэрсэн үе энэ байв. Өөрийнх нь төлөө хийсэн жинхэнэ гэрчлэлийг Тэр анх удаа харж, олж авсан нь энэ байсан юм.

Иовын гэрчлэл болон Иовын янз бүрийн талын тухай мэдээ сонсоод ихэнх хүн өөрсдийнхөө урдах замд төлөвлөгөөтэй байх болно гэдэгт Би итгэж байна. Иймээс айдас, түгшүүрээр дүүрэн ихэнх хүн бие, сэтгэлийнхээ аль алинд аажмаар амарч эхлэн, тайвшралыг бага багаар мэдэрч эхэлнэ гэдэгт Би бас итгэж байна…

Доорх эшлэлүүд нь мөн Иовын тухай тэмдэглэл юм. Үргэлжлүүлэн уншицгаая.

4. Иов Бурханыг чихээрээ сонссон нь

Иов 9:11 Хараач, Тэр хажууд явж байхад би Түүнийг хардаггүй: Түүнийг бас цаашаа өнгөрөхөд би Түүнийг ажигладаггүй.

Иов 23:8–9 Харагтун, би урагшаа явдаг, гэвч Тэр тэнд байхгүй; хойшоо явсан ч би Түүнийг олж харж чаддаггүй. Зүүн гар талд Тэр ажиллаж байвч би Түүнийг харж чаддаггүй, Тэр баруун гар талд нуугдахад би Түүнийг олж харж чаддаггүй.

Иов 42:2–6 Та бүх зүйлийг хийж чадна, ямар ч бодлыг Танаас нууж чадахгүй гэдгийг би мэднэ. Мэдлэггүйгээр ямар нэг зөвлөгөөг нуудаг ямар хүн байх билээ? Тиймээс би ойлгоогүй юмаа хэлчихлээ; миний мэддэггүй байсан юмс надад дэндүү гайхамшигтай. Сонсооч дээ, би Танаас гуйж байна, би ярья: Би Танаас гуйя, Та Өөрийгөө надад харуулаач дээ. Би Таны тухай чихээрээ сонссон; харин одоо нүдээрээ харж байна. Тэгээд л би өөрийгөө жигшиж, шороо ба үнсэн дунд гэмшдэг.

Бурхан Өөрийгөө Иовд харуулаагүй боловч Иов Бурханы дээд эрхэд итгэдэг

Эдгээр үг ямар учиртай юм бэ? Та нарын хэн нэг нь энд баримт байгааг анзаарсан уу? Нэгдүгээрт, Бурхан байдгийг Иов хэрхэн мэдсэн бэ? Тэгээд тэнгэр, газар, бүх зүйлийг Бурхан захирдгийг тэр хэрхэн мэдсэн бэ? Энэ хоёр асуултад хариулах эшлэл бий: “Би Таны тухай чихээрээ сонссон; харин одоо нүдээрээ харж байна. Тэгээд л би өөрийгөө жигшиж, шороо ба үнсэн дунд гэмшдэг.” Иов Бурханыг өөрийн нүдээр харсан гэхээс илүү, Бурханы тухай үлгэр домгоос мэдэж авсныг бид эдгээр үгээс харж болно. Тэр эдгээр нөхцөл байдалд Бурханыг дагах замаар алхаж эхэлсэн бөгөөд дараа нь тэр өөрийнх нь амьдралд, мөн бүх зүйлийн дотор Бурхан оршиж байдгийг нотолжээ. Энд үгүйсгэхийн аргагүй баримт байна—тэр баримт нь юу вэ? Бурханаас эмээж, муугаас зайлах замыг дагах чадвартай байсан ч гэсэн Иов Бурханыг хэзээ ч хараагүй. Энэ тухайд тэр өнөөгийн хүмүүстэй адилхан байсан биш үү? Иов хэзээ ч Бурханыг хараагүй гэсний утга санаа нь гэвэл, хэдийгээр тэр Бурханы тухай сонссон боловч Бурхан хаана байдгийг, Бурхан ямар болохыг, эсвэл Бурхан юу хийж байгааг мэдээгүй. Эдгээр нь хийсвэр хүчин зүйлс юм; бодитоор ярих юм бол, хэдийгээр тэр Бурханыг дагадаг байсан ч Бурхан хэзээ ч түүнд үзэгдэж, түүнтэй ярьж байгаагүй. Энэ баримт биш гэж үү? Хэдийгээр Бурхан Иовтой яриагүй, эсвэл түүнд ямар нэгэн тушаал өгч байгаагүй ч гэсэн Иов, Бурханы оршин тогтнолыг харсан бөгөөд бүх зүйлийн дундаас, мөн Бурханы тухай өөрийн чихээр сонсож мэдсэн үлгэр домгоос Түүний дээд эрхийг харсныхаа дараа Иов Бурханаас эмээж, муугаас зайлах амьдралыг эхэлсэн юм. Бурханыг дагасан Иовын замналын гарал үүсэл, үйл явц ийм байлаа. Гэхдээ тэр Бурханаас эмээж, муугаас зайлж байсан ч, шулуун шударга байдлаа хатуу баримталж байсан ч Бурхан хэзээ ч түүний өмнө гарч ирээгүй билээ. Энэ эшлэлийг уншицгаая. Тэр: “Хараач, Тэр хажууд явж байхад би Түүнийг хардаггүй: Түүнийг бас цаашаа өнгөрөхөд би Түүнийг ажигладаггүй” (Иов 9:11) гэж хэлсэн. Эдгээр үг юу хэлж байна вэ гэвэл, Иов Бурханыг өөрийн эргэн тойронд байхыг мэдэрсэн ч байж магадгүй, эсвэл үгүй ч байж магадгүй—гэхдээ тэр хэзээ ч Бурханыг харж чадаагүй. Бурхан түүний өмнүүр өнгөрч, юм хийж, эсвэл хүнийг удирдан чиглүүлж байна гэж төсөөлдөг үе түүнд

байсан ч гэсэн тэр хэзээ ч мэдээгүй юм. Хүнийг огт санаандгүй байхад нь Бурхан түүн дээр ирдэг; Бурхан түүн дээр хэзээ ирэхийг, эсвэл хаанаас түүн дээр ирэхийг хүн мэддэггүй, учир нь хүн Бурханыг харж чаддаггүй, тиймээс хүний хувьд Бурхан түүнээс нуугдаж байдаг.

Бурхан өөрөөс нь нуугдаж байснаас болж Бурханд итгэх Иовын итгэл ганхаагүй

Библийн дараах эшлэлд Иов: “Харагтун, би урагшаа явдаг, гэвч Тэр тэнд байхгүй; хойшоо явсан ч би Түүнийг олж харж чаддаггүй. Зүүн гар талд Тэр ажиллаж байвч би Түүнийг харж чаддаггүй, Тэр баруун гар талд нуугдахад би Түүнийг олж харж чаддаггүй” (Иов 23:8–9) хэмээсэн. Энэ тэмдэглэлээс бид, Иовын туулсан амьдралын турш Бурхан түүнээс нуугдаж байсан гэдгийг мэдэж болно; Бурхан түүнд ил үзэгдээ ч үгүй, мөн түүнд ямар нэг үг ил шууд хэлээ ч үгүй, гэсэн ч Иов зүрх сэтгэлдээ Бурханы оршин тогтнолын талаар итгэлтэй байсан. Бурхан түүний өмнө алхаж байж магадгүй, эсвэл түүний хажууд ажиллаж байж магадгүй бөгөөд Бурханыг олж харж чаддаггүй байсан хэдий ч Бурхан хавь ойрын бүх зүйлийг удирдан түүний хажууд байгаа гэдэгт тэр үргэлж итгэдэг байв. Иов, Бурханыг хэзээ ч харж байгаагүй боловч өөрийнхөө итгэлд үнэнч байж чадсан, өөр ямар ч хүн ингэж чадаагүй. Яагаад бусад хүн тэгж чадаагүй вэ? Яагаад гэвэл, Бурхан Иовтой яриагүй, эсвэл түүнд ил харагдаагүй бөгөөд хэрвээ тэр үнэхээр итгээгүй байсан бол цааш үргэлжлүүлэн явж чадахгүй, мөн Бурханаас эмээж, муугаас зайлах замыг чанд баримталж чадахгүй байх байсан. Энэ үнэн биш гэж үү? Иов эдгээр үгийг хэлснийг уншаад чамд ямар санагдаж байна вэ? Иовын төгс, шулуун шударга байдал болон Бурханы өмнө зөв шударга байдаг нь жинхэнэ бөгөөд Бурханы зүгээс хэтрүүлсэн хэрэг биш гэдгийг чи мэдэрч байна уу? Хэдийгээр Бурхан Иовд бусад хүнд ханддагтай адил хандаж, түүнд харагдаагүй, түүнтэй яриагүй боловч Иов үнэнч шударга чанараа бат хадгалж, Бурханы дээд эрхэд итгэсээр байсан бөгөөд цаашлаад, Бурханыг гомдоохоос айдаг байсны дүнд ахин дахин шатаалт тахил өргөж, Бурханы өмнө залбирдаг байсан юм. Бурханыг хараагүй хэрнээ Бурханаас эмээх Иовын чадвараас бид, эерэг зүйлсийг хэчнээн их хайрлаж байсныг нь болон түүний итгэл хэчнээн тууштай, бодитой байсныг харж болно. Бурхан өөрөөс нь нуугдаж байсан учраас Бурханы оршин тогтнолыг үгүйсгээгүй, мөн Бурханыг хэзээ ч хараагүй учраас итгэлээ алдаж, Бурханыг орхиогүй. Үүний оронд, бүх зүйлийг захирах Бурханы нуугдмал ажил дундаас Бурханы оршин тогтнолыг ухаарч, Бурханы дээд эрх болон хүч чадлыг мэдэрсэн юм. Бурхан нуугдсан учраас тэр шулуун шударга байхаа болиогүй, мөн Бурхан хэзээ ч өөрт нь үзэгдээгүй учраас Бурханаас эмээж, муугаас зайлах замыг орхиогүй. Өөрийн оршин тогтнолыг батлахын тулд ил гарч ирээч гэж Иов Бурханаас хэзээ ч гуйгаагүй, учир нь тэр аль хэдийн бүх зүйлийн дундаас Бурханы дээд эрхийг харсан бөгөөд тэрээр бусдын олж авч чадаагүй ерөөл, нигүүлслийг

олж авсан гэж итгэж байсан билээ. Хэдийгээр Бурхан түүнээс нуугдсан хэвээр үлдсэн ч, Бурханд итгэх Иовын итгэл хэзээ ч ганхаагүй. Тиймдээ ч тэр өөр хэнд ч байгаагүй зүйл болох Бурханы сайшаал болон Бурханы ерөөлийн үр шимийг хүртсэн юм.

Иов Бурханы нэрийг алдаршуулдаг бөгөөд ерөөл, гай зовлонгийн талаар боддоггүй

Иовын талаарх Библийн түүхүүдийн дотор хэзээ ч дурдаж байгаагүй нэг баримт байдаг бөгөөд бид өнөөдөр энэ баримтад анхаарлаа хандуулна. Иов хэдийгээр хэзээ ч хараагүй, Бурханы үгийг өөрийн чихээр сонсоогүй ч Иовын зүрх сэтгэлд Бурханы орон зай байсан. Тэгвэл Бурханд хандах Иовын хандлага ямар байсан бэ? Өмнө хэлсэнчлэн “Еховагийн нэр алдаршиг” хэмээх байсан юм. Бурханы нэрийг алдаршуулж байгаа нь ямар ч болзолгүй, нөхцөл байдал хамаагүй, мөн шалтгаангүй байсан. Иов зүрх сэтгэлээ Бурханд өгч, түүнийгээ Бурханаар хянуулахыг зөвшөөрсөн гэдгийг бид харж болно; түүний бодсон бүхэн, шийдсэн бүхэн, зүрх сэтгэлдээ төлөвлөсөн бүхэн Бурханы өмнө нээлттэй байсан бөгөөд Бурханаас нууж хаагаагүй юм. Түүний зүрх сэтгэл Бурханы эсрэг зогсоогүй, өөрийнх нь төлөө ямар нэг зүйл хийгээч гэж, эсвэл өөрт нь ямар нэг юм өгөөч гэж Бурханаас гуйгаагүй бөгөөд Бурханыг шүтэн мөргөснөөрөө ямар нэг ашиг олж авна гэсэн даврууу хүсэл ч өвөрлөөгүй. Иов Бурхантай наймаа хэлэлцээгүй, Бурханд ямар ч хүсэлт, шаардлага тавиагүй. Тэрээр бүх зүйлийг захирах Бурханы агуу хүч чадал, эрх мэдлээс болж Бурханы нэрийг алдаршуулж байсан бөгөөд энэ нь ерөөл хүртсэн, эсвэл гай гамшигт нэрвэгдсэн эсэхээс нь хамаараагүй. Бурхан хүмүүсийг ерөөж, эсвэл тэдэнд гай гамшиг авчрах эсэхийг үл харгалзан, Бурханы хүч чадал, эрх мэдэл өөрчлөгдөхгүй, тиймээс хүний нөхцөл байдлыг үл харгалзан Бурханы нэрийг магтвал зохино гэж тэр итгэдэг байсан юм. Хүн Бурханаар ерөөгдөх нь Бурханы дээд эрхээс болдог бөгөөд хүнд гай гамшиг тохиолдох үед энэ нь ч бас Бурханы дээд эрхээс болдог. Бурханы хүч чадал, эрх мэдэл хүний бүх зүйлийг захиран, зохицуулдаг; хүний хувь заяаны гэнэтийн тайлбарлашгүй өөрчлөлтүүд нь Бурханы хүч чадал, эрх мэдлийн илрэл бөгөөд хүний үзэл бодлыг үл харгалзан Бурханы нэрийг магтвал зохино. Энэ нь өөрийн амьдралын хугацаанд Иовын мэдэрч, мэдэж авсан зүйл юм. Иовын бүх бодол, үйлдэл нь Бурханы чихэнд хүрч, Бурханы өмнө очсон бөгөөд Бурханд чухал гэж харагдсан. Бурхан Иовын энэ мэдлэгийг нандигнаж, ийм зүрх сэтгэлтэй байгаад нь Иовыг эрхэмлэн хайрлажээ. Энэ зүрх сэтгэл нь Бурханы тушаалыг үргэлж, бүхий л газарт хүлээж, өөрт нь тохиолдсон бүхнийг хэдийд ч, хаана ч байсан дуртайяа хүлээн авч байв. Иов Бурханд ямар ч шаардлага тавиагүй. Түүний өөрөөсөө шаардаж байсан зүйл нь Бурханаас ирсэн бүх зохицуулалтыг хүлээж, хүлээн авч, нүүр тулж, дуулгавартай дагах явдал байсан; энэ нь түүний үүрэг гэж Иов итгэсэн бөгөөд энэ нь яг Бурханы хүссэн зүйл байсан юм. Иов хэзээ ч Бурханыг хараагүй, мөн Түүнийг ямар нэг үг

хэлэхийг, тушаал өгөхийг, ямар нэг сургаал айлдахыг, эсвэл өөрт нь ямар нэг заавар өгөхийг сонсоогүй. Өнөөгийн үгээр бол, Бурхан үнэний талаар түүнд ямар ч гэгээрэл, удирдамж, хангалт өгөөгүй байхад тэр тийм мэдлэг болон Бурханд хандах хандлагыг эзэмшиж чадсан нь үнэ цэнтэй зүйл байсан, тэр ийм зүйлсийг харуулсан нь Бурханд хангалттай байсан бөгөөд түүний гэрчлэл Бурханд сайшаагдаж, Бурханд эрхэмлэгдсэн. Иов Бурханыг хэзээ ч хараагүй, эсвэл Бурхан түүнд Өөрийн биеэр ямар нэг сургаал хэлэхийг сонсоогүй, гэхдээ Бурханы өмнө гүн онол ярьж, зөвхөн сайрхаж, тахил өргөх тухай ярьдаг боловч хэзээ ч Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй байгаагүй, хэзээ ч Бурханаас үнэхээр эмээж байгаагүй хүмүүстэй харьцуулахад Иовын зүрх сэтгэл болон тэр өөрөө Бурханд хавьгүй илүү эрхэм нандин байсан билээ. Учир нь, Иовын зүрх сэтгэл цэвэр ариун агаад Бурханаас нуугдаагүй байсан, тэрээр хүн чанарын хувьд үнэнч шударга, зөөлөн сэтгэлтэй байж, шударга ёсыг болон эерэг бүхнийг хайрладаг байсан билээ. Зөвхөн тийм зүрх сэтгэл, хүн чанартай хүн л Бурханы замыг дагаж чадах байсан бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлах чадвартай байсан. Тийм хүн Бурханы дээд эрхийг харж, Түүний эрх мэдэл, хүч чадлыг харж чадах ба Түүний дээд эрх болон зохицуулалтад дуулгавартай байж чадах хэмжээнд хүрэх юм. Зөвхөн тийм л хүн Бурханы нэрийг үнэхээр магтаж чадна. Яагаад гэвэл, тэрээр Бурхан өөрийг нь ерөөж, эсвэл өөрт нь гай гамшиг авчрах эсэхийг хардаггүй, учир нь бүх зүйл Бурханы гарт захирагддаг бөгөөд хүн санаа зовно гэдэг бол тэнэг зан, мунхаглал ухаан мөхөс байдлын, мөн Бурхан бүх зүйлийг захирдаг баримтад эргэлзэж, Бурханаас эмээдэггүйн шинж гэдгийг тэр мэддэг байсан. Иовын мэдлэг бол яг Бурханы хүсэж байсан зүйл юм. Тэгэхээр Иов Бурханы талаар та нараас илүү онолын мэдлэгтэй байсан уу? Тэр үеийн Бурханы ажил болон айлдвар цөөхөн байсан учраас Бурханы талаар мэдлэг олж авах нь амаргүй хэрэг байжээ. Иовын тийм амжилт шалихгүй хэрэг байгаагүй. Тэр Бурханы ажлыг үзэж туулаагүй, Бурханы ярихыг хэзээ ч сонсоогүй, мөн Бурханы нүүр царайг хараа ч үгүй. Тэр Бурханд хандах тийм хандлагатай байж чадсан нь бүхэлдээ түүний хүн чанар, хувийн эрэл хайгуул буюу одоогийн хүмүүсийн эзэмшиж чадаагүй хүн чанар, эрэл хайгуулын үр дүн билээ. Тиймээс тэр үед Бурхан “Төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй” гэж хэлсэн. Тэр үед Бурхан түүний талаар аль хэдийн ийм үнэлгээ хийж, ийм дүгнэлтэд хүрсэн байлаа. Энэ нь өнөөдөр хэр их үнэн байх байсан бэ?

Бурхан хэдийгээр хүнээс нуугддаг боловч бүх зүйлийн дундах үйл хэрэг нь Түүнийг мэдэхэд хүнд хангалттай юм

Иов Бурханы царайг хараагүй, Бурханы хэлсэн үгийг сонсоогүй бөгөөд тэр ч бүү хэл, Бурханы ажлыг биечлэн туулаагүй, гэхдээ түүний Бурханаас эмээх байдал болон шалгалтуудын үеийн гэрчлэлийг бүгд нүдээр харсан ба тэдгээрийг нь Бурхан хайрлаж, ихэд таашаан бахдаж, сайшааж, хүмүүс атаархаж, биширч, бүр үгээ олж

ядан магтдаг. Түүний амьдралын тухайд гэвэл, агуу, ер бусын юм юу ч байгаагүй: Тэрээр бусад жирийн хүний адилаар хүнээс ялгарах юмгүй амьдарч, нар мандахад ажилдаа явж, нар жаргахад гэртээ амрахаар ирдэг байв. Ялгаа нь гэвэл, амьдралынхаа ердийн хэдэн арван жилийн туршид тэрээр өөр ямар ч хүний олж чадаагүй Бурханы замын талаарх мэдлэгийг олж авч, Бурханы агуу хүч чадал, дээд эрхийг ухаарч ойлгосон юм. Тэр бусад эгэл хүнээс илүү ухаалаг байгаагүй, гойд амь бөхтэй ч байгаагүй, цаашлаад түүнд онцгой далд ур чадвар ч байгаагүй. Гэхдээ түүний эзэмшсэн зүйл бол үнэнч, өрөвч зөөлөн сэтгэл, шулуун шударга зан чанар, шударга ёс, зөвт байдал болон эерэг зүйлсийг хайрладаг зан чанар байсан— эдгээр зүйлийн алийг ч эгэл хүмүүсийн ихэнх нь эзэмшдэггүй. Тэрээр хайр, хорслыг хооронд нь ялгадаг, шударга ёсны мэдрэмжтэй, тууштай, тэсвэр хатуужилтай, бодол санаандаа нарийн нягт анхаарал хандуулдаг байв. Тиймээс дэлхий дээрх ердийн амьдралдаа Бурханы хийсэн бүхий л ер бусын зүйлийг харж, Бурханы агуу, ариун, зөвт байдлыг харсан, хүний төлөө гэсэн Бурханы зовнил, нигүүлсэл, хамгаалалтыг харсан бөгөөд хамгийн дээд Бурханы хүндтэй байдал, эрх мэдлийг харсан билээ. Ямар ч эгэл хүнээс давсан эдгээр зүйлийг Иов олж авч чадсаны эхний шалтгаан бол, тэр ариун зүрх сэтгэлтэй байсан ба түүний зүрх сэтгэл Бурханд харьяалагдаж, Бүтээгчээр удирдуулж байсан юм. Хоёр дахь шалтгаан нь түүний эрэл хайгуул байсан: өө сэвгүй, төгс байж, Тэнгэрийн хүслийг дагадаг, Бурханд хайрлагдсан, муугаас зайлсан хүн байх гэсэн түүний эрэл хайгуул байв. Бурханыг харж, Бурханы үгийг сонсож чадахгүй байх зуураа Иов эдгээр зүйлийг эзэмшиж, эрэлхийлсэн; тэр Бурханыг хэзээ ч хараагүй боловч бүх зүйлийг захирдаг Бурханы арга барилыг мэдэж авсан бөгөөд Бурханы ингэж хийдэг мэргэн ухааныг ойлгосон юм. Хэдийгээр Бурханы хэлсэн үгийг хэзээ ч сонсож байгаагүй боловч хүнийг шагнах, хүнээс авах үйл хэрэг бүгд Бурханаас ирдэг гэдгийг Иов мэдэж байлаа. Хэдийгээр түүний амьдралын жилүүд бусад эгэл хүнийхээс өөр байгаагүй боловч түүний амьдралын энэхүү энгийн байдал нь бүх зүйлийг захирах Бурханы дээд эрхийн талаарх түүний мэдлэгт нөлөөлж, Бурханаас эмээж, муугаас зайлах замыг дагахад нь нөлөөлөхийг тэр зөвшөөрөөгүй. Түүний үзэхэд, бүх зүйлийн хууль Бурханы үйл хэргээр дүүрэн байсан бөгөөд Бурханы дээд эрхийг хүний амьдралын ямар ч хэсгээс харж болох байсан. Тэр Бурханыг хараагүй, гэхдээ Бурханы үйл хэрэг хаа сайгүй байгааг ухаарч чадсан бөгөөд дэлхий дээрх ердийн амьдралынхаа хугацаанд, өөрийн амьдралын бүх өнцөг булан бүрээс Бурханы ер бусын, гайхалтай үйл хэргийг харж, ухаарч, Бурханы гайхалтай зохицуулалтыг харж чадсан юм. Бурхан нуугдаж, чимээгүй байдаг нь Бурханы үйл хэргийг ойлгож, ухаарахад Иовд саад болоогүй, мөн Бурхан бүх зүйлийг захирдаг талаарх түүний мэдлэгт ч нөлөөлөөгүй. Түүний амьдрал нь бүх зүйлийн дотор нуугддаг Бурханы дээд эрх, зохицуулалтыг өдөр тутмын амьдралдаа мэдрэх ухаарал байлаа. Бүх зүйлийн дунд чимээгүй байдаг атлаа бүх зүйлийн хуулийг захирч Өөрийн зүрх сэтгэлийн дуу хоолой болон Өөрийн үгийг илэрхийлдэг Бурханы зүрх сэтгэлийн дуу

хоолойг, Бурханы үгийг тэр бас өдөр тутмын амьдралдаа сонсож, ойлгодог байлаа. Тэгэхээр, хэрвээ хүмүүс Иов шиг хүн чанар, эрэл хайгуултай байх юм бол Иов шиг ухаарал, мэдлэг олж авч чадах ба бүх зүйлийг захирах Бурханы дээд эрхийн талаар Иовынхтой адилхан ойлголт, мэдлэгийг эзэмшиж чадах юм. Бурхан Иовд харагдаж, түүнтэй ярьж байгаагүй боловч Иов төгс, шулуун шударга байж, Бурханаас эмээж, муугаас зайлж чадсан юм. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнд харагдаж, түүнтэй ярихгүй байхад, бүх зүйлийн дундах Бурханы үйл хэрэг болон бүх зүйлийг захирах Түүний дээд эрх нь Бурханы оршин тогтнол, хүч чадал, эрх мэдлийг хүн мэдэж авахад хангалттай байдаг бөгөөд Бурханы хүч чадал, эрх мэдэл нь хүнийг Бурханаас эмээж, муугаас зайлах замд оруулахад хангалттай юм. Иов шиг эгэл хүн Бурханаас эмээж, муугаас зайлж чадсан байхад Бурханыг дагадаг эгэл хүн бүр бас чадах ёстой. Хэдийгээр эдгээр үг зохистой дүгнэлт мэт сонсогдож болох боловч энэ нь юмсын хуулийг зөрчдөггүй. Гэтэл баримтууд санасанд хүрээгүй: Бурханаас эмээж, муугаас зайлахыг гагцхүү Иов л сахих зүйл мэт харагддаг. “Бурханаас эмээж, муугаас зайлах” талаар дурдахад хүмүүс, Бурханаас эмээж, муугаас зайлах зам нь Иовын нэрээр хаяглагдсан ба бусад хүнд ямар ч хамаагүй мэт үүнийг зөвхөн Иов л хийх ёстой гэж боддог. Үүний шалтгаан тодорхой: Учир нь, зөвхөн Иов л үнэнч, зөөлөн сэтгэлтэй, шулуун шударга агаад шударга ёс, зөвт байдал болон эерэг зүйлсийг хайрладаг зан чанартай байсан, тиймээс зөвхөн Иов л Бурханаас эмээж, муугаас зайлах замыг дагаж чадсан. Та нар бүгдээрээ энд буй цаад учрыг ойлгосон байх ёстой—үнэнч, өрөвч зөөлөн, шулуун шударга агаад шударга ёс, зөвт байдал болон эерэг зүйлийг хайрладаг хүн чанарыг хэн ч эзэмшээгүй учраас хэн ч Бурханаас эмээж, муугаас зайлж чадахгүй, тиймээс хүмүүс хэзээ ч Бурханы баяр баяслыг олж авч, шалгалтуудын дунд бат зогсож чадахгүй юм. Энэ нь бас, Иовоос бусад бүх хүн мөн л Сатанд хүлэгдэж, урхидуулсан хэвээр байгаа; тэд бүгд Сатанд буруушаагдаж, довтлуулж, доромжлогддог. Сатан тэднийг залгих гэж оролддог, тэд бүгд Сатанд олзлогдсон эрх чөлөөгүй хоригдлууд гэсэн утгатай юм.

Зүрх сэтгэл нь Бурхантай дайсагнадаг бол хүн яаж Бурханаас эмээж, муугаас зайлж чадах билээ?

Нэгэнт өнөөгийн хүмүүс Иовынхтой адил хүн чанарыг эзэмшээгүй болохоор тэдний уг чанар-мөн чанар ба Бурханд хандах хандлага нь ямар вэ? Тэд Бурханаас эмээдэг үү? Тэд муугаас зайлдаг уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаггүй хүмүүсийг хоёр үгээр дүгнэн хэлж болно: “Бурханы дайснууд”. Та нар энэ хоёр үгийг үргэлж хэлдэг боловч жинхэнэ утга учрыг нь ерөөсөө мэдээгүй. “Бурханы дайснууд” гэсэн үгэнд мөн чанар байдаг: Энэ нь Бурхан хүнийг дайснаа гэж хардаг гээгүй, харин хүн Бурханыг дайснаа гэж хардаг. Нэгдүгээрт, хүмүүс Бурханд итгэж эхлэх үедээ өөрийн зорилго, далд санаа, хүсэл эрмэлзэлгүй хэн байх билээ? Хэдийгээр тэдний нэг хэсэг нь Бурханы оршин тогтнолд итгэж, Бурханы оршин тогтнолыг

харсан ч гэсэн Бурханд итгэх итгэл нь мөн л тэдгээр далд санааг агуулдаг хэвээр бөгөөд Бурханд итгэх эцсийн зорилго нь Түүний ерөөлийг болон өөрсдийн хүссэн зүйлийг хүртэх явдал байдаг. Хүмүүсийн амийн туршлагаас харвал, “Би Бурханы төлөө гэр бүл, ажил мэргэжлээ хаясан, гэтэл Тэр надад юу өгсөн юм бэ? Би үүнийг базаж дүгнээд батлах ёстой—би саяхан ямар нэг ерөөл хүртсэн бил үү? Би энэ хугацаанд маш ихийг өгсөн, би гүйж гүйж, бас их зовлоо—хариуд нь Бурхан надад амлалт өгсөн үү? Тэр миний сайн үйлийг санасан уу? Миний төгсгөл ямар байх бол? Би Бурханы ерөөлийг хүртэж чадах болов уу?…” гэж тэд дотроо үргэлж боддог. Хүн бүхэн зүрх сэтгэлдээ байнга ийм тооцоо хийж, өөрсдийн санаархал, жолоогүй хүсэл, өгөө авааталй бодол агуулсан шаардлагыг Бурханд тавьдаг. Өөрөөр хэлбэл, хүн зүрх сэтгэлдээ үргэлж Бурханыг туршиж, Бурханы талаар байнга төлөвлөгөө зохиож, өөрийнхөө төгсгөлийн төлөө Бурхантай байнга маргалдаж, мөн Бурхан хүссэн зүйлийг нь өгч чадах эсэхийг харахын тулд Бурханаас үг авах гэж оролддог. Бурханыг эрэлхийлж байхдаа хүн Бурханыг Бурхан гэж үзэж ханддаггүй. Хүн үргэлж Бурхантай наймаацах гэж оролдож, Түүнээс тасралтгүй юм шаардаж, тэр ч байтугай алхам бүрдээ Түүнийг шахаж, гар бариад бугуй барих гэж оролддог. Бурхантай наймаацах гэж оролдохын зэрэгцээ хүн бас Түүнтэй маргадаг бөгөөд өөрсдөд нь шалгалт тулгарч, эсвэл хэцүү байдалд орсноо мэдвэл ихэнхдээ сул дорой, идэвхгүй болж, ажилдаа назгайрч, Бурханы талаар гомдлоор дүүрдэг хүмүүс ч байдаг. Анх Бурханд итгэж эхлэх үеэсээ хүн Бурханыг элбэг дэлбэгийн бэлгэдэл эвэр, Швейцарийн армийн хутга хэмээн үзэж, өөрийгөө Бурханы хамгийн агуу зээлдүүлэгч гэж үзээд, Бурханаас ерөөл болон амлалт авах гэж оролдох нь түүний төрөлхийн эрх, үүрэг, харин хүнийг хамгаалж, халамжлан, түүнийг хэрэгтэй зүйлээр хангах нь Бурханы хариуцлага мэт байдаг. Энэ нь Бурханд итгэдэг бүх хүний “Бурханд итгэх итгэлийн” талаарх үндсэн ойлголт бөгөөд Бурханд итгэх ухагдахууны талаарх хамгийн гүнзгий ойлголт нь юм. Хүний уг чанар-мөн чанараас түүний бодит эрэл хайгуул хүртэл Бурханаас эмээхтэй холбоотой юу ч байдаггүй. Бурханд итгэх хүний зорилго нь Бурханыг шүтэн мөргөхтэй ямар ч хамаагүй байж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл, Бурханд итгэх итгэл нь Бурханаас эмээж, Бурханыг шүтэн мөргөхийг шаарддаг гэдгийг хүн хэзээ ч авч үзээгүй, мөн ойлгоогүй. Тийм байдалд хүний мөн чанар илэрхий байдаг. Энэ мөн чанар нь юу вэ? Энэ бол хүний зүрх сэтгэл хорлонтой, хар санаа, заль мэх өвөрлөдөг, шударга ёс, зөвт байдал, эерэг зүйлд дургүй бөгөөд жигшмээр бөгөөд шуналтай чанар юм. Хүний зүрх сэтгэл Бурханд үүнээс илүү хаалттай байж яахин чадна; тэр үүнийг Бурханд огтхон ч өгөөгүй. Бурхан хүний үнэн зүрх сэтгэлийг хэзээ ч хараагүй, мөн хүн Түүнийг хэзээ ч шүтэн мөргөөгүй. Бурхан хэчнээн их төлөөс төлсөн ч, хэчнээн их ажил хийсэн ч, эсвэл Тэр хүнийг хэчнээн их зүйлээр хангасан ч хамаагүй хүн нүдэн балай байж, огт хайхрамжгүй хэвээр үлддэг. Хүн зүрх сэтгэлээ хэзээ ч Бурханд өгөөгүй, өөрийнхөө зүрх сэтгэлийг өөрөө мэдэж, шийдвэрээ өөрөө гаргахыг л хүсдэг—үүний цаад утга нь бол хүн Бурханаас эмээж,

муугаас зайлах замыг дагахыг хүсдэггүй, Бурханы дээд эрх, зохицуулалтад дуулгавартай байхыг хүсдэггүй, мөн Бурханыг Бурхан хэмээн шүтэн мөргөхийг хүсдэггүй гэсэн үг. Хүний өнөөдрийн байгаа байдал ийм юм. Одоо Иовыг дахин харцгаая. Юуны түрүүнд, тэр Бурхантай тохиролцоо хийсэн үү? Бурханаас эмээж, муугаас зайлах замыг чанд баримтлахдаа далд санаа агуулж байсан уу? Тэр үед Бурхан, ирж буй төгсгөлийн талаар хэн нэгэнд хэлсэн үү? Тэр үед Бурхан, төгсгөлийн талаар хэнд ч амлалт өгөөгүй бөгөөд ийм байхад л Иов Бурханаас эмээж, муугаас зайлж чадсан юм. Өнөөдрийн хүмүүс Иовтой харьцуулах хэмжээнд хүрэх үү? Хэтэрхий их ялгаа бий; тэд өөр өөр чанартай. Хэдийгээр Иов Бурханы талаар их мэдлэгтэй байгаагүй ч зүрх сэтгэлээ Бурханд өгсөн ба зүрх сэтгэл нь Бурханд харьяалагдаж байсан. Тэр хэзээ ч Бурхантай наймаацаж байгаагүй, Бурханаас хэтэрхий ихийг хүсэж, шаардаж байгаагүй; тэгэхийн оронд “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа” гэж итгэдэг байсан. Энэ нь олон жилийн амьдралынхаа туршид Бурханаас эмээж, муугаас зайлах замд үнэнч байснаар түүний харж, олж авсан зүйл юм. Түүнчлэн “Бид Бурханы гараас сайныг хүлээн аваад мууг хүлээн авахгүй юу?” гэсэн үгээр төлөөлүүлсэн үр дүнг олж авсан. Энэ хоёр өгүүлбэр нь, туулсан амьдралынхаа явцад Бурханд дуулгавартай байсан хандлагынхаа үр дүнд түүний харж, мэдэж авсан зүйл байсан ба тэдгээр нь мөн Сатаны сорилтыг ялан дийлэхэд хамгийн хүчтэй зэвсэг болж, Бурханыг гэрчлэх гэрчлэлдээ бат зогсох суурь нь болсон юм. Энэ мөчид та нар Иовыг хайр татам хүн гэж төсөөлж байна уу? Та нар тийм хүн болно гэж найдаж байна уу? Та нар Сатаны сорилтыг туулахаас айж байна уу? Иовынхтой адилхан шалгалтуудыг өөрсөддөө тулгах талаар Бурханд залбирах гэж шийдсэн үү? Ихэнх хүн ийм маягаар залбирч зүрхлэхгүй нь эргэлзээгүй. Тэгэхээр та нарын итгэл өрөвдмөөр өчүүхэн гэдэг нь илэрхий; Иовтой харьцуулбал, та нарын итгэлийг ер дурдахын ч хэрэггүй. Та нар Бурханы дайснууд, та нар Бурханаас эмээдэггүй, Бурханд өгөх гэрчлэлдээ бат зогсох чадваргүй бөгөөд Сатаны дайралт, буруушаалт, сорилтуудыг ялах чадваргүй. Та нарыг юу Бурханы амлалтыг хүлээж авах эрхтэй болгож байгаа юм бэ? Иовын түүхийг сонсож, хүнийг аврах Бурханы санаа болон хүний авралын утга учрыг ойлгоод та нарт одоо Иовынхтой адил шалгалтуудыг хүлээн авах итгэл байна уу? Бурханаас эмээж, муугаас зайлах замыг дагахыг өөрсдөдөө зөвшөөрөх бага ч гэсэн шийдвэр та нарт байх ёстой биш гэж үү?

Бурханы шалгалтын тухай бүү эргэлз

Шалгалтуудынх нь төгсгөлд Иовоос гэрчлэл хүлээн авсны дараа Бурхан Иовтой адилхан хүмүүсээс бүрдсэн нэг бүлэг хүмүүсийг, эсвэл нэг бүлгээс илүү олон хүнийг олж авна гэж шийдсэн, гэхдээ Сатан Бурхантай мөрийцөж, Иовыг сорьж, дайрч, хорлосон шиг аргаа хэрэглэн өөр ямар ч хүнийг дайрч, хорлохыг Сатанд хэзээ ч дахин зөвшөөрөхгүй гэж шийдсэн; сул дорой, тэнэг, мунхаг хүнд дахин хэзээ ч тийм зүйл хийхийг Бурхан Сатанд зөвшөөрөөгүй—Сатан Иовыг

сорьсон нь хангалттай байв! Хүмүүсийг зоргоороо хорлохыг Сатанд зөвшөөрөөгүй нь Бурханы өршөөл билээ. Бурханы хувьд Иов Сатаны сорилт болон хүчирхийллийг амсаж зовсон нь хангалттай байсан юм. Бурхан, Сатанд дахин хэзээ ч ийм зүйл хийхийг зөвшөөрөөгүй, учир нь Бурханыг дагадаг хүмүүсийн амь болон бүх зүйлийг Бурхан захирч, зохион байгуулдаг бөгөөд Бурханы сонгосон хүмүүсийг хүссэнээрээ ашиглах эрх Сатанд байдаггүй—та нар энэ зүйлийн талаар тодорхой мэдэж байх ёстой! Бурхан хүний сул талд санаа тавьж, тэнэг зан, мэдлэггүй байдлыг нь ойлгодог. Хэдийгээр хүнийг бүрэн аврахын тулд Бурхан түүнийг Сатаны гарт өгөх ёстой боловч Сатан хүнийг хууран мэхэлж, зовоож байхыг нь Бурхан харах хүсэлгүй бөгөөд хүн үргэлж зовж байгааг харахыг хүсдэггүй. Хүнийг Бурхан бүтээсэн ба Бурхан хүний бүх зүйлийг захирч, зохицуулдаг нь тун жам ёсны, үндэслэлтэй зүйл; энэ нь Бурханы хариуцлага, бүх зүйлийг захирдаг Бурханы эрх мэдэл юм! Хүнийг хүссэнээрээ хорлож, мууг нь үзэхийг Бурхан Сатанд зөвшөөрдөггүй, хүний замыг алдуулахын тулд янз бүрийн арга бач хэрэглэхийг Бурхан Сатанд зөвшөөрдөггүй, цаашлаад, хүнийг захирах Бурханы дээд эрхэд саад болохыг Сатанд зөвшөөрдөггүй, мөн хүн төрөлхтнийг удирдах, аврах Бурханы агуу ажлыг бүү хэл, бүх зүйлийг захирахдаа баримтладаг хууль дүрмийг дэвслэн сүйтгэхийг Сатанд зөвшөөрдөггүй! Бурханы аваръя гэсэн хүмүүс болон Бурханд гэрчлэл хийж чадах хүмүүс нь Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний гол цөм ба биежилт, түүнчлэн зургаан мянган жилийн ажилдаа зориулсан Түүний хичээл чармайлтын үнэ юм. Бурхан энэ хүмүүсийг Сатанд санаандгүй өгч хэрхэн чадах билээ?

Хүмүүс Бурханы шалгалтад үргэлж санаа зовж, эмээдэг атлаа дандаа Сатаны урхинд амьдарч, Сатанд довтлуулж, хүчирхийлүүлдэг аюултай орчинд амьдарч байна—гэхдээ тэд айдсыг мэдэхгүй, амарлингуй байдаг. Юу болоод байна вэ? Бурханд итгэх хүний итгэл зөвхөн өөрийнх нь харж чадах зүйлсээр л хязгаарлагддаг. Тэрээр хүнийг гэсэн Бурханы хайр, зовнил, хүнд тавих Түүний өрөвч сэтгэл, анхаарал халамжийг өчүүхэн төдий ч үнэлдэггүй. Харин хүн Бурханы шалгалт, шүүлт, гэсгээлт, сүр жавхлан, уур хилэнгийн талаар бага зэрэг айдас, түгшүүртэй байдгаас биш Бурханы сайн санааны талаар өчүүхэн ч ойлголтгүй байдаг. Шалгалтын талаар дурдахад Бурхан далд сэдэл агуулж байгаа мэт хүмүүст санагддаг, тэр ч байтугай зарим нь Бурхан хорон муу санаа өвөрлөдөг гэж итгэдэг бөгөөд Бурхан тэдэнд яг юу хийх гэж байгааг мэддэггүй; тиймээс, Бурханы дээд эрх болон зохицуулалтад дуулгавартай байх тухай хашхирахын зэрэгцээ хүнийг захирах Бурханы дээд эрх болон хүнийг гэх Бурханы зохицуулалтыг эсэргүүцэж, тэрслэхийн тулд чадах бүхнээ хийдэг, учир нь хэрвээ тэд анхааралтай байхгүй бол Бурхан тэднийг төөрөгдүүлэх болно, хэрвээ тэд өөрсдийн хувь заяаг захирахгүй бол тэдэнд байгаа бүхнийг Бурхан авч, тэдний амь төгсөж ч болох юм гэж тэд итгэдэг. Хүн Сатаны баазад байдаг, гэхдээ тэр Сатанд хүчирхийлүүлж байгаа

талаараа хэзээ ч санаа зовдоггүй бөгөөд Сатанд хүчирхийлүүлдэг мөртлөө Сатанд олзлогдохоос хэзээ ч айдаггүй. Хүн, Бурханы авралыг хүлээн зөвшөөрч байна гэж хэлээд л байдаг мөртлөө хэзээ ч Бурханд итгээгүй, эсвэл Бурхан хүнийг үнэхээр Сатаны савраас аврах болно гэж итгээгүй. Хэрвээ хүн Иовтой адилаар Бурханы зохион байгуулалт болон зохицуулалтад захирагдаж, өөрийн бүхий л оршихуйг Бурханы гарт өгч чадах юм бол хүний төгсгөл Иовынхтой адил байж—Бурханы ерөөлийг хүлээж авахгүй гэж үү? Хэрвээ хүн Бурханы дээд эрхийг хүлээн зөвшөөрч, захирагдаж чадах юм бол алдах зүйл юу байна вэ? Тиймээс та нар үйлдлээ анхаарч, өөрт тохиолдох гэж буй бүх зүйлд болгоомжтой хандаж бай гэж Би зөвлөж байна. Бүү яарч, уулгамчил, мөн Бурханд болон та нарын төлөө Түүний зохицуулсан хүмүүс, аливаа үйл явдал болон юманд өөрийн түргэн зангаар, өөрийн зөнгөөр, эсвэл өөрийн төсөөлөл, үзлээр бүү ханд; та нар үйлдэлдээ болгоомжтой байх ёстой ба Бурханы уур хилэнг хүргэхээс зайлсхийхийн тулд залбирч, илүү их эрж хайх ёстой гэж Би зөвлөж байна. Үүнийг санаж яв!

Дараа нь бид, шалгалтын дараа Иов ямар байсныг харах болно.

5. Шалгалтын дараах Иов

Иов 42:7–9 Тэгээд Ехова эдгээр үгийг Иовд айлдсаныхаа дараа, теман хүн Елифазад хэлсэн нь: “Та нар Миний тухай Миний зарц Иовын ярьсан шиг зөв зүйл яриагүйн учир чамд болон чиний хоёр нөхөрт Миний уур хилэн асаж байна. Тийм учраас одоо долоон бух, долоон хуц өөрсөддөө авч, мөн Миний зарц Иов дээр очиж, өөрсдийнхөө төлөө шатаалт тахил өргө; Миний зарц Иов та нарын төлөө залбирна: Би түүнийг хүлээн зөвшөөрсөн тул тэнэглэсний чинь улмаас та нарыг шийтгэхгүй. Та нар Миний тухай Миний зарц Иовын ярьсан шиг зөв зүйл яриагүй” гэв. Тиймээс теман хүн Елифаз болон шух хүн Билдад, наамат хүн Зофар гарч, Еховагийн тушаасан ёсоор хийв: Ехова Иовыг хүлээн зөвшөөрөв.

Иов 42:10 Тэгээд түүнийг найз нөхдийнхөө төлөө залбирахад нь Ехова Иовыг урьдын байснаар нь сэргээв: Ехова бас Иовд өмнөхөөс нь хоёр дахин ихийг өгчээ.

Иов 42:12 Иймээс Ехова Иовын сүүлчийн өдрүүдийг эхэн үеэс нь илүүгээр ерөөжээ: учир нь тэр арван дөрвөн мянган хонь, зургаан мянган тэмээ, нэг мянган буулгат хос шар, мөн нэг мянган эм илжигтэй байлаа.

Иов 42:17 Иов өтөлж, өдөр хоногоо гүйцээгээд өөд болов.

Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүмүүсийг Бурхан нандигнадаг, харин мунхаг хүмүүсийг Бурхан дорд үздэг

Иов 42:7–9-д Бурхан Иовыг Өөрийн зарц гэж хэлсэн. Тэр Иовын тухай дурдахдаа “зарц” гэдэг нэр томьёог ашигласан нь Түүний зүрх сэтгэл дэх Иовын ач холбогдлыг харуулсан; хэдийгээр Бурхан Иовыг илүү хүндэтгэлтэйгээр нэрлээгүй ч гэсэн энэ нэршил нь Бурханы зүрх сэтгэл дэх Иовын үнэ цэнд нөлөөлөөгүй. Энд байгаа “зарц” гэдэг нь Иовд Бурханы өгсөн, өхөөрдсөн нэр байсан юм. “Миний зарц

Иов” хэмээн Бурхан хэд хэдэн удаа дурдсан нь Иовд хэчнээн сэтгэл хангалуун байсныг нь харуулж байна. Хэдийгээр Бурхан “зарц” хэмээх үгийн цаад утгыг хэлээгүй ч гэсэн “зарц” гэдэг үгийн талаарх Бурханы тайлбарыг Библийн энэ эшлэлд дурдсан үгээс нь харж болно. Бурхан эхлээд теман хүн Елифазд “Та нар Миний тухай Миний зарц Иовын ярьсан шиг зөв зүйл яриагүйн учир чамд болон чиний хоёр нөхөрт Миний уур хилэн асаж байна” гэж хэлсэн. Эдгээр үг нь түүнд ноогдсон Бурханы шалгалтуудын дараах Иовын хэлсэн, хийсэн бүхнийг сайшаан зөвшөөрсөн гэдгээ Бурхан хүмүүст ил тод хэлсэн анхны тохиолдол байсан ба Иовын хэлсэн, хийсэн бүхний үнэн зөв, алдаа мадаггүй байдлыг Тэр ил тод нотолсон анхны тохиолдол байсан юм. Тэдний буруу, учир утгагүй үг ярианы улмаас Бурхан Елифаз болон бусдад нь уурласан, яагаад гэвэл, тэд Иовын нэгэн адил амьдралдаа Бурханы илрэлтийг хараагүй, Түүний хэлсэн үгийг сонсоогүй байсан боловч Иов Бурханы талаар тийм нарийн зөв мэдлэгтэй байхад тэд Бурханы тухай зөвхөн сохроор таамаглаж, Бурханы хүслийг зөрчиж, хийдэг бүхнээрээ Түүний зэвүүг хүргэсэн. Үүнээс үүдэн Бурхан, Иовын хэлсэн, хийсэн бүхнийг сайшаахын зэрэгцээ бусдад нь хилэгнэх болсон, учир нь Бурханаас эмээх ямар ч бодит байдлыг Тэр тэднээс олж харж чадаагүйгээр үл барам, тэдний хэлж ярьж байгаад Бурханаас эмээсэн зүйл огт байхгүй байгааг мөн сонссон юм. Иймээс Бурхан дараа нь тэдэнд доорх шаардлагыг тавьсан: “Тийм учраас одоо долоон бух, долоон хуц өөрсөддөө авч, мөн Миний зарц Иов дээр очиж, өөрсдийнхөө төлөө шатаалт тахил өргө; Миний зарц Иов та нарын төлөө залбирна: Би түүнийг хүлээн зөвшөөрсөн тул тэнэглэсний чинь улмаас та нарыг шийтгэхгүй.” Энэ эшлэлд Бурхан Елифаз болон бусдад нь өөрсдийн нүглийг наманчлах зүйл хий гэж хэлсэн, учир нь тэдний тэнэглэл бол Ехова Бурханы эсрэг нүгэл байсан бөгөөд тиймээс тэд алдаагаа засахын тулд шатаалт тахил өргөх хэрэгтэй болжээ. Шатаалт тахилыг үргэлж Бурханд өргөдөг, гэхдээ эдгээр шатаалт тахилын тухайд юу ер бусын байна вэ гэвэл, тэдгээрийг Иовд өргөсөн юм. Иов шалгалтуудын үеэр Бурханд гэрчлэл хийсэн учраас Бурхан сайшаасан. Харин тэгэхэд Иовын эдгээр нөхөд түүний шалгалтын үеэр илчлэгдсэн; өөрсдийн тэнэглэлийн улмаас тэд Бурханд яллагдаж, Бурханы уур хилэнг хүргэсэн бөгөөд Бурханд шийтгүүлэх ёстой болсон—Иовын өмнө шатаалт тахил өргөж шийтгүүлсэн—үүний дараа тэдэнд ирсэн Бурханы шийтгэл, уур хилэнг арилгахын тулд Иов тэдний төлөө залбирсан юм. Бурханы санаа нь тэдэнд ичгүүр авчрах явдал байсан, учир нь тэд Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүмүүс байгаагүй бөгөөд тэд Иовын шударга чанарыг зэмлэсэн. Нэг талаар, Бурхан тэдний үйлдлийг сайшаагаагүй боловч Иовыг ихэд сайшааж, таашааж байсан гэдгээ тэдэнд хэлж байсан; нөгөө талаар, Бурханд сайшаагдан зөвшөөрөгдөх нь хүнийг Бурханы өмнө өргөдөг, хүн өөрийн тэнэглэлийн улмаас Бурханд жигшигддэг, үүний улмаас Бурханыг гомдоодог бөгөөд Бурханы нүдэнд дорд агаад өөдгүй үзэгддэг гэдгийг Бурхан тэдэнд хэлж байсан. Эдгээр нь хоёр өөр төрлийн хүнд өгсөн Бурханы тодорхойлолт, мөн энэ хоёр төрлийн хүнд хандах

Бурханы хандлага бөгөөд энэ хоёр төрлийн хүний үнэ цэн, нэр хүндийн талаарх Бурханы илэрхийлэл билээ. Хэдийгээр Бурхан Иовыг Өөрийн зарц хэмээн нэрлэсэн ч, Бурханы нүдэнд энэхүү зарц нь хайрлагдсан бөгөөд бусдын төлөө залбирч, тэдний алдааг уучлах эрх мэдэл хүртсэн байсан юм. Энэ зарц нь Бурхантай шууд ярилцаж, Бурханы өмнө шууд ирж чаддаг байсан ба байр суурь нь бусад хүмүүсийнхээс илүү өндөр, илүү хүндтэй байв. Энэ нь Бурханы хэлсэн “зарц” хэмээх үгийн жинхэнэ утга учир юм. Бурханаас эмээж, муугаас зайлдаг учраас Иов ийм онцгой алдар хүнд хүртсэн бөгөөд бусад нь яагаад Бурханд зарц гэж дуудуулаагүйн шалтгаан гэвэл, тэд Бурханаас эмээж, муугаас зайлдаггүй байсан юм. Бурханы илт хоёр өөр энэ хандлага нь хоёр төрлийн хүнд хандах Түүний хандлага юм: Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүмүүс Бурханд сайшаагдан зөвшөөрөгдөж, Түүний нүдэнд үнэ цэнтэй харагддаг байхад мулгуу хүмүүс Бурханаас эмээдэггүй, муугаас зайлах чадваргүй ба Бурханы тааллыг хүртэж чаддаггүй; тэд үргэлж Бурханд жигшигдэж, яллагддаг ба Бурханы нүдэнд дорд үзэгддэг.

Бурхан Иовд эрх мэдэл олгосон нь

Иов нөхдийнхөө төлөө залбирсан ба дараа нь Иовын залбирлын ачаар Бурхан тэдэнтэй тэнэглэлд нь тааруулж харьцаагүй—Тэр тэднийг шийтгээгүй, тэдэнд ямар нэг залхаан цээрлүүлэлт хүртээгээгүй. Яагаад тэр вэ? Учир нь, Бурханы зарц Иовын тэдний төлөө хийсэн залбирал Түүний чихэнд хүрсэн; Иовын залбирлыг хүлээн авсан учраас Бурхан тэднийг уучилсан. Тэгэхээр, бид эндээс юу харж байна вэ? Бурхан хүнийг ерөөх үедээ олон шагнал өгдөг, энэ нь зөвхөн эд зүйл байдаггүй: Бурхан тэдэнд эрх мэдэл өгч, бусдын төлөө залбирах эрх олгодог ба эдгээр залбирлыг сонсдог учраас Бурхан тэр хүмүүсийн гэм бурууг мартаж, тоолгүй орхидог. Энэ нь Бурханы Иовд өгсөн яг тэр эрх мэдэл юм. Тэднийг яллахыг болиулах гэсэн Иовын залбирлаар Ехова Бурхан тэр мулгуу хүмүүст ичгүүр авчирсан—энэ нь мэдээжээр, Елифаз болон бусдад нь өгсөн Түүний онцгой шийтгэл байсан юм.

Иов дахин нэг удаа Бурханд ерөөгдөж, Сатанд дахин хэзээ ч буруушаагдаагүй

Ехова Бурханы айлдварт “Та нар Миний тухай Миний зарц Иовын ярьсан шиг зөв зүйл яриагүй” гэсэн үг байсан. Иовын хэлсэн зүйл юу байсан бэ? Энэ бол бидний өмнө нь ярьсан зүйл бөгөөд түүнчлэн Иовын Номд Иовыг хэлсэн гэж тэмдэглэсэн олон хуудас үг юм. Эдгээр олон хуудас үгэнд Иов Бурханы талаар ямар нэгэн гомдол, сэжиг ганц ч удаа хэлээгүй. Тэр зүгээр л үр дүнг хүлээдэг. Энэ хүлээлт нь түүний дуулгавартай байдлын хандлага бөгөөд үүний үр дүнд болон Бурханд хэлсэн үгийнхээ үр дүнд Иов Бурханд сайшаагдсан юм. Түүнийг шалгалт туулж, зовлон бэрхшээл амсаж байх үед Бурхан түүний хажууд байсан бөгөөд

Бурхан дэргэд нь байснаар түүний зовлон багасаагүй хэдий боловч Бурхан харахыг хүссэн зүйлээ харж, сонсохыг хүссэн зүйлээ сонссон. Иовын үйлдэл, үг нэг бүр Бурханы нүд, чихэнд хүрсэн; Бурхан сонссон, Бурхан харсан—энэ бол баримт. Тэр хугацаанд Бурханы талаарх Иовын мэдлэг, түүний зүрх сэтгэл дэх Бурханы тухай бодол нь тэр үед үнэндээ өнөөгийн хүмүүсийнхтэй адил тодорхой биш байсан боловч тухайн үеийн нөхцөлд Бурхан Иовын хэлсэн бүхнийг мөн л хүлээн зөвшөөрсөн, учир нь түүний ааш авир, зүрх сэтгэл дэх бодол болон илчилж, илэрхийлж байсан зүйл нь Түүний шаардлагад хангалттай байсан юм. Иовд шалгалт тулгарах хугацаанд түүний зүрх сэтгэлдээ бодсон зүйл болон хийхээр шийдсэн зүйл Бурханд үр дүн харуулсан, үүнд нь Бурхан сэтгэл ханамжтай байсан ба үүний дараа Бурхан Иовын шалгалтыг болиулж, Иов өөрийн зовлон бэрхшээлээс өндийн гарч ирсэн бөгөөд түүний шалгалтууд үгүй болж, түүнд дахин хэзээ ч тохиолдоогүй. Иов аль хэдийн шалгалтад орж, эдгээр шалгалтын явцад бат зогсож, Сатаныг бүрэн ялан дийлсэн учраас хүртэх эрхтэй ерөөлүүдийг нь Бурхан түүнд өгсөн юм. Иов 42:10, 12-т бичигдсэнээр Иов дахиж ерөөгдсөн ба эхний удаагийнхаасаа ч илүү ихээр ерөөгджээ. Энэ үед Сатан холдон явсан бөгөөд цаашид юу ч хэлж, юу ч хийгээгүй, тэр үеэс хойш Сатан Иовд саад учруулаагүй, дайрч довтлоогүй, Сатан Иовд өгсөн Бурханы ерөөлийг дахиж буруушаагаагүй.

Иов амьдралынхаа сүүлийн хагасыг Бурханы ерөөл дунд өнгөрөөжээ

Хэдийгээр тэр үед Бурханы ерөөл зөвхөн хонь, үхэр, тэмээ, эд хөрөнгө гэх мэт зүйлээр хязгаарлагдаж байсан боловч Иовд хүртээхийг зүрх сэтгэлдээ хүсэж байсан Бурханы ерөөл үүнээс хавьгүй их байсан юм. Тэр үед Бурхан Иовд ямар төрлийн мөнхийн амлалтууд өгөхийг хүсэж байсан талаар тэмдэглэсэн байдаг уу? Иовд өгсөн ерөөлдөө Бурхан түүний төгсгөлийг дурдаж, цухуйлгаагүй ба Бурханы зүрх сэтгэлд Иов хэр зэрэг чухал, эсвэл ямар байр суурьтай байсныг үл харгалзан ерөнхийдөө, Бурхан Өөрийн ерөөлийг тун хэмжээ хязгаартай байлгасан. Бурхан Иовын төгсгөлийг зарлаагүй. Энэ юу гэсэн үг вэ? Тэр үед Бурханы төлөвлөгөө хүний төгсгөлийг тунхаглах цэгт хараахан хүрээгүй байсан бөгөөд төлөвлөгөө нь Түүний ажлын сүүлчийн үе шатанд хараахан ороогүй байхад Бурхан зүгээр л эд хөрөнгийн ерөөлийг хүнд хүртээгээд, төгсгөлийн талаар огт дурдаагүй. Энэ нь ямар утгатай вэ гэхээр Иовын амьдралын сүүлийн хагас Бурханы ерөөл дунд өнгөрсөн бөгөөд үүгээрээ тэр бусад хүнээс өөр байсан—гэхдээ тэр бусдын л адил хөгширсөн ба ямар ч жирийн хүний нэгэн адил хорвоотой салах ёс хийх өдөр түүнд ирсэн. Тиймээс “Иов өтөлж, өдөр хоногоо гүйцээгээд өөд болов” (Иов 42:17) хэмээн тэмдэглэсэн байна. Энд байгаа “өдөр хоногоо гүйцээгээд өөд болов” гэдэг нь ямар утгатай вэ? Бурхан хүмүүсийн төгсгөлийг тунхаглахаас өмнөх эрин үед Бурхан, Иовд амьдрах нас тогтоосон байсан бөгөөд тэр насаа наслаад энэ дэлхийгээс жамаараа одох боломжийг Иовд олгосон юм. Иовын хоёр дахь ерөөлөөс насан эцэслэх хүртэл нь Бурхан түүнд ямар ч зовлон бэрхшээл нэмээгүй. Бурханы хувьд

Иовын үхэл жам ёсны бөгөөд бас шаардлагатай байсан; энэ нь маш энгийн зүйл бөгөөд шүүлт ч биш, ял зэмлэл ч биш байсан юм. Иов амьд байхдаа Бурханыг шүтэн мөргөж, Бурханаас эмээдэг байсан; үхсэнийх нь дараа түүнд ямар төрлийн төгсгөл ирсэн талаар Бурхан юу ч хэлээгүй ба энэ талаар тайлбар ч хийгээгүй. Бурхан хэлж, хийж байгаа зүйлдээ ёс зүйн өндөр мэдрэмжтэй байдаг бөгөөд Түүний үг ба үйлдлийн агуулга, зарчим нь Түүний ажлын үе шат болон Түүний ажиллаж байгаа цаг хугацааны дагуу байдаг. Иов шиг ийм хүн Бурханы зүрх сэтгэлд ямар төрлийн төгсгөлтэй байсан бэ? Бурхан Өөрийн зүрх сэтгэлд ямар нэгийг шийдсэн байсан уу? Мэдээж, Тэр тэгсэн! Энэ нь зүгээр л хүнд мэдэгдээгүй; Бурхан хүнд хэлэхийг ч хүсээгүй, хүнд хэлэх санаа ч байгаагүй. Тиймээс өнгөцхөн хэлэхэд, Иов хоногоо гүйцээгээд өөд болсон ба Иовын амьдрал ийм л байсан юм.

Бүхий л амьдралдаа Иовын амьдран харуулсан үнэ цэн

Иов үнэ цэнтэй амьдралаар амьдарсан уу? Үнэ цэн нь хаана байсан бэ? Түүнийг үнэ цэнтэй амьдралаар амьдарсан гэж яагаад хэлдэг вэ? Хүний хувьд, түүний үнэ цэн юу байсан бэ? Хүний үзэл бодлоос харвал, Сатан болон дэлхийн хүмүүсийн өмнө Бурханд жинтэй гэрчлэл хийснээрээ тэрээр Бурханы аврахыг хүсдэг хүн төрөлхтнийг төлөөлсөн. Тэгээд Бурханы бүтээлийн биелүүлэх учиртай үүргийг биелүүлж, үлгэр дуурайл үзүүлж, Бурханы аврахыг хүссэн бүх хүний хувьд үлгэр жишээ болж, Бурханд итгэж найдсанаар Сатаныг ялах бүрэн боломжтой гэдгийг харах боломжийг хүмүүст олгосон юм. Бурханы хувьд, түүний үнэ цэн юу байсан бэ? Бурханы хувьд, Иовын амьдралын үнэ цэн нь Бурханаас эмээх, Бурханыг шүтэн мөргөх, Бурханы үйл хэргийг гэрчлэх, Бурханы үйл хэргийг магтан алдаршуулах, Бурханд тав тух болон баярлуулах зүйл авчрах чадварт нь оршиж байсан; Бурханы хувьд, Иовын амьдралын үнэ цэн нь насан эцэслэхээсээ өмнө Иов хэрхэн шалгалт туулж, Сатаныг ялж, Сатан болон дэлхийн хүмүүсийн өмнө Бурханд цангинасан гэрчлэлд хийсэнд оршиж байсан, ингэснээр Бурхан хүн төрөлхтний дунд алдрыг олж авч, зүрх сэтгэлээ тайтгаруулан, Өөрийн хүсэн тэмүүлсэн зүрх сэтгэлд үр дүнг үзэж, итгэл найдварыг харсан юм. Түүний гэрчлэл нь хүн Бурханы гэрчлэлд баттай зогсох чадварын, мөн хүн төрөлхтнийг удирдах Бурханы ажилд Бурханы өмнөөс Сатаныг шившиглэж чадах жишгийг тогтоосон. Энэ нь Иовын амьдралын үнэ цэн биш гэж үү? Иов Бурханы зүрх сэтгэлд тайтгарал авчирч, алдрыг олж авахын баяр хөөрийг Бурханд урьдчилан амсуулж, Бурханы удирдлагын төлөвлөгөөг гайхалтай эхлэлээр хангасан юм. Энэ мөчөөс эхлээд Иовын нэр Бурхан алдрыг олж авсны бэлгэ тэмдэг, хүн төрөлхтөн Сатаныг ялсны тэмдэг болсон юм. Амьдралынхаа турш Иовын амьдран харуулсан зүйл болон Сатаныг ялсан түүний гайхамшигт ялалтыг Бурхан үүрд эрхэмлэх бөгөөд түүний төгс, шулуун шударга, Бурханаас эмээдэг байдлыг хойч үеийнхэн хүндэтгэн дуурайх болно. Түүнийг Бурхан өөгүй, гялалзсан сувд шиг үүрд нандигнах ба хүн ч бас түүнийг эрхэмлүүштэй юм!

Дараа нь Хуулийн эрин үеийн Бурханы ажлыг авч үзэцгээе.

IV. Хуулийн эрин үеийн хуулиуд

Арван Тушаал

Тахилын ширээ босгох зарчим

Зарц нарт хандах хууль

Хулгай ба нөхөн төлбөрийн хууль

Амралтын жил болон гурван баярыг мөрдөх нь

Амралтын өдрийн хууль

Тахилын хууль

Шатаалт тахил

Үр тарианы тахил

Эвийн тахил

Нүглийн төлөөх тахил

Гэмийн төлөөх тахил

Тахилч нарын тахилын хууль (Аарон болон түүний хөвгүүдэд үүнийг дагаж мөрдөхийг тушаасан)

Тахилч нарын өргөх шатаалт тахил

Тахилч нарын өргөх үр тарианы тахил

Тахилч нарын өргөх нүглийн төлөөх тахил

Тахилч нарын өргөх гэмийн төлөөх тахил

Тахилч нарын өргөх эвийн тахил

Тахилч нар тахилыг идэх журам

Цэвэр ба бохир амьтад (идэж болох ба болохгүй амьтад)

Хүүхэд төрүүлсний дараа эмэгтэйчүүдийн цэвэрших хууль

Уяман өвчний үзлэг хийх стандарт

Уяман өвчин нь эдгэсэн хүмүүст зориулсан хууль

Халдвартай байшинг ариутгах хууль

Хэвийн бус шүүрдсээс болж зовж буй хүмүүст зориулсан хууль

Эвлэрүүллийн өдрийг жилд нэг удаа сахиж мөрдөх ёстой

Үхэр, хонь нядлах журам

Харь үндэстнүүдийн жигшүүрт зуршлын талаарх хориг (цус ойртохгүй байх гэх мэт)

Хүмүүсийн дагах ёстой хууль (“Та нар ариун байх ёстой: учир нь та нарын Бурхан Ехова Би ариун билээ” (Леви 19:2))

Хүүхдүүдээ Молехт тахил болгон өгсөн хүмүүсийг цаазлах нь

Садар самууны гэмт хэргийг шийтгэх хууль

Тахилч нарын дагаж мөрдөх ёстой дүрэм (Тэдний өдөр тутмын зан авирын дүрэм, ариун зүйлсийг хэрэглэх дүрэм, тахил өргөх дүрэм гэх мэт)

Сахин тэмдэглэх ёстой баярууд (Амралтын өдөр, Алгасал баяр, Пентэкост, Эвлэрүүллийн өдөр гэх мэт)

Бусад хууль (Дэнлүү асаах, Эвэр бүрээдэлтийн жил, Газраа буцааж авах, Тангараг өргөх, Аравны нэгийн өргөл гэх мэт)

Хуулийн эрин үеийн хуулиуд нь Бурхан бүх хүн төрөлхтнийг удирдан чиглүүлдгийн бодит нотолгоо юм

Тэгэхээр та нар Хуулийн эрин үеийн эдгээр хууль болон зарчмыг уншлаа, тийм үү? Хууль журам өргөн хүрээг хамарч байна уу? Нэгдүгээрт, тэдгээр нь Арван Тушаалыг хамардаг, үүний дараа хэрхэн тахилын ширээ босгох гэх мэт хуулиуд байдаг. Эдгээрийн араас Амралтын өдрийг сахих болон гурван баярыг тэмдэглэх хууль, дараа нь тахилын хууль байдаг. Хэдэн төрлийн тахил байгааг та нар харсан уу? Шатаалт тахил, үр тарианы тахил, эвийн тахил, нүглийн төлөөх тахил гэх мэт байна. Тэдгээрийн дараа тахилчдын өргөдөг шатаалт тахил, үр тарианы тахил болон бусад төрлийн тахилыг оролцуулаад тахилчдын өргөх тахилын хууль байдаг. Хуулийн найм дахь багц нь тахилчид тахил идэх тухай. Тэгээд дараа нь хүмүүс амьдралдаа сахин мөрдөх ёстой зүйлсийн тухай хуулиуд байдаг. Хүмүүс юу идэж болох, юу идэж болохгүй тухай, хүүхэд төрүүлсэн эмэгтэйн цэвэршүүлэлт ба уяман өвчин нь эдгэрсэн хүмүүст зориулсан хууль гэх мэтээр хүмүүсийн амьдралын олон талд зориулсан болзол заалтууд байдаг. Эдгээр хуульд, Бурхан өвчний тухай хүртэл ярьсан бөгөөд бүр хонь, үхэр нядлах дүрэм журам гэх мэт ч байдаг. Хонь, үхрийг Бурхан бүтээсэн бөгөөд чи тэднийг Бурханы хэлснээр л нядалбал зохино; Бурханы үгэнд учир шалтгаан байдаг нь ямар ч эргэлзээгүй, Бурханы тушааснаар үйлдэх нь гарцаагүй зөв агаад хүмүүст ач тустай нь дамжиггүй! Мөн түүнчлэн Амралтын өдөр, Алгасал баяр гэх мэтийн сахин тэмдэглэх ёстой баяр, журам дүрмүүд байдаг—Бурхан энэ бүхний тухай ярьсан. Сүүлчийн хэдийг нь харцгаая: бусад хууль болох—дэнлүү асаах, эвэр бүрээдэлтийн жил, газраа буцааж авах, тангараг өргөх, аравны нэгийн өргөл гэх мэт. Эдгээр нь өргөн хүрээг хамарч байна уу? Эхний ярих зүйл бол хүмүүсийн тахилын асуудал. Тэгээд хулгай болон нөхөн төлбөрийн хууль, Амралтын өдрийг тэмдэглэх хууль байдаг…; амьдралын юм бүхэн нэг бүрчлэн багтсан байдаг. Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийн удирдлагын төлөвлөгөөний албан ёсны ажлыг эхлэх үедээ хүний дагах учиртай олон хуулийг тогтоосон. Эдгээр хууль нь хүнд, газар дээрх хүний хэвийн амьдралаар буюу Бурхан болон Түүний удирдамжаас салшгүй хэвийн амьдралаар амьдрах боломжийг хүнд олгохын тулд байсан. Бурхан эхлээд хүнд тахилын ширээ хэрхэн босгохыг, тахил яаж байрлуулахыг хэлж өгсөн. Дараа нь хэрхэн тахил өргөх талаар хүнд хэлсэн бөгөөд хүн хэрхэн амьдрахыг—амьдралдаа юуг анхаарах ёстойг, юуг сахин мөрдөх ёстойг, юу хийх ёстойг, юу хийх ёсгүйг тодорхойлон тогтоосон. Хүний төлөө Бурханы тогтоосон зүйлс бүгдийг хамарсан байсан бөгөөд эдгээр ёс заншил, хууль, зарчмаар дамжуулан Тэр хүмүүсийн зан авирыг стандартжуулж, тэдний амьдралыг залж, Бурханы хуульд ороход нь тэднийг залж, Бурханы тахилын ширээний өмнө ирэхэд нь тэднийг чиглүүлж, хүний

төлөө Бурханы бүтээсэн бүх зүйлийн дундаас эмх цэгц, дэг журам, хүлээцтэй байдлыг эзэмшсэн амьдралтай байхад нь тэднийг удирдан чиглүүлсэн. Бурхан хүнд хязгаар тогтоохын тулд анх эдгээр энгийн хууль болон зарчмыг ашигласан, тэгснээр хүн газар дээр Бурханыг шүтэн мөргөдөг хэвийн амьдралтай байх байсан, хүний хэвийн амьдралтай байх байсан; энэ нь Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний эхлэлийн онцгой агуулга юм. Хууль, дүрэм маш өргөн агуулгыг хамардаг, тэдгээр нь Хуулийн эрин үед хүн төрөлхтөнд өгсөн Бурханы удирдамжийн тодорхой зүйлс бөгөөд Хуулийн эрин үеэс өмнө байсан хүмүүс тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хүндлэх учиртай байсан, тэдгээр нь Хуулийн эрин үед Бурханы хийсэн ажлын тэмдэглэл агаад бүх хүн төрөлхтнийг удирдан залах Бурханы удирдлага, удирдамжийн бодит баталгаа билээ.

Хүн төрөлхтөн Бурханы сургаал болон хангамжаас мөнхөд салшгүй

Эдгээр хуулиас бид, Өөрийн ажилд, Өөрийн удирдлагад, мөн хүн төрөлхтөнд хандах Бурханы хандлага нь нухацтай, хянуур, нарийн чанд, хариуцлагатай байдаг гэдгийг харж болно. Тэрээр хүн төрөлхтний дунд хийх ёстой ажлаа Өөрийн алхмуудын дагуу өчүүхэн төдий ч зөрүүгүй хийж, хүн төрөлхтөнд хэлэх ёстой үгээ өчүүхэн төдий ч алдаа мадаггүй, хасаж орхилгүй айлдахдаа хүн бол Бурханы удирдлагаас салшгүй гэдгийг харах боломжийг хүнд олгож, Бурханы хийдэг, хэлдэг бүхэн хүн төрөлхтөнд хэчнээн чухал болохыг харуулдаг. Дараагийн эрин үед хүн ямар байхаас үл хамааран, хамгийн анх—Хуулийн эрин үед—Бурхан эдгээр энгийн зүйлийг хийсэн юм. Бурханы хувьд, тухайн эрин үед Бурхан, дэлхий ертөнц болон хүн төрөлхтний талаар хүмүүсийн ухагдахуун хийсвэр, ойлгомжгүй байсан ба хэдийгээр тэдэнд зарим нэг ухамсарт санаа, зорилго байсан ч гэсэн тэдгээр нь бүгд тодорхой бус, буруу байсан, тиймээс хүн төрөлхтөн тэднийг гэх Бурханы сургаал болон хангамжаас салшгүй байсан юм. Хамгийн эртний хүн төрөлхтөн юу ч мэддэггүй байсан, иймээс Бурхан амьд үлдэх хамгийн наад захын, энгийн зарчмууд болон амьдрахад шаардлагатай хуулиудыг хүнд зааж эхлэх хэрэгтэй болсон ба эдгээр зүйлийг хүний зүрх сэтгэлд бага багаар шингээсэн. Үгээс бүтсэн эдгээр хуулиар, эдгээр дүрэм журмаар дамжуулан Бурхан хүнд Өөрийнхөө талаар зугуухан ойлгуулж, Өөрийнхөө удирдлагын тухай мэдлэг, ойлголт, хүн Бурхан хоёрын хоорондын харилцааны үндсэн ухагдахууныг аажмаар өгсөн. Зөвхөн энэ үр дүнд хүрсний дараа л Бурхан бага багаар хожим хийх ажлаа хийж чадах болсон. Тиймээс эдгээр хууль болон Хуулийн эрин үед Бурханы хийсэн ажил нь хүн төрөлхтнийг аврах Түүний ажлын үндэс суурь бөгөөд Бурханы удирдлагын төлөвлөгөөн дэх ажлын эхний үе шат юм. Хуулийн эрин үеийн ажлаас өмнө Бурхан хэдийгээр Адам, Еватай болон тэдний үр удамтай ярьсан ч гэсэн тэдгээр тушаал, сургаал нь нэг бүрчлэн хүнд олгохуйц тийм ч эмхтэй, нарийн тодорхой байгаагүй ба тэдгээрийг бичиж тэмдэглээгүй, мөн тэдгээр нь хууль болоогүй. Яагаад гэвэл, тэр үед Бурханы төлөвлөгөө тийм ч хол яваагүй байсан; Бурхан хүнийг энэ алхам

руу хөтөлсөн үедээ л Хуулийн эрин үеийн эдгээр хуулийг ярьж эхлэн, тэдгээрийг хүнээр гүйцэтгүүлэн эхэлж чадах байсан юм. Энэ нь зайлшгүй үйл явц байсан ба үр дүн нь гарцаагүй байсан билээ. Эдгээр энгийн зуршил, хууль нь хүнд Бурханы удирдлагын ажлын алхмуудыг болон удирдлагын төлөвлөгөөндөө Бурханы илчилсэн мэргэн ухааныг харуулдаг. Өөрт нь гэрчлэл хийж чадах бүлэг хүмүүсийг олж авахын тулд, Өөртэй нь адил санаатай бүлэг хүмүүсийг олж авахын тулд, эхлэхдээ ямар агуулга болон арга барилыг хэрэглэх, үргэлжлүүлэхийн тулд ямар арга хэрэглэхээ, төгсгөхийн тулд ямар арга хэрэглэхээ Бурхан мэддэг. Хүний дотор юу байгааг Тэр мэддэг, хүнд юу дутагдаж байгааг мэддэг. Юу өгөх хэрэгтэйгээ Тэр мэддэг, хүнийг хэрхэн удирдан чиглүүлэх ёстойгоо Тэр мэддэг, мөн түүнчлэн хүн юу хийх ёстойг болон юу хийх ёсгүйг Тэр мэддэг билээ. Хүн яг л хүүхэлдэй шиг: Хэдийгээр тэр Бурханы хүслийн талаар ямар ч ойлголтгүй байдаг боловч өөрийн эрхгүй алхам алхмаар өнөөдрийг хүртэл Бурханы удирдлагын ажилд хөтлөгдсөн. Юу хийх гэж байгаа талаараа Бурханы зүрх сэтгэлд бүрхэг зүйл байгаагүй; Түүний зүрх сэтгэлд маш тодорхой, тод томруун төлөвлөгөө байсан бөгөөд хийхийг хүссэн ажлаа Өөрийн алхмууд болон Өөрийн төлөвлөгөөний дагуу өнгөцхөнөөс гүн гүнзгий рүү давшин Өөрөө хэрэгжүүлсэн юм. Хэдийгээр Тэр хожим хийх гэж буй ажлаа дурдаагүй ч гэсэн Түүний дараагийн ажил төлөвлөгөөтэй нь нягт уялдан үргэлжлэн хэрэгжиж, урагшилсаар байгаа нь Бурханд юу байгаа болон Тэр юу болохын илрэл бөгөөд мөн Бурханы эрх мэдэл билээ. Тэр Өөрийн удирдлагын төлөвлөгөөний аль үе шатанд ажиллаж байгаагаас үл хамааран, Түүний зан чанар, Түүний мөн чанар Өөрийг нь төлөөлдөг. Энд ямар ч алдаа мадаг үгүй. Эрин үе, ажлын үе шат болон Бурхан ямар төрлийн хүмүүсийг хайрлаж, ямар төрлийн хүмүүсийг жигшдэгээс үл хамааран Түүний зан чанар, Түүнд байгаа бүхэн болон Тэр юу болох нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хэдийгээр Хуулийн эрин үед Бурханы тогтоосон эдгээр хууль, зарчим нь өнөөгийн хүмүүст маш энгийн, наад захын зүйл мэт санагддаг боловч, хэдийгээр ойлгож, хэрэгжүүлэхэд амархан боловч тэдгээрт Бурханы мэргэн ухаан байсаар байдаг ба Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох нь оршсоор байдаг. Учир нь, эдгээр энгийн юм шиг хуульд хүн төрөлхтний төлөөх Бурханы хариуцлага, анхаарал халамж, бас Түүний бодлын гайхалтай нарийн мөн чанар илэрхийлэгддэг, тэгснээр Бурхан бүх зүйлийг захирдаг бөгөөд бүх зүйлийг Түүний гар удирддаг гэсэн баримтыг үнэхээр ухаарах боломжийг хүнд олгодог. Хүн төрөлхтөн хэчнээн их мэдлэг эзэмшиж, хэчнээн онол, нууцыг ойлгосон нь хамаагүй, Бурханы хувьд эдгээрийн юу нь ч хүн төрөлхтөнд өгөх Түүний хангамж болон удирдлагыг орлож чаддаггүй; хүн төрөлхтөн Бурханы удирдамж болон Бурханы биечлэн хийх ажлаас хэзээд салшгүй байна. Хүн, Бурхан хоёрын салшгүй харилцаа ийм юм. Бурхан та нарт тушаал, хууль өгч, эсвэл та нарт Өөрийн хүслийг ойлгуулах үнэнийг өгөх эсэхийг үл харгалзан, Тэр юу ч хийсэн хамаагүй, Бурханы зорилго бол хүнийг сайхан маргааш руу хөтлөх явдал юм. Бурханы айлддаг үг болон Түүний хийдэг ажил хоёулаа Түүний мөн чанарын нэг талын илчлэл бөгөөд

Түүний зан чанар, Түүний мэргэн ухааны нэг талын илчлэл; тэдгээр нь Түүний удирдлагын төлөвлөгөөний зайлшгүй чухал алхам билээ. Үүнийг анзаарахгүй өнгөрч болохгүй! Бурханы хийдэг юм бүхэнд Түүний хүсэл бий; Бурхан таарамжгүй үгээс айдаггүй, мөн Түүний тухай хүний ямар ч үзэл, бодлоос айдаггүй. Тэр Өөрийн удирдлагын төлөвлөгөөний дагуу ямар ч хүн, хэрэг явдал, эд зүйлд баригдалгүй зүгээр л Өөрийн ажлыг хийж, Өөрийн удирдлагыг үргэлжлүүлдэг.

За. Өнөөдрийн хувьд ингээд дууслаа. Дараа дахин уулзья!

2013 оны 11 дүгээр сарын 9

БУРХАНЫ АЖИЛ, БУРХАНЫ ЗАН ЧАНАР БА БУРХАН ӨӨРӨӨ III

Бидний сүүлийн хэдэн нөхөрлөл та нарын хүн нэг бүрд маш их нөлөө үзүүлсэн. Одоогийн байдлаар хүмүүс эцэст нь Бурханы жинхэнэ оршин тогтнол болоод Бурхан үнэндээ хүнд маш ойр байдгийг лавтай мэдэрч чаддаг. Хэдийгээр хүмүүс Бурханд маш олон жил итгэж байсан боловч Түүний бодол, санааг хэзээ ч одоогийнх шигээ үнэхээр ойлгоогүй, мөн Түүний бодитой үйлсийг одоогийнх шигээ үнэхээр мэдрээгүй. Мэдлэг байна уу, бодит хэрэгжүүлэлт байна уу аль нь ч бай, ихэнх хүн ямар нэг шинэ зүйл сурч, илүү их ойлголтод хүрч, урьдын эрэл хайгуулынхаа алдааг ухаарч, өөрсдийн туршлагын өнгөц байдлыг болон хэтэрхий их туршлага нь Бурханы хүсэлд нийцдэггүй болохыг, мөн хүнд хамгийн их дутагддаг зүйл нь Бурханы зан чанарын талаарх мэдлэг юм гэдгийг ухаарсан. Хүмүүсийн хувьд бол энэхүү мэдлэг нь ердөө л мэдрэмжид суурилсан мэдлэгийн нэг төрөл юм; ухаалаг мэдлэгийн түвшин рүү өсөхийн тулд туршлагаараа дамжуулан аажмаар гүнзгийрүүлж, бататгахыг шаарддаг. Хүн Бурханыг үнэхээр ойлгохоосоо өмнө, зүрх сэтгэлдээ Бурханы оршин тогтнолд итгэдэг гэж субьектив байдлаар хэлж болох боловч Тэр үнэндээ ямар төрлийн Бурхан бэ, Түүний хүсэл юу вэ, Түүний зан чанар ямар вэ, хүн төрөлхтөнд хандах Түүний бодит хандлага ямар вэ гэх мэт тодорхой асуултуудын талаар тэдэнд ямар ч бодитой ойлголт байдаггүй. Энэ нь хүмүүсийн Бурханд итгэх итгэлийг асар ихээр эвдэж, итгэл нь хэзээ нэгэн цагт цэвэр ариун, төгс байдалд хүрэхэд саад болдог. Хэдий чи Бурханы үгтэй нүүр тулж, эсвэл туршлагаараа дамжуулан Бурхантай учирсан гэж санагдсан ч гэсэн Түүнийг бүрэн ойлгодог гэж хэлж бас л болохгүй. Чи Бурханы бодол, Тэр юуг хайрладаг, юуг үзэн яддаг, Түүнийг юу уурлуулдаг, Түүнд юу баяр хөөр авчирдгийг мэддэггүй учраас Түүний талаарх жинхэнэ ойлголт чамд байдаггүй. Итгэл чиний субьектив хүсэл дээр үндэслэсэн тодорхойгүй байдал, төсөөллийн суурин дээр бий болсон. Жинхэнэ итгэлээс энэ нь хол хэвээр, чи жинхэнэ дагагч болох хол хэвээр л байна. Библийн эдгээр түүхээс авсан жишээнүүдийн тайлбар нь хүмүүст Бурханы зүрх сэтгэл, Тэр ажлынхаа алхам бүрд юу бодож байсан, Тэр яагаад энэ ажлыг хийсэн, үүнийг хийх үеийн Түүний анхны санаа зорилго, төлөвлөгөө юу байсан, Тэр Өөрийн санаандаа хэрхэн хүрсэн, мөн Өөрийн төлөвлөгөөг хэрхэн бэлтгэж, боловсруулсныг мэдэх боломж олгосон. Эдгээр түүхээр дамжуулан бид Бурханы зургаан мянган жилийн удирдлагын ажлын үеийн тодорхой санаа, бодит бодол бүрийнх нь талаар, өөр өөр цаг хугацаанд, өөр өөр эрин үед хүнд хандах Бурханы хандлагын талаар нарийвчилсан тодорхой ойлголт олж авч чадна. Нөхцөл байдал болгонтой тулгарахдаа Бурхан юу бодож байсан, Түүний хандлага ямар байсан, Түүний ил гаргадаг зан чанарыг хүмүүс ойлгож чадвал Түүний жинхэнэ оршин тогтнолыг улам гүнзгий ухаарч, Түүний бодитой, жинхэнэ байдлыг илүү гүнзгий мэдрэхэд нь хүн бүрд тусалж чадна. Эдгээр түүхийг ярьж байгаа Миний зорилго бол хүмүүст Библийн

түүхийг ойлгуулах гэсэндээ биш, мөн Библийн мөрүүдийг, тэнд гардаг хүмүүсийг мэддэг болоход нь тэдэнд туслах гэсэндээ ч биш, тэр тусмаа, Хуулийн эрин үед Бурханы хийсэн зүйлийн цаад шалтгааныг ойлгоход хүмүүст туслахын тулд биш юм. Харин ч Бурханы хүсэл, зан чанар, Түүний өчүүхэн хэсэг нэг бүрийг ойлгож, Бурханы талаар илүү жинхэнэ, илүү үнэн зөв ойлголт, мэдлэг олж авахад хүмүүст туслахын төлөө юм. Ингэснээр хүмүүсийн зүрх сэтгэл бага багаар Бурханд нээгдэж, Бурхантай ойр болж, тэд Түүнийг, Түүний зан чанар, мөн чанарыг илүү сайн ойлгож, жинхэнэ Бурханыг Өөрийг нь илүү сайн мэдэж чадна.

Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох тухай мэдлэг нь хүмүүст эерэг нөлөө үзүүлж чадна. Бурханд илүү итгэлтэй болж, жинхэнээсээ Түүнд дуулгавартай болж, Түүний төлөө эмээдэг байдалд хүрэхэд нь тэдэнд тусалж чадна. Тэгээд тэд Түүнийг сохроор дагаж, шүтэн мөргөдгөө болино. Бурхан тэнэгүүдийг, олонхыг сохроор дагадаг хүмүүсийг биш, харин зүрх сэтгэлдээ Бурханы зан чанарын талаар тодорхой ойлголт, мэдлэгтэй, Бурханы гэрч болж чадах бүлэг хүнийг, Түүний хайр татам байдал, Түүнд юу байгаа, Тэр юу болох, Түүний зөвт зан чанараас болж Бурханыг хэзээ ч орхихгүй хүмүүсийг хүсдэг. Хэрвээ Бурханы дагагчийн хувьд, зүрх сэтгэл нь тодорхойгүй байдалтай байсаар, эсвэл Бурханы жинхэнэ оршин тогтнол, Түүний зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох, хүн төрөлхтнийг аврах Түүний удирдлагын төлөвлөгөө талаар тодорхой мэдэхгүй, төөрөлдсөөр байгаа бол итгэл чинь Бурханы магтаалыг хүртэж чадахгүй. Иймэрхүү хүн Өөрийг нь дагахыг Бурхан хүсдэггүй, ийм төрлийн хүн Өөрийнх нь өмнө ирэхэд Тэр дургүй. Учир нь, иймэрхүү хүн Бурханыг ойлгодоггүй, зүрх сэтгэлээ Бурханд өгч чаддаггүй—тэдний зүрх сэтгэл Бурханд хаалттай байдаг учраас Түүнд итгэх итгэл нь өө сэвээр дүүрэн байдаг. Бурханыг дагаж байгаа байдлыг нь зөвхөн сохор гэж л хэлж болно. Бурханд жинхэнээсээ дуулгавартай болж, Түүнээс эмээхэд хүргэдэг Бурханы талаарх жинхэнэ ойлголт, мэдлэгтэй байвал л хүмүүс жинхэнэ итгэлийг олж авч, жинхэнэ дагагчид болж чадна. Зөвхөн ийм маягаар л тэд зүрх сэтгэлээ Бурханд өгч, Түүнд нээж чадна. Үүнийг Бурхан хүсдэг, учир нь тэдний хийдэг, боддог бүхэн Бурханы туршилтыг давж, Бурханд гэрчлэл хийж чадна. Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох, Түүний хийж байгаа бүхэн дэх хүсэл, Түүний бодлынх нь талаар Миний та нарт ярьж байгаа бүхэн, Би ямар ч байрнаас, ямар ч өнцгөөс ярьж байсан, бүгд л Бурханы жинхэнэ оршин тогтнолын тухай илүү лавтай мэдэж, хүн төрөлхтний төлөөх Түүний хайр, хүмүүсийн төлөөх Бурханы сэтгэлийн зовнил, хүн төрөлхтнийг аварч, удирдах Түүний чин хүслийг үнэхээр улам илүү ойлгож, бодитойгоор үнэлэхэд чинь туслахын төлөө билээ.

Дэлхийг бүтээснээс хойших Бурханы бодол, санаа, үйлдлийн тойм

Өнөөдөр бид эхлээд хүн төрөлхтнийг бүтээснээс хойших Бурханы бодол, санаа, хөдөлгөөн бүрийг дүгнэж, дэлхийг бүтээснээс эхлээд Нигүүлслийн эрин үе

албан ёсоор эхлэх хүртэл Тэр ямар ажил хэрэгжүүлснийг авч үзэх болно. Бид дараа нь Бурханы бодол, санааны алийг нь хүн мэдэхгүй байгааг олж мэдэж болох бөгөөд тэндээсээ Бурханы удирдлагын төлөвлөгөөний дэс дарааллыг тодруулж, Бурхан Өөрийн удирдлагын ажлыг бий болгосон орчин нөхцөл, түүний эх сурвалж, хөгжлийн үйл явцыг, мөн түүнчлэн Түүний удирдлагын ажлаасаа гаргахыг хүсдэг үр дүнг—өөрөөр хэлбэл, Түүний удирдлагын ажлын гол цөм болон зорилгыг нэгд нэгэнгүй ойлгож чадна. Эдгээр зүйлийг ойлгохын тулд бид хүн байхгүй байсан тэр алс холын, нам гүм, чимээгүй үе рүү буцаж очих хэрэгтэй…

Бурхан анхны амьд хүнийг биечлэн бүтээв

Бурханыг орноосоо өндийхөд нь анх төрсөн бодол нь: амьд хүн—жинхэнэ, амьтай хүнийг, хамт амьдарч, байнгын хань нөхөр нь байх хэн нэгнийг бүтээх явдал байв; энэ хүн Түүнийг сонсож, Тэр түүнд сэтгэлээ дэлгэж, ярилцаж чадах байв. Тэгээд Бурхан, анх удаа атга шороо авч, түүнийгээ ашиглан оюун санаандаа төсөөлсөн дүр төрхийн дагуу хамгийн анхны амьд хүнийг бүтээж, дараа нь энэхүү амьтай бүтээлд Адам хэмээх нэр өгсөн. Энэхүү амьд, амьсгалдаг хүнтэй болчхоод Түүнд ямар санагдсан бэ? Анх удаагаа Тэр хайртай хүн, хань нөхөртэй байхын баяр баяслыг мэдэрсэн. Тэрээр мөн эцэг байхын хариуцлага, үүнтэй хамт ирдэг сэтгэлийн зовнилыг анх удаа мэдэрсэн юм. Энэхүү амьд агаад амьсгалдаг хүн Бурханд аз жаргал, баяр баясгалан авчирсан; Тэр анх удаа тайтгарлыг мэдэрсэн. Энэ бол Бурханы бодлоороо, тэр ч бүү хэл үгээрээ биш, харин хоёр гараараа хийсэн анхных нь зүйл байсан юм. Ийм оршихуй—бие махбод, хэлбэр дүрстэй, мах цуснаас бүрдсэн амьд, амьсгалдаг хүн Бурханы өмнө зогсоод Бурхантай ярьж чадаж байхад Тэр урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй тийм баяр хөөрийг мэдэрсэн билээ. Бурхан хариуцлагаа үнэхээр мэдэрч, энэхүү амьд оршихуй зүрх сэтгэлийг нь хөндөөд зогсохгүй, мөн өчүүхэн хөдөлгөөн бүрээрээ Түүний сэтгэлийг хөдөлгөж, зүрх сэтгэлийг нь дулаацуулж байсан. Энэхүү амьд оршихуй Бурханы өмнө зогсох үед олон ийм хүн олж авъя гэж Тэр анх удаагаа бодсон юм. Бурханд төрсөн энэхүү анхны бодлоос эхэлсэн хэд хэдэн үйл явдлууд нь энэ байсан билээ. Бурханы хувьд энэ бүх үйл явдал нь анх удаа тохиолдсон боловч эдгээр анхны үйл явдал дээр Тэр тухайн үед баяр баясгалан, хариуцлага, сэтгэл зовнил гээд юу ч мэдэрч байсан гэсэн, тэдгээрийг Өөртэй нь хуваалцах хэн ч байгаагүй. Тэр мөчөөс эхлээд Бурхан урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй ганцаардал, уйтгар гунигийг үнэхээр мэдэрсэн. Хүн Түүний хайр, сэтгэл зовнил, хүнийг гэх санаа зорилгыг нь хүлээн авч, ухаарч ойлгож чадахгүй гэдгийг Тэр мэдэрсэн учраас Тэр зүрх сэтгэлдээ уйтгар гуниг, шаналлыг мэдэрсээр байсан юм. Хэдийгээр Тэр эдгээр зүйлийг хүний төлөө хийсэн боловч хүн үүнийг нь мэдэхгүй, бас ойлгоогүй. Бурханд хүний авчирсан аз жаргал, баяр баясгалан, тайтгарал нь уй гуниг, ганцаардлын анхны мэдрэмжийг Түүнд нэн даруй авчирсан юм. Эдгээр нь тэр үеийн Бурханы бодол, мэдрэмж байв. Бурхан энэ бүх зүйлийг хийж байх зуур Түүний зүрх сэтгэл

дэх баяр баясгалан нь харуусал болж, харуусал нь шаналал болон хувирч, эдгээр мэдрэмж нь сэтгэлийн түгшүүртэй холилдож байв. Түүний хийхийг хүсэж байсан ганц зүйл нь энэ хүнд, энэ хүн төрөлхтөнд Өөрийн зүрх сэтгэлд юу байгааг мэдүүлж, Өөрийн санаа зорилгыг эртхэн ойлгуулахаар яаравчлах явдал байлаа. Тэгвэл тэд Түүний дагалдагчид болж, Түүнтэй адил бодолтой байж, Түүний хүсэлд нийцэж чадах байв. Тэд Бурханы айлдахыг зүгээр л сонсож, хэлэх үггүй хэвээр үлдэхээ болино; тэд Бурханы ажилд хэрхэн нэгдэхээ мэдэхгүй байхаа болино; юун түрүүнд тэд Бурханы шаардлагад хайхрамжгүй хандахаа болино. Бурханы хийсэн эдгээр анхны зүйл маш их утга учиртай бөгөөд Түүний удирдлагын төлөвлөгөө болон өнөөдрийн хүн төрөлхтний хувьд асар их үнэ цэнтэй байдаг.

Бүх зүйл болон хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараа Бурхан амраагүй. Тэр Өөрийн удирдлагыг хэрэгжүүлж, хүн төрөлхтний дундаас ихэд хайрладаг хүмүүсээ олж авах гэж тэсэн ядаж байв.

Хуулийн эрин үеийн хавьцаа Бурхан урьд хожид хийгдээгүй хэд хэдэн ажлыг хийв

Дараа нь Бурхан хүн төрөлхтөнийг бүтээснээс хойш нэг их удалгүй, бүх дэлхий даяар асар их үер болсон гэдгийг бид Библиэс харж болно. Үерийн тухай тэмдэглэлд Ноа дурдагддаг ба Ноа бол Бурханы даалгаврыг гүйцэтгэхийн тулд Түүнтэй хамт ажиллахаар Бурханы дуудлагыг хүлээн авсан анхны хүн байсан гэхэд болно. Мэдээжээр, энэ нь мөн Бурхан дэлхий дээр нэг хүнийг Өөрийнхөө тушаалын дагуу ямар нэг зүйл хийлгэхээр дуудсан анхны тохиолдол байсан. Ноа бүхээг барьж дуусахад Бурхан газар дэлхийг анх удаагаа үерт автуулсан. Бурхан дэлхийг үерээр устгах үедээ, хүмүүсийг бүтээснээсээ хойш тэднийг анх удаа маш их жигшиж байлаа; энэ нь хүн төрөлхтнийг усны үерээр устгах шаналгаатай шийдвэр гаргахад хүргэсэн зүйл юм. Үер газар дэлхийг сүйрүүлсний дараа Бурхан дэлхийг дахин хэзээ ч үерээр устгахгүй гэдгийг харуулах гэрээ буюу Өөрийн анхны гэрээг хүмүүстэй байгуулжээ. Энэхүү гэрээний тэмдэг нь солонго байлаа. Энэ нь хүн төрөлхтөнтэй байгуулсан Бурханы анхны гэрээ байсан тул солонго нь Бурханы өгсөн гэрээний анхны тэмдэг байв; солонго бол оршин байдаг бодитой, биет зүйл юм. Солонгын оршин тогтнол урьд нь алдсан хүн төрөлхтний хойноос Бурханд үргэлж уй гашууг төрүүлж, тэдэнд юу тохиолдсоныг Түүнд байнга сануулах зорилготой… Бурхан хурдаа сааруулаагүй—Тэр Өөрийн удирдлагын дараагийн алхмыг хийх гэж тэсэн ядаж байлаа. Тэгээд Бурхан Абрахамыг Израиль даяар хийх Өөрийн ажилд анхны сонголт болгон сонгосон. Энэ нь бас Бурхан ийм хүнийг сонгосон анхны тохиолдол байсан юм. Энэ хүнээр дамжуулан хүн төрөлхтнийг аврах Өөрийн ажлыг хэрэгжүүлэн эхэлж, энэ хүний үр удмын дунд Өөрийн ажлыг үргэлжлүүлэхээр Бурхан шийдсэн. Абрахамтай хамт Бурханы хийсэн зүйл энэ юм гэдгийг бид Библиэс харж болно. Тэгээд Бурхан Израилийг эхний сонгогдсон газар болгож, Өөрийнхөө сонгосон ард түмэн буюу израильчуудаар дамжуулан Хуулийн

эрин үеийн ажлаа эхэлсэн юм. Бурхан бас дахин анх удаагаа хүн төрөлхтний дагах ёстой тусгай хууль, дүрмээр израильчуудыг хангаж, тэдэнд дэлгэрэнгүй тайлбарласан. Энэ нь, тэд яаж тахил өргөвөл зохих, яаж амьдарвал зохих, юу хийх ёстой ба хийх ёсгүй, ямар баяр болон өдрүүдийг тэмдэглэх ёстой болон хийж байгаа бүхэндээ баримталбал зохих зарчмуудынх нь талаар маш тодорхой, стандартчилсан дүрмийг Бурхан хүнд өгсөн анхны тохиолдол байв. Энэ нь Бурхан хүн төрөлхтөнд хэрхэн амьдрах талаар тийм дэлгэрэнгүй, стандартчилсан журам, зарчим өгсөн анхны удаа байлаа.

Би “анх удаа” гэж хэлэх бүрдээ Бурханы урьд өмнө нь хэзээ ч гүйцэтгэж байгаагүй ажлыг хэлдэг. Энэ нь урьд өмнө нь оршин байгаагүй ажлыг хэлдэг бөгөөд Бурхан хэдийгээр хүн төрөлхтөн, бүх төрлийн биет, амьд зүйлсийг бүтээсэн боловч энэ нь Бурханы өмнө нь хэзээ ч хийж байгаагүй төрлийн ажил юм. Энэ бүх ажил нь хүн төрөлхтнийг удирдах Бурханы удирдлагыг багтаасан; энэ нь бүгд хүмүүстэй, Түүний аврал болон хүн төрөлхтнийг удирдахтай холбоотой байсан. Абрахамын дараа Бурхан дахин нэг зүйлийг анх удаа хийсэн—Тэр Иовыг Бурханаас эмээж, муугаас зайлж, Бурханы төлөө гэрчлэлд үргэлжлүүлэн зогсох зууraa Сатаны уруу таталтыг дааж чадах, хуулийн доор амьдардаг нэгэн болгохоор сонгосон. Энэ нь Бурхан Сатанд хүнийг уруу татах боломж олгосон анхны удаа байсан бөгөөд Сатантай мөрий тавьсан анхны удаа байсан. Эцэст нь Тэрээр, Сатантай тулгарах зууraa Өөрт нь гэрчлэл хийж чадах хүнийг, Сатаныг бүрмөсөн шившиглэж чадах хүнийг анх удаагаа олж авсан. Бурхан хүн төрөлхтнийг бүтээснээс хойш энэ нь Түүний олж авсан, Түүнд гэрчлэл хийж чадах анхны хүн байсан юм. Энэ хүнийг олж авчхаад Бурхан Өөрийн удирдлагыг үргэлжлүүлэн ажлынхаа дараагийн үе шатыг гүйцэтгэж, Өөрийнхөө ажлын дараагийн алхамд зориулан сонгох байршил болон хүмүүсийг бэлтгэхийг бүр ч илүү хүсэн эрмэлзэх болсон.

Энэ бүхний тухай нөхөрлөсний дараа та нар Бурханы хүслийн талаар жинхэнэ ойлголттой болсон уу? Хүн төрөлхтнийг удирдах, хүн төрөлхтнийг аврах энэ явдлыг Бурхан өөр юунаас ч илүү чухал гэж үздэг. Тэр эдгээр зүйлийг зөвхөн Өөрийн санаагаар, Өөрийн үгээр хийдэггүй ба мэдээж хааш яаш хандлагаар хийдэггүй—Тэр энэ бүх зүйлийг төлөвлөгөө, зорилго, стандарттайгаар, хүсэлтэйгээр хийдэг. Хүн төрөлхтнийг аврах энэ ажил нь Бурхан, хүн хоёрын аль алины хувьд асар их ач холбогдолтой гэдэг нь ойлгомжтой. Уг ажил хэчнээн хэцүү байх нь хамаагүй, саад бартаа хэчнээн их байх нь, хүн хэчнээн сул дорой байх нь, эсвэл хүн төрөлхтний тэрслүү зан хэр гүнзгий байх нь хамаагүй, аль нь ч Бурханд хэцүү биш юм. Бурхан Өөрийгөө завгүй байлгаж, уйгагүй хичээл чармайлтаа зарцуулж, хийхийг хүсдэг ажлаа удирддаг. Түүнчлэн бүх зүйлийг зохицуулж, Өөрийн ажиллах тэр бүх хүнийг болон гүйцэлдүүлэхийг хүсдэг бүх ажлаа захирч байдаг—эдгээрийн аль нь ч урьд өмнө хэзээ ч хийгдэж байгаагүй. Энэ нь Бурхан эдгээр аргыг хэрэглэж, хүн төрөлхтнийг удирдаж, аврах энэхүү гол том төсөлд тийм өндөр төлөөс төлсөн анхны удаа юм. Бурхан энэ ажлыг гүйцэтгэх зууraa Өөрийн шаргуу

хичээл чармайлт, Түүнд юу байгаа, Тэр юу болох, Өөрийн мэргэн ухаан, төгс хүчин болон Өөрийн зан чанарын бүх талыг хүн төрөлхтөнд бага багаар, юу ч үлдээлгүй илэрхийлж, гаргаж байгаа. Тэрээр урьд өмнө нь Өөрийн хэзээ ч хийж байгаагүй эдгээр зүйлийг гаргаж, илэрхийлдэг. Иймээс бүхий л орчлон ертөнцөд Бурханы удирдаж, аврахаар зорьсон хүмүүсээс өөр Бурханд ийм их ойр бөгөөд Түүнтэй тийм дотно харьцаатай байсан ямар ч бүтээл хэзээ ч байгаагүй юм. Удирдаж, аврахыг хүссэн хүн төрөлхтөн нь Түүний зүрх сэтгэлд хамгийн чухал; Тэр энэ хүн төрөлхтнийг юу юунаас илүү үнэлдэг. Хэдийгээр Тэр тэдний төлөө маш их төлөөс төлсөн ч гэсэн, хэдийгээр тэд Түүнийг үргэлжлүүлэн гомдоож, дуулгаваргүй загнадаг ч гэсэн Тэр тэднийг хэзээ ч хаядаггүй бөгөөд ямар ч гомдол, харамсалгүйгээр Өөрийн ажлыг цуцалтгүй үргэлжлүүлдэг. Учир нь эрт орой хэзээ нэгэн цагт хүмүүс Түүний дуудлагаар сэрж, Түүний үгэнд уярч, Түүнийг бүтээлийн Эзэн хэмээн таньж, Түүний дэргэд буцаж ирнэ гэдгийг Тэр мэддэг билээ…

Өнөөдөр энэ бүхнийг сонссоныхоо дараа Бурханы хийдэг бүх зүйл маш энгийн юм шиг та нарт санагдаж магадгүй. Хүмүүс Бурханы үг болон ажлаас тэдний төлөө гэсэн Түүний санаа зорилгын заримыг үргэлж мэдэрдэг мэт боловч тэдний мэдрэмж, мэдлэг болон Бурханы юу бодож байгаагийн хооронд үргэлж тодорхой хэмжээний зай байдаг. Тийм учраас, Бурхан яагаад хүн төрөлхтнийг бүтээсэн тухай болон Өөрийн найдаж буй хүн төрөлхтнийг олж авах хүслийнх нь цаад шалтгааны талаар бүх хүнд хэлэх нь чухал гэж Би боддог. Үүнийг хүн бүхэнтэй хуваалцах нь чухал, ингэснээр хүн бүхэн үүнийг зүрх сэтгэлдээ тодорхой мэддэг болж, ойлгож авна. Бурханы бодол, санаа бүр, Түүний ажлын үе, шат болгон бүхий л удирдлагын ажилтай нь уялдаж, нягт холбоотой байдаг, тиймээс та нар ажлынх нь алхам бүр дэх Бурханы бодол, санаа болон хүслийг ойлговол энэ нь Түүний удирдлагын төлөвлөгөөний ажил хэрхэн бий болсныг ойлгохтой адилхан юм. Энэ суурин дээр Бурханы талаарх ойлголт чинь гүнзгийрдэг. Миний өмнө нь дурдсан, энэ дэлхийг анх бүтээхдээ Бурханы хийсэн бүх зүйл нь хэдийгээр одоохондоо “мэдээлэл” төдий бөгөөд үнэнийг эрж хайхад хамаагүй мэт санагдаж болох боловч туршлагын чинь явцад, энэ нь ганц хоёрхон мэдээлэл төдий энгийн зүйл ч биш, зүгээр ч нэг нууц төдий биш юм гэж бодох өдөр ирэх болно. Чиний амь өсөхийн хэрээр, зүрх сэтгэлд чинь Бурхан жаахан байр эзлэх үед, эсвэл Түүний хүслийг бүхэлд нь гүн гүнзгий ойлгох үедээ чи Миний өнөөдөр ярьж байгаа зүйлийн ач холбогдол, хэрэгцээг үнэхээр ойлгох болно. Та нар үүнийг одоо хэр хэмжээнд хүлээн авсан нь хамаагүй, эдгээр зүйлийг ойлгож, мэдэх нь мөн л чухал юм. Бурхан ямар нэг зүйл хийхдээ, Өөрийн ажлыг гүйцэтгэхдээ санаагаараа ч бай, гараараа ч бай хамаагүй, анхны удаагаа ч юм уу, эсвэл сүүлчийн удаагаа ч хийсэн байх нь хамаагүй—хамгийн гол нь Бурханд төлөвлөгөө байдаг бөгөөд хийдэг юм бүхэнд нь Түүний зорилго, Түүний бодол байдаг. Эдгээр зорилго болон бодол нь Бурханы зан чанарыг төлөөлдөг ба тэдгээр нь Түүнд юу байгаа, Тэр юу болохыг илэрхийлдэг. Энэ хоёр зүйл—Бурханы зан чанар болон Түүнд юу байгаа, Тэр юу болох гэдгийг—хүн нэг бүр ойлгох ёстой.

Түүний зан чанар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохыг хүн ойлгомогцоо Бурхан яагаад ингэж хийж, яагаад ингэж хэлдгийг аажмаар ойлгож чадна. Тэгснээр тэд Бурханыг дагаж, үнэнийг болон зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэхдээ илүү их итгэлтэй байж чадна. Өөрөөр хэлбэл, Бурханы талаарх хүний ойлголт болон Бурханд итгэх итгэл нь салшгүй юм.

Хүмүүсийн мэдэж, ойлгож авдаг зүйл нь Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох байдаг байхад тэдний олж авдаг зүйл Бурханаас ирдэг амь байх болно. Нэгэнт энэ амь дотор чинь шингэсэн бол Бурханаас эмээх чинь улам бүр ихэснэ. Энэ бол аяндаа гарах үр дүн юм. Хэрвээ чи Бурханы зан чанар, эсвэл мөн чанарыг ойлгож мэдэхийг хүсэхгүй бол, хэрвээ чи эдгээр зүйлийн талаар тунгаан бодож, анхаарлаа хандуулахыг бүр ч хүсэхгүй байгаа бол Бурханд итгэх итгэлийг эрж хайж байгаа одоогийн арга зам чинь Түүний хүсэлд хэзээ ч нийцэхгүй, Түүний магтаалыг хүртэх боломж чамд олдохгүй гэдгийг Би баттай хэлж чадна. Түүнээс гадна, чи үнэхээр хэзээ ч аврал хүртэж чадахгүй—эдгээр нь эцсийн үр дагавар юм. Хүмүүс Бурханыг ойлгодоггүй, Түүний зан чанарыг мэддэггүй бол зүрх сэтгэлээ Түүнд хэзээ ч үнэнээсээ нээж чадахгүй. Тэд Бурханыг ойлгомогцоо Түүний зүрх сэтгэлд байгаа зүйлийг ойлгож, амтлахаар сонирхож, үүнд итгэж эхэлнэ. Бурханы зүрх сэтгэлд байгаа зүйлийг ойлгож, амтлах үед зүрх сэтгэл чинь аажмаар, бага багаар Түүнд нээгддэг. Зүрх сэтгэлээ Түүнд нээх үедээ чи Бурхантай наймаацсан наймаа чинь, Бурханаас нэхдэг зүйл чинь, хэрээс хэтэрсэн хүсэл чинь хэчнээн ичгүүртэй, жигшүүртэй болохыг мэдрэх болно. Зүрх сэтгэлээ Бурханд үнэхээр нээх үедээ Түүний зүрх сэтгэл маш хязгааргүй ертөнц болохыг чи ойлгож, өмнө нь хэзээ ч үзэж мэдэрч байгаагүй хүрээнд орох болно. Энэ хүрээнд ямар ч башир арга, ямар ч хууран мэхлэлт, ямар ч харанхуй, ямар ч хорон муу байдаггүй. Тэнд зөвхөн чин сэтгэл болон итгэлтэй байдал байдаг; зөвхөн гэрэл болон шударга зан байдаг; зөвхөн зөвт байдал болон сайхан сэтгэл байдаг. Энэ нь хайр, халамжаар дүүрэн, энэрэл нигүүлсэл, хүлээцтэй байдлаар дүүрэн байдаг бөгөөд үүгээр дамжуулан чи амьд байхын аз жаргал, баяр хөөрийг мэдэрнэ. Эдгээр зүйл нь зүрх сэтгэлээ Бурханд нээсний чинь дараа Түүний чамд илчлэх зүйл юм. Энэхүү хязгааргүй ертөнц Бурханы мэргэн ухаан, бүхнийг чадагч байдлаар дүүрэн байдаг; энэ нь мөн Түүний хайр, Түүний эрх мэдлээр дүүрэн байдаг. Эндээс чи Бурханд юу байгаа болон Тэр юу болох, Түүнд юу баяр баясгалан авчирдаг, Тэр яагаад санаа зовдог, Тэр яагаад гунигладаг, Тэр яагаад уурладаг … гэх мэт бүх талыг харж болно. Энэ нь өөрийнхөө зүрх сэтгэлийг нээж, Бурханыг оруулсан хүн нэг бүрийн харж чадах зүйл юм. Чи зүрх сэтгэлээ Түүнд нээсэн цагт л Бурхан зүрх сэтгэлд чинь орж чадна. Хэрвээ Тэр зүрх сэтгэлд чинь орох л юм бол чи Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг харж чадах ба мөн чамайг гэх Түүний санаа зорилгыг харж чадна. Тэр үед чи Бурханы талаарх юм бүхэн маш үнэ цэнтэй бөгөөд Түүнд юу байгаа, Тэр юу болохыг үнэхээр эрхэмлэвээс зохистой гэдгийг олж мэдэх болно. Үүнтэй харьцуулахад эргэн тойронд чинь байгаа хүмүүс, юмс, үйл явдлууд, тэр ч байтугай

хайртай хүмүүс, хань нөхөр, дуртай зүйлсийг чинь бараг дурдахын ч хэрэггүй юм. Тэдгээр нь маш өчүүхэн, маш дорд; ямар ч эд зүйл чамайг дахин хэзээ ч татаж чадахгүй, мөн ямар ч эд зүйл чамайг уруу татан, үүний төлөө ямарваа нэгэн төлөөс төлүүлж дахиад хэзээ ч чадахгүй гэдгийг чи мэдэрнэ. Бурханы даруу зангаас чи Түүний агуу байдал, бүхнээс давуу чанарыг нь харах болно. Түүнчлэн урьд нь чиний нэлээд жижиг гэж итгэж байсан, Бурханы зарим үйл хэргээс чи Түүний хязгааргүй мэргэн ухаан, хүлээцтэй байдлыг харж, Түүний тэвчээр, тэсвэр, мөн чиний талаарх ойлголтыг харах болно. Энэ нь чамд Түүнийг гэх хайрыг төрүүлнэ. Хүн төрөлхтөн ийм бузар ертөнцөд амьдарч байгааг, хажууд чинь байгаа хүмүүс, амьдралд чинь тохиолддог зүйлс, бүр хайрладаг хүмүүсийг чинь ч, чамайг гэсэн тэдний хайр, хамгаалалт, халамж гэгчийг нь хүртэл дурдахын ч хэрэггүй—гагцхүү Бурхан л чиний хайртай Нэгэн бөгөөд чиний хамгийн их эрхэмлэдэг Нэгэн бол гагцхүү Бурхан юм гэдгийг чи тэр өдөр мэдрэх болно. Тэр өдөр ирэхэд дараах зүйлийг хэлэх хүмүүс гарна гэж Би итгэж байна: Бурханы хайр маш агуу бөгөөд Түүний мөн чанар маш ариун—Бурханд ямар ч заль мэх, ямар ч хорон муу, ямар ч атаархал, хэрүүл тэмцэл байдаггүй, харин зөвхөн зөвт байдал, жинхэнэ байдал л байдаг ба Бурханд юу байгаа, Тэр юу болохын юм бүхнийг хүн хүсэн эрмэлзэх хэрэгтэй. Хүмүүс үүний төлөө хичээж, эрмэлзэх хэрэгтэй. Үүнд хүрэх хүн төрөлхтний чадвар юун дээр үндэслэдэг вэ? Энэ нь Бурханы зан чанарын талаарх тэдний ойлголт болон Бурханы мөн чанарын талаарх тэдний ойлголт дээр үндэслэдэг. Иймээс Бурханы зан чанарыг болон Түүнд юу байгаа, Тэр юу болохыг ойлгох нь хүн бүрийн насан туршийн хичээл; зан чанараа өөрчлөхийг эрмэлздэг, Бурханыг мэдэхийг эрмэлздэг хүн бүрийн зорих насан туршийн зорилго юм.

Бурхан ажил хийхээр анх удаа бие махбодтой болов

Бид Бурханы анх удаа хийсэн, өмнө нь хэзээ ч хийж байгаагүй цуврал бүх ажлынх нь талаар дөнгөж сая ярилаа. Эдгээр зүйл нь дор бүрнээ Бурханы удирдлагын төлөвлөгөө болон Бурханы хүсэлтэй холбоотой юм. Тэдгээр нь бас Бурханы Өөрийн зан чанар болон Түүний мөн чанартай холбоотой. Хэрвээ бид Бурханд юу байгаа, Тэр юу болохыг илүү сайн ойлгохыг хүсэж байгаа бол Хуучин Гэрээ юм уу Хуулийн эрин үед зогсож болохгүй—бид цааш үргэлжлүүлэн, Бурханы ажлын алхмуудыг дагах хэрэгтэй. Иймээс Бурхан Хуулийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийг эхлүүлэхдээ бидний өөрсдийн алхмыг Нигүүлслийн эрин үе рүү—нигүүлсэл, авралаар дүүрэн эрин үе рүү аваачсан. Энэ эрин үед Бурхан өмнө нь хэзээ ч хийж байгаагүй дахиад нэг маш чухал зүйлийг анх удаагаа хийсэн. Энэ шинэ эрин үе дэх ажил нь Бурхан болон хүн төрөлхтний аль алинд шинэ эхлэлийн цэг—Бурханы анх удаа хийсэн бас өөр нэг шинэ ажлаас бүрдсэн эхлэлийн цэг байсан юм. Энэ шинэ ажил нь урьд өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй, хүмүүс болон бүх зүйлийн төсөөлөхийн аргагүй зүйл байсан. Энэ нь одоо бүх хүний сайн мэддэг зүйл бөгөөд—Бурхан анх удаа хүн болж, анх удаа

хүний дүр төрхтэйгээр, хүний ялгамж чанартайгаар шинэ ажлаа эхэлсэн юм. Энэ шинэ ажил нь Бурхан Хуулийн эрин үе дэх Өөрийн ажлыг дуусгасныг болон Тэрээр цаашид хуулийн дор юу ч хийхгүй, хэлэхгүй гэдгийг харуулжээ. Тэр хуулийн хэлбэрээр, эсвэл хуулийн дүрэм журам, зарчмын дагуу юуг ч ярихгүй ба юу ч хийхгүй. Өөрөөр хэлбэл, хууль дээр үндэслэсэн Түүний бүх ажил үүрд зогссон бөгөөд цаашид үргэлжлэхгүй, яагаад гэвэл, Бурхан шинэ ажил эхэлж, шинэ зүйл хийхийг хүссэн. Түүний төлөвлөгөө дахин нэгэнтээ шинэ эхлэлийн цэгт хүрсэн тул Бурхан хүн төрөлхтнийг дараагийн эрин үе рүү хөтлөх ёстой болжээ.

Энэ нь хүмүүсийн хувьд баярт мэдээ байсан уу, эсвэл муу ёрын мэдээ байсан уу гэдэг нь хувь хүн бүрийн мөн чанар ямар байснаас шалтгаалж байв. Зарим хүний хувьд энэ нь баяртай биш, харин муу ёрын мэдээ байсан гэж хэлж болно, учир нь зөвхөн хууль, дүрэм, сургаал номлолыг дагадаг боловч Бурханаас эмээдэггүй тэр хүмүүс Бурханыг шинэ ажлаа эхлэхэд нь Бурханы хуучин ажлыг хэрэглэн шинэ ажлыг нь яллах хандлагатай байлаа. Энэ хүмүүсийн хувьд энэ нь муу ёрын мэдээ байсан. Гэвч гэм зэмгүй, нээлттэй, Бурханд үнэнч бөгөөд Түүний авралыг хүлээн авахад бэлэн хүн бүрийн хувьд Бурхан анх удаа бие махбод болсон нь маш баяртай мэдээ байлаа. Учир нь хүмүүс оршин тогтнох болсноос хойш Бурхан хүмүүсийн дунд Сүнс бус хэлбэртэйгээр гарч ирж, амьдарсан анхны удаа нь энэ байсан; энэ удаа Тэр хүнээс төрж, хүмүүсийн дунд хүний Хүү болон амьдарч, тэдний дунд ажилласан юм. Энэхүү “анхны удаа” нь хүмүүсийн үзлийг нураасан; мөн бүх төсөөллийг давсан. Түүнчлэн Бурханы бүх дагагч бодитой ашиг тус хүртсэн юм. Бурхан хуучин эрин үеийг дуусгаснаар үл барам Өөрийн хуучин ажиллах арга барил болон ажиллах маягийг ч цэглэсэн. Тэрээр Өөрийнх нь хүслийг дамжуул гэж элч нараас шаардахаа больж, үүлний цаана нуугдахаа больж, аянгаар дамжуулан хүмүүст харагдаж, тушаангуй ярихаа ч больсон. Өмнөх ямар ч зүйлтэй адилгүйгээр, хүмүүсийн хувьд ойлгож, хүлээн зөвшөөрөхөд хэцүү байсан төсөөлшгүй аргаар буюу бие махбод болж, тухайн үеийн ажлыг эхлүүлэхийн тулд Тэрээр хүний Хүү болсон юм. Бурханы энэ үйлдэл хүн төрөлхтнийг бүрэн гайхшируулсан; энэ нь тэднийг бас сандраасан, учир нь Бурхан урьд өмнө хэзээ ч хийж байгаагүй шинэ ажлаа дахиад эхлүүлжээ. Өнөөдөр бид шинэ эрин үед Бурхан ямар шинэ ажил гүйцэтгэснийг харах бөгөөд Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохын тухайд энэ шинэ ажлаас юу сурч болохыг авч үзнэ.

Дараах үгийг Библийн Шинэ Гэрээнд тэмдэглэжээ:

1. Есүс Амралтын өдөр тариан түрүү шувтран идэв

Матай 12:1 Тэр үед, Есүс амралтын өдөр тариан талбайгаар өнгөрөхөд, Түүний шавь нар нь өлсөж байсан тул улаан буудайн түрүүнээс шувтарч идэв.

2. Хүний Хүү бол Амралтын өдрийн Эзэн мөн

Матай 12:6–8 Гэвч Би та нарт хэлье, энэ газарт сүмээс ч илүү аугаа Нэгэн байна.

Хэрэв та нар Би тахилыг бус, өршөөлийг хүсдэг гэсэн нь ямар утгатай болохыг ойлгосон бол гэмгүй нэгэнийг буруутгахгүй байх байсан. Учир нь хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн.

Эхлээд энэ хэсийг авч үзье: “Тэр үед, Есүс амралтын өдөр тариан талбайгаар өнгөрөхөд, Түүний шавь нар нь өлсөж байсан тул улаан буудайн түрүүнээс шувтарч идэв.”

Би яагаад энэ хэсгийг сонгосон бэ? Энэ нь Бурханы зан чанартай ямар холбоотой вэ? Амралтын өдөр байтал Эзэн Есүс гадагш гарч, тариан талбай дундуур шавь нараа дагуулан явсан гэдэг нь энэ бичвэрээс хамгийн түрүүнд бидэнд мэдэгдсэн зүйл юм. Үүнээс ч “тэрслүү” нь юу гэвэл, тэд бүр “улаан буудайн түрүүнээс шувтарч идэв.” Хуулийн эрин үед Ехова Бурханы хуульд зааснаар бол Амралтын өдөр хүмүүс дурааараа гадагшаа гарах юм уу ямар нэг үйл ажиллагаанд оролцож болдоггүй байлаа—Амралтын өдрөөр хийж болдоггүй олон зүйл байв. Эзэн Есүсийн хийсэн энэ үйлдэл нь урт хугацааны турш уг хуульд захирагдан амьдарсан хүмүүсийг балмагдуулж, тэр ч байтугай энэ нь бүр шүүмжлэл өдөөсөн юм. Тэдний самгардсан болон Есүсийн хийсэн зүйлийн талаар хэрхэн ярьж байсан тухай бид одоохондоо хойш тавиад Эзэн Есүс яагаад бүх өдрийн дундаас Амралтын өдөр үүнийг хийхээр сонгож, тус хуульд захирагдан амьдарч байсан хүмүүст энэ үйлдлээрээ юу хэлэхийг хүссэн тухай эхлээд хэлэлцэх болно. Энэ хэсэг болон Миний ярихыг хүсэж байгаа Бурханы зан чанарын хоорондох холбоо энэ юм.

Эзэн Есүс ирэхдээ, Бурхан Хуулийн эрин үеийг орхин явж, шинэ ажил эхлүүлсэн ба энэхүү шинэ ажил нь Амралтын өдрийг сахихыг шаарддаггүй гэдгийг хүмүүст хэлэхийн тулд Өөрийн бодитой үйлдлийг ашигласан юм. Бурхан Амралтын өдрийн хязгаараас гарч буй нь ердөө л Түүний шинэ ажлын урьдчилсан жишээ байсан ба бодитой, агуу ажил үргэлжлэн явагдах гэж байсан юм. Эзэн Есүс Өөрийн ажлыг эхлүүлэхдээ Хуулийн эрин үеийн “гав дөнгийг” аль хэдийн ардаа орхисон ба тэрхүү эрин үеийн дүрэм, зарчмуудыг эвдэж гарсан байв. Түүнд хуультай холбоотой ямар ч зүйлийн ул мөр байгаагүй; Тэр үүнийг бүрмөсөн хаяж, цаашид мөрдөхөө больсон ба үүнийг мөрд гэж хүн төрөлхтнөөс шаардахаа больсон. Эндээс чи Эзэн Есүс Амралтын өдөр тариан талбайгаар явсан, Эзэн амраагүй гэдгийг харж байна; Тэрээр амралгүй, гадаа ажиллаж байсан. Түүний энэ үйлдэл нь хүмүүсийн үзэлд цохилт болсон ба Тэр цаашид хуульд захирагдан амьдрахаа больж, Амралтын өдрийн хязгаарыг орхиж, хүн төрөлхтний өмнө, тэдний дунд шинэ дүр төрхтэйгээр, ажиллах шинэ арга замтайгаар гарч ирсэн гэдгийг энэ нь тэдэнд мэдэгдсэн юм. Түүний энэ үйлдэл нь хуулийн дооройоос гарч, Амралтын өдрийг орхисноор эхэлсэн шинэ ажлыг авчирсан гэдгийг нь хүмүүст хэлсэн юм. Бурхан Өөрийн шинэ ажлыг хэрэгжүүлэхдээ өнгөрсөнтэй цаашид зууралдаагүй бөгөөд Хуулийн эрин үеийн дүрэм журмын талаар цаашид тоохоо больсон. Мөн өмнөх

эрин үе дэх Түүний ажил ч Түүнд нөлөөлөөгүй, харин Тэр өдөр бүр ажилладагтайгаа адилаар Амралтын өдрөөр бас л ажилласан ба Амралтын өдөр шавь нар нь өлсөх үедээ тариан түрүү шувтран идэж байжээ. Бурханы нүдээр энэ нь тун хэвийн зүйл байв. Бурханы хувьд, хийхийг хүсдэг шинэ ажил, хэлэхийг хүсдэг шинэ зүйлээ шинээр эхлүүлэх боломжтой юм. Тэр ямар нэг шинэ зүйлийг эхлэх үедээ өмнөх ажлаа дахин дурддаг ч үгүй, үргэлжлүүлэн явуулдаг ч үгүй. Учир нь Бурхан ажиллахдаа Өөрийн гэсэн зарчимтай байдаг, Түүний шинэ ажил эхлэхийг хүсдэг үе нь хүн төрөлхтнийг Өөрийн ажлын шинэ үе шатанд аваачихыг хүсдэг үе бөгөөд тэр үед Түүний ажил илүү өндөр түвшинд орно. Хэрвээ хүмүүс хуучны үгээр юм уу дүрэм журмын дагуу ажилласаар, тэдгээртэй зууралдсаар байвал Тэр үүнийг нь санахгүй, эсвэл сайшаахгүй. Учир нь Тэр аль хэдийн шинэ ажил авчирсан ба Өөрийн ажлын шинэ үе шатанд орчихсон. Шинэ ажил эхлүүлэх үедээ Тэр хүн төрөлхтөнд цоо шинэ өнцгөөс, цоо шинэ дүр төрхтэйгээр, цоо шинэ арга замаар илрэн гардаг, ингэснээр хүмүүс Түүний зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохын өөр өөр талыг харж чаддаг. Энэ нь Түүний шинэ ажил дахь Түүний зорилгуудын нэг юм. Бурхан хуучин зүйлтэй зууралддаггүй, эсвэл хуучирч элэгдсэн замаар алхдаггүй; ажиллаж, ярих үедээ Тэр хүмүүсийн төсөөлдөг шиг хориотой байдаггүй. Бурханд бүх юм чөлөөлөгдсөн, чөлөөтэй байдаг ба юу ч хориглодоггүй, ямар ч хязгаарлалт байдаггүй—Түүний хүн төрөлхтөнд авчирдаг зүйл нь эрх чөлөө болон чөлөөлөлт байдаг. Тэр бол амьд Бурхан, жинхэнээсээ үнэхээр оршин байдаг Бурхан юм. Тэр хүүхэлдэй, эсвэл шавар баримал биш бөгөөд хүмүүсийн хоймортоо залж, шүтэн мөргөдөг шүтээнүүдээс огт өөр. Тэр бол амьд, цоглог бөгөөд хүн төрөлхтөнд авчирдаг үг болон ажил нь бүгд амь, гэрэл, бүгд эрх чөлөө, чөлөөлөлт байдаг, учир нь Тэр үнэн, амь, замыг агуулдаг—Тэр Өөрийн ямар ч ажилд юунд ч баригддаггүй. Хүмүүсийн юу хэлэх нь хамаагүй, Түүний шинэ ажлыг яаж ч харж, яаж ч үнэлэх нь хамаагүй, Тэр Өөрийн ажлыг огт тээнэгэлзэлгүй биелүүлэх болно. Тэр хэний ч үзлийг, эсвэл Өөрийнх нь ажил болон үгийг буруутган чичихийг, Өөрийнх нь шинэ ажлыг хүчтэйгээр эсэргүүцэж сөрөхийг ч хүртэл тоохгүй. Бүх бүтээлийн дундаас хэн ч хүний оюун ухаан, хүний төсөөлөл, мэдлэг, эсвэл ёс суртахууныг ашиглан Бурхан юу хийдгийг хэмжиж, тодорхойлж, Түүний ажлыг гутааж, тасалдуулж, хорлон сүйтгэж чадахгүй. Түүний ажил болон Түүний хийдэг зүйлд ямар ч хориг байдаггүй; энэ нь ямар ч хүн, үйл явдал, зүйлд хязгаарлагдахгүй, үүнийг ямар ч дайсагнагч хүчин тасалдуулж чадахгүй. Түүний шинэ ажлын тухайд бол, Тэр үүрдийн ялгуусан Хаан байж, аливаа дайсагнагч хүчин болон хүн төрөлхтний бүх тэрс үзэл, төөрөгдөл Түүний хөлийн улан дор гишгэлүүлдэг. Тэрээр Өөрийн ажлын аль шинэ үе шатыг хэрэгжүүлж байгаа нь хамаагүй, энэ нь гарцаагүй хүн төрөлхтний дунд өрнөж, өргөжих бөгөөд Түүний агуу ажил гүйцэлдэх хүртэл бүхий л орчлон ертөнц даяар саадгүй хэрэгжих нь лавтай. Энэ бол Бурханы төгс хүчин, мэргэн ухаан бөгөөд Түүний эрх мэдэл, хүч чадал билээ. Тиймээс Эзэн Есүс Амралтын өдрөөр шууд гадагш гарч, ажиллаж байсан,

учир нь Түүний зүрх сэтгэлд ямар ч дүрэм байгаагүй, хүн төрөлхтнөөс үүсэн гарсан ямар ч мэдлэг, сургаал номлол байгаагүй. Түүнд байсан зүйл нь Бурханы шинэ ажил, Бурханы зам юм. Түүний ажил хүн төрөлхтнийг чөлөөлж, хүмүүсийг суллаж, гэрэлд оршин тогтнож, амьдрах боломж олгох зам байлаа. Харин шүтээн болон хуурамч бурхдыг шүтдэг хүмүүс өдөр бүр Сатанд хүлэгдэн амьдарч, бүх төрлийн дүрэм, хориг цээрт баригддаг—өнөөдөр нэг зүйл хориглогдсон бол маргааш нь өөр нэг зүйл гэх мэтээр—амьдралд нь ямар ч эрх чөлөө байдаггүй. Тэд ярьж хэлэх ямар ч баяр баясгалангүй амьдардаг, гав, дөнгөтэй хоригдол шиг л байдаг. “Хориг” гэж юуг төлөөлдөг вэ? Энэ нь хязгаарлалт, хүлээс болон мууг төлөөлдөг. Хүн нэг шүтээн шүтэж эхэлмэгцээ хуурамч бурхан, муу ёрын сүнсийг шүтэж байгаа юм. Тийм үйл ажиллагаанд оролцохын хамтаар хориг ирдэг. Чи энийг, эсвэл тэрийг идэж болохгүй, өнөөдөр гарч болохгүй, маргааш хоол хийж болохгүй, нөгөөдөр шинэ байранд нүүж орж болохгүй, хурим, эсвэл оршуулга хийхэд, эсвэл бүр хүүхэд төрүүлэхэд ч тодорхой өдрүүдийг сонгох ёстой болдог. Үүнийг юу гэдэг вэ? Үүнийг хориг гэдэг; энэ нь хүн төрөлхтний хүлээс бөгөөд тэднийг хянаж, тэдний зүрх сэтгэл, биеийг хязгаарлаж байгаа Сатан болон муу ёрын сүнснүүдийн гав дөнгө юм. Бурхан ийм хориг тавьдаг уу? Бурханы ариун байдлын талаар ярих үедээ чи эхлээд: Бурхан ямар ч хориг тавьдаггүй. Бурханд үг болон ажилдаа баримталдаг зарчим байдаг боловч ямар ч хориг тавьдаггүй, учир нь Бурхан Өөрөө үнэн, зам, амь мөн гэдэг талаар бодох ёстой.

Одоо бичвэрээс дараах эшлэлийг авч үзэцгээе: “Гэвч Би та нарт хэлье, энэ газарт сүмээс ч илүү аугаа Нэгэн байна. Хэрэв та нар Би тахилыг бус, өршөөлийг хүсдэг гэсэн нь ямар утгатай болохыг ойлгосон бол гэмгүй нэгэнийг буруутгахгүй байх байсан. Учир нь хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн” (Матай 12:6–8). Энд буй “сүм” гэх үг юуг хэлж байна вэ? Энгийн үгээр хэлбэл, “сүм” гэж сүр жавхлантай, өндөр барилгыг хэлдэг ба Хуулийн эрин үед сүм нь тахилчид Бурханд шүтэн мөргөдөг газар байсан юм. Эзэн Есүс “энэ газарт сүмээс ч илүү аугаа Нэгэн байна” гэхдээ “нэгэн” гэж хэнийг хэлсэн бэ? Мэдээжээр, “нэгэн” гэдэг нь бие махбодтой Эзэн Есүс байсан, учир нь зөвхөн Тэр л сүмээс илүү агуу байлаа. Тэдгээр үг нь хүмүүст юу хэлсэн бэ? Тэдгээр нь хүмүүсийг сүмээс гар гэж хэлсэн—Бурхан сүмийг аль хэдийн орхиж, тэнд ажиллахаа больсон байсан, тиймээс хүмүүс сүмийн гадна Бурханы мөрийг хайж, Түүний шинэ ажилд Түүний алхмыг дагах ёстой юм. Эзэн Есүс ингэж хэлсний цаад үндэслэл нь хуулийн доорх хүмүүс сүмийг Бурханаас Өөрөөс нь илүү агуу зүйл гэж үздэг болсон байв. Өөрөөр хэлбэл, хүмүүс Бурханд шүтэн мөргөхөөс илүү сүмийг шүтэж байсан учраас шүтээн бүү шүт, харин Бурханыг шүт, учир нь Тэр бол дээдийн дээд юм гэдгийг Эзэн Есүс тэдэнд анхааруулжээ. Тиймээс Тэр: “Би тахилыг бус, өршөөлийг болгооно” гэж хэлсэн юм. Эзэн Есүсийн нүдээр бол хуулийн доор амьдарч байсан ихэнх хүмүүс Еховаг шүтэн мөргөхөө больж, харин зүгээр л тахил өргөсөн дүр эсгэж байсан нь тодорхой бөгөөд Эзэн Есүс үүнийг шүтээн шүтэх явдал гэж тодорхойлсон. Эдгээр шүтээн

шүтэгч нь сүмийг Бурханаас илүү агуу, илүү дээгүүр зүйл гэж үзэж байсан. Тэдний зүрх сэтгэлд Бурхан биш, зөвхөн сүм байсан бөгөөд хэрвээ тэд сүмээ алдвал амьдрах газраа алдах байв. Сүмгүйгээр тэд шүтэх газаргүй болж, тахилаа өргөж чадахгүй болдог байлаа. Тэдний “амьдрах газар” гэгч нь сүмд байрлаж, өөрсдийн хувийн хэрэг явдлыг хэрэгжүүлэхийн тулд Ехова Бурханыг шүтэн мөргөх нэрийдлээр хуурамч дүр эсгэдэг газар юм. Тэдний “тахил өргөх” гэгч нь сүмд үйлчилж байгаа гэсэн нэрийн дор ердөө л өөрсдийнхөө хувийн ичгэвтэр ажлыг гүйцэтгэх явдал байсан юм. Энэ нь тэр үеийн хүмүүс сүмийг Бурханаас илүү агуу гэж үздэгийн шалтгаан байв. Тэд хүмүүс болон Бурханыг хуурахдаа сүмийг нүүрэн тал, тахилыг халхавч болгон ашиглаж байсан учраас Эзэн Есүс хүмүүст анхааруулахын тулд эдгээр үгийг хэлсэн билээ. Хэрвээ та нар эдгээр үгийг өнөө үед хамааруулж үзвэл энэ нь адилхан хүчинтэй, адилхан чиг хандлагатай хэвээр байна. Хэдийгээр өнөөдөр хүмүүс Хуулийн эрин үеийн хүмүүсийн туулсан Бурханы ажлаас ялгаатай ажлыг туулсан боловч тэдний уг чанар-мөн чанар нь адилхан. Өнөөдрийн ажлын орчин нөхцөлд хүмүүс “сүм бол Бурханаас илүү агуу” гэх үгээр дүрсэлсэнтэй адил төрлийн зүйлийг хийсээр л байх болно. Жишээ нь, хүмүүс үүргээ биелүүлэхийг өөрсдийн ажил мэт үздэг; Бурханд гэрчлэл хийж, агуу улаан луутай тулалдахыг тэд хүний эрхийг хамгаалсан, ардчилал, эрх чөлөөний төлөөх улс төрийн хөдөлгөөн мэтээр үздэг; тэд өөрсдийн үүргийг ашиглан ур чадвараа мэргэжил болгосон боловч Бурханаас эмээж, муугаас зайлах явдлыг зүгээр л нэг дагаж мөрдөх шашны номлолоос өөр юу ч биш мэт үздэг; гэх мэт. Эдгээр зан авир нь мөн чанартаа “сүм бол Бурханаас илүү агуу” гэсэнтэй адил биш гэж үү? Ялгаа нь гэвэл, хоёр мянган жилийн өмнө хүмүүс өөрсдийн хувийн ажил хэргийг бодит сүмд явуулж байсан бол өнөөдөр өөрсдийн хувийн ажил хэргийг биет бус сүмд явуулж байна. Дүрмийг эрхэмлэдэг тэр хүмүүс дүрмийг Бурханаас илүү агуу гэж үздэг, байр сууринд хайртай хүмүүс байр суурийг Бурханаас илүү агуу гэж үздэг, мэргэжилдээ хайртай хүмүүс мэргэжлээ Бурханаас илүү агуу гэж үздэг гэх мэт—тэдний бүхий л илэрхийлэл нь Намайг “Хүмүүс үгээрээ Бурханыг хамгийн агуу гэж магтдаг боловч тэдний нүдэнд бүх зүйл Бурханаас илүү агуу байдаг” гэж хэлэхэд хүргэж байна. Учир нь хүмүүс Бурханыг дагах замдаа өөрсдийн авьяасыг харуулж, өөрсдийн ажил хэрэг, мэргэжлийн албыг гүйцэтгэх боломж олмогцоо Бурханаас холдож, хайртай ажил мэргэжилдээ өөрсдийгөө зориулдаг. Бурханаас тэдэнд даалгасан зүйл, Бурханы хүслийн тухайд бол тэдгээр зүйл аль хэдийн хаягдсан байдаг. Энэ хүмүүс болон хоёр мянган жилийн өмнө өөрсдийн ажил хэргийг сүмд явуулж байсан хүмүүсийн байр байдал хоорондоо ямар ялгаатай юм бэ?

Дараа нь энэ хэсэг дэх “Учир нь хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн” гэсэн сүүлчийн өгүүлбэрийг харцгаая. Энэ өгүүлбэрт бодитой тал байна уу? Та нар бодитой талыг нь харж байна уу? Бурханы хэлдэг үг бүр Түүний зүрх сэтгэлээс гардаг, тэгвэл Тэр яагаад ингэж хэлсэн бэ? Та нар үүнийг хэрхэн ойлгож байна вэ? Та нар энэ өгүүлбэрийн утгыг одоо ойлгож байж магадгүй, гэхдээ үүнийг хэлсэн тэр

цагэх үед тийм ч олон хүн ойлгоогүй, учир нь хүн төрөлхтөн дөнгөж Хуулийн эрин үеэс гарч байсан юм. Тэдний хувьд Амралтын өдрийг орхих нь маш хэцүү байсан бөгөөд жинхэнэ Амралтын өдөр юу болохыг ойлгох талаар бол ярихын ч хэрэггүй.

“Хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн” гэсэн өгүүлбэр нь хүмүүст Бурханы талаарх бүх зүйл материаллаг бус шинж чанартай гэдгийг хэлж байгаа бөгөөд хэдийгээр Бурхан бүх материаллаг хэрэгцээг чинь хангаж чадах боловч бүх материаллаг хэрэгцээ чинь хангагдмагц эдгээр зүйлээс авах сэтгэл ханамж үнэний эрэл хайгуулыг чинь орлож чадах уу? Мэдээж тэгэх боломжгүй! Бидний нөхөрлөсөн Бурханы зан чанар болон Түүнд юу байгаа, Тэр юу болох нь хоёулаа үнэн юм. Үүний үнэ цэнийг, хэчнээн ч үнэ цэнтэй бай, ямар нэг материаллаг зүйлтэй харьцуулж болохгүй, мөн үнэ цэнийг нь мөнгөөр хэмжиж болохгүй, учир нь энэ бол материаллаг зүйл биш бөгөөд хүн нэг бүрийн зүрх сэтгэлийн хэрэгцээг хангадаг. Хүн бүрийн хувьд эдгээр биет бус үнэний үнэ цэн нь чиний үнэлдэг ямар ч материаллаг зүйлийн үнэ цэнээс илүү байх ёстой, тийм биз дээ? Энэ мэдэгдэл нь та нарын тунгаан бодох хэрэгтэй зүйл юм. Бурханд юу байгаа, Тэр юу болох болон Бурханы юм бүхэн хүн нэг бүрийн хувьд хамгийн чухал зүйл бөгөөд тэдгээрийг ямар ч материаллаг зүйл орлож чадахгүй гэдэг бол Миний хэлсэн үгийн гол утга нь юм. Би чамд нэг жишээ хэлье: Өлссөн үед чамд хоол хэрэгтэй. Энэ хоол нь харьцангуй сайн, эсвэл харьцангуй хангалтгүй байж болох боловч цадталаа идчих л юм бол өлсгөлөн байх тааламжгүй мэдрэмж арилна—алга болно. Чи тайван сууж чадах ба бие чинь амарна. Хүмүүсийн өлсгөлөнг хоолоор шийдэж болно, харин чи Бурханыг дагаж байхдаа Түүний талаар юу ч ойлгоогүйгээ мэдэрвэл өөрийн зүрх сэтгэл дэх хоосон байдлыг хэрхэн шийдэх вэ? Үүнийг хоолоор шийдэж болох уу? Эсвэл чи Бурханыг дагаж байхдаа Түүний хүслийг ойлгохгүй бол зүрх сэтгэл дэх тэрхүү өлсгөлөнгөө дарахын тулд юу хэрэглэх вэ? Бурханаар аврууулах туршлагынхаа явцад өөрийн зан чанарыг өөрчлөхөөр зорих зуураа хэрвээ чи Түүний хүслийг ойлгохгүй бол, эсвэл үнэн юу болохыг мэдэхгүй бол, Бурханы зан чанарыг ойлгохгүй бол сэтгэл чинь тавгүйтэх бус уу? Зүрх сэтгэл чинь айхтар өлсөж, цангахыг мэдрэх бус уу? Эдгээр мэдрэмж зүрх сэтгэлдээ амар амгаланг мэдрэхэд чинь саад болох бус уу? Иймээс чи өөрийн зүрх сэтгэл дэх тэрхүү өлсгөлөнг хэрхэн дарах вэ—үүнийг шийдэх арга зам бий юу? Зарим хүн дэлгүүр хэсдэг, зарим нь итгэл даах найзтай болдог, зарим нь ханатлаа унтдаг, бусад нь Бурханы үгийг илүү их уншдаг, эсвэл үүргээ биелүүлэхийн тулд улам шаргуу ажиллаж, илүү их хүч чармайлт зарцуулдаг. Эдгээр зүйл та нарын жинхэнэ бэрхшээлийг шийдэж чадах уу? Та нар иймэрхүү аргыг бүгдээрээ бүрэн ойлгож байгаа. Арга тасрах үед чинь, үнэний бодит байдал болон Бурханы хүслийг мэдэх боломжийг олгох Бурханы гэгээрлийг олж авъя гэсэн хүчтэй хүслийг мэдрэх үед чинь чамд юу хамгийн их хэрэгтэй вэ? Чамд хэрэгцээтэй зүйл бол их хоол ч биш, хэдэн сайхан үг ч биш, тэр ч байтугай, махан биеийн түр зуурын тав тух болон ханамж ч биш—чамд хэрэгцээтэй зүйл бол юу хийх ёстойг чинь, үүнийг хэрхэн хийх

ёстойг чинь Бурхан чамд шууд, тодорхой хэлэх, үнэн гэж юу болохыг чамд тодорхой хэлж өгөх явдал юм. Үүнийг ойлгосны дараа, өчүүхэн жаахан ойлголттой болсон ч гэсэн чиний зүрх сэтгэлд сайхан хоол идсэнээс ч илүү ханамжтай санагдахгүй гэж үү? Сэтгэл чинь хангалуун байх үед зүрх сэтгэл, бүхий л оршихуй чинь жинхэнэ амралтыг олж авдаг бус уу? Би яагаад “хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн” гэсэн энэ өгүүлбэрийг та нартай хуваалцахыг хүссэнийг энэ зүйрлэл болон шинжилгээнээс одоо ойлгож байна уу? Үүний утга нь Бурханаас ирдэг зүйл, Түүнд юу байгаа болон Тэр юу болох, Түүний юм болгон нь бусад ямар ч зүйлээс, хамгийн их нандигнан хайрладаг гэж бодож байсан зүйл юм уу хүнээс чинь ч илүү агуу юм. Өөрөөр хэлбэл, хэрвээ хүн Бурханы амнаас үг сонсож чадахгүй, Түүний хүслийг ойлгохгүй бол амралтыг олж авч чадахгүй. Намайг яагаад та нарт энэ эшлэлийг харуулах гэж хүссэнийг та нар хожмын туршлагаараа ойлгох болно—энэ бол маш чухал. Бурханы хийдэг бүхэн нь үнэн ба амь юм. Үнэн гэдэг бол хүмүүсийн амьдралд дутагдаж болохгүй зүйл, тэд үүнгүйгээр байж чадахгүй зүйл юм; бас энэ бол хамгийн агуу зүйл гэж хэлж болно. Хэдийгээр чи үүнийг харж, хүрч чадахгүй боловч ач холбогдлыг нь үл ойшоож болохгүй; энэ бол зүрх сэтгэлийг чинь амраж чадах цорын ганц зүйл билээ.

Үнэний талаарх ойлголт чинь та нарын байр байдалтай нийлж байна уу? Бодит амьдрал дээр аль үнэн нь чамтай учирсан хүмүүс, үйл явдал, зүйлстэй холбоотой байгааг чи эхлээд бодох ёстой; эдгээр үнэний дундаас л чи Бурханы хүслийг олж, өөртөө тулгарсан зүйлийг Түүний хүсэлтэй холбож чадах юм. Үнэний аль тал нь чамд учирсан зүйлстэй холбоотой болохыг мэдэлгүйгээр шууд Бурханы хүслийг хайхаар явбал энэ нь үр дүнд хүрч чадахгүй харалган хандлага юм. Хэрэв чи үнэнийг хайж, Бурханы хүслийг ойлгохыг хүсэж байгаа бол эхлээд чамд ямар зүйлс тохиолдсон, тэдгээр нь үнэний ямар талтай холбоотой болохыг харж, чиний туулсан зүйлтэй холбоотой зарим үнэнийг Бурханы үгээс хайх хэрэгтэй. Дараа нь өөртөө тохирох хэрэгжүүлэлтийн замыг тэрхүү үнэнээс хай; ийм маягаар чи Бурханы хүслийг шууд бусаар ойлгож чадна. Үнэнийг хайж, хэрэгжүүлэх нь эргэцүүлж бодолгүй шууд л нэг сургаалыг хэрэглэх, эсвэл нэг хэв загварыг дагах явдал биш юм. Үнэн бол нэгэн хэвийн зүйл ч биш, хууль ч биш. Энэ нь үхмэл биш—энэ бол амь өөрөө, энэ бол амьд зүйл бөгөөд бүтээгдсэн зүйлийн амьдралдаа дагах ёстой дүрэм, өөрийнхөө амьдралд байлгах ёстой дүрэм юм. Энэ бол туулсан туршлагаараа аль болох их ойлгох ёстой зүйл билээ. Чи өөрийнхөө туршлагаар ямар түвшинд хүрсэн нь хамаагүй, энэ бүгд Бурханы үг болон үнэнээс салшгүй байдаг. Бурханы зан чанарын талаар юу ойлгодог чинь, мөн Бурханд юу байгаа, Тэр юу болох талаар юу мэддэг чинь бүгд Бурханы үгээр илэрхийлэгддэг; тэдгээр нь үнэнээс салгах аргагүй холбоотой байдаг. Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох нь өөрсдөө үнэн юм; уг үнэн нь Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохын жинхэнэ илрэл билээ. Энэ нь Бурханд юу байгаа, Тэр юу болохыг тод томруун болгож, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг тодорхой илэрхийлдэг; энэ

нь Бурхан юунд дуртай, Тэр юунд дургүй, Тэр чамаас юу хий гэж хүсдэг, Тэр чамд юу хийхийг зөвшөөрдөггүй, ямар хүмүүсийг Тэр жигшдэг, ямар хүмүүсийг Тэр бахаддагийг чамд илүү тодорхой хэлж өгдөг. Бурханы илэрхийлдэг үнэний ард Түүний баяр баясгалан, уур, гуниг, аз жаргал болон Түүний мөн чанар байгааг хүмүүс харж болно—энэ нь Түүний зан чанарын илэрхийлэл юм. Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг мэдэж, Түүний үгээс зан чанарыг нь ойлгохоос гадна хамгийн чухал зүйл бол бодитой туршлагаар энэхүү ойлголтод хүрэх шаардлага юм. Хэрвээ хүн Бурханыг мэдэхийн тулд бодит амьдралаас холдвол үүнийгээ биелүүлж чадахгүй. Бурханы үгээс зарим нэг ойлголт олж авч чаддаг хүмүүс байсан ч гэсэн тэдний ойлголт нь онол болон үгээр хязгаарлагддаг бөгөөд Бурхан Өөрөө яг ямар вэ гэдгээс зөрүүтэй байдаг.

Бидний одоо ярилцаж байгаа зүйлс бүгд Библид тэмдэглэсэн түүхийн цар хүрээнд байдаг. Эдгээр түүхээр дамжуулан, эдгээр тохиолдсон зүйлсийг шинжилснээр дамжуулан хүмүүс Түүний зан чанарыг болон Түүний илэрхийлсэн Түүнд юу байгаа, Тэр юу болохыг ойлгож чадах ба энэ нь Бурханы бүх талыг илүү өргөн, илүү гүнзгий, илүү ойлгомжтой, илүү нарийн ойлгох боломжийг тэдэнд олгодог. Тэгэхээр Бурханы бүх талыг таних цорын ганц арга зам нь эдгээр түүхийг мэдэх явдал уу? Үгүй ээ, энэ нь цорын ганц арга зам биш! Учир нь, Хаанчлалын эрин үед Бурханы хэлдэг зүйл, хийдэг ажил нь Түүний зан чанарыг мэдэж, үүнийг илүү бүрэн мэдэхэд хүмүүст илүү сайн тусалж чаддаг. Гэвч хүмүүсийн сайн мэддэг Библид тэмдэглэсэн түүх юм уу жишээгээр дамжуулан Бурханы зан чанарыг, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг ойлгох нь арай хялбар гэж Би бодож байна. Би шүүлт, гэсгээлтийн үгсийг болон өнөөдөр Бурханы илэрхийлдэг үнэнийг үг үгээр нь хэлж, ийм маягаар Бурханыг мэдүүлэх гэвэл чамд энэ нь хэтэрхий улиг болсон, хэтэрхий залхмаар санагдах бөгөөд тэр ч байтугай, зарим хүнд Бурханы үг нэгэн хэвийн санагдах болно. Харин Бурханы зан чанарыг мэдэхэд нь хүмүүст туслахын тулд Би Библийн түүхүүдийг жишээ болгон авах юм бол хүмүүст уйтгартай санагдахгүй. Тэр үед Бурханы зүрх сэтгэлд юу байсан тухай—Түүний ааш зан, уян сэтгэл, эсвэл Түүний бодол, санаа гээд нарийн зүйлс хүмүүст хүний хэлээр өгүүлэгдсэн, эдгээр жишээг тайлбарлах явцад энэ бүхний зорилго нь Бурханд юу байгаа, Тэр юу болох нь нэгэн хэвийн биш гэдгийг тэдэнд ойлгуулж, мэдрүүлэх явдал гэж хэлж болох юм. Энэ нь домог биш, эсвэл хүмүүсийн харж, хүрч чадахгүй зүйл ч биш. Энэ бол үнэхээр оршин байдаг, хүмүүсийн мэдэрч, ойлгож чадах зүйл гэдгийг тэдэнд ойлгуулж, мэдрүүлдэг. Энэ бол эцсийн зорилго билээ. Энэ эрин үед амьдарч байгаа хүмүүс ерөөгдсөн гэж хэлж болно. Бурханы өмнөх ажлын талаар илүү өргөн ойлголтыг олж авахын тулд тэд Библийн түүхүүдийг ашигладаг; Түүний хийсэн ажлаас тэд Түүний зан чанарыг харж чадна; Бурханы илэрхийлсэн эдгээр зан чанараар дамжуулан хүн төрөлхтнийг гэх Бурханы хүслийг ойлгож, Түүний ариун байдлын тод томруун илрэл болон хүмүүсийг гэх анхаарал халамжийг нь ойлгож чадна, ийм маягаар тэд Бурханы зан чанарын талаар илүү нарийн, илүү гүн гүнзгий

мэдлэгт хүрч чадна. Та нар одоо бүгдээрээ үүнийг мэдэрч байгаа гэдэгт Би итгэж байна!

Нигүүлслийн эрин үед Эзэн Есүсийн дуусгасан ажлын цар хүрээнээс Бурханд юу байгаа, Тэр юу болохын өөр нэг талыг харж болно. Энэ тал нь Түүний бие махбодоор дамжин илэрхийлэгдсэн бөгөөд Түүний хүн чанараас хүмүүс үүнийг харж, ойлгож чадсан юм. Махбод дахь Бурхан Өөрийн хүн чанарыг хэрхэн амьдран харуулсныг хүмүүс хүний Хүүгээс харсан бөгөөд махбодоор илэрхийлэгдсэн Бурханы бурханлаг чанарыг харсан юм. Энэ хоёр төрлийн илэрхийлэл нь тун бодитой Бурханыг харах боломжийг хүмүүст олгож, Бурханы талаар өөр ухагдахуунтай болох боломжийг олгосон. Гэвч дэлхийг бүтээснээс Хуулийн эрин үеийн төгсгөл хүртэлх цаг хугацаанд, өөрөөр хэлбэл, Нигүүлслийн эрин үеэс өмнө хүмүүсийн харж, сонсож, туулсан Бурханы талууд нь Бурханы бурханлаг чанар, материаллаг бус хүрээнд Бурханы хийсэн, хэлсэн зүйл, мөн харж, хүрч болшгүй үнэн биеэсээ Түүний илэрхийлсэн зүйлс байлаа. Эдгээр зүйл нь хүмүүст, Бурхан агуу байдлаараа сүндэрлэж байдаг бөгөөд тэд Түүнд ойртож чадахгүй гэдгийг байнга мэдрүүлдэг байв. Бурхан өөрсдийнх нь ухамсарлах чадварт жирсхийн орж ирээд гараад явчихдаг гэсэн сэтгэгдлийг хүмүүст Бурхан төрүүлсэн бөгөөд Түүний бодол, санаа нэг бүрийг ойлгож, ухаарахаар оролдох нь байтугай тэдгээрт хүрэх ямар ч аргагүй, маш нууцлаг, баригдашгүй гэж хүмүүст санагддаг байлаа. Хүмүүсийн хувьд Бурханы бүх зүйл маш хол, хүмүүс харж, хүрч чадахааргүй тун хол байв. Тэрээр тэнгэрт өндөрт байгаа мэт санагддаг, бас огт оршин байдаггүй мэт санагддаг байлаа. Иймээс хүмүүсийн хувьд Бурханы зүрх сэтгэл, санааг, эсвэл Түүний ямар нэгэн бодлыг ойлгох нь биелшгүй, бүр хүрэхийн ч аргагүй байсан юм. Хэдийгээр Бурхан Хуулийн эрин үед тодорхой зарим ажил гүйцэтгэж, түүнчлэн Түүний тухай зарим нэг бодитой мэдлэгийг биеэр туулж, ухамсарлах боломжийг хүмүүст олгох нэлээд нарийн тодорхой үг хэлж, нэлээд нарийн тодорхой зан чанар илэрхийлсэн боловч эцсийн эцэст, Бурханд юу байгаа, Тэр юу болохын эдгээр илэрхийлэл нь материаллаг бус хүрээнээс ирсэн бөгөөд хүмүүсийн ойлгосон, мэдсэн зүйл мөн л Түүнд юу байгаа, Тэр юу болохын бурханлаг тал байсан юм. Хүн төрөлхтөн Түүнд юу байгаа, Тэр юу болох тухай энэ илэрхийллээс тодорхой үзэл баримтлал олж авч чадаагүй бөгөөд Бурханы талаарх сэтгэгдэл нь “ойртоход хэцүү, мэдрэхүйд жирсхийн орж ирээд, гараад явчихдаг сүнслэг биеийн” цар хүрээн дотор гацсан хэвээр байлаа. Бурхан хүмүүсийн өмнө харагдахын тулд материаллаг ертөнцийн онцгой нэг объект юм уу дүр зураг хэрэглээгүй учраас тэд Түүнийг хүний хэл ашиглан тодорхойлж бас л чадаагүй. Хүмүүс зүрх сэтгэл болон оюун ухаандаа Бурханд стандарт тогтоож, Тэр хэр өндөр, хэр том байдаг, ямар харагддаг, яг юунд дуртай, Түүний зан байдал ямар байдаг гэх зэргээр Түүнийг бодит болгож, хүн шиг болгохын тулд өөрсдийн хэлийг ашиглахыг үргэлж хүсэж байлаа. Үнэндээ, хүмүүс ингэж бодож байсныг Бурхан зүрх сэтгэлдээ мэдэж байв. Тэрээр хүмүүсийн хэрэгцээг огт анддаггүй байсан, мэдээж Өөрөө юу хийх ёстойгоо

ч мэдэж байсан тул Нигүүлслийн эрин үед Өөрийн ажлыг өөр арга замаар хэрэгжүүлсэн. Энэ шинэ арга зам нь бурханлаг, бас хүнлэг байсан. Эзэн Есүсийг ажиллаж байх үеэр Бурханд хүн чанарын олон илэрхийлэл байдгийг хүмүүс харсан. Жишээ нь, Тэр бүжиглэж чаддаг, хуримд оролцож чаддаг, хүмүүстэй харилцаж, тэдэнтэй ярьж, тэдэнтэй аливааг хэлэлцэж чаддаг байсан. Түүнчлэн Эзэн Есүс бас бурханлаг чанарыг нь төлөөлсөн маш их ажил гүйцэтгэсэн бөгөөд мэдээжээр, энэ бүх ажил нь Бурханы зан чанарын илэрхийлэл, илчлэл байлаа. Хүмүүсийн харж, хүрч болох эгэл жирийн бие махбодод Бурханы бурханлаг чанар биеллээ олсон энэ үед Тэрээр жирсхийн гарч ирээд явдаг, мөн Түүнд ойртож чадахгүй гэж хүмүүст санагдахаа больсон юм. Харин ч тэд хүний Хүүгийн хөдөлгөөн, үг, ажил болгоноос Бурханы хүслийг ухаарч, бурханлаг чанарыг нь ойлгох гэж оролдож байв. Бие махбодтой болсон хүний Хүү нь Өөрийн хүн чанараар Бурханы бурханлаг чанарыг илэрхийлсэн бөгөөд Бурханы хүслийг хүн төрөлхтөнд дамжуулсан билээ. Үүний зэрэгцээ Тэрээр Бурханы хүсэл, зан чанарыг илэрхийлснээрээ дамжуулан сүнсний ертөнцөд оршдог харж, хүрч болохгүй Бурханыг хүмүүст илчилсэн. Хүмүүсийн харсан зүйл нь мах, цуснаас бүтсэн бодит Бурхан Өөрөө байв. Иймээс бие махбодтой болсон хүний Хүү нь Бурханы Өөрийн ялгамж чанар, Бурханы байр суурь, дүр төрх, зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг тодорхой, хүний шинжтэй болгосон. Бурханы төрхийн хувьд хүний Хүүгийн гадаад байдалд тодорхой хэмжээний хязгаарлалт байсан хэдий ч Түүний мөн чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох нь бүхэлдээ Бурханы Өөрийн ялгамж чанар, байр суурийг төлөөлж чадаж байсан—зөвхөн илэрхийлэх хэлбэрт нь л зарим нэг ялгаа байсан юм. Хүний Хүү нь Өөрийн хүн чанар, бурханлаг чанарын аль алинаар Бурханы Өөрийн ялгамж чанар, байр суурийг төлөөлж байсан гэдгийг бид үгүйсгэж чадахгүй. Гэхдээ энэ хугацаанд Бурхан махбодоор ажиллаж, махбодын өнцгөөс ярьж, хүн төрөлхтний өмнө хүний Хүүгийн ялгамж чанар болон байр суурьтайгаар зогсож байсан бөгөөд энэ нь хүн төрөлхтний дундах Бурханы үнэн үг болон ажилтай харьцаж, туулах боломжийг хүмүүст олгосон юм. Энэ нь бас Түүний бурханлаг чанар, даруу атлаа агуу байдлыг ухаарах, түүнчлэн Бурханы үнэн ба бодит байдлын тухай урьдчилсан ойлголт, тодорхойлолт олж авах боломжийг хүмүүст олгосон. Хэдийгээр Эзэн Есүсийн гүйцэтгэсэн ажил, Түүний ажиллах аргууд, ярьсан өнцөг нь сүнсний ертөнц дэх Бурханы жинхэнэ биеэс ялгаатай байсан боловч Түүний бүх зүйл нь урьд өмнө хүн төрөлхтний хэзээ ч харж байгаагүй Бурханыг Өөрийг нь үнэхээр төлөөлж байсан—үүнийг үгүйсгэж болохгүй! Өөрөөр хэлбэл, Бурхан ямар хэлбэрээр илрэн гарах нь хамаагүй, ямар өнцгөөс ярих нь, эсвэл ямар дүр төрхтэйгээр хүн төрөлхтөнтэй нүүр учрах нь хамаагүй, Бурхан өөр юуг ч биш харин Өөрийгөө л төлөөлдөг. Тэрээр ямар нэг хүнийг, эсвэл завхарсан ямар ч хүн төрөлхтнийг төлөөлж чадахгүй. Бурхан бол Бурхан Өөрөө бөгөөд үүнийг үгүйсгэж болохгүй.

Дараа нь бид Нигүүлслийн эрин үед Эзэн Есүсийн ярьсан сургаалт зүйрлэлийг авч үзэх болно.

3. Алдагдсан хонины тухай сургаалт зүйрлэл

Матай 18:12–14 Та нар юу гэж бодож байна? Хэрвээ хүн зуун хоньтой байгаад тэдний нэг нь төөрч явсан бол тэр хүн ерэн есөн хонио үлдээгээд уул руу явж, төөрсөн нэг хонио эрж хайхгүй гэж үү? Тэгээд түүнийг олбол тэр хонь нь төөрөөгүй үлдсэн ерэн есөн хониоос ч илүү баярлуулна гэж Би та нарт лавтай хэлнэ. Тэгээд ч бас энэ багачуудаас нэг нь алдагдах нь тэнгэрт буй Эцэгийн чинь хүсэл биш юм.

Энэ хэсэг бол сургаалт зүйрлэл—энэ нь хүмүүст ямархуу мэдрэмж өгдөг вэ? Энд ашигласан илэрхийлллийн арга буюу сургаалт зүйрлэл нь хүний хэлний уран дүрслэл бөгөөд ийм болохоор энэ нь хүний мэдлэгийн хүрээнд хамаардаг. Хэрвээ Бурхан Хуулийн эрин үед үүнтэй төстэй зүйл хэлсэн бол ийм үг нь Бурхан хэн болохтой үнэхээр нийцэхгүй байнагэж хүмүүст санагдах байсан, харин Нигүүлслийн эрин үед хүний Хүү эдгээр үгийг өгүүлэх үед энэ нь хүмүүст сэтгэл зассан, аятайхан бөгөөд дотно санагдсан. Бурхан махбодтой болж, хүний дүр төрхөөр гарч ирэхдээ Өөрийн зүрх сэтгэлийн дуу хоолойг илэрхийлэхийн тулд Өөрийнх нь хүн чанараас бий болсон маш тохиромжтой сургаалт зүйрлэл ашигласан. Энэ дуу хоолой нь Бурханы дуу хоолойг болон тухайн эрин үед хийхийг хүссэн Түүний ажлыг төлөөлжээ. Энэ нь мөн Нигүүлслийн эрин үеийн хүмүүст хандах Бурханы хандлагыг төлөөлсөн. Хүмүүст хандах Бурханы хандлагын өнцгөөс авч үзвэл, Тэрээр хүн бүрийг хоньтой зүйрлэсэн юм. Хэрэв нэг хонь төөрвөл түүнийг олохын тулд Тэр хэрэгтэй бүхнийг хийх байсан. Энэ нь тухайн үед хүн төрөлхтний дунд махбодод байх үеийн Бурханы ажлын зарчмыг төлөөлсөн. Бурхан тэрхүү ажилд гаргах Өөрийн эрмэлзэл болон хандлагыг дүрслэхийн тулд энэ сургаалт зүйрлэлийг ашигласан юм. Энэ нь Бурхан махбод болсны давуу тал байв: Тэрээр хүн төрөлхтний мэдлэгийг ашиглан хүний хэлээр хүмүүстэй ярьж, Өөрийн хүслийг илэрхийлж чадсан. Тэрээр хүмүүсийн ойлгошгүй гүн гүнзгий, бурханлаг хэлээ хүний хэлээр, хүний арга замаар хүмүүст тайлбарлаж, “орчуулж өгсөн”. Энэ нь Түүний хүслийг ойлгож, Тэр юу хийхийг хүсэж байсныг мэдэхэд нь хүмүүст тусалсан юм. Тэр мөн хүний хэл хэрэглэн хүмүүстэй хүний өнцгөөс яриа өрнүүлж, хүмүүст ойлгогдохуйцаар ярилцаж чадаж байв. Тэрчлэн хүний хэл, мэдлэгийг хэрэглэн ярьж, ажиллаж, хүмүүст Бурханы сайн санаа, ойр дотно байдлыг мэдрүүлж, зүрх сэтгэлийг нь харуулж чадсан. Та нар үүнээс юу харж байна вэ? Бурханы үг болон үйлдэлд ямар нэг хориг байна уу? Хүмүүсийн үзэж байгаагаар бол Бурхан Өөрийнхөө хэлэхийг хүссэн зүйл, хийхийг хүссэн ажлын талаар ярихдаа, эсвэл Өөрийн хүслийг илэрхийлэхдээ хүний мэдлэг, хэл, ярих маягийг ашиглах ямар ч аргагүй. Гэвч энэ нь эндүү ташаа бодол юм. Бурхан ийм төрлийн сургаалт зүйрлэл хэрэглэснээр хүмүүс Бурханы бодит байдал болон чин сэтгэлийг мэдэрч, тэр үеийн хүмүүст хандаж байсан хандлагыг нь харж чадсан. Энэ сургаалт зүйрлэл нь хуулийн дор удаан хугацаанд амьдарч байсан хүмүүсийг нойрноос нь сэрээсэн бөгөөд Нигүүлслийн эрин үед амьдарч байсан хүмүүсийн

дараа дараагийн үеийнхэнд ч урам зориг өгсөн. Энэ сургаалт зүйрлэлийн хэсгийг уншсанаар хүмүүс хүн төрөлхтнийг аврах гэсэн Бурханы чин сэтгэлийг мэдэж, Бурханы зүрх сэтгэлд хүн төрөлхтний эзлэх жин, ач холбогдлыг ойлгодог.

Энэ хэсгийн сүүлчийн өгүүлбэрийг харцгаая: “Тэгээд ч бас энэ багачуудаас нэг нь алдагдах нь тэнгэрт буй Эцэгийн чинь хүсэл биш юм.” Энэ нь Эзэн Есүсийн өөрийнх нь үг байсан уу, эсвэл тэнгэрт буй Эцэгийн үг байсан уу? Өнгөцхөн авч үзвэл Эзэн Есүс ярьж байгаа мэт харагдах боловч Түүний хүсэл нь Бурханы Өөрийн хүслийг төлөөлдөг тул Тэр: “Тэгээд ч бас энэ багачуудаас нэг нь алдагдах нь тэнгэрт буй Эцэгийн чинь хүсэл биш юм” гэж хэлжээ. Тухайн үеийн хүмүүс зөвхөн тэнгэрт буй Эцэгийг л Бурхан гэж хүлээн зөвшөөрсөн бөгөөд өөрсдийнх нь нүдний өмнө харагдаж байсан энэ хүн ердөө л Түүний илгээсэн хүн бөгөөд тэнгэрт буй Эцэгийг төлөөлж чадахгүй гэж үзэж байлаа. Тийм учраас, Эзэн Есүс энэ сургаалт зүйрлэлийн төгсгөлд энэ өгүүлбэрийг нэмэх ёстой болсон, ингэснээр хүмүүс хүн төрөлхтний төлөөх Бурханы хүслийг лавтай мэдэрч, Түүний хэлсэн үгийн үнэн магадтай, нарийн зөв байдлыг мэдэрч чадах байсан юм. Хэдийгээр энэ өгүүлбэр нь хэлэхэд энгийн нэг зүйл байсан боловч халамж, хайраар хэлэгдсэн бөгөөд Эзэн Есүсийн даруу, нууцлаг байдлыг харуулжээ. Бурхан махбод болсон ч бай, эсвэл сүнсний ертөнцөд ажилласан ч бай, хүний зүрх сэтгэлийг хамгийн сайн мэддэг, хүмүүст юу хэрэгтэйг хамгийн сайн ойлгодог байсан, хүмүүс юунд санаа зовдог, тэднийг юу төөрөгдүүлдгийг мэддэг байсан, тийм учраас Тэр энэ өгүүлбэрийг нэмсэн юм. Энэ өгүүлбэр нь хүн төрөлхтөнд нуугдсан нэг асуудлыг тодруулсан: Хүмүүс хүний Хүүгийн хэлсэн зүйлд үл итгэж байсан болохоор Эзэн Есүс ярьж байх үедээ: “Тэгээд ч бас энэ багачуудаас нэг нь алдагдах нь тэнгэрт буй Эцэгийн чинь хүсэл биш юм” гэж нэмж хэлэх ёстой болсон бөгөөд зөвхөн энэ шалтгаанаар л Түүний үг үр дүнд хүрч, тэдгээрийн нарийн зөвд хүмүүсийг итгүүлж, тэдгээрийн үнэмшилтэй байдлыг сайжруулж чадах байсан. Бурхан жирийн нэг хүний Хүү болоход Бурхан ба хүн төрөлхтний харилцаа маш төвөгтэй болж, хүний Хүүгийн нөхцөл байдал маш бэрхшээлтэй байсан гэдгийг энэ нь харуулдаг. Мөн тухайн үед хүмүүсийн дунд Эзэн Есүсийн эзлэх байр суурь хэчнээн ялихгүй байсныг харуулдаг. Тэр үүнийг хэлэхдээ үнэндээ хүмүүст, эдгээр үг бол Миний Өөрийн зүрх сэтгэлд юу байгааг төлөөлөөгүй, харин та нарын зүрх сэтгэлдээ тээдэг Бурханы хүсэл гэдэгт та нар итгэж болно гэж хэлэх гэсэн юм. Хүн төрөлхтний хувьд энэ нь егөөтэй зүйл байсан бус уу? Хэдийгээр Бурхан махбодоор ажиллах нь Түүний үнэн биед байдаггүй олон давуу талтай байсан боловч Тэр тэдний эргэлзээ, үл тоох байдал, түүнчлэн тэдний хөшүүн байдал, мунхаг занг сөрөх хэрэгтэй байлаа. Хүний Хүүгийн ажлын үйл явц нь хүн төрөлхтний гололтыг амсаж, Өөрийнх нь эсрэг тэмцлийг туулах үйл явц байсан гэж хэлж болно. Түүнээс гадна, биечлэн ажиллаж, Түүнд юу байгаа болон Тэр юу болохоороо, мөн Өөрийн мөн чанараар хүн төрөлхтний итгэлийг тасралтгүй олж авч, хүн төрөлхтнийг байлдан дагуулах үйл явц байсан юм. Энэ нь бие махбодтой болсон Бурхан газар дээр Сатаны эсрэг

дайн хийж байсан зүйл биш байв; харин ч энэ бол Бурхан эгэл хүн болж, Өөрийг нь дагаж байсан хүмүүстэй тэмцэж эхэлсэн явдал байсан бөгөөд энэхүү тэмцэлд хүний Хүү Өөрийн даруу зангаар, Түүнд юу байгаа болон Тэр юу болохоор, мөн Өөрийн хайр, мэргэн ухаанаар Өөрийн ажлыг гүйцээсэн юм. Тэр Өөрийн хүссэн хүмүүсийг олж авч, Өөртөө тохирох ялгамж чанар, байр суурийг эзэмшиж, Өөрийн сэнтийд "эргэн очсон."

Дараа нь доорх хоёр хэсгийг судраас авч үзэцгээе.

4. Дал дахин долоон удаа уучлах

Матай 18:21–22 Дараа нь Петр Түүн дээр ирж, "Эзэн минь, ах дүү маань миний эсрэг бурууг үйлдвэл би түүнийг хэдэн удаа уучлах вэ? Долоон удаа юу?" гэв. Есүс түүнд: "Би чамд долоон удаа биш, харин дал дахин долоон удаа гэж хэлье" гэжээ.

5. Эзэний Хайр

Матай 22:37–39 Есүс түүнд, "Чи өөрийн Бурхан Эзэнийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх ухаанаараа хайрла. Энэ бол эн тэргүүний бөгөөд хамгийн том тушаал юм. Мөн хоёр дахь нь ч бас адилхан, чи бусдыг өөрийн адил хайрла" гэжээ.

Энэ хоёр хэсгийн нэг нь уучлалын тухай, нөгөө нь хайрын тухай өгүүлдэг. Энэ хоёр сэдэв нь Эзэн Есүсийн Нигүүлслийн эрин үед хэрэгжүүлэхийг хүссэн ажлыг үнэхээр тодотгодог.

Бурхан махбод болохдоо Өөрийн ажлын нэг үе шатыг авчирсан нь тухайн эрин үе дэх тодорхой ажил, Түүний илэрхийлэхийг хүссэн зан чанар байсан юм. Тухайн үед хүний Хүүгийн хийсэн бүхэн нь тэр эрин үед Бурханы хийхийг хүссэн ажлын эргэн тойронд явагджээ. Тэр үүнээс илүүг ч, дутууг ч хийхгүй байсан. Түүний хэлсэн юм болгон, хэрэгжүүлсэн бүх төрлийн ажил нь бүгд энэ эрин үед хамаатай байв. Тэр үүнийг хүний хэлээр хүний арга замаар илэрхийлсэн ч бай, эсвэл бурханлаг хэлээр илэрхийлсэн ч бай, ямар аргаар, эсвэл ямар өнцгөөс тийнхүү үйлдсэн нь хамаагүй, Түүний зорилго бол Тэр юу хийхийг хүсдэг, Түүний хүсэл юу болох, Тэр хүмүүсээс юу шаарддагийг ойлгоход хүмүүст туслах явдал байсан юм. Түүний хүслийг ойлгож мэдэж, хүн төрөлхтнийг аврах Түүний ажлыг ойлгоход нь хүмүүст туслахын тулд Тэр янз бүрийн арга барил, өөр өөр үзэл бодол ашиглаж байв. Иймээс Нигүүлслийн эрин үед, хүн төрөлхтөнтэй ярилцахыг хүссэн зүйлээ илэрхийлэхийн тулд Эзэн Есүс ихэвчлэн хүний хэл ашиглаж байсныг бид хардаг. Үүнээс гадна, бид Түүнийг хүмүүстэй ярилцаж, хэрэгцээг нь хангаж, хүссэн зүйлээр нь тусалж байсан эгэл нэгэн замч гэдэг өнцгөөс хардаг. Ингэж ажиллах нь Нигүүлслийн эрин үеийн өмнөх Хуулийн эрин үед үзэгдээгүй зүйл байв. Тэр хүн төрөлхтөнтэй илүү дотно, илүү энэрэнгүй болсон ба түүнчлэн арга, хэлбэрийн аль алинаар илүү бодитой үр дүнд хүрч чадсан. Хүмүүсийг дал дахин долоон удаа уучлах тухай зүйрлэл энэ санааг үнэхээр тодорхой болгодог. Энэ зүйрлэл дэх тооны зорилго нь үүнийг өгүүлэх үеийн Эзэн Есүсийн санаа зорилгыг хүмүүст

ойлгуулах явдал байв. Түүний санаа зорилго бол хүмүүс бусдыг нэг юм уу хоёр удаа ч биш, бүр долоон удаа ч биш, харин дал дахин долоон удаа уучлах ёстой гэдэг санаа байлаа. “Дал дахин долоон удаа” гэх санаан дотор ямар гээчийн санаа агуулагддаг вэ? Энэ нь, уучлалыг өөрсдийн хариуцлага, сурах ёстой зүйл, баримтлах ёстой “зам” болгоход хүмүүсийг хүргэхийн төлөө байв. Хэдий энэ нь зүгээр л нэг зүйрлэл боловч гол чухал зүйлийг тодруулж өгсөн билээ. Энэ нь, Түүний санааг ихэд ойлгож, хэрэгжүүлэлтийн зохистой арга зам ба хэрэгжүүлэлтийн зарчим, стандартыг олоход хүмүүст тусалсан. Энэхүү зүйрлэл тодорхой ойлгоход нь хүмүүст тусалсан бөгөөд тэд ямар ч болзолгүйгээр, ямар ч хязгааргүйгээр, бусдыг ойлгож, хүлээцтэй байх хандлагатайгаар уучилж сурах ёстой гэсэн тодорхой үзэл баримтлалыг тэдэнд өгчээ. Эзэн Есүс үүнийг хэлэх үед зүрх сэтгэлд нь юу байсан бэ? Тэр үнэхээр “дал дахин долоон удаа” гэх тоог гэж бодож байсан уу? Үгүй, тэгээгүй. Бурхан хүнийг хэдэн удаа уучлах тоо байдаг уу? Энд дурдсан “хэдэн удаа” гэдгийг маш их сонирхдог, энэ тооны эх үүсвэр болон утга учрыг ойлгохыг үнэхээр хүсдэг олон хүн бий. Яагаад энэ тоо Эзэн Есүсийн амнаас гарсныг тэд ойлгохыг хүсдэг; энэ тоонд илүү гүнзгий далд утга бий гэж тэд боддог. Гэхдээ үнэндээ энэ бол зүгээр л Бурханы ашигласан хүний ярианы зүйрлэл байсан. Ямар нэг далд санаа, эсвэл утга учрыг Эзэн Есүсийн хүн төрөлхтөнд тавьсан шаардлагын хамтаар авч үзэх ёстой. Бурхан хараахан махбод болоогүй байх үед Түүний үг бүрэн бурханлаг чанараас гардаг байсан учраас хүмүүс хэлсэн зүйлийнх нь ихэнхийг ойлгодоггүй байлаа. Түүний хэлсэн зүйлийн өнцөг болон нөхцөл байдал нь хүмүүст харагдашгүй, хүршгүй байсан; үүнийг хүмүүсийн харж чаддаггүй сүнсний ертөнцөөс илэрхийлдэг байсан. Махан биед амьдардаг хүмүүсийн хувьд тэд сүнсний ертөнцөд нэвтэрч чадахгүй байсан юм. Гэхдээ Бурхан махбод болсныхоо дараа хүн чанарын өнцгөөс хүн төрөлхтөнтэй ярьсан бөгөөд сүнсний ертөнцөөс гарч, цар хүрээг нь давсан. Бурханыг ойлгож, мэдэх, Түүний санаа зорилго болон тэдний чадварын цар хэмжээнд тааруулан шаардсан стандартыг чадах хэрээрээ ойлгож ухаарах боломжийг хүн төрөлхтөнд олгохын тулд Тэр хүмүүсийн төсөөлж чадах зүйлсээр болон амьдралдаа харсан, тулгарсан зүйлсээр нь дамжуулан, хүмүүсийн хүлээн авч чадах аргыг ашиглан, ойлгож чадах хэлээр нь, олж авч чадах мэдлэгээр нь дамжуулан Өөрийн бурханлаг зан чанар, хүсэл, хандлагыг илэрхийлж чадсан юм. Энэ нь Бурханы хүн чанар дахь ажлын арга барил, зарчим байлаа. Хэдийгээр махбодод ажиллах Бурханы арга зам болон зарчмууд нь ихэвчлэн хүн чанарын арга барилаар, эсвэл хүн чанарар дамжин биелж байсан боловч энэ нь шууд бурханлаг чанараар ажиллаад хүрч чадахааргүй үр дүнд үнэхээр хүрч чадсан юм. Хүн чанар дахь Бурханы ажил илүү тодорхой, жинхэнэ, зорилттой, арга барил нь хавьгүй уян хатан байсан бөгөөд хэлбэрээрээ Хуулийн эрин үед хийгдсэн ажлыг давж гарсан.

Одоо Эзэнийг хайрлах, хөршөө өөр шигээ хайрлах талаар ярилцъя. Энэ нь шууд бурханлаг чанараар илэрхийлсэн зүйл мөн үү? Үгүй, мэдээж тийм биш!

Эдгээр нь хүний Хүүгийн хүн чанарааараа хэлсэн бүх зүйл байсан; хүмүүс л “Хөршөө өөр шигээ хайрла”, “Өөрийнхөө амийг нандигнадаг шигээ бусдыг хайрла” гэх мэтийн зүйл хэлдэг. Гагцхүү хүмүүс л иймэрхүү маягаар ярьдаг. Бурхан хэзээ ч ийм маягаар ярьж байгаагүй. Наад зах нь, хүн төрөлхтнийг гэсэн Өөрийн хайрыг зохицуулахын тулд “хөршөө өөр шигээ хайрла” гэх маягийн зарчим Түүнд хэрэггүй учраас, мөн хүн төрөлхтнийг гэсэн Бурханы хайр нь Түүнд юу байгаа, Тэр юу болохын төрөлхийн илчлэл учраас Бурханы бурханлаг чанарт ийм төрлийн хэл байдаггүй. Бурхан: “Би хүн төрөлхтнийг Өөр шигээ хайрладаг” гэх мэтийн зүйл хэлж байхыг та нар ер нь хэзээ сонссон юм бэ? Та нар тэгж сонсоогүй, учир нь, хайр бол Бурханы мөн чанарт, Түүнд юу байгаа, Тэр юу болоход байдаг билээ. Хүн төрөлхтнийг хайрлах Бурханы хайр, Түүний хандлага, хүмүүст хандах арга зам нь Түүний зан чанарын жам ёсны илэрхийлэл, илчлэл юм. Тэр үүнийг тодорхой нэгэн арга замаар зориуд хийх хэрэггүй, эсвэл хөршөө Өөр шигээ хайрладаг болохын тулд тодорхой нэгэн арга барил, ёс зүйн дүрмийг зориуд дагах хэрэггүй—Тэр аль хэдийн ийм мөн чанарыг эзэмшсэн байдаг. Чи үүнээс юу харж байна вэ? Бурхан хүн чанараар ажиллах үед Түүний олон арга барил, үг болон үнэн нь хүний арга замаар илэрхийлэгдсэн. Гэхдээ үүний зэрэгцээ хүмүүст мэдэгдэж, ойлгуулахын тулд Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох болон Түүний хүсэл илэрхийлэгдсэн. Тэдний мэдэж авсан, ойлгосон зүйл бол Бурханы Өөрийн төрөлх ялгамж чанар болон байр суурийг төлөөлдөг Түүний мөн чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох байв. Өөрөөр хэлбэл, махбод дахь хүний Хүү нь байж болох хамгийн их хэмжээгээр, аль болох нарийн зөвөөр Бурханы Өөрийн төрөлх зан чанар болон мөн чанарыг илэрхийлсэн юм. Хүний Хүүгийн хүн чанар нь тэнгэрт буй Бурхантай харилцах хүний харилцаа болон харилцан үйлчлэлд саад тотгор болоогүйгээр зогсохгүй, үнэндээ хүн төрөлхтнийг бүтээлийн Эзэнтэй холбох цорын ганц суваг, цорын ганц гүүр байсан юм. Одоо энэ мөчид, Нигүүлслийн эрин үед Эзэн Есүсийн хийсэн ажлын шинж чанар, арга барил болон ажлын одоогийн үе шатны хооронд адил төстэй байдал олон байгааг та нар мэдэрдэггүй гэж үү? Ажлын одоогийн энэ үе шат нь Бурханы зан чанарыг илэрхийлэхийн тулд хүний хэлийг ихээхэн ашиглаж, Бурханы Өөрийн хүслийг илэрхийлэхийн тулд хүн төрөлхтний өдөр тутмын амьдралын үг хэл, арга барил болон хүний мэдлэгийг ашигладаг. Бурхан махбод болмогцоо хүний өнцгөөс, эсвэл бурханлаг өнцгөөс ярьж байгаа нь хамаагүй, Түүний хэл болон илэрхийлэх арга барилын олонх нь бүгд хүний хэл, арга барилаар дамжин ирдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан махбод болох үед энэ нь чиний хувьд Бурханы бүхнийг чадагч байдал, мэргэн ухааныг харах, Бурханы бүх бодитой талыг мэдэх хамгийн сайн боломж юм. Бурхан махбод болсон үед, өсөх явцдаа Тэрээр хүн төрөлхтний зарим мэдлэг, ердийн мэдлэг, хэл болон илэрхийлэх арга барилыг хүн чанараар ойлгож, суралцаж, мэдэж авсан. Бие махбодтой болсон Бурхан Өөрийн бүтээсэн хүмүүсээс гарсан эдгээр зүйлийг эзэмшсэн юм. Тэдгээр нь махбод дахь Бурханы Өөрийн зан чанар, Өөрийн

бурханлаг чанарыг илэрхийлэх хэрэгсэл болсон бөгөөд хүн төрөлхтний дунд, хүний өнцгөөс, хүний хэлийг ашиглан ажиллах үедээ Өөрийн ажлыг илүү тохиромжтой, илүү жинхэнэ, илүү нарийн зөв болгох боломжийг Түүнд олгожээ. Энэ нь Түүний ажлыг хүмүүст илүү хүртээмжтэй, илүү хялбар ойлгогдохуйц болгож, улмаар Бурханы хүссэн үр дүнд хүрсэн юм. Бурханы хувьд махбодод ийм байдлаар ажиллах нь илүү бодитой биш гэж үү? Энэ Бурханы мэргэн ухаан биш гэж үү? Бурхан махбод болсон үе, мөн Бурханы махбод биелүүлэхийг хүссэн ажлаа хийж чаддаг болсон үе нь Тэр Өөрийн зан чанар болон ажлыг бодитоор илэрхийлэх үе бөгөөд бас Өөрийн үйлчлэлийг хүний Хүүгийн хувиар албан ёсоор эхлүүлж чадах үе байсан юм. Энэ нь, Бурхан, хүн хоёрын хооронд “үеийн зай завсар” байхаа больж, Бурхан элчүүдээр дамжуулан ярилцах ажлаа удахгүй зогсоож, мөн Өөрийн хүссэн бүх үг болон ажлыг Бурхан Өөрөө биечлэн илэрхийлж чадах болсон гэсэн үг байв. Энэ нь бас, Бурханы авардаг хүмүүс Түүнд илүү ойр байж, Түүний удирдлагын ажил шинэ газар нутагт орж, бүх хүн төрөлхтөн шинэ эринтэй учрах дөхлөө гэсэн үг байлаа.

Эзэн Есүсийг төрөх үед олон үйл явдал тохиолдсон гэдгийг Библийг уншсан хүн бүхэн мэддэг. Тэдгээр үйл явдлын дотроос хамгийн том нь Тэрээр диаволын хаанд агнуулж, тэр ч бүү хэл, тус хотын хоёр болон түүнээс бага насны бүх хүүхэд хядуулах хэмжээнд хүрсэн явдал юм. Хүн төрөлхтний дунд махбод болсноороо Бурхан асар их эрсдэл хүлээсэн нь илэрхий юм; хүн төрөлхтнийг аврах Өөрийн удирдлагыг гүйцээхийн тулд Тэр асар их төлөөс төлсөн нь мөн илэрхий билээ. Хүн төрөлхтний дунд махбодоор хийх ажилдаа тавьж байсан Бурханы асар их итгэл найдвар ч илэрхий. Бурханы махбод хүн төрөлхтний дунд ажлаа явуулах боломжтой болоход Түүнд ямар санагдсан бэ? Хүмүүс үүнийг тодорхой хэмжээнд ойлгож чадах ёстой, тийм биз дээ? Хамгийн наад зах нь Бурхан Өөрийн шинэ ажлыг хүмүүсийн дунд өрнүүлж чадах болсон учраас баяртай байсан. Эзэн Есүс баптисм хүртэж, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхийн тулд ажлаа албан ёсоор эхлэх үед Бурханы зүрх сэтгэл баяр хөөрөөр бялхсан юм, учир нь маш олон жил хүлээж, бэлдсэний дараа Тэрээр хэвийн хүний махбодыг өмсөөд хүмүүсийн харж, хүрч чадах мах цуснаас бүрдсэн махан биетэй хүний дүртэйгээр Өөрийн шинэ ажлыг эхэлж чадах болсон юм. Тэр эцэстээ хүний ялгамж чанараар дамжуулан хүмүүстэй нүүр нүүрээ харалцан, чин сэтгэлээсээ ярилцаж чадах болсон. Бурхан эцэстээ хүн төрөлхтөнтэй нүүр тулан хүний арга замаар, хүний хэлээр ярилцаж чадах болсон; Тэрээр хүний хэлийг ашиглан хүн төрөлхтнийг хангаж, гэгээрүүлж, тэдэнд тусалж чадах болсон; Тэр тэдэнтэй хамт нэг ширээнд хооллож, тэдэнтэй хамт нэг орон зайд амьдарч чадах болсон. Тэр мөн хүмүүстэй адилаар, бүр тэдний нүдээр хүмүүсийг харж, аливаа зүйлийг харж, бүх зүйлийг харж чадах болсон. Бурханы хувьд энэ нь аль хэдийн махбод дахь Түүний ажлын эхний ялалт байсан юм. Үүнийг мөн агуу ажлын биелэлт байсан гэж хэлж болно—энэ нь мэдээж Бурханы хамгийн их баярласан зүйл билээ. Тэр үеэс эхлээд хүн төрөлхтний дунд

явуулах ажилдаа Бурхан анх удаа тайтгарах шиг болсон юм. Болж өнгөрсөн энэ бүх үйл явдал нь маш бодитой, маш жирийн байсан бөгөөд Бурханы мэдэрсэн тайтгарал тун бодитой байлаа. Хүн төрөлхтний хувьд, Бурханы ажлын шинэ үе шат биелж, Бурхан баярлах болгонд хүн төрөлхтөн Бурханд, авралд улам ойртож чадах юм. Бурханд бол, энэ нь бас Түүний шинэ ажлын эхлэл, Түүний удирдлагын төлөвлөгөө нэг алхам урагшлах үе, цаашлаад, Түүний санаа зорилго бүрэн биелэхэд дөхөж очих үе билээ. Хүн төрөлхтний хувьд ийм боломж ирж байгаа нь азтай бөгөөд маш сайн хэрэг; Бурханы авралыг хүлээдэг бүх хүний хувьд бол маш чухал, баяр хөөртэй мэдээ юм. Бурхан ажлын шинэ үе шатыг хэрэгжүүлэх үед Түүнд шинэ эхлэл байдаг ба энэ шинэ ажил болон шинэ эхлэлийг тавьж, хүн төрөлхтөнд танилцуулах үе нь ажлын энэ үе шатны үр дүн аль хэдийн тодорхойлогдож, үүний эцсийн үр нөлөө, үр ашгийг Бурхан аль хэдийн харчихсан байдаг үе юм. Бас эдгээр үр нөлөө Бурханыг сэтгэл хангалуун болгож, мэдээж Түүний зүрх сэтгэлийг баярлуулдаг үе юм. Бурханы нүдээр бол, Тэр Өөрийн хайж байсан хүмүүсийг аль хэдийн хараад тодорхойлчихсон ба энэ бүлэг хүмүүсийг буюу Түүний ажлыг амжилттай болгож, Түүнд сэтгэл ханамжийг авчирч чадах энэ бүлэг хүмүүсийг аль хэдийн олоод авчихсан тул Бурханы санаа амардаг. Тиймээс Тэрээр санаа зовохоо болиод аз жаргалыг мэдэрдэг. Өөрөөр хэлбэл, Бурханы махбод хүмүүсийн дунд шинэ ажил эхлүүлэх боломжтой болж, хийх ёстой ажлаа саадгүй хийж эхлэхэд, мөн бүх зүйл биелсэн гэж Түүнд санагдахад Түүний хувьд төгсгөлийг нь аль хэдийн харчихдаг. Үүнээс үүдэн Түүний сэтгэл ханаж, зүрх сэтгэл нь жаргалтай байдаг. Бурханы аз жаргал хэрхэн илэрхийлэгддэг вэ? Хариулт нь ямар байж болохыг та нар төсөөлж чадах уу? Бурхан уйлж болох уу? Бурхан уйлж чадах уу? Бурхан алга ташиж чадах уу? Бурхан бүжиглэж чадах уу? Бурхан дуулж чадах уу? Тэгвэл Тэр юу дуулах бол? Мэдээж Бурхан сайхан, сэтгэл хөдлөм дуу буюу Өөрийнх нь зүрх сэтгэл дэх баяр баясгалан, аз жаргалыг илэрхийлж чадах дуу дуулж чадна. Тэр үүнийг хүн төрөлхтний төлөө, Өөрийнхөө төлөө, бүх зүйлийн төлөө дуулж чадна. Бурханы аз жаргал ямар ч байдлаар илэрхийлэгдэж болно—Бурханд баяр баясгалан, уйтгар гуниг байдаг ба Түүний янз бүрийн мэдрэмж нь төрөл бүрийн байдлаар илэрхийлэгдэж болох учраас энэ бүхэн нь хэвийн юм. Энэ бол Түүний эрх бөгөөд үүнээс илүү хэвийн, зүй зохистой юу ч үгүй. Хүмүүс энэ талаар өөрөөр бодох ёсгүй. Та нар Бурханд “цагариг чангалах шившлэг”[a] ашиглахаар оролдон, Тэр энийг, эсвэл тэрийг хийх ёсгүй, ингэж, эсвэл тэгж үйлдэх ёсгүй хэмээн Түүнд хэлж, ийм маягаар Түүний аз жаргал юм уу Түүнд байж болох аливаа мэдрэмжийг хязгаарлах учиргүй. Хүмүүсийн зүрх сэтгэлд, Бурхан аз

[a] “Цагариг чангалах шившлэг” нь “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” хэмээх хятад романд Тансан ламын ашигладаг шившлэг юм. Тэрээр энэ шившлэгийг ашиглан Сүн Үүнийг хянаж, толгой дахь төмөр цагаригийг нь чангалснаар, толгойг нь янгинатал өвтгөж, улмаар түүнийг хяналтдаа оруулдаг. Энэ нь хүнийг хүлдэг зүйлийг дүрслэх зүйрлэл болжээ.

жаргалтай байж болохгүй, нулимс урсгаж болохгүй, уйлж болохгүй—Тэр ямар ч сэтгэл хөдлөл илэрхийлж болохгүй. Энэ хоёр нөхөрлөлийн үеэр бидний ярилцсан зүйлээс та нар Бурханыг цаашид ингэж харахгүй, харин Бурханд зарим нэг эрх чөлөө, чөлөөлөлтийг олгох болно гэдэгт Би итгэж байна. Энэ бол маш сайн зүйл. Ирээдүйд Бурхан гунигтай байгаа тухай сонсоод та нар Түүний уйтгар гунигийг үнэхээр мэдэрч, Түүний жаргалтай байгааг сонсоод Түүний аз жаргалыг үнэхээр мэдэрч чадаж байвал та нар ядаж Бурханыг юу баярлуулдаг, юу гуниглуулдгийг тодорхой мэдэж, ойлгож чадна. Бурханыг гунигтай байхад гунигийг нь мэдэрч, Бурхан аз жаргалтай байхад аз жаргалыг нь мэдэрч чаддаг бол Тэр чиний зүрх сэтгэлийг бүрэн олж авсан байх бөгөөд та хоёрын хоорондх ямар ч саад бартаа байхаа болино. Чи Бурханыг хүний төсөөлөл, үзэл болон мэдлэгээр хязгаарлах гэж оролдохоо болино. Тэр үед Бурхан чиний зүрх сэтгэлд амьд агаад тод томруун болно. Тэр чиний амийн Бурхан, бүх зүйлийн чинь Эзэн байх болно. Та нарт ийм хүсэл эрмэлзэл байдаг уу? Үүнийг биелүүлж чадна гэдэгтээ итгэлтэй байна уу?

Дараа нь Бичвэрийн дараах хэсгүүдийг уншицгаая.

6. Уулан дээрх Сургаал

Ерөөлүүд (Матай 5:3–12)
Давс ба гэрэл (Матай 5:13–16)
Хууль (Матай 5:17–20)
Хилэгнэл (Матай 5:21–26)
Завхайрал (Матай 5:27–30)
Гэр бүл салах нь (Матай 5:31–32)
Тангараг (Матай 5:33–37)
Нүдийг нүдээр (Матай 5:38–42)
Дайснаа хайрлах нь (Матай 5:43–48)
Өглөгийн тухай заавар (Матай 6:1–4)
Залбирал (Матай 6:5–8)

7. Эзэн Есүсийн сургаалт зүйрлэлүүд

Тариачны тухай сургаалт зүйрлэл (Матай 13:1–9)
Үрийн сүүлний тухай сургаалт зүйрлэл (Матай 13:24–30)
Гичийн үрийн тухай сургаалт зүйрлэл (Матай 13:31–32)
Хөрөнгөний тухай сургаалт зүйрлэл (Матай 13:33)
Үрийн сүүлний тухай сургаалт зүйрлэлийн тайлбар (Матай 13:36–43)
Эрдэнэсийн тухай сургаалт зүйрлэл (Матай 13:44)
Сувдны тухай сургаалт зүйрлэл (Матай 13:45–46)
Торны тухай сургаалт зүйрлэл (Матай 13:47–50)

8. Тушаалууд

Матай 22:37–39 Есүс түүнд, “Чи өөрийн Бурхан Эзэнийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх ухаанаараа хайрла. Энэ бол эн тэргүүний бөгөөд хамгийн том тушаал юм. Мөн хоёр дахь нь ч бас адилхан, чи бусдыг өөрийн адил хайрла” гэжээ.

Юун түрүүнд “Уулан дээрх сургаалын” янз бүрийн хэсгийг авч үзье. Энэ өөр өөр хэсгүүд юуг хөнддөг вэ? Янз бүрийн энэ хэсгүүдийн агуулга нь бүгд Хуулийн эрин үеийн дүрэм журмаас илүү өргөгдсөн, илүү тодорхой бөгөөд хүмүүсийн амьдралд илүү ойр дөхөм байсан гэж лавтай хэлж болно. Орчин үеийн үг хэллэгээр хэлбэл эдгээр зүйл нь хүмүүсийн бодит хэрэгжүүлэлттэй илүү холбоотой байдаг.

Дараах тодорхой агуулгыг уншицгаая: Ерөөлүүдийг чи хэрхэн ойлгох ёстой вэ? Хуулийн талаар чи юу мэдэх ёстой вэ? Хилэгнэлийг хэрхэн тодорхойлох ёстой вэ? Завхайралд хэрхэн хандах ёстой вэ? Гэр бүл салалтын талаар юу гэж хэлсэн, үүнд ямар төрлийн дүрмүүд байдаг вэ? Хэн салж болох, хэн салж болохгүй вэ? Тангараг, нүдийг нүдээр, дайснаа хайрлах, өглөг өгөх заавар гэх мэтийн талаар юу гэсэн билээ? Гэх мэтчилэн. Энэ бүх зүйл нь хүн төрөлхтний Бурханд итгэж, Бурханыг дагах хэрэгжүүлэлтийн тал бүрд хамаатай байдаг. Эдгээр хэрэгжүүлэлтийн зарим нь өнөөдөр ч гэсэн хэрэглэгдсээр байгаа боловч одоо хүмүүсээс шаарддаг зүйлээс илүү өнгөц юм. Тэдгээр нь Бурханд итгэх явцад хүмүүст тулгардаг нэлээд анхан шатны үнэн билээ. Эзэн Есүс ажиллаж эхэлсэн цагаасаа хүний амь зан чанар дээр ажлаа хэдийн явуулж эхэлсэн боловч Түүний ажлын энэ талууд нь хуулийн суурин дээр үндэслэж байлаа. Эдгээр сэдвийн талаар ярих дүрэм болон арга зам үнэнтэй хамаатай байсан уу? Мэдээж тийм байсан! Өмнөх бүх дүрэм журам, зарчим болон Нигүүлслийн эрин үеийн эдгээр номлол нь бүгд Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохтой болон мэдээж үнэнтэй хамаатай байсан. Бурхан юу илэрхийлсэн, яаж илэрхийлсэн, эсвэл ямар илэрхийлэл юм уу хэл хэрэглэсэн нь хамаагүй, Түүний илэрхийлсэн бүх зүйлийн үндэс суурь, эх сурвалж, эхлэлийн цэг нь Түүний зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохын зарчим дээр суурилдаг. Энэ бол туйлын үнэн. Иймээс Түүний хэлсэн эдгээр зүйл одоо бага зэрэг өнгөцхөн мэт санагддаг хэдий ч тэдгээрийг үнэн биш гэж хэлж мөн л болохгүй, учир нь тэдгээр нь, Бурханы хүслийг хангаж, амь зан чанартаа өөрчлөлт хийхийн тулд Нигүүлслийн эрин үеийн хүмүүст зайлшгүй хэрэгтэй байсан зүйлс юм. Эдгээр номлолын аль нэг нь үнэнтэй нийцэхгүй байна гэж хэлж болох уу? Үгүй, болохгүй! Эдгээр нь нэг бүрчлэн үнэн, учир нь бүгдээрээ хүн төрөлхтөнд тавьсан Бурханы шаардлага байсан; тэдгээр нь бүгд биеэ хэрхэн авч явах талаар Бурханы өгсөн зарчим, цар хүрээ байсан бөгөөд Бурханы зан чанарыг төлөөлдөг. Гэвч тухайн үеийн амийн өсөлтийнхөө түвшинд үндэслээд тэд зөвхөн эдгээр зүйлийг хүлээн авч, ойлгож чаддаг байсан. Хүн төрөлхтний нүгэл хараахан шийдэгдээгүй байсан учраас Эзэн Есүс зөвхөн эдгээр үгийг л хэлж чадсан ба тэд хэрхэн үйлдэх ёстой, юу хийх ёстой, ямар зарчим болон цар хүрээнд аливааг хийх ёстой болон хэрхэн Бурханд итгэж,

Түүний шаардлагыг хангах ёстой талаар тухайн үеийн хүмүүст хэлэхийн тулд Тэр ийм хүрээнд багтсан энгийн сургаалыг л ашиглаж чадаж байлаа. Энэ бүхэн нь тэр үеийн хүн төрөлхтний биеийн хэмжээн дээр үндэслэн тодорхойлогджээ. Хуульд захирагдан амьдарч байсан хүмүүсийн хувьд эдгээр сургаалыг хүлээн авахад амархан биш байсан, иймээс Эзэн Есүсийн заасан зүйл энэ цар хүрээн дотор л байх хэрэгтэй байв.

Дараа нь “Эзэн Есүсийн сургаалт зүйрлэлүүдийн” янз бүрийн агуулгыг харцгаая.

Эхнийх нь тариачны тухай сургаалт зүйрлэл юм. Энэ нь маш сонирхолтой сургаалт зүйрлэл; үр тариа тарих нь хүмүүсийн амьдралд нийтлэг тохиолддог үйл явдал билээ. Хоёр дахь нь үрийн сүүлний тухай сургаалт зүйрлэл юм. Үр тариа тарьж байсан ямар ч хүн, мэдээж насанд хүрэгчид бүгд “үрийн сүүл” гэж юу болохыг мэднэ. Гурав дахь нь гичийн үрний тухай сургаалт зүйрлэл юм. Гич гэж юу болохыг та нар бүгд мэднэ, тийм үү? Хэрвээ мэддэггүй бол Библиэс харах хэрэгтэй. Дөрөв дэх сургаалт зүйрлэл нь хөрөнгөний тухай сургаалт зүйрлэл бөгөөд исгэхэд зориулж хөрөнгө хэрэглэдгийг, мөн энэ нь хүмүүсийн өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг зүйл гэдгийг ихэнх хүн мэднэ. Эрдэнэсийн тухай зургаа дахь сургаалт зүйрлэл, сувдны тухай долоо дахь сургаалт зүйрлэл, торны тухай найм дахь сургаалт зүйрлэлийг оролцуулаад дараагийн бүх сургаалт зүйрлэл нь хүмүүсийн амьдралаас урган гарсан, хүмүүсийн бодит амьдралаас үүдэлтэй байдаг. Эдгээр сургаалт зүйрлэл нь ямар төрлийн зүйлийг дүрсэлж байна вэ? Энэ нь Бурхан хэвийн хүн болж, хүн төрөлхтөнтэй зэрэгцэн амьдарч, амьдралын хэл буюу хүний хэлийг ашиглан, хүмүүстэй ярилцаж, хэрэгтэй зүйлээр нь хангаж байгаа дүр зураг юм. Бурхан махбод болж, хүн төрөлхтний дунд удаан хугацаанд амьдрахдаа хүмүүсийн олон янзын амьдралын хэв маягийг мэдэрч, нүдээр харсны дараа эдгээр туршлага нь Өөрийн бурханлаг хэлийг хүний хэл болгон өөрчилсөн сургалтын материал нь болжээ. Мэдээжээр, амьдралд Түүний харж, сонссон эдгээр зүйл нь хүний Хүүгийн туршлагыг ч бас баяжуулсан. Тэрээр хүмүүст зарим үнэнийг ойлгуулж, Бурханы зарим хүслийг ойлгуулахыг хүсэх үедээ Бурханы хүсэл болон хүн төрөлхтөнд тавих шаардлагын тухай хүмүүст хэлэхийн тулд дээр дурдсантай адил сургаалт зүйрлэлүүдийг ашиглаж байв. Эдгээр сургаалт зүйрлэл нь бүгд хүмүүсийн амьдралтай холбоотой байсан; хүний амьдралаас гадуурх нэг ч зүйл байгаагүй. Эзэн Есүс хүн төрөлхтөнтэй хамт амьдарч байхдаа тариан талбайгаа арчилж байгаа тариачдыг харсан бөгөөд үрийн сүүл болон хөрөнгө гэж юу болохыг мэдсэн; хүмүүс эрдэнэст дуртайг Тэр ойлгосон, иймээс Тэр эрдэнэс болон сувдны сургаалт зүйрлэлийг хоёуланг нь ашигласан. Амьдрал дээр Тэр тороо хаяж буй загасчдыг олон удаа харсан; Эзэн Есүс үүнийг болон хүний амьдралтай холбоотой бусад үйл ажиллагааг харсан бөгөөд Өөрөө ч бас тийм амьдралыг туулсан. Бусад бүх хэвийн хүний адилаар Тэрээр хүмүүсийн өдөр тутмын хэвшлийг туулж, өдөрт гурав хооллож байсан. Тэр ердийн хүний амьдралыг биеэр амсаж, бусдын амьдралыг ажигласан. Тэр энэ бүхнийг ажиглаж, биечлэн

туулах үедээ яаж сайхан амьдрах, эсвэл яаж илүү эрх чөлөөтэй, илүү тав тухтай амьдрах талаар бодоогүй юм. Харин, жинхэнэ хүний амьдралыг туулж байхдаа Эзэн Есүс хүмүүсийн амьдралын зовлон бэрхшээлийг харсан. Сатаны эзэмшил, Сатаны завхралын дор нүгэлт амьдралаар амьдарч байгаа хүмүүсийн зовлон бэрхшээл, өрөвдөлтэй байдал, уйтгар гунигийг Тэр харсан. Тэр хүний амьдралыг биечлэн туулж байх зуураа ялзрал дунд амьдарч байгаа хүмүүс хэчнээн арга мөхөс байдгийг бас мэдэрсэн бөгөөд нүгэлд амьдардаг, Сатан болон ёрын муугийн учруулсан тамлал дунд бүх зүг чигээ алдсан хүмүүсийн өрөвдөлтэй нөхцөл байдлыг харж, мэдэрсэн. Эзэн Есүс эдгээр зүйлийг харахдаа Өөрийн бурханлаг чанараар харсан уу, эсвэл хүн чанарааraa харсан уу? Түүний хүн чанар үнэхээр оршин байсан, яахын аргагүй амьд байсан; Тэр энэ бүхнийг мэдэрч, харж чадаж байсан. Гэхдээ мэдээж Тэр үүнийг Өөрийн мөн чанар буюу бурханлаг чанараар ч гэсэн харсан. Өөрөөр хэлбэл, хүн болсон Эзэн Есүс буюу Христ Өөрөө энийг харсан бөгөөд Түүний харсан бүхэн нь махбодод амьдрах хугацаандаа махбодоор хийж эхэлсэн Өөрийнх нь ажлын ач холбогдол, чухал хэрэгцээг Түүнд мэдрүүлсэн. Бие махбодоор үүрэх ёстой болсон Түүний хариуцлага маш их бөгөөд Түүнд тулгарах зовлон шаналал хэчнээн харгис хатуу байж болохыг Тэр Өөрөө мэдэж байсан хэдий ч хүн төрөлхтөн нүглийн дунд арчаагүй байгааг хараад, тэдний амьдралын өрөвдөлтэй байдал болон хуулийн доорх сулхан тэмцлийг нь хараад улам их уй гашууг мэдэрч, хүн төрөлхтнийг нүглээс аврах гэж улам их дэнслэх болсон. Тэр ямар ч бэрхшээлтэй тулгарсан бай, эсвэл ямар ч зовлон шаналал туулсан бай, нүгэл дунд амьдарч байгаа хүн төрөлхтнийг золин аврахаар улам бүр шийдсэн юм. Энэ явцад Эзэн Есүс Өөрийн хийх хэрэгтэй ажлыг болон Түүнд юу даалгасныг улам ч илүү тодорхой ойлгож эхэлсэн гэхэд болно. Тэр бас хийх гэж байгаа ажлаа дуусгахыг бүр их хүсэн эрмэлзэх болсон—энэ нь хүн төрөлхтний бүх нүглийг үүрч, хүн төрөлхтнийг золин аврах байсан, ингэснээр нүглийн төлөөх тахилын улмаас тэд цаашид нүгэлтэйгээр амьдрахгүйн зэрэгцээ Бурхан хүний нүглийг уучилж, хүн төрөлхтнийг аврах Өөрийн ажлыг үргэлжлүүлэн явуулж чадах байсан юм. Эзэн Есүс хүн төрөлхтний төлөө Өөрийгөө тахил болгон өргөж, Өөрийгөө золиослоход зүрх сэтгэлдээ бэлэн байсан гэж хэлж болно. Тэр бас нүглийн тахил болж, загалмайд цовдлогдоход бэлэн байсан ба үнэндээ энэ ажлыг дуусгахаар тэмүүлж байв. Хүний амьдралын хөөрхийлөлтэй нөхцөл байдлыг хараад Тэр Өөрийн үүрэг даалгаврыг нэг ч минут, ганц ч агшин хойшлуулалгүй аль болох хурдан биелүүлэхийг бүр ч их хүссэн. Тэгж их яарсандаа Тэр Өөрийнх нь шаналал зовлон ямар их байхыг бодоогүй, Өөрөө хэчнээн их доромжлолыг тэвчих хэрэгтэй болох талаар ч цаашид бодоогүй. Өөрийн зүрх сэтгэлд Тэр ганцхан итгэл үнэмшлийг тээж байсан нь: Тэр Өөрийгөө өргөн барих л юм бол, нүглийн тахил болж загалмайд цовдлогдох л юм бол Бурханы хүсэл хэрэгжиж, Бурхан шинэ ажил эхлүүлж чадна гэдэг байлаа. Хүн төрөлхтний нүгэл дунд амьдарч, оршин тогтнодог байдал бүрмөсөн өөрчлөгдөх байсан. Түүний итгэл үнэмшил болон хийхээр

шийдсэн зүйл нь хүнийг аврахтай холбоотой байсан бөгөөд Бурханы хүслийг биелүүлэх цорын ганц зорилго Түүнд байв, ингэснээр Бурхан ажлынхаа дараагийн алхмыг амжилттайгаар эхлүүлж чадах байлаа. Тэр үед Эзэн Есүсийн санаанд ийм л зүйл байсан юм.

Бие махбодтой болсон Бурхан махбодод амьдрахдаа хэвийн хүн чанартай байсан; Түүнд хэвийн хүний сэтгэл хөдлөл, эрүүл ухаан байсан. Тэр аз жаргал гэж юу болохыг, өвчин зовлон гэж юу болохыг мэддэг байсан бөгөөд хүн төрөлхтөн ийм амьдралаар амьдарч буйг хараад хүмүүст зүгээр л хэдэн сургаал хайрлаж, ямар нэг зүйлээр тэднийг хангаж, тэдэнд ямар нэг юм зааж сургах нь нүглээс нь салгахад хангалтгүй гэдгийг ихээхэн мэдэрсэн юм. Тушаалуудад дуулгавартай байлгах нь ч бас тэднийг нүглээс аварч чадахгүй—гагцхүү хүн төрөлхтний нүглийг үүрч, нүгэлт биетэй адил болж байж л Тэр хариуд нь хүн төрөлхтний эрх чөлөө, хүн төрөлхтнийг уучлах Бурханы уучлалыг олж авч чадах байв. Иймээс хүний нүгэлт амьдралыг туулж, нүдээр харсныхаа дараа Эзэн Есүсийн зүрх сэтгэлд хүчтэй хүсэл илэрсэн нь нүгэл дунд тэмцэлдэн амьдардаг амьдралаасаа салах боломжийг хүмүүст олгох хүсэл байсан. Энэ хүсэл нь, Түүнийг загалмай руу аль болох хурдан очиж, хүн төрөлхтний нүглийг үүрэх ёстой гэж улам ихээр бодоход хүргэсэн юм. Эдгээр нь тухайн үед хүмүүстэй хамт амьдарч, тэдний нүгэлт амьдралын гаслан зовлонг харж, сонсож, мэдэрсний дараах Эзэн Есүсийн бодол байлаа. Бие махбодтой болсон Бурхан хүн төрөлхтний төлөө ийм хүсэлтэй байж, ийм зан чанарыг илэрхийлж, илчилж чадсан—энэ нь ердийн хүнд байдаг зүйл мөн үү? Иймэрхүү орчинд амьдарч байгаа ердийн хүн юу харах бол? Тэд юу бодох вэ? Хэрвээ ердийн хүн энэ бүхэнтэй тулгарвал асуудлыг өндөр өнцгөөс авч үзэх үү? Мэдээж үгүй! Хэдийгээр бие махбодтой болсон Бурханы гадаад төрх байдал хүнтэй яг адилхан байж, хүний мэдлэгийг суралцаж, хүний хэлээр ярьж, заримдаа бүр хүний арга барил, илэрхийллээр Өөрийн санааг илэрхийлж байсан ч хүнийг болон юмны мөн чанарыг хардаг Түүний арга зам нь хүн төрөлхтөн болон юмны мөн чанарыг хардаг ялзарсан хүмүүсийн арга замаас тэс ондоо юм. Түүний өнцөг болон Түүний зогсож буй өндөр нь ялзарсан хүн хүрэхийн аргагүй зүйл билээ. Учир нь Бурхан бол үнэн, Түүний өмсдөг махбод ч бас Бурханы мөн чанартай бөгөөд Түүний бодол, Түүний хүн чанараар илэрхийлэгдсэн зүйл ч бас үнэн билээ. Ялзарсан хүмүүсийн хувьд Түүний махбодоор илэрхийлдэг зүйл нь үнэний болон амийн хангалт юм. Эдгээр хангалт нь зөвхөн нэг хүнд биш, харин бүх хүн төрөлхтөнд зориулагддаг. Ямар ч ялзарсан хүний зүрх сэтгэлд өөртэй нь холбоотой цөөхөн хүн л байдаг. Тэрхүү цөөн хэдхэн хүнийг л тэр анхаарч, санаа тавьдаг. Гамшиг нүүрлэх үед тэрээр юун түрүүнд өөрийн хүүхдүүд, хань ижил, аль эсвэл эцэг эхийг бодно. Арай энэрэнгүй хүн бол хамгийн ихдээ л зарим хамаатнаа, эсвэл сайн найзаа бодно, гэхдээ тийм энэрэнгүй хүн ч гэсэн үүнээс олон хүнийг бодох уу? Үгүй, хэзээ ч үгүй! Учир нь, хүмүүс бол эцсийн эцэст хүмүүс бөгөөд бүх зүйлийг зөвхөн хүний өнцгөөс, хүний өндрөөс л харж чадна. Гэтэл бие махбодтой болсон Бурхан бол ялзарсан хүнээс

тэс өөр юм. Бие махбодтой болсон Бурханы махбод хэчнээн жирийн, хэчнээн хэвийн, хэчнээн дорд байх нь хамаагүй, хүмүүс Түүнийг хэчнээн басамжилж дорд үзэх нь хамаагүй, Түүний бодол болон хүн төрөлхтөнд хандах хандлага нь ямар ч хүний эзэмшиж чадахгүй, ямар ч хүний дуурайж чадахгүй зүйл билээ. Тэрээр хүн төрөлхтнийг бурханлаг чанарын өнцгөөс, Бүтээгч хэмээх Өөрийн байр суурийн өндрөөс үргэлж ажиглах болно. Тэр Бурханы мөн чанар, сэтгэхүйгээр хүн төрөлхтнийг үргэлж харах болно. Тэр хүн төрөлхтнийг жирийн хүний дорд өндрөөс, ялзарсан хүний өнцгөөс харж огтхон ч чадахгүй. Хүмүүс хүн төрөлхтнийг харахдаа хүний хараагаар л хардаг бөгөөд хүний мэдлэг, хүний дүрэм болон онолыг хэмжүүрээ болгодог. Энэ нь хүмүүсийн нүдээрээ харж чадах цар хүрээ, ялзарсан хүмүүсийн хүрч чадах цар хүрээн дотор байдаг. Бурхан хүн төрөлхтнийг харахдаа бурханлаг хараагаар хардаг бөгөөд Өөрийн мөн чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг хэмжүүрээ болгодог. Энэ цар хүрээ нь хүмүүсийн харж чаддаггүй зүйлсийг багтаадаг бөгөөд үүгээрээ бие махбодтой болсон Бурхан ба ялзарсан хүмүүс хоорондоо эрс ялгардаг. Энэ ялгаа нь хүмүүс болон Бурханы өөр өөр мөн чанараар тодорхойлогддог бөгөөд эдгээр ялгаатай мөн чанар нь тэдний ялгамж чанар, байр суурь, аливааг харах өнцөг болон өндрийг тодорхойлдог. Бурханы Өөрийн илэрхийлэл болон илчлэлийг та нар Эзэн Есүсээс харж байна уу? Эзэн Есүсийн хэлсэн, хийсэн бүхэн нь Түүний үйлчлэл болон Бурханы удирдлагын ажилтай холбоотой байсан бөгөөд энэ нь бүхэлдээ Бурханы мөн чанарын илэрхийлэл, илчлэл байсан гэж хэлж болно. Хэдийгээр Түүнд хүний илрэл байсан боловч Түүний бурханлаг мөн чанар болон бурханлаг чанарын илчлэлийг үгүйсгэж болохгүй. Энэхүү хүний илрэл нь үнэхээр хүн чанарын илрэл байсан уу? Түүний хүн чанарын илрэл нь ялзарсан хүмүүсийн хүний илрэлээс мөн чанараараа бүхэлдээ өөр. Эзэн Есүс бол бие махбодтой болсон Бурхан байсан. Хэрвээ Тэр үнэхээр эгэл жирийн ялзарсан хүмүүсийн нэг байсан бол хүн төрөлхтний нүгэлт амьдралыг бурханлаг өнцгөөс харж чадах байсан уу? Яавч үгүй! Энэ бол хүний Хүү ба жирийн хүмүүсийн хоорондох ялгаа юм. Ялзарсан хүмүүс бүгд нүгэлд амьдардаг бөгөөд аливаа хүн нүглийг харах үедээ ямар ч онцгой юм мэдэрдэггүй; тэд бүгд адилхан, тав тухгүй, эсвэл бохир гэдгийг огтхон ч мэдрэхгүйгээр шаварт амьдардаг гахай шиг—харин ч сайн идэж, бөх унтдаг. Хэрвээ гахайн хороог цэвэрлэвэл гахай үнэндээ даруй тавгүйтэх бөгөөд цэвэрхэн байж чадахгүй. Тэр бохир заваан амьтан учраас тун удалгүй дахиад л тун таатайгаар шаварт өнхөрч байх болно. Хүмүүс гахайг бохир заваан гэж үздэг, хэрвээ чи гахайн хороог цэвэрлэх юм бол гахайд тийм ч таатай санагдахгүй—тийм учраас хэн ч гэртээ гахай байлгадаггүй. Хүмүүс гахайг яаж харах нь гахайд өөрсдөд нь ямар санагддагаас үргэлж өөр байх болно, учир нь хүн гахай хоёр бол адил төрлийнх биш юм. Бие махбодтой болсон хүний Хүү ялзарсан хүнтэй адил төрлийнх биш учраас зөвхөн бие махбодтой болсон Бурхан л хүн төрөлхтнийг болон бүх зүйлийг бурханлаг өнцгөөс, Бурханы өндрөөс харж чадна.

Бурхан махбод болж, хүн төрөлхтний дунд амьдрах үедээ ямар зовлон туулдаг вэ? Энэ зовлон нь юу вэ? Үнэхээр ойлгодог хүн бий юу? Зарим хүн, Бурхан асар их зовдог бөгөөд хэдийгээр Тэр Бурхан Өөрөө мөн боловч хүмүүс Түүний мөн чанарыг ойлгодоггүй, харин Түүнийг үргэлж хүн гэж үзэх хандлагатай байдаг, энэ нь Түүнийг гомдоож, хэлмэгдсэн мэт санагдуулдаг гэж хэлдэг—ийм шалтгааны улмаас Бурханы зовлон үнэхээр их гэж тэд хэлдэг. Бусад хүмүүс, Бурхан гэм зэмгүй, ямар ч нүгэлгүй боловч хүн төрөлхтөнтэй адилхан зовж, хүн төрөлхтний хамт хавчлага, гүтгэлэг, доромжлол амсдаг гэж хэлдэг; Тэр мөн Өөрийн дагагч нарын үл ойлголцол, дуулгаваргүй байдлыг хүлцдэг—тиймээс Бурханы зовлонг үнэхээр хэмжих боломжгүй гэж тэд хэлдэг. Та нар Бурханыг үнэхээр ойлгодоггүй юм шиг байна. Үнэн хэрэгтээ та нарын ярьдаг энэ зовлон Бурханы хувьд бол жинхэнэ зовлонд тооцогддоггүй, учир нь үүнээс ч их зовлон байдаг. Тэгвэл Бурханы Өөрийнх нь хувьд жинхэнэ зовлон гэж юу вэ? Бурханы махбод болсон биеийн хувьд жинхэнэ зовлон юу вэ? Бурханы хувьд хүн төрөлхтөн Түүнийг ойлгохгүй байх нь зовлонд тооцогддоггүй ба хүмүүс Бурханы талаар зарим нэг буруу ойлголттой байж, Түүнийг Бурхан гэж үздэггүй нь ч зовлонд тооцогддоггүй. Гэсэн хэдий ч Бурхан асар их шударга бусыг туулсан байж таарна, Бурхан махбодод өнгөрүүлсэн хугацаандаа Өөрийн үнэн биеийг хүн төрөлхтөнд харуулж, Өөрийнхөө агуу байдлыг болон Бурхан ялихгүй махбодод даруухнаар нуугдаж байгааг хүмүүст харуулж чадахгүй, тиймээс энэ нь Түүнд асар их шаналгаатай байсан биз гэж хүмүүс дандаа боддог. Хүмүүс Бурханы зовлонгийн талаар өөрсдийн ойлгож чадах, харж чадах зүйлсийг сэтгэлдээ ойрхон тусган авч, Бурханыг элдэв янзын өрөвдөх сэтгэлээр дардаг ба тэр ч байтугай, Түүний зовлонгийн талаар үргэлж жаахан магтаал хэлнэ. Үнэн хэрэгтээ Бурханы зовлонгийн талаар хүмүүс юу ойлгодог болон Тэр үнэхээр юу мэдэрдгийн хооронд их ялгаа бий. Би та нарт үнэнийг хэлж байна—Бурханы Сүнс, эсвэл Бурханы махбод болсон бие ч бай хамаагүй, Бурханы хувьд тийм зовлон бол жинхэнэ зовлон биш. Тэгвэл Бурхан яг юунд зовж шаналдаг вэ? Бурханы зовлонг зөвхөн бие махбодтой болсон Бурханы өнцгөөс ярьцгаая.

Бурхан махбод болж, эгэл жирийн, хэвийн хүн болж, хүн төрөлхтний дунд хүмүүстэй мөр зэрэгцэн амьдрах үедээ хүмүүсийн амьдралын арга барил, хууль болон гүн ухааныг харж, мэдэрч чадахгүй гэж үү? Эдгээр амьдрах арга барил, хууль нь Түүнд ямар санагддаг вэ? Тэр зүрх сэтгэлдээ жигшил зэвүүцлийг мэдэрдэг үү? Тэр яагаад жигшиж зэвүүцэх билээ? Хүн төрөлхтний амьдрах арга барил, хуулиуд юу вэ? Тэдгээр нь ямар зарчимд үндэслэдэг вэ? Тэдгээр нь юун дээр тулгуурладаг вэ? Хүн төрөлхтний амьдралын арга барил, хууль гэх мэт нь—бүгд Сатаны логик, мэдлэг болон гүн ухаанд тулгуурлан бий болсон. Ийм төрлийн хуулин дор амьдарч байгаа хүмүүст ямар ч хүн чанар, ямар ч үнэн байдаггүй—тэд бүгд үнэнийг эсэргүүцэж, Бурханд дайсагнадаг. Хэрвээ бид Бурханы мөн чанарыг харвал, Түүний мөн чанар Сатаны логик, мэдлэг болон гүн ухааны яг эсрэг байдаг.

Түүний мөн чанар зөвт байдал, үнэн, ариун байдал болон эерэг бүх зүйлийн бусад бодит байдлаар дүүрэн байдаг. Ийм мөн чанарыг эзэмшээд, ийм хүн төрөлхтний дунд амьдарч байгаа Бурхан юу мэдэрдэг вэ? Зүрх сэтгэлдээ юу мэдэрдэг вэ? Шаналлаар дүүрэн байдаг бус уу? Түүний зүрх сэтгэл шаналж байдаг бөгөөд энэхүү шаналал нь ямар ч хүний ойлгож, мэдэрч чадахгүй зүйл юм. Яагаад гэвэл, Түүний нүүр тулж, тулгарч, сонсож, харж, амсаж байгаа бүхэн нь бүх хүн төрөлхтний ялзрал, ёрын муу, үнэний эсрэг тэрсэлж, сөрөх явдал байдаг. Хүмүүсээс гардаг бүхэн нь Түүний зовлонгийн эх сурвалж юм. Өөрөөр хэлбэл, Түүний мөн чанар нь ялзарсан хүмүүсийнхтэй адил биш учраас хүмүүсийн ялзрал нь Түүний хамгийн их зовлонгийн эх сурвалж болдог. Бурхан махбод болоод Өөртэй нь адилхан хэлтэй хэн нэгнийг олж чадах уу? Ийм хүнийг хүн төрөлхтний дундаас олох аргагүй. Бурхантай ярилцаж, харилцан ойлголцож чадах хүн нэг ч олдохгүй—Бурхан энэ талаар ямар сэтгэл хөдлөлтэй байдаг гэж чи хэлэх вэ? Хүмүүсийн хэлэлцдэг, хайрладаг, эрэлхийлж, хүсэн хүлээдэг зүйлс нь бүгд нүгэл болон ёрын муу чиг хандлагатай хамаатай байдаг. Бурхан энэ бүхэнтэй нүүр тулах үед Түүний зүрх рүү хутга дүрж байгаа мэт байдаггүй гэж үү? Эдгээр зүйлтэй тулгараад Тэр зүрх сэтгэлдээ баяр хөөртэй байж чадах уу? Тэр тайтгарал олж чадах уу? Түүнтэй хамт амьдарч буй хүмүүс тэрслүү зан, ёрын муугаар дүүрсэн хүмүүс юм—тиймд Түүний зүрх сэтгэл зовж шаналахгүй байж яаж чадах билээ? Энэ зовлон үнэхээр хэр их вэ, хэн энийг хайхардаг вэ? Хэн анхаарал хандуулдаг вэ? Хэн үүнийг ойлгох чадвартай вэ? Хүмүүс Бурханы зүрх сэтгэлийг ойлгох ямар ч аргагүй. Түүний зовлонг хүмүүс үнэндээ ойлгох чадваргүй бөгөөд хүмүүсийн хүйтэн, хөшүүн байдал Бурханы зовлонг бүр ч гүнзгийрүүлдэг.

Библид: “Үнэгэнд нүх, шувуудад ч үүр бий; гэтэл хүний Хүү толгой хоргодох газаргүй байна” гэсэн эшлэл байдаг учраас Христийн зовлонг ургэлж өрөвддөг зарим хүн байдаг. Хүмүүс үүнийг сонсоод үнэн сэтгэлээсээ авч үзэн, энэ нь Бурханы амсдаг хамгийн их зовлон, Христийн туулдаг хамгийн их зовлон мөн гэж боддог. Одоо үүнийг баримтуудын өнцгөөс харвал үнэхээр тийм байна уу? Үгүй; Бурхан эдгээр бэрхшээлийг зовлон гэж үздэггүй. Тэр махан биеийн бэрхшээлээсээ болоод шударга бус байдлыг эсэргүүцэн гомдоллож байгаагүй ба хүмүүсээс хариу нэхэж, эсвэл Өөрийг нь ямар нэг зүйлээр шагна гэж шаардаагүй. Гэхдээ Тэр хүн төрөлхтний бүх зүйлийг, ялзармал амьдралыг, ялзарсан хүний ёрын мууг харах үедээ, хүн төрөлхтөн Сатаны атганд, Сатанд хоригдоод зугтаж чадахгүй байгааг, нүгэлтэй амьдарч байгаа хүмүүс үнэн гэж юу болохыг мэдэхгүй байгааг харах үедээ энэ бүх нүглийг тэвчиж чаддаггүй. Хүн төрөлхтнийг жигших Түүний жигшил зэвүүцэл өдөр өдрөөр ихэсдэг боловч Тэр энэ бүхнийг тэвчих хэрэгтэй болсон. Энэ бол Бурханы асар их зовлон юм. Бурхан Өөрийн зүрх сэтгэлийн дуу хоолойг ч, эсвэл Өөрийн сэтгэл хөдлөлийг ч дагалдагчдынхаа дунд бүрэн илэрхийлж чаддаггүй ба Түүний дагалдагчдаас хэн нь ч Түүний зовлонг үнэхээр ойлгож чадахгүй. Энэ зовлонг өдөр өнжилгүй, жил алгасалгүй, ахин дахин амсдаг Түүний

зүрх сэтгэлийг хэн ч ойлгож, тайвшруулах гэж оролддоггүй. Та нар энэ бүгдээс юу харж байна вэ? Бурхан өгсөн зүйлийнхээ хариуд хүмүүсээс юу ч шаарддаггүй, гэвч мөн чанараасаа болж Тэрээр хүн төрөлхтний ёрын муу, ялзрал болон нүглийг огтхон ч тэвчиж чаддаггүй, харин ч туйлын их жигшил, үзэн ядалтыг мэдэрдэг, энэ нь Бурханы зүрх сэтгэл, бие махбодыг дуусашгүй их зовлон туулахад хүргэдэг. Та нар энэ бүхнийг харсан уу? Та нарын хэн нь ч үүнийг харж чадахгүй нь бараг л үнэн биз, учир нь та нарын хэн нь ч Бурханыг үнэхээр ойлгож чаддаггүй. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр та нар үүнийг аажмаар өөрсдөө туулах ёстой.

Одоо судрын дараах хэсгийг авч үзье:

9. Есүс гайхамшиг үзүүлсэн нь

а. Есүс таван мянган хүнийг хооллосон нь

Иохан 6:8–13 Түүний шавь нарын нэг Симон Петрийн дүү Андрей Түүнд: “Энд таван арвайн талх, хоёр жижиг загастай нэг хөвгүүн байна: гэвч энэ нь өдий олон хүнд юу болох вэ?” гэсэнд Есүс: “Хүмүүсийг суулга” гэв. Тэр газар өвс ихтэй байв. Ийнхүү таван мянга орчим хүн сууцгаалаа. Тэгээд Есүс талхнуудыг авч, талархал өргөснийхөө дараа шавь нартаа тараан өгч, шавь нар нь нөгөө суусан хүмүүст хуваж өгөв; мөн загасыг ч хүссэн хэмжээгээр нь өгчээ. Хүмүүс цадсаны дараа Тэр шавь нартаа: “Юу ч хаяхгүйн тулд үлдэгдлийг нь цуглуул” гэв. Тийнхүү хүмүүс идээд илүү гарсан таван арвайн талхнаас үлдсэн цөвдлийг тэд бүгдийг нь цуглуулж, арван хоёр саг дүүргэжээ.

б. Лазарын амилал Бурханыг алдаршуулсан нь

Иохан 11:43–44 Тэр тийнхүү өгүүлснийхээ дараа чанга дуугаар “Лазар, гараад ир!” гэж хашхирсанд гар хөл нь оршуулгын бөсөөр ороолттой, нүүр нь алчуураар ороолттой тэр үхсэн хүн гарч ирэв. Есүс тэдэнд, “Түүнийг тайлж явуул” гэв.

Эзэн Есүсийн үзүүлсэн гайхамшгуудын дундаас бид энэ хоёрыг л сонгосон, учир нь эдгээр нь энд Миний ярихыг хүссэн зүйлийг харуулахад хангалттай. Энэ хоёр гайхамшиг нь үнэхээр гайхмаар бөгөөд Нигүүлслийн эрин үед Эзэн Есүсийн үзүүлсэн гайхамшгуудыг маш сайн төлөөлдөг.

Эхлээд эхний хэсгийг авч үзэцгээе: Есүс таван мянган хүнийг хооллосон нь.

“Таван талх, хоёр загас” гэдгийн санаа нь юу вэ? Таван талх, хоёр загас ер нь хэдэн хүнийг хангалттай хооллож чадах вэ? Хэрвээ та нар дундаж хүний хоолны дуршилд үндэслэн хэмжих юм бол энэ нь ердөө хоёр хүнд л хангалттай. Энэ бол “таван талх, хоёр загасны” хамгийн үндсэн санаа юм. Гэсэн хэдий ч энэхүү хэсэгт таван талх, хоёр загасаар хэдэн хүнийг хооллосон бэ? Библид дараах байдлаар тэмдэглэсэн байдаг: “Тэр газар өвс ихтэй байв. Ийнхүү таван мянга орчим хүн сууцгаалаа.” Таван талх, хоёр загастай харьцуулахад таван мянга их тоо юу? Энэ тоо маш их гэдэг нь юуг харуулдаг вэ? Хүний өнцгөөс харвал, таван талх болон хоёр загасыг таван мянган хүнд хуваах боломжгүй, учир нь хүмүүс болон хоолны хоорондох зөрүү дэндүү их. Хүн болгон тун жаахан хазсан ч гэсэн таван мянган

хүнд хүрэлцэхгүй. Гэвч энд Эзэн Есүс гайхамшиг үзүүлсэн—Тэр зөвхөн таван мянган хүнийг цадтал нь идүүлсэн төдийгүй бүр хоол үлдсэн. Библид: “Хүмүүс цадсаны дараа Тэр шавь нартаа: ‘Юу ч хаяхгүйн тулд үлдэгдлийг нь цуглуул’ гэв. Тийнхүү хүмүүс идээд илүү гарсан таван арвайн талхнаас үлдсэн цөвдлийг тэд бүгдийг нь цуглуулж, арван хоёр сагс дүүргэжээ” гэсэн байна. Энэ гайхамшиг нь Эзэн Есүсийн ялгамж чанар, байр суурийг хүмүүст харуулж, Бурханд боломжгүй юм гэж байдаггүйг харуулсан—ийм маягаар тэд Бурханы бүхнийг чадагч байдлын үнэн мөнийг харсан юм. Таван талх ба хоёр загас нь таван мянган хүнийг хооллоход хангалттай байсан, гэхдээ тэнд ямар ч хоол байгаагүй бол Бурхан таван мянган хүнийг хооллож чадах байсан уу? Мэдээж, чадах байсан! Энэ бол гайхамшиг байсан, иймээс хүмүүст энэ нь ойлгохын аргагүй, ер бусын, нууцлаг санагдаж байсан нь гарцаагүй, харин Бурханы хувьд тийм зүйл хийх нь юу ч биш байв. Энэ нь Бурханы хувьд нэгэнт энгийн зүйл байсан юм бол яагаад одоо үүнийг онцгойлон тайлбарлах ёстой юм бэ? Яагаад гэвэл, энэ гайхамшгийн цаана байгаа зүйл нь урьд өмнө нь хүн төрөлхтний хэзээ ч нээн илрүүлээгүй Эзэн Есүсийн хүслийг агуулдаг.

Эхлээд энэ таван мянган хүн ямар хүмүүс байсныг ойлгох гээд үзье. Тэд Эзэн Есүсийн дагалдагчид байсан уу? Тэд Түүний дагалдагчид байгаагүй гэдгийг бид Библиэс мэдэж байна. Эзэн Есүс хэн болохыг тэд мэддэг байсан уу? Мэдээж үгүй! Ядаж л, өмнө нь зогсож буй хүн Христ байсныг тэд мэдээгүй, эсвэл зарим хүн зөвхөн Түүний нэрийг мэдэж, Түүний хийсэн зүйлийн талаар ямар нэг зүйл мэдсэн юм уу сонссон байж магадгүй. Тэдний хувьд Эзэн Есүсийн тухай түүхийг сонсох үедээ сониуч зан нь төрсөн төдий, харин тэднийг Түүнийг дагадаг байсан гэх нь бүү хэл, Түүнийг ойлгодог байсан гэж хэлж лав болохгүй. Эзэн Есүс энэ таван мянган хүнийг харахад тэд өлсөж, гэдсээ дүүргэх тухай л бодож байсан тул энэ нөхцөлд Эзэн Есүс тэдний хүслийг биелүүлжээ. Тэдний хүслийг биелүүлэхдээ Түүний зүрх сэтгэлд юу байсан бэ? Зөвхөн цадталаа идэхийг л хүсэж байсан энэ хүмүүст хандах Түүний хандлага ямар байсан бэ? Энэ үед Эзэн Есүсийн бодол болон хандлага нь Бурханы зан чанар, мөн чанартай хамаатай байсан. Зөвхөн их хоол идэхийг л хүссэн хоосон ходоодтой энэ таван мянган хүнтэй тулгараад, Өөрийнх нь талаар сониуч зан, итгэл найдвараар дүүрэн энэ хүмүүстэй тулгараад Эзэн Есүс тэдэнд нигүүлсэл хүртээхийн тулд энэ гайхамшгийг ашиглах талаар л бодсон. Гэхдээ тэд Өөрийнх нь дагалдагч болно гэж Тэр найдаагүй, учир нь тэд зүгээр л зугаацаж, цадталаа идэхийг хүссэн гэдгийг Тэр мэдэж байсан тул Өөртөө байсан зүйлийг ашигтайгаар ашиглаж, таван мянган хүнийг хооллохын тулд таван талх, хоёр загас хэрэглэжээ. Тэр сонирхолтой зүйл харах дуртай, гайхамшиг харахыг хүссэн энэ хүмүүсийн нүдийг нээж, тэд бие махбодтой болсон Бурханы гүйцэлдүүлж чадах зүйлсийг өөрсдийн нүдээр харсан билээ. Хэдийгээр тэдний сониуч занг хангахын тулд Эзэн Есүс биет зүйл ашигласан боловч энэ таван мянган хүн ердөө л сайн хоол идэхийг хүсэж байсныг зүрх сэтгэлдээ хэдийнээ мэдэж

байсан болохоор Тэр тэдэнд номлоогүй, юу ч хэлээгүй—зүгээр л тэдэнд энэ гайхамшгийг харуулсан. Тэр энэ хүмүүст Өөрийг нь үнэнчээр дагадаг шавь нартаа ханддаг шиг хандаж яавч чадаагүй, гэхдээ Бурханы зүрх сэтгэлд бүх бүтээл Өөрийнх нь захиралт дор байдаг бөгөөд шаардлагатай үед Бурханы нигүүлслийг хүртэх боломжийг Өөрийн хараанд буй бүтээлд олгодог юм. Энэ хүмүүс Түүний хэн болохыг мэдээгүй, Түүнийг ойлгоогүй, талх, загас идсэнийхээ дараа ч Түүний талаар ямар нэг гойд сэтгэгдэл, Түүнд талархах сэтгэл төрөөгүй байлаа ч энэ нь Бурханы дургүйцээд байх юм биш байсан—Тэр энэ хүмүүст Бурханы нигүүлслийг эдлэх гайхалтай боломж өгсөн. Бурхан хийдэг зүйлдээ зарчимч байдаг бөгөөд үл итгэгчдийг харж, хамгаалдаггүй, ялангуяа тэдэнд Өөрийнхөө нигүүлслийг эдлүүлдэггүй гэж зарим хүн хэлдэг. Үнэхээр тийм байдаг уу? Бурханы нүдээр бол тэд Түүний Өөрийнх нь бүтээсэн амьд бүтээл мөн болохоор Тэр тэднийг удирдаж, анхаарал тавьж, олон янзын байдлаар тэдэнд хандаж, тэдний төлөө төлөвлөж, тэднийг захирна. Эдгээр нь бүх зүйлд хандах Бурханы бодол ба хандлага юм.

Хэдийгээр талх, загас идсэн таван мянган хүн Эзэн Есүсийг дагахаар төлөвлөөгүй ч гэсэн Тэр тэдэнд хатуу шаардлага тавиагүй; тэднийг цадталаа идсэний дараа Эзэн Есүс юу хийснийг та нар мэдэх үү? Тэр тэдэнд ер нь номлосон уу? Үүнийг хийснийхээ дараа Тэр хаашаа явсан бэ? Сударт Эзэн Есүс тэдэнд ямар нэг зүйл хэлсэн гэж тэмдэглээгүй, харин Тэр гайхамшиг үйлдчихээд чимээгүйхэн явж одсон. Тэгвэл тэр хүмүүст Тэрээр ямар нэгэн шаардлага тавьсан уу? Ямар нэгэн үзэн ядалт байсан уу? Үгүй, эдгээрийн аль нь ч байгаагүй. Өөрийг нь дагаж чадахгүй энэ хүмүүст Тэр цаашид ямар ч анхаарал хандуулахыг хүсээгүй бөгөөд энэ удаа Түүний зүрх сэтгэл шаналж байсан. Яагаад гэвэл, Тэрээр хүн төрөлхтөн буруу замд орсныг харж, хүн төрөлхтөн Өөрийг нь голсныг мэдэрсэн бөгөөд энэ хүмүүсийг харж, тэдэнтэй хамт байх үедээ хүний мулгуу, мунхаг байдлаас болж маш их гуниглаж, сэтгэл нь өвдсөн учраас Тэр энэ хүмүүсийг аль болох хурдан орхиж явахыг л хүссэн. Эзэн зүрх сэтгэлдээ тэдэнд ямар ч шаардлага тавиагүй, тэдэнд ямар ч анхаарал хандуулахыг хүсээгүй, тэр тусмаа Өөрийн эрч хүчийг тэдэнд зарцуулахыг хүсээгүй. Тэд Өөрийг нь дагаж чадахгүй гэдгийг мэдэж байсан боловч энэ бүхнийг үл хайхран тэдэнд хандах Түүний хандлага мөн л маш тодорхой байв. Тэдэнд нигүүлсэл хүртээхийн тулд Тэр тэдэнд эелдгээр хандахыг л хүсэж байсан бөгөөд үнэндээ энэ нь Өөрийн захиралт доорх бүх бүтээлд хандах Бурханы хандлага буюу бүх бүтээлд эелдгээр хандаж, тэднийг хангаж, хооллож тэжээх явдал юм. Эзэн Есүс бие махбодтой болсон Бурхан байсан учраас Бурханы мөн чанарыг аяндаа илчилж, энэ хүмүүст эелдгээр хандсан. Тэр өршөөнгүй, хүлээцтэй сэтгэлээр тэдэнд хандаж, тийм зүрх сэтгэлээр эелдэг зангаа харуулж байсан юм. Энэ хүмүүс Эзэн Есүсийг яаж үзэж байсан болон ямар үр дүн гарахаас үл хамааран бүх бүтээлийн Эзэний байр сууринд үндэслэн бүтээл бүрд хандсан. Түүний илчилсэн бүхэн нь гарцаагүй Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох байв. Эзэн Есүс энэ зүйлийг чимээгүйхэн хийгээд, дараа нь чимээгүйхэн

явсан—энэ нь Бурханы зан чанарын ямар тал вэ? Үүнийг Бурханы хайр энэрэл гэж болох уу? Үүнийг Бурханы аминч бус байдал гэж хэлж болох уу? Энэ нь жирийн нэг хүний хийж чадах зүйл мөн үү? Мэдээж үгүй! Эзэн Есүсийн таван талх, хоёр загасаар хооллосон энэ таван мянган хүн мөн чанартаа хэн байсан бэ? Тэдгээр нь Түүнтэй нийцдэг хүмүүс байсан гэж хэлж болох уу? Тэд бүгд Бурханд дайсагнаж байсан гэж хэлж болох уу? Тэд Эзэнтэй огт нийцтэй байгаагүй бөгөөд тэдний мөн чанар нь Бурханд туйлын дайсагнасан байсан гэж итгэлтэйгээр хэлж болно. Гэвч Бурхан тэдэнтэй хэрхэн харьцсан бэ? Тэрээр хүмүүсийн Бурханд хандах дайсагналыг намдаах арга ашигласан—энэ аргыг “найрсаг зан” гэдэг юм. Өөрөөр хэлбэл, хэдийгээр Эзэн Есүс энэ хүмүүсийг нүгэлтнүүд гэж харсан ч гэсэн Бурханы нүдэнд тэд Түүний бүтээл байсан, иймээс Тэр эдгээр нүгэлтэнтэй мөн л найрсаг харьцсан юм. Энэ бол Бурханы хүлээцтэй зан бөгөөд энэ хүлээцтэй зан нь Бурханы Өөрийн ялгамж чанар болон мөн чанараар тодорхойлогддог. Иймээс энэ нь Бурханы бүтээсэн ямар ч хүний хийж чадахгүй зүйл—Бурхан л үүнийг хийж чадна.

Чи Бурханы бодол, хүн төрөлхтөнд хандах хандлагыг үнэхээр ойлгож, бүтээгдсэн зүйл бүрийг гэх Бурханы сэтгэл хөдлөл, санаа зовнилыг үнэхээр ойлгох үедээ Бүтээгчийн бүтээсэн хүн нэг бүрд зориулсан халамж, хайрыг ойлгож чадна. Ийм зүйл тохиолдох үед чи Бурханы хайрыг дүрслэх хоёр үгийг хэрэглэнэ. Тэр хоёр үг нь юу вэ? Зарим хүн “аминч бус” гэдэг, зарим нь “энэрэн туслах” гэдэг. Энэ хоёроос “энэрэн туслах” гэдэг нь Бурханы хайрыг илэрхийлэхэд хамгийн тохиромжгүй үг юм. Энэ үг бол хүмүүс уужим сэтгэлтэй, өргөн мэдлэгтэй хүнийг дүрслэхдээ хэрэглэдэг үг юм. Энэ нь ямар ч зарчмыг үл харгалзан буяны ажлыг ялгаварлахгүйгээр, мухар сохроор хийхийг хэлдэг учраас Би энэ үгийг үзэн яддаг. Энэ нь мунхаг, төөрөлдсөн хүмүүст түгээмэл байдаг уян сэтгэлийн илэрхийлэл юм. Бурханы хайрыг дүрслэхээр энэ үгийг хэрэглэх үед гарцаагүй гутаан доромжилсон утга байдаг. Бурханы хайрыг илүү зохистойгоор илэрхийлэх хоёр үг энд Надад байна. Тэр нь юу вэ? Эхнийх нь “энгүй”. Энэ үг маш их дурсамж сэргээдэг биш үү? Хоёр дахь нь “уудам”. Бурханы хайрыг дүрслэхэд Миний хэрэглэдэг энэ хоёр үг цаанаа бодит утга учиртай. Үгчилбэл, “энгүй” гэдэг нь юмны хэмжээ, эсвэл багтаамжийг дүрслэдэг, гэхдээ тэр зүйл хэчнээн том байх нь хамаагүй, энэ нь хүмүүсийн харж, хүрч чадах зүйл юм. Яагаад гэвэл, энэ нь оршин байдаг—энэ нь хийсвэр юм биш, харин хүмүүст харьцангуй үнэн зөв, бодитой байдлаар ойлголт өгч чадах зүйл юм. Чи үүнийг хоёр юм уу гурван хэмжээст өнцгөөс харж байгаа нь хамаагүй, энэ нь бодитой байдлаар оршин байдаг зүйл учраас оршин тогтнолыг нь төсөөлөх шаардлагагүй. Бурханы хайрыг дүрслэхийн тулд “энгүй” гэдэг үг хэрэглэх нь хэдийгээр Түүний хайрыг тоо хэмжээгээр тодорхойлохоор оролдож байгаа мэт боловч энэ нь Түүний хайр бол тоолохын аргагүй гэсэн мэдрэмжийг мөн өгдөг. Бурханы хайр нь хий хоосон зүйл ч биш, үлгэр домгийн зүйл ч биш учраас Бурханы хайрын хэмжээг тодорхойлж болно гэж Би хэлдэг. Харин ч энэ нь Бурханы захиралт доор буй бүх зүйлийн хуваалцдаг зүйл бөгөөд бүх бүтээл янз бүрийн түвшинд өөр

өөр өнцгөөс хүртдэг зүйл билээ. Хэдийгээр хүмүүс үүнийг харж, эсвэл үүнд хүрч чадахгүй боловч энэхүү хайр бүх зүйлийг тэжээж, амьдруулдаг нь тэдний амьдралд Бурханы хайрыг бага багаар илчилдэг ба өнгөрөн одож буй хором бүрд тэдний эдэлсэн Бурханы хайрыг тоолж, гэрчилдэг. Бүх зүйлийг хангаж, тэжээн тэтгэж байгаа Бурханы нууц нь, мөн бүх зүйлийн төлөөх Бурханы бодол, ялангуяа хүмүүсийн төлөөх Бурханы бодол нь хүмүүсийн хувьд ойлгож ухаарахад хэцүү зүйл учраас Би Бурханы хайр бол хэмжээлшгүй гэж хэлдэг. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний төлөө урсгасан Бүтээгчийн цус, нулимсыг хэн ч мэдэхгүй. Өөрийнхөө гараар бүтээсэн хүн төрөлхтнийг гэх Бурханы хайрын гүнийг юм уу жинг хэн ч ухаарч чадахгүй, хэн ч ойлгож чадахгүй. Бурханы хайрыг энгүй гэж дүрслэх нь үүний өргөн хүрээ болон оршин тогтнолын үнэнийг ухаарч, ойлгоход хүмүүст туслахын тулд байдаг. Мөн ингэснээр хүмүүс “Бүтээгч” гэдэг үгийн жинхэнэ утгыг илүү гүнзгий ухаарч, “бүтээл” хэмээх нэршлийн жинхэнэ утгыг илүү гүнзгий ойлгож чадна. “Уудам” гэдэг үг ихэнхдээ юу дүрсэлдэг вэ? Энэ нь ерөнхийдөө “уудам орчлон”, эсвэл “уудам далай” гэх мэтээр далай тэнгис, эсвэл орчлон ертөнцийг дүрслэхэд хэрэглэгддэг. Орчлон ертөнцийн өргөн уудам, аниргүй гүнийг хүн ойлгохын аргагүй; энэ нь хүний төсөөллийг эзэмддэг, тэдний асар их бахдан биширдэг зүйл юм. Үүний нууцлаг, гүн гүнзгий байдал нь нүдэнд харагдахуйц атлаа хүрэхийн аргагүй байдаг. Далай тэнгисийн тухай бодохдоо чи өргөн уудмыг нь боддог—энэ нь зах хязгааргүй харагддаг ба чи үүний нууцлаг байдал болон асар ихийг багтаах багтаамжийг нь мэдэрдэг. Ийм учраас Би Бурханы хайрыг дүрслэхийн тулд “уудам” гэдэг үгийг хэрэглэж, энэ хайр хэчнээн үнэ цэнтэйг мэдэрч, Бурханы хайрын гүн гүнзгий гоо сайхныг болон Түүний хайрын хүч хязгааргүй, өргөн уудам гэдгийг мэдрэхэд нь хүмүүст туслах гэсэн билээ. Би Түүний хайрын ариун байдал болон Түүний хайраар илчлэгдсэн Бурханы эрхэм чанар, халдашгүй байдлыг мэдрэхэд нь хүмүүст туслахын тулд энэ үгийг ашигласан юм. Одоо та нар “уудам” гэдэг нь Бурханы хайрыг дүрслэхэд тохиромжтой үг мөн гэж бодож байна уу? Бурханы хайр “энгүй”, “уудам” гэсэн энэ хоёр үгтэй тохирох уу? Маргаангүй! Гагцхүү энэ хоёр үг л Бурханы хайрыг хүний хэлээр дүрслэхэд харьцангуй тохиромжтой, харьцангуй ойр дөхөм байдаг. Та нар тэгж бодохгүй байна уу? Хэрвээ Би та нараар Бурханы хайрыг дүрслүүлсэн бол та нар энэ хоёр үгийг хэрэглэх байсан уу? Та нар бараг л тэгэхгүй, учир нь Бурханы хайрын талаарх та нарын ойлголт болон ухаарал хоёр хэмжээст өнцгийн цар хүрээнд хязгаарлагдсан бөгөөд гурван хэмжээст орон зайн өндөрт хүрээгүй. Иймээс хэрвээ Би та нараар Бурханы хайрыг дүрслэн хэлүүлсэн бол хэлэх үг дутаж байгаагаа та нар мэдрэх байсан; эсвэл та нар бүр хэлэх ч үггүй болох байсан. Өнөөдөр Миний ярьсан хоёр үгийг ойлгоход та нарт хэцүү байсан байж магадгүй, эсвэл та нар зүгээр л санал нийлэхгүй байж ч магадгүй. Энэ нь Бурханы хайрын талаарх та нарын ухаарал болон ойлголт өнгөцхөн бөгөөд явцуу хүрээнд хязгаарлагддагийг л харуулж байна. Бурхан аминч бус гэж Би өмнө нь хэлсэн; та нар “аминч бус” гэх

энэ үгийг санаж байгаа. Бурханы хайрыг зөвхөн аминч бус хэмээн дүрсэлж болох юм гэж үү? Энэ нь хэт явцуу хүрээ биш гэж үү? Та нар үүнээс ямар нэг зүйл олж авахын тулд энэ асуудлыг илүү их тунгаан бодох ёстой.

Дээрх зүйлс нь эхний гайхамшгаас Бурханы зан чанар, мөн чанарын талаар бидний харсан зүйл юм. Энэ нь хэдэн мянган жилийн турш хүмүүсийн уншиж ирсэн түүх хэдий ч нэгэн энгийн үйл явдлыг агуулдаг, хүмүүст нэгэн энгийн үзэгдэл харах боломж олгодог атлаа энэхүү энгийн үйл явдлаас бид илүү үнэ цэнтэй зүйл болох Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг харж чаддаг. Түүнд юу байгаа, Тэр юу болох нь Бурханыг Өөрийг нь төлөөлдөг бөгөөд Бурханы Өөрийнх нь бодлын илэрхийлэл юм. Бурхан Өөрийнхөө бодлыг илэрхийлэх нь Түүний зүрх сэтгэлийн дуу хоолойн илэрхийлэл байдаг. Түүнийг ойлгож, Түүнийг мэдэж, Түүний хүслийг ухаарч, Түүний зүрх сэтгэлийн дуу хоолойг сонсож, Түүний хүслийг хангахаар идэвхтэйгээр хамтран ажиллаж чадах хүмүүс байх болно гэж Тэр найддаг. Эзэн Есүсийн хийсэн эдгээр зүйл нь Бурханы чимээгүй илэрхийлэл байсан юм.

Дараа нь Лазарын амилал Бурханыг алдаршуулсан нь гэх хэсгийг харцгаая.

Энэ хэсгийг уншсаны дараа та нарт ямар сэтгэгдэл төрсөн бэ? Эзэн Есүсийн гүйцэтгэсэн энэ гайхамшгийн ач холбогдол нь өмнөхөөсөө хамаагүй их байсан, учир нь үхсэн хүнийг булшнаас нь буцаан амилуулахаас илүү гайхалтай гайхамшиг гэж үгүй. Эзэн Есүс иймэрхүү зүйлийг хийх нь тухайн эрин үед туйлын ач холбогдолтой байв. Бурхан бие махбодтой болсон учраас хүмүүс зөвхөн Түүний гадаад дүр төрхийг, Түүний бодитой талыг болон Түүний ялихгүй жаахан талыг л харж байсан. Хэдийгээр зарим хүн Түүний зан авирын заримыг юм уу Түүнд байсан зарим онцгой чадварыг харж, ойлгож байсан боловч Эзэн Есүс хаанаас ирснийг, мөн чанартаа чухам хэн байсныг, үнэндээ өөр ямар зүйл хийх чадвартайг хэн ч мэдээгүй. Энэ бүхнийг хүн төрөлхтөн мэддэггүй байсан. Маш олон хүн Эзэн Есүсийн талаарх эдгээр асуултад хариулах нотолгоог олж, үнэнийг мэдэхийг хүссэн. Бурхан Өөрийн ялгамж чанарыг нотлохын тулд ямар нэг зүйл хийж чадах байсан уу? Бурханы хувьд энэ нь хялбархан ажил байлаа. Тэр Өөрийн ялгамж чанар, мөн чанарыг нотлохын тулд хаана ч, хэдийд ч ямар нэг юм хийж чадах байв, гэхдээ Бурхан аливааг төлөвлөгөөтэйгээр, алхам алхмаар хийдэг. Тэр аливаа зүйлийг эмх замбараагүйгээр хийгээгүй, харин ч хүнд харуулах хамгийн утга учиртай зүйлийг хийхдээ зөв цаг, зөв боломжийг хайдаг байлаа. Ийм маягаар Тэр эрх мэдэл, ялгамж чанараа нотолсон юм. Тэгвэл Лазарыг амилуулсан нь Эзэн Есүсийн ялгамж чанарыг нотолж чадсан уу? Бичвэрийн дараах хэсгийг харцгаая: “Тэр тийнхүү өгүүлснийхээ дараа чанга дуугаар ‘Лазар, гараад ир!’ гэж хашхирсанд … тэр үхсэн хүн гарч ирэв…” Эзэн Есүс үүнийг хийх үедээ: “Лазар, гараад ир” гэдэг ганц зүйл л хэлсэн. Лазар дараа нь булшнаасаа гарч ирсэн—энэ нь Эзэний хэлсэн хэдхэн үгээс үүдэн биелсэн юм. Энэ хугацаанд Эзэн Есүс тахилын ширээ босгоогүй, өөр ямар ч үйлдэл хийгээгүй. Тэр ганцхан зүйл л хэлсэн.

Үүнийг гайхамшиг гэх ёстой юу, эсвэл тушаал гэх үү? Эсвэл ид шид маягийн юм байсан уу? Өнгөн дээрээ энэ нь гайхамшиг гэгдэж болох юм шиг санагддаг бөгөөд үүнийг орчин үеийн өнцгөөс харвал мэдээж бас л гайхамшиг гэж болно. Харин үхсэн хүний сүнсийг дуудаж авчрах учиртай нэг төрлийн ид шид гэж үзэж болохгүй, энэ нь яавч ямар нэг төрлийн илбэ увдис байгаагүй. Энэ гайхамшиг нь Бүтээгчийн эрх мэдлийн хамгийн энгийн, өчүүхэн төдий баталгаа байсан гэж хэлэх нь зөв. Энэ бол Бурханы эрх мэдэл, хүч чадал билээ. Бурханд хүнийг үхүүлж, түүний сүнсийг биеэс нь одуулж, Үхэгсдийн орон руу, эсвэл очих ёстой газар луу нь явуулах эрх мэдэл байдаг. Хүний үхэх хугацаа, үхсэнийхээ дараа очих газрыг Бурхан шийддэг. Тэрээр хүмүүс, үйл явдал, обьект, орон зай, газар нутагт хязгаарлагдалгүйгээр эдгээр шийдвэрийг хаана ч, хэдийд ч гаргаж чадна. Тэр хийхийг хүсвэл хийж чадна, учир нь бүх зүйл, бүх амьд амьтан Түүний захиралт дор байдаг бөгөөд бүх зүйл Түүний үгээр, Түүний эрх мэдлээр төрж, амьдарч, устаж үгүй болдог. Тэр үхсэн хүнийг амилуулж чадна, энэ нь ч бас Түүний хэдийд ч, хаана ч хийж чадах зүйл юм. Энэ бол гагцхүү Бүтээгчийн эзэмшдэг эрх мэдэл билээ.

Лазарыг үхлээс буцаан авчрах гэх зэрэг зүйлийг хийсэн Эзэн Есүсийн зорилго нь хүн болон Сатанд нотолгоо харуулах, мөн хүн төрөлхтний бүх зүйлийг, хүн төрөлхтний амьдрал, үхлийг Бурхан шийддэг ба Тэр хэдийгээр бие махбодтой болсон ч гэсэн харж болох бодит ертөнц, түүнчлэн хүний харж чадахгүй сүнсний ертөнцийг захирсан хэвээр байгаа гэдгийг хүмүүс болон Сатанд мэдэгдэх явдал байсан юм. Үүгээрээ хүн төрөлхтний бүх зүйл Сатаны тушаал дор байдаггүй гэдгийг хүн төрөлхтөн болон Сатанд харуулах гэсэн. Энэ нь Бурханы эрх мэдлийг илчилж, харуулсан ба мөн хүн төрөлхтний амьдрал, үхэл Бурханы гарт байдаг гэсэн үгийг бүх зүйлд илгээх Бурханы арга байсан юм. Эзэн Есүс Лазарыг амилуулсан нь хүн төрөлхтөнд зааж, зааварлах Бүтээгчийн аргуудын нэг байлаа. Энэ нь хүн төрөлхтөнд зааварлаж, хүн төрөлхтнийг хангахын тулд Өөрийн хүч чадал, эрх мэдлийг ашигласан бодит үйлдэл байсан юм. Энэ нь Тэр бүх зүйлийг удирддаг хэмээх үнэнийг хүн төрөлхтөнд харуулах Бүтээгчийн үггүй арга байв. Мөн Түүгээр дамжихгүйгээр ямар ч аврал байхгүй гэдгийг хүн төрөлхтөнд бодит үйлдлээр хэлэх Түүний арга зам байлаа. Хүн төрөлхтөнд зааварчлахдаа Түүний ашигласан ийм чимээгүй арга барил нь үүрдийн, арилшгүй байдаг бөгөөд хүмүүсийн зүрх сэтгэлээс хэзээ ч арилахгүй цочрол болон гэгээрлийг авчирсан юм. Лазар амилсан нь Бурханыг алдаршуулсан—энэ нь Бурханы дагалдагч нэг бүрд гүн нөлөө үзүүлсэн. Энэ нь уг үйл явдлыг гүнээ ойлгодог хүн бүрд гагцхүү Бурхан л хүн төрөлхтний амьдрал, үхлийг тушааж чадна гэсэн ойлголт, үзэгдлийг бат суулгасан. Бурханд ийм эрх мэдэл байдаг хэдий ч, мөн Тэр Лазарыг амилуулж хүн төрөлхтний амьдрал, үхлийг захирдаг Өөрийнхөө дээд эрхийг мэдэгдсэн хэдий ч энэ нь Түүний үндсэн ажил байгаагүй. Бурхан ямар нэг зүйлийг хэзээ ч утга учиргүйгээр хийдэггүй. Түүний хийдэг юм бүхэн асар их үнэ цэнтэй байдаг бөгөөд энэ нь эрдэнэсийн агуулах дахь гоц гойд эрдэнийн чулуу юм. Тэрээр “хүнийг булшнаас нь

гаргахыг” Өөрийн ажлын үндсэн, цорын ганц зорилго юм уу хэсэг огтхон ч болгохгүй. Бурхан утга учиргүй зүйл хийдэггүй. Дан ганц Лазарын амилал нь Бурханы эрх мэдлийг харуулж, Эзэн Есүсийн ялгамж чанарыг батлахад хангалттай юм. Ийм учраас Эзэн Есүс ийм гайхамшгийг давтаагүй. Бурхан аливаа зүйлийг Өөрийнхөө зарчмын дагуу хийдэг. Хүний хэлээр бол Бурханы оюун санааг ноцтой асуудлууд эзэмддэг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, Бурхан аливааг хийхдээ Өөрийн ажлын зорилгоос хазайдаггүй. Энэ үе шатанд Тэр ямар ажил хийхийг хүсэж байгаагаа, юу бүтээхийг хүсэж байгаагаа мэддэг бөгөөд Өөрийн төлөвлөгөөний дагуу хатуу чанд ажиллана. Хэрвээ ялзарсан хүнд ийм чадвар байсан бол тэр хэчнээн аймаар гэдгээ бусдад мэдэгдэхийн тулд өөрийн чадварыг харуулах арга замыг л бодох ба ингэснээр тэд түүнд мэхийн ёсолж, ингэснээр тэр тэднийг хянаж, тэднийг залгих байсан. Энэ бол Сатанаас гардаг ёрын муу юм—үүнийг ялзрал гэдэг. Бурханд тийм зан чанар байдаггүй, тийм мөн чанар байдаггүй. Аливааг хийх Түүний зорилго бол Өөрийгөө гайхуулах явдал биш, харин хүн төрөлхтнийг илүү их илчлэл болон удирдамжаар хангах явдал юм, иймээс хүмүүс Библиэс ийм төрлийн тун цөөхөн жишээ хардаг. Энэ нь Эзэн Есүсийн хүч чадал хязгаарлагдмал байсан, эсвэл Тэр тийм төрлийн зүйл хийх чадваргүй байсан гэсэн үг биш юм. Бурхан зүгээр л үүнийг хийхийг хүсээгүй, учир нь Эзэн Есүс Лазарыг амилуулсан нь маш бодит ач холбогдолтой байсан, мөн Бурхан бие махбодтой болсны үндсэн ажил нь гайхамшиг үзүүлэх явдал байгаагүй, үхсэн хүмүүсийг амьдруулах явдал байгаагүй, харин хүн төрөлхтнийг золин аврах ажил байсан юм. Иймээс Эзэн Есүсийн гүйцэтгэсэн ажлын ихэнх нь хүмүүст заах, тэднийг хангах, тэдэнд туслах явдал байсан бөгөөд Лазарыг амилуулах зэрэг үйл явдал нь Эзэн Есүсийн хэрэгжүүлсэн үйлчлэлийн ердөө өчүүхэн хэсэг байв. Тэр ч бүү хэл “гайхуулах” гэдэг нь Бурханы мөн чанарын нэг хэсэг биш гэж хэлж болох тул Эзэн Есүс илүү олон гайхамшиг үзүүлээгүй нь зориуд биеэ барьсных биш, мөн орчны хязгаарлалтаас ч болсон биш бөгөөд хүч чадал дутсаных лав биш байсан юм.

Эзэн Есүс Лазарыг үхлээс буцааж авчрахдаа: “Лазар, гараад ир” гэсэн энэ хэдэн үгийг л хэрэглэсэн. Тэр үүнээс өөр юу ч хэлээгүй. Тэгвэл эдгээр үг юуг харуулдаг вэ? Эдгээр нь, үхсэн хүнийг амилуулахыг оролцуулаад Бурхан үг яриагаараа юуг ч бүтээж чадна гэдгийг харуулдаг. Бурхан бүх зүйлийг бүтээхдээ, дэлхийг бүтээхдээ үгээрээ л хийж, аман тушаал, эрх мэдэлтэй үг хэрэглэсэн бөгөөд ийм маягаар бүх зүйл бүтээгдэж, тийнхүү гүйцэлдсэн. Эзэн Есүсийн хэлсэн энэ хэдхэн үг тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээхдээ Бурханы хэлсэн үгтэй яг адилхан байсан; энэ нь Бурханы эрх мэдэл, Бүтээгчийн хүч чадлыг адил тэнцүү агуулж байлаа. Бурханы амнаас гарсан үгийн үрээр бүх зүйл бүрэлдэж тогтсонтой яг адилаар Эзэн Есүсийн амнаас гарсан үгээс болж Лазар булшнаасаа алхан гарч ирсэн юм. Энэ нь Өөрийн махбод болсон биеэр нотлон харуулж, гүйцэтгэсэн Бурханы эрх мэдэл байсан билээ. Ийм төрлийн эрх мэдэл болон чадвар нь Бүтээгчид болон Бүтээгчийн биеллээ олсон хүний Хүүд харьяалагдаж байв. Энэ нь

Лазарыг үхлээс буцаан авчирснаар хүн төрөлхтөнд Бурханы заасан ойлголт юм. Одоо бид энэ сэдвийн талаарх хэлэлцүүлгээ ингээд дуусгая. Тэгээд бичвэрийг дахиад жаахан уншицгаая.

10. Есүсийн талаарх фарисайчуудын шүүлт

Марк 3:21–22 Есүсийн хамаатан нь энэ тухай сонсоод Түүнийг барьж авахаар явав. Тэд, “Тэр өөрийн ухаангүй болжээ” хэмээв. Иерусалимаас бууж ирсэн хуулийн багш нар, “Түүнд Беелзебүл байгаа, Тэр чөтгөрүүдийн захирагчаар чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг” гэв.

11. Есүс фарисайчуудыг зэмлэсэн нь

Матай 12:31–32 Би та нарт хэлж буйн учир бол хүмүүсийн аливаа нүгэл болон доромжлол уучлагдаж болно: гэвч Ариун Сүнсийг доромжилсон хүний нүгэл уучлагдахгүй. Хүний Хүүгийн эсрэг үг хэлдэг хэн боловч уучлагдана: гэвч Ариун Сүнсний эсрэг үг хэлдэг хэн боловч энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй.

Матай 23:13–15 Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Яагаад гэвэл та нар хүмүүсээс тэнгэрийн хаанчлалыг хааж, өөрсдөө орохгүй бөгөөд орж буй хүмүүсийг ч бас оруулдаггүй. Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар бэлэвсэн эмэгтэйчүүдийн гэрийг цөлмөдөг ба дүр үзүүлж удаан залбирал хийдэг: тийм учраас та нар илүү их хараал хүртэх болно. Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Та нар тэнгис далай болон газар нутгийг тойрч, ганц хүнийг сүсэгтнээ болгохын тулд уруу татан, тэгэх үедээ түүнийг өөрсдөөсөө хоёр дахин дор тамын хүү болгодог.

Дээр буй хоёр хэсгийн агуулга нь өөр. Эхлээд эхний хэсгийг нь харцгаая: Есүсийн талаарх фарисайчуудын шүүлт.

Есүсийн Өөрийнх нь талаар болон Түүний хийсэн зүйлийн талаар фарисайчуудын үнэлснийг Библид: “Тэр өөрийн ухаангүй болжээ… Түүнд Беелзебүл байгаа, Тэр чөтгөрүүдийн захирагчаар чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг гэж тэд хэлжээ” (Марк 3:21–22) гэсэн. Эзэн Есүсийн талаарх хуулийн багш нар болон фарисайчуудын шүүлт нь зүгээр л бусад хүмүүсийн үгийг дуурайж байсан хэрэг биш, үндэслэлгүй таамаглал ч байсан юм биш—энэ нь Эзэн Есүсийн үйлдлийг харж, сонссон зүйлээсээ үүдэн Түүний талаар гаргасан дүгнэлт нь юм. Хэдийгээр тэдний дүгнэлт өнгөн дээрээ шударга ёсны төлөө хийгдсэн, үндэслэл сайтай мэт хүмүүст харагдаж байсан боловч Эзэн Есүсийг шүүсэн хэгжүүн зангаа барих нь тэдэнд ч гэсэн хэцүү байсан. Эзэн Есүсийг үзэн ядах улайрсан эрч хүч нь тэдний өөрсдийнх нь зэрлэг хүсэл эрмэлзэл болон ёрын муу сатанлаг төрх байдал, түүнчлэн Бурханыг эсэргүүцсэн атаг муу уг чанарыг илчилсэн юм. Эзэн Есүсийг шүүхдээ тэдний хэлсэн эдгээр зүйл нь өөрсдийнх нь зэрлэг хүсэл эрмэлзэл, атаархал болон Бурхан ба үнэнд дайсагнасан балиар, атаг муу уг чанараас үүсэн гарсан юм. Тэд Эзэн Есүсийн үйлдлийн эх үүсвэрийг судлаагүй, Түүний хэлсэн, эсвэл хийсэн зүйлийн

мөн чанарыг ч шалгаагүй. Харин ч зориуд тэгэхээс тэгэх гэж сохроор, уурсан галзуурч, Түүний хийсэн зүйлийг дайрч давшлан, гутаасан. Тэд бүр Түүний Сүнсийг буюу Ариун Сүнсийг, Бурханы Сүнсийг хамаа намаагүй гутаахдаа тулсан. Тэдний “Тэр өөрийн ухаангүй болжээ”, “Бээлзебүл” ба “чөтгөрүүдийн захирагч” гэж хэлсэн нь ийм учиртай юм. Өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс нь Бээлзебүл буюу чөтгөрүүдийн захирагч гэж тэд хэлсэн. Өөрийгөө махбодоор хувцасласан, бие махбодтой болсон Бурханы Сүнсний ажлыг тэд галзуу хэмээн тодорхойлсон. Тэд Бурханы Сүнсийг Бээлзебүл, чөтгөрүүдийн захирагч гэж доромжилсноор үл барам Бурханы ажлыг яллаж, Эзэн Есүс Христийг яллаж, доромжилсон. Тэдний эсэргүүцэл болон Бурханыг доромжилсны мөн чанар нь Сатан болон диаволын Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл, доромжлолын мөн чанартай тэр чигээрээ адилхан байлаа. Тэд ялзарсан хүмүүсийг төлөөлөөд зогсохгүй, бүр Сатаны биелэл байсан юм. Тэд хүн төрөлхтний дундах Сатаны суваг байсан ба Сатаны хамсаатан, зарц нар байв. Тэдний Эзэн Есүс Христийг доромжилж, гүтгэсэн мөн чанар нь байр суурийн төлөө Бурхантай хийсэн тэдний тэмцэл, Бурхантай хийсэн тэдний өрсөлдөөн, Бурханыг эцэс төгсгөлгүй туршсан явдал байсан юм. Бурханыг эсэргүүцсэн тэдний эсэргүүцлийн мөн чанар болон Түүнд дайсагнасан хандлага, түүнчлэн тэдний үг, тэдний бодол Бурханы Сүнсийг шууд доромжилж, хилэгнүүлсэн. Тиймээс Бурхан тэдний хэлсэн, хийсэн зүйлийг зүй зохистойгоор шүүн тодорхойлж, тэдний үйл хэргийг Ариун Сүнсний эсрэг доромжлол үйлдсэн нүгэл гэж тодорхойлсон. Энэ нүгэл нь: “Ариун Сүнсийг доромжилсон хүний нүгэл уучлагдахгүй” ба “Ариун Сүнсний эсрэг үг хэлдэг хэн боловч энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй” хэмээх судрын хэсэгт хэлсэнчлэн энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй. “Энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй” хэмээх Бурханы үгийн жинхэнэ утга учрын тухай өнөөдөр ярилцъя. Өөрөөр хэлбэл, “энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй” гэх үгийг Бурхан хэрхэн биелүүлдгийн нууцыг тайлцгаая.

Бидний ярьсан бүхэн Бурханы зан чанар болон хүмүүс, үйл явдал, аливаа зүйлд хандах Түүний хандлагатай холбоотой. Мэдээжээр, дээрх хоёр хэсэг ч ялгаагүй. Библийн энэ хоёр хэсгээс та нар ямар нэг юм анзаарав уу? Тэдгээрээс Бурханы уур хилэнг харсан гэж зарим хүн хэлдэг. Зарим хүн, хүн төрөлхтний халдахыг тэвчдэггүй Бурханы зан чанарын нэг талыг харсан бөгөөд хэрвээ хүмүүс Бурханыг доромжлох ямар нэг зүйл хийвэл Түүний уучлалыг хүртэж чадахгүй гэж хэлдэг. Энэ хоёр хэсгээс хүмүүс Бурханы уур хилэн болон хүний халдахыг тэвчдэггүй байдлыг нь харж, ойлгодог баримт байгаа ч гэсэн тэд Түүний хандлагыг лавтай ойлгоогүй хэвээр байдаг. Энэ хоёр хэсэгт Түүнийг доромжилж, уурлуулдаг хүмүүст хандах Бурханы жинхэнэ хандлага болон арга замын далд утга агуулагддаг. Түүний хандлага болон арга зам нь “Ариун Сүнсний эсрэг үг хэлдэг хэн боловч энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй” хэмээх энэ хэсгийн жинхэнэ утга учрыг харуулдаг. Хүмүүс Бурханыг доромжилж, уурлуулах үед Тэр

ялын тогтоол гаргадаг ба энэ ялын тогтоол нь Түүний өгсөн үр дүн юм. Үүнийг Библид ийм байдлаар дүрсэлсэн байдаг: “Би та нарт хэлж буйн учир бол хүмүүсийн аливаа нүгэл болон доромжлол уучлагдаж болно: гэвч Ариун Сүнсийг доромжилсон хүний нүгэл уучлагдахгүй” (Матай 12:31), “Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ!” (Матай 23:13). Гэвч тэдгээр хуулийн багш нар, фарисайчууд, түүнчлэн Эзэн Есүсийг эдгээр зүйлийг хэлсний дараа Түүнийг галзуу гэж хэлсэн хүмүүс ямар үр дүн амссаныг Библид тэмдэглэсэн үү? Тэд ямар нэг шийтгэл амссан гэсэн тэмдэглэл Библид байдаг уу? Байгаагүй, үүнийг баттай хэлж болно. “Байгаагүй” гэж хэлсэн нь тийм тэмдэглэл байгаагүй гэсэн үг биш, харин үнэндээ хүний нүдээр харж болох ямар ч үр дүн байгаагүй юм. “Тэмдэглэгдээгүй” гэдэг нь тодорхой зүйлсийг шийдэх Бурханы хандлага болон зарчмын асуудлыг тодорхой болгодог. Өөрийг нь доромжилж, эсэргүүцдэг хүмүүс, эсвэл бүр Түүнийг гүтгэдэг хүмүүс—Түүнийг санаатайгаар дайрч давшилж, гүтгэж, хараадаг хүмүүстэй харьцахдаа—Бурхан нүдэн балай чихэн дүлий байдаггүй, харин ч тэдэнд хандах Түүний хандлага тодорхой байдаг. Тэрээр зүрх сэтгэлдээ энэ хүмүүсийг жигшиж, ялладаг. Тэр ч байтугай тэдний үр дүн ямар байхыг ил тод зарладаг, ингэснээр Түүнийг доромжилдог хүмүүст хандах Түүний хандлага тодорхой гэдгийг хүмүүс мэдэж, өөрсдийнх нь үр дүнг Тэр хэрхэн тодорхойлохыг мэдэж авна. Гэвч Бурхан эдгээр зүйлийг хэлсний дараа ч тэр хүмүүсийг Бурхан хэрхэн зохицуулах тухай үнэнийг хүмүүс тун бага ойлгодог ба тэдэнд Бурханы өгсөн төгсгөл болон ялын тогтоолын цаад зарчмыг ойлгож чаддаггүй. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдийг нь зохицуулах Бурханы тодорхой хандлага болон арга барилыг харж чаддаггүй. Энэ нь аливааг хийх Бурханы зарчимтай холбоотой. Бурхан зарим хүмүүсийн ёрын муу үйлд арга хэмжээ авахдаа бодит баримтуудыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, Тэр тэдний нүглийг зарладаггүй, тэдний төгсгөлийг тодорхойлдоггүй, харин тэдэнд тохирох шийтгэл, шударга цээрлүүлэлтийг оноохын тулд бодит баримтуудыг шууд хэрэглэдэг. Эдгээр баримт гарч ирэх үед хүмүүсийн махан бие шийтгэл хүртдэг, өөрөөр хэлбэл, уг шийтгэл нь хүний нүдээр харж болох зүйл байдаг. Зарим хүний муу үйлдэлд арга хэмжээ авахдаа Бурхан тэднийг үгээр л хараадаг, бас Бурханы хилэгнэл тэдэн дээр буудаг боловч тэдний хүлээн авах шийтгэл нь хүмүүсийн харж чадахгүй зүйл байж магадгүй. Гэсэн хэдий ч иймэрхүү төгсгөл нь шийтгүүлэх, алуулах гэх мэт хүмүүсийн харж чадах төгсгөлөөс ч илүү ноцтой байж болно. Яагаад гэвэл, Бурхан энэ төрлийн хүнийг аврахгүй, цаашид өршөөл үзүүлэхгүй, эсвэл тэднийг тэвчихгүй, тэдэнд өөр боломж олгохгүй гэж шийдсэн тохиолдолд тэдэнд хандах Түүний хандлага нь тэднийг хойш тавих явдал юм. Энд буй “хойш тавих” гэдгийн утга юу вэ? Энэ нэр томьёоны үндсэн утга нь ямар нэг зүйлийг хойш тавиад, үл тоож, анхаарал хандуулахаа болих гэсэн үг. Гэвч Бурхан хэн нэг хүнийг хойш тавих үед үүний утга учрын талаар хоёр өөр тайлбар байдаг: Эхний тайлбар нь Тэр тухайн хүний амь, тухайн хүний бүх зүйлийг Сатанд хариуцуулан өгдөг бөгөөд Бурхан тэр хүнийг цаашид хариуцахгүй, цаашид

удирдахгүй. Тэр хүн нь галзуу, тэнэг байна уу, амьд байна уу, үхсэн байна уу, эсвэл шийтгүүлээд тамд унасан байна уу гэдгийн аль нь ч Бурханд хамаагүй. Тийм бүтээл Бүтээгчтэй ямар ч хамаагүй байна гэсэн үг. Хоёр дахь тайлбар нь гэвэл, Бурхан Өөрөө тухайн хүнд Өөрийн гараар ямар нэг зүйл хийхийг хүсэж байна гэж шийдсэн гэсэн үг. Тэр иймэрхүү хүний үйлчлэлийг ашиглах юм уу ийм хүнийг товойлгогч болгон ашиглаж болзошгүй. Ийм төрлийн хүнтэй харьцах тусгай арга, тэдэнд хандах тусгай арга Түүнд байх боломжтой, жишээ нь яг Паул шиг. Энэ бол ийм төрлийн хүнтэй харьцахаар шийдсэн Бурханы зүрх сэтгэл дэх зарчим ба хандлага юм. Иймээс хүмүүс Бурханыг эсэргүүцэж, Түүнийг гүтгэж, доромжлохдоо Түүний зан чанарыг хилэгнүүлбэл, эсвэл Бурханы тэвчээрийн хязгаарыг давбал үр дагавар нь төсөөлөхийн ч аргагүй байдаг. Хамгийн хатуу ширүүн үр дагавар нь Бурхан тэдний амийг болон тэдний бүх зүйлийг Сатанд бүрмөсөн шилжүүлэн өгөх явдал юм. Тэд үүрд мөнхөд уучлагдахгүй. Энэ нь тэр хүн Сатаны аманд орсон хоол, түүний гар дахь тоглоом болно гэсэн үг бөгөөд тэр үеэс хойш тухайн хүн Бурханд ямар ч хамаагүй болно. Сатан Иовыг сорих үед энэ нь ямархуу зовлон зүдүүр байсныг та нар төсөөлж чадах уу? Иовын амийг хөнөөхийг Сатанд зөвшөөрөөгүй болзол байсан ч гэсэн Иов асар их зовсон юм. Сатанд бүрмөсөн өгөгдсөн, Сатаны атганд бүрэн орсон, Бурханы анхаарал, өршөөлийг бүрэн алдсан, цаашид Бүтээгчийн захиралт дор байхаа больсон, Түүнийг шүтэн мөргөх эрх, Бурханы захиралт дор бүтээл байх эрхээ алдсан, бүтээлийн Эзэнтэй харилцах харилцаа нь бүрмөсөн таслагдсан хүнд Сатаны учруулах хор хөнөөлийг төсөөлөхөд бүр ч хэцүү байх бус уу? Иовд үзүүлсэн Сатаны хавчлага нь хүний нүдээр харж болох зүйл байсан, гэхдээ Бурхан хүний амийг Сатанд өгвөл үр дагавар нь хүний төсөөлшгүй зүйл байх болно. Жишээ нь, зарим хүн үхэр, илжиг болон төрж магадгүй, харин зарим хүн бузар, муу ёрын сүнсэнд эзлэгдэж, эзэмдүүлж магадгүй гэх мэт. Энэ бол Бурханы Сатанд хүлээлгэн өгсөн зарим хүний төгсгөл юм. Гаднаасаа бол, Эзэн Есүсийг шоолсон, муулсан, гүтгэсэн, ялласан, доромжилсон хүмүүс ямар ч үр дагавар амсаагүй мэт харагддаг. Гэвч үнэн хэрэгтээ, бүх зүйлтэй харьцах арга зам Бурханд байдаг. Тэр төрөл бүрийн хүмүүстэй хэрхэн харьцдагийнхаа үр дүнг хүмүүст хэлэхдээ ойлгомжтой хэл ашиглахгүй байж болох юм. Заримдаа Тэр шууд хэлдэггүй, харин шууд хийдэг. Тэр энэ талаар ярихгүй байна гэдэг нь үр дүн байхгүй гэсэн үг биш—үнэндээ тийм тохиолдолд үр дүн нь бүр ч илүү ноцтой байж болзошгүй. Гаднаасаа Бурхан зарим хүнд Өөрийнхөө хандлагыг илэн далангүй хэлдэггүй мэт харагддаг ч үнэндээ Бурхан тэдэнд удаан хугацаанд ямар ч анхаарал хандуулахыг хүсээгүй байдаг. Тэр тэднийг дахин харахыг хүсдэггүй. Тэдний хийсэн зүйл, зан авирын улмаас, тэдний уг чанар-мөн чанарын улмаас Бурхан тэднийг Өөрийн нүднээс далд оруулахыг хүсдэг ба тэднийг шууд Сатанд өгч, тэдний сүнс, оюун ухаан, биеийг Сатанд өгч, хүссэн бүхнээ хийхийг Сатанд зөвшөөрөхийг л хүсдэг. Бурхан тэднийг хэр зэрэг үзэн ядаж, хэр зэрэг жигшиж байгаа нь ойлгомжтой юм. Хэрвээ хүн өөрийг нь харах ч хүсэлгүй болж, бүрмөсөн

орхихоор бэлдэх хүртэл нь, Өөрөө харьцахыг ч хүсэхгүй болох хүртэл нь Бурханыг хилэгнүүлбэл—хэрвээ Бурхан түүнийг Сатанд өгч, Сатан хүссэн зүйлээ хийж, түүнийг хянаж, залгиж, зоргоороо хандахыг нь зөвшөөрөх тийм хэмжээнд хүрвэл—энэ хүн бүрмөсөн дуусна. Түүний хүн байх эрх нь бүр цуцлагдаж, Бурханы бүтээлийн зүйл байх эрх нь ч дуусна. Энэ хамгийн ноцтой шийтгэл биш гэж үү?

Дээр өгүүлсэн бүхэн нь: “энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй” гэсэн үгийн учрыг бүрэн тайлбарласан бөгөөд энэ нь бас бичвэрийн эдгээр хэсгийн тухай энгийн тайлбар юм. Та бүхэн одоо энэ талаар ойлголттой болсон гэж Би бодож байна.

Одоо Бичвэрийн дараах хэсгүүдийг уншицгаая.

12. Өөрийн амиллын дараа шавь нартаа хэлсэн Есүсийн үг

Иохан 20:26–29 Тэгээд найман өдрийн дараа Түүний шавь нар, мөн Томас тэдэнтэй хамт дотор байв: хаалга хаалттай байсан боловч Есүс ирж, тэдний дунд зогсоод, “Амар амгалан та нарт байх болтугай” гэв. Дараа нь Тэр Томаст, “Энд хуруугаа хүргээд Миний гарыг барь; энд гараа хүргэж, Миний сүвээ рүү хий: бүү итгэлгүй бай, харин итгэлтэй бай” гэлээ. Тэгэхэд Томас Түүнд хариулан, “Эзэн минь, Бурхан минь” гэв. Есүс Томаст өгүүлрүүн, “Томас, чи Намайг харсан учир Надад итгэсэн; хараагүй атлаа итгэсэн хүмүүс ерөөлтэй еэ!” гэжээ.

Иохан 21:16–17 Тэр дахиад хоёр дахь удаагаа “Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу?” гэхэд тэр “Тийм ээ, Эзэн минь, би Таныг хайрладаг гэдгийг Та мэднэ шүү дээ” гэв. Тэр түүнд “Миний хонийг тэжээ” гэлээ. Тэр дахиад гурав дахь удаагаа “Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу?” гэв. Тэр “Чи Намайг хайрладаг уу?” гэж гурав дахь удаагаа асуусан учир Петр зовниж, “Эзэн минь, Та бүхнийг мэднэ, би Таныг хайрладаг гэдгийг Та мэднэ” гэв. Есүс “Миний хонийг тэжээ” гэж түүнд хэллээ.

Эдгээр хэсэгт өгүүлж буй зарим зүйл нь дахин амилсныхаа дараа Эзэн Есүсийн хийсэн болон шавь нартаа айлдсан зүйлс юм. Эхлээд Эзэн Есүсийг амилахаас өмнө болон дараа ямар нэгэн ялгаа байсан эсэхийг харцгаая. Тэр урьдын Эзэн Есүс хэвээрээ байсан уу? Эргэж амилсны дараах Эзэн Есүсийг дүрсэлсэн дараах мөрүүд Бичвэрт байдаг: “Хаалга хаалттай байсан боловч Есүс ирж, тэдний дунд зогсоод, ‘Амар амгалан та нарт байх болтугай’ гэв.” Тэр үед Эзэн Есүс махбодод оршин байхаа болиод сүнслэг биед байх болсон гэдэг нь маш тодорхой байна. Учир нь Тэр махан биеийн хязгаарлалтыг даван гарсан; хаалга хаалттай байхад ч гэсэн Тэр хүмүүсийн дунд орж ирээд тэдэнд Өөрийгөө харуулж чадсан. Энэ бол эргэж амилсны дараах Эзэн Есүс болон амилахаасаа өмнө махан биед амьдарч байсан Эзэн Есүсийн хоорондын хамгийн том ялгаа юм. Хэдийгээр тэр агшны сүнслэг биеийн харагдах байдал болон Эзэн Есүсийн урьдны гадаад төрх хоорондоо ямар ч ялгаагүй байсан боловч тэр агшинд Эзэн Есүс нь хүмүүст танихгүй хүн шиг санагдсан, учир нь Тэр үхлээс эргэж амилсныхаа дараа сүнслэг

бие болсон ба өмнөх махан биетэй нь харьцуулбал энэхүү сүнслэг бие нь хүмүүст илүү ээдрээтэй, будилмаар байсан. Түүнчлэн энэ нь Эзэн Есүс болон хүмүүсийн хооронд улам их зай бий болгосон ба тэр агшинд Эзэн Есүс улам нууцлаг болсныг хүмүүс зүрх сэтгэлдээ мэдэрсэн юм. Хүмүүсийн энэ танин мэдэхүй болон мэдрэмжүүд нь харж, эсвэл хүрч чадахгүй Бурханд итгэдэг байсан эрин үе рүү нь тэднийг гэнэт буцаан аваачсан. Иймээс Өөрийн амиллын дараа Эзэн Есүсийн хийсэн эхний зүйл нь хүн бүхэнд, Түүнийг харж, Тэр оршин байгаа гэдгийг нотолж, Түүний эргэж амилсан бодит баримтыг нотлох боломжийг олгосон. Түүнээс гадна, энэ үйлдэл нь хүмүүстэй харилцах Түүний харилцааг махбодоор ажиллаж байх үеийнхтэй нь, хүмүүсийн харж, хүрч чадах Христ байсан үеийнхтэй нь адил болгож сэргээжээ. Үүний нэг үр дүн бол Эзэн Есүс загалмайд цовдлогдсоны дараа үхлээс эргэж амилсан гэдэгт хүмүүс огт эргэлзээгүй ба хүн төрөлхтнийг золин аврах Эзэн Есүсийн ажилд ч эргэлзэхгүй байсан. Өөр нэг үр дүн нь бол Эзэн Есүс эргэж амилсныхаа дараа хүмүүст харагдаж, Түүнийг харж, Түүнд хүрэх боломжийг хүмүүст олгосон нь хүн төрөлхтнийг Нигүүлслийн эрин үед баттай бэхэлж, энэ цагаас эхлэн Эзэн Есүс “алга болсон”, эсвэл “нэг ч үг хэлэлгүй орхиж явснаас” болоод хүмүүс өмнөх эрин үе буюу Хуулийн эрин үед буцаж очихгүй байх байсан. Тийнхүү Тэр тэднийг Эзэн Есүсийн сургаалыг болон Түүний хийсэн ажлыг даган урагшилсаар байхаар болгосон. Тиймээс Нигүүлслийн эрин үе дэх ажлын шинэ үе шат албан ёсоор нээгдэж, тэр үеэс эхлэн, хуулийн дор амьдарч байсан хүмүүс албан ёсоор хуулиас гарч, шинэ эрин рүү шинэ эхлэлтэйгээр орсон. Эдгээр нь эргэж амилсныхаа дараа Эзэн Есүс хүн төрөлхтөнд харагдсаны олон талт утга учир юм.

Эзэн Есүс сүнслэг биед байсан юм бол хүмүүс яаж Түүнд хүрч, Түүнийг харж байсан бэ? Энэ асуулт нь Эзэн Есүсийн хүн төрөлхтөнд харагдсаны ач холбогдлыг хөнддөг. Дөнгөж сая уншсан бичвэрийн хэсгүүдээс та нар ямар нэг юм анзаарав уу? Үндсэндээ сүнслэг бие харагдаж, баригддаггүй ба эргэж амилсныхаа дараа Эзэн Есүсийн хийсэн ажил аль хэдийн гүйцсэн байсан. Иймээс ер нь бол хүмүүстэй уулзахын тулд Тэр Өөрийн анхдагч төрхөөр тэдний дунд эргэж ирэх хэрэг огтхон ч байгаагүй, гэхдээ Эзэн Есүсийн сүнслэг бие Томас мэтийн хүмүүст харагдсан нь Түүний харагдсаны ач холбогдлыг илүү бодитой болгож, хүмүүсийн зүрх сэтгэлд илүү гүн шингэсэн. Тэр Томас дээр ирэхдээ эргэлзэгч Томасыг гартаа хүргүүлээд түүнд ингэж хэлсэн: “Энд гараа хүргэж, Миний сүвээ рүү хий: бүү итгэлгүй бай, харин итгэлтэй бай.” Эдгээр үг, үйлдэл нь Эзэн Есүс зөвхөн эргэж амилсныхаа дараа хэлж, хийхийг хүссэн зүйл биш байсан; үнэндээ энэ нь загалмайд цовдлогдохоосоо өмнө Түүний хэлж, хийхийг хүсэж байсан зүйл юм, учир нь Томасын эргэлзээ зөвхөн тэр үед л эхэлсэн юм биш, харин Эзэн Есүсийг дагаж байсан тэр бүх хугацаанд түүнд байсан билээ. Загалмайд цовдлогдохоосоо өмнө Эзэн Есүс Томас мэтийн хүмүүсийн талаар аль хэдийн ойлгож байсан нь илэрхий юм. Иймээс бид үүнээс юу харж болох вэ? Тэр эргэж амилсныхаа дараа ч бас Эзэн

Есүс хэвээр байсан. Түүний мөн чанар өөрчлөгдөөгүй. Гэхдээ үхлээс амилж, сүнсний ертөнцөөс Өөрийнхөө анхдагч дүрээр, Өөрийнхөө анхдагч зан чанартайгаар, бие махбодтой байх үедээ хүн төрөлхтнийг ойлгож байсан ойлголттойгоо эргэн ирсэн Эзэн Есүс эхлээд Томасыг олж очин Томасыг хавиргандаа хүргүүлж, эргэж амилсны дараах Өөрийн сүнслэг биеийг харуулаад зогсоогүй, Томасын гарыг хүргүүлж, сүнслэг биеийнхээ оршин буйг мэдрүүлэн эргэлзээг нь бүрмөсөн арилгасан юм. Эзэн Есүсийг загалмайд цовдлогдохоос өмнө Христ мөн гэдэгт нь Томас үргэлж эргэлзэж, итгэж чадахгүй байжээ. Бурханд итгэх түүний итгэл нь зөвхөн нүдээрээ харж, гараараа барьж чадах зүйл дээр л үндэслэн бүрэлдэж байсан. Эзэн Есүс ийм төрлийн хүмүүсийн итгэлийг сайн ойлгодог байлаа. Тэд зөвхөн тэнгэр дэх Бурханд л итгэдэг байсан ба Бурханы илгээсэн Нэгэнд, эсвэл махбод дахь Христэд итгэдэг ч үгүй, Түүнийг хүлээн авдаг ч үгүй байсан. Эзэн Есүсийн оршин тогтнолыг болон Тэр үнэхээр бие махбодтой болсон Бурхан гэдгийг Томасаар хүлээн зөвшөөрүүлж, итгүүлэхийн тулд Тэр Томаст гараа сунган хавирганд нь хүрэхийг зөвшөөрсөн. Эзэн Есүсийг амилсны өмнө болон дараа Томаст байсан эргэлзээ ялгаатай байсан уу? Тэр үргэлж эргэлзэж байсан ба Эзэн Есүсийн сүнслэг бие түүнд биечлэн харагдаж, Өөрийн бие дэх хадаасны оромд хүргэснийг эс тооцвол өөр хэн ч түүний эргэлзээг тайлж чадахгүй, хэн ч түүнийг эргэлзээнээс нь салгаж чадахгүй байв. Иймээс Эзэн Есүс Томасыг хавиргандаа хүргүүлж, хадаасны сорвинууд үнэхээр байгааг мэдрүүлсэн цагаас хойш Томасын эргэлзээ арилж, Эзэн Есүс эргэн амилсныг лавтай мэдэж, Эзэн Есүс бол жинхэнэ Христ, бие махбодтой болсон Бурхан гэдгийг хүлээн зөвшөөрч, итгэсэн. Хэдийгээр энэ удаа Томас эргэлзэхээ больсон боловч Христтэй уулзах боломжоо үүрд алдсан байсан юм. Тэр Түүнтэй хамт байх, Түүнийг дагах, Түүнийг мэдэх боломжоо үүрд алджээ. Мөн Христээр төгс болгуулах боломжоо ч алдсан юм. Эзэн Есүсийн илрэлт болон үг эргэлзээгээр дүүрэн байсан хүмүүсийн итгэлийг дүгнэлт, шийдвэрээр хангасан. Тэрээр эргэлзэгчдэд хэлэхийн тулд, зөвхөн тэнгэрт байдаг Бурханд итгэдэг, харин Христэд үл итгэгчдэд хэлэхийн тулд Өөрийн бодитой үг, үйлдлийг ашигласан: Бурхан тэдний итгэлийг сайшаагаагүй, мөн Түүнийг дагах зуураа Түүнд эргэлзэж байгааг нь ч сайшаагаагүй. Тэд Бурханд болон Христэд бүрэн итгэсэн тэр өдөр л Бурхан Өөрийн агуу ажлыг дуусгасан өдөр болж чадсан юм. Мэдээжээр, тэр өдөр нь бас тэдний эргэлзээнд ялын тогтоол гарсан өдөр байсан. Христэд хандах тэдний хандлага хувь заяаг нь тодорхойлсон ба тэдний арилшгүй эргэлзээ нь тэдний итгэл ямар ч үр өгөөж авчраагүйг илтгэж, хөшүүн байдал нь тэдний итгэл найдвар талаар болсныг илтгэж байсан. Тэнгэр дэх Бурханд итгэх тэдний итгэл төсөөллөөр тэжээгдэж, Христэд эргэлздэг нь үнэндээ Бурханд хандах тэдний жинхэнэ хандлага байсан учраас хэдийгээр тэд Эзэн Есүсийн бие дээрх хадаасны сорвинд хүрсэн ч гэсэн тэдний итгэл хэрэггүй хэвээр байсан бөгөөд тэдний үр дүнг хулсан хувингаар ус хутгах шиг хий дэмий гэж л дүрсэлж болох юм. Эзэн Есүсийн Томаст хэлсэн зүйл бас хүн бүрд хэлэх Түүний арга зам гэдэг нь маш тодорхой байлаа: Амилсан Эзэн

Есүс бол гучин гурван жил хагасыг хүн төрөлхтний дунд ажиллаж өнгөрөөсөн Эзэн Есүс юм. Хэдийгээр Тэр загалмайд цовдлогдож, үхлийн сүүдэрт хөндийг туулж, амиллыг туулсан боловч Түүнд ямар ч талаар өөрчлөлт гараагүй. Хэдийгээр Тэр одоо бие дээрээ хадаасны сорвитой ч гэсэн, амилж булшнаас алхан гарч ирсэн ч гэсэн, Түүний зан чанар, хүн төрөлхтний тухай Түүний ойлголт, хүн төрөлхтөнд хандах Түүний санаа зорилго өчүүхэн төдий ч өөрчлөгдөөгүй. Түүнчлэн загалмайнаас буун ирж, нүглийг ялж, бэрхшээлийг даван туулж, үхлийг ялсан гэдгээ Тэрээр хүмүүст хэлж байв. Хадаасны сорвинууд нь ердөө л Тэр Сатаныг ялсны нотолгоо, бүх хүн төрөлхтнийг амжилттайгаар аврахын тулд нүглийн тахил болсны нотолгоо байсан юм. Тэр хүн төрөлхтний нүглийг аль хэдийн Өөртөө үүрч, Өөрийн золин аврах ажлыг дуусгасан гэдгээ хүмүүст хэлж байлаа. Тэр шавь нартайгаа уулзахаар эргэж ирэхдээ Өөрийнхөө илрэлтээр дамжуулан тэдэнд энэ мессежийг хэлсэн юм: “Би амьд хэвээрээ, оршин буй хэвээрээ; өнөөдөр Би та нарын өмнө үнэхээр зогсож байна, иймээс та нар Намайг харж, Надад хүрч болно. Би үргэлж та нартай хамт байх болно.” Эзэн Есүс Томасын тохиолдлыг хожмын хүмүүст зориулсан анхааруулга болгон ашиглахыг ч бас хүссэн: Хэдийгээр чи Эзэн Есүст итгэхдээ Түүнийг харж, Түүнд хүрч чадахгүй ч жинхэнэ итгэлээсээ үүдэн ерөөгдсөн бөгөөд жинхэнэ итгэлээрээ дамжуулан Эзэн Есүсийг харж чадна, ийм хүмүүс ерөөгддөг.

Томаст харагдах үедээ Эзэн Есүсийн хэлсэн, Библид тэмдэглэгдсэн эдгээр үг нь Нигүүлслийн эрин үеийн бүх хүнд асар их тус болсон. Томаст харагдаж, Томаст үг хэлсэн нь дараагийн үеийнхэнд гүн гүнзгий нөлөө үзүүлсэн; эдгээр нь үүрдийн ач холбогдлыг агуулдаг. Томас Бурханд итгэдэг боловч Бурханд эргэлздэг хүмүүсийг төлөөлдөг. Тэд сэжиглэмтгий зантай, хар дотортой, урвамтгай бөгөөд Бурханы гүйцэлдүүлж чадах зүйлд итгэдэггүй. Тэд Бурханы бүхнийг чадагч байдал болон Түүний дээд эрхэд итгэдэггүй, бие махбодтой болсон Бурханд ч итгэдэггүй. Гэвч Эзэн Есүсийн амилсан нь тэдний энэ зан байдалд хүчтэй цохилт өгсөн ба энэ нь бас тэдэнд өөрсдийн эргэлзээг нээн илрүүлэх, өөрсдийн эргэлзээг таних, хар санаатай байснаа хүлээн зөвшөөрч, улмаар Эзэн Есүсийн оршин тогтнол болон амилалд үнэхээр итгэх боломж олгосон. Томаст тохиолдсон зүйл нь хожмын үеийнхэнд зориулсан анхааруулга, сануулга байсан, ингэснээр илүү олон хүн Томас шиг эргэлзэгч байж болохгүй, эргэлзээгээр дүүрэх юм бол харанхуйд живэх болно гэдгийг өөрсдөдөө анхааруулж чадах юм. Хэрвээ чи Бурханыг яг Томас шиг дагаж, Бурхан оршин байдаг уу, үгүй юу гэдгийг баталж, нотолж, эргэцүүлж бодохын тулд Эзэний хавирганд хүрч, Түүний хадаасны сорвийг тэмтэрч үзэхийг үргэлж хүсдэг бол Бурхан чамайг орхино. Иймээс Эзэн Есүс хүмүүсийг Томас шиг зөвхөн нүдээрээ харсан зүйлд л итгэдэг биш, харин цэвэр, үнэнч хүмүүс байж, Бурханд эргэлзэх сэтгэл өвөрлөлгүйгээр зүгээр л Түүнд итгэж, дагахыг шаарддаг. Ийм хүмүүс ерөөгддөг. Энэ бол Эзэн Есүсийн хүмүүст тавьж буй тун жаахан шаардлага, Өөрийнхөө дагалдагчдад өгсөн анхааруулга юм.

Дээрх нь эргэлзээгээр дүүрэн хүмүүст хандах Эзэн Есүсийн хандлага билээ. Тэгвэл Өөрт нь үнэнчээр итгэж, дагаж чадсан хүмүүст Эзэн Есүс юу хэлж, юу хийсэн бэ? Үүнийг бид Эзэн Есүс, Петр хоёрын ярианаас харах гэж байна.

Энэ яриand Эзэн Есүс: “Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу?” гэх нэг зүйлийг Петрээс ахин дахин асуусан. Энэ бол Эзэн Есүс эргэн амилсныхаа дараа Христэд үнэхээр итгэж, Эзэнийг хайрлах гэж эрмэлздэг Петртэй адилхан хүмүүсээс шаардаж байсан илүү өндөр стандарт юм. Энэ асуулт нь лавлаж нягтлах шиг, бас байцаах шиг байсан, гэхдээ үүнээс гадна энэ нь Петр шиг хүмүүст тавьсан шаардлага, хүлээлт байсан. Хүмүүс өөрсдийгөө эргэцүүлж, өөрсдийгөө шалгаж, Эзэн Есүсийн хүмүүст тавьдаг шаардлага юу вэ? Би Эзэнийг хайрладаг уу? Би Бурханыг хайрладаг хүн мөн үү? Би Бурханыг яаж хайрлах ёстой вэ? гэж асууж байг гэсэндээ Эзэн Есүс лавлан асуух энэхүү аргыг ашиглажээ. Хэдийгээр Эзэн Есүс энэ асуултыг зөвхөн Петрээс асуусан боловч үнэн хэрэгтээ Петрээс эдгээр асуултыг асууснаараа, энэ боломжийг ашиглан Бурханыг хайрлахаар эрмэлздэг илүү олон хүнээс ийм асуулт асуухыг зүрх сэтгэлдээ хүсэж байв. Петр бол ердөө л ийм хүмүүсийн төлөөлөгч болж, Эзэн Есүсийн амнаас ийм асуулт сонсохоор ерөөгдсөн байжээ.

Эргэн амилсныхаа дараа Эзэн Есүсийн Томаст хэлсэн “Энд гараа хүргэж, Миний сүвээ рүү хий: бүү итгэлгүй бай, харин итгэлтэй бай” гэх үгтэй харьцуулбал “Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу?” гэж Петрээс гурван удаа давтан асуусан нь Эзэн Есүсийн хандлагын хатуу чанд байдал болон асуух үедээ Түүний мэдэрсэн яаралтай байдлыг илүү сайн мэдрэх боломжийг хүмүүст олгосон. Зальжин, хуурмаг уг чанартай бөгөөд эргэлзэгч Томасын тухайд гэвэл, Эзэн Есүс Өөрийнхөө бие дэх хадаасны сорвинд түүний гарыг хүргүүлж, улмаар Эзэн Есүс бол эргэж амилсан хүний Хүү мөн гэдэгт түүнийг итгүүлж, Эзэн Есүсийн Христ хэмээх ялгамж чанарыг хүлээн зөвшөөрүүлсэн. Хэдийгээр Эзэн Есүс Томасыг хатуу ширүүн зэмлээгүй, мөн түүний талаар ямар ч тодорхой шүүлтийг үг яриагаараа илэрхийлээгүй боловч тийм хүмүүст хандах Өөрийн хандлага, шийдэмгий байдлыг харуулангаа түүнийг ойлгосон гэдгээ бодитой үйлдлээрээ Томаст мэдэгдсэн. Эзэн Есүсийн ийм төрлийн хүмүүст тавих шаардлага, хүлээлтийг хэлсэн үгээс нь харж чадахгүй, учир нь Томас шиг хүмүүст өчүүхэн төдий ч жинхэнэ итгэл байдаггүй. Тэдэнд тавих Эзэн Есүсийн шаардлага ердөө энэ хүрсэн, харин Петр шиг хүмүүст үзүүлсэн Түүний хандлага огт өөр байсан. Тэр Петрээс гараа сунгаж, хадаасны сорвинд нь хүр гэж шаардаагүй, “бүү итгэлгүй бай, харин итгэлтэй бай” гэж Петрт хэлээ ч үгүй. Харин ч Тэр Петрээс нэг асуултаа ахин дахин асуусан. Энэ асуулт нь Христийн дагагч бүхнийг өөрийн эрхгүй харамсаж, айж, Эзэн Есүсийн санаа зовсон, гунигтай байдлыг мэдрэхэд хүргэдэг тунгаан бодууштай, утга учиртай асуулт байсан. Тэд асар их өвдөж, зовж байхдаа Эзэн Есүсийн анхаарал, халамжийг илүү их ойлгож чаддаг; ариун цагаан, үнэнч хүмүүст хандах Түүний чин сэтгэлийн сургаал, хатуу чанд шаардлагуудыг тэд ухаардаг.

Эдгээр энгийн үгэнд илчлэгдсэн, хүмүүсээс хүсэж буй Эзэний хүлээлт бол зөвхөн Түүнийг итгэж, дагах биш харин хайранд хүрч, өөрийн Эзэнийг, өөрийн Бурханыг хайрлах явдал юм гэдгийг Эзэн Есүсийн асуулт хүмүүст мэдрүүлдэг. Ийм хайр нь санаа тавих, дуулгавартай байх явдал юм. Энэ нь хүмүүс Бурханы төлөө амьдарч, Бурханы төлөө үхэж, бүх зүйлээ Бурханд зориулж, бүх зүйлээ Бурханы төлөө зарцуулж, өгөх явдал юм. Ийм хайр бас Бурханыг тайвшруулж, гэрчлэлийг таашааж, амрах боломж олгодог. Энэ бол хүн төрөлхтөн Бурханд хариу барьж байгаа хэрэг, хүний хариуцлага, үүрэг, даалгавар бөгөөд хүмүүсийн насан туршдаа дагах ёстой зам юм. Энэ гурван асуулт нь Петр болон төгс болгуулах боломжтой бүх хүнд тавьсан Эзэн Есүсийн шаардлага, сургамж байсан юм. Петрийг эцсээ хүртэл амьдралын замаа дагахад хөтөлж, зоригжуулсан зүйл нь энэ гурван асуулт байсан бөгөөд Эзэн Есүсийн явахдаа асуусан энэ асуултууд нь Эзэнийг гэх хайраасаа болж төгс болох замаа эхлэхэд Петрийг хөтлөн, энэ хайраасаа болж Эзэний зүрх сэтгэлд анхаарал тавьж, Эзэнд дуулгавартай байж, Эзэнд тайвшрал өгч, өөрийнхөө бүхий л амьдрал, бүхий л оршихуйг өргөл болгоход нь түүнийг хөтөлсөн юм.

Нигүүлслийн эрин үед Бурханы ажил нь үндсэндээ хоёр төрлийн хүмүүст зориулсан байсан. Эхний төрлийнх нь Түүнд итгэж, дагадаг, Түүний тушаалыг сахиж, загалмай үүрч чаддаг, Нигүүлслийн эрин үеийн замыг баримталж чаддаг хүмүүс байсан юм. Ийм төрлийн хүн Бурханы ерөөлийг хүртэж, Бурханы нигүүлслийг эдэлдэг байв. Хоёр дахь төрлийн хүмүүс нь Петр шиг, төгс болгуулж чадах хүмүүс байсан. Иймээс Эзэн Есүс дахин амилсныхаа дараа хамгийн их утга учиртай энэ хоёр зүйлийг эхлээд хийсэн юм. Нэгийг нь Томаст, нөгөөг нь Петрт хийсэн. Энэ хоёр зүйл юуг төлөөлдөг вэ? Эдгээр нь хүн төрөлхтнийг аврах Бурханы жинхэнэ санаа зорилгыг төлөөлдөг үү? Тэдгээр нь Бурханы хүн төрөлхтөнд хандах чин сэтгэлийг харуулдаг уу? Томаст хийсэн Түүний ажил нь эргэлзэгч байлгүй, зүгээр л итгэ гэж хүмүүст анхааруулах явдал байсан. Петрт хийсэн ажил нь Петр шиг хүмүүсийн итгэлийг бэхжүүлж, ийм хүмүүст тодорхой шаардлага тавьж, тэдний зорих ёстой зорилго юу вэ гэдгийг харуулах явдал байлаа.

Эзэн Есүс амилсныхаа дараа шаардлагатай гэж үзсэн хүмүүстээ харагдаж, тэдэнтэй ярилцаж, тэдэнд шаардлага тавьж, Өөрийн санаа болон хүмүүст тавих хүлээлтийг ардаа орхисон. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы хувиар хүн төрөлхтнийг гэх Түүний зовнил болон хүмүүст тавих шаардлага хэзээ ч өөрчлөгдөөгүй; эдгээр нь Түүнийг махбодод байх үед ч, цовдлогдож, эргэн амилсныхаа дараа сүнслэг биед байхад ч адилхан хэвээр байсан. Загалмайд цовдлогдохоосоо өмнө ч Тэр эдгээр шавийнхаа төлөө санаа зовж байсан, хүн нэг бүрийн байдлыг зүрх сэтгэлдээ сайн мэдэж байсан, хүн бүрийн дутагдлыг ойлгож байсан ба мэдээж нас барж, амилж, сүнслэг бие болсныхоо дараа ч гэсэн хүн бүрийн талаарх Түүний ойлголт бие махбодтой байх үеийнхтэй нь адил байсан. Хүмүүс Түүний ялгамж чанар бол Христ гэдэгт бүрэн итгээгүй байгааг Тэр мэдэж

байсан, харин махбодод байх хугацаандаа Тэр хүмүүст хатуу чанд шаардлага тавиагүй. Гэхдээ Тэр амилсныхаа дараа тэдэнд үзэгдэж, Эзэн Есүс бол Бурханаас ирсэн, Тэр бол бие махбодтой болсон Бурхан байсан гэдгийг тэдэнд төгс итгүүлсэн бөгөөд Өөрийн илрэлт болон амиллын баримтыг хүн төрөлхтний насан туршийн эрэл хайгуулын хамгийн агуу үзэгдэл, сэдэл болгон ашигласан. Түүний үхлээс амилсан нь Түүнийг дагасан бүх хүнийг хатуужуулаад зогсоогүй, мөн Нигүүлслийн эрин үе дэх Түүний ажлыг хүн төрөлхтний дунд бүрэн хэрэгжүүлсэн, тийнхүү Нигүүлслийн эрин үе дэх Эзэн Есүсийн авралын сайн мэдээ нь хүн төрөлхтний дунд өнцөг булан бүрд аажмаар тархсан юм. Эзэн Есүс амиллынхаа дараа илэрсэн нь ямар нэгэн ач холбогдолтой байсан гэх үү? Хэрвээ чи тэр үед Томас юм уу Петр байсан бол, ийм утга учиртай энэ зүйл чиний амьдралд тохиолдсон бол чамд ямаршуу үр нөлөө үзүүлэх байсан бэ? Чи үүнийг Бурханд итгэх амьдралынхаа дээд зэргийн, хамгийн агуу үзэгдэл гэж үзэх байсан уу? Чи үүнийг Бурханыг дагах, Түүнийг сэтгэл хангалуун байлгахаар хичээх, насан туршдаа Бурханы хайрыг эрж хайх жолоодогч хүч гэж үзэх байсан уу? Энэхүү хамгийн агуу үзэгдлийг түгээхийн тулд чи насан туршийн хичээл чармайлтаа зориулах байсан уу? Эзэн Есүсийн авралыг түгээх явдлыг чи Бурханаас ирсэн даалгавар гэж хүлээн авах байсан уу? Хэдийгээр та нар үүнийг биеэр туулаагүй ч Томас, Петр хоёрын жишээ нь орчин үеийн хүмүүсийн хувьд Бурхан болон Бурханы хүслийн талаар тодорхой ойлгож авахад хэдийн хангалттай юм. Бурхан махбод болсныхоо дараа, хүн төрөлхтний дундах амьдралыг биечлэн туулж, хүний амьдралыг биечлэн туулсныхаа дараа, хүн төрөлхтний доройтол болон хүний амьдралын нөхцөл байдлыг харсныхаа дараа хүн төрөлхтөн хэчнээн арга мөхөс, гашуудалтай, өрөвдөлтэй болохыг махбод дахь Бурхан илүү гүн гүнзгий мэдэрсэн гэж хэлж болно. Бурхан махбодод амьдарч байхдаа Өөрийн хүн чанараас болж, бие махбодын зөн совингоосоо болж хүний нөхцөл байдлыг улам их өрөвдөх болсон. Энэ нь Түүнийг дагалдагчдадаа илүү санаа тавихад хүргэсэн юм. Эдгээр нь та нарын ойлгож чадахааргүй зүйл байж болзошгүй, гэвч дагалдагч нэг бүрийнхээ төлөө Бурхан ингэж санаа зовж, анхаардгийг Би “үлэмж анхаарал” гэсэн хоёрхон үгээр дүрсэлж чадна. Хэдийгээр энэ нэр томьёо хүний хэлнээс гарсан ч, хэдийгээр энэ нь яг л хүний хэллэг боловч дагалдагч нараа гэсэн Бурханы сэтгэлийг үнэхээр илэрхийлж, дүрсэлдэг. Хүмүүсийг гэх Бурханы үлэмж анхаарлын тухайд гэвэл, өөрсдийнхөө туршлагын явцад та нар үүнийг аажмаар мэдэрч, амсах болно. Гэвч өөрийн хувийн зан чанарыг өөрчлөхөөр зорьсны үндсэн дээр Бурханы зан чанарыг аажмаар ойлгосноор л үүнийг биелүүлж болно. Эзэн Есүс ингэж харагдах үедээ дагалдагчдадаа тавих Өөрийн анхаарлыг хүн чанарт бодитой болгож, Өөрийн сүнслэг биед буюу та нарын хэлдгээр Өөрийнхөө бурханлаг чанарт дамжуулж өгсөн. Түүний илрэлт нь хүмүүст Бурханы анхаарал, халамжийг дахин нэгэнтээ туулж, мэдрэх боломж олгосны сацуу Бурхан бол эрин үеийг эхлүүлж, эрин үеийг өрнүүлж, бас эрин үеийг төгсгөдөг Нэгэн гэдгийг хүчирхгээр нотолж өгсөн юм.

Өөрийн илрэлтээр дамжуулан Тэр бүх хүний итгэлийг батжуулж, Тэр бол Бурхан Өөрөө мөн гэсэн баримтыг дэлхий ертөнцөд баталсан билээ. Энэ нь Түүний дагагчдад мөнхийн баталгаа өгсөн ба Тэрээр Өөрийн илрэлтээр дамжуулан шинэ эрин үе дэх ажлынхаа үе шатыг бас эхлүүлсэн юм.

13. Есүс дахин амилсныхаа дараа талх идэж, судрыг тайлбарласан нь

Лук 24:30–32 Тийнхүү Тэр тэдэнтэй хамт ширээнд сууж, талх авч ерөөгөөд хугалж, тэдэнд өгөв. Тэгэхэд тэдний нүд нээгдэж, Түүнийг танив; харин Тэр тэдний хараанд үзэгдэхгүй алга болжээ. Тэд бие биедээ “Замд Түүнийг бидэнтэй ярилцаж байхад, бидэнд судар нээж үзүүлэхэд зүрх маань бидний дотор шатаж байгаагүй гэж үү?” гэцгээв.

14. Шавь нар нь Есүст хайрсан загас өгсөн нь

Лук 24:36–43 Мөн тэднийг тийнхүү ярьж байхад нь Есүс Өөрөө тэдний дунд зогсоод, “Амар амгалан нь та нарт байх болтугай” гэв. Гэвч тэд айн эмээж, сүнс харлаа гэж бодоцгоов. Тэгэхэд нь Тэр “Та нар яагаад зовнив? Та нарын сэтгэлд яагаад элдвийн бодол төрөв? Миний гар, хөлийг хар, энэ бол Би байна: Намайг бариад үз; учир нь сүнсэнд яс, мах байхгүй, харин та нарыг харахад Надад байна шүү дээ” гэв. Тэр тийнхүү өгүүлээд тэдэнд гар, хөлөө үзүүлэв. Тэднийг баярласандаа бас л итгэж ядан гайхширч байхад нь Тэрээр: “Та нарт энд идэх юм байна уу?” гэхэд тэд нэг хэсэг хайрсан загас зөгийн балны сархинагтай өгөв. Тэр үүнийг авч, тэдний өмнө идэв.

Одоо бичвэрийн дээр дурдсан хэсгүүдийг авч үзэцгээе. Эхний хэсэгт Эзэн Есүс амилсныхаа дараа талх идэж, судар тайлбарлаж байгаа тухай өгүүлж байгаа бол хоёр дахь хэсэгт Эзэн Есүс хайрсан загас идэж байгаа тухай өгүүлж байна. Энэ хоёр хэсэг нь Бурханы зан чанарыг мэдэхэд чинь яаж туслах вэ? Эзэн Есүс талх идэж, дараа нь хайрсан загас идсэн тухай эдгээр дүрслэлээс та нар ямар дүр зураг төсөөлж байна вэ? Эзэн Есүс та нарын өмнө суугаад талх идэж байсан бол ямар санагдах байсныг та нар төсөөлж чадах уу? Эсвэл Тэр та нартай хамт нэг ширээнд суугаад хооллож, хүмүүстэй хамт загас, талх идэж байсан бол тэр мөчид чамд ямар санагдах байсан бэ? Чи өөрөө Эзэнд маш ойр, Тэр чамд тун дотно байна гэж чамд санагдвал энэ мэдрэмж чинь зөв. Энэ бол Эзэн Есүс эргэж амилсныхаа дараа цугларсан хүмүүсийн өмнө талх, загас идсэнээр олж авахыг хүсэж байсан яг тэр үр дүн юм. Хэрвээ Эзэн Есүс амилсныхаа дараа хүмүүстэй зөвхөн ярилцаж, тэд Түүний яс, махыг нь тэмтэрч чадалгүй, харин Тэр бол хүрч болшгүй Сүнс гэж л бодсон бол тэдэнд ямар санагдах байсан бэ? Тэдний урам хугарах байсан бус уу? Урам хугарсан хүмүүст хаягдсан мэт санагдах байсан бус уу? Эзэн Есүс Христээс холдсон мэт санагдах байсан бус уу? Ийм зай Бурхантай харьцах хүмүүсийн харилцаанд ямар сөрөг нөлөө үзүүлэх байсан бэ? Хүмүүс гарцаагүй айж, Түүнд ойртож зүрхлэхгүй байсан ба тэгээд Түүнийг хүндэтгэсэн хандлагатай болох байсан. Тэр үеэс эхлээд тэд Эзэн Есүс Христтэй харилцах дотно харилцаагаа тасалж, Нигүүлслийн эрин үеэс өмнө байсан шигээ тэнгэр дэх Бурхан ба хүн

төрөлхтний хоорондох харилцаа руугаа буцаж очих байсан. Хүмүүсийн хүрч, эсвэл мэдэрч чадахгүй сүнслэг бие нь тэдний Бурхантай ойр дотно байдлыг үндсээр нь таслах байсан бөгөөд Эзэн Есүс Христийг махбодод байхад бий болсон, Тэр болон хүмүүсийн хооронд ямар ч зайгүй байсан тэр дотно харилцааг үгүй болоход ч хүргэх байсан юм. Сүнслэг биеийн хүмүүст төрүүлсэн зүйлс нь зөвхөн айх, зайлсхийх, дуугүй ширтэх мэдрэмж л байсан. Тэд Түүнийг дагаж, итгэж, хүндлэх нь бүү хэл, Түүнд ойртож, ярилцаж ч зүрхлэхгүй байх байлаа. Хүмүүс Өөрт нь ийм сэтгэлээр хандахыг Бурхан харахыг хүсээгүй. Хүмүүс Түүнээс зайлсхийж, эсвэл өөрсдийгөө Түүнээс холдуулж байхыг Тэр харахыг хүсээгүй; хүмүүс Түүнийг ойлгож, Түүнд ойртож, Түүний гэр бүл байгаасай гэж л хүссэн. Хэрвээ чиний гэр бүл, чиний хүүхдүүд чамайг харсан атлаа танихгүй, бас чамд дөхөж ирж зүрхлэхгүй, харин үргэлж чамаас дөлөөд байвал, мөн тэдний төлөө хийсэн бүхнийг чинь ойлгохгүй байвал чамд ямар санагдах вэ? Шаналгаатай байхгүй гэж үү? Чиний зүрх шархлахгүй гэж үү? Хүмүүс Түүнээс зайлсхийхэд Бурханд яг ийм санагддаг. Иймээс Өөрийн амиллын дараа Эзэн Есүс хүмүүст мах цуснаас бүрдсэн Өөрийн биеэр үзэгдэж, тэдэнтэй хамт мөн л идэж, уусан юм. Бурхан хүмүүсийг гэр бүлээ гэж үздэг ба хүн төрөлхтөн ч бас Түүнийг хамгийн ойр дотноо Нэгнээ гэж үзээсэй хэмээн хүсдэг; зөвхөн ийм маягаар л Бурхан хүмүүсийг үнэхээр олж авч чадна, ийм маягаар л хүмүүс Бурханыг үнэхээр хайрлаж, шүтэн мөргөж чадна. Одоо та нар амилсныхаа дараа Эзэн Есүс талх идээд судрыг тайлбарласан тухай болон шавь нар нь Түүнд хайрсан загас өгсөн тухай энэ хоёр хэсгийг сонгож авсны минь санаа зорилгыг ойлгож чадах нь уу?

Амилсныхаа дараа хэлсэн, хийсэн олон зүйлээ Эзэн Есүс сайтар бодсон гэж хэлж болно. Эдгээр зүйл хүн төрөлхтнийг гэх Бурханы элдэг зан, хайр сэтгэлээр дүүрэн байсан ба махбодод байх хугацаандаа хүн төрөлхтөнтэй тогтоосон дотно харилцаандаа тавьдаг хичээнгүй анхаарал, нандигналаар нь ч бас дүүрэн байсан. Үүнээс гадна, тэдгээр нь махбодод байх хугацаандаа Өөрийн дагагчидтай хамт хооллож, амьдарч байсан үеийнх нь дурсамж, хүсэл тэмүүллээр дүүрэн байсан юм. Иймээс Бурхан, хүн хоёр хоорондоо хөндий зайтай гэж хүмүүст санагдуулахыг Бурхан хүсээгүй, хүн төрөлхтнийг Бурханаас холдоосой гэж ч хүсээгүй. Түүнчлэн Эзэн Есүс амилсныхаа дараа хүмүүстэй маш ойр дотно байсан Эзэн биш болсон гэж, мөн Тэрээр сүнсний ертөнц рүү буцаж, хүмүүсийн хэзээ ч харж, хүрч чадашгүй Эцэг дээрээ буцаж очсон учраас хүн төрөлхтөнтэй хамт байхаа больсон гэж хүн төрөлхтөнд санагдуулахыг Тэр хүсээгүй. Түүний болон хүн төрөлхтний хооронд байр суурийн ялгаа бий болсон гэж хүмүүст санагдуулахыг Тэр хүсээгүй. Өөрийг нь дагахыг хүсдэг боловч Түүнийг хүндэтгэсэн зайд байлгадаг хүмүүсийг хараад Бурханы зүрх сэтгэл өвддөг, учир нь энэ бол тэдний зүрх сэтгэл Түүнээс маш хол байгаа, тэдний зүрх сэтгэлийг татах нь Түүний хувьд маш хэцүү байх болно гэсэн үг юм. Иймээс хэрвээ Тэр тэдний харж, хүрч чадахгүй сүнслэг биетэйгээр хүмүүст үзэгдсэн бол хүнийг Бурханаас дахиад нэг удаа холдуулах байсан ба энэ нь эргэн

амилсныхаа дараа Христ өндөр дээд агаад хүмүүсээс өөр болчихсон, тэгээд цаашид хүнтэй хамт нэг ширээнд сууж хооллож чадахгүй, яагаад гэвэл, хүмүүс нүгэлтэй, бохир заваан, Бурханд ойртож хэзээ ч чадахгүй гэж хүн төрөлхтөн андуурахад хүрэх байсан. Хүн төрөлхтний энэ буруу ойлголтыг арилгахын тулд Эзэн Есүс махбодоор хийдэг байсан шигээ, Библид тэмдэглэсэн “Тэр талх авч ерөөгөөд хугалж, тэдэнд өгөв” гэх зэрэг олон зүйлийг хийсэн. Түүнчлэн Тэр урьдынхтайгаа адилаар бичвэрийг тэдэнд тайлбарлаж өгсөн. Эзэн Есүсийн хийсэн энэ бүх зүйл нь Эзэн өөрчлөгдөөгүй, Тэр бол урьдын Эзэн Есүс хэвээрээ гэдгийг Түүнийг харсан бүх хүнд мэдрүүлсэн. Хэдийгээр Тэр загалмайд цовдлогдож, үхлийг үзсэн боловч эргэж амилсан ба хүн төрөлхтнийг орхиогүй. Тэр хүмүүсийн дунд байх гээд эргэж ирсэн бөгөөд Түүний юу ч өөрчлөгдөөгүй. Хүмүүсийн өмнө зогсож байсан хүний Хүү бол Эзэн Есүс мөн байсан. Түүний зан төрх, хүмүүстэй ярьж хөөрөх нь тун танил санагдаж байжээ. Тэр өгөөмөр сэтгэл, нигүүлсэл, хүлээцтэй байдлаар дүүрэн байсан—Тэр бусдыг Өөр шигээ хайрладаг, хүн төрөлхтнийг дал дахин долоон удаа өршөөж чадах Эзэн Есүс хэвээр байсан. Тэр урьдын адилаар хүмүүстэй хамт хооллож, бичвэрийг хамт хэлэлцэж байсан ба үүнээс ч чухал нь, Тэр яг өмнөхтэйгээ адил мах, цуснаас бүтсэн, харж, хүрч болохоор байсан. Хүний Хүү Тэрээр ойр дотно байдлыг мэдэрч, санаа амар байж, алдсан зүйлээ олж авахын баяр баяслыг мэдрэх боломжийг хүмүүст олгосон. Хүмүүс асар тайвнаар, хүн төрөлхтний нүглийг уучилж чадах хүний Хүүд зоригтой, итгэлтэйгээр найдаж эхэлсэн. Тэд мөн тээнэгэлзэх зүйлгүйгээр Эзэн Есүсийн нэрээр залбирч, Түүний нигүүлсэл, ерөөлийг олж авахаар, Түүнээс амар амгалан, баяр баясгаланг олж авч, халамж, хамгаалалт авахын тулд залбирч эхэлсэн бөгөөд Эзэн Есүсийн нэрийн дор өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулж эхэлсэн юм.

Эзэн Есүсийг махбодоор ажиллаж байх үед Түүний дагагчдын ихэнх нь Түүний ялгамж чанарыг болон Түүний хэлсэн зүйлийг бүрэн нотолж чадаагүй. Түүнийг загалмайд цовдлогдох гэж байх үед Түүний дагагчдын хандлага нь ажигласан байдалтай байсан. Тэгээд Түүнийг загалмайд цовдлогдохоос эхлээд булшинд хийх хүртэл Түүнд хандах хүмүүсийн хандлага нь урам хугаралт байсан. Энэ хугацаанд, Эзэн Есүсийн махбодод байх үедээ айлдсан зүйлсэд хүмүүс зүрх сэтгэлдээ эргэлзэж байснаа тэр чигт нь үгүйсгэх болсон. Дараа нь Түүнийг булшнаас гарч, хүмүүст нэг бүрчлэн үзэгдэхэд Түүнийг нүдээрээ харж, Түүний амилсан тухай мэдээг сонссон хүмүүсийн дийлэнх нь үгүйсгэх хандлагаас тээнэгэлзэх хандлага руу аажмаар шилжсэн. Эзэн Есүс Томасын гарыг сүвээндээ хүргүүлж, амилсныхаа дараа талх хуваж, олон хүний өмнө идээд дараа нь тэдний өмнө хайрсан загас идэх үед л Эзэн Есүс бол бие махбодтой Христ юм гэсэн баримтыг тэд үнэхээр хүлээн зөвшөөрсөн. Энэхүү мах цустай сүнслэг бие тэр хүмүүсийн өмнө зогсоод хүн нэг бүрийг зүүднээс нь сэрээж байгаа мэт байсан гэж хэлж болно: тэдний өмнө зогсож байсан хүний Хүү нь эрт галвын үеэс оршин байсан Нэгэн байсан юм. Тэр хэлбэр дүрс, мах цустай байсан бөгөөд аль хэдийнээс урт удаан хугацааны турш

хүн төрөлхтөнтэй хамт амьдарч, хооллож байсан… Тэр үед хүмүүс Түүний оршин тогтнол тун үнэн, маш гайхалтай гэдгийг мэдэрсэн. Үүний зэрэгцээ тэд бас маш их баяртай, аз жаргалтай байж, сэтгэл хөдлөлөөр дүүрэн байв. Түүний дахин илрэлт нь Түүний даруу байдлыг үнэхээр харж, Түүний ойр дотно байдлыг, хүн төрөлхтөнд татагддагийг нь, тэдний талаар хэр их боддогийг нь мэдрэх боломжийг хүмүүст олгосон юм. Энэхүү богинохон уулзалт нь Эзэн Есүсийг харсан хүмүүст, нэг насны амьдрал нь өнгөрсөн мэт санагдуулсан. Тэдний төөрсөн, будилсан, айсан, түгшсэн, хүсэн хүлээсэн, хөшүүн зүрх сэтгэл тайвшралыг олсон. Тэд эргэлзэж, эсвэл урам хугарахаа больсон, учир нь одоо шинэ итгэл, найдах ямар нэг зүйл байна гэдгийг тэд мэдэрсэн юм. Тэдний өмнө зогсож буй хүний Хүү цаг үргэлж тэдний ар тал байна; Тэр үүрд мөнхөд тэдний бат бөх цамхаг, хоргодох газар болно.

Хэдийгээр Эзэн Есүс дахин амилсан боловч зүрх сэтгэл болон ажил нь хүн төрөлхтнийг орхиогүй. Хүмүүст харагдсанаараа Тэр, ямар ч хэлбэрээр оршин байх нь хамаагүй, хэдийд ч, хаана ч хүмүүсийг дагалдаж, тэдэнтэй хамт алхаж, тэдэнтэй хамт байна гэдгээ хэлсэн юм. Тэр хэдийд ч, хаана ч хүн төрөлхтнийг хангаж, хариулж, Түүнийг харж, Түүнд хүрэх боломжийг олгох бөгөөд тэдэнд дахин хэзээ ч хүчин мөхөс санагдуулахгүй гэдгээ хүмүүст хэлсэн юм. Түүнчлэн Эзэн Есүс хүмүүст энэ дэлхий дээр амьдрахдаа ганцаараа биш гэдгийг нь хүмүүст мэдэгдэхийг хүссэн. Хүн төрөлхтөнд Бурханы халамж байгаа; Бурхан тэдэнтэй хамт байдаг. Тэд үргэлж Бурханд найдаж болно, Тэр бол Өөрийн дагагч нэг бүрийн гэр бүл юм. Түшиж тулах Бурхантай байснаар хүн төрөлхтөн цаашид ганцаардмал, арчаагүй байхаа болих бөгөөд Түүнийг өөрсдийн нүглийн тахил хэмээн хүлээн авсан хүмүүс нүгэлд хүлэгдэхээ болино. Хүний нүдээр бол дахин амилсныхаа дараа Эзэн Есүсийн гүйцэтгэсэн ажлын эдгээр хэсэг нь маш жаахан зүйлс байсан, харин Миний үзэж байгаагаар бол, Түүний хийсэн юм болгон маш утга учиртай, маш их үнэ цэнтэй, маш чухал, ач холбогдол ихтэй байсан.

Хэдийгээр Эзэн Есүсийн махбодоор ажилласан үе нь бэрхшээл, зовлонгоор дүүрэн байсан боловч мах цустай сүнслэг биеэрээ гарч ирснээрээ Тэрээр хүн төрөлхтнийг махбодоор золин аврах тухайн үеийн ажлаа бүрэн дүүрэн, төгс хийж гүйцэлдүүлсэн юм. Тэр махбод болсноор үйлчлэлээ эхэлсэн бөгөөд Өөрийн махан биеийн дүр төрхөөр хүн төрөлхтөнд үзэгдсэнээр Өөрийн үйлчлэлийг төгсгөсөн билээ. Тэрээр Нигүүлслийн эрин үеийг зарлан тунхаглаж, Христийн ялгамж чанарааараа шинэ эрин үеийг эхлүүлсэн юм. Христ хэмээх Өөрийн ялгамж чанараар Тэр Нигүүлслийн эрин үе дэх ажлыг хэрэгжүүлж, Өөрийн бүх дагалдагчийг Нигүүлслийн эрин үед хатуужуулж, удирдсан. Бурханы ажлын тухайд гэвэл, Тэр эхэлсэн зүйлээ мадаггүй дуусгадаг гэж хэлж болно. Төлөвлөгөө, алхмууд байдаг ба ажил нь Бурханы мэргэн ухаан, бүхнийг чадагч байдал, гайхалтай үйл хэрэг, Бурханы хайр, өршөөлөөр дүүрэн байдаг. Мэдээж, Бурханы бүх ажилд байдаг үндсэн зангилаа нь хүн төрөлхтний төлөөх Түүний анхаарал халамж юм; үүнд Түүний хэзээ ч хойш тавьж чадахгүй санаа зовнилын мэдрэмж шингэсэн байдаг.

Библийн эдгээр эшлэлд, амилсныхаа дараа Эзэн Есүсийн хийсэн юм бүхэнд хүн төрөлхтний төлөөх Бурханы хувиршгүй найдвар, анхаарал, мөн түүнчлэн Бурханы хичээнгүй халамж, хүн төрөлхтнийг гэх энхрийлэл илчлэгдсэн юм. Эдүгээг хүртэл эдгээрийн аль нь ч өөрчлөгдөөгүй—та нар үүнийг харж байна уу? Үүнийг харах үедээ зүрх сэтгэл чинь өөрийн мэдэлгүй Бурханд ойртдог бус уу? Хэрвээ та нар тэр эрин үед амьдарч байгаад Эзэн Есүс амилсныхаа дараа бодитой хэлбэрээр та нарт үзэгдсэн бол, хэрвээ та нарын өмнө суугаад талх, загас идэн, та нарт бичвэрийг тайлбарлаж, та нартай ярилцсан бол ямар санагдах байсан бэ? Та нар баярлах байсан уу? Эсвэл буруутай санагдах байсан уу? Өмнөх буруу ойлголт, Бурханаас зайлсхийж, Бурхантай зөрчилдөж, Түүнд эргэлзсэн зэрэг нь—зүгээр л арилах байсан бус уу? Бурхан, хүн хоёрын харилцаа улам хэвийн, зүй зохистой болох байсан бус уу?

Библийн энэ хязгаарлагдмал бүлгүүдийг тайлбарласнаар та нар Бурханы зан чанараас ямар нэгэн өө сэв олсон уу? Та нар Бурханы хайраас ямар нэгэн хольц олж илрүүлсэн үү? Бурханы бүхнийг чадагч байдал, мэргэн ухаанаас ямар нэгэн заль мэх, ёрын мууг харсан уу? Мэдээж үгүй! Одоо та нар Бурхан бол ариун гэж баттай хэлж чадах уу? Бурханы сэтгэл хөдлөл болгон нь Түүний мөн чанар, зан чанарын илчлэл гэж баттай хэлж чадах уу? Та нар эдгээр үгийг уншсаны дараа үүнээс олж авсан ойлголт чинь зан чанараа өөрчилж, Бурханаас эмээхэд чинь тусалж, үр ашгаа өгч, эдгээр үг нь та нарт өдөр бүр өсөн нэмэгдэх үр ашиг өгч, ингэснээр энэхүү эрэл хайгуулын явцад та нар Бурханд улам бүр ойртож, Бурханы шаарддаг стандартад улам бүр ойртоно гэж Би найдаж байна. Та нар үнэний эрэл хайгуулаас уйдахаа больж, үнэний эрэл хайгуул болон зан чанарын өөрчлөлт нь та нарт төвөгтэй, илүүц мэт санагдахаа болино. Харин ч Бурханы жинхэнэ зан чанарын илэрхийлэл болон Бурханы ариун мөн чанарын зоригжуулалтаар та нар гэрлийг эгээрэн хүсэж, шударга ёсыг эгээрэн хүснэ, мөн үнэнийг эрэлхийлж, Бурханы хүслийг хангахаар чармайж, Бурханаар авхуулах хүн болж, жинхэнэ хүн болно.

Өнөөдөр бид, Нигүүлслийн эрин үед анх удаа бие махбодтой болохдоо Бурханы хийсэн зарим зүйлийн талаар ярилцлаа. Эдгээр зүйлээс бид Түүний махбодоор илэрхийлж, илчилсэн зан чанарыг болон Түүнд юу байгаа, Тэр юу болохын бүх талыг харлаа. Түүнд юу байгаа, Тэр юу болохын энэ бүх тал нь ихэд хүнлэг болсон санагддаг боловч үнэндээ илчилж, илэрхийлсэн бүхний мөн чанар нь Түүний хувийн зан чанараас салшгүй юм. Хүн чанараар Өөрийн зан чанарыг илэрхийлж буй бие махбодтой болсон Бурханы бүх арга, бүх тал нь Түүний хувийн мөн чанартай салшгүй холбогдсон байдаг. Иймээс Бурхан бие махбодтой болох арга замыг ашиглан хүн төрөлхтөн дээр ирсэн нь маш чухал юм. Түүнчлэн махбодоор хийсэн Түүний ажил ч бас чухал, гэхдээ махан биетэй амьдарч байгаа хүн бүхэнд болон ялзралд амьдарч байгаа хүн болгонд бүр ч илүү чухал зүйл бол Түүний илчилсэн зан чанар, Түүний илэрхийлсэн хүсэл юм. Энэ нь та нарын ойлгож

чадах зүйл мөн үү? Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг ойлгосныхоо дараа та нар Бурханд яаж хандвал зохих талаараа ямар нэгэн дүгнэлт хийсэн үү? Эцэст нь энэ асуултын хариуд Би та бүхэнд гурван зөвлөгөө өгмөөр байна: Нэгдүгээрт, Бурханыг бүү турш. Бурханы тухай хэр зэрэг ойлгодог чинь хамаагүй, Түүний зан чанарын талаар хэр зэрэг мэддэг чинь хамаагүй, Түүнийг туршиж огтхон ч болохгүй. Хоёрдугаарт, Бурхантай байр суурь бүү булаацалд. Бурхан чамд ямар байр суурь өгч, эсвэл чамд ямар ажил даалгах нь хамаагүй, Тэр чамаар ямар үүрэг гүйцэтгүүлэхээр өргөх нь хамаагүй, Бурханы төлөө өөрийгөө хэчнээн их зарлагадаж, золиосолсон чинь ч хамаагүй, Түүнтэй байр суурь огтхон ч бүү булаацалд. Гуравдугаарт, Бурхантай бүү тэмцэлд. Бурханы чамд хийсэн зүйлийг, чиний төлөө Түүний зохицуулсан зүйлийг, Түүний чамд авчирсан зүйлийг ойлгох эсэх чинь, дуулгавартай дагаж чадах эсэх чинь хамаагүй, Бурхантай огтхон ч бүү тэмцэлд. Хэрвээ чи энэ гурван зөвлөгөөг мөрдөж чадах юм бол нэлээд аюулгүй байх бөгөөд Бурханыг тийм ч амархан уурлуулахгүй. Өнөөдрийн нөхөрлөлөө ингээд дуусгая.

2013 оны 11 дүгээр сарын 23

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ I
БУРХАНЫ ЭРХ МЭДЭЛ (I)

Миний сүүлийн хэдэн нөхөрлөл Бурханы ажил, Бурханы зан чанар болон Бурханы Өөрийнх нь тухай байсан. Эдгээр нөхөрлөлийг сонссоны дараа та нарт Бурханы зан чанарын талаар ойлголт, мэдлэг олж авсан мэт санагдаж байна уу? Хэр их ойлголт, мэдлэг олж авсан бэ? Та нар үүнийгээ хэмжиж чадах уу? Эдгээр нөхөрлөл та нарт Бурханы талаар илүү гүн гүнзгий ойлголт өгсөн үү? Эдгээр ойлголтыг Бурханы талаарх жинхэнэ мэдлэг гэж хэлж болох уу? Бурханы талаарх эдгээр мэдлэг, ойлголтыг Бурханы бүхий л мөн чанар, мөн Түүнд юу байгаа, Тэр юу болох тухай мэдлэг гэж хэлж болох уу? Үгүй, мэдээж үгүй! Учир нь эдгээр нөхөрлөл Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох тухай бүх ойлголтыг бүхэлд нь бус, нэг хэсэг ойлголтыг л өгсөн. Эдгээр нөхөрлөл та нарт Бурханы өнгөрсөнд хийсэн ажлын нэг хэсгийг ойлгох боломж олгосон, эдгээр нөхөрлөлөөр дамжуулан та нар Бурханы зан чанар болон Түүнд юу байгаа, Тэр юу болохыг, мөн Түүний хийсэн бүх зүйлийн цаадах чиг хандлага, бодол санааг харсан. Гэхдээ энэ нь Бурханы талаарх шууд утгаар, үгээр илэрхийлсэн ойлголтоос цаашгүй бөгөөд зүрх сэтгэл дотроо та нар үүний хэчнээн нь бодитой болохыг тодорхой мэдэхгүй хэвээр байгаа. Ийм зүйлсийн талаарх хүмүүсийн ойлголтод бодит байдал байгаа эсэх нь юугаар голчлон тодорхойлогддог вэ? Тэд жинхэнэ туршлагынхаа явцад Бурханы үг, зан чанараас хэр ихийг үнэхээр туулсан бэ, мөн тэд эдгээр жинхэнэ туршлагын явцад хэр ихийг харж, мэдэж чадсан бэ гэдгээр энэ нь тодорхойлогддог. “Сүүлийн хэдэн нөхөрлөл нь бидэнд Бурханы хийсэн зүйлс, Бурханы бодол, түүнчлэн хүн төрөлхтөнд хандах Бурханы хандлага, Түүний үйлдлийн үндэслэл болон Түүний үйлдлийн зарчмыг ойлгох боломж олгосон. Иймээс бид Бурханы зан чанарыг ойлгож, Бурханыг бүхэлд нь мэдэж авсан” гэж хэлэх хүн байна уу? Ингэж хэлэх зөв үү? Мэдээж, үгүй. Яагаад Би ингэж хэлэх нь буруу гэж хэлж байна вэ? Бурханы зан чанарыг болон Түүнд юу байгаа, Тэр юу болохыг Түүний хийсэн зүйлс, хэлсэн үг нь илэрхийлдэг. Хүн Бурханы хийсэн ажил, хэлсэн үгээр дамжуулан Түүнд юу байгаа, Тэр юу болохыг харж чаддаг боловч эдгээр ажил, үг нь хүнд Бурханы зан чанарын болон Түүнд юу байгаа, Тэр юу болохын нэг хэсгийг л ойлгох боломж олгодог гэсэн үг. Хэрвээ хүн Бурханы талаар илүү өргөн, гүн гүнзгий ойлголт олж авахыг хүсвэл Бурханы үг болон ажлыг илүү их туулах ёстой. Хүн Бурханы үг, ажлын нэг хэсгийг туулахдаа Бурханы талаар хагас хугас ойлголт олж авдаг хэдий ч энэ хагас хугас ойлголт нь Бурханы жинхэнэ зан чанарыг төлөөлдөг үү? Энэ нь Бурханы мөн чанарыг төлөөлдөг үү? Мэдээж энэ нь Бурханы жинхэнэ зан чанар болон Бурханы мөн чанарыг төлөөлдөг, үүнд эргэлзэх зүйл үгүй. Цаг хугацаа, орон зайг үл харгалзан, эсвэл Бурхан Өөрийн ажлыг ямар байдлаар хийдэг, ямар хэлбэрээр хүнд үзэгддэг, Өөрийн хүслийг ямар замаар илэрхийлдгээс ч үл хамааран, Түүний илчилдэг, илэрхийлдэг бүхэн нь Бурханыг Өөрийг нь,

Бурханы мөн чанарыг, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг төлөөлдөг. Түүнд юу байгаа, Тэр юу болох болон Өөрийн жинхэнэ ялгамж чанараар Бурхан ажлаа хэрэгжүүлдэг; энэ бол туйлын үнэн. Гэсэн ч, өнөөдөр хүмүүс Бурханы үгээр дамжуулан, мөн номлолоос сонссон зүйлээрээ дамжуулан Түүний талаар зөвхөн хагас хугас ойлголттой болдог, иймээс энэ ойлголтыг тодорхой хэмжээнд зөвхөн онолын мэдлэг л гэж хэлж болох юм. Бодит байр байдлыг чинь харгалзан үзвэл, чи өнөөдөр өөрийн сонссон, харсан, эсвэл зүрх сэтгэлдээ ойлгож, мэдсэн Бурханы тухай ойлголт, мэдлэгээ бодит туршлагаараа туулж, бага багаар мэдэж авсан цагт л баталгаажуулж чадна. Хэрвээ эдгээр үгийг Би та нартай нөхөрлөөгүй бол та нар зөвхөн туршлагаараа дамжуулан Бурханы талаарх жинхэнэ мэдлэгт хүрч чадах байсан уу? Тэгнэ гэдэг маш хэцүү л байх сан болов уу. Учир нь, хэрхэн туулахаа мэдэхийн тулд хүмүүст эхлээд Бурханы үг байх ёстой юм. Хүмүүс Бурханы үгийг хэдий чинээ их иднэ, төдий чинээ ихийг үнэхээр туулж чадна. Бурханы үг өмнөх замыг зааж, хүнийг туршлагад нь удирдан чиглүүлдэг. Товчхондоо гэвэл, тодорхой хэмжээний жинхэнэ туршлагатай хүмүүст, үнэний талаар илүү гүн гүнзгий ойлголт болон Бурханы талаар илүү бодитой мэдлэг олж авахад нь сүүлийн энэ хэдэн нөхөрлөл тусална. Харин ямар ч жинхэнэ туршлагагүй хүмүүс, эсвэл дөнгөж туршлага авч эхэлсэн хүмүүс болон бодит байдалд дөнгөж хүрч эхэлсэн хүмүүсийн хувьд энэ нь асар том туршилт юм.

Сүүлийн хэдэн нөхөрлөлийн үндсэн агуулга нь “Бурханы зан чанар, Бурханы ажил болон Бурханы Өөрийн” тухай байсан. Миний ярьсан бүх зүйлийн гол, чухал хэсгүүдээс та нар юу харсан бэ? Энэ ажлыг хийж, эдгээр зан чанарыг илчилсэн Тэрээр бүх зүйлийн дээд эрхийг атгадаг цорын ганц Бурхан Өөрөө гэдгийг та нар эдгээр нөхөрлөлөөр дамжуулан таньж чадав уу? Хэрвээ та нар тийм гэж хариулсан бол юу та нарыг ийм дүгнэлтэд хүргэсэн бэ? Энэ дүгнэлтэд хүрэхдээ та нар хэдэн талаас нь харгалзан үзсэн бэ? Надад хэлж чадах хүн байна уу? Сүүлийн нөхөрлөлүүд та нарт гүнээ нөлөөлж, та нарын зүрх сэтгэл дотор Бурханы талаарх мэдлэгт чинь шинэ эхлэл тавьсныг Би мэднэ, энэ нь маш сайн зүйл. Хэдийгээр та нар урьдынхтайгаа харьцуулахад Бурханы талаарх ойлголтдоо асар том үсрэлт хийсэн боловч Бурханы ялгамж чанарын талаарх тодорхойлолт чинь Хуулийн эрин үеийн Ехова Бурхан, Нигүүлслийн эрин үеийн Эзэн Есүс болон Хаанчлалын эрин үеийн Төгс Хүчит Бурханы нэрсээс цааш ахих болоогүй байна. Өөрөөр хэлбэл, “Бурханы зан чанар, Бурханы ажил болон Бурханы Өөрийн” тухай эдгээр нөхөрлөл та нарт Бурханы нэгэнтээ хэлсэн үг, нэгэнтээ хийсэн ажил, Бурханы нэгэнтээ илчилсэн оршихуй болон эзэмшлийн тухай зарим нэг ойлголтыг өгсөн боловч та нар “Бурхан” хэмээх үгийн жинхэнэ тодорхойлолт, оновчтой баримжааг гаргаж өгч чаддаггүй. Мөн та нарт Бурханы Өөрийн байр суурь, ялгамж чанарын талаар, өөрөөр хэлбэл, Бурханы бүх зүйлийн дундах болон бүхий л орчлон ертөнц даяарх байр суурийн талаар жинхэнэ, оновчтой баримжаа болон мэдлэг байдаггүй. Учир нь, Бурханы Өөрийн тухай болон Бурханы зан чанарын тухай өмнөх нөхөрлөлүүдийн

бүх агуулга нь Библид тэмдэглэгдсэн Бурханы урьдын илэрхийлэл, илчлэлүүд дээр үндэслэсэн юм. Гэсэн ч хүн төрөлхтнийг удирдах удирдлага, авралынхаа үеэр болон бусад үеэр Бурханы илчилж, илэрхийлсэн оршихуй болон эзэмшлийг олж илрүүлнэ гэдэг хүмүүст хэцүү байдаг. Иймээс та нар Бурханы урьдын хийсэн ажилд илчлэгдсэн Түүний оршихуй болон эзэмшлийг ойлголоо ч гэсэн, Бурханы ялгамж чанар, байр сууриин талаарх тодорхойлолт чинь бүх зүйлийн дээд эрхийг атгадаг цорын ганц Бурханы ялгамж чанар, байр сууриас хол зөрүүтэй, бас “Бүтээгч”-ийнхээс өөр байдаг. Сүүлийн хэдэн нөхөрлөл хүн бүрд ижил сэтгэгдэл төрүүлсэн: Хүн Бурханы бодлыг хэрхэн мэдэж чадах юм бэ? Хэрвээ хэн нэгэн үнэхээр мэдлээ гэхэд тэр хүн Бурхан байх нь гарцаагүй, учир нь Бурхан Өөрөө л Өөрийнхөө бодлыг мэддэг ба Бурхан Өөрөө л хийдэг бүх зүйлийнхээ цаад үндэслэл, хандлагыг мэддэг билээ. Та нарт Бурханы ялгамж чанарыг ийм байдлаар таньж мэдэх нь оновчтой агаад үндэслэлтэй санагддаг, гэхдээ Бурханы зан чанар болон ажлаас хараад энэ нь хүний ажил биш, үнэхээр Бурханы Өөрийн ажил, Бурханы өмнөөс хүний хийж чадах ажил биш гэдгийг хэн хэлж чадах юм бэ? Энэ ажил нь Бурханы мөн чанар, хүч чадалтай Нэгний дээд эрхэн дор оршдог гэдгийг хэн харж чадах юм бэ? Өөрөөр хэлбэл, Тэр бол Бурханы ялгамж чанартай Бурхан Өөрөө гэдгийг, бас бүх зүйлийн дээд эрхийг атгадаг Нэгэн мөн гэдгийг та нар ямар шинж тэмдэг, мөн чанараар дамжуулан таньж чадах юм бэ? Та нар тэр талаар ер нь бодож үзсэн үү? Хэрвээ та нар бодож үзээгүй бол энэ нь нэг баримтыг баталж байна: Сүүлийн хэдэн нөхөрлөл нь Бурханы урьд нь хийсэн ажлын тухай түүх, мөн энэ ажлын үеэрх Бурханы хандлага, илрэл болон илчлэлийн талаарх зарим нэг ойлголтыг л та нарт өгсөн. Хэдийгээр ийм ойлголтоороо та нар ажлын энэ хоёр үе шатыг хэрэгжүүлсэн Нэгэн нь та нарын итгэж, дагадаг Бурхан Өөрөө бөгөөд та нарын үүрд дагах ёстой Нэгэн мөн гэдгийг дор бүрдээ эргэлзэх зүйлгүйгээр таньж мэдсэн боловч Тэр бол дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш оршин байсаар ирсэн, цаашид ч мөнх орших Бурхан гэдгийг таньж мэдэх чадваргүй хэвээр байгаагийн дээр Тэр бол бүх хүн төрөлхтнийг удирддаг, дээд эрх барьдаг Нэгэн гэдгийг ч таньж чаддаггүй. Та нар энэ асуудлын талаар хэзээ ч бодож үзээгүй нь лавтай. Ехова ч бай, эсвэл Эзэн Есүс ч бай, Тэр бол та нарын дагах ёстой Бурхан мөнөөр зогсохгүй хүн төрөлхтнийг удирдаж, хүн төрөлхтний хувь заяаг атгах дээд эрхтэй Нэгэн, цаашлаад тэнгэр, газар, бүх зүйлийг захирах дээд эрхтэй цорын ганц Бурхан Өөрөө гэдгийг нь мөн чанар, илрэлийн аль талаар дамжуулан та нар таньж чаддаг вэ? Итгэж, дагадаг Нэгэн чинь бүх зүйлийг захирдаг Бурхан Өөрөө гэдгийг та нар ямар сувгаар дамжуулж таньдаг вэ? Та нар өөрсдийн итгэдэг Бурханыг хүн төрөлхтний хувь заяаг атгах дээд эрхтэй Бурхантай ямар сувгаар дамжуулан холбодог вэ? Итгэдэг Бурхан чинь тэнгэр, газарт болон бүх зүйлийн дунд байдаг цорын ганц Бурхан Өөрөө гэдгийг таних боломжийг та нарт юу олгодог вэ? Энэ бол дараагийн хэсэгт Миний шийдэх асуудал юм.

Та нарын хэзээ ч бодож үзээгүй, эсвэл бодож чадахгүй асуудлууд Бурханыг мэдэхэд хамгийн чухал зүйлс байх өндөр боломжтой ба хүний ойлгошгүй үнэнийг

эдгээрээс эрж хайж болно. Эдгээр асуудал та нарт тохиолдож, та нар нүүр тулж, сонголт хийх шаардлагатай болох үед мунхаг, мэдлэггүй байдлаасаа болж, эсвэл хэтэрхий өнгөц туршлагатай бөгөөд Бурханы талаар жинхэнэ мэдлэг дутуугаасаа болж эдгээр асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй бол Бурханд итгэх замд чинь эдгээр нь хамгийн том саад тотгор, хамгийн том бартаа болох болно. Иймээс энэ сэдвээр та нартай нөхөрлөх асар их шаардлагатай гэж Надад санагдаж байна. Та нарын асуудал юу болохыг одоо мэдэв үү? Миний ярьж байгаа асуудлууд та нарт тодорхой байна уу? Эдгээр нь та нарт тулгарах асуудлууд мөн үү? Та нарын ойлгодоггүй асуудлууд мөн үү? Та нарын хэзээ ч бодож байгаагүй асуудлууд мөн үү? Эдгээр асуудал та нарт чухал уу? Эдгээр нь үнэхээр асуудал мөн үү? Энэ асуудал та нарт асар их төөрөгдөл үүсгэдэг бөгөөд итгэдэг Бурханыхаа талаар жинхэнэ ойлголтгүй, мөн Түүнийг нухацтайгаар авч үздэггүй чинь үүгээр харагддаг. “Тэр бол Бурхан гэдгийг би мэднэ, тиймээс ч би Түүнийг дагадаг, учир нь Түүний үг бол Бурханы илэрхийлэл юм. Энэ л хангалттай. Өөр ямар нотолгоо хэрэгтэй юм бэ? Бид Бурханы талаар эргэлзэх хэрэгтэй гэж үү? Мэдээж бид Бурханыг турших ёсгүй биз дээ? Бид Бурханы мөн чанар, Бурханы Өөрийнх нь ялгамж чанарт эргэлзэх хэрэгтэй гэж үү?” гэж зарим нь хэлдэг. Та нар ингэж боддог ч бай, үгүй ч бай, Бурханы талаар та нарт төөрөгдөл үүсгэх, мөн та нараар Түүнийг туршуулах, тэр ч бүү хэл Бурханы ялгамж чанар, мөн чанарын талаар та нарт эргэлзээ төрүүлэх гэсэндээ Би ийм асуулт тавьдаггүй. Харин ч Би та нарт Бурханы мөн чанарын талаар илүү их ойлгуулж, Бурханы байр суурийн талаар илүү баттай итгэл үнэмшилтэй болгохын тулд ийнхүү хийдэг, ингэснээр Бурханыг дагадаг бүх хүний зүрх сэтгэлд Бурхан цорын ганц Нэгэн болж, мөн бүх зүйлийн Бүтээгч, Захирагч, цорын ганц Бурхан Өөрөө хэмээх Бурханы анхдагч байр суурь нь бүх бүтээлийн зүрх сэтгэлд дахин сэргэх юм. Энэ нь бас Миний нөхөрлөх гэж байгаа сэдэв билээ.

Одоо Библиэс дараах бичвэрийг уншиж эхэлцгээе.

1. Бурхан бүх зүйлийг бүтээхдээ үг ашигладаг

Эхлэл 1:3–5 Мөн Бурхан: “Гэрэл бий болог!” гэхэд тэнд гэрэл бий болов. Бурхан гэрлийг харахад энэ нь сайн байв: тэгээд Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ. Дараа нь Бурхан гэрлийг Өдөр, харанхуйг Шөнө гэж нэрлэв. Үдэш болоод өглөө болсон нь эхний өдөр байсан юм.

Эхлэл 1:6–7 Бурхан: “Усны голд огторгуй байж, усыг уснаас салгаг” гэв. Бурхан огторгуйг бүтээж, огторгуйн доор байсан усыг огторгуйн дээр байсан уснаас салгасан ба энэ нь ёсоор болов.

Эхлэл 1:9–11 Бурхан: “Тэнгэрийн доорх ус нэг дор цуглаж, хуурай газар гарч ирэг” хэмээхэд энэ нь ёсоор болов. Ингээд Бурхан хуурай газрыг Газар; хурсан их усыг Тэрээр Далай хэмээн нэрлэв: Бурханыг харахад тэр нь сайн байлаа. Бурхан: “газар нь ногоон өвс, үрт ургамал ногоо болон газарт үрээ гөвдөг үр жимст модыг төрөл төрлөөр нь ургуулаг” гэхэд хэлсэн ёсоор нь болов.

Эхлэл 1:14–15 Бурхан: “Өдрийг шөнөөс салгахын тулд огторгуйн мандалд гэрэлтүүлэгчид бий болог; эдгээр нь тэмдэг, улирал, өдөр ба жилд зориулагдаг: Тэдгээр нь газрыг гэрэлтүүлдэг огторгуйн мандал дахь гэрэл байг” хэмээв, тэгэхэд хэлсэн ёсоор нь боллоо.

Эхлэл 1:20–21 Бурхан: “Уснууд амьд амьтдаар бялхаж, жигүүртэн шувууд газар дээгүүр, тэнгэр огторгуйд нисэг” гэв. Тэгээд Бурхан аварга загас ба усанд үржин амьдардаг бүхий л амьтдыг төрөл төрлөөр нь бүтээгээд дараа нь жигүүртэн шувуудыг төрөл төрлөөр нь бүтээв: Бурханыг харахад энэ нь сайн байлаа.

Эхлэл 1:24–25 Бурхан: “Газар дэлхий амьтдыг төрөл төрлөөр нь бий болгож, мал амьтан, мөлхөгчид, зэрлэг араатан амьтдыг төрөл төрлөөр нь бий болгог” гэсэнд тэр нь ёсоор болов. Дараа нь газрын араатан амьтад төрөл төрлөөрөө бүтээгдэж, мал адгуус, газар дээр мөлхдөг хорхой шавж төрөл төрлөөрөө бүтээгдэв. Бурханыг харахад тэр нь сайн байлаа.

Эхний өдөр, Бурханы эрх мэдлийн ачаар хүн төрөлхтний өдөр, шөнө бий болж, бат зогсов

Эхний эшлэлийг харцгаая: “Мөн Бурхан: ‘Гэрэл бий болог!’ гэхэд тэнд гэрэл бий болов. Бурхан гэрлийг харахад энэ нь сайн байв: тэгээд Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ. Дараа нь Бурхан гэрлийг Өдөр, харанхуйг Шөнө гэж нэрлэв. Үдэш болоод өглөө болсон нь эхний өдөр байсан юм” (Эхлэл 1:3–5). Энэ эшлэл нь бүтээлийн эхэн дэх Бурханы эхний үйлдлийг, мөн үдэш болж өглөө болсноор Бурханы өнгөрүүлсэн эхний өдрийг дүрсэлдэг. Гэхдээ энэ нь ер бусын өдөр байсан: Бурхан бүх зүйлийн төлөө гэрлийг бэлдэж эхэлсэн бөгөөд бас харанхуйгаас гэрлийг салгасан. Энэ өдөр Бурхан үг хэлж эхэлсэн ба Түүний үг болон эрх мэдэл зэрэгцэн оршиж байсан юм. Түүний эрх мэдэл бүх зүйлийн дунд ил болж, Түүний үгээс үүдэн Түүний хүч чадал бүх зүйлийн дунд түгсэн. Энэ өдрөөс хойш бүх зүйл Бурханы үг, Бурханы эрх мэдэл, Бурханы хүч чадлаас үүдэн бүтээгдэж, бат зогссон бөгөөд Бурханы үг, Бурханы эрх мэдэл, Бурханы хүч чадлын ачаар үүргээ биелүүлж эхэлсэн билээ. “Гэрэл бий болог!” гэх үгийг Бурхан хэлэхэд гэрэл бий болсон. Бурхан ямар ч ажлын хөтөлбөр эхлүүлээгүй; Түүний үгийн үр дүнд гэрэл бий болсон юм. Өнөөдөр ч гэсэн хүний оршин тогтнол энэ гэрэлд түшиглэдэг бөгөөд энэ нь Бурханы өдөр хэмээн нэрлэсэн гэрэл юм. Бурханы тушаалаар, үүний мөн чанар болон үнэ цэн хэзээ ч өөрчлөгдөөгүй ба энэ нь хэзээ ч алга болоогүй. Үүний оршин тогтнол нь Бурханы эрх мэдэл, хүч чадлыг харуулж, Бүтээгчийн оршин байгааг тунхагладаг. Энэ нь Бүтээгчийн ялгамж чанар болон байр суурийг ахин дахин баталгаажуулдаг. Энэ нь биегүй, хий хоосон бус, харин хүний харж чадах бодит гэрэл юм. Тэр цагаас эхлээд “газар ямар ч хэлбэргүй, хоосон байсан ба гүний гадаргуу дээр харанхуй бүрхэж” байсан хоосон дэлхий дээр хамгийн эхний материаллаг зүйл бий болсон. Энэ зүйл нь Бурханы амнаас гарсан үгээс үүсэж, Бурханы эрх мэдэл, айлдвараас үүдэн бүх зүйлийн бүтээлийн нэгдүгээр үзэгдэлд илэрсэн. Удалгүй Бурхан гэрэл, харанхуйг салахыг тушаасан…

Бурханы үгээс үүдэн бүх зүйл өөрчлөгдөж, гүйцэлдсэн… Бурхан энэ гэрлийг “Өдөр” гэж нэрлэн, харанхуйг “Шөнө” хэмээн нэрийдсэн. Тэр цаг үед Бурханы бүтээхийг зорьсон дэлхийд эхний үдэш, эхний өглөө бий болсон бөгөөд Бурхан үүнийг эхний өдөр хэмээжээ. Энэ өдөр нь бүх зүйлийг бүтээсэн Бүтээгчийн эхний өдөр, бүх зүйлийн бүтээлийн эхлэл, мөн Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлыг Түүний бүтээсэн энэ дэлхийд анх удаа харуулсан явдал байсан билээ.

Хүн эдгээр үгээр дамжуулан Бурханы эрх мэдэл, Бурханы үгийн эрх мэдэл болон Бурханы хүч чадлыг харж чаддаг. Бурхан л ийм хүч чадлыг эзэмшдэг учраас Бурханд л ийм эрх мэдэл байдаг ба Бурхан ийм эрх мэдлийг эзэмшдэг учраас Бурханд л ийм хүч чадал байдаг. Аливаа хүн, эд зүйл ийм эрх мэдэл, хүч чадлыг эзэмшиж чадах байсан уу? Та нарын зүрх сэтгэлд хариулт байна уу? Бурханаас өөр бүтээгдсэн эсвэл бүтээгдсэн бус аливаа зүйл ийм эрх мэдлийг эзэмшдэг үү? Та нар ийм зүйлийн жишээг өөр бусад ном, хэвлэлээс харж байсан уу? Хэн нэг хүн тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн гэх бүртгэл байдаг уу? Өөр бусад ном, бүртгэлд ингэж гардаггүй; эдгээр нь мэдээж Бурханы газар дэлхийг сүр жавхлантайгаар бүтээсэн тухай Библид тэмдэглэгдсэн эрх мэдэл, хүч чадалтай цорын ганц үг бөгөөд эдгээр үг нь Бурханы цорын ганц эрх мэдэл, ялгамж чанарыг төлөөлдөг. Ийм эрх мэдэл, хүч чадал нь Бурханы цорын ганц ялгамж чанарыг бэлгэддэг гэж хэлж болох уу? Тэдгээрийг зөвхөн Бурхан ганцаараа эзэмшдэг гэж хэлж болох уу? Ямар ч эргэлзээгүйгээр, Бурхан л ийм эрх мэдэл, хүч чадлыг эзэмшдэг! Энэ эрх мэдэл болон хүч чадлыг аливаа бүтээгдсэн, бүтээгдсэн бус зүйл эзэмшиж эсвэл орлож чадахгүй! Энэ нь цорын ганц Бурханы Өөрийн шинж чанаруудын нэг мөн үү? Та нар үүнийг нүдээр үзсэн үү? Эдгээр үг нь хүмүүст, Бурхан цорын ганц эрх мэдэл, цорын ганц хүч чадлыг болон дээдийн дээд ялгамж чанар, байр суурийг эзэмшдэг хэмээх бодит баримтыг хурдан, тодорхой ойлгох боломж олгодог. Дээрх нөхөрлөлөөс үзээд та нар итгэдэг Бурханаа цорын ганц Бурхан Өөрөө мөн гэж хэлж чадах уу?

Хоёр дахь өдөр, Бурханы эрх мэдэл нь усыг зохицуулж, огторгуйг бүтээсэн ба хүмүүсийн амьдрах хамгийн үндсэн орон зай гарч ирсэн

Библийн хоёр дахь эшлэлийг уншицгаая: “Бурхан: ‘Усны голд огторгуй байж, усыг уснаас салгаг’ гэв. Бурхан огторгуйг бүтээж, огторгуйн доор байсан усыг огторгуйн дээр байсан уснаас салгасан ба энэ нь ёсоор болов” (Эхлэл 1:6–7). Бурханы “Усны голд огторгуй байж, усыг уснаас салгаг” гэж хэлсний дараа ямар өөрчлөлт гарсан бэ? Бичвэрүүдэд: “Бурхан огторгуйг бүтээж, огторгуйн доор байсан усыг огторгуйн дээр байсан уснаас салгасан” гэж байдаг. Бурхан үүнийг хэлж, хийсний дараах үр дүн нь юу байсан бэ? Эшлэлийн “энэ нь ёсоор болов” хэмээх сүүлийн хэсэгт хариулт нь оршдог.

Энэ хоёр богино өгүүлбэр нь сүр жавхлантай үйл явдлыг тэмдэглэж, гайхалтай дүр зураг буюу Бурхан усыг захирч, хүн төрөлхтний оршин тогтнох орон зайг бүтээсэн асар том үйл хэргийг дүрсэлдэг…

Энэ дүр зурагт, ус болон огторгуй Бурханы нүдний өмнө хоромхон зуурт гарч ирэн, Бурханы үгийн эрх мэдлээр хуваагдаж, Бурханы заасан байдлаар дээд, доод болон тусгаарлагдсан. Өөрөөр хэлбэл, Бурханы бүтээсэн огторгуй нь доорх усыг бүрхээд зогсохгүй, дээрх усыг мөн тогтоон барьсан… Энд, Бүтээгч усыг хөдөлгөж, усанд тушааж, огторгуйг бүтээсэн сүр жавхлантай дүр зураг болон Түүний эрх мэдлийн хүчийг хүн гайхан биширсэндээ гөлөрч, мэл гайхан, уулга алдахаас өөр аргагүй. Бурхан Өөрийн үг, хүч чадал, эрх мэдлээр дамжуулан бас нэгэн агуу үйл хэргийг гүйцэлдүүлсэн. Энэ нь Бүтээгчийн эрх мэдлийн сүр хүч биш гэж үү? Бичвэрүүдийг ашиглан Бурханы үйл хэргийг тайлбарлацгаая: Бурхан үгээ хэлсэн ба Бурханы эдгээр үгийн улмаас усны дунд огторгуй бий болсон. Үүний зэрэгцээ, Бурханы эдгээр үгийн улмаас энэ орон зайд асар их өөрчлөлт гарсан бөгөөд энэ нь энгийн нэг өөрчлөлт байгаагүй, харин оргүй хоосон нь ортой зүйл болж солигдсон явдал байсан юм. Энэ нь Бүтээгчийн бодлоос төрж, Бүтээгчийн хэлсэн үгээс үүдэн оргүй хоосноос ортой зүйл болсон ба цаашлаад, энэ мөчөөс хойш Бүтээгчийн төлөө оршин тогтнож, бат зогсож, Бүтээгчийн бодлын дагуу шилжиж, өөрчлөгдөж, шинэчлэгдэх болсон юм. Энэ эшлэл нь бүх дэлхийг бүтээсэн Бүтээгчийн хоёр дахь үйлдлийг дүрсэлдэг. Энэ нь Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлын бас нэгэн илэрхийлэл байсан ба Бүтээгчийн өөр нэг анхдагч үйл хэрэг байсан юм. Энэ өдөр нь дэлхийг бүтээснээс хойш Бүтээгчийн өнгөрүүлсэн хоёр дахь өдөр бөгөөд Түүний хувьд бас нэгэн гайхамшигт өдөр байв: Тэр гэрлийн дунд алхаж, огторгуйг авчирсан, Тэр усыг захирч, зохицуулсан ба шинэ өдөрт Түүний үйл хэрэг, эрх мэдэл, хүч чадал ажиллаж эхэлсэн билээ…

Бурхан үгээ хэлэхээс өмнө усны дунд огторгуй байсан уу? Мэдээж үгүй! Тэгвэл Бурхан “Усны голд огторгуй байг” гэж хэлсний дараа юу болсон бэ? Бурханы зорьсон зүйлс гарч ирсэн; усан дунд огторгуй бий болж, Бурхан “усыг уснаас салгаг” гэж хэлсэн учраас ус тусгаарлагдсан. Ийм маягаар, Бурханы үгийг даган Бурханы эрх мэдэл, хүч чадлын үр дүнд хоёр шинэ эд юм, шинээр бий болсон хоёр зүйл бүх зүйлийн дунд гарч ирсэн. Тэгвэл энэ хоёр шинэ зүйлийн илрэлт та нарт ямар санагдаж байна вэ? Бүтээгчийн хүч чадлын агуу байдлыг та нар мэдэрч байна уу? Та нар Бүтээгчийн цор ганц, ер бусын сүр хүчийг мэдэрч байна уу? Ийм агуу сүр хүч болон хүч чадал нь Бурханы эрх мэдлээс үүдэлтэй ба энэ эрх мэдэл нь Бурханы Өөрийнх нь төлөөлөл, Бурханы Өөрийн цорын ганц шинж чанар билээ.

Энэ эшлэл та нарт Бурханы цорын ганц чанарын талаар бас нэгэн гүн гүнзгий мэдрэмж төрүүлсэн үү? Гэвч үнэндээ энэ нь ер хангалтгүй; Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадал үүнээс хол илүү байдаг. Тэр ердөө өөр ямар ч бүтээлтэй адилгүй мөн чанарыг эзэмшдэг учраас биш, харин Түүний эрх мэдэл, хүч чадал нь ер бусын, хил хязгааргүй, бүхнээс давуу, бүхний дээр оршдог учраас, цаашлаад Түүний эрх мэдэл болон Түүнд юу байгаа, Тэр юу болох нь амийг бүтээж, гайхамшгийг бий болгож, онц сонин, ер бусын минут, секунд тутмыг бүтээж байдаг учраас Тэр цор ганц чанартай байдаг юм. Үүний зэрэгцээ Тэр Өөрийн бүтээсэн амийг удирдах

чадвартай, мөн Өөрийн бүтээсэн гайхамшгууд болон минут секунд бүрийг захирах дээд эрхтэй.

Гурав дахь өдөр, Бурханы үг газар болон тэнгисийг бий болгосон ба Бурханы эрх мэдэл нь дэлхий ертөнцийг амиар бялхахад хүргэсэн

Одоо, Эхлэл 1:9–11-ийн эхний өгүүлбэрийг уншицгаая: “Бурхан: ‘Тэнгэрийн доорх ус нэг дор цуглаж, хуурай газар гарч ирэг’ гэсэн.” Бурхан зүгээр л “Тэнгэрийн доорх ус нэг дор цуглаж, хуурай газар гарч ирэг” гэж хэлсний дараа ямар өөрчлөлтүүд гарсан бэ? Гэрэл болон огторгуйгаас гадна энэ орон зайд бас юу байсан бэ? Бичвэрүүдэд: “Ингээд Бурхан хуурай газрыг Газар; хурсан их усыг Тэрээр Далай хэмээн нэрлэв: Бурханыг харахад энэ нь сайн байлаа” гэж бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл, одоо энэ орон зайд газар, далай бий болсон ба хуурай газар, далай хоёр тусгаарлагджээ. Эдгээр шинэ зүйлийн илрэлт нь Бурханы амнаас гарсан тушаалын улмаас “энэ нь ёсоор болов.” Бурхан үүнийг хийх зууpаа завгүй тэвдэж байсан хэмээн Бичвэрүүдэд дүрсэлсэн үү? Энд Түүнийг биеийн хүчний ажил хийж байгаагаар дүрсэлсэн үү? Тэгвэл, Бурхан энэ бүхнийг хэрхэн хийсэн юм бэ? Бурхан эдгээр шинэ зүйлийг хэрхэн бий болгосон юм бэ? Энэ бүхнийг гүйцэлдүүлж, бүхнийг бүтээхийн тулд Бурхан үг ашигласан гэдэг нь илэрхий юм.

Дээрх гурван эшлэлээс бид гурван агуу үйл явдал тохиолдсоныг мэдэж авсан. Энэ гурван агуу үйл явдал Бурханы үгээр дамжин илрэн гарч, бий болсон бөгөөд Түүний үгээс үүдэн эхлэж дараалан Бурханы нүдний өмнө гарч ирсэн. Тиймээс “Бурхан үг хэлдэг ба энэ нь биелэх болно; Тэр тушаадаг ба энэ нь оршин тогтнох болно” гэдэг нь хий хоосон үг биш гэдгийг харж болно. Бурханы энэ мөн чанар нь Түүнд бодол төрсөн мөчид баталгааждаг ба Бурханыг үг хэлэхээр амаа нээх үед мөн чанар нь бүрэн тусгагддаг.

Энэ эшлэлийн сүүлийн өгүүлбэрийг үргэлжлүүлэн уншицгаая: “Бурхан: ‘газар нь ногоон өвс, үрт ургамал ногоо болон газарт үрээ гөвдөг үр жимст модыг төрөл төрлөөр нь ургуулаг’ гэхэд хэлсэн ёсоор нь болов.” Бурханыг үг хэлж байх зуур энэ бүх зүйл Бурханы бодлыг даган бий болж, агшин зуурын дотор янз бүрийн өчүүхэн жаахан амьд биетүүд газрын хөрснөөс дэнжгэнэн толгойгоо цухуйлгаж эхэлсэн ба бие дээрх шороогоо сэгсэрч унагахаасаа ч өмнө өөр хоорондоо баяртайгаар даллан мэндэлж, дэлхий ертөнц рүү толгой дохин, инээмсэглэж байсан. Тэд өөрсдөд нь амь хайрласан Бүтээгчид талархаж, бүх зүйлийн нэг хэсэг гэдгээ, мөн дор бүрнээ Бүтээгчийн эрх мэдлийг харуулахын тулд өөрсдийн амийг зориулна гэдгээ дэлхий ертөнцөд зарласан юм. Бурхан үгээ хэлэхэд газар үржил шимтэй, ногоон болж, хүний таашааж болох бүх төрлийн хүнсний ногоо газрыг зүсэн соёолж, уул тал ой хөвчөөр шигүү бүрхэгдсэн… Амийн ямар ч ул мөргүй байсан үржил шимгүй энэ дэлхий элбэг арвин өвс ургамал, мод бутаар хурдацтай бүрхэгдэж, ногоон ургамлаар бялхаж байсан… Өвсний анхилуун үнэр болон

хөрсний таатай үнэр агаарт түгж, төрөл бүрийн ургамал агаарын урсгалтай зэрэгцэн амьсгалж, ургах үйл явцаа эхлүүлсэн. Үүний зэрэгцээ Бурханы үгийн ачаар, Бурханы бодлыг даган бүх ургамал ургаж, цэцэглэж, жимсэлж, үрждэг амьдралын тасралтгүй мөчлөгийг эхлүүлжээ. Тэд тус тусын амийн замналаа чандлан мөрдөж, бүх зүйлийн дунд тус бүрийн үүргээ гүйцэтгэж эхэлсэн юм… Тэд бүгд Бүтээгчийн үгээс үүдэн төрж, амьдарсан. Тэд Бүтээгчээс дуусашгүй хангалт, тэжээл хүлээн авч, Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлыг харуулахын тулд газар дэлхийн өнцөг булан бүрд үргэлж цөхрөлтгүйгээр амьд үлдэж, Бүтээгчийн хайрласан амийн хүчийг үргэлж харуулж байлаа…

Бүтээгчийн амь нь ер бусын, бодол нь ер бусын, эрх мэдэл нь ч ер бусын байдаг, иймээс Түүнийг үг хэлэх үед эцсийн үр дүн нь “хэлсэн ёсоор нь болов.” Мэдээж Бурхан үйлдэл хийхдээ гараа гарган ажиллах хэрэггүй байдаг; Тэр зүгээр л удирдахын тулд Өөрийн бодлыг, тушаахын тулд Өөрийн үгийг ашигладаг бөгөөд ийм маягаар аливаа зүйл биелдэг. Энэ өдөр Бурхан усыг нэг газар хуримтлуулж, хуурай газрыг ил гаргасан, үүний дараа Бурхан газраас өвс ногоо, үрлэгч хүнсний ногоо, үр жимстэй моддыг ургуулсан бөгөөд Бурхан тэдгээрийг төрөл төрлөөр нь ангилан, тус бүрийг нь үрээ тээдэг болгосон. Энэ бүхэн нь Бурханы бодлын дагуу, мөн Бурханы үгийн тушаалын дагуу биелж, дор бүрнээ ээлж дараалан энэ шинэ дэлхийд бий болсон.

Өөрийн ажлыг хараахан эхлээгүй байх үедээ Бурхан хүрэх гэж зорьсон зүйлийнхээ дүр зургийг аль хэдийн сэтгэлдээ буулгасан байсан ба эдгээр зүйлийг биелүүлж эхлэн, мөн энэ дүр зургийн агуулгыг хэлэх гэж амаа нээх үед Бурханы эрх мэдэл, хүч чадлын ачаар бүх зүйлд өөрчлөлт гарч эхэлсэн. Бурхан үүнийг хэрхэн хийж, эсвэл Өөрийн эрх мэдлийг хэрхэн хэрэгжүүлснээс үл хамааран, бүгд Бурханы төлөвлөгөөний дагуу, Бурханы үгээс үүдэн алхам алхмаар биелж, Бурханы үг болон эрх мэдлийн ачаар тэнгэр газрын хооронд алхам алхмаар өөрчлөлт гарсан юм. Энэ бүх өөрчлөлт, үүсэл хөгжил нь Бүтээгчийн эрх мэдлийг болон Бүтээгчийн амийн хүч чадлын ер бусын агаад агуу байдлыг харуулсан юм. Түүний бодол нь энгийн санаа, эсвэл хоосон дүр зураг биш, харин амин чанар, ер бусын эрч хүчийг агуулсан эрх мэдэл бөгөөд тэдгээр нь бүх зүйлийг өөрчлөгдөж, сэргэж, шинэчлэгдэж, мөхөхөд хүргэдэг хүч чадал билээ. Иймээс бүх зүйл Түүний бодлоос үүдэн чиг үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ Түүний амнаас гарсан үгээс болж биелдэг…

Бүх зүйл гарч ирэхээс өмнө Бурханы бодолд бүрэн төгс төлөвлөгөө аль хэдийн бүрэлдэж, шинэ дэлхий аль хэдийн биелсэн байсан юм. Хэдийгээр гурав дахь өдөр газар дээр бүх төрлийн ургамал гарч ирсэн ч энэ дэлхийг бүтээх алхмуудаа зогсоох ямар ч шалтгаан Бурханд байгаагүй; Тэр үгээ үргэлжлүүлэн хэлж, шинэ зүйл болгоны бүтээлийг үргэлжлүүлэн гүйцэлдүүлэхээр зорьсон. Тэр үг хэлж, Өөрийн тушаалыг буулгаж, эрх мэдлээ хэрэгжүүлж, хүч чадлаа харуулахаар зорьж байсан бөгөөд Өөрийн бүтээхээр зорьсон бүх зүйл болон хүн төрөлхтөнд зориулан бэлдэхээр төлөвлөсөн бүх зүйлийг бэлдэж байсан юм…

Дөрөв дэх өдөр, Бурханыг эрх мэдлээ дахин нэг удаа хэрэгжүүлэхэд хүн төрөлхтний улирал, өдөр, жил бий болжээ

Бүтээгч төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ үгээ ашигласан бөгөөд Түүний төлөвлөгөөний эхний гурван өдөр энэ мэтчилэн өнгөрөв. Энэ гурван өдрийн туршид Бурхан завгүй юм уу ядарсан харагдаагүй; харин ч эсрэгээрээ Тэр төлөвлөгөөнийхөө эхний гурван өдрийг гайхалтай өнгөрөөгөөд, дэлхий ертөнцийг эрс өөрчлөх агуу үйл хэргийг гүйцэлдүүлсэн. Түүний нүдний өмнө цоо шинэ ертөнц бий болж, Түүний бодол дотор битүүмжлэгдэн байсан үзэсгэлэнт дүр зураг эцэст нь Бурханы үгээр хэсэг хэсгээрээ илчлэгдсэн юм. Бий болж буй шинэ зүйл бүр нь яг л шинээр төрж буй нярай хүүхэд мэт байсан бөгөөд нэгэнтээ оюун бодолд нь байсан боловч одоо амилсан байгаа дүр зураг Бүтээгчид таатай байлаа. Энэ үед Түүний зүрх сэтгэлд өчүүхэн ч гэсэн сэтгэл ханамж төрсөн боловч Түүний төлөвлөгөө дөнгөж эхэлж байв. Нүд ирмэхийн зуурт шинэ өдөр ирлээ—Бүтээгчийн төлөвлөгөөний дараагийн хуудас юу байсан бэ? Тэр юу гэж хэлсэн бэ? Тэр эрх мэдлээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ? Мөн энэ зуур, энэ шинэ дэлхий дээр ямар шинэ зүйлс бий болсон бэ? Бүтээгчийн удирдамжаар, Бурхан бүх зүйлийг бүтээсэн дөрөв дэх өдөр буюу бас нэгэн цоо шинэ эхлэлийн өдөр дээр бидний хараа туслаа. Мэдээж Бүтээгчийн хувьд энэ нь бас нэгэн гайхамшигт өдөр байсан нь эргэлзээгүй ба өнөөгийн хүн төрөлхтний хувьд бас нэг туйлын чухал өдөр байлаа. Энэ өдөр мэдээж хэмжээлшгүй үнэ цэнтэй байсан юм. Яагаад гайхамшигтай, яагаад тийм чухал, мөн яагаад хэмжээлшгүй үнэ цэнтэй байсан бэ? Эхлээд бид Бүтээгчийн хэлсэн үгийг сонсоцгооё…

“Бурхан: ‘Өдрийг шөнөөс салгахын тулд огторгуйн мандалд гэрэлтүүлэгчид бий болог; эдгээр нь тэмдэг, улирал, өдөр ба жилд зориулагдаг: Тэдгээр нь газрыг гэрэлтүүлдэг огторгуйн мандал дахь гэрэл байг’ хэмээв” (Эхлэл 1:14–15). Энэ нь, хуурай газар болоод үүн дээрх өвс ургамлыг бүтээснийхээ дараа Бурханы бүтээлүүдээр дамжуулан харуулсан эрх мэдлийнх нь өөр нэгэн хэрэгжилт байв. Бурханы хувьд ийм үйл нь урьд өмнө хийж байсантай нь адил амархан байсан, учир нь Бурханд тийм хүч чадал бий; Бурхан үгэндээ хүрдэг бөгөөд Түүний үг биелэх болно. Бурхан тэнгэрт гэрэлтүүлэгч бий болохыг тушаасан ба эдгээр гэрэлтүүлэгч нь тэнгэр, газар дээр гэрэлтээд зогсохгүй өдөр шөнө, улирал, хоног, жилийн тэмдэг болжээ. Ийм маягаар, Бурханы үгээ хэлэхэд гүйцэлдүүлэхийг хүссэн үйл бүр нь Бурханы зорьсон ёсоор, Бурханы тогтоосон байдлаар биелсэн юм.

Тэнгэр дэх гэрэлтүүлэгчид нь гэрэл цацруулж чаддаг тэнгэр дэх зүйл юм; тэдгээр нь тэнгэрт гэрэлтэж, хуурай газар, тэнгис далайг гийгүүлж чаддаг. Тэд Бурханы тушаасан хэмнэл, давтамжийн дагуу эргэлдэж, газрыг өөр өөр цаг хугацаанд гэрэлтүүлдэг ба энэ маягаар гэрэлтүүлэгчдийн эргэлдэх мөчлөгөөр газрын баруун, зүүн зүгт өдөр шөнө бий болдог, мөн тэдгээр нь өдөр шөнийн тэмдэг болоод зогсохгүй, эдгээр өөр өөр мөчлөгөөр дамжуулан хүн төрөлхтний баяр

наадам, төрөл бүрийн онцгой өдрүүдийг тэмдэглэдэг. Тэдгээр нь Бурханы бүтээсэн хавар, зун, намар, өвөл гэсэн дөрвөн улирлын төгс чимэг, хослол бөгөөд эдгээртэй хамт гэрэлтүүлэгчид хүн төрөлхтний сарны тоолол, өдөр, жилийн тогтмол, үнэн зөв тэмдэг болон зохицон үйлчилдэг. Хэдийгээр газар тариалан дөнгөж үүссэний дараа л хүмүүс Бурханы бүтээсэн гэрэлтүүлэгчдээс үүдсэн сарны тоолол, өдөр, жилийг ойлгож, тэдгээртэй тулгарч эхэлсэн боловч үнэндээ өнөөдөр хүмүүсийн ойлгодог сарны тоолол, өдөр, жил нь аль эрт Бурхан бүх зүйлийг бүтээсэн дөрөв дэх өдөрт бий болсон бөгөөд хүмүүсийн мэдэрч туулдаг хавар, зун, намар, өвлийн ээлжлэн солигддог мөчлөг ч гэсэн аль эрт Бурхан бүх зүйлийг бүтээсэн дөрөв дэх өдрөөс үүсэж эхэлсэн юм. Бурханы бүтээсэн гэрэлтүүлэгчид нь хүнд өдөр шөнийг тогтмол, яв цав, тодорхой ялгаж, хоног өдрийг тоолж, сарны тоолол болон жилийг тодорхой бүртгэх боломжийг олгосон. (Тэргэл сартай өдөр нэг сар дууссаны илэрхийлэл байв, эндээс хүн гэрэлтүүлэгчдийн гэрэл шинэ мөчлөгийг эхлүүлдгийг мэдэж авсан; тал сартай өдөр нь нэг сар дундаа орсны илэрхийлэл байв, эндээс хүн сарны шинэ тоолол эхэлснийг мэдэж, сарны тоололд хэдэн өдөр, хэдэн шөнө байдгийг, нэг улиралд хэдэн сарны тоолол байдгийг, нэг жилд хэдэн улирал байдгийг тооцоолж болдог байсан бөгөөд бүх илчлэл нь гайхалтай зүй тогтолтой байсан.) Иймээс, хүн төрөлхтөн гэрэлтүүлэгчдийн тойрог замын эргэлтээр тэмдэглэгддэг сарны тоолол, өдөр, жилийг амархан бүртгэж чаддаг байв. Энэ мөчөөс эхлээд хүн төрөлхтөн болон бүх зүйл гэрэлтүүлэгчдийн тойрог замын эргэлтээр үүсэх эмх цэгцтэйгээр солигдох өдөр шөнө болон ээлжлэх улирлуудыг элээн өөрийн ухамсаргүйгээр амьдарсан юм. Бүтээгч дөрөв дэх өдөр гэрэлтүүлэгчдийг бүтээсний ач холбогдол энэ байлаа. Үүний адилаар, Бүтээгчийн энэ үйлдлийнх нь зорилго болон ач холбогдол эрх мэдэл, хүч чадлаас нь мөн л салшгүй холбоотой байсан юм. Иймээс Бурханы бүтээсэн гэрэлтүүлэгчид болон тэдгээрийн хүнд авчрах үнэ цэн нь Бүтээгчийн эрх мэдлийн хэрэгжилтийн бас нэгэн агуу бүтээл байсан билээ.

Хүн төрөлхтөн хараахан гарч ирээгүй байсан энэ шинэ дэлхийд удахгүй бүтээх гэж буй шинэ амьдаа зориулан Бүтээгч үдэш ба өглөө, огторгуй, газар ба далай тэнгис, өвс ургамал, хүнсний ногоо ба төрөл бүрийн мод, гэрэлтүүлэгчид, улирал, өдөр хоног, жилийг бэлтгэсэн юм. Бүтээсэн шинэ зүйл бүр нь Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлыг илэрхийлж байсан бөгөөд Түүний үг, бүтээмж хоёр өчүүхэн ч зөрөхгүйгээр, өчүүхэн төдий ч цагийн зөрүүгүйгээр тохиож байлаа. Эдгээр шинэ зүйлийн илрэлт болон үүсэл нь Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлын баталгаа байсан: Тэр үгэндээ хүрдэг бөгөөд Түүний үг биелэх болно, мөн биелсэн зүйл нь үүрд үргэлжилнэ. Энэ баримт хэзээ ч өөрчлөгдөөгүй: энэ нь урьд нь ч ийм байсан, өнөөдөр ч ийм байгаа ба үүрд мөнхөд ийм байх болно. Бичвэрийн эдгээр үгийг дахин нэг харахад та нарт шинэлэг санагдаж байна уу? Та нар шинэ агуулгыг харж, шинэ нээлт хийв үү? Тэгсэн бол Бүтээгчийн үйл хэрэг та нарын зүрх сэтгэлийг хөдөлгөж, та нарыг Өөрийн эрх мэдэл, хүч чадлын талаарх мэдлэг рүү чиглүүлж,

Бүтээгчийг ойлгох ойлголтын чинь үүдийг нээж, Түүний үйл хэрэг, эрх мэдэл эдгээр үгэнд амь хайрласнаас болж байгаа юм. Иймээс хүн эдгээр үгээс Бүтээгчийн эрх мэдлийн бодитой, тод томруун илэрхийллийг харж, Бүтээгчийн дээд эрхийг бодитоор харж, Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлын ер бусын байдлыг харсан.

Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадал гайхамшгийг ар араас нь бүтээж, Тэр хүмүүсийн анхаарлыг татдаг бөгөөд Түүний эрх мэдлийн хэрэгжилтээс үүдсэн гайхалтай үйл хэргийг хүн өөрийн эрхгүй зогтусан ширтдэг. Түүний ер бусын хүч чадал баяр хөөрийг ар араас нь авчирдаг бөгөөд хүмүүсийн нүд баясаж, хөөрөн баярладаг, шагшин гайхсандаа уулга алдаж, бахдан биширч, уухайлдаг; цаашлаад хүний сэтгэл илт хөдлөн, түүнд хүндлэл, бишрэл, татагдах сэтгэл төрдөг. Бүтээгчийн эрх мэдэл болон үйл хэрэг нь хүний сүнсэнд асар их нөлөө үзүүлж, хүний сүнсийг цэвэрлэж, цаашлаад хүний сүнсийг цатгадаг. Түүний бодол нэг бүр, айлдвар нэг бүр, эрх мэдлийнх нь илчлэл бүр бүх зүйлийн дундах сор бүтээл бөгөөд бүтээгдсэн хүн төрөлхтний гүн гүнзгий ойлгож, мэдэх ёстой хамгийн үнэ цэнтэй агуу ажил хэрэг юм. Бид Бүтээгчийн үгээс үүссэн бүтээл бүрийг тоолох үед сүнс маань Бурханы хүч чадлын гайхамшигт татагдан өөрийн мэдэлгүйгээр Бүтээгчийн мөрийг дагаж, удаах өдөр буюу Бурханы бүх зүйлийг бүтээсэн тав дахь өдөр лүү хүрч ирсэн.

Бүтээгчийн өөр олон үйл хэргийг харах зуур Бичвэрийг хэсэг, хэсгээр нь үргэлжлүүлэн уншицгаая.

Тав дахь өдөр, янз бүрийн хэлбэртэй амь Бүтээгчийн эрх мэдлийг өөр өөр байдлаар харуулсан

Бичвэрт, “Бурхан: ‘Уснууд амьд амьтдаар бялхаж, жигүүртэн шувууд газар дээгүүр, тэнгэр огторгуйд нисэг’ гэв. Тэгээд Бурхан аварга загас ба усанд үржин амьдардаг бүхий л амьтдыг төрөл төрлөөр нь бүтээгээд дараа нь жигүүртэн шувуудыг төрөл төрлөөр нь бүтээв: Бурханыг харахад энэ нь сайн байлаа” (Эхлэл 1:20–21) гэж байдаг. Энэ өдөр Бурхан усан дахь амьтад болон агаар дахь шувуудыг бүтээсэн, өөрөөр хэлбэл Тэр янз бүрийн загас, шувуудыг бүтээж, тэдгээрийг дор бүрд нь төрөл төрлөөр нь ангилсан гэдгийг Бичвэр бидэнд тодорхой өгүүлдэг. Энэ маягаар газар, тэнгэр болон ус Бурханы бүтээлийн улмаас баяжжээ…

Бурханыг үгээ хэлэхэд дор бүрнээ өөр өөр хэлбэртэй цоо шинэ амь Бүтээгчийг үгээ хэлэх зуур даруй амь орж байв. Тэд байраа олох гэж түлхэлцэн, үсрэн харайж, баяр хөөртэйгөөр наадан тоглож, энэ дэлхий дээр ирсэн юм… Бүх төрлийн загас усан дотор сүлжилдэж, бүх төрлийн дун элснээс гарч ирж, хайрстай, хясаатай, сээр нуруугүй амьтад том, жижиг, урт богино янз бүрийн хэлбэртэйгээр яаран бий болж байв. Мөн олон төрлийн далайн замаг шаламгай гэгч нь ургаж, олон янзын усны амьтдын хөдөлгөөнд найган далбаганаж: Хурдал! Найз нөхдөө авчир! Учир нь чи хэзээ ч дахин ганцаардахгүй! гэж хэлж буй мэт тогтоол усыг шавдуулж байлаа. Бурханы бүтээсэн олон янзын амьтад усанд гарч ирсэн мөчөөс эхлээд цоо шинэ амь бүр, асар урт удаан хугацаанд тогтонги байсан усанд эрч хүч авчирч, шинэ

эрин үеийг урин залжээ… Тэр үеэс хойш тэд бие биеэ түшиж, бие биедээ хань болж, үй зайгүй болцгоожээ. Дотроо буй амьтдын төлөө ус оршин тогтнож, өвөрт нь оршдог амь бүрийг тэжээн тэтгэсэн бөгөөд шим тэжээлтэй болохоор нь усны төлөө амь бүхэн оршин тогтносон юм. Тэд бүгд бие биедээ амь хайрлаж, үүний зэрэгцээ бүгд ийм маягаар Бүтээгчийн бүтээлийн гайхалтай, агуу байдал болон Бүтээгчийн эрх мэдлийн давшгүй их хүч чадлыг гэрчилж байлаа…

Далай тэнгис цаашид нам гүм байхаа больж, тэнгэр ч гэсэн хөөр хөгжөөнтэй болж эхэлсэн. Том, жижиг шувууд нэг нэгээрээ газраас тэнгэрт хөөрөн ниссэн юм. Тэнгисийн амьтдаас ялгаатай нь тэд даль жигүүртэй, мөн туяхан, уян налархай биеийг нь бүрхсэн өд сөдтэй байв. Тэд далавчаа дэрвэлзүүлэн, Бүтээгчийн хайрласан гоёмсог өдөн хүрэм болон өөрийн онцгой чиг үүрэг, ур чадварыг бахархалтай, ихэмсгээр харуулж байлаа. Тэд эрх чөлөөтэйгөөр халин дүүлж, тэнгэр газрын хооронд, өвст тал, ой хөвчийг дамнан чадварлагаар хэрэн ниссэн… Тэд агаарын хайртай амьтад, бүх зүйлийн хайрыг татсан амьтад байсан билээ. Тэд удалгүй тэнгэр газар хоорондын холбоо болж, бүх зүйлд мэдээ дамжуулдаг байсан юм… Тэд дуулан жиргэж, баяр хөөртэйгөөр халин нисэж, нэгэнтээ хоосон байсан энэхүү дэлхий ертөнцөд баяр баясал, инээд хөөр, эрч хүчийг авчирсан билээ… Тэд өөрсдөд нь амь хайрласных нь төлөө Бүтээгчийг магтахын тулд зүрх сэтгэл доторх үгээ хэрэглэж, цээлхэн, уянгалаг жиргээгээ ашиглажээ. Тэд Бүтээгчийн бүтээлийн төгс агаад ер бусын байдлыг харуулахын тулд баяр хөөртэйгөөр бүжсэн бөгөөд өөрсдөд нь Түүний хайрласан онцгой амиар дамжуулан Бүтээгчийн эрх мэдэлд гэрчлэл хийхийн төлөө бүхий л амьдралаа зориулдаг байлаа…

Усанд байна уу, тэнгэрт байна уу хамаагүй, энэхүү элбэг олон амьд биет нь Бүтээгчийн тушааснаар амьдралын өөр өөр хэлбэртэйгээр оршин тогтнож, Бүтээгчийн тушааснаар тус тусын төрөл зүйлийнхээ дагуу цугларсан бөгөөд энэ хууль, энэ дүрмийг ямар ч бүтээл өөрчлөх аргагүй байсан. Тэд Бүтээгчийн өөрсдөд нь тогтоож өгсөн хил хязгаарыг хэзээ ч давж зүрхлээгүй, тэгэх чадвар ч тэдэнд байгаагүй. Өнөөдрийг хүртэл тэд Бүтээгчийн тушаасан ёсоор амьдарч, өсөн үржиж, Бүтээгчийн тэдэнд тогтоож өгсөн амьдралын замнал, хууль дүрмийг чанд мөрдөж, тэдэнд өгсөн үгээр илэрхийлээгүй тушаал болон тэнгэрлэг зарлиг, зааврыг нь ухамсарлан дагасан юм. Тэд өөрсдийн тусгай аргаар Бүтээгчтэй ярилцаж, Бүтээгчийн санаа зорилгыг ойлгож эхэлсэн бөгөөд Түүний тушаалыг дуулгавартай дагасан юм. Бүтээгчийн эрх мэдлийг хэн ч, хэзээ ч зөрчиж байгаагүй бөгөөд тэднийг захирах дээд эрх, тушаал нь Түүний бодол дотор хэрэгждэг байсан; нэг ч үг хэлдэггүй байсан боловч Бүтээгчийн цор ганц эрх мэдэл хүн төрөлхтнөөс ялгаатай, хэл яриа эзэмшээгүй бүх зүйлийг аниргүйд хянадаг байсан. Эрх мэдлээ ийм онцгой байдлаар хэрэгжүүлсэн нь хүнд Бүтээгчийн цор ганц эрх мэдлийн талаар шинэ мэдлэг олгож, шинэ тайллыг нээж өгсөн юм. Энэ шинэ өдөр Бүтээгч эрх мэдлээ хэрэгжүүлснээрээ Өөрийн цорын ганц чанарыг дахин нэгэнтээ харуулсан гэдгийг энд Би та нарт хэлэх ёстой.

Одоо бичвэрийн энэ эшлэлийн сүүлийн өгүүлбэрийг харцгаая: “Бурханыг харахад энэ нь сайн байлаа.” Энэ нь юу гэсэн үг гэж та нар бодож байна вэ? Энэ үгэнд Бурханы сэтгэл санааны байдал багтсан байдаг. Өөрийн үгээс улбаалан бүтээсэн бүх зүйл нь бий болж, бат зогсож, аажмаар өөрчлөгдөж эхлэхийг Бурхан харсан. Энэ үед Бурхан үгээрээ бүтээсэн янз бүрийн зүйлдээ, гүйцэлдүүлсэн олон янзын үйлдэлдээ сэтгэл хангалуун байсан уу? “Бурханыг харахад энэ нь сайн байлаа” гэдэг нь үүний хариулт юм. Та нар эндээс юу харж байна вэ? “Бурханыг харахад энэ нь сайн байлаа” гэдэг нь юуг төлөөлж байна вэ? Энэ юуг бэлгэдэж байна вэ? Энэ нь, төлөвлөж тушаасан зүйлээ биелүүлж, хүрэх гэж зорьсон зорилгодоо хүрэх хүч чадал, мэргэн ухаан Бурханд байсан гэсэн үг юм. Бурхан ажил бүрээ гүйцэлдүүлчхээд харамссан уу? Хариулт нь мөн л “Бурханыг харахад энэ нь сайн байлаа” гэдэг юм. Өөрөөр хэлбэл, Тэр харамсаагүйгээр үл барам, харин ч сэтгэл хангалуун байсан. Тэр харамсаагүй гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь, Бурханы төлөвлөгөө бол төгс, мөн хүч чадал, мэргэн ухаан нь төгс бөгөөд Түүний эрх мэдэл л тийм төгс байдлыг биелүүлж чадах цорын ганц эх сурвалж гэсэн үг юм. Хүн ямар нэг зүйлийг биелүүлэх үедээ Бурханы адилаар тэр нь сайн байлаа гэж хэлж болох уу? Хүний хийдэг бүх зүйл төгс болж чаддаг уу? Хүн аливаа зүйлийг нэгмөсөн гүйцэлдүүлж чаддаг уу? “Төгс зүйл гэж үгүй, харин илүү дээр зүйл л гэж байдаг” гэж хүмүүс хэлдэгчлэн хүний хийдэг юу ч төгс болж чаддаггүй. Хийсэн, биелүүлсэн бүхэн нь сайн байсныг Бурхан харах үед Бурханы бүтээсэн бүхэн Түүний үгээр болсон, өөрөөр хэлбэл, “Бурханыг харахад энэ нь сайн байх” үед Түүний бүтээсэн бүхэн тогтсон хэлбэр дүрсээ олж, өөрсдийн төрлөөр ангилагдан, эцсийн тогтсон орон байр, хэрэгцээ болон чиг үүрэг нь өгөгдсөн гэсэн үг юм. Түүнчлэн, тэдний бүх зүйлийн дунд гүйцэтгэх үүрэг болон бүх зүйлийг удирдах Бурханы удирдлагын үеэр туулах ёстой аян зам нь Бурханаар аль хэдийн урьдчилан тогтоогдсон бөгөөд үүрд хувиршгүй юм. Бүтээгчийн бүх зүйлд өгсөн тэнгэрлэг хууль энэ байлаа.

“Бурханыг харахад энэ нь сайн байлаа” хэмээх энэхүү энгийн бөгөөд дутуу үнэлэгдсэн, ихэвчлэн үл ойшоогддог үг нь Бурханаас бүх бүтээлд өгсөн тэнгэрлэг хууль, тэнгэрлэг зарлиг юм. Энэ үг нь Бүтээгчийн эрх мэдлийн илүү бодитой, илүү гүн гүнзгий өөр нэгэн биелэл юм. Бүтээгч үгээрээ дамжуулан олж авах гэж зорьсон бүхнээ олж авч, хүрэх гэж зорьсон бүхэндээ хүрч чадсанаар зогсохгүй бүтээсэн бүхнээ гартаа хянаж, Өөрийн эрх мэдэл дор захирч чадсан, цаашлаад энэ бүхэн нь дэг журамтай, тогтмол байсан. Бүх зүйл Түүний үгээр өсөн үржиж, оршин тогтнож, устаж үгүй болсон төдийгүй Түүний эрх мэдлийн хүчинд тэд Түүний тогтоосон хуулийн дунд оршин тогтносон бөгөөд үүнээс ангид ямар ч зүйл байгаагүй юм! Энэ хууль нь “Бурханыг харахад энэ нь сайн байх” яг тэр мөчид эхэлсэн бөгөөд Бүтээгчийн хүчингүй болгох өдөр хүртэл Бурханы удирдлагын төлөвлөгөөний төлөө оршин тогтнож, үргэлжилж, чиг үүргээ гүйцэтгэх болно! Бүтээгчийн цор ганц эрх мэдэл нь бүх зүйлийг бүтээж, бүх зүйлд бий болохыг

тушаах чадвараар нь илрээд зогсохгүй, бүх зүйлийг удирдаж захирах, бүх зүйлд амийн эрч хүчийг хайрлах, цаашлаад төлөвлөгөөнийхөө дагуу бүтээх бүх зүйлээ Өөрийн бүтээсэн дэлхийд төгс хэлбэр, төгс амийн бүтэц, төгс үүрэгтэйгээр нэгмөсөн гарч ирж, оршин тогтноход хүргэх Түүний чадвараар илэрсэн. Энэ нь мөн Бүтээгчийн бодол ямар ч хориг хязгаарт баригддаггүй, цаг хугацаа, орон зай, газар зүйд хязгаарлагддаггүй байдлаар илэрсэн. Эрх мэдлийнх нь адилаар Бүтээгчийн цор ганц ялгамж чанар ч мөнхөөс мөнхөд үл өөрчлөгдөнө. Түүний эрх мэдэл үргэлж цор ганц ялгамж чанарынх нь төлөөлөл, бэлгэ тэмдэг байх бөгөөд Түүний эрх мэдэл ялгамж чанартай нь зэрэгцэн үүрд мөнх орших болно!

Зургаа дахь өдөр, Бүтээгчийг үгээ хэлмэгц Түүний оюун санаан дахь төрөл бүрийн амьтад ээлж дараалан гарч ирсэн

Бүх зүйлийг бүтээх Бүтээгчийн ажил таван өдөр анзаарагдалгүй үргэлжилсэн ба үүний дараа Бүтээгч бүх зүйлийг бүтээх зургаа дахь өдрөө даруй угтан авсан. Энэ өдөр нь өөр нэг шинэ эхлэл, бас нэгэн ер бусын өдөр байсан юм. Тэгвэл энэ шинэ өдөр ирэхийн өмнө Бүтээгчийн ямар төлөвлөгөөтэй байсан бэ? Ямар шинэ бүтээлүүдийг Тэр бий болгож, бүтээх гэж байсан бэ? Сонс, тэр бол Бүтээгчийн дуу хоолой юм…

“Бурхан: ‘Газар дэлхий амьтдыг төрөл төрлөөр нь бий болгож, мал амьтан, мөлхөгчид, зэрлэг араатан амьтдыг төрөл төрлөөр нь бий болгог’ гэсэнд тэр нь ёсоор болов. Дараа нь газрын араатан амьтад төрөл төрлөөрөө бүтээгдэж, мал адгуус, газар дээр мөлхдөг хорхой шавж төрөл төрлөөрөө бүтээгдэв. Бурханыг харахад тэр нь сайн байлаа” (Эхлэл 1:24–25). Үүнд ямар амьтад багтаж байна вэ? Бичвэрт: мал амьтан, хорхой шавж болон газрын зэрлэг амьтад төрөл төрлөөрөө гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, энэ өдөр газар дээр бүх төрлийн амьтад бий болоод зогсохгүй, тэдгээр нь бүгд төрөл төрлөөрөө ангилагдсан ба бас “Бурханыг харахад энэ нь сайн байлаа.”

Бүтээгч өмнөх таван өдрийнхтэйгөө адил өнгөөр ярьж, Өөрийн хүссэн амьтдыг төрөхийг тушаасан ба тэдгээр нь газар дээр төрөл төрлөөрөө гарч ирсэн. Бүтээгч эрх мэдлээ хэрэгжүүлэх үед Түүний хэлсэн ямар ч үг талаар болдоггүй учир зургаа дахь өдөр Түүний бүтээхээр зорьсон амьтан бүр заасан цагт гарч ирсэн юм. Бүтээгчийг “Газар дэлхий амьтдыг төрөл төрлөөр нь бий болгог” хэмээн хэлэхэд, газар дэлхий тэр дороо амьдралаар дүүрч, газар дээр бүх төрлийн амьтдын амьсгал гэнэт гарч иржээ… Зүлэгт ногоон атар талд тарган үхрүүд сүүлээ шарван ар араасаа гарч ирж, хоньд майлан сүрэглэн бэлчиж, морьд янцгаан давхилдаж эхэлсэн юм… Анир чимээгүй уудам ногоон тал тэр дороо амьдралаар бялхжээ… Эдгээр янз бүрийн мал амьтан гарч ирсэн нь тогтуун хээр тал дээрх үзэсгэлэнт дүр зураг байсан бөгөөд хязгааргүй эрч хүчийг авчирсан юм… Эдгээр нь хээр талын хань, хээр талын эзэн болж, бүгд бие биеэсээ харилцан хамааралтай байна; мөн тэд хээр талын хамгаалагч, сахиул нь болох бөгөөд хээр тал ч тэдний байнгын

нутаг болж, тэднийг хэрэгтэй бүхнээр хангаж, оршихуйг нь мөнхөд тэжээн тэтгэх эх үүсвэр нь байх болно…

Эдгээр төрөл бүрийн мал амьтан Бүтээгчийн үгээр бий болсон тэр өдөр үй олон шавж хорхой бас ар араасаа гарч ирсэн. Тэд бүх бүтээлийн дундаас хамгийн жижигхэн амьтад байсан боловч амийн хүч нь мөн л Бүтээгчийн гайхамшигт бүтээл байсан бөгөөд хэт оройтож ирээгүй билээ… Зарим нь жаахан далавчаа дэвж байхад, өөр нэг нь аажмаар мөлхөж байсан; зарим нь дэвхэрч, харайж, нөгөө нь найган ганхаж байлаа; зарим нь урагш шаламгай хөдөлж байхад бусад нь хурднаар ухарч байв; зарим нь хажуу тийш хөдөлж байхад, өөр бусад нь өндөр нам үсэрч байв… Бүгд гэр орноо олох гэж чармайн, завгүй байлаа: Зарим нь өвс рүү шурган орж, зарим нь газар нүхлэхээр зүтгэж, нөгөө хэсэг нь мод руу нисэж, ой шугуйд бүгжээ… Тэд хэдийгээр жижиг ч гэсэн гэдэс хоосон байхын зовлон амсахыг хүсээгүй бөгөөд амьдрах газраа олсныхоо дараа идэх хоол хүнсээ эрж хайхаар яарчээ. Зарим нь зөөлөн навч идэх гэж өвсөнд авирч, зарим нь амаараа дүүрэн шороо үмхэж залгин ходоод руугаа оруулж, тун их дуршил, тааламжтайгаар иджээ (тэдний хувьд шороо хүртэл амттай зоог юм); зарим нь ойд бүгсэн боловч гялалзсан хар ногоон навчны шүүс нь шимтэй хоол болж байсан тул тэд амрах гэж зогссонгүй… Цадсаныхаа дараа ч гэсэн шавжууд хөдөлгөөнөө зогсоогоогүй юм; тэд хэдийгээр биеэр жижиг ч гэсэн асар их эрч хүч, хязгааргүй тамир тэнхээтэй байсан тул бүх бүтээлээс хамгийн идэвхтэй, хамгийн хөдөлмөрч нь юм. Тэд хэзээ ч залхуурч, амрахыг эрхэмлэж байсангүй. Ходоод гэдэс нь цадангуутаа тэд ирээдүйнхээ төлөө мөн л шаргуу хөдөлмөрлөж, маргаашийнхаа төлөө, амьд үлдэхийн төлөө борви бохисхийх чөлөөгүй, яаран зүтгэж байлаа… Тэд өөрсдийгөө шавдуулж, зоригжуулахын тулд олон янзын айзам хэмнэлт эгшгийг намуухан аялж байсан. Түүнчлэн өвс ногоо, ой хөвч, хөрсний ямх бүрд баяр хөөр нэмж, өдөр бүр, жил болгоныг онцгой болгож байсан билээ… Өөрсдийн хэл болон өөрсдийн аргаар тэд газар дээрх бүх амьтанд мэдээлэл дамжуулдаг байсан. Мөн амьдралынхаа онцгой замналыг ашиглан бүх зүйл дээр ул мөрөө үлдээж тэмдэглэсэн юм… Тэд хөрс шороо, өвс ногоо, ой хөвчтэй дотно холбоотой байсан бөгөөд хөрс шороо, өвс ногоо, ой хөвчид эрч хүч, амин чанарыг авчирч, бүх амьтанд Бүтээгчийн захиас, мэндчилгээг хүргэсэн билээ…

Бүтээгчийн харц бүтээсэн бүх зүйлийнхээ дээгүүр хараа бэлчээх энэ мөчид харц нь ой хөвч, уул нурууд дээр саатаж, оюун санаа нь эргэлдэж байлаа. Түүнийг үгээ айлдахад, өтгөн ой шугуй болон уул нуруудад урьд өмнө гарч ирж байгаагүй амьтад гарч ирэв: Тэдгээр нь Бурханы амаар хэлэгдсэн зэрлэг амьтад байлаа. Оройтож гарч ирсэн тэд толгойгоо сэгсэрч, сүүлээ шарвацгааж, дор бүрнээ дахин давтагдашгүй зүстэй байлаа. Зарим нь үслэг арьстай, зарим нь хуягтай, зарим нь ярзайсан соёотой, бас зарим нь ярзайтал инээсэн, зарим нь урт хүзүүтэй, зарим нь оготор сүүлтэй, зарим нь догшин нүдтэй, зарим нь аймхай харцтай, зарим нь өвс идэхээр бөхийж байхад, зарим нь амандаа цустай, зарим нь хоёр хөл дээрээ

дэгдэж, зарим нь дөрвөн туурайгаараа алхалж, зарим нь модны оройгоос алсын бараа ширтэж, зарим нь ой модон дотор отон хэвтэж, зарим нь амрах агуй хайж, зарим нь тал газар хөгжилдөн давхиж, зарим нь ойд гэтэж байв…; зарим нь архирч, зарим нь ульж, зарим нь хуцаж, зарим нь орилж байлаа…; зарим нь нарийн, зарим нь баргил хоолойтой, зарим нь цээлхэн, зарим нь тод уянгалаг дуутай байсан…; зарим нь догшин, зарим нь хөөрхөн, зарим нь ой гутам, зарим нь өхөөрдөм, зарим нь аймаар, зарим нь хайр татам гэнэн байсан… Тэд нэг нэгээрээ гарч ирсэн. Тэд ямар сүрлэг бөгөөд хүчирхэг, эрх чөлөөтэй, бие биеэ зүгээр л үл хайхран, нэг нэгнээ зэрвэс ч харахгүй байгааг хараач… Тэд дор бүрнээ Бүтээгчийн онцгойлон хайрласан амийг болон зэрлэг, догшин байдлаа хадгалж, ой шугуй, уул нуруудад гарч ирсэн. Бүхнийг үл ойшоогч, туйлын эзэрхэг тэд эцсийн эцэст уул нурууд, ой хөвчийн жинхэнэ эзэд байсан. Гарч ирэхийг нь Бүтээгч тушаасан мөчөөс эхлээд тэд ой мод, уул нуруудад “эзэн суусан”, учир нь Бүтээгч аль хэдийн тэдний хил хязгаарыг тогтоож, оршихуйнх нь цар хүрээг тодорхойлсон юм. Зөвхөн тэд уул нурууд, ой хөвчийн жинхэнэ эзэд байсан, ийм ч учраас тэд маш зэрлэг, дээрэнгүй байсан юм. Тэднийг “зэрлэг амьтан” хэмээн нэрийдсэн нь ердөө л тэд бүх бүтээлүүдээс үнэхээр зэрлэг, догшин, номхоршгүй байсанд оршино. Тэднийг гаршуулж болдоггүй тул өсгөж үржүүлж болдоггүй, тэд хүн төрөлхтөнтэй эв найртай амьдарч, хүн төрөлхтний төлөө хөдөлмөрлөж чаддаггүй байсан. Тэднийг өсгөж үржүүлж болдоггүй байсан учраас тэд хүн төрөлхтний төлөө ажиллаж чадаагүй бөгөөд хүн төрөлхтнөөс хол амьдрах ёстой болж, хүн тэдэнд ойртож чаддаггүй байсан. Нэгэнт тэд хүн төрөлхтнөөс хол амьдарч, хүмүүс тэдэнд ойртож чаддаггүй байсан учраас Бүтээгчийн хайрласан үүрэг буюу уул нурууд, ой хөвчийг манах үүргээ биелүүлж чадсан. Тэдний зэрлэг байдал уул нуруудыг хамгаалж, ой хөвчийг манаж байсан бөгөөд энэ нь тэдний оршин тогтнол, үржлийн хамгийн сайн хамгаалалт, баталгаа байсан. Үүний зэрэгцээ тэдний зэрлэг байдал нь бүх зүйлийн дундах тэнцвэрийг хадгалж, баталгаажуулсан. Тэд ирсэн нь уул нурууд, ой хөвчид тусламж дэмжлэг, түшиг тулгуур авчирсан; тэд ирсэн нь онгон зэлүүд уул нурууд, ой хөвчийг хязгааргүй их эрч хүч, амин чанараар сэлбэсэн. Энэ үеэс хойш уул нурууд болон ой хөвч тэдний байнгын нутаг болсон бөгөөд уул нурууд болон ой хөвч тэдний төлөө бий болж, оршиж буй тул тэд гэр орноо хэзээ ч алдахгүй болсон; зэрлэг амьтад үүргээ биелүүлж, уул нурууд болон ой хөвчийг сахин хамгаалахын тулд чадах бүхнээ хийдэг. Түүнчлэн газар нутгаа хадгалж үлдэхийн тулд зэрлэг амьтад ч гэсэн Бүтээгчийн сургамжийг чанд сахисан бөгөөд Бүтээгчийн байгуулсан бүх зүйлийн тэнцвэрийг хадгалж, Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлыг харуулахын тулд араатны уг чанараа цаашид ашигласаар байх болно!

Бүтээгчийн эрх мэдлийн дор бүх зүйл төгс байдаг

Жигүүртэн шувууд, загас жараахай, мод, цэцэг гэх мэт хөдөлдөг болон хөдөлдөггүй зүйлс, мөн зургаа дахь өдөр бүтээсэн мал амьтан, хорхой шавж,

зэрлэг амьтад зэрэг Бурханы бүтээсэн бүх зүйл—Бурханы хувьд бүгд сайн байсан төдийгүй Бурханы нүдээр эдгээр зүйл төлөвлөгөөнийх нь дагуу бүгд төгс байдлын оргилд хүрч, Бурханы хүрэх гэсэн стандартад хүрсэн юм. Бүтээгч хийхээр зорьсон ажлаа Өөрийн төлөвлөгөөний дагуу алхам алхмаар хийсэн. Түүний бүтээхээр зорьсон зүйлс ар араасаа бий болсон бөгөөд тус бүрийнх нь илрэлт Бүтээгчийн эрх мэдлийн тусгал, биелэл байсан, эдгээр биеллээс үүдэн бүх бүтээл, Бүтээгчийн нигүүлсэл, хангалтад өөрийн эрхгүй талархаж байв. Бурханы гайхамшигт үйл хэргийн улмаас энэ дэлхий ертөнц хэсэг хэсгээрээ Бурханы бүтээсэн бүх зүйлээр дүүрч, эмх замбараагүй, харанхуй байснаа цэвэр тунгалаг, гэрэл гэгээтэй болж, үхсэн мэт анир чимээгүй байснаа хөл хөдөлгөөнтэй, хязгааргүй эрч хүчтэй болж өөрчлөгдсөн юм. Томоос жижиг, жижгээс бичил хүртэлх бүтээгдсэн бүх зүйл дундаас Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлаар бүтээгдээгүй нэг ч зүйл байгаагүй ба бүтээл бүрийн оршин тогтнолд цорын ганц, төрөлх хэрэгцээ, үнэ цэн байв. Хэлбэр, бүтэц дэх ялгаанаасаа үл хамааран тэд Бүтээгчээр л бүтээгдсэн бол Бүтээгчийн эрх мэдэл дор оршин тогтноно. Заримдаа хүмүүс үзэшгүй муухай шавж хараад, “Энэ шавж үнэхээр муухай юм, ийм муухай зүйлийг Бурхан бүтээсэн байх учиргүй—Тэр ийм муухай зүйл бүтээнэ гэж байхгүй” гэж хэлнэ. Ямар мунхаг бодол вэ! Тэд “Энэ шавж маш муухай ч гэсэн Бурхан бүтээсэн болохоор өөрийн гэсэн өвөрмөц зорилготой л байх ёстой” гэж хэлэх ёстой. Бурхан бодохдоо бүтээсэн төрөл бүрийн амьд зүйлдээ бүхий л янзын дүр төрх, бүх төрлийн чиг үүрэг болон хэрэглээг өгөхөөр зорьсон тул Бурханы бүтээсэн зүйлсээс аль нь ч нэг хэвд цутгагдаагүй. Тэдний гадна талаас эхлээд дотоод бүтэц нь, амьдрах зуршлаас нь эхлээд оршин суудаг газар нутаг нь—дор бүрнээ өөр өөр байдаг. Үхэр нь үхрийн дүр төрхтэй, илжиг нь илжигний дүр төрхтэй, буга нь бугын төрхтэй, заан нь зааны төрхтэй байдаг. Аль нь хамгийн үзэсгэлэнтэй, аль нь хамгийн үзэшгүй муухай гэдгийг чи хэлж чадах уу? Аль нь хамгийн хэрэгтэй, алиных нь оршин тогтнол хамгийн хэрэгцээгүй гэдгийг чи хэлж чадах уу? Зарим хүнд зааны харагдах байдал таалагддаг боловч талбайд үр суулгахдаа хэн ч зааныг ашигладаггүй; бүх зүйлийн дотроос хамгийн сүрлэг дүр төрхтэй болохоор нь зарим хүн арслан, барын харагдах байдалд дуртай байдаг хэдий ч чи тэднийг гэрийн тэжээвэр амьтан болгож чадах уу? Товчхондоо, бүх зүйлийн тухайд хүмүүс Бүтээгчийн эрх мэдлийг дагах ёстой, өөрөөр хэлбэл, бүх зүйлд оноосон Бүтээгчийн хуулийг дагах ёстой; энэ бол хамгийн ухаалаг хандлага юм. Бүтээгчийн анхдагч санаа зорилгыг хайж, үүнд дуулгавартай байх хандлага нь л Бүтээгчийн эрх мэдлийг үнэхээр хүлээн зөвшөөрч, бат итгэж буй явдал билээ. Бурханд энэ нь сайн байсан учраас үүнээс өө хайх ямар шалтгаан хүнд байгаа юм бэ?

Тиймээс Бүтээгчийн эрх мэдэл дор байгаа бүх зүйл Бүтээгчийн дээд эрхийн төлөө шинэ найрал хөгжмийг тоглож, Түүний шинэ өдрийн ажлын гайхалтай удиртгалыг эхлүүлэх ба энэ мөчид Бүтээгч мөн удирдлагын ажлынхаа шинэ хуудсыг нээх болно! Бүтээгчийн тогтоосон хаврын нахиалж, зуны боловсорч,

намрын ургац хурааж, өвлийн нөөцлөх тухай хуулийн дагуу бүх зүйл Бүтээгчийн удирдлагын төлөвлөгөөтэй хамт цуурайтаж, өөрсдийн шинэ өдөр, шинэ эхлэл болон амьдралын шинэ замналыг угтаж, Бүтээгчийн эрх мэдлийн дээд эрхэн дор өдөр бүрийг угтахын тулд эцэс төгсгөлгүйгээр үе залгамжлан үржих болно…

Бүтээгдсэн болон бүтээгдсэн бус зүйлсийн юу ч Бүтээгчийн ялгамж чанарыг орлож чадахгүй

Бүх зүйлийг бүтээж эхэлснээс хойш Бурханы хүч чадал илэрхийлэгдэж, илчлэгдэж эхэлсэн, учир нь Бурхан бүх зүйлийг бүтээхдээ үг ашигласан. Тэр тэднийг ямар байдлаар, яагаад бүтээсэн нь хамаагүй, бүх зүйл Бурханы үгийн ачаар бий болж, бат зогсож, оршин тогтносон бөгөөд энэ бол Бүтээгчийн цорын ганц эрх мэдэл юм. Хүн төрөлхтөн дэлхий дээр гарч ирэхээс өмнөх хугацаанд Бүтээгч, хүн төрөлхтний төлөө бүх зүйлийг бүтээхийн тулд хүч чадал, эрх мэдлээ хэрэглэж, хүн төрөлхтөнд тохирох амьдралын орчныг бэлтгэхийн тулд цор ганц арга барилаа ашигласан. Түүний хийсэн бүхэн удалгүй амьсгалыг нь хүлээн авах хүн төрөлхтөнд зориулсан бэлтгэл байв. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтнийг бүтээхээс өмнөх хугацаанд Бурханы эрх мэдэл тэнгэр, гэрэл, тэнгис далай, хуурай газар зэрэг агуу том зүйлс болон ан амьтан, жигүүртэн шувууд, бүх төрлийн шавж, бичил биетэн, тэр дундаа хүний нүдэнд харагдахгүй олон янзын нян гэх мэт өчүүхэн жижиг зүйлс зэрэг хүн төрөлхтнөөс бусад бүх бүтээл дээр илэрсэн юм. Бүтээгчийн үгээр амьд үлддэггүй юу ч үгүй, Бүтээгчийн үгээр өсөж үрждэггүй юу ч байхгүй, мөн Бүтээгчийн үгийн захиралт дор амьдардаггүй юу ч үгүй. Тэд Бүтээгчийн амьсгалыг хүлээн аваагүй ч гэсэн өөр өөр хэлбэр дүрс, бүтцээрээ Бүтээгчийн өөрсдөд нь хайрласан амийн эрч хүчийг харуулж байсан; тэд хүн төрөлхтөнд өгсөнтэй нь адил ярих чадварыг Бүтээгчээс хүлээн аваагүй боловч Бүтээгчийн хайрласан хүний хэлээс ялгаатайгаар амийг илэрхийлэх аргыг дор бүрнээ хүлээн авсан байв. Бүтээгчийн эрх мэдэл илэрхий хөдөлгөөнгүй материаллаг зүйлсэд амийн эрч хүчийг өгдөг, тиймээс тэд хэзээ ч алга болдоггүй, түүнчлэн бүх амьд зүйлд үржиж олшрох зөн мэдрэмж өгдөг, тиймээс тэд хэзээ ч устдаггүй, ийнхүү тэд Бүтээгчийн олгосон оршин тогтнох хууль, зарчмыг үеэс үед уламжлах болно. Бүтээгч эрх мэдлээ хэрэгжүүлдэг байдал нь макро эсвэл микро үзэл бодлыг хатуу чанд баримталдаггүй бөгөөд энэ нь ямар ч хэлбэрээр хязгаарлагддаггүй; Тэр орчлон ертөнцийн үйл ажиллагааг захирч, мөн бүх зүйлийн амьдрал, үхлийг захирч чадах ба цаашлаад Өөртөө үйлчлүүлэхийн тулд бүх зүйлийг удирдан жолоодож чаддаг; Тэр уул нурууд, гол нуурын бүх ажиллагааг зохицуулж, тэдгээрийн доторх бүх зүйлийг захирч чаддаг, түүнчлэн бүх зүйлийг хэрэгтэй зүйлээр нь хангаж чаддаг. Энэ бол хүн төрөлхтнөөс бусад бүх зүйлийн дундах Бүтээгчийн цорын ганц эрх мэдлийн илрэл юм. Энэ нь нэг амьдралын туршид л илэрдэггүй, энэ хэзээ ч зогсож, амрахгүй бөгөөд ямар ч хүн болон зүйл өөрчилж, сэвтээж чадахгүй, бас ямар ч хүн, зүйл нэмж, хорогдуулж чадахгүй—учир

нь Бүтээгчийн ялгамж чанарыг хэн ч орлож чадахгүй, тиймээс Бүтээгчийн эрх мэдлийг ямар ч бүтээгдсэн зүйл орлож чадахгүй ба ямар ч бүтээгдсэн бус зүйл үүнд хүрэх аргагүй юм. Жишээ нь, Бурханы элч, тэнгэрэлч нарыг авч үзье. Тэд Бүтээгчийн эрх мэдлийг эзэмших нь бүү хэл Бурханы хүч чадлыг ч эзэмшдэггүй. Тэдэнд Бурханы хүч чадал, эрх мэдэл байдаггүйн шалтгаан бол тэд Бүтээгчийн мөн чанарыг эзэмшдэггүйгээс нь үүдэлтэй. Бурханы элчүүд болон тэнгэрэлчүүд гэх зэрэг бүтээгдсэн бус зүйлс хэдийгээр Бурханы өмнөөс зарим зүйлийг хийж чадах боловч Бурханыг төлөөлж чадахгүй. Тэд хүний эзэмшдэггүй зарим нэг хүч чадлыг эзэмшдэг ч гэсэн Бурханы эрх мэдлийг эзэмшдэггүй, тэд бүх зүйлийг бүтээх, бүх зүйлийг удирдах, бүх зүйлийг захирах Бурханы эрх мэдлийг эзэмшдэггүй. Иймээс Бурханы цор ганц байдлыг бүтээгдсэн бус ямар ч зүйл орлож чадахгүй, үүний адилаар Бурханы эрх мэдэл, хүч чадлыг ч бүтээгдсэн бус ямар ч зүйл орлож чадахгүй. Бурханы хэн нэг элч бүх зүйлийг бүтээсэн гэж чи Библиэс харсан уу? Бүх зүйлийг бүтээхийн тулд Бурхан яагаад Өөрийн элчүүд, эсвэл тэнгэрэлчүүдийг илгээгээгүй вэ? Тэд Бурханы эрх мэдлийг эзэмшдэггүй байсан учраас Бурханы эрх мэдлийг хэрэгжүүлэх чадваргүй байсан. Бүх бүтээлийн адилаар тэд бүгд Бүтээгчийн дээд эрх, Бүтээгчийн эрх мэдэл дор байдаг ба иймээс Бүтээгч мөн л тэдний Бурхан, тэдний Захирагч билээ. Сурвалжит ч бай, дорд ч бай, хүч чадал нь их ч бай, бага ч бай хамаагүй, тэд бүгдийн дотроос Бүтээгчийн эрх мэдлийг даван гарах нэг ч зүйл байхгүй, иймд тэдний дотроос нэг нь ч Бүтээгчийн ялгамж чанарыг орлож чадахгүй. Тэд хэзээ ч Бурхан гэж нэрлэгдэхгүй ба хэзээ ч Бүтээгч болж чадахгүй. Энэ бол хувиршгүй үнэн агаад бодит баримт юм!

Дээрх нөхөрлөлөөр дамжуулан бид дараах зүйлийг баталж болно: цорын ганц эрх мэдэл, цорын ганц хүч чадлыг эзэмшсэн бүх зүйлийн Бүтээгч ба Захирагчийг л цор ганц Бурхан Өөрөө гэж нэрлэж болох уу? Одоо та нарт миний асуулт хэтэрхий гүн гүнзгий санагдаж магадгүй. Одоохондоо та нар үүнийг ойлгох чадваргүй, доторх мөн чанарыг ч ойлгож чадахгүй байгаа, иймээс энэ мөчид та нарт үүнд хариулах хэцүү санагдаж байгаа. Энэ тохиолдолд Би нөхөрлөлөө үргэлжлүүлэх болно. Дараа нь Би Бурханы ганцаараа эзэмшдэг эрх мэдэл, хүч чадлын олон талын бодит үйл хэргийг харах боломжийг та нарт олгоно, тэгснээр Бурханы цор ганц байдлыг, мөн Бурханы цор ганц эрх мэдэл гэдэг нь юу гэсэн үг болохыг үнэхээр ухамсарлаж, ойлгож, мэдэж авах боломжийг олгоно.

2. Хүнтэй гэрээ байгуулахын тулд Бурхан Өөрийн үгийг ашигласан

Эхлэл 9:11–13 Би та нартай гэрээ байгуулах ба мах цустай бүхнийг дахиж үерийн усаар устгахгүй; газар дэлхийг сүйрүүлэх үер дахиад болохгүй. Тэгээд Бурхан: “Миний та нартай болон та нартай хамт байгаа амьд амьтан болгонтой үеийн үед хийх гэрээний тэмдэг нь энэ: Би үүлэнд солонго татуулах ба энэ нь дэлхий бид хоёрын хоорондын гэрээний тэмдэг байх болно” гэв.

Бүх зүйлийг бүтээснийх нь дараа Бүтээгчийн эрх мэдэл солонгон гэрээнд дахин нэг удаа батлагдаж, харагдсан юм

Бүтээгчийн эрх мэдэл нь бүх бүтээлийн дунд хэзээд харагдаж, хэрэгждэг ба Тэр бүх зүйлийн хувь заяаг захираад зогсохгүй, өөр өөр амийн бүтцийг эзэмшиж, өөр өөр амийн хэлбэртэйгээр оршдог, Өөрийн гараар бүтээсэн онцгой бүтээл болох хүн төрөлхтнийг захирдаг юм. Бүх зүйлийг бүтээснийхээ дараа Бүтээгч эрх мэдэл, хүч чадлаа илэрхийлэхээ зогсоогоогүй; Түүний хувьд бол бүх зүйл, бүх хүн төрөлхтний хувь заяаг захирч байсан эрх мэдэл нь Өөрийнх нь гараас хүн төрөлхтөн үнэхээр төрөх тэр үед л албан ёсоор эхэлсэн юм. Тэр хүн төрөлхтнийг удирдаж, захирахаар зорьсон, Тэр хүн төрөлхтнийг аварч, үнэхээр олж авч, бүх зүйлийг удирдаж чадах хүн төрөлхтнийг олж авахаар зорьсон бөгөөд ийм хүн төрөлхтнийг эрх мэдлийнхээ дор амьдруулж, эрх мэдлийг нь мэддэг, дуулгавартай дагадаг болгохоор зорьсон юм. Тиймээс Бурхан Өөрийн үгийг ашиглан хүмүүсийн дунд эрх мэдлээ албан ёсоор илэрхийлж, үгээ биелүүлэхийн тулд эрх мэдлээ ашиглаж эхэлсэн. Мэдээж, энэ үйл явцад Бурханы эрх мэдэл бүхий л газарт харагдсан; гэхдээ Би ердөө л тодорхой, олонд танигдсан зарим жишээг сонгосон ба та нар эдгээрээс Бурханы цор ганц байдлыг ойлгон мэдэж, Бурханы цор ганц эрх мэдлийг ойлгож, мэдэж болох юм.

Эхлэл 9:11–13 дэх эшлэл болон Бурхан дэлхийг бүтээсэн тухай тэмдэглэсэн дээрх эшлэлүүдийн хооронд төстэй тал байдаг боловч ялгаатай тал бас бий. Төстэй тал нь юу вэ? Бурхан зорьсон зүйлээ хийхийн тулд үг ашигладагт төстэй тал нь оршдог бол ялгаатай тал нь энэ эшлэл Бурханы хүнтэй хийсэн яриа бөгөөд үүгээрээ хүнтэй гэрээ байгуулж, гэрээнд агуулагдсан зүйлийн тухай хүнд хэлсэн явдал юм. Энэ удаа Бурханы эрх мэдлийн хэрэгжилт нь Бурхан хүн хоёрын яриагаар дамжин биелсэн юм, өөрөөр хэлбэл, хүн төрөлхтнийг бүтээхээс өмнөх Бурханы үг нь бүтээх гэж зорьсон бүтээлүүддээ өгсөн заавар, тушаал байсан. Харин нэгэнт Бурханы үгийг сонсох хүн байсан учраас Түүний үг нь хүнтэй ярилцах яриа, мөн хүнд өгсөн сануулга, сэрэмжлүүлэг байсан төдийгүй, цаашлаад Түүний эрх мэдлийг агуулсан, бүх зүйлд хүргэсэн тушаал байсан.

Энэ эшлэлд Бурханы ямар үйлдэл тэмдэглэгдсэн бэ? Үүнд дэлхийг үерээр сүйрүүлснийхээ дараа Бурханы хүнтэй байгуулсан гэрээг тэмдэглэсэн бөгөөд Бурхан энэ дэлхийд дахин тийм сүйрэл авчрахгүй, тиймдээ ч Бурхан тэмдэг хийсэн гэдгийг хүнд хэлдэг—энэ тэмдэг нь юу байсан бэ? Бичвэрт “Би үүлэнд солонго татуулах ба энэ нь дэлхий бид хоёрын хоорондын гэрээний тэмдэг байх болно” гэсэн байдаг. Эдгээр нь Бүтээгчийн анх хүн төрөлхтөнд хэлсэн үг юм. Тэр эдгээр үгийг хэлэхэд хүний нүдний өмнө солонго бий болсон бөгөөд өнөөдөр ч солонго оршсоор байгаа билээ. Бүх хүн тийм солонгыг харсан, тэгвэл солонгыг харах үедээ чи хэрхэн гарч ирдгийг нь мэддэг үү? Шинжлэх ухаан үүнийг баталж, эх үүсвэрийг нь тогтоож, эсвэл хаана байдгийг нь тодорхойлж чадахгүй. Учир нь солонго бол

Бүтээгч болон хүний хооронд хийгдсэн гэрээний тэмдэг юм; үүнд ямар ч шинжлэх ухааны үндэслэл хэрэггүй, үүнийг хүн хийгээгүй, мөн хүн үүнийг өөрчлөх чадваргүй. Энэ нь үгээ хэлснийх нь дараах Бүтээгчийн эрх мэдлийн үргэлжлэл юм. Хүнтэй байгуулсан Өөрийн гэрээ болон Өөрийн амлалтыг биелүүлэхийн тулд Бүтээгч Өөрийн гэсэн онцгой аргыг ашигласан, иймээс Өөрийн байгуулсан гэрээний тэмдэг болгон солонгыг ашигласан, энэ нь Бүтээгчийн хувьд ч, эсвэл бүтээгдсэн хүн төрөлхтний хувьд ч үүрд мөнх хувиршгүй үлдэх тэнгэрийн зарлиг, хууль билээ. Гэсэн ч энэ хувиршгүй хууль нь бүх зүйлийг бүтээсний дараах Бүтээгчийн эрх мэдлийн өөр нэг жинхэнэ илрэл юм гэдгийг хэлэх ёстой бөгөөд Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадал нь хязгааргүй гэдгийг хэлэх ёстой; солонгыг тэмдэг болгон хэрэглэсэн нь Бүтээгчийн эрх мэдлийн үргэлжлэл болон өргөжилт юм. Энэ нь Бурханы үгээ ашиглан хийсэн өөр нэгэн үйл байсан бөгөөд үг ашиглан хүнтэй байгуулсан гэрээнийх нь тэмдэг байв. Тэр юу хийхээр шийдсэнээ болон үүнийг ямар байдлаар хэрэгжүүлж, биелүүлэх тухайгаа хүнд хэлсэн бөгөөд ийм маягаар Бурханы амнаас гарсан үгийн дагуу энэ нь биелсэн. Зөвхөн Бурхан л ийм хүч чадлыг эзэмшдэг ба Тэр эдгээр үгийг хэлснээс хойш хэдэн мянган жилийн дараа, өнөөдөр ч хүмүүс Бурханы амаар хэлэгдсэн солонгыг харж чадна. Бурханы айлдсан тэдгээр үгийн ачаар энэ зүйл өнөөдрийг хүртэл хувирч, өөрчлөгдөлгүй үлдсэн. Хэн ч энэ солонгыг алга болгож чадахгүй, хэн ч үүний хуулийг өөрчилж чадахгүй бөгөөд энэ нь гагцхүү Бурханы үгийн төлөө оршдог. Үүнийг л Бурханы эрх мэдэл гээд байгаа юм. “Бурхан үгэндээ хүрдэг бөгөөд Түүний үг биелнэ, тэгээд биелсэн зүйл нь үүрд мөнх үргэлжлэх болно.” Ийм үг энд тодорхой харагддаг бөгөөд энэ нь Бурханы эрх мэдэл, хүч чадлын тодорхой тэмдэг, шинж чанар юм. Ийм тэмдэг, шинж чанар ямар ч бүтээгдсэн зүйлд байдаггүй, тэдний алинаас ч харагддаггүй, бүтээгдсэн бус ямар нэг зүйлээс ч харагддаггүй. Энэ нь зөвхөн цор ганц Бурханд харьяалагддаг ба гагцхүү Бурханы эзэмшдэг ялгамж чанар, мөн чанарыг бүтээлүүдийнхээс ялгадаг. Үүний зэрэгцээ энэ нь бас, Бурханаас Өөрөөс нь өөр, бүтээгдсэн юм уу бүтээгдсэн бус ямар ч зүйлсийн хэзээ ч даван гарч чадахааргүй тэмдэг болон шинж чанар юм.

Бурхан хүнтэй гэрээ байгуулсан нь асар чухал үйл явдал байсан. Тэр үүгээр дамжуулан хүнд нэг баримтыг болон Өөрийн хүслийг хэлсэн юм. Бурхан энэ зорилгодоо хүрэхийн тулд өвөрмөц арга барил хэрэглэж, хүнтэй гэрээ байгуулахад онцгой тэмдэг ашигласан ба энэ тэмдэг нь Түүний хүнтэй байгуулсан гэрээний амлалт байлаа. Тэгвэл, энэ гэрээг байгуулсан нь агуу үйл явдал байсан уу? Яг хэр агуу байсан бэ? Үүнд л энэ гэрээний маш онцгой чанар оршдог юм: Энэ нь хоёр хүн, хоёр бүлэг, хоёр улсын хооронд байгуулсан гэрээ бус, харин Бүтээгч, бүх хүн төрөлхтний хооронд байгуулсан гэрээ бөгөөд Бүтээгч бүх зүйлийг эцэслэх хүртэл хүчинтэй хэвээр байх болно. Энэ гэрээг хэрэгжүүлэгч нь Бүтээгч, үүнийг сахиулагч нь ч бас Бүтээгч юм. Товчхондоо бол, хүн төрөлхтөнтэй байгуулсан солонгон гэрээ нь бүхэлдээ Бүтээгч, хүн төрөлхтний хоорондын ярианы дагуу хэрэгжиж, биелсэн

бөгөөд өнөөдрийг хүртэл энэ хэвээр байж ирсэн. Бүтээлүүд Бүтээгчийн эрх мэдэлд захирагдаж, дуулгавартай байж, итгэж, ойлгож, нүдээр үзэж, магтахаас өөр юу хийж чадах билээ? Учир нь цорын ганц Бурхан л ганцаараа тийм гэрээ байгуулах хүч чадлыг эзэмшдэг. Ахин дахин солонго татах нь хүн төрөлхтөнд зарлал тунхаглаж буй хэрэг бөгөөд энэ нь хүний анхаарлыг Бүтээгч болон хүн төрөлхтөн хоорондын гэрээнд хандуулдаг. Бүтээгч болон хүн төрөлхтний хоорондох гэрээний тогтмол илрэл болж хүн төрөлхтөнд харагддаг зүйл нь солонго бус, уг гэрээ ч бус, харин Бүтээгчийн хувиршгүй эрх мэдэл билээ. Ахин дахин солонго гарч ирэх нь Бүтээгчийн нуугдмал газар дахь агуу, гайхалтай үйл хэргийг илэрхийлдгийн зэрэгцээ хэзээ ч бөхөхгүй, хэзээ ч өөрчлөгдөхгүй Бүтээгчийн эрх мэдлийн эрч хүчтэй тусгал болдог. Энэ нь Бүтээгчийн цорын ганц эрх мэдлийн өөр нэг талын илрэл биш гэж үү?

3. Бурханы ерөөлүүд

Эхлэл 17:4–6 Харагтун, Миний хувьд чамтай гэрээ байгуулж, чи олон үндэстний эцэг болно. Үүнээс хойш чамайг Абрам гэж нэрлэхгүй, харин Абрахам гэх болно; учир нь Би чамайг олон үндэстний эцэг болгосон. Би чамайг өнөр өтгөн болгож, чамаас үндэстнүүдийг бий болгох бөгөөд хаад чамаас гарах болно.

Эхлэл 18:18–19 Абрахам гарцаагүй агуу, хүчирхэг үндэстэн болж, газар дэлхийн бүх үндэстэн түүгээр ерөөгдөнө. Учир нь өөрийнх нь араас үнэн зөв, шударгыг үйлдэж, Еховагийн замыг сахихыг тэр хүүхдүүд болон гэр бүлийнхэндээ тушаана гэдгийг Би мэддэг; ингэснээр Абрахамд амласан зүйлээ Ехова биелүүлж болох юм.

Эхлэл 22:16–18 Ехова: “Чи энэ зүйлийг хийж, цорын ганц хүүгээ харамлаагүй учраас Би Өөртөө тангараглаж байна: Би чамайг ерөөж, чиний үр удмыг тэнгэрийн од, далайн эрэг дээрх элс шиг олшруулна; чиний үр удам дайснуудынхаа үүд хаалгыг эзэгнэнэ; чи Миний дуу хоолойг дуулгавартай дагасан учир үр удмаар чинь газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөнө” гэлээ.

Иов 42:12 Иймээс Ехова Иовын сүүлчийн өдрүүдийг эхэн үеэс нь илүүгээр ерөөжээ: учир нь тэр арван дөрвөн мянган хонь, зургаан мянган тэмээ, нэг мянган буулгат хос шар, мөн нэг мянган эм илжигтэй байлаа.

Бүтээгчийн айлдварын өвөрмөц байдал болон шинж чанар нь Бүтээгчийн цор ганц ялгамж чанар болон эрх мэдлийн бэлгэ тэмдэг юм

Олон хүн Бурханы ерөөлийг эрж хайж, олж авахыг хүсдэг боловч эдгээр ерөөлийг хүн болгон олж авч чаддаггүй, учир нь Бурханд Өөрийн гэсэн зарчим байдаг бөгөөд Өөрийн гэх арга замаар хүмүүсийг ерөөдөг. Бурханы хүнд өгдөг амлалтууд болон хайрладаг нигүүлслийн хэмжээ нь хүний бодол, үйлдэл дээр үндэслэн хуваарилагддаг. Тэгвэл Бурханы ерөөл юу харуулдаг вэ? Хүмүүс тэндээс юу харж болох вэ? Одоохондоо, Бурхан ямар хүмүүсийг ерөөдөг тухай болон Бурхан хүнийг ерөөдөг зарчмыг хэлэлцэхээ түр хойш тавьцгаая. Үүний оронд,

Бурханы эрх мэдлийг мэдэх зорилгоор, Бурханы эрх мэдлийг мэдье гэсэн өнцгөөс Бурханы хүнийг ерөөх ерөөлийг харцгаая.

Бичвэр дээрх дөрвөн эшлэл нь бүгд Бурхан хүнийг ерөөсөн тухай тэмдэглэл юм. Тэдгээр нь Абрахам, Иов зэрэг Бурханы ерөөлийг хүртэгчдийн тухай, түүнчлэн Бурхан ерөөлөө хайрласан шалтгаан болон эдгээр ерөөл юу агуулж байсан тухай нарийвчилсан дүрслэлийг харуулдаг. Бурханы айлдварын өнгө, хэв маяг, хэлсэн өнцөг, байр суурь нь ерөөл хайрладаг Нэгэн болон ийм ерөөлийг хүртэгчид нь харваас өөр ялгамж чанар, байр суурь, мөн чанартай байдаг гэдгийг хүмүүст ойлгуулдаг. Эдгээр айлдварын өнгө, хэв маяг, хэлсэн байр суурь нь Бүтээгчийн ялгамж чанарыг эзэмшдэг Бурханд л ганцхан байдаг. Түүнд эрх мэдэл, сүр хүч, Бүтээгчийн нэр хүнд, түүнчлэн ямар ч хүний эргэлзээг тэвчдэггүй сүр жавхлан байдаг.

Эхлээд Эхлэл 17:4–6-г харцгаая: “Харагтун, Миний хувьд чамтай гэрээ байгуулж, чи олон үндэстний эцэг болно. Үүнээс хойш чамайг Абрам гэж нэрлэхгүй, харин Абрахам гэх болно; учир нь Би чамайг олон үндэстний эцэг болгосон. Би чамайг өнөр өтгөн болгож, чамаас үндэстнүүдийг бий болгох бөгөөд хаад чамаас гарах болно.” Эдгээр үг нь Бурханы Абрахамтай байгуулсан гэрээ, түүнчлэн Абрахамд өгсөн Бурханы ерөөл байсан: Бурхан Абрахамыг үндэстнүүдийн эцэг болгож, үр удмыг нь өнөр өтгөн болгож, түүнээс үндэстнүүдийг бий болгож, хаадыг гаргах байв. Чи эдгээр үгээс Бурханы эрх мэдлийг харж байна уу? Тийм эрх мэдлийг хэрхэн харж байна вэ? Бурханы эрх мэдлийн мөн чанарын аль талыг чи харж байна вэ? Эдгээр үгийг няхуур уншвал Бурханы эрх мэдэл, ялгамж чанар нь Бурханы айлдварт тодорхой илчлэгдсэн гэдгийг олж мэдэхэд амархан. Жишээлбэл, “чамтай гэрээ байгуулж, чи … болно, Би чамайг … болгосон. Би чамайг … болгох болно” гэж Бурхан хэлэх үед Бурханы ялгамж чанар, эрх мэдлийн баталгааг агуулсан “чи тэгэх болно” ба “Би тэгэх болно” гэх мэтийн хэллэг нь нэг талаараа Бүтээгчийн итгэмжит байдлын илрэл; нөгөө талаараа тэдгээр нь Бүтээгчийн ялгамж чанарыг эзэмшдэг Бурханы ашигладаг тусгай үгс—түүнчлэн уламжлалт үгсийн сангийн нэг хэсэг юм. Хэрэв хэн нэгэн хүн, өөр нэг хүний үр удам нь өнөр өтгөн болж, түүнээс үндэстнүүд бий болж, хаад гарна гэж найддагаа хэлбэл энэ нь нэг төрлийн хүсэл бөгөөд амлалт, ерөөл биш гэдэг нь эргэлзээгүй. Иймээс хүмүүс “Би чамайг ийм, тийм болгоно, чи ийм тийм болох болно,” гэж хэлж зүрхэлдэггүй, учир нь тэд ийм хүч чадал эзэмшдэггүйгээ мэднэ; энэ нь тэднээс шалтгаалдаггүй, ийм зүйл хэллээ ч гэсэн энэ нь хий хоосон, утгагүй, хүсэл санаархалд нь жолоодуулсан үг байх байсан. Хүслээ биелүүлж чадахгүй юм шиг санагдвал хэн ч бай, ийм сүрлэг өнгөөр ярьж зүрхэлнэ гэж үү? Хүн бүр л үр удамдаа сайн сайхныг хүсэж, чадварлаг болж, агуу амжилтад хүрээсэй гэж найддаг. “Нэг нь эзэн хаан болчихвол ямар сайхан агуу хувь заяа байх сан билээ! Нэг нь захирагч болбол, ер нь нэр нөлөөтэй хүн л болж байвал мөн л сайн хэрэг!” Эдгээр нь бүгд хүний хүсэл боловч хүмүүс үр удамдаа ерөөлийг л хүсдэг ба өөрсдийнхөө ямар ч амлалтыг хэрэгжүүлж, эсвэл биелүүлж чаддаггүй. Ийм зүйлийг биелүүлэх хүч

чадлыг эзэмшдэггүй гэдгээ хүн бүр зүрх сэтгэлдээ сайн мэддэг, учир нь тэдний бүх зүйл өөрсдийнх нь мэдлээс гадна байдаг байхад бусдын хувь заяаг яаж захирч чадах юм бэ? Харин Бурхан ийм үгийг хэлж чаддагийн шалтгаан гэвэл Бурхан ийм эрх мэдлийг эзэмшдэг бөгөөд хүнд өгдөг бүх амлалтаа хэрэгжүүлж, гүйцэтгэж, хүнд хайрласан бүх ерөөлөө биелүүлэх чадвартай. Хүнийг Бурхан бүтээсэн бөгөөд Бурханы хувьд хэн нэгнийг улам үржүүлэх нь хүүхдийн тоглоом төдий; хэн нэгний үр удмыг амжилтад хүргэхэд Түүний нэг үг л шаардлагатай. Тэр ийм зүйлийн төлөө хэзээ ч хөлсөө гоожтол ажиллаж, сэтгэлээ чилээж, үүнээс болж санаагаа зовоохгүй; энэ бол Бурханы жинхэнэ хүч чадал, жинхэнэ эрх мэдэл юм.

Эхлэл 18:18 дахь “Абрахам гарцаагүй агуу, хүчирхэг үндэстэн болж, газар дэлхийн бүх үндэстэн түүгээр ерөөгдөнө” гэдгийг уншсаны дараа та нар Бурханы эрх мэдлийг мэдэрч чадав уу? Бүтээгчийн ер бусын байдлыг мэдэрч чадав уу? Бүтээгчийн эрхэм дээд байдлыг мэдэрч чадав уу? Бурханы үг тодорхой байдаг. Бурхан амжилтдаа итгэсэндээ, үүнийгээ төлөөлүүлэхийнтулд ийм үг хэлдэггүй; харин тэдгээр нь Бурханы айлдварын эрх мэдлийн нотолгоо бөгөөд Бурханы үгийг хэрэгжүүлдэг тушаал юм. Энд та нарын анхаарах ёстой хоёр илэрхийлэл бий. Бурханы хэлсэн “Абрахам гарцаагүй агуу, хүчирхэг үндэстэн болж, газар дэлхийн бүх үндэстэн түүгээр ерөөгдөнө” хэмээх эдгээр үгэнд ямар нэгэн тодорхойгүй элемент байна уу? Санаа зовоох ямар нэгэн элемент байна уу? Айдсын ямар нэгэн элемент байна уу? Бурханы айлдвар дахь “гарцаагүй ингэх болно”, “тэгэх болно” гэсэн үгээс үүдэн, хүнд ялангуяа байдаг, хүнээс ихэвчлэн харагддаг эдгээр элемент нь Бүтээгчтэй хэзээ ч, ямар ч хамаатай байгаагүй юм. Бусдад сайн сайхныг хүсэхдээ хэн ч тийм үг ашиглаж зүрхлэхгүй, хэн ч ийм итгэлтэйгээр өөр нэгнийг агуу, хүчирхэг үндэстэн болгохоор ерөөж, газар дээрх бүх үндэстэн түүгээр ерөөгдөнө гэж амлаж зүрхлэхгүй. Бурханы үг хэдий чинээ тодорхой байна, ямар нэг зүйлийг төдий чинээ баталдаг—тэгвэл тэр зүйл нь юу вэ? Бурханд ийм эрх мэдэл байгаа бөгөөд Түүний эрх мэдэл эдгээр зүйлийг биелүүлж чадна, мөн эдгээрийн хэрэгжилт нь гарцаагүй юм гэдгийг энэ нь баталдаг. Бурхан Абрахамыг ерөөхдөө зүрх сэтгэлдээ өчүүхэн ч эргэлзээгүй, бүрэн итгэлтэй байсан. Цаашлаад энэ нь бүхэлдээ Түүний үгийн дагуу биелэх бөгөөд биелэлтийг нь ямар ч хүч өөрчилж, саад болж, сулруулж, үймүүлж чадахгүй юм. Юу ч тохиолдсон бай, Бурханы үгийн хэрэгжилт, биелэлтийг юу ч цуцалж, нөлөөлж чадахгүй. Энэ нь Бүтээгчийн амнаас гарсан үгийн жинхэнэ хүч бөгөөд хүний үгүйсгэлийг тэвчдэггүй Бүтээгчийн эрх мэдэл юм! Чи эдгээр үгийг уншчихаад эргэлзсээр л байна уу? Эдгээр үг Бурханы амнаас гарсан бөгөөд Бурханы үгэнд хүч чадал, сүр жавхлан, эрх мэдэл байдаг. Ийм сүр хүч, эрх мэдэл, бодит баримт хэрэгжих нь гарцаагүй байдалд бүтээгдсэн, бүтээгдсэн бус ямар ч зүйл хүрч чадахгүй бөгөөд бүтээгдсэн, бүтээгдсэн бус ямар ч зүйл үүнийг давах аргагүй. Бүтээгч л хүн төрөлхтөнтэй ийм өнгө, аялгатайгаар ярьж чадах бөгөөд Түүний амлалтууд нь хоосон үг, хий дэмий бардамнал биш, харин ямар ч хүн,

зүйл, эд юмсын давах аргагүй цор ганц эрх мэдлийн илэрхийлэл юм гэдгийг баримтууд нотолсон билээ.

Бурханы хэлсэн үг, хүний хэлсэн үг хоёрын ялгаа юу вэ? Чи Бурханы хэлсэн эдгээр үгийг уншихдаа Бурханы үгийн сүр хүч болон Бурханы эрх мэдлийг мэдэрдэг. Хүмүүс ийм үг хэлэх үед чамд ямар санагддаг вэ? Тэд туйлын биеэ тоосон, онгироо бөгөөд өөрсдийгөө гайхуулж байна гэж чамд боддог уу? Тэд ийм хүч чадалгүй учраас, ийм эрх мэдэл эзэмшдэггүй тул тийм зүйлсийг биелүүлэх ямар ч чадваргүй юм. Тэд амлалтдаа маш итгэлтэй байдаг нь үгэндээ хайхрамжгүй ханддагийг нь илтгэдэг. Хэн нэгэн хүн ийм үг хэлж байвал тэр гарцаагүй биеэ тоосон, өөртөө хэт итгэлтэй нэгэн байх бөгөөд тэргүүн тэнгэрэлчийн зан чанарын сонгодог жишээ гэдгээ үүгээрээ илчлэх болно. Эдгээр үг Бурханы амнаас гарсан; чи эндээс биеэ тоосон зангийн ямар нэг элементийг мэдэрч байна уу? Бурханы үг зүгээр л наргиан юм шиг чамд санагдаж байна уу? Бурханы үг бол эрх мэдэл, Бурханы үг бол баримт бөгөөд Түүний амнаас үг гарахаас өмнө, өөрөөр хэлбэл, Тэр ямар нэг зүйлийг хийх шийдвэр гаргах үед тухайн зүйл аль хэдийн биелсэн байдаг. Бурханы Абрахамд хэлсэн бүхэн нь Абрахамтай байгуулсан Бурханы гэрээ, Абрахамд өгсөн Бурханы амлалт байсан гэж хэлж болно. Эдгээр амлалт нь хүлээн зөвшөөрөгдсөн баримт, мөн хэрэгжсэн баримт байсан бөгөөд эдгээр баримт Бурханы төлөвлөгөөний дагуу Бурханы бодолд аажмаар гүйцэлдсэн. Иймээс Бурханы хувьд ийм үгсийг хэлэх нь Тэр биеэ тоосон зан чанартай гэсэн үг биш, учир нь Бурхан ийм зүйлсийг биелүүлэх чадвартай билээ. Түүнд ийм хүч чадал, эрх мэдэл байдаг бөгөөд эдгээр үйлийг биелүүлэх бүрэн чадвартай, мөн тэдгээрийн биелэлт нь бүхэлдээ Түүний чадварын хүрээнд оршдог. Бурханы амнаас иймэрхүү үг гарах үед Бурханы жинхэнэ зан чанарын илчлэл, илрэл, Бурханы мөн чанар, эрх мэдлийн төгс илчлэл, илрэл байдаг бөгөөд Бүтээгчийн ялгамж чанарыг нотлох үүнээс илүү тохиромжтой, зохистой юу ч үгүй. Ийм айлдварын өнгө, хэв маяг, хэллэг нь яг Бүтээгчийн ялгамж чанарыг илтгэдэг бөгөөд Бурханы ялгамж чанарын илэрхийлэлд төгс зохицдог, мөн эдгээрт ямар ч дүр эсгэлт, хольц байдаггүй; тэдгээр нь Бүтээгчийн мөн чанар болон эрх мэдлийн бүрэн бүтэн, туйлын төгс илэрхийлэл юм. Бүтээлүүдийн хувьд гэвэл, Бурханаас өгөгдсөн хүч чадлыг эзэмших нь бүү хэл, энэ эрх мэдэл, энэ мөн чанарын алийг нь ч эзэмшдэггүй. Хүн ийм зан авир харуулах юм бол энэ нь гарцаагүй ялзарсан зан чанарынх нь тэсрэлт байх бөгөөд тухайн хүний их зан, жолоогүй санаархлын хөндлөнгийн нөлөө, мөн хүмүүсийг хуурч, Бурханаас урвахад уруу татахыг хүсдэг өнөөх диавол Сатаны хорон санааны илрэлээс үүдэлтэй байх болно. Иймэрхүү үг хэлээр илчлэгдсэн зүйлд Бурхан хэрхэн ханддаг вэ? Бурхан чамайг, Өөрийнх нь байрыг булааж, Өөрийг нь дуурайж, орлохыг хүсэж байна гэж хэлнэ. Чи Бурханы айлдварын өнгийг дуурайх үедээ хүмүүсийн зүрх сэтгэл дэх Бурханы байр суурийг орлож, Бурханд зүй ёсоор харьяалагддаг хүн төрөлхтнийг өөрийн болгох санаа зорилготой байдаг. Энэ бол Сатанаас өөр хэн ч биш; эдгээр нь Тэнгэрийн хувьд

тэвчишгүй тэргүүн тэнгэрэлчийн үр удмын үйлдэл юм! Хүмүүсийг төөрөгдүүлж, мэхлэх санаатайгаар цөөн хэдэн үг хэлж, үг, үйлдэл нь Бурханы эрх мэдэл, сүр хүчийг агуулдаг, мөн чанар болон ялгамж чанар нь цор ганц, тэр ч бүү хэл ярианы өнгө нь хүртэл Бурханыхтай төстэй хэмээн хүмүүст санагдуулахын тулд Бурханыг хэзээ нэгэн цагт тодорхой маягаар дуурайж байсан хүн та нарын дунд бий юу? Та нар хэзээ нэгэн цагт иймэрхүү зүйл хийж байсан уу? Бурханы зан чанарыг төлөөлөх мэт үйл хөдлөлөөр, сүр хүч, эрх мэдэлтэй гэмээр байдлаар Бурханы өнгийг хэзээ нэгэн цагт дуурайн ярьж байсан уу? Та нарын олонх нь үргэлж ийм маягаар аяглаж, эсвэл ингэж аяглахаар төлөвлөдөг үү? Одоо Бүтээгчийн эрх мэдлийг үнэхээр харж, ойлгож, мэдээд, юу хийж, өөрсдийгөө илчилдэг байснаа эргэн санах үедээ ой гутаж байна уу? Та нар олиггүй, ичгүүргүй байдлаа хүлээн зөвшөөрч байна уу? Ийм хүмүүсийн зан чанар болон мөн чанарыг судалж шинжилсний дараа тэднийг хараал хүрсэн тамын хүү гэж хэлж болохоор байна уу? Ийм зүйл хийдэг хүн бүр өөрсдийгөө доромжилж байна гэж хэлж болох уу? Үүний шинж чанар ноцтой гэдгийг та нар мэдсэн үү? Энэ нь яг хэр ноцтой вэ? Ингэж аягладаг хүмүүсийн санаа зорилго нь Бурханыг дуурайх явдал. Тэд Бурхан байж, хүмүүсээр өөрсдийгөө Бурхан мэт шүтүүлэхийг хүсдэг. Тэд хүмүүсийг хянаж, хүмүүсийг залгиж, эзэмшилдээ авахын тулд хүмүүсийн зүрх сэтгэл дэх Бурханы байр суурийг үгүй хийж, хүмүүсийн дунд ажилладаг Бурханаас ангижрахыг хүсдэг. Хүн бүрд ийм далд хүсэл, санаархал байдаг ба хүн болгон ийм ялзарсан сатанлаг мөн чанартайгаар амьдарч, Бурхантай дайсагнаж, Бурханаас урваж, Бурхан болохыг хүсдэг ийм сатанлаг уг чанартайгаар амьдардаг. Бурханы эрх мэдлийн тухай сэдэвтэй Миний нөхөрлөлийн дараа та нар Бурханыг хуулбарлаж, дуурайхыг хүсэж, тэмүүлсээр л байна уу? Та нар Бурхан байхыг хүссээр л байна уу? Та нар Бурхан болохыг хүссээр л байна уу? Бурханы эрх мэдлийг хүн дуурайж чадахгүй, Бурханы ялгамж чанар болон байр суурийг хүн хуулбарлаж чадахгүй. Бурханы ярианы өнгийг чи дуурайж чадах боловч Бурханы мөн чанарыг дуурайж чадахгүй. Хэдийгээр чи Бурханы оронд зогсож, Бурханыг дуурайж чадах боловч Бурханы хийхээр зорьдог зүйлийг хэзээ ч хийж чадахгүй бөгөөд хэзээ ч бүх зүйлийг удирдан, захирч чадахгүй. Бурханы нүдээр чи үүрд өчүүхэн бүтээл байх бөгөөд ур дүй, ур чадвар чинь хэчнээн агуу ч бай, авьяас билиг чинь хэчнээн их ч бай хамаагүй, чи бүхэлдээ Бүтээгчийн эрх мэдэл дор байдаг. Чи ганц нэг хүчтэй үг хэлж чадлаа гээд энэ нь чамайг Бүтээгчийн мөн чанартай болгон харагдуулж чадахгүй, Бүтээгчийн эрх мэдлийг эзэмшсэн гэдгийг ч илэрхийлэхгүй. Бурханы эрх мэдэл болон хүч чадал нь Бурханы Өөрийн мөн чанар юм. Тэдгээрийг сурч мэдсэн юм биш, гаднаас олж авсан ч юм биш, харин энэ нь Бурханы Өөрийн төрөлх мөн чанар юм. Иймээс Бүтээгч, бүтээл хоёрын харилцаа хэзээ ч өөрчлөгдөхгүй. Бүтээлүүдийн нэг болохын хувьд хүн өөрт оногдсон байраа хадгалж, ухамсартайгаар авирлаж, Бүтээгчийн өөрт нь даалгасан зүйлийг хариуцлагатайгаар биелүүлэх ёстой. Хүн хэмжээ хязгаараас хэтэрч, чадвар чансаанаас нь давсан зүйл юм уу Бурханы

жигшдэг зүйлийг хэзээ ч хийх ёсгүй. Хүн агуу, супер хүн болж, бусдаас дээр байхаар хичээх ёсгүй, мөн Бурхан болох гэж эрэлхийлэх ёсгүй. Хүмүүс ийм байхыг хүсэх ёсгүй юм. Агуу, супер хүн болохыг эрэлхийлнэ гэдэг нь утгагүй зүйл. Бурхан болохыг хичээх нь бүр ч гутамшигтай; энэ нь ой гутаж, жигшмээр үйлдэл юм. Магтууштай зүйл буюу бүтээлүүдийн юунаас ч илүүгээр баримтлах ёстой зүйл нь жинхэнэ бүтээл болох явдал; энэ л бүх хүний эрэлхийлэх ёстой цорын ганц зорилго билээ.

Бүтээгчийн эрх мэдэл нь цаг хугацаа, орон зай, эсвэл газар зүйд хязгаарлагддаггүй ба Бүтээгчийн эрх мэдэл хэмжээлшгүй

Эхлэл 22:17–18-ыг харцгаая. Энэ нь Ехова Бурханы хэлсэн бас нэгэн эшлэл бөгөөд Абрахамд, “Би чамайг ерөөж, чиний үр удмыг тэнгэрийн од, далайн эрэг дээрх элс шиг олшруулна; чиний үр удам дайснуудынхаа үүд хаалгыг эзэгнэнэ; чи Миний дуу хоолойг дуулгавартай дагасан учир үр удмаар чинь газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөнө” гэж хэлсэн. Ехова Бурхан Абрахамыг үр удам нь өнөр өтгөн болно хэмээн олон удаа ерөөсөн—тэгвэл хэр хэмжээгээр өнөр өтгөн болох юм бэ? Бичвэрт өгүүлснээр: “тэнгэрийн од, далайн эрэг дээрх элс шиг” олон болно. Өөрөөр хэлбэл, Бурхан Абрахамд тэнгэрийн одод шиг олон, далайн эргийн элс мэт арвин үр удмыг хайрлахыг хүссэн. Бурхан дүрслэл ашиглан ярьсан бөгөөд энэ дүрслэлээс Бурхан Абрахамд ердөө нэг, хоёр, эсвэл бүр мянган мянга ч биш, харин үй олон үндэстэн болоход хангалттай тоо томшгүй олон үр удмыг хайрлана гэдгийг ойлгоход амархан, учир нь Бурхан олон үндэстний эцэг болгоно гэж Абрахамд амласан юм. Энэ тоог хүн шийдсэн үү, Бурхан шийдсэн үү? Хэчнээн үр удамтай байхаа хүн хянаж чадах уу? Энэ нь хүнээс шалтгаалдаг уу? “Тэнгэрийн од, далайн эрэг дээрх элс шиг” олон байх нь бүү хэл, хэд хэдэн үр удамтай байх уу, үгүй юу гэдэг нь ч хүнээс шалтгаалдаггүй. Үр хойчоо од шиг үй олон болгохыг хүсдэггүй хэн байх билээ? Харамсалтай нь, аливаа зүйл үргэлж хүссэнээр чинь болдоггүй. Хүн хэчнээн чадвар, чадамжтай бай, энэ нь хүнээс шалтгаалдаггүй; хэн ч Бурханы урьдчилан тогтоосон зүйлээс гадуур байж чадахгүй. Тэр чамд хэдий чинээ ихийг өгнө, чи төдий чинээ ихийг л авах болно: Бурхан чамд багыг өгвөл чи хэзээ ч их зүйлтэй болохгүй, Бурхан чамд ихийг өгвөл чи их зүйлтэй байгаадаа хэчнээн дургүйцээд ч нэмэргүй. Ийм байдаг биш үү? Энэ бүхэн бүгд хүнээс бус, Бурханаас шалтгаалдаг! Бурхан хүнийг захирдаг ба хэн ч үүнээс ангид байдаггүй!

Бурхан “Би чиний үр удмыг олшруулна” гэж хэлсэн нь Бурханы Абрахамтай байгуулсан гэрээ билээ. Энэ нь Абрахамд өгсөн Бурханы амлалт бөгөөд солонгон гэрээтэй адил мөнх биелэх юм. Бурхан л энэ амлалтыг биелүүлэхэд тохиромжтой, мөн биелүүлэх чадвартай. Хүн үүнд итгэдэг ч бай, үгүй ч бай, үүнийг хүлээн зөвшөөрдөг ч бай, үгүй ч бай, мөн үүнийг хэрхэн үзэж, үүнд хэрхэн ханддаг ч бай, энэ бүгд нь Бурханы хэлсэн үгийн дагуу нэгд нэггүй биелэх болно. Хүний хүсэл юм уу, үзэл дэх өөрчлөлтийн улмаас Бурханы үг өөрчлөгдөхгүй ба аливаа хүн, зүйл,

эд юман дахь өөрчлөлтөөс болж өөрчлөгдөхгүй. Бүх зүйл үгүй болж болох ч Бурханы үг үүрд үлдэнэ. Харин ч, бүх зүйл үгүй болох өдөр нь Бурханы үг бүрэн биелэх яг тэр өдөр байдаг, учир нь Тэр бол Бүтээгч бөгөөд Бүтээгчийн эрх мэдэл, хүч чадлыг эзэмшиж, бүх зүйлийг болон амийн бүх хүчийг хянадаг билээ; Тэр оргүй хоосноос ортой зүйлийг бий болгож, ортой зүйлийг үгүй хийж чаддаг ба амьдаас үхсэн хүртэлх бүх зүйлийн хувиралт өөрчлөлтийг хянадаг, иймээс Бурханы хувьд хүний үрийг үржүүлэхээс амархан зүйл гэж үгүй. Энэ нь хүнд уран зөгнөл, үлгэр мэт сонсогддог боловч Бурханы хувьд хийхээр шийдсэн, хийх гэж амласан зүйл нь уран зөгнөл ч биш, үлгэр ч биш. Харин энэ нь Бурханы аль хэдийн харсан, гарцаагүй биелэх баримт юм. Та нар үүнийг ухамсарлаж байна уу? Абрахамын үр удам үй олон байсан гэдгийг баримтууд нотолж байна уу? Яг хэр олон байсан бэ? Бурханы хэлснээр “тэнгэрийн од, далайн эрэг дээрх элс шиг” олон уу? Тэд дэлхий дээрх бүх үндэстэн, бүс нутаг, газар орон бүрд тархсан уу? Энэ баримтыг юу биелүүлсэн бэ? Энэ нь Бурханы үгийн эрх мэдлээр биелсэн үү? Бурхан үгээ хэлснээс хойш хэдэн зуун, хэдэн мянган жилийн турш Бурханы үг үргэлжлэн биелж, байнга бодит байдал болсоор байсан; энэ нь Бурханы үгийн сүр хүч, Бурханы эрх мэдлийн баталгаа юм. Бурхан анх бүх зүйлийг бүтээхдээ гэрэл бий болтугай гэж хэлэхэд гэрэл бий болсон. Энэ нь маш хурдан болж өнгөрч, тун богино хугацаанд биелсэн, үүний биелэлт болон хэрэгжилтэд ямар ч саатал байгаагүй; Бурханы үгийн үр нөлөө нь шуурхай байсан. Аль аль нь Бурханы эрх мэдлийн илрэл байсан, гэхдээ Бурхан Абрахамыг ерөөхдөө Бурханы эрх мэдлийн мөн чанарын өөр нэг талын зэрэгцээ Бүтээгчийн эрх мэдлийн хэмжээлшгүй байдал, цаашлаад Бүтээгчийн эрх мэдлийн илүү бодитой, илүү нарийн талыг харах боломжийг хүнд олгосон юм.

Бурханыг үгээ хэлмэгц Бурханы эрх мэдэл энэ ажлыг хариуцан авч, Бурханы амаараа амласан баримт нь аажмаар бодит байдал болдог. Үүний үрээр бүх зүйлийн дунд, хавар ирэх, зүлэг ногоорох, цэцэг дэлгэрэх, мод нахиалах, шувууд жиргэх, галуу буцаж ирэх, талбай хүмүүсээр дүүрэх гэх мэтээр юм бүхэнд өөрчлөлт гарч эхэлдэг… Хавар ирснээр бүх зүйл сэргэсэн ба энэ нь Бүтээгчийн гайхалтай үйл хэрэг юм. Бурхан амлалтаа биелүүлэх үед тэнгэр газар дахь бүх зүйл Бурханы бодлын дагуу шинэчлэгдэж, өөрчлөгддөг—юу ч үүнээс ангид байдаггүй. Бурханы амнаас амлалт гарах үед бүх зүйл үүний хэрэгжилтэд үйлчилж, үүний хэрэгжилтийн төлөө жолоодуулж, бүх бүтээл Бүтээгчийн эрх мэдэл дор зохион байгуулагдан, зохицуулагдаж, тус тусын үүргээ биелүүлж, дор бүрнээ чиг үүргээ гүйцэтгэдэг. Энэ нь Бүтээгчийн эрх мэдлийн илрэл юм. Үүнээс чи юу олж харж байна вэ? Бурханы эрх мэдлийг чи хэрхэн мэддэг вэ? Бурханы эрх мэдэлд цар хүрээ бий юу? Цаг хугацааны хязгаар бий юу? Үүнийг тодорхой өндөртэй, тодорхой урттай гэж хэлж болох уу? Тодорхой хэмжээ, хүч чадалтай гэж хэлж болох уу? Үүнийг хүний хэмжигдэхүүнээр хэмжиж болох уу? Бурханы эрх мэдэл нь асаж унтардаггүй, ирж буцдаггүй ба Түүний эрх мэдэл хэчнээн агуу болохыг хэн ч хэмжиж чадахгүй. Хэр их цаг хугацаа өнгөрөхөөс үл хамааран Бурхан хүнийг ерөөх үед энэхүү ерөөл нь

үргэлжилж, үргэлжлэл нь Бурханы хэмжээлшгүй эрх мэдлийг гэрчилж, Бүтээгчийн бөхөшгүй амийн хүчний дахин илрэлтийг удаа дараа харах боломжийг хүн төрөлхтөнд олгох болно. Түүний эрх мэдлийн илрэл бүр нь Түүний амнаас гарсан үгийн төгс үзүүлэн болж бүх зүйлд болон хүн төрөлхтөнд харагддаг. Түүнчлэн, Түүний эрх мэдлээр хэрэгжсэн бүх зүйл нь юутай ч харьцуулшгүй нарийн гоёмсог, туйлын өө сэвгүй юм. Түүний бодол, Түүний үг, Түүний эрх мэдэл болон Түүний хэрэгжүүлдэг бүх ажил бүгд харьцуулахын аргагүй сайхан дүр зураг бөгөөд бүтээлүүдийн хувьд хүн төрөлхтний хэл нь үүний ач холбогдол болон үнэ цэнийг илэрхийлэх чадваргүй гэж хэлж болно. Бурхан хүнд амлалт өгөх үед, тухайн хүний хаана амьдардаг, юу хийдэг эсэх нь, амлалтыг хүлээн авахын өмнөх, эсвэл дараах нөхцөл, мөн амьдрах орчинд нь хэр их өөрчлөлт байсан эсэх нь—Бурханд бүгд алган дээр нь байгаа мэт тодхон байдаг. Бурхан үгээ хэлсний дараа хэчнээн их хугацаа өнгөрөх нь хамаагүй Бурханы хувьд үгээ дөнгөж хэлсэн мэт л байдаг. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөнд өгсөн амлалт бүрээ бүртгэж, хянаж, биелүүлэх хүч чадал, ийм эрх мэдэл Бурханд байдаг бөгөөд тухайн амлалт нь юу ч бай, бүрэн биелэх хүртлээ хэр их хугацаа шаарддаг ч бай, бүр цаг хугацаа, газар зүй, арьс өнгөөр тодорхойлогдох хэрэгжүүлэлтийнх нь цар хүрээ хэр өргөн байдаг ч бай, энэ амлалт биелж, хэрэгжих болно, түүнчлэн хэрэгжилт, биелэлт нь Түүнээс өчүүхэн төдий ч хичээл зүтгэл шаардахгүй. Энэ нь юуг нотолдог вэ? Бурханы эрх мэдэл, хүч чадлын өргөн хүрээ нь бүхий л орчлон ертөнцийг болон бүхий л хүн төрөлхтнийг хянахад хангалттай. Бурхан гэрлийг бүтээсэн, гэхдээ Бурхан гэрлийг л удирддаг гэсэн үг биш, эсвэл Тэр усыг бүтээсэн учраас усыг л удирдаж, бусад бүх зүйл Бурхантай хамааралгүй байдаг гэсэн үг биш. Энэ нь буруу ойлголт биш гэж үү? Абрахамд өгсөн Бурханы ерөөл нь хэдэн зуун жилийн дараа аажмаар хүний ой ухаанаас арилсан хэдий ч Бурханы хувьд энэхүү амлалт хэвээр үлдсэн. Энэ нь мөн л хэрэгжих явцдаа байсан бөгөөд хэзээ ч зогсоогүй. Бурхан эрх мэдлээ хэрхэн хэрэгжүүлдэг болох, бүх зүйл хэрхэн зохион байгуулагдаж, зохицуулагддаг болох, энэ хугацаанд Бурханы бүтээсэн бүх зүйл дунд хэчнээн гайхалтай түүх тохиолдсон болохыг хүн хэзээ ч мэдээгүй, дуулаагүй боловч Бурханы эрх мэдлийн илэрхийлэл, үйл хэргийнх нь илчлэлийн гайхалтай хэсэг бүр бүх зүйлийн дунд уламжлагдаж, өргөмжлөгдөн, бүх зүйл Бүтээгчийн гайхалтай үйл хэргийг харуулж, энэ тухай ярьсан бөгөөд бүх зүйлийг захирах Бүтээгчийн дээд эрхийн тухай түгээмэл яригддаг түүх бүрийг бүх зүйл үүрд мөнх тунхаглах болно. Бурханы бүх зүйлийг захирдаг эрх мэдэл, мөн хүч чадал нь Бурхан цаг үргэлжид хаа сайгүй оршин байдаг гэдгийг бүх зүйлд харуулдаг. Бурханы эрх мэдэл болон хүч чадал хаа сайгүй байдгийг нүдээр үзэх үедээ чи Бурхан цаг үргэлжид газар сайгүй байдаг гэдгийг харна. Бурханы эрх мэдэл, хүч чадал нь цаг хугацаа, газар зүй, орон зай, аливаа хүн, эд юм, зүйлээр хязгаарлагдахгүй. Бурханы эрх мэдэл болон хүч чадлын өргөн хүрээ нь хүний төсөөллийг даван гардаг; энэ нь хүн ойлгохын аргагүй, хүн төсөөлөхийн аргагүй байдаг бөгөөд хүн хэзээ ч бүрэн мэдэж авахгүй.

Зарим хүн тааж төсөөлөх дуртай, гэвч хүний төсөөлөл хэр хол хүрч чадах вэ? Энэ дэлхий ертөнцөөс даван гарч чадах уу? Хүн Бурханы эрх мэдлийн жинхэнэ байдал болон үнэн зөв байдлыг тааж төсөөлөх чадвартай юу? Хүний таамаг, төсөөлөл нь Бурханы эрх мэдлийн тухай мэдлэгтэй болгох чадвартай юу? Тэдгээр нь Бурханы эрх мэдлийг үнэхээр үнэлж, үүнд захирагдахад хүмүүсийг хүргэж чадах уу? Хүний таамаг болон төсөөлөл нь зөвхөн хүний оюун ухааны бүтээл бөгөөд Бурханы эрх мэдлийн талаарх хүний мэдлэгт өчүүхэн төдий ч тус нэмэр, үр ашиггүй гэдгийг баримтууд баталдаг. Шинжлэх ухааны уран зөгнөлийг уншаад, зарим хүн сарыг төсөөлж, одод ямар вэ гэдгийг төсөөлж чаддаг. Гэсэн ч энэ нь, хүн Бурханы эрх мэдлийн тухай ямар нэгэн ойлголттой гэсэн үг биш юм. Хүний төсөөлөл нь зүгээр л төсөөлөл юм. Эдгээр зүйлийн баримтуудаас, өөрөөр хэлбэл, Бурханы эрх мэдэлтэй холбогдох эдгээрийн холбооноос хүн юуг ч огт ухаардаггүй. Чи саран дээр очсон байлаа гээд яах юм бэ? Энэ нь Бурханы эрх мэдлийн талаар олон хэмжээст ойлголттойг чинь харуулах уу? Энэ нь Бурханы эрх мэдэл болон хүч чадлын өргөн хүрээг төсөөлж чадна гэдгийг чинь харуулах уу? Хүний таамаг, төсөөлөл нь Бурханы эрх мэдлийг мэдэх боломж олгож чадахгүй юм хойно, хүн яах ёстой вэ? Хамгийн ухаалаг сонголт бол таамаглаж, төсөөлөхгүй байх, өөрөөр хэлбэл, Бурханы эрх мэдлийг мэдэх тухайд хүн хэзээ ч төсөөлөлдөө найдаж, таамагтаа түшиглэх ёсгүй юм. Би энд та нарт юу гэж хэлэх гээд байна вэ? Бурханы эрх мэдэл, Бурханы хүч чадал, Бурханы ялгамж чанар, Бурханы мөн чанарын тухай мэдлэгт төсөөлөлдөө найдсанаар хүрч чадахгүй. Бурханы эрх мэдлийг мэдэхийн тулд чи төсөөлөлдөө найдаж болохгүй болохоор ямар арга замаар Бурханы эрх мэдлийн талаарх жинхэнэ мэдлэгийг олж авч чадах вэ? Чи Бурханы үгийг идэж, ууснаар, Бурханы үгийг нөхөрлөж, туулснаар аажмаар Бурханы эрх мэдлийн талаар туршлага, баталгаажуулалттай болж, улмаар энэ тухай шат дараатай ойлголт, нэмэлт мэдлэгийг олж авах болно. Энэ нь Бурханы эрх мэдлийн тухай мэдлэгт хүрэх цорын ганц зам юм; ямар ч дөт зам байхгүй. Та нараас битгий төсөөл гэж гуйж байгаа нь сүйрлийг чинь хүлээлгэн зүгээр суулгах юм уу юу ч хийлгэхгүй байхтай адилгүй. Бодож, төсөөлөхдөө уураг тархиа ашиглахгүй байна гэдэг нь таамаглахад логик ашиглахгүй, дүн шинжилгээ хийхэд мэдлэг ашиглахгүй, шинжлэх ухааныг үндэслэл болгон ашиглахгүй байх явдал бөгөөд үүний оронд Бурханы үг, үнэн болон амьдралд чинь тулгарч байгаа бүх зүйлээр дамжуулан чиний итгэдэг Бурханд эрх мэдэл бий гэдгийг ухамсарлаж, бататгаж, баталгаажуулах, мөн Бурхан хувь заяаг чинь захирдгийг, Түүний хүч чадал цаг үргэлж жинхэнэ Бурхан Өөрөө гэдгийг нь нотолдог болохыг баталгаажуулах явдал юм. Аливаа хүн Бурханы тухай ойлголтыг олж авах цорын ганц арга энэ билээ. Зарим нь энэ зорилгод хүрэх хялбар арга зам олмоор байна гэдэг, гэхдээ та нар ийм хялбар арга замыг бодож олсон уу? Бодох хэрэг байхгүй гэдгийг чамд Би хэлье: Өөр ямар ч арга зам байхгүй! Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг илэрхийлдэг үг, хийдэг зүйл бүрээр нь дамжуулан чин сэтгэлээсээ, тууштайгаар мэдэж, бататгана гэдэг цорын ганц арга зам юм. Энэ нь

Бурханыг мэдэх цорын ганц зам. Учир нь Бурханд юу байгаа, Тэр юу болох болон Бурханы бүх зүйл хөндий, хоосон биш—харин бодитой билээ.

Бүх зүйл болон амьтдыг Бүтээгч хянаж, захирдаг баримт нь Бүтээгчийн эрх мэдлийн жинхэнэ оршин тогтнолыг илтгэдэг

Үүний адилаар, Иовыг ерөөсөн Еховагийн ерөөл Иовын Номд бичигдсэн. Бурхан Иовд юу хайрласан бэ? “Иймээс Ехова Иовын сүүлчийн өдрүүдийг эхэн үеэс нь илүүгээр ерөөжээ: учир нь тэр арван дөрвөн мянган хонь, зургаан мянган тэмээ, нэг мянган буулгат хос шар, мөн нэг мянган эм илжигтэй байлаа” (Иов 42:12). Хүний харах өнцгөөс бол Иовд өгсөн эдгээр зүйл юу байсан бэ? Эдгээр нь хүний эд хөрөнгө байсан уу? Эдгээр хөрөнгөтэй байснаар Иов тухайн эрин үед маш баян байх байсан биш үү? Тэгвэл тэр ийм эд хөрөнгийг яаж олж авсан бэ? Юу түүнийг хөрөнгөжүүлсэн бэ? Бурханы ерөөлийн ачаар Иов эдгээрийг эзэмших болсон гэдэг нь тодорхой юм. Эдгээр хөрөнгийг Иов хэрхэн үзэж, Бурханы ерөөлд хэрхэн хандаж байсан гэдэг нь энд бидний ярилцах зүйл биш. Бурханы ерөөлийн тухайд, бүх хүн Бурханаар ерөөгдөх гэж өдөр шөнөгүй хүсэн хүлээдэг боловч насан туршдаа хэр их хөрөнгө олж авч чадах, мөн Бурханы ерөөлийг хүртэж чадах эсэх нь хүний мэдлийн хэрэг биш—энэ бол маргашгүй баримт билээ! Хүнд хүссэн эд хөрөнгөө хайрлаж, адис хүртэх боломжийг хүссэнээрээ олгох эрх мэдэл, хүч чадал Бурханд байдаг боловч Бурханы ерөөлд зарчим гэж бий. Ямар хүмүүсийг Бурхан ерөөдөг вэ? Мэдээж, Өөртөө таалагдсан хүмүүсийг ерөөдөг! Абрахам, Иов хоёрын хэн хэнийг нь Бурхан ерөөсөн, гэхдээ тэдний хүлээн авсан ерөөл адилхан байгаагүй. Бурхан Абрахамыг элсний ширхэг болон одод шиг олон үр удамтай болог гэж ерөөсөн. Бурхан Абрахамыг ерөөх үедээ нэг хүний үр удам болон нэг үндэстнийг хүчирхэг, амжилттай болгосон. Ийнхүү, бүх зүйл, амьтдын дундаас Бурханы амьсгалаар амьсгалсан хүн төрөлхтнийг Бурханы эрх мэдэл захирсан юм. Бурханы эрх мэдлийн дээд эрх дор энэ хүн төрөлхтөн Бурханы шийдсэн цар хүрээн дотор, Бурханы шийдсэн хурдцын дагуу өсөн үржиж, оршин тогтносон. Ялангуяа энэ үндэстний амьдрах чадвар, өсөж үржих түвшин, наслалт нь бүгд Бурханы зохицуулалтын нэг хэсэг байсан бөгөөд энэ бүхний зарчим нь тэр чигтээ Бурханы Абрахамд өгсөн амлалтад үндэслэж байсан юм. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдлаас үл хамааран Бурханы амлалт Түүний эрх мэдлийн ивээл дор саадгүй хэрэгжиж, биелэх болно. Бурханы Абрахамд өгсөн амлалтын дагуу, дэлхий ертөнцийн өөрчлөлт, эрин үе, хүн төрөлхтний туулсан гай гамшгаас үл хамааран, Абрахамын үр удам газрын хөрснөөс арчигдах эрсдэлд орохгүй бөгөөд тэдний үндэстэн мөхөхгүй байх байсан юм. Харин Иовыг ерөөсөн Бурханы ерөөл нь түүнийг асар баян болгосон. Бурхан түүнд амьд, амьсгалдаг сүрэг олон амьтан өгсөн бөгөөд тэдгээрийн тоо толгой, өсөн үржих хурд, амьдрах чадвар, өөх таргынх нь хэмжээ гэх мэт нарийн ширийн зүйлийг нь мөн л Бурхан хянаж байсан юм. Энэ амьтад ярих чадваргүй байсан боловч мөн л Бүтээгчийн зохицуулалтын нэг хэсэг байсан бөгөөд

тэдгээрийг зохицуулах Бурханы зохицуулалтын цаад зарчим нь Иовд амласан Бурханы ерөөлд суурилж байсан юм. Абрахам, Иов хоёрт өгсөн Бурханы ерөөлд амласан зүйлс нь өөр өөр байсан боловч Бүтээгчийн бүх зүйл, амьтдыг захирах эрх мэдэл нь нэгэн адил байсан билээ. Бурханы эрх мэдэл, хүч чадлын бүх нарийн учир нь Абрахам, Иов хоёрт өгсөн өөр өөр амлалт, ерөөлд нь илэрхийлэгдсэн байдаг бөгөөд Бурханы эрх мэдэл нь хүний төсөөллөөс хол давуу гэдгийг хүн төрөлхтөнд дахин нэг удаа харуулдаг. Хүн Бурханы эрх мэдлийг мэдье гэвэл зөвхөн Бурханы үгээс, мөн Бурханы ажлыг туулснаар л мэдэж авч болно гэдгийг эдгээр нарийн ширийн зүйл хүн төрөлхтөнд дахин нэг удаа хэлдэг билээ.

Бүх зүйлийг захирах Бурханы эрх мэдэл нь нэг баримтыг харах боломжийг хүнд олгодог: Бурханы эрх мэдэл “Бурханыг гэрэл бий бол гэхэд гэрэл бий болж, Огторгуй бий бол гэхэд огторгуй бий болж, Газар бий бол гэхэд газар бий болсон” гэдэг үгэнд биеллээ олоод зогсохгүй, цаашилбал гэрлийг үргэлжлүүлж, огторгуйг үгүй болохоос сэргийлж, газрыг үүрд уснаас салангид байлгах үед нь болон гэрэл, огторгуй, газар зэрэг бүтээсэн бүтээлээ захирч, удирдах явц дахь нарийн ширийн үйл хэрэгт нь ч биеллээ олдог юм. Хүн төрөлхтөнд өгсөн Бурханы ерөөлөөс та нар өөр юуг олж харж байна вэ? Мэдээж, Абрахам, Иов хоёрыг ерөөснийхөө дараа Бурхан алхаагаа зогсоогоогүй, учир нь Тэр эрх мэдлээ дөнгөж хэрэгжүүлж эхэлсэн байсан ба үг бүрээ бодит байдал болгож, Өөрийн ярьсан нарийн учир нэг бүрийг биелүүлэхээр зорьсон, иймээс дараагийн жилүүдэд нь Тэр зорьсон бүх зүйлээ үргэлжлүүлэн хийсэн. Бурхан эрх мэдэлтэй тул бүх зүйл, эд юмсыг хэрэгжүүлэхийн тулд үг л хэлээд, хуруугаа ч хөдөлгөх хэрэггүй байдаг мэт хүнд санагддаг байх. Ингэж төсөөлнө гэдэг жаахан хөгийн юм! Хэрвээ чи, үг ашиглан хүнтэй байгуулсан Бурханы гэрээний талаар болон үг ашиглан Бурханы биелүүлсэн бүх зүйлийн талаар өрөөсгөл бодолтой байж, Бурханы эрх мэдлийн захиралтад байгаа бүх зүйлийн оршин тогтнолын олон янзын шинж тэмдэг, баримтыг харж чадахгүй бол Бурханы эрх мэдлийн талаарх ойлголт чинь хэтэрхий хоосон, хөгийн байгаа хэрэг! Хүн Бурханыг ингэж төсөөлдөг бол Бурханы талаарх мэдлэг нь эцсийн оролдлогодоо очиж, мухардалд хүрсэн гэж хэлэхээс аргагүй, учир нь хүний төсөөлдөг Бурхан бол эрх мэдэл эзэмшсэн Бурхан бус, тушаал буулгадаг машин юм. Абрахам, Иов хоёрын жишээнээс чи юу олж харсан бэ? Бурханы эрх мэдэл, хүч чадлын бодитой талыг харсан уу? Бурхан Абрахам, Иов хоёрыг ерөөснийхөө дараа байгаа газартаа үлдээгүй, бас гарах үр дүнг нь харахаар хүлээнгээ Өөрийн элчүүдийг ажиллуулаагүй. Харин ч Бурханыг үгээ айлдмагц, Бурханы эрх мэдлийн удирдамж дор бүх зүйл Бурханы хийх гэж зорьсон ажилтай нийцэж эхэлсэн бөгөөд Бурханы шаардсан хүмүүс, зүйлс болон эд юмс бэлтгэгдсэн байсан. Өөрөөр хэлбэл, Бурханы амнаас үг гармагц бүхий л газар нутаг даяар Түүний эрх мэдэл хэрэгжиж эхэлсэн бөгөөд Тэрээр Абрахам болон Иовд өгсөн амлалтаа хэрэгжүүлж, биелүүлэх замаа тавих зуураа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн алхам, гол үе шат болгондоо шаардагдах бүх зүйлийг зохих ёсоор төлөвлөж, бэлтгэдэг. Энэ

хугацаанд Бурхан Өөрийн элч нарыг төдийгүй, бүтээсэн бүх зүйлээ удирдан жолоодсон. Өөрөөр хэлбэл, Бурханы хэрэгжүүлсэн эрх мэдлийн цар хүрээ дотор элч нар төдийгүй бүх зүйл хамрагдаж байсан ба биелүүлэх гэж зорьсон ажлаа гүйцэтгэхийн тулд Тэр эдгээрийг удирдан жолоодсон; ийм тодорхой арга замаар Бурханы эрх мэдэл хэрэгжсэн юм. Зарим хүн үзэл бодолдоо Бурханы эрх мэдлийн талаар дараах ойлголттой байдаг: Бурханд эрх мэдэл байгаа, Бурханд хүч чадал байгаа, иймээс Бурхан гуравдагч тэнгэрт юм уу, тогтсон газраа л байх хэрэгтэй, тодорхой нэгэн ажил хийх хэрэггүй, Бурханы ажил бүхэлдээ бодол дотор нь гүйцэлддэг. Бас Бурхан Абрахамыг ерөөсөн ч гэсэн, Түүнд юу ч хийх хэрэг байгаагүй бөгөөд үгээ хэлэх төдийхөн л хангалттай байсан гэж зарим нэг хүн боддог байж магад. Ийм зүйл үнэхээр тохиолдсон уу? Мэдээж үгүй! Хэдийгээр Бурхан эрх мэдэл, хүч чадлыг эзэмшдэг боловч эрх мэдэл нь хий хоосон бус, жинхэнэ, бодитой байдаг. Бурханы эрх мэдэл, хүч чадлын жинхэнэ, бодит байдал нь Түүний бүх зүйлийг бүтээх, бүх зүйлийг хянах мөн хүн төрөлхтнийг удирдаж, чиглүүлэх үйл явцад нь аажмаар илчлэгдэн, биеллээ олдог. Хүн төрөлхтөн болон бүх зүйлийг захирах Бурханы арга барил, харах өнцөг, нарийн учир бүр, мөн Түүний хэрэгжүүлсэн бүх ажил, бүх зүйлийн талаарх Түүний ойлголт—эдгээр нь бүгд Бурханы эрх мэдэл, хүч чадал нь хоосон үг биш гэдгийг яг таг нотолдог. Түүний эрх мэдэл, хүч чадал бүх зүйл дээр байнга харагдаж, илчлэгддэг. Эдгээр илрэл, илчлэл нь Бурханы эрх мэдлийн бодит оршин тогтнолыг өгүүлдэг, учир нь Тэр агшин тутамд Өөрийн эрх мэдэл, хүч чадлаар ажлаа үргэлжлүүлж, бүх зүйлийг удирдаж, захирдаг бөгөөд Түүний хүч чадал, эрх мэдлийг тэнгэрэлч нар юм уу Бурханы элч нар орлож чадахгүй юм. Абрахам, Иов хоёрт ямар ерөөл хайрлахаа Бурхан шийдсэн—энэ нь Бурханаас хамаарсан. Хэдийгээр Бурханы элч нар Абрахам болон Иов дээр биечлэн очсон боловч үйлдэл нь Бурханы тушаалын дагуу, Бурханы эрх мэдлийн дор, мөн Бурханы дээд эрхийн дор байсан. Хүмүүс, Библийн тэмдэглэлээс Бурханы элч нар Абрахам дээр зочилсныг мэдэх бөгөөд харин Ехова Бурханы аливааг биечлэн хийж байхыг нь хараагүй боловч үнэндээ хүч чадал, эрх мэдлийг үнэхээр хэрэгжүүлдэг цорын ганц Нэгэн бол Бурхан Өөрөө бөгөөд энэ нь ямар ч хүний эргэлзээг тэвчихгүй! Тэнгэрэлч болон элч нар агуу хүч чадлыг эзэмшиж, гайхамшгуудыг үйлдэх юм уу Бурханы даалгасан зарим зүйлийг хэрэгжүүлснийг чи харсан ч гэсэн, тэдний үйлдэл ердөө л Бурханы даалгаврыг гүйцэлдүүлэхийн төлөө байдаг бөгөөд Бурханы эрх мэдлийн илрэл яавч биш—бүх зүйлийг бүтээж, захирах Бүтээгчийн эрх мэдэл ямар ч хүн, эд юманд байхгүй, тэд үүнийг эзэмшдэггүй. Иймээс ямар ч хүн, эд юм Бүтээгчийн эрх мэдлийг хэрэгжүүлэх юм уу харуулж чадахгүй.

Бүтээгчийн эрх мэдэл хувиршгүй ба халдашгүй

Бичвэрийн энэ гурван хэсгээс та нар юу ойлгосон бэ? Бурханд эрх мэдлээ хэрэгжүүлдэг зарчим байдгийг та нар харав уу? Жишээлбэл, Бурхан хүнтэй гэрээ байгуулахын тулд солонгыг ашиглаж, дэлхий ертөнцийг сүйрүүлэхэд дахин хэзээ ч

үер ашиглахгүй гэдгээ хүнд хэлэхийн тулд үүлэн дунд солонгыг тавьсан. Өнөөдөр хүмүүсийн хардаг солонго нь Бурханы амаараа хэлсэн солонготой бас л адилхан уу? Үүний шинж чанар, утга учир өөрчлөгдсөн үү? Өөрчлөгдөөгүй гэдэг нь ямар ч эргэлзээгүй. Энэ үйлдлийг хэрэгжүүлэхийн тулд Бурхан эрх мэдлээ ашигласан ба хүнтэй байгуулсан гэрээ нь өнөөдрийг хүртэл үргэлжилсэн, энэхүү гэрээ өөрчлөгдөх цаг үе нь мэдээж Бурханаас хамаарна. Бурхан “Би үүлэнд солонго татуулах болно” гэж хэлснийхээ дараа энэ гэрээг өнөөдрийг хүртэл үргэлж мөрдөж ирсэн. Үүнээс чи юуг олж харж байна вэ? Бурхан эрх мэдэл, хүч чадалтай ч гэсэн, үйлдэлдээ маш нягт нямбай, зарчимч байж, хэлсэн үгэндээ хүрдэг. Түүний хатуу чанд байдал болон үйлдлийн зарчмууд нь Бүтээгчийн халдашгүй байдал болон Бүтээгчийн эрх мэдлийн даван туулшгүй байдлын илрэл юм. Бурхан дээдийн дээд эрх мэдлийг эзэмшдэг, бүх зүйл Түүний эрх мэдэл дор байдаг, бүх зүйлийг захирах хүч чадал Түүнд байдаг хэдий ч Бурхан хэзээ ч Өөрийн төлөвлөгөөг нурааж, тасалдуулж байгаагүй бөгөөд эрх мэдлээ хэрэгжүүлэх болгондоо Өөрийнхөө зарчмыг чанд баримталж, амаараа хэлсэн зүйлээ яг таг дагаж, төлөвлөгөөнийхөө алхмууд болон зорилгыг дагадаг. Бурханы захирдаг бүх зүйл Бурханы эрх мэдлийн хэрэгждэг зарчмуудыг ч мөн дуулгавартай дагадаг ба Түүний эрх мэдлийн зохицуулалтаас зугтдаг ямар ч хүн, зүйл гэж үгүй, мөн тэд Түүний эрх мэдлийн хэрэгждэг зарчмуудыг өөрчилж чадахгүй гэдгийг хэлэх нь илүүц юм. Бурханы нүдээр бол, ерөөгдсөн хүмүүс Түүний эрх мэдлээр бий болсон сайн хувь заяаг хүртэж, хараагдсан хүмүүс Бурханы эрх мэдлийн улмаас шийтгэлээ хүлээдэг. Бурханы эрх мэдлийн дээд эрхэн дор, эрх мэдлийнх нь хэрэгжилтээс ангид ямар ч хүн юм уу зүйл байдаггүй, тэд Түүний эрх мэдлийн хэрэгждэг зарчмуудыг ч өөрчилж чадахгүй. Бүтээгчийн эрх мэдэл нь аливаа хүчин зүйлийн өөрчлөлтөөр хувирдаггүй, тэрчлэн Түүний эрх мэдлийн хэрэгжих зарчмууд нь ямар ч шалтгааны улмаас өөрчлөгддөггүй. Тэнгэр, газарт асар их өөрчлөлт гарч болох ч Бүтээгчийн эрх мэдэл өөрчлөгдөхгүй; бүх зүйл үгүй болж болох ч Бүтээгчийн эрх мэдэл хэзээ ч алга болохгүй. Энэ бол Бүтээгчийн хувиршгүй, халдашгүй эрх мэдлийн мөн чанар бөгөөд энэ нь чухамдаа Бүтээгчийн цор ганц байдал юм!

Дараах үг Бурханы эрх мэдлийг мэдэхэд амин чухал бөгөөд эдгээрийн утга учрыг доорх нөхөрлөлд өгүүлсэн юм. Бичвэрийг үргэлжлүүлэн уншицгаая.

4. Бурханы Сатанд өгсөн тушаал

Иов 2:6 Тэгээд Ехова Сатанд хандан, “Харагтун, тэр чиний гарт байна; харин түүний аминд л бүү хүр” гэв.

Сатан хэзээ ч Бүтээгчийн эрх мэдлийг зөрчиж зүрхлээгүй ба үүний ачаар бүх зүйл дэг журамтай амьдардаг

Энэ бол Иовын Номоос авсан эшлэл бөгөөд энэ үгэн дэх “тэр” гэдэг нь Иовыг хэлж байгаа юм. Хэдий товчхон ч энэ өгүүлбэр нь олон асуудлыг тодорхой

болгодог. Энэ нь Бурхан, Сатан хоёрын тодорхой харилцан яриаг дүрслэн, Бурханы үгийн бай нь Сатан байсан гэдгийг бидэнд хэлдэг. Мөн Бурханы хэлсэн зүйлийг тусгайлан тэмдэглэсэн байдаг. Бурханы үг нь Сатанд өгсөн захирамж, тушаал байсан. Энэ тушаалын онцгой нарийн учир нь Иовын амийг хэлтрүүлэхтэй холбоотой бөгөөд энд Бурхан, Сатаны Иовд үзүүлэх хандлагад хязгаар тогтоосон—Сатан Иовын амийг хэлтрүүлэх ёстой болсон юм. Энэ өгүүлбэрээс бидний мэдэж авах эхний зүйл бол эдгээр нь Бурханы Сатанд хэлсэн үг байжээ. Иовын Номын эх бичвэрт энэ үгийн цаад шалтгааныг бидэнд өгүүлсэн байдаг: Сатан Иовыг буруутгахыг хүссэн тул түүнийг сорихоосоо өмнө Бурханы зөвшөөрлийг авах ёстой болсон. Иовыг сорих хүсэлтэд нь зөвшөөрөл олгохдоо Сатанд Бурхан дараах болзлыг тавьсан: “Иов чиний гарт байна, харин түүний аминд л бүү хүр.” Эдгээр үгийн шинж чанар юу вэ? Эдгээр нь мэдээж захирамж, тушаал юм. Эдгээр үгийн шинж чанарыг чи ойлгосон тул энэ тушаалыг буулгасан Нэгэн бол Бурхан, тушаалыг хүлээн авч, дуулгавартай дагасан нэгэн нь Сатан байсан гэдгийг мэдээж бас ухаарах ёстой. Эдгээр үгийг хэн ч уншсан гэсэн энэ тушаалд, Бурхан, Сатан хоёрын харилцаа илэрхий байдаг гэдгийг хэлэх нь илүүц билээ. Мэдээж энэ нь бас, Судар дахь Бурхан, Сатан хоёрын харилцан ярианы тэмдэглэлд байсан сүнсний ертөнц дэх Бурхан, Сатан хоёрын харилцаа, Бурхан, Сатан хоёрын ялгамж чанар, байр суурийн ялгаа бөгөөд өнөөг хүртэл энэ нь Бурхан, Сатан хоёрын ялгамж чанар, байр суурийн илэрхий ялгааг хүн мэдэж авч болох тодорхой жишээ ба бичгэн тэмдэглэл юм. Энэ үед, эдгээр үгийн тэмдэглэл нь Бурханы ялгамж чанар болон байр суурийн талаарх хүн төрөлхтний мэдлэгт чухал баримт бичиг бөгөөд энэ нь Бурханы талаарх хүн төрөлхтний мэдлэгийг чухал мэдээллээр хангадаг. Сүнсний ертөнц дэх Бүтээгч, Сатан хоёрын энэ харилцан яриагаар дамжуулан хүн Бүтээгчийн эрх мэдлийн дахин нэг тодорхой агуулгыг ойлгож чаддаг. Эдгээр үг нь Бүтээгчийн цор ганц эрх мэдлийн бас нэгэн гэрчлэл юм.

Гаднаа бол эдгээр нь Ехова Бурхан, Сатан хоёрын харилцан яриа. Эдгээрийн мөн чанар нь гэвэл, Ехова Бурханы ярьж буй хандлага, байр суурь нь Сатанаас дээгүүр байсан явдал билээ. Өөрөөр хэлбэл, Ехова Бурхан захирсан өнгөөр Сатанд тушааж, Иов аль хэдийн гарт нь орсон ба Иовд хүссэнээрээ хандаж болно, гэхдээ Иовын амийг л авч болохгүй хэмээн Сатанд юу хийх ёстой, юу хийх ёсгүйг нь хэлж байна. Цаад санаа нь гэвэл, Иовыг Сатаны гарт өгсөн боловч амийг нь Сатанд өгөөгүй; Бурханы зөвшөөрөлгүйгээр хэн ч Иовын амийг Бурханы гараас авч чадахгүй. Бурханы хандлага Сатанд өгсөн энэ тушаалд тодорхой илэрхийлэгдсэн ба энэ тушаал нь мөн Ехова Бурханы Сатантай ярилцдаг байр суурийг илэрхийлж, илчилдэг. Энд Ехова Бурхан дан ганц гэрэл, агаар, бүх зүйл, амьтдыг бүтээсэн Бурханы, бүх зүйл, амьтдыг захирдаг Бурханы байр суурийг баримтлаад зогсохгүй, хүн төрөлхтнийг захирч, Үхэгсдийн орныг захирдаг Бурханы, мөн амьтай бүх зүйлийн үхэл амьдралыг хянадаг Бурханы байр суурийг баримталдаг. Сүнсний

ертөнцөд Бурханаас өөр хэн Сатанд ийм тушаал гаргаж зүрхлэх билээ? Яагаад Бурхан Сатанд биечлэн тушаал өгсөн бэ? Учир нь хүний амь, тэр дундаа Иовын амийг ч Бурхан захирдаг. Бурхан Иовын амийг авах, аминд нь хор хөнөөл учруулахыг Сатанд зөвшөөрөөгүй, Сатанд Иовыг сорихыг зөвшөөрөхдөө ч онцгойлон тэрхүү тушаалыг буулгахаа умартаагүй бөгөөд Иовын амийг авахгүй байхыг Сатанд дахин нэгэнтээ тушаасан байдаг. Сатан хэзээ ч Бурханы эрх мэдлийг зөрчиж зүрхлээгүй, мөн цаашлаад Бурханы тушаал болон онцгой захирамжуудыг үргэлж анхааралтай сонсож, дуулгавартай даган, эдгээрийг хэзээ ч үл тоож зүрхлээгүй ба Бурханы аливаа зарлигийг дур мэдэн өөрчилж мэдээж зүрхлээгүй. Энэ нь Бурханы Сатанд тогтоож өгсөн хязгаар тул Сатан эдгээр хязгаарыг хэзээ ч давж зүрхлээгүй. Бурханы эрх мэдлийн сүр хүч энэ биш гэж үү? Бурханы эрх мэдлийн гэрчлэл энэ биш гэж үү? Бурханд хэрхэн хандаж, Бурханыг хэрхэн үзэх талаар Сатан хүн төрөлхтнөөс илүү тодорхой мэддэг тул сүнсний ертөнц дэх Бурханы эрх мэдэл, байр суурийг маш тодорхой харж, Бурханы эрх мэдлийн сүр хүч болон Түүний эрх мэдлийн хэрэгжилтийн цаад зарчмуудыг илүү гүн гүнзгий ухамсарладаг. Сатан эдгээрийг үл ойшоож огтхон ч зүрхэлдэггүй бөгөөд ямар нэг байдлаар зөрчиж зүрхэлдэггүй, мөн Бурханы эрх мэдлийг зөрчих ямар ч зүйл хийдэггүй, ямар нэгэн байдлаар Бурханы уур хилэнг сорьж ч зүрхэлдэггүй. Хэдийгээр ёрын муу, биеэ тоосон уг чанартай боловч Сатан өөрт нь зориулж Бурханы тогтоосон зааг, хязгаарыг хэзээ ч давж зүрхлээгүй. Мянга мянган жилийн турш Сатан эдгээр зааг хязгаарыг чанд мөрдөж, Бурханы өгсөн бүх тушаал, зарлигийг мөрдсөн бөгөөд хэзээ ч энэ хэм хэмжээг давж зүрхлээгүй. Сатан хэдий хорлонтой боловч ялзарсан хүн төрөлхтнөөс хамаагүй ухаалаг; тэр Бүтээгчийн ялгамж чанарыг болон өөрийн хил хязгаарыг мэддэг. Бурханы эрх мэдэл, хүч чадал нь Сатаны зөрчиж чадахгүй тэнгэрийн зарлиг гэдгийг, мөн Бурханы эрх мэдэл болон цор ганц байдлаас л улбаалан бүх зүйл дэг журамтай байдлаар өөрчлөгдөж, үржиж олшрон, хүн төрөлхтөн Бурханы тогтоосон замналаар амьдарч, өсөн үржиж чаддаг бөгөөд ямар ч хүн юм уу эд юм энэ дэг журмыг нураах чадваргүй, ямар ч хүн юм уу, эд юм энэ хуулийг өөрчлөх чадваргүй гэдгийг Сатаны “хүлцэнгүй” үйлдлээс харж болно—учир нь эдгээр нь бүгд Бүтээгчийн гараас, Бүтээгчийн урьдчилан тогтоосноор, Бүтээгчийн эрх мэдлээс гарсан.

Бүтээгчийн ялгамж чанартай Бурханд л цор ганц эрх мэдэл байдаг

Сатаныг онцгой ялгамж чанартай болохоор нь маш олон хүн түүний янз бүрийн талын илрэлийг хүчтэй сонирхох болсон. Гайхамшиг үзүүлж, хүн төрөлхтний хийх боломжгүй зүйлсийг хийх чадвартай болохоор нь Сатаныг бас Бурхан шиг эрх мэдэл эзэмшдэг гэж боддог мунхаг хүмүүс ч олон байдаг. Иймээс хүн төрөлхтөн Бурханыг шүтэн мөргөхийн сацуу зүрх сэтгэлдээ Сатанд ч бас орон зай үлдээж, тэр ч бүү хэл Сатаныг Бурхан хэмээн шүтдэг. Энэ хүмүүс хөөрхийлөлтэй агаад жигшмээр. Тэд мэдлэггүй учраас хөөрхийлөлтэй ба тэрс үзэл, төрөлхийн ёрын муу

мөн чанарынхаа улмаас жигшүүртэй. Одоо та нарт, эрх мэдэл гэж юу болох, энэ нь юуг бэлгэдэж, юуг төлөөлдөг болохыг хэлэх шаардлагатай мэт Надад санагдаж байна. Ерөнхийд нь ярихад, Бурхан Өөрөө эрх мэдэл юм, Бурханы эрх мэдэл Өөрийнх нь дээдийн дээд байдал, мөн чанарыг бэлгэддэг ба Бурханы Өөрийн эрх мэдэл нь Бурханы байр суурь, ялгамж чанарыг төлөөлдөг. Ийм байхад Сатан өөрийгөө Бурхан гэж хэлж зүрхлэх үү? Сатан өөрийгөө бүх зүйлийг бүтээсэн, бүхнийг захирдаг гэж хэлж зүрхэлдэг үү? Мэдээж үгүй! Учир нь Сатан бүх зүйлийг бүтээх чадваргүй; өдийг хүртэл тэр Бурханы бүтээлээс нэг ч атугай зүйлийг бүтээж байсан удаагүй бөгөөд ямар нэг амьтай зүйлийг бүтээж үзээгүй. Учир нь түүнд Бурханы эрх мэдэл байхгүй, Бурханы байр суурь, ялгамж чанарыг хэзээ ч эзэмших боломжгүй бөгөөд энэ нь түүний мөн чанараар тодорхойлогддог. Түүнд Бурхантай адил хүч чадал бий юу? Мэдээж үгүй! Сатаны үйл, үзүүлсэн гайхамшгийг бид юу гэж нэрлэдэг вэ? Энэ нь хүч чадал уу? Үүнийг эрх мэдэл гэж нэрлэж болох уу? Мэдээж үгүй! Сатан хорон муу урсгалыг удирдаж, Бурханы ажлыг бүх талаар нурааж, доголдуулж, тасалдуулдаг. Сүүлийн хэдэн мянган жилд хүн төрөлхтнийг ялзруулж, зовоож, хүнийг урхидаж, мэхлэн доройтолд оруулж, хүнийг үхлийн сүүдэрт хөндий рүү явуулахын тулд Бурханыг голоход хүргэснээс бусдаар Сатан хүнд дурсагдаж, сайшаагдаж, нандигнамаар зүйл өчүүхэн төдийхнийг ч хийсэн гэж үү? Сатан эрх мэдэл, хүч чадал эзэмшдэг байсан бол хүн төрөлхтнийг ялзруулах байсан уу? Сатан эрх мэдэл, хүч чадал эзэмшдэг байсан бол хүн төрөлхтнийг хорлох байсан уу? Хэрвээ Сатан эрх мэдэл, хүч чадал эзэмшдэг байсан бол хүн төрөлхтөн Бурханыг орхиж, үхэл рүү явах байсан уу? Сатанд ямар ч эрх мэдэл, хүч чадал байдаггүй болохоор хийдэг бүхнийх нь мөн чанарыг бид юу гэж дүгнэх хэрэгтэй вэ? Сатаны хийдэг бүхнийг шалихгүй заль мэх гэж тодорхойлдог хүмүүс бий, гэхдээ тийм тодорхойлолт төдийлөн зохистой биш гэж Би боддог. Хүн төрөлхтнийг ялзруулсан түүний муу үйл нь шалихгүй заль мэх гэж үү? Иовыг хэрцгийлсэн Сатаны муу ёрын хүч болон түүнийг хэрцгийлж, залгих гэсэн догшин хүсэл нь шалихгүй заль мэх төдийхнөөр хийгдсэн байж хэрхэвч таарахгүй. Эргээд харвал, уул толгодоор хаяагүй таран бэлчсэн Иовын мал сүрэг хормын төдийд үгүй болсон; Иовын их хөрөнгө агшин зуурын төдийд алга болсон. Үүнийг шалихгүй заль мэх төдийхнөөр хийж болно гэж үү? Сатаны хийдэг бүхний уг чанар нь хохироох, тасалдуулах, устгах, хорлох, муу ёр, хорлонт байдал, харанхуй гэх мэт сөрөг нэр томьёотой таарч, нийцдэг тул шударга бус, ёрын муу бүх тохиолдол нь Сатаны үйлтэй нягт холбоотой, Сатаны муу ёрын мөн чанараас салшгүй байдаг. Сатан хэчнээн “хүчирхэг” ч бай, хэчнээн давлиун, амбицтай ч бай, хэчнээн их хор хохирол учруулах чадалтай ч бай, хүнийг ялзруулж, урхидах арга барил нь хэчнээн ч өргөн хүрээтэй бай, хүнийг айлган сүрдүүлэх заль мэх, явуулга нь хэчнээн ч ухаалаг бай, оршин тогтнодог хэлбэр нь хэчнээн ч хувирамтгай бай хамаагүй, тэр хэзээ ч ямар нэгэн амьд зүйлийг бүтээж чадаагүй, хэзээ ч бүх зүйлийн оршин тогтнолын хууль, дүрмийг тогтоож чадаагүй, бас амьтай, амьгүй аливаа эд юмыг

хэзээ ч удирдаж, захирч чадаагүй юм. Орчлон ертөнц, өргөн уудам газар нутаг даяар, түүнээс төрж, түүнээс болж оршин тогтнодог нэг ч хүн, нэг ч эд юм байхгүй; түүнд захируулж, удирдуулдаг нэг ч хүн, нэг ч юм байхгүй. Харин ч эсрэгээрээ, тэр Бурханы эрх мэдэл дор амьдрах ёстойгоор барахгүй Бурханы бүх тушаал, захирамжийг дуулгавартай дагах ёстой. Бурханы зөвшөөрөлгүйгээр газар дээрх дусал ус юм уу элсний ширхэгт хүрэх ч Сатанд хэцүү; Бурханы зөвшөөрөлгүйгээр Бурханы бүтээсэн хүн төрөлхтөн байтугай газар дээрх шоргоолжийг ч хөдөлгөх эрх чөлөө Сатанд байхгүй. Бурханы нүдээр бол Сатан, уулын сараана цэцэгс, агаарт нисэх шувууд, тэнгисийн загас, хөрс шороон дээрх өтнөөс ч дорд. Бүх зүйлийн дундах түүний үүрэг гэвэл бүх зүйлд болон хүн төрөлхтөнд үйлчилж, бас Бурханы ажил болон удирдлагын төлөвлөгөөнд үйлчлэх явдал юм. Түүний уг чанар хэчнээн ч хорлонтой, мөн чанар нь хэчнээн ч ёрын муу бай, Бурханд үйлчлэл үзүүлж, Бурханы товойлгогч байх чиг үүргээ лхариуцлагатайгаар биелүүлэх нь түүний хийж чадах ганц зүйл юм. Сатаны мөн чанар, байр суурь ийм байдаг. Түүний мөн чанар нь амь, хүч чадал, эрх мэдэлтэй холбоогүй; тэр бол ердөө л Бурханы гар дахь тоглоом, Бурханд үйлчлэх машин төдий юм!

Олон хүн Сатаны үнэн төрхийг ойлгочхоод, эрх мэдэл гэж юу болохыг бас л ойлгодоггүй, иймээс Би чамд хэлж өгье! Эрх мэдлийг Бурханы хүч чадал хэмээн тайлбарлаж болно. Нэгдүгээрт, эрх мэдэл, хүч чадал хоёрын аль аль нь эерэг гэдгийг баттай хэлж болно. Эдгээр нь ямар ч сөрөг зүйлтэй холбоогүй бөгөөд бүтээгдсэн, бүтээгдсэн бус ямар ч зүйлтэй хамаагүй. Бурханы хүч чадал нь амь болон амин чанар бүхий ямар ч хэлбэрийн зүйлсийг бүтээх чадвартай бөгөөд Бурханы амь үүнийг тогтоосон байдаг. Бурхан бол амь, иймээс Тэр бол бүх амьд зүйлийн эх сурвалж мөн. Түүнчлэн Бурханы эрх мэдэл нь Бурханы үг бүрийг бүх амьд зүйл дуулгавартай дагадаг болгож чаддаг, өөрөөр хэлбэл, тэд Бурханы амнаас гарах үгийн дагуу бий болж, Бурханы тушаалаар амьдарч, үрждэг. Дараа нь Бурхан бүх амьд зүйлийг захирч, тушаадаг бөгөөд үүрдийн үүрд хэзээ ч гажуудал гарахгүй. Ямар ч хүн, эд юманд эдгээр зүйл байхгүй; Бүтээгч л ийм хүч чадлыг эзэмшиж, агуулдаг тул үүнийг эрх мэдэл хэмээдэг. Энэ бол Бүтээгчийн цор ганц байдал билээ. Иймээс “эрх мэдэл” гэх үг нь өөрөө юу, эсвэл эрх мэдлийн мөн чанар нь уу гэдгээс үл хамааран аль алийг нь Бүтээгчтэй л холбон үзэж болдог, учир нь энэ нь Бүтээгчийн цор ганц ялгамж чанар, мөн чанарын бэлгэ тэмдэг бөгөөд Бүтээгчийн ялгамж чанар болон байр суурийг төлөөлдөг; Бүтээгчээс өөр хэн ч, юу ч “эрх мэдэл” хэмээх үгтэй холбоотой байж чадахгүй. Энэ бол Бүтээгчийн цор ганц эрх мэдлийн тайлбар билээ.

Хэдийгээр Сатан Иовыг шунахай харцаар харсан боловч Бурханы зөвшөөрөлгүйгээр Иовын бие дэх ширхэг үсэнд ч хүрч зүрхлээгүй. Сатан хэдий төрөлхийн ёрын муу, харгис ч гэсэн Бурханыг тушаал өгсний дараа тушаалыг нь дагахаас өөр сонголт түүнд байгаагүй. Иймээс Сатан Иов дээр ирэхдээ хонинд орсон чоно мэт улангассан байсан ч Бурханы өөрт нь тогтоосон хязгаарыг умартаж зүрхлээгүй,

Бурханы тушаалыг зөрчиж зүрхлээгүй ба хийсэн бүх зүйлдээ Сатан Бурханы үгийн зарчим болон хязгаарыг давж зүрхлээгүй—энэ баримт биш гэж үү? Сатан, Ехова Бурханы ямар ч үгийг зөрчиж зүрхэлдэггүй гэдгийг үүнээс харж болно. Сатанд бол Бурханы амнаас гарсан үг бүр тушаал, тэнгэрлэг хууль, Бурханы эрх мэдлийн илэрхийлэл юм—учир нь Бурханы тушаалыг зөрчдөг, учир нь Бурханы үг болгоны ард тушаалыг нь зөрчиж, тэнгэрлэг хуулийг дуулгавартай дагадаггүй хүмүүсийг шийтгэх Бурханы шийтгэл агуулагдаж байдаг. Бурханы тушаалыг зөрчвөл Бурханы эрх мэдэлд халдаж, тэнгэрлэг хуулийг эсэргүүцсэнийхээ үр дагаврыг хүртэх ёстойг Сатан тодорхой мэддэг. Тэгвэл эдгээр үр дагавар нь яг юу вэ? Эдгээр нь мэдээж Бурханы шийтгэл гэдгийг хэлэх нь илүүц юм. Сатаны Иовд гаргасан үйлдэл бол хүнийг ялзруулах үйлийнх нь бичил дүр зураг төдий зүйл байсан. Сатаны хэрэгжүүлэх эдгээр үйлдэлд Бурханы тогтоосон хязгаар, Сатанд өгсөн тушаал нь Сатаны хийдэг бүх зүйлийн ард үйлчилдэг зарчмуудын ердөө л бичил дүр зураг нь байсан юм. Үүнээс гадна, энэ асуудал дахь Сатаны үүрэг, байр суурь нь ердөө Бурханы удирдлагын ажил дахь түүний үүрэг, байр суурийн бичил дүр зураг байсан ба Иовыг сорихдоо Сатан Бурханд бүрэн дуулгавартай байсан нь Бурханы удирдлагын ажилд Бурханыг өчүүхэн төдий ч эсэргүүцэж зүрхлээгүйнх нь бичил дүр зураг төдий байсан. Эдгээр бичил дүр зураг та нарт ямар анхааруулга өгч байна вэ? Сатан байтугай бүх зүйлийн дотроос Бүтээгчийн тогтоосон тэнгэрлэг хууль, зарлигийг зөрчиж чадах, эдгээр тэнгэрлэг хууль, зарлигийг зөрчиж зүрхлэх ямар ч хүн болон зүйл үгүй. Учир нь эдгээрийг дуулгавартай дагадаггүй хүмүүст Бүтээгчийн оноодог шийтгэлийг ямар ч хүн болон эд юм өөрчилж, мултарч чаддаггүй. Бүтээгч л тэнгэрлэг хууль, зарлигийг тогтоож чадна, эдгээрийг хүчинтэй болгох хүч чадал Бүтээгчид л байдаг ба Бүтээгчийн хүч чадлыг л ямар ч хүн, эд зүйл даван гарч чадахгүй. Энэ бол Бүтээгчийн цор ганц эрх мэдэл, энэ эрх мэдэл нь бүх зүйлийн дунд дээдийн дээд тул “Бурхан хамгийн агуу нь, Сатан удаах нь” гэж хэлэх боломжгүй. Цор ганц эрх мэдлийг эзэмшсэн Бүтээгчээс өөр ямар ч Бурхан байхгүй!

Та нар одоо Бурханы эрх мэдлийн талаар шинэ мэдлэгтэй болсон уу? Нэгдүгээрт, дөнгөж сая дурдсан Бурханы эрх мэдэл болон хүний хүч чадлын хооронд ялгаа бий юу? Ялгаа нь юу вэ? Энэ хоёрыг хооронд нь харьцуулшгүй гэж зарим хүн хэлдэг. Тэр бол зөв! Энэ хоёрыг хооронд нь харьцуулшгүй гэж хүмүүс хэлдэг ч хүн бодол болон үзэлдээ хүний хүч чадлыг эрх мэдэлтэй байнга андуурч, энэ хоёрыг байнга нэг нэгэнтэй нь харьцуулдаг. Энд юу болоод байна вэ? Хүмүүс санамсаргүйгээр нэгийг нь нөгөөгөөр орлуулах алдаа гаргаж байгаа юм биш үү? Энэ хоёр хооронд холбоогүй, хооронд нь харьцуулшгүй байхад хүмүүс бас л андуурдаг. Үүнийг хэрхэн шийдвэрлэх ёстой вэ? Чи шийдэл үнэхээр олмоор байвал Бурханы цор ганц эрх мэдлийг ойлгож, мэдэх л ганц арга бий. Чи Бүтээгчийн эрх мэдлийг ойлгож мэдсэнийхээ дараа хүний эрх мэдэл, Бүтээгчийн эрх мэдэл хоёрыг эн тэнцүү ярихгүй.

Хүний эрх мэдэл гэж юуг хэлдэг вэ? Энгийнээр хэлбэл, энэ нь хүний ялзарсан зан чанар, хүсэл, санаархлыг асар ихээр нэмэгдүүлэх юм уу биелэх боломжтой болгодог чадал, чадвар юм. Үүнийг эрх мэдэл гэж үзэх үү? Хүний хүсэл, санаархал хэчнээн маадгар, шунахай байлаа ч тэр хүнийг эрх мэдэл эзэмшдэг гэж хэлж болохгүй; сайндаа л энэхүү додигор байдал, амжилт нь хүмүүсийн дундах Сатаны маазралын илэрхийлэл төдий, сайндаа л энэ нь Бурхан болох гэсэн эрмэлзлээ биелүүлэхийн тулд Сатан өөрөө өөрийнхөө өвөг дээдэс мэт авирладаг инээдтэй явдал юм.

Чи одоо Бурханы эрх мэдлийг яг хэрхэн үзэж байна вэ? Эдгээр үгийн талаар нөхөрлөчихсөн юм чинь чи Бурханы эрх мэдлийн талаар шинэ мэдлэгтэй болсон байх ёстой. Иймээс Би та нараас асууя: Бурханы эрх мэдэл юуг бэлгэддэг вэ? Бурханы Өөрийн ялгамж чанарыг бэлгэддэг үү? Бурханы Өөрийн хүч чадлыг бэлгэддэг үү? Бурханы Өөрийн цор ганц байр суурийг бэлгэддэг үү? Бүх зүйлийн дунд чи Бурханы эрх мэдлийг юунаас харсан бэ? Яаж харсан бэ? Хүний туулдаг дөрвөн улирлын тухайд, хавар, зун, намар, өвөл ээлжлэн солигдох хуулийг хэн нэгэн хүн өөрчилж чадах уу? Хавар мод нахиалж, цэцэглэдэг; зун навчаар бүрхэгддэг; намар жимс нь ургаж, өвөл навчис унадаг. Энэ хуулийг хэн нэгэн өөрчилж чадах уу? Энэ нь Бурханы эрх мэдлийн нэг талыг харуулдаг уу? Бурхан “Гэрэл бий болог” хэмээн хэлэхэд гэрэл бий болсон. Энэхүү гэрэл одоо ч оршдог уу? Энэ нь юунаас болж оршдог вэ? Мэдээж Бурханы үг, Бурханы эрх мэдлийн ачаар оршин тогтнодог. Бурханы бүтээсэн агаар одоо ч оршсоор байдаг уу? Хүний амьсгалдаг агаар Бурханаас үүсэлтэй юу? Бурханаас ирдэг зүйлсийг хэн нэгэн булаан авч чадах уу? Эдгээрийн мөн чанар, чиг үүргийг хэн нэгэн өөрчилж чадах уу? Бурханы хуваарилсан өдөр, шөнийг болон Бурханы тушаасан өдөр шөнийн хуулийг хэн нэгэн сүйтгэх чадвартай юу? Сатан ийм зүйл хийж чадах уу? Чи шөнө унталгүй, шөнийг өдөр гэж үзсэн ч гэсэн шөнийн цаг хэвээр л байна; чи өдөр тутмын хэвшлээ өөрчилж болох ч өдөр шөнө ээлжлэн солигдох хуулийг өөрчлөх чадваргүй—энэ баримтыг ямар ч хүн өөрчлөх аргагүй, тийм биз дээ? Арсланг анжсанд үхэр шиг хөллөөд, газар хагалуулж чадах хүн бий юу? Зааныг илжиг болгон өөрчилж чадах хүн бий юу? Тахиаг бүргэд мэт тэнгэрт дүүлэн нисгэж чадах хүн бий юу? Чоныг хонь мэт өвс идүүлж чадах хүн бий юу? (Үгүй.) Усны загасыг хуурай газар дээр амьдруулж чадах хүн бий юу? Үүнийг хүмүүс хийж чадахгүй. Яагаад чадахгүй гэж? Бурхан усанд амьдар гэж загасанд тушаасан учраас тэд усанд амьдардаг. Тэд газар дээр амьд үлдэж чадалгүй үхнэ; Бурханы тушаалын хязгаарыг давж чадахгүй. Бүх зүйлд оршин тогтнох хууль, хил хязгаар байдаг ба бүгд өөрсдийн гэсэн төрөлх араншинтай байдаг. Эдгээрийг Бүтээгч тушаасан ба ямар ч хүн өөрчилж, даван гарах аргагүй. Жишээлбэл, арслан хүний нийгмээс үргэлж хол, зэрлэг байгальд амьдрах бөгөөд хүнтэй хамт амьдарч, хүний төлөө ажилладаг шар үхэр адил номхон, үнэнч байж хэзээ ч чадахгүй. Хэдийгээр заан, илжиг хоёр хоёулаа амьтан, хоёулаа дөрвөн хөлтэй, агаараар амьсгалдаг бүтээл

боловч төрөл зүйл нь ондоо байдаг. Учир нь тэднийг Бурхан өөр өөр төрөлд хуваасан, тэд тус тусын зөн мэдрэмжтэй, иймээс тэд хэзээ ч нэг нь нөгөөгөө орлохгүй. Хэдийгээр тахиа бүргэд шиг хоёр хөлтэй, хос далавчтай боловч хэзээ ч агаарт нисэж чадахгүй; сайндаа л модон дээр гарч чаддаг—энэ нь зөн мэдрэмжээр нь тодорхойлогддог. Энэ бүхэн нь Бурханы эрх мэдлийн тушаалаас үүддэг гэдгийг хэлэх нь илүүц юм.

Өнөөгийн хүн төрөлхтний хөгжлийн хувьд хүн төрөлхтний шинжлэх ухааныг хөгжин цэцэглэж яваа гэж хэлж болох бөгөөд хүний шинжлэх ухааны эрэл хайгуулын ололт амжилтыг бахдам гэж тодорхойлж болно. Хүний чадвар улам их өсөж байгаа гэж хэлж болох ч хүн төрөлхтөн шинжлэх ухаанаар нээлт хийж чаддаггүй нэг зүйл байдаг: Хүн төрөлхтөн нисэх онгоц, нисэх онгоц тээвэрлэгч болон цөмийн бөмбөг хийсэн, хүн төрөлхтөн сансарт нисэж, саран дээр алхаж, интернэт зохион бүтээж, өндөр технологи бүхий амьдралын хэв маягаар амьдарсан, гэсэн ч хүн төрөлхтөн амьд, амьсгалдаг зүйлийг бүтээх чадваргүй байна. Амьтан бүрийн зөн мэдрэмж, амьдардаг хууль, мөн бүх төрлийн амьд зүйлийн амьдрал, үхлийн мөчлөг—энэ бүхэн нь хүн төрөлхтний шинжлэх ухаанд боломжгүй, мөн захирагдахгүй. Одоо, хүний шинжлэх ухаан хэчнээн их өндөрлөгт хүрсэн ч бай, Бүтээгчийн ямар ч бодолтой харьцуулшгүй юм. Энэ нь Бүтээгчийн бүтээлийн гайхалтай байдал болон Түүний эрх мэдлийн сүр хүчийг хэмжих чадваргүй гэдгийг хэлэх ёстой. Газар дэлхий дээр маш олон далай тэнгис байдаг боловч эдгээр нь хэзээ ч хязгаараа давж, хуурай газар дээр дураараа гарч ирээгүй, учир нь Бурхан дор бүрд нь хил хязгаар тогтоож өгсөн; эдгээр нь Түүний хаа тушаасан газарт байдаг бөгөөд Бурханы зөвшөөрөлгүйгээр ийш тийш чөлөөтэй нүүж чаддаггүй. Эдгээр нь Бурханы зөвшөөрөлгүйгээр бие биедээ халдаж болдоггүй бөгөөд Бурханыг хөдөл гэхэд л хөдөлж чаддаг. Хаа хүрч, хаана үлдэхийг нь Бурханы эрх мэдэл тодорхойлдог.

Шулуухан хэлэхэд, “Бурханы эрх мэдэл” гэдэг нь Бурханаас хамаарна гэсэн үг юм. Аливаа зүйлийг яаж хийхийг шийдэх эрх Бурханд байдаг бөгөөд Тэр хүссэнээрээ л хийдэг. Бүх зүйлийн хууль хүнээс бус, Бурханаас хамаардаг; үүнийг хүн өөрчилж чадахгүй. Энэ нь хүний хүслээр хөдлөхгүй, харин Бурханы бодол, Бурханы мэргэн ухаан, Бурханы тушаалаар өөрчлөгддөг, энэ нь ямар ч хүний үгүйсгэж чадахгүй баримт юм. Тэнгэр, газар, бүх зүйл, орчлон ертөнц, одот тэнгэр, жилийн дөрвөн улирал гэх мэт хүнд харагдах болон үл харагдах зүйлс—бүгд Бурханы эрх мэдлийн дор, Бурханы захирамжийн дагуу, Бурханы тушаалын дагуу, бүтээлийн эхлэлийн хуулийн дагуу өчүүхэн төдий ч алдаа мадаггүйгээр оршин тогтнож, үйл ажиллагаа явуулж, өөрчлөгдөж байдаг. Ганц ч хүн, эсвэл эд юм өөрсдийн хуулийг өөрчилж чадахгүй, бас үйл ажиллагаагаа явуулдаг төрөлхийн замналаа ч өөрчилж чадахгүй; тэд Бурханы эрх мэдлээс үүдэн бий болсон бөгөөд Бурханы эрх мэдлийн улмаас мөхдөг. Энэ бол Бурханы эрх мэдэл юм. Энэ хэрийн зүйл ярьсны дараа чи, Бурханы эрх мэдэл нь Бурханы ялгамж чанар болон байр

суурийн бэлгэ тэмдэг гэдгийг мэдэрч байна уу? Бурханы эрх мэдлийг аливаа бүтээгдсэн, бүтээгдсэн бус зүйл эзэмшиж чадах уу? Үүнийг ямар нэг хүн, зүйл, эсвэл эд юм дуурайж, хуулбарлаж, орлож чадах уу?

Бүтээгчийн ялгамж чанар цор ганц бөгөөд чи олон бурхан шүтэх үзэл санааг баримтлах ёсгүй

Сатаны чадвар, чадамж хүнийхээс илүү бөгөөд хүний биелүүлэх аргагүй зүйлийг хийж чаддаг хэдий ч, Сатаны хийдэг зүйлд чиний атаархдаг эсвэл хүрэхийг эрмэлздэг эсэх, тэдгээрийг нь чи үзэн яддаг эсвэл жигшдэг эсэхээс үл хамааран, тэдгээрийг чи харж чаддаг ч бай, үгүй ч бай, Сатан хэр ихийг бүтээж, хэчнээн олон хүнийг мэхлэн өөрийгөө шүтүүлж, тахиулж чаддаг ч бай, түүнийг чи яаж ч тодорхойлдог бай хамаагүй Сатанд Бурханы эрх мэдэл, хүч чадал бий гэж хэлэх ямар ч боломжгүй. Бурхан бол Бурхан бөгөөд цорын ганцхан Бурхан байдаг гэдгийг чи мэдэх ёстой. Түүнчлэн, Бурханд л эрх мэдэл байдаг бөгөөд бүх зүйлийг захирч, удирдах хүч чадал байдаг гэдгийг чи мэдэх ёстой. Сатан хүмүүсийг хуурах чадвартай, Бурханыг дуурайж, Бурханы үзүүлсэн тэмдэг, гайхамшгийг хуулбарлаж чаддаг, мөн Бурханы хийсэнтэй төстэй зүйл хийдэг болохоор чи Бурханыг цор ганц биш, олон байдаг, тэд зүгээр л их, бага ур чадвартай, эзэмшдэг хүч чадлынх нь хүрээ ялгаатай гэж андуу ташаа бодож болохгүй. Чи тэдний агуу байдлыг ирсэн дараалал, насны эрэмбээр нь жагсааж, Бурханаас өөр шүтээн байдаг, Бурханы эрх мэдэл, хүч чадал цор ганц биш хэмээн эндүүрэн бодож болохгүй. Хэрвээ чи ийм үзэл санаатай бол, хэрвээ чи Бурханы цор ганц чанарыг хүлээн зөвшөөрдөггүй, бас Бурхан л эрх мэдэл эзэмшдэг гэж боддоггүй бол, хэрвээ чи зөвхөн олон бурхан шүтэх үзэл санааг баримталдаг бол Би чамайг Бүтээлийн дундах хог шаар, Сатаны жинхэнэ биелэл, бас туйлын муу ёрын хүн гэж хэлнэ! Эдгээр үгийг хэлснээр Би та нарт юу заах гээд байгааг ойлгож байна уу? Цаг хугацаа, газар нутаг, чиний гарал үүсэл ямар байх нь хамаагүй, чи Бурханыг өөр ямар ч хүн, зүйл, эсвэл эд юмтай андуурах ёсгүй. Бурханы эрх мэдэл болон Бурханы Өөрийн мөн чанар чамд хэчнээн тайлагдашгүй, хүрэх аргагүй мэт санагддаг ч бай, Сатаны үг, үйл хэрэг чиний үзэл, төсөөлөлтэй хэчнээн их нийцдэг ч бай, эдгээрт чи хэчнээн сэтгэл ханамжтай байдаг ч бай бүү тэнэглэ, эдгээр ойлголтыг бүү хольж хутга, Бурханы оршин тогтнолыг бүү үгүйсгэ, Бурханы ялгамж чанар, байр суурийг бүү үгүйсгэ, зүрх сэтгэл дэх Бурханаа орлуулж, Бурханаа болгох гэж Сатаныг бүү оруул, Бурханыг бүү түлхэн гарга. Та нар ингэснийхээ үр дагаврыг төсөөлж чадна гэдэгт чинь Би эргэлзэхгүй байна!

Хүн төрөлхтөн хэдий ялзарсан ч гэсэн Бүтээгчийн эрх мэдлийн дээд эрх дор амьдарсаар байдаг

Сатан хүн төрөлхтнийг олон мянган жилийн турш ялзруулж ирсэн. Тэр тоолохын аргагүй олон ёрын мууг үйлдэж, үе үеийнхнийг хууран мэхэлж, дэлхий

дээр аймшигтай том нүгэл үйлдсэн. Тэр хүнийг зовоож, хууран мэхэлж, Бурханы эсрэг уруу татаж, бас Бурханы удирдлагын төлөвлөгөөг нурааж, доголдуулах муу үйл хэргийг ахин дахин үйлдсэн. Гэсэн ч Бурханы эрх мэдэл дор бүх зүйл болон амьд амьтад Бурханы тогтоосон хууль, дүрмийг үргэлжлүүлэн баримталдаг. Бурханы эрх мэдэлтэй харьцуулахад Сатаны муу ёрын уг чанар, цадиггүй явдал маш муу муухай, маш ой гутам, жигшүүртэй, маш өчүүхэн агаад хэврэг юм. Хэдийгээр Сатан Бурханы бүтээсэн бүх зүйлийн дунд алхдаг ч гэсэн Бурханд захирагддаг хүмүүс, зүйлс, эд юмст өчүүхэн төдий ч өөрчлөлт оруулж чадахгүй. Хэдэн мянган жил өнгөрсөн ба хүн төрөлхтөн одоо ч Бурханы хайрласан гэрэл, агаарыг эдэлж, Бурханы Өөрийн гаргасан амьсгаагаар амьсгалж, Бурханы бүтээсэн цэцэгс, шувууд, загас жараахай, шавж хорхойг эдэлж, Бурханы хангасан бүх зүйлийг эдэлдэг; өдөр шөнө бас л үргэлжлэн ар араасаа солигддог; дөрвөн улирал ердийнхөөрөө ээлжилдэг; тэнгэрт нисэх галуу энэ өвөл нүүдэллэн одож, дараа хавар нь эргэн ирдэг; усан дахь загас жараахай өөрсдийн гэр болох гол, нуурыг хэзээ ч орхидоггүй; газар дээрх голио зуны өдрүүдэд хоолой мэдэн донгоддог; өвсөн дундах хүрэлзгэнэ намрын салхины аясаар аяархан гүнгэнэдэг; галуу сүрэглэн цуглардаг байхад бүргэд ганцаараа амьдардаг; арслангийн сүрэг ан хийн амь зогоодог; хандгай өвс ногоо, цэцэгсээс холддоггүй… Бүх зүйлийн дундах төрөл бүрийн амьтад холдон одож, эргэн ирдэг, дараа нь дахин оддог гээд л нүд ирмэхийн төдийд үй түмэн өөрчлөлт тохиолддог—харин тэдний зөн мэдрэмж, амьд үлдэх хууль л өөрчлөгддөггүй. Тэд Бурханы хангалт, тэжээл дор амьдардаг бөгөөд зөнг мэдрэмжийг нь хэн ч өөрчилж, амьд үлдэх дүрмийг нь хэн ч доголдуулж чадахгүй. Хэдийгээр бүх зүйлийн дунд амьдардаг хүн төрөлхтнийг Сатан ялзруулж, мэхэлсэн боловч Бурханы бүтээсэн ус, Бурханы бүтээсэн агаар, Бурханы бүтээсэн бүх зүйлээс тэд бас л татгалзаж чадахгүй бөгөөд Бурханы бүтээсэн энэхүү орон зайд хүн амьдарч, өсөн үржсээр байдаг. Хүн төрөлхтний зөн мэдрэмж өөрчлөгдөөгүй. Хүн одоо ч харахын тулд нүд, сонсохын тулд чих, бодохын тулд уураг тархи, ойлгохын тулд зүрх сэтгэл, алхахын тулд хөл, ажиллахын тулд гар гэх зэрэгтээ түшиглэдэг; Бурханы хангалтыг хүлээн зөвшөөрч чаддаг болгох гэж Бурханаас хүнд хайрласан бүх зөн мэдрэмж нь өөрчлөгдөлгүй хэвээр үлдсэн, Бурхантай хамтран ажиллах хүний чадавх өөрчлөгдөөгүй, бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлэх хүн төрөлхтний чадавх өөрчлөгдөөгүй, хүн төрөлхтний сүнслэг хэрэгцээ өөрчлөгдөөгүй, гарал үүслээ олж тогтоох хүн төрөлхтний хүсэл өөрчлөгдөөгүй, Бүтээгчээр аврууллах гэсэн хүн төрөлхтний хүсэл тэмүүлэл ч өөрчлөгдөөгүй. Бурханы эрх мэдэл дор амьдарч, Сатаны авчирсан цуст сүйрлийг тэвчсэн хүн төрөлхтний одоогийн нөхцөл байдал энэ юм. Хэдийгээр хүн төрөлхтөн Сатаны дарангуйлалд орж, бүтээлийн эхлэлийн Адам, Ева биш болж, мэдлэг, төсөөлөл, үзэл гэх мэт Бурхантай тэрслэх зүйлс болон ялзарсан сатанлаг зан чанараар дүүрсэн боловч Бурханы нүдэнд одоо ч Өөрийнх нь бүтээсэн тэр хүн төрөлхтөн хэвээрээ юм. Хүн төрөлхтөн одоо ч Бурханд захирагдаж, зохион

байгуулагдаж, одоо ч Бурханы тогтоосон замналаар амьдардаг, иймээс Сатаны ялзруулсан хүн төрөлхтөн нь Бурханы нүдээр бол жаахан хир буртагт баригдсан, хоржигносон ходоодтой, үл ялиг удаан хөдөлгөөнтэй, өмнөх шигээ сайн ой санамжтай байхаа больж, бага зэрэг хөгширсөн төдий л боловч хүний бүх чиг үүрэг, зөн билэг нь тэр чигтээ бүрэн бүтэн харагддаг. Энэ бол Бурханы аврах гэж зорьдог хүн төрөлхтөн юм. Энэ хүн төрөлхтөн Бүтээгчийн дуудлагыг сонсож, Бүтээгчийн дуу хоолойг сонсох л юм бол энэ дуу хоолойны эх үүсвэрийг олж тогтоохоор яаран босох болно. Энэ хүн төрөлхтөн Бүтээгчийн дүрийг харах л юм бол Бурханд өөрийгөө зориулахын тулд өөр юуг ч хайхрахаа больж, бүх зүйлийг орхиж, тэр ч байтугай өөрийн амийг Түүний төлөө зориулах болно. Зүрх сэтгэл нь Бүтээгчийн үнэн сэтгэлийн үгийг ойлгох үед хүн төрөлхтөн Сатаныг хаяж, Бүтээгчийн талд ирэх болно; хүн төрөлхтөн биеийнхээ хир буртгийг бүрэн угааж, Бүтээгчийн хангалт, тэжээлийг дахин нэг удаа хүртсэн үед хүн төрөлхтний ой санамж сэргэж, энэ үед хүн төрөлхтөн Бүтээгчийн эрх мэдэл дор үнэхээр эргэн очсон байх болно.

2013 оны 12 дугаар сарын 14

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ II
БУРХАНЫ ЗӨВТ ЗАН ЧАНАР

Бурханы эрх мэдлийн тухай өмнөх нөхөрлөлийг одоо та нар сонссон болохоор энэ асуудлын талаар нэлээд их үгээр зэвсэглэсэн гэдэгт чинь Би итгэлтэй байна. Та нар хэр ихийг хүлээн авч, ухаарч, ойлгож чадах нь бүгд хэр их хичээл зүтгэл гаргахаас чинь хамаардаг. Та нар энэ асуудалд чин сэтгэлээсээ хандаж чадна гэж Би найдаж байна; үүнд хайнга хандаж огт болохгүй! Тэгвэл, Бурханы эрх мэдлийг мэдэх нь Бурханыг бүхэлд нь мэдэхтэй адилхан уу? Бурханы эрх мэдлийг мэдэх нь цор ганц Бурханыг Өөрийг нь мэдэхийн эхлэл гэж хэлж болох бөгөөд Бурханы эрх мэдлийг мэднэ гэдэг нь хүн цор ганц Бурханы Өөрийнх нь мөн чанарыг мэдэх үүд хаалгаар аль хэдийн алхан орсон гэсэн үг гэж бас хэлж болно. Энэхүү ойлголт нь Бурханыг мэдэхийн нэг хэсэг юм. Тэгвэл нөгөө хэсэг нь юу вэ? Өнөөдөр Миний нөхөрлөхийг хүсэж буй сэдэв бол энэ—Бурханы зөвт зан чанар билээ.

Би өнөөдрийн сэдвийн талаар нөхөрлөхөөр Библиэс хоёр хэсгийг сонгон авсан: Эхнийх нь Бурхан Содомыг устгахтай хамаатай ба үүнийг Эхлэл 19:1–11 болон Эхлэл 19:24–25-аас олж харж болно; хоёр дахь нь Бурхан Ниневег чөлөөлөхтэй хамаатай бөгөөд үүнийг Иона 1:1–2-оос болон Ионагийн номын гурав, дөрөв дэх бүлгээс олж харж болно. Энэ хоёр хэсгийн талаар юу хэлэхийг минь сонсохоор та бүхэн хүлээж байгаа гэж Би таамаглаж байна. Мэдээжийн хэрэг, Миний хэлэх зүйл Бурханыг Өөрийг нь мэдэх, Түүний мөн чанарыг мэдэх тухай цар хүрээнээс давж болохгүй, гэхдээ өнөөдрийн нөхөрлөл юун дээр төвлөрөх вэ? Та нараас хэн нэг чинь үүнийг мэдэх үү? Бурханы эрх мэдлийн тухай Миний нөхөрлөлийн аль хэсэг анхаарлыг чинь татсан бэ? Тийм эрх мэдэл, хүч чадлыг эзэмшдэг Нэгэн л Бурхан Өөрөө гэж Би яагаад хэлсэн бэ? Ингэж хэлснээрээ Би юуг тайлбарлахыг хүссэн бэ? Үүнээс та нар юу сураасай гэж Би хүссэн бэ? Бурханы мөн чанарыг илэрхийлдэг нэг тал нь Түүний эрх мэдэл, хүч чадал мөн үү? Тэдгээр нь Түүний ялгамж чанар, байр суурийг баталдаг мөн чанарынх нь нэг хэсэг мөн үү? Эдгээр асуултад үндэслэн Миний юу ярих гэж байгааг та нар хэлж чадах уу? Би юуг та нарт ойлгуулахыг хүсэж байна вэ? Үүнийг сайтар эргэцүүлэн бод.

Бурханыг зөрүүдлэн эсэргүүцсэнийхээ төлөө хүн Бурханы уур хилэнд сүйрдэг

Юуны түрүүнд, Бурхан Содомыг сүйрүүлсэн тухай тайлбарласан судрын хэдэн хэсгийг харцгаая.

Эхлэл 19:1–11 Хоёр тэнгэрэлч Содомд нар жаргах цагаар ирэхэд Содомын гол хаалган дээр сууж байсан Лот тэднийг хараад угтан босож, нүүрээрээ газар унан мөргөөд: “Хараач, эзэд минь, зам зуурtаа зарцынхаа гэрт орж, бүхий л шөнөжингөө саатан, хөлөө угааж, өглөө эрт босоод аян замдаа гарна уу” гэж хэлэв. Тэд, “Үгүй, бид бүхэл шөнийг гадаа өнгөрөөнө” гэлээ. Тэр тэднийг ихэд хүчлэн гуйсанд тэд түүний гэрт оржээ; тэр тэднийг

дайлж цайлан, исгээгүй талх барьж өгснийг тэд идэв. Харин тэднийг хэвтэхээс өмнө хотын хүмүүс буюу Содомын хүмүүс хүртэл хөгшин залуугүй дөрвөн зүгээс ирж, гэрийг нь бүслээд Лотыг дуудаж: “Энэ шөнө танайд ирсэн хүмүүс хаана байна? Тэднийг бидэнд авчир, бид тэдэнтэй хүссэнээ хийе” гэцгээв. Лот гарч ирж, хаалгаа хаагаад “Ах дүү нар минь, ийм муухай зүйл битгий хийгээч гэж би та нараас гуйж байна. Хараач, би эр хүн үзээгүй хоёр охинтой; тэднийг та нарт авчрахыг минь зөвшөөрөөч, та нар сайн гэж үзсэн зүйлээ тэдэнтэй хий: манай гэрт ирсэн учраас энэ хүмүүст л юу ч битгий хийгээрэй” гэж хэлэв. Тэд, “Хойшоо бай. Энэ хүмүүс түр хугацаагаар ирчихээд бас шүүгч болох юм гэнэ: бид чамд тэднээс муугаар хандана” гээд Лотыг хүртэл хүчээр түлхэж, хаалгыг нь эвдэхээр дөхөж очлоо. Харин нөгөө хүмүүс гараа сунган Лотыг гэрт татан оруулж, хаалгыг хаав. Тэгээд тэд гэрийн хаалган дээр байсан хүмүүсийг том жижиггүй юу ч харахгүй болгосонд тэд хаалга олох гэж ихэд зүдрэв.

Эхлэл 19:24–25 Тэгээд Ехова Содом, Гоморра хоёрт хүхэр ба галыг тэнгэрээс Еховагаас илгээж; хотуудыг, бүх тал хөндийг болон хотын бүх оршин суугчийг, газар дээрх ургамал амьтан бүгдийг сүйрүүлэв.

Содомын хорон муу, завхрал нь хүн болон Бурханы аль аль нь жигшихээр түвшинд хэдийнээ хүрсэн учраас Бурханы нүдэнд бол уг хотыг сүйрүүлэх нь зүйтэй байсан гэдгийг эдгээр хэсгээс ойлгоход хэцүү биш юм. Гэхдээ сүйрүүлэхээс өмнө хотын дотор юу болсон бэ? Эдгээр үйл явдлаас хүмүүс ямар урам зориг авч болох вэ? Эдгээр үйл явдалд хандах Бурханы хандлага нь Түүний зан чанарын талаар хүмүүст юуг харуулдаг вэ? Үйл явдлыг бүхэлд нь ойлгохын тулд Сударт юу гэж тэмдэглэснийг анхааралтай уншицгаая…

Содомын завхрал: Хүний уурыг хүргэж, Бурханыг хилэгнүүлэв

Тэр шөнө, Лот Бурханы илгээсэн хоёр элчийг хүлээн авч, тэдэнд зоог бэлдэж өгчээ. Хоол идсэний дараа, тэднийг хэвтэцгээхээс өмнө хотын өнцөг булан бүрээс хүмүүс ирж, Лотын байшинг тойрон хүрээлж, түүнийг дуудсан. Тэднийг “Энэ шөнө танайд ирсэн хүмүүс хаана байна? Тэднийг бидэнд авчир, бид тэдэнтэй хүссэнээ хийе” хэмээсэн гэж Сударт тэмдэглэсэн байдаг. Хэн энэ үгийг хэлсэн бэ? Хэнд энэ үгийг хэлсэн бэ? Энэ нь байшингийнх нь гаднаас Лотод сонсгох гэж хашхирах Содомын ард иргэдийн үг байсан. Эдгээр үгийг сонсоход ямар санагдаж байна вэ? Чиний уур хүрч байна уу? Эдгээр үг зэвүүг чинь хүргэж байна уу? Уур хилэн чинь буцалж байна уу? Эдгээр үгээс Сатан нэвт мэдрэгдэж байгаа бус уу? Тэдгээрээс чи энэ хот дахь ёрын муу, хар барааныг мэдэрч чадаж байна уу? Үгээр нь дамжуулан чи энэ хүмүүсийн хэрцгий, бүдүүлэг зан авирыг мэдэрч чадаж байна уу? Тэдний үйлдлээс завхрал нь хэр гүн байгааг мэдэрч чадаж байна уу? Тэдний хорон муу уг чанар, харгис хэрцгий зан чанар өөрсдөө ч хянахын аргагүй түвшинд хүрсэн гэдгийг хэлсэн үгийнх нь агуулгаас харах хэцүү биш. Лотыг эс тооцвол, энэ хотын хүн бүхэн Сатанаас ялгаагүй байсан; өөр хүнийг харах төдийд энэ хүмүүс хорлож, сүйтгэхийг хүсэж байв… Эдгээр зүйл нь, энэ хотын аюулт, аймшигт

чанараас гадна эргэн тойрных нь үхлийн аураг хүнд мэдрүүлээд зогсохгүй хорон муу, цусанд шунасан байдлыг нь бас мэдрүүлдэг.

Хүний сүнсийг залгих галзуу хүслээр дүүрэн хүмүүс, хүний үнэргүй бүлэг дээрэмчинтэй нүүр тулаад Лот хэрхэн хариу барьсан бэ? Сударт өгүүлснээр: “Ийм муухай зүйл битгий хийгээч гэж би та нараас гуйж байна. Хараач, би эр хүн үзээгүй хоёр охинтой; тэднийг та нарт авчрахыг минь зөвшөөрөөч, та нар сайн гэж үзсэн зүйлээ тэдэнтэй хий: манай гэрт ирсэн учраас энэ хүмүүст л юу ч битгий хийгээрэй” гэжээ. Лот энэ үгээрээ юу хэлэх гэсэн бэ гэвэл: Элч нарыг хамгаалахын тулд тэрээр хоёр охиноо өгөхөд бэлэн байв. Ямар ч эрүүл ухаанаар тооцож үзвэл, тэр хүмүүс Лотын болзлыг зөвшөөрч, хоёр элчийг тайван орхих ёстой байлаа; эцсийн эцэст, элч нар тэдний хувьд огт танихгүй, тэдэнтэй ямар ч хамаагүй, ашиг сонирхолд нь ямар ч хохирол учруулаагүй хүмүүс байсан. Гэвч, хорон муу уг чанартаа автсан тэд уг асуудлыг ингээд орхиогүй, харин ч хүчин чармайлтаа улам нэмэгдүүлсэн. Энд байгаа тэдний өөр нэг харилцан яриа нь, энэ хүмүүсийн жинхэнэ, хорон уг чанарын талаар илүү гүнзгий ойлголтыг хүмүүст гарцаагүй өгч чадахын зэрэгцээ Бурхан яагаад энэ хотыг сүйрүүлэхийг хүссэн шалтгааныг ухаарч, ойлгох боломжийг хүмүүст олгодог.

Тэд дараа нь юу гэж хэлсэн бэ? Библид өгүүлснээр: “Тэд, ‘Хойшоо бай. Энэ хүмүүс түр хугацаагаар ирчихээд бас шүүгч болох юм гэнэ: бид чамд тэднээс муугаар хандана’ гээд Лотыг хүртэл хүчээр түлхэж, хаалгыг нь эвдэхээр дөхөж очлоо.” Тэд яагаад Лотын хаалгыг эвдэхийг хүссэн бэ? Учир нь тэд, тэр хоёр элчид хор хүргэхээр байж ядаж байсан юм. Тэрхүү элч нар яах гэж Содомд ирсэн бэ? Тэдний ирсэн зорилго нь Лот болон түүний гэр бүлийг аврах явдал байсан боловч, хотын хүмүүс тэднийг албан тушаал хүлээн авахаар ирсэн хэмээн андуурсан юм. Хотын хүмүүс цэвэр таамаглал дээр үндэслэж зорилгыг нь асуулгүйгээр энэхүү хоёр элчид хэрцгийгээр хор хүргэхийг хүссэн; тэд өөрсөдтэй нь огтоос хамаагүй хоёр хүнд хор хүргэхийг хүссэн. Энэ хотын хүмүүс хүн чанар, эрүүл ухаанаа бүрмөсөн алдсан байсан нь тодорхой. Тэдний галзуурал, зэрлэг догшин байдлын түвшин нь хүмүүсийг хорлож, сүйтгэдэг Сатаны хорон уг чанараас хэдийнээ ялгаагүй болсон байлаа.

Тэд Лотоос энэ хүмүүсийг өгөхийг шаардахад Лот юу хийсэн бэ? Лот тэднийг өгөөгүйг бид бичвэрээс мэднэ. Бурханы энэ хоёр элчийг Лот мэддэг байсан уу? Мэдээж үгүй! Гэтэл тэр яагаад энэ хоёр хүнийг аварч чадсан бэ? Тэд юу хийхээр ирснийг тэр мэдэж байсан уу? Хэдийгээр ирсэн шалтгааныг нь мэдээгүй боловч Бурханы зарц нар гэдгийг нь Лот мэдэж байсан тул тэднийг гэртээ оруулсан юм. Тэрээр Бурханы энэхүү зарц нарыг “эзэн” хэмээх цолоор дуудаж байсан нь Лот бол Содомын бусад хүмүүстэй адилгүй, Бурханы сурамгай дагагч байсныг нь харуулдаг. Тиймээс Бурханы элч нар өөр дээр нь ирэх үед энэ хоёр зарцыг гэртээ оруулахын тулд тэрээр амь насаараа дэнчин тавьсан; түүнчлэн энэхүү хоёр зарцыг хамгаалахын тулд хоёр охиноороо солих санал тавьсан. Энэ бол Лотын зөв

шударга үйл хэрэг байсан; энэ нь Лотын уг чанар-мөн чанарын бодит илэрхийлэл, мөн Лотыг аврахын тулд Бурхан Өөрийн зарц нарыг илгээсэн шалтгаан юм. Аюул тулгарсан үед Лот өөр юуг ч үл хайхран энэ хоёр зарцыг хамгаалсан; тэр ч байтугай хоёр охиноо зарц нарын аюулгүй байдлын төлөө солихоор оролдсон. Тэр хотод ийм зүйл хийж чадах хүн Лотоос өөр байсан уу? Байгаагүй гэдгийг баримт нотолдог! Тиймээс Лотыг эс тооцвол Содомд байсан хүн бүр сүйрлийн бай болсон, тэд үүнийг хүртэх ёстой байсан гэдгийг хэлэх нь илүүц биз.

Бурханы уур хилэнг хүргэснийхээ төлөө Содом бүр мөсөн газрын хөрснөөс арчигджээ

Содомын ард иргэд энэ хоёр зарцыг хараад, ирсэн шалтгааныг нь асуугаагүй, Бурханы хүслийг түгээхээр ирсэн эсэхийг нь ч бас нэг ч хүн асуугаагүй. Эсрэгээрээ, тэд тайлбарлахыг нь хүлээлгүйгээр бөөгнөрөн цугларч, зэрлэг нохой, догшин чоно мэт тэр хоёр зарцыг барихаар ирсэн. Ийм зүйл болж байгааг Бурхан харсан уу? Хүний ийм зан авир, ийм үйл явдлыг хараад Бурхан зүрх сэтгэлдээ юу бодож байсан бэ? Бурхан энэ хотыг устгахаар шийдсэн; Тэр тээнэгэлзэж, азнахгүй байсан, тэвчээртэй хандахаа ч бас болих байсан. Түүний өдөр ирсэн тул хийхийг хүссэн ажлаа хийж эхэлсэн. Тиймээс Эхлэл 19:24–25-д, “Тэгээд Ехова Содом, Гоморра хоёрт хүхэр ба галыг тэнгэрээс Еховагаас илгээж; хотуудыг, бүх тал хөндийг болон хотын бүх оршин суугчийг, газар дээрх ургамал амьтан бүгдийг сүйрүүлэв” гэж байдаг. Энэ хоёр эшлэл нь, энэ хотыг сүйрүүлсэн Бурханы аргаас гадна, бас Бурханы сүйрүүлсэн зүйлсийг хэлж өгдөг. Эхлээд, Бурхан хотыг түймэрдсэн бөгөөд галын хэмжээ нь бүх хүнийг, газарт ургасан бүхнийг устгахад хангалттай байсан гэж Библид өгүүлдэг. Өөрөөр хэлбэл, тэнгэрээс буусан гал нь зөвхөн хотыг устгаад зогсоогүй, дотор нь байсан бүх хүн, бүх амьд зүйлийг ганц ч ул мөр үлдээлгүйгээр устгасан. Хотыг сүйрүүлсний дараа газар дээр амьд зүйл үлдээгүй байв; ямар ч амьдрал үлдээгүй, бас амьдралын ямар ч шинж тэмдэг үлдээгүй. Хот үхмэл нам гүм байдлаар дүүрэн эзгүй хоосон, зэлүүд газар болж хувирсан. Энэхүү газарт Бурханы эсрэг хорон муу үйл хэрэг үйлдэгдэхээ больж, аллага хийж, цус асгаруулахаа больсон.

Яагаад Бурхан энэ хотыг тэр чигээр нь шатаахыг хүссэн бэ? Та нар үүнээс юу харж болох вэ? Бурхан Өөрийнх нь бүтээл болох хүн төрөлхтөн болон байгалийг ингэж сүйрэхийг харж үнэхээр тэвчих байсан уу? Хэрвээ чи Ехова Бурханы уур хилэнг тэнгэрээс буулгасан галаас ялган харж чадвал, Түүний сүйрүүлсэн бай, энэхүү хот ямар хэмжээнд газрын хөрснөөс арчигдсанаас Түүний уур хилэн ямар их байсныг ойлгоход хэцүү биш юм. Бурхан нэг хотыг жигшвэл Өөрийн шийтгэлийг онооно. Бурхан хотод зэвүүцвэл уураа хүмүүст мэдүүлэхийн тулд дахин дахин сануулга өгнө. Гэхдээ Бурхан хотыг сүйрүүлж, устгахаар шийдэх үед—өөрөөр хэлбэл, Түүний уур хилэн, сүр жавхланд халдсан үед—Тэр шийтгэл, сануулга

өгөхөө больж, харин ч шууд устгана. Тэр огт байхгүй болгох болно. Энэ бол Бурханы зөвт зан чанар билээ.

Содом Өөрт нь ахин дахин дайсагнаж, эсэргүүцсэний дараа Бурхан бүрмөсөн газрын хөрснөөс арчсан

Бурханы зөвт зан чанарын талаар ерөнхийд нь ойлгосон болохоор бид, нүглийн хот хэмээн Бурханы үзэж байсан газар, Содом хот руу ахин анхаарлаа хандуулж болох юм. Энэ хотын мөн чанарыг ойлгосноор Бурхан яагаад устгахыг хүссэн, яагаад үүнийг бүрмөсөн устгасан болохыг бид ойлгож чадна. Үүнээс бид Бурханы зөвт зан чанарыг мэдэж авч чадна.

Хүний өнцгөөс харвал, Содом нь хүний хүсэл мөрөөдөл, ёрын мууг бүрэн дүүрэн хангаж чадах хот байв. Шөнө болгон хөгжим бүжгээр уруу татан, сэтгэл булааж, эзэмдэх энэхүү хотын хөгжил цэцэглэлт нь хүнийг ховсдож, галзуурахад хүргэж байжээ. Ёрын муу байдал нь хүмүүсийн зүрх сэтгэлийг эвдэж, ховсодсоор самуурахад хүргэдэг. Энэ бол бузар, ёрын муу сүнснүүд галзууран гүйлдэж байдаг хот байлаа; аллага, нүглээр бялхаж, цуст, илжирсэн үнэр нэвт ханхалж байв. Энэ бол хүмүүсийн цусыг царцаасан, хүн айсандаа дайжин холдох хот байв. Эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу аль нь ч бай хэн ч энэ хотод үнэн замыг эрж хайгаагүй; хэн ч гэрлийг хүсэмжилж, нүглээс зайлж холдохоор тэмүүлээгүй. Тэд Сатаны хяналтад, Сатаны завхрал, хууран мэхлэлт дор амьдарч байлаа. Тэд хүн чанараа гээж, эрүүл ухаанаа, хүний оршин тогтнолын анхдагч зорилгоо алдсан байв. Тэд Бурханыг эсэргүүцэх тоо томшгүй олон хорон муу үйл үйлдсэн; Түүний удирдамжаас татгалзаж, Түүний хүслийг эсэргүүцсэн. Энэ хүмүүс, энэ хот, хотын доторх бүх амьд зүйлийг алхам алхмаар сүйрлийн замд аваачсан зүйл нь тэдний хорон муу үйл хэрэг байсан билээ.

Хэдийгээр энэхүү хоёр хэсэг нь Содомын ард иргэдийн завхралын хэмжээг бүгдийг нь нарийн ширийн тэмдэглээгүй, харин хотод ирснийх нь дараа Бурханы хоёр зарцтай хэрхэн харьцаж байсныг тэмдэглэсэн боловч Содомын ард иргэд хэр их завхарсан, ёрын муу байсан, Бурханыг хэр хэмжээнд эсэргүүцэж байсныг илчилсэн энгийн баримт бий. Үүгээр хотын хүмүүсийн үнэн нүүр царай, мөн чанарыг бас харуулдаг. Тэд Бурханы анхааруулгыг хүлээн авахаас татгалзсанаар үл барам Түүний шийтгэлээс айгаагүй. Эсрэгээрээ тэд Бурханы уур хилэнг басамжилсан. Тэд Бурханыг сохроор эсэргүүцэж, Тэр юу ч хийсэн, яаж ч хийсэн бай, тэдний хорон уг чанар улам л их болж, Бурханыг ахин дахин эсэргүүцэж байсан юм. Содомын хүмүүс Бурханы оршин тогтнол, ирэлт, шийтгэл, тэр ч бүү хэл Түүний анхааруулгад дайсагнаж байв. Тэд дэндүү биеэ тоосон, залгиж, хорлож болох бүх хүнийг залгиж, хорлодгийн дээр Бурханы зарц нарт ч мөн ялгаагүй хандсан. Содомын ард иргэдийн үйлдсэн бүх хорон муу үйлийн тухайд, Бурханы зарц нарт хор хүргэсэн нь зөвхөн мөсөн уулын орой бөгөөд ийнхүү илчлэгдсэн хорон муу уг чанар нь үнэндээ захгүй их далай дахь ганц дуслаас хэтрэхгүй юм.

Тиймээс Бурхан тэднийг галаар устгахыг сонгосон. Бурхан хотыг устгахын тулд үер, эсвэл хар салхи, газар хөдлөлт, цунами болон өөр бусад аргыг хэрэглээгүй. Энэ хотыг устгахдаа Бурхан галыг ашигласан нь юуг илтгэдэг вэ? Энэ нь хот бүрэн дүүрэн сүйрч; газрын хөрснөөс тэр чигээрээ арчигдаж, оршин тогтнохоо бүрмөсөн больсон гэсэн үг байв. Энд, “сүйрэл” гэдэг нь хотын хэлбэр дүрс, бүтэц, гадаад харагдах байдал үгүй болохыг хэлээд зогсохгүй; мөн хотын доторх хүмүүсийн сүнс оршихоо больж, бүрмөсөн устгагдсан гэсэн утгатай юм. Энгийнээр хэлбэл, энэ хоттой холбоотой бүх хүн, үйл явдал, юмс устсан. Тэрхүү хотын хүмүүсийн хувьд хойд нас, дахин төрөлт гэж байхгүй; Бурхан тэднийг бүтээгдсэн хүн төрөлхтний дундаас үүрд арилгасан. Гал ашигласан нь энэ газарт нүгэл эцэс болсныг, нүглийг тэнд хазаарлан барьсныг илтгэж байв; энэ нүгэл оршин тогтнож, тархахаа больсон. Энэ нь, Сатаны ёрын муу шим тэжээлтэй хөрсөө алдсаны зэрэгцээ орогнож, амьдрах газар нь болж байсан үхээрийн газраа алдсан гэсэн үг байв. Бурхан, Сатан хоёрын тулаанд Бурхан галыг ашигласан нь Сатаныг тамгалсан Түүний ялалтын тэмдэг байлаа. Содомын сүйрэл бол хүнийг завхруулж, залгиснаараа Бурханыг эсэргүүцэх Сатаны санаархлын асар том алдаа, бас хүн Бурханы удирдамжийг голж, бузар үйлд автаж байсан хүн төрөлхтний хөгжлийн гутамшигт үе юм. Түүнчлэн энэ нь Бурханы зөвт зан чанарын жинхэнэ илрэлийн тухай тэмдэглэл билээ.

Тэнгэрээс Бурханы илгээсэн гал Содомыг юу ч үгүй үнсэн товрог болгох үед “Содом” гэх нэртэй хот, хотын доторх бүх зүйлийн хамт цаашид оршин тогтнохоо болино гэсэн үг байлаа. Бурханы уур хилэнд энэ нь сүйрч, Бурханы уур хилэн, сүр жавхлан дотроос үгүй болсон. Бурханы зөвт зан чанараас болж Содом тохирсон шийтгэл, зүй ёсны төгсгөлөө хүртсэн. Содом оршин тогтнохоо больсон нь ёрын муугаас нь болсон бөгөөд энэхүү хотыг, энд амьдарч байсан ямар ч хүнийг, уг хотын дотор өсөж үржсэн ямар ч амийг хэзээ ч харахыг хүсээгүй Бурханы хүслээс бас болсон юм. Бурханы “энэ хотыг хэзээ ч дахин харахгүй байх хүсэл” бол Түүний уур хилэн, мөн түүнчлэн Түүний сүр жавхлан билээ. Хотын хорон муу байдал, нүгэл нь Түүний уур, зэвүүцэл, жигшил, мөн хотыг, түүн доторх ямар ч хүн, амьд зүйлсийг дахин хэзээ ч харахгүй байх хүслийг нь төрүүлсэн учраас Бурхан энэ хотыг шатаасан юм. Хот шатаж дуусаад үнсэн товрог л үлдмэгц Бурханы нүдэнд үнэхээр оршин тогтнохоо больсон; энэ хотын тухай Түүний дурсамж хүртэл үгүй болж, арилсан. Тэнгэрээс илгээсэн гал Содом хотыг бүхэлд нь, түүн доторх нүглээр дүүрэн хүмүүс, хотын доторх нүгэлд сэвтсэн бүх зүйлийг устгаад зогсохгүй; үүнээс ч илүүтэйгээр Бурханы эсрэг хүн төрөлхтний ёрын муу болоод эсэргүүцлийн дурсамжийг хүртэл устгасан гэсэн үг юм. Хотыг шатаасан Бурханы зорилго энэ байлаа.

Энэ хүн төрөлхтөн туйлын их ялзарсан. Энэ хүмүүс Бурхан хэн болох, өөрсдөө хаанаас ирснээ мэдэхгүй байсан. Хэрвээ чи Бурханыг дурдвал энэ хүмүүс дайран давшилж, гүтгэж, доромжлох байв. Бурханы зарц нар Түүний анхааруулгыг

түгээхээр ирэхэд хүртэл энэ завхарсан хүмүүс ямар ч гэмшсэн шинж үзүүлээгүй төдийгүй хорон муу үйлээ орхиогүй, харин ч эсрэгээрээ тэд Бурханы зарц нарт улайм цайм хор хүргэсэн. Тэдний илэрхийлж, харуулсан зүйл бол Бурханд туйлын ихээр дайсагнадаг уг чанар-мөн чанар нь байсан юм. Энэ завхарсан хүмүүсийн Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл нь тэдний завхарсан зан чанарын илрэлээс хамаагүй илүү, зүгээр нэг үнэний тухай ойлголт дутмагаас үүдэн гүжирдэж, доог тохуу хийх явдлаас хавьгүй илүү зүйл байсан гэдгийг бид харж болно. Тэдний хорон муу авир тэнэглэл, мэдлэггүй байдлаас болоогүй; тэд мэхлэгдсэнээс болж ингэж авирлаагүй, төөрөлдсөнөөс бүр ч болоогүй. Тэдний авир Бурханы эсрэг жигшмээр эрээ цээргүй дайсагнаж, эсэргүүцэж, хашхичих түвшинд хүрсэн. Хүний ийм зан авир Бурханыг, Түүний зан чанарыг—халдаж болохгүй зан чанарыг хилэгнүүлэх нь эргэлзээгүй. Тиймээс Бурхан уур хилэн, сүр жавхлангаа шууд, ил тод гаргасан; энэ нь Түүний зөвт зан чанарын жинхэнэ илрэл билээ. Нүглээр бялхсан хоттой нүүр тулгараад Бурхан аль болох хурдан устгаж, доторх хүмүүсийг нь болон тэдний бүх нүглийг хамгийн бүрэн төгс аргаар газрын хөрснөөс арчиж, энэ хотын хүмүүсийн оршин тогтнохыг болиулж, энэ газарт нүгэл өсөж үржихийг зогсоохыг хүссэн. Үүнийг хийх хамгийн түргэн агаад бүрэн төгс арга нь галаар шатаах явдал байв. Содомын ард түмэнд хандах Бурханы хандлага нь хаяж, үл тоох биш байлаа. Харин ч энэ хүмүүсийг шийтгэж, цохин унагааж, бүрмөсөн сүйрүүлэхийн тулд Тэр уур хилэн, сүр жавхлан, эрх мэдлээ ашигласан. Тэдэнд хандах Түүний хандлага нь бие махбодыг нь сүйрүүлээд зогсохгүй, мөн сүнсийг нь сүйрүүлж, газрын хөрснөөс үүрд мөнх арчих явдал байсан юм. “Оршин тогтнохоо болих” гэдэг үгээр Бурханы хэлэх гэсэн жинхэнэ утга санаа энэ билээ.

Бурханы уур хилэн нуугдмал агаад хүнд мэдэгддэггүй боловч халдахыг тэвчдэггүй

Мунхаг, харанхуй бүдүүлэг бүх хүн төрөлхтөнд хандах Бурханы хандлага нь үндсэндээ өршөөл, хүлээцтэй байдалд үндэслэдэг. Нөгөө талаар, Түүний уур хилэн нь асар урт хугацаанд, бараг ихэнх үйл явдал дээр далдлагдаж, хүнд мэдэгддэггүй. Үүний үр дүнд, Бурхан уур хилэнгээ илэрхийлж байгааг харах нь хүний хувьд хэцүү, Түүний уур хилэнг ойлгоход ч бас хэцүү байдаг. Ийм болохоор хүн Бурханы уур хилэнг үл тоодог. Бурханы хамгийн сүүлчийн ажил, хүнд хүлээцтэй хандаж, уучлах алхамтай хүн нүүр тулах үедээ—өөрөөр хэлбэл, Бурхан сүүлчийн удаа хүн төрөлхтөнд өршөөл үзүүлж, анхааруулга өгөх үед—хэрвээ хүн Бурханыг эсэргүүцэх нөгөө л аргаа хэрэглэсээр, гэмшиж замаа засаж, Түүний өршөөлийг хүлээн авах гэж ямар ч хүчин чармайлт гаргахгүй бол Бурхан тэдэнд хүлээцтэй, тэвчээртэйгээр хандахаа болино. Эсрэгээрээ, энэ үед Бурхан өршөөлөө буцаан авах болно. Үүний дараа Тэр зөвхөн уур хилэнгээ л гаргана. Тэр өөр өөр арга хэрэглэн хүмүүсийг шийтгэж, устгаж болдгийн адил уур хилэнгээ өөр өөр байдлаар илэрхийлж болно.

Содом хотыг устгахдаа Бурхан гал ашигласан нь хүн төрөлхтнийг юм уу аливаа зүйлийг бүрмөсөн үгүй хийх хамгийн хурдан арга байсан юм. Содомын ард иргэдийг шатаасан нь тэдний махан биеийг устгаад зогсохгүй; тэдний сүнс, сэтгэл, биеийг бүхэлд нь устгаж, энэ хотод байсан хүмүүс, материаллаг ертөнц болоод хүнд үл үзэгдэх ертөнцийн аль алинд нь оршин тогтнохооргүй болгосон. Энэ бол Бурхан Өөрийн уур хилэнг харуулж, илэрхийлдэг нэг арга зам нь юм. Ийм маягийн илрэл, илэрхийлэл нь Бурханы уур хилэнгийн мөн чанарын нэг тал байдгийн адил бас Бурханы зөвт зан чанарын мөн чанарын илрэл билээ. Бурхан уур хилэнгээ гаргахдаа, ямар ч өршөөл, өгөөмөр сэтгэлийг харуулахаа больж, мөн хүлээцтэй байдал, тэвчээрээ ч харуулахаа больдог; үргэлжлүүлэн тэвчээртэй байж, өршөөлөө дахин хүртээж, хүлээцтэй байдлаа дахин нэгэнтээ хайрла гэж Түүнийг ятгаж чадах ямар ч хүн, юмс, учир шалтгаан гэж үгүй. Харин ч оронд нь, Бурхан ганц ч хором эргэлзэхгүйгээр уур хилэн, сүр жавхлангаа гаргаж, хүссэн зүйлээ хийдэг. Тэр эдгээр зүйлийг Өөрийн хүсэлд нийцүүлэн хурдан, цэвэрхэн байдлаар хийх болно. Энэ бол Өөрийн уур хилэн, сүр жавхланг гаргадаг Бурханы арга зам, хүн үүнд халдаж болохгүй, мөн энэ нь Түүний зөвт зан чанарын нэг талын илэрхийлэл билээ. Бурхан хүний төлөө санаа зовж, хүнийг хайрлаж байгааг хүмүүс хараад уур хилэнг нь мэдэрч, сүр жавхланг нь харж, халдахыг тэвчдэггүй гэдгийг нь мэдэрч чаддаггүй. Эдгээр зүйл нь, Бурханы зөвт зан чанар нь гагцхүү өршөөл, хүлээцтэй байдал, хайр юм гэдэгт хүмүүсийг итгэхэд үргэлж хүргэдэг. Гэвч Бурхан хотыг устгаж, хүн төрөлхтнийг жигшихийг нь хүн харах үед, хүнийг сүйрүүлэх Түүний уур хилэн, сүр жавхлан нь Түүний зөвт зан чанарын өөр нэг талыг зэрвэс харах боломжийг хүмүүст олгодог. Энэ бол Бурханы халдахыг тэвчдэггүй байдал юм. Халдахыг тэвчдэггүй Бурханы зан чанар нь аливаа бүтээгдсэн зүйлийн төсөөллөөс даван гардаг бөгөөд бүтээгдээгүй зүйлсийн дундаас нэг нь ч үүнд хөндлөнгөөс оролцож, нөлөөлөх чадваргүй; үүнээс ч илүүтэйгээр үүнийг хуулбарлаж, дуурайж чадахгүй. Тиймээс Бурханы зан чанарын энэ тал нь хүн төрөлхтний хамгийн сайн мэдэх ёстой зүйл юм. Бурханд Өөрт нь л ийм зан чанар байдаг, Бурхан Өөрөө л ийм зан чанарыг эзэмшдэг. Хорон муу, харанхуй бүдүүлэг, тэрслүү байдал, хүн төрөлхтнийг завхруулж, залгидаг Сатаны ёрын муу үйлдлийг Бурхан үзэн яддаг, Өөрийг нь эсэргүүцдэг бүх нүгэлт үйлдлийг жигшдэг учраас, мөн ариун, бузартаагүй мөн чанарынхаа улмаас Бурхан ийм зөвт зан чанартай байдаг. Үүнээс болж, ямар ч бүтээгдсэн, эсвэл бүтээгдээгүй зүйлс Өөрийг нь илт эсэргүүцэж, сөрөхийг Тэр тэвчихгүй. Түүний нэгэнтээ өршөөл үзүүлж, эсвэл сонгож байсан хүн Түүний зан чанарыг уурлуулж, тэвчээртэй, хүлээцтэй байдлын зарчмыг нь зөрчих л юм бол Тэр өчүүхэн төдий ч өршөөж, тээнэгэлзэлгүйгээр халдахыг тэвчдэггүй зөвт зан чанараа гаргаж, харуулах болно.

Бурханы уур хилэн бол бүх шударга хүч, бүх эерэг зүйлийн баталгаа

Бурханы үг, бодол, үйлдлийн талаарх эдгээр жишээг ойлгосноор чи Бурханы зөвт зан чанарыг, хүний халдахыг тэвчихгүй зан чанарыг ойлгож чадах уу? Товчоор

хэлбэл, үүнээс хүн хэр ихийг ойлгож чадахаас үл хамааран, энэ бол зөвхөн Түүнд л байдаг, Бурханы Өөрийнх нь зан чанарын нэг тал билээ. Бурханы халдахыг тэвчдэггүй байдал нь Түүний онцгой мөн чанар; Бурханы уур хилэн бол Түүний онцгой зан чанар; Бурханы сүр жавхлан бол Түүний онцгой мөн чанар юм. Бурханы уур хилэнгийн цаад зарчим нь зөвхөн Өөрт нь байдаг ялгамж чанар болоод байр суурийг харуулдаг. Энэхүү зарчим нь бас цор ганц Бурханы Өөрийнх нь мөн чанарын бэлгэ тэмдэг гэдгийг хэлэх нь илүүц биз. Бурханы зан чанар бол цаг хугацаа өнгөрлөө гээд огтхон ч өөрчлөгддөггүй, газар зүйн байршил өөрчлөгдлөө гээд ч бас өөрчлөгддөггүй, Түүний төрөлхийн мөн чанар билээ. Түүний төрөлх зан чанар нь Түүний угийн мөн чанар юм. Тэр Өөрийн ажлыг хэн дээр хэрэгжүүлэхээс үл хамааран, мөн чанар нь өөрчлөгддөггүй, бас Түүний зөвт зан чанар ч тэр. Хүн Бурханыг уурлуулах үед Түүний гаргадаг зүйл нь Түүний төрөлх зан чанар юм; энэ үед Түүний уур хилэнгийн цаад зарчим өөрчлөгддөггүй, бас Түүний цор ганц ялгамж чанар, байр суурь ч тэр. Мөн чанар нь өөрчлөгдсөн, эсвэл Түүний зан чанараас өөр өөр элемент гарсан учраас Тэр уурладаггүй, харин Өөрийг нь эсэргүүцэх хүний эсэргүүцэл зан чанарт нь халддаг учраас уурладаг. Хүн Бурханыг эрээ цээргүйгээр өдөөн хатгах нь Бурханы ялгамж чанар, байр суурийг ихэд сорьдог. Бурханы үзэл бодлоор бол хүн Түүнийг өдөхдөө Түүнтэй тэмцэлдэж, Түүний уур хилэнг сорьж байдаг. Хүн Бурханыг эсэргүүцэж, Бурхантай тэмцэлдэж, Бурханы уур хилэнг тасралтгүй сорих үед—нүгэл хяналтаас гарсан ийм нь л үед—Бурханы уур хилэн аяндаа илэрч, харагдана. Тиймээс Бурхан уур хилэнгээ илэрхийлэх нь бүх ёрын муу хүч оршин байхаа болихын бэлгэ тэмдэг; дайсагнагч бүх хүч устгагдахын бэлгэ тэмдэг билээ. Энэ бол Бурханы зөвт зан чанарын, Бурханы уур хилэнгийн хосгүй чанар билээ. Бурханы эрхэм чанар, ариун байдлыг сорьж, шударга хүчинд хүн саад хийж, харахгүй байх үед Бурхан уур хилэнгээ гаргах болно. Бурханы мөн чанарын улмаас, Бурхантай өрсөлдөж, эсэргүүцэж, тэмцэлддэг газар дээрх тэдгээр бүх хүч нь ёрын муу, завхарсан, шударга бус юм; тэдгээр нь Сатанаас ирсэн, түүнд харьяалагддаг. Бурхан шударга, гэрэл гэгээтэй, өө сэвгүй ариун учраас Бурханы уур хилэн дүрэлзэхийн хамтаар ёрын муу, ялзарсан, Сатанд харьяалагддаг бүх зүйл үгүй болох болно.

Бурханы уур хилэн асгарах нь Түүний зөвт зан чанараа илэрхийлэх нэг тал нь мөн боловч Бурханы уур хилэн байны тухайд яавч ялгаварладаггүй биш, бас зарчимгүй ч биш. Эсрэгээрээ, Бурхан огтхон ч түргэн ууртай биш, Өөрийн уур хилэн, сүр жавхланг ч бас амархан харуулдаггүй. Түүнчлэн, Бурханы уур хилэн тун хяналттай, хэмжээтэй байдаг; энэ нь хүний уурлаж бухимдан, уураа гаргадаг зуршилтай огтхон ч харьцуулшгүй. Хүн, Бурхан хоёрын хоорондох маш олон яриа Библид тэмдэглэгдсэн байдаг. Ярианд оролцсон хүмүүсийн заримынх нь үг өнгөцхөн, мэдлэггүй агаад хүүхдийнх шиг байсан боловч Бурхан тэднийг цохин унагааж, бас яллаа ч гүй. Ялангуяа, Иовын шалгалтын үеэр Иовд хэлсэн үгийг нь сонссоныхоо дараа Ехова Бурхан Иовын гурван найз болон бусад хүнд хэрхэн

хандсан бэ? Тэр тэднийг ялласан уу? Тэдэнд хилэгнэсэн үү? Тэрээр ямар ч ийм зүйл хийгээгүй! Харин ч тэдний өмнөөс гуйж, тэдний төлөө залбир гэж Иовд хэлсэн бөгөөд Бурхан Өөрөө тэдний алдааг хүндээр хүлээж аваагүй. Эдгээр тохиолдол нь бүгд, ийм завхарсан, харанхуй бүдүүлэг хүмүүст ханддаг Бурханы үндсэн хандлагыг төлөөлдөг. Тиймээс, Бурхан уур хилэнгээ гаргах нь Өөрийн сэтгэл санааны байдлыг илэрхийлж байгаа хэрэг огт биш, мэдрэмжээ гаргаж байгаа явдал ч бас биш юм. Хүний буруу ойлголтоос эсрэгээр, Бурханы уур хилэн нь бүрэн тэсрэн гардаг хилэн биш. Бурхан сэтгэл хөдлөлөө барьж чадахаа больсон, эсвэл уур нь буцалж, гаргахаас аргагүй болсноос болж уур хилэнгээ гаргадаг юм биш. Эсрэгээрээ, Түүний уур хилэн бол зөвт зан чанарынх нь илэрхийлэл, жинхэнэ илрэл, Түүний ариун мөн чанарыг бэлгэдсэн илчлэл билээ. Бурхан бол уур хилэн, халдахыг Тэр тэвчдэггүй—энэ нь, Бурханы уур хилэн учир шалтгааныг ялгадаггүй, эсвэл зарчимгүй байдаг гэсэн үг биш; харин учир шалтгааныг ялгалгүй, зарчимгүйгээр, дураараа дүрсхийдэг уур хилэн, зөвхөн завхарсан хүн төрөлхтөнд л байдаг. Хүн байр суурьтай болмогц сэтгэл хөдлөлөө хянахад үргэлж хэцүү болох учраас сэтгэл ханамжгүй байдлаа илэрхийлж, сэтгэл хөдлөлөө гаргах боломжийг шүүрч авахдаа дуртай байх болно; өөрийн чадлыг харуулж, байр суурь, ялгамж чанар нь энгийн хүмүүсийнхээс ялгаатай гэдгийг бусдад мэдэгдэхийн тулд тэрээр ямар ч илэрхий шалтгаангүйгээр байнга дүрсхийн уурладаг. Мэдээж ямар ч байр суурьгүй завхарсан хүмүүс ч бас үргэлж хяналтаа алддаг. Хувийн ашиг сонирхол нь хохирсноос болж тэд байнга уурладаг. Өөрсдийн байр суурь, нэр хүндийг хамгаалахын тулд тэд сэтгэл хөдлөлөө үргэлж гаргаж, биеэ тоосон уг чанараа харуулах болно. Нүглийн оршин тогтнолыг хамгаалж тэтгэхийн тулд хүн дүрсхийн уурлаж, сэтгэл хөдлөлөө гаргах бөгөөд эдгээр үйлдэл нь хүний сэтгэл ханамжгүй байдлаа илэрхийлэх арга юм; эдгээр нь хольц, заль мэх, далд явуулга, хүний завхрал, ёрын муугаар бялхдаг, юу юунаас ч илүүтэйгээр хүний зэрлэг санаархал, хүслээр бялхаж байдаг. Шударга ёс хорон муу байдалтай харшилдах үед, хүн шударга ёсны оршин тогтнолыг хамгаалж, хадгалахын тулд дүрсхийн уурлахгүй; харин ч эсрэгээрээ, шударга ёсны хүчинд заналхийлж, түүнийг хяхан хавчиж, дайрч довтлох үед, хүн үл ойшоож, зайлсхийж, далдичин зугтах хандлагатай байдаг. Харин муу ёрын хүчтэй тулгарах үедээ хүн аялдан дагаж, мэхийж, бөхөлзсөн хандлагатай байдаг. Тиймээс хүн уураа гаргах нь ёрын муу хүчний гарах гарц, махан биетэй хүний улангассан, зогсоохын аргагүй ёрын муу авирын илэрхийлэл юм. Харин Бурхан уур хилэнгээ гаргах үед, бүх ёрын муу хүч зогсож, хүнд хор хүргэх бүх нүглийг тогтоон барьж, Бурханы ажилд саад болдог дайсагнагч бүх хүчийг ил болгож, тусгаарлаж, харааж, Бурханыг эсэргүүцдэг Сатаны бүх хамсаатныг шийтгэж, үндсээр нь устгана. Оронд нь, Бурханы ажил ямар ч саадгүйгээр үргэлжилж, Бурханы удирдлагын төлөвлөгөө хувааарийн дагуу алхам алхмаар үргэлжлүүлэн хөгжиж, Бурханы сонгосон хүмүүс Сатаны үймээн, хууралтаас ангид байдаг бол, Бурханыг дагадаг хүмүүс амар амгалан, тайван орчинд Бурханы манлайлал, хангалтыг эдэлнэ. Бурханы уур хилэн бол бүх ёрын муу

хүчийг өсөж үржин, хаа хамаагүй тархахаас сэргийлдэг хамгаалалт, мөн бүх зөв шударга, эерэг зүйлийн оршин тогтнол, тархалтыг хамгаалж, тэднийг дарангуйлал, сүйрлээс мөнхөд хамгаалдаг хамгаалалт билээ.

Бурхан Содомыг сүйрүүлсэн явдлаас та нар Түүний уур хилэнгийн мөн чанарыг харж чадаж байна уу? Түүний уур хилэнтэй өөр ямар нэг зүйл холилдсон уу? Бурханы уур хилэн хольцгүй цэвэр үү? Хүний үгээр хэлбэл Бурханы уур хилэн жинхэнэ үү? Түүний уур хилэнгийн цаана ямар нэг арга заль байдаг уу? Ямар нэгэн нууц явуулга байдаг уу? Хэлж болохгүй ямар нэгэн нууц байдаг уу? Би та нарт хатуухан бөгөөд нухацтайгаар ингэж хэлж чадна: Бурханы уур хилэнд хэн нэгнийг эргэлзэхэд хүргэж болох ямар ч зүйл байхгүй. Түүний уур хилэн бол өөр ямар нэгэн санаа, зорилго өвөрлөдөггүй цэвэр, жинхэнэ уур билээ. Түүний уур хилэнгийн цаад шалтгаан нь цэвэр ариун, гэм зэмгүй, шүүмжлэлээс дээгүүр байдаг. Энэ нь Түүний ариун мөн чанарын төрөлхийн илрэл, илэрхийлэл; энэ бол өөр ямар ч бүтээлд байдаггүй зүйл билээ. Энэ бол Бурханы цор ганц зөвт зан чанарын нэг хэсэг, бас Бүтээгч болон Түүний бүтээлийн тус тусынх нь мөн чанарын хоорондох эрс тэс ялгаа юм.

Хүн бусдын нүдэн дээр, эсвэл бусдын нүднээс далдуур уурлах нь хамаагүй хүн бүхэн уурлахдаа өөр өөр санаа, зорилготой байдаг. Магадгүй тэд нэр төрөө өсгөж, эсвэл хувийн ашиг сонирхлоо хамгаалж, дүр төрхөө хадгалж, нэр нүүрээ бодож байж болох юм. Зарим хүн уураа барихаар хичээдэг байхад зарим нь илүү түргэн зантай, өчүүхэн төдий ч биеэ барилгүйгээр хүссэн үедээ уур хилэн нь бадардаг. Товчхондоо, хүний уур завхарсан зан чанараас нь үүсдэг. Зорилго нь ямар байх нь хамаагүй, энэ нь махан биеийнх, уг чанарынх байдаг; хүний уг чанар-мөн чанарын юу нь ч үнэнтэй нийцдэггүй учраас энэ нь шударга ёс, шударга бус байдалтай ямар ч хамаагүй. Тиймээс завхарсан хүн төрөлхтний уур уцаарыг Бурханы уур хилэнтэй харьцуулах ёсгүй. Сатаны завхруулсан хүний үйлдэл нь ямагт завхралыг хадгалж хамгаалах хүслээс эхэлдгийн дээр үнэндээ завхрал дээр үндэслэдэг; тийм учраас хэдий онолын хувьд хүний уур уцаар хэчнээн зүй ёсны мэт санагдаж байсан ч гэсэн хүний уурыг Бурханы уур хилэнтэй харьцуулж болохгүй. Бурхан уур хилэнгээ гаргах үед, ёрын муу хүчнүүд зогсож, ёрын муу зүйлс устгагддаг байхад зөв шударга болоод эерэг зүйлс Бурханы халамж, хамгаалалтыг эдэлж, үргэлжлүүлэх боломжтой болдог. Шударга бус, сөрөг, ёрын муу зүйлс нь шударга, эерэг зүйлсийн хэвийн үйл ажиллагаа болон хөгжлийг саатуулж, үймүүлж, сүйтгэдэг учраас Бурхан уур хилэнгээ гаргадаг. Бурханы уур хилэн нь байр суурь, ялгамж чанараа хамгаалах зорилготой байдаггүй, харин шударга, эерэг, үзэсгэлэнтэй, сайн сайхан зүйлсийн оршин тогтнолыг хамгаалж, хүн төрөлхтний хэвийн амьдрах хууль, дэг журмыг хамгаалах зорилготой юм. Энэ бол Бурханы уур хилэнгийн эх үндэс билээ. Бурханы уур хилэн бол Түүний зан чанарын маш зүй ёсны, байх л ёстой, жинхэнэ илрэл мөн. Түүний уур хилэнд ямар ч далд санаа байдаггүй, хүсэл, заль мэх, хорон санаа, хүчирхийлэл, муу муухай болоод завхарсан хүн төрөлхтний өөр бусад

аливаа нийтлэг шинжийг байтугай хууран мэхлэлт, хуйвалдаан ч агуулдаггүй. Бурхан Өөрийн уур хилэнг гаргахаасаа өмнө, бүх зүйлийн мөн чанарыг аль хэдийн тов тодорхой, бүрэн дүүрэн ухан ойлгож, тодорхой, үнэн зөв тодорхойлолт, дүгнэлтийг аль хэдийн боловсруулсан байдаг. Тиймээс бүх зүйлийг хийхдээ баримталдаг Бурханы зорилго нь Түүний хандлагатай адил тов тодорхой байдаг. Тэр мунгинуу, харалган, түргэн зантай, хайхрамжгүй биш, Тэр яавч зарчимгүй биш. Энэ бол Бурханы уур хилэнгийн бодитой тал, Бурханы уур хилэнгийн энэхүү бодитой талаас үүдэн хүн төрөлхтөн хэвийн оршин тогтнох болсон юм. Бурханы уур хилэнгүйгээр хүн төрөлхтөн хэвийн бус амьдрах нөхцөл рүү уруудаж, шударга, үзэсгэлэнтэй, сайн сайхан бүх зүйл устаж, оршин тогтнохоо болих байв. Бурханы уур хилэнгүйгээр бүтээгдсэн зүйлийн оршин тогтнох хууль, дэг журам эвдэгдэж, эсвэл бүр бүрэн сүйрэх байлаа. Хүнийг бүтээснээс хойш Бурхан, хүн төрөлхтний хэвийн оршин тогтнолыг хамгаалж, хадгалахын тулд зөвт зан чанараа тасралтгүй ашигласан юм. Түүний зөвт зан чанар нь уур хилэн, сүр жавхланг агуулдаг учраас бүх ёрын муу хүн, зүйл, эд юмс болон хүн төрөлхтний хэвийн оршин тогтнолыг үймүүлж, хохироодог бүх зүйл Түүний уур хилэнгийн улмаас шийтгүүлж, хянуулж, устдаг. Сүүлийн хэдэн мянган жилийн туршид, хүн төрөлхтнийг удирдах Бурханы ажилд Бурханыг эсэргүүцэж, Сатаны хамсаатан, боол мэт авирладаг бүхий л төрлийн бузар, муу ёрын сүснүүдийг цохин унагааж, устгахаар Бурхан зөвт зан чанараа тасралтгүй ашигласаар ирсэн. Тиймээс хүнийг аврах Бурханы ажил үргэлж Өөрийнх нь төлөвлөгөөний дагуу урагшилж байсан. Өөрөөр хэлбэл, Бурханы уур хилэн оршин тогтнодог учраас хүмүүсийн хамгийн зөв шударга үйл хэрэг хэзээ ч сүйрээгүй.

Та нар Бурханы уур хилэнгийн мөн чанарын талаар ойлголттой болсон болохоор Сатаны ёрын мууг хэрхэн ялгах талаар бүр ч илүү дээр ойлголттой гарцаагүй болсон байх ёстой!

Сатан энэрэнгүй, шударга, журамтай мэт харагддаг ч мөн чанартаа харгис агаад ёрын муу билээ

Сатан хүмүүсийг мэхлэх замаар нэр хүнд олж авдгийн дээр үргэлж өөрийгөө зөв шударга байдлын манлайлагч, үлгэр дуурайл болгодог. Зөв шударга байдлыг хамгаалах нэрийдлээр хүмүүст хор учруулж, сүнсийг нь залгиж, хүнийг хөшүүн болгож, хууран мэхэлж, турхирахын тулд бүхий л төрлийн арга барил ашигладаг. Түүний зорилго нь, ёрын муу үйл хэргийг нь хүн хүлээн зөвшөөрч, дагадаг болгож, Бурханы эрх мэдэл, дээд эрхийг эсэргүүцэхэд хүнийг өөртөө нэгтгэх явдал юм. Гэвч, хүн түүний явуулга, хуйвалдаан, өөдгүй төрхийг мэддэг болж, түүнд гишгэчүүлж, хууртаж, үргэлжлүүлэн түүнд боолчлогдож, түүнтэй хамт шийтгүүлж, сүйрэхийг хүсэхгүй байх үед Сатан урьдын ариун гэгээн төрхөө өөрчилж, хуурамч багаа хуулан ёрын муу, харгис догшин, муухай, хэрцгий жинхэнэ нүүр царайгаа илчилдэг. Тэр өөрийг нь дагахаас татгалзаж, өөрийнх нь муу ёрын хүчийг эсэргүүцдэг бүх хүнийг үгүй хийхэд юунаас ч илүү дуртай. Энэ үед Сатан итгэл

даахуйц, боловсон дүр төрхтэй байж чадахаа больж; харин ч хонины арьсан доороос муу муухай, диаволлог жинхэнэ төрх нь ил гардаг. Явуулга нь илчлэгдэж, жинхэнэ төрх нь ил болмогц Сатан уурсаж, зэрлэг балмад зангаа харуулдаг. Үүний дараа хүмүүсийг хорлож, залгих хүсэл нь улам бүр л нэмэгдэх болно. Учир нь, хүн үнэнийг ухаарахад тэр уурсдагийн дээр эрх чөлөө болон гэрэлд тэмүүлж, өөрийнх нь шоронгоос чөлөөлөгдөхийг хүсэн эрмэлзсэнийх нь төлөө тэрээр хүнд асар их өс хонзон санадаг. Түүний уур хилэн өөрийн ёрын мууг л хамгаалж хадгалахыг зорьдог бөгөөд энэ нь ч бас харгис хэрцгий уг чанарынх нь жинхэнэ илрэл юм.

Сатаны хийсэн бүхэн нь түүний ёрын муу уг чанарыг харуулдаг. Хүнд Сатаны хийсэн бүх ёрын муу үйл хэргээс—хүнийг төөрөгдүүлэн өөрийгөө дагуулах гэсэн эртний хичээл чармайлтаас нь эхлээд хүнийг ашиглаж, ёрын муу үйл хэрэгтээ татан оруулах хүртэл, мөн үнэн нүүр царай нь илчлэгдэж, хүн түүнийг таньж, хаясны дараа хүнд өс санах хүртэл—бүгд Сатаны ёрын муу мөн чанарыг илчилдэг, Сатан эерэг зүйлтэй ямар ч хамаагүй, Сатан бол бүх ёрын муу зүйлийн эх сурвалж хэмээх баримтыг бүгд баталдаг, Түүний үйлдэл нэг бүр муу муухайг нь хадгалж, муу үйл хэргийг нь үргэлжлүүлж, шударга болон эерэг зүйлсийн эсрэг явж, хүний хэвийн оршин тогтнолын хууль, дэг журмыг алдагдуулдаг. Сатаны эдгээр үйл нь Бурханд дайсагнадаг бөгөөд Бурханы уур хилэнд сүйрэх болно. Сатанд өөрийн гэсэн уур хилэн байдаг боловч түүний уур хилэн бол ердөө л ёрын муу уг чанараа гаргах арга зам юм. Сатан унтууцаж, улангасан уурладгийн шалтгаан нь гэвэл: Түүний үгээр хэлшгүй явуулга ил болсон; түүний хуйвалдаан зүгээр өнгөрөхөд амаргүй байдаг; Бурханыг орлож, Бурхан шиг авирлах гэсэн түүний галзуу санаархал, эрмэлзэл нь цохигдож, саад учирсан; бүх хүн төрөлхтнийг захирах түүний зорилго нь одоо талаар болж, хэзээ ч биелэх боломжгүй болсон. Сатаны хуйвалдаан хэрэгжихийг зогсоож, Сатаны муу муухай дэлгэрч, тархахыг тасалдуулсан зүйл бол Бурхан уур хилэнгээ ахин дахин гаргасан явдал юм. Тийм учраас Сатан, Бурханы уур хилэнг үзэн ядаж, бас түүнээс айдаг. Бурханы уур хилэн буух болгондоо Сатаны жигшүүрт үнэн дүр төрхийг ил болгоод зогсохгүй, Сатаны хорон муу хүслийг харуулах явцдаа хүн төрөлхтний эсрэг Сатаны уур хилэнгийн шалтгааныг бүрмөсөн илчилдэг. Сатаны уур хилэн буцалж байгаа нь түүний хорон муу уг чанар жинхэнээсээ илчлэгдэж, түүний явуулга ил болж байгаа явдал юм. Мэдээж Сатан уурсах болгонд, энэ нь ёрын муу зүйлсийн сүйрлийг, мөн эерэг зүйлс хамгаалагдаж, үргэлжлэн байгааг тунхагладаг; Бурханы уур хилэнд халдаж болохгүй гэдэг бодит үнэнийг тунхагладаг!

Бурханы зөвт зан чанарыг мэдэхийн тулд хүн туршлага болон төсөөлөлдөө найдах ёсгүй

Чи Бурханы шүүлт, гэсгээлттэй нүүр тулсан үедээ, Бурханы үгийг хуурамч гэж хэлэх үү? Чи Бурханы уур хилэнгийн цаана түүх байгаа бөгөөд тэр нь хуурамч гэж хэлэх үү? Бурханы зан чанар бүхэлдээ зөвт байх албагүй хэмээн хэлж Түүнийг

гүтгэх үү? Бурханы үйл болгонтой харьцахдаа чи Бурханы зөвт зан чанарт өөр ямар ч хольц байхгүй, ариун агаад өө сэвгүй гэдэгт эхлээд итгэлтэй байх ёстой. Эдгээр үйлд, Бурхан хүн төрөлхтнийг цохин унагааж, шийтгэж, сүйрүүлэх багтдаг. Бурхан үйл болгоноо бүгдийг нь Өөрийн төрөлх зан чанар, төлөвлөгөөнд чанд нийцүүлэн хийдэг бөгөөд үүнд хүний ямар ч мэдлэг, уламжлал, гүн ухаан хамаардаггүй. Бурханы үйл нэг бүр нь завхарсан хүн төрөлхтөнд харьяалагддаг ямар ч зүйлтэй холбоогүй, Түүний зан чанар, мөн чанарын илэрхийлэл билээ. Зөвхөн хүн төрөлхтөнд хандах Бурханы хайр, өршөөл, хүлээцтэй байдал л өө сэвгүй, жинхэнэ агаад ариун гэсэн үзэл хүн төрөлхтөнд байдаг, харин Бурханы хилэгнэл болон уур хилэн мөн адил жинхэнэ гэдгийг хэн ч мэддэггүй; түүнчлэн Бурхан яагаад халдахыг тэвчдэггүй, Түүний хилэгнэл яагаад асар их байдаг гэх мэт асуултуудыг хэн ч эргэцүүлэн бодож байгаагүй. Эсрэгээрээ, зарим хүн Бурханы уур хилэнг завхарсан хүн төрөлхтнийх шиг муухай ааштай андуурч, Бурханы уурыг завхарсан хүн төрөлхтнийх шиг улангассан уур гэж буруу ойлгодог. Тэр ч бүү хэл, тэд Бурханы уурыг хүн төрөлхтний завхарсан зан чанарын ердийн илрэлтэй яг адил, Бурхан уур хилэнгээ гаргах нь завхарсан хүмүүсийн онцгүй нөхцөл байдалтай тулгарахдаа гаргадаг ууртай яг адилхан гэж эндүүрч бодон, Бурхан уур хилэнгээ гаргах нь Түүний сэтгэл хөдлөлийн илэрхийлэл гэж итгэдэг. Энэ нөхөрлөлийн дараа та нар дор бүрнээ Бурханы зөвт зан чанарын талаар буруу ойлголт, төсөөлөл, таамаглалтай байхаа болино гэж Би найдаж байна. Миний үгийг сонссоныхоо дараа Бурханы зөвт зан чанарын уур хилэнг зүрх сэтгэлдээ үнэхээр танин мэдэж, Бурханы уур хилэнгийн талаарх урьдын буруу ойлголтоо хаяж, Бурханы уур хилэнгийн мөн чанарын талаарх өөрсдийн буруу итгэл үнэмшил, үзэл бодлыг өөрчилж чадна гэж Би найдаж байна. Түүнчлэн, та нар зүрх сэтгэлдээ Бурханы зан чанарын талаар үнэн зөв тодорхойлолттой болж чадна, Бурханы зөвт зан чанарын талаар эргэлзэхээ больж, Бурханы жинхэнэ зан чанарт хүний аливаа эргэцүүлэл, төсөөллийг тулгахгүй гэж Би найдаж байна. Бурханы зөвт зан чанар бол Бурханы Өөрийнх нь жинхэнэ мөн чанар билээ. Энэ бол хүний бичсэн, эсвэл тодорхойлсон зүйл биш. Түүний зөвт зан чанар бол Түүний л зөвт зан чанар, ямар ч бүтээлтэй хамаатай, холбоотой биш. Бурхан Өөрөө бол Бурхан л Өөрөө. Тэр хэзээ ч бүтээлийн нэг хэсэг болохгүй, бүтээгдсэн зүйлсийн нэг болсон ч гэсэн, Түүний төрөлх зан чанар болоод мөн чанар өөрчлөгдөхгүй. Тиймээс Бурханыг мэдэх нь эд юмыг мэдэхтэй адил биш; Бурханыг мэдэх нь ямар нэг зүйлийг задлан шинжлэх явдал биш, хүнийг ойлгохтой ч бас адилгүй. Хэрвээ хүн эд юмыг мэдэх, эсвэл хүнийг ойлгох үзэл баримтлал, арга барилаа Бурханыг мэдэхэд ашигладаг бол Бурханы талаарх мэдлэгийг хэзээ ч олж авч чадахгүй. Бурханыг мэдэх нь туршлага, төсөөллөөс хамааралтай биш учраас чи туршлага болон төсөөллөө Бурханд хэзээ ч тулгах ёсгүй; туршлага болон төсөөлөл чинь хэчнээн ч баялаг байсан, бас л хязгаарлагдмал юм. Үүнээс ч илүүтэйгээр төсөөлөл чинь баримттай нийцдэггүй, үнэнтэй бүр ч нийцдэггүй, Бурханы жинхэнэ зан чанар болоод мөн

чанартай таардаггүй. Бурханы мөн чанарыг ойлгохын тулд төсөөлөлдөө найдах юм бол чи хэзээ ч амжилт олохгүй. Цорын ганц зам бол Бурханаас ирдэг бүхнийг хүлээн авч, дараа нь аажмаар туулж, ойлгох явдал юм. Ингээд зогсохгүй, хамтарч ажилласны чинь төлөө, бас үнэнээр өлсөж, цангасны чинь төлөө Өөрийгөө үнэхээр ойлгуулж, мэдүүлэхээр Бурхан чамайг гэгээрүүлэх өдөр ирнэ. Үүгээр ярианыхаа энэ хэсгийг дуусгацгаая.

Хүмүүс чин сэтгэлээсээ гэмшсэнээр Бурханы өршөөл, хүлээцтэй байдлыг хүртэнэ

“Бурхан Ниневег аварсан” тухай Библийн түүхийг дор өгүүлэв.

Иона 1:1–2 Еховагийн үг Амиттаин хүү Ионад ирээд, “Бос, их хот Ниневе уруу очиж, түүний оршин суугчдад хашхир. Учир нь тэдний хорон муу Миний өмнө ирэв” гэжээ.

Иона 3 Еховагийн үг Ионад хоёр дахь удаагаа ирж “Бос, их хот Ниневе рүү явж, Миний чамд айлдах тунхаглалыг тэдэнд зарла” гэж хэлэв. Ингээд Иона босож, Еховагийн үгийн дагуу Ниневе рүү явжээ. Ниневе, гурван өдрийн турш явж туулах үлэмж том хот байв. Иона нэг өдөржингөө хотоор явж, “Ердөө дөч хоногийн дараа Ниневе хөмөрнө” гэж хашхиран хэлж байлаа. Тэгээд Ниневе хотын хүмүүс Бурханд итгэж, мацаг барилт зарлан, хамгийн томоосоо хамгийн бага хүртлээ таар өмсөв. Ниневе хотын хаанд энэ үг хүрэхэд тэр сэнтийнээсээ босож, нөмрөгөө тайлан, таар нөмрөөд үнсэн дээр суулаа. Тэрээр тунхаг гаргаж, “Хаан болон түүний ноёдын зарлигийн дагуу хүн, адгуус амьтан, мал сүрэг юу ч амсаж болохгүй: тэд юм идэж, ус ууж болохгүй. Харин хүн болон адгуус амьтад бүгд таар нөмрөх ёстой, хүн Бурханд хандан чадлаараа гуй, хүн бүр ёрын муу замаасаа эргэж, гар дахь хүчирхийллээ хая. Бурхан эргэж зөөлрөн, догшин ширүүн уур хилэнгээ эргүүлж, бид мөхөхгүй ч байх юм билүү, хэн мэдэх билээ?” гэжээ. Бурхан ёрын муу замаасаа эргэсэн тэдний үйлсийг харав; тэгээд тэдэн дээр буулгана гэж хэлсэн гай гамшигтаа гэмшиж, улмаар тэднийг сүйрүүлсэнгүй.

Иона 4 Гэхдээ энэ нь Ионад огт таалагдсангүй, тэр маш их уурлав. Тэгээд тэрээр Еховад залбирч: “Өө, Ехова минь, би Танд залбирч байна, би нутагтаа байхдаа Танд үүнийг хэлээгүй гэж үү? Та бол нигүүлсэнгүй, өршөөнгүй, уурлахдаа удаан, сайхан сэтгэлтэй, гай гамшгийг зөөлрүүлэгч гэдгийг би мэддэг учраас Таршиш руу зугтсан. Тийм учраас, өө Ехова минь, Та надаас миний амийг аваач гэж би гуйж байна: учир нь, надад амьд явахаас үхэх нь илүү дээр” гэж хэлэв. Тэгэхэд нь Ехова түүнээс “Чамд уурлах шалтгаан байна уу?” гэж асуулаа. Улмаар Иона хотоос гарч, хотын зүүн талд суув, тэнд өөртөө сүүдрэвч бариад, хотод юу тохиолдохыг харах хүртлээ сүүдэрт нь суужээ. Тэгэхэд Ехова Бурхан эрэндийн бут бэлтгэж, толгой дээгүүр нь сүүдэрлэн, гуниг ганьхралаас нь салгахын тулд Ионагийн дээгүүр ургууллаа. Иона эрэндийн бутанд маш их баярлав. Гэхдээ дараа өдрийн өглөө болоход Бурхан өт бэлдэж, эрэндийн бутыг нэрвэхэд тэр нь гандаж хатав. Нар мандахад Бурхан дорнын халуун салхи бэлдэж, Ионагийн толгойг наранд цохиулахад тэр ухаан балартаж, үхэхийг хүсэн “Амьд явахаас үхсэн нь надад дээр” гэж хэлэв. Бурхан Ионагаас “Эрэндийн бутны төлөө уурлах шалтгаан чамд байна уу?” гэж асуухад

тэрээр, “Надад бүр үхтэлээ уурлах шалтгаан байна” гэлээ. Тэгэхэд Ехова: “Чи өөрөө хөдөлмөрлөж, ургуулаагүй, нэг шөнийн дотор ургаад, хатаж үхсэн эрэндийн бутыг өрөвдсөн. Тэгэхэд Би, баруун, зүүн гараа ялган салгаж чадахгүй зуун хорин мянгаас илүү хүнтэй, бас олон малтай их хот Ниневег өрөвдөн хайрлах хэрэггүй гэж үү?” гэж хэлэв.

Ниневегийн түүхийн тойм

“Бурхан Ниневег аварсан” тухай түүх хэдий богинохон боловч Бурханы зөвт зан чанарын нөгөө талыг зэрвэс харах боломжийг хүнд олгодог. Тэрхүү тал нь яг юунаас бүрдэж байгааг ойлгохын тулд бид Судар луу буцаж очоод, Өөрийн ажлын явцад хэрэгжүүлсэн Бурханы үйл хэргийг эргэж нэг харах ёстой.

Эхлээд энэ түүхийн эхлэлийг харцгаая: “Еховагийн үг Амиттаин хүү Ионад ирээд, ‘Бос, их хот Ниневе уруу очиж, түүний оршин суугчдад хашхир. Учир нь тэдний хорон муу Миний өмнө ирэв’ гэжээ” (Иона 1:1–2). Судрын энэ хэсгээс бид, Ехова Бурхан, Ниневе хот руу явахыг Ионад тушаасан гэдгийг мэднэ. Тэр яагаад Ионад энэ хот руу яв гэж тушаасан бэ? Библид энэ тухай маш тодорхой өгүүлсэн: Энэ хотын хүмүүсийн хорон муу нь Ехова Бурханы нүдэнд өртсөн учраас Өөрийн хийхийг зорьж байгаа зүйлийг тэдэнд тунхаглахын тулд Тэр Ионаг илгээжээ. Иона гэж хэн байсныг бидэнд хэлж өгөх юу ч тэмдэглэгдээгүй боловч энэ нь мэдээж Бурханыг мэдэхтэй хамаагүй. Тиймээс та нар Иона гэх энэ хүнийг ойлгохын хэрэггүй. Та нар Бурхан Ионад юу хий гэж тушаасныг, Бурхан ийм зүйл хийсэн шалтгааныг л мэдэх хэрэгтэй.

Ехова Бурханы анхааруулга Ниневед хүрэв

Бид хоёр дахь хэсэг буюу Ионагийн номын гуравдугаар бүлэг рүү орцгооё: “Иона нэг өдөржингөө хотоор явж, ‘Ердөө дөч хоногийн дараа Ниневе хөмөрнө’ гэж хашхиран хэлж байлаа.” Эдгээр нь Ниневе хотынхонд хэл гэж Ионад Бурханы шууд дамжуулсан үг байв, тэгэхээр мэдээж эдгээр нь Ниневе хотынхонд хэлэхийг хүссэн Еховагийн үг юм. Тэдний хорон муу нь Түүний нүдэнд өртсөн учир, Бурхан энэ хотын хүмүүсийг жигшиж, үзэн ядаж эхэлсэн, иймээс энэ хотыг Тэр устгахыг хүссэн гэдгийг эдгээр үг хүмүүст хэлдэг. Гэсэн хэдий ч, Бурхан хотыг устгахаасаа өмнө Ниневе хотынхонд зарлан тунхаглахын зэрэгцээ хорон муу байдалдаа гэмшиж, шинээр эхлэх боломжийг тэдэнд өгсөн. Энэ боломж нь дөч хоног үргэлжлээд дуусах байв. Өөрөөр хэлбэл, хотын хүмүүс дөчин өдрийн дотор гэмшиж, Ехова Бурханы өмнө нүглээ улайж, нүүрээрээ газар унан мөргөхгүй бол Бурхан Содомын нэгэн адилаар энэ хотыг устгах байсан юм. Ехова Бурханы Ниневегийн хүмүүст хэлэхийг хүссэн зүйл энэ байлаа. Энэ нь энгийн нэг тунхаглал байгаагүй нь тодорхой. Энэ нь Ехова Бурханы уурыг дамжуулаад зогсохгүй, мөн Ниневе хотынхонд хандах хандлагыг нь дамжуулсны зэрэгцээ бас уг хотод амьдарч байсан хүмүүст хатуу анхааруулга болсон. Энэхүү анхааруулга нь тэдний хорон муу үйлдэл Ехова Бурханы үзэн ядалтыг төрүүлсэн, удахгүй тэднийг сүйрлийн ирмэгт

аваачна гэдгийг хэлсэн. Тиймээс Ниневегийн оршин суугч нэг бүрийн аминд аюул заналхийлж байсан юм.

Ехова Бурханы анхааруулгад үзүүлсэн Ниневе болон Содомын хариу үйлдлийн эрс тэс ялгаа

Хөмрөх гэдэг нь юу гэсэн үг вэ? Ярианы хэлээр бол энэ нь оршин тогтнохоо болно гэсэн үг. Гэхдээ ямар замаар? Хэн бүхэл бүтэн хотыг хөмөрч чадах вэ? Хүний хувьд мэдээж ийм үйлдлийг гүйцэтгэх боломжгүй. Ниневегийн хүмүүс тэнэг байгаагүй; энэ тунхаглалыг сонсмогцоо л тэд даруй ойлгосон. Тэрхүү тунхаглал нь Бурханаас ирснийг, Бурхан ажлаа гүйцэтгэх гэж байгааг, өөрсдийнх нь хорон муу байдал Ехова Бурханыг хилэгнүүлж, Түүний уурыг өөрсөд дээрээ авчирч, ингэснээр удахгүй хоттойгоо хамт сүйрэх юм байна гэдгээ тэд мэдсэн. Ехова Бурханы анхааруулгыг сонссоныхоо дараа уг хотын хүмүүс хэрхэн авирласан бэ? Хаанаасаа эхлээд энгийн иргэд хүртэл хүмүүс ямар хариу үйлдэл хийснийг Библид маш дэлгэрэнгүй дүрсэлсэн. Дараах үгс Сударт тэмдэглэгдсэн байдаг: “Тэгээд Ниневе хотын хүмүүс Бурханд итгэж, мацаг барилт зарлан, хамгийн томоосоо хамгийн бага хүртлээ таар өмсөв. Ниневе хотын хаанд энэ үг хүрэхэд тэр сэнтийнээсээ босож, нөмрөгөө тайлан, таар нөмрөөд үнсэн дээр суулаа. Тэрээр тунхаг гаргаж, ‘Хаан болон түүний ноёдын зарлигийн дагуу хүн, адгуус амьтан, мал сүрэг юу ч амсаж болохгүй: тэд юм идэж, ус ууж болохгүй. Харин хүн болон адгуус амьтад бүгд таар нөмрөх ёстой, хүн Бурханд хандан чадлаараа гуй, хүн бүр ёрын муу замаасаа эргэж, гар дахь хүчирхийллээ хая…’ гэжээ” (Иона 3:5–9).

Ехова Бурханы тунхаглалыг сонссоны дараа, Ниневегийн хүмүүс Содомын хүмүүсийнхээс шал өөр хандлага харуулсан—Содомын хүмүүс Бурханыг илт эсэргүүцэж, муугаас мууг хийж байсан бол энэ үгийг сонссоныхоо дараа Ниневе хотынхон хэрэг явдалд тоомсоргүй хандаагүй, эсэргүүцээ ч гүй. Харин тэд Бурханд итгэж, мацаг барилт зарласан. Энд “итгэсэн” гэдэг үг нь юуг хэлж байна вэ? Энэ үг нь өөрөө итгэл, дуулгавартай байдал гэсэн утгыг илэрхийлдэг. Хэрвээ бид Ниневе хотынхны бодит үйлдлийг ашиглан энэ үгийг тайлбарлавал, Бурхан хэлснийхээ дагуу хийж чадна, хийх ч болно гэж тэд итгэсний дээр гэмшихэд бэлэн байсан гэсэн үг юм. Ниневегийн хүмүүс заналхийлж буй аюулаас айж байсан уу? Тэдний итгэл нь тэдний зүрх сэтгэлд айдас төрүүлж байсан. Тэгэхээр Ниневе хотынхны итгэл болон айдсыг батлахын тулд бид юу ашиглаж болох вэ? Библид өгүүлсэнчлэн: “…тэд мацаг барилт зарлан, хамгийн томоосоо хамгийн бага хүртлээ таар өмсжээ.” Өөрөөр хэлбэл, Ниневе хотынхон үнэхээр итгэсэн, энэхүү итгэлээс айдас төрж, тэднийг мацаг барьж, таар өмсөхөд хүргэсэн. Гэмшиж эхэлж байгаагаа тэд ингэж харуулсан юм. Содомын хүмүүсээс шал эсрэгээр Ниневегийн хүмүүс Бурханыг эсэргүүцээгүйгээр үл барам, мөн зан авир болон үйлдлээрээ гэмшиж байгаагаа тодорхой харуулсан. Мэдээж энгийн ард иргэд төдийгүй, хаан нь ч ялгаагүй, Ниневегийн хүмүүс бүгд үүнийг хийсэн.

Ниневегийн хааны гэмшил Ехова Бурханы сайшаалыг хүртсэн

Ниневегийн хаан энэ мэдээг сонсоод сэнтийнээсээ босож, өмсгөлөө тайлан, таар нөмрөөд, үнсэн дээр суусан. Тэгээд тэр, хотод байгаа хэн ч юу ч амсаж болохгүй, үхэр хонь, өөр бусад ямар ч амьтан идээшилж, ус ууж болохгүй хэмээн тунхагласан. Хүн болон мал амьтад адилхан таар нөмрөх учиртай, хүмүүс чин сэтгэлээсээ Бурханаас гуйх ёстой байсан. Бас хүн бүр муу замаасаа татгалзаж, хүчирхийлэл хийдгээ болих ёстой гэж хаан тунхагласан. Эдгээр үйлдлээс үзвэл, Ниневегийн хаан үнэн сэтгэлээсээ гэмшиж байсан юм. Сэнтийнээсээ босож, хааны өмсгөлөө тайлж, таар нөмрөн, үнсэн дээр суусан гээд түүний хийсэн эдгээр үйлдэл нь Ниневегийн хаан хааны байр сууриа орхиж, энгийн ардын хамтаар таар өмссөн гэдгийг хүмүүст хэлж өгдөг. Өөрөөр хэлбэл, Ехова Бурханы тунхаглалыг сонссоныхоо дараа Ниневегийн хаан өөрийн муу замыг, хүчирхийлэл хийхээ үргэлжлүүлэхээр хаан суудлаа эзэгнээгүй; харин ч өөрийн барьж байсан эрх мэдлийг орхиж, Ехова Бурханы өмнө гэмшсэн. Энэ үед Ниневегийн хаан, хааны хувиар гэмшээгүй; харин Бурханы энгийн албатын хувиар гэмшиж, нүглээ улайхын тулд Бурханы өмнө очсон. Түүнчлэн Ехова Бурханы өмнө өөр шиг нь нүглээ улайж, гэмшихийг бүхий л хотынхонд бас хэлсэн; дээр нь нэмээд, үүнийг хийх тодорхой төлөвлөгөө түүнд байсныг Сударт ийнхүү өгүүлжээ: “Хүн, адгуус амьтан, мал сүрэг юу ч амсаж болохгүй: тэд юм идэж, ус ууж болохгүй … хүн Бурханд хандан чадлаараа гуй, хүн бүр ёрын муу замаасаа эргэж, гар дахь хүчирхийллээ хая.” Хотын захирагч болохын хувьд Ниневегийн хаан эрхэм дээд байр суурь болоод эрх дархтай бөгөөд хүссэн бүхнээ хийж чадах байсан. Ехова Бурханы тунхаглалтай нүүр тулах үедээ тэр хэрэг явдлыг үл тоож, эсвэл зүгээр л ганцаараа гэмшиж, нүглээ улайж болох байсан; хотын хүмүүсийн гэмших эсэхийн тухайд бол тэрээр үүнийг огт тоохгүй орхиж болох байсан юм. Гэхдээ Ниневегийн хаан огтхон ч ингээгүй. Тэр сэнтийнээсээ босож, үнс, таар өмсөж, Ехова Бурханы өмнө гэмшиж, нүглээ улайгаад зогсохгүй, бас уг хотод байгаа бүх хүн, малд мөн адил ингэхийг тушаасан. Тэр ч бүү хэл тэрээр “Бурханд хандан чадлаараа гуйхыг” хүмүүст тушаасан. Энэхүү хэд хэдэн үйлдлээрээ Ниневегийн хаан, удирдагч хүний хийх ёстой зүйлийг үнэхээр биелүүлсэн. Түүний үйлдлүүд нь хүн төрөлхтний түүхэн дэх ямар ч хааны хувьд хийхэд хэцүү зүйл байсан ба үнэндээ өөр ямар ч хаан ийм зүйл хийж чадаагүй. Эдгээр үйлдлийг хүн төрөлхтний түүхэнд урьд өмнө болж байгаагүй зүйл гэж хэлж болох бөгөөд хүн төрөлхтөн үүнийг дуурсаж, даган дуурайваас зохистой. Хүн үүссэн цагаас хойш бүхий л хаад Бурханыг сөрж, эсэргүүцэхэд албатуудаа хөтөлж байсан. Өөрсдийн хорон муугийнхаа төлөө аврал эрэн Бурханаас гуйж, Ехова Бурханы өршөөлийг хүлээн авч, заналхийлж буй шийтгэлээс зайлсхийхэд хэн ч, хэзээ ч албатуудаа хөтөлж байгаагүй. Ниневегийн хаан харин албатуудаа Бурхан руу хандуулж, дор бүрнээ хорон муу замыг орхиж, хүчирхийлэл хийхээ болиход хүргэж чадсан. Түүнчлэн тэр хаан ширээгээ орхиж

чадсан бөгөөд хариуд нь Ехова Бурхан сэтгэл нь өөрчлөгдөж, харамсаж, уур хилэнгээ татаж, хотын хүмүүст амьд үлдэх боломж олгож, тэднийг сүйрлээс хамгаалжээ. Энэхүү хааны үйлдлийг хүн төрөлхтний түүхэн дэх ховор гайхамшиг, тэр ч бүү хэл завхарсан хүн төрөлхтөн Бурханы өмнө гэмшиж, нүглээ улайж байгаагийн үлгэр дуурайл гэж л нэрлэж болно.

Бурхан Ниневе хотынхны зүрх сэтгэлийн гүн дэх чин сэтгэлийн гэмшлийг харсан нь

Бурханы тунхаглалыг сонссоныхоо дараа Ниневегийн хаан болон түүний албатууд хэд хэдэн үйлдэл хийсэн. Тэдний зан авир болоод үйлдлийн уг чанар юу байсан бэ? Өөрөөр хэлбэл, тэдний авирын ерөнхий мөн чанар нь юу байсан бэ? Тэд яагаад тийм юм хийсэн бэ? Бурханы нүдээр бол тэд үнэхээр гэмшсэн, учир нь тэд чин сэтгэлээсээ Бурханаас гуйж, Түүний өмнө нүглээ улайгаад зогсохгүй, хорон муу авирлахаа больсон. Бурханы үгийг сонсоод тэд ихэд эмээж, Тэр хэлснээрээ хийнэ гэж итгэсэн учраас ийм үйлдэл хийжээ. Мацаг барьж, таар өмсөж, үнсэнд сууснаараа тэд замаа засаж, хорон мууг цээрлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэхийг хүсэж, уураа барихыг гуйн Ехова Бурханд залбирч, шийдвэрээ буцааж, өөрсөд дээр нь буух гэж буй гай гамшгийг зогсоохыг Ехова Бурханаас гуйж байв. Тэдний бүх зан авирыг шинжилж үзвэл, өөрсдийнх нь урьдын хорон муу үйл Ехова Бурханд жигшүүртэй байсан гэдгийг тэд аль хэдийн ойлгосон байсан ба Тэр яагаад өөрсдийг нь удахгүй сүйрүүлэх болсныг ч бас тэд хэдийнээ ойлгосон байсан гэдгийг бид харж болно. Энэ шалтгааны улмаас тэд бүгд бүрэн дүүрэн гэмшиж, хорон муу замаасаа татгалзаж, хүчирхийлэл хийхээ болихыг хүссэн. Өөрөөр хэлбэл, Ехова Бурханы тунхаглалыг мэдмэгцээ тэд бүгд зүрх сэтгэлдээ айдас мэдэрсэн; тэд хорон муу авирлахаа больж, Ехова Бурханы ихэд жигшдэг үйлийг үйлдэхээ больсон юм. Түүнчлэн, урьдын нүглийг нь уучилж, урьдын үйлдлүүдээр нь хандахгүй байхыг Ехова Бурханаас гуйсан. Тэд Ехова Бурханыг дахин хэзээ ч хилэгнүүлэхгүй байх боломжтой л байвал ахин хэзээ ч хорон мууг үйлдэхгүй байж, Ехова Бурханы зааврын дагуу үйлдэхэд бэлэн байлаа. Тэдний гэмшил чин сэтгэлийн агаад бүрэн гүйцэд байв. Энэхүү гэмшил нь тэдний зүрх сэтгэлийн гүнээс гарсан бөгөөд хуурамч, түр зуурын байгаагүй.

Нэгэнтээ, Ниневегийн бүх хүн, хаанаасаа эхлээд ардууд хүртэл, Ехова Бурхан өөрсдөд нь хилэгнэсэн, тэдний дараа дараагийн үйлдэл бүр, бүхий л авир, мөн гаргасан шийдвэр, хийсэн сонголт бүрийг Бурхан тов тодорхой харж чадна гэдгийг мэдэж авсан. Бурханы зүрх сэтгэл Тэдний зан авирыг дагаж өөрчлөгдсөн юм. Яг тэр үед Бурханы сэтгэл санаа ямар байсан бэ? Библи тэр асуултад чинь хариулж чадна. Дараах үгс сударт тэмдэглэгдсэн байсан: “Бурхан ёрын муу замаасаа эргэсэн тэдний үйлсийг харав; тэгээд тэдэн дээр буулгана гэж хэлсэн гай гамшигтаа гэмшиж, улмаар тэднийг сүйрүүлсэнгүй” (Иона 3:10). Хэдийгээр Бурхан санаагаа өөрчилсөн ч Түүний сэтгэл санаанд ямар ч ярвигтай зүйл байгаагүй. Тэр

зүгээр л ууpаа илэрхийлж байснаа тайтгарсан бөгөөд дараа нь Ниневе хотын хүмүүст гай гамшиг учруулахгүй байхаар шийдсэн. Ниневе хотынхныг гай гамшгаас хэлтрүүлэх Бурханы шийдвэр маш хурдан байсны шалтгаан нь Бурхан Ниневегийн хүн бүрийн зүрх сэтгэлийг ажигласанд оршино. Тэдний чин сэтгэлээсээ гэмшиж, нүглээ улайж, чин сэтгэлээсээ Түүнд итгэж, хорон муу үйлдэл нь Бурханы зан чанарыг хилэгнүүлснийг гүнээ мэдэрч, үүний улмаас Ехова Бурханы заналхийлж буй шийтгэлээс айсан гээд тэдний зүрх сэтгэлийн гүнд байгаа зүйлийг нь Тэр харсан юм. Үүний зэрэгцээ, энэхүү гай гамшгаас зайлсхийж магадгүй гэсэндээ өөрсдөд нь уурлахаа болихыг Түүнээс гуйж зүрх сэтгэлийнхээ гүнээс залбирсан залбирлыг нь Ехова Бурхан бас сонссон билээ. Энэ бүх бодит байдлыг ажиглаад Бурханы уур хилэн бага багаар намжсан. Түүний уур хилэн урьд нь хэчнээн их байсан ч гэсэн, энэ хүмүүсийн зүрх сэтгэлийн гүн дэх чин сэтгэлийн гэмшлийг хараад Түүний сэтгэл хөдөлсөн болохоор тэдэнд гай гамшиг учруулж түвдээгүйн дээр тэдэнд хилэгнэхээ больсон. Харин ч Тэр тэдэнд Өөрийн өршөөл, хүлээцтэй байдлыг үргэлжлүүлэн үзүүлж, тэднийг үргэлжлүүлэн залж чиглүүлж, хангаж байсан билээ.

Бурханд итгэх итгэл чинь жинхэнэ бол чи Түүний халамжийг үргэлж хүртэнэ

Бурхан Ниневегийн хүмүүст хандах санаа зорилгоо өөрчилсөнд ямар ч эргэлзээ юм уу тодорхойгүй байдал хамаагүй. Харин ч энэ нь цэвэр уур хилэнгээс цэвэр хүлээцтэй байдал болж хувирсан юм. Энэ бол Бурханы мөн чанарын жинхэнэ илрэл билээ. Бурхан үйлдэхдээ хэзээ ч шийдэмгий бус байж, тээнэгэлздэггүй; Түүний үйлдлийн цаад зарчим болон зорилго бүгд тодорхой, ил тод, цэвэр ариун, өө сэвгүй, мөн ямар ч заль мэх, далд явуулга огт холилдоогүй байдаг. Өөрөөр хэлбэл, Бурханы мөн чанар ямар ч хар бараан, ёрын мууг агуулдаггүй. Ёрын муу үйлдэл нь Түүний нүдэнд өртсөн учраас Бурхан Ниневе хотынхонд хилэгнэсэн; тэр үед Бурханы уур хилэн мөн чанараас нь үүдэн гарсан. Гэсэн хэдий ч, Бурханы уур хилэн арилж, дахин нэг удаа Ниневегийн хүмүүст хүлээцтэй хандах үед Түүний харуулсан бүхэн нь бас л Түүний мөн чанар байсан юм. Энэ өөрчлөлт нь бүхэлдээ Бурханд хандах хүний хандлага өөрчлөгдсөнөөс болсон. Энэ бүх хугацаанд Бурханы халдашгүй зан чанар өөрчлөгдөөгүй; Бурханы хүлээцтэй мөн чанар өөрчлөгдөөгүй; Бурханы энэрэнгүй, өршөөнгүй мөн чанар өөрчлөгдөөгүй. Хүмүүс хорон муу үйл үйлдэж, Бурханд халдах үед Тэр тэдэнд хилэгнэнэ. Хүмүүс үнэхээр гэмших үед, Бурханы зүрх сэтгэл өөрчлөгдөж, уур хилэн нь намжих болно. Хүмүүс зөрүүдлэн Бурханыг эсэргүүцсээр байвал Түүний хилэн намжихгүй, Бурхан уур хилэнгээрээ бага багаар дарсаар тэднийг сүйрүүлэх болно. Энэ бол Бурханы зан чанарын мөн чанар юм. Бурхан уур хилэн, өршөөл, өгөөмөр сэтгэлийн алийг нь ч үзүүлж байсан, Бурханы зан чанарын илрэлээр аль нь илрэн гарахыг, хүний авир, зан байдал, зүрх сэтгэлийнх нь гүнд дэх Бурханд хандах

хандлага шийддэг. Хэрвээ Бурхан тасралтгүй нэг хүнд уурлаж байвал тэр хүний зүрх сэтгэл Бурханыг эсэргүүцдэг нь гарцаагүй. Тэр хүн хэзээ ч үнэхээр гэмшиж, Бурханы өмнө толгой бөхийж, Бурханд жинхэнээсээ итгэж байгаагүй учраас Бурханы өршөөл, хүлээцтэй байдлыг хэзээ ч хүртээгүй. Хэрвээ хүн Бурханы халамж, өршөөл, хүлээцтэй байдлыг үргэлж хүртдэг бол тэр хүн зүрх сэтгэлдээ Бурханд үнэхээр итгэдэг нь гарцаагүй бөгөөд түүний зүрх сэтгэл Бурханыг эсэргүүцдэггүй. Тийм хүн үргэлж Бурханы өмнө үнэхээр гэмшдэг; тиймээс Бурханы сахилгажуулалт түүн дээр дандаа ирдэг ч гэсэн, Түүний уур хилэн ирэхгүй.

Энэхүү товч тайлбар нь хүмүүст Бурханы зүрх сэтгэл, Түүний мөн чанарын үнэн бодитой байдал, Бурханы уур хилэнг харуулж, Түүний сэтгэл өөрчлөгдөх нь учир шалтгаантай байдаг гэдгийг харуулдаг. Ууртай байх үедээ болон сэтгэл нь өөрчлөгдөх үедээ Бурхан эрс тэс ялгаатай харагддаг нь уур хилэн болон хүлээцтэй байдал хэмээх Бурханы мөн чанарын хоёр талын хооронд томоохон зай, ялгаа оршиж байгаа гэж хүмүүст итгүүлдэг ч гэсэн Ниневе хотынхны гэмшилд хандах Бурханы хандлага нь Бурханы жинхэнэ зан чанарын өөр нэг талыг дахин нэг удаа хүмүүст харуулдаг. Бурханы сэтгэл өөрчлөгдөх нь Бурханы өршөөл, өгөөмөр сэтгэлийн үнэн бодитой байдал, Бурханы мөн чанарын жинхэнэ илрэлийг хүн төрөлхтөнд дахин нэг удаа үнэн бодитоор харуулдаг. Бурханы өршөөл, өгөөмөр сэтгэл нь домог биш, худал зүйл ч биш гэдгийг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Учир нь Бурханы тухайн үеийн мэдрэмж жинхэнэ байсан; Бурханы сэтгэл өөрчлөгдсөн нь ч үнэн байсан; Бурхан үнэхээр хүн төрөлхтөнд дахин нэг удаа өршөөлөө хайрлаж, хүлээцтэй хандсан.

Ниневе хотынхон үнэн сэтгэлээсээ гэмшсэнээр Бурханы өршөөлийг хүртэж, төгсгөлөө өөрчилсөн

Бурханы сэтгэл өөрчлөгдсөн болон Түүний уур хилэнгийн хооронд ямар нэгэн харшилдах зүйл байсан уу? Мэдээж үгүй! Учир нь яг тухайн үеийн Бурханы хүлээцтэй байдал өөрийн гэсэн шалтгаантай байсан. Энэ нь ямар шалтгаан байж болох вэ? Энэ бол Библид өгүүлсэн “Хүн бүр ёрын муу замаасаа татгалзаж”, “өөрсдийн гар дахь хүчирхийллээ хаях” хэмээх шалтгаан юм.

Энэхүү “ёрын муу зам” нь цөөн хэдэн муу үйлийг хэлдэггүй, харин хүмүүсийн зан авир урган гардаг ёрын муу эх сурвалжийг хэлдэг. “Ёрын муу замаасаа эргэх” гэдэг нь тухайн хүмүүс дахин хэзээ ч тийм үйлдэл гаргахгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, тэд ахин хэзээ ч ийм ёрын муу авир гаргахгүй; тэдний үйлдлийн арга барил, эх үүсвэр, зорилго, санаа зорилго, зарчим бүгд өөрчлөгдсөн; зүрх сэтгэлдээ таашаал, аз жаргал авчрахын тулд тэд дахин хэзээ ч тэдгээр арга барил, зарчмыг ашиглахгүй. “Гар дахь хүчирхийллээ хаях” гэдгийн “хаях” гэдэг нь болих, орхих, өнгөрснөөсөө бүрэн салах, хэзээ ч эргэж буцахгүй байх гэсэн утгатай. Ниневегийн хүмүүс хүчирхийлэл хийхээ болих үед энэ нь тэдний жинхэнэ гэмшлийг баталж, бас илэрхийлсэн. Бурхан хүмүүсийн гадаад байдлыг харж, мөн зүрх сэтгэлийг нь

ажигладаг. Ниневе хотынхон чин сэтгэлээсээ гэмшихийг нь гарцаагүй ажиглаж, мөн ёрын муу замаа орхиж, гар дахь хүчирхийллээ хаясныг нь хараад Бурхан зүрх сэтгэлээ өөрчилсөн. Өөрөөр хэлбэл, энэ хүмүүсийн авир, зан байдал, аливааг хийх янз бүрийн арга, түүнчлэн үнэн сэтгэлээсээ нүглээ улайж, гэмшсэн учраас Бурханы сэтгэл өөрчлөгдөж, санаагаа өөрчилж, шийдвэрээ буцаан, тэднийг шийтгэж сүйрүүлэхээ больсон. Тиймээс Ниневегийн хүмүүсийн төгсгөл өөрчлөгдсөн. Тэд амиа золин аварсны зэрэгцээ Бурханы өршөөл, хүлээцтэй байдлыг хүртсэн, энэ мөчид Бурхан бас уур хилэнгээ татсан билээ.

Бурханы өршөөл, хүлээцтэй байдал ховор биш, хүний жинхэнэ гэмшил л ховор юм

Бурхан Ниневе хотынхонд хэчнээн их уурласан ч гэсэн, тэднийг мацаг барихаа зарлаж, таар, үнс өмсмөгц Түүний зүрх сэтгэл нь зөөлөрч, санаа нь өөрчлөгдөж эхэлсэн. Хотыг нь устгах болно гэдгээ тэдэнд тунхаглах үед буюу тэднийг нүглээ улайж, гэмшихээс өмнө, Бурхан тэдэнд уурласан хэвээр байв. Тэднийг гэмшлийн хэд хэдэн үйлдэл хийнгүүт Ниневегийн хүмүүст уурлах Бурханы уур аажмаар өршөөл, хүлээцтэй байдал болон хувирсан. Бурханы зан чанарын энэ хоёр тал нэг үйл явдал дээр давхцан илэрсэнд ямар ч зөрчилдөх зүйл байхгүй. Тэгэхээр ийнхүү зөрчилдөхгүй гэдгийг хүн хэрхэн ойлгож, мэдэх ёстой вэ? Ниневегийн хүмүүсийг гэмших үед Бурхан, энэхүү хоёр эсрэг тэсрэг мөн чанарыг илэрхийлэн, харуулж, Бурханы мөн чанарын үнэн бодитой агаад халдашгүй байдлыг харах боломжийг хүмүүст олгосон. Хүмүүст дараах зүйлийг хэлэхийн тулд Бурхан Өөрийн хандлагыг ашигласан: Бурхан хүмүүсийг тэвчдэггүй, эсвэл тэдэнд өршөөл үзүүлэхийг хүсдэггүйдээ биш; харин хүмүүс Бурханд үнэхээр гэмших нь ховор, муу замаасаа татгалзаж, хүчирхийлэл хийхээ болих нь ховор билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнд уурлахдаа хүнийг жинхэнээсээ гэмшиж чадна гэж найддаг, үнэндээ хүний жинхэнэ гэмшлийг харна гэж найддаг, тэгсэн тохиолдолд Тэр хүнд өршөөлөө өгөөмрөөр хайрлаж, хүлээцтэй хандсаар байх болно. Өөрөөр хэлбэл, хүний ёрын муу авир Бурханы уур хилэнг төрүүлдэг байхад Бурханыг сонсож, Түүний өмнө үнэхээр гэмшдэг, мөн муу замаасаа татгалзаж, хүчирхийлэл хийхээ больсон хүмүүст Бурхан өршөөлөө хайрлаж, хүлээцтэй ханддаг. Ниневе хотынхонд хандсан байдлаас Бурханы хандлага маш тодорхой харагдсан: Бурханы өршөөл, хүлээцтэй байдлыг хүртэх нь огтоос хэцүү биш, хүнээс Тэр жинхэнэ гэмшлийг л шаарддаг. Хүмүүс муу замаасаа татгалзаж, хүчирхийлэл үйлдэхээ больсон цагт Бурхан зүрх сэтгэлээ, тэдэнд хандах хандлагаа өөрчилнө.

Бүтээгчийн зөвт зан чанар нь жинхэнэ агаад тод томруун

Ниневегийн хүмүүсийн талаарх Бурханы сэтгэл өөрчлөгдөх үед Түүний өршөөл, хүлээцтэй байдал нь хуурамч байсан уу? Мэдээж үгүй! Тэгвэл энэхүү нэг нөхцөл байдалтай харьцах явцад Бурханы зан чанарын энэхүү хоёр тал

өөрчлөгдсөнөөр юуг харуулсан бэ? Бурханы зан чанар бол нэгэн бүхэл, огтхон ч салангид биш. Тэр хүмүүст Өөрийн уур хилэн, эсвэл өршөөл, хүлээцтэй байдлыг илэрхийлэх эсэх нь хамаагүй, эдгээр нь бүгд Түүний зөвт зан чанарын илэрхийлэл юм. Бурханы зан чанар идэвхтэй эрч хүчээр дүүрэн, Тэрээр аливаа зүйлийн өрнөл явцын дагуу бодол, хандлагаа өөрчилдөг. Ниневе хотынхонд хандах Түүний хандлага өөрчлөгдсөн нь, Түүнд Өөрийн гэсэн бодол, санаа байдаг гэдгийг хүн төрөлхтөнд хэлж өгдөг; Тэр бол робот юм уу шавар баримал биш, харин амьд Бурхан Өөрөө билээ. Тэр Ниневегийн хүмүүст уурлаж чадах ч тэдний хандлагаас хамаарч өнгөрснийг нь уучилж бас чадна. Тэр Ниневе хотынхонд гай гамшиг авчрахаар шийдэж болно, бас тэдний гэмшлээс үүдэн Өөрийн шийдвэрийг өөрчилж болно. Хүмүүс дүрэм журмыг хатуу чанд мөрдөж, тэрхүү дүрэм журмаа ашиглан Бурханд хязгаар тогтоож, Түүнийг тодорхойлох дуртай байдгийн адил томьёо ашиглан Бурханы зан чанарыг ойлгохоор оролдох дуртай байдаг. Тиймээс хүний бодлоор бол Бурхан боддоггүй, Түүнд мөн чанартай холбоотой санаа ч бас байдаггүй. Гэвч бодит байдал дээр, Бурханы бодол аливаа юмс болон хүрээлэн буй орчны өөрчлөлтийн дагуу байнга өөрчлөгдөж байдаг. Эдгээр бодол нь өөрчлөгдөж байх зуур Бурханы мөн чанарын өөр өөр тал нь илрэн гардаг. Энэхүү өөрчлөлтийн явцад, сэтгэл нь өөрчлөгдөх яг тэр агшинд Бурхан Өөрийнх нь амь жинхэнээсээ оршин байдаг, Түүний зөвт зан чанар идэвхтэй эрч хүчээр дүүрэн байдгийг харуулдаг. Үүний зэрэгцээ Өөрийнх нь уур хилэн, өршөөл, хайр энэрэл, хүлээцтэй байдал үнэхээр оршин байдгийг хүн төрөлхтөнд батлахын тулд Бурхан Өөрийн жинхэнэ илчлэлийг ашигладаг. Аливаа зүйл хэрхэн өрнөхөөс хамаарч Түүний мөн чанар хэдийд ч, хаана ч илрэн гардаг. Түүнд арслангийн уур хилэн, эхийн өршөөл, хүлээцтэй байдал байдаг. Түүний зөвт зан чанарт эргэлзэж, түүнд нь халдаж, өөрчилж, эсвэл мушгин гуйвуулахыг ямар ч хүнд зөвшөөрөхгүй. Бүх хэрэг явдал, бүх зүйлийн дунд Бурханы зөвт зан чанар буюу Бурханы уур хилэн, Бурханы өршөөл нь хэдийд ч, хаана ч илрэн гарч болно. Тэр эдгээр талыг бүх бүтээлийн өнцөг булан бүрд эрч хүчтэйгээр илэрхийлж, агшин бүрд эрч хүчтэйгээр хэрэгжүүлдэг. Бурханы зөвт зан чанар цаг хугацаа, орон зайгаар хязгаарлагддаггүй; өөрөөр хэлбэл, Бурханы зөвт зан чанар нь цаг хугацаа, орон зайн хязгаарт баригдан механикаар илэрхийлэгдэж, илэрдэггүй, харин хэдийд ч, хаана ч чөлөөтэй илэрч, илэрхийлэгддэг. Бурханы сэтгэл өөрчлөгдөж, уур хилэнгээ илэрхийлэхээ больж, Ниневе хотыг устгахаас түдгэлзэж байгааг хараад чи Бурхан зөвхөн өршөөнгүй агаад элэгсэг гэж хэлж чадах уу? Бурханы уур хилэн зүгээр л хоосон үг гэж чи хэлж чадах уу? Бурхан догшин ширүүнээр хилэгнэж, өршөөлөө буцаан авах үед Тэр хүн төрөлхтнийг жинхэнээсээ огт хайрладаггүй гэж чи хэлж чадах уу? Бурхан хүмүүсийн ёрын муу үйлийн хариуд ийнхүү догшин ширүүн уур хилэнгээ илэрхийлдэг; Түүний уур хилэн өө сэвгүй. Хүмүүсийн гэмшлийн хариуд Бурханы зүрх сэтгэл хөдөлдөг бөгөөд энэхүү гэмшлээс болж Түүний сэтгэл өөрчлөгддөг. Түүний сэтгэл хөдөлж, сэтгэл нь өөрчлөгдөж, хүнд өршөөл, хүлээцтэй байдлаа үзүүлж

байгаа энэ бүгд нь огт өө сэвгүй; тэдгээр нь цэвэр, ариун, өө сэвгүй, жинхэнэ байдаг. Бурханы өршөөл нь өршөөлөөс өөр юу ч биш байдгийн адил хүлээцтэй байдал нь чухамхүү хүлээцтэй байдал билээ. Хүний гэмшил болоод зан байдлын өөрчлөлтийн дагуу Түүний зан чанар нь уур хилэн, эсвэл өршөөл, хүлээцтэй байдал харуулдаг. Тэр юуг харуулж, илэрхийлэх нь хамаагүй, бүгд ариун агаад шууд байдаг; мөн чанар нь өөр ямар ч бүтээлийнхээс ялгаатай байдаг. Үйлдэл нь суурилдаг зарчмыг Бурхан илэрхийлэхэд, тэдгээр нь ямар ч өө сэвгүй байдаг, Түүний бодол, санаа, гаргаж буй шийдвэр болгон, хийж буй үйлдэл болгон нь мөн адил. Бурхан ийнхүү шийдэж, ийнхүү үйлдсэн болохоор ажил хэргээ ч бас ингэж гүйцэлдүүлдэг. Эх үүсвэр нь өө сэвгүй учраас Түүний ажил хэргийн үр дүн нь алдаа мадаггүй, зөв байдаг билээ. Бурханы уур хилэн өө сэвгүй. Үүний адилаар, бүх бүтээлийн дундаас өөр хэнд ч байдаггүй, Бурханы өршөөл, хүлээцтэй байдал нь ариун, өө сэвгүй агаад сайтар эргэцүүлэн бодож, туршлагажихыг тэсвэрлэж чадна.

Ниневегийн түүхийг ойлгосноороо та нар Бурханы зөвт зан чанарын мөн чанарын нөгөө талыг одоо харж байна уу? Бурханы цор ганц зөвт зан чанарын нөгөө талыг харж байна уу? Хүн төрөлхтний дундаас хэн нэгэнд нь ийм зан чанар байдаг уу? Хэн нэгэнд нь ийм уур хилэн буюу Бурханы уур хилэн байдаг уу? Бурханд байдаг шиг өршөөл, хүлээцтэй байдал хэн нэгэнд байна уу? Бүтээлийн дундаас хэн ийм асар их уур хилэнг хуралдуулж, хүн төрөлхтнийг устгаж, эсвэл тэдэн дээр гай гамшиг буулгахаар шийдэж чадах вэ? Мөн хэн хүнд өршөөл хайрлаж, хүлээцтэй хандаж, уучилж, улмаар хүнийг устгана гэсэн өмнөх шийдвэрээ өөрчилж чадахуйц вэ? Бүтээгч Өөрийн өвөрмөц арга барил, зарчмуудаар дамжуулан зөвт зан чанараа илэрхийлдэг, Тэр ямар ч хүн, үйл явдал, юмсын хяналт, хязгаарлалтад захирагддаггүй. Тэр цор ганц зан чанартай болохоор хэн ч Түүний бодол, санааг өөрчилж чадахгүй, бас хэн ч Түүнийг ятгаж, ямар нэг шийдвэрийг нь өөрчилж чадахгүй. Бүх бүтээлийн үйлдэл болон бодол бүхэлдээ Түүний зөвт зан чанарын шүүлтийн дор оршдог. Тэр уурлан хилэгнэх эсвэл өршөөл үзүүлэх эсэхийг хэн ч хянаж чаддаггүй; Бүтээгчийн мөн чанар, өөрөөр хэлбэл, Бүтээгчийн зөвт зан чанар л үүнийг шийдэж чадна. Бүтээгчийн зөвт зан чанарын хосгүй чанар нь ийм билээ!

Ниневегийн хүмүүст хандах Бурханы хандлага өөрчлөгдсөнийг шинжилж, ойлгосноороо та нар “цор ганц” хэмээх үгийг ашиглан Бурханы зөвт зан чанарт байдаг өршөөлийг тайлбарлаж чадах уу? Бурханы уур хилэн бол Түүний цор ганц зөвт зан чанарын мөн чанарын нэг тал юм гэдгийг бид өмнө нь хэлсэн. Одоо Би, Бурханы уур хилэн болон Бурханы өршөөл гэсэн хоёр талыг Түүний зөвт чанар хэмээн тодорхойлох болно. Бурханы зөвт зан чанар нь ариун; халдаж, эргэлзэхийг тэвчдэггүй; бүтээгдсэн, бүтээгдээгүй зүйлсийн алинд нь ч байдаггүй зүйл юм. Энэ нь цор ганц агаад ганцхан Бурханд л байдаг. Өөрөөр хэлбэл, Бурханы уур хилэн ариун бөгөөд халдашгүй. Үүний адилаар, Бурханы зөвт зан чанарын нөгөө тал болох Бурханы өршөөл ариун агаад халдаж болохгүй. Бүтээгдсэн, бүтээгдээгүй

зүйлийн аль нь ч Бурханыг үйл хэрэгт нь орлож, эсвэл төлөөлж чадахгүй, мөн Содомын сүйрэл, Ниневегийн аврал дээр хэн ч Түүнийг орлох юм уу төлөөлж бас чадахгүй. Энэ нь Бурханы цор ганц зөвт зан чанарын жинхэнэ илэрхийлэл билээ.

Хүн төрөлхтөнд хандах Бүтээгчийн үнэн сэтгэл

Бурханыг таньж мэдэх нь амаргүй гэж хүмүүс үргэлж ярьдаг. Гэхдээ Бурханыг таньж мэдэх нь огтхон ч хэцүү зүйл биш гэж би хэлнэ, учир нь Бурхан Өөрийн үйл хэргийг хүнд байнга харуулдаг. Бурхан хүн төрөлхтөнтэй ярилцахаа хэзээ ч зогсоогоогүй, Өөрийгөө хүнээс хэзээ ч нуугаагүй, Өөрөө ч нуугдаагүй билээ. Түүний бодол, санаа, үг, үйл хэрэг бүгд хүн төрөлхтөнд илчлэгддэг. Тиймээс хүн Бурханыг таньж мэдэхийг хүсэх л юм бол төрөл бүрийн арга замаар Түүнийг ойлгож, мэдэж авч чадна. Бурхан өөрөөс нь санаатайгаар зайлсхийж, Өөрийгөө хүн төрөлхтнөөс санаатайгаар нуусан, хүнд Өөрийгөө ойлгуулж, мэдүүлэх санаагүй байна гэж хүн сохроор бодохын шалтгаан нь тэрээр Бурхан гэж хэн болохыг мэдэхгүй, бас Бурханыг ойлгохыг хүсэхгүйд байгаа юм. Түүгээр ч үл барам, хүн Бүтээгчийн бодол, ажил, үйл хэргийн талаар ер бодолцохгүй байгаа юм… Үнэнийг хэлэхэд, хүн ердөө өөрийн чөлөөт цагаа ашиглаад Бүтээгчийн үг эсвэл үйл хэрэг дээр төвлөрч, тэдгээрийг ойлгож, Бүтээгчийн бодол, Түүний зүрх сэтгэлийн дуу хоолойд багахан л анхаарвал, Бүтээгчийн бодол, үг, үйл хэрэг нь харагдахуйц, ил тод гэдгийг төвөггүйхэн ойлгох болно. Түүнчлэн Бүтээгч хүмүүсийн дунд цаг ямагт байдаг, Тэр хүн болон бүх бүтээлтэй үргэлж ярилцдаг, Тэр өдөр бүр шинэ үйл хэрэг бүтээдгийг ойлгоход багахан хүчин чармайлт гарна. Түүний мөн чанар, Түүний зан чанар хүнтэй ярилцахад нь харагддаг; Түүний бодол, санаа үйл хэрэгт нь шингэсэн байдаг; Тэр хүн төрөлхтөнтэй үргэлж хамт байж, ажиглаж байдаг. Тэр хүн төрөлхтөн болон бүтээл бүхэнтэй Өөрийн чимээгүй үгээр ийн ярилцдаг: “Би тэнгэрт байна, Өөрийн бүтээлүүдийн дунд байна. Би харуулд гарч байна; Би хүлээж байна; Би чиний дэргэд байна…” Түүний гар дулаахан бөгөөд хүчтэй; Түүний алхаа хөнгөн; Түүний хоолой зөөлөн бөгөөд ялдам; Түүний дүр нааш цааш эргэлдэж, хүн төрөлхтнийг тэврэн авдаг; Түүний зүс царай үзэсгэлэнтэй бөгөөд эелдэг. Тэр хэзээ ч орхиж явж, алга болоогүй. Өдөр, шөнөгүй Тэр хүн төрөлхтөнд байнга хань болж, хэзээ ч орхиж явдаггүй. Тэр Ниневе хотыг аврах үед хүн төрөлхтнийг гэсэн анхаарал халамж, онцгой дотно сэтгэл, бас хүнийг гэх чин сэтгэлийн хайр, санаа зовнил нь бага багаар харагдсан билээ. Ялангуяа, Ехова Бурхан, Иона хоёрын ярианаас Бүтээгч Өөрийнхөө бүтээсэн хүн төрөлхтөнд хэчнээн зөөлөн ханддаг нь бүрэн харагдана. Тэдгээр үгээс чи хүн төрөлхтөнд хандах Бурханы чин сэтгэлийн талаар гүнзгий ойлголт авч болно…

Дараах мөрүүд Ионагийн номын 4:10–11-д тэмдэглэгджээ: “Тэгэхэд Ехова: ‘Чи өөрөө хөдөлмөрлөж, ургуулаагүй, нэг шөнийн дотор ургаад, хатаж үхсэн эрэндийн бутыг өрөвдсөн. Тэгэхэд Би, баруун, зүүн гараа ялган салгаж чадахгүй зуун хорин мянгаас илүү хүнтэй, бас олон малтай их хот Ниневег өрөвдөн хайрлах хэрэггүй

гэж үү?’ гэж хэлэв.” Энэ бол Ехова Бурханы хэлсэн үг бөгөөд үүнийг Бурхан, Иона хоёрын ярианаас тэмдэглэгдэж үлджээ. Хэдий энэ яриа нь товчхон боловч Бүтээгчийн хүн төрөлхтөнд санаа тавьдаг, тэднийг орхихыг хүсэхгүй байгаа нь харагддаг. Эдгээр үг нь Бурханы зүрх сэтгэлийн гүнд дэх бүтээлдээ ханддаг жинхэнэ хандлага, сэтгэлийг илэрхийлдэг. Эдгээр товч тодорхой, хүнд ховор сонсогддог үгээрээ Бурхан хүн төрөлхтнийг яг хэрхэх тухайгаа өгүүлдэг. Энэ яриа Бурхан Ниневе хотын иргэдэд хэрхэн ханддагийг илэрхийлсэн байна—харин энэ нь ямар хандлага вэ? Энэ бол Ниневе хотын хүмүүст гэмшсэнийх нь өмнө болон хойно хандсан хандлага нь бөгөөд хүн төрөлхтөнд ханддаг хандлага юм. Эдгээр үгэнд Түүний бодол, Түүний зан чанар агуулагддаг.

Бурханы ямар бодол энэ үгэнд илэрдэг вэ? Хэрэв чи үгийг нь уншихдаа сайтар анхаарах юм бол Тэр “өрөвдөх” гэдэг үг ашигласныг төвөггүй анзаарах болно; энэ үгийг ашигласан нь хүн төрөлхтөнд ханддаг Бурханы жинхэнэ хандлагыг харуулж байгаа юм.

Шууд утгаар нь авч үзвэл “өрөвдөх” гэдэг үгийг хүмүүс янз янзаар тайлбарлаж болно: Нэгд, “хайрлах, хамгаалах, ямар нэг зүйлд зөөлөн сэтгэлээр хандах” гэсэн утгатай; хоёрт, “ихэд хайрлах”; эцэст нь, “ямар нэг зүйлийг гэмтээхийг хүсэхгүй, тэгэхийг тэвчиж чадахгүй” гэсэн утгыг агуулдаг. Товчхондоо, энэ үг нь энхрийлэн хайрлах, хайр сэтгэл, мөн хэн нэгнийг, ямар нэг зүйлийг орхихыг хүсэхгүй байх гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд хүнд хандах Бурханы өршөөл, тэвчээр гэсэн утгыг агуулдаг. Хүмүүсийн түгээмэл хэрэглэдэг энэ үгийг Бурхан ашигласан атал энэхүү үг нь Бурханы зүрх сэтгэлийн дуу хоолой болон хүн төрөлхтөнд ханддаг Түүний хандлагыг бас ил болгож чадсан.

Ниневе хот нь Содомын хүмүүсийнх шиг завхарсан, ёрын муу, хүчирхийллээр дүүрсэн байсан боловч тэдний гэмшил Бурханыг бодлоо өөрчилж тэднийг устгахгүй байхаар шийдэхэд хүргэжээ. Бурханы үг, зааварт хандаж байгаа тэдний байдал нь Содомын иргэдийнхээс огт өөр байсан бөгөөд тэд Бурханд үнэн сэтгэлээсээ захирагдаж, хийсэн нүгэлдээ үнэн сэтгэлээсээ гэмшиж, зан авир нь бүх талаараа жинхэнэ бөгөөд чин сэтгэлийнх байсан тул Бурхан чин сэтгэлээсээ тэднийг өрөвдөж байгаагаа дахин нэгэнтээ илэрхийлж, өрөвдөх сэтгэлээ тэдэнд хайрлажээ. Хүн төрөлхтөнд Бурханы хайрладаг зүйл, хүн төрөлхтнийг өрөвдөх сэтгэлийг хэн ч хуулбарлаж чадахгүй бөгөөд Бурханы өршөөл, тэвчээр, хүн төрөлхтөнд хандах чин сэтгэл ямар ч хүнд байх боломжгүй юм. Чиний бодлоор бол өндөрт зогсоод агуу хүний өнцгөөс ярьж, хамгийн өндөр цэгээс хүн төрөлхтөнд юм уу бүтээлд хандаж ийм үг хэлж чадах агуу хүн эсвэл супер хүн байгаа юу? Хүн төрөлхтөн дунд хүний амьдралын байдлыг гарын таван хуруу шигээ мэдэх хүн хэн байна вэ? Хүн төрөлхтний оршин тогтнолын төлөө ачаа үүрч, хариуцлага хүлээж чадах хүн хэн байна вэ? Хотыг нураана гэж тунхаглаж чадахуйц хэн байна вэ? Хотыг өршөөж чадахуйц хэн байна вэ? Өөрийнхөө бүтээлийг өрөвддөг гэж хэн хэлж чадах вэ? Зөвхөн Бүтээгч! Зөвхөн Бүтээгч хүн төрөлхтөнд өр зөөлөн ханддаг.

Зөвхөн Бүтээгч энэ хүн төрөлхтнийг энэрч, хайрладаг. Зөвхөн Бүтээгч л энэ хүн төрөлхтнийг жинхэнэ, салшгүй хайраар хайрладаг. Түүнчлэн зөвхөн Бүтээгч л хүн төрөлхтөнд өршөөлөө хайрлаж, Өөрийн бүтээлийг бүгдийг нь өрөвдөж чадна. Хүний үйлдэл бүрд Түүний зүрх булгилж, шаналж байдаг: хүний муу болон завхралд уурсаж, бухимдаж, гашууддаг; хүний гэмшил, итгэл үнэмшлийг таашааж, баярлаж, уучилж, хөөрөн баясдаг; Түүний бодол санаа бүр хүн төрөлхтний төлөө оршиж, хүн төрөлхтнийг тойрон эргэлддэг; Тэр юу болох, Түүнд юу байгаа нь бүхэлдээ хүн төрөлхтний төлөө зориулагдаж байдаг; Түүний сэтгэл хөдлөл бүхэлдээ хүн төрөлхтний оршин тогтнолтой холбоотой байдаг. Хүн төрөлхтний төлөө Тэр аялж, яардаг; Тэр амийнхаа хэсэг бүрийг чимээгүйхэн өгч байдаг; Тэр амийнхаа минут, секунд бүрийг зориулж байдаг… Тэр өөрийн амийг нандигнахаа огт мэддэггүй мөртөө Өөрийн бүтээсэн хүн төрөлхтнийг үргэлж өрөвдөж ирсэн… Тэр Өөрт байгаа бүхнээ энэ хүн төрөлхтөнд өгдөг… Тэр өршөөл, тэвчээрээ болзолгүйгээр, хариу нэхэхгүйгээр үзүүлдэг. Хүн төрөлхтөн нүднийх нь өмнө амьдарч, Өөрийнх нь амийн хангалтыг хүртсээр байгаасай гэсэндээ л Тэр ингэдэг. Хүн төрөлхтөн нэг л өдөр Түүний өмнө захирагдаж, Тэр хүний оршин тогтнолыг тэтгэж, бүх бүтээлийн амийг хангадаг гэдгийг мэдээсэй гэсэндээ л ингэдэг.

Бүтээгч хүн төрөлхтөнд зориулж үнэн сэтгэлээ илэрхийлдэг

Ехова Бурхан, Иона хоёрын хоорондох энэ яриа нь хүн төрөлхтнийг гэх Бүтээгчийн чин сэтгэлийн илэрхийлэл гэдэг нь эргэлзээгүй. Нэг талаар энэ нь, Өөрийнх нь дээд эрхийн дор байдаг бүх бүтээлийн тухай Бүтээгчийн ойлголтыг хүмүүст мэдүүлдэг; Ехова Бурханы хэлсэнчлэн “Тэгэхэд Би, баруун, зүүн гараа ялган салгаж чадахгүй зуун хорин мянгаас илүү хүнтэй, бас олон малтай их хот Ниневег өрөвдөн хайрлах хэрэггүй гэж үү?” Өөрөөр хэлбэл, Ниневегийн талаарх Бурханы ойлголт нь огт өнгөц биш байсан. Тэрээр хотын доторх амьд зүйлсийн (хүмүүс, амьтдыг оролцуулаад) тоог мэдээд зогсохгүй, мөн хэчнээн хүн баруун, зүүн гараа ялгаж мэдэхгүй байгааг, өөрөөр хэлбэл, хэчнээн хүүхэд, залуус байгааг мэдэж байв. Энэ нь хүн төрөлхтнийг Бурхан бүрэн дүүрэн ойлгодгийн бодит баталгаа юм. Нөгөө талаар энэ нь хүн төрөлхтөнд хандах Бүтээгчийн хандлагыг, өөрөөр хэлбэл, Бүтээгчийн зүрх сэтгэлд хүн төрөлхтний эзлэх жинг хүмүүст мэдүүлдэг. Яг л Ехова Бурханы хэлсэнчлэн: “Чи өөрөө хөдөлмөрлөж, ургуулаагүй, нэг шөнийн дотор ургаад, хатаж үхсэн эрэндийн бутыг өрөвдсөн. Тэгэхэд Би … их хот Ниневег өрөвдөн хайрлах хэрэггүй гэж үү?” Эдгээр нь Ионаг зэмлэсэн Ехова Бурханы үг боловч бүгд үнэн юм.

Ехова Бурханы үгийг Ниневегийн хүмүүст тунхаглахыг Ионад даалгасан хэдий ч, тэрээр Ехова Бурханы санаа зорилгыг ойлгоогүй, мөн уг хотын хүмүүсийн төлөөх Түүний санаа зовнил болоод хүлээлтийг ч бас ойлгоогүй. Бурхан энэхүү зэмлэлээрээ, хүн төрөлхтнийг Тэр Өөрийн гараар бүтээж, хүн нэг бүрийн төлөө уйгагүй хүчин чармайлт гаргаж, хүн бүр Бурханы итгэл найдварыг хүлээж, хүн бүр

Бурханы амийн хангалтыг эдэлсэн; хүн нэг бүрийн төлөө Бурхан уйгагүй хүчин чармайлтын төлөөс төлсөн гэдгийг түүнд хэлэхийг хүссэн юм. Иона эрэндийн бутыг өрөвдөн хайрлаж байсны адилаар Бурхан Өөрийн гараар бүтээсэн хүн төрөлхтнийг өрөвдөн хайрлаж байсан гэдгийг ч бас энэхүү зэмлэл Ионад хэлсэн. Ялангуяа хотод маш олон хүүхэд, гэмгүй мал амьтад байсан учраас, Бурхан эцсийн боломжит мөчийг хүртэл хүн төрөлхтнийг яавч тийм амархан орхихгүй. Баруун, зүүн гараа ч ялгаж чадахгүй, Бурханы бүтээлийн эдгээр залуу, мэдлэггүй бүтээгдэхүүнтэй харьцахдаа, Бурхан тэдний амийг тасалж, төгсгөлийг нь тийм түргэн тодорхойлно гэж бүр ч төсөөлөхийн аргагүй байсан юм. Бурхан тэдний өсөж том болохыг харахыг хүссэн; тэд ахмадуудынхаа явсан замаар алхахгүй, Ехова Бурханы анхааруулгыг тэд дахин сонсохгүй, Ниневегийн өнгөрсөн үеийг гэрчилнэ гэж Тэр найдсан. Үүнээс ч илүүтэйгээр, гэмшсэнийх нь дараах Ниневег харж, гэмшлийнх нь дараах Ниневегийн ирээдүйг харж, Бурханы өршөөл дор Ниневег дахин нэгэнтээ амьдрахыг нь харна гэж Бурхан бүр ч их найдсан. Тиймээс, Бурханы нүдээр бол, баруун, зүүн гараа ялгаж мэдэхгүй тэдгээр бүтээлийн объект нь Ниневегийн ирээдүй байв. Тэд Ниневегийн жигшүүрт өнгөрсөн үеийг мөрөндөө үүрэх байсны адилаар, Ехова Бурханы удирдамж дор Ниневегийн өнгөрсөн болон ирээдүйг гэрчлэх чухал үүрэг хүлээх байв. Ехова Бурхан ийнхүү чин сэтгэлээ илэрхийлэхдээ хүн төрөлхтнийг гэх Бүтээгчийн өршөөлийг бүрэн дүүрэн харуулсан. “Бүтээгчийн өршөөл” бол хоосон үг биш, хуурамч амлалт ч биш гэдгийг хүн төрөлхтөнд энэ нь харуулсан; үүнд тодорхой зарчим, арга барил, зорилго байдаг. Бурхан бол жинхэнэ, бодит агаад ямар ч худал хуурмаг, хуурамч төрх ашигладаггүй, ийм маягаар Тэр өршөөлөө цаг хугацаа, эрин үе болгонд эцэс төгсгөлгүйгээр хүнд хайрладаг. Гэхдээ өнөөдрийг хүртэл Бүтээгчийн Ионатай ярьсан яриа нь, Тэр яагаад хүн төрөлхтөнд өршөөл үзүүлдэг, хүн төрөлхтөнд хэрхэн өршөөл үзүүлдэг, хүн төрөлхтөнд хэр хүлээцтэй байдаг, хүн төрөлхтнийг гэх чин сэтгэлийнхээ талаар Түүний хэлсэн цорын ганц мэдэгдэл юм. Энэхүү ярианы үеэр Ехова Бурханы товчхон хэлсэн үг нь хүн төрөлхтний талаарх Түүний бодлыг бүрэн дүүрэн илэрхийлдэг; хүн төрөлхтөнд хандах Түүний зүрх сэтгэлийн хандлагын жинхэнэ илэрхийлэл, мөн хүн төрөлхтөнд хайрласан Түүний арвин их өршөөлийн бодит нотолгоо юм. Тэр өршөөлөө зөвхөн хүн төрөлхтний ахмад үеийнхэнд л хайрлаагүй, залуу үеийнхэнд ч бас өгсөн бөгөөд үеэс үед үргэлж ийм л байж ирсэн. Хэдийгээр Бурханы уур хилэн хүн төрөлхтний тодорхой өнцөг буланд, тодорхой эрин үед байнга буудаг боловч Бурханы өршөөл хэзээ ч зогсоогүй. Тэрээр Өөрийн бүтээлийг үеийн үед, өршөөлөөрөө залж чиглүүлж, хөтөлж, хангаж, тэжээн тэтгэдэг, учир нь хүн төрөлхтөнд хандах Түүний чин сэтгэл хэзээ ч өөрчлөгдөхгүй. Яг л Ехова Бурханы хэлсэнчлэн: “Тэгэхэд Би … өрөвдөн хайрлах хэрэггүй гэж үү?” Тэр Өөрийн бүтээлийг үргэлж өрөвдөн хайрласаар ирсэн. Энэ бол Бүтээгчийн зөвт зан чанарын өршөөл, мөн Бүтээгчийн бүрэн дүүрэн цор ганц чанар юм!

Таван төрлийн хүн

Бурханы зөвт зан чанарын тухай нөхөрлөлөө Би энэ хүрээд түр орхиё. Цааш нь Би Бурханы дагагчдыг Бурханы тухай ойлголт болон Түүний зөвт зан чанарын талаарх ойлголт, туршлагаар нь хэд хэдэн төрөл болгон ангилна, ингэснээр та нар өөрсдийн одоогийн үе шат, одоогийн биеийн хэмжээгээ мэдэж авч болно. Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг, Түүний зөвт зан чанарыг ойлгосон байдлын тухайд, хүмүүсийн оршиж байгаа өөр өөр үе шат болон биеийн хэмжээг ерөнхийд нь таван төрөлд хувааж болно. Энэхүү сэдэв нь цор ганц Бурхан, Түүний зөвт зан чанарыг мэдэх суурин дээр тулгуурладаг. Тиймээс дараах агуулгыг уншихдаа та нар, Бурханы цор ганц чанар, зөвт зан чанарын талаар чухамхүү хэр их ойлголт, мэдлэгтэй вэ гэдгээ ойлгохоор сайтар оролдож, дараа нь үр дүнг нь ашиглан үнэхээр аль үе шатанд харьяалагдаж байгаа, биеийн хэмжээ чинь үнэхээр хэр том болох, үнэхээр ямар төрлийн хүн болохоо баримжаалах ёстой.

Нэг дэх төрөл: Өлгийтэй нярай үе шат

“Өлгийтэй нярай” гэдэг нь юу гэсэн үг вэ? Өлгийтэй нярай гэдэг нь хорвоод дөнгөж төрсөн нялх хүүхэд юм. Энэ үед хүмүүс хамгийн дутуу дулимаг байдаг.

Энэ үе шатанд байгаа хүмүүс Бурханд итгэх явдлын талаар үндсэндээ ямар ч мэдлэг, ухамсаргүй байдаг. Тэд бүх зүйлийн талаар гайхширч, харанхуй бүдүүлэг байдаг. Энэ хүмүүс Бурханд маш удаан хугацаанд, эсвэл магадгүй маш богино хугацаанд итгэсэн байж болох ч гайхширсан, харанхуй бүдүүлэг байдал болоод жинхэнэ биеийн хэмжээнийхээ улмаас тэд өлгийтэй нярай үе шатанд ордог. Өлгийтэй нярайн нөхцөл байдлын тухай ийм яг таг тодорхойлолт байдаг: Ийм төрлийн хүн Бурханд хэчнээн удаан итгэсэн байх нь хамаагүй, үргэлж мунгинуу, будилсан, дүйнгэ байдалтай байдаг; тэр яагаад Бурханд итгэдгээ мэддэггүй, бас Бурхан хэн болох, хэн Бурхан бэ гэдгийг ч мэддэггүй. Хэдий тэр Бурханыг дагадаг ч зүрх сэтгэлд нь Бурханы талаар яг таг тодорхойлолт байдаггүй, Бурханд үнэхээр итгэж, Түүнийг дагах ёстой эсэхээ шийдэх нь байтугай, өөрийнх нь дагадаг Нэгэн, Бурхан мөн эсэхийг ч тодорхойлж чаддаггүй. Ийм төрлийн хүний жинхэнэ байдал нь энэ юм. Ийм төрлийн хүмүүсийн бодол нь бүрхэг, товчоор хэлбэл, итгэл нь булингартсан байдаг. Тэд үргэлж гайхширсан, алмайрсан байдалд оршдог; “мунгинуу”, “будилсан”, “дүйнгэ” байдлаар тэдний байдлыг нэгтгэн дүгнэдэг. Тэд Бурханы оршин тогтнолыг хэзээ ч харж, бас мэдэрч байгаагүй учраас Бурханыг мэдэх талаар тэдэнтэй ярих нь тэдэнд дүрс үсгээр бичсэн ном уншуулахтай л адилхан; тэд үүнийг ойлгох ч үгүй, мөн хүлээн авах ч үгүй. Тэдний хувьд, Бурханыг мэдэх нь уран зөгнөлт түүх сонсохтой адил. Тэдний бодол нь бүрхэг байж болох ч үнэндээ Бурханыг мэдэх нь цаг хугацаа, хичээл зүтгэлийн гарз гэж бат итгэдэг. Энэ бол өлгийтэй нярай хэмээх эхний төрлийн хүн юм.

Хоёр дахь төрөл: Хөхүүл хүүхдийн үе шат

Өлгийтэй нярайтай харьцуулбал ийм төрлийн хүн зарим нэг ахиц дэвшил гаргасан байдаг. Харамсалтай нь, тэд Бурханы талаар ямар ч ойлголтгүй хэвээр байна. Тэд, Бурханы талаарх тодорхой ойлголт, мэдлэг ухаанаар дутмаг хэвээр байдгийн дээр, яагаад Бурханд итгэх ёстойгоо тийм ч сайн мэддэггүй атлаа зүрх сэтгэлдээ өөрийн гэсэн зорилго, тодорхой санаатай байдаг. Бурханд итгэх зөв эсэх нь тэдэнд хамаагүй, Бурханд итгэх итгэлээр дамжуулан эрж хайдаг зорилго, зорилт нь Бурханы нигүүлслийг эдлэх, баяр хөөртэй, амар тайван байх, тав тухтай амьдралаар амьдрах, Бурханы халамж, хамгаалалтыг авч, Бурханы ерөөл дор амьдрах юм. Тэд Бурханыг хэр их мэддэг байх талаар анхаардаггүй; Бурханыг ойлгохоор эрж хайх хүсэл тэдэнд байдаггүй, мөн Бурхан юу хийж байгаа, юу хийхийг хүсдэг талаар анхаардаггүй. Тэд зөвхөн Бурханы нигүүлслийг эдэлж, Түүнээс илүү их ерөөл хүртэх гэж сохроор эрж хайдаг; тэд өнөөгийн эрин үед зуу дахин ихийг, дараагийн эрин үед мөнх амь олж авахаар эрж хайдаг. Тэдний бодол, өөрсдийгөө хэр зарлагадаж, зориулдаг, түүнчлэн зовж зүдэрч байгаа нь бүгд Бурханы нигүүлсэл, ерөөлийг хүртэх гэсэн нэгэн зорилготой. Тэд өөр юуг ч анхаардаггүй. Ийм төрлийн хүн, Бурхан өөрийг нь аюулгүй байлгаж, нигүүлслээ хайрлаж чадна гэдэгт л итгэлтэй байдаг. Бурхан яагаад хүнийг аврахыг хүсдэг, эсвэл үг болон ажлаараа Бурханы хүрэхийг хүсдэг үр дүнгийн талаар сонирхдоггүй, бас тийм ч сайн мэддэггүй гэж хэлж болно. Тэд Бурханы мөн чанар, зөвт зан чанарыг мэдэх гэж хэзээ ч хичээл чармайлт гаргаж байгаагүй, тэгэх сонирхол ч төрдөггүй. Тэд ийм зүйлд анхаарлаа хандуулах сонирхолгүй, мэдэхийг ч хүсдэггүй. Тэд Бурханы ажил, хүнд тавих Бурханы шаардлага, Бурханы хүсэл болон Бурхантай холбоотой өөр юуны ч талаар асуухыг хүсдэггүйн дээр бас эдгээр зүйлийн талаар асуух сонирхолгүй байдаг. Яагаад гэвэл, эдгээр зүйл Бурханы нигүүлслийг эдлэхтэй хамаагүй гэж тэд итгэж, зөвхөн өөрсдийнх нь ашиг сонирхолтой шууд хамаатайгаар оршдог, хүнд нигүүлсэл хайрлаж чадах Бурханыг л сонирхдог. Өөр ямар ч зүйлийг тэд сонирхдоггүй учраас хэчнээн олон жил Бурханд итгэсэн ч гэсэн, үнэн-бодит байдалд орж чаддаггүй. Тэднийг байнга усалж, тэжээх хэн нэгэн байхгүй бол тэдний хувьд Бурханд итгэх итгэлийн замаа үргэлжлүүлэх нь хэцүү байдаг. Хэрвээ тэд урьдын амар амгалан, баяр хөөр, эсвэл Бурханы нигүүлслийг эдэлж чадахгүй бол яваад өгөх магадлал тун өндөр. Энэ бол хоёр дахь төрлийн буюу хөхүүл хүүхдийн үе шатанд байгаа хүн юм.

Гурав дахь төрөл: Хөхнөөс гарч буй буюу жаахан хүүхдийн үе шат

Энэхүү бүлэг хүн тодорхой хэмжээний мэдлэг ойлголт сайтай байдаг. Бурханы нигүүлслийг эдэлнэ гэдэг нь өөрсдөө жинхэнэ туршлагатай болсон гэсэн үг биш гэдгийг тэд мэддэг бөгөөд амар амгалан, баяр хөөрийг эрж хайж, нигүүлслийг эрж хайхаас хэзээ ч залхдаггүй байсан ч гэсэн Бурханы нигүүлслийг эдэлсэн туршлагаа хуваалцаж, эсвэл өөрсдөд нь ерөөл хайрласны төлөө Бурханыг магтсанаар

гэрчлэл хийж чаддаг бол эдгээр нь амийг эзэмшдэг гэсэн үг биш, мөн үнэний бодит байдал тэдэнд байгаа гэсэн үг ч биш гэдгийг тэд мэддэг. Ухамсраасаа эхлээд, өөрсдийг нь зөвхөн Бурханы нигүүлсэл дагалдах болно гэсэн даварсан найдвар тээхээ больдог; харин ч тэд Бурханы нигүүлслийг эдлэхийн зэрэгцээ Бурханы төлөө ямар нэг зүйл хийхийг хүсдэг. Тэд үүргээ биелүүлж, бага зэргийн зовлон бэрхшээл, зүдүүр туулж, тодорхой хэмжээнд Бурхантай хамтран ажиллахыг хүсдэг. Гэвч Бурханд итгэх итгэлийн эрэл хайгуул нь хэтэрхий хуурамч, өвөрлөдөг хувийн санаа зорилго, хүсэл эрмэлзэл нь хэтэрхий хүчтэй, зан чанар нь дэндүү биеэ тоосон байдаг учраас Бурханы хүслийг хангаж, Бурханд үнэнч байх тэдэнд маш хэцүү байдаг. Тиймээс тэд өөрсдийн хувийн хүсэл, Бурханд өгсөн амлалтаа биелүүлж үргэлж чаддаггүй. Тэд Бурханыг байж болох хамгийн их хэмжээгээр хангалуун байлгахыг маш их хүсдэг атлаа Түүнийг хамаг чадлаараа эсэргүүцдэг, үргэлж Бурханд тангараг өргөдөг боловч андгайнаасаа амархан буцдаг гээд үргэлж ийм зөрчилдөөнтэй байдалд байдаг. Тэд чин сэтгэлээсээ Бурханд итгэдэг атлаа Бурханыг болон Түүнээс ирдэг бүхнийг үгүйсгэдэг; Бурхан тэднийг гэгээрүүлж, хөтөлж, хангаж, тэдэнд туслах болно гэж сэтгэл түгшин найддаг атлаа гарах гарцаа хайсаар байдаг гээд өөр бусад зөрчилдөөнтэй байдалд орох нь бүр ч олонтоо байдаг. Тэд Бурханыг ойлгож, мэдэхийг хүсдэг мөртөө Түүнд ойртох дургүй. Харин ч тэд үргэлж Бурханаас зайлсхийж, зүрх сэтгэл нь Түүнд хаалттай байдаг. Бурханы үг, үнэний үгчилсэн утгын талаар өнгөц ойлголт, туршлагатай, Бурхан болон үнэний талаар өнгөц үзэл баримтлалтай байдаг ч дотоод ухамсартаа Бурхан үнэн мөн эсэхийг баталж, тодорхойлж чаддаггүй, Бурхан үнэхээр зөвт эсэхийг баталж бас чаддаггүй. Мөн Бурханы жинхэнэ оршин тогтнолыг байтугай, Түүний зан чанар, мөн чанарын үнэн бодитой байдлыг тодорхойлж чаддаггүй. Бурханд итгэхдээ тэд үргэлж эргэлзэж, буруу ойлголттой байж, мөн төсөөлөл, үзэлтэй байдаг. Тэд итгэлээ баяжуулж, Бурханд итгэх туршлагаа нэмэгдүүлж, Бурханд итгэх тухай ойлголтоо бататгаж, өөрсдийн бүтээсэн амьдралын замаар алхан, хүн төрөлхтний төлөө зөв шударга үйл хэргийг гүйцэтгэж, бардам сэтгэлээ хангалуун болгохын тулд Бурханы нигүүлслийг эдлэх явцдаа боломжийн гэж үзсэн зарим үнэнийг мөн дуртай дургүй туулж, хэрэгжүүлдэг. Үүний зэрэгцээ тэд хүн төрөлхтөнд зориулан илүү их ерөөл хүлээж авна гэж найдаж тавьсан мөрийнийх нь нэг хэсэг болох ерөөл хүртэх хүслээ хангаж, Бурханыг олж авах хүртлээ амрахгүй байх асар их эрмэлзэл, насан туршийн хүслээ биелүүлэхийн тулд мөн ийм зүйл хийдэг. Ийм хүмүүс Бурханы гэгээрлийг олж авч чадах нь ховор, учир нь ерөөл хүртэх хүсэл эрмэлзэл, санаархал нь тэдний хувьд дэндүү чухал юм. Тэд үүнийгээ хаях ямар ч хүсэлгүй, хаяж ч тэвчихгүй. Ерөөл хүртэх хүсэл эрмэлзэл, Бурханыг олж авах хүртлээ амрахгүй байх удаан нандигнасан санаархал нь байхгүй бол Бурханд итгэх сэдлээ алдана гэдгээс тэд айдаг. Тиймээс тэд бодит байдалтай нүүр тулахыг хүсдэггүй. Тэд Бурханы үг, Бурханы ажилтай тулгарахыг хүсдэггүй. Тэд Бурханы зан чанар, мөн чанарыг хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй, Бурханыг мэдэх тухай сэдвийг

хөндөхийг бүр ч хүсдэггүй. Учир нь Бурхан, Бурханы мөн чанар, зөвт зан чанар тэдний төсөөллийг орломогц мөрөөдөл нь утаа болон замхарч, олон жилийн уйгагүй хөдөлмөрөөр хуримтлуулсан цэвэр ариун итгэл болон “гавьяа” гээч зүйл нь алга болж, талаар өнгөрөх болно. Үүний адилаар, тэдний олон жилийн турш хөлс цусаараа байлдан дагуулсан “нутаг дэвсгэр” нь сүйрлийг үзэх болно. Тэдний олон жилийн шаргуу хөдөлмөр, хичээл зүтгэл хий дэмий болж, дахин оргүй хоосноос эхлэх ёстой гэдгийг энэ бүхэн илтгэнэ. Энэ нь тэдний хувьд зүрх сэтгэлдээ тээх хамгийн хэцүү шаналал, харахыг хамгийн их хүсдэггүй үр дүн учраас тэд үргэлж ийм мухардалд гацаж, эргэж буцахаас татгалзаж байдаг. Энэ бол гурав дахь төрлийн буюу хөхнөөс гарч буй хүүхдийн үе шатанд байгаа хүн юм.

Дээр тайлбарласан гурван төрлийн хүмүүст, өөрөөр хэлбэл, энэ гурван үе шатанд байгаа хүмүүст, Бурханы ялгамж чанар, байр суурь, зөвт зан чанарт итгэх жинхэнэ итгэл байдаггүй, мөн эдгээр зүйлийг том томруун агаад үнэн зөвөөр хүлээн зөвшөөрч, батлаагүй. Тиймээс энэ гурван төрлийн хүний хувьд үнэний бодит байдалд орох нь маш хэцүү, мөн Бурханы өршөөл, гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүлээн авахад ч бас хэцүү байдаг, учир нь тэдний Бурханд итгэдэг байдал, Бурханд хандах буруу хандлагаас нь болж Бурхан тэдний зүрх сэтгэл дотор ажиллах боломжгүй болдог. Бурханы талаарх тэдний эргэлзээ, эндүүрэл, төсөөлөл нь Бурханд итгэх итгэл, Бурханы тухай мэдлэгээс нь хэтэрсэн. Энэ бол маш эрсдэлтэй байдалд байгаа гурван төрлийн хүн бөгөөд эдгээр нь тун аюултай гурван үе шат юм. Хүн Бурхан, Бурханы мөн чанар, Бурханы ялгамж чанар, Бурхан үнэн мөн эсэх, Тэр үнэхээр оршиж байгаа эсэх талаар эргэлзсэн хандлага баримталж, итгэлтэй байж чадахгүй байхдаа Бурханаас ирдэг бүхнийг яаж хүлээн авч чадах юм бэ? Бурхан бол үнэн, зам, амь гэсэн бодит үнэнийг хэрхэн хүлээн авч чадах юм бэ? Бурханы гэсгээлт, шүүлтийг хэрхэн хүлээн авч чадах билээ? Бурханы авралыг хэрхэн хүлээн авч чадах билээ? Ийм төрлийн хүн Бурханы жинхэнэ удирдамж, хангалтыг хэрхэн олж авч чадах билээ? Энэ гурван үе шатанд байдаг хүмүүс хэдийд ч Бурханыг эсэргүүцэж, Бурханыг шүүж, Бурханыг доромжилж, Бурханаас урваж чадна. Тэд хэдийд ч үнэн замыг орхиж, Бурханыг хаяж чадна. Энэ гурван үе шатанд байгаа хүмүүс бүгд шийдвэрлэх үедээ оршдог гэж хэлж болно, учир нь тэд Бурханд итгэх зөв замдаа ороогүй байгаа билээ.

Дөрөв дэх төрөл: Торниж байгаа хүүхэд буюу хүүхэд насны үе шат

Хөхнөөс гарсны дараа, өөрөөр хэлбэл, арвин их нигүүлсэл эдэлснийхээ дараа, хүн Бурханд итгэнэ гэж юу гэсэн үг болохыг судалж, хүн яагаад амьдардаг, хүн хэрхэн амьдрах ёстой, Бурхан Өөрийн ажлыг яагаад хүн дээр гүйцэтгэдэг гэх мэт янз бүрийн асуултыг ойлгохыг хүсэж эхэлдэг. Эдгээр тодорхой бус бодол, төөрөлдсөн бодол санааны хэв маяг тэдний дотор үүсэж, оршин тогтнох болсон үед, тэд усалгааг тасралтгүй хүлээн авч, бас үүргээ биелүүлж чаддаг. Энэ үед, Бурхан оршин байдаг тухай үнэнд тэд огт эргэлзэхээ больж, Бурханд итгэнэ гэдэг

юу гэсэн үг болох талаар үнэн зөв ойлголттой болдог. Энэ суурин дээрээс тэд Бурханы талаар алгуур мэдлэгтэй болж, Бурханы зан чанар, мөн чанарын тухай тодорхой бус бодол, төөрөлдсөн бодол санаандаа зарим нэг хариултыг аажмаар олж авдаг. Тэдний зан чанарын өөрчлөлтөөс гадна Бурханы талаарх мэдлэгийн тухайд гэвэл, энэ үе шатанд байгаа хүмүүс зөв зам руу алхан орж, шилжилтийн үе рүү орж эхэлдэг. Энэ үе шатанд л хүмүүс амьтай болж эхэлдэг юм. Амьтай болж байгаагийн тодорхой шинж тэмдэг нь, хүмүүсийн зүрх сэтгэл дэх буруу ойлголт, төсөөлөл, Бурханы талаарх бүдэг бадаг тодорхойлолт гэх мэт Бурханыг мэдэхтэй холбоотой олон янзын асуултыг аажмаар шийдвэрлэж буй байдал бөгөөд тэд Бурханы оршин тогтнолын бодитой байдалд үнэхээр итгэж, танин мэдээд зогсохгүй, бас Бурханы талаар үнэн зөв тодорхойлолттой болж, зүрх сэтгэлдээ Бурханд зориулсан зөв орон зайтай болж, тодорхойгүй итгэлийнхээ оронд Бурханыг үнэхээр дагадаг. Энэ үе шатанд, хүмүүс Бурханы талаарх өөрсдийн эндүүрэл, андуу ташаа итгэлийн зам, эрэл хайгуулаа аажмаар мэдэж авдаг. Тэд үнэнээр цангаж, Бурханы шүүлт, цээрлүүлэлт, сахилгажуулалтыг туулж, зан чанараа өөрчлөхийн хүслэн болж эхэлдэг. Энэ үе шатанд тэд Бурханы талаарх бүхий л үзэл, төсөөллөө аажмаар хаяхын зэрэгцээ Бурханы тухай буруу мэдлэгээ өөрчилж, залруулан, Бурханы талаар зарим нэг зөв зүйтэй, суурь мэдлэгийг олж авдаг. Хэдийгээр энэ үе шатны хүмүүсийн эзэмшсэн мэдлэгийн зарим хэсэг нь тийм ч тодорхой, үнэн зөв байдаггүй боловч ядаж л өөрсдийн үзэл, андуу ташаа мэдлэг, Бурханы талаарх буруу ойлголтоо аажмаар орхиж эхэлдэг; тэд Бурханы тухай өөрсдийн гэсэн үзэл, төсөөлөлтэй байхаа больдог. Тэд өөрсдийнх нь үзэлд байдаг, мэдлэгээс үүссэн, Сатанаас ирсэн зүйлсийг хэрхэн хаяхаа сурч эхэлдэг; тэд зөв зүйтэй, эерэг зүйлд, тэр ч бүү хэл Бурханы үгээс ирсэн, үнэнд нийцдэг зүйлд захирагдахыг хүсэж эхэлдэг. Тэд бас Бурханы үгийг туулж, Түүний үгийг биеэрээ мэдэж, хэрэгжүүлж, Түүний үгийг өөрсдийн үйлдлийн зарчим, зан чанараа өөрчлөх үндэс болгон хүлээн авахаар оролдож эхэлдэг. Энэ үед хүмүүс Бурханы шүүлт, гэсгээлтийг өөрийн мэдэлгүй хүлээн авч, Бурханы үгийг өөрийн мэдэлгүй амиа болгодог. Тэд Бурханы шүүлт, гэсгээлт, үгийг хүлээн авах явцдаа зүрх сэтгэлдээ итгэдэг Бурхан нь үнэхээр оршин байдаг гэдгийг улам бүр мэддэг болж, мэдэрч чаддаг. Бурханы үг, өөрсдийн туршлага болон амьдралаас тэд, Бурхан үргэлж хүний хувь заяаг захирч, хүнийг залж чиглүүлж, хангаж ирсэн гэдгийг улам бүр мэдэрдэг. Бурхантай тогтоосон холбоогоороо дамжуулан тэд Бурханы оршин тогтнолыг аажмаар баталдаг. Тиймээс тэд ухаарахаасаа өмнө аль хэдийнээ дотоод ухамсартаа Бурханы ажлыг сайшааж, үүнд бат итгэж, Бурханы үгийг сайшааж байсан. Хүмүүс, Бурханы үг, ажлыг сайшаамагцаа өөрсдийгөө улам бүр үгүйсгэж, өөрсдийн үзэл, мэдлэг, төсөөллөө үгүйсгэхийн зэрэгцээ үнэн гэж юу болох, Бурханы хүсэл юу болохыг улам бүр эрж хайдаг. Хөгжлийн энэ үед, Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг тун өнгөц байдаг, тэд энэхүү мэдлэгээ үгээр тодорхой тайлбарлах чадваргүйн дээр, бас нарийвчлан дэлгэрэнгүй илэрхийлж чаддаггүй,

тэдэнд ухаж ойлгосон ойлголт л байдаг; гэвч өмнөх гурван үе шаттай харьцуулбал энэ үед байгаа хүмүүсийн боловсорч гүйцээгүй амь нь Бурханы үгийн усалгаа, хангалтыг хэдийнээ хүлээн авсан учраас аль хэдийн нахиалж эхэлсэн байдаг. Тэдний амь нь газарт суулгасан үртэй адилхан; чийг болон шим тэжээл хүртсэнийхээ дараа хөрсийг нэвтлэн гарах бөгөөд нахиалж байгаа нь шинэ амь төрснийг илтгэдэг. Ийнхүү төрөх нь амийн шинж тэмдгийг зэрвэс харах боломжийг хүнд олгодог. Амьтай болсон цагт хүмүүс өсдөг. Тиймээс Бурханд итгэх зөв замд аажмаар орж, өөрсдийн үзлийг хаяж, Бурханы удирдамжийг хүлээн авах зэрэг эдгээр суурин дээрээс хүмүүсийн амь бага багаар өсөх нь гарцаагүй. Юун дээр үндэслэж энэ өсөлтийг хэмждэг вэ? Үүнийг Бурханы үгийн талаарх хүний туршлага, Бурханы зөвт зан чанарын талаарх жинхэнэ ойлголтынх нь дагуу хэмждэг. Өсөлтийн энэ үедээ Бурхан, Түүний мөн чанарын талаарх мэдлэгээ өөрийнхөө үгээр үнэн зөв тайлбарлахад тэдэнд маш хэцүү санагддаг хэдий ч энэ бүлэг хүн Бурханы нигүүлслийг эдлэх замаар тав тухыг эрэлхийлж, Бурханы нигүүлслийг хүртэх зорилгоо эрэлхийлэх гэж Бурханд итгэхийг субьектив байдлаар хүсэхээ больдог. Үүний оронд, тэд Бурханы үгээр амьдрахыг зорьж, Бурханы аврах хүн болохыг хүсдэг. Түүнчлэн, тэд Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авахдаа итгэлтэй, бэлэн байдаг. Энэ бол өсөлтийн үе шатанд байгаа хүний тэмдэг юм.

Хэдийгээр энэ үе шатан дахь хүмүүст Бурханы зөвт зан чанарын талаар зарим нэг мэдлэг байдаг ч энэхүү мэдлэг нь маш бүдэг бадаг, тодорхойгүй байдаг. Энэ талаар тодорхой тайлбарлаж чаддаггүй боловч дотроо ямар нэг зүйлийг аль хэдийн олж авсан мэт тэдэнд санагддаг, учир нь тэр Бурханы шүүлт, гэсгээлтээр дамжуулан Бурханы зөвт зан чанарын тухай зарим мэдлэг, ойлголтыг олж авсан билээ. Гэхдээ энэ бүгд нь нэлээд өнгөцхөн бөгөөд мөн л анхан шатандаа байдаг. Энэхүү бүлэг хүн Бурханы нигүүлсэлд хандах тодорхой үзэл бодолтой байдаг бөгөөд энэ нь тэдний зорьдог зорилго болон эрэлхийлэх арга замын өөрчлөлтөөр илэрхийлэгддэг. Хэрвээ үнэнийг эрэлхийлэхгүй хэвээр, бодит байдалд орохоор эрэлхийлэхгүй хэвээр, үгийг нь туулах явцдаа Бурханыг хангалуун байлгаж, Бурханыг мэдэхээр эрэлхийлэхгүй байвал, Бурханд итгэхийн утга учрыг алдах болно гэдгээ тэд Бурханы үг, ажил, хүнд тавьдаг Түүний бүх төрлийн шаардлага, хүний тухай Түүний илчлэлээс аль хэдийнээ харсан. Бурханы нигүүлслийг хэчнээн их эдлэх нь хамаагүй, тэд зан чанараа өөрчилж, Бурханыг хангалуун болгож, Бурханыг мэдэж чадахгүй бөгөөд хүмүүс Бурханы нигүүлсэл дор үргэлж амьдардаг бол хэзээ ч өсөж, амийг олж авч, аврал хүртэж чадахгүй гэдгийг тэд хардаг. Дүгнэж хэлбэл, хэрвээ хүн Бурханы үгийг үнэхээр туулж чадахгүй, Бурханы үгээр дамжуулан Түүнийг мэдэх чадваргүй бол нярай үе шатанд мөнхөд үлдэж, амиа өсгөхөөр нэг ч алхам урагшилж хэзээ ч чадахгүй. Хэрвээ чи нярай үе шатанд мөнхөд байж, Бурханы үгийн бодит байдалд хэзээ ч орж чадахгүй, Бурханы үгийг хэзээ ч амиа болгож чадахгүй, Бурханд жинхэнээсээ итгэж, Бурханы талаарх мэдлэгийг хэзээ ч эзэмшиж чадахгүй бол Бурханаар бүрэн төгс болгуулах боломж

чамд байна гэж үү? Тиймээс, Бурханы үгийн бодит байдалд орж, Бурханы үгийг амиа болгож, Бурханы гэсгээлт, шүүлтийг хүлээн авч эхлэн, завхарсан зан чанар нь өөрчлөгдөж эхэлж байгаа, үнэнээр цангадаг зүрх сэтгэлтэй, Бурханыг мэдэж, Бурханы авралыг хүлээн авах хүсэлтэй ямар ч хүн бол амь үнэхээр байдаг хүмүүс юм. Энэ бол үнэхээр дөрөв дэх төрлийн хүн, торниж байгаа хүүхэд буюу хүүхэд насны үе шатанд байгаа хүн юм.

Тав дахь төрөл: Амь нь боловсрох үе шат буюу насанд хүрэгчийн үе шат

Хүүхэд насны үе шат, ахин дахин унаж босох үеүдээр дүүрэн өсөлтийн үе шатыг паацганан алхаж, туулсны дараа хүмүүсийн амь тогтворжиж, урагшаа алхахдаа саатахаа больж, хэн ч тэдэнд саад болж чаддаггүй. Хэдийгээр өмнөх зам нь бартаатай, овон товонтой хэвээр байгаа ч тэд сул дорой, айдастай байхаа больж, урагшаа тэмтчиж, зүг чигээ алдахаа больдог. Бурханы үгийн бодит туршлага дотор тэд сууриа гүн тавьж, зүрх сэтгэл нь Бурханы эрхэм чанар, агуу байдалд татагдаж ирсэн. Тэд Бурханы мөрийг дагаж, мөн чанарыг нь мэдэж, Бурханы талаар бүгдийг нь мэдэхийн хүслэн болдог.

Энэ үе шатанд байгаа хүмүүс хэнд итгэдгээ хэдийнээ сайн мэдэж байдгийн дээр яагаад Бурханд итгэх ёстойгоо, амьдралынхаа утга учрыг, Бурханы илэрхийлдэг бүхэн нь үнэн гэдгийг тодорхой мэддэг. Олон жилийн туршлагаасаа тэд, Бурханы шүүлт, гэсгээлтгүйгээр хүн хэзээ ч Бурханыг хангалуун болгож, Бурханыг мэдэж чадахгүй, Бурханы өмнө үнэхээр очиж хэзээ ч чадахгүй гэдгийг ухаардаг. Энэ хүмүүсийн зүрх сэтгэлд, шалгагдах зууpаа Бурханы зөвт зан чанарыг харж, илүү цэвэр ариун хайрыг олж авахын зэрэгцээ Бурханыг илүү жинхэнээсээ ойлгож, мэдэж чаддаг байхын тулд Бурханаар шалгуулах маш их хүсэл байдаг. Энэ үе шатанд байгаа хүмүүс, нялх үе шат, Бурханы нигүүлслийг эдэлж, цадталаа талх идэх үе шаттайгаа аль хэдийн бүрэн дүүрэн салах ёс хийсэн байдаг. Бурханыг өөрсдөд нь хүлээцтэй хандаж, өршөөл үзүүлдэг болгох тухай хэрээс хэтэрсэн итгэл найдвар тавихаа тэд больдог; харин ч тэд завхарсан зан чанараасаа салж, Бурханыг хангалуун байлгахын тулд Бурханы дуусашгүй гэсгээлт, шүүлтийг хүлээн авахдаа итгэлтэй байж, үүнд найддаг. Бурханы талаарх тэдний мэдлэг, эрэл хайгуул, эсвэл эрэл хайгуулынх нь эцсийн зорилго бүгд зүрх сэтгэлд нь тун тодорхой байдаг. Тиймээс, насанд хүрэгчийн үе шатанд байгаа хүмүүс, тодорхойгүй итгэлийн үе шат, авралын төлөө нигүүлсэлд найддаг үе шат, шалгалтыг тэсэж чаддаггүй дутуу дулимаг амьтай байх үе шат, тодорхойгүй байдлын үе шат, тэмтэрч бэдэрсэн үе шат, үргэлж ямар ч явах замгүй байдаг үе шат, гэнэтийн халуун, хүйтэн ээлжилдэг тогтворгүй үе шат, нэг нүдээ дарчхаад Бурханыг дагадаг үе шаттай аль хэдийнээ бүрмөсөн салах ёс хийсэн байдаг. Ийм төрлийн хүмүүс үргэлж Бурханы гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүлээн авч, үргэлж Бурхантай жинхэнэ холбоо, харилцаатай байдаг. Энэ үе шатанд амьдарч байгаа хүмүүс Бурханы хүслийн

зарим хэсгийг аль хэдийн ухааран ойлгосон, хийж байгаа юм бүхэндээ үнэний зарчмыг олж чаддаг, Бурханы хүслийг хэрхэн хангахаа мэддэг гэж хэлж болно. Түүнчлэн, тэд Бурханыг мэдэх замыг олж, Бурханы талаарх мэдлэгээ гэрчилж эхэлсэн байдаг. Аажмаар өсөх явцдаа тэд Бурханы хүсэл, хүн төрөлхтнийг бүтээж, хүн төрөлхтнийг удирдах Бурханы хүслийн талаар аажмаар ойлгож, мэддэг. Мөн чанарын тухайд Бурханы зөвт зан чанарыг мөн тэд аажмаар ойлгож, мэддэг. Хүний ямар ч үзэл, төсөөлөл энэхүү мэдлэгийг орлож чадахгүй. Тав дахь үе шатанд хүний амь бүрэн боловсорсон байдаг, эсвэл энэ хүн бол зөв шударга, бүрэн төгс гэж хэлж болохгүй боловч ийм төрлийн хүн амь нь боловсрох үе шат руу аль хэдийн алхаж эхлэн, аль хэдийн Бурханы өмнө ирж, Бурханы үг болон Бурхантай нүүр тулан зогсох чадвартай болсон байдаг. Ийм төрлийн хүн Бурханы маш их үг, тоо томшгүй олон шалгалт, Бурханаас ирсэн тоо томшгүй олон удаагийн сахилгажуулалт, шүүлт, гэсгээлтийг туулсан байдаг учраас ямар нэгэн зүйлээс хамаарч биш, харин бүрэн дүүрэн Бурханд захирагддаг. Бурханы талаарх тэдний мэдлэг дотоод ухамсраас яг таг, тодорхой, өнгөцхөнөөс гүнзгий, бүрэлзсэн бүдэг бадгаас нарийн бодитой мэдлэг болж хувирсан. Тэд хүчлэн тэмтчиж, идэвхгүй эрж хайхаас сурцтай мэдлэгтэй, санаачилгатайгаар гэрчлэл хийдэг болсон. Энэ үе шатанд байгаа хүмүүс Бурханы үгийн үнэн-бодит байдалтай болж, Петрийн алхаж байсан шиг төгс болгуулах замд хөл тавьсан гэж хэлж болно. Энэ бол боловсорсон байдалд—насанд хүрэгчийн үе шатанд амьдардаг, тав дахь төрлийн хүн юм.

2013 оны 12 дугаар сарын 14

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ III
БУРХАНЫ ЭРХ МЭДЭЛ (II)

Өнөөдөр бид нөхөрлөлөө “Цор ганц Бурхан Өөрөө” гэсэн сэдвээр үргэлжлүүлэх болно. Бид энэ сэдвээр өмнө нь хоёр ч удаа нөхөрлөсөн бөгөөд эхнийх нь Бурханы эрх мэдлийн талаар, хоёр дахь нь Бурханы зөвт зан чанарын талаар байсан. Энэ хоёр нөхөрлөлийг сонсоод та нар Бурханы ялгамж чанар, байр суурь, мөн чанарын талаар шинэ ойлголт олж авсан уу? Эдгээр мэдлэг ухаан нь, Бурханы оршин тогтнолын үнэний тухай илүү үндэслэлтэй мэдлэг олж авч, үүнд итгэлтэй болоход та нарт тусалсан уу? Өнөөдөр Би “Бурханы эрх мэдэл” хэмээх сэдвийг дэлгэрүүлэн үзэхээр төлөвлөж байна.

Бурханы эрх мэдлийг макро болон микро өнцгөөс ойлгох нь

Бурханы эрх мэдэл бол цор ганц. Энэ бол Бурханы Өөрийнх нь өвөрмөц шинж бүхий илэрхийлэл, онцгой мөн чанар, ялгамж чанар бөгөөд бүтээгдсэн, бүтээгдээгүй зүйлийн алинд нь ч ийм чанар байдаггүй; зөвхөн Бүтээгчид л ийм эрх мэдэл байдаг. Өөрөөр хэлбэл, зөвхөн Бүтээгч—Цор ганц Бурхан л ийм байдлаар илэрхийлэгддэг, ийм мөн чанартай байдаг. Тэгэхээр яагаад бид Бурханы эрх мэдлийн талаар ярих хэрэгтэй вэ? Бурханы Өөрийнх нь эрх мэдэл хүний оюун санаандаа төсөөлдөг эрх мэдлээс ямар ялгаатай вэ? Юу нь онцгой вэ? Үүний талаар энд ярилцах нь яагаад онцгой ач холбогдолтой вэ? Та нар дор бүрнээ энэ асуудлыг анхааралтай авч үзэх ёстой. Ихэнх хүмүүсийн хувьд “Бурханы эрх мэдэл” нь ойлгоход маш их хүчин чармайлт шаарддаг тодорхой бус ойлголт бөгөөд энэ талаарх аливаа хэлэлцүүлэг хийсвэр байх магадлалтай. Тиймээс Бурханы эрх мэдлийн тухай хүний ээмшиж чадах мэдлэг болон Бурханы эрх мэдлийн мөн чанарын хооронд зөрүү байнга байх болно. Энэхүү зөрүүг арилгахын тулд хүмүүс, үйл явдал, юмс, янз бүрийн үзэгдлээр дамжуулан, хүн болгон хүний хүрч болох, бодит амьдралдаа ойлгож чадах хэмжээндээ Бурханы эрх мэдлийг бага багаар мэдэж авах ёстой. “Бурханы эрх мэдэл” хэмээх хэллэг нь хэдийгээр ойлгошгүй мэт санагдаж болох ч Бурханы эрх мэдэл бол хийсвэр зүйл огт биш. Тэр амьдралынх нь хором бүрд хүнтэй хамт байж, өдөр бүр хүнийг хөтөлж байдаг. Иймээс бодит амьдрал дээр хүн болгон Бурханы эрх мэдлийн хамгийн баримттай талыг гарцаагүй харж, мэдрэх болно. Энэхүү баримттай тал нь Бурханы эрх мэдэл үнэхээр оршин байдаг гэдгийг хангалттай нотолж, Бурхан ийм эрх мэдэлтэй байдаг гэдгийг таньж мэдэж, ухаарч ойлгох боломжийг хүнд бүрэн олгодог.

Бурхан бүгдийг бүтээсэн, бүтээсэн болохоороо Тэр бүх зүйлийг ноёрхдог. Тэр бүгдийг ноёрхохоос гадна бүх зүйлийг хянадаг. “Бурхан бүх зүйлийг хянадаг” гэсэн санаа нь ямар учиртай вэ? Үүнийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Бодит амьдралд энэ нь хэрхэн тусдаг вэ? Бурхан бүх зүйлийг хянадаг гэсэн бодит үнэнийг ойлгох нь Түүний эрх мэдлийн тухай ойлголтод хэрхэн хүргэж болох вэ? “Бурхан бүх

зүйлийг хянадаг” гэдэг яг энэ хэллэгээс бид Бурхан гараг эрхсийн нэг хэсэг биш, бүтээлийн нэг хэсэг биш, хүн төрөлхтний нэг хэсэг ч биш, харин нүсэр томоос бичил жижиг, харагддагаас үл үзэгдэх, сансар огторгуйн оддоос дэлхий дээрх амьд юмс, мөн энгийн нүдээр харах боломжгүй бичил биетэн, өөр хэлбэрээр оршдог биетүүд хүртэлх бүх зүйлийг хянадаг гэдгийг нь харах хэрэгтэй. Энэ л Бурханы “хянадаг” “бүх зүйлийн” яг таг тодорхойлолт; энэ бол Түүний эрх мэдлийн цар хүрээ, Түүний дээд эрх болон захиргааны хэр хэмжээ юм.

Энэхүү хүн төрөлхтөн үүсэн бий болохоос өмнө сансар огторгуй—бүх гараг, тэнгэрийн бүх од—аль хэдийн оршиж байсан. Макро түвшинд, хэчнээн олон жил болсон ч эдгээр тэнгэрийн эрхэс оршин байх бүхий л хугацаандаа Бурханы хяналт дор тогтмол тойрон эргэсээр байж ирсэн. Ямар гараг яг ямар цагт хаашаа явдаг; ямар гараг хэзээ, ямар даалгавар биелүүлдэг; ямар гараг ямар тойрог замаар эргэдэг, хэзээ алга болж, эсвэл солигддог гээд энэ бүхэн өчүүхэн төдий ч алдаа мадаггүй явагдаж байдаг. Гарагуудын байрлал, тэдгээрийн хоорондын зай бүгд чанд тогтсон зүй тогтлыг дагадаг бөгөөд бүгдийг нь яг таг мэдээллээр тодорхойлж болно; тэдгээрийн аялах зам, тойрог замын хурд болон зүй тогтол, янз бүрийн байрлалд очих цаг гээд энэ бүгдийг нарийн тооцоолж, тусгай хуулиар тодорхойлж болно. Олон мянган жилийн туршид гарагууд эдгээр хуулийг өчүүхэн төдий ч гажихгүйгээр дагасан. Тэдний тойрог зам, дагадаг зүй тогтлыг нь ямар ч хүч өөрчилж, тасалдуулж чадахгүй. Тэдний хөдөлгөөнийг захирдаг тусгай хууль болон тэдгээрийг тодорхойлдог нарийн мэдээллийг Бүтээгчийн эрх мэдэл урьдаас тогтоосон байдаг учраас тэдгээр нь Бүтээгчийн дээд эрх, хяналтын дор эдгээр хуулийг сайн дураараа дуулгавартай дагадаг. Макро түвшинд, зарим нэг зүй тогтол, мэдээлэл, хачирхалтай, тайлбарлахын аргагүй хууль, үзэгдлийг хүн олж нээхэд хэцүү зүйл биш. Хэдийгээр хүн төрөлхтөн Бурхан оршин байдаг гэдгийг, бас Бүтээгч бүх зүйлийг бүтээсэн, бүх зүйлийг ноёрхдог гэдэг бодит үнэнийг, түүнчлэн Бүтээгчийн эрх мэдлийн оршин тогтнолыг хүлээн зөвшөөрдөггүй ч гэсэн хүн судлалын эрдэмтэд, одон орон судлаачид, физикч нар хорвоо ертөнц дээрх бүх зүйлийн оршин тогтнол, тэдгээрийн хөдөлгөөнийг удирддаг зарчим, зүй тогтол бүгдийг асар том, үл үзэгдэх хар энерги захирч, хянадаг гэдгийг улам бүр олж нээсээр байна. Энэхүү баримт нь хүнийг, хөдөлгөөний эдгээр зүй тогтлын дунд бүх зүйлийг зохион байгуулдаг Төгс Хүчит Нэгэн байна гэдэгтэй эрхгүй нүүр тулж, хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг. Түүний хүч чадал ер бусын бөгөөд хэдийгээр хэн ч Түүний жинхэнэ нүүр царайг харж чадахгүй боловч, Тэр хором бүрд бүх зүйлийг захирч, хянаж байдаг. Хэн ч, ямар ч хүч Түүний дээд эрхийг даван гарч чадахгүй. Энэ баримттай тулгараад, бүх зүйлийн оршин тогтнолыг захирч байдаг хуулийг хүн хянаж чадахгүй, хэн ч өөрчилж чадахгүй гэдгийг хүн хүлээн зөвшөөрөх ёстой; мөн хүмүүс эдгээр хуулийг бүрэн дүүрэн ойлгож чадахгүй, тэдгээр нь аяндаа өрнөж байдаг юм биш, харин Эзэн захирагчийн тушаалаар болдог гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Эдгээр нь бүгд, макро түвшинд хүн төрөлхтний ухамсарлаж чадах Бурханы эрх мэдлийн илэрхийлэл юм.

Микро түвшинд, газар дэлхий дээр хүний харж болох бүх уул, гол, нуур, далай, хуурай газар, хүний үзэж туулдаг бүх улирал, дэлхий дээр амьдардаг ургамал, амьтан, бичил биетэн, хүмүүс гээд бүх зүйл Бурханы дээд эрх, хяналтад захирагдаж байдаг. Бурханы дээд эрх, хяналтын дор бүх зүйл Түүний бодлын дагуу үүсэн бий болж, үгүй болж байдаг; тэдгээрийн оршин тогтнолыг захирдаг хуулиуд бий болж, тэдгээр нь үүний дагуу өсөж үрждэг. Ямар ч хүн, ямар ч зүйл эдгээр хуулиас дээгүүр байдаггүй. Яагаад тэр вэ? Цорын ганц хариулт бол: Бурханы эрх мэдлийн улмаас тэр юм. Эсвэл, өөрөөр хэлбэл, Бурханы бодол, Бурханы үгийн улмаас тэр; Бурхан Өөрийн биеэр үйлддэг учраас тэр билээ. Энэ нь Бурханы эрх мэдэл, Бурханы санаа бодол эдгээр хуулийг үүсгэдэг бөгөөд эдгээр хууль нь Түүний бодлын дагуу шилжин, өөрчлөгдөж, эдгээр шилжилт, өөрчлөлт нь бүгд Түүний төлөвлөгөөний төлөө гарч ирж, алга болж байдаг гэсэн үг. Жишээ нь, тахлыг аваад үзье. Тахал ямар ч анхааруулгагүйгээр гардаг. Тэдгээрийн гарал үүсэл, яг яагаад гарсан шалтгааныг хэн ч мэддэггүй бөгөөд тодорхой нэг газар нутагт тахал гарах болгонд үйл нь ирсэн хүмүүс гамшгаас зугтаж чаддаггүй. Тахал нь аюулт, хөнөөлт нянгийн тархалтын улмаас үүсдэг гэдгийг хүн төрөлхтний шинжлэх ухаан ойлгодгийн дээр тэдгээрийн хурд, хамрах хүрээ, халдварлах арга замыг хүн төрөлхтний шинжлэх ухаан урьдчилан хэлж, хянаж чаддаггүй. Хэдийгээр хүмүүс боломжит бүх арга хэрэгслээр тахлыг эсэргүүцдэг боловч тахал гарахад ямар хүмүүс, эсвэл ямар амьтад гарцаагүй өртөхийг тэд хянаж чадахгүй. Хүмүүсийн хийж чадах цорын ганц зүйл нь тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг эсэргүүцэх, судлах гэж хичээх явдал юм. Гэхдээ аливаа нэгэн тахлын эхлэл, төгсгөлийг тайлбарлах үндсэн шалтгааныг хэн ч мэдэхгүй, хэн ч тэдгээрийг хянаж чадахгүй. Тахлын үүсэл, тархалттай нүүр тулаад хүмүүсийн авдаг хамгийн эхний арга хэмжээ нь вакцин гаргах байдаг боловч ихэнхдээ вакцин бэлэн болохоос өмнө тахал өөрөө үгүй болдог. Тахал яагаад устаж арилдаг вэ? Бактерийг хяналтдаа авч чадсан гэж зарим хүн хэлдэг бол, харин зарим нь улирлын өөрчлөлтийн улмаас тэдгээр нь устаж арилдаг гэж хэлдэг… Эдгээр галзуу таамаглал үндэслэлтэй эсэх тухайд гэвэл, шинжлэх ухаан ямар ч тайлбар санал болгож, ямар ч тодорхой хариулт өгч чаддаггүй. Хүн төрөлхтөн дан ганц эдгээр таамаглалаас гадна, хүн төрөлхтний дутуу ойлголт, тахлаас айх айдсын талаар бодож үзэх ёстой. Тахал яагаад эхэлдэг, яагаад дуусдагийг эцсийн дүндээ хэн ч мэдэхгүй. Хүн төрөлхтөн, зөвхөн шинжлэх ухаанд л итгэж, үүнд бүрмөсөн найддаг, Бүтээгчийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, Түүний дээд эрхийг хүлээж авдаггүй учраас тэд хэзээ ч хариулт олж авахгүй.

Бурханы дээд эрхийн дор, Түүний эрх мэдэл болон удирдлагаас үүдэн бүх зүйл төрж, амьдарч, устан үгүй болдог. Зарим зүйл чимээгүйхэн ирээд буцдаг бөгөөд тэдгээр нь хаанаас ирснийг хүн хэлж, эсвэл дагадаг зүй тогтлыг нь ухаарч чаддаггүй, тэр ч байтугай тэдний ирээд буцдаг шалтгааныг ойлгодоггүй. Хэдийгээр хүн бүх зүйлийн дунд болж өнгөрч буй бүхнийг нүдээрээ харж, чихээрээ сонсож,

эсвэл биеэрээ туулж чаддаг боловч; хэдийгээр энэ бүгд хүнд хамааралтай бөгөөд хүн янз бүрийн үзэгдлийн харьцангуй ер бусын байдал, зүй тогтол, бүр этгээд хачин байдлыг дотоод ухамсартаа ухамсарладаг боловч тэдгээрийн цаана юу байгааг огт мэддэггүй, энэ нь Бурханы хүсэл ба бодол юм. Эдгээр үзэгдлүүдийн цаана олон түүх, олон нуугдмал үнэн байдаг. Хүн Бүтээгчээс төөрч яваад, Бүтээгчийн эрх мэдэл бүх зүйлийг захирдаг гэсэн бодит үнэнийг хүлээн зөвшөөрдөггүй учраас Бүтээгчийн бүрэн эрхийн дээд эрхийн дор болж буй бүхнийг хэзээ ч мэдэхгүй бас ухаарч ойлгохгүй. Ихэнхдээ, Бурханы хяналт, дээд эрх нь хүний төсөөлөл, хүний мэдлэг, хүний ойлголт болон шинжлэх ухааны хүрч чадах хязгаараас давж, бүтээгдсэн хүмүүсийн мэдлэгийн хүрээнээс хальсан байдаг. Зарим хүн “Чи Бурханы дээд эрхийг нүдээрээ хараагүй байж бүх зүйл Түүний эрх мэдэлд байдаг гэж яаж итгэж чадаж байна вэ?” гэдэг. Харснаараа үргэлж итгэдэг юм биш; үргэлж танин мэдэж, ойлгох ч бас биш. Тэгэхээр итгэл хаанаас гардаг вэ? Итгэл нь аливаа зүйлийн бодит байдал, үндсэн шалтгааны талаарх хүмүүсийн ойлголт, туршлагын түвшин болон гүнээс гардаг гэдгийг Би баттай хэлж чадна. Хэрвээ чи Бурхан оршдог гэдэгт итгэдэг ч бүх зүйлийг захирах Бурханы хяналт болон Бурханы дээд эрхийг ухамсарлах нь бүү хэл, танин мэдэж чадахгүй бол Бурханд ийм эрх мэдэл байдаг бөгөөд Бурханы эрх мэдэл цор ганц гэдгийг зүрх сэтгэлдээ хэзээ ч хүлээн зөвшөөрч чадахгүй. Чи Бүтээгчийг хэзээ ч өөрийн Эзэн, өөрийн Бурхан хэмээн үнэхээр хүлээн зөвшөөрөхгүй.

Хүн төрөлхтний болон орчлон ертөнцийн хувь заяа Бүтээгчийн дээд эрхтэй салшгүй холбоотой

Та нар бүгд насанд хүрсэн хүмүүс. Та нарын зарим нь дунд эргэм насных; зарим нь ахимаг насных. Бурханд итгэдэггүй байснаа итгэдэг болж, Бурханд итгэж эхэлснээ Түүний үгийг хүлээн зөвшөөрч, Түүний ажлыг туулдаг болох хүртлээ та нар явсан. Бурханы дээд эрхийн талаар та нар хэр их мэдлэгтэй вэ? Хүний хувь заяаны тухайд чи ямар мэдлэг ухааныг олж авсан бэ? Хүн амьдралд хүссэн бүхэндээ хүрч чадах уу? Өөрсдийн оршин байсан хэдхэн арван жилд та нар хэр олон зүйлийг хүссэнээрээ биелүүлж чадсан бэ? Хэчнээн санаанд чинь хэзээ ч ороогүй зүйлс та нарт тохиолдсон бэ? Хэчнээн гэнэтийн таатай зүйл болсон бэ? Хэчнээн зүйлийг хүмүүс үр дүнгээ өгөхийг нь хүлээж, өөрийн мэдэлгүй тохиромжтой мөчийг хүлээж, Тэнгэрийн хүслийг хүлээсээр байна вэ? Хэчнээн зүйл хүмүүсийг арга мухардуулж, саад болж байна вэ? Хүн бүр хувь заяаныхаа талаар итгэл найдвараар дүүрэн байж, амьдралынх нь бүх зүйл хүссэнээр нь болж, хоол хувцсаар дутахгүй, эд хөрөнгө нь гайхалтайгаар өснө гэж горьддог. Зовлон зүдүүрээр дүүрэн, гай гамшгаар хүрээлэгдсэн ядуу зүдүү, дарамттай амьдралыг хэн ч хүсдэггүй. Гэхдээ хүмүүс эдгээр зүйлийг урьдаас мэдэж, хянаж чадахгүй. Зарим хүний хувьд өнгөрсөн үе бол ердөө л эх захгүй туршлага юм; тэд Тэнгэрийн хүсэл юу болохыг хэзээ ч мэдэж авдаггүй, мөн энэ нь юу болохыг тоодог ч үгүй. Тэд

хүн төрөлхтний хувь заяаны талаар, хүмүүс яагаад амьд байдаг, тэд хэрхэн амьдрах учиртайг хайхрахгүйгээр өдөр өдрийг амьтад шиг амьдарч, өөрсдийнхөө амьдралыг бодож санах зүйлгүйгээр амьдран харуулдаг. Ийм хүмүүс хүмүүний хувь заяаны талаар ямар ч ойлголт олж авалгүйгээр хөгширдөг бөгөөд үхэх мөчөө хүртэл амьдрал гэж юу болох талаар ямар ч ойлголтгүй байдаг. Тийм хүмүүс үхмэл; тэд бол сүнсгүй амьтад; тэд бол адгуус. Хүмүүс бүтээлийн дотор амьдарч, дэлхий ертөнцийн материаллаг хэрэгцээг нь хангаж өгдөг олон арга замаас цэнгэлийг олж авдаг, энэхүү материаллаг ертөнц нь тасралтгүй урагшилж байгааг тэд харах авч тэдний өөрсдийн туршлага—тэдний зүрх сэтгэл болон тэдний сүнс юу мэдэрч, амсах нь материаллаг зүйлтэй ямар ч хамаагүй бөгөөд ямар ч материаллаг зүйл туршлагыг орлож чадахгүй. Туршлага бол хүн зүрх сэтгэлийнхээ гүнд танин мэддэг, энгийн нүдээр харж болдоггүй зүйл юм. Ийнхүү танин мэдэх нь хүмүүний амьдрал болоод хүмүүний хувь заяаг хүн ойлгож, ухамсарлахад оршдог. Энэ нь үл үзэгдэгч Эзэн бүх зүйлийг зохицуулж, хүний төлөө бүх зүйлийг зохион байгуулж байна гэдгийг ихэнхдээ хүн ойлгоход хүргэдэг. Энэ бүхний дунд хувь заяаны зохицуулалт, зохион байгуулалтыг хүлээн зөвшөөрөхөөс өөр арга хүнд үгүй; Бүтээгчийн төлөвлөсөн замыг болон хүний хувь заяаг захирах Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрөхөөс өөр арга хүнд үгүй. Энэ бол маргаангүй баримт юм. Хүн хувь заяаны талаар ямар ч мэдлэг ухаан, хандлагатай байхаас үл хамааран, хэн ч энэ баримтыг өөрчилж чадахгүй.

Өдөр бүр хаашаа явах, юу хийх, хэнтэй эсвэл юутай таарах, юу хэлж ярих, чамд юу тохиолдох гээд эдгээрийн аль нэгийг тааварлаж болох уу? Хүмүүс эдгээр нөхцөл байдал хэрхэн өрнөхийг хянах нь байтугай энэ бүх үйл явдлыг урьдаас мэдэж чаддаггүй. Амьдрал дээр, урьдчилан харах боломжгүй эдгээр зүйл цаг үргэлж тохиолддог; тэдгээр нь өдөр тутмын үйл явдал юм. Өдөр тутмын эдгээр нөхцөл байдлын өөрчлөлт болон тэдгээрийн өрнөж байгаа байдал, эсвэл дагаж буй буй зүй тогтол нь ямар ч зүйл санаандгүй тохиолддоггүй, үйл явдал бүрийн болж буй явц, зайлшгүй байдлыг хүний хүслээр өөрчилж болдоггүй гэдгийг хүн төрөлхтөнд байнга сануулж байдаг. Үйл явдал бүр нь Бүтээгчээс хүн төрөлхтөнд өгч буй сануулгыг дамжуулдаг бөгөөд мөн хүмүүс өөрсдийн хувь заяаг хянаж чадахгүй гэсэн санааг илгээдэг. Үйл явдал бүр хувь заяагаа гартаа авах гэсэн хүн төрөлхтний ойворгон, хий дэмий, хүсэл, эрмэлзлийг няцаадаг. Тэдгээр нь яг л хүн төрөлхтний нүүрийг дахин дахин хүчтэй алгадан, эцэст нь хэн тэдний хувь тавиланг удирдаж, хянаж байдгийг эргэцүүлэхэд хүмүүсийг хүчээр хүргэдэг. Тэдний хүсэл, эрмэлзэл нь удаа дараалан бүтэлгүйтэж, нуран унахад хүмүүс аяндаа өөрт ноогдсон хувь заяаг хүлээн зөвшөөрч, бодит байдал, Тэнгэрийн хүсэл ба Бүтээгчийн дээд эрхийг өөрийн эрхгүй хүлээн зөвшөөрдөг. Өдөр тутмын эдгээр нөхцөл байдлын өөрчлөлтөөс эхлээд хүний бүхий л амьдралын хувь заяа хүртэл, Бүтээгчийн төлөвлөгөө болон дээд эрхийг илчилдэггүй зүйл нэгээхэн ч үгүй; “Бүтээгчийн эрх мэдлийг даван гарч чадахгүй” гэсэн санааг илгээдэггүй, мөн

“Бүтээгчийн эрх мэдэл бол эрхэм дээд юм” гэсэн мөнхийн үнэнийг дамжуулдаггүй зүйл нэгээхэн ч үгүй.

Хүн төрөлхтөн болон орчлон ертөнцийн хувь заяа Бүтээгчийн дээд эрхтэй нягт сүлжилдэж, Бүтээгчийн зохион байгуулалттай салшгүйгээр холбогдсон байдаг; эцсийн эцэст тэдгээр нь Бүтээгчийн эрх мэдлээс ангид байж чаддаггүй. Бүх зүйлийн хуулиас хүн Бүтээгчийн зохион байгуулалт болон Түүний дээд эрхийг ойлгож авдаг; бүх зүйлийн амьд үлдэх хуулиас тэр Бүтээгчийн засаглалыг ухамсарладаг; бүх зүйлийн хувь заяанаас тэр Бүтээгч Өөрийн дээд эрх, хяналтаа тогтоодог арга замыг таамагладаг; хүмүүс болон бүх зүйлийн амьдралын мөчлөгөөс хүн, бүх зүйл ба амьд оршихуйн төлөөх Бүтээгчийн зохион байгуулалт, зохицуулалтыг үнэхээр туулж, тэдгээр зохион байгуулалт, зохицуулалт нь газар дэлхийн бүх хууль, дүрэм журам, дэг жаяг, бусад бүх эрх мэдэл болон хүчнээс давсан байдгийг нүдээрээ харж авдаг. Иймээс, Бүтээгчийн дээд эрхийг бүтээгдсэн ямар ч зүйл зөрчиж чадахгүй, Бүтээгчийн урьдаас тогтоосон үйл явдал болон зүйлст ямар ч хүч хөндлөнгөөс оролцож, эсвэл өөрчилж чадахгүй гэдгийг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрнэ. Эдгээр тэнгэрлэг хууль, дүрэм журмын дор хүмүүс болон бүх зүйл үеэс үед амьдарч, өсөн үрждэг. Бүтээгчийн эрх мэдлийн жинхэнэ биелэл энэ бус уу? Хэдийгээр хүн бодит хуулиудаас, бүх үйл явдал болон бүх зүйлд Бүтээгчийн дээд эрх болон Түүний зарлиг байгааг хардаг боловч орчлон ертөнцийг захирах Бүтээгчийн дээд эрхийн зарчмыг хэчнээн хүн ухаарч ойлгож чадах вэ? Өөрсдийнх нь хувь заяаг захирч, зохицуулдаг, Бүтээгчийн дээд эрхийг хэр олон хүн үнэхээр мэдэж, танин мэдэж, хүлээн зөвшөөрч, захирагдаж чадах вэ? Бүх зүйлийг захирдаг Бүтээгчийн дээд эрхийн бодит үнэнд итгэсэн байж, Бүтээгч бас хүмүүсийн амьдралын хувь заяаг захирдаг гэдэгт хэн үнэхээр итгэж, хүлээн зөвшөөрөх вэ? Хүний хувь заяа Бүтээгчийн гарт байдаг бодит баримтыг хэн үнэхээр ухаарч ойлгож чадах вэ? Бүтээгч хүн төрөлхтний хувь заяаг захирч, хянаж байдаг бодит баримттай нүүр тулахдаа хүн төрөлхтөн Бүтээгчийн дээд эрхэд ямар байдлаар хандах ёстой вэ? Энэхүү бодит баримттай тулгараад байгаа хүн бүрийн өөрөө гаргах учиртай шийдвэр энэ мөн билээ.

Хүний амьдралын зургаан онцгой үе

Амьдралынхаа явцад хүн бүр хэд хэдэн шийдвэрлэх онцгой үе дээр ирдэг. Эдгээр нь хүний амьдралын хувь заяаг тодорхойлдог хамгийн үндсэн, хамгийн чухал алхмууд билээ. Амьдралынхаа явцад хүн бүрийн туулах ёстой эдгээр замын тэмдгийг дараах байдлаар товч тайлбарлалаа.

Эхний онцгой үе: Төрөлт

Хүн хаана, ямар гэр бүлд төрсөн, хүний хүйс, дүр төрх, төрсөн цаг гэвд эдгээр нь хүний амьдралын эхний онцгой үеийн нарийн зүйлс юм.

Энэхүү онцгой үеийн тодорхой нарийн зүйлсийг хэн ч сонгож болохгүй; тэдгээрийг бүгдийг нь Бүтээгч аль эрт урьдаас тогтоосон байдаг. Тэдгээрт гадаад орчин ямар нэгэн байдлаар нөлөөлдөггүй, Бүтээгчийн урьдаас тогтоосон эдгээр баримтыг хүний бий болгосон ямар ч хүчин зүйл өөрчилж чадахгүй. Хүн төрнө гэдэг нь тухайн хүнд зориулан зохицуулсан хувь заяаных нь эхний алхмыг Бүтээгч аль хэдийн биелүүлсэн гэсэн үг юм. Энэ бүх нарийн зүйлийг Тэр аль эрт урьдаас тогтоосон учраас аль нэгийг нь өөрчлөх хүч хэнд ч байхгүй. Хүний цаашдын хувь заяанаас үл хамааран хүний төрөх нөхцөлүүд урьдаас тогтоогдож, тэр хэвээрээ үлддэг; тэдгээрт хүний амьдралын хувь заяа ямар нэгэн байдлаар нөлөөлдөггүй, мөн тэдгээр нь хүний амьдралын хувь заяаг захирах Бүтээгчийн дээд эрхэд ямар нэг байдлаар нөлөөлдөггүй.

1) Бүтээгчийн төлөвлөгөөнөөс шинэ амь төрдөг

Эхний онцгой үеийн хүний төрөх газар, гэр бүл, хүйс, бие махбодын төрх байдал, төрөх цаг хугацаа гэх мэт нарийн зүйлээс алийг нь хүн өөрөө сонгож чадах вэ? Мэдээжийн хэрэг хүн төрөх нь идэвхгүй үйл явдал юм. Хүн өөрийн хүслээс үл хамааран тодорхой нэгэн газарт, тодорхой нэгэн цагт, тодорхой нэгэн гэр бүлд, тодорхой нэгэн дүр төрхтэйгөөр төрдөг; хүн өөрийн эрхгүй тодорхой нэгэн ургийн модны нэг мөчир, тодорхой нэгэн өрхийн гишүүн болдог. Амьдралын энэхүү эхний онцгой үе дээр хүнд ямар ч сонголт байдаггүй, харин Бүтээгчийн төлөвлөгөөний дагуу бэлдсэн орчинд, тодорхой нэгэн гэр бүлд, тодорхой хүйс, дүр төрхтэйгөөр, тухайн хүний амьдралын замналтай нягт холбоотой тодорхой нэгэн цагт төрдөг. Энэхүү шийдвэрлэх онцгой үе дээр хүн юу хийж чадах вэ? Ерөнхийдөө, өөрийнх нь төрөлттэй холбоотой эдгээр нарийн зүйлээс нэгийг нь ч сонгох боломж хүнд байдаггүй. Бүтээгчийн урьдчилсан төлөвлөлт, Түүний удирдамж байгаагүй бол энэ дэлхийд шинээр төрсөн амь хаашаа явах, хаана байхаа мэдэхгүй, ямар ч хамаарал байхгүй, хаана ч хамаардаггүй, жинхэнэ орон гэргүй байх байсан. Харин Бүтээгч нямбайлан зохицуулсан учраас энэхүү шинэ амь байрлах газар, эцэг эх, харьяалагдах газартай, хамаатан садантай байдаг, тийнхүү тэрхүү амь амьдралын замналаа эхэлдэг. Энэхүү үйл явцын туршид, энэхүү шинэ амь бүрэлдэн бий болохыг Бүтээгчийн төлөвлөгөө тодорхойлдог бөгөөд түүний эзэмших бүх зүйлийг Бүтээгч түүнд хайрладаг. Энэ нь өөрийн гэх юу ч үгүй хөвөгч бие байснаа бодож, амьсгалж, халуун хүйтнийг мэдэрдэг; материаллаг ертөнц дээрх бүтээгдсэн зүйлийн бүх ердийн үйл ажиллагаанд оролцож чаддаг; бүтээгдсэн хүний амьдралдаа туулах учиртай бүх зүйлийг амсаж туулах Бурханы бүтээлүүдийн нэг, мах цуснаас бүрдсэн, нүдэнд үзэгдэх, гарт баригдах хүмүүн аажмаар болдог. Хүний төрөлтийг Бүтээгч урьдаас тодорхойлно гэдэг нь амьдрахад шаардлагатай бүх зүйлийг тухайн хүнд хайрлана гэсэн үг юм; үүний нэгэн адил, хүн төрнө гэдэг нь амьдрахад шаардлагатай бүх зүйлийг тэр Бүтээгчээс хүлээн авч, тэр мөчөөс эхлээд Бүтээгчээс хангаж өгсөн өөр хэлбэрт, Бүтээгчийн дээд эрхэд захирагдан амьдарна гэсэн үг юм.

2) Яагаад өөр өөр хүмүүс өөр өөр нөхцөлд төрдөг вэ

Хэрвээ тэд дахиж төрвөл алдар цуутай гэр бүлд төрөх байсан; хэрвээ эмэгтэй байсан бол Цасан цагаан шиг харагддаг, хүн бүрийн хайрыг татах байсан, хэрвээ эрэгтэй байсан бол юугаар ч гачигддаггүй, хорвоо бүхэлдээ далайсан газар нь далд орж, далласан газар нь ил гардаг Царайлаг ханхүү байх байсан гэж хүмүүс ихэвчлэн төсөөлөх дуртай байдаг. Өөрсдийн төрөлтийн талаар олон төөрөгдөл тээж амьдардаг, төрсөндөө сэтгэл дундуур байдаг, гэр бүл, дүр төрх, хүйс, тэр ч бүү хэл төрсөн цаг хугацаандаа хүртэл дургүйцдэг хүмүүс байх нь олонтоо. Гэсэн ч яагаад тухайн гэр бүлд төрснөө, яагаад тийм харагддагаа хүмүүс хэзээ ч ойлгодоггүй. Тэд хаана төрсөн, ямар харагддагаас үл хамааран Бүтээгчийн удирдлага дор олон янзын үүрэг гүйцэтгэж, өөр өөр даалгавар биелүүлэх ёстой бөгөөд энэхүү зорилго хэзээ ч өөрчлөгдөхгүй гэдгийг мэддэггүй. Бүтээгчийн нүдээр бол хүний төрсөн газар, хүйс, дүр төрх зэрэг нь бүгд түр зуурын зүйлс юм. Тэдгээр нь, Түүний бүхий л хүн төрөлхтнийг удирдах үе шат болгон дахь дараалсан өчүүхэн тэмдэглэл, бяцхан ялгах тэмдэг юм. Хүний бодит хүрэх газар болон төгсгөлийг ямар ч тодорхой үе шатанд түүний төрөлт тодорхойлдоггүй, харин амьдралдаа биелүүлдэг үүрэг даалгавар нь, Бүтээгчийн удирдлагын төлөвлөгөө биелэх үед түүнийг шүүх Бүтээгчийн шүүлт тодорхойлдог.

Үр дүн болгонд учир шалтгаан байдаг, учир шалтгаангүй үр дүн гэж байдаггүй гэж хэлдэг. Иймээс хүний төрөлт нь хүний өнөөгийн амьдрал болон өмнөх амьдралтай заавал холбоотой байдаг. Хүний үхэл өнөөгийн амьдралынх нь хугацааг төгсгөдөг бол хүний төрөлт нь шинэхэн мөчлөгийн эхлэл юм; хуучин мөчлөг хүний өмнөх амьдралыг төлөөлдөг бол шинэ мөчлөг нь яах аргагүй өнөөгийн амьдрал юм. Хүний төрөлт нь хүний өнгөрсөн амьдрал болон өнөөгийн амьдралтай нь холбоотой байдаг болохоор хүний төрөлттэй холбоотой байршил, гэр бүл, хүйс, дүр төрх болон өөр бусад иймэрхүү хүчин зүйл нь бүгд хүний өнгөрсөн болон одоогийн амьдралтай заавал хамаатай байдаг. Энэ нь хүний төрөлтийн хүчин зүйлд өмнөх амьдрал нь нөлөөлдөг төдийгүй, өнөөгийн амьдрал дахь хувь тавилан нь тэдгээрийг тодорхойлдог гэсэн үг бөгөөд энэ нь хүмүүсийн төрсөн янз бүрийн ялгаатай нөхцөл байдлыг тайлбарладаг: Зарим нь ядуу гэр бүлд, зарим нь баян гэр бүлд төрдөг. Нэг хэсэг нь эгэл гаралтай байхад нөгөө хэсэг нь алдар цуутай удам судартай байдаг. Зарим нь өмнөд нутагт, зарим нь хойд нутагт төрдөг. Нэг хэсэг нь элсэн цөлд, нөгөө хэсэг нь ногоон газар нутагт төрдөг. Зарим хүмүүсийн төрөлтийг баяр хөөр, инээд, баяр ёслол дагалддаг; заримынх нь уйлаан, гай гамшиг, гаслан зовлон авчирдаг. Зарим нь нандигнан хайрлагдахаар, зарим нь хогийн ургамал мэт хаягдахаар төрдөг. Нэг хэсэг нь сайхан зүс царайтай, нөгөө хэсэг нь орсгой муруй төрдөг. Зарим нь харахад дур булаам, зарим нь царай муутай байдаг. Нэг хэсэг нь шөнө дунд, нөгөө хэсэг нь үд дундын нар хурцаар шарж байхад төрдөг… Бүх төрлийн хүмүүсийн төрөлтийг тэдэнд зориулж Бүтээгчийн бэлдсэн хувь заяа тодорхойлдог; тэдний төрөлт нь тэдний өнөөгийн амьдралын

хувь заяаг, мөн түүнчлэн гүйцэтгэх үүрэг, биелүүлэх даалгаврыг нь тодорхойлдог. Энэ бүхэн нь Бүтээгчийн дээд эрхэд захирагддаг, Түүгээр урьдчилан тогтоогдсон байдаг; хэн ч нэгэнт тогтоогдсон хувь зохиолоосоо зугтаж чадахгүй, хэн ч өөрсдийн төрөлтийг өөрчилж, хувь заяагаа сонгож чадахгүй.

Хоёр дахь онцгой үе: Өсөж торних

Ямар айлд төрснөөс хамааранд хүмүүс гэр бүлийн өөр өөр орчинд өсөж, эцэг эхээсээ өөр өөр зүйл суралцдаг. Эдгээр хүчин зүйл нь хүний өсөж том болох нөхцөлийг тодорхойлдог бөгөөд өсөж торних нь хүний амьдралын хоёр дахь шийдвэрлэх онцгой үеийг төлөөлдөг. Энэхүү онцгой үе дээр хүмүүст мөн л ямар ч сонголт байдаггүй гэдгийг хэлэх нь илүүц биз ээ. Үүнийг мөн л урьдаас тогтоож, зохицуулсан байдаг.

1) Хүн болгоны өсөж том болох тогтсон нөхцөл байдлыг Бүтээгч төлөвлөсөн

Өсөж торниход нь сургамж болж, нөлөөлөх хүмүүс, үйл явдал, юмсыг хүн сонгож чадахгүй. Хүн ямар мэдлэг, ур чадвар олж авах, ямар зуршилтай болохоо сонгож чадахгүй. Өөрийнх нь эцэг эх, хамаатан садан хэн байх, ямар орчинд өсөхөө хүн шийдэж чадахгүй; эргэн тойрныхоо хүмүүс, үйл явдал, юмстай харилцах хүний харилцаа, тэдгээр нь түүний хөгжилд хэрхэн нөлөөлдөг нь бүгд хүний хяналтаас гадуур байдаг. Тэгвэл эдгээр зүйлийг хэн шийддэг вэ? Хэн тэдгээрийг зохицуулдаг вэ? Энэ асуудал дээр хүмүүст ямар ч сонголт байдаггүй, тэд эдгээр зүйлийг өөрсдөө шийдэж чаддаггүй, мөн тэдгээр нь мэдээжээр аяндаа бүрэлддэггүй болохоор, энэ бүх хүн, үйл явдал, юмсын бүрэлдэх эсэх нь Бүтээгчийн гарт байдаг нь ярангүй. Бүтээгч нь хүн бүрийн төрөлтийн онцгой нөхцөл байдлыг зохицуулдаг шигээ хүний өсөж том болох тодорхой нөхцөл байдлыг мөн зохицуулдаг гэдэг нь мэдээжийн хэрэг. Хэрвээ хүний төрөлт нь эргэн тойрных нь хүмүүс, үйл явдал, юмст өөрчлөлт авчирдаг юм бол тухайн хүний өсөлт, хөгжил ч мөн тэдгээрт зайлшгүй нөлөөлөх болно. Жишээлбэл, зарим хүн ядуу гэр бүлд төрдөг боловч эд баялгаар хүрээлүүлэн өсдөг; зарим нь чинээлэг гэр бүлд төрдөг боловч гэр бүлийнхээ хөрөнгийг барж, улмаар ядуу орчинд өсдөг. Хэний ч төрөлт тогтсон дүрэм журамд захирагддаггүй бөгөөд зайлшгүй, тогтсон нөхцөл байдалд өсөж торнидог хэн ч үгүй. Эдгээр нь хүний төсөөлж, хянаж чадах зүйлс биш; тэдгээр нь хүний хувь заяаны үр дүн бөгөөд хүний хувь заяагаар тодорхойлогддог. Мэдээж, хүн болгонд зориулан Бүтээгчийн урьдаас тогтоосон хувь заяа эцсийн дүндээ эдгээр зүйлийг тодорхойлдог; тухайн хүний хувь заяаг захирдаг Бүтээгчийн дээд эрх болон төлөвлөгөө тэдгээрийг тодорхойлдог.

2) Хүмүүсийн өсөж торнидог янз бүрийн нөхцөл байдал нь өөр өөр үүргийг бий болгодог

Хүний төрөлтийн нөхцөл байдал нь түүний өсөж торних орчин, нөхцөлийг энгийн түвшинд тогтоодог бөгөөд хүний өсөж торнидог нөхцөл байдал нь мөн л

түүний төрөлтийн нөхцөл байдлын үр дүн юм. Энэ хугацаанд хүн хэл сурч эхэлдэг, хүний ухаан ухаан олон шинэ зүйлтэй тулгарч, ойлгож өөрийн болгож эхлэх явцдаа хүн үргэлж өсөж байдаг. Хүний чихээрээ сонсож, нүдээрээ харж, оюун ухаанаараа ойлгож авдаг зүйлс нь хүний дотоод ертөнцийг аажмаар дүүргэж, сэргээдэг. Хүнтэй тааралддаг хүмүүс, үйл явдал, юмс; хүний суралцдаг эрүүл ухаан, мэдлэг, ур чадвар; хүнд нөлөөлж, хүнийг үнэмшүүлж, хүнд зааж сургадаг сэтгэлгээний арга барил нь бүгд хүний амьдралын хувь заяаг залж чиглүүлж, нөлөөлөх болно. Өсөхдөө сурдаг хэл болон сэтгэлгээний арга барил нь хүний залуу насаа өнгөрүүлдэг орчинтой салшгүй холбоотой, тэрхүү орчин нь эцэг эх, ах дүүс болон тэдний эргэн тойрны бусад хүн, үйл явдал, юмсаас бүрддэг. Иймээс хүний хөгжлийн замналыг түүний өссөн орчин тодорхойлдог, энэ хугацаанд тааралддаг хүмүүс, үйл явдал, юмсаас мөн хамаардаг. Хүний өсөж торних нөхцөл байдлыг аль эрт урьдаас тодорхойлсон байдаг болохоор энэ үйл явцын үеэр амьдрах орчныг ч гэсэн бас л угийн урьдаас тодорхойлсон байдаг. Хүн сонгож, шилснээр энэ нь шийдэгдэхгүй, харин Бүтээгчийн төлөвлөгөөний дагуу Бүтээгчийн нямбай зохицуулалтаар, хүний амьдралын хувь заяаг захирах Бүтээгчийн дээд эрхээр тодорхойлогдож, шийдэгддэг. Иймээс өсөж том болох явцдаа аливаа хүний уулзсан хүмүүс, тааралдсан юмс бүгд угийн Бүтээгчийн зохион байгуулалт, зохицуулалттай холбоотой байдаг. Хүмүүс ийм адармаатай холбоо хамаарлыг урьдаас харж чадахгүй, мөн тэд тэдгээрийг хянаж, ойлгож ч чадахгүй. Хүний өсөж торних орчинд олон янзын хүн, юмс нөлөөлдөг бөгөөд ямар ч хүн хэлхээ холбооны ийм асар том сүлжээг зохицуулж, зохион байгуулах чадахгүй. Бүх хүн, үйл явдал юмс бий болохыг Бүтээгчээс өөр ямар ч хүн, ямар ч зүйл хянаж чадахгүй, тэдгээрийн оршин байж, үгүй болохыг ч бас тэд хянаж чадахгүй, энэ бол Бүтээгчийн урьдчилан тогтоосноор хүний хөгжлийг төлөвшүүлж, хүмүүсийн өсөж торних янз бүрийн орчныг байгуулдаг хэлхээ холбооны асар том сүлжээ юм. Бүтээгчийн удирдлагын ажилд шаардлагатай янз бүрийн үүргийг бий болгож, үүрэг даалгавраа амжилттай биелүүлэх найдвартай бат бөх суурийг хүмүүст тавьж өгдөг зүйл нь энэ билээ.

Гурав дахь онцгой үе: Биеэ даах

Хүн бага нас, өсвөр насыг өнгөрөөгөөд аажмаар, өөрийн эрхгүй нас биед хүрсний дараа залуу настайгаа бүрмөсөн салах ёс хийж, эцэг эхдээ баяртай гэж хэлээд, урдах замаа бие даасан насанд хүрэгчийн хувиар угтах нь түүний хийх дараагийн алхам билээ. Энэ үед тэд насанд хүрэгчийн нүүр тулах ёстой бүх хүн, үйл явдал, юмстай тулгарч, удалгүй тохиох хувь заяаныхаа бүх талтай нүүр тулах ёстой. Энэ нь хүний туулж өнгөрөх ёстой гурав дахь онцгой үе юм.

1) Биеэ даасныхаа дараа хүн Бүтээгчийн дээд эрхийг мэдэрч эхэлдэг

Төрж, өсөх нь хүний амьдралын замналын “бэлтгэл үе” болж, хувь заяаных нь тулганы чулууг тавьдаг бол биеэ даах нь хүний амьдралын хувь заяаны нээлтийн монологи юм. Хэрвээ төрж, өсөх нь амьдралын хувь заяандаа бэлдэж хураасан эд

баялаг бол, биеэ даах нь хүн тэрхүү эд хөрөнгөө үрж, эсвэл нэмэгдүүлж эхлэх үе юм. Хүн эцэг эхээ орхин явж, биеэ даах үед түүнд тулгарах нийгмийн нөхцөл байдал болон түүнд олдох ажил, мэргэжлийн замналын аль алиныг нь хувь заяа шийддэг бөгөөд эцэг эх нь үүнд ямар ч хамаагүй. Зарим хүн коллежид сайн мэргэжил сонгож, сургуулиа төгсөөд сэтгэлдээ нийцсэн ажил олж, амьдралынхаа аянд анхныхаа ялгуусан алхмыг хийдэг. Зарим хүн олон янзын ур чадвар сурч, эзэмшдэг боловч ажил мэргэжлийн замналтай болох нь бүү хэл өөртөө тохирох ажил, байр сууриа хэзээ ч олдоггүй; тэд амьдралын замналынхаа эхэнд алхам бүрдээ бүтэлгүйтэж, хүндрэл бэрхшээлээр хүрээлэгдэж, ирээдүй нь бүрхэг, амьдрал нь тодорхойгүй байдалд ордог. Зарим хүн хичээл номдоо чармайн суралцдаг боловч, өндөр боловсрол олж авах боломж болгоныг ам мөлтөс алддаг; тэд хэзээ ч амжилтад хүрч чадахааргүй тавилантай мэт санагдаж, амьдралын аяны хамгийн анхны хүсэл тэмүүлэл нь ул мөргүй замхран алга болдог. Урдах зам нь бартаатай эсэхийг мэдэхгүй тэд, хүний хувь тавилан хувьсагчаар дүүрэн болохыг анх удаа мэдэрдэг учраас горьдлого болон айдастайгаар амьдралд ханддаг. Зарим хүн тийм ч сайн боловсрол эзэмшээгүй ч ном бичиж, тодорхой хэмжээний алдар нэрд хүрдэг; харин зарим нь бараг бичиг үсэгт тайлагдаагүй ч бизнес хийн мөнгө олж, өөрсдийгөө авч явдаг… Хүн ямар мэргэжил сонгох, хэрхэн амь зуух тухайд: сайн, эсвэл муу сонголт хийх эсэхээ хүмүүс хянаж чадах уу? Эдгээр зүйл нь хүмүүсийн хүсэл, шийдвэрээр болдог уу? Ихэнх хүмүүс бага ажиллаж, их мөнгө олж, нар, бороонд хүнд хүчир ажил хийхгүй, сайхан хувцаслаж, хаа сайгүй гялалзан гэрэлтэж, бусдаас илүү гарч, өвөг дээдэстээ нэр төр авчрах хүсэлтэй байдаг. Хүмүүс төгс зүйлийг хүсэж найддаг боловч амьдралын аянд эхний алхмаа хийхдээ, хүний хувь тавилан хэчнээн төгс бус болохыг аажмаар ухаардаг бөгөөд хэдийгээр хүн ирээдүйнхээ төлөө зоримог төлөвлөгөө гаргаж, зоригтой төсөөлөл өвөрлөж болох боловч мөрөөдлөө биелүүлэх чадвар, эрх мэдэл хэнд ч байхгүй, хэн ч ирээдүйгээ хянаж чадахгүй гэдэг бодит үнэнийг тэд анх удаагаа үнэхээр ухаарч ойлгодог. Хүний мөрөөдөл болон нүүр тулах ёстой бодит байдал хоёр хоорондоо үргэлж бага зэрэг зайтай байх болно; аливаа зүйл хэзээ ч хүний хүссэнээр байдаггүй, ийм бодит байдалтай нүүр тулсан хүмүүс хэзээ ч сэтгэл ханаж, сэтгэл хангалуун болж чадахгүй. Зарим хүн хувь заяагаа өөрчлөх гэж оролдохдоо төсөөлж болох юуг ч хийхээс буцахгүй, ахуй амьдрал, ирээдүйнхээ төлөө маш их хүчин чармайлт гаргаж, ихийг золиосолно. Гэвч эцэст нь, шаргуу ажиллах замаар хүсэл, мөрөөдлөө биелүүлж чадлаа ч гэсэн тэд хувь заяагаа хэзээ ч өөрчилж чадахгүй, хэчнээн цөхрөлтгүй хичээх нь хамаагүй, хувь тавилангийн оноосон зүйлээс илүү гарч хэзээ ч чадахгүй. Том, жижиг, өндөр нам, өргөмжлөгдсөн, эсвэл олхиогүй зантайг хооронд нь огт ялгадаггүй хувь заяаны өмнө хүмүүс, ур чадвар, оюуны чадамж, сэтгэлийн тэнхээний ялгааг үл харгалзан бүгд эн тэнцүү байдаг. Хүн ямар ажил мэргэжил эрхлэх, амьдрахын тулд юу хийх, амьдралдаа хэр их эд баялаг хураахыг хүний эцэг эх, авьяас чадвар, хичээл зүтгэл, хүсэл эрмэлзэл шийддэггүй, харин Бүтээгч урьдчилан тодорхойлдог юм.

2) Эцэг эхээ орхин явж, амьдралын театрт жинхэнээсээ дүрдээ орж тоглож эхлэх нь

Хүн нас биед хүрээд эцэг эхээ орхин явж, өөрөө биеэ дааж эхэлж чаддаг бөгөөд энэ үед хүн үнэхээр өөрийн үүргийг гүйцэтгэж эхлэн, манан арилж, хүний амьдрал дахь үүрэг даалгавар нь аажмаар тодорхой болдог. Хүн эцэг эхтэйгээ ойр холбоотой хэвээр байдаг нэртэй боловч хүний үүрэг даалгавар болон амьдралдаа биелүүлэх үүрэг нь эцэг эхтэй нь ямар ч хамаагүй учраас хүн аажмаар биеэ даах явцад энэхүү дотно холбоо нь бодит байдал дээр алгуурхан тасардаг. Биологийн өнцгөөс авч үзвэл, хүмүүс далд ухамсартаа эцэг эхээсээ хамааралтай хэвээр байхаас өөр аргагүй боловч, бодитоор яривал, өсөж том болмогцоо эцэг эхээсээ бүрмөсөн тусдаа амьдралтай болж, хүлээсэн үүргээ бие даан биелүүлэх болно. Хүүхдүүдийнхээ амьдралд эцэг эхийн хүлээх үүрэг хариуцлага бол төрүүлж, өсгөж хүмүүжүүлэхээс гадна хэлбэр дүрсээрээ өсөж том болоход нь тохирсон орчноор л хангах явдал байдаг, учир нь Бүтээгчийн урьдчилан тогтоосноос өөр юу ч хүний хувь заяанд нөлөөлдөггүй билээ. Хүний ирээдүй ямар байхыг хэн ч хянаж чадахгүй; үүнийг аль хэдийн урьдчилан тодорхойлсон байдаг бөгөөд эцэг эх нь хүртэл хүний хувь заяаг өөрчилж чадахгүй. Хувь заяаны тухайд гэвэл, хүн бүхэн биеэ даасан байдаг, хүн бүхэнд өөрийн гэсэн хувь заяа байдаг. Иймээс хэний ч эцэг эх хүний амьдралын хувь заяанд саад хийж, эсвэл амьдралд гүйцэтгэх үүрэгт нь өчүүхэн төдий ч нөлөө үзүүлж чадахгүй. Хүний төрөхөөр заяагдсан гэр бүл, өсөж том болох орчин нь тухайн хүний амьдралын даалгавраа биелүүлэх урьдач нөхцөлөөс өөр юу ч биш гэж хэлж болно. Тэдгээр нь хүний амьдралын хувь заяаг, эсвэл ямар тавиланд хүн даалгавраа биелүүлэхийг тодорхойлж яавч чадахгүй. Иймээс хэний ч эцэг эх амьдралд даалгавраа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж чадахгүй, үүний адил амьдралд үүргээ хүлээн авахад нь хэний ч хамаатан садан тусалж чадахгүй. Хүн даалгавраа хэрхэн гүйцэтгэх, ямар амьдрах орчинд үүргээ биелүүлэх нь бүхэлдээ хүний амьдралын хувь заяагаар тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл, Бүтээгчийн урьдчилан тогтоосон хүний даалгаварт өөр ямар ч объектив нөхцөл нөлөөлж чадахгүй. Бүх хүн өөрсдийн өсөж том болох тэр орчиндоо нас биед хүрдэг; дараа нь тэд аажмаар, алхам алхмаар амьдралын замдаа гарч, өөрсдөд нь зориулан Бүтээгчийн төлөвлөсөн хувь тавилангаа биелүүлдэг. Тэд аяндаа, өөрийн эрхгүй өргөн уудам далай шиг их хүний дунд орж, амьдралынхаа байр суурийг эзэлж, Бүтээгчийн тогтоосон тавилан, Түүний дээд эрхийн төлөө, бүтээгдсэн зүйлийн үүрэг хариуцлагаа биелүүлж эхэлдэг.

Дөрөв дэх онцгой үе: Гэрлэлт

Хүн өсөж том болон, насанд хүрэх үедээ эцэг эхээсээ, төрж, өссөн орчноосоо улам холдож, оронд нь амьдралын зүг чигийг эрж хайн, эцэг эхийнхээ хэв маягаас өөр, өөрийн гэсэн амьдралын зорилгыг хөөж эхэлдэг. Энэ үед хүнд цаашид эцэг эх нь биш, харин амьдралаа хамт туулж чадах хань ижил буюу эхнэр, нөхөр, хувь заяа

нь нягт холбогдсон хүн хэрэгтэй байдаг. Тиймээс биеэ даасны дараах хамгийн анхны томоохон үйл явдал буюу хүний туулж өнгөрөх ёстой дөрөв дэх онцгой үе нь гэрлэлт юм.

1) Гэрлэлтэд хувь хүний сонголт хамаарахгүй

Ямар ч хүний амьдралд гэрлэлт бол гол үйл явдал юм; хүн энэ үед л үнэхээр олон янзын үүрэг хариуцлага үүрч, олон янзын даалгаврыг аажмаар хэрэгжүүлж эхэлдэг. Хүмүүс өөрсдөө биеэрээ үзэж туулахаасаа өмнө гэрлэлтийн талаар олон төөрөгдөлтэй байдаг бөгөөд энэ бүгд нь тун сайхан төөрөгдөл юм. Эмэгтэйчүүд хань ижлээ Царайлаг ханхүү байх болно гэж төсөөлдөг бөгөөд эрчүүд өөрсдийгөө Цасан гуатай гэрлэнэ гэж төсөөлдөг. Хүн бүр гэрлэлтэд тавих тодорхой болзол, өөрсдийн гэсэн шаардлага, стандарттай байдаг гэдгийг эдгээр хоосон төсөөлөл харуулж байдаг. Хэдийгээр энэ хорон муу эрин үед хүмүүс гэрлэлтийн талаар мушгин гуйвуулсан мэдээгээр байнга бөмбөгдүүлж, энэ нь бүр олон нэмэлт болзол бий болгож, хүмүүст бүхий л байдлаар дарамт болж, хачин хандлагатай болгодог боловч хүн үүнийг хэрхэн ойлгож, яаж хандах нь хамаагүй, гэрлэлт бол хувь хүний сонгох хэрэг биш гэдгийг гэрлэж үзсэн ямар ч хүн мэднэ.

Хүн амьдралдаа олон хүнтэй тааралддаг боловч хэн өөрийнх нь хань ижил болохыг хэн ч мэддэггүй. Хэдийгээр хүн болгон гэрлэлтийн тал дээр өөрийн гэсэн санаа бодол, хувийн байр суурьтай байдаг боловч эцэст нь хэн үнэхээр нэгэн биеийнх нь нөгөө тал болохыг хэн ч урьдаас харж чадахгүй, хүний санаснаар болох нь бараг үгүй. Таалагдсан хүнтэйгээ танилцаны дараа чи тэр хүний араас хөөцөлдөж болно; гэхдээ тэр чамайг сонирхох эсэх, чиний хань ижил болж чадах эсэх нь чиний шийдэх зүйл биш. Хайрыг чинь татсан хүн амьдралаа хуваалцаж чадах хүн чинь байх албагүй; гэтэл чиний хэзээ ч хүлээж байгаагүй хүн амьдралд чинь чимээгүйхэн орж ирээд хань ижил чинь, хувь заяаны чинь хамгийн чухал хэсэг, нэгэн биеийн чинь нөгөө тал болж, хувь заяа чинь түүнтэй адармаатайгаар холбогддог. Иймээс хэдийгээр дэлхий дээр сая сая гэрлэлт байдаг ч бүгд хоорондоо ялгаатай: Маш олон гэрлэлт сэтгэл ханамжтай биш, маш олон нь аз жаргалтай байдаг; маш олон нь Зүүн, Барууныг холбож, маш олон нь Умард, Өмнөдийг холбодог; маш олон нь төгс тохирсон, маш олон нь нийгмийн ижил зиндааных байдаг; маш олон нь аз жаргал, эвтэй найртай, маш олон нь зовлон, гунигтай байдаг; маш олон нь бусдын атаархлыг төрүүлж, маш олон нь буруу ойлголт, дургүйцлийг төрүүлдэг; маш олон нь баяр хөөрөөр дүүрэн, маш олон нь нулимсанд автаж, цөхрөл авчирдаг билээ… Эдгээр тоо томшгүй олон гэрлэлтээр хүмүүс үнэнч байдал, гэрлэлтэд насан туршдаа үнэнч байхаа харуулдаг; тэд хайр, дассан сэтгэл, салж хагацашгүй байдал, хүлцэнгүй байдал, үл ойлголцлыг харуулдаг. Зарим нь гэрлэлтээсээ урваж, бүр үзэн яддаг. Гэрлэлт аз жаргал, зовлон шаналал авчрахын аль нь ч бай, хүн бүрийн гэрлэлтийн даалгаврыг Бүтээгч урьдчилан тогтоодог бөгөөд энэ нь өөрчлөгдөхгүй; энэ бол хүн бүрийн биелүүлэх

ёстой даалгавар юм. Гэрлэлт бүрийн цаана байх хүний бүрийн хувь заяа өөрчлөгдөшгүй, үүнийг Бүтээгч аль эрт урьдаас тодорхойлсон байдаг.

2) Гэрлэлт хань ижлүүдийн хоёулынх нь хувь заяанаас төрдөг

Гэрлэлт бол хүний амьдралын чухал онцгой үе юм. Энэ нь хүний хувь заяаны үр дүн, хувь заяаных нь шийдвэрлэх холбоос юм; энэ нь аливаа хүний хувийн хүсэл зориг, шилж сонгох дээр үндэслэдэггүй бөгөөд ямар ч гадаад хүчин зүйлс нөлөөлдөггүй, харин энэ нь хоёр талын хувь заяагаар, тэр хосын хоёулынх нь хувь заяаг Бүтээгчийн зохицуулж, урьдчилан тодорхойлсноор бүрэн тодорхойлогддог. Өнгөн дээрээ гэрлэлт нь хүний удам угсааг үргэлжлүүлэх зорилготой боловч үнэндээ гэрлэлт бол даалгавраа биелүүлэх явцад хүний туулдаг зан үйлээс өөр юу ч биш. Гэрлэлтээр хүмүүс зүгээр нэг дараагийн үеэ өсгөж хүмүүжүүлэх үүргээ биелүүлсэн төдий болдог юм биш; тэд гэрлэлтээ хадгалахтай хамаатай төрөл бүрийн үүрэг, тэдгээр үүргийг гүйцэтгэхийг шаарддаг даалгаврууды сонгон авдаг. Хүний төрөлт эргэн тойрных нь хүмүүс, үйл явдал, юмсын өөрчлөлтөд нөлөөлдөг болохоор хүний гэрлэлт ч бас эдгээр хүн, үйл явдал, юмст гарцаагүй нөлөөлж, улмаар тэдгээрийг бүгдийг нь янз бүрийн байдлаар өөрчлөх болно.

Хүн биеэ даахаараа, гэрлэлттэй нь холбоотой хүмүүс, үйл явдал, юмс руу алхам алхмаар хөтөлдөг өөрийн гэсэн амьдралын замналаа эхэлдэг. Үүний зэрэгцээ, тэрхүү гэрлэлтийн нөгөө хүн нь яг тэр хүмүүс, үйл явдал, юмс руу алхам алхмаар дөхөж байдаг. Бүтээгчийн дээд эрхийн дор хувь заяа нь холбоотой, хамааралгүй хоёр хүн аажмаар нэгэн гэрлэлтээр нэгдэж, гайхамшигтай байдлаар гэр бүл: “нэг уяанаас зуурсан хоёр царцаа” болдог. Иймээс, гэрлэх үед хүний амьдралын замнал нэгэн биеийнх нь нөгөө талд нөлөөлж, хөндөн, үүний нэгэн адилаар ханийнх нь амьдралын замнал эргээд өөрийнх нь амьдралын хувь заяанд нь нөлөөлж, хөндөх болно. Өөрөөр хэлбэл, хүмүүний хувь заяа хоорондоо холбогдсон байдаг бөгөөд хэн ч бусдаас тусдаа бүрэн бие даан амьдралын даалгавраа биелүүлж, үүргээ гүйцэтгэж чадахгүй. Хүний төрөлт харилцааны асар том гинжин хэлхээнд нөлөөлдөг; өсөж торних нь мөн л харилцааны нарийн төвөгтэй гинжин хэлхээтэй хамаатай; үүний адилаар гэрлэлт нь хүний харилцаа холбооны өргөн уудам, нарийн төвөгтэй сүлжээн дотор гарцаагүй оршиж, байж, тэрхүү сүлжээний гишүүн бүрийг оролцуулан, түүний нэг хэсэг нь болох хүн бүрийн хувь заяанд нөлөөлж байдаг. Гэрлэлт бол хоёр гишүүний гэр бүл, тэдний өссөн нөхцөл байдал, дүр төрх, нас, яс чанар, авьяас чадвар, аливаа өөр бусад хүчин зүйлийн үр дүн биш; харин ч энэ нь хамтын даалгавар болон хувь заяаны хамаарлаас үүсдэг. Бүтээгчийн зохион байгуулж, зохицуулсан хүмүүний хувь заяаны бүтээгдэхүүн, гэрлэлтийн эх үүсвэр энэ билээ.

Тав дахь онцгой үе: Үр удам

Гэрлэснийхээ дараа хүн дараагийн үеэ өсгөн хүмүүжүүлж эхэлнэ. Хэдэн хүүхэдтэй, ямар хүүхэдтэй болохоо хүн шийдэж чадахгүй; үүнийг мөн л Бүтээгчийн

урьдчилан тогтоосон хүний хувь заяагаар тодорхойлдог. Энэ бол хүний туулж өнгөрөх ёстой тав дахь онцгой үе юм.

Хэрвээ хүн хэн нэгний хүүхдийн үүргийг гүйцэтгэхээр төрсөн бол хэн нэгний эцэг эхийн үүргийг биелүүлэхээр дараагийн үеийг өсгөн хүмүүжүүлдэг. Үүргийн энэхүү шилжилт нь хүнийг, амьдралын өөр өөр үеийг өөр өөр өнцгөөс туулахад хүргэдэг. Мөн энэ нь амьдралын өөр өөр цогц туршлагыг хүнд өгч, үүгээр хүн үргэлж нэг л байдлаар тунхагладаг Бүтээгчийн дээд эрхийг мэдэж авч, үүгээр хүн Бүтээгчийн урьдчилан тогтоосныг хэн ч даван гарч, эсвэл өөрчилж чадахгүй гэсэн бодит үнэнтэй нүүр тулдаг.

1) Хүний үр хүүхэд ямар болохыг хэн ч хянах боломжгүй

Төрж, өсөж, гэрлэх нь бүгд төрөл бүрээр, янз бүрийн хэмжээгээр гонсойлгодог. Зарим хүн гэр бүлдээ, эсвэл гадаад үзэмждээ сэтгэл хангалуун бус байдаг; зарим нь эцэг эхдээ дургүй; зарим нь өссөн орчиндоо дургүйцэж, гомдоллодог. Ихэнх хүний хувьд, энэ бүх гонсойлгосон зүйлийн дундаас гэрлэлт нь хамгийн сэтгэл дундуур байдаг зүйл юм. Хүн өөрийн төрөлт, өсөлт, гэрлэлтдээ хэчнээн сэтгэл дундуур байсан ч гэсэн хаана, хэзээ төрөх, ямар харагдах, эцэг эх нь хэн байх, хань ижил нь хэн байхыг сонгож чадахгүй, харин зүгээр л Тэнгэрийн хүслийг хүлээн зөвшөөрөх ёстой гэдгийг үүнийг туулсан хүн бүр мэддэг. Гэхдээ дараагийн үеэ өсгөж хүмүүжүүлэх цаг ирэхэд амьдралынхаа эхний хагаст биелүүлж чадаагүй бүх хүслийг үр удамдаа даатгаж, амьдралынхаа эхний хагасын бүх гонсойлтыг нь үр хүүхэд нь нөхнө байх гэж найдах болно. Иймээс хүмүүс охид нь гайхам үзэсгэлэнтэй эмэгтэй, хөвгүүд нь золбоолог эр хүн; охид нь боловсролтой, авьяаслаг, хөвгүүд нь гялалзсан сурагч, шилдэг тамирчин; охид нь дөлгөөн, журамтай, ухаалаг, хөвгүүд нь ухаантай, чадамгай, өр нимгэн байх болно гэх мэтээр хүүхдүүдийнхээ талаар зүсэн зүйлийн хоосон төсөөлөлд автдаг. Үр хүүхэд нь охин ч бай, хүү ч бай ахмадаа хүндэлж, эцэг эхдээ санаа тавьж, бүх хүнээр хайрлуулж, магтуулах болно гэж тэд найддаг… Энэ үед амьдралын төлөөх найдвар шинээр ундарч, хүмүүсийн зүрх сэтгэлд шинэ хүсэл тэмүүлэл асдаг. Энэ амьдралд тэд хүчин мөхөс агаад найдлагагүй болсон, бусдаас онцгойрох өөр боломж, өөр найдвар тэдэнд байхгүй, хувь заяагаа хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй гэдгийг хүмүүс мэддэг. Иймээс тэд бүх найдвар, биелээгүй хүслээ дараагийн үедээ даатгаж, мөрөөдөлдөө хүрч, хүслээ биелүүлэхэд үр хүүхэд нь тэдэнд тусалж чадна; охид, хөвгүүд нь гэр бүлийнхээ нэрд алдар суу авчирч, чухал, баян, алдартай хүн болно гэж найддаг. Товчхондоо, тэд хүүхдүүдийнх нь аз хийморь өндөрт цойлж байгааг харахыг хүсдэг. Хүмүүсийн төлөвлөгөө, хоосон төсөөлөл төгс байдаг; хэдэн хүүхэдтэй болох, хүүхдүүдийнх нь дүр төрх, ур чадвар гэх мэт нь тэдний шийдэх зүйл биш, хүүхдүүдийнх нь хувь заяа тэдний гарт огтхон ч байдаггүй гэдгийг тэд мэддэггүй гэж үү? Хүмүүс хувь заяаныхаа эзэд нь биш атлаа залуу үеийнхээ хувь заяаг өөрчилнө гэж найддаг; тэд хувь заяанаасаа зугтах

аргагүй байдаг атлаа охид, хөвгүүдийнхээ хувь заяаг хянах гэж хичээдэг. Тэд өөрсдийгөө хэтэрхий өндөр үнэлж байгаа бус уу? Хүний мунхаглал, харанхуй бүдүүлэг байдал энэ бус уу? Хүмүүс үр хүүхдүүдийнхээ төлөө юу ч хийхээс буцахгүй боловч эцсийн эцэст, хэдэн хүүхэдтэй болох, тэр хүүхдүүд нь ямар байх нь хүний төлөвлөж, хүссэнээр болохгүй. Зарим хүн сохор зоосгүй ч олон хүүхэд төрүүлдэг; зарим хүн чинээлэг боловч нэг ч хүүхэдгүй байдаг. Зарим нь охинтой болохыг хүсдэг ч тэр хүсэл нь бүтдэггүй; зарим нь хүү хүсдэг ч хүүтэй болж чаддаггүй. Зарим хүний хувьд хүүхдүүд бол ерөөл; өөр бусдын хувьд тэд бол хараал юм. Зарим хос хурц ухаантай ч ухаан муутай хүүхдүүд төрүүлдэг; зарим эцэг эх хөдөлмөрч, үнэнч шударга байдаг ч өсгөсөн хүүхдүүд нь залхуу хойрго байдаг. Зарим эцэг эх сайхан сэтгэлтэй, шулуун шударга боловч хүүхдүүд нь зальтай, хорон байдаг. Зарим эцэг эх оюун санаа, бие бялдрын хувьд эрүүл саруул ч тахир дутуу хүүхэд төрүүлэх нь бий. Зарим эцэг эх жирийн, амжилт олоогүй ч асар их зүйлд хүрсэн хүүхдүүдтэй байдаг. Зарим эцэг эх доод зиндааных ч өндөр зиндаанд хүрсэн хүүхдүүдтэй байдаг…

2) Дараагийн үеэ өсгөн хүмүүжүүлсний дараа хүмүүс хувь заяаны талаар шинэ ойлголт олж авдаг

Ихэнх хүн гуч орчим насандаа, хүний хувь заяаны талаар ямар ч ойлголтгүй байх амьдралын энэ үедээ гэрлэдэг. Гэхдээ хүмүүс хүүхдүүдээ өсгөж эхлээд, үр хүүхдүүд нь том болохын хэрээр шинэ үеийнхэн нь өмнөх үеийнхний амьдрал болон бүх туршлагыг давтаж байгааг хардаг бөгөөд өнгөрсөн амьдралаа тэднээс олж үзээд, залуу үеийн алхаж байгаа замыг яг л өөрсдийнх шиг нь төлөвлөж, сонгож болдоггүй юм байна гэдгийг ухаардаг. Энэ бодит үнэнтэй тулгарсан тэд хүн бүрийн хувь заяаг урьдчилан тогтоосон байдгийг зөвшөөрөхөөс өөр аргагүй болдог бөгөөд өөрийн мэдэлгүйгээр өөрсдийн хүслийг аажмаар хойш тавьж, зүрх сэтгэл дэх дэвүүн хүсэл нь бөхөж унтардаг… Энэ хугацаанд хүмүүс амьдралынхаа чухал үеүдийг үндсэндээ туулж өнгөрөөсөн байдаг болохоор, амьдралын талаар шинэ ойлголттой болж, шинэ хандлагатай болсон байдаг. Энэ насны хүн ирээдүйгээс хэр ихийг хүлээж, ямар хэтийн ирээдүйг хүсэн хүлээх ёстой вэ? Тавин настай ямар эмэгтэй Царайлаг ханхүүг мөрөөдсөөр байх юм бэ? Тавин настай ямар эр хүн Цасан гуагаа хайсаар байх юм бэ? Дунд эргэм насны ямар эмэгтэй нугасны муухай дэгдээхэй байснаа хун болно гэж найдсаар байх юм бэ? Ихэнх ахимаг насны эрэгтэй залуу эрчүүдтэй адил тушаал дэвших гэж улайрдаг уу? Дүгнэж хэлэхэд, эрэгтэй, эмэгтэй байхаас үл хамааран энэ насны ямар ч хүн гэрлэлт, гэр бүл, хүүхдүүдийн талаар харьцангуй ухаалаг, бодитой хандлагатай байх талтай. Ийм хүнд үндсэндээ ямар ч сонголт, хувь заяагаа сорих хүсэл эрмэлзэл үлдээгүй байдаг. Хүний туршлагын тухайд гэвэл, хүн энэ насанд хүрмэгцээ аяндаа “Хүн хувь заяаг хүлээн зөвшөөрөх ёстой; хүүхдүүд өөрсдийн гэсэн заяа төөрөгтэй байдаг; хүмүүний хувь заяаг Тэнгэр тодорхойлдог” гэсэн хандлагатай болдог. Үнэнийг

ойлгодоггүй ихэнх хүн энэ хорвоогийн бүхий л энхэл донхол, бүтэлгүйтэл, зовлон бэрхшээлийг даван туулсны дараа хүний амьдралын талаарх мэдлэг ухаанаа “Хувь заяа нь тэр!” гэсэн хэдхэн үгээр л нэгтгэн дүгнэх болно. Хэдийгээр энэ хэллэг нь хорвоогийн хүмүүсийн хүний хувь заяаг ухаарсан ухаарал, хүрсэн дүгнэлтийг нь товчоор илэрхийлдэг, хэдий энэ нь хүн төрөлхтний арчаагүй байдлыг илэрхийлдэг, маш гярхай агаад үнэн зөв гэж тодорхойлж болох боловч Бүтээгчийн дээд эрхийн талаарх ойлголтоос асар зөрүүтэй, Бүтээгчийн эрх мэдлийн тухай мэдлэгийг ердөө ч орлож чадахгүй.

3) Хувь заяанд итгэх нь Бүтээгчийн дээд эрхийн тухай мэдлэгийг орлохгүй

Маш олон жилийн турш Бурханыг дагасан байтлаа хувь заяаны талаарх та нарын болон хорвоогийн хүмүүсийн мэдлэгийн хооронд бодит ялгаа байна уу? Та нар Бүтээгчийн урьдчилан тодорхойлсныг үнэхээр ойлгож, Бүтээгчийн дээд эрхийг үнэхээр мэдэж авсан уу? Зарим хүн “хувь заяа нь тэр” хэмээх хэллэгийн талаар ултай, гүнээ мэдэрсэн ойлголттой байдаг боловч Бурханы дээд эрхэд өчүүхэн ч итгэдэггүй; хүмүүний хувь заяаг Бурхан зохицуулж, зохион байгуулдаг гэдэгт тэд итгэдэггүй, Бурханы дээд эрхэд захирагдах дургүй байдаг. Ийм хүмүүс идэвхгүйгээр хүлээж, хувь заяагаа дагахаас өөр ямар ч сонголтгүй, далайн давлагаанд шидэгдэн, урсгал даган зөнгөөрөө хөвж байгаа мэт байдаг. Гэсэн ч тэд, хүмүүний хувь заяа Бурханы дээд эрхэд захирагддаг гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй; тэд өөрсдийн санаачилгаар Бурханы дээд эрхийг мэдэж авч, тэгснээрээ Бурханы эрх мэдлийн талаарх мэдлэгт хүрч, Бурханы зохион байгуулалт болон зохицуулалтад захирагдаж, хувь заяаг эсэргүүцэхээ болиод Бурханы халамж, хамгаалалт, удирдамж дор амьдарч чаддаггүй. Өөрөөр хэлбэл, хувь заяаг хүлээн зөвшөөрөх нь Бүтээгчийн дээд эрхэд захирагдахтай адил зүйл биш; хувь заяанд итгэнэ гэдэг нь хүн Бүтээгчийн дээд эрхийг хүлээн авч, зөвшөөрч, мэднэ гэсэн үг биш; хувь заяанд итгэнэ гэдэг нь ердөө л энэ үнэнийг, үүний өнгөц илрэлийг танин мэдэх явдал юм. Энэ нь хүн төрөлхтний хувь заяаг Бүтээгч хэрхэн захирдгийг мэдэх, Бүтээгч бол бүх зүйлийн хувь заяаг ноёрхдог эх үүсвэр гэдгийг танин мэдэхээс өөр, хүн төрөлхтний хувь заяанд зориулсан Бүтээгчийн зохион байгуулалт, зохицуулалтад захирагдахаас үнэхээр асар их ялгаатай. Хэрвээ хүн хувь заяанд л итгэдэг, үүнд бүр гүнээ итгэдэг ч гэсэн, ингэснээр хүн төрөлхтний хувь заяаг захирдаг Бүтээгчийн дээд эрхийг мэдэж, хүлээн зөвшөөрч, түүнд захирагдаж, түүнийг хүлээн авч чадахгүй байвал амьдрал нь бас л эмгэнэлтэй, дэмий, хоосон амьдарсан амьдрал байх болно; тэр жинхэнэ утгаараа бүтээгдсэн хүн болж, Бүтээгчийн сайшаалыг эдлэхээр Бүтээгчийн ноёрхолд орж чадахгүй хэвээр байх болно. Бүтээгчийн дээд эрхийг үнэхээр мэдэж, мэдэрдэг хүн идэвхгүй, арчаагүй биш, идэвхтэй байдалд байвал зохино. Тийм хүн бүх зүйл тавилантай гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ амьдрал болон хувь заяаны талаар “Бүхий

л амьдрал Бүтээгчийн дээд эрхэд захирагддаг” гэсэн үнэн зөв тодорхойлолттой болбол зохино. Хүн туулж өнгөрүүлсэн замаа эргэн харж, амьдралын замналын үе шат бүрээ дурсан санахдаа, замнал нь энхэл донхолтой, эсвэл толигор аль нь ч бай, Бурхан алхам бүрд замыг нь залж чиглүүлж, төлөвлөж өгч байсныг ойлгодог. Өнөөдрийг хүртэл хүнийг мэдэгдэлгүйгээр хөтөлж байсан зүйл нь Бурханы нямбай зохицуулалт, Түүний хичээнгүй төлөвлөлт байжээ. Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрч, Түүний авралыг хүртэх чадвартай байна гэдэг хэчнээн агуу завшаан бэ! Хэрвээ хүн хувь заяанд сөрөг ханддаг бол, түүнд зориулж Бурханы зохицуулсан бүхнийг тэр эсэргүүцдэг, түүнд захирагдах хандлага байхгүйг энэ нь батална. Хэрвээ хүний хувь заяаг захирах Бурханы дээд эрхийн талаар хүн эерэг хандлагатай бол амьдралын замналаа эргэн харж, Бурханы дээд эрхийг үнэхээр ухан ойлгох үедээ Бурханы зохицуулсан бүх зүйлд захирагдахыг чин сэтгэлээсээ хүсэж, хувь заяагаа зохион байгуулахыг Бурханд зөвшөөрч, Бурханы эсрэг тэрслэхээ болихдоо илүү шийдэмгий, итгэлтэй болно. Учир нь хувь заяаг ухаарч ойлгохгүй, Бурханы дээд эрхийг ойлгохгүй, манан дундуур гуйвж дайван зоргоороо урагшаа тэмтчин явахад уг замнал хэтэрхий хэцүү, хэтэрхий зүрх зүсэм байдгийг ойлгодог. Иймээс хүмүүс хүний хувь заяаг захирдаг Бурханы дээд эрхийг танин мэдэхээрээ ухаалаг хүмүүс нь өөрийн гараар сайхан амьдрал бүтээх гэж хичээж байсан бэрх өдрүүдтэйгээ салах ёс хийж, хувь заяаны эсрэг тэмцэж, “амьдралын зорилго” гэх зүйлээ өөрийнхөөрөө эрэлхийлэхээ болихоор мэдэж, хүлээн зөвшөөрөх замыг сонгодог. Хүнд Бурхан байхгүй, Түүнийг харж чадахгүй, Бурханы дээд эрхийг тодорхой танин мэдэж чадахгүй үед өдөр бүр нь утга учиргүй, үнэ цэнгүй, өрөвдөлтэй байдаг. Хүн хаана ч байсан, ажил нь ямар ч байсан, амьдрах арга зам болон зорилгоор хөөцөлдөх нь эргэн дурсаж ч чадамгүй эцэс төгсгөлгүй их уй гашуу, хөнгөвчлөхийн аргагүй зовлон шаналлаас өөр юуг ч авчрахгүй. Бүтээгчийн дээд эрхийг хүлээн авч, Түүний зохион байгуулалт, зохицуулалтад захирагдаж, жинхэнэ хүмүүний амьдралыг эрж хайсан цагт л хүн бүх уй гашуу, зовлон шаналлаас аажмаар ангижирч, амьдралын бүхий л утгагүй хоосон байдлаас салж эхэлнэ.

4) Бүтээгчийн дээд эрхэд захирагддаг хүмүүс л жинхэнэ эрх чөлөөг олж авч чадна

Хүмүүс Бурханы зохион байгуулалт болон дээд эрхийг таньж мэддэггүйн улмаас хувь заяатай нүүр тулахдаа үргэлж эсэргүүцсэн, тэрслүү хандлагатай байдгийн дээр, одоогийн нөхцөл байдлаа хувиргаж, хувь заяагаа өөрчилнө гэж дэмий л найдан Бурханы эрх мэдэл, дээд эрх болон хувь заяаны төөргөөс татгалзахыг үргэлж хүсэж байдаг. Гэвч тэд хэзээ ч тэгж чаддаггүй, алхам тутамд нь саад тотгор учирна. Энэ бүх хугацаанд хүн амиа дэмий шалихгүй юманд үрж байхад, хүний сэтгэлийн гүнд явагддаг энэхүү тэмцэл ясанд нь хүрэхээр тийм гүнзгий шаналлыг авчирдаг. Энэ зовлон шаналлын шалтгаан нь юу вэ? Энэ нь

Бурханы дээд эрхээс шалтгаалдаг уу, эсвэл хүн азгүй төрснөөс шалтгаалдаг уу? Мэдээж аль аль нь үнэн биш. Үндсэндээ энэ нь хүмүүсийн явсан замаас, хүмүүсийн амьдрахаар сонгосон арга замаас шалтгаалдаг. Зарим хүн эдгээр зүйлийг ухаараагүй байж болох юм. Гэвч Бурхан хүн төрөлхтний хувь заяаг захирах дээд эрхтэй гэдгийг үнэхээр танин мэдэж, үнэхээр хүлээн зөвшөөрсөн үед, чамд зориулж Бурханы төлөвлөсөн, чиний өмнөөс шийдсэн бүхэн нь асар их ашиг тус, хамгаалалт гэдгийг чи үнэхээр ойлгох үед зовлон шаналал чинь аажмаар хөнгөрч эхлэхийг, бүхэлдээ тайван, эрх чөлөөтэй, чөлөөлөгдсөн болж байгаагаа мэдрэх болно. Дийлэнх хүний байдлаас авч үзвэл, хэдийгээр субьектив түвшинд тэд өмнөх маягаараа амьдраад байхыг хүсэхгүй, зовлон шаналлаасаа чөлөөлөгдөхийг хүсдэг боловч үнэндээ бол хүний хувь заяаг захирах Бүтээгчийн дээд эрхийн бодит үнэ цэн, утга учрыг үнэхээр ойлгож чаддаггүй; үнэндээ бол тэд Бүтээгчийн дээд эрхийг үнэхээр танин мэдэж, түүнд захирагдаж чаддаггүй, Бүтээгчийн зохион байгуулалт, зохицуулалтыг хэрхэн эрж хайж, хүлээн авахаа бүр ч мэддэггүй. Тиймээс хэрвээ Бүтээгчид хүний хувь заяа болон хүний бүх хэрэг явдлыг захирах дээд эрх байдаг гэсэн бодит үнэнийг хүмүүс үнэхээр танин мэдэж чадахгүй бол, Бүтээгчийн ноёрхолд үнэхээр захирагдаж чадахгүй бол, “хүний хувь заяа өөрийнх нь гарт байдаг” гэсэн санаанд хөтлөгдөж, дөнгөлөгдөхгүй байхад хэцүү болно. Хувь заяаны болон Бүтээгчийн эрх мэдлийн эсрэг хүчтэй тэмцлийнхээ зовлон шаналлаас салах хэцүү байх бөгөөд үнэхээр чөлөөлөгдөж, эрх дураараа болж, Бурханыг шүтэн мөргөдөг хүмүүс болоход тэдэнд мөн хэцүү байх болно гэдгийг хэлэхийн ч хэрэггүй. Гэхдээ ийм байдлаас өөрийгөө чөлөөлөх их энгийн арга зам байдаг нь урьдын амьдрах арга замтайгаа салах ёс гүйцэтгэх; урьдын амьдралын зорилгодоо баяртай гэж хэлэх; урьдын амьдралын хэв маяг, амьдралыг үзэх үзэл, эрэл хайгуул, хүсэл, туйлын зорилгыг нэгтгэн дүн шинжилгээ хийх; дараа нь тэдгээрийг Бурханы хүсэл болон хүнд тавих шаардлагатай харьцуулаад, тэдгээрийн аль нэг нь Бурханы хүсэл, шаардлагатай нийцэж байгаа эсэх, аль нэг нь амьдралд зөв үнэ цэн өгч, үнэнийг илүү сайн ойлгоход хүнийг хөтөлж, хүн чанартайгаар, хүн шиг амьдрах боломжийг олгож байгаа эсэхийг харах юм. Чи хүмүүсийн эрэлхийлдэг амьдралын олон янзын зорилго, тоо томшгүй олон амьдрах арга замыг нь ахин дахин судалж, нарийвчлан задлан шинжилбэл тэдгээрийн нэг нь ч, хүн төрөлхтнийг бүтээсэн Бүтээгчийн анхны санаа зорилготой нийцдэггүй гэдгийг олж мэднэ. Тэдгээр нь бүгд хүмүүсийг Бүтээгчийн дээд эрх болон анхаарал халамжаас холдуулдаг; тэдгээр нь бүгд хүмүүсийг самуурахад хүргэдэг, там руу хөтөлдөг урхи юм. Үүнийг танин мэдсэний дараа чиний хийх зүйл бол амьдралын талаарх хуучин үзлээ хойш тавьж, олон янзын урхи занганаас хол байж, амьдралыг чинь хариуцаж, чиний төлөө зохицуулалт хийхийг Бурханд даатгах; зөвхөн Бурханы зохион байгуулалт, удирдамжид захирагдан, хувийн сонголтгүйгээр амьдарч, Бурханыг шүтэн мөргөдөг хүн болохоор хичээх явдал юм. Энэ нь амархан сонсогддог боловч хийхэд хэцүү зүйл билээ. Зарим хүн үүний зовлонг нь тэсвэрлэж

чадах ч зарим нь чадахгүй. Зарим нь дагаж мөрдөхөд бэлэн байдаг ч зарим нь дурамжхан байдаг. Дурамжхан байгаа хүмүүст үүнийг хийх хүсэл, шийдэмгий байдал дутагдаж байдаг; тэд Бурханы дээд эрхийн талаар тодорхой ойлгодог, Бурхан хүний хувь заяаг төлөвлөж, зохицуулдаг гэдгийг бүрэн төгс мэддэг атлаа эсэргүүцэж, тэмцэлдсээр, хувь заяагаа Бурханы гарт өгч, Бурханы дээд эрхэд захирагдахтай эвлэрэхгүй хэвээр; улмаар Бурханы зохион байгуулалт болон зохицуулалтад дургүйцэж байдаг. Тиймээс юу чаддагаа өөрсдөө харахыг хүсдэг хүмүүс үргэлж байх болно; тэд өөрийн гараар хувь заяагаа өөрчилж, өөрийн чадлаар аз жаргалд хүрэхийг, Бурханы эрх мэдлийн хязгаарыг даван гарч, Бурханы дээд эрхээс дээш гарч чадах эсэхээ харахыг хүсдэг. Хүний эмгэнэл нь аз жаргалтай амьдрал эрж хайж, нэр алдар, эд баялгаар хөөцөлдөж, хувь заяагаа сөрөн манан дундуур тэмцэж байгаад биш, харин Бүтээгчийн оршин тогтнолыг харж, хүний хувь заяаг захирах дээд эрх Бүтээгчид бий гэдэг бодит үнэнийг мэдсэнийхээ дараа ч гэсэн өөрийгөө засаж чадахгүй хэвээр, хөлөө намаг балчгаас татаж гаргаж чадахгүй, харин ч сэтгэлээ чангалж, алдаагаа туйлбартай үргэлжлүүлж байдаг нь юм. Тэр харин ч шавхай дундуур туучиж, Бүтээгчийн дээд эрхийн эсрэг зөрүүдлэн тэмцэлдэж, өчүүхэн төдий ч гэмшилгүйгээр эцсээ хүртэл эсэргүүцсээр байхыг илүүд үзнэ. Нурж унан, цус алдан хэвтэж байхдаа л эцэст нь тэр бууж өгч, буцахаар шийддэг. Энэ бол хүмүүний жинхэнэ уй гашуу юм. Иймээс захирагдахыг сонгодог нь цэцэн хүмүүс, тэмцэж, зайлж зугтаахыг сонгодог нь мунхаг хүмүүс гэж Би хэлнэ.

Зургаа дахь онцгой үе: Үхэл

Маш их үймээн бужигнаан, маш их бүтэлгүйтэл, гонсойлгосон үйл явдал, маш их баяр хөөр, уй гашуу, сайн, муу, маш олон мартагдашгүй он жил, улирлууд ахин дахин солигдохыг харсны дараа хүн амьдралын чухал үеүдийг анзааралгүй өнгөрөөж, нүд ирмэхийн зуурт л насны нар хэвийх үедээ ирсэн байдаг. Цаг хугацааны ул мөр бүхий л биеэр нь үлдсэн байдаг: Хүн цэх шулуун зогсож чадахаа больж, хар үстэй байсан толгой нь цагаан болж, нэгэн цагт гэрэлтсэн тунгалаг байсан нүд нь сүүмийн булингартаж, зөөлөн толигор арьс нь үрчийж, цоохортдог. Хүний сонсгол муудаж, шүд нь сулран унаж, хариу үйлдэл нь удааширч, хөдөлгөөн нь удаан болдог… Энэ үед хүн залуу насныхаа оргилсон он жилүүдтэй бүрмөсөн салах ёс хийж, амьдралынхаа насны нар хэвийх үе болох өтөл нас руугаа ордог. Дараа нь тэрээр хүний амьдралын сүүлчийн онцгой үе болох үхэлтэй нүүр тулна.

1) Хүний амьдрал, үхлийг хянах эрх гагцхүү Бүтээгчид бий

Хэрвээ хүний төрөлтийг өмнөх амьдрал нь заяадаг бол хүний үхэл тэрхүү хувь төөргийн төгсгөлийг заадаг. Хэрвээ хүний төрөлт нь энэ амьдрал дахь хүний үүрэг даалгаврын эхлэл юм бол хүний үхэл нь тэрхүү үүрэг даалгаврын төгсгөлийг заадаг. Бүтээгч хүний төрөлтөд зориулсан тогтсон цогц нөхцөл байдлыг тодорхойлчихсон байдаг болохоор Тэр мөн үхэлд нь зориулан тогтсон цогц нөхцөл

байдлыг зохицуулчихсан байдаг нь илэрхий юм. Өөрөөр хэлбэл, хэн ч санамсаргүй төрдөггүй, хэний ч үхэл гэнэтхэн байдаггүй, төрөх, үхэх хоёр хоёулаа хүний өмнөх болон өнөөгийн амьдралтай гарцаагүй холбоотой байдаг. Хүний төрөлт болон үхлийн нөхцөл байдлын аль алиныг нь Бүтээгч урьдчилан тодорхойлдог; энэ бол хүний хувь тавилан, хувь заяа юм. Хүний төрөлтийн талаар олон тайлбар байдаг хойно, хүний үхэл өөрийн гэсэн янз бүрийн онцгой цогц нөхцөл байдалд болдог нь мөн үнэн билээ. Хүмүүсийн амьдрах хугацаа өөр өөр, үхсэн байдал, цаг нь ялгаатай байдгийн шалтгаан нь энэ юм. Зарим хүн эрүүл, чийрэг ч эрт үхдэг; зарим нь сул дорой, эмгэг хуучтай ч өндөр насалж, зоволгүйгээр таалал төгсдөг. Зарим нь зуурдаар, зарим нь жамаараа нас нөгчдөг. Зарим нь гэрээсээ хол насан эцэслэж байхад зарим нь хайртай хүмүүсийнхээ дэргэд нүд аньдаг. Зарим хүн агаар дээр, зарим нь газар доор нас бардаг. Зарим нь усанд живж, зарим нь гамшигт үгүй болдог. Зарим нь өглөө, зарим нь орой нас бардаг… Хүн бүхэн нэр цуутай төрөлт, гялалзсан амьдрал, алдар суутай үхлийг хүсдэг боловч хэн ч өөрийн хувь тавиланг даван гарч, Бүтээгчийн дээд эрхээс зугтаж чадахгүй. Энэ бол хүний хувь заяа юм. Хүн ирээдүйдээ зориулан бүхий л төрлийн төлөвлөгөө гаргаж болох боловч өөрийн төрөх болон энэ дэлхийгээс явах байдал, цаг хугацааг хэн ч төлөвлөж чадахгүй. Хүмүүс хэдийгээр үхлээс зайлсхийж, эсэргүүцэхийн тулд чадах бүхнээ хийдэг боловч үхэл тэдэнд мэдэгдэлгүйгээр чимээгүйхэн ойртсоор байдаг. Хэзээ үхэх, яаж үхэх, тэр ч бүү хэл хаана тохиолдохыг хэн ч мэдэхгүй. Мэдээжийн хэрэг, амьдрал, үхлийн эрхийг барьдаг нь хүн төрөлхтөн биш, байгаль дэлхий дээрх ямар нэг амьтан биш, харин цор ганц эрх мэдэлтэй Бүтээгч юм. Хүн төрөлхтний амьдрал, үхэл нь байгаль дэлхийн хуулийн үр дүн биш, харин Бүтээгчийн эрх мэдлийн дээд эрхийн үр дагавар билээ.

2) Бүтээгчийн дээд эрхийг мэддэггүй хүн үхлийн айдаст автана

Өтөл насандаа очих үед хүнд тулгардаг сорилт нь гэр бүлээ тэжээх, эсвэл амьдралын агуу их нэр төрийг тогтоох биш, харин амьдралтай хэрхэн салах ёс хийж, амьдралынхаа төгсгөлтэй хэрхэн учрах, амьдралын ялын төгсгөлд хэрхэн цэг тавих вэ гэдэг явдал юм. Хэдийгээр хүмүүс гаднаа үхэлд анхаарал бага хандуулдаг мэт байдаг боловч хэн ч энэ сэдвийг судлахаас зайлсхийж чадахгүй, учир нь үхлийн цаад талд өөр ертөнц, хүний ухамсарлаж, мэдэрч чадахгүй, тэдний огтхон ч мэддэггүй ертөнц оршин байдаг эсэхийг хэн ч мэдэхгүй билээ. Энэ нь хүмүүсийг үхэлтэй халз тулахаас, зохих ёсоор нүүр тулгарахаас айхад хүргэдэг; харин ч тэд энэ сэдвээс зайлсхийхийн тулд чадах бүхнээ хийдэг. Иймээс энэ нь хүн бүрийг үхлийн тухай айдсаар дүүргэж, амьдралын энэхүү зайлшгүй үнэнд нууцлаг халхавч нэмж, хүн бүхний зүрх сэтгэлд байнгын сүүдэр тусгадаг.

Бие нь дордож байгааг мэдэрч, үхэл ойртож байгааг мэдрэхдээ хүн тодорхойгүй эмээх сэтгэл, үгээр илэрхийлэхийн аргагүй айдсыг мэдэрдэг. Үхлээс айх айдас нь хүнд бүр ч их ганцаардал, арчаагүй байдлыг мэдрүүлдэг бөгөөд энэ үед хүн

өөрөөсөө ийнхүү асуудаг: Хүн хаанаас ирсэн бэ? Хүн хаашаа явж байна вэ? Хүний амьдрал урсан өнгөрч, хүн ингээд үхдэг юм гэж үү? Хүний амьдралын төгсгөлийг тэмдэглэдэг үе энэ гэж үү? Эцсийн эцэст, амьдралын утга учир юу юм бэ? Эцэст нь амьдрал ямар үнэ цэнтэй юм бэ? Энэ нь алдар нэр, эд хөрөнгийн төлөө байдаг гэж үү? Үр хүүхэд өсгөхийн төлөө байдаг гэж үү?… Хүн яг энэ асуултуудын тухай бодсон эсэх, үхлээс хэр гүнзгий айдгаас үл хамааран нууцыг судлах хүсэл, амьдралыг ойлгохгүй байх мэдрэмж, эдгээртэй холилдсон дэлхий ертөнцөд хоргодох сэтгэл, орхин одох хүсэлгүй байдал хүн бүхний зүрх сэтгэлийн гүнд үргэлж байдаг. Магадгүй хүний айдаг зүйл юу болох, эрж хайдаг зүйл юу болох, тэр юунд хоргодох сэтгэлтэй байдаг, юуг орхин одох хүсэлгүй байдгийг хэн ч тодорхой хэлж чадахгүй байх…

Үхлээс айдаг учраас хүмүүс маш их зүйлд санаа зовдог; үхлээс айдаг учраас орхиж чаддаггүй зүйл хүмүүст маш их байдаг. Үхэх гэж байхдаа зарим хүн энэ ч тэр ч юманд цухалддаг; тэд санаа зовснооroo үхлийн авчрах зовлон шаналал, айдсыг арилгаж, амьд хүмүүстэй ямар нэгэн байдлаар ойр дотно харьцааг хадгалснаараа үхлийг дагалдан ирдэг арчаагүй, ганцаардмал байдлаас зугтаж чадах юм шиг үр хүүхэд, хайртай хүмүүс, эд хөрөнгөндөө санаа зовж байдаг. Хүний сэтгэлийн гүнд тодорхойгүй айдас, хайртай хүмүүсээсээ хагацаж, хөх тэнгэрийг дахин хэзээ ч харахгүй, материаллаг ертөнцийг дахин хэзээ ч харахгүй гэсэн айдас байдаг. Хайртай хүмүүстэйгээ хамт байж дассан ганцаардмал сүнс, зуурсан гараа тавьж, үл мэдэгдэх, танихгүй ертөнц рүү цор ганцаараа явах дургүй байдаг.

3) Алдар нэр, эд баялаг хөөцөлдөж өнгөрүүлсэн амьдрал хүнийг үхэлтэй тулгарахад барьц алдуулна

Өөрийн гэсэн юу ч үгүй эхэлсэн ганцаардмал сүнс, Бүтээгчийн дээд эрх болон урьдчилан тогтоосны улмаас эцэг эх, гэр бүлтэй болж, хүн төрөлхтний нэг гишүүн болох боломж, хүмүүний амьдрал туулж, дэлхий ертөнцийг харах боломжийг олж авдаг. Энэхүү сүнс мөн Бүтээгчийн дээд эрхийг мэдэрч, Бүтээгчийн бүтээлийн гайхалтай сайхныг мэдэж, түүнээс ч илүүтэйгээр Бүтээгчийн эрх мэдлийг мэдэж, захирагдах боломжийг олж авдаг. Гэхдээ ихэнх хүн энэхүү ховор, агшин зуурын боломжийг үнэндээ барьж авдаггүй. Хүн, хувь заяаны эсрэг тэмцэж насан туршийн эрч хүчээ шавхан, гэр бүлээ тэжээх гэж хичээн, эд баялаг, байр суурийн хооронд нааш цааш давхиж, хөл үймээн болж хамаг цагаа зарцуулдаг. Хүмүүсийн нандигнадаг зүйл нь гэр бүл, мөнгө, алдар нэр байдаг, тэд эдгээрийг амьдралын хамгийн үнэ цэнтэй зүйлс гэж үздэг. Бүх хүн хувь заяаныхаа талаар гомдоллодог боловч, хүн яагаад амьд байдаг, хүн хэрхэн амьдрах ёстой, амьдралын үнэ цэн, утга учир юу вэ гэсэн шинжилж, ойлговол зохих хамгийн чухал асуудлуудыг бодлынхоо мухар луу түлхсээр байдаг. Хэчнээн урт наслах байсан ч бай, залуу нас нь нисэн одож, үрчлээтэж, буурал болох хүртлээ ердөө л алдар нэр, эд баялаг эрж хайн тэвдэж гүйсээр хамаг амьдралаа үрдэг. Нэр хүнд, эд баялаг өтөл насны

доройтол руу уруудахыг нь зогсоож чадахгүй гэдгийг, мөнгө сэтгэлийн хоосролыг дүүргэж чадахгүй, төрж, хөгширч, өвдөж, үхэх хуулиас хэн ч ангид байдаггүй, хувь заяаны төөргөөс хэн ч зугтаж чадахгүй гэдгийг ойлгох хүртлээ тэд ингэж амьдардаг. Тэд амьдралын эцсийн онцгой үетэй тулгарахаас аргагүй болсон үедээ л, асар их эд баялаг, үлэмж их эд хөрөнгөтэй, эрх дархтай, өндөр зиндаатай байсан ч гэсэн хэн ч үхлээс зугтаж чадахгүй, анхны байрандаа эргэн очиж, өөрийн гэх ямар ч юмгүй орь ганц сүнс болно гэдгийг лавтай ухаардаг. Хүмүүс эцэг эхтэй байх үедээ, эцэг эх бол бүх юм гэж итгэдэг; эд хөрөнгөтэй байх үедээ мөнгө бол хүний түшиг тулгуур, амьдрах арга хэрэгсэл гэж боддог; байр суурьтай болохоороо түүнтэйгээ ягштал зууралдаж, түүний төлөө амиа дэнчин тавихаар байдаг. Хүмүүс энэ хорвоог орхих гэж байхдаа л өөрсдийнх нь эрж хайж амьдралаа өнгөрүүлсэн зүйлс үзэгдээд өнгөрөх үүлсээс өөр юу ч биш, тэдгээрийн алийг нь ч хадгалж үлдэж чадахгүй, алийг ч аваад явж чадахгүй, аль нь ч үхлээс чөлөөлж чадахгүй, аль нь ч буцах замд нь ганцаардмал сүнстэй хамт байж, тайтгаруулж чадахгүй; хамгийн наад зах нь, эдгээр зүйлийн аль нь ч хүнийг аварч, үхлийг даван туулах боломж олгож чадахгүй гэдгийг ухаардаг. Материаллаг ертөнцөд олж авдаг нэр алдар, эд баялаг нь түр зуурын сэтгэл ханамж, зуурдын таашаал, хуурамч тайвшрах мэдрэмжийг хүнд өгч; ингэх явцдаа хүнийг замаа алдахад хүргэдэг. Иймээс хүмүүс, хүн төрөлхтний өргөн уудам далайд бачимдан, амар тайван байдал, тав тух, зүрх сэтгэлийн амар амгаланг хүсэн мөрөөдөхийн хэрээр давлагаанд ахин дахин нөмрүүлдэг. Тэд хаанаас ирсэн, яагаад амьд байгаа, хаашаа явж байгаа гэх мэт ойлговол зохих хамгийн чухал асуултуудыг хүмүүс хараахан ойлгоогүй байхдаа алдар нэр, эд баялагт уруу татагдаж, будилж, тэдгээрт захирагдаж, эргэлт буцалтгүйгээр төөрөлддөг. Цаг хугацаа нисэн одож; он жил нүд цавчихын төдийд өнгөрч, хүн нэг л мэдэхэд амьдралынхаа хамгийн сайхан жилүүдтэй салах ёс хийсэн байдаг. Хүн хорвоогоос явах нь дөхөхөд хорвоо дээрх бүх зүйл урсан оддог, анх өөрийнх нь байсан зүйлсийг цаашид хадгалж үлдэж чадахгүй гэдгийг аажмаар ухаарахад хүрдэг; тэгээд энэ хорвоод дөнгөж мэндлээд орилж байгаа, хараахан өөрийн гэсэн юу ч байхгүй нярай хүүхэд шиг гэдгээ хүн үнэхээр мэдэрдэг. Энэ үед хүн амьдралдаа юу хийсэн, амьд байхын үнэ цэн, энэ нь ямар утга учиртай, хүн яагаад энэ хорвоод ирснийг тунгаан бодоход хүрдэг. Тэгээд энэ үед л хүн, хойд нас гэж үнэхээр байдаг эсэх, Тэнгэр үнэхээр оршдог эсэх, цээрлүүлэлт үнэхээр байдаг эсэхийг мэдэхийг улам их хүсдэг… Хүн үхэх нь ойртох тусам амьдрал гэж үнэндээ юу болохыг ойлгохыг улам их хүсдэг; хүн үхэх нь ойртох тусам зүрх сэтгэл нь улам хоосон санагддаг; хүн үхэх нь ойртох тусмаа арчаагүй байдлыг улам их мэдэрдэг; ийнхүү хүний үхлээс айх айдас өдрөөс өдөрт улам их болдог. Үхэх нь ойртох үед хүмүүст ийм мэдрэмж төрдөг хоёр шалтгаан бий: Нэгдүгээрт, тэд амьдрал нь хамаарч байсан алдар нэр, эд баялгаа алдаж, хорвоо дээрх нүдэнд харагдах бүхнийг ардаа орхин одох гэж байна; хоёрдугаарт, тэд хөл тавихаас айдаг, хайртай хүмүүс нь байхгүй, ямар ч дэмжлэг туслалцаа байхгүй танил бус ертөнцтэй,

нууцлаг, үл мэдэх оронтой орь ганцаараа нүүр тулах гэж байна. Энэ хоёр шалтгааны улмаас үхэлтэй нүүр тулсан хүн бүхэнд түгшүүртэй санагдаж, урьд өмнө нь хэзээ ч үзээгүйгээр сандарч, арчаагүй байдлыг мэдэрдэг. Үнэндээ энэ цэгт хүрээд л, хүн хаанаас гаралтай, яагаад хүмүүс амьд байгаа, хүний хувь заяаг хэн шийддэг, хүний оршин тогтнолыг хэн хангадаг, үүнийг захирах дээд эрх хэнд байдаг вэ гэдэг нь энэ хорвоод хөл тавингуутаа хамгийн түрүүнд ойлгох учиртай зүйл юм байна гэдгийг хүн ухаардаг. Гэр бүлээ хэрхэн тэжээж, алдар нэр, эд баялагт хэрхэн хүрэхэд суралцах биш, хэрхэн бусдаас онцгойроход, эсвэл илүү чинээлэг амьдрахад суралцах ч бас биш, хэрхэн бусдаас илүү дээр байж, амжилттай өрсөлдөхөд суралцах явдал бүр ч биш харин энэхүү мэдлэг бол хүний амьдрах жинхэнэ арга хэрэгсэл, гол суурь мөн. Хэдийгээр хүмүүсийн амьдралаа зарцуулан сурч эзэмшдэг олон янзын амь зуух ур чадвар нь асар их материаллаг тав тухыг өгч чадах боловч зүрх сэтгэлд нь жинхэнэ амар амгалан, тайтгарлыг хэзээ ч авчирдаггүй, харин ч хүмүүсийг байнга зүг чигээ алдаж, биеэ барихад хэцүү болж, амьдралын утга учрыг мэдэж авах боломж болгоныг алдахад хүргэдэг; амьд үлдэх эдгээр ур чадвар нь үхэлтэй хэрхэн зүй ёсоор нүүр тулах тухай сэтгэл зовних далд мэдрэмжийг төрүүлдэг. Хүмүүсийн амьдрал ийм байдлаар сүйрдэг. Бүтээгч хүн болгонд шударга хандаж, Өөрийнх нь дээд эрхийг туулж, мэдэх насан туршийн үнэт боломжийг хүн бүрд олгодог хэдий ч зөвхөн үхэх нь дөхөж, үхэл заналхийлэх үед л хүн ухаарч эхэлдэг боловч тэр үед хэтэрхий оройтсон байдаг!

Хүмүүс мөнгө, алдар нэрийн хойноос хөөцөлдөн амьдралаа үрдэг; эдгээр хэрэггүй зүйл тэдэнд байвал амьд явж, үхлээс мултарч чадах юм шиг, цорын ганц найдвар нь хэмээн бодож тэдгээрээс зуурдаг. Гэвч үхэх гэж байхдаа л эдгээр зүйл тэднээс хэчнээн хол, үхлийн өмнө тэд хэчнээн сул дорой болох, хэчнээн амархан сүйрдэг, хаашаа ч явах аргагүй, хэчнээн ганцаардмал, арчаагүй болохоо тэд ухаардаг. Амийг мөнгө, эсвэл алдар нэрээр худалдан авч болдоггүй, хүн хэчнээн баян чинээлэг байх, байр суурь нь хэчнээн өндөр дээд байх нь хамаагүй, үхлийн өмнө бүх хүн адилхан ядуу дорой, өчүүхэн гэдгийг ухаардаг. Мөнгөөр амь худалдан авч чадахгүй, алдар нэр үхлийг баллуурдаж чадахгүй, мөнгө, алдар нэрийн аль нь ч хүний амьдралыг ганц минут, ганц секундээр уртасгаж чадахгүй гэдгийг тэд ухаардаг. Хүмүүст ингэж санагдах тусам, амьд явахыг улам их хүсэмжилдэг; хүмүүст хэдий чинээ их ингэж санагдана, үхэл ойртохоос төдий чинээ их айж эмээдэг. Энэ үед л тэд өөрсдийнх нь амь тэдэнд хамаардаггүй, тэдний хянадаг зүйл биш, амьдрах, үхэхээ хүн шийдэж чадахгүй, энэ бүхэн хүний хяналтаас гадуур байдаг гэдгийг үнэхээр ухаардаг.

4) Бүтээгчийн ноёрхол дор орж, үхэлтэй тайвнаар нүүр тул

Хүн төрөх мөчид ганцаардмал нэгэн сүнс газар дээрх амьдралын туршлагаа, түүнд зориулан Бүтээгчийн зохицуулсан Бүтээгчийн эрх мэдлийг туулах туршлагаа эхлүүлдэг. Тухайн хүн—сүнсний хувьд энэ нь Бүтээгчийн дээд эрхийн тухай

мэдлэгийг олж авч, Түүний эрх мэдлийг мэдэж авч, үүнийг биеэрээ туулах хосгүй сайхан боломж юм гэдгийг хэлэх нь илүүц биз ээ. Хүмүүс Бүтээгчийн тавьж өгсөн хувь заяаны хуулийн дотор амьдардаг бөгөөд мөс чанартай, эрүүл ухаантай ямар ч хүний хувьд амьдралынхаа хэдэн арван жилийн явцад Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрч, Түүний эрх мэдлийг мэдэж авах нь хэцүү зүйл биш юм. Тиймээс хүн бүрийн хувьд амьдралынхаа хэдэн арван жилийн туршлагаар бүх хүний хувь заяаг урьдчилан тогтоосон байдаг гэдгийг танин мэдэж, амьд байхын утга учир юу болохыг ухаарч, нэгтгэн дүгнэх нь тун амархан байх ёстой. Хүн амьдралын эдгээр сургамжийг хүлээн авах явцдаа амь хаанаас ирдгийг ойлгож, зүрх сэтгэлд нь үнэндээ юу хэрэгтэй, амьдралын жинхэнэ зам руу хүнийг юу хөтөлдөг, хүний амьдралын даалгавар, зорилго юу байх учиртайг аажмаар ухаарч эхэлдэг. Хэрвээ хүн Бүтээгчийг шүтэн мөргөхгүй, Түүний ноёрхол дор орохгүй бол үхэлтэй тулгарах цаг ирэхэд, хүний сүнс Бүтээгчтэй дахин нүүр тулах гэж байх үед зүрх сэтгэл нь энгүй их айдас, бухимдлаар дүүрэх болно. Хэрвээ хүн энэ хорвоо дээр хэдэн арван жил байсан атлаа хүний амь хаанаас ирдгийг хараахан мэдэж аваагүй, хүний хувь заяа хэний гарт байдгийг ч бас танин мэдээгүй бол үхэлтэй тайвнаар нүүр тулж чадахгүйд нь гайхах зүйлгүй. Хүмүүний амьдралыг хэдэн арван жил туулахдаа Бүтээгчийн дээд эрхийн талаар мэдлэг олж авсан хүн бол амьдралын утга учир, үнэ цэнийг үнэн зөв ойлгодог хүн билээ. Ийм хүн амьдралын зорилгын талаар гүн гүнзгий мэдлэгтэй, Бүтээгчийн дээд эрхийн талаар жинхэнэ туршлага, ойлголттой, түүнээс ч илүүтэйгээр Бүтээгчийн эрх мэдэлд захирагдах чадвартай байдаг. Ийм хүн, Бурхан хүн төрөлхтнийг бүтээсний утга учрыг ойлгодог, хүн Бүтээгчийг шүтэн мөргөх хэрэгтэй, хүнд байдаг бүх зүйл Бүтээгчээс ирдэг, ойрын ирээдүйд хэзээ нэгэн өдөр Түүнд буцааж өгнө гэдгээ ойлгодог. Бүтээгч хүний төрөхийг зохицуулдаг, хүний үхлийг захирах дээд эрхтэй, амьдрал, үхлийн аль алийг нь Бүтээгчийн эрх мэдлээр урьдчилан шийддэг гэдгийг ийм хүн ойлгодог. Иймээс хүн эдгээр зүйлийг үнэхээр ойлгохоороо, аяндаа үхэлтэй тайвнаар нүүр тулж, энэ хорвоогийн бүх эд хөрөнгөө тайвнаар орхиж, дараа нь тохиолдох бүхнийг баяртайгаар хүлээн зөвшөөрч, захирагдан, Бүтээгчийн зохицуулсан амьдралын сүүлчийн онцгой үеэс сохроор айж, эсэргүүцэж тэмцэлдэхийн оронд баяртайгаар байгаагаар нь угтан авна. Хэрвээ хүн, Бүтээгчийн дээд эрхийг мэдэрч, Түүний эрх мэдлийг мэдэж авах боломж гэж амьдралыг үзвэл, өөрийн амьдралыг бүтээгдсэн зүйлийн хувьд үүргээ гүйцэтгэж, даалгавраа биелүүлэх ховорхон боломж гэж үзвэл, амьдралын талаар гарцаагүй зөв үзэл бодолтой болж, Бүтээгчийн ерөөж, залж чиглүүлсэн амьдралаар гарцаагүй амьдарч, Бүтээгчийн гэрэл дор гарцаагүй алхаж, Бүтээгчийн дээд эрхийг гарцаагүй мэдэж, Түүний ноёрхол дор гарцаагүй орж, Түүний ер бусын үйл хэрэг, Түүний эрх мэдлийг гарцаагүй гэрчлэх болно. Тийм хүн гарцаагүй Бүтээгчээр хайрлуулж, хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд тийм хүн л үхэлд тайван хандаж, амьдралын эцсийн онцгой үеийг баяр хөөртэйгөөр угтан авч чадна гэдгийг хэлэх нь илүүц биз. Мэдээжээр үхэлд ингэж хандаж байсан нэг хүн

бол Иов байсан. Иов амьдралынхаа сүүлчийн онцгой үеийг баяртайгаар хүлээн зөвшөөрч чадсан бөгөөд амьдралын замналаа төвөггүй төгсгөж, амьдралын даалгавраа биелүүлснээр Бүтээгчийн дэргэд эргэн очсон юм.

5) Иовын амьдралын эрэл хайгуул, олж авсан зүйл нь үхэлтэй тайвнаар нүүр тулах боломжийг түүнд олгосон

Сударт Иовын талаар ингэж бичигдсэн байдаг: “Иов өтөлж, өдөр хоногоо гүйцээгээд өөд болов” (Иов 42:17). Энэ нь, Иов нас барахдаа харамсах юмгүй, ямар ч өвдөлт мэдрэлгүй, харин энэ хорвоогоос жам ёсоороо явсан гэсэн үг юм. Хүн бүхний мэдэж байгаачлан, Иов амьд байхдаа Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүн байсан. Бурхан түүний үйл хэргийг сайшааж, хүмүүс тэдгээрийг дурсан санаж байсны дээр түүний амьдрал бусад бүх хүнээс ч илүү үнэ цэнтэй, ач холбогдолтой байсан гэж хэлж болно. Иов газар дээр Бурханы ерөөлийг эдэлж, Түүгээр зөв шударга хэмээн дуудуулж, мөн Бурханд шалгуулж, Сатанд сориулсан. Тэр Бурханы төлөө гэрчлэлд зогсож, Түүгээр зөв шударга хүн гэж дуудуулах гавьяатай байсан. Тэр Бурханд шалгуулсныхаа дараа хэдэн арван жилийн туршид өмнөхөөсөө бүр ч илүү их үнэ цэнтэй, утга учиртай, үндэслэлтэй, амар тайван амьдралаар амьдарсан. Зөв шударга үйлийнх нь улмаас Бурхан түүнийг шалгасан, мөн зөв шударга үйлийнх нь улмаас Бурхан түүнд үзэгдэж, түүнтэй шууд ярьсан юм. Иймээс шалгуулснаасаа хойших жилүүдэд Иов амьдралын үнэ цэнийг илүү бодитойгоор ойлгож, үнэлж, Бүтээгчийн дээд эрхийн талаар илүү гүнзгий ойлголтыг олж авч, Бүтээгч ерөөлөө хэрхэн өгч, авдаг талаар илүү нарийн, тодорхой мэдлэг олж авсан. Ехова Бурхан өмнө нь өгч байснаасаа илүү их ерөөлийг Иовд хайрлаж, Иовыг Бүтээгчийн дээд эрхийг мэдэж, үхэлтэй тайвнаар нүүр тулах илүү таатай нөхцөлд байдалтай болгосон гэдгийг Иовын номд тэмдэглэсэн байдаг. Иймээс хөгширч, үхэлтэй нүүр тулах үедээ Иов эд хөрөнгийнхөө талаар сэтгэл зовоогүй нь мэдээж юм. Түүнд санаа зовох, харамсах зүйл байгаагүй, мэдээж үхлээс айгаагүй, учир нь тэр бүхий л амьдралаа Бурханаас эмээж, муугаас зайлах замаар алхаж өнгөрүүлсэн. Өөрийнхөө төгсгөлийн талаар санаа зовох ямар ч шалтгаан түүнд байгаагүй билээ. Үхэлтэйгээ тулгарах үедээ Иовын үйлдсэн бүхий л байдлаар өнөөдөр хэчнээн олон хүн үйлдэж чадах вэ? Яагаад хэн ч тийм энгийн гаднах намба төрхийг хадгалж чаддаггүй вэ? Үүнд ердөө нэг л шалтгаан бий: Иов Бурханы дээд эрхэд итгэж, танин мэдэж, захирагдахыг бодитоор эрэлхийлж амьдарсны дээр амьдралынхаа чухал онцгой үеүдийг ийнхүү итгэж, танин мэдэж, захирагдан өнгөрөөж, амьдралынхаа сүүлчийн жилүүдийг амьдран харуулж, амьдралынхаа эцсийн онцгой үеийг угтсан юм. Иов юу туулснаас үл хамааран түүний амьдралын зорилго, эрэл хайгуул нь зовлон шаналалтай биш, харин жаргалтай байсан. Зөвхөн Бүтээгчийн хайрласан ерөөл, сайшаалаас болж биш, харин түүнээс ч чухал нь, өөрийн эрэл хайгуул, амьдралын зорилго, Бурханаас эмээж, муугаас зайлснаараа олж авсан Бүтээгчийн дээд эрхийн тухай улам нэмэгдэх мэдлэг, жинхэнэ ойлголт,

цаашлаад Бүтээгчийн дээд эрхэд захирагдаж байхдаа биеэрээ мэдэрсэн Бурханы гайхалтай үйл хэрэг болон Бурхан хүн хоёрын зэрэгцэн оршиж, танилцаж, харилцан ойлголцсон тухай халуун дулаан, мартагдашгүй туршлага, дурсамжийн улмаас тэр жаргалтай байсан юм. Бүтээгчийн хүслийг мэдсэний улмаас төрсөн тав тух, баяр хөөр, Түүнийг агуу, гайхалтай, хайр татам, итгэмжит гэдгийг нь харсны дараа төрсөн хүндлэл бишрэлийн улмаас Иов аз жаргалтай байсан. Үхэхээрээ Бүтээгчийн дэргэд буцаж очно гэдгээ мэдэж байсан учраас Иов ямар ч зовлон зүдүүргүйгээр үхэлтэй нүүр тулах чадвартай байсан. Мөн түүний амьдралдаа хийсэн эрэл хайгуул, олж авсан зүйл нь үхэлтэй тайвнаар нүүр тулж, Бүтээгч түүний амийг буцаан авах явдалтай сэтгэл тайван нүүр тулж, цаашлаад Бүтээгчийн өмнө ямар ч хир толбогүй, санаа зовох зүйлгүйгээр зогсох боломж олгосон. Өнөөгийн хүмүүс Иовд байсан шиг тийм аз жаргалд хүрч чадах уу? Та нарт тэгэхэд шаардлагатай нөхцөл байна уу? Өнөөгийн хүмүүст ийм нөхцөл байгаа хэр нь яагаад Иов шиг аз жаргалтай амьдарч чадахгүй байна вэ? Яагаад тэд үхлээс айх айдсын зовлонгоос зугтаж чадахгүй байна вэ? Үхэлтэй нүүр тулах үедээ зарим хүн өөрийн эрхгүй өмдөндөө шээдэг; зарим нь дагжин чичирч, ухаан алдаж, Тэнгэр болон хүнийг аль алиныг нь хараан загнадаг; зарим нь бүр орь дуу тавин цурхиран уйлдаг. Эдгээр нь үхэх дөхөхөд гэнэтхэн гарч ирдэг ердийн хариу үйлдлүүд огтхон ч биш юм. Гол нь хүмүүс зүрх сэтгэлийнхээ гүнд үхлээс айдаг учраас, Бурханы дээд эрх, Түүний зохицуулалтын талаар тодорхой мэдлэг, ойлголт байдаггүй, тэр ч бүү хэл тэдгээрт үнэхээр захирагддаггүй учраас ийм ичмээр авирладаг. Хүмүүс бүх зүйлийг өөрсдөө зохицуулж, захирч, хувь заяагаа, амьдралаа, үхлийг хянахаас өөрийг хүсдэггүй учраас ингэж авирладаг. Тиймээс хүмүүс үхлийн айдсаас хэзээ ч зугтаж чаддаггүйг гайхах хэрэггүй юм.

6) Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрснөөр л хүн Түүний хажууд эргэн очиж чадна

Хүн Бурханы дээд эрх, Түүний зохицуулалтын талаар тодорхой мэдлэг, туршлагагүй байх үед хувь заяа болон үхлийн талаарх хүний мэдлэг авцалдаагүй байх нь гарцаагүй. Бүх зүйл Бурханы гарт байдаг гэдгийг хүмүүс тодорхой ойлгож чаддаггүй, бүх зүйлийг Бурханы хяналт, дээд эрхийн дор байдаг гэдгийг ухаарч, хүн тийм дээд эрхийг хаяж, зугтаж чадахгүй гэдгээ танин мэддэггүй. Ийм шалтгааны улмаас тэд үхэлтэй нүүр тулах цаг ирэхэд сүүлчийн үг, сэтгэлийн шаналал, харамсалд нь төгсгөл байдаггүй. Тэд маш их дарамт, дурамжхан байдал, төөрөгдлийн дарамтад байдаг. Энэ нь тэднийг үхлээс айхад хүргэдэг. Энэ хорвоод мэндэлсэн ямар ч хүний хувьд төрөх шаардлагатай, үхэх нь зайлшгүй; хэн ч юмсын энэхүү замналыг даван гарч чадахгүй. Хэрвээ хүн энэ хорвоогоос зовлонгүйгээр явахыг хүсэж байвал, хэрвээ хүн дургүйлхэлгүй, сэтгэл зоволгүйгээр амьдралынхаа эцсийн онцгой үетэй нүүр тулах чадвартай байхыг хүсэж байвал, цорын ганц арга зам нь ямар ч харамсах зүйл үлдээхгүй байх юм. Харамсах зүйлгүйгээр явах цорын

ганц зам бол Бүтээгчийн дээд эрх, Түүний эрх мэдлийг мэдэж, тэдгээрт захирагдах явдал билээ. Хүн ийм маягаар л хүмүүний тэмцэлдээнээс, ёрын муу, Сатаны боолчлолоос хол байж, ингэж байж л хүн Иовынх шиг Бүтээгчээр удирдуулж, ерөөлгөсөн амьдралаар, эрх дураараа, чөлөөлөгдсөн, үнэ цэн, утга учиртай, үнэнч шударга, илэн далангүй амьдралаар амьдарч чадна. Ийм маягаар л хүн Иов шиг Бүтээгчийн шалгалтад орж, хоосорч, Бүтээгчийн зохион байгуулалт, зохицуулалтад захирагдаж чадна. Ийм маягаар л хүн Бүтээгчийг бүх амьдралаараа шүтэн мөргөж, Иовын адилаар Түүний сайшаалыг хүртэж, Түүний дуу хоолойг сонсож, Түүний илрэхийг харж чадна. Зөвхөн ийм маягаар л хүн Иов шиг ямар ч шаналал, сэтгэлийн зовнил, харамсалгүйгээр жаргалтай амьдарч, үхэж чадна. Ийм байдлаар л хүн Иов шиг гэрэлд амьдарч, амьдралынхаа онцгой үе бүрийг гэрэлд өнгөрүүлж, өөрийн замналыг гэрэлд төвөггүй төгсгөж, бүтээгдсэн зүйл болохын хувьд Бүтээгчийн дээд эрхийг мэдэрч, сурч, мэдэж авах даалгавраа амжилттайгаар биелүүлж, гэрэлд нас барж чаддаг бөгөөд түүнээс хойш бүтээгдсэн хүний хувиар Бүтээгчид сайшаагдан Түүний хажууд үүрд зогсох болно.

Бүтээгчийн дээд эрхийг мэдэх боломжийг бүү алд

Дээр тайлбарласан зургаан онцгой үе нь энгийн хүн болгоны амьдралдаа туулах ёстой, Бүтээгчийн бэлдэж тавьсан шийдвэрлэх чухал үе шатууд юм. Хүний өнцгөөс бол эдгээр онцгой үе бүр бодитой, тэдгээрийн алийг ч тойрч гарч болохгүй, бүгд л Бүтээгчийн урьдчилан тогтоосонтой, Түүний дээд эрхтэй холбоотой. Иймээс, хүний хувьд эдгээр онцгой үе бүр нь чухал шалган нэвтрүүлэх цэг бөгөөд нэг бүрийг нь хэрхэн амжилттай давж өнгөрөх ноцтой асуулттай та бүхэн одоо нүүр тулаад байна.

Хүний амьдралыг бүрдүүлдэг хэдэн арван жил нь урт ч биш, богино ч биш. Төрснөөс насанд хүрэхийн хоорондох хорин хэдэн жил нь нүд ирмэхийн төдийд өнгөрдөг бөгөөд хэдийгээр, амьдралын энэ үед, хүнийг насанд хүрсэнд тооцдог боловч энэ насны хүмүүс хүний амьдрал, хүний хувь заяаны талаар бараг юу ч мэддэггүй. Тэд илүү их туршлага хуримтлуулахын хэрээр дунд эргэм нас руу аажмаар ордог. Гуч, дөч орчим насандаа хүмүүс амьдрал болон хувь заяаны талаар шинэхэн туршлага олж авдаг боловч эдгээрийн талаарх санаа бодол нь тун бүрхэг хэвээр байдаг. Дөчин нас хүрээд л зарим хүн Бурханы бүтээсэн хүн төрөлхтөн, орчлон ертөнцийг ойлгож, хүмүүний амьдрал, хүмүүний хувь заяа ямар учиртай болохыг ухаарч ойлгож эхэлдэг. Зарим хүн хэдийгээр удаан хугацаанд Бурханы дагагч байж, одоо дунд эргэм настай болсон атлаа Бурханы дээд эрх, тэр ч бүү хэл жинхэнэ дуулгавартай байдлын талаар үнэн зөв мэдлэг, тодорхойлолттой болоогүй л байдаг. Зарим хүн ерөөл хүлээн авахыг хичээхээс өөр юу ч тоодоггүй, тэд олон жил амьдарсан хэдий ч хүний хувь заяаг захирдаг Бүтээгчийн дээд эрхийн бодит үнэнийг өчүүхэн ч мэдэж, ойлгодоггүй, Бурханы зохион байгуулалт болон зохицуулалтад захирагдах тухай бодит сургамж авах гэж бага ч гэсэн алхам хийгээгүй. Тийм хүмүүс тэр чигээрээ мунхаг, тэд хоосон амьдралаар амьдардаг.

Хэрвээ хүний амьдралын хугацааг амьдралын туршлага болон хувь заяаны талаарх мэдлэгийн түвшнээр нь хуваавал, ойролцоогоор гурван үе шатанд хувааж болно. Эхний үе шат нь төрөхөөс дунд эргэм насны хоорондох он жилүүд буюу төрснөөс гучин нас хүртэлх залуу нас юм. Хоёр дахь үе шат нь дунд наснаас өтөл нас хүртэлх буюу гучаас жаран нас хүртэлх боловсрох явцын үе юм. Гурав дахь үе шат нь жаран наснаас эхлээд хорвоогоос халих хүртэлх, өтөл наснаас эхэлдэг хүний боловсорч гүйцэх үе юм. Өөрөөр хэлбэл, төрснөөсөө эхлээд дунд эргэм нас хүртэл ихэнх хүний, хувь заяа, амьдралын талаарх мэдлэг нь бусдын үзэл санааг дуурайхаар хязгаарлагддаг, бараг ямар ч үнэн, бодитой мөн чанар байдаггүй. Энэ хугацаанд хүний амьдралыг үзэх үзэл, бусад хүмүүстэй харилцах арга зам нь нэлээд өнгөц, гэнэн байдаг. Энэ бол хүний өсвөр насны үе юм. Хүн амьдралын бүх баяр хөөр, уйтгар гунигийг амссаныхаа дараа л хувь заяаны талаар жинхэнэ ойлголт олж авч, дотоод ухамсартаа, зүрх сэтгэлийнхээ гүнд хувь заяаны эргэлт буцалтгүй байдлыг аажмаар ойлгож, хүний хувь заяаг захирдаг Бүтээгчийн дээд эрх үнэхээр оршдогийг аажуухнаар ухаарч эхэлдэг. Энэ бол хүний боловсрох үе юм. Хүн хувь заяаны эсрэг тэмцэхээ больж, цаашид сөргөлдөөнд орох хүсэлгүй болж, харин хувь тавилангаа мэдэж, Тэнгэрийн хүсэлд захирагдаж, амьдралын амжилт, алдааг нэгтгэн дүгнэж, амьдралыг нь шүүх Бүтээгчийн шүүлтийг хүлээдэг болох үед хүн боловсорч гүйцэх үедээ ордог. Энэ гурван үе шатны туршид хүмүүсийн олж авдаг өөр өөр туршлага, олж авдаг зүйлийг авч үзвэл, хэвийн нөхцөлд Бүтээгчийн дээд эрхийг мэдэх завшаан олдох боломж хүнд тийм ч их байдаггүй. Хэрвээ хүн жар насалбал, түүнд Бурханы дээд эрхийг мэдэх гуч орчим жил л байна; хэрвээ хүн илүү урт хугацаа хүсэх юм бол, түүний амьдрал хангалттай урт байвал, хүн зуун жил амьдарч чадвал л энэ нь боломжтой. Иймээс хүний оршин тогтнолын энгийн хуулиар бол хүн Бүтээгчийн дээд эрхийг мэдэх тухай сэдэвтэй анх тулгарсан цагаас эхлээд Бүтээгчийн дээд эрхийн бодит үнэнийг танин мэдэж чадах хүртэл, тэгээд тэндээсээ түүнд захирагдаж чадах үе хүртэл маш урт хугацааны үйл явц байдаг боловч хэрвээ он жилүүдээ үнэхээр тоолоод үзвэл эдгээр шагналыг олж авах боломжтой гуч юм уу дөчөөс ихгүй жил байдаг гэж Би хэлнэ. Хүмүүс ихэвчлэн ерөөл хүлээн авах хүсэл, эрмэлзэлдээ автдаг учраас хүний амьдралын мөн чанар хаана оршдогийг ялган салгаж чаддаггүй, Бүтээгчийн дээд эрхийг мэдэхийн ач холбогдлыг ухаардаггүй. Ийм хүмүүс хүмүүний амьдралыг туулж, Бүтээгчийн дээд эрхийг туулахаар хүний хорвоод ирэх энэхүү үнэт боломжийг нандигнадаггүй бөгөөд бүтээгдсэн зүйлийн хувьд Бүтээгчийн биеэрээ залж чиглүүлэхийг хүлээн авах нь хэчнээн эрхэм нандин болохыг ухаардаггүй. Иймээс Бурханы үнэн биеийг даруйхан харж, аль болох хурдан ерөөгдөхийн тулд, Бурханы ажил хурдан дуусахыг хүсдэг, Бурхан хүний төгсгөлийг аль болох хурдан зохицуулаасай гэж хүсэмжилдэг хүмүүс бол хамгийн дуулгаваргүй байдгаараа гэмтэй, туйлын мунхаг гэж Би хэлнэ. Харин хүмүүсийн дундаас ухаалаг нь, хамгийн хурц ухаантай нь хязгаарлагдмал хугацаандаа Бүтээгчийн дээд эрхийг мэдэх

энэхүү цорын ганц боломжийг шүүрэн авахыг хүсдэг хүмүүс юм. Энэхүү хоёр өөр хүсэл нь асар их ялгаатай хоёр өөр үзэл бодол, эрэл хайгуулыг ил болгодог: Ерөөл эрж хайдаг хүмүүс бол хувиа хичээсэн агаад хүний үнэргүй, Бурханы хүслийг хайхардаггүй, Бурханы дээд эрхийг мэдэх гэж хэзээ ч эрж хайдаггүй, захирагдахыг хэзээ ч хүсдэггүй, харин зүгээр л хүссэнээрээ амьдрахыг хүсдэг. Тэд бол хэнэггүй адгийн шаарнууд бөгөөд энэ ангиллын хүмүүсийг устгах болно. Бурханыг мэдэх гэж эрж хайдаг хүмүүс нь өөрсдийн хүслийг хойш тавьж чаддаг, Бурханы дээд эрх болон Бурханы зохицуулалтад захирагдахад бэлэн байдаг, Бурханы эрх мэдэлд захирагдаж, Бурханы хүслийг хангадаг хүмүүс байхыг чармайдаг. Тийм хүмүүс гэрэлд, Бурханы ерөөлийн дунд амьдардаг, Бурхан тэднийг гарцаагүй сайшаах болно. Юу ч болсон гэсэн, хүний сонголт ямар ч нэмэргүй, Бурханы ажил хэр удахыг хүн шийдэхгүй. Хүмүүс Бурханы эрхшээлд орж, Түүний дээд эрхэд захирагдсан нь дээр. Хэрвээ чи Түүний эрхшээлд орохгүй бол юу хийж чадах вэ? Үр дүнд нь Бурхан хохирох уу? Хэрвээ чи Түүний эрхшээлд орохгүй, харин өөрөө өөртөө эзэн байх гэж хичээвэл чи тэнэг сонголт хийж байгаа хэрэг бөгөөд эцэст нь хохирох хүн ганцхан чи л байх болно. Хүмүүс Бурхантай аль болох хурдан хамтран ажилласан цагт, Түүний зохион байгуулалтыг хүлээн авч, Түүний эрх мэдлийг мэдэж, тэдний төлөө Түүний хийсэн бүхнийг нь ойлгохоор яаравчилсан цагт л тэдэнд итгэл найдвар бий болно. Ингэж байж л тэд амьдралаа хий дэмий өнгөрөөхгүй, авралд хүрэх болно.

Бурханд хүний хувь заяаг захирах дээд эрх байдаг гэсэн бодит үнэнийг хэн ч өөрчилж чадахгүй

Миний дөнгөж сая хэлсэн бүхнийг сонссоны дараа хувь заяаны талаарх та нарын бодол санаа өөрчлөгдсөн үү? Хүний хувь заяаг захирдаг Бурханы дээд эрхийн бодит үнэнийг та нар хэрхэн ойлгодог вэ? Үүнийг энгийнээр хэлбэл, Бурханы эрх мэдэл дор бүх хүн Түүний дээд эрх, зохицуулалтыг идэвхтэйгээр, эсвэл идэвхгүйгээр хүлээн авдаг бөгөөд амьдралынхаа явцад хүн хэрхэн тэмцэж, хэчнээн олон тахир муруй замаар явах нь хамаагүй, эцэстээ Бүтээгчийн өөрт нь зориулан тодорхойлсон хувь заяаны тойрог зам руу буцах болно. Энэ бол Бүтээгчийн эрх мэдлийн даван туулшгүй байдал, Түүний эрх мэдлийн орчлон ертөнцийг хянаж, захирдаг арга барил юм. Энэхүү даван туулшгүй байдал, энэхүү хянан захирах хэлбэр нь бүх зүйлийн амьдралыг захирч, дахин төрлийг саадгүйгээр ахин дахин олох боломжийг хүмүүст олгож, дэлхийг өдрөөс өдөрт, жилээс жилд тогтмол эргүүлж, урагшлуулдаг хуулиудыг хариуцдаг. Та нар энэ бүх бодит үнэнийг нүдээр харсан бөгөөд тэдгээрийг өнгөцхөн ч бай, гүн гүнзгий ч бай ойлгодог, хэр гүнзгий ойлгосон чинь үнэний талаарх мэдлэг, туршлага, Бурханы талаарх мэдлэгээс чинь хамаарна. Үнэн-бодит байдлыг хэр сайн мэддэг, Бурханы үгийг хэр их туулсан, Бурханы мөн чанар, зан чанарыг хэр сайн мэддэг гээд энэ бүгд Бурханы дээд эрх, зохицуулалтын талаарх чиний ойлголт хэр гүнийг

илэрхийлдэг. Бурханы дээд эрх болон зохицуулалтын оршин тогтнол нь хүн тэдгээрт захирагдах эсэхээс хамаардаг уу? Бурханд энэхүү эрх мэдэл байдаг гэсэн бодит үнэн нь хүн төрөлхтөн үүнд захирагдах эсэхээр тодорхойлогддог уу? Бурханы эрх мэдэл нь нөхцөл байдлыг үл харгалзан оршдог. Бүх нөхцөл байдалд Бурхан хүн бүрийн хувь заяа болон бүх зүйлийг Өөрийн бодол, Өөрийн хүслийн дагуу захиран, зохицуулдаг. Хүмүүс өөрчлөгдсөнөөс болж энэ нь өөрчлөгдөхгүй; энэ нь хүний хүслээс хамаарахгүй, цаг хугацаа, орон зай, газар зүйн ямар ч өөрчлөлтөөс болж хувирах боломжгүй, учир нь Бурханы эрх мэдэл бол Түүний үнэн мөн чанар билээ. Хүн Бурханы дээд эрхийг мэдэж, хүлээн авч чадах эсэх, мөн үүнд захирагдаж чадах эсэх нь гэвэл эдгээр нөхцөлийн аль нь ч хүний хувь заяаг захирах Бурханы дээд эрхийн бодит үнэнийг өчүүхэн төдий ч өөрчилдөггүй. Өөрөөр хэлбэл, хүн Бурханы дээд эрхийн талаар ямар хандлагатай байх нь хамаагүй, хүний хувь заяа болон бүх зүйлийг захирах дээд эрх Бурханд байдаг гэсэн бодит үнэнийг өөрчилж ердөө чадахгүй. Чи Бурханы дээд эрхэд захирагддаггүй байсан ч гэсэн Тэр чиний хувь заяаг захирч л байдаг; чи Түүний дээд эрхийг мэдэж чадахгүй байсан ч гэсэн Түүний эрх мэдэл оршсоор л байдаг. Бурханы эрх мэдэл болон хүний хувь заяаг захирдаг Бурханы дээд эрхийн бодит үнэн нь хүний хүслээс хамааралгүй бөгөөд хүний эрхэмлэдэг зүйл, сонголтын дагуу өөрчлөгддөггүй. Бурханы эрх мэдэл хаа сайгүй, цаг тутам, агшин бүрд байдаг. Тэнгэр, газар үгүй болно, харин Түүний эрх мэдэл хэзээ ч үгүй болохгүй, учир нь Тэр бол Бурхан Өөрөө, Түүнд цор ганц эрх мэдэл байдаг, мөн Түүний эрх мэдэл хүмүүс, үйл явдал, юмс, орон зай, газар зүйн байршлаар хязгаарлагддаггүй билээ. Бурхан цаг ямагт Өөрийн эрх мэдлийг ашиглаж, Өөрийн сүр хүчийг харуулж, Өөрийн удирдлагын ажлыг үргэлж хийдэг шигээ үргэлжлүүлдэг; үргэлж хийдэг шигээ л Тэр цаг ямагт бүх зүйлийг захирч, хангаж, зохион байгуулдаг. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Энэ бол бодит үнэн; балар эртний үеэс хойш энэ нь өөрчлөгдөшгүй үнэн байсаар ирсэн!

Бурханы эрх мэдэлд захирагдахыг хүсдэг хүний зөв хандлага ба хэрэгжүүлэлт

Одоо хүн, Бурханы эрх мэдэл болон хүний хувь заяаг захирах Бурханы дээд эрхийн бодит үнэнийг ямар хандлагатайгаар мэдэж, авч үзвэл зохих вэ? Энэ бол хүн бүрийн өмнө тулгардаг бодит асуудал юм. Бодит амьдралын асуудлуудтай тулгарах үедээ чи Бурханы эрх мэдэл болон дээд эрхийг хэрхэн мэдэж, ойлговол зохилтой вэ? Чи эдгээр асуудалтай тулгараад, хэрхэн ойлгож, шийдвэрлэж, туулахыг мэдэхгүй байх үедээ Бурханы дээд эрх болон зохицуулалтад захирагдах санаа зорилго, хүсэл, бодит байдлаа харуулахын тулд ямар хандлага баримталбал зохих вэ? Эхлээд чи хүлээж сурах ёстой; дараа нь чи эрж хайж сурах ёстой; тэгээд чи захирагдаж сурах ёстой. “Хүлээх” гэдэг нь Бурханы цагийг хүлээж, чамд зориулан Түүний зохицуулсан хүмүүс, үйл явдал, юмсыг хүлээж, Түүний хүсэл аажмаар чамд илчлэгдэхийг хүлээнэ гэсэн үг юм. “Эрж хайх” гэдэг нь чиний төлөө

гэсэн Бурханы сайн санааг Түүний бэлдэж тавьсан хүмүүс, үйл явдал, юмсаар дамжуулан ажиглаж ойлгох, тэдгээрээр дамжуулан үнэнийг ойлгох, хүн юу биелүүлэх ёстойг болон түүний дагаж мөрдөх ёстой арга замыг ойлгох, Бурхан хүмүүс дээр ямар үр дүнд хүрэхийг хүсэж, тэднээс Тэр ямар ололт амжилт олж авах санаатай байгааг ойлгох гэсэн үг юм. “Захирагдах” гэдэг нь мэдээж, Бурханы зохион байгуулсан хүмүүс, үйл явдал, юмсыг, Түүний дээд эрхийг хүлээн авч, түүгээр дамжуулан Бүтээгч хүний хувь заяаг хэрхэн захирдаг, Тэр Өөрийн амиар хүнийг хэрхэн хангадаг, хүний дотор үнэнийг хэрхэн оруулдгийг мэдэж авахыг хэлнэ. Бурханы зохицуулалт болон дээд эрхийн доорх бүх зүйл байгалийн хуулийг дуулгавартай дагадаг бөгөөд хэрвээ чи өөрийнхөө бүх зүйлийг зохицуулж, захирахыг Бурханд зөвшөөрөхөөр шийдвэл чи хүлээж, эрж хайж, захирагдаж сурах хэрэгтэй. Энэ бол Бурханы эрх мэдэлд захирагдахыг хүсдэг хүн бүхний баримтлах ёстой хандлага, Бурханы дээд эрх, зохицуулалтыг хүлээн авахыг хүсдэг хүн бүхэнд байх ёстой үндсэн чанар юм. Ийм хандлагатай болж, ийм чанарыг эзэмшихийн тулд чи илүү шаргуу ажиллах ёстой. Жинхэнэ бодит байдалд орж болох цорын ганц арга зам энэ юм.

Бурханыг цор ганц Эзэнээ гэдгийг хүлээн зөвшөөрөх нь авралд хүрэх эхний алхам юм

Бурханы эрх мэдлийн талаарх үнэн нь хүн бүрийн нухацтай авч үзэх ёстой, зүрх сэтгэлээрээ туулж, ойлгох ёстой үнэн юм; учир нь эдгээр үнэн хүн бүрийн амьдралд; хүн бүрийн өнгөрсөн, одоо, ирээдүйд; хүн бүрийн амьдралдаа туулан өнгөрөх ёстой шийдвэрлэх онцгой үеүдэд; Бурханы дээд эрхийн тухай хүний мэдлэг болон Бурханы эрх мэдэлтэй тулгарахдаа баримтлах хандлагад нь; тэгээд мэдээжээр, хүн бүрийн эцсийн хүрэх газарт нөлөөлдөг билээ. Иймээс тэдгээрийг ойлгож, мэдэхэд насан туршийн эрч хүч шаардагддаг. Бурханы эрх мэдлийг нухацтайгаар авч үзэхдээ, Бурханы дээд эрхийг хүлээн зөвшөөрөх үедээ чи Бурханы эрх мэдэл оршин байдаг үнэнийг аажмаар ухаарч, ойлгох болно. Гэвч хэрвээ чи Бурханы эрх мэдлийг хэзээ ч танин мэдэж, Түүний дээд эрхийг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй бол хэчнээн олон жил амьдрах чинь хамаагүй, Бурханы дээд эрхийн талаар өчүүхэн төдий ч мэдлэг олж авч чадахгүй. Хэрвээ чи Бурханы эрх мэдлийг үнэхээр мэдэж, ойлгож чадахгүй бол замын төгсгөлд хүрэх үедээ хэдий Бурханд олон арван жил итгэж байсан ч гэсэн, чамд амьдралаараа харуулах зүйл юу ч байхгүй, хүний хувь заяаг захирах Бурханы дээд эрхийн талаар өчүүхэн ч мэдлэг чамд байхгүй байна. Энэ нь тун гунигтай зүйл бус уу? Иймээс амьдралдаа хэр хол явсан, одоо хэдэн настай, замналын чинь үлдсэн хэсэг хэр урт байх нь хамаагүй, чи эхлээд Бурханы эрх мэдлийг танин мэдэж, нухацтайгаар авч үзэж, Бурхан бол чиний цор ганц Эзэн гэдэг бодит үнэнийг хүлээн зөвшөөрөх ёстой. Хүмүүний хувь заяаг захирдаг Бурханы дээд эрхтэй холбоотой эдгээр үнэний талаар тодорхой, үнэн зөв мэдлэг, ойлголтыг олж авах нь хүн бүрийн заавал авах

сургамж; энэ бол хүний амьдралыг мэдэж, үнэнийг олж авах түлхүүр юм. Өдөр бүр хүн бүрийн нүүр тулдаг, хэний ч зайлсхийж чадахгүй, Бурханыг мэдэх амьдрал, түүнийг сурах үндсэн явц нь ийм билээ. Хэрвээ хэн нэгэн энэ зорилгод хүрэхийн тулд дөт замаар явахыг хүсэж байгаа бол тэр чинь боломжгүй гэдгийг одоо Би чамд хэлчихье! Хэрвээ та нар Бурханы дээд эрхээс зугтахыг хүсэж байгаа бол тэр чинь бүр ч боломжгүй! Бурхан бол хүний цорын ганц Эзэн, Бурхан бол хүний хувь заяаны цорын ганц Эзэн учраас хүн өөрийн хувь заяаг захирах боломжгүй, үүнийг даван гарах боломж ч байхгүй. Хүний ур чадвар хэчнээн агуу байх нь хамаагүй, хүн бусдын хувь заяаг зохион байгуулж, зохицуулж, хянаж, өөрчлөх нь бүү хэл нөлөөлж ч чадахгүй. Зөвхөн цор ганц Бурхан Өөрөө л хүнд зориулж бүх зүйлийг захирч чадна. Учир нь зөвхөн цор ганц Бурхан Өөрөө л хүний хувь заяаг захирах дээд эрх бүхий цорын ганц эрх мэдэлтэй байдаг, Бүтээгч л хүний цор ганц Эзэн билээ. Бурханы эрх мэдэл нь зөвхөн бүтээгдсэн хүн төрөлхтнөөр зогсохгүй, ямар ч хүний харж чадахгүй бүтээгдээгүй зүйлс, одод, сансар огторгуйг захирах дээд эрхийг атгадаг. Энэ бол маргашгүй бодит үнэн, үнэхээр оршин байдаг бодит үнэн бөгөөд ямар ч хүн, зүйл үүнийг өөрчилж чадахгүй. Хэрвээ та нарын нэг нь юмсын байгаа байдалд сэтгэл ханамжгүй хэвээр байж, өөрийгөө зарим нэг онцгой ур чадвар, авьяастай гэж итгэн, аз дайрч, өнөөгийн нөхцөл байдлаа өөрчилж, эсвэл тэдгээрээс зугтаж чадна гэж бодсоор байгаа бол; хэрвээ чи хүний хичээл чармайлтаар хувь заяагаа өөрчлөх гэж оролдон, тэгснээрээ бусдаас ялгаран гарч, алдар нэр, эд баялаг олдог бол; чи юмыг өөртөө л хэцүү болгож байна, чи өөртөө гай л дуудаж, булшныхаа нүхийг ухаж байна гэдгийг Би чамд хэлье! Эрт, орой хэзээ нэгэн өдөр чи буруу сонголт хийж, хичээл зүтгэл чинь талаар өнгөрснийг олж мэдэх болно. Хувь заяаны эсрэг тэмцэх хүсэл, эрмэлзэл болон цадигаа алдсан авир чинь чамайг буцах замгүй болгож, үүнийхээ төлөө чи гашуун төлөөс төлөх болно. Хэдийгээр одоогоор чи үр дагаврын айхтар ноцтой байдлыг ойлгохгүй байгаа ч гэсэн, Бурхан бол хүний хувь заяаны Эзэн хэмээх үнэнийг улам илүү гүнзгий мэдэрч, ойлгохын хэрээр Миний өнөөдрийн ярьж байгаа зүйл болон үүний жинхэнэ утга санааг аажмаар ухаарч эхэлнэ. Чамд зүрх сэтгэл, сүнс үнэхээр бий эсэх, чи үнэнийг хайрладаг хүн мөн эсэх нь, Бурханы дээд эрх болон үнэний талаар ямар хандлагатай вэ гэдгээс чинь хамаардаг. Мэдээжийн хэрэг энэ нь Бурханы эрх мэдлийг үнэхээр мэдэж, ойлгож чадаж байгаа эсэхийг чинь тодорхойлдог. Хэрвээ чи амьдралдаа Бурханы эрх мэдлийг танин мэдэж, хүлээн зөвшөөрөх нь байтугай Бурханы дээд эрх болон Түүний зохицуулалтыг хэзээ ч мэдэрч байгаагүй бол явсан зам, хийсэн сонголтынхоо үрээр чи ямар ч хэрэггүй болж, эргэлзээгүй Бурханд жигшигдэн, гологдоно. Гэхдээ Бурханы ажилд Түүний шалгалт, дээд эрхийг хүлээн зөвшөөрч, Түүний эрх мэдэлд захирагдаж, Түүний үгийг аажмаар жинхэнээсээ туулдаг хүмүүс нь Бурханы эрх мэдлийн тухай жинхэнэ мэдлэгтэй болж, Түүний дээд эрхийн тухай жинхэнэ ойлголтыг олж авсан байх болно; тэд үнэхээр Бүтээгчид захирагдсан байх болно. Ийм хүмүүс л үнэхээр аврагдсан байх болно. Тэд Бурханы

дээд эрхийг мэдсэн, үүнийг хүлээн зөвшөөрсөн учраас хүний хувь заяаг захирах Бурханы дээд эрхийн бодит үнэнийг ойлгож, түүнд захирагдах нь бодитой, үнэн зөв байдаг. Үхэлтэй нүүр тулах үедээ тэд Иовын адилаар ямар ч хувийн сонголт, хүсэлгүйгээр бүх зүйл дээр Бурханы зохион байгуулалт, зохицуулалтад захирагдаж, үхлээс айдаггүй сэтгэлтэй байж чадна. Ийм хүмүүс л жинхэнэ бүтээгдсэн хүний хувиар Бүтээгчийн дэргэд эргэн очиж чадна.

2013 оны 12 дугаар сарын 17

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ IV
БУРХАНЫ АРИУН БАЙДАЛ (I)

Сүүлийн цуглааны үеэр бид Бурханы эрх мэдлийн талаар цааш нь нэмж нөхөрлөсөн. Одоохондоо Бурханы зөвт байдлын тухай сэдвийг хэдүүлээ ярилцахгүй. Өнөөдөр бид цоо шинэ сэдэв буюу Бурханы ариун байдлын талаар ярина. Бурханы ариун байдал бол Бурханы хосгүй мөн чанарын өөр нэгэн тал, иймээс энэ сэдвийн тухай нөхөрлөх нь чухал билээ. Би өмнө нь Бурханы зөвт зан чанар болон Бурханы эрх мэдэл хэмээх хоёр талын тухай нөхөрлөсөн; энэ талууд, мөн өнөөдөр Миний нөхөрлөх гэж буй тал бүгд цор ганц биш гэж үү? (Тийм.) Бурханы ариун байдал ч бас хосгүй, иймээс бидний өнөөдрийн нөхөрлөлийн сэдэв бол энэхүү хосгүй байдлын суурь, сурвалжийг юу бүрдүүлдэг тухай байх болно. Өнөөдөр бид Бурханы хосгүй мөн чанар—Бурханы ариун байдлын тухай нөхөрлөх болно. Та нарын заримд эргэлзээ төрж, “Яагаад Бурханы ариун байдлыг нөхөрлөх хэрэгтэй юм бэ?” хэмээн асууж байгаа байх. Бүү санаа зов, Би та нарт үүнийг алгуурхнаар ярьж өгнө. Миний юу хэлэхийг сонсоод энэ сэдвийн талаар нөхөрлөх нь Надад яагаад тийм чухал болохыг та нар мэднэ.

Эхлээд “ариун” гэдэг үгийг тодорхойлцгооё. Өөрийн ойлголт болон олж авсан бүх мэдлэгээсээ хараад “ариун” гэдэг үгийн тодорхойлолтыг та нар юу гэж ойлгож байна вэ? (“Ариун” гэдэг нь хиртээгүй бөгөөд хүний ялзрал, өө сэв огт байхгүй гэсэн үг. Ариун байдал нь бодолд ч бай, яриа, эсвэл үйлдэлд ч бай бүхий л эерэг зүйлийг гэрэлтүүлдэг.) Маш сайн байна. (“Ариун” гэдэг бол гэгээн, хиртээгүй, хүн халдаж чадашгүй. Энэ нь хосгүй, гагцхүү Бурханых бөгөөд Түүний бэлгэ тэмдэг билээ.) Энэ бол та нарын тодорхойлолт. “Ариун” хэмээх энэ үг хүн бүрийн зүрх сэтгэлд цар хэмжээ, тодорхойлолт болон тайлбартай байдаг. Хамгийн наад зах нь “ариун” хэмээх үгийг харах үед та нарын оюун ухаан хоосон байдаггүй. Та нарт энэ үгийг тодорхойлох зарим нэгэн цар хэмжээ байдаг бөгөөд зарим хүний хэлдэг үг Бурханы зан чанарын мөн чанарыг тодорхойлдогтой зарим талаар ойртож очдог. Энэ бол маш сайн. Ихэнх хүмүүс “ариун” хэмээх үг нь эерэг үг гэж итгэдэг бөгөөд энэ нь чухам үнэн. Гэхдээ өнөөдөр бид Бурханы ариун байдлын талаар нөхөрлөхдөө Би зүгээр л тодорхойлолт, тайлбарын тухай ярихгүй. Харин Би Бурханыг яагаад ариун гэдэг, мөн Бурханы мөн чанарыг тодорхойлохдоо яагаад “ариун” хэмээх үгийг ашигладгаа чамд үзүүлэхийн тулд нотолгоо болгон хэдэн баримт харуулна. “Ариун” хэмээх үгийг Бурханы мөн чанарыг тодорхойлоход болон Бурханы тухай ярихдаа ашиглах нь бүрэн зүй ёсны агаад хамгийн зохистой юм гэдгийг нөхөрлөл дуусах үеэр чи мэдрэх болно. Хамгийн наад зах нь, хүн төрөлхтний одоогийн хэлний орчинд энэ үгийг Бурханы тухай ярихдаа ашиглах нь нэн оновчтой—энэ нь хүний хэлний бүх үгийн дотор Бурханыг тодорхойлоход бүрэн тохирох цорын ганц үг юм. Бурханыг тодорхойлоход хэрэглэх энэ үг бол дэмий хоосон үг ч биш, ул үндэсгүй магтаал эсвэл хоосон бялдуучлалын ч нэр биш. Бидний нөхөрлөлийн зорилго бол

Бурханы мөн чанарын энэ талын тухай үнэнийг танин мэдэх боломжийг хүн бүхэнд олгох явдал юм. Бурхан хүний ойлголтоос айдаггүй, харин буруугаар ойлгохоос нь айдаг. Хүн бүхэн Түүний мөн чанарыг болон Түүнд юу байгаа, Тэр юу болохыг мэдээсэй гэж Бурхан хүсдэг. Иймээс Бурханы мөн чанарын нэг талыг дурдах болгондоо бид, Бурханы мөн чанарын энэ тал үнэхээр оршдог гэдгийг харах боломжийг хүмүүст олгох олон баримтыг гаргаж болно.

Одоо бид “ариун” хэмээх үгийн тодорхойлолтыг мэдсэн болохоор хэдэн жишээ ярилцъя. Хүмүүс өөрсдийн үзлээр олон зүйл болон хүнийг “ариун” гэж төсөөлдөг. Жишээлбэл, хүн төрөлхтний толь бичигт онгон хөвгүүд, охидыг ариун гэж тодорхойлдог. Гэхдээ тэд үнэндээ ариун уу? Энэхүү “ариун” гэгч нь бидний өнөөдөр нөхөрлөх “ариунтай” нэг адил уу? Хүмүүсийн дундах ёс суртахуун сайтай, төгөлдөр, боловсон яриатай, хэнд ч хэзээ ч гэм хийдэггүй, үг яриагаараа бусдыг аятай, таатай байлгадаг хүмүүс ариун уу? Үргэлж сайныг хийж, бусдад асар их тусламж үзүүлдэг өглөгч хүмүүс болон хүмүүсийн амьдралд их баяр цэнгэл авчирдаг хүмүүс ариун уу? Өөртөө ашигтай бодол тээдэггүй, хэнд ч хатуу ширүүн шаардлага тавьдаггүй, хүн бүрд хүлээцтэй ханддаг хүмүүс ариун уу? Хэнтэй ч хэзээ ч маргалдаж байгаагүй, эсвэл хэнийг ч ашиглаж байгаагүй хүмүүс ариун уу? Бусдын сайн сайхны төлөө ажилладаг, бусдад тус дэм үзүүлж, бүх талаар бусдад сургамж сургаал хайрладаг хүмүүс ариун уу? Насан туршийнхаа хадгаламжийг бусдад өгч, энгийн амьдралаар амьдардаг, өөртөө хатуу чанга боловч бусдад өгөөмөр ханддаг хүмүүс ариун уу? (Үгүй.) Ээж нар чинь та нарт анхаарал тавьж, боломжит бүх аргаар харж хандсаныг та нар бүгд санадаг—тэд ариун уу? Алдартай хүмүүс, одод, эсвэл агуу хүмүүс ч бай та нарын эрхэмлэдэг шүтээнүүд ариун уу? (Үгүй.) Олон хүний хувьд үл мэдэгдэх ирээдүйг хэлж чаддаг байсан Библи дэх эш үзүүлэгчдийг одоо авч үзье—тэр хүмүүс ариун байсан уу? Бурханы үг болон Түүний ажлын баримтуудыг Библид тэмдэглэж чадсан хүмүүс ариун байсан уу? Мосе ариун байсан уу? Абрахам ариун байсан уу? (Үгүй.) Иовыг юу гэх вэ? Тэр ариун байсан уу? (Үгүй.) Бурхан Иовыг зөвт хүн гэсэн, тэгвэл яагаад түүнийг ч гэсэн ариун биш гэж байна вэ? Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүмүүс үнэхээр ариун биш гэж үү? Тэд ариун уу, үгүй юу? (Үгүй.) Та нар жаахан итгэлгүйхэн, хариултыг нь сайн мэдэхгүй бөгөөд “Үгүй” гэж хэлж зүрхлэхгүй боловч “Тийм” гэж хэлж ч бас зүрхэлдэггүй тул эцэст нь шийдэмгий бусаар “Үгүй” гэж хэлдэг. Би өөр нэг асуулт асууя. Бурханы элчүүд—газарт Бурханы илгээдэг элчүүд ариун уу? Тэнгэрэлчүүд ариун уу? (Үгүй.) Сатаны ялзруулаагүй хүн төрөлхтөн ариун уу? (Үгүй.) Та нар асуулт болгонд “Үгүй” гэж хариулаад л байна. Юуны үндсэн дээр? Та нар будилж байна, тийм биз дээ? Тэгэхээр, яагаад тэнгэрэлчүүдийг хүртэл ариун биш гэж байгаа юм бэ? Та нар одоо итгэлгүйхэн байна, тийм үү? Өмнө нь бидний дурдсан хүмүүс, юмс, эсвэл бүтээгдээгүй зүйлс юуны үндсэн дээр ариун биш байдгийн учрыг та нар олж чадах уу? Та нар чадахгүй гэдэгт Би итгэлтэй байна. Иймээс та нарын “Үгүй” гэж хэлж байгаа нь бага зэрэг хариуцлагагүй бус уу? Та нар сохроор

хариулж байгаа биш үү? “Та ийм байдлаар асуусан болохоор хариу нь гарцаагүй ‘Үгүй’ байх ёстой” гэж зарим хүн гайхаж байгаа. Надад хялбар хариулт бүү өг. Хариулт “Тийм” байх уу, “Үгүй” байх уу гэж сайн бод. Бид дараах сэдвийн талаар нөхөрлөсний дараа хариулт яагаад “Үгүй” байхыг та нар мэдэх болно. Би та нарт хариултыг нь удахгүй өгнө. Эхлээд судраас уншицгаая.

1. Хүнд өгсөн Ехова Бурханы тушаал

Эхлэл 2:15–17 Ехова Бурхан хүнийг авч, Еден цэцэрлэгийг арчлуулан мануулахын тулд тэнд суулгажээ. Ехова Бурхан хүнд тушааж, “Цэцэрлэгийн бүх модны жимсээс чөлөөтэй идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс л идэж болохгүй, учир нь идсэн тэр өдөртөө л чи гарцаагүй үхнэ” хэмээв.

2. Могой, эмэгтэйг уруу татсан нь

Эхлэл 3:1–5 Ехова Бурханы бүтээсэн ямар ч хээрийн араатан амьтдаас могой хамгийн зальтай нь байлаа. Тэр могой эмэгтэйгээс, “Та нарт энэ цэцэрлэг дэх бүх модны жимснээс идэж болохгүй гэж Бурхан үнэхээр хэлсэн үү?” гэжээ. Тэр эмэгтэй могойд, “Бид энэ цэцэрлэгийн модны жимсийг идэж болно, харин энэ цэцэрлэгийн голд байгаа модны жимсний тухайд Бурхан, ‘Та нар үүнээс идэж болохгүй, мөн хүрч ч болохгүй, эс бөгөөс та нар үхнэ’ гэж айлдсан” хэмээжээ. Тэгэхэд могой эмэгтэйд хандан, “Та нар үхэхгүй байж магадгүй, учир нь та нар үүнийг идсэн өдөртөө л нүд чинь нээгдэж, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ” гэжээ.

Энэ хоёр хэсэг нь Библийн Эхлэл номын эшлэл юм. Та нар бүгдээрээ энэ хоёр хэсгийг мэдэх үү? Энэ нь хүн төрөлхтөн анх бүтээгдэх үеийн эхэнд тохиолдсон үйл явдлуудад холбоотой юм; эдгээр үйл явдал нь бодитой байсан. Адам, Ева хоёрт Ехова Бурхан ямар тушаал өгснийг эхлээд харцгаая; энэхүү тушаалын агуулга манай өнөөдрийн сэдэвт маш чухал юм. “Ехова Бурхан хүнд тушааж, ‘Цэцэрлэгийн бүх модны жимсээс чөлөөтэй идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс л идэж болохгүй, учир нь идсэн тэр өдөртөө л чи гарцаагүй үхнэ’ хэмээв.” Энэ хэсэг дэх хүнд өгсөн Бурханы тушаалын гол санаа юу байна вэ? Нэгдүгээрт, юу идэж болохыг, тухайлбал, олон янзын модны жимсийг идэж болно гэдгийг Бурхан хүнд хэлдэг. Ямар ч аюул, ямар ч хор байхгүй; бүгдийг нь хүн хүссэнээрээ санаа зовж, эргэлзэх юмгүй идэж болно. Энэ бол Бурханы тушаалын нэг хэсэг нь. Нөгөө хэсэг нь анхааруулга. Энэхүү анхааруулгаар Бурхан сайн мууг мэдүүлэгч модноос жимс идэх ёсгүй гэж хүнд хэлдэг. Энэ модноос идвэл юу тохиолдох вэ? Бурхан хүнд: “Хэрвээ үүнийг идвэл чи гарцаагүй үхнэ” гэж хэлсэн. Эдгээр үг ойлгоход хялбар байна уу? Хэрвээ Бурхан чамд энийг хэлсэн боловч чи яагаад гэдгийг нь ойлгоогүй бол Түүний үгийг дагах дүрэм, эсвэл тушаал гэж чи үзэх байсан уу? Ийм үгийг дагах ёстой. Гэхдээ хүн дагаж чадах ч бай, үгүй ч бай, Бурханы үг хоёрдмол санаагүй. Бурхан хүнд юу идэж болох, юу идэж болохгүйг нь болон идэж болохгүйг идвэл юу тохиолдохыг маш тодорхой хэлсэн. Бурханы

хэлсэн эдгээр товчхон үгээс чи Бурханы ямар нэг зан чанарыг харж байна уу? Бурханы эдгээр үг үнэн үү? Ямар нэгэн хууран мэхлэлт байна уу? Ямар нэгэн худал хуурмаг байна уу? Ямар нэг сүрдүүлэг байна уу? (Үгүй.) Бурхан хүнд юу идэж болох, юу идэж болохгүйг ний нуугүй, үнэн сэтгэлээсээ, чин санаанаасаа хэлсэн. Бурхан тодорхой, түс тас хэлсэн. Эдгээр үгэнд ямар нэгэн далд утга байна уу? Эдгээр үг шулуухан бус уу? Таамаглах хэрэг байна уу? Таавар хэрэггүй. Тэдгээрийн утга нь хармагц илт. Үүнийг уншаадхүн утгыг нь бүрэн ойлгох шиг болдог. Өөрөөр хэлбэл, Бурхан юу хэлэхийг хүсдэг, юу илэрхийлэхийг хүсдэг нь Түүний зүрх сэтгэлээс гардаг. Бурханы илэрхийлдэг зүйлс цэвэр, ойлгоход хялбар бөгөөд тодорхой байдаг. Ямар ч нууц сэдэл, эсвэл ямар ч далд утга байдаггүй. Тэр хүнд юу идэж болохыг, юу идэж болохгүйг нь хэлж, шууд ярьдаг. Өөрөөр хэлбэл, Бурханы эдгээр үгээр дамжуулан Бурханы зүрх сэтгэл илэрхий бөгөөд үнэн юм гэдгийг хүн харж болно. Энд худал хуурмагийн мөр ч байдаггүй; идэж болох зүйлийг идэж болохгүй гэж хэлэх юм уу, идэж болохгүй зүйлийг “Идээд үз, тэгээд юу болохыг хар” гэж хэлдэг юм биш. Бурхан тэгэх гэдэггүй. Бурхан зүрх сэтгэлдээ юу бодож байна, түүнийгээ л хэлдэг. Тэр ийм байдлаар эдгээр үгэн дотор Өөрийгөө харуулж, илчилдэг учраас Бурхан бол ариун гэж Би хэлэх юм бол туулайн чинээ юмыг уулын чинээ болгож, эсвэл арай л хэтрүүлсэн мэт чамд санагдаж магад. Хэрвээ тийм бол бүү санаа зов; бид хараахан дуусаагүй байна.

“Могой эмэгтэйг уруу татсан” талаар ярилцъя. Могой хэн бэ? Сатан. Сатан Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөнд товойлгогчийн үүрэг гүйцэтгэсэн ба энэ бол Бурханы ариун байдлын талаар нөхөрлөхдөө дурдах ёстой үүрэг роль юм. Би яагаад ингэж хэлж байна вэ? Хэрвээ чи Сатаны ёрын муу ба ялзралыг мэдэхгүй бол, эсвэл Сатаны уг чанарыг мэдэхгүй бол ариун байдлыг ухаарах аргагүй, мөн үнэндээ ариун байдал гэж юу болохыг мэдэж ч чадахгүй. Төөрөлдөж будилсандаа хүмүүс Сатаны хийдэг зүйл бол зөв гэж итгэдэг, учир нь тэд ийм ялзармал зан чанарын дотор амьдардаг. Товойлгогчгүй, харьцуулах юмгүй бол чи ариун байдал гэж юу болохыг мэдэж чадахгүй. Тийм учраас Сатаныг энд дурдах ёстой. Ингэж дурддаг нь хоосон яриа биш. Харин Сатаны үг, үйл хэргээр дамжуулан Сатан хэрхэн авирладгийг, хүн төрөлхтнийг хэрхэн ялзруулдгийг, мөн Сатаны уг чанар, нүүр царай ямар болохыг бид харна. Тэгвэл уг эмэгтэй могойд юу гэж хэлсэн бэ? Тэр эмэгтэй Ехова Бурхан өөрт нь юу хэлснийг могойд нэгд нэгэнгүй тоочсон. Эдгээр үгийг хэлэхдээ Өөрт нь Бурханы хэлсэн зүйл үнэн гэдэгт тэр итгэж байсан уу? Тэр үнэмшиж чадаагүй. Шинээр бүтээгдсэн нэгэн учир түүнд сайн, мууг ялгах чадвар байгаагүй, мөн өөрийнхөө эргэн тойрны аливаа зүйлийн талаар ямар ч ойлголт байгаагүй. Түүний могойд хэлсэн үгээс үзэхэд, Бурханы үг зөв гэдэгт зүрх сэтгэлдээ эргэлзэж байсан; түүний хандлага ийм байв. Иймээс уг эмэгтэй Бурханы үгэнд эргэлзээтэй хандлагатай байхыг могой хараад: “Та нар үхэхгүй байж магадгүй, учир нь та нар үүнийг идсэн өдөртөө л нүд чинь нээгдэж, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ” гэж хэлсэн юм. Эдгээр

үгэнд будлиантай зүйл байна уу? Энэ өгүүлбэрийг уншихдаа та нар могойн цаад санаа зорилгыг мэдэрч байна уу? Тэр санаа зорилго нь юу байв? Тэр, энэ эмэгтэйг уруу татах, Бурханы үгийг тоохыг нь болиулахыг хүссэн. Гэвч эдгээр зүйлийг шулуухан хэлээгүй. Иймээс тэр бол маш зальтай гэж бид хэлж болно. Дотроо хав дарж, хүнээс нуудаг өөрийн зорьсон зорилгод хүрэхийн тулд тэр санааг зальжин, тойруу замаар илэрхийлдэг—энэ бол могойн заль мэх юм. Энэ нь үргэлж Сатаны ярьж, үйлдэж ирсэн арга зам байсан билээ. Тэрээр аль нэгийг нотлохгүйгээр "магадгүй" гэж хэлдэг. Гэхдээ үүнийг сонсоод энэ мэдлэггүй эмэгтэйн сэтгэл хөдөлсөн. Үг нь хүссэн үр нөлөөгөө үзүүлсэн учраас могой баярласан—могойн зальт санаа ийм байсан юм. Түүнээс гадна, хүмүүст хүсүүштэй санагддаг үр дүнг амлан эмэгтэйг уруу татаж, "үүнийг идсэн өдөртөө л нүд чинь нээгдэх болно" гэжээ. Иймээс эмэгтэй эргэцүүлж: "Миний нүд нээгдэнэ гэдэг бол сайн зүйл!" гэж бодно. Дараа нь могой бүр ч их хорхой хүрэм зүйлийг, хүн урьд өмнө огт мэдээгүй үгийг, сонссон хүмүүсийг уруу татах асар их хүчтэй үгийг хэлсэн: "Та нар Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно." Эдгээр үг хүнийг уруу татах хүчирхэг биш гэж үү? Энэ нь хэн нэгэн чамд: "Хамрын чинь хянга л жаахан намхан болохоос биш чиний царай гайхалтай хэлбэртэй юм. Үүнийгээ засуулчихвал дэлхийн хэмжээний үзэсгэлэн гоо бүсгүй болно оо!" гэж хэлэхтэй адилхан. Эдгээр үг нь урьд нь гоо сайхны мэс засал хийлгэх ямар ч хүсэл хэзээ ч агуулж байгаагүй хүний сэтгэлийг нь хөдөлгөх үү? Эдгээр үг уруу татмаар биш үү? Энэ уруу таталт нь чиний хорхойг хүргэхгүй гэж үү? Энэ нь сорилт биш гэж үү? (Мөн.) Бурхан иймэрхүү зүйл хэлдэг үү? Бидний дөнгөж сая нягтлан уншсан Бурханы үгэнд энэ талаар ямар нэг битүү сануулга байсан уу? Бурхан Өөрийн зүрх сэтгэлд бодож байгаа зүйлээ хэлдэг үү? Бурханы үгээс хүн зүрх сэтгэлийг нь харж чадах уу? (Чадна.) Харин могой эдгээр үгийг тэр эмэгтэйд хэлэх үед чи могойн зүрх сэтгэлийг харж чадсан уу? Үгүй. Хүний мэдлэггүй байдлын улмаас хүн могойн үгэнд амархан уруу татагдаж, хялбархан мэхлэгдсэн. Тэгвэл чи Сатаны санаархлыг харж чадсан уу? Чи түүний хэлсэн зүйлийн цаадах зорилгыг харж чадсан уу? Чи Сатаны явуулга болон заль мэхийг харж чадсан уу? (Үгүй.) Сатаны ярих арга зам ямар зан чанарыг төлөөлдөг вэ? Эдгээр үгээр дамжуулан чи Сатаны ямар мөн чанарыг харсан бэ? Зальжин бус уу? Магадгүй гадна талдаа тэр чам руу инээмсэглэж, эсвэл ямар ч илэрхийлэл үзүүлэхгүй байж болох юм. Гэхдээ зүрх сэтгэлдээ тэр өөрийнхөө зорилгод хэрхэн хүрэхээ тооцоолж байдаг бөгөөд чиний харж чадахгүй зүйл бол энэхүү зорилго юм. Чамд өгдөг түүний бүх амлалт, түүний ярьдаг бүх ашиг хонжоо нь түүний уруу таталтын халхавч юм. Чи тэдгээр зүйлийг сайн гэж үзэх ба түүний хэлдэг нь Бурханы хэлдгээс илүү хэрэгтэй, илүү бодитой мэт санагдана. Энэ үед хүн хүлцэнгүй хоригдол болохгүй гэж үү? Сатаны ашигласан энэ аргууд хэрцгий биш гэж үү? Чи өөрийгөө доройтолдыг оруулдаг. Сатан хуруугаа ч хөдөлгөх хэрэггүй, энэ хоёр өгүүлбэрийг хэлэх төдийд чи Сатаныг дагаж, Сатаны үгэнд орох дуртай болдог. Ийнхүү Сатаны зорилго биелдэг. Энэ санаархал нь хорлонтой биш гэж үү?

Энэ нь Сатаны хамгийн гол нүүр царай биш гэж үү? Сатаны үгээс хүн түүний хорлонтой сэдлийг харж, түүний зэвүүн нүүр царайг болон мөн чанарыг харж чадна. Тийм биш гэж үү? Эдгээр өгүүлбэрийг задлан шинжлэлгүй харьцуулахад Еховагийн үг сонирхолгүй, ердийн, улиг болсон мэт, мөн тэдгээр нь Бурханы үнэнч шударга занг магтаж ихэд бахдан ярихыг зөвтгөхгүй юм шиг чамд санагдаж магадгүй юм. Гэхдээ бид Сатаны үгийг болон түүний зэвүүн нүүр царайг товойлгогч болгонавч үзэхэд Бурханы эдгээр үг өнөөдрийн хүмүүст чухал нөлөөтэй юу? (Тийм.) Хүн энэ харьцуулалтаас Бурханы цэвэр ариун өө сэвгүй байдлыг харж чадна. Сатаны хэлдэг үг бүр, түүнчлэн Сатаны сэдэл, санаархал болон ярих байдал нь—бүгд хольцтой байдаг. Түүний ярих аргын гол онцлог юу вэ? Чамайг уруу татахын тулд тэр чамд хуурмаг зангаа харуулахгүйгээр, мөн түүний зорилгыг ялган салгах боломж олгохгүйгээр булзаж займруулсан үг хэрэглэдэг; Сатан чамд өгөөш үмхүүлдэг, гэхдээ чи бас түүнийг магтаж, ач гавьяаг нь дуулах хэрэгтэй. Энэ заль нь Сатаны сонголтын заншсан арга биш гэж үү? (Мөн.) Одоо Сатаны өөр ямар үг болон илэрхийлэл нь түүний зэвүүн нүүр царайг харах боломжийг хүнд олгодгийг харцгаая. Судраас дахиад хэдэн бичвэр уншицгаая.

3. Сатан, Ехова Бурхан хоёрын харилцан яриа

Иов 1:6–11 Нэгэн өдөр Бурханы хөвгүүд өөрсдийгөө Еховагийн өмнө үзүүлэхээр ирэхэд тэдний дунд Сатан бас ирэв. Ехова Сатанаас, “Чи хаанаас ирэв?” гэхэд Сатан Еховад хариулан, “Газар дэлхий дээгүүр хэрэн хэсүүчилж, энүүгээр тэрүүгээр явсаар ирлээ” гэв. Тэгээд Ехова Сатанд, “Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй” хэмээв. Дараа нь Сатан Еховад хариулж, “Иов Бурханаас учир шалтгаангүйгээр эмээдэг гэж үү? Та түүнийг, түүний байшинг тойруулж, түүнд буй бүхнийг нь тойруулж хашаалаагүй гэж үү? Та түүний гарын ажлыг ерөөсөн, тэгээд түүний эд хөрөнгө энэ нутагт олширсон. Харин одоо гараа сунган түүнд буй бүхэнд хүр, тэгээд тэр Таны өөдөөс хараах болно” гэв.

Иов 2:1–5 Өөр нэг өдөр Бурханы хөвгүүд өөрсдийгөө Еховагийн өмнө үзүүлэхээр ирэхэд тэдний дунд Сатан бас ирэв. Ехова Сатанаас, “Чи хаанаас ирэв?” гэлээ. Сатан Еховад хариулан, “Газар дэлхий дээгүүр хэрэн хэсүүчилж, энүүгээр тэрүүгээр явсаар ирлээ” гэв. Ехова Сатанд хандан, “Миний зарц Иовын талаар чи анзаарсан уу? Бурханаас эмээж, муугаас зайлдаг төгс агаад шулуун шударга түүн шиг хүн газар дээр нэг ч үгүй. Түүнийг шалтгаангүйгээр устгахын тулд чи Намайг түүний эсрэг турхирсан ч тэр үнэнч шударга байдлаа гуйвалтгүй хадгалж байна” хэмээв. Мөн Сатан Еховад хариулж, “Арьсыг арьсаар, тийм ээ, хүн өөртөө байгаа бүхнийг амийнхаа төлөө өгөх л болно. Харин Чи одоо гараа сунгаад түүний яс, маханд нь хүр, тэр Чиний өөдөөс хараах болно” гэв.

Энэ хоёр хэсэг нь бүхэлдээ Бурхан, Сатан хоёрын харилцан ярианаас бүрддэг; тэдгээр нь Бурхан юу хэлснийг, Сатан юу хэлснийг тэмдэглэсэн. Бурхан их яриагүй, Тэр тун энгийнээр ярьсан. Түүний энгийн үгээс бид Бурханы ариун байдлыг харж

чадах уу? Ингэхэд амархан биш гэж зарим хүн хэлнэ. Тэгвэл бид Сатаны зэвүүн байдлыг хариултаас нь харж чадах уу? Ехова Бурхан Сатанаас ямар асуулт асуусныг эхлээд харцгаая. “Чи хаанаас ирэв?” Энэ тодорхой асуулт биш үү? Энд далд утга байна уу? Үгүй; энэ нь зүгээр л илэн далангүй асуулт. Хэрвээ Би таараас: “Чи хаанаас ирэв?” гэж асуусан бол та нар юу гэж хариулах байсан бэ? Энэ хариулахад хэцүү асуулт уу? Та нар: “Хэрэн хэсүүчилж, энүүгээр тэрүүгээр явсаар ирлээ” гэх байсан уу? (Үгүй.) Та нар ингэж хариулахгүй. Тэгэхээр Сатан ингэж хариулахыг хараад та нарт ямар санагдах вэ? (Сатан бол хөгийн байна, гэхдээ бас зальхай юм гэж санагддаг.) Надад ямар санагдаж байгааг та нар хэлж чадах уу? Эдгээр үгийг харах бүр Миний зэвүү хүрдэг, учир нь Сатан ярьдаг боловч үг нь ямар ч бодит юм агуулдаггүй! Тэр Бурханы асуултад хариулсан уу? Үгүй, Сатаны хэлсэн үг хариулт биш байсан, тэдгээр нь юу ч хэлж өгөөгүй. Тэр нь Бурханы асуултын хариулт биш байсан. “Газар дэлхий дээгүүр хэрэн хэсүүчилж, энүүгээр тэрүүгээр явсаар ирлээ.” Чи эдгээр үгийг юу гэж ойлгож байна вэ? Сатан яг хаанаас ирсэн бэ? Та нар энэ асуултад хариулт авсан уу? (Үгүй.) Энэ бол үнэндээ яг юу хэлж байгаагаа хэнд ч мэдэгдэхгүй байх Сатаны зальхай хар санааны “суу билэг” юм. Тэр хариулаад дуусчихсан байхад ч гэсэн чи эдгээр үгийг сонсоод түүний хэлсэн зүйлийг бас л ялган салгаж чадахгүй. Сатан өөрийгөө төгс хариулсан гэж боддог. Тэгвэл чамд ямар санагддаг вэ? Зэвүүн үү? (Тийм.) Одоо чи эдгээр үгэнд зэвүүцэж эхэлж байна. Сатаны үг тодорхой онцлогтой байдаг: Чи Сатаны хэлсэн зүйлийн эх сурвалжийг ухамсарлаж чадалгүй хуйхаа маажаад үлддэг. Заримдаа Сатан сэдэл өвөрлөж, зориуд ярьдаг, заримдаа уг чанартаа захирагдаж, тиймэрхүү үгс аяндаа Сатаны амнаас шууд гарч ирдэг. Сатан иймэрхүү үгийг дэнслэхэд удаан хугацаа зарцуулдаггүй; харин ч бодолгүйгээр илэрхийлдэг. Хаанаас ирснийг нь Бурхан асуухад Сатан хоёрдмол утгатай хэдхэн үгээр хариулсан. Чи маш их будилж, Сатан яг хаанаас ирснийг хэзээ ч мэддэггүй. Та нарын дунд ингэж ярьдаг хүн бий юу? Энэ нь яаж ярьж байгаа хэрэг вэ? (Энэ нь хоёрдмол утгатай бөгөөд тодорхой хариулт өгдөггүй.) Ийм маягаар ярихыг дүрслэхийн тулд бид ямар үг ашиглах ёстой вэ? Энэ нь анхаарал сарниулж, төөрөгдүүлдэг. Нэг хүн өчигдөр юу хийснээ бусдад мэдэгдэхийг хүсэхгүй байлаа гэж үзье. Чи түүнээс “Би чамайг өчигдөр харсан. Чи хаашаа явж байсан юм бэ?” гэж асуувал тэр хаашаа явснаа чамд шууд хэлэхгүй. Харин “Өчигдөр ямар өдөр байв аа. Их ядарсан шүү!” гэнэ. Тэр чиний асуултад хариулсан уу? Хариулсан, гэхдээ тэр нь чиний хүссэн хариулт биш. Энэ бол хүний үг ярианы арга залийн “суу билэг” юм. Чи тэр нь юу гэсэн үг болохыг хэзээ ч олж мэдэж, эсвэл үгийнх нь эх сурвалж буюу санаа зорилгыг ойлгож чадахгүй. Түүний зүрх сэтгэлд өөрийнх нь түүх байгаа учраас тэр юунаас зайлсхийх гээд байгааг чи мэдэхгүй—энэ нь дотуур тамиртай байдал юм. Та нарын дунд ч бас дандаа ингэж ярьдаг хүн байгаа юу? (Байгаа.) Тэгвэл та нарын зорилго юу вэ? Заримдаа өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалахын төлөө, заримдаа өөрсдийн бахархал, байр суурь, дүр төрхийг хадгалж, хувийн амьдралынхаа нууцыг хамгаалахын төлөө

байдаг уу? Зорилго нь ямар ч байлаа гэсэн, энэ нь та нарын ашиг сонирхлоос салшгүй, ашиг сонирхолтой чинь холбоотой байдаг. Энэ нь хүний уг чанар биш гэж үү? Ийм уг чанартай бүх хүн Сатаны гэр бүл биш юм аа гэхэд Сатантай ойрын холбоотой биш гэж үү? Бид ингэж хэлж болно, тийм биз дээ? Ерөнхийд нь хэлбэл, энэхүү илрэл нь жигшүүртэй бөгөөд зэвүүцмээр юм. Одоо та нарт ч бас зэвүүцмээр санагдаж байна, тийм биз дээ? (Тийм.)

Дараах эшлэлийг харцгаая. Сатан дахиж Еховагийн асуултад “Иов Бурханаас учир шалтгаангүйгээр эмээдэг гэж үү?” гэж хариулдаг. Иовыг үнэлсэн Еховагийн үнэлгээг Сатан дайрч эхэлж байгаа бөгөөд энэхүү дайралт нь дайсагнасан өнгөтэй байна. “Та түүнийг, түүний байшинг тойруулж, түүнд буй бүхнийг нь тойруулж хашаалаагүй гэж үү?” Энэ бол Иовд хийсэн Еховагийн ажлын талаарх Сатаны ойлголт болон үнэлгээ юм. Сатан үүнийг ийнхүү үнэлж, “Та түүний гарын ажлыг ерөөсөн, тэгээд түүний эд хөрөнгө энэ нутагт олширсон. Харин одоо гараа сунган түүнд буй бүхэнд хүр, тэгээд тэр Таны өдөөс хараах болно” гэсэн. Сатан үргэлж хоёрдмол утгаар ярьдаг боловч энд тэр баталсан байдлаар ярьдаг. Гэхдээ баталж хэлсэн хэдий ч эдгээр үг нь Ехова Бурхан руу, Бурхан руу Өөрт нь чиглэсэн дайралт, доромжлол, мөчөөрхөл юм. Эдгээр үгийг сонсоход та нарт ямар санагдаж байна вэ? Та нарт дургүйцэл төрж байна уу? Та нар түүний далд санааг харж чадаж байна уу? Юуны өмнө Сатан, Бурханаас эмээж, муугаас зайлдаг нэгэн хэмээх Иовын тухай Еховагийн үнэлгээг үгүйсгэдэг. Дараа нь Иовын хэлдэг, хийдэг бүхнийг үгүйсгэдэг, өөрөөр хэлбэл, Еховагаас эмээдэг гэдгийг нь үгүйсгэдэг. Энэ нь буруушааж байгаа хэрэг биш үү? Сатан, Еховагийн хийдэг, хэлдэг бүхнийг буруутгаж, няцааж, сэжиглэж байна. Тэрээр “Хэрвээ Та юмс ийм байдаг гэж хэлж байвал үүнийг би яахаараа хараагүй билээ? Та түүнд маш олон ерөөл өгсөн, тэр Танаас эмээхгүй байж яахан болох билээ?” хэмээж үл итгэдэг. Энэ нь Бурханы хийдэг бүхнийг үгүйсгэж байгаа биш гэж үү? Буруушаалт, үгүйсгэл, доромжлол—түүний үг халдлага биш гэж үү? Тэдгээр нь Сатан зүрх сэтгэл дотроо юу бодож байдгийн жинхэнэ илэрхийлэл биш гэж үү? Эдгээр үг нь бидний дөнгөж сая уншсан: “Газар дэлхий дээгүүр хэрэн хэсүүчилж, энүүгээр тэрүүгээр явсаар ирлээ” хэмээх үгтэй лав адилгүй. Тэдгээр нь шал өөр. Сатан эдгээр үгээр дамжуулан зүрх сэтгэлдээ юу агуулдгаа—Бурханд хандах хандлагаа болон Иовын Бурханаас эмээх байдлыг жигшдэгээ бүрмөсөн ил гаргадаг. Энэ үед түүний хорон санаа, ёрын муу уг чанар бүрмөсөн илэрдэг. Тэр Бурханаас эмээдэг хүмүүсийг үзэн яддаг, муугаас зайлдаг хүмүүсийг үзэн яддаг, хүнд ерөөл хайрласных нь төлөө Еховаг бүр ч их үзэн яддаг. Тэр энэ боломжийг ашиглан Бурханы Өөрийн гараар өсгөсөн Иовыг сүйрүүлэхийг хүсэж: “Иов Танаас эмээж, муугаас зайлдаг гэж Та хэлдэг. Харин би үүнийг өөрөөр хардаг” гэсэн. Тэр Еховаг уурлуулж, уруу татахын тулд янз бүрийн арга хэрэглэдэг ба Иовыг дураараа ашиглаж, хорлож, зовоох гэсэндээ түүнийг Ехова Бурханаас авах гэж янз бүрийн заль мэх хэрэглэдэг. Тэрээр Бурханы нүдэнд зөв шударга, төгс энэ хүнийг устгахын тулд энэ боломжийг ашиглахыг хүсдэг.

Зүгээр нэг агшин зуурын импульс Сатаныг ийм зүрх сэтгэлтэй байхад хүргэдэг үү? Үгүй, тийм биш. Удаан хугацаанд ийм байсан. Бурхан ажиллаж, нэг хүнийг халамжилж, тэр хүнийг шинжиж, ивээж, сайшаах үед Сатан ч бас тувт салахгүй мөрдөж, тэр хүнийг хуурч, хорлохыг хичээдэг. Хэрвээ Бурхан нэг хүнийг олж авахыг хүсвэл Сатан Бурханд саад болж, Бурханы ажлыг уруу татаж, үймүүлж, хохироохоор янз бүрийн хорон муу заль мэх ашиглан далд зорилгодоо хүрэхийн төлөө чадах бүхнээ хийнэ. Энэ зорилго нь юу вэ? Бурхан хэнийг ч олж авахыг тэр хүсдэггүй; Бурханы олж авахыг хүсдэг бүх хүнийг тэр өөртөө булааж авч эзэмшихийг хүсдэг, тэднийг хянаж, удирдахыг хүсдэг ба ингэснээр тэр хүмүүс Сатаныг шүтэж, ёрын муу үйл үйлдэхэд нь түүнтэй нэгдэж, Бурханыг эсэргүүцэх юм. Энэ нь Сатаны хорлонтой сэдэл биш гэж үү? Сатан бол маш муу, маш ёрын гэж та нар дандаа хэлдэг, гэхдээ та нар түүнийг харсан уу? Та нар хүн төрөлхтөн хэчнээн муу болохыг харж чадна; бодитой Сатан хэчнээн муу болохыг хараагүй. Гэхдээ Иовын явдал дээр Сатан ямар хорон муу болохыг тодорхой ажигласан. Энэ явдал нь Сатаны зэвүүн царай зүс болон мөн чанарыг тун тодорхой болгосон. Бурхантай тулалдаж, Түүний араас мөшгөхдөө Сатаны зорилго бол Бурханы хийхийг хүсдэг бүх ажлыг нурааж, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг эзэмдэж, хянах, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг бүрмөсөн устгах явдал юм. Хэрвээ тэднийг устгахгүй бол тэд Сатаны эзэмшилд орж, түүгээр ашиглуулдаг—энэ бол түүний зорилго. Бурхан юу хийдэг вэ? Бурхан энэ хэсэгт зөвхөн энгийн нэг өгүүлбэр л хэлдэг; Бурханы хийсэн өөр ямар ч зүйлийн талаар тэмдэглэл байхгүй боловч Сатан юу хийж, хэлдэг талаар илүү олон тэмдэглэл байгааг бид хардаг. Судрын доор дурдах хэсэгт Ехова, Сатанаас “Чи хаанаас ирэв?” хэмээн асуусан. Сатаны хариулт юу вэ? (Энэ нь мөн л “Газар дэлхий дээгүүр хэрэн хэсүүчилж, энүүгээр тэрүүгээр явсаар ирлээ” гэдэг.) Өнөөх л өгүүлбэр. Энэ нь Сатаны уриа лоозон, Сатаны онцлог шинж юм. Яаж ийм байна вэ? Сатан хорсолтой биш гэж үү? Энэхүү зэвүүцмээр өгүүлбэрийг нэг хэлэхэд л хангалттай. Сатан яагаад үүнийг давтан хэлээд байна вэ? Энэ нь нэг зүйлийг нотолдог: Сатаны уг чанар өөрчлөгдөшгүй. Сатан ёозгүй царайгаа нуух гээд дүр эсгэсэн ч нууж чадахгүй. Бурхан түүнээс асуулт асууж, түүний хариулж байгаа нь энэ. Ийм болохоор хүмүүст хэрхэн хандаж таарахыг нь төсөөлөөд үз! Сатан Бурханаас айдаггүй, Бурханаас эмээдэггүй, Бурханыг дуулгавартай дагадаггүй. Иймээс тэр Бурханы өмнө дур зоргоороо давилуун байж, Бурханы асуултыг үл ойшоохын тулд өнөө л хэдэн үгийг ашиглаж, Бурханы асуултад өнөө л нэг хариултыг удаа дараа ашиглаж, Бурханыг будилуулах гэж энэ хариултыг ашиглахаар оролдож зүрхэлдэг—энэ бол Сатаны ёозгүй царай юм. Тэр, Бурханы төгс хүчит байдалд итгэдэггүй, Бурханы эрх мэдэлд итгэдэггүй ба Бурханы ноёрхолд захирагдахыг лав хүсдэггүй. Тэр байнга Бурханыг эсэргүүцэж, Бурханы хийдэг бүхнийг байнга дайрч давшилж, Бурханы хийдэг бүхнийг сүйрүүлэхээр оролдож байдаг—энэ бол түүний ёрын муу зорилго юм.

Иовын Номонд тэмдэглэснээр Сатаны хэлсэн энэ хоёр хэсэг болон Сатаны хийсэн зүйлс нь Бурханыг Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөнд эсэргүүцдэгийнх нь төлөөлөл—энд Сатаны үнэн царай зүс илэрдэг. Чи бодит амьдралд Сатаны үг болон үйл хэргийг харсан уу? Чи тэдгээрийг харах үедээ тэр нь Сатаны хэлсэн зүйл гэж боддоггүй, харин хүний хэлсэн зүйл гэж боддог байх. Хүн тиймэрхүү юм ярихдаа юу төлөөлдөг вэ? Сатаныг төлөөлдөг. Чи үүнийг зөвшөөрдөг ч гэсэн тэрийг үнэхээр Сатан хэлснийг бас л ухамсарлаж чаддаггүй. Гэхдээ одоо чи, Сатан өөрөө юу хэлснийг мадаггүй харлаа. Чи одоо Сатаны зэвүүн царай зүс болон ёрын муугийн талаар мадаггүй, тов тодорхой ойлголттой боллоо. Тэгвэл Сатаны хэлсэн энэ хоёр хэсэг Сатаны уг чанарыг мэдэж авахад нь өнөөгийн хүмүүст туслах үнэ цэнэтэй юу? Өнөөдрийн хүн төрөлхтөн Сатаны зэвүүн царай зүсийг таньж, Сатаны жинхэнэ, үнэн нүүр царайг таньж чаддаг болгохын тулд энэ хоёр хэсгийг нягт хадгалах нь ач холбогдолтой юу? Хэдийгээр ингэж хэлэх нь тийм ч зохистой биш мэт санагдавч эдгээр үгийг ийнхүү илэрхийлэх нь ямар ч гэсэн нарийн зөв гэж тооцогдож болно. Үнэндээ энэ санааг Би ингэж л илэрхийлж чадна, хэрвээ та нар ойлгож чадвал болох нь тэр. Сатан Еховагийн хийдэг зүйлийг ахин дахин дайрч, Ехова Бурханаас Иов эмээдэг талаар буруушааж зэмлэдэг. Тэр, Иовыг уруу татахыг Еховагаар зөвшөөрүүлэх гэж мэрийн янз бүрийн аргаар Еховаг өдөөн хатгахаар оролддог. Тиймээс түүний үг туйлын өдөөн хатгасан шинжтэй юм. Тэгэхээр Надад хэл дээ, Сатан эдгээр үгийг хэлэхэд нь Сатан юу хийхийг хүсэж байгааг Бурхан тодорхой харж чадсан уу? (Тэгсэн.) Бурханы зүрх сэтгэлд, Бурханы ажигладаг Иов гэдэг энэ хүн—Бурхан зөвт, төгс хүн хэмээн үздэг Бурханы энэхүү зарц нь—ийм уруу таталтыг тэсвэрлэж чадах уу? (Тийм.) Тэр талаар Бурхан яагаад тийм итгэлтэй байна вэ? Бурхан үргэлж хүний зүрх сэтгэлийг шалгаж байдаг уу? (Тийм.) Сатан ч бас хүний зүрх сэтгэлийг шалгаж чадах уу? Сатан чадахгүй. Сатан чиний зүрх сэтгэлийг харж чадлаа ч гэсэн түүний ёрын муу уг чанар нь ариун байдал бол ариун байдал гэдэгт, эсвэл бузар муухай байдал бол бузар муухай байдал гэдэгт итгэх боломж түүнд хэзээ ч өгөхгүй. Ёрын муу Сатан, аливаа ариун, зөвт, гэгээлэг юуг ч, хэзээ ч эрхэмлэж чадахгүй. Сатан өөрийн уг чанар, ёрын муугийн дагуу ердийн аргаараа дамжуулан өөрийн эрхгүй цөхрөлтгүй ажилладаг. Бурханд шийтгүүлж, устгагдах уршигтай байсан ч тэр, Бурханыг зөрүүдлэн эсэргүүцэхдээ тээнэгэлздэггүй—энэ бол ёрын муу, энэ бол Сатаны уг чанар билээ. Иймээс энэ хэсэгт Сатан: “Арьсыг арьсаар, тийм ээ, хүн өөртөө байгаа бүхнийг амийнхаа төлөө өгөх л болно. Харин Чи одоо гараа сунгаад түүний яс, маханд нь хүр, тэр Чиний өөдөөс хараах болно” гэж хэлдэг юм. Хүн Бурханаас маш их ашиг тус хүртдэг учраас Бурханаас эмээдэг гэж Сатан боддог. Хүн Бурханаас ашиг тус хүртдэг, иймээс Бурхан бол сайн гэж хэлдэг. Гэхдээ энэ нь Бурхан сайн байдаг учраас биш, харин хүн маш олон ашиг тус хүртсэн учраас л Бурханаас ингэж эмээж болно. Бурхан түүнийг эдгээр ашиг тусаас нь салгахаар Бурханыг орхино. Ёрын муу уг чанартаа Сатан, хүний зүрх сэтгэл Бурханаас үнэхээр эмээж болно гэдэгт

итгэдэггүй. Учир нь, түүний ёрын муу уг чанар ариун байдал гэж юу болохыг мэдэхгүй, эмээсэн хүндлэл гэж юу болохыг бүр ч мэддэггүй. Тэр, Бурханыг дуулгавартай дагах гэж юу байдгийг, эсвэл Бурханаас эмээх гэж юу байдгийг мэддэггүй. Тэр ийм зүйлсийг мэддэггүй учраас хүн ч бас Бурханаас эмээж чадахгүй гэж боддог. Надад хэлээч, Сатан ёрын муу биш гэж үү? Манай чуулганаас бусад янз бүрийн шашин болон урсгал, эсвэл шашны болон нийгмийн бүлгүүдийн аль нь ч Бурханы оршин тогтнолд итгэдэггүй, Бурхан махбод болчихоод шүүлтийн ажил хийж байгаа гэдэгт бүр ч итгэдэггүй, иймээс чиний итгэдэг зүйл Бурхан биш гэж тэд боддог. Садар самуун хүн эргэн тойрноо харж, хүн бүхнийг яг өөр шигээ садар самуун гэж боддог. Худалч хүн эргэн тойрноо харж, зөвхөн худал, хуурмагийг үздэг. Муу хүн бүсад хүн бүрийг муу гэж үздэг ба харсан хүн бүхэнтэйгээ тэмцэлдэхийг хүсдэг. Харин харьцангуй шударга үнэнч хүмүүс хүн бүхнийг шударга үнэнч гэж боддог болохоор үргэлж мэхлэгдэж, үргэлж хууртагдаж байдаг, тэд энэ тухайд яаж ч чаддаггүй. Та нарын үнэмшлийг батагтахын тулд Би энэ цөөн хэдэн жишээ өгье: Сатаны ёрын муу уг чанар нь зурсхийх хүсэл, эсвэл нөхцөл байдлаас үүссэн зүйл биш, мөн ямар нэгэн шалтгаанаас юм уу, нөхцөл байдлын хүчин зүйлээс бий болсон түр зуурын илрэл биш юм. Огтхон ч биш! Сатан зүгээр л байхаас өөр яаж ч чаддаггүй! Тэр ямар ч сайн зүйл хийж чаддаггүй. Тэр сонсоход таатай зүйл хэлэхдээ ч гэсэн зүгээр л чамайг уруу татах гэдэг. Түүний үг хэдий чинээ сайхан, хэдий чинээ аятайхан, хэдий чинээ эелдэг байх тусмаа эдгээр үгийн цаадах зэвүүн санаархал нь төдий чинээ хорлонтой байдаг. Энэ хоёр хэсэгт Сатан ямар нүүр царай, ямар уг чанар харуулдаг вэ? (Зальжин, хорлонтой, ёрын муу.) Түүний үндсэн шинж чанар нь ёрын муу; юуны өмнө, Сатан бол ёрын муу агаад хорон санаатай.

Одоо бид Сатаны тухай хэлэлцэж дууссан болохоор Бурханы тухай яриандаа эргэн орцгооё. Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний турш Бурханы шууд хэлсэн үгийн тун багахан нь Библид тэмдэглэгдсэн ба тэр тэмдэглэгдсэн зүйл нь маш энгийн. Тэгэхээр эхнээс нь эхэлье. Бурхан хүнийг бүтээсэн бөгөөд тэр цагаас хойш хүн төрөлхтний амьдралыг ямагт залж чиглүүллээ. Хүн төрөлхтөнд ерөөл хайрлаж, хүмүүст хууль болон тушаал бүтээхдээ ч, эсвэл амьдралын янз бүрийн дүрэм журмыг чухалчлан заахдаа ч, эдгээр зүйлийг хийхдээ Бурханы зорьсон зорилго юу вэ гэдгийг та нар мэдэх үү? Нэгдүгээрт, Бурханы хийдэг бүхэн хүн төрөлхтний сайн сайхны төлөө байдаг гэж та нар итгэл төгс хэлж чадах уу? Эдгээр нь та нарт сүржин, хоосон үг шиг санагдаж магадгүй боловч нарийн шалгавал Бурханы хийдэг бүхэн нь хүнийг хэвийн амьдралаар амьдрахад удирдан чиглүүлэхэд зорьдоггүй гэж үү? Хүн Түүний дүрэм журмыг дагах ч бай, эсвэл Түүний хуулийг сахих ч бай, Бурханы зорилго бол хүн Сатаныг шүтдэг болчихгүй, хүнийг Сатанд хорлогдохгүй байлгах явдал юм; энэ нь хамгийн чухал бөгөөд хамгийн анх хийгдсэн зүйл юм. Хамгийн анх хүн Бурханы хүслийг ойлгоогүй байх үед Бурхан зарим энгийн хууль, дүрэм журамгаргаж, байж болох бүх талыг хамарсан ёс горим тогтоосон юм. Эдгээр ёс горим нь энгийн атлаа

дотроо Бурханы хүслийг агуулдаг. Бурхан хүн төрөлхтнийг нандигнан энхрийлж, халуун дотноор хайрладаг. Тэгвэл Түүний зүрх сэтгэл ариун гэж хэлж болох уу? Түүний зүрх сэтгэл цэвэр гэж хэлж болох уу? (Болно.) Бурханд өөр сэдэл байдаг уу? (Үгүй.) Тэгвэл Түүний энэ зорилго зөв агаад эерэг үү? Бурханы тогтоосон бүх ёс горим нь Түүний ажлын явцад хүний замыг чиглүүлж, хүнд эерэг нөлөөтэй байсан. Тэгэхээр Бурханы оюун санаанд хувийн ашиг хөөцөлдсөн бодол байдаг уу? Бурханд хүний талаар ямар нэгэн нэмэлт зорилго байдаг уу? Хүнийг Бурхан ямар нэгэн байдлаар ашиглахыг хүсдэг үү? Огтхон ч үгүй. Бурхан Өөрийн хэлсний дагуу хийдэг ба Түүний үг, үйлс хоёр зүрх сэтгэл дэх бодолтой нь таардаг. Ямар ч бохир зорилго, хувиа хичээсэн бодол байдаггүй. Тэр Өөрийнхөө төлөө юу ч хийдэггүй; хувийн ямар ч зорилгогүйгээр бүх зүйлийг хүний төлөө хийдэг. Хэдийгээр хүнд оногдуулсан төлөвлөгөө, санаа зорилго Түүнд байдаг боловч аль нь ч Өөрийнх нь төлөө биш билээ. Түүний хийдэг бүхэн нь гагцхүү хүн төрөлхтний төлөө, хүн төрөлхтнийг хамгаалахын төлөө, хүн төрөлхтнийг замаа алдахаас сэргийлэхийн төлөө хийгддэг. Тэгэхээр Түүний энэхүү зүрх сэтгэл эрхэм нандин биш гэж үү? Чи ийм эрхэм нандин зүрх сэтгэлийн өчүүхэн жаахныг ч гэсэн Сатанаас харж чадах уу? Чи үүний өчүүхэн төдий ул мөрийг ч Сатанаас харж чадахгүй, огтхон ч харж чадахгүй. Бурханы хийдэг бүхэн аяндаа илэрдэг. Одоо, Бурханы ажилладаг арга замыг харцгаая; Тэр Өөрийн ажлыг хэрхэн хийдэг вэ? Бурхан эдгээр хууль болон Өөрийн үгийг авч, хүн бүрийн толгойг ягштал ороож, цагариг чангалах шившлэг[a] мэт үүнийгээ хүн нэг бүрт тулгадаг уу? Тэр ийм маягаар ажилладаг уу? (Үгүй.) Тэгвэл Бурхан Өөрийн ажлыг ямар арга замаар хийдэг вэ? Тэр заналхийлдэг үү? Тэр та нартай ярихдаа бөөрөнхийлдөг үү? (Үгүй.) Үнэнийг ойлгохгүй байх үед чинь Бурхан хэрхэн залж чиглүүлдэг вэ? Тэр чамайг гэгээрүүлж, үүнийг хийх нь үнэнтэй нийцэхгүй байна гэдгийг чамд тодорхой хэлээд юу хийх хэрэгтэй гэдгийг хэлдэг. Бурханы ажилладаг эдгээр арга замаас чи өөрийгөө Бурхантай ямар харилцаатай гэж санадаг вэ? Бурхан хүрэхийн аргагүй гэж санагддаг уу? (Үгүй.) Тэгвэл Бурханы ажилладаг эдгээр арга замыг харахад ямар санагддаг вэ? Бурханы үг тун бодитой, хүнтэй харилцах харилцаа нь тун хэвийн байдаг. Бурхан чамд гойд ойрхон байна, Бурхан та хоёрын дунд ямар ч зай байхгүй. Бурхан чамайг залж чиглүүлэх үед, Тэр чамайг хангаж, чамд тусалж, чамайг дэмжих үед чи Бурхан хэчнээн найрсаг гэдгийг, Түүний хүндлэл төрүүлдэг байдлыг мэдэрдэг; Тэр хэчнээн хайр татам байдгийг мэдэрч, Түүний илчийг мэдэрдэг. Гэвч Бурхан ялзралаас чинь болж чамайг зэмлэх үедээ, эсвэл Түүний эсрэг тэрсэлсний чинь төлөө чамайг шүүж, сахилгажуулах үедээ ямар арга

[a] “Цагариг чангалах шившлэг” нь “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” хэмээх хятад романд Тансан ламын ашигладаг шившлэг юм. Тэрээр энэ шившлэгийг ашиглан Сүн Үүнийг хянаж, толгой дахь төмөр цагаригийг нь чангалснаар, толгойг нь янгинатал өвтгөж, улмаар түүнийг хяналтдаа оруулдаг. Энэ нь хүнийг хүлдэг зүйлийг дүрслэх зүйрлэл болжээ.

ашигладаг вэ? Тэр чамайг үгээр зэмлэдэг үү? Тэр орчноор чинь, эсвэл хүмүүс, хэрэг явдал болон зүйлсээр дамжуулан чамайг сахилгажуулдаг уу? (Тийм.) Бурхан чамайг хэдий хэмжээнд хүртэл сахилгажуулдаг вэ? Сатан хүнийг хорлодогтой адил түвшинд сахилгажуулдаг уу? (Үгүй, Бурхан хүнийг хүний тэсэж чадах түвшинд л сахилгажуулдаг.) Бурхан зөөлөн, эвтэй, хайрлаж, халамжилсан байдлаар, нэн хянуур, зүй зохистой байдлаар ажилладаг. Түүний арга зам нь чамд “Бурхан надаар энийг хийлгүүлэх ёстой” юм уу, эсвэл “Бурхан надаар тэрийг хийлгүүлэх ёстой” гэх мэтийн хүчтэй сэтгэлийн хөдөлгөөнт бодол төрүүлдэггүй. Бурхан чамд аливаа зүйлийг тэсвэрлэшгүй болгох тийм санаа, сэтгэлийн хүчлэл хэзээ ч өгдөггүй. Тийм биз дээ? Бурханы шүүлт, гэсгээлтийн үгийг хүлээн авахдаа ч гэсэн ямар санагддаг вэ? Бурханы эрх мэдэл, хүч чадлыг мэдрэх үед чамд ямар санагддаг вэ? Бурхан бол ариун дээд агаад халдашгүй гэдгийг мэдэрдэг үү? Энэ үед Бурхан та хоёрын дунд зайтай гэж санагддаг уу? Чи Бурханаас айдаг уу? Үгүй, харин чи Бурханыг эмээн хүндлэхээ мэдэрдэг. Хүмүүс Бурханы ажлын үрээр энэ бүх зүйлийг мэдэрдэг бус уу? Хэрвээ Сатан ажиллаж байсан бол хүмүүс ингэж мэдрэх байсан уу? Яавч үгүй. Бурхан хүнийг тасралтгүй хангаж, дэмжихийн тулд Өөрийн үг, Өөрийн үнэн болон Өөрийн амийг ашигладаг. Хүнийг сул дорой байхад, хүн урвайж гутарсан байхад нь Бурхан л лав: “Бүү урвайж гутар. Урвайж гутраад байх юм юу байна? Чи яагаад сул дорой байгаа юм бэ? Сул дорой байх шалтгаан юу байна? Чи дандаа ийм сул дорой, үргэлж ийм олиггүй байдаг! Чамд амьд явахын хэрэг юу байна? Зүгээр л үх, тэгээд боллоо!” гэж хатуу ширүүн хэлдэггүй. Бурхан ингэж ажилладаг уу? (Үгүй.) Ийм маягаар үйлдэх эрх мэдэл Бурханд байдаг уу? Байдаг. Гэхдээ Бурхан ийм маягаар үйлддэггүй. Бурхан ингэж үйлддэггүйн шалтгаан нь Түүний мөн чанараас, Бурханы ариун байдлын мөн чанараас болдог. Хүнийг гэсэн Түүний хайр, хүнийг эрхэмлэн, нандигнадгийг нь ердөө ганц, хоёрхон өгүүлбэрээр тодорхой илэрхийлж чадахгүй. Энэ нь хүмүүсийн магтаж бахадсанаар бий болдог зүйл биш, харин Бурхан бодит хэрэгжүүлэлтэд үүсгэдэг зүйл юм; энэ бол Бурханы мөн чанарын илэрхийлэл билээ. Бурханы ажилладаг энэ бүх арга зам хүнд Бурханы ариун байдлыг харуулж чадах уу? Бурханы сайн санаа зорилгыг оролцуулаад, Бурхан, хүн дээр биелүүлэхийг хүсдэг үр нөлөөг оролцуулаад, хүн дээр ажиллахын тулд Бурханы авч хэрэглэдэг өөр өөр арга зам, Түүний хийдэг ажил, Тэр хүнд юу ойлгуулахыг хүсдэгийг оролцуулаад Бурханы ажилладаг энэ бүх арга замаас—чи Бурханы сайн санаа зорилгод ямар нэгэн ёрын муу, эсвэл заль мэх олж харсан уу? (Үгүй.) Тэгэхээр Бурханы хийдэг бүхэн, Бурханы хэлдэг бүхэн, зүрх сэтгэлдээ боддог бүхнээс, түүнчлэн Бурханы илэрхийлдэг бүх мөн чанараас—бид Бурханыг ариун гэж нэрлэж болох уу? (Болно.) Аливаа хүн хэзээ нэгэн цагт энэхүү ариун байдлыг энэ дэлхийгээс, эсвэл өөрөөсөө харсан уу? Чи үүнийг Бурханаас гадна аливаа хүнээс, эсвэл Сатанаас ер нь харсан уу? (Үгүй.) Энэ хүртэл хэлэлцсэн дээрээ үндэслээд бид Бурханыг цор ганц, ариун Бурхан Өөрөө гэж нэрлэж болох уу? (Болно.) Бурханы үг, хүн дээр Бурханы ажилладаг өөр

өөр арга зам, Бурханы хүнд хэлдэг зүйл, Бурханы сануулдаг зүйл, зөвлөж, зоригжуулдаг зүйлсийг оролцуулаад Бурханы хүнд өгдөг бүхэн нь бүгд нэг мөн чанараас үүсдэг: Бурханы ариун байдлаас үүсдэг. Хэрвээ тийм ариун Бурхан байдаггүй бол нэг ч хүн Түүний хийдэг ажлыг хийхээр Түүнийг орлож чадахгүй. Хэрвээ Бурхан энэ хүмүүсийг бүгдийг нь Сатаны гарт өгчихсөн бол өнөөдөр та нар ямар нөхцөлд байх байснаа бодож үзсэн үү? Та нар энд бүгд бүрэн бүтэн, гэмтээгүй сууж байх байсан уу? Та нар бас: “Газар дэлхий дээгүүр хэрэн хэсүүчилж, энүүгээр тэрүүгээр явсаар ирлээ” гэж хэлэх байсан уу? Та нар маш увайгүй, маш омогтой бөгөөд Бурханы өмнө ийм үг ярьж, ичгүүргүй бардамнаж, пээдийн алхах байсан уу? Та нар ямар ч эргэлзээгүй яг л тэгнэ! Хүнд хандах Сатаны хандлага нь Сатаны уг чанар-мөн чанар бол Бурханыхаас үнэхээр тэс ондоо гэдгийг харах боломжийг хүнд олгодог. Сатаны ямар мөн чанар Бурханы ариун байдлын эсрэг вэ? (Сатаны ёрын муу.) Сатаны ёрын муу уг чанар нь Бурханы ариун байдлын эсрэг юм. Бурханы энэ илчлэл, Бурханы ариун байдлын энэ мөн чанарыг хүмүүсийн дийлэнх нь танин мэддэггүйн шалтгаан нь, тэд Сатаны ноёрхол дор, Сатаны ялзрал дунд, Сатаны амьдралын хүрээнд амьдардгаас болдог. Тэд ариун байдал гэж юу болохыг, эсвэл ариун байдлыг хэрхэн тодорхойлохыг мэддэггүй. Чи Бурханы ариун байдлыг ухамсарлах үедээ ч гэсэн үүнийг Бурханы ариун байдал гэж итгэлтэйгээр тодорхойлж мөн л чаддаггүй. Энэ нь Бурханы ариун байдлын тухай хүний мэдлэг дэх их зөрөө юм.

Хүн дээрх Сатаны ажил ямар онцлог шинжтэй байдаг вэ? Та нар үүнийг өөрсдийнхөө туршлагаар мэдэж авч чадах ёстой—энэ бол Сатаны хамгийн сонгодог онцлог шинж, түүний хамгийн их хийдэг зүйл, түүний хүн нэг бүртэй хийхийг хүсдэг зүйл юм. Та нар энэ онцлог шинжийг харж чадахгүй байх, тиймээс та нар Сатаны маш аймшигтай, зэвүүнийг мэдэрдэггүй. Энэ онцлог шинж нь юу болохыг мэддэг хүн байна уу? (Тэр хүнийг урхидаж, өдөж, уруу татдаг.) Зөв; эдгээр нь энэ онцлогийн ил болдог хэдэн арга зам юм. Сатан бас хүнийг төөрөгдүүлж, дайрч, бууутгадаг—эдгээр нь бүгд илрэл юм. Дахиад өөр юм байна уу? (Тэр худлаа ярьдаг.) Хуурч, худлаа ярих нь Сатанаас хар аяндаа гардаг. Тэр ийм зүйл байнга хийдэг. Түүнчлэн хүмүүст даргархаж, тэднийг өдөөн хатгаж, албадан юм хийлгэж, захиран тушааж, хүчээр чөтгөрт эзэмдүүлдэг. Би одоо та нарын толгойтой үс өрвийлгөм зүйлийг та нарт дүрслэн хэлнэ, гэхдээ Би та нарыг айлгахын тулд үүнийг хийдэггүй. Бурхан хүн дээр ажилладаг ба Түүний хандлага болон зүрх сэтгэл нь хүнийг нандигнадаг. Сатан эсрэгээрээ хүнийг огтхон ч нандигнадаггүй бөгөөд бүх цагаа хүнийг хэрхэн хорлох тухай бодож өнгөрөөдөг. Тийм биш гэж үү? Тэр хүнийг хорлох тухай бодохдоо сэтгэл яарсан байдалтай байдаг уу? (Тийм.) Иймээс хүн дээрх Сатаны ажлын тухайд гэвэл, Сатаны ёрын муу, хорлонт байдлыг хангалттай дүрсэлж, Сатаны жигшүүрт байдлыг та нарт үнэхээр мэдүүлж чадах хоёр хэллэг Надад байна: Сатан хүнд хандахдаа хүнийг бүрэн хянаж, ноцтой хорлож чадах хэмжээнд хүртэл хүнийг, хүн нэг бүрийг хүчээр эзлэн авч, эзэмдэхийг

үргэлж хүсдэг, ингэснээр, зорилгодоо хүрч, улайрсан хүсэл эрмэлзлээ биелүүлж чадах юм. “Хүчээр эзлэн авах” гэж юу гэсэн үг вэ? Энэ нь чиний зөвшөөрөлтэй болдог уу, эсвэл зөвшөөрөлгүйгээр болдог уу? Энэ нь чамайг мэдэж байхад тохиолддог уу, мэдээгүй байхад тохиолддог уу? Үүний хариу гэвэл, чамайг огт мэдээгүй байхад тохиолддог! Мэдээгүй байхад чинь, магадгүй тэр чамд юу ч хэлэлгүй, юу ч хийлгүйгээр, ямар ч оршил, нөхцөлгүйгээр—Сатан, чиний ойр тойронд, чамайг хүрээлэн байж байдаг. Тэр ашиглах боломж хайж, дараа нь чамайг хүчээр эзлэн авч, эзэмдэн чамайг бүрэн хянаж, чамд хор хүргэх зорилгодоо хүрдэг. Энэ бол хүн төрөлхтнийг Бурханаас булааж авах гэж тэмцэхдээ Сатаны гаргадаг хамгийн нийтлэг санаархал болон ааш авир юм. Үүнийг сонсоход та нарт ямар санагддаг вэ? (Зүрх сэтгэлдээ айж, эмээж байна.) Та нар зэвүүцэж байна уу? (Тийм.) Та нар зэвүүцэх үедээ Сатан бол ичгүүргүй гэж бодож байна уу? Та нар Сатан бол ичгүүргүй гэж бодох үедээ, эргэн тойронд чинь байдаг та нарыг үргэлж хянахыг хүсдэг, байр суурь, ашиг сонирхлын замбараагүй хүсэл эрмэлзэлтэй хүмүүст зэвүүцэж байна уу? (Тийм.) Тэгэхээр, хүнийг эзэмдэж, эзлэн авахын тулд Сатан ямар аргууд ашигладаг вэ? Та нар үүнийг мэдэж байна уу? “Хүчээр эзлэн авах” болон “эзэмдэх” гэх энэ хоёр нэр томьёог сонсох үедээ та нар зэвүүцэж, эдгээр үгийн ёрын мууг мэдэрч чадна. Чиний зөвшөөрөлгүйгээр, эсвэл чамд мэдэгдэлгүйгээр Сатан чамайг эзэмдэж, хүчээр эзлэн авч, ялзруулдаг. Чи зүрх сэтгэлдээ юу мэдэрч чадах вэ? Чи жигшил, зэвүүцлийг мэдэрдэг үү? (Тийм.) Сатаны ийм байдалд энэхүү жигшил, зэвүүцлийг мэдрэх үедээ чи Бурханы талаар ямар мэдрэмжтэй байдаг вэ? (Талархах.) Чамайг аварсны төлөө Бурханд талархсан байдал. Тэгвэл одоо, энэ мөчид өөртөө буй бүхнийг болон өөрийгөө Бурханд хариуцуулж, хянуулах хүсэл, эрмэлзэл чамд байна уу? (Тийм.) Ямар нөхцлөөс болж чи ингэж хариулж байна? Чи Сатанд хүчээр эзлэгдэж, эзэмдүүлэхээс айсандаа “тийм” гэж хэлж байна уу? (Тийм.) Чи ийм бодолтой байж болохгүй; энэ буруу. Бүү ай, учир нь, Бурхан энд байна. Айх зүйл юу ч байхгүй. Сатаны ёрын муу мөн чанарыг ойлгохоороо чи Бурханы хайр, Бурханы сайн санаа, хүнд Бурханы энэрэлтэй, хүлээцтэй байдгийг болон Түүний зөвт зан чанарын талаар илүү нарийн зөв ойлгож, илүү гүнзгий эрхэмлэн нандигнадаг болно. Сатан бол маш заналтай, гэсэн ч энэ нь Бурханыг гэх хайрыг чинь болон Бурханд итгэх итгэл, найдварыг чинь бас л бадраахгүй бол чи ямаршуу хүн бэ? Чи өөрийгөө Сатанд ингэж хорлуулмаар байна уу? Сатаны ёрын муу, зэвүүн байдлыг харсныхаа дараа эргээд Бурханыг харцгаая. Бурханы талаарх мэдлэгт чинь одоо ямар нэгэн өөрчлөлт гарсан уу? Бурхан бол ариун гэж хэлж болох уу? Бурхан бол өөгүй гэж хэлж болох уу? “Бурхан бол цор ганц ариун байдал”—Бурхан энэ нэрийг дааж чадах уу? (Тийм.) Тэгвэл энэ дэлхийд ба бүх зүйлийн дунд хүний энэхүү ойлголтыг дааж чадах нь зөвхөн Бурхан Өөрөө биш гэж үү? (Тийм.) Тэгвэл Бурхан хүнд яг юу өгдөг вэ? Тэр чамайг анзаараагүй байхад зөвхөн бага зэргийн асрал, халамж, анхаарал өгдөг үү? Бурхан хүнд юу өгсөн бэ? Бурхан хүнд амь өгсөн, хүнд бүхнийг

өгсөн ба хүнээс юу ч шаардаж нэхэхгүйгээр, ямар ч далд санаагүйгээр, болзолгүйгээр хүртээдэг. Хүнийг залж чиглүүлэхийн тулд Тэр үнэнийг ашигладаг, Өөрийн үгийг ашигладаг, Өөрийн амийг ашигладаг ба хүнийг Сатаны хор хөнөөлөөс холдуулж, Сатаны уруу таталт, хатгалгаас холдуулан Сатаны ёрын муу уг чанар болон зэвүүн нүүр царайг тодорхой харах боломжийг хүнд олгодог. Хүн төрөлхтнийг гэх Бурханы хайр болон анхаарал жинхэнэ үү? Энэ нь та нарын бүгдийн чинь мэдэрч чаддаг зүйл мөн үү? (Мөн.)

Өнөөг хүртэлх амьдралаа, итгэлийн чинь бүх он жилд чам дээр Бурханы хийсэн бүхнийг эргээд нэг хар. Үүнээс төрсөн мэдрэмж гүн ч юм уу, гүехэн ч бай, энэ нь чамд хамгаас чухал зүйл байгаагүй гэж үү? Үүнийг олж авах нь чиний хувьд хамгийн хэрэгтэй байгаагүй гэж үү? (Тийм.) Энэ үнэн бус уу? Энэ амь бус уу? (Мөн.) Бурхан хэзээ нэгэн цагт чамд гэгээрэл хайрлаад, дараа нь өгсөн бүхнийхээ хариуд Өөрт нь ямар нэг зүйл буцааж өгөхийг чамаас шаардсан уу? (Үгүй.) Тэгэхээр Бурханы зорилго юу вэ? Бурхан яагаад үүнийг хийдэг вэ? Чамайг эзлэн авах зорилго Бурханд байдаг уу? (Үгүй.) Бурхан хүний зүрх сэтгэл дэх Өөрийн сэнтийд суухыгхүсдэг үү? (Тийм.) Тэгвэл Бурхан сэнтийдээ суух, Сатан хүчээр эзлэн авах хоёрын ялгаа юу вэ? Бурхан хүний зүрх сэтгэлийг олж авахыг хүсдэг, Тэр хүний зүрх сэтгэлийг эзлэн авахыг хүсдэг—энэ нь юу гэсэн үг вэ? Бурхан, хүнийг Өөрийнхөө хүүхэлдэй, Өөрийнхөө машин болгохыг хүсдэг гэсэн үг үү? (Үгүй.) Тэгвэл Бурханы зорилго юу вэ? Бурхан хүний зүрх сэтгэлийг эзлэн авахыг хүсэх болон Сатан хүнийг хүчээр эзлэн авч, эзэмдэхийн хооронд ялгаа байдаг уу? (Байдаг.) Ялгаа нь юу вэ? Та нар Надад тодорхой хэлж чадах уу? (Сатан үүнийг хүчээр хийдэг байхад Бурхан хүнийг сайн дураар нь хийлгэдэг.) Ялгаа нь энэ үү? Бурхан яах гэж чиний зүрх сэтгэлийг хүсдэг вэ? Мөн Бурхан яах гэж чамайг эзлэн авахыг хүсдэг вэ? Зүрх сэтгэлдээ та нар “Бурхан хүний зүрх сэтгэлийг эзлэн авдаг” гэдгийг хэрхэн ойлгодог вэ? Бид энд Бурханы талаар ярихдаа шударга хандах ёстой, тэгэхгүй бол хүмүүс үргэлж буруугаар ойлгон: “Бурхан намайг эзлэн авахыг үргэлж хүсдэг. Тэр намайг яах гэж эзлэн авахыг хүсдэг юм бэ? Би эзлүүлэхийг хүсэхгүй, би зүгээр л өөрөө өөрийнхөө эзэн баймаар байна. Сатан хүмүүсийг эзлэн авдаг гэж Та хэлдэг, гэхдээ Бурхан ч бас хүмүүсийг эзлэн авдаг. Аль аль нь адилхан биш гэж үү? Би хэнд ч эзлэгдэхийг хүсэхгүй байна. Би бол би!” гэж хэлдэг. Энд ялгаа нь юу байна вэ? Үүнийг жаахан бодоод үз. Би та нараас асууя: “Бурхан хүнийг эзлэн авах” гэдэг нь дэмий хоосон хэллэг үү? Бурхан хүнийг эзлэн авах гэдэг нь Тэр чиний зүрх сэтгэлд амьдарч, чиний үг бүрийг, хөдөлгөөн бүрийг хянадаг гэсэн үг үү? Тэр чамд суу гэж хэлбэл чи зогсож зүрхлэх үү? Тэр чамд зүүн зүг яв гэж хэлбэл, чи баруун зүг явж зүрхлэх үү? “Эзлэн авах” гэдэг нь иймэрхүү байна гэсэн үг үү? (Үгүй, тийм биш. Бурханд юу байгаа, Тэр юу болохыг хүн амьдран харуулаасай гэж Бурхан хүсдэг.) Бурхан хүнийг удирдсан энэ бүх жилийн турш, хүн дээрх ажилдаа энэ сүүлчийн үе шатанд одоог хүртэл Түүний хэлсэн бүх үгийн хүнд үзүүлэх үр нөлөө ямар байсан бэ? Энэ нь Бурханд юу байгаа, Тэр юу болохыг хүн

амьдран харуулах мөн үү? “Бурхан хүний зүрх сэтгэлийг эзлэн авдаг” гэдгийн үгчилсэн утгыг харвал, Бурхан хүний зүрх сэтгэлийг авч, эзлээд тэнд амьдарч, дахин гарч ирдэггүй юм шиг санагддаг; Тэр хүний эзэн болж, хүний зүрх сэтгэлийг хүслээрээ ноёлж, жолоодож чаддаг, ингэснээр хүн, Бурхан юу л хэлснийг хийх ёстой. Энэ утгаараа, хүн бүр Бурхан болж, Түүний мөн чанар, зан чанарыг эзэмшиж чадах мэт санагдана. Тэгээд энэ тохиолдолд хүн бас Бурханы үйл хэргийг гүйцэтгэж чадах уу? “Эзлэн авах” гэдгийг ингэж тайлбарлаж болох уу? (Үгүй.) Тэгвэл энэ юу вэ? Би та нараас үүнийг асууя: Бурханы хүнийг хангадаг бүх үг ба үнэн нь Түүний мөн чанар болон Түүнд юу байгаа, Тэр юу болохын илэрхийлэл мөн үү? (Мөн.) Энэ бол гарцаагүй үнэн. Гэхдээ Бурхан хүнийг хангадаг бүх үгийг Бурхан Өөрөө хэрэгжүүлж, эзэмших нь чухал байдаг уу? Үүнийг жаахан бодоод үз. Бурхан хүнийг шүүхдээ юунаас болж шүүдэг вэ? Хүнийг шүүх үедээ Бурханы хэлдэг эдгээр үгийн агуулга юу вэ? Тэдгээр нь юун дээр үндэслэдэг вэ? Хүний ялзарсан зан чанар дээр үндэслэдэг үү? (Тийм.) Тэгвэл хүнийг шүүх Бурханы шүүлтийн үр нөлөө Бурханы мөн чанар дээр үндэслэн хүрдэг үү? (Тийм.) Тэгвэл Бурхан “хүнийг эзлэн авах” гэдэг нь хоосон хэллэг үү? Мэдээж, үгүй. Тэгвэл Бурхан яагаад эдгээр үгийг хүнд хэлдэг вэ? Эдгээр үгийг хэлэх Түүний зорилго юу вэ? Тэр эдгээр үгийг хүний амь болгон ашиглахыг хүсдэг үү? (Тийм.) Бурхан эдгээр үгэнд хэлсэн энэ бүх үнэнийг хүний амь болгон ашиглахыг хүсдэг. Хүн энэ бүх үнэнийг болон Бурханы үгийг авч, тэдгээрийг өөрийн амь болгон хувиргаж чадвал Бурханд дуулгавартай байж чадах уу? Хүн тэгээд Бурханаас эмээж чадах уу? Хүн тэгээд муугаас зайлж чадах уу? Хүн энэ түвшинд хүрчихээд Бурханы дээд эрх болон зохицуулалтад дуулгавартай байж чадах уу? Хүн тэгээд Бурханы эрх мэдэлд захирагддаг болж чадах уу? Иов шиг, эсвэл Петр шиг хүмүүс замынхаа төгсгөлд очих үед, амь нь боловсорсон гэж тооцогдох үед, тэд Бурханы талаар жинхэнэ ойлголттой болох үед—Сатан тэднийг дагуулан явж мөн л чадах уу? Сатан тэднийг эзлэн авч мөн л чадах уу? Сатан тэднийг хүчээр эзэмдэж мөн л чадах уу? (Үгүй.) Тэгвэл энэ ямар хүн бэ? Энэ нь Бурханы бүрэн олж авсан хүн мөн үү? (Мөн.) Ийм утга учрын түвшинд, Бурханы бүрэн олж авсан ийм хүнийг та нар хэрхэн үздэг вэ? Бурханы үзэхэд, ийм нөхцөл байдалд Тэр аль хэдийн энэ хүний зүрх сэтгэлийг эзлэн авсан. Харин энэ хүнд ямар санагддаг вэ? Бурханы үг, Бурханы эрх мэдэл, Бурханы зам нь хүний доторх амь болж, тэгээд энэхүү амь хүний бүхий л оршихуйг эзлэн авч, түүний амьдран харуулдаг зүйл болон мөн чанарыг Бурханыг хангалуун байлгахуйц болгодог уу? Бурханы үзэхэд, яг энэ мөчид хүн төрөлхтний зүрх сэтгэл Түүнд эзлэгдсэн байдаг уу? (Тийм.) Та нар энэ түвшний утгыг одоо хэрхэн ойлгож байна вэ? Чамайг эзлэн авдаг нь Бурханы Сүнс үү? (Үгүй, Бурханы үг биднийг эзлэн авдаг.) Бурханы зам, Бурханы үг чиний амь болж, бас үнэн чиний амь болсон. Энэ үед, хүн тэгээд Бурханаас ирсэн амийг эзэмшдэг боловч энэхүү амь нь Бурханы амь гэж бид хэлж болохгүй. Өөрөөр хэлбэл, Бурханы үгээс хүний авах амь бол Бурханы амь гэж бид хэлж болохгүй. Иймээс Бурханыг хүн хэр удаан дагах нь

хамаагүй, Бурханаас хэчнээн их үг хүлээн авах нь хамаагүй, хүн хэзээ ч Бурхан болж чадахгүй. Нэгэн өдөр Бурхан “Би чиний зүрх сэтгэлийг эзлэн авлаа, чи одоо Миний амийг эзэмшдэг” гэж хэлсэн ч гэсэн, чамд тэгэхэд чи өөрөө Бурхан гэж санагдах уу? (Үгүй.) Тэгвэл чи юу болох вэ? Чи Бурханд туйлын дуулгавартай байхгүй гэж үү? Зүрх сэтгэл чинь Бурханы хайрласан амиар дүүрэхгүй гэж үү? Энэ нь, Бурхан хүний зүрх сэтгэлийг эзлэн авах үе тохиолдох тун хэвийн илрэл юм. Энэ бол бодит баримт. Тэгвэл үүнийг энэ талаас нь харвал, хүн Бурхан болж чадах уу? Хүн Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулж, Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаг болох үедээ Бурханы амийн мөн чанар, ариун байдлыг эзэмшиж чадах уу? Яавч үгүй. Юу ч болж байсан хамаагүй, эцсийн эцэст хүн бол хүн хэвээр байна. Чи бол бүтээл; Бурханаас Бурханы үгийг хүлээн авч, Бурханы замыг хүлээн авахдаа чи Бурханы үгээс ирсэн амийг л эзэмшдэг бөгөөд Бурханы сайшаадаг хүн болдог ч Бурханы амийн мөн чанарыг хэзээ ч эзэмшихгүй, Бурханы ариун байдлыг бүр ч эзэмшихгүй.

Одоо дөнгөж сая хэлэлцсэн сэдэв рүүгээ буцаад оръё. Энэ хэлэлцүүлгийн үеэр Би та нараас нэг асуулт асуусан—Абрахам ариун уу? Иов ариун уу? (Үгүй.) Энэхүү “ариун байдал” нь Бурханы мөн чанар, зан чанарыг төлөөлдөг бөгөөд хүн хэзээ ч үүнд хүрч чадахгүй. Хүнд Бурханы мөн чанар, эсвэл Бурханы зан чанар байдаггүй. Хүн Бурханы бүх үгийг туулж, тэдгээрийн бодит байдлаар зэвсэглэсэн ч гэсэн Бурханы ариун мөн чанарыг эзэмшиж хэзээ ч чадахгүй; хүн бол хүн. Та нар ойлгосон, тийм үү? Тэгвэл одоо “Бурхан хүний зүрх сэтгэлийг эзлэн авдаг” хэмээх энэ хэллэгийг та нар хэрхэн ойлгож байна вэ? (Энэ бол Бурханы үг, Бурханы зам болон Түүний үнэн хүний амь болдог.) Та нар эдгээр үгийг цээжилжээ. Та нар илүү гүнзгий ойлголттой болно гэж Би найдаж байна. Зарим хүн: “Тэгвэл яагаад Бурханы элч болон тэнгэрэлчүүдийг ариун биш гэж хэлдэг юм бэ?” гэж асууж болох юм. Та нар энэ асуултын талаар юу гэж бодож байна вэ? Та нар үүнийг өмнө нь бодож үзээгүй байх. Би энгийн жишээ ашиглая: Та нар нэг робот асаахад энэ нь бүжиглэж, ярьж чадах ба чи хэлж байгааг нь ойлгож чадна. Чи үүнийг хөөрхөн, цовоо гэж болох боловч түүнд амь байхгүй учраас тэр ойлгохгүй. Чи түүнийг тэжээлээс нь салгавал тэр хөдөлсөөр байж чадах уу? Энэ роботыг идэвхжүүлсэн үед чи цовоо, хөөрхөн болохыг нь харж чаддаг. Үүнийг үнэлж үзвэл, энэ нь бодитой ч бай, эсвэл өнгөц ч бай, аль ч тохиолдолд чи түүний хөдөлж байгааг харна. Гэхдээ тэжээлийг нь унтраахад чи үүнээс ямар нэгэн зан ааш хардаг уу? Энэ нь ямар нэгэн мөн чанар эзэмшдэгийг хардаг уу? Миний хэлж байгаа зүйлийн утгыг ойлгож байна уу? Өөрөөр хэлбэл, хэдийгээр энэ робот хөдөлж, зогсож чаддаг боловч чи үүнийг ямар нэгэн мөн чанартай гэж хэзээ ч хэлж чадахгүй. Энэ нь бодит баримт биш гэж үү? Одоо бид энэ талаар дахиж цааш нь ярихгүй. Утга учрынх нь талаар ерөнхий ойлголттой байхад л та нарт хангалттай. Өнөөдрийн нөхөрлөлийг ингээд дуусгая. Баяртай!

2013 оны 12 дугаар сарын 17

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ V
БУРХАНЫ АРИУН БАЙДАЛ (II)

Өнөөдөр магтан дуу дуулцгаая, ах, эгч нар аа. Та нар өөрсдийн дуртай, байнга дуулдаг дуугаа ол. (Бид “Сэвгүй ариун хайр” хэмээх Бурханы үгийн 760-р магтан дууг дуулмаар байна.)

1 “Хайр” гэж цэвэр, өө сэвгүй сэтгэл хөдлөлийг хэлдэг бөгөөд хайрлах, мэдрэх, хайхрамжтай байхад зүрх сэтгэлээ ашиглахыг хэлдэг. Хайранд ямар ч болзол, саад бэрхшээл, зай гэж үгүй. Хайранд ямар ч сэжиг, хууран мэхлэлт, заль мэх байдаггүй. Хайранд ямар ч наймаа, бузар бохир үгүй. Хэрэв чи хайрладаг бол мэхлэхгүй, гомдоллохгүй, урвахгүй, тэрслэхгүй, шалж шаардахгүй, эсвэл ямар нэг зүйлийг олж авахаар, тодорхой хэмжээгээр олж авахаар эрэлхийлэхгүй.

2 “Хайр” гэж цэвэр, өө сэвгүй сэтгэл хөдлөлийг хэлдэг бөгөөд хайрлах, мэдрэх, хайхрамжтай байхад зүрх сэтгэлээ ашиглахыг хэлдэг. Хайранд ямар ч болзол, саад бэрхшээл, зай гэж үгүй. Хайранд ямар ч сэжиг, хууран мэхлэлт, заль мэх байдаггүй. Хайранд ямар ч наймаа, бузар бохир үгүй. Хэрэв чи хайрладаг бол өөрийгөө баяртайяа зориулж, бэрхшээлийг баяртайгаар туулж, Надтай нийцэлтэй байж, Миний төлөө өөрт байгаа бүхнээ хаяж, гэр бүл, ирээдүй, залуу нас, гэрлэлтээ орхино. Эс тэгвээс, чиний хайр ердөө ч хайр биш, харин хууран мэхлэлт, урвалт байх болно!

Хургыг дагаж шинэ дуу дуулъя

Энэ дуу сайхан сонголт болжээ. Та нар энэ дууг дуулах дуртай юу? Энэ дууг дуулсны дараа юу мэдэрч байна? Та нарын сэтгэлд ийм хайр мэдрэгдэж байна уу? (Хараахан үгүй.) Энэ дууны аль үгэнд сэтгэл чинь хамгийн их хөдөлж байна вэ? (Хайранд болзол, саад, зай байдаггүй. Хайранд сэрдлэг, ов мэх, заль байдаггүй. Хайранд ямар ч наймаа, ямар ч хольц байхгүй. Гэхдээ миний дотор олон хольц байгааг, Бурхантай наймаацахаар оролддог олон зүйл байгааг би бас л хардаг. Би ийм сэвгүй ариун хайрыг үнэхээр олж аваагүй.) Хэрвээ чи сэвгүй ариун хайр олж аваагүй юм бол чиний хайр ямар түвшинд байна? (Би ердөө л эрж хайхад бэлэн, хүсэн эрмэлзэж буй үе шатанд байгаа байна.) Биеийн хэмжээндээ үндэслээд өөрийн туршлагаас яривал чи ямар түвшинд хүрчхээд байна вэ? Чи ов мэх гаргаж байна уу? Гомдол байна уу? Зүрх сэтгэлд чинь шаардлага байна уу? Бурханаас хүсэж, эрмэлздэг зүйл байна уу? (Тийм ээ, миний дотор эдгээр бохир зүйл бий.) Ямар нөхцөлд тэр чинь гарч ирдэг вэ? (Надад зориулж Бурханы зохицуулсан нөхцөл үзэлтэй минь нийцэхгүй байх үед, эсвэл хүсэл минь биелэхгүй байх үед: ийм мөчүүдэд би иймэрхүү завхарсан зан чанараа илчилдэг.) Тайваниас ирсэн ах эгч та нар ч энэ магтан дууг байнга дуулдаг уу? “Сэвгүй ариун хайрыг” та нар хэрхэн ойлгодог тухайгаа жаахан ярьж болох уу? Бурхан хайрыг яагаад ийм маягаар тодорхойлдог вэ? (Би энэ магтан дуунд маш дуртай, учир нь энэ хайр бол бүрэн

дүүрэн хайр гэдэг нь эндээс харагддаг. Гэхдээ би одоо ч тэр стандартад нийцэхээргүй, бас жинхэнэ хайрыг олж авахад маш хол байгаагаа мэдэрч байна. Зарим зүйл дээр би ахиц гаргаж, бас Бурханы үгийн өгдөг хүч чадал болон залбирлаар дамжуулан хамтран ажиллаж чадсан. Гэхдээ тодорхой шалгалт юм уу илчлэлтэй тулгарах үед надад ирээдүй, хувь заяа байхгүй, хүрэх газар байхгүй гэж санагддаг. Тийм мөчүүдэд би маш сул дорой болдог ба энэ асуудал надад үргэлж саад болдог.) “Ирээдүй, хувь заяа” гэж чи эцсийн эцэст яг юуг хэлж байна вэ? Тодорхой нэг зүйлийг хэлж байна уу? Энэ чинь дүр зураг уу, эсвэл чиний төсөөлсөн зүйл үү, аль эсвэл ирээдүй, хувь заяа чинь үнэндээ нүдэнд харагддаг зүйл үү? Бодитой зүйл юм уу? Та нар дор бүрнээ үүнийг бодож үзээсэй гэж Би хүсэж байна: Ирээдүй, хувь заяаныхаа талаарх зовнил чинь яг юуны тухай байна вэ? (Аврагдаж чадах, тэгснээр би амьд үлдэж болно.) Бусад ах, эгч та бүхэн ч бас “Сэвгүй ариун хайрын” талаарх ойлголтоосоо товчхон яриач. (Ийм хайр бүхий хувь хүнээс ямар ч ариун бус зүйл гарахгүй, мөн тэр хүн ирээдүй, хувь заяаны эрхшээлд автахгүй. Бурхан яаж ч харьцлаа гэсэн Бурханы ажил, зохион байгуулалтыг тэд бүрэн дуулгавартай дагаж, эцсээ хүртэл Түүнийг дагаж чаддаг. Бурханыг хайрлах ийм хайр л сэвгүй ариун хайр юм. Өөрийгөө үүнтэй жишиж үзэхэд, өнгөрсөн хэдэн жилд би Бурханд итгэхдээ өөрийгөө зарлагадаж, зарим зүйлийг хөсөр хаясан мэт байвч Бурханд зүрх сэтгэлээ өгч үнэндээ чадаагүй гэдгээ олж мэдсэн. Бурхан намайг илчлэхэд би аврагдах аргагүй мэт санагдаж, сөрөг байдалд автдаг. Би үүргээ биелүүлж байгаа харагддаг ч үүнийхээ зэрэгцээ Бурхантай наймаацах гэж оролддог бөгөөд Бурханыг чин сэтгэлээсээ хайрлаж чаддаггүй, бас хүрэх газар, ирээдүй, хувь заяа минь санаанаас ер гардаггүй.) Та нар энэ магтан дууны талаар бага зэрэг ойлгодог, мөн энэ дуу бодит туршлагатай чинь зарим талаар холбоотой юм шиг байна. Гэвч та нар “Сэвгүй ариун хайр” хэмээх магтан дууны үг хэллэг болгоныг өөр өөр түвшинд хүлээн зөвшөөрдөг. Зарим хүн үүнийг бэлэн байх тухай гэж бодож байна, зарим нь ирээдүйгээ хөсөр хаяхаар эрэлхийлж байна, зарим нь гэр бүлээ орхихыг оролдож байна, зарим нь юм хүлээн авахын төлөө эрж хайхгүй байна. Харин зарим нь ов мэх гаргахгүй, гомдоллохгүй, Бурханы эсрэг тэрслэхгүй байх шаардлага өөрсдөдөө тавьж байна. Бурхан яагаад ийм хайр санал болгохыг хүсэж, Өөрийг нь ингэж хайрлахыг хүмүүсээс шаардах юм бэ? Хүмүүс ийм төрлийн хайрыг эзэмшиж чадах уу? Өөрөөр хэлбэл, ингэж хайрлах чадвартай юү? Хүмүүст ийм хайрын үнэр ч байдаггүй тул чадахгүй гэдгээ ойлгож магад. Хүмүүст ийм хайр үгүй, мөн хайрын талаар үндсэндээ мэдэхгүй байхад Бурхан эдгээр үгийг хэлдэг бөгөөд энэ үгс хүмүүст танил бус байдаг. Хүмүүс энэ ертөнцөд завхарсан зан чанартайгаар амьдардаг тул хэрвээ хүмүүс ийм маягаар хайрладаг байсан бол, эсвэл ямар ч хүсэлт, шаардлага тавьдаггүй хайр, өөрсдийгөө зориулж, зовлон туулж, өөрийн гэсэн бүхнээ орхиход бэлэн ийм маягийн хайрыг хэн нэгэн эзэмшиж чадсан бол ингэж хайрладаг хүнийг бусад нь юу гэж бодох вэ? Ийм хүн төгс байх биш үү? (Тийм ээ.) Үүн шиг төгс хүн энэ ертөнцөд байдаг уу? Ийм хүн энэ ертөнцөд

огт байхгүй. Энэ бол маргаангүй. Иймээс зарим хүн өөрсдийн туршлагаар эдгээр үгийн дайд хүрэх гэж ихээхэн хүчин чармайлт гаргадаг. Өөрсөдтэйгөө харьцаж, өөрсдийгөө хорьж, тэр ч бүү хэл, өөрсдийгөө цаг ямагт хаядаг. Тэд зовлон тэвчиж, үзлээ орхидог. Өөрсдийн тэрслүү зан, хүсэл, хэрэгцээг хаядаг. Гэвч эцэст нь мөн л өнөөх үгийн дайд хүрдэггүй. Яагаад тэгдэг вэ? Бурхан хүмүүст дагаж баримтлах стандарт өгч, улмаар тэднээс шаарддаг стандартаа хүмүүст мэдэгдэхийн тулд ийм үг хэлдэг. Гэвч Бурхан хүмүүсийг шууд ийм болох ёстой гэж ер нь хэлдэг үү? Ийм болоход хүмүүст хэр их цаг байгааг хэлдэг үү? (Үгүй.) Бурханыг хүмүүс ийм маягаар хайрлах ёстой гэж ер нь хэлдэг үү? Бичвэрийн энэ хэсэгт ингэж хэлж байна уу? Үгүй, ингэж хэлдэггүй. Бурхан Өөрийн өгүүлж байсан хайрын талаар л хүмүүст хэлж байгаа юм. Харин хүмүүс Бурханыг ийм маягаар хайрлаж, Бурханд ийм байдлаар хандаж чадах эсэх тухайд бол Бурхан хүнд ямар шаардлага тавьдаг вэ? Тэдгээрийг даруй биелүүлэх шаардлагагүй, учир нь хүний чадамж хүрэхгүй. Ийм маягаар хайрлахын тулд хүмүүс ямар нөхцөлийг хангах хэрэгтэй гэдэг талаар та нар бодож үзсэн үү? Хэрвээ хүмүүс эдгээр үгийг тогтмол уншвал яваандаа ингэж хайрладаг болох уу? (Үгүй.) Тэгвэл ямар нөхцөлүүд байдаг юм бэ? Нэгдүгээрт, хүмүүс Бурханы талаарх сэрдлэгээс яаж ангижирч чадах вэ? (Үнэнч шударга хүмүүс л тэгж чадна.) Ов мэхгүй байх тухайд юу гэх вэ? (Бас л үнэнч шударга хүмүүс байж таарна.) Бурхантай наймаацдаггүй хүний тухайд юу гэх вэ? Энэ ч бас үнэнч шударга хүн байхын нэг хэсэг. Арга зальгүй байх тухайд юу гэх вэ? Хайранд сонголт гэж үгүй хэмээдэг нь ямар утга учиртай вэ? Энэ бүх зүйл эргээд үнэнч шударга хүн байхтай холбогддог уу? Энд нарийн ширийн зүйл их бий. Бурхан ийм төрлийн хайрын талаар ийнхүү ярьж, тодорхойлж чаддаг нь юуг нотолдог вэ? Бурхан ийм хайрыг эзэмшсэн гэж хэлж болох уу? (Болно.) Та нар үүнийг яаж мэддэг юм бэ? (Хүнийг хайрлах Бурханы хайраас.) Хүнийг гэх Бурханы хайр болзолтой юу? Бурхан, хүн хоёрын хооронд саад, зай бий юу? Бурхан хүнийг хардаж сэрддэг үү? (Үгүй.) Бурхан хүнийг ажиглаж, ойлгодог; Бурхан хүнийг үнэхээр ойлгодог. Бурхан хүнийг мэхэлдэг үү? (Үгүй.) Бурхан энэ хайрын талаар ингэтлээ төгс төгөлдөр ярьдаг учраас Түүний зүрх сэтгэл, мөн чанар ч бас төгс байж болох уу? (Болно.) Гарцаагүй болно; хүмүүсийн туршлага тодорхой хэмжээнд хүрэхэд тэд үүнийг мэдэрч чадна. Хүмүүс хайрыг ер нь ингэж тодорхойлж байсан уу? Хүн хайрыг ямар нөхцөлд тодорхойлсон бэ? Хайрын талаар хүн хэрхэн ярьдаг вэ? Хүн өгөө авааны хүрээнд хайрыг ярьдаг биш үү? (Тийм ээ.) Хайрын талаарх энэ тодорхойлолт өнгөцхөн; мөн чанаргүй байдаг.

Хайрын талаарх Бурханы тодорхойлолт, хайрын талаар ярьж буй байдал нь Түүний мөн чанарын нэг талтай холбоотой, харин энэ нь ямар тал вэ? Урьд нь хүмүүсийн байнга хэлэлцдэг байсан маш чухал сэдвээр бид өнгөрсөн удаа нөхөрлөсөн. Энэ сэдэв нь Бурханд итгэх явцад байнга яригддаг атлаа хүн бүрийн мэддэг ч юм шиг, мэддэггүй ч юм шиг нэг үгээс бүрддэг. Би яагаад ингэж хэлж байна вэ? Энэ нь хүний хэл ярианаас гарсан үг; гэвч энэ үгийн тодорхойлолт нь хүмүүст

илэрхий атлаа бүрхэг байдаг. Энэ ямар үг вэ? (Ариун байдал.) Ариун байдал: өнгөрсөн удаа бид энэ сэдвээр нөхөрлөсөн. Бид энэ сэдвийн нэг хэсгийн тухай нөхөрлөсөн шүү дээ. Өнгөрсөн удаагийн нөхөрлөлөөс Бурханы ариун байдлын мөн чанарын талаар хүн бүр шинэ ойлголт олж авсан уу? Энэ ойлголтын аль тал нь цоо шинэ гэж та нар үзэж байна вэ? Өөрөөр хэлбэл, Бурханы ариун байдлын тухай ойлголт чинь нөхөрлөлийн үеэр Миний ярьсан Бурханы ариун байдлаас өөр, ялгаатай байгааг та нарт энэ ойлголт буюу эдгээр үгийн дотроос юу нь мэдрүүлсэн бэ? Энэ талаар ямарваа сэтгэгдэл төрсөн үү? (Бурхан зүрх сэтгэлдээ мэдэрч буй зүйлээ хэлдэг; Түүний үг сэвтээгүй байдаг. Энэ нь ариун байдлын нэг талын илрэл юм.) (Бурхан хүн төрөлхтөнд хилэгнэх нь бас ариун байдал; Түүний уур хилэн өө сэвгүй.) (Бурханы ариун байдлын хувьд гэвэл, Бурханы уур хилэн, өршөөл хоёрын аль аль нь Түүний зөвт зан чанарт багтдаг гэж би ойлгодог. Энэ нь надад маш хүчтэй сэтгэгдэл үлдээсэн. Өнгөрсөн удаагийн нөхөрлөлөөр бас Бурханы зөвт зан чанарыг цорын ганц гэж дурдсан—үүнийг би өмнө нь ойлгодоггүй байж. Бурханы нөхөрлөсөн зүйлийг сонссоныхоо дараа л би Бурханы уур хилэн хүний ууранс ялгаатай гэдгийг ойлгосон. Бурханы уур хилэн бол эерэг зүйл бөгөөд зарчимтай байдаг; энэ нь Бурханы төрөлх мөн чанараас үүдэн гардаг. Бурхан сөрөг зүйл хараад уур хилэнгээ гаргадаг. Энэ нь ямар ч бүтээгдсэн зүйлд байдаггүй зүйл юм.) Өнөөдрийн сэдэв маань Бурханы ариун байдал. Хүмүүс бүгд Бурханы зөвт зан чанарын талаар зарим нэг зүйл сонсож, мэдсэн байдаг. Түүнчлэн олон хүн Бурханы ариун байдал, Бурханы зөвт зан чанарын талаар байнга нэг түвшинд авч үздэг; тэгээд Бурханы зөвт зан чанарыг ариун гэцгээдэг. “Ариун” гэдэг үгийг бүгд мэддэг нь лавтай—энэ бол өргөн хэрэглэгддэг үг. Гэхдээ энэ үгийн доторх утга учрын тухайд Бурханы ариун байдлын ямар илэрхийллийг хүмүүс харж чаддаг вэ? Хүмүүсийн таньж чадах юуг Бурхан илчилсэн бэ? Харамсалтай нь үүнийг хэн ч мэддэггүй. Бурханы зан чанар зөвт байдаг хэдий ч Бурханы зөвт зан чанарыг ариун гэж хэлэх юм бол жаахан бүрхэг, жаахан ойлгомжгүй болдог; яагаад тэр вэ? Бурханы зан чанарыг чи зөвт гэдэг, эсвэл зөвт зан чанарыг нь ариун гэж хэлдэг, тэгвэл Бурханы ариун байдлыг та нар зүрх сэтгэлдээ хэрхэн тодорхойлж, хэрхэн ойлгодог вэ? Өөрөөр хэлбэл, Бурхан юу илчилснийг юм уу, эсвэл Бурханд юу байдаг, Тэр юу болох тухайд юу гэх вэ, хүмүүс ариун гэж үзэх үү? Энэ талаар өмнө нь бодож үзсэн үү? Миний харснаар хүмүүс дандаа нийтлэг хэрэглэдэг үг гэнэт хэлдэг, эсвэл дахин дахин хэлдэг хэдэн хэллэгтэй байдаг боловч өөрсдөө юу гэж хэлээд байгаагаа ч мэддэггүй. Хүн болгон яг ингэж хэлдэг бөгөөд дадсан зангаараа хэлдэг тул энэ нь тэдний хувьд хэвшсэн нэр томьёо болдог. Гэвч шинжилж, нарийн ширийнийг нь үнэхээр судалсан бол бодит утга нь юу болохыг, энэ нь юу хэлээд байгааг мэдэхгүй гэдгээ ухаарна. Яг л “ариун” гэх үгийг мэддэггүйн адилаар, өөрсдийнх нь ярьдаг Бурханы ариун байдал Бурханы мөн чанарын яг аль талыг хэлээд байгааг хэн ч мэддэггүй, мөн “ариун” гэдэг үгийг Бурханд хэрхэн тааруулахаа хэн ч мэддэггүй. Хүмүүс зүрх сэтгэлдээ будилсан байдаг бөгөөд

Бурханы ариун байдлыг бүрхэг, тодорхойгүй байдлаар хүлээн зөвшөөрдөг. Бурхан хэрхэн ариун байдгийг хэн ч сайн мэддэггүй. Өнөөдөр бид “ариун” гэдэг үгийг Бурханд тааруулж, улмаар Бурханы ариун байдлын мөн чанарын бодит агуулгыг хүмүүст харуулахын тулд энэ сэдвээр нөхөрлөнө. Ингэснээр зарим хүн энэ үгийг дадсанаараа хэнэггүй хэрэглэх, юу гэж байгаагаа, эсвэл өөрсдийнх нь зөв, зүйтэйг мэдэхгүй байж хаа хамаагүй юм хэлэхээс сэргийлнэ. Хүмүүс ямагт ийнхүү ярьсаар ирсэн; чи ч ярьсан, тэр ч ярьсан, тэгээд энэ нь ярианд дадал болчихжээ. Энэ нь тус нэр томьёог санамсаргүй сэвтүүлдэг юм.

“Ариун” гэдэг үг гаднаа маш ойлгомжтой юм шиг санагддаг, тийм биз? Хүмүүс наад зах нь “ариун” гэдэг үгийг цэвэр, бузартаагүй, гэгээн, нандин гэсэн утгатай хэмээн итгэдэг. Мөн “ариун байдлыг” бидний дөнгөж сая дуулсан “Сэвгүй ариун хайр” хэмээх магтан дууны “хайртай” холбодог хүмүүс бий. Энэ нь зөв; энэ бол ариун байдлын нэг тал юм. Бурханы хайр бол мөн чанарынх нь нэг хэсэг болохоос мөн чанар нь бүхэлдээ биш. Гэвч хүмүүс үзэлдээ энэ үгийг хараад өөрсдийн цэвэр ариун гэж үздэг зүйлстэй холбож, эсвэл бузартаагүй, өө сэвгүй гэж боддог зүйлстэйгээ холбох хандлагатай байдаг. Жишээ нь, бадамлянхуа цэцэг цэвэр байдаг, бохир шалбаагаас өө сэвгүй дэлбээлдэг гэж зарим хүн хэлсэн. Иймээс хүмүүс “ариун” гэдэг үгийг бадамлянхуа цэцэгт хамаатуулж эхэлсэн юм. Зарим хүн хуурамч хайрын түүхийг ариун гэж үздэг, эсвэл зохиомол, биширмээр дүрийг ариун гэж үзэж магад. Түүнчлэн зарим нь Библид гардаг хүмүүс, сүнслэг номуудад тэмдэглэгдсэн—байдаг ариун хүмүүс, элч нарыг, эсвэл Бурханыг ажлаа хийж байхад нь дагаж явсан бусад хүмүүс зэрэг бас бус хүнийг—ариун сүнслэг туршлагатай байсан гэж үздэг. Эдгээр нь бүгд хүмүүсийн бодож олсон зүйл; эдгээр нь хүмүүсийн баримталдаг үзэл юм. Хүмүүс яагаад ийм үзэл баримталдаг вэ? Шалтгаан нь маш энгийн: Учир нь хүмүүс завхарсан зан чанар дунд амьдарч, ёрын муу, бузар булай ертөнцөд амьдран суудаг. Тэдний хардаг бүх зүйл, хүрдэг бүх зүйл, туулдаг бүх зүйл нь Сатаны ёрын муу байдал, завхрал болон бас Сатаны нөлөөгөөр хүмүүсийн дунд өрнөдөг явуулга, дотоодын тэмцэл, дайн дажин байдаг. Иймээс Бурхан хүмүүст ажлаа хийж, бүр үг хэлж, зан чанар, мөн чанараа илчлэхэд ч гэсэн хүмүүс Бурханы ариун байдал, мөн чанарыг олж харж, мэдэж чаддаггүй. Бурхан ариун гэж хүмүүс байнга хэлдэг ч жинхэнэ ойлголтоор хомсхон бөгөөд зүгээр л хоосон үг хэлж байдаг. Учир нь хүмүүс бузар буртаг, завхрал дунд амьдарч, Сатаны эзэмшил дор байдаг бөгөөд гэрлийг хардаггүй, эерэг асуудлын талаар юу ч мэддэггүйгээс гадна үнэнийг мэддэггүй, “ариун” гэж юу гэсэн үг болохыг хэн ч үнэндээ мэддэггүй. Тэгвэл энэ завхарсан хүн төрөлхтний дунд ариун зүйл, ариун хүн бий юү? Үгүй, байхгүй гэж бид баттай хэлж чадна, учир нь Бурханы мөн чанар л ариун байдаг билээ.

Өнгөрсөн удаа бид Бурханы мөн чанар ариун байдгийн нэг талын тухай нөхөрлөсөн. Үүгээр хүмүүст Бурханы ариун байдлын талаар мэдэх урам өгсөн боловч энэ нь хангалтгүй юм. Энэ нь хүмүүст Бурханы ариун байдлыг бүрэн мэдэх

боломж хангалттай олгож чадахгүйн зэрэгцээ Бурханы ариун байдал цор ганц гэдгийг хангалттай ойлгуулж чадахгүй. Түүнчлэн Бурханд бүрэн биежсэн ариун байдлын жинхэнэ утга учрыг хүмүүст хангалттай ойлгуулж чадахгүй. Иймээс бид энэ сэдвээр үргэлжлүүлэн нөхөрлөх шаардлагатай. Өнгөрсөн удаа нөхөрлөл маань гурван сэдвийг хөндсөн тул одоо бид дөрөв дэх сэдвийг хэлэлцэх хэрэгтэй. Судраас уншаад нөхөрлөлөө эхэлцгээе.

Сатаны сорилт

Матай 4:1–4 Тэгээд Есүс диаволоор соригдохын тулд цөл рүү Сүнсээр хөтлөгдөв. Тэр дөчин өдөр, дөчин шөнө мацаг барьсны дараа өлсжээ. Соригч Түүн дээр ирээд, “Хэрвээ Чи Бурханы Хүү мөн юм бол энэ чулуунуудыг талх бол гэж тушаа” гэж хэлэв. Гэвч Есүс үүнд хариулан, “Хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдардаг гэж бичигдсэн байдаг” хэмээн хэлэв.

Диавол анх Эзэн Есүсийг сорихоор оролдсон үг энэ юм. Диаволын хэлсэн үг ямар агуулгатай байна вэ? (“Хэрвээ Чи Бурханы Хүү мөн юм бол энэ чулуунуудыг талх бол гэж тушаа.”) Диаволын хэлсэн эдгээр үг нэлээд энгийн хэдий ч мөн чанарт нь асуудал байна уу? “Хэрвээ Чи Бурханы Хүү мөн юм бол” гэж диавол хэлсэн, гэвч Есүс бол Бурханы хүү мөн гэдгийг диавол зүрх сэтгэлдээ мэдэж байсан уу, үгүй юу? Түүнийг Христ гэж мэдэж байсан уу, үгүй юу? (Мэдэж байсан.) Тэгвэл яагаад “Хэрвээ Чи … мөн юм бол” гэж хэлсэн юм бэ? (Тэр Бурханыг сорихоор оролдож байсан.) Гэвч ямар зорилготой ингэсэн юм бэ? “Хэрвээ Чи Бурханы Хүү мөн юм бол” гэж диавол хэлсэн. Есүс Христ бол Бурханы хүү гэдгийг тэр зүрх сэтгэлдээ мэдэж, тун тодорхой ойлгож, мэдсээр байж Түүнд захирагдаж, Түүнийг шүтэн мөргөсөн үү? (Үгүй.) Диавол яахыг хүссэн бэ? Энэ арга болон эдгээр үгийг ашиглан Эзэн Есүсийг уурлуулаад, дараа нь Түүнийг хуурч өөрийнхөө санаа зорилгод нийцүүлэн үйлдүүлэхийг хүссэн. Диаволын үг цаанаа ийм утгатай байсан бус уу? Эзэн Есүс Христ мөн гэдгийг нь Сатан зүрх сэтгэлдээ сайн мэдэж байсан хэрнээ ийм үг хэлсэн. Энэ нь Сатаны уг чанар бус уу? Сатаны уг чанар юу вэ? (Зальжин, ёрын муу бөгөөд Бурханыг огт хүндлэхгүй байх.) Бурханыг огт хүндлэхгүй байхаас ямар үр дагавар гарах вэ? Сатан Бурхан руу дайрч давшлахыг хүссэн бус уу? Энэ аргыг ашиглан Бурхан руу дайрч давшлахыг хүссэн тул “Хэрвээ Чи Бурханы Хүү мөн юм бол энэ чулуунуудыг талх бол гэж тушаа” хэмээсэн; энэ нь Сатаны ёрын муу санаархал бус уу? Тэр яг юу хийх гэж оролдсон бэ? Сатаны зорилго тун илэрхий байна: тэр ийм аргыг ашиглан Эзэн Есүс Христийн байр суурь, ялгамж чанарыг үгүйсгэхээр оролдож байсан юм. Сатаны тэр үг “Хэрвээ Чи Бурханы Хүү юм бол эдгээр чулууг талх болго. Тэгж чадахгүй бол Чи Бурханы Хүү биш, тиймээс ажлаа цаашид гүйцэтгэх ёсгүй” гэсэн утгатай байсан. Тийм байгаа биз дээ? Сатан энэ арга барилыг ашиглан Бурхан руу дайрч давшилж, Бурханы ажлыг нурааж, сүйрүүлэхийг хүссэн; Сатаны хорлонт байдал гэж энэ юм. Сатаны хорлонт байдал уг чанарынх нь төрөлх илэрхийлэл байдаг. Эзэн Есүс Христ бол Бурханы Хүү, бие

махбодтой болсон Бурхан Өөрөө яг мөн гэдгийг Сатан мэдэж байсан хэдий ч биеэ барьж чадалгүй ийм зүйл хийж, Бурханы араас ойрхон дагаж, Түүн рүү шаргуу дайрч давшлан, Бурханы ажлыг саатуулж, сүйтгэхийн тулд асар их хичээл зүтгэл гаргасан билээ.

Тэгвэл Сатаны хэлсэн “энэ чулуунуудыг талх бол гэж тушаа” хэмээх үгийг задлан шинжилье. Чулууг талх болгон хувиргах—энэ ямар нэг утгатай юу? Хоол байгаа бол яагаад түүнийгээ идэхгүй гэж? Яагаад чулууг хоол болгох шаардлагатай гэж? Энэ нь ямар ч утгагүй юм гэж хэлж болох уу? Тухайн үед Эзэн Есүс мацаг барьж байсан ч идэх хоолтой л байсан байлтай? (Тийм ээ.) Тэгвэл Сатаны үг учир утгагүй гэдгийг бид эндээс харж байна. Сатан заль мэхтэй, хорлонтой атлаа утга учиргүй, ухаанд багтамгүй байдгийг бид мөн л харж болно. Сатаны хийдэг хэд хэдэн зүйлээс хорлонт уг чанар нь харагддаг; Бурханы ажлыг бусниулах зүйл хийж байгааг нь харж болох бөгөөд үүнийг нь хараад Сатан бол үзэн ядам, уур хүргэм гэдгийг чи мэдэрнэ. Гэвч нөгөөтээгүүр, чи Сатаны үг, үйлдлийн цаанаас томоогүй, хөгийн уг чанар байгааг харахгүй байна уу? Сатаны уг чанарын илчлэл энэ юм; Сатан иймэрхүү уг чанартай тул ийм зүйл хийнэ. Өнөөгийн хүмүүст Сатаны эдгээр үг утга учиргүй, марзан санагддаг. Гэвч Сатан үнэхээр ийм үг хэлэх чадвартай. Түүнийг мунхаг, утгагүй гэж хэлж болох уу? Сатаны ёрын муу газар сайгүй байдаг бөгөөд цаг ямагт илчлэгддэг. Эзэн Есүс түүнд хэрхэн хариулсан бэ? (“Хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдардаг гэж бичигдсэн байдаг.”) Эдгээр үгэнд ямар нэг хүч чадал байна уу? (Байна.) Яагаад бид эдгээрт хүч чадал байна гэж хэлдэг вэ? Учир нь эдгээр үг үнэн юм. Тэгвэл хүн гагцхүү талхаар амь зуудаг уу? Эзэн Есүс дөчин өдөр, дөчин шөнийн турш мацаг барьсан. Тэгээд өлбөрч үхсэн үү? Түүнийг өлбөрч үхээгүй тул Сатан ирээд “Чи чулууг хоол болгон хувиргавал идэх юмтай болох бус уу? Тэгвэл мацаг барих, гэдэс хоосон явах шаардлагагүй шүү дээ” гэх зэрэг үг хэлж, чулууг хоол болгон хувирга гэж шавдуулсан. Гэвч Эзэн Есүс, “Хүн зөвхөн талхаар амьдардаггүй” хэмээсэн нь хүн хэдий махан биед амьдардаг ч бие махбодыг нь хоол биш, харин Бурханы амаараа айлдсан үг бүр амьдруулж, амьсгалуулдаг юм гэсэн утгатай. Нэг талаар, эдгээр үг бол үнэн; тэдгээр нь хүмүүст итгэл өгч, Бурханд найдаж болно, Бурхан бол үнэн мөн гэдгийг тэдэнд мэдрүүлдэг. Нөгөө талаар, эдгээр үгэнд бодитой тал байна уу? Эзэн Есүс дөчин өдөр, дөчин шөнийн турш мацаг барьсныхаа дараа мөн л амьд сэрүүн зогсож байсан бус уу? Энэ бодит жишээ бус уу? Дөчин өдөр, дөчин шөнийн турш ямар ч хоол идээгүй атлаа Тэр амьд мэнд хэвээр байсан. Энэ нь Түүний үг үнэн гэдгийн хүчирхэг нотолгоо юм. Эдгээр үг энгийн боловч Эзэн Есүсийн хувьд, Сатан Өөрийг нь уруу татах үед л Тэр тэгж хэлсэн үү, эсвэл тэдгээр нь аль хэдийн угаасаа Түүний нэг хэсэг байсан уу? Өөрөөр хэлбэл, Бурхан бол үнэн ба амь боловч Бурханы үнэн ба амь дараа нь нэмэгдсэн хэрэг үү? Хожмын туршлагаас гарсан хэрэг үү? Үгүй, тэдгээр нь Бурханд угаасаа байдаг. Өөрөөр хэлбэл, үнэн ба амь нь Бурханы мөн

чанар юм. Бурханд юу ч тохиолдлоо гэсэн Түүний илэрхийлдэг бүхэн үнэн байдаг. Түүний ярианы агуулга урт ч бай, богино ч бай—энэхүү үнэн, эдгээр үг хүнд амьдрах боломж олгож, амь өгдөг; тэдгээр нь хүмүүст үнэнийг олж авах, хүний амьдралын зам мөрийн талаар тодорхой ойлголттой болох, Бурханд итгэх боломж олгож чаддаг. Өөрөөр хэлбэл, Бурхан эдгээр үгийг хэрэглэдэг нь эерэг эх сурвалжтай. Иймээс бид энэ эерэг зүйлийг ариун гэж хэлж болох уу? (Болно.) Сатаны тэр үгс Сатаны уг чанараас үүдэлтэй. Сатан ёрын муу, хорлонт уг чанараа цаг ямагт газар сайгүй илчилдэг. Тэгвэл Сатан эдгээр илчлэлийг аяндаа хийдэг үү? Эсвэл хэн нэгэн түүнийг ингэ гэж удирддаг уу? Хэн нэгэн түүнд тусалдаг уу? Түүнийг албаддаг уу? Үгүй. Энэ бүх илчлэлээ Сатан өөрийн хүслээр хийдэг. Энэ нь Сатаны ёрын муу уг чанар юм. Бурхан юуг ч, яаж ч хийхэд Сатан Түүнийг өсгий даран дагадаг. Сатаны хэлж, хийдэг эдгээр зүйлийн мөн чанар, жинхэнэ уг чанар нь Сатаны мөн чанар буюу ёрын муу, хорлонт мөн чанар юм. Тэгвэл цааш уншихад Сатан өөр юу гэж хэлсэн байна вэ? Уншицгаая.

Матай 4:5–7 Тэгээд диавол Түүнийг ариун хотод аваачиж, сүмийн орой дээр зогсоогоод Түүнд, “Хэрвээ Чи Бурханы Хүү юм бол доошоо үсэр: учир нь, Чиний төлөө Тэр тэнгэрэлчүүддээ тушаал өгнө: Чамайг хөлөө чулуунд цохих вий гэсэндээ тэд Чамайг гар дээрээ өргөх болно гэж бичигдсэн байдаг шүү дээ” гэлээ. Есүс түүнд, “Чи өөрийн Бурхан Эзэнээ бүү сорь гэж бас бичигдсэн байдаг” гэж хэлэв.

Сатаны энд хэлсэн үгийг эхлээд харъя. “Хэрвээ Чи Бурханы Хүү юм бол доошоо үсэр” гэж Сатан хэлээд “Чиний төлөө Тэр тэнгэрэлч нартаа тушаах болно: Чамайг хөлөө чулуунд цохих вий гэсэндээ тэд Чамайг гар дээрээ өргөх болно” хэмээн судраас эш татсан байна. Сатаны үгийг сонсоход ямаршуу санагдаж байна? Маш томоогүй байгаа биз? Түүний үг маш томоогүй, утга учиргүй, ой гутам байна. Би яагаад ингэж хэлж байна вэ? Сатан үргэлж мунхаг зүйл хийж, өөрийгөө тун овжин гэж боддог. Судраас—тэр ч бүү хэл Бурханы хэлсэн үгийг хүртэл—байнга эш татаж, Бурханы ажлын төлөвлөгөөг сүйтгэх зорилгоо биелүүлэхийн тулд эдгээр үгийг Бурханы эсрэг эргүүлж, Түүн рүү дайрч давшлах, Түүнийг сорихоор оролддог. Чи Сатаны хэлсэн эдгээр үгээс ямар нэг зүйл харж чадав уу? (Сатан ёрын муу санаа өвөрлөдөг.) Сатан хийдэг бүхэндээ цаг ямагт хүн төрөлхтнийг сорихоор эрэлхийлж ирсэн юм. Сатан илэн далангүй ярьдаггүй, харин сорьж, толгой эргүүлж, сэтгэл булаахыг хэрэглэн бөөрөнхийлдөг. Сатан сорилтдоо Бурханыг эгэл хүн мэтээр үзэж, Түүнийг мөн л мэдлэггүй, мунхаг, бөгөөд аливаа зүйлийн жинхэнэ дүрийг яг л хүн шиг тодорхой ялгаж чадахгүй гэж итгэх хандлагатай байдаг. Бурхан, хүн хоёрын аль аль нь Сатаны мөн чанар, ов мэх, ёрын санаа зорилгыг нэвт харж чадахгүй гэж Сатан боддог. Сатаны мунхаглал гэж энэ бус уу? Түүнчлэн Сатан судраас хэт их эш татдаг, ингэснээр өөрийгөө үнэмшилтэй болгох ба чи үгээс нь ямар ч өө сэв олж чадахгүй, мөн хууртахаас зайлсхийж чадахгүй гэж итгэдэг. Сатаны утга учиргүй, томоогүй зан энэ бус уу? Хүмүүс сайн мэдээ түгээж, Бурханд

гэрчлэл хийх үетэй энэ нь яг адил: Заримдаа үл итгэгчид Сатаны хэлсэнтэй төстэй зүйл хэлэх бус уу? Хүмүүс иймэрхүү зүйл хэлэхийг та нар сонсож байсан уу? Ийм үг сонсоод чамд ямар санагддаг вэ? Ой гутдаг уу? (Тийм.) Ой гутахдаа мөн хорсол, үзэн ядалт мэдэрдэг үү? Ийм мэдрэмж төрөх үед Сатан болон Сатаны хүнд өгдөг завхарсан зан чанар нь хорон муу гэдгийг чи таньж чаддаг уу? “Сатан ярихдаа дайрч давшилж, сорьж байдаг; Сатаны үг утгагүй, хөгийн, томоогүй, ой гутам юм; гэтэл Бурхан хэзээ ч ийм маягаар үг хэлж, ажиллахгүй, Тэр үнэхээр хэзээ ч тэгж байгаагүй” хэмээн зүрх сэтгэлдээ чи ер нь ухаардаг уу? Мэдээж, энэ нөхцөлд хүмүүс үүнийг бүдэг бадаг л мэдэрч чаддаг бөгөөд Бурханы ариун байдлыг ухаарч чадахгүй хэвээр үлддэг. Өнөөгийн биеийн хэмжээгээрээ та нар гагцхүү ингэж мэдэрдэг: “Бурханы хэлдэг бүхэн үнэн бөгөөд бидэнд ашиг тустай, бид үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой.” Үүнийг чи хүлээн зөвшөөрч чаддаг ч бай, үгүй ч бай ялгаагүй Бурханы үг бол үнэн, Бурхан бол үнэн гэж хэлдэг хэдий ч үнэн өөрөө ариун, Бурхан бол ариун гэдгийг мэддэггүй.

Тэгвэл Сатаны эдгээр үгэнд Есүс юу гэж хариулсан бэ? “Чи өөрийн Бурхан Эзэнээ бүү сорь гэж бас бичигдсэн байдаг” хэмээсэн. Есүсийн хэлсэн эдгээр үг үнэний ортой юу? Эдгээр нь гарцаагүй үнэний ортой. Гаднаа бол эдгээр үг нь хүмүүсийн дагаж мөрдөх тушаал, энгийн нэг хэллэг боловч хүн, Сатан хоёр хоёулаа эдгээр үгэнд байнга халддаг байв. Иймээс Эзэн Есүс, “Чи өөрийн Бурхан Эзэнээ бүү сорь” гэж Сатанд хэлсэн, учир нь Сатан үргэлж ийм зүйл хийж, ингэхдээ их л хичээл зүтгэл гаргадаг байсан юм. Сатан үүнийгээ ичгүүр, сонжуургүй хийдэг байсан гэж хэлж болно. Бурханаас айхгүй, зүрх сэтгэлдээ Бурханыг хүндлэхгүй байх нь Сатаны салшгүй уг чанар-мөн чанар юм. Сатан Бурханы дэргэд зогсож, Түүнийг харж байхдаа ч биеэ барьж чадалгүй Бурханыг сорьсон. Иймээс Эзэн Есүс Сатанд, “Чи өөрийн Бурхан Эзэнээ бүү сорь” хэмээжээ. Бурхан эдгээр үгийг Сатанд байнга хэлсэн. Тэгвэл энэ хэллэгийг өнөөдөр хэрэглэхэд тохиромжтой юу? (Тийм, яагаад гэвэл, бид ч бас Бурханыг байнга сорьдог.) Хүмүүс Бурханыг яагаад байнга сорьдог юм бэ? Сатанлаг завхарсан зан чанараар дүүрэн байдаг учраас тэр үү? (Тийм ээ.) Тэгвэл Сатаны дээр дурдсан үгийг хүмүүс байнга хэлдэг үү? Мөн ямар нөхцөлд энэ үгсийг хэлдэг вэ? Хүмүүс хэзээ, хаана гэдгээс үл хамааран ийм үг хэлсээр ирсэн гэхэд болно. Хүмүүсийн зан чанар нь Сатаны завхарсан зан чанараас ялгарах юмгүй гэдгийг энэ нотолдог. Эзэн Есүс үнэнийг төлөөлдөг, хүнд хэрэгтэй эгэл жирийн цөөхөн үг хэлсэн. Гэхдээ энэ нөхцөлд Эзэн Есүс Сатантай маргахын тулд ийм маягаар ярьж байсан уу? Түүний Сатанд хэлсэн үгэнд сөргөлдсөн зүйл байсан уу? (Байгаагүй.) Эзэн Есүсийн сэтгэлд Сатаны сорилт ямар санагдсан бэ? Үүнд нь Эзэний ой гутаж, жигшил төрсөн үү? Эзэн Есүс ой нь гутаж, жигшсэн атлаа Сатантай маргаагүй бөгөөд аливаа агуу зарчмын талаар бүр ч яриагүй. Яагаад тэр вэ? (Яагаад гэвэл, Сатан ямагт ийм байдаг; тэр хэзээ ч өөрчлөгдөж чадахгүй.) Сатан эрүүл ухаангүй гэж хэлж болох уу? (Болно.) Бурхан бол үнэн гэдгийг Сатан зөвшөөрч чадах уу? Бурхан бол үнэн гэдгийг Сатан хэзээ ч

зөвшөөрөхгүй, мөн Бурхан бол үнэн гэдгийг хэзээ ч хүлээж авахгүй; энэ бол Сатаны уг чанар юм. Сатаны уг чанарт бас нэг жигшүүртэй тал бий. Тэр нь юу вэ? Эзэн Есүсийг сорих гэж чармайхдаа Сатан бүтэлгүйтэх байсан ч хамаагүй бас л оролдоод үзнэ гэж бодсон. Шийтгүүлэх байсан ч гэсэн оролдоод үзэхээр шийдсэн. Ингэх нь хэдийгээр ямар ч ашиггүй байсан боловч оролдож, шаргуу зүтгэл гарган, Бурханы эсрэг эцсээ хүртэл зогсох байсан юм. Энэ ямар янзын уг чанар вэ? Ёрын муу бус уу? Бурханыг дурдах үед хилэгнэж, багтартлаа уурладаг хүн Бурханыг харсан уу? Бурхан гэж хэн болохыг мэдэх үү? Тэр хүн Бурхан гэж хэн болохыг мэддэггүй, Түүнд итгэдэггүй бөгөөд Бурхан түүнтэй яриагүй байдаг. Бурхан түүнд хэзээ ч төвөг удаагүй атал юунд уурлана вэ? Энэ хүнийг ёрын муу гэхэд болох уу? Дэлхий ертөнцийн чиг хандлага, идэж уух, зугаа цэнгэлээр хөөцөлдөх, алдартнуудын араас гүйх—эдгээр зүйлийн аль нь ч ийм хүнд төвөг уддаггүй. Гэвч “Бурхан” гэх үгийг, эсвэл Бурханы үгийн үнэнийг дөнгөж дурдмагц тэрээр багтартлаа уурладаг. Ёрын муу уг чанартай гэдгийг энэ нь илтгэдэг бус уу? Энэ хүний ёрын муу уг чанар гэдгийг үүгээр нотлоход хангалттай. Тэгвэл та нарын хувьд яривал, үнэнийг дурдахад юм уу, хүн төрөлхтнийг шалгах Бурханы шалгалт, эсвэл хүнийг шүүсэн Бурханы шүүлтийн үгийг дурдахад зэвүүцэх үе байдаг уу? Та нарт жигшүүртэй санагдаж, тийм зүйл сонсохыг хүсдэггүй юу? “Бурхан бол үнэн гэж хүн бүхэн хэлдэггүй юм уу? Эдгээр үгийн зарим нь худлаа! Хүнд чиглэсэн Бурханы сануулга л байна!” гэж чи сэтгэлдээ бодож магад. Зарим хүн, тэр ч бүү хэл зүрх сэтгэлдээ ихэд зэвүүцэж, “Өдөр болгон л Түүний шалгалт, шүүлтийн тухай ярьдаг, хэзээ болих юм бэ? Бид сайн хүрэх газрыг хэзээ хүлээж авах юм бэ?” гэж бодож магадгүй. Энэхүү үндэслэлгүй уур хаанаас гардаг нь мэдэгддэггүй. Энэ ямар янзын уг чанар вэ? (Ёрын муу уг чанар.) Үүнийг Сатаны ёрын муу уг чанар удирдан чиглүүлдэг. Бурханы зүгээс Сатаны ёрын муу уг чанар, хүний завхарсан зан чанарын тухайд хэзээ ч маргаж, эсвэл хүмүүсийн эсрэг өс санадаггүй бөгөөд хүмүүсийг мунхаглах үед хэзээ ч сүр бадруулдаггүй. Аливаа зүйлийн тухайд Бурхан хүмүүстэй адилхан бодолтой байхыг чи хэзээ ч харахгүй, түүнээс гадна асуудлыг зохицуулахдаа хүн төрөлхтний үзэл бодол, мэдлэг, шинжлэх ухаан, гүн ухаан, төсөөллийг ашиглаж байхыг нь хэзээ ч харахгүй. Харин ч Бурханы хийдэг бүхэн, илчилдэг бүхэн нь үнэнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, Түүний хэлсэн үг, хийсэн үйлдэл бүр үнэнтэй уялдаж байдаг. Энэ үнэн нь үндэслэлгүй уран сэтгэмжийн үр дүн биш; энэ үнэн, эдгээр үг нь Бурхан Өөрийн мөн чанар, амийн үр дүнд илэрхийлэгддэг. Эдгээр үг болон Бурханы хийсэн бүх зүйлийн мөн чанар нь үнэн байдаг тул Бурханы мөн чанар ариун гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, Бурханы хэлдэг бүх үг, хийдэг бүх зүйл хүмүүст амин чанар, гэрэл авчирч, эерэг зүйл болон тэдгээрийн бодит байдлыг харах боломж олгож, зөв замаар алхуулахын тулд хүн төрөлхтөнд зам заадаг. Эдгээр зүйл бүгд Бурханы мөн чанар болон Түүний ариун байдлын мөн чанараар тодорхойлогддог. Та нар одоо үүнийг ойлгосон биз дээ? За, судраас бас нэгэн хэсгийг цааш уншицгаая.

Матай 4:8–11 Диавол Түүнийг дахин асар өндөр ууланд аваачаад дэлхийн бүх хаанчлалыг болон алдар сууг нь үзүүллээ; Тэгээд тэр Түүнд, “Хэрвээ Чи газар унан, надад мөргөвөл би энэ бүхнийг чамд өгнө” гэв. Тэгэхэд Есүс түүнд, “Зайл, Сатан: учир нь ‘Чи өөрийн Бурхан Эзэнийг шүтэн мөргөж, зөвхөн Түүнд үйлчил’ гэж бичигдсэн байдаг” гэж хэлжээ. Тэгээд диавол Түүнийг орхиход тэнгэрэлчүүд ирж, Түүнд үйлчилж эхлэв.

Өмнөх хоёр явуулга нь бүтэлгүйтчихсэн атал диавол Сатан бас нэгэн явуулга хийхээр оролджээ: Эзэн Есүст ертөнцийн бүх хаант улс, тэдгээрийн алдар сууг үзүүлээд, намайг шүтээч гэж хүссэн байна. Энэ нөхцөл байдлаас диаволын үнэн төрхийн тухайд юу харагдаж байна вэ? Диавол Сатан туйлын ичгүүргүй гэдэг нь харагдаж байна уу? (Тийм ээ.) Яагаад ичгүүргүй байна вэ? Бүх зүйлийг Бурхан бүтээсэн атал Сатан эргээд Бурханд бүх зүйлийг үзүүлж, “Энэ бүх хаант улсын эд баялаг, алдар сууг хар. Намайг шүтвэл энэ бүхнийг Чамд өгье” хэмээсэн. Энэ нь байдлыг орвонгоор нь эргүүлсэн хэрэг бус уу? Сатан ичгүүргүй бус уу? Бурхан бүх зүйлийг бүтээхдээ бүхнийг Өөрийн таашаалд зориулан бүтээсэн гэж үү? Бурхан хүн төрөлхтөнд бүх зүйлийг өгсөн, харин Сатан энэ бүхнийг булааж авахыг хүссэн бөгөөд бүгдийг нь булаачхаад, “Намайг шүт! Намайг шүт, тэгвэл энэ бүхнийг Чамд өгье” гэж Бурханд хэлсэн. Энэ бол Сатаны үзэшгүй муухай царай мөн; тэр туйлын ичгүүргүй! Сатан “ичгүүр” гэдэг үг ямар утгатайг ч мэддэггүй. Энэ нь Сатаны ёрын муу байдлын бас нэг жишээ юм. Ичгүүр гэж юу болохыг ч тэр мэддэггүй. Бурхан бүх зүйлийг бүтээсэн, мөн Бурхан бүх зүйлийг удирдаж, ноёрхдог гэдгийг Сатан мэддэг нь тодорхой. Бүх зүйл Бурханы харьяа байдаг болохоос хүнд харьяалагддаггүй, Сатанд бүр ч харьяалагддаггүй. Гэтэл диавол Сатан бүх зүйлийг Бурханд өгнө гэж ичихгүй хэлсэн. Сатан дахиад л утгагүй, ичгүүргүй аашилж байгаагийн бас нэгэн жишээ энэ бус уу? Үүнээс үүдэн Бурхан Сатаныг улам ч их үзэн яддаг, тийм биз дээ? Гэвч Сатан яаж ч оролдлоо гэсэн Эзэн Есүс хуурtсан уу? Эзэн Есүс юу гэж хэлсэн бэ? (“Чи өөрийн Бурхан Эзэнийг шүтэн мөргөж, зөвхөн Түүнд үйлчил.”) Эдгээр үг нь бодит утгатай юу? (Тийм ээ.) Ямаршуу бодит утгатай вэ? Сатаны ёрын муу, ичгүүргүй байдал ярианаас нь харагддаг. Иймээс хүн Сатаныг шүтвэл ямар үр дүнд хүрэх вэ? Бүх хаант улсын эд баялаг, алдар сууг хүртэх үү? (Үгүй.) Тэгвэл юу хүртэх вэ? Хүн төрөлхтөн яг л Сатан шиг ичгүүргүй, хөгийн болох уу? (Тэгнэ.) Тэгвэл тэд Сатанаас ямар ч ялгаагүй болно. Иймээс Эзэн Есүс, “Чи өөрийн Бурхан Эзэнийг шүтэн мөргөж, зөвхөн Түүнд үйлчил” хэмээсэн нь хүн нэг бүрд чухал үг юм. Энэ нь чи Эзэнээс өөр, Бурханаас өөр нэгэнд үйлчилсэн бол, диавол Сатаныг шүтсэн бол Сатантай адилхан бузар булайд хөлбөрнө гэсэн үг. Тэгээд чи Сатаны ичгүүргүй, ёрын мууг хуваалцаж, яг Сатаны яг адилаар Бурханыг сорьж, Бурхан руу дайрч давшилна. Тэгээд чи ямар үр дүнд хүрэх вэ? Бурханд жигшигдэж, Бурханаар цохиулж унан, сөнөх болно. Эзэн Есүсийг Сатан хэдэнтээ сориод бүтэлгүйтсэнийхээ дараа дахин оролдож үзсэн үү? Дахин оролдолгүй яваад өгсөн. Энэ юуг нотолдог вэ? Бурханы өмнө Сатаны ёрын муу уг

чанар, хорлонт зан, утгагүй, дэмий балай байдлыг дурдах ч хэрэггүй гэдгийг нотолдог. Эзэн Есүсийн гуравхан өгүүлбэрт ялагдчихаад Сатан нүүрээ харуулахаас ч ичиж, сүүлээ хавчин яаран гүйсэн бөгөөд Эзэн Есүсийг дахин хэзээ ч сориогүй. Сатаны энэ сорилтыг Эзэн Есүс дийлсэн тул Өөрийн хийх ёстой ажил, өмнөө байгаа албыг амархан үргэлжлүүлж чадсан юм. Энэ нөхцөлд Эзэн Есүсийн хэлсэн үг, хийсэн бүхнийг өнөө үед хэрэглэсэн бол хүн нэг бүрд ямарваа бодит утга учиртай байх уу? (Тийм ээ.) Ямар бодит утга байх вэ? Сатаныг ялах амархан хэрэг үү? Сатаны ёрын муу уг чанарын талаар хүмүүс тодорхой ойлголттой байх ёстой юу? Сатаны сорилтын талаар хүмүүс нарийн ойлголттой байх ёстой юу? (Тийм ээ.) Чи өөрийн амьдралд Сатаны сорилтыг туулахдаа ёрын муу уг чанарыг нь нэвт харж чадсан бол түүнийг ялж чадах бус уу? Хэрвээ Сатаны утгагүй, дэмий балай байдлын талаар мэдсэн бол чи мөн л Сатаны талд зогсон Бурхан руу дайрч давшилна гэж үү? Сатаны хорлонтой, ичгүүргүй байдал чамаар дамжин хэрхэн илэрч байгааг ойлгосон бол, эдгээр зүйлийг тодорхой таньж, ухаарсан бол Бурханыг ийм маягаар дайрч давшилж, сорьсоор байх уу? (Үгүй, тэгэхгүй.) Тэгвэл юу хийх вэ? (Бид Сатаны эсрэг тэрсэлж, түүнийг хөсөр хаях байсан.) Тэгэх амархан хэрэг үү? Тэр амаргүй. Ингэхийн тулд хүмүүс тогтмол залбирч, Бурханы өмнө байнга очиж, өөрсдийгөө шинжих ёстой. Мөн Бурханаас сахилгажуулалт, шүүлт, гэсгээлт хүртэхийг зөвшөөрөх ёстой. Ийм маягаар л хүмүүс Сатаны ов мэх, хяналтаас аажмаар ангижирна.

Сатаны хэлсэн энэ бүх үгийг хараад Сатаны мөн чанарыг бүрдүүлдэг зүйлсийг нэгтгэн дүгнэе. Нэгдүгээрт, Сатаны мөн чанарыг Бурхан ариун байдалтай жишихэд ёрын муу гэж ерөнхийдөө хэлж болно. Яагаад Би Сатаны мөн чанарыг ёрын муу гэж хэлж байна вэ? Энэ асуултад хариулахын тулд хүмүүст Сатаны хийдэг зүйлийн үр дагаврыг шинжих ёстой. Сатан хүнийг завхруулж, хянадаг бөгөөд хүн Сатаны завхарсан зан чанарын дор үйлдэж, Сатаны завхруулсан хүний ертөнцөд амьдардаг. Хүн төрөлхтөн өөрийн мэдэлгүй Сатанд эзэмдүүлж, уусдаг; иймээс хүн Сатаны уг чанар болох Сатаны завхарсан зан чанартай байдаг. Сатаны биеэ тоосон занг хэлсэн үг, хийсэн бүхнээс нь харав уу? Заль мэх, хорон санааг нь харсан уу? Сатаны биеэ тоосон зан гол төлөв хэрхэн харагддаг вэ? Сатан, Бурханы байр суурийг эзлэх хүсэл ямагт өвөрлөдөг үү? Сатан хүмүүс өөрийг нь дагаж, дэмжиж, шүтдэг болоосой гэсэндээ Бурханы ажил, байр суурийг нурааж, булааж авахыг ямагт хүсдэг; энэ нь Сатаны биеэ тоосон уг чанар юм. Сатан хүмүүсийг завхруулахдаа тэдэнд яах ёстойг шууд хэлдэг үү? Сатан Бурханыг сорихдоо гарч ирээд “Би Чамайг сорьж байна, би Чам руу дайрч давшлах гэж байна” гэж хэлдэг үү? Огт тэгдэггүй. Тэгвэл Сатан ямар арга барил хэрэглэдэг вэ? Уруу татаж, сорьж, дайрч давшилж, урхи тавьж, тэр ч бүү хэл судраас эш татдаг. Сатан ёрын зорилгодоо хүрч, санаа зорилгоо биелүүлэхийн тулд янз бүрийн байдлаар үг хэлж, үйлддэг. Ингэснийх нь дараа хүнд илэрдэг зүйлээс юу харж болох вэ? Хүмүүс бас биеэ тоодог бус уу? Хүн олон мянган жилийн турш Сатаны завхралд өртсөн тул

биеэ тоосон, ов мэхтэй, хорон санаатай, эрүүл ухаангүй болсон юм. Энэ бүх зүйл нь Сатаны уг чанарын улмаас бий болдог. Сатан ёрын муу уг чанартай тул ийм ёрын муу уг чанарыг хүнд өгч, ийм ёрын муу, завхарсан зан чанарыг хүнд авчирчээ. Иймээс хүн завхарсан сатанлаг зан чанарын дор амьдарч, Сатаны адилаар Бурханыг эсэргүүцэж, Бурхан руу дайрч давшилж, Түүнийг сорьдог бөгөөд Бурханыг шүтэн мөргөж чадахгүй, мөн Бурханыг хүндлэх зүрх сэтгэлгүй болохдоо тулдаг.

Сатан хүнийг завхруулдаг таван арга зам

Бурханы ариун байдал танил сэдэв байж болох ч яриад үзэхээр зарим хүнд арай хийсвэр болж, агуулга нь арай гүнзгий, хүрэхийн аргагүй байж магадгүй. Гэхдээ санаа зовох хэрэггүй. Бурханы ариун байдал гэж юу болохыг ойлгоход чинь Би тусална. Хэн нэгний ямаршуу хүн бэ гэдгийг ойлгохын тулд хийдэг зүйл, үйлдлийнх нь үр дүнг хар, тэгвэл тухайн хүний мөн чанарыг ойлгож чадна. Ингэж хэлж болох уу? (Болно.) Тэгвэл эхлээд Бурханы ариун байдлын талаар энэ өнцгөөс нөхөрлөцгөөе. Сатаны мөн чанар ёрын муу байдаг гэж хэлж болно, иймээс хүнд чиглэсэн Сатаны үйлдэл хүнийг зогсолтгүй завхруулах явдал байж ирлээ. Сатан ёрын муу учраас түүний завхруулсан хүмүүс гарцаагүй ёрын муу байна. “Сатан ёрын муу, гэхдээ түүний завхруулсан хүн ариун байж магадгүй” гэж хэлэх үү? Тэгвэл хөгийн юм болно биз дээ? Тийм зүйл байж болно гэж үү? (Болохгүй.) Сатан ёрын муу бөгөөд түүний ёрын муу байдалд мөн чанарын болон бодитой тал аль аль нь бий. Энэ зүгээр ч нэг хоосон үг биш. Бид Сатаныг гутаах гээгүй; бид гагцхүү үнэн ба бодит байдлын тухай нөхөрлөж байна. Энэ сэдвийн бодит байдлын талаар нөхөрлөхөөр зарим нэг хүн, эсвэл тодорхой нэг бүлэг хүмүүс эмзэглэж магадгүй ч үүнд ямарваа хорон санаа байхгүй: өнөөдөр та нар үүнийг сонсоод жаахан тавгүйрхэж магад, гэвч үүнийг хүлээн зөвшөөрөх өдөр удахгүй ирэхэд та нар өөрсдийгөө жигших бөгөөд өнөөдөр ярьсан зүйл маань та нарт маш хэрэгтэй, тун үнэ цэнтэй гэдгийг мэдэрнэ. Сатаны мөн чанар ёрын муу байдаг, тиймээс Сатаны үйлдлийн үр дүн гарцаагүй ёрын муу, эсвэл дор хаяад ёрын муутай нь холбоотой байдаг гэж хэлж болох уу? (Болно.) Тэгвэл Сатан хүмүүсийг хэрхэн завхруулж байдаг вэ? Дэлхийд болон хүн төрөлхтний дунд Сатаны хийдэг ёрын муугийн дотроос тухайлсан ямар тал нь хүмүүст илэрхий, ойлгомжтой байдаг вэ? Та нар энэ талаар урьд нь бодож үзсэн үү? Энэ тухайд та нар нэг их бодоогүй байж магад тул Би хэдэн гол асуудлыг хөндье. Сатаны дэвшүүлдэг хувьслын онолын талаар хүн бүр мэднэ, тийм биз? Энэ нь хүмүүсийн судалдаг мэдлэгийн салбар биз дээ? (Тийм.) Ингээд, Сатан хүнийг завхруулахын тулд эхлээд эрдэм мэдлэгийг ашигладаг бөгөөд тэдэнд мэдлэг олгох гэж өөрийн сатанлаг арга барилыг ашигладаг. Дараа нь тэр хүнийг завхруулах гээд шинжлэх ухааныг ашиглан эрдэм мэдлэг, шинжлэх ухаан, нууцлаг юмс болон хүмүүсийн судлахыг хүсдэг зүйлсийн тухай сонирхлыг нь өдөөдөг. Хүнийг завхруулахад ашигладаг дараачийн зүйлс нь уламжлалт соёл, мухар сүсэг бөгөөд үүний дараа нийгмийн хандлага байдаг.

Эдгээр нь бүгд хүмүүсийн өдөр тутмын амьдралд тохиолддог ба хүмүүсийн ойр орчимд оршдог зүйлс юм; тэдгээр нь бүгд хүмүүсийн хардаг, сонсдог, хүрдэг, мэдэрдэг зүйлстэй холбоотой байдаг. Хүн болгон эдгээр зүйлээр хүрээлүүлэн амьдардаг бөгөөд өөрөө хүсэвч эдгээрээс ангижирч, чөлөөлөгдөж чаддаггүй гэхэд болно. Эдгээр зүйлтэй тулгараад хүн төрөлхтөн аргаа барах агаад нөлөөнд нь автаж, халдвар авч, хяналт, хүлээсэнд нь орохоос өөр яаж ч чадахгүй; хүн тэдгээрээс мултрахад хүчин мөхөстдөг.

а. Сатан хүнийг завхруулахад эрдэм мэдлэгийг хэрхэн ашигладаг тухай

Эхлээд эрдэм мэдлэгийн талаар ярилцъя. Эрдэм мэдлэгийг хүн бүр эерэг зүйл гэж үздэг үү? Наад зах нь, “эрдэм мэдлэг” гэдэг үгийг хүмүүс сөрөг гэхээсээ эерэг утгатай гэж боддог. Тэгвэл Сатан хүнийг завхруулахдаа эрдэм мэдлэгийг ашигладаг гэж бид энд яагаад дурдаад байна вэ? Хувьслын онол нь эрдэм мэдлэгийн нэг тал бус уу? Ньютоны шинжлэх ухааны хуулиуд эрдэм мэдлэгийн нэг хэсэг бус уу? Дэлхийн таталцлын хүч ч мөн эрдэм мэдлэгийн нэг хэсэг, тийм биз? (Тийм.) Тэгвэл хүн төрөлхтнийг завхруулахад Сатаны ашигладаг зүйлсийн дунд яагаад эрдэм мэдлэгийг жагсаасан байна вэ? Та нар энэ тухай юу гэж бодож байна? Эрдэм мэдлэгт өчүүхэн төдий ч үнэн байдаг гэж үү? (Байхгүй.) Тэгвэл эрдэм мэдлэг ямар мөн чанартай вэ? Хүн олж авдаг бүх эрдэм мэдлэгийг юун дээр үндэслэн сурдаг вэ? Хувьслын онолд үндэслэдэг үү? Судалгаа шинжилгээгээр олж авсан хүний мэдлэг, дүгнэлт нь бурхангүйн үзэлд үндэслэдэг бус уу? Энэхүү эрдэм мэдлэгийн аль нэг нь Бурхантай холбоотой юу? Бурханыг шүтэн мөргөхтэй холбоотой юу? Үнэнтэй холбоотой юу? (Үгүй.) Тэгвэл Сатан хүнийг завхруулахад эрдэм мэдлэгийг хэрхэн ашигладаг вэ? Энэ эрдэм мэдлэгийн аль нь ч Бурханыг шүтэн мөргөхтэй юм уу, үнэнтэй холбоогүй гэж Би сая хэллээ. Зарим хүн энэ тухай “Эрдэм мэдлэг үнэнд ямар ч хамаагүй байж болно, гэхдээ бас хүмүүсийг завхруулдаггүй шүү дээ” гэж боддог. Та нар энэ тухай ямар бодолтой байна? Хүн аз жаргалаа хоёр гараараа бүтээх ёстой гэж эрдэм мэдлэг чамд заасан уу? Хүний хувь заяа өөрийнх нь гарт байдаг гэж эрдэм мэдлэг чамд заасан уу? (Тийм.) Энэ ямар янзын яриа вэ? (Диаволын яриа.) Яг зөв! Диаволын яриа! Мэдлэг бол хэлэлцэхэд ээдрээтэй сэдэв. Чи эрдэм мэдлэгийн салбар бол зүгээр л мэдлэгээс цаашгүй гэж хэлж магад. Энэ бол Бурханыг шүтэн мөргөхөд тулгуурлахгүй, Бурхан бүх зүйлийг бүтээсэн гэдгийг ойлгохгүйгээр сурдаг эрдэм мэдлэгийн салбар юм. Хүмүүс ийм төрлийн мэдлэгт суралцах үедээ Бурхан бүх зүйлд дээд эрх барьдгийг ойлгодоггүй; мөн Бурхан бүх зүйлийг хариуцаж, удирдаж байгааг хардаггүй. Харин тэд гагцхүү эрдэм мэдлэгийн тэр салбараа эцэс төгсгөлгүй судалж шинжлэн, эрдэм мэдлэгт үндэслэсэн хариулт хайдаг. Гэвч хүмүүс Бурханд итгэхгүй, харин зөвхөн судлахаар эрэлхийлбэл жинхэнэ хариултыг хэзээ ч олохгүй гэдэг үнэн биз дээ? Эрдэм мэдлэг чамайг өлмөн зэлмэн явуулалгүй амьжиргаа, ажил, орлого л өгч

чадна; гэвч эрдэм мэдлэг чамайг хэзээ ч Бурханыг шүтэн мөргөдөг болгохгүй, мөн ёрын муугаас хол байлгахгүй. Хүмүүс эрдэм мэдлэгийг судлах тусмаа Бурханы эсрэг тэрслэх, Бурханыг судалгаандаа хамруулах, Бурханыг сорьж, эсэргүүцэх хүсэл нь улам ихэснэ. Ингээд эрдэм мэдлэг хүмүүст юу зааж байгааг бид одоо харж байна уу? Энэ нь бүгд Сатаны гүн ухаан юм. Завхарсан хүмүүсийн дунд Сатаны түгээн дэлгэрүүлсэн амьд үлдэх тухай гүн ухаан, дүрэм журам үнэнтэй ямар нэг холбоотой юу? Үнэнтэй огт холбоогүй, чухамдаа үнэний эсрэг байдаг. “Амьдрал бол хөдөлгөөн”, “Хүн бол төмөр, будаа бол ган, хүн хоол идэхгүй бол жигтэйхэн өлсдөг” гэж хүмүүс байнга хэлдэг. Эдгээр мэргэн үг юу вэ? Эдгээр нь төөрөгдөл бөгөөд эдгээрийг сонсоход ой гутах мэдрэмж төрдөг. Хүний эрдэм мэдлэг гэгчид Сатан амьдралын гүн ухаанаа, мөн сэтгэлгээнийхээ нэлээд ихийг шингээсэн. Сатан үүнийг хийхдээ өөрийнхөө сэтгэлгээ, гүн ухаан, үзэл бодлыг хүлээн авах боломжийг хүнд олгож, тэгснээрээ хүнийг Бурханы оршин тогтнолыг үгүйсгэх, бүх зүйл ба хүний хувь заяаг Бурхан ноёрхдогийг үгүйсгэх болгодог. Иймээс хүний хичээл сурлага ахиж, улам их мэдлэгтэй болох тусам Бурханы оршин тогтнол түүнд бүрхэг болох мэт санагддаг бөгөөд Бурханы оршин тогтнолыг мэдрэхээ больж ч магад. Сатан тодорхой нэг бодол, санаа, үзлийг хүнд суулгасан учраас Сатан энэхүү хорыг дотор нь суулгамагц хүн Сатанд хууртаж, Сатанаар завхруулагддаг бус уу? Тэгвэл өнөөдрийн хүмүүс юугаар амьдардаг гэж та нар хэлэх вэ? Тэд Сатаны суулгасан мэдлэг, бодлоор амьдардаггүй гэж үү? Энэхүү мэдлэг, бодол дотор нуугдсан зүйлс нь Сатаны гүн ухаан, хор биш гэж үү? Хүн Сатаны гүн ухаан, хороор амьдардаг. Тэгэхээр Сатан хүнийг завхруулдгийн гол цөм нь юу вэ? Сатан хүнийг өөр шиг нь Бурханыг үгүйсгэж, эсэргүүцэж, Бурханы эсрэг зогсдог болгохыг хүсдэг; энэ бол Сатан хүнийг завхруулдгийн зорилго, мөн Сатан хүнийг завхруулдаг арга барил юм.

Эрдэм мэдлэгийн хамгийн өнгөцхөн талаас эхэлж ярья. Хэлний дүрэм, үгс хүнийг завхруулж чадах уу? Үг хүмүүсийг завхруулж чадах уу? Үг хүнийг завхруулдаггүй; үг бол хүний ярианд ашиглагддаг хэрэглүүр, мөн хүмүүс Бурхантай харилцдаг хэрэглүүр төдийгүй Бурхан эдүгээ хүмүүстэй үг, хэлээр харилцдаг билээ. Тэдгээр нь хэрэглүүр ба хэрэгцээ юм. Нэг дээр нэгийг нэмбэл хоёр, хоёр хоёрын дөрөв; энэ мэдлэг бус уу? Гэхдээ энэ чамайг завхруулж чадах уу? Энэ бол нийтлэг мэдлэг, тогтсон хэв маяг тул хүмүүсийг завхруулж чаддаггүй. Тэгвэл ямар төрлийн мэдлэг хүмүүсийг завхруулдаг вэ? Завхруулдаг мэдлэг нь Сатаны үзэл бодолтой холилдсон мэдлэг юм. Сатан эдгээр үзэл бодлыг эрдэм мэдлэгээр дамжуулан хүн төрөлхтөнд шингээх гэж оролддог. Жишээ нь, нэг нийтлэлд бичигдсэн үгст ямар ч асуудал байхгүй. Харин тухайн нийтлэлийг бичихдээ зохиогч ямар үзэл бодол, ба санаа зорилготой байсанд, түүнчлэн бодлынх нь агуулгад асуудал оршдог. Эдгээр нь сүнсний зүйл бөгөөд хүмүүсийг завхруулж чаддаг. Жишээ нь, чи телевизийн нэвтрүүлэг үзэж байлаа гэхэд ямаршуу зүйл нь хүмүүсийн үзэл бодлыг өөрчилж болох вэ? Уран бүтээлчдийн юу хэлсэн нь, үг

өөрөө хүмүүсийг завхруулж чадах уу? (Чадахгүй.) Ямар төрлийн зүйл хүмүүсийг завхруулах вэ? Найруулагчийн үзэл бодлыг төлөөлөх нэвтрүүлгийн гол санаа, агуулга хүмүүсийг завхруулна. Эдгээр үзэл бодолд агуулагдсан мэдээлэл хүмүүсийн зүрх сэтгэл, оюун санааг эргүүлж чадна. Тийм биз дээ? Сатан хүмүүсийг завхруулахын тулд эрдэм мэдлэгийг ашигладаг талаар хэлэлцэхдээ Миний юу гэж хэлээд байгааг одоо та нар мэдлээ. Үүнийг та нар буруу ойлгохгүй биз дээ? Тэгэхээр дараачийн удаа чи тууж юм уу, нийтлэл уншихдаа бичсэн үгэнд илэрхийлэгдсэн бодол хүн төрөлхтнийг завхруулж байна уу, хүн төрөлхтөнд хувь нэмэр оруулж байна уу, үгүй юү гэдгийг үнэлж чадах уу? (Тийм ээ, бага зэрэг чадна.) Энэ бол аажмаар судалж, туулах ёстой зүйл бөгөөд шууд амархан ойлгогдох зүйл биш юм. Жишээ нь, эрдэм мэдлэгийн нэг салбарыг судалж, сурч байхад тухайн эрдэм мэдлэгийн зарим эерэг тал нь тус салбарын талаарх зарим ерөнхий мэдлэгийг ойлгоход тус болохын зэрэгцээ хүмүүс юунаас зайлсхийх ёстойг мэдэх боломж олгож болох юм. Жишээ нь, “цахилгааныг аваад үз—энэ нь мэдлэгийн нэг талбар биз дээ? Хүмүүс цахилгаанд цохиулж, гэмтэж болно гэдгийг мэдээгүй бол чи мэдлэггүй байх бус уу? Харин мэдлэгийн энэ талбарыг ойлгосон хойно чи цахилгаан гүйдэлтэй юманд гар хүрэхдээ хайнга хандахгүй бөгөөд цахилгааныг хэрхэн хэрэглэхээ мэднэ. Энэ хоёр хоёулаа эерэг зүйлс юм. Эрдэм мэдлэг хүмүүсийг хэрхэн завхруулдаг тухайд юу хэлэлцэж байсныг та нар одоо тодорхой ойлгов уу? Дэлхий дээр олон төрлийн мэдлэгийг судалдаг бөгөөд та нар тэдгээрийг өөрсдөө яаралгүй ялгаж салгах ёстой.

б. Сатан хүнийг завхруулахад шинжлэх ухааныг хэрхэн ашигладаг тухай

Шинжлэх ухаан гэж юу вэ? Шинжлэх ухааныг хүн нэг бүр оюун санаандаа өндөр нэр төртэй гэж үзэн, гүн гүнзгий гэж тооцдог бус уу? Шинжлэх ухааныг дурдах үед хүмүүс “Энэ нь эгэл хүмүүсээс давсан зүйл; эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн л хөндөж чадах сэдэв; энэ нь жирийн ард бидэнд ямар ч хамаагүй” гэж боддог бус уу? Шинжлэх ухаан жирийн хүмүүст хамаатай юу? (Хамаатай.) Сатан хүмүүсийг завхруулахын тулд шинжлэх ухааныг хэрхэн ашигладаг вэ? Энд бид хэлэлцүүлэгтээ хүмүүсийн амьдралд байнга тулгардаг зүйлсийн тухай л ярьж, бусад асуудлыг анхааралгүй орхиё. “Ген” гэдэг нэг үг бий. Та нар энэ тухай сонссон уу? Энэ нэр томьёог та нар бүгд мэднэ. Генийг шинжлэх ухаанаар олж нээсэн бус уу? Ген гэдэг нь хүмүүст яг юу гэсэн утгатай вэ? Энэ нь биеийг нууцлаг зүйл гэж хүмүүст санагдуулдаг бус уу? Энэ сэдвийг танилцуулахад улам ихийг мэдмээр, илүү нарийн ширийнийг мэдье гэж хүсэх зарим хүн—ялангуяа сониуч хүмүүс—байх бус уу? Энэхүү сониуч хүмүүс энэ сэдэвт эрч хүчээ төвлөрүүлж, өөр хийх юмгүй байх үедээ энэ талаар илүү нарийн ширийнийг олж мэдэхээр ном болон интернэтээс мэдээлэл хайх болно. Шинжлэх ухаан гэж юу вэ? Шулуухан хэлэхэд, шинжлэх ухаан гэдэг нь хүмүүсийн сониучирхдаг, үл мэдэгдэх

ба Бурханы хэлж өгөөгүй зүйлсийн талаарх бодол, онол юм; шинжлэх ухаан нь хүмүүсийн шинжлэхийг хүсдэг нууцуудын талаарх бодол, онол билээ. Шинжлэх ухааны хамрах хүрээ ямар вэ? Шинжлэх ухаан үнэндээ өргөн хүрээтэй гэж хэлж болно; хүн сонирхдог бүхнээ судалж, шинжилдэг. Эдгээр зүйлийн нарийн ширийнийг, мөн хуулийг судлаад дараа нь үнэмшилтэй онол гаргаж, “Энэ эрдэмтэд үнэхээр сүрхий юм! Эдгээр зүйлийг ойлгохуйц маш их мэдлэгтэй юм!” гэж хүн болгонд бодогдуулах явдал шинжлэх ухаанд багтдаг. Хүмүүс эрдэмтдийг маш их биширдэг, тийм биз дээ? Шинжлэх ухаан судалдаг хүмүүс ямар үзэл бодолтой байдаг вэ? Орчлон ертөнцийг судалъя, сонирхдог салбарынхаа нууцлаг зүйлсийг судалъя гэж тэд хүсдэг бус уу? Үүнээс эцэст нь ямар үр дүн гардаг вэ? Зарим шинжлэх ухаанд хүмүүс таамгаар дүгнэлт гаргадаг бол бусад нь хүний туршлагад тулгуурлан дүгнэлт хийдэг. Мөн шинжлэх ухааны өөр салбаруудад хүмүүс түүхэн болон суурь нөхцөл байдлын ажиглалтад үндэслэн дүгнэлтэд хүрдэг. Тийм биз дээ? Тэгвэл шинжлэх ухаан хүмүүсийн төлөө юу хийдэг юм бэ? Шинжлэх ухаан гагцхүү биет ертөнц дэх юмсыг хүмүүст харуулж, хүний сониуч занг хангадаг боловч бүх зүйлийг Бурхан ноёрхдог хуулийг нь хүнд ойлгуулж чаддаггүй. Хүн шинжлэх ухаанаас хариулт олдог мэт боловч тэдгээр хариулт нь ээдрээтэй бөгөөд зөвхөн түр зуурын сэтгэл ханамж, хүний зүрх сэтгэлийг материаллаг ертөнцөд хорих үүрэг л гүйцэтгэдэг сэтгэл ханамж авчирдаг. Хүн шинжлэх ухаанаас хариулт авсан гэж боддог тул ямар ч асуудал гарахад тухайн асуудлыг нотолж, хүлээн зөвшөөрөх гэж шинжлэх ухааны үзэл бодлоо үндэслэл болгон ашигладаг. Хүний зүрх сэтгэл шинжлэх ухаанд уруу татагдаж, эзэмдүүлсээр Бурханыг мэдье, Бурханыг шүтэн мөргөе, бүх зүйл Бурханаас гардаг ба хүн Бурханаас хариулт хүсэх ёстой гэдэгт итгэе гэж бодохоо болиход хүрдэг. Тийм биш үү? Хүн шинжлэх ухаанд итгэх тусмаа улам утгагүй болж, бүх зүйлд шинжлэх ухааны шийдэл бий, судалгаа бүхнийг шийдвэрлэж чадна гэж итгэдэг. Тэд Бурханыг эрж хайдаггүй, Бурхан оршдог гэдэгт итгэдэггүй. Удаан хугацаанд Бурханд итгэсэн зарим итгэгч ямар нэг асуудалтай тулгарах үедээ компьютер ашиглан мэдээлэл хайж, хариулт хайдаг; тэд шинжлэх ухааны мэдлэгт л итгэдэг. Тэд Бурханы үг үнэн гэдэгт итгэдэггүй, Бурханы үг хүн төрөлхтний бүх асуудлыг шийдвэрлэж чадна гэдэгт итгэдэггүй, хүн төрөлхтний үй түмэн асуудлыг үнэний өнцгөөс хардаггүй. Тэд ямар ч асуудалтай тулгарсан бай, хэзээ ч Бурханд залбирдаггүй, Бурханы үгээс үнэнийг хайснаар шийдэл эрэлхийлдэггүй. Тэд олон хэрэг явдал дээр, эрдэм мэдлэг асуудлыг шийдвэрлэж чадна гэж итгэхийг илүүд үзнэ; тэдний хувьд шинжлэх ухаан бол эцсийн хариулт. Ийм хүмүүсийн зүрх сэтгэлд Бурхан огт байдаггүй. Тэд бол үл итгэгчид бөгөөд Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодол нь үргэлж шинжлэх ухааны арга ашиглан Бурханыг шинжилж судлахыг оролддог олон алдартай академич, эрдэмтнийхээс өөрцгүй. Жишээлбэл, бүхээг зогссон уул руу очиж, улмаар бүхээг оршин тогтнолыг нотолсон шашны мэргэжилтэн олон бий. Гэхдээ тэд бүхээгийг үзээд Бурханы оршин тогтнолыг хардаггүй. Тэд гагцхүү үлгэр домог,

түүхэд л итгэдэг; энэ нь тэдний шинжлэх ухааны судалгаа, материаллаг ертөнцийн шинжилгээний үр дүн юм. Хэрвээ чи микробиологи, одон орон судлал ч юм уу газар зүй зэрэг материаллаг зүйлсийг судалбал Бурхан оршин тогтнодог, бүх зүйлийг захирдаг гэдгийг тодорхойлох үр дүнг хэзээ ч олохгүй. Тэгвэл шинжлэх ухаан хүний төлөө юу хийдэг вэ? Хүнийг Бурханаас холдуулдаг бус уу? Бурханыг судлахад хүмүүсийг хүргэдэг бус уу? Хүмүүсийг Бурханы оршин тогтнол, дээд эрхэд улам их эргэлзэж, улмаар Бурханыг үгүйсгэж, Бурханаас урвахад хүргэдэг бус уу? Үр дагавар нь ийм байдаг. Тэгвэл Сатан шинжлэх ухааныг ашиглан хүнийг завхруулахдаа ямар зорилгод хүрэхээр оролдож байгаа вэ? Сатан шинжлэх ухааны дүгнэлтийг ашиглан хүмүүсийг хуурч, хөшүүн болгохыг, мөн хоёрдмол санаатай хариулт ашиглан хүмүүсийн зүрх сэтгэлийг гартаа оруулахыг хүсдэг, ингэснээр тэд Бурханы оршин тогтнолыг эрж хайхгүй, эсвэл Бурханы оршин тогтнолд итгэхгүй. Иймээс шинжлэх ухаан бол хүмүүсийг завхруулдаг Сатаны нэг арга гэж Би хэлдэг.

в. Сатан хүнийг завхруулахад уламжлалт соёлыг хэрхэн ашигладаг тухай

Уламжлалт соёлын хэсэг гэж тооцогддог олон зүйл байдаг уу? (Байдаг.) Энэ “уламжлалт соёл” гэдэг нь ямар утгатай вэ? Зарим нь үүнийг өвөг дээдсээс уламжилж ирсэн гэж хэлдэг—энэ бол нэг тал нь. Анхнаасаа амьдралын хэв маяг, зан заншил, үг хэллэг, дүрэм журам нь гэр бүл, угсаатны бүлэг, тэр ч байтугай бүхий л хүн төрөлхтний дунд өвлөгдөж ирсэн бөгөөд хүмүүсийн бодолд шингэсэн байдаг. Хүмүүс тэдгээрийг амьдралынх нь туйлын чухал хэсэг гэж үзэн, дүрэм журам гэж ханддаг бөгөөд тэдгээр нь өөрөө амь мэтээр дагаж мөрддөг. Үнэндээ, өвөг дээдсээс нь уламжилж ирсэн тул эдгээр зүйлийг өөрчилж, орхихыг хэзээ ч хүсдэггүй. Күнз, Мэнзээс өвлөгдөж ирсэн зүйлс, хүмүүст хятадын Дао, Күнзийн сургаалын зааж сургасан зүйлс гэх зэрэг хүмүүсийн яс маханд шингэсэн уламжлалт соёлын өөр талууд бий. Тийм биз дээ? Уламжлалт соёлд ямар зүйл багтдаг вэ? Хүмүүсийн тэмдэглэдэг баярууд багтдаг уу? Жишээ нь: Цагаан сар, Дэнлүүний баяр, Бунхан цэвэрлэх өдөр, Луут завины баяр, Сүнсний баяр, Намрын дунд сарын наадам. Зарим гэр бүлд өндөр настнууд тодорхой нас зооглосны ой, хүүхдүүд нэг сар хүрсэн, эсвэл зуу хоног болсон өдрийг хүртэл тэмдэглэдэг. Гэх мэтчилэн бий. Эдгээр нь бүгд уламжлалт баяр юм. Эдгээр баярын суурь нь уламжлалт соёл байдаг бус уу? Уламжлалт соёлын гол цөм нь юу вэ? Энэ нь Бурханыг шүтэн мөргөхтэй холбоотой юу? Үнэнийг хэрэгжүүл гэж хүмүүст хэлэхтэй холбоотой юу? Бурханд өргөл өргөж, Бурханы тахилын ширээ рүү очиж, Түүний сургаалыг сонсдог аливаа баяр наадам бий юу? Тийм баяр наадам байдаг уу? (Байхгүй.) Энэ бүх баяр наадмаар хүмүүс юу хийдэг вэ? Орчин үед эдгээрийг идэж ууж, наргиж цэнгэх үйл явдал гэж үздэг. Уламжлалт соёлын суурь эх үүсвэр юу байдаг вэ? Уламжлалт соёл хэнээс гаралтай вэ? Сатанаас гардаг. Эдгээр уламжлалт баяр наадмын дүр

зургийн цаана Сатан хүнд тодорхой зүйлсийг шингээдэг. Эдгээр зүйл нь юу вэ? Эдгээрийн нэг нь хүмүүсийг өвөг дээдсээ дурсдаг байлгах явдал мөн үү? Жишээ нь, Бунхан цэвэрлэх өдрөөр хүмүүс өвөг дээдсээ мартахгүйн тулд булшийг нь цэвэрлэж, өвөг дээдэстээ өргөл өргөдөг. Түүнчлэн Сатан хүмүүст эх оронч байхыг сануулдгийн нэг жишээ нь Луут завины баяр юм. Тэгвэл Намрын дунд сарын наадам яадаг вэ? (Гэр бүлээрээ цугладаг.) Гэр бүлийн цугларалтын цаад үндэс юу вэ? Үүний шалтгаан юу вэ? Ярилцаж, сэтгэлээрээ холбогдох явдал. Мэдээж, Цагаан сарын битүүнийг тэмдэглэнэ үү, Дэнлүүний баяр тэмдэглэнэ үү, эдгээр тэмдэглэлт үйл явдлын цаад шалтгааныг тайлбарлах олон арга бий. Гэвч яаж тайлбарлалаа гэсэн эдгээр шалтгаан нь дор бүрдээ өөрийн гүн ухаан, сэтгэлгээг хүмүүст шингээх Сатаны арга зам байдаг бөгөөд ингэснээр хүмүүс Бурханаас төөрч, Бурхан байгаа гэдгийг мэддэггүй болж, өвөг дээдэстээ юм уу, Сатанд өргөл барьж, эс бөгөөс махан биеийн хүслийн төлөө идэж ууж, наргиж цэнгэнэ. Энэ баяр наадам бүрийг тэмдэглэх зуур Сатаны үзэл, бодол хүмүүст мэдэгдэлгүйгээр оюун санааных нь гүнд суудаг. Хүмүүс дөч, тавь, эсвэл бүр өндөр насанд хүрэхэд Сатаны эдгээр үзэл, бодол зүрх сэтгэлд нь аль хэдийн гүн үндэслэсэн байдаг. Түүнчлэн хүмүүс зөв ч бай, буруу ч байсан эдгээр санааг хойч үедээ ялгаваргүй, бүрэн уламжлах гэж чадах чинээгээрээ хичээдэг. Тийм биз дээ? (Тийм ээ.) Уламжлалт соёл, эдгээр баяр наадам хүмүүсийг хэрхэн завхруулдаг вэ? Та нар мэдэх үү? (Хүмүүс эдгээр уламжлалын дүрэмд хязгаарлагдаж, хүлэгдээд Бурханыг эрж хайх цаг зав, эрч хүчгүй болдог.) Нэг тал нь ийм байдаг. Жишээ нь, Цагаан сарыг хүн бүр тэмдэглэдэг—тэмдэглэхгүй бол чи гуниглах бус уу? Зүрх сэтгэлдээ хадгалж явдаг ямарваа мухар сүсэг чамд бий юу? “Би шинэ оноо тэмдэглэсэнгүй, бас Цагаан сарын өдөр муу өдөр байсан болохоор энэ жил ч бас тэр чигтээ муу байх бус уу” гэж бодож болох уу? Санаа зовж, жаахан айж эмээхгүй гэж үү? Олон жил өвөг дээдэстээ өргөл өргөөгүй хүн талийгаач өөрөөс нь мөнгө нэхэж байгаа зүүд гэнэт зүүдлэх нь ч байдаг. Тэдэнд ямар санагдах вэ? “Одоо өөд болчихсон хүнд үрэх мөнгө хэрэгтэй байгаа нь яасан гунигтай юм бэ! Тэдэнд зориулаад цаасан мөнгө шатаая. Тэгэхгүй бол огт болохгүй. Амьд бидэнд асуудал үүсгэж магадгүй—гай барцад хэзээ ниргэхийг хэн мэдлээ?” Тэд үргэлж иймэрхүү багахан айдас өвөрлөж, сэтгэлдээ зовнино. Хэн тэдэнд ийм зовнил өгдөг вэ? Сатан бол энэхүү зовнилын эх сурвалж юм. Сатан хүнийг завхруулдаг аргуудын нэг нь энэ бус уу? Сатан чамайг мэл гайхуулж, буулган авч, захирахын тулд хянаж, заналхийлж, хүлэх янз бүрийн арга, шалтаг ашигладаг; Сатан ийнхүү хүнийг завхруулдаг. Хүмүүс ихэвчлэн сул дорой байхдаа, нөхцөл байдлыг бүрэн мэдэхгүй байх үедээ юмыг өөрийн эрхгүй төөрөгдсөн байдлаар хийж болно; өөрөөр хэлбэл, тэд Сатаны атгад санаандгүй орж, өөрийн эрхгүй үйлдэн, юу хийж байгаагаа мэдэхгүйгээр аливааг хийж магадгүй юм. Сатан ийм маягаар хүнийг завхруулдаг. Гүн үндэслэсэн уламжлалт соёлоос хагацахдаа дурамжхан, үүнийг ердөө л орхиж чаддаггүй хүмүүс одоо нэлээд цөөнгүй бий. Тэд ялангуяа сул дорой, идэвхгүй байх үедээ ийм

баяр наадам тэмдэглэхийг хүсдэг бөгөөд Сатантай уулзаж, сэтгэлийг нь дахин хангалуун болгож, өөрсдийн зүрх сэтгэлийг тайтгаруулахыг хүсэмжилдэг. Уламжлалт соёлын цаад нөхцөл байдал ямар байдаг вэ? Хөшигний ард Сатаны хар гар удирдаж байна уу? Сатаны ёрын муу уг чанар явуулга хийж, хянаж байна уу? Энэ бүгдийг Сатан эрхэндээ байлгадаг уу? (Тийм.) Хүмүүс уламжлалт соёлд амьдарч, иймэрхүү уламжлалт баяр наадам тэмдэглэдэг нь Сатанд хууртаж, завхрах орчин болдог төдийгүй тэд Сатанд дуртайяа хууртаж, Сатанаар завхруулагддаг гэж хэлж болох уу? (Болно.) Энэ бол та бүгдийн хүлээн зөвшөөрдөг, мэддэг зүйл юм.

г. Сатан хүнийг завхруулахын тулд мухар сүсгийг хэрхэн ашигладаг тухай

Та нар “мухар сүсэг” гэдэг нэр томьёог мэднэ, тийм үү? Мухар сүсэг, уламжлалт соёлын хооронд зарим холбоо байдаг боловч өнөөдөр бид тэдгээрийн талаар ярихгүй. Харин Би мэргэ төлгө, хувь заяа үзэх, хүж шатааж, Буддаг шүтэх зэрэг хамгийн түгээмэл тааралддаг мухар сүсгийн хэлбэрийн талаар ярья. Зарим хүн мэргэ төлгө хийдэг, өөр бусад нь Буддаг шүтэж, хүж шатаадаг бол бусад нь хувь заяагаа мэргэлүүлж, царайны хэлбэрээ шинжүүлж, хувь заяагаа ийм байдлаар хэлүүлдэг. Та нараас хэр олон чинь хувь заяагаа мэргэлүүлж, царайгаа шинжүүлсэн бэ? Үүнийг ихэнх хүн сонирхдог, тийм биз? (Тийм.) Яагаад? Мэргэ төлгө, хувь заяаны мэргээс хүмүүс ямар төрлийн ашиг тус хүртдэг вэ? Ямар төрлийн сэтгэл ханамж олж авдаг вэ? (Сониуч зангаа хангадаг.) Ганц сониуч зан гэж үү? Миний бодлоор, заавал тийм биш. Мэргэ төлгө болон хувь заяа мэргэлэхийн зорилго юу вэ? Яагаад хийдэг вэ? Ирээдүйг харахын төлөө хийдэг биш үү? Зарим нь ирээдүйгээ мэдэхийн тулд царайгаа шинжүүлж, бусад нь азтай байх эсэхээ мэдэхийн тулд мэргэлүүлдэг. Зарим хүн гэрлэлтээ ямар байхыг мэдэх гэж мэргэлүүлдэг бол өөр бусад нь ирж яваа жил ямар аз авчрахыг үзэх гэж мэргэлүүлдэг. Зарим хүн өөрийнхөө болон үр хүүхдийнхээ хэтийн ирээдүйг мэдэхийн тулд царайгаа шинжүүлдэг бол зарим бизнес эрхлэгч хэр их мөнгө олохоо үзэх гэж мэргэлүүлж, яах ёстой талаар төлгөчөөс удирдамж эрэлхийлдэг. Тэгэхээр сониуч зангаа хангах гэж л ингэдэг гэж үү? Хүмүүс ирээдүйн хувийн эрх ашгийнхаа төлөө царайгаа шинжүүлэх юм уу, иймэрхүү зүйл хийдэг; энэ бүхэн өөрсдийнх нь хувь заяатай нягт холбоотой гэдэгт тэд итгэдэг. Аль нэг нь хэрэгтэй юу? (Үгүй.) Яагаад хэрэггүй вэ? Эдгээрээр дамжуулж зарим нэг мэдлэг авах нь сайн юм биш үү? Эдгээр арга нь хэзээ асуудал үүсэж магадгүй тухай мэдэхэд тус болдог, хэрвээ эдгээр асуудлыг гарахаас нь өмнө мэддэг юм бол зайлсхийж болох бус уу? Хувь заяагаа үзүүлбэл ээдрээнээс зөв замаа хэрхэн олохыг харуулж болох ба улмаар чи ирэх жилдээ азтай байж, бизнесээрээ их эд баялаг хурааж болох юм. Тэгэхээр энэ хэрэгтэй юу, үгүй юу? Хэрэгтэй эсэх нь бидэнд хамаагүй бөгөөд өнөөдрийн бидний нөхөрлөл энэ сэдвийг хамрахгүй. Сатан хүнийг завхруулахдаа мухар сүсгийг хэрхэн ашигладаг вэ? Хүмүүс бүгд хувь заяагаа мэдэхийг хүсдэг тул

Сатан сониуч занг нь далимдуулан тэднийг уруу татдаг. Хүмүүс ирээдүйд өөрсдөд нь юу тохиолдохыг, мөн урд нь ямар зам хүлээж байгааг олж мэдэхийн тулд мэргэ төлгө, царай шинжих, хувь заяа үзэх гэх мэтэд оролцдог. Гэвч эцсийн эцэст хүмүүсийн тэгж их анхаардаг хувь заяа, хэтийн ирээдүй хэний гарт байдаг вэ? (Бурханы гарт.) Энэ бүх зүйл Бурханы гарт байдаг. Сатан эдгээр арга барилыг ашиглан хүмүүст юу мэдүүлэхийг хүсдэг вэ? Сатан царай шинжих, хувь заяаны мэргийг ашиглан тэр өөрөө хүмүүсийн ирээдүйн хувь заяаг мэддэг бөгөөд эдгээр зүйлсийг мэдэхээр үл барам хянадаг гэж хүмүүст хэлэхийг хүсдэг. Сатан энэ боломжийг далимдуулж, мөн ийм арга барил ашиглан хүмүүсийг хянаж, улмаар өөртөө сохроор итгүүлэн, үг бүрийг нь дуулгавартай дагадаг болгохыг хүсдэг. Жишээ нь, чи царайгаа шинжүүлсэн бол, төлгөч нүдээ аниад өнгөрсөн хэдэн арван жилд чамд тохиолдсон бүхнийг тов тодорхой хэлбэл сэтгэлд чинь ямар санагдах вэ? “Яг зөв хэлж байна! Би өнгөрсөн амьдралаа урьд нь хэнд ч, хэзээ ч хэлээгүй атал энэ тухай яаж мэдэв ээ? Энэ төлгөчийг би үнэхээр биширч байна!” гэж чи тэр дороо бодно. Чиний өнгөрсөн үеийн талаар мэдэх нь Сатаны хувьд дэндүү амархан бус уу? Бурхан чамайг өнөөдрийн байгаа байр руу хөтөлсөн бөгөөд тэр хооронд Сатан хүмүүсийг завхруулж, чамайг дагасаар ирсэн. Амьдралын чинь хэдэн арван жилийн хугацаа Сатаны хувьд юу ч биш бөгөөд эдгээр зүйлийг мэдэх Сатанд хэцүү биш. Сатаны хэлж буй бүхэн оновчтой байгааг олж мэдэх үедээ чи зүрх сэтгэлээ түүнд хүлээлгэн өгч буй бус уу? Өөрийн ирээдүй, хувь заяаг хяналтад нь оруулж, түүнийг түшиж тулж байгаа бус уу? Зүрх сэтгэл чинь хоромхон зуур түүнийг хүндэлж, эсвэл бишрэх ба энэ үед зарим хүний сүнсийг тэр аль хэдийн булаачихсан байж ч болно. Тэгээд чи төлгөчөөс даруйхан ингэж асууна: “Би одоо яах хэрэгтэй вэ? Ирэх жил юунаас зайлсхийх ёстой вэ? Ямар зүйл хийх ёсгүй вэ?” Тэгэхээр чинь төлгөч: “Чи тэнд очиж болохгүй, ингэх ёсгүй, ийм өнгийн хувцас битгий өмс, иймэрхүү газруудаар явахаа багасгаж, ийм зүйл илүү их хийх хэрэгтэй…” хэмээнэ. Түүний хэлсэн бүхнийг чи тэр даруй зүрх сэтгэлдээ тусгаж авах бус уу? Түүний үгийг чи Бурханы үгээс ч хурдан цээжилнэ. Яагаад тийм хурдан цээжлэх вэ? Яагаад гэвэл, чи азтай байх гээд Сатанд найдахыг хүснэ. Сатан энэ л үед зүрх сэтгэлийг чинь эзэмддэг бус уу? Зөгнөл нь ар араасаа биелэхээр чи түүн дээр шууд эргэж очоод дараа жилийн хувь төөрөг ямар байхыг мэдэхийг хүсэх бус уу? (Тийм ээ.) Тэгээд Сатаны хий гэсэн бүхнийг хийж, боль гэсэн бүхнээс зайлсхийнэ. Энэ маягаар чи Сатаны хэлсэн бүхнийг дуулгавартай дагаж байгаа бус уу? Түүний тэвэрт маш хурдан орж, хууртаж, хяналтад нь орно. Сатаны хэлдэг зүйлийг үнэн гэж итгэн, өнгөрсөн болоод өнөөгийн амьдралын чинь тухай, мөн ирээдүйд юу болох тухай мэддэг гэж чи итгэдэг учраас ийм зүйл болдог. Энэ бол хүмүүсийг хянах гэж Сатаны ашигладаг арга барил юм. Гэвч бодит байдал дээр хэн үнэхээр хяналтыг атгадаг вэ? Сатан бус, Бурхан Өөрөө хяналтыг атгадаг. Сатан энэ тохиолдолд мэдлэггүй хүмүүсийг хуурч, зөвхөн материаллаг ертөнцийг хардаг хүмүүсийг хуурах замаар өөртөө итгүүлж, өөрт нь найддаг болгох гэж л овжин явуулгаа ашиглаж байна. Дараа нь тэд Сатаны саварт

унаж, үг бүрийг нь дуулгавартай дагадаг. Гэвч хүмүүс Бурханд итгэж, Бурханыг дагахыг хүсэх үед Сатан ер нь тэднийг алддаг уу? Алддаггүй. Ийм нөхцөлд хүмүүс үнэхээр Сатаны саварт орж байгаа хэрэг үү? (Тийм.) Энэ асуудал дээрх Сатаны зан авирыг ичгүүргүй гэж хэлж болох уу? (Болно.) Яагаад тэгж хэлэх вэ? Яагаад гэвэл, эдгээр нь зальхай, ов мэхтэй арга байна. Сатан ичгүүргүй бөгөөд өөрөө хүмүүсийн бүх зүйлийг хянадаг, бүр хувь заяаг нь хянадаг гэж хүмүүст эндүү ташаа бодогдуулдаг. Ингэснээр мэдлэггүй хүмүүс Сатаныг бүрэн дуулгавартай дагахад хүрдэг. Тэд ердөө хэдхэн үгэнд хууртдаг. Тэгээд мэл гайхсандаа Сатаны өмнө мөргөдөг. Тэгэхээр, Сатан чамайг өөртөө итгүүлэхийн тулд ямар төрлийн арга ашиглаж, юу гэж хэлдэг вэ? Жишээ нь, чи Сатанд ам бүл хэдүүлээ байдгаа хэлээгүй боловч Сатан хэдүүлээ байдгийг мөн эцэг эх, үр хүүхдийн чинь насыг хэлж чадаж ч болох юм. Хэдийгээр чи үүнээс өмнө Сатаны талаар хардаж сэрдэж, эргэлзэж явсан байж болох ч ийм зүйл хэлэхийг нь сонсвол Сатан жаахан үнэмшилтэй санагдах бус уу? Дараа нь Сатан, ойрын үед ажил чинь хэр хэцүү байсан, дарга нар чинь чамайг зохих ёсоор үнэлдэггүй, цаг үргэлж чиний эсрэг ажилладаг гэх мэт зүйл хэлж магад. Үүнийг сонсчхоод чи “Яг үнэн! Ажил дээр хэцүү байгаа шүү” гэж бодно. Тэгээд Сатанд арай их итгэнэ. Дараа нь тэр чамайг хуурах өөр нэг зүйл хэлж, өөртөө улам ч их итгүүлнэ. Бага багаар чи Сатаныг эсэргүүцэж чадахаа больж, хардаж сэрдэхээ болино. Сатан ердөө л шалихгүй хэдэн арга заль, бүр ялихгүй өчүүхэн арга заль хэрэглэдэг ба ийм маягаар толгойг чинь эргүүлдэг. Толгой чинь эргэхээр чи байр байдлаа мэдэхээ байж, яах учраа олохоо больж, Сатаны хэлснийг дагаж эхэлнэ. Энэ бол хүнийг завхруулахад Сатаны ашигладаг “суут” арга бөгөөд үүнээс үүдэн чи өөрийн мэдэлгүй Сатаны урхинд орж, түүнд уруу татагддаг. Сатан чамд хүмүүсийн сайн гэж боддог цөөн зүйл хэлээд дараа нь юу хийх, юунаас зайлсхийх вэ гэдгийг хэлдэг. Ийнхүү чи өөрийн мэдэлгүй хууртдаг. Нэгэнд хууртчихвал чиний хувьд юмс тааламжгүй болно; Сатан юу гэж хэлсэн, юу хий гэсэн талаар цаг ямагт бодож, өөрөө ч мэдэлгүй түүнд эзэмдүүлнэ. Яагаад ингэдэг вэ? Яагаад гэвэл, хүн төрөлхтөн үнэнээр дулимаг тул бат зогсож, Сатаны уруу таталт, сорилтыг тэсвэрлэх чадваргүй юм. Сатаны ёрын муу, ов мэх, урвалт, хорон санаатай тулгарсан хүн төрөлхтөн маш мэдлэггүй, томоогүй, сул дорой байдаг, тийм бус уу? Сатан хүнийг завхруулдаг нэг арга зам нь энэ бус уу? (Мөн.) Сатаны янз бүрийн арга барилд хүн өөрийн эрхгүй бага багаар мэхлэгдэж, хууртдаг нь эерэг, сөрөг зүйлсийг ялгаж салгах чадвар дутдагаас нь болдог. Тэдэнд ийм биеийн хэмжээ, Сатаныг ялан дийлэх чадвар дутагддаг.

д. Сатан хүнийг завхруулахад нийгмийн чиг хандлагыг хэрхэн ашигладаг тухай

Нийгмийн чиг хандлага хэзээ бий болсон бэ? Өнөө үед л бий болсон гэж үү? Сатан хүмүүсийг завхруулж эхлэх үед нийгмийн чиг хандлага бий болсон гэхэд болно. Нийгмийн чиг хандлагад юу багтдаг вэ? (Хувцаслах хэв маяг, оо энгэсэг

багтдаг.) Эдгээр нь хүмүүсийн байнга харьцдаг зүйлс юм. Хувцаслах хэв маяг, загвар, хандлага—эдгээр зүйл нэг жаахан хэсгийг бүрдүүлдэг. Өөр зүйл бий юу? Хүмүүсийн байнга хэлдэг түгээмэл үг хэллэг бас ордог уу? Хүмүүсийн хүсдэг амьдралын хэв маяг ордог уу? Хүмүүсийн дуртай дуу, хөгжмийн одод, алдартнууд, сонин сэтгүүл, тууж, роман ордог уу? (Тийм ээ.) Та нарын бодлоор нийгмийн чиг хандлагын аль тал нь хүнийг завхруулж чаддаг вэ? Эдгээр хандлагын аль нь та нарын сэтгэлийг хамгийн их татдаг вэ? “Бид бүгд тодорхой насанд хүрсэн, тавь, жараад нас, эсвэл дал, наяад нас хүрсэн болохоор эдгээр хандлагыг дагаж чадахаа больсон, тэгээд ч үнэндээ бидний анхаарлыг татдаггүй” гэж зарим хүн хэлдэг. Энэ зөв үү? “Бид алдартнуудыг сонирхдоггүй, хориод насны залуучууд л тэгдэг шүү дээ; бид бас загварлаг хувцас өмсдөггүй, дүр төрхдөө анхаардаг хүмүүс л тэгдэг юм” гэж бусад нь хэлдэг. Тэгвэл эдгээрийн аль нь та нарыг завхруулж чаддаг вэ? (Түгээмэл мэргэн үгс.) Эдгээр мэргэн үг хэллэг хүнийг завхруулж чадах уу? Би жишээ хэлье, тэгээд хүмүүсийг завхруулдаг эсэх нь та нарт харагдана: “Амьдрал мөнгөн дээр тогтдог”; энэ чиг хандлага мөн үү? Та нарын дурдсан хэв маяг, хоол ундны хандлагатай харьцуулахад энэ бүр ч долоон дор биш үү? “Амьдрал мөнгөн дээр тогтдог” гэдэг нь Сатаны гүн ухаан юм. Энэ нь бүхий л хүн төрөлхтний дунд, хүний нийгэм бүрд зонхилдог; үүнийг чиг хандлага гэж хэлж болно. Яагаад гэвэл, анх энэ үгийг хүлээн зөвшөөрдөггүй байсан ч бодит амьдралтай нүүр тулаад аажмаар үүнийг үг дуугүй зөвшөөрч, үнэн хэрэгтээ эдгээр үг үнэн гэж боддог болсон хүн нэг бүрийн зүрх сэтгэлд энэ нь шингэчихсэн. Сатан хүнийг завхруулах явц энэ бус уу? Хүмүүс энэ мэргэн үгийг адилхан түвшинд ойлгодоггүй байж болох ч хүн бүр эргэн тойронд нь тохиолдсон зүйл, хувийн туршлагадаа үндэслэн энэ үгийг өөр, өөр хэмжээнд тайлбарлаж, хүлээн зөвшөөрдөг. Тийм биз дээ? Энэ мэргэн үгийн талаар хэр их туршлагатайгаас нь үл хамааран хүний зүрх сэтгэлд энэ үг ямар сөрөг нөлөө үзүүлж болох вэ? Та нарыг нэг бүрчлэн оролцуулаад энэ ертөнцийн хүмүүсийн хүн зан чанараар нэг зүйл илчлэгддэг. Энэ нь юу вэ? Энэ нь мөнгө шүтэх явдал юм. Үүнийг хүний зүрх сэтгэлээс арилгах хэцүү юу? Маш хэцүү! Сатан хүнийг үнэхээр гүнзгий завхруулсан бололтой! Сатан мөнгө ашиглан хүмүүсийг уруу татаж, мөнгийг шүтэж, материаллаг зүйлсийг дээдэлдэг болгон завхруулдаг. Тэгвэл хүмүүс мөнгийг шүтдэгийн илрэл юу вэ? Энэ ертөнцөд ямар ч мөнгөгүйгээр амьдарч чадахгүй, мөнгөгүй ганц хонох ч боломжгүй санагддаг уу? Хүмүүсийн байр суурь, хүлээдэг хүндэтгэл нь ч тэдний хэр их мөнгөтэйгөөс шалтгаалдаг. Ядуу тарчиг хүмүүс ичсэндээ нуруу бөхийж, харин баячууд өндөр дээд байр сууриндаа баясдаг. Тэд чанга дуугаар ярьцгаан биеэ тоосон байдалтай амьдарч, зоримог, бардам байдаг. Энэ мэргэн үг, ийм хандлага хүмүүст юу авчирдаг вэ? Олон хүн мөнгө хөөцөлдөхдөө юугаа ч золиосолдог нь үнэн биш гэж үү? Олон хүн илүү их мөнгө хөөцөлдөн өөрсдийн нэр төр, шударга чанарыг гээдэг бус уу? Олон хүн үүргээ биелүүлэх, Бурханыг дагах боломжоо мөнгөний төлөө алддаг бус уу? Хүмүүсийн

хувьд үнэнийг олж авч, аврагдах боломжоо алдах нь хамгийн том гарз хохирол бус уу? Хүмүүсийг ийм хэмжээнд хүртэл завхруулах гэж ийм арга барил, мэргэн үг ашигладаг Сатан хөнөөлтэй биш гэж үү? Энэ нь хорлонт заль мэх бус уу? Энэхүү түгээмэл мэргэн үгийг эсэргүүцдэг байснаа эцэст нь үнэн хэмээн хүлээн зөвшөөрөх үед чиний зүрх сэтгэл Сатаны саварт бүрэн орж, улмаар чи өөрийн эрхгүй тэр мэргэн үгийн дагуу амьдрах болдог. Энэ үг чамд хэр хэмжээгээр нөлөөлсөн бэ? Чи үнэн замыг мэддэг, үнэнийг мэддэг байж болох ч үүнийг эрэлхийлэхэд хүчин мөхөстдөг. Бурханы үг бол үнэн гэдгийг чи тодорхой мэддэг байж болох ч үнэнийг олж авахын тулд төлөөс төлж, зовохыг хүсдэггүй. Харин ч Бурханыг эцсээ хүртэл эсэргүүцэх гэж өөрийн ирээдүй, хувь заяаг золиослохыг илүүд үзнэ. Бурхан юу ч хэлж, юу ч хийлээ гэсэн хамаагүй, чамайг гэх Бурханы хайр хэчнээн гүн гүнзгий, хэр агуу болохыг ойлгодог эсэх чинь ч хамаагүй, чи өөрийнхөөрөө явна гэж зөрүүдлэн зүтгэж, энэ мэргэн үгийн төлөө төлөөс төлдөг. Өөрөөр хэлбэл, энэ мэргэн үг хэдийнээ бодлыг чинь мэхэлж, хянаж, зан авирыг чинь хэдийнээ захирсан бөгөөд чи эд баялаг эрэлхийлэхээ хойш тавихын оронд хувь заяагаа үүнд захируулахыг илүүд үздэг. Хүмүүс ингэж үйлдэж, Сатаны үгэнд захирагдаж, аргад нь орж байгаа нь Сатанд мэхлэгдэж, завхруулагдсан гэсэн үг бус уу? Сатаны гүн ухаан, сэтгэлгээ, Сатаны зан чанар зүрх сэтгэлд чинь үндэслэсэн бус уу? Чи эд баялгийн хойноос сохроор хөөцөлдөж, үнэний эрэл хайгуулаа орхих үед Сатан чамайг мэхлэх зорилгодоо хүрдэг бус уу? Яг тэгдэг. Тэгвэл Сатанд мэхлэгдэж, завхруулагдсанаа чи мэдэрч чадах уу? Чадахгүй. Сатан яг өмнө чинь зогсож байгааг харж, эсвэл далдуур үйлдэж байгааг мэдэрч чадахгүй бол Сатаны хорон муу байдлыг чи харж чадах уу? Сатан хүн төрөлхтнийг хэрхэн завхруулдгийг мэдэж чадах уу? Сатан хүнийг хаа сайгүй цаг ямагт завхруулдаг. Сатан хүнийг энэ завхралаас зайлах боломжгүй болгож, түүний эсрэг хүчин мөхөстүүлдэг. Чамайг учраа олохгүй, өөрт юу тохиолдоод байгааг мэдэхгүй байх нөхцөлд Сатан өөрийн бодол, үзэл санаа, өөрөөс нь гардаг ёрын муу зүйлсийг чамаар хүлээн зөвшөөрүүлдэг. Хүмүүс эдгээрийг огт эсэргүүцэлгүй хүлээн зөвшөөрдөг. Тэгээд эднийг эрдэнэ мэт нандигнан зууралдаж, өөрсдийг нь жолоодож, тоглоом тохуу хийх боломж олгодог. Хүмүүс ингэж Сатаны эрх мэдэл дор амьдарч, өөрийн мэдэлгүй Сатаныг дуулгавартай дагаж, Сатан хүнийг завхруулах нь улам гүнзгийрдэг.

Сатан хүнийг завхруулахад энэ хэдэн аргыг ашигладаг. Хүн эрдэм мэдлэгтэй, мөн шинжлэх ухааны зарим зарчмын талаар ойлголттой, хүн уламжлалт соёлын нөлөөнд амьдардаг бөгөөд хүн бүр уламжлалт соёлыг өвлөн авагч, уламжлан үлдээгч байдаг. Хүн Сатаны өгсөн уламжлалт соёлыг зайлшгүй үргэлжлүүлэх ёстой, бас хүн төрөлхтөнд Сатаны өгдөг нийгмийн чиг хандлагыг дагадаг. Хүн Сатанаас салж хагацашгүй бөгөөд цаг ямагт Сатаны хийдэг бүхнийг даган мөрдөж, ёрын муу байдал, ов мэх, хорон санаа, биеэ тоосон байдлыг нь хүлээн авдаг. Хүн Сатаны эдгээр зан чанарыг эзэмшдэг болмогцоо ийм завхарсан хүн төрөлхтний дунд амьдрахдаа жаргалтай байсан уу, гунигтай байсан уу? (Гунигтай байсан.)

Яагаад тэгж хэлж байна вэ? (Яагаад гэвэл, хүн эдгээр завхарсан зүйлийн хүлээс, хяналтад автаад, нүгэл дотор амьдарч, хүнд бэрх тэмцэлд живдэг.) Зарим хүн нүдний шил зүүж, тун ухаантай харагддаг; тэд уран цэцэн үг, эрүүл ухаантайгаар тун намбалаг ярьдаг байж магадгүй бөгөөд олон зүйлийг туулсан учраас маш их туршлагатай, хашир байж магадгүй. Тэд их, бага асуудлуудын талаар нарийвчлан ярьж чаддаг байж магад; мөн аливаа зүйлийн үнэн зөв байдал, учир шалтгааныг үнэлж чаддаг байж ч магадгүй. Зарим нь энэ хүмүүсийн ааш авир, дүр төрх, ёс жудаг, хүн чанар, биеэ авч явах байдал гэх мэтийг хараад ямар ч өө олохгүй байж магад. Ийм хүмүүс өнөөгийн нийгмийн чиг хандлагад гойд сайн дасан зохицож чаддаг. Ийм хүмүүс ахимаг насны байж болох ч цаг үеийн чиг хандлагаас хэзээ ч хоцордоггүй, сурч боловсроход хэзээ ч хөгшиддөггүй. Гаднаа, ийм хүнээс хэн ч өө олж чадахгүй боловч дотоод мөн чанартаа тэд Сатаны завхралд туйлын их, бүрмөсөн өртсөн байдаг. Ийм хүмүүс гаднаа ямар ч өөгүй, өнгөн дээрээ эелдэг, боловсон, эрдэм мэдлэгтэй, тодорхой ёс суртахуунтай, шударга чанартай, эрдэм мэдлэгийн хувьд залуучуудаас яавч дутахааргүй байвч уг чанар-мөн чанарынхаа хувьд ийм хүмүүс бол Сатаны жинхэнэ амилсан загвар; Сатантай өвчсөн мэт адилхан байдаг. Энэ нь Сатан хүнийг завхруулсны “үр жимс” юм. Миний хэлсэн зүйлд та нар эмзэглэж болох ч энэ бүгд үнэн. Хүний судалдаг эрдэм мэдлэг, хүний ойлгодог шинжлэх ухаан, нийгмийн хандлагад зохицохын тулд хүний сонгодог арга зам нь бүгд хүнийг завхруулах Сатаны арга хэрэглүүр байдаг. Энэ туйлын үнэн. Иймээс хүн Сатаны бүрэн завхруулсан зан чанартайгаар амьдардаг бөгөөд Бурханы ариун байдал юм уу мөн чанар гэж юу болох талаар огт мэдэх аргагүй юм. Учир нь Сатан хүнийг завхруулдаг арга замаас гадна талд өө олж чадахгүй; буруу юм байгаа эсэхийг хүний ааш авираас хэлж чадахгүй. Хүн болгон хэвийн байдлаар ажлаа хийж, хэвийн амьдардаг; хэвийн байдлаар ном, сонин уншиж, хэвийн байдлаар сурч, ярьдаг. Зарим хүн цөөн хэдэн ёс зүй сурсан, ярьж хөөрөхдөө сайн, уужуу сэтгэлтэй, нөхөрсөг, бусдад тусч, өгөөмөр байдаг бөгөөд хүмүүстэй шалихгүй маргаан дэгдээдэггүй, тэднийг шулж мөлждөггүй. Гэвч тэдний завхарсан сатанлаг зан чанар дотор нь гүн үндэслэсэн байдаг бөгөөд энэхүү мөн чанар нь тэдний гаднаа гаргадаг хүчин чармайлтад тулгуурлан өөрчлөгдөж чадахгүй юм. Энэ мөн чанарын улмаас хүн Бурханы ариун байдлыг мэдэж чаддаггүй бөгөөд Бурханы ариун байдлын мөн чанар хүнд ил болсон ч гэсэн үүнийг нухацтай хүлээж авдаггүй. Учир нь, Сатан аль хэдийн янз бүрийн аргаар хүний сэтгэл хөдлөл, санаа, үзэл, бодлыг бүрэн эзэмдээд авчихсан байдаг. Энэхүү эзэмдэлт, завхрал нь зуурдын, алдаг оног байдаггүй, харин хаа сайгүй цаг үргэлж оршдог. Тиймээс Бурханд гурав, дөрвөн жил, бүр тав, зургаан жил итгэсэн асар олон хүн Сатаны шингээсэн эдгээр ёрын муу бодол, үзэл санаа, гүн ухааныг эрдэнэс мэт үзэн, тэдгээрийг орхиж чаддаггүй. Сатаны уг чанараас гардаг ёрын муу, биеэ тоосон, хорлонт зүйлсийг хүн хүлээн авсан тул хүний хоорондын харилцаанд хямрал, маргаан, таарамжгүй байдал байнга гарах нь зайлшгүй бөгөөд энэ нь Сатаны биеэ

тоосон уг чанараас үүдэлтэй юм. Сатан хүн төрөлхтөнд эерэг зүйл өгсөн бол—жишээ нь, хүмүүсийн хүлээн авсан уламжлалт соёлын Күнз, Даогийн сургаал сайн юм байсан бол—эдгээрийг хүлээн авсны дараа нэг төрлийн хүмүүс хоорондоо эвтэй байж чадах учиртай. Гэтэл адилхан зүйлийг хүлээн авсан хүмүүсийн дунд яагаад ийм том зааг ялгаа байдаг юм бэ? Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, эдгээр зүйл Сатанаас гаралтай бөгөөд Сатан хүмүүсийн дунд хагарал үүсгэдэг. Сатанаас гаралтай юмс гаднаа хэчнээн нэр төртэй, агуу харагдавч хүнийг гагцхүү биеэ тооход хүргэж, хүний амьдралд гагцхүү биеэ тоосон байдлыг илэрхий болгодог бөгөөд Сатаны ёрын муу уг чанарын ов мэхнээс цаашгүй. Тийм биш гэж үү дээ? Өөрсдийгөө өнгөлөн далдалж чаддаг, арвин их мэдлэгтэй хүн, эсвэл сайн хүмүүжилтэй хүн ч завхарсан сатанлаг зан чанараа нуухад хэцүү. Өөрөөр хэлбэл, энэ хүн өөрийгөө хэчнээн олон янзаар өнгөлөн далдалсан ч бай, энэ хүнийг чи ариун хүн гэж бодсон, эсвэл төгс нэгэн гэж, эсвэл тэнгэрэлч гэж бодсон ч бай, хэчнээн ариун гэж санасан ч бай хамаагүй, хөшигний ард тэдний бодит амьдрал ямар байдаг вэ? Тэдний зан чанарын илчлэлээс чи ямар мөн чанарыг олж харах вэ? Сатаны ёрын муу уг чанарыг олж харах нь эргэлзээгүй. Ингэж хэлж болох уу? (Болно.) Жишээлбэл, сайн хүн гэж бодож явсан, магадгүй шүтээнээ болгодог байсан дотнын нэг хүн чамд байдаг гэж бодъё. Өнөөгийн биеийн хэмжээгээрээ чи тэдний тухай юу гэж бодож байна вэ? Нэгдүгээрт, ийм хүнийг чи хүн чанартай эсэх, үнэнч эсэх, хүмүүсийг чин сэтгэлээсээ хайрладаг эсэх, үг үйлдэл нь бусдад үр өгөөж өгч, тус болдог эсэхээр нь үнэлдэг. (Тэд тийм байдаггүй.) Энэ хүмүүсийн илчилдэг сайхан сэтгэл, хайр, сайн сайхан байдал гэгч нь юу байдаг вэ? Бүгд худал хуурмаг, бүгд өнгөлөн далдлалт байдаг. Энэхүү өнгөлөн далдлалтын цаана эцсийн эцэст эрхэмлэгдэн шүтэгдэх ёрын муу зорилго бий. Үүнийг та нар тодорхой ойлгож байна уу? (Тийм ээ.)

Хүмүүсийг завхруулахын тулд Сатаны ашигладаг арга хүн төрөлхтөнд юу авчирдаг вэ? Эерэг зүйл авчирдаг уу? Нэгдүгээрт, хүн сайн, мууг ялгаж чаддаг уу? Энэ дэлхий ертөнц дээрх алдартай, агуу хүн ч бай, эсвэл зарим нэг сэтгүүл, өөр бусад хэвлэл ч бай, ямар нэг зүйлийг сайн муу, зөв буруу гэж шүүхдээ тэдний ашигладаг стандарт үнэн зөв үү? Үйл явдал, хүмүүсийг тэд шударгаар үнэлдэг үү? Тэдгээр нь үнэний ортой юу? Энэ ертөнц, энэ хүн төрөлхтөн эерэг ба сөрөг зүйлийг үнэний стандартад үндэслэн үнэлдэг үү? (Үгүй.) Яагаад хүмүүс тэгэх чадваргүй байдаг юм бэ? Хүмүүс асар их сурч боловсорсон, шинжлэх ухааны өргөн их мэдлэгтэй юм чинь агуу их чадвар эзэмшсэн байдаг юм биш үү? Гэтэл тэд яагаад эерэг, сөрөг зүйлийг ялгах чадваргүй байдаг юм бэ? Яагаад тэр вэ? (Яагаад гэвэл, хүмүүст үнэн байхгүй; шинжлэх ухаан, эрдэм мэдлэг нь үнэн биш юм.) Хүн төрөлхтөнд Сатаны авчирдаг бүх зүйл ёрын муу, завхарсан бөгөөд үнэн, амь, замгүй байдаг. Сатан ёрын муу байдал, завхралыг хүн төрөлхтөнд авчирдаг байхад Сатанд хайр байдаг гэж чи хэлж чадах уу? Хүнд хайр байдаг гэж хэлж чадах уу? “Та эндүүрч байна; ядуус, орон гэргүй хүмүүст тусалдаг олон хүн дэлхий даяар

бий. Тэд сайн хүмүүс биш үү? Бас сайн ажил хийдэг буяны байгууллагууд ч бий; тэдний хийдэг ажил сайн үйлс биш юм уу?” гэж зарим хүн хэлж магад. Чи тэр талаар юу гэх вэ? Сатан хүнийг завхруулахын тулд олон өөр арга барил болон онол ашигладаг; хүний энэ завхрал бүрхэг ойлголт уу? Үгүй, энэ бүрхэг биш. Сатан бас зарим нэг бодитой зүйл хийж, энэ ертөнц, нийгэмд үзэл бодол, онолоо бас дэвшүүлдэг. Улс гүрэн болгонд, эрин зуун бүрд Сатан нэг онол дэвшүүлж, хүмүүсийн оюун санаанд үзэл бодол шингээдэг. Эдгээр бодол, онол нь аажмаар хүмүүсийн зүрх сэтгэлд үндэслэж, дараа нь хүмүүс тэдгээрийн дагуу амьдарч эхэлдэг. Нэгэнт тэдгээрийн дагуу амьдарч эхлэхээрээ хүмүүс өөрийн мэдэлгүй Сатан болдог бус уу? Тэгээд Сатантай нэгддэг бус уу? Хүмүүс Сатантай нэг болчихоор эцэстээ Бурханд хэрхэн ханддаг вэ? Энэ нь Бурханд хандах Сатаны хандлагатай адилхан бус уу? Үүнийг хэн ч хүлээн зөвшөөрч зүрхэлдэггүй, тийм биз? Яасан аймшигтай гээч! Сатаны уг чанар ёрын муу гэж Би яагаад хэлдэг вэ? Үүнийг Би үндэслэлгүйгээр хэлдэг юм биш; харин Сатаны уг чанар бол хийсэн зүйл, илчилсэн юман дээр нь үндэслэн тодорхойлогдож, шинжигдсэн. Сатан ёрын муу гэж Би дөнгөж сая хэллээ; та нар юу гэж бодох вэ? “Сатан харваас ёрын муу” гэж бодно. Тэгэхээр Би чамаас асууна: “Сатаны ямар тал нь ёрын муу байдаг юм бэ?” Хэрвээ чи “Сатан Бурханыг эсэргүүцдэг нь ёрын муу” гэж хэлбэл мөн л тодорхой ярихгүй байгаа хэрэг. Одоо Би нарийн ширийн зүйлийн талаар ингээд ярьсан болохоор Сатаны ёрын муу мөн чанарын онцгой агуулгын талаар та нар ойлгов уу? (Тэглээ.) Хэрвээ та нар Сатаны ёрын муу уг чанарыг тодорхой харж чадвал өөрсдийнхөө нөхцөл байдлыг харна. Энэ хоёр зүйлийн хоорондямар нэгэн харилцаа байна уу? Энэ нь та нарт нэмэртэй юу, үгүй юү? (Нэмэртэй.) Бурханы ариун байдлын мөн чанарын талаар нөхөрлөх үедээ Би Сатаны ёрын муу мөн чанарын талаар нөхөрлөх шаардлагатай юу? Та нар энэ тухай юу гэж бодож байна? (Тийм ээ, шаардлагатай.) Яагаад? (Сатаны ёрын муу нь Бурханы ариун байдлыг тод томруун болгодог.) Тэгдэг гэж үү? Энэ нь нэг талаар зөв, Сатаны ёрын муугүйгээр Бурхан ариун гэдгийг хүмүүс мэдэхгүй; ингэж хэлэх нь зөв. Гэвч Бурханы ариун байдал гагцхүү Сатаны ёрын мууд харш учраас оршин тогтнодог гэж хэлбэл зөв үү? Ийнхүү харилцан эсрэгцүүлж бодох нь буруу. Бурханы ариун байдал нь Бурханы төрөлх мөн чанар юм; Бурхан үүнийг Өөрийн үйл хэргээр илчилдэг хэдий ч энэ нь Бурханы мөн чанарын уг илэрхийлэл, Бурханы төрөлх мөн чанар хэвээр байдаг; хүн үүнийг харж чаддаггүй ч гэлээ энэ нь цаг ямагт оршиж ирсэн бөгөөд Бурханд Өөрт нь угаасаа, төрөлхөөсөө байдаг. Учир нь хүн Сатаны завхарсан зан чанар, Сатаны нөлөөн дунд амьдардаг бөгөөд ариун байдлын тухай мэддэггүй, Бурханы ариун байдлын онцгой агуулгыг бүр ч мэддэггүй. Иймээс, бид эхлээд Сатаны ёрын муу мөн чанарын тухай нөхөрлөх шаардлагатай юу? (Тийм ээ, шаардлагатай.) “Та Бурханы Өөрийнх нь талаар нөхөрлөж байж яагаад Сатан хүмүүсийг хэрхэн завхруулдаг, Сатаны уг чанар ямар ёрын муу байдаг талаар үргэлж яриад байгаа юм бэ?” гэж зарим хүн эргэлзээгээ илэрхийлж болох юм. Одоо

та нар энэ эргэлзээгээ орхисон биз дээ? Хүмүүс Сатаны ёрын мууг ялган таньж, яг таг тодорхойлж, ёрын муугийн онцгой агуулга, илрэл болон ёрын муугийн эх сурвалж, мөн чанарыг тодорхой ойлгож чадахаараа л Бурханы ариун байдлыг хэлэлцэх замаар Бурханы ариун байдал гэж юу болох, ариун байдал гэж юу болохыг тодорхой ухаарч, таньж чаддаг. Би Сатаны ёрын муугийн талаар ярихгүй бол нийгэмд болон хүмүүсийн дунд хүмүүсийн хийдэг зарим зүйл—эсвэл энэ ертөнцөд оршдог зарим зүйл—ариун байдалтай ямар нэг холбоотой гэж зарим хүн эндүүрч итгэнэ. Ингэж бодох нь буруу бус уу? (Тийм ээ, буруу.)

Сатаны мөн чанарын талаар Би ийнхүү нөхөрлөлөө, тэгвэл өнгөрсөн хэдэн жилд та нар өөрсдийн туршлага, Бурханы үгийг уншсанаасаа, Түүний ажлыг туулсан туршлагаасаа Бурханы ариун байдлын талаар ямаршуу ойлголт авсан бэ? За, энэ талаар яриач. Чи чихэнд чимэгтэй үг хэрэглэх албагүй, зүгээр л өөрийн туршлагаас ярихад болно. Бурханы ариун байдал гагцхүү Бурханы хайраас бүрддэг үү? Ариун байдал гэж бидний хэлдэг нь ердөө Бурханы хайр уу? Тэгвэл хэтэрхий өрөөсгөл болно, тийм биз? Бурханы хайраас гадна Бурханы мөн чанарын бусад тал байдаг уу? Та нар тэдгээрийг харсан уу? (Тийм ээ. Баяр наадам, зан заншил, мухар сүсгийг Бурхан жигшдэг; энэ ч мөн Бурханы ариун байдал юм.) Бурхан ариун тул юмсыг жигшдэг гэж хэлэх гээд байна уу? Тийм бол Бурханы ариун байдал гэж яг юу юм бэ? Бурханы ариун байдалд дорвитой агуулга үгүй, зөвхөн үзэн ядалт байдаг хэрэг үү? Та нар санаандаа “Бурхан эдгээр ёрын муу зүйлийг үзэн яддаг учраас Бурханыг ариун гэж хэлж болно” гэж бодож байна уу? Энэ чинь таамаг биш үү? Энэ нь гаргалгаа, дүгнэлтийн нэг хэлбэр биш үү? Бурханы мөн чанарыг бид ойлгохдоо заавал зайлсхийх ёстой хамгийн том алдаа эндэл юу вэ? (Бодит байдлыг ардаа орхиж, оронд нь хоосон сургаал ярьдаг.) Энэ бол маш том алдаа эндэл. Өөр зүйл бий юу? (Таамаглал, төсөөлөл.) Эдгээр нь ч мөн маш ноцтой алдаа эндэл. Таамаг, төсөөлөл яагаад хэрэггүй вэ? Чи таамаглаж, төсөөлдөг зүйлээ үнэхээр харж чаддаг уу? Тэдгээр нь Бурханы жинхэнэ мөн чанар мөн үү? (Биш.) Өөр юунаас зайлсхийх ёстой вэ? Бурханы мөн чанарыг тодорхойлохдоо зүгээр л сайхан үг цээжээр урсгах нь алдаа эндэл мөн үү? (Мөн.) Ингэх нь сүржин, утга учиргүй байх бус уу? Дүгнэлт, таамаглал нь сайхан үг сонгож хэлэхтэй адилхан утгагүй байдаг. Хоосон магтаал ч мөн утгагүй, тийм биз? Хүмүүс иймэрхүү хий дэмий юм ярихыг сонсоод Бурхан баярладаг уу? (Үгүй, баярладаггүй.) Үүнийг сонсоод Бурхан эвгүйцдэг! Бурхан бүлэг хүмүүсийг замчилж, аврах үед энэхүү бүлэг хүмүүс нь Түүний үгийг сонссоныхоо дараа юу гэсэн утгатайг нь огт ойлгодоггүй. “Бурхан сайн уу?” гэж хүн асууж болно, тэд “Тийм ээ!” гэж хариулна. “Хэр сайн юм бэ?” “Маш сайн!” “Бурхан хүнд хайртай юу?” “Хайртай!” “Хэр их хайртай вэ? Чи дүрслээд хэлж чадах уу?” “Маш их! Бурханы хайр тэнгэрээс ч өндөр, далайгаас ч гүн!” Эдгээр үг дэмийрэл бус уу? Ийм дэмийрэл нь “Бурхан Сатаны завхарсан зан чанарыг үзэн яддаг учраас Бурхан бол ариун” гэж та нарын сая хэлсэнтэй адилхан бус уу? (Тийм ээ.) Та нарын сая хэлсэн үг дэмийрэл биш

үү? Тэгвэл яригддаг дэмий юмны дийлэнх нь хаанаас гардаг вэ? Яригддаг дэмий зүйл нь гол төлөв хүмүүс Бурханд хариуцлагагүй хандаж, Түүнийг хүндэлдэггүйгээс үүддэг. Ингэж хэлж болох уу? Чи ямар ч ойлголтгүй байсан атлаа хий дэмий юм ярьсан. Энэ чинь хариуцлагагүй хэрэг бус уу? Энэ чинь Бурханд хүндэтгэлгүй хандсан хэрэг бус уу? Чи зарим нэг мэдлэг олж, жаахан тайлбар, логик ойлгож авчхаад үүнийгээ ашигласан төдийгүй Бурханыг ойлгох арга зам болгон ийм зүйл хийлээ. Чиний ингэж хэлэхийг сонсоод Бурхан дургүйцнэ гэж чи боддог уу? Та нар яаж эдгээр арга барилыг ашиглан Бурханыг мэдэхээр оролдож чадна вэ? Та нар ингэж ярихад эвгүй сонсогдохгүй байна уу? Иймээс Бурханы талаарх мэдлэгтээ хүн маш болгоомжтой байх ёстой; Бурханыг мэддэг хэр хэмжээндээ л ярь. Энгийн, бодитой ярь, үгээ бялдууч магтаалаар бүү гоёж чим, зусар үг бүү хэрэглэ; Бурханд энэ хэрэггүй; иймэрхүү зүйл Сатанаас гардаг юм. Сатан биеэ тоосон зан чанартай; Сатан хоосон магтаал, сайхан үг сонсох дуртай. Хүмүүс сурсан бүх сайхан үгээ цээжээр уншиж, тэднийгээ Сатанд хэлбэл Сатан баярлаж, сэтгэл хангалуун байх болно. Гэвч Бурханд энэ хэрэггүй; зусардаж, бялдуучлах нь Бурханд хэрэггүй бөгөөд Бурхан хүмүүсээс дэмий юм ярьж, Өөрийг нь сохроор магт гэж шаарддаггүй. Бодит байдлаас зөрүүтэй магтаал, зусар үгийг Бурхан жигшиж, бүр огт сонсохгүй. Иймээс зарим хүн Бурханыг худал магтан, сохроор тангараг өгч, залбирахад Бурхан огт сонсдоггүй. Чи хэлж байгаа зүйлээ хариуцах ёстой. Хэрвээ чи ямар нэг зүйлийг мэдэхгүй бол зүгээр л тэгж хэл; мэдэж байгаа бол үүнийгээ бодитой байдлаар илэрхийл. Тэгвэл, Бурханы ариун байдал яг үнэндээ юунд хүргэдэг вэ, энэ талаарх жинхэнэ ойлголт та нарт бий юу? (Би тэрслүү байдлаа илэрхийлж, гэм бурууг үйлдээд Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авсан бөгөөд тэндээс Бурханы ариун байдлыг харсан. Бас миний санаж байсантай нийцээгүй орчинтой тулгарах үедээ эдгээр зүйлийн талаар залбирч, Бурханы санаа зорилгыг эрж хайсан бөгөөд намайг үгээрээ гэгээрүүлж, залж чиглүүлэх үед нь Бурханы ариун байдлыг би харсан.) Энэ чиний өөрийн туршлага байна. (Сатан завхруулж, хорлосны дараа хүн ямар болдог вэ гэдгийг би Бурханы хэлсэн үгээс харсан. Гэсэн хэдий ч Бурхан биднийг аврахын тулд бүхнээ өгсөн бөгөөд эндээс би Бурханы ариун байдлыг хардаг.) Бодитой байдлаар ярих гэдэг бол энэ юм; энэ бол жинхэнэ мэдлэг юм. Үүнийг өөрөөр ойлгох арга зам байна уу? (Еваг уруу татан нүгэл үйлдүүлэх гэж хэлсэн үгээс нь, мөн Эзэн Есүсийг сорьсноос нь би Сатаны ёрын мууг хардаг. Адам, Ева хоёрт юу идэж болох, юу идэж болохгүй гэдгийг хэлсэн Бурханы үгээс би Бурхан илэн далангүй, тодорхой, итгэл үнэмшилтэй ярьдаг гэдгийг хардаг; эндээс би Бурханы ариун байдлыг хардаг.) Дээрх яриаг сонсоод аль нь та нарыг “амен” гэж хэлэхэд хамгийн их урамшуулж байна вэ? Хэнийх нь нөхөрлөл өнөөдрийн нөхөрлөсөн сэдэвт хамгийн ойр байв? Сүүлийн эгчийн нөхөрлөл ямар байсан бэ? (Сайн байсан.) Тэр эгчийн хэлсэн үгэнд та нар “амен” гэж хэлж байна. Эгчийн ямар үг яг голыг нь олж хэлсэн бэ? (Бурханы үг илэн далангүй, маш тодорхой байдаг бөгөөд Сатаны тойруу яриатай огт адилгүй гэдгийг би энэ эгчийн сая хэлсэн үгээс

сонслоо. Үүнээс би Бурханы ариун байдлыг харсан.) Энэ бол нэг хэсэг нь. Энэ зөв үү? (Зөв.) Маш сайн байна. Та нар өнгөрсөн хоёр нөхөрлөлөөс юм олж авсан нь харагдаж байна, гэхдээ та нар шаргуу ажиллахаа үргэлжлүүлэх ёстой. Учир нь, Бурханы мөн чанарыг ойлгоно гэдэг маш гүн гүнзгий хичээл юм; үүнийг хүн нэг хоногийн дотор ойлгож авдаг юм биш, мөн цөөн хэдхэн үгээр тодорхой илэрхийлж чаддаг ч юм биш.

Хүмүүсийн завхарсан сатанлаг зан чанар, эрдэм мэдлэг, гүн ухаан, хүмүүсийн бодол, үзэл санааны бүх тал, хувь хүний зарим нэг хувийн тал Бурханы мөн чанарыг мэдэхэд нь асар их саад болдог; иймээс эдгээр сэдвийг сонсоход зарим нь чиний хэрээс хэтэрсэн байж магад; заримыг нь чи ойлгохгүй байхад заримыг нь үндсэндээ бодит байдалтай холбож чадахгүй байж болох юм. Ямар ч атугай, Бурханы ариун байдлын талаарх та нарын ойлголтыг Би сонслоо, бас Бурханы ариун байдлын талаарх Миний хэлсэн үг, хийсэн нөхөрлөлийг та нар зүрх сэтгэлдээ хүлээн зөвшөөрч эхэлж байгааг Би мэдэж байна. Та нарын зүрх сэтгэлд Бурханы ариун байдлын мөн чанарыг мэдэх хүсэл нахиалж эхэлж байгааг Би мэднэ. Гэвч та нарын зарим нь Бурханы ариун байдлын талаарх мэдлэгээ аль хэдийн хамгийн энгийн үг ашиглан тайлбарлаж чаддаг болсон нь Намайг бүр ч илүү баярлуулж байна. Энэ нь хэдийгээр хэлэхэд энгийн зүйл бөгөөд Би өмнө нь үүнийг хэлсэн ч гэлээ та нарын олонх чинь зүрх сэтгэлдээ эдгээр үгийг хүлээн зөвшөөрөх хараахан болоогүй ба үнэндээ оюун санаанд чинь ямар ч сэтгэгдэл үлдээгүй байна. Гэхдээ та нарын зарим нь эдгээр үгийг цээжилчхэж. Энэ бол маш сайн, тун ирээдүйтэй эхлэл. Та нар гүнзгий гэж боддог сэдвээр—эсвэл ойлголтоос чинь давсан сэдвүүдээр улам их эргэцүүлж, улам л их нөхөрлөнө гэж Би найдаж байна. Чиний ойлгодоггүй асуудлуудаар илүү удирдамж өгч чадах хүн гарч ирнэ. Хэрвээ одоо мэддэг салбаруудынхаа тухай илүү их нөхөрлөл хийвэл Ариун Сүнс ажлаа хийж, та нарын ойлголт сайжирна. Бурханы мөн чанарыг ойлгох, Бурханы мөн чанарыг мэдэх нь хүмүүсийн амийн оролтод туйлын чухал байдаг. Та нар үүнийг үл тоомсорлож, тоглоом наргиан гэж бодохгүй гэж Би найдъя, яагаад гэвэл, Бурханыг мэдэх нь хүний итгэлийн суурь бөгөөд үнэнийг эрэлхийлж, аврал олох түлхүүр юм. Хэрвээ хүн Бурханд итгэдэг атлаа Түүнийг мэддэггүй, гагцхүү үг, хоосон сургаал дотор амьдардаг бол үнэний өнгөц утгын дагуу амьдарч, үйлдэвч аврал хэзээ ч хүрч чадахгүй. Өөрөөр хэлбэл, Бурханд итгэдэг атлаа Түүнийг мэддэггүй бол итгэл чинь бүгд талаар өнгөрдөг бөгөөд бодит байдлыг огт агуулдаггүй. Та нар ойлгосон биз дээ? (Тийм ээ, ойлголоо.) Өнөөдрийн нөхөрлөлөө ингээд дуусгая.

2014 оны 1 дүгээр сарын 4

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ VI
БУРХАНЫ АРИУН БАЙДАЛ (III)

Өнгөрсөн удаа бидний нөхөрлөсөн сэдэв Бурханы ариун байдал байсан. Бурханы ариун байдал нь Бурханы Өөрийн аль талтай хамаатай вэ? Энэ нь Бурханы мөн чанартай хамаатай юу? (Тийм.) Тэгвэл нөхөрлөлөөрөө бидний ярьсан Бурханы мөн чанарын гол тал юу вэ? Бурханы ариун байдал уу? Бурханы ариун байдал бол Бурханы цор ганц мөн чанар юм. Өнгөрсөн удаа бидний нөхөрлөлийн гол агуулга юу байсан бэ? (Сатаны ёрын мууг ялгаж таних. Өөрөөр хэлбэл, Сатан мэдлэг, шинжлэх ухаан, уламжлалт соёл, мухар сүсэг, нийгмийн чиг хандлага ашиглан хүн төрөлхтнийг хэрхэн завхруулдаг тухай.) Энэ нь өнгөрсөн удаа бидний хэлэлцсэн гол сэдэв байсан. Сатан хүнийг завхруулахдаа мэдлэг, шинжлэх ухаан, мухар сүсэг, уламжлалт соёл болон нийгмийн чиг хандлагыг ашигладаг; энэ тав нь хүнийг завхруулдаг Сатаны арга зам юм. Сатан хүнийг завхруулахдаа эдгээрээс алийг нь хамгийн их хэрэглэдэг гэж та нар бодож байна вэ? Хүнийг хамгийн гүн завхруулахад алийг нь ашигладаг вэ? (Уламжлалт соёл. Яагаад гэвэл, Күнз, Мэнзийн сургаал гэх мэт сатанлаг гүн ухаан бидний оюун санаанд гүн шингэсэн.) Тэгвэл, хариулт нь “уламжлалт соёл” гэж зарим ах эгч бодож байна. Өөр хариулттай хүн байна уу? (Мэдлэг. Мэдлэг нь хэзээ ч биднийг Бурханд шүтэн мөргүүлэхгүй. Энэ нь Бурханы оршин тогтнолыг үгүйсгэж, Бурханы захиралтыг үгүйсгэдэг. Өөрөөр хэлбэл, бага залуугаасаа суралцаж эхэл, зөвхөн суралцаж, мэдлэгтэй болсноор л гэрэл гэгээтэй ирээдүйтэй, аз жаргалтай хувь заяатай байна гэж Сатан бидэнд хэлдэг.) Сатан ирээдүй, хувь заяаг чинь хянахын тулд мэдлэгийг ашигладаг, дараа нь чамайг эрхэндээ оруулдаг; Сатан хүнийг ингэж хамгийн гүн завхруулдаг гэж чи боддог. Тэгвэл та нарын ихэнх нь Сатан мэдлэгийг ашиглан хүнийг хамгийн гүн завхруулдаг гэж бодож байна. Өөр саналтай хүн байна уу? Жишээ нь, шинжлэх ухаан, эсвэл нийгмийн чиг хандлагын тухайд ямар вэ? Эдгээрийг хариулт нь гэж үзэж байгаа хүн байна уу? (Байна.) Өнөөдөр Би хүнийг завхруулдаг Сатаны таван арга замын тухай дахин нөхөрлөнө, тэгээд дуусмагцаа Сатан хүнийг хамгийн гүнзгий завхруулахдаа эдгээр зүйлийн яг алийг нь ашигладгийг харахын тулд та нараас дахиад хэдэн асуулт асууна.

Сатан хүнийг завхруулдаг таван арга зам

а. Сатан хүнийг завхруулахдаа эрдэм мэдлэгийг ашиглаж, хүнийг хянахдаа алдар нэр, ашиг хонжоог ашигладаг

Хүнийг завхруулдаг Сатаны таван арга замаас бидний дурдсан эхнийх нь мэдлэг, иймээс нөхөрлөлийнхөө эхний сэдэв болгон мэдлэгийг авч үзэцгээе. Сатан мэдлэгийг өгөөш болгон ашигладаг. Анхааралтай сонс: Мэдлэг бол зүгээр л нэг төрлийн өгөөш юм. Хүмүүс мэрийн сурч, өдөр өдрөөр өөрсдийгөө сайжруулж, мэдлэгийг зэр зэвсэг болгон өөрсдийгөө зэвсэглэж, дараа нь шинжлэх ухааны

үүдийг нээхийн тулд мэдлэгээ ашиглахад сэтгэл татагддаг; өөрөөр хэлбэл, чи мэдлэгтэй болох тусмаа, улам ихийг ойлгоно. Сатан энэ бүхнийг хүмүүст хэлдэг; мэдлэгт суралцангаа өндөр дээд туйлын зорилготой бай гэж хүмүүст хэлж, амбицтай, хүсэл эрмэлзэлтэй бол гэж зааварчилдаг. Сатан хүмүүст мэдэгдэлгүйгээр иймэрхүү олон санааг дамжуулдаг ба эдгээр зүйл нь зөв, эсвэл ач тустай гэж хүмүүст санагдуулдаг. Хүмүүс өөрийн мэдэлгүй энэ замд хөл тавьж, өөрийн мэдэлгүй туйлын зорилго, амбицдаа хөтлөгддөг. Хүмүүс алхам алхмаар, өөрийн мэдэлгүйгээр агуу, алдартай хүмүүсийн үзэл санааг Сатаны өгсөн мэдлэгээс суралцдаг. Тэд бас баатрууд гэж тооцогддог хүмүүсийн үйл хэргээс зарим зүйлд суралцдаг. Сатан энэ баатруудын үйл хэргээр хүнд юу ухуулж байна вэ? Сатан хүнд юу суулгахыг хүсдэг вэ? Хүн эх оронч байж, үндсэрхэг үзэлтэй байж, баатарлаг зоригтой байх ёстой. Хүн түүхэн үйл явдлуудаас, эсвэл баатарлаг хүмүүсийн намтраас юу суралцдаг вэ? Шударга журамтай байх, анд найз, ахан дүүсийнхээ төлөө юу ч хийхэд бэлэн байх. Сатаны энэхүү мэдлэг дотроос хүн огтхон ч эерэг бус олон зүйлийг өөрийн эрхгүй суралцдаг. Нэг л мэдэхэд, Сатаны бэлтгэсэн үр хүмүүсийн төлөвшөөгүй оюун ухаанд суудаг. Эдгээр үр нь, тэдэнд агуу хүн байх учиртай, алдартай байх учиртай, баатар, эх оронч, гэр бүлээ хайрладаг хүн, найзынхаа төлөө юуг ч хийдэг хүн, шударга журамтай хүн байх учиртай гэж санагдуулдаг. Сатанд уруу татагдаад тэд өөрсдөд нь зориулан Сатаны бэлдсэн замаар өөрийн мэдэлгүй алхдаг. Энэ замаар алхангаа тэд Сатаны амьдралын дүрэм журмыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болдог. Огтхон ч мэдэлгүйгээр тэд амьдардаг дүрэм журмаа бий болгодог боловч эдгээр нь тэдэнд албан хүчээр суулгасан Сатаны дүрэм журмаас цаашгүй юм. Суралцах үйл явцын үеэр, өөрсдийн гэсэн зорилго тавьж, амьдралын зорилго, амьдрах дүрэм журам, амьдралын чиглэлээ тодорхойлоход Сатан тэднийг хүргэдэг, тэгэх зуураа Сатаны зүйлсийг тэдэнд суулгаж, түүх, намтар болон боломжтой бүх аргыг ашиглан өгөөш үмхэх хүртэл нь бага багаар хүмүүсийг уруу татдаг. Ийм маягаар, суралцах явцдаа зарим нь уран зохиолд, зарим нь эдийн засагт, зарим нь одон орон, эсвэл газарзүйд дуртай болдог. Бас зарим нь улс төрд дуртай болж, зарим нь физик, зарим нь химид дуртай болдог ба теологид дуртай зарим хүн ч мөн л байдаг. Эдгээр нь бүгд мэдлэг гэх бүхэл зүйлийн хэсгүүд юм. Зүрх сэтгэлдээ та нар дор бүрнээ эдгээр зүйл үнэндээ юу болохыг мэддэг; та нар дор бүрнээ урьд нь тэдгээртэй харьцаж байсан. Мэдлэгийн эдгээр салбарын аль нэгнийх нь талаар та нар дор бүрнээ эцэс төгсгөлгүй үргэлжлүүлэн ярих чадвартай. Иймээс энэ мэдлэг хүмүүсийн оюун ухаанд хэр гүн орсон нь тодорхой юм; энэхүү мэдлэгийн хүний оюун ухаанд эзэлдэг байр суурь болон хүнд хэр гүн үр нөлөө үзүүлдгийг харахад амархан. Хүн мэдлэгийн нэг талд сэтгэл татагдмагцаа, үүнд гүнээ дурлах үедээ өөрийн мэдэлгүй туйлын зорилготой болдог: Зарим хүн уран бүтээлч байхыг хүсдэг, зарим нь зохиолч байхыг хүсдэг, зарим нь улс төрийг ажил мэргэжлээ болгохыг хүсдэг бөгөөд зарим нь эдийн засагт оролцож, бизнес эрхлэгч болохыг хүсдэг. Тэгтэл баатар болохыг, агуу, алдартай байхыг хүсдэг бүлэг хүмүүс

бий. Хүн ямар хүн байхыг хүсдэгээс үл хамааран, тэдний зорилго бол мэдлэгт суралцах арга замаар дамжуулан зорилгодоо хүрч, хүсэл болон амбицаа биелүүлэх явдал юм. Энэ хэчнээн сайхан сонсогдох нь хамаагүй—тэд мөрөөдлөө биелүүлж, энэ амьдралаа дэмий үрэхгүй байхыг хүсдэг ч бай, эсвэл тодорхой ажил мэргэжилтэй болохыг хүсдэг ч бай—тэд өндөр дээд туйлын зорилго, амбиц өвөрлөдөг боловч мөн чанартаа энэ бүхэн нь юуны төлөө байдаг вэ? Та нар энэ асуултыг өмнө нь ер нь бодож үзэж байсан уу? Сатан яагаад ийм маягаар үйлддэг вэ? Эдгээр зүйлийг хүнд суулгах Сатаны зорилго юу вэ? Та нарын зүрх сэтгэл энэ асуултын талаар тодорхой мэдэж байх ёстой.

Сатан хүнийг завхруулахын тулд мэдлэгийг хэрхэн ашигладаг тухай одоо ярилцацгаая. Эхлээд бид эдгээр зүйлийг тодорхой ойлгох ёстой: Мэдлэгээр Сатан хүнд юу өгөхийг хүсдэг вэ? Хүнийг ямар зам руу хөтлөхийг хүсдэг вэ? (Бурханыг эсэргүүцэх зам руу.) Тийм ээ, Бурханыг эсэргүүцэх гэдэг бол гарцаагүй мөн. Энэ бол мэдлэг олж авч байгаа хүмүүсийн үр дагавар—тэд Бурханыг эсэргүүцэж эхэлдэг гэдгийг чи харж болно. Тэгвэл Сатаны өөдгүй муу сэдэл юу вэ? Энэ талаар тодорхой мэдэхгүй байгаа биз дээ? Хүн мэдлэгийг суралцах явцад, Сатан түүх ярих ч бай, тэдэнд зүгээр л нэг хэсэг мэдлэг өгөх ч бай, эсвэл хүсэл, амбицаа биелүүлэх боломж олгох ч бай хамаагүй, төрөл бүрийн арга ашигладаг. Сатан ямар зам руу чамайг хөтлөхийг хүсдэг вэ? Мэдлэг сурахад ямар ч буруу зүйл байхгүй, энэ бол тэр чигтээ зүй ёсны хэрэг гэж хүмүүс боддог. Зөөлрүүлж хэлбэл, өндөр дээд туйлын зорилго өвөрлөж, амбицтай байх нь чин эрмэлзэлтэй байгаа хэрэг бөгөөд энэ нь амьдралын зөв зам байх ёстой. Хүмүүс амьдралдаа өөрсдийн туйлын зорилгыг биелүүлж, эсвэл ажил мэргэжлээ амжилттай үндэслэж чадвал, тэдний хувьд энэ нь илүү алдар цуутай арга зам биш гэж үү? Эдгээр зүйлийг хийснээр хүн өвөг дээдсээ алдаршуулаад зогсохгүй, бас түүхэнд мөрөө үлдээх боломжтой байдаг—энэ нь сайн зүйл биш гэж үү? Энэ нь, ертөнцийн хүмүүсийн нүдээр сайн зүйл бөгөөд тэдний хувьд энэ нь зүй зохистой, эерэг байх ёстой. Гэхдээ Сатан өөдгүй муу сэдлээрээ хүмүүсийг ийм замд оруулаад, тэгээд л болдог уу? Мэдээж үгүй. Үнэндээ хүний туйлын зорилго хэчнээн өндөр дээд байх нь хамаагүй, хүний хүсэл хэчнээн бодитой, хэчнээн зүй зохистой байх нь хамаагүй, хүний хүрэхийг хүсдэг бүхэн, эрж хайдаг бүхэн хоёр үгтэй салшгүй холбоотой байдаг. Энэ хоёр үг нь хүн бүрийн амьдралд амин чухал бөгөөд эдгээр нь Сатаны хүнд суулгахаар зорьдог зүйл юм. Энэ хоёр үг юу вэ? Тэр нь “алдар нэр”, “ашиг хонжоо” юм. Сатан тун аядуу зөөлөн арга буюу хүмүүсийн үзэлтэй тун их нийцдэг арга ашигладаг нь ямар нэг төрлийн радикал арга биш бөгөөд үүгээр дамжуулан хүмүүс Сатаны амьдрах арга зам, амьдардаг дүрэм журмыг өөрийн мэдэлгүй хүлээн зөвшөөрч, амьдралын зорилго, чиглэлээ тогтоож, улмаар өөрийн мэдэлгүй амьдралдаа амбицтай болдог. Амьдралын эдгээр амбиц гаднаа хэчнээн агуу сүрлэг санагдах нь хамаагүй, тэдгээр нь “алдар нэр”, “ашиг хонжоотой” салшгүй холбоотой байдаг. Ямар ч агуу, алдартай хүн, үнэндээ бүх хүний амьдралдаа дагадаг бүхэн нь ердөө “алдар нэр”, “ашиг

хонжоо” хэмээх энэ хоёр үгтэй л холбоотой байдаг. Алдар нэр, ашиг хонжоотой болмогцоо тэдгээрийг ашиглан, өндөр байр суурь, асар их эд баялгийг эдэлж, амьдралыг таашааж болно гэж хүмүүс боддог. Алдар нэр, ашиг хонжоо нь зугаа цэнгэлээр хөөцөлдөх амьдрал болон махан биеийн цадиггүй таашаалыг олж авахдаа ашиглаж болох нэг төрлийн хөрөнгө юм гэж тэд боддог. Хүн төрөлхтний ихэд шунадаг энэхүү алдар нэр, ашиг хонжооны төлөө хүмүүс сайн дурааараа хэрнээ өөрсдийн мэдэлгүйгээр бие, сэтгэл, өөртөө байгаа бүхнийг, өөрсдийн ирээдүй, хувь заяаг бүгдийг нь Сатанд хүлээлгэн өгдөг. Тэд нэг хором ч эргэлзэхгүйгээр, өгсөн бүхнээ буцаан авах хэрэгтэйг ер мэдэхгүйгээр үүнийг хийдэг. Ийм маягаар Сатанд хоргодож, түүнд үнэнч болмогцоо хүмүүс өөрсдийгөө хянасаар байж чадах уу? Мэдээж үгүй. Тэднийг Сатан бүрмөсөн, бүрэн дүүрэн хянадаг. Мөн тэд намагт бүрмөсөн, тэр чигтээ живсэн бөгөөд өөрсдийгөө чөлөөлж чаддаггүй. Хүн алдар нэр, ашиг хонжооны намагт живмэгцээ гэрэл гэгээтэй зүйлийг, зөв шударга зүйлийг, эсвэл сайн, сайхан зүйлсийг эрж хайхаа больдог. Яагаад гэвэл, хүмүүсийг уруу татах алдар нэр, ашиг хонжооны хүч чадал дэндүү их; тэдгээр нь хүмүүсийн насан туршдаа, бүр эцэс төгсгөлгүйгээр үүрд мөнх хөөцөлддөг зүйлс болдог. Энэ нь үнэн биш гэж үү? Мэдлэгт суралцах нь, цаг үеэсээ хоцрохгүйн тулд, эсвэл дэлхий ертөнцөөс хоцрохгүйн тулд ном уншиж, хараахан мэдээгүй байсан цөөн хэдэн зүйлээ сурахаас цаашгүй. Тэгээд идэх хоолтой байхын тулд, ирээдүйнхээ төлөө, эсвэл үндсэн хэрэгцээгээ хангахын тулд л мэдлэгт суралцдаг гэж зарим хүн хэлнэ. Ердөө үндсэн хэрэгцээнийхээ төлөө, ердөө хоол хүнсний асуудлаа шийдвэрлэхийн тулд арван жил мэрийн суралцах хэн нэгэн байдаг уу? Үгүй, ийм хүн нэг ч байхгүй. Тэгвэл энэ бүх жилүүдэд хүн юуны төлөө эдгээр бэрхшээлийг туулдаг юм бэ? Алдар нэр, ашиг хонжооны төлөө. Алдар нэр, ашиг хонжоо түүнийг зайдуу хүлээж, дуудаж байдаг бөгөөд өөрийнхөө хичээл зүтгэл, зовлон бэрхшээл, тэмцлээр дамжуулан алдар нэр, ашиг хонжоонд хүрэх замыг дагаж чадна гэж хүн итгэдэг. Тийм хүн ирээдүйн замынхаа төлөө, ирээдүйн зугаа цэнгэлийнхээ төлөө, илүү сайхан амьдралын төлөө эдгээр зовлон бэрхшээлийг туулах учиртай. Энэ мэдлэг ер нь яг юу юм бэ—та нар Надад хэлж өгч чадах уу? Энэ нь хүнд Сатаны суулгадаг “Намаа хайрла, эх орноо хайрла, шашнаа хайрла”, “Ухаантай хүн нөхцөл байдалд захирагддаг” гэх мэт амьдралын дүрэм журам, гүн ухаан биш гэж үү? Хүнд Сатаны суулгасан амьдралын “өндөр дээд туйлын зорилго” биш гэж үү? Жишээ нь, агуу хүмүүсийн үзэл санаа, алдартай хүмүүсийн ёс жудаг, баатарлаг хүмүүсийн зориг зүрхийг аваад үз, эсвэл бие хамгаалах урлагийн романы гол дүр, илдчиний шударга журам, эелдэг занг аваад үз—энэ нь эдгээр туйлын зорилгыг суулгадаг Сатаны арга зам биш гэж үү? Эдгээр үзэл санаа нэгээс нөгөө үед нөлөөлдөг бөгөөд үе үеийн хүмүүс эдгээр үзэл санааг хүлээн авдаг. Тэд “өндөр дээд туйлын зорилгыг” эрэлхийлэхээр байнга тэмцэж, амиа ч золиосолно. Сатан хүмүүсийг завхруулахдаа мэдлэгийг ашигладаг арга барил, хэрэгсэл нь энэ юм. Тэгвэл Сатан тэднийг ийм зам руу хөтөлсний дараа

хүмүүс Бурханд дуулгавартай байж, шүтэн мөргөж чадах уу? Тэд Бурханы үгийг хүлээн авч, үнэнийг эрэлхийлж чадах уу? Огтхон ч үгүй, учир нь Сатан тэднийг төөрөлдүүлсэн. Хүмүүст Сатаны суулгасан мэдлэг, бодол, санааг дахин нэг харцгаая: Эдгээр зүйл Бурханд дуулгавартай байж, шүтэн мөргөх үнэнийг агуулдаг уу? Бурханаас эмээж, муугаас зайлах тухай үнэн тэнд бий юу? Бурханы аль нэг үг бий юу? Үнэнтэй холбоотой ямар нэгэн зүйл бий юу? Огтхон ч үгүй. Ийм зүйл огт байхгүй. Хүмүүст Сатаны суулгасан зүйлст үнэн байхгүй гэдэгт та нар итгэлтэй байж болох уу? Та нар тэгж зүрхэлдэггүй—гэхдээ хамаагүй. “Алдар нэр”, “ашиг хонжоо” бол хүмүүсийг ёрын муу зам руу уруу татахдаа Сатаны ашигладаг хоёр түлхүүр үг гэдгийг чи ухаарсан л бол тэр чинь хангалттай.

Одоог хүртэл хэлэлцсэн зүйлээ дахиад товчхон дүгнэцгээе: Сатан хүнийг хяналтдаа баттай байлгаж байхын тулд юу ашигладаг вэ? (Алдар нэр, ашиг хонжоо.) Тэгвэл Сатан, алдар нэр, ашиг хонжооноос өөр юу ч бодохгүй болтол нь хүний бодлыг хянахын тулд алдар нэр, ашиг хонжоог ашигладаг. Тэд алдар нэр, ашиг хонжооны төлөө тэмцэж, алдар нэр, ашиг хонжооны төлөө зовлон бэрхшээл туулж, алдар нэр, ашиг хонжооны төлөө доромжлолыг тэвчиж, алдар нэр, ашиг хонжооны төлөө байгаа бүхнээ золиосолдог ба алдар нэр, ашиг хонжооны төлөө ямар ч шүүлт хийж, шийдвэр гаргана. Ийм маягаар Сатан хүнийг үл үзэгдэх гав дөнгөөр хүлдэг ба энэ гав дөнгө биед нь байхад, хүнд үүнээс ангижрах хүч чадал ч, зориг ч байдаггүй. Хүмүүс өөрийн мэдэлгүйгээр энэ гав дөнгийг зүүж, асар их хүндрэлтэйгээр урагшаа арай ядан сажилдаг. Энэхүү алдар нэр, ашиг хонжооны төлөө хүн төрөлхтөн Бурханаас зайлж, Түүнээс урваж, улам хорон муу болдог. Тиймээс, ийм маягаар Сатаны алдар нэр, ашиг хонжооны дунд үе удам ээлж дараалан сүйрдэг. Сатаны үйлдлийг одоо харвал өөдгүй муу сэдэл нь туйлын жигшүүртэй бус уу? Магадгүй өнөөдөр ч гэсэн та нар Сатаны өөдгүй муу сэдлийг нэвт шувт харж чадахгүй байгаа, учир нь алдар нэр, ашиг хонжоогүйгээр хүн амьдарч чадахгүй гэж та нар боддог. Хэрвээ хүмүүс алдар нэр, ашиг хонжоог ардаа орхих л юм бол өмнөх замаа харж чадахаа больж, өөрсдийн зорилгыг харж чадахаа болих бөгөөд ирээдүй нь харанхуй, бүүдгэр, бүрхэг болно гэж боддог. Гэхдээ алдар нэр, ашиг хонжоо нь хүнийг хүлэхдээ Сатаны ашигладаг аварга том гав дөнгө юм гэдгийг та нар нэг л өдөр аажмаар ухаарна. Тэр өдөр ирэхэд чи Сатаны хяналтыг нэгд нэггүй эсэргүүцэж, чамайг хүлэхдээ Сатаны ашигладаг гав дөнгийг нэгд нэггүй эсэргүүцнэ. Сатаны чамд суулгасан бүхнийг хаяхыг хүсэх өдөр ирэх үед чи Сатанаас бүрмөсөн салж, Сатаны чамд авчирсан бүхнийг үнэхээр үзэн ядна. Тэр үед л хүн төрөлхтөн Бурханыг гэх жинхэнэ хайр, хүсэл тэмүүлэлтэй болно.

б. Сатан хүнийг завхруулахдаа шинжлэх ухааныг ашигладаг

Хүнийг завхруулахын тулд Сатан мэдлэгийг хэрхэн ашигладаг тухай бид дөнгөж сая ярилцлаа, тэгвэл дараа нь Сатан хүнийг завхруулахдаа шинжлэх ухааныг хэрхэн ашигладаг тухай нөхөрлөцгөөе. Юуны өмнө Сатан, хүний сониуч

зан болон шинжлэх ухааныг судалж, нууцуудыг шинжлэх хүслийг хангахын тулд шинжлэх ухааны нэрийг ашигладаг. Шинжлэх ухааны нэрийн дор Сатан хүний материаллаг хэрэгцээг болон амьдралынхаа чанарыг тасралтгүй сайжруулах шаардлагыг нь хангадаг. Тиймээс, Сатан ийм шалтгаар хүнийг завхруулахын тулд шинжлэх ухааныг ашигладаг. Сатан ийм маягаар шинжлэх ухааныг ашиглан хүний бодол санаа, оюун ухааныг л завхруулдаг уу? Бидний хардаг, харьцдаг эргэн тойрны зүйлс, үйл явдал, хүмүүсийн дундаас Сатан өөр юуг шинжлэх ухаанаар завхруулдаг вэ? (Байгаль орчин.) Зөв. Та нар үүний улмаас гүнээ хохирч, мөн энэ нь та нарт гүнээ нөлөөлсөн юм шиг байна. Хүнийг хуурахын тулд шинжлэх ухааны янз бүрийн нээлт, дүгнэлтийг ашиглахаас гадна Сатан, хүнд Бурханы өгсөн амьдрах орчныг зэрлэг балмадаар сүйтгэж, мөлжин ашиглахдаа ч бас шинжлэх ухааныг ашигладаг. Хэрвээ хүн шинжлэх ухааны судалгаа явуулах юм бол хүний амьдрах орчин улам дээрдэж, хүний амьдралын стандарт тасралтгүй сайжирна, цаашлаад хүмүүсийн өдөр ирэх бүр өсөн нэмэгдэж байгаа материаллаг хэрэгцээг болон амьдралынхаа чанарыг сайжруулсаар байх хэрэгцээг хангах нь шинжлэх ухааны хөгжлийн зорилго юм гэсэн шалтгаар Сатан үүнийг хийдэг. Энэ нь Сатаны, шинжлэх ухааныг хөгжүүлэх онолын үндэс юм. Гэхдээ шинжлэх ухаан хүн төрөлхтөнд юу авчирсан бэ? Бидний амьдрах орчин, бүх хүн төрөлхтний амьдрах орчин бохирдсон бус уу? Хүний амьсгалдаг агаар бохирдсон бус уу? Бидний ундалдаг ус бохирдсон бус уу? Бидний иддэг хоол хүнс органик, байгалийн гаралтай хэвээрээ гэж үү? Ихэнх үр тариа, хүнсний ногоо генийн өөрчлөлттэй, бордоогоор ургуулсан бөгөөд зарим нь шинжлэх ухаанаар гаргаж авсан төрлүүд байдаг. Бидний иддэг хүнсний ногоо, жимс байгалийн гаралтай байхаа больсон. Одоо органик өндөг ч олдохоо больсон ба Сатаны шинжлэх ухаан гээч зүйлээр боловсруулчихсан болохоор өндөг өмнөх шигээ амтагдахаа больсон. Том дүр зургийг харвал бүхий л агаар мандал сүйдэж, бохирдсон; уулс, нуур, ой мод, гол мөрөн, далай, газрын дээр, доор байгаа бүхэн бүгд шинжлэх ухааны ололт амжилт гээч зүйлээс болж сүйтгэгдсэн. Товчхондоо, хүн төрөлхтөнд Бурханы өгсөн байгаль экологийн орчин болон амьдрах орчин бүхэлдээ шинжлэх ухаан гэгчээс болж устаж, сүйджээ. Хэдийгээр олон хүн эрж хайж байсан амьдралын чанартайгаа холбоотойгоор үргэлж найдаж байсан зүйлээ олж авч, өөрсдийн хүсэл болон махан биеийн аль алийг хангасан боловч шинжлэх ухааны авчирсан янз бүрийн “ололт амжилтаас” болж хүний амьдардаг хүрээлэн буй орчин үндсэндээ устаж, сүйдсэн юм. Одоо бид цэвэр агаараар амьсгалах эрхтэй байхаа ч больсон. Энэ нь хүн төрөлхтний уй гашуу бус уу? Хүн ийм орон зайд амьдрах ёстой болсон үед хүний хувьд яриад байх ямар нэгэн аз жаргал үлдсэн гэж үү? Хүний амьдардаг энэхүү орон зай, амьдрах орчныг Бурхан бүр анхнаасаа хүнд зориулж бүтээсэн юм. Хүмүүсийн уудаг ус, амьсгалдаг агаар, иддэг янз бүрийн хоол хүнс, ургамал, амьтад, тэр ч бүү хэл, уул, нуур, далай тэнгис—энэхүү амьдрах орчны хэсэг бүрийг хүнд Бурхан өгсөн; энэ нь байгалиас заяасан бөгөөд Бурханы тогтоосон байгалийн

хуулийн дагуу ажилладаг. Шинжлэх ухаан байгаагүй бол хүмүүс Бурханы хайрласан арга барилыг дагаж, бүх зүйлийг хамгийн анхны, байгалиас заяасан байдлаар нь эдэлж, аз жаргалтай байж чадах байлаа. Одоо гэхдээ энэ бүхнийг Сатан устгаж, сүйтгэсэн; хүний амьдрах үндсэн орон зай цаашид онгон дагшин байхаа больсон. Гэхдээ үүнийг юу учруулсныг, энэ нь хэрхэн бий болсныг хэн ч танин мэдэж чаддаггүй бөгөөд бүр олон хүн Сатаны өөрсдөд нь суулгасан үзэл санаагаар дамжуулан шинжлэх ухаанд хандаж, үүнийг ойлгодог. Энэ нь туйлын жигшүүртэй, өрөвдөлтэй биш гэж үү? Сатан одоо хүн төрөлхтний оршин байдаг орон зай болон амьдрах орчныг аваад ийм болтол завхруулсан болохоор, хүн төрөлхтөн ийм маягаар үргэлжлүүлэн хөгжих юм бол энэ хүмүүсийг Бурхан биечлэн устгах хэрэг байна уу? Хэрвээ хүмүүс ийм маягаар үргэлжлүүлэн хөгжих юм бол ямар чиглэлд явах вэ? (Тэд устгагдана.) Хэрхэн устгагдах вэ? Хүмүүс алдар нэр, ашиг хонжоог шуналтайгаар хайдаг дээрээ нэмээд шинжлэх ухааны хайгуул, гүнзгий судалгааг тасралтгүй явуулж, улмаар өөрсдийн материаллаг хэрэгцээ болон хүслийг хангахын тулд ийм маягаар тасралтгүй үйлддэг; тэгвэл хүнд авчрах үр дагавар юу вэ? Юун түрүүнд, экологийн тэнцвэр алдагддаг, ингэх үед ийм төрлийн тэнцвэргүй орчноос болоод хүмүүсийн бие, дотоод эрхтэн муудаж, гэмтдэг бөгөөд янз бүрийн халдварт өвчин, тахал дэлхий даяар тархдаг. Одоо энэ нь хүний огт хянаж чаддаггүй нөхцөл байдал юм, тийм биш гэж үү? Та нар үүнийг ойлгосон болохоор хэрвээ хүн төрөлхтөн Бурханыг дагахгүй, харин үргэлж ийм маягаар Сатаныг дагаж—өөрсдийгөө байнга баяжуулахын тулд мэдлэгийг ашиглаж, хүний амьдралын ирээдүйг судлахын тулд шинжлэх ухааныг тасралтгүй ашиглаж, үргэлжлүүлэн амьдрахын тулд ийм аргыг ашиглах юм бол—хүн төрөлхтний хувьд энэ нь яаж төгсөхийг та нар ухамсарлаж чадах уу? Хүн төрөлхтөн аяндаа мөхнө: Хүн төрөлхтөн алхам алхмаар сүйрэл рүү, өөрсдийнхөө сүйрэл рүү урагшилдаг! Энэ нь өөрсдийгөө сүйрүүлж байгаа хэрэг бус уу? Шинжлэх ухааны ахиц дэвшлийн үр дагавар бус уу? Одоо, шинжлэх ухаан бол хүнд зориулан Сатаны бэлтгэсэн нэг төрлийн шидэт ханд шиг санагдаж байна, ингэснээр та нар аливааг ялган салгахаар оролдохдоо манарч самуурсан байдлаар хийдэг; хэчнээн мэрийж харсан ч гэсэн аливааг тодорхой харж чаддаггүй бөгөөд хэчнээн мэрийн оролдсон ч гэсэн тэдгээрийг ойлгож чаддаггүй. Гэхдээ Сатан дур хүслийг чинь төрүүлж, ёроолгүй ангал руу, үхэл рүү чамайг бурантагтай тэмээ шиг зугуухан хөтлөхийн тулд шинжлэх ухааны нэрийг ашигладаг. Тийм болохоор, үнэндээ хүний сүйрэл Сатаны гараар хийгдэж байгааг, Сатан гол буруутан нь болохыг хүмүүс тодорхой харах болно. Тийм биш гэж үү? (Тийм.) Энэ бол Сатан хүн төрөлхтнийг завхруулдаг хоёр дахь арга зам юм.

в. Сатан хүнийг завхруулахдаа уламжлалт соёлыг ашигладаг

Уламжлалт соёл бол Сатан хүнийг завхруулдаг гурав дахь арга зам юм. Уламжлалт соёл болон мухар сүсгийн хооронд ижил төстэй байдал олон байдаг

боловч уламжлалт соёлд тодорхой түүх, зүйрлэл, эх сурвалж байдаг. Сатан түүхийн номд байдаг үлгэр домог, түүх олныг зохиож, бий болгон, уламжлалт соёл, эсвэл мухар сүсэг дэх хүмүүсийн талаарх гүн гүнзгий сэтгэгдлийг хүмүүст үлдээжээ. Жишээ нь, Хятадад “Найман сахиус тэнгисийг гаталсан нь”, “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”, Хаш Хаан, “Нежа Луу Хааныг байлдан дагуулсан нь”, “Бурхан болгож өргөмжилсөн нь” зэрэг байдаг. Эдгээр нь хүний оюун ухаанд гүн үндэслээгүй гэж үү? Та нарын зарим нь бүх нарийн ширийнийг нь мэдэхгүй байсан ч гэсэн ерөнхий түүхүүдийг мөн л мэддэг бөгөөд ерөнхий агуулга нь зүрх сэтгэлд чинь, оюун санаанд чинь суудаг болохоор мартаж чаддаггүй. Эдгээр нь аль эртнээс хүнд зориулж Сатаны бэлдсэн янз бүрийн үзэл санаа, үлгэр домог бөгөөд өөр өөр цаг хугацаанд тараагдсан юм. Эдгээр зүйл хүмүүсийн сэтгэлийг шууд хорлож, эвдэн, хүмүүсийг нэгээс нөгөө тарнийн шившлэгт автуулдаг. Өөрөөр хэлбэл, тийм уламжлалт соёл, түүх, эсвэл мухар сүсгийн зүйлсийг хүлээн зөвшөөрмөгц, мөн эдгээр зүйл оюун ухаанд чинь үндэслэж, зүрх сэтгэлд чинь ормогц чи тарнийн шившлэгт автсантай адил—чи эдгээр соёлын занга, эдгээр үзэл санаа, уламжлалт түүхийн нөлөөнд орж, үүнтэй орооцолддог. Тэдгээр нь амьдралд чинь, амьдралыг үзэх үзэлд чинь, аливаа зүйлийг үнэлэхэд чинь нөлөөлдөг. Үүнээс ч илүүтэйгээр тэдгээр нь амьдралын жинхэнэ замын төлөөх эрэл хайгуулд чинь нөлөөлдөг: Энэ бол үнэхээр хорон муу тарнийн шившлэг юм. Чи чадлаараа оролдсон ч тэдгээрээс ангижирч чадахгүй; тэдгээрийг цавчсан ч бүрэн тасдаж чадахгүй; цохьсон ч буулган авч чадахгүй. Цаашлаад хүмүүс өөрийн мэдэлгүй ийм тарнийн шившлэгт автсаныхаа дараа өөрийн мэдэлгүй Сатаныг шүтэж, Сатаны дүр төрхийг зүрх сэтгэлдээ тээж эхэлдэг. Өөрөөр хэлбэл, тэд Сатаныг өөрсдийн шүтээн буюу өөрсдийн шүтэж, бишрэх зүйл болгодог, тэр ч бүү хэл түүнийг Бурхан гэж үзэхдээ тулдаг. Өөрийн мэдэлгүй эдгээр зүйл хүмүүсийн зүрх сэтгэлд оршиж, үг болон үйл хэргийг нь хянадаг. Түүнчлэн, чи анх эдгээр түүх, үлгэр домгийг худлаа гэж үздэг байсан ч дараа нь өөрийн мэдэлгүйгээр эдгээр түүхийн оршин тогтнолыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг жинхэнэ хүмүүс, жинхэнэ оршин байдаг юмс болгодог. Нэг л мэдэхэд чи эдгээр үзэл санаа болон эдгээр зүйлийн оршин тогтнолыг ухамсартайгаар хүлээн авдаг. Чи бас диаволууд, Сатан, хуурамч шүтээнийг гэртээ болон зүрх сэтгэлдээ санаатайгаар хүлээн авдаг—энэ нь үнэхээр тарнийн шившлэг юм. Та нарт бас ингэж санагдаж байна уу? (Тийм.) Та нарын дунд арц уугиулж, Буддад шүтэн мөргөж байсан хүн байна уу? (Байна.) Тэгвэл арц уугиулж, Буддад шүтэн мөргөхийн зорилго юу байсан бэ? (Амар амгалангийн төлөө залбирах.) Одоо бодоод үзвэл, амар амгалан байдлын төлөө Сатанд залбирах нь утгагүй бус уу? Сатан амар амгаланг авчирдаг уу? (Үгүй.) Та нар тэр үед хэчнээн мэдлэггүй байснаа харахгүй байна уу? Тиймэрхүү зан авир нь утгагүй, мэдлэггүй, гэнэн биш гэж үү? Сатан чамайг хэрхэн завхруулах талаар л анхаардаг. Сатан чамд амар амгаланг өгч яавч чадахгүй, зөвхөн түр зуурын завсарлага л өгч чадна. Гэхдээ энэ завсарлагыг авахын тулд чи тангараг өргөх ёстой бөгөөд хэрвээ амлалтаа зөрчвөл,

эсвэл Сатанд өгсөн тангаргаа зөрчвөл чамайг хэрхэн тарчилгахыг нь чи харна. Чамаар тангараг өргүүлэхдээ тэр үнэндээ чамайг хянахыг хүсдэг. Амар амгалан байдлын төлөө залбирах үедээ та нар амар амгаланг олж авсан уу? (Үгүй.) Та нар амар амгаланг олж аваагүй, харин ч эсрэгээрээ, хичээл чармайлт чинь золгүй явдал, дуусашгүй гай зовлон—үнэхээр гашуун зовлонгийн зах хязгааргүй далайг авчирсан. Сатаны эзэмшил дотор амар амгалан байдал байдаггүй ба энэ бол үнэн. Энэ нь феодалын мухар сүсэг болон уламжлалт соёлын хүн төрөлхтөнд авчирсан үр дагавар юм.

г. Сатан хүнийг завхруулахдаа нийгмийн чиг хандлагыг ашигладаг

Эцэст нь Сатан нийгмийн чиг хандлагаар дамжуулан хүнийг завхруулж, хянадаг. Нийгмийн чиг хандлага нь алдартай, агуу хүмүүсийг шүтэх, мөн кино, хөгжмийн шүтээн, алдартныг шүтэх, онлайн тоглоом гэх мэт янз бүрийн талбарыг оролцуулаад олон талыг хамардаг—эдгээр нь бүгд нийгмийн чиг хандлагын нэг хэсэг бөгөөд энд нарийвчлан ярих шаардлагагүй. Бид зөвхөн нийгмийн чиг хандлагын хүмүүст авчирдаг үзэл санаа, хүмүүсийн энэ дэлхий дээр биеэ авч явах байдалд хүргэдэг арга зам болон хүмүүст авчирдаг амьдралын зорилго, амьдралыг үзэх үзлийн тухай л ярилцана. Эдгээр нь маш чухал; тэд хүний бодол, санааг хянаж, үүнд нөлөөлдөг. Эдгээр чиг хандлага ар араасаа гарч ирдэг бөгөөд хүн төрөлхтнийг тасралтгүй доройтуулдаг ёрын муу нөлөө үзүүлэн, мөс чанар, хүн чанар, эрүүл ухаанаа алдахад тэднийг хүргэж, ёс суртахуун, жудгийг нь улам бүр дордуулж, дийлэнх хүмүүс одоо ёс жудаггүй, хүн чанаргүй болсон, тэдэнд эрүүл ухаан бүү хэл, ямар ч мөс чанар байдаггүй гэж хэлж болохуйц хэмжээнд хүрсэн. Тэгвэл энэ нийгмийн чиг хандлага нь юу вэ? Чи энгийн нүдээр эдгээр чиг хандлагыг харж чадахгүй. Шинэ чиг хандлага дэлхий даяар сэвэлзэх үед магадгүй ердөө цөөн тооны хүмүүс л эн тэргүүнд байж, шинэ чиг хандлагыг тогтоогчид болдог. Тэд шинэ зүйл хийж эхлээд, дараа нь зарим нэг үзэл санаа, зарим нэг үзэл бодлыг хүлээн авдаг. Гэвч хүмүүсийн дийлэнх нь нэг л мэдэхэд ийм чиг хандлагаар тасралтгүй халдварлагдаж, үүнд сэтгэл татагдаж, уусаж, өөрийн мэдэлгүйгээр, аяндаа бүгд үүнийг хүлээн авч, үүнд автаж, хяналтад нь орохдоо тулдаг. Ийм чиг хандлага нь ээлж дараалан, эрүүл саруул бие, оюун ухаантай биш, үнэн гэж юу болохыг мэддэггүй, эерэг сөрөг зүйлсийг огт ялгаж чаддаггүй хүмүүсээр энэ чиг хандлага, Сатанаас ирдэг амьдралыг үзэх үзэл, үнэт зүйлсийг баяртайяа хүлээн зөвшөөрүүлдэг. Тэд амьдралд хандах талаар Сатаны хэлсэн зүйл, Сатаны “хайрласан” амьдрах арга замыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд тэдэнд эсэргүүцэх хүч чадал ч, чадвар ч байдаггүй, эсэргүүцэх ухамсар бүр ч байдаггүй. Тэгвэл ийм чиг хандлагыг яаж таних вэ? Би та нарын аажмаар ойлгож авч чадах энгийн нэг жишээ сонголоо. Жишээ нь, урьд нь хүмүүс хэнийг ч луйвардалгүй бизнесээ эрхэлдэг байв; хэн худалдан авахаас үл хамааран бараагаа адилхан үнээр зардаг байлаа. Мөс чанар болон хүн чанар сайтайн зарим элемент энд илэрхийлэгдэж байгаа бус уу? Хүмүүс

бизнесээ ингэж үнэнчээр эрхэлж байсан нь тухайн үед тэдэнд мөс чанар, хүн чанар байсаар байж гэдгийг харуулдаг. Гэвч мөнгөний төлөөх хүний хэрэгцээ улам өсөн нэмэгдсэнээр хүмүүс өөрийн мэдэлгүй мөнгө, ашиг хонжоо, зугаа цэнгэлийг улам бүр хайрлах болсон. Хүмүүс мөнгийг урьдынхаасаа илүү чухалчлан үздэг биш үү? Хүмүүс мөнгийг маш чухал гэж үзэх үедээ өөрсдийн нэр хүнд, алдар цуу, нэр нүүр, ёс жудагт өөрийн мэдэлгүй багахан ач холбогдол өгч эхэлдэггүй гэж үү? Бизнес эрхлэх үедээ чи, бусад нь хүмүүсийг хуурч мэхлэн баяжиж байгааг хардаг. Хэдийгээр олсон мөнгө нь буруу аргаар олсон мөнгө боловч тэд улам баяжсаар байдаг. Тэдний гэр бүлийн эдэлж байгаа бүхнийг хараад чи гонсойдог: “Бид хоёр хоёулаа бизнес хийдэг байтал тэднийх баян болчихлоо. Би яагаад их мөнгө олж чадахгүй байгаа юм бэ? Би тэвчихгүй нь, би илүү их мөнгөтэй болох арга олох ёстой.” Дараа нь чи яаж хөрөнгөтэй болох тухайгаа л боддог. “Хэнийг ч хуурахгүйгээр, мөс чанартайгаар мөнгө олох ёстой” гэдэг итгэл үнэмшлээсээ татгалзмагцаа, ашиг сонирхолдоо хөтлөгдөн бодол чинь аажмаар өөрчлөгдөж, үйлдлийн чинь цаад зарчим ч бас өөрчлөгддөг. Анх удаагаа хэн нэгнийг хуурахдаа мөс чанарынхаа зэмлэлийг мэдэрч, зүрх сэтгэл чинь чамд “Үүнийг л хийчихвэл дахиад хэнийг ч хуурахгүй. Хүмүүсийг үргэлж хуурвал цээрлүүлэлт амсана!” гэж хэлдэг. Чамайг эргэлзүүлж, чамайг зэмлэх нь хүний мөс чанарын чиг үүрэг болохоор хэн нэгнийг хуурах үед чамд эвгүй санагддаг. Харин хэн нэгнийг амжилттай хуурсныхаа дараа чи одоо өмнөхөөсөө илүү их мөнгөтэй болсноо харах ба энэ арга чиний хувьд тун ашигтай байж болох юм гэж боддог. Өөрийнхөө зүрх сэтгэл дэх үл ялиг өвдөлтийг үл харгалзан чи амжилт гаргасандаа өөртөө баяр хүргэмээр санагдаж, өөрөөрөө бага зэрэг бахархдаг. Анх удаагаа чи өөрийн үйлдлийг зөвтгөж, зальхай арга замаа зөвтгөдөг. Энэхүү мэхлэлт хүнийг бохирдуулмагц энэ нь мөрийтэй тоглоомд орж, дараа нь мөрийтэй тоглогч болсон хүнтэй адил байдаг. Чи хууран мэхлэх үйлдлээ өөрийн мэдэлгүй зөвтгөж, хүлээн зөвшөөрдөг. Өөрийн мэдэлгүйгээр чи хууран мэхлэлтийг хууль ёсны арилжааны зан байдал, мөн оршин тогтнож, амь зуухад чинь хамгийн ашиг тустай арга барил гэж үздэг; ингэснээрээ хурдан баяжиж чадна гэж боддог. Үйл явц нь энэ: Эхлээд хүмүүс, ийм зан байдлыг хүлээн зөвшөөрч чаддаггүй ба ийм зан байдал, хэрэгжүүлэлтийг дорд үздэг. Дараа нь тэд ийм зан байдлыг өөрсдөө туршиж, өөрсдийнхөө арга замаар оролдож үзээд зүрх сэтгэл нь аажмаар өөрчлөгдөж эхэлдэг. Тэгвэл энэ нь ямархуу өөрчлөлт байдаг вэ? Энэ нь, нийгмийн хандлагын чамд суулгасан энэхүү хандлага, энэхүү үзэл санааг зөвтгөж, хүлээн зөвшөөрөх явдал юм. Нэг л мэдэхэд, бизнес хийхдээ хүмүүсийг хуурч мэхлэхгүй бол алдагдал хүлээнэ гэж чамд санагддаг; мөн бусдыг хуурч мэхлэхгүй бол ямар нэгэн зүйлийг алдчихсан юм шиг санагддаг. Өөрийн мэдэлгүйгээр энэхүү хууран мэхлэлт нь чиний амин сүнс, гол тулгуур, амьдралын чинь зарчим болсон тийм шаардлагатай чухал зан авир болдог. Хүн энэхүү зан байдал, энэ бодол санааг хүлээн авсны дараа зүрх сэтгэлд нь өөрчлөлт гардаг бус уу? Чиний зүрх сэтгэл өөрчлөгдсөн,

тэгвэл ёс жудаг чинь ч бас өөрчлөгдсөн үү? Хүн чанар чинь өөрчлөгдсөн үү? Мөс чанар чинь өөрчлөгдсөн үү? Чи зүрх сэтгэлээсээ эхлээд бодол санаа хүртлээ, гадна доторгүй бүхэлдээ өөрчлөгдсөн ба энэ нь чанарын өөрчлөлт юм. Энэхүү өөрчлөлт нь чамайг Бурханаас улам холдуулж, чи Сатантай улам таарамжтай болдог; тэгээд Сатантай улам адилхан болж, үр дүнд нь Сатаны завхрал чамайг чөтгөр болгодог.

Нийгмийн эдгээр чиг хандлагыг харвал тэдгээр нь хүмүүст томоохон нөлөө үзүүлдэг гэж чи хэлэх үү? Хүмүүст гүн гүнзгий хортой үр нөлөө үзүүлдэг үү? Хүмүүст маш гүн хортой үр нөлөө үзүүлдэг. Сатан хүний ямар талуудыг завхруулахын тулд эдгээр чиг хандлагыг нэг бүрчлэн ашигладаг вэ? Сатан үндсэндээ хүний мөс чанар, эрүүл ухаан, хүн чанар, ёс суртахуун, амьдралыг үзэх үзлийг завхруулдаг. Нийгмийн эдгээр чиг хандлага хүмүүсийг аажмаар доройтуулж, завхруулдаг бус уу? Сатан хүмүүсийг диаволын үүр лүү алхам алхмаар хөтлөхийн тулд нийгмийн эдгээр чиг хандлагыг ашигладаг бөгөөд ингэснээр хүмүүс нийгмийн чиг хандлагад баригдаж, өөрийн мэдэлгүй мөнгө, материаллаг хүсэл, хорон муу явдал болон хүчирхийллийг өмгөөлж дэмждэг. Эдгээр зүйл хүний зүрх сэтгэлд ормогц хүн юу болдог вэ? Хүн диавол Сатан болдог! Яагаад? Учир нь, хүний зүрх сэтгэлд ямар сэтгэл зүйн хандлага оршдог вэ? Хүн юуг хүндэлдэг вэ? Хүн хорон муу явдал болон хүчирхийлэлд дуртай болж эхэлдэг ба гоо сайхан, сайн сайхан, тэр ч бүү хэл энх тайванд дургүй болдог. Хүмүүс хэвийн хүн чанартай жирийн амьдралаар амьдрахыг хүсдэггүй, харин оронд нь өндөр байр суурь, асар их эд хөрөнгийг эдэлж, махан биеийн зугаа цэнгэлд баясаж, өөрсдийг нь барих ямар ч хязгаарлалтгүйгээр, ямар ч хүлээсгүйгээр махан биеийнхээ хүслийг хангахад бүх хичээл чармайлтаа зориулдаг, өөрөөр хэлбэл, хүссэн бүхнээ хийдэг. Тэгвэл, хүн иймэрхүү чиг хандлагуудад автсан үед сурсан мэдлэг чинь өөрийгөө чөлөөлөхөд тусалж чадах уу? Уламжлалт соёл, мухар сүсгийн тухай ойлголт чинь энэхүү хүнд хэцүү байдлаас ангижрахад тусалж чадах уу? Хүний мэддэг уламжлалт ёс суртахуун болон уламжлалт ёслолууд хязгаарлалт хийхэд нь хүмүүст тусалж чадах уу? Жишээ нь, Күнзийн сургаал болон Тао Тэ Чинг аваад үз. Эдгээр ёрын муу чиг хандлагын намаг балчгаас хөлөө татан авахад энэ нь хүмүүст тусалж чадах уу? Яавч үгүй. Тиймээс, хүн улам бүр ёрын муу, биеэ тоосон, дээрэлхүү, аминчхан, хорлонтой болдог. Хүмүүсийн хооронд ямар ч хайр дурлал байхгүй, гэр бүлийн гишүүдийн хооронд ямар ч хайр байхгүй, хамаатан садан, найз нөхдийн дунд ямар ч ойлголцол байхгүй болдог; хүний харилцаа хүчирхийллийн шинжтэй болчихсон. Хүмүүсийн дунд амьдрахдаа хүн нэг бүр хүчирхийллийн арга барил хэрэглэхийг хүсдэг; тэд хүчирхийлэл ашиглан амьжиргаагаа залгуулдаг; хүчирхийлэл ашиглан байр сууриндаа хүрч, ашиг олдог бөгөөд догшин ширүүн, ёрын муу арга ашиглан хүссэн бүхнээ хийдэг. Энэ хүн төрөлхтөн аймаар биш гэж үү? Тийм ээ, маш аймаар: Тэд Бурханыг цовдлоод зогсохгүй, Түүнийг дагадаг хүмүүсийг алж хяддаг. Учир нь хүн дэндүү хорон муу. Миний дөнгөж сая ярьсан энэ бүх зүйлийг сонссоныхоо

дараа Сатан хүн төрөлхтнийг завхруулдаг энэ орчин, энэ дэлхий ертөнц, ийм хүмүүсийн дунд амьдрах нь аймаар гэж та нар бодож байгаа биз дээ? (Тийм.) Тэгвэл та нар өрөвдөлтэй гэдгээ ер нь мэдэрч байсан уу? Энэ хоромд та нар үүнийг бага зэрэг мэдэрч байх учиртай, тийм үү? (Тийм.) Дууны өнгийг чинь сонсоход, “Сатанд хүнийг завхруулах маш олон өөр арга байдаг. Тэр боломж бүрийг шүүрэн авдаг бөгөөд бид хаашаа ч эргэсэн тэр тэнд байдаг. Хүн мөн л аврагдаж чадна гэж үү?” хэмээн бодож байгаа юм шиг байна. Хүн мөн л аврагдаж чадах уу? Хүн өөрийгөө аварч чадах уу? (Үгүй.) Хаш Хаан хүнийг аварч чадах уу? Күнз хүнийг аварч чадах уу? Гуаньинь Бодьсадва хүнийг аварч чадах уу? (Үгүй.) Тэгвэл хэн хүнийг аварч чадах вэ? (Бурхан.) Гэвч, зарим хүн зүрх сэтгэлдээ иймэрхүү асуулт тавих болно: “Сатан биднийг амьдрах ямар ч найдваргүй, амьдрах ямар ч итгэлгүй болтол маш догшин ширүүнээр, ихэд улайран хорлодог. Бид бүгд завхрал дунд амьдардаг ба хүн нэг бүр Бурханыг эсэргүүцдэг, тэгээд одоо зүрх сэтгэл маань чинээндээ тултал дордсон. Тэгвэл Сатан биднийг завхруулж байхад Бурхан хаана байдаг юм бэ? Бурхан юу хийж байна вэ? Бурхан бидний төлөө юу ч хийж байсан бай, бид үүнийг хэзээ ч мэдэрдэггүй!” Зарим хүн гарцаагүй сэтгэлээр унаж, бага зэрэг зүрхшээдэг. Та нарт энэхүү мэдрэмж тун гүнзгий байдаг, учир нь Миний хэлсээр ирсэн бүхэн, ямар ч итгэл найдваргүй гэдгийг нь, мөн Бурханд хаягдсан гэдгийг нь хүмүүст улам бүр мэдрүүлж, аажмаар ойлгуулдаг. Гэхдээ санаа бүү зов. Өнөөдрийн нөхөрлөлийн маань сэдэв болох “Сатаны ёрын муу” гэдэг нь бидний жинхэнэ сэдэв биш. Гэхдээ Бурханы ариун байдлын мөн чанарын тухай ярихдаа, хүн одоо ямар нөхцөл байдалд байгааг хүмүүст илүү тодорхой ойлгуулахын тулд бид эхлээд Сатан хүнийг хэрхэн завхруулдаг тухай болон Сатаны ёрын муугийн тухай ярих ёстой. Энэ тухай ярихын нэг зорилго нь хүмүүст Сатаны ёрын мууг мэдэх боломж олгох, харин нөгөө нь жинхэнэ ариун байдал гэж юу болохыг илүү гүнзгий ойлгох боломжийг хүмүүст олгох явдал юм.

Сая хэлэлцсэн эдгээр зүйлийн талаар Би өнгөрсөн удаагийнхаасаа илүү дэлгэрэнгүй ярьсан бус уу? Та нарын ойлголт одоо арай илүү гүнзгий болсон уу? (Тэгсэн.) Одоо олон хүн Бурханы ариун байдал гэж яг юу болох талаар хэлэхийг минь хүлээж байгааг Би мэднэ, гэхдээ Бурханы ариун байдлын талаар ярихдаа Би эхлээд Бурханы хийдэг үйл хэргийн тухай ярина. Та нар бүгд анхааралтай сонсох ёстой. Дараа нь Би та нараас Бурханы ариун байдал гэж яг юу болохыг асууна. Би та нарт шууд хэлэхгүй, харин оронд нь үүнийг бодож олох боломжийг та нарт олгож, үүнийг тунгаан бодох орон зайг та нарт үлдээнэ. Энэ аргыг юу гэж бодож байна вэ? (Сайн арга байна.) Тэгвэл анхааралтай сонсоорой.

Хүнд хийдэг зүйлээс нь Бурханы ариун байдлыг ойлгох нь

Сатан хүнийг завхруулж, эсвэл хүнд харгис хор хөнөөл учруулах болгонд Бурхан гар хумхин суудаггүй, мөн Өөрийн сонгосон хүмүүсийг үл тоомсорлож, хараагүй дүр үзүүлдэг ч үгүй. Сатаны хийдэг бүхнийг Бурхан тов тодорхой

ойлгодог. Сатан юу хийх нь хамаагүй, ямар чиг хандлага бий болгох нь хамаагүй, Сатаны хийхээр оролдож байгаа бүхнийг Бурхан мэддэг ба сонгосон хүмүүсээ хаядаггүй. Харин ч Бурхан огт анхаарал таталгүйгээр, нууцаар, чимээгүйхнээр, шаардлагатай бүхнийг хийдэг. Бурхан хэн нэгэн дээр ажиллаж эхлэх үедээ, хэн нэгнийг сонгосон үедээ энэ мэдээг хэнд ч зарладаггүй, Сатанд ч зарладаггүй, тэр ч бүү хэл ямар нэгэн томоохон дохио үзүүлдэггүй. Тэр ердөө тун чимээгүйхнээр, тун ердийн байдлаар шаардлагатай зүйлийг хийдэг. Эхлээд, Тэр чамд зориулсан гэр бүлийг сонгодог; гэр бүлийн чинь нөхцөл байдал, чиний эцэг эх, өвөг дээдэс—энэ бүхнийг Бурхан урьдчилан шийддэг. Өөрөөр хэлбэл, Бурхан эдгээр шийдвэрийг тэрхэн зуурт гаргадаггүй; харин ч Тэр энэ ажлыг аль эртнээс эхэлсэн. Бурхан чамд зориулсан гэр бүлийг сонгомогцоо төрөх хугацааг чинь сонгодог. Дараа нь Бурхан энэ дэлхийд уйлан төрөхийг чинь хардаг. Тэгээд төрөхийг чинь харж, анхны үгээ хэлэхийг чинь харж, бүдэрч, майжганан анхны алхмаа хийж, алхаж сурахыг чинь хардаг. Чи эхлээд нэг алхам, дараа нь өөр нэг алхмаа хийдэг—одоо чи гүйж, үсэрч харайж, ярьж, мэдрэмжээ илэрхийлж чадна… Хүмүүс өсөхийн хэрээр, бар олзоо ажигладагтай адилаар Сатаны харц хүн нэг бүр дээр тогтсон байдаг. Харин Өөрийн ажлыг хийхдээ Бурхан хүмүүс, үйл явдал, аливаа зүйлс, цаг хугацаа, орон зайн ямар нэгэн хязгаарлалтад хэзээ ч баригддаггүй; Тэр Өөрийн хийх хэрэгтэй, хийх ёстой зүйлийг хийдэг. Өсөх үйл явцдаа чи өвчин, бүтэлгүйтэл гэх мэт өөрт таалагдахгүй олон зүйлтэй тулгарч болох юм. Гэхдээ энэ замаар алхах зуур чиний амь, чиний ирээдүй Бурханы чанд хатуу анхаарал халамжинд байдаг. Бурхан бүх амьдралд чинь хүрэлцэх жинхэнэ баталгааг өгдөг, учир нь Тэр яг чиний хажууд, чамайг хамгаалж, харж хандаж байдаг билээ. Үүнийг мэдэлгүйгээр чи өсдөг. Чи шинэ зүйлстэй харилцаж эхэлдэг ба энэ дэлхий ертөнцийг, энэ хүн төрөлхтнийг мэдэж авч эхэлдэг. Чамд юм бүхэн шинэлэг, шинэ байдаг. Чамд хийх дуртай зүйл гэж бий. Чи хүн чанар дотроо амьдарч, өөрийн гэсэн орон зайд амьдардаг бөгөөд Бурханы оршин тогтнолыг өчүүхэн төдий ч ухамсарладаггүй. Харин чамайг өсөж байх зуур Бурхан алхам бүрд чамайг харж байдаг бөгөөд урагшлах алхмаа хийх бүрд чинь харж байдаг. Мэдлэгт суралцаж, эсвэл шинжлэх ухааныг судалж байх үед чинь ч гэсэн Бурхан чиний хажуугаас нэг алхам ч холдож байгаагүй. Чи бусад хүмүүсийн л адилаар, дэлхий ертөнцийг танин мэдэж, үүнтэй харилцах явцдаа өөрийн гэсэн туйлын зорилготой болж, өөрийн гэсэн хобби, сонирхолтой болж, бас асар их амбиц өвөрлөдөг. Чи ирээдүйгээ дандаа эргэцүүлж, ирээдүй чинь ямар харагдах ёстой тухай дүр зургийг дандаа зураглаж байдаг. Гэхдээ зам зуурт юу тохиолдох нь хамаагүй, Бурхан энэ бүхнийг тов тодорхой хардаг. Магадгүй чи өөрөө өнгөрсөн үеэ мартчихсан байж болох юм, харин Бурханы хувьд, чамайг Түүнээс илүү сайн ойлгож чадах өөр хэн ч үгүй. Чи Бурханы харцан дор амьдарч, өсөж бойжиж, нас бие гүйцдэг. Энэ хугацаанд Бурханы хийсэн хамгийн чухал зүйл бол хэний ч ухамсарлаж чадахгүй, хэний ч мэдэхгүй зүйл юм. Бурхан энэ талаар хэзээ ч хүмүүст хэлдэггүй нь мэдээж. Тэгвэл энэ хамгийн чухал зүйл юу вэ? Энэ

бол Бурхан хүнийг аварна гэдгийн баталгаа гэж хэлж болох юм. Энэ нь, Бурхан энэ хүнийг аврахаар шийдсэн бол үүнийг хийх ёстой гэсэн үг. Энэ нь хүн, Бурхан хоёрын аль алинд амин чухал билээ. Та нар юу болохыг нь мэдэх үү? Та нарт энэ талаар ямар ч мэдрэмж байхгүй, мөн энэ тухай ямар ч ойлголт байхгүй байгаа юм шиг байна, иймээс Би та нарт хэлж өгье. Чамайг төрсөн цагаас эхлээд одоог хүртэл Бурхан чам дээр маш их ажил хийсэн боловч Өөрийн хийсэн бүхнийг Тэр чамд нарийвчлан тайлагнадаггүй. Бурхан чамд үүнийг мэдэх боломж олгоогүй, мөн чамд хэлээгүй. Гэхдээ хүн төрөлхтний хувьд Түүний хийдэг бүхэн чухал. Бурханы тухайд гэвэл, энэ нь Түүний хийх ёстой зүйл юм. Түүний зүрх сэтгэлд байдаг Өөрийнх нь хийх ёстой ямар нэгэн чухал зүйл, энэ бүх зүйлээс хавьгүй илүү давдаг. Өөрөөр хэлбэл, хүнийг төрөхөөс эхлээд одоог хүртэл Бурхан аюулгүй байдлыг нь батлан даах ёстой. Эдгээр үгийг сонссоны дараа та нарт бүрэн ойлгохгүй байгаа мэт санагдаж магадгүй. “Аюулгүй байдал тийм чухал уу?” гэж асууж болох юм. Тэгвэл “аюулгүй байдал” гэдгийн үгчилсэн утга нь юу вэ? Магадгүй та нар үүнийг амар амгалан гэсэн утгатай гэж ойлгож байгаа, эсвэл магадгүй ямар нэгэн аюул, гамшиг хэзээ ч туулалгүйгээр, сайхан амьдарч, хэвийн амьдралаар амьдрах гэсэн утгатай гэж ойлгож байгаа. Гэхдээ зүрх сэтгэлдээ та нар энэ нь тийм ч энгийн биш гэдгийг мэдэж байх ёстой. Тэгвэл Бурханы хийх ёстой гэж Миний яриад байгаа энэ зүйл яг юу юм бэ? Аюулгүй байдал гэдэг нь Бурханы хувьд юу гэсэн үг вэ? Энэ нь үнэхээр “аюулгүй байдлыг” баталгаажуулах явдал уу? Үгүй. Тэгвэл Бурханы хийдэг зүйл юу юм бэ? Энэхүү “аюулгүй байдал” нь чи Сатанд залгиулахгүй гэсэн үг. Энэ нь чухал уу? Сатанд залгиулахгүй байх гэдэг нь чиний аюулгүй байдалтай холбоотой юу, үгүй юу? Тийм ээ, энэ нь хувийн аюулгүй байдалтай чинь холбоотой бөгөөд үүнээс илүү чухал зүйл гэж үгүй. Сатанд залгиулмагц сүнс болон махан бие чинь Бурханд харьяалагдахаа больдог. Бурхан чамайг аврахаа болино. Сатанд залгиулсан сүнснүүд болон хүмүүсийг Бурхан хаядаг. Иймээс Бурханы хийх учиртай хамгийн чухал зүйл бол чиний аюулгүй байдлыг баталгаажуулах, чамайг Сатанд залгиулахгүй байлгах явдал юм гэж Би хэлдэг. Энэ нь маш чухал, тийм биз? Тэгвэл та нар яагаад хариулж чадахгүй байна вэ? Та нар Бурханы агуу нинжин сэтгэлийг мэдэрч чаддаггүй юм шиг байна!

Бурхан хүмүүсийн аюулгүй байдлыг баталгаажуулж, тэднийг Сатанд залгиулахгүй байхаас гадна хавьгүй их ажил хийдэг. Тэр бас хэн нэгнийг сонгож, аврахын өмнө асар их бэлтгэл ажил хийдэг. Юун түрүүнд, чи ямар зан ааштай байх, ямар гэр бүлд төрөх, эцэг эх чинь хэн байх, хэдэн ах эгч, дүүтэй байх, төрсөн гэр бүлийн чинь байдал, эдийн засгийн байдал ямар байх, гэр бүлийн чинь нөхцөл ямар байх талаар Бурхан нягт нямбай бэлтгэл хийдэг. Бурханы сонгосон хүмүүсийн дийлэнх нь ямархуу гэр бүлд төрдгийг та нар мэдэх үү? Тэдгээр нь алдар цуутай гэр бүл байдаг уу? Тийм гэр бүлд төрсөн хүн нэг ч байхгүй гэж бид итгэлтэйгээр хэлж чадахгүй. Байж магадгүй боловч тэр нь тун цөөхөн. Тэрбумтан, олон саяын хөрөнгөтэй хүн гэх мэтийн хосгүй эд хөрөнгөтэй гэр бүлүүдэд тэд төрдөг үү? Үгүй,

ийм гэр бүлд бараг хэзээ ч төрдөггүй. Тэгвэл Бурхан энэ хүмүүсийн дийлэнхэд зориулж ямархуу гэр бүлийг зохицуулдаг вэ? (Жирийн гэр бүлүүдийг.) Тэгвэл ямар гэр бүлүүдийг “жирийн” гэж тооцож болох вэ? Үүнд ажилчин гэр бүлүүд буюу амьдрахын тулд цалиндаа түшиглэдэг, үндсэн хэрэгцээгээ хангаж чаддаг, тийм ч чинээлэг бус гэр бүлүүд багтдаг; үүнд бас тариачин гэр бүлүүд багтдаг. Тариаланчид хоол хүнсэндээ зориулж тариа тарихад түшиглэдэг ба идэх тариа будаатай, өмсөх хувцас хунартай байдаг болохоор өлсдөггүй, эсвэл даарч хөрдөггүй. Тэгээд бас жижиг бизнес ажиллуулдаг зарим гэр бүл байдаг, заримынх нь эцэг эх сэхээтнүүд байдаг бөгөөд эдгээрийг ч бас жирийн гэр бүл гэж тооцож болно. Түүнчлэн зарим нь албан хаагч, эсвэл доогуур зиндааны төрийн албан хаагч эцэг эхтэй байдаг ба тэднийг бас л алдар цуутай гэр бүл гэж тооцож болохгүй. Ихэнх нь жирийн гэр бүлд төрдөг бөгөөд үүнийг бүгдийг нь Бурхан зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, юуны өмнө амьдарч байгаа энэхүү орчин чинь хүмүүсийн төсөөлдөг хөрөнгө мөнгөтэй чинээлэг гэр бүл биш, харин чиний төлөө Бурханы шийдсэн гэр бүл бөгөөд хүмүүсийн дийлэнх нь ийм гэр бүлийн хязгаар дотор амьдардаг. Тэгвэл нийгмийн байр суурийн хувьд ямар вэ? Дийлэнх эцэг эхийн эдийн засгийн байдал дундаж байдаг бөгөөд тэдэнд нийгмийн өндөр байр суурь байдаггүй—тэдний хувьд ердөө ажилтай байх нь л хангалттай. Тэдэн дунд засаг дарга байдаг уу? Эсвэл улсын ерөнхийлөгч байдаг уу? Байдаггүй биз дээ? Хамгийн ихдээ л тэд жижиг бизнесийн менежер, эсвэл жижиг бизнесийн эзэд гэх мэтийн хүмүүс байдаг. Тэдний нийгмийн байр суурь дунд зэргийн, эдийн засгийн нөхцөл байдал нь дундаж байдаг. Өөр нэг хүчин зүйл бол гэр бүлийн амьдрах орчин юм. Юун түрүүнд, эдгээр гэр бүлийн дотор, мэргэ төлгө болон заяа төөрөг мэргэлэх замаар алхахад нь хүүхдүүддээ илтэд нөлөөлөх ямар ч эцэг эх байдаггүй; тийм зүйл хийдэг хүмүүс тун цөөхөн байдаг. Ихэнх эцэг эхчүүд нэлээд энгийн байдаг. Бурхан хүмүүсийг сонгохын зэрэгцээ тэдэнд зориулан ийм орчныг бэлддэг нь хүмүүсийг аврах Түүний ажилд асар их ач тустай юм. Гаднаа, хүний төлөө Бурхан тэнгэр газрыг донсолгосон юу ч хийгээгүй мэт харагддаг; Тэрээр Өөрийн хийдэг бүхнийг зүгээр л сэмхэн, нууцаар, даруухнаар, чимээгүйхэн хийдэг. Гэвч үнэн хэрэгтээ, Бурханы хийдэг бүхэн чиний авралын төлөөх суурийг тавьж, урдах замыг чинь бэлдэж, чиний аврал хэрэгтэй бүх нөхцөлийг бэлдэхийн тулд хийгддэг. Дараа нь, тодорхой товлогдсон хугацаанд Бурхан хүн бүрийг Өөрийнхөө өмнө авчирдаг: Тэр үед л чи Бурханы дуу хоолойг сонсдог; тэр үед л чи Түүний өмнө очдог. Үүнийг тохиолдох үед зарим хүн өөрсдөө аль хэдийн эцэг эх болсон байдаг байхад бусад нь зүгээр л хэн нэгний хүүхэд хэвээр байдаг. Өөрөөр хэлбэл, зарим хүн гэрлэж, үр хүүхдүүдтэй болсон байхад зарим нь хараахан гэр бүлээ эхлээгүй, ганц бие хэвээр байдаг. Гэхдээ хүний нөхцөл байдлаас үл хамааран, Бурхан сонгогдох цагийг чинь болон Өөрийнх нь сайн мэдээ болон үг чамд хүрэх цагийг аль хэдийн тогтоочихсон. Бурхан чамд үгээ сонсгох гэсэндээ тодорхой орчныг тогтоож, чамд сайн мэдээ дамжуулах тодорхой хүн юм уу тодорхой нөхцөлийг

шийддэг. Бурхан чиний төлөө шаардлагатай бүх нөхцөлийг аль хэдийн бэлдсэн. Ийм маягаар хүн өөрийн мэдэлгүй Бурханы өмнө очиж, Бурханы гэрт буцан очдог. Түүнчлэн хүн өөрийн мэдэлгүй Бурханыг дагаж, Түүний ажлын алхам бүрд орж, хүний төлөө бэлдсэн Бурханы ажлын арга барилын алхам бүрд ордог. Энэ хугацаанд хүний төлөө юм хийхдээ Бурхан ямар арга зам ашигладаг вэ? Эхлээд, хамгийн наад зах нь хүний эдэлдэг Бурханы халамж, хамгаалалт юм. Үүнээс гадна, Бурхан янз бүрийн хүмүүс, үйл явдал болон зүйлсийг бэлдэж, тэдгээрээр дамжуулан хүн Түүний оршин тогтнол болон үйл хэргийг хүнд харуулдаг. Жишээ нь, гэр бүлийнх нь хэн нэгэн өвчтэй болохоор Бурханд итгэдэг зарим хүн байдаг. Бусад нь сайн мэдээ түгээхэд тэд Бурханд итгэж эхэлдэг бөгөөд Бурханд итгэх энэхүү итгэл нь нөхцөл байдлын улмаас бий болдог. Тэгвэл энэ нөхцөл байдлыг хэн зохицуулсан бэ? (Бурхан.) Энэ өвчнөөр дамжуулан зарим гэр бүл бүгдээрээ итгэдэг байхад заримд нь тун цөөхөн хүн л итгэдэг. Гаднаа, танай гэр бүлийн нэг нь өвчин эмгэгтэй харагддаг боловч үнэн хэрэгтээ энэ нь чамд өгөгдсөн, Бурханы өмнө ирж болох нөхцөл юм—энэ бол Бурханы нинжин сэтгэл билээ. Зарим хүний хувьд гэр бүлийн амьдрал хүнд хэцүү бөгөөд тэд ямар ч амар амгаланг олж чаддаггүй учраас санаандгүй боломж гарч ирж, хэн нэгэн хүн сайн мэдээ дамжуулан, “Эзэн Есүст итгэ, тэгвэл чи амар амгалан болно” хэмээн хэлдэг. Тиймээс, өөрийн мэдэлгүй тэд тун хэвийн орчин нөхцөлд Бурханд итгэж эхэлдэг, тэгвэл энэ нь нэг төрлийн нөхцөл байдал биш гэж үү? Гэр бүл нь амар тайван биш байх нь Бурханаас хайрласан нигүүлсэл бус уу? Өөр шалтгааны улмаас Бурханд итгэж эхэлдэг зарим хүн ч байдаг. Өөр өөр шалтгаан, өөр өөр маягийн итгэл байдаг боловч ямар шалтгаан чамайг Бурханд итгүүлсэн нь хамаагүй, үүнийг үнэн хэрэгтээ Бурхан зохицуулж, залж чиглүүлж байдаг. Эхлээд Бурхан чамайг сонгож, Өөрийн гэрт авчрахын тулд янз бүрийн арга зам ашигладаг. Энэ бол хүн нэг бүрд Бурханы хайрладаг нигүүлсэл билээ.

Эцсийн өдрүүдийн ажлын одоогийн үе шатанд Бурхан урьдынхтайгаа адилаар хүнд цаашид зөвхөн нигүүлсэл, ерөөл хайрлахгүй, мөн хүнийг урагш явуулахын тулд аргадах ч үгүй. Ажлын энэ үе шатанд өөрийнхөө туулсан Бурханы ажлын бүх талаас хүн юу харсан бэ? Хүн Бурханы хайр, Бурханы шүүлт, гэсгээлтийг харсан. Энэ хугацаанд Бурхан, хүнд аажмаар Өөрийнхөө санаа зорилгыг мэдүүлэхийн тулд, Өөрийнхөө хэлдэг үг болон хүнд өгдөг үнэнийг мэдүүлэхийн тулд хүнийг хангаж, дэмжиж, гэгээрүүлж, залж чиглүүлдэг. Хүнийг сул дорой, сэтгэлээр унасан, хаашаа ч явах аргагүй байх үед Бурхан хүнд зөвлөж, хүнийг тайтгаруулж, зоригжуулахын тулд Өөрийн үгийг ашигладаг, ингэснээр биеийн хэмжээ багатай хүн аажмаар хүч чадалтай болж, эерэгээр өндийн босож, Бурхантай хамтран ажиллахад бэлэн болдог. Гэхдээ хүн Бурханд дуулгаваргүй хандаж, Түүнийг эсэргүүцэх үед, эсвэл завхралаа илчлэх үед Бурхан ямар ч өршөөл үзүүлэлгүйгээр хүнийг цээрлүүлж, сахилгажуулна. Гэхдээ, Бурхан хүний тэнэглэл, мэдлэггүй, сул дорой, төлөвшөөгүй байдалд хүлээцтэй, тэвчээртэй хандана. Ийм маягаар, хүний

төлөө Бурханы хийдэг бүх ажлаар дамжуулан хүн аажмаар төлөвшиж, өсөж, Бурханы санаа зорилгыг мэдэж, тодорхой нэг үнэнийг ойлгож, ямар зүйл эерэг, ямар нь сөрөг болохыг мэдэж, ёрын муу, харанхуй гэж юу болохыг мэдэж авдаг. Бурхан хүнийг үргэлж цээрлүүлж, сахилгажуулах ганцхан хандлага баримталдаггүй, гэхдээ бас үргэлж хүлээцтэй, тэвчээртэй ханддаггүй. Харин үүний оронд Тэр өөр өөр үе шатных нь дагуу, өөр өөр биеийн хэмжээ болон хэв чанарынх нь дагуу хүн нэг бүрийг өөр өөр арга замаар хангадаг. Тэр хүний төлөө олон зүйл хийж, асар их төлөөс төлдөг; хүн эдгээр зүйлийг, эсвэл энэхүү төлөөсийг огт ухамсарладаггүй ч Бурханы хийдэг бүхэн үнэндээ хүн нэг бүр дээр үнэхээр хийгддэг. Бурханы хайр бодитой: Бурханы нигүүлслээр дамжуулан хүн гай гамшгаас ахин дахин зайлсхийдэг, тэр бүх хугацаанд Бурхан хүний сул дорой байдалд ахин дахин хүлээцтэй ханддаг. Бурханы шүүлт, гэсгээлт нь хүмүүст, хүн төрөлхтний завхрал болон сатанлаг мөн чанарыг аажмаар мэдэж авах боломж олгодог. Бурханы хангадаг зүйлс, хүнийг гэгээрүүлэх Түүний гэгээрэл, удирдамж нь бүгд, үнэний мөн чанарыг улам бүр ойлгож, хүмүүст юу хэрэгтэй, тэд ямар замаар явах ёстой, тэд юуны төлөө амьдардаг, амьдралынх нь утга учир, үнэ цэн болон урдах замаараа хэрхэн алхах зэргийг улам бүр ойлгох боломжийг хүмүүст олгодог. Бурханы хийдэг энэ бүх зүйл Түүний анхдагч нэгэн зорилгоос салшгүй юм. Тэгвэл энэ зорилго нь юу вэ? Бурхан хүн дээр ажлаа хэрэгжүүлэхдээ яагаад эдгээр арга барилыг ашигладаг вэ? Тэр ямар үр дүнд хүрэхийг хүсдэг вэ? Өөрөөр хэлбэл, Тэр хүнээс юу харахыг хүсдэг вэ? Мөн тэднээс юу авахыг хүсдэг вэ? Хүний сэтгэлийг сэрээж болно гэдгийг Бурхан харахыг хүсдэг. Хүн дээр ажиллахдаа Түүний ашигладаг эдгээр арга барил нь хүний зүрх сэтгэлийг сэрээж, хүний сүнсийг сэрээж, хаанаас ирснийг нь, хэн тэднийг чиглүүлж, дэмжиж, хангаж байдгийг, мөн хэн тэдэнд өдий хүртэл амьдрах боломж олгосныг хүнд ойлгуулах гэсэн байнгын хүчин чармайлт билээ; тэдгээр нь Бүтээгч хэн болохыг, хэнд шүтэн мөргөх ёстойг, ямар замаар алхах ёстойг, ямар замаар Бурханы өмнө очих ёстойг хүнд ойлгуулах арга зам юм; тэдгээр нь хүнд Бурханы зүрх сэтгэлийг мэдүүлж, Бурханы зүрх сэтгэлийг ойлгуулж, хүнийг аврах Түүний ажлын ар дахь асар их халамж, санаа бодлыг ухааруулахын тулд хүний зүрх сэтгэлийг аажмаар сэргээх арга зам юм. Зүрх сэтгэл нь сэргэх үед хүн доройтсон, завхарсан зан чанартайгаар амьдрахыг хүсэхээ больж, харин оронд нь Бурханыг сэтгэл хангалуун байлгахын төлөө үнэнийг эрэлхийлэхийг хүсдэг. Хүний зүрх сэтгэл сэрчихсэн байх үед хүн Сатанаас бүрмөсөн салж чаддаг. Тэрээр Сатанд хорлогдохоо больж, түүнд хянуулж, хууртахаа больдог. Харин ч хүн Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд Бурханы ажил болон үгэнд идэвх санаачилгатайгаар хамтран ажиллаж, улмаар Бурханаас эмээж, муугаас зайлдаг. Энэ бол Бурханы ажлын анхдагч зорилго юм.

Сатаны ёрын муугийн талаар бидний дөнгөж сая ярьсан яриа, хүн асар аз жаргалгүй байдалд амьдардаг ба хүний амьдрал золгүй явдлаар хүрээлэгдсэн байдаг гэж хүн бүрд санагдуулдаг. Харин одоо Намайг Бурханы ариун байдал

болон хүн дээр хийдэг ажлынх нь тухай ярих үед та нарт ямар санагдаж байна вэ? (Маш баяртай байна.) Бурханы хийдэг бүхэн, хүний төлөө Түүний уйгагүй зохицуулдаг бүхэн алдаа мадаггүй байдгийг бид одоо харж болно. Бурханы хийдэг бүхэн ямар ч алдаа мадаггүй байдаг, өөрөөр хэлбэл, энэ нь алдаагүй, хэн ч үүнийг засаж, үүнд зөвлөгөө өгч, ямар нэгэн өөрчлөлт хийх хэрэггүй байдаг. Хүн нэг бүрийн төлөө Бурханы хийдэг бүхэн ямар ч эргэлзээгүй; Тэр хүн бүрийг гараас нь хөтөлж, урсан өнгөрөх хором бүрд чамайг харж хамгаалдаг бөгөөд хажуугаас чинь хэзээ ч холдоогүй. Хүмүүс ийм төрлийн орчинд, ийм нөхцөл байдалд өсдөг тул хүмүүс үнэн хэрэгтээ Бурханы гарт өсдөг гэж хэлж болох уу? (Болно.) Тэгвэл одоо та нарт арга барагдсан мэт санагдсаар л байна уу? Хэн нэгэн сэтгэлээр унасан хэвээр байна уу? Бурхан хүн төрөлхтнийг орхисон мэт хэн нэгэнд санагдаж байна уу? (Үгүй.) Тэгвэл Бурхан яг юу хийсэн юм бэ? (Тэр хүн төрөлхтнийг хараа хяналтдаа байлгасан.) Бурхан хийдэг бүхэндээ асар их бодол, сэтгэлээ зориулдаг нь маргаангүй. Үүнээс гадна, Бурхан Өөрийн ажлыг хийхдээ үргэлж ямар ч болзолгүйгээр хийсэн. Чамаар Өөртөө гүнээ талархуулахын тулд чиний төлөө төлсөн төлөөсийг нь мэд гэж Тэр та нарын хэнээс ч, хэзээ ч шаардаагүй. Бурхан ингэж ер нь шаардаж байсан уу? (Үгүй.) Хүний амьдралын урт удаан замналд, бараг хүн бүр аюултай олон нөхцөл байдалтай тулгарч, олон уруу таталттай нүүр тулсан. Учир нь Сатан харцаа чам дээр байнга тогтоон, чиний хажууд зогсож байгаа. Чамайг гай зовлон нэрвэхэд Сатан баясдаг; чамд гай гамшиг тохиолдоход, бүх юм чинь бүтэлгүйтэхэд, чамайг Сатаны урхинд орооцолдоход, Сатан эдгээр зүйлээс асар их таашаал авдаг. Бурханы хийж байгаа зүйлийн тухайд бол, Тэр чамайг хором бүрд хамгаалж, нэгээс нөгөө золгүй явдлаас, нэгээс нөгөө гай гамшгаас зайлсхийлгэж байгаа. Ийм учраас хүнд байдаг бүхэн—амар амгалан болон баяр хөөр, ерөөл хийгээд хувийн аюулгүй байдал нь—бүгд үнэндээ Бурханы хяналтан дор байдаг; Тэрээр хүн нэг бүрийн хувь заяаг залж чиглүүлж, шийдэж байдаг гэж Би хэлдэг. Гэхдээ зарим хүний хэлдгээр Өөрийн байр суурийн талаар хэт хөөрөгдсөн үзэл Бурханд байдаг уу? Бурхан чамд “Би бол бүгдээс агуу. Би л та нарыг хариуцдаг. Та нар Надаас өршөөл гуйх ёстой, дуулгаваргүй байвал үхлээр шийтгэнэ” гэж хэлдэг үү? Бурхан хүн төрөлхтнийг ийм маягаар ер нь сүрдүүлж байсан уу? (Үгүй.) “Хүн төрөлхтөн завхарсан, иймээс Би тэдэнд яаж ч хандсан хамаагүй, тэдэнд яаж ч хандаж болно; Би тэдний төлөө сайн зохицуулалт хийх хэрэггүй” гэж Тэр ер нь хэлсэн үү? Бурхан ийм маягаар боддог уу? Бурхан ийм маягаар үйлдсэн үү? (Үгүй.) Эсрэгээрээ, хүн нэг бүрд хандах Бурханы хандлага чин үнэнч агаад хариуцлагатай байдаг. Тэрээр өөртөө ханддагаас чинь ч илүү хариуцлагатайгаар чамд ханддаг. Тийм биш гэж үү? Бурхан дэмий ярьдаггүй, Өөрийнхөө өргөмжлөгдсөн байр сууриар гайхуулдаг ч үгүй, эсвэл хөнгөн хийсвэрээр хүмүүсийг мэхэлдэг ч үгүй. Үүний оронд Тэр үнэнчээр, чимээгүйхнээр Өөрийнхөө хийх хэрэгтэй зүйлийг хийдэг. Эдгээр зүйл нь хүнд ерөөл, амар амгалан, баяр хөөр авчирдаг. Тэдгээр нь хүнийг Бурханы харц руу, Түүний гэр лүү

амар амгалан, аз жаргалтайгаар аваачдаг; тэгээд тэд хэвийн эрүүл ухаан, сэтгэхүйтэйгээр Бурханы өмнө амьдарч, Бурханы авралыг хүлээн зөвшөөрдөг. Тэгвэл Бурхан ер нь Өөрийнхөө ажилд хүнд хоёр нүүр гаргасан уу? Тэр хэзээ нэгэн цагт хуурамчаар нинжин сэтгэл харуулж, чихэнд чимэгтэй хэдхэн үгээр хүнийг хуураад, дараа нь хүнээс нүүр буруулж байсан уу? (Үгүй.) Бурхан ер нь нэг зүйл хэлчихээд дараа нь өөрийг хийж байсан уу? Бурхан ер нь хоосон амлалт өгч, бардамнаж, тэдний төлөө үүнийг хийнэ, эсвэл түүнийг хийхэд чинь тусална гэж хэлээд дараа нь сураггүй алга болж байсан уу? (Үгүй.) Бурханд ямар ч ов мэх, ямар ч хуурамч байдал байдаггүй. Бурхан бол итгэмжит бөгөөд хийдэг бүхэндээ үнэнч байдаг. Тэр бол хүмүүсийн найдаж болох Нэгэн, мөн өөрсдийн амьдралыг болон өөрсдөдөө байгаа бүхнийг даатгаж болох Бурхан юм. Бурханд ямар ч ов мэх байдаггүй тул Бурхан бол хамгийн чин үнэнч гэж хэлж болох уу? (Болно.) Мэдээж болно! Хэдийгээр “чин үнэнч” гэдэг үгийг Бурханд хэрэглэхэд хэтэрхий өчүүхэн, хэтэрхий хүнлэг байдаг ч бид өөр ямар үг ашиглах юм бэ? Энэ нь хүний хэлний хязгаар юм. Бурханыг “чин үнэнч” гэж хэлэх нь бага зэрэг тохиромжгүй боловч одоохондоо бид ямартай ч энэ үгийг ашиглана. Бурхан бол итгэмжит агаад чин үнэнч. Тэгвэл эдгээр талын тухай ярихдаа бид юуг хэлж байна вэ? Бид Бурхан болон хүний хоорондох ялгаа, мөн Бурхан болон Сатаны хоорондох ялгааг хэлж байна уу? Тийм ээ, тэгж хэлж болно. Яагаад гэвэл, хүн Сатаны завхарсан зан чанарын нэг ч ул мөрийг Бурханаас харж чадахгүй. Ингэж хэлж байгаа минь зөв үү? Амен? (Амен!) Сатаны ёрын муу зан чанарын аль нь ч Бурханаас харагддаггүй. Бурханы хийдэг, илчилдэг бүхэн хүнд бүхэлдээ ач тустай, нэмэртэй байдаг, мөн бүхэлдээ хүнийг хангахын тулд хийгддэг, амиар дүүрэн байдаг бөгөөд хүнд дагах зам болон явах чиглэлийг өгдөг. Бурхан завхарсан биш, түүнчлэн Бурханы хийдэг бүхнийг одоо хараад Бурхан бол ариун гэж хэлж болох уу? Бурханд хүн төрөлхтний завхарсан зан чанарын юу ч байдаггүй, мөн завхарсан хүн төрөлхтний сатанлаг мөн чанартай адилхан юу ч байдаггүй, энэ үзэл бодлын үүднээс бид Бурхан бол ариун гэж хэлж болно. Бурхан ямар ч завхрал харуулдаггүй ба ажиллах явцдаа Өөрийн мөн чанарыг илчилдэг нь Бурхан Өөрөө ариун гэдгийг бүрэн баталдаг. Та нар үүнийг ойлгож байна уу? Бурханы ариун мөн чанарыг мэдэхийн тулд одоохондоо энэ хоёр талыг харцгаая: Нэгдүгээрт, Бурханд завхарсан зан чанарын ямар ч ул мөр байдаггүй, хоёрдугаарт, хүн дээрх Бурханы ажлын мөн чанар нь, Бурханы Өөрийн мөн чанарыг болон энэхүү мөн чанар нь бүхэлдээ эерэг гэдгийг харах боломжийг хүнд олгодог. Учир нь Бурханы ажлын хэсэг бүрийн хүнд авчирдаг зүйлс нь бүгд эерэг байдаг. Юун түрүүнд Бурхан хүнээс үнэнч байхыг шаарддаг—энэ нь эерэг зүйл биш гэж үү? Бурхан хүнд мэргэн ухаан өгдөг—энэ нь эерэг биш гэж үү? Бурхан хүнийг сайн, мууг ялгах чадвартай болгодог—энэ нь эерэг биш гэж үү? Тэр хүний амьдралын утга учир, үнэ цэнийг ойлгох боломжийг хүнд олгодог—энэ нь эерэг биш гэж үү? Тэрээр, хүмүүс, үйл явдал болон аливаа зүйлсийн мөн чанарыг үнэний дагуу тодорхой харах боломжийг хүнд олгодог—энэ

нь эерэг бус уу? Тийм ээ. Энэ бүхний үр дүнд хүн Сатанд хууртахаа больж, Сатанд үргэлжлүүлэн хорлогдохоо, эсвэл хянагдахаа больдог. Өөрөөр хэлбэл, эдгээр зүйл нь өөрсдийгөө Сатаны завхралаас бүрмөсөн чөлөөлж, тэгснээрээ Бурханаас эмээж, муугаас зайлах замаар аажмаар алхах боломжийг хүмүүст олгодог. Та нар энэ замаар одоо хэр хол алхсан бэ? Үүнийг хэлэхэд хэцүү, тийм биз? Гэхдээ ядаж л та нар одоо Сатан хүнийг хэрхэн завхруулдаг, ямар зүйлс нь ёрын муу, ямар зүйл нь сөрөг болох тухай анхан шатны ойлголттой болсон уу? Та нар одоо ядаж л амьдралын зөв замаар алхаж байна. Тэгж хэлж болох уу? Яг болно.

Бурханы ариун байдлын тухай нөхөрлөх ёстой нэг зүйл бий. Өөрсдийн сонсож, хүлээж авсан бүхэндээ үндэслээд Бурханы ариун байдал гэж юу болохыг та нарын хэн чинь хэлж чадах вэ? Миний ярьдаг Бурханы ариун байдал нь юуг хэлдэг вэ? Энэ тухай хэсэг зуур бодоод үз. Бурханы ариун байдал нь Түүний үнэн зөв байдал мөн үү? Бурханы итгэмжит байдал нь Түүний ариун байдал мөн үү? Бурханы аминч бус байдал нь Түүний ариун байдал мөн үү? Бурханы даруу байдал нь Түүний ариун байдал мөн үү? Хүнийг гэсэн Бурханы хайр Түүний ариун байдал мөн үү? Бурхан үнэн болон амийг хүнд чөлөөтэй хайрладаг—энэ нь Түүний ариун байдал уу? Бүгдээрээ мөн. Бурханы илчилдэг энэ бүхэн цор ганц бөгөөд завхарсан хүмүүсийн дотор оршдоггүй, мөн хүмүүсээс ч харагддаггүй. Үүний өчүүхэн төдий ул мөрийг, хүнийг завхруулах Сатаны үйл явцын үеэр, Сатаны завхарсан зан чанараас ч, Сатаны мөн чанар, уг чанараас ч харж чадахгүй. Бурханд байгаа бүхэн болон Тэр юу болох бүхэн нь цор ганц; Зөвхөн Бурхан Өөрөө л ийм мөн чанартай бөгөөд Тэр л үүнийг эзэмшдэг. Энэ хүртэл ярилцахад, та нараас хэн нэг чинь Миний дөнгөж сая дүрсэлсэн шиг ариун хүнийг хүн төрөлхтний дундаас харж байсан уу? (Үгүй.) Тэгвэл та нарын шүтэн биширдэг шүтээн, алдартай, агуу хүмүүсийн дунд ийм ариун хүн байдаг уу? (Үгүй.) Тэгэхээр Бурханы ариун байдал нь цор ганц гэж хэлэх үед энэ нь хэтрүүлэг мөн үү? Үнэндээ тийм биш. Түүнчлэн, Бурханы ариун цор ганц байдалд ч бас бодитой тал бий. Миний одоо ярьж байгаа ариун байдал болон урьд нь та нарын бодож, төсөөлж байсан ариун байдлын хоорондямар нэгэн ялгаа байна уу? (Байна.) Маш их ялгаа бий. Хүмүүс ариун байдлын тухай ярихдаа ихэвчлэн юуг хэлдэг вэ? (Гадаад талын зарим нэг үйлдэл.) Үйлдэл, эсвэл ямар нэгэн зүйлийг ариун гэж хэлэх үедээ хүмүүс үүнийг цэвэрхэн, мэдрэхэд тааламжтай гэж хардаг учраас л ингэж хэлдэг. Гэхдээ эдгээр зүйлд ариун байдлын бодит гол чанар үргэлж дутагддаг—энэ бол хоосон сургаалын нэг тал юм. Үүнээс гадна, оюун ухаандаа хүмүүсийн төсөөлдөг ариун байдлын бодитой тал гэдгээр юуг хэлдэг вэ? Энэ нь ихэнхдээ тэдний төсөөлдөг, эсвэл мөн гэж үнэлдэг зүйл байдаг бус уу? Жишээ нь, зарим Буддын шашинтан дадлагажих явцдаа нас эцэслэж, суугаагаараа унтаж байх зуураа нас бардаг. Зарим хүн тэднийг ариун болоод, тэнгэр лүү одсон гэж хэлдэг. Энэ нь ч бас төсөөллийн үр дүн юм. Тэгтэл тэнгэрээс доош хөөрөн бууж буй дагина бол ариун гэж боддог зарим хүн бий. Үнэндээ, “ариун” хэмээх үгийн талаарх хүмүүсийн ойлголт зүгээр л нэг төрлийн хий

хоосон төсөөлөл, онол төдий байж, үндсэндээ ямар ч бодит мөн чанаргүй, түүнчлэн ариун байдлын мөн чанартай ямар ч хамаагүй байсаар ирсэн. Ариун байдлын мөн чанар нь жинхэнэ хайр юм, гэхдээ үүнээс ч илүүтэйгээр энэ нь үнэн, зөвт байдал болон гэрлийн мөн чанар билээ. “Ариун” хэмээх үгийг зөвхөн Бурханд хэрэглэх нь л зохистой; бүтээлийн юу ч “ариун” хэмээн нэрлэгдэхүйц биш. Хүн үүнийг ойлгох ёстой. Одооноос эхлээд “ариун” хэмээх үгийг бид зөвхөн Бурханд л хэрэглэнэ. Энэ нь зохистой юу? (Тийм ээ, зохистой.)

Хүнийг завхруулахдаа Сатаны хэрэглэдэг заль мэх

Сатан хүнийг завхруулахдаа ямар аргуудыг хэрэглэдэг тухай яриандаа одоо буцан орцгооё. Бид дөнгөж сая хүн дээр ажилладаг Бурханы янз бүрийн арга замын тухай ярилцсан бөгөөд үүнийг та нар дор бүрнээ өөрсдөө туулж болно, иймээс Би хэтэрхий их дэлгэрэнгүй ярихгүй. Гэхдээ зүрх сэтгэлдээ магадгүй та нар, хүнийг завхруулахдаа Сатан ямар арга заль, ов мэх хэрэглэдгийг тодорхой мэддэггүй, эсвэл ядаж л тэдгээрийг тодорхой ойлгодоггүй. Би энэ талаар дахин ярих нь ашиг тустай юу? Та нар энэ талаар мэдэж авахыг хүсэж байна уу? Магадгүй та нарын зарим нь: “Яагаад Сатаны тухай дахиад ярина гэж? Сатаныг дурдах мөчид бид уурладаг, түүний нэрийг сонсох үедээ бид тун тавгүйтдэг” гэж асууна. Энэ нь та нарыг хэчнээн их тавгүйтүүлэх нь хамаагүй, та нар баримтуудтай нүүр тулах ёстой. Хүний ойлголтод тус болохын төлөө эдгээр зүйлийг тодорхой хэлж, ойлгомжтой болгох ёстой; эс бөгөөс хүн үнэхээр Сатаны нөлөөнөөс ангижирч чадахгүй.

Бид өмнө нь, Сатан хүнийг завхруулдаг таван арга замыг хэлэлцсэн, энэ нь Сатаны заль мэхийг агуулдаг. Хүнийг завхруулдаг Сатаны арга замууд нь ердөө гаднах давхарга; хамгийн хорлонтой нь энэхүү гадаад талын цаана нуугдаж байгаа арга заль бөгөөд тэдгээрийг ашиглаад Сатан зорилгодоо хүрдэг. Эдгээр заль мэх нь юу вэ? Алив, нэгтгэн дүгнэ дээ. (Тэр хуурч, уруу татаж, айлган сүрдүүлдэг.) Та нар хэдий чинээ их заль мэх жагсаана, төдий чинээ ойртоно. Та нар Сатанд гүнээ хорлогдсон бөгөөд энэ сэдвийн талаар хүчтэй мэдрэмжтэй байгаа мэт харагдаж байна. (Тэр бас уран үг ашигладаг. Тэгээд хүмүүст нөлөөлж, тэднийг хүчээр эзлэн авдаг.) Хүчээр эзлэн авдаг—энэ нь тун гүн сэтгэгдэл төрүүлдэг. Хүмүүс Сатанд хүчээр эзлүүлэхээс айдаг. Өөр заль мэх бий юу? (Тэр хүмүүсийг хэрцгийгээр хорлож, заналхийлж, хорхой хүрэм санал тавьж, худлаа ярьдаг.) Худал хэлэх нь түүний хийдэг зүйлсийн нэг юм. Сатан чамайг хуурахын тулд худлаа ярьдаг. Худлаа ярихын шинж чанар нь юу вэ? Худлаа ярих нь хуурахтай адилхан биш гэж үү? Худлаа ярихын зорилго нь үнэндээ чамайг хуурахын төлөө байдаг. Өөр заль мэх байна уу? Өөрсдийн мэддэг Сатаны заль мэхийг бүгдийг нь Надад хэл. (Тэр уруу татаж, хорлож, хуурч, мэхэлдэг.) Та нарын ихэнх нь энэхүү хууран мэхлэлтийн тухайд адилхан бодолтой байгаа. Өөр байна уу? (Тэр хүнийг хянаж, хүнээс тавихгүй зуурч, хүнийг айлган сүрдүүлж, Бурханд итгүүлдэггүй.) Би та нарын хэлж

байгаа зүйлийг ерөнхийд нь мэднэ, сайн байна. Та нар бүгд энэ талаар ямар нэгэн юм мэдэж байна, тэгвэл одоо эдгээр заль мэхийг нэгтгэн дүгнэцгээе.

Хүнийг завхруулахдаа Сатаны хэрэглэдэг зургаан үндсэн заль мэх бий

Эхнийх нь хяналт ба албадлага. Өөрөөр хэлбэл, Сатан зүрх сэтгэлийг чинь хянахын тулд боломжтой бүхнийг хийнэ. “Албадлага” гэж юу гэсэн үг вэ? Энэ нь, заналхийлэл болон албадсан тактик ашиглан өөрийгөө чамаар дуулгавартай дагуулж, дуулгавартай байхгүй бол ямар үр дагаварт хүрэх талаар чамд бодогдуулна гэсэн үг юм. Чи айж, түүнийг эсэргүүцэж зүрхэлдэггүй, ингээд чи түүнд захирагддаг.

Хоёр дахь нь хуурах болон зальдах. “Хуурах болон зальдах” гэж юуг хэлдэг вэ? Сатан зарим нэг түүх, худал яриа зохиож, чамайг зальдан тэдгээрт итгүүлдэг. Хүнийг Бурхан бүтээсэн гэж тэр хэзээ ч чамд хэлэхгүй, гэхдээ чамайг Бурхан бүтээгээгүй гэж ч бас шууд хэлэхгүй. Тэр “Бурхан” гэдэг үгийг огтхон ч хэрэглэдэггүй, харин оронд нь өөр ямар нэгэн зүйлийг орлуулан ашиглаж, чамайг мэхлэхийн тулд энэ зүйлийг ашигладаг, ингэснээр чи Бурханы оршин тогтнолын талаар үндсэндээ ямар ч ойлголтгүй байдаг. Энэ “заль” нь мэдээж ганцхан үүгээр зогсохгүй, өөр олон талыг агуулдаг.

Гурав дахь нь хүчээр итгүүлэн үнэмшүүлэх. Хүмүүсийг юугаар хүчээр үнэмшүүлдэг вэ? Хүчээр итгүүлэн үнэмшүүлэх нь хүний өөрийн сонголтоор хийгддэг үү? Энэ нь хүний зөвшөөрөлтэйгөөр хийгддэг үү? Огтхон ч үгүй. Чи зөвшөөрдөггүй байсан ч гэсэн, яаж ч чадахгүй. Мэдээгүй байхад чинь Сатан чамайг үнэмшүүлж, өөрийн үзэл санаа, амьдралын дүрэм журам болон мөн чанарыг чамд суулгадаг.

Дөрөв дэх нь сүрдүүлж, залилах. Өөрөөр хэлбэл, Сатан янз бүрийн заль мэх ашиглан чамаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж, дагуулж, өөртөө үйлчлүүлдэг. Тэгээд зорилгодоо хүрэхийн тулд юу ч хийнэ. Заримдаа тэр чамд бага сага ач тус үзүүлж, тэгэнгээ чамайг уруу татан нүгэл үйлдүүлдэг. Хэрвээ чи түүнийг дагахгүй бол, тэр чамайг зовоож, шийтгэх бөгөөд чам руу дайрч давшлан, чиний эсрэг хуйвалдахын тулд янз бүрийн арга зам ашиглана.

Тав дахь нь мэхлэлт болон саажилт. “Мэхлэлт болон саажилт” гэдэг нь, Сатан хүмүүсийн үзэлтэй нийцдэг, үнэмшилтэй санагддаг чихэнд чимэгтэй үг яриа, үзэл санааг хүмүүст суулгаж, хүмүүсийн махан биеийг анхааран үзэж байгаа мэт, эсвэл тэдний амьдрал болон ирээдүйг бодож байгаа мэт санагдуулдаг, гэвч үнэндээ түүний цорын ганц зорилго нь чамайг хуурах явдал юм. Тэр дараа нь чамайг мэдээгүй болгодог, ингэснээр чи юу нь зөв, юу нь буруу болохыг мэдэлгүй, өөрийн мэдэлгүй мэхлэгдэж, улмаар түүний хяналтан дор ордог.

Зургаа дахь нь бие, сэтгэлийн сүйрэл. Сатан хүний ямар хэсгийг сүйрүүлдэг вэ? Сатан оюун санааг чинь сүйрүүлж, чамайг эсэргүүцэх тэнхэлгүй болгодог нь зүрх

сэтгэл чинь бага багаар өөрийн эрхгүй Сатан руу эргэдэг гэсэн үг юм. Тэр эдгээр зүйлийг чамд өдөр бүр суулгадаг, мөн чамд нөлөөлж, чамайг хүмүүжүүлэхийн тулд эдгээр үзэл санаа болон соёлыг өдөр бүр ашиглан, чиний хүсэл зоригийг бага багаар сулруулж, эцэст нь чамайг сайн хүн байх хүсэлгүй болгож, “зөв шударга байдал” гэж нэрлэдэг зүйлийнхээ төлөө өндийн босох хүсэлгүй болгодог. Өөрийн мэдэлгүйгээр чи цаашид урсгал сөрөн сэлэх сэтгэлийн тэнхээгүй болж, харин оронд нь урсгал даган хөвдөг. “Сүйрэл” гэдэг нь Сатан хүмүүсийг маш их тарчилгадаг болохоор тэд хүн байхаа больж, сүг сүүдэр л болдог гэсэн үг юм. Энэ үед Сатан завшааныг далимдуулан тэднийг залгидаг.

Хүнийг завхруулахдаа Сатаны хэрэглэдэг эдгээр заль мэх нь тус бүрдээ хүнийг эсэргүүцэх тэнхээгүй болгож чадна; тэдгээрийн аль нь ч хүмүүсийг үхэлд хүргэж чадна. Өөрөөр хэлбэл, Сатаны хийдэг ямар ч зүйл, түүний хэрэглэдэг ямар ч заль мэх чамайг доройтуулж, Сатаны хяналтан дор аваачиж, ёрын муу болон нүглийн намагт шигдүүлж чадна. Энэ нь хүнийг завхруулахдаа Сатаны хэрэглэдэг заль мэх юм.

Бид Сатаныг ёрын муу гэж хэлж болно, гэхдээ үүнийг батлахын тулд Сатан хүнийг завхруулсны үр дагавар юу болохыг болон тэрээр хүнд ямар зан чанар, мөн чанар авчирдгийг бид мөн л харах ёстой. Та нар бүгд бага зэрэг мэднэ, иймээс энэ талаар ярьцгаа. Сатан хүмүүсийг завхруулахын үр дагавар юу вэ? Тэд ямар завхарсан зан чанарыг илэрхийлж, илчилдэг вэ? (Биеэ тоосон ба ихэмсэг, аминч агаад жигшүүртэй, шударга бус агаад зальжин, муу санаатай агаад хорлонтой, ямар ч хүн чанаргүй.) Ерөнхийдөө тэдэнд ямар ч хүн чанар байхгүй гэж хэлж болно. Тэгвэл бусад ах эгч нараар яриулъя. (Хүнийг Сатан завхруулмагц тэд ерөнхийдөө биеэ тоосон, өөрийгөө зөвтгөдөг, өөрийгөө чухалчилдаг, ихэмсэг, шуналтай, аминч байдаг. Эдгээр нь хамгийн ноцтой асуудал гэж надад санагддаг.) (Сатан хүмүүсийг завхруулсны дараа тэд материаллаг зүйл болон эд хөрөнгө олж авахын тулд яахаас ч буцдаггүй. Тэгээд бүр Бурханд дайсагнаж, Бурханыг эсэргүүцэж, Бурханд дуулгаваргүй ханддаг бөгөөд хүнд байх учиртай мөс чанар, эрүүл ухаанаа алддаг.) Та нарын хэлсэн зүйл бүгд үндсэндээ адилхан, ердөө бага зэргийн л ялгаатай байна; заримынх чинь л бага зэрэг дэлгэрэнгүй байна. Дүгнэж хэлэх юм бол, завхарсан хүмүүсийн тухайд хамгийн их товойн гарч ирдэг зүйл бол биеэ тоосон, зальжин, хорлонтой, аминч зан юм. Гэхдээ та нар бүгд нэг адилхан зүйлийг орхигдууллаа. Хүмүүс мөс чанаргүй, эрүүл ухаанаа алдсан, ямар ч хүн чанаргүй—гэхдээ та нарын хэний ч дурдаагүй бас нэгэн тун чухал зүйл бий. Энэ нь “урвалт” юм. Сатанаар завхруулагдмагц ямар ч хүнд оршин байдаг эдгээр зан чанарын эцсийн үр дагавар нь Бурханаас урвах урвалт билээ. Бурхан хүмүүст юу хэлдэг нь, эсвэл тэдэн дээр ямар ажил хийдэг нь хамаагүй, тэд үнэн гэж мэддэг зүйлээ анхаардаггүй. Өөрөөр хэлбэл, тэд Бурханы хүлээн зөвшөөрөхөө больж, Түүнээс урвадаг; энэ бол Сатан хүнийг завхруулсны үр дагавар юм. Хүний бүх завхарсан зан чанарын хувьд энэ нь адилхан. Хүнийг завхруулахдаа Сатаны ашигладаг арга

замуудын дунд—хүмүүсийн суралцдаг мэдлэг, тэдний мэддэг шинжлэх ухаан, ойлгодог мухар сүсэг, уламжлалт соёл болон нийгмийн чиг хандлагын дунд—юу нь зөв шударга, юу нь зөв шударга бус болохыг мэдэхдээ хүний ашиглаж болох ямар нэгэн зүйл байдаг уу? Юу нь ариун, юу нь ёрын муу болохыг мэдэхэд хүнд тусалж чадах ямар нэгэн зүйл байдаг уу? Эдгээр зүйлийг хэмжих ямар нэгэн стандарт байдаг уу? (Үгүй.) Хүнд тусалж чадах ямар ч стандарт, ямар ч үндэслэл байдаггүй. Хүмүүс “ариун” хэмээх үгийг мэддэг байлаа ч гэсэн, юу ариун болохыг үнэхээр мэддэг нэг ч хүн үгүй. Тэгвэл Сатаны хүнд авчирдаг эдгээр зүйл үнэнийг мэдэхэд нь хүнд тусалж чадах уу? Тэдгээр нь илүү их хүн чанартайгаар амьдрахад нь хүнд тусалж чадах уу? Бурханд улам их шүтэн мөргөж чаддаг байдлаар амьдрахад нь хүнд тусалж чадах уу? (Үгүй.) Тэдгээр нь, Бурханд шүтэн мөргөж, үнэнийг ойлгоход хүнд тусалж чадахгүй, мөн ариун байдал болон ёрын муу юу болохыг мэдэхэд нь ч тусалж чадахгүй нь илэрхий юм. Эсрэгээрээ хүн улам бүр доройтож, Бурханаас улам бүр холддог. Сатаныг ёрын муу гэж хэлдгийн маань цаад шалтгаан энэ юм. Сатаны маш их ёрын муу гол чанарыг задлан шинжилчхээд та нар түүний гол чанараас, эсвэл түүний мөн чанарын талаарх ойлголтоосоо, Сатанд ариун байдлын ямар нэгэн элемент байхыг харсан уу? (Үгүй.) Тэр бол мэдээж. Тэгвэл Сатаны мөн чанарын ямар нэг тал Бурханыхтай адил төстэй байхыг харсан уу? (Үгүй.) Сатаны ямар нэгэн илэрхийлэл Бурханыхтай адил төстэй байдаг уу? (Үгүй.) Тэгвэл одоо, Би та нараас ингэж асуумаар байна: Та нарын үгээр бол, Бурханы ариун байдал гэж яг юу вэ? Юун түрүүнд, “Бурханы ариун байдлыг” юутай холбоотойгоор хэлдэг вэ? Үүнийг Бурханы мөн чанартай холбоотойгоор хэлдэг үү? Эсвэл Түүний зан чанарын зарим талтай холбоотойгоор хэлдэг үү? (Үүнийг Бурханы мөн чанартай холбоотойгоор хэлдэг.) Бид хүссэн сэдэвтээ хүрэхийн тулд гол цэгээ тодорхой тогтоох ёстой. Эдгээр үгийг Бурханы мөн чанартай холбоотойгоор хэлдэг. Юуны өмнө, бид Сатаны ёрын мууг Бурханы мөн чанарыг товойлгогч болгон ашигласан, тэгвэл чи Сатаны ямар нэгэн мөн чанарыг Бурханаас олж харсан уу? Хүн төрөлхтний ямар нэг мөн чанарыг харсан уу? (Үгүй, хараагүй. Бурхан биеэ тоосон, аминчхан биш, бас урвадаггүй бөгөөд үүнээс бид Бурханы ариун мөн чанар илчлэгдэхийг хардаг.) Өөр нэмэх юм байна уу? (Бурханд Сатаны завхарсан зан чанарын ямар ч ул мөр байдаггүй. Сатанд байдаг зүйл бүхэлдээ сөрөг байхад Бурханд байгаа зүйл бүхэлдээ эерэг байдаг. Биднийг тун жаахан байхаас одоог хүртэл, бүхий л амьдралын маань туршид, ялангуяа будилж, замаа алдсан үед маань Бурхан үргэлж бидний хажууд байж, биднийг харж хандаж, хамгаалж байсныг харж болно. Бурханд ямар ч ов мэх, хууран мэхлэлт байдаггүй. Тэр тун тодорхой, ойлгомжтой ярьдаг ба энэ ч бас Бурханы жинхэнэ мөн чанар юм.) Тун сайн байна! (Бид Бурханаас Сатаны ямар ч завхарсан зан чанарыг, ямар ч хоёр нүүр, ямар ч бардамнал, ямар ч хоосон амлалт, ямар ч ов мэхийг хардаггүй. Бурхан бол хүний итгэж болох Нэгэн. Бурхан итгэмжит агаад чин үнэнч. Бурхан хүмүүст үнэнч бай гэж хэлж, тэдэнд мэргэн ухаан өгөөд, сайн мууг ялгаж, янз

бүрийн хүмүүс, үйл явдал болон зүйлсийг ялган таних чадвартай болгодгийг бид Бурханы ажлаас харж болно. Үүнээс бид Бурханы ариун байдлыг харж чаддаг.) Та нар дуусав уу? Та нар хэлсэн зүйлдээ сэтгэл хангалуун байна уу? Зүрх сэтгэлд чинь Бурханы тухай ойлголт үнэндээ хэр их байна вэ? Мөн Бурханы ариун байдлыг хэр их ойлгож байна вэ? Та нар дор бүрнээ зүрх сэтгэлдээ зарим нэг түвшний танин мэдэхүйн ойлголттой байгаа гэдгийг Би мэднэ, учир нь өөрсөд дээр нь хийгддэг Бурханы ажлыг хүн бүр мэдэрч чаддаг ба янз бүрийн хэмжээнд Бурханаас олон зүйлийг олж авдаг; хүн нигүүлсэл ерөөл, гэгээрэл, гэрэлтүүлэлт болон Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авдаг ч бай, эдгээр зүйлээс үүдэн Бурханы мөн чанарын талаар зарим нэгэн энгийн ойлголттой болдог.

Өнөөдөр бидний хэлэлцэж байгаа Бурханы ариун байдал ихэнх хүмүүст танил бус санагдаж болох хэдий ч, үүнээс үл хамааран бид энэ сэдвийг эхэлсэн бөгөөд урьд чинь байгаа замаар алхангаа та нар илүү гүнзгий ойлголттой болно. Энэ нь, өөрийнхөө туршлагаар аажмаар мэдэрч, ойлгохыг та нараас шаарддаг. Одоохондоо Бурханы мөн чанарын талаарх танин мэдэхүйн ойлголт чинь үүнийг мэдэж авч, баталж, мэдэрч, туулахад мөн л удаан хугацаа шаардана, тэгээд нэг л өдөр, “Бурханы ариун байдал” гэдэг нь Бурханы мөн чанар өө сэвгүй, Бурханы хайр аминч бус, Бурханы хүнд өгдөг бүхэн аминч бус гэсэн утгатай гэдгийг та нар зүрх сэтгэлийнхээ гүнээс мэдэх бөгөөд Бурханы ариун байдал нь өө сэвгүй, гэм зэмгүй гэдгийг мэдэж авна. Бурханы мөн чанарын эдгээр тал нь Өөрийн ялгамж чанараа гайхуулахын тулд Түүний хэрэглэдэг үг төдийхөн биш, харин ч Бурхан хүн нэг бүртэй чимээгүйхнээр, чин сэтгэлээсээ харьцахын тулд Өөрийн мөн чанарыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, Бурханы мөн чанар дэмий хоосон биш, мөн онол буюу ягшмал сургаал ч биш, бас нэг төрлийн мэдлэг биш гэдэг нь гарцаагүй. Энэ нь хүнд зориулсан нэг төрлийн боловсрол биш; харин ч энэ нь Бурханы Өөрийн үйлдлийн жинхэнэ илчлэл, Бурханд юу байгаа, Тэр юу болохыг илчилсэн мөн чанар билээ. Бурханы хийдэг бүхэн, хэлдэг үг болгон хүн нэг бүрд асар их үнэ цэнтэй, асар их ач холбогдолтой учраас хүн энэ мөн чанарыг мэдэж, ойлгох ёстой. Бурханы ариун байдлыг ойлгож эхлэх үедээ чи Бурханд үнэхээр итгэж чадна; Бурханы ариун байдлыг ойлгож эхлэх үедээ чи “Цор ганц Бурхан Өөрөө” гэдэг үгийн жинхэнэ утга учрыг үнэхээр ухаарч чадна. Чи үүнээс өөр замыг сонгоод алхаж болно гэж төсөөлөхөө болих бөгөөд чамд зориулан Бурханы зохицуулсан бүхнээс урвахыг хүсэхээ болино. Бурханы мөн чанар ариун учраас зөвхөн Бурханаар л дамжуулан чи амьдралын гэрэл гэгээтэй, зөв замаар алхаж чадна; зөвхөн Бурханаар л дамжуулан амьдралын утга учрыг мэдэж чадна; Бурханаар л дамжуулан жинхэнэ хүн чанарыг амьдран харуулж, үнэнийг эзэмшиж, мэдэж чадна. Бурханаар л дамжуулан чи үнэнээс амийг олж авч чадна. Бурхан Өөрөө л муугаас зайлахад чинь чамд тусалж, Сатаны хор хөнөөл, хяналтаас чамайг ангижруулж чадна. Чамайг дахин зовоохгүйн тулд Бурханаас өөр хэн ч, юу ч чамайг зовлонгийн далайгаас аварч чадахгүй. Энэ нь Бурханы мөн чанараар тодорхойлогддог. Зөвхөн

Бурхан Өөрөө л чамайг амь бие хайрлалгүй авардаг; эцсийн эцэст Бурхан л ирээдүй, хувь заяа, амьдралыг чинь хариуцдаг бөгөөд бүх зүйлийг чиний төлөө зохицуулдаг. Энэ нь бүтээгдсэн, эсвэл бүтээгдээгүй ямар ч зүйлийн хүрч чадахгүй зүйл юм. Учир нь бүтээгдсэн, эсвэл бүтээгдээгүй юу ч Бурханых шиг мөн чанарыг эзэмшдэггүй, иймээс ямар ч хүн, эсвэл зүйлд чамайг аврах, удирдан хөтлөх чадвар байхгүй. Энэ бол Бурханы мөн чанарын хүнд өгдөг чухал ач холбогдол юм. Миний хэлсэн эдгээр үг зарчмын хувьд бага зэрэг тусалж болох юм шиг та нарт санагдаж байж магадгүй. Гэхдээ хэрвээ чи үнэнийг эрэлхийлдэг бол, хэрвээ чи үнэнийг хайрладаг бол эдгээр үг хувь заяаг чинь өөрчлөөд зогсохгүй, үүнээс ч илүүтэйгээр хүний амьдралын зөв замд чамайг аваачина гэдгийг чи туршлагаараа мэдрэх болно. Үүнийг ойлгож байгаа биз дээ? Тэгвэл одоо та нар Бурханы мөн чанарыг мэдэхээр сонирхож байна уу? (Тийм.) Сонирхож байгаа чинь сайн. Бурханы ариун байдлыг мэдэх тухай нөхөрлөлийн сэдвээ өнөөдөртөө ингээд дуусгая.

*　　*　　*

Өнөөдрийн цугларалтын эхэнд та нарын хийсэн, Намайг гайхшруулсан зүйлийн талаар Би та нартай яримаар байна. Та нарын зарим нь магадгүй талархлын мэдрэмж өвөрлөж байсан, эсвэл талархаж байсан байх, иймээс сэтгэл хөдлөл чинь тийм үйлдэл хийсэн. Хийсэн юм чинь зэмлэх шаардлагатай зүйл биш; энэ нь зөв ч биш, бас буруу ч биш. Гэхдээ Би та нарт нэг зүйлийг ойлгуулмаар байна. Миний ойлгуулахыг хүсээд байгаа зүйл юу вэ? Эхлээд, Би дөнгөж сая хийсэн зүйлийн чинь талаар та нараас асуумаар байна. Та нар нүүрээрээ газар унан мөргөж байсан уу, эсвэл шүтэн мөргөхөөр өвдөг сөгдөж байсан уу? Надад хэлж өгөх хүн байна уу? (Нүүрээрээ газар унан мөргөж байсан гэж бодож байна.) Энэ нь нүүрээрээ газар унан мөргөх явдал байсан гэж та нар итгэж байна, тэгвэл нүүрээрээ газар унан мөргөхийн утга учир юу вэ? (Шүтэн мөргөх.) Тэгвэл шүтэн мөргөхөөр өвдөг сөгдөх нь юу юм бэ? Би өмнө нь та нартай энэ талаар нөхөрлөөгүй, харин өнөөдөр энэ сэдвийг та нартай нөхөрлөх шаардлагатай гэж санагдаж байна. Та нар ердийн цугларалтууд дээрээ нүүрээрээ газар унан мөргөдөг үү? (Үгүй.) Залбирах болгондоо нүүрээрээ газар унан мөргөдөг үү? (Тийм.) Нөхцөл байдал бүрдвэл та нар залбирах болгондоо нүүрээрээ газар унан мөргөдөг үү? (Тийм.) Сайн байна. Гэхдээ Бурхан хоёр төрлийн хүний сөхрөхийг л хүлээн зөвшөөрдөг гэдгийг Би өнөөдөр та нарт ойлгуулахыг хүсэж байна. Бид Библи юм уу аливаа сүнслэг хүмүүсийн биеэ авч явах байдлыг лавлаж үзэх хэрэггүй. Харин Би одоо та нарт нэг үнэн юм хэлье. Юун түрүүнд, нүүрээрээ газар унан мөргөх болон шүтэн мөргөхийн тулд өвдөг сөгдөх нь адилхан зүйл биш. Яагаад Бурхан нүүрээрээ газар унан мөргөдөг хүмүүсийн сөхрөхийг хүлээн зөвшөөрдөг вэ? Яагаад гэвэл Бурхан хэн нэгнийг Өөр лүүгээ дуудаж, Бурханы даалгаврыг хүлээн зөвшөөрөхийг энэ хүнд тушаадаг, иймээс Өөрийнх нь өмнө нүүрээрээ газар унан мөргөхийг түүнд

зөвшөөрдөг. Энэ нь эхний төрлийн хүн юм. Хоёр дахь төрөл нь Бурханаас эмээж, муугаас зайлдаг хүн шүтэн мөргөхдөө өвдөг сөгдөх. Ердөө ийм хоёр төрлийн л хүн байдаг. Тэгвэл та нар аль төрөлд нь харьяалагддаг вэ? Та нар хэлж чадах уу? Хэдий мэдрэмжийг чинь бага зэрэг шархлуулж магадгүй ч энэ бол үнэн юм. Залбирах үедээ хүмүүс сөхөрдөг тухайд хэлэх юм юу ч алга—энэ нь зүй зохистой бөгөөд ийм л байх учиртай, учир нь хүмүүс залбирах үедээ ихэвчлэн ямар нэг юмны төлөө залбирч, зүрх сэтгэлээ Бурханд нээж, Түүнтэй нүүр тулан уулздаг. Энэ нь Бурхантай хийсэн чин сэтгэлийн харилцан яриа, хөөрөө юм. Өвдөг сөгдөн шүтэн мөргөх нь ёс төдий зүйл байх ёсгүй. Би өнөөдрийн хийсэн зүйлийн чинь төлөө та нарыг зэмлэх гэсэнгүй. Зүгээр л энэ зарчмыг ойлгуулах гэсэндээ та нарт үүнийг ойлгомжтой болгох гэсэн юм—үүнийг мэдэж байгаа биз дээ? (Тийм ээ, бид мэднэ.) Би та нарт хэлсэн болохоор ийм зүйл дахиад тохиолдохгүй. Тэгвэл, Бурханы өмнө нүүрээрээ газар унан мөргөж, өвдөг сөгдөх ямар нэгэн боломж хүмүүст байдаг уу? Ийм боломж хэзээ ч байдаггүй юм биш. Эрт орой хэзээ нэгэн цагт тэр өдөр ирнэ, гэхдээ тэр цаг нь одоо биш. Та нар ойлгов уу? Энэ нь та нарыг гуниглуулж байна уу? (Үгүй.) Сайн байна. Магадгүй эдгээр үг та нарыг зоригжуулж, эсвэл урамшуулна, ингэснээр та нар зүрх сэтгэлдээ Бурхан, хүн хоёрын хоорондох одоогийн байдлыг болон одоо тэдний хооронд ямар төрлийн харилцаа оршин байгааг мэдэж чадна. Хэдийгээр бид саяхан ярилцаж, дахиад жаахан хэлэлцсэн боловч Бурханы талаарх хүний мэдлэг ер хангалтгүй байсаар байгаа. Бурханыг ойлгохоор эрэлхийлэх энэ замд хүний хийх юм бас л их байна. Та нараар үүнийг яаралтай хийлгэх юм уу ийм хүсэл эрмэлзэл, мэдрэмжийг илэрхийлэхээр яарах нь Миний санаа зорилго биш. Өнөөдөр хийсэн зүйл чинь жинхэнэ мэдрэмжийг чинь харуулж, илэрхийлж байгаа байх, Би үүнийг мэдэрсэн. Иймээс үүнийг хийж байх үед чинь Би зүгээр л босож зогсоод та нарт сайн сайхныг хүсмээр байна, учир нь Би та нарыг бүгдээрээ сайн байгаасай гэж хүсдэг. Иймээс, та нарыг бүх зүйлийн талаар зөв зүйтэй ойлголт, зөв зүйтэй үзэл бодолтой байгаасай гэсэндээ Би Өөрийн үг, үйлдэл бүрээр та нарт тусалж, та нарыг залж чиглүүлэхийн тулд боломжтой бүхнийг хийдэг. Та нар үүнийг ойлгож чадна биз дээ? (Тийм.) Сайн байна. Хэдийгээр хүмүүс Бурханы янз бүрийн зан чанар, Бурханд юу байдаг, Тэр юу болохын талууд болон Бурханы хийдэг ажлын талаар зарим нэг ойлголттой байдаг ч энэхүү ойлголтын дийлэнх нь үгийг өнгөцхөн уншиж, зарчмын хувьд ойлгож, эсвэл ердөө тэдгээрийн талаар бодохоос хэтэрдэггүй. Хүмүүст хамгийн их дутагдаж байдаг зүйл нь бодит туршлагаас гарсан жинхэнэ ойлголт, мэдлэг ухаан юм. Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлийг сэрээхийн тулд янз бүрийн арга ашигладаг хэдий ч үүнийг гүйцэлдэхээс өмнө хийх зүйл мөн л маш их байна. Бурхан ганцааранг нь орхисон мэт, өөрсдийг нь хаяж, нүүр буруулсан мэт хэн нэгэнд санагдахыг Би хармааргүй байна. Харин хүн бүр үнэнийг эрэлхийлж, Бурханыг ойлгохоор эрж хайсан замаар гуйвшгүй шийдвэртэйгээр, ямар ч эргэлзээ тээнэгэлзэл, ачаа дарамтгүйгээр урагшаа зоримог алхаж байгааг л харахыг хүсэж

байна. Чи ямар буруу зүйл үйлдсэн нь хамаагүй, замаа алдаад хэр хол явсан чинь, эсвэл хэр ноцтой гэм нүгэл үйлдсэн чинь хамаагүй, эдгээрийг Бурханыг ойлгох эрэл хайгуулдаа үүрэх ачаа, илүүдэл тээш бүү болго. Үргэлжлүүлэн урагш алх. Бурхан хүний авралыг цаг ямагт зүрх сэтгэлдээ байлгадаг; энэ нь хэзээ ч өөрчлөгддөггүй. Энэ бол Бурханы мөн чанарын хамгийн эрхэм нандин хэсэг юм. Та нарт одоо арай дээр санагдаж байна уу? (Тийм.) Та нар бүх зүйл дээр болон Миний ярьсан үгэнд зөв хандлага баримталж чадна гэж Би найдаж байна. Энэ нөхөрлөлөө энд ингээд дуусгацгаая. Баяртай!

2014 оны 1 дүгээр сарын 11

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ VII
БУРХАН БОЛ БҮХ ЗҮЙЛИЙН АМИЙН ЭХ СУРВАЛЖ (I)

Бурханы эрх мэдэл, Бурханы зөвт зан чанар, Бурханы ариун байдлын тухай тойм

Залбирч дууссаны дараа зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тогтуун тайван байдаг уу? (Тэгдэг.) Зүрх сэтгэл нь тогтуун тайван болж чаддаг бол хүн Бурханы үгийг сонсож, ойлгож чадах бөгөөд үнэнийг сонсож, ойлгож чадна. Харин зүрх сэтгэл чинь тогтуун тайван болж чаддаггүй бол, зүрх сэтгэл чинь үргэлж урсгал даган хөвж, эсвэл үргэлж өөр юм боддог бол Бурханы үгийг сонсохоор цуглаанд оролцоход энэ байдал чинь нөлөөлнө. Тэгэхээр бидний одоо ярилцаж байгаа зүйлийн гол цөм нь юу вэ? Гол сэдвээ эргээд жаахан бодъё. Цор ганц Бурханыг Өөрийг нь мэдэх тухайд бол, эхний хэсэгт бид Бурханы эрх мэдлийг хэлэлцсэн. Хоёр дахь хэсэгт бид Бурханы зөвт зан чанарыг хэлэлцсэн бөгөөд Бурханы ариун байдлыг гурав дахь хэсэгт хэлэлцсэн. Тухай бүрд бидний хэлэлцсэн онцгой агуулга та нарт сэтгэгдэл төрүүлсэн үү? “Бурханы эрх мэдэл” гэдэг эхний хэсгээс юу та нарт хамгийн гүн сэтгэгдэл үлдээсэн бэ? Аль хэсэг нь та нарт хамгийн их нөлөөлсөн бэ? (Бурхан эхлээд Бурханы үгийн эрх мэдэл, сүр хүчний тухай ярьсан; Бурхан хэлсэн үгэндээ хүрдэг ба Түүний үг биелнэ. Энэ бол Бурханы төрөлх мөн чанар.) (Иовыг сорьж болох боловч амийг нь авч болохгүй гэж Бурхан Сатанд тушаасан. Үүнээс бид Бурханы үгийн эрх мэдлийг хардаг.) Өөр нэмэх зүйл байна уу? (Бурхан тэнгэр, газар болон тэдгээрийн доторх бүх зүйлийг бүтээхийн тулд үг ашигласан бөгөөд хүнтэй гэрээ байгуулж, хүнд ерөөл хайрлахын тулд үг хэлдэг. Эдгээр нь бүгд Бурханы үгийн эрх мэдлийн жишээ юм. Түүнчлэн, булшнаасаа алхан гарч ирэхийг Эзэн Есүс Лазарт тушаасныг бид харсан, энэ нь хүний амьдрал, үхэл Бурханы хяналтан дор байдаг бөгөөд Сатанд амьдрал, үхлийг хянах хүч үгүй, Бурханы ажил махбод, эсвэл Сүнсний алинаар ч хийгдсэн бай, Түүний эрх мэдэл цор ганц гэдгийг харуулдаг.) Нөхөрлөл сонссоныхоо дараа та нар ийм ойлголт авсан. Бурханы эрх мэдлийн тухай ярьж байхад та нар “эрх мэдэл” гэдэг үгийг хэрхэн ойлгож байна? Бурханы эрх мэдлийн хүрээнд, Бурханы хийдэг болон илчилдэг зүйлээс хүмүүс юу хардаг вэ? (Бид Бурханы төгс хүчин, мэргэн ухааныг хардаг.) (Бурханы эрх мэдэл үргэлж байдаг бөгөөд үнэхээр оршин байдгийг бид хардаг. Бурханы эрх мэдлийг өргөн хүрээнд харвал Тэр бүх зүйлийг захирдаг, харин бага цар хүрээнд харвал Тэр хүн бүрийн амьдралыг хянадаг. Бурхан үнэндээ амьдралын зургаан онцгой үеийг төлөвлөж, хянадаг. Түүнээс гадна, Бурханы эрх мэдэл цор ганц Бурханыг Өөрийг нь төлөөлдөг ба бүтээгдсэн, бүтээгдээгүй зүйлсээс юу ч үүнийг эзэмшиж чадахгүй гэдгийг бид хардаг. Бурханы эрх мэдэл нь Түүний ялгамж чанарыг бэлгэддэг.) “Бурханы ялгамж чанар болон Бурханы байр суурийн бэлгэдэл” гэж хэлэхийг бодоход та нар энэ үгсийн талаар ягшмал ойлголттой бололтой. Та нарт

Бурханы эрх мэдлийн тухай үндсэн ойлголт байна уу? (Биднийг жаахан байхаас эхлээд Бурхан биднийг харж хандаж, хамгаалж ирсэн, үүнээс бид Бурханы эрх мэдлийг хардаг. Биднийг отсон аюулыг бид мэддэггүй, гэтэл Бурхан нууцаар биднийг үргэлж хамгаалж байсан; энэ ч бас Бурханы эрх мэдэл.) Маш сайн. Сайхан хэллээ.

Бурханы эрх мэдлийн тухай ярих үед гол зүйл, гол санаа нь юу вэ? Бид үүнийг яагаад хэлэлцэх хэрэгтэй вэ? Үүнийг хэлэлцэх эхний зорилго бол Бурханы Бүтээгч хэмээх ялгамж чанар болон бүх зүйлийн дундах Түүний байр суурийг хүмүүсийн зүрх сэтгэлд тогтоох явдал юм. Энэ бол хүмүүсийн эхлээд мэдэж, харж, мэдэрч чадах зүйл билээ. Чиний хардаг, мэдэрдэг зүйлс нь Бурханы үйлдэл, Бурханы үг, бүх зүйлийг хянах Бурханы хяналтаас үүсэлтэй. Тэгвэл Бурханы эрх мэдлээр дамжуулан харж, сурч, мэддэг бүхнээсээ хүмүүс ямар жинхэнэ ойлголтыг олж авдаг вэ? Бид эхний зорилгоо хэлэлцчихлээ. Хоёр дахь нь Бурханы хийсэн, хэлсэн ба эрх мэдлээрээ хянасан бүхнээр нь дамжуулан хүмүүст Бурханы хүч чадал, мэргэн ухааныг ойлгох боломж олгох явдал юм. Бүхнийг хянахдаа Бурхан хэчнээн хүчирхэг, хэчнээн мэргэн ухаалаг байдгийг чамд ойлгуулах явдал юм. Бидний өмнө нь хэлэлцсэн Бурханы цор ганц эрх мэдлийн гол санаа, гол анхаарах зүйл энэ биш байсан гэж үү? Уг нь нэг их хугацаа өнгөрөөгүй атал зарим чинь үүнийг мартчихсан байгаа нь та нар Бурханы эрх мэдлийн талаар гүнзгий ойлголт олж аваагүйг баталдаг. Хүн Бурханы эрх мэдлийг хараагүй гэж хэлсэн ч болохоор байна. Одоо та нар жаахан ч гэсэн ойлгож байна уу? Бурханы эрх мэдлийг бодит үйлдэл дээр харахдаа чи үнэхээр юу мэдэрдэг вэ? Бурханы хүч чадлыг үнэхээр мэдэрсэн үү? (Тэгсэн.) Бурхан бүх зүйлийг хэрхэн бүтээсэн тухай Бурханы үгийг уншихдаа чи Түүний хүч чадлыг мэдэрдэг, Түүний бүхнийг чадагч байдлыг мэдэрдэг. Бурхан хүмүүсийн хувь заяаг захирдгийг харахдаа чи юу мэдэрдэг вэ? Түүний хүч чадал, мэргэн ухааныг мэдэрдэг үү? Хэрвээ Бурхан энэ хүч чадлыг эзэмшээгүй байсан бол, энэ мэргэн ухааныг эзэмшээгүй байсан бол бүх зүйлийг ноёрхож, хүмүүсийн хувь заяаг захирч чадах байсан уу? Бурханд тийм хүч чадал, мэргэн ухаан бий, иймээс Түүнд эрх мэдэл байдаг. Энэ бол цор ганц. Бүх бүтээлийн дунд Бурханых шиг хүч чадалтай ямар нэгэн хүн ч юм уу, амьтныг чи ер нь харсан уу? Тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээж, түүнчлэн тэднийг удирдаж, ноёрхох хүч чадалтай хэн нэгэн юм уу ямар нэг зүйл бий юу? Бүх хүн төрөлхтнийг захирч, дагуулж чадах, хэдийд ч хаа сайгүй байж чадах ямар нэг хүн, ямар нэг зүйл бий юу? (Үгүй, байхгүй.) Одоо та нар Бурханы цор ганц эрх мэдлийн жинхэнэ утга учрыг ойлгож байна уу? Та нар бага зэрэг ойлголттой болов уу? (Тэглээ.) Ингээд Бурханы цор ганц эрх мэдлийн тухай сэдвийг эргэн харж дууслаа.

Хоёр дахь хэсэгт бид Бурханы зөвт зан чанарын тухай ярьсан. Бид энэ сэдвээр олон зүйлийг хэлэлцээгүй, яагаад гэвэл, энэ үе шатан дахь Бурханы ажил үндсэндээ шүүлт, гэсгээлтээс бүрддэг. Хаанчлалын эрин үед Бурханы зөвт зан чанар тодорхой бөгөөд маш дэлгэрэнгүй илчлэгдсэн. Тэрээр бүтээлийн цаг үеэс

хойш огт хэлж байгаагүй үгийг хэлсэн; Түүний үгийг уншиж, туулсан бүх хүн Түүний үгэнд зөвт зан чанар нь илчлэгдсэнийг харсан. Тэгвэл Бурханы зөвт зан чанарын тухай бидний хэлэлцэж буй зүйлийн гол санаа юу вэ? Та нар үүнийг гүнзгий ухаардаг уу? Та нар туршлагаараа ойлгож авдаг уу? (Тухайн үеийн хүмүүс маш их завхарч, Бурханы уур хилэнг өдөөсөн учраас Бурхан Содом хотыг шатаасан. Үүнээс бид Бурханы зөвт зан чанарыг хардаг.) Эхлээд жаахан лавшруулан харъя: Хэрвээ Бурхан Содомыг устгаагүй бол чи Бурханы зөвт зан чанарыг мэдэж чадах байсан уу? Чи мөн л мэдэж чадах байсан. Үүнийг чи Хаанчлалын эрин үед Бурханы илэрхийлсэн үгээс, бас хүнд чиглүүлсэн шүүлт, гэсгээлт болон хараалаас нь харж чадна. Ниневег аварсан явдлаас нь та нар Бурханы зөвт зан чанарыг хардаг уу? (Хардаг.) Энэ эрин үед хүмүүс Бурханы өршөөл, хайр, хүлээцтэй байдлын заримыг харж чаддаг ба хүн гэмшвэл Бурхан зүрх сэтгэлээ өөрчилдгийг хүмүүс бас харж болдог. Бурханы зөвт зан чанарын тухай яриагаа эхлэхэд энэ хоёрыг жишээ болгосон нь Түүний зөвт зан чанар илчлэгдсэнийг тун тодорхой харуулах боловч бодит байдалд Бурханы зөвт зан чанарын үндсэн шинж Библийн энэ хоёр түүхэнд илчлэгдсэн зүйлээр хязгаарлагддаггүй. Бурханы үг болон ажлаас сурсан, харсан, туулсан зүйлээсээ та нар юуг Бурханы зөвт зан чанар гэж үзэх вэ? Туршлагаасаа яриач. (Хүнд зориулан Бурханы бүтээж өгсөн орчинд хүмүүс үнэнийг эрэлхийлж, Бурханы хүслийн дагуу байж чадах үед Бурхан тэднийг замчилж, гэгээрүүлж, зүрх сэтгэлд нь гэрэл гэгээ мэдрүүлдэг. Хүмүүс Бурханыг эсэргүүцэж, Бурханд тэрсэлж, Түүний хүслийн дагуу явахгүй байхад Бурхан өөрсдийг нь хаясан мэт тэдний дотор их харанхуй байдаг. Тэд залбирахдаа хүртэл Түүнд юу гэж хэлэхээ мэддэггүй. Гэвч үзэл, төсөөллөө хойш тавьж, Бурхантай хамтран ажиллахад бэлэн болж, сайжрахаар чармайх үедээ тэд Бурханы инээмсэглэсэн царайг аажмаар харж чаддаг. Үүнээс бид Бурханы зөвт зан чанарын ариун байдлыг мэдэрдэг; Бурхан ариун хаанчлалд үзэгддэг боловч бузар газруудад Өөрийгөө нуудаг.) (Хүмүүст ханддаг байдлаас нь би Бурханы зөвт зан чанарыг хардаг. Ах, эгч нарын маань биеийн хэмжээ, хэв чанар өөр бөгөөд бид бүхнээс Бурханы шаарддаг зүйл ч бас ялгаатай байдаг. Бид бүгд Бурханы гэгээрлийг янз бүрийн түвшинд хүлээн авч чаддаг бөгөөд би үүнээс Бурханы зөвт байдлыг хардаг. Учир нь хүн хүндээ ингэж хандаж чаддаггүй, харин Бурхан чаддаг.) Одоо та нар бүгдээрээ бага зэрэг бодитой мэдлэгийг ярьж чаддаг боллоо.

Бурханы зөвт зан чанарыг ойлгоход юу мэдэх нь чухал болохыг та нар мэдэж байна уу? Та нар энэ сэдвийн талаар туршлагаасаа ярих юм их байж магадгүй боловч эхлээд Би та нарт цөөн хэдэн гол зүйл хэлэх ёстой. Бурханы зөвт зан чанарыг ойлгохын тулд хүн эхлээд Бурханы мэдрэмжийг ойлгох ёстой: Тэр юуг үзэн яддаг, юуг жигшдэг, юуг хайрладаг, хэнийг тэвчдэг, хэнд өршөөнгүй байдгийг, мөн ямар төрлийн хүн тэр өршөөлийг хүртдэгийг ойлгох ёстой. Энэ бол нэг гол зүйл юм. Бурхан хэчнээн элэгсэг ч гэлээ, хүмүүсийг хэчнээн их хайрлаж, өршөөдөг ч гэлээ, Өөрийнх нь ялгамж чанар, байр сууринд халдсан хэнийг ч тэвчдэггүй, мөн Өөрийнх

нь эрхэм чанарт халдсан хэнийг ч тэвчдэггүй гэдгийг хүн ойлгох ёстой. Бурхан хүмүүсийг хайрладаг боловч тэднийг эрхлүүлдэггүй. Тэрээр хүмүүст хайр, өршөөлөө өгч, хүлээцтэй байдаг, гэвч тэднийг хэзээ ч бөөцийлөөгүй; Түүнд Өөрийн зарчим, Өөрийн хязгаар бий. Чи Бурханы хайрыг хэчнээн их мэдэрсэн нь хамаагүй, тэр хайр хэчнээн гүн байх нь хамаагүй, өөр хүнтэй харьцдаг шигээ Бурхантай харьцаж хэзээ ч болохгүй. Бурхан хүмүүст маш ойр дотно ханддаг нь үнэн хэдий ч, хэрвээ хүн Бурханыг ердөө л өөр нэг хүнтэй адилхан үзэж, Түүнийг ердөө л өөр нэг бүтээл юм шиг, найз нь ч юм уу, шүтээн нь мэт үзвэл Бурхан тэднээс нүүр буруулж, тэднийг хаяна. Энэ бол Түүний зан чанар бөгөөд хүмүүс энэ асуудалд гоомой хандах ёсгүй. Иймээс Өөрийнхөө зан чанарын талаар Бурхан үргэлж ингэж хэлдэг: Хэчнээн олон замаар аялсан чинь хамаагүй, хэр их ажил хийж, хэр их зовлон амссан чинь хамаагүй, Бурханы зан чанарт халдмагц Тэр хийсэн зүйлд чинь үндэслэн хүн нэг бүрд хариу өгөх болно. Юу гэсэн үг вэ гэвэл, Бурхан хүмүүст маш ойр дотно ханддаг боловч хүмүүс Түүнд найз шигээ, эсвэл хамаатан шигээ хандах ёсгүй. Бурханыг “найз аа” гэж бүү дууд. Чи Түүнээс хэр их хайр хүлээн авсан нь хамаагүй, Тэр чамайг хэчнээн их тэвчсэн нь хамаагүй, чи хэзээ ч Бурханыг зүгээр нэг найзтайгаа адил авч үзэх ёсгүй. Энэ бол Бурханы зөвт зан чанар. Ойлгож байна уу? Энэ тухай Би нэмж ярих хэрэгтэй юу? Өмнө нь та нар үүнийг ойлгодог байсан уу? Хүн хоосон сургаалыг ойлгодог ч бай, үгүй ч бай, эсвэл өмнө нь энэ тухай огт бодоогүй ч бай, ерөнхийдөө энэ бол хүмүүсийн хамгийн амархан гаргадаг алдаа юм. Хүн Бурханыг уурлуулах нь нэг удаагийн тохиолдол юм уу хэлсэн ганц зүйлээс нь болдоггүй байж магад, харин ч тэдний хандлага, байгаа байдлаас болдог. Энэ бол тун аймаар зүйл. Зарим хүн, Бурханы тухай ойлгодог, Бурханыг бага зэрэг мэддэг гэж боддог, тэд бүр Бурханы таалалд нийцэх зарим зүйлийг хийдэг ч байж мэднэ. Тэдэнд Бурхантай эн тэнцүү мэт, Бурхантай найзууд болсон мэт санагдаж эхэлдэг. Иймэрхүү мэдрэмж бол асар буруу. Хэрэв чи үүнийг гүнзгий ойлгодоггүй бол, тодорхой ойлгодоггүй бол Бурханыг маш хялбар уурлуулж, Бурханы зөвт чанарт халдана. Одоо чи үүнийг ойлгосон, тийм үү? Бурханы зөвт зан чанар цор ганц биш гэж үү? Энэ нь хүний зан төлөв юм уу ёс суртахууны байдалтай адилхан түвшинд байж ер нь болох уу? Хэзээ ч болохгүй. Тэгэхээр, Бурхан хүмүүстэй яаж ч харьцдаг бай, хүмүүсийн тухай юу ч боддог бай хамаагүй, Бурханы байр суурь, эрх мэдэл, ялгамж чанар хэзээ ч өөрчлөгддөггүй гэдгийг чи мартах ёсгүй. Хүн төрөлхтний хувьд, Бурхан бол үргэлж бүхний Эзэн ба Бүтээгч юм.

Бурханы ариун байдлын талаар та нар юу олж мэдсэн бэ? “Бурханы ариун байдлын” тухай тэр хэсэгт Сатаны хорон муу байдлыг товойлгогч болгон ашигласнаас гадна Бурханы ариун байдлын талаарх хэлэлцүүлгийн маань гол сэдэв юу байсан бэ? Бурханд юу байгаа болон Тэр юу болох мөн үү? Бурханд юу байгаа, Тэр юу болох нь Бурханд Өөрт нь байдаг цор ганц чанар уу? (Тийм.) Энэ нь бүтээгдсэн зүйлд байдаггүй. Тийм болохоор бид Бурханы ариун байдлыг цор ганц гэж хэлдэг. Энэ бол та нарын ойлгож чаддаг байх ёстой зүйл. Бид Бурханы

ариун байдлын талаар гурван цуглаан хийсэн. Та нар Бурханы ариун байдлыг юу гэж боддогоо өөрсдийнхөө үгээр, өөрсдийнхөө ойлгосноор дүрслэн хэлж чадах уу? (Өнгөрсөн удаа Бурханыг бидэнтэй ярилцахад бид Түүний өмнө өвдөг сөгдсөн. Бурхан бидэнтэй, нүүрээрээ газар унан мөргөх болон Түүнийг шүтэн мөргөхөөр өвдөг сөгдөхтэй холбоотой үнэнийг нөхөрлөсөн. Түүний шаардлагад хүрээгүй байхдаа Түүнийг шүтэн мөргөхөөр өвдөг сөгдөх нь Түүний хүсэлд нийцэхгүй гэдгийг бид ойлгосон бөгөөд үүнээс бид Бурханы ариун байдлыг харсан.) Тун үнэн. Өөр зүйл байна уу? (Хүн төрөлхтөнд хэлсэн Бурханы үгээс бид, Түүний илэн далангүй, тодорхой ярьдаг, гол санаагаа шууд хэлдгийг хардаг. Сатан тойруу замаар ярьдаг бөгөөд худал хуурмагаар дүүрэн байдаг. Бурханы өмнө нүүрээрээ газар унан мөргөсөн өнгөрсөн удаагийн явдлаас бид Бурханы үг ба үйлдэл үргэлж зарчимтай байдгийг харсан. Бид юу хийх ёстой, юу баримталж, хэрхэн үйлдвэл зохихыг хэлэхдээ Тэр үргэлж тодорхой, ойлгомжтой байдаг. Харин хүмүүс ийм биш. Сатан хүн төрөлхтнийг ялзруулсны дараа хүмүүс өөрсдийн үйлдэл ба үгээр хувийн санаархал, зорилго болон хүслээ биелүүлэхээр эрмэлздэг болсон. Бурхан хүн төрөлхтнийг харж хандаж, хамгаалж, халамжилж байгаагаас бид Бурханы хийдэг бүхэн эерэг бөгөөд тодорхой байдгийг хардаг. Ийм замаар бид Бурханы ариун байдлын мөн чанарын илчлэлийг хардаг.) Сайхан хэллээ! Өөр юм нэмж хэлэх хүн байна уу? (Бурхан Сатаны ёрын муу мөн чанарыг ил болгоход бид Бурханы ариун байдлыг харж, Сатаны ёрын мууг илүү сайн мэддэг болж, хүн төрөлхтний зовлонгийн эх сурвалжийг хардаг. Өмнө нь бид Сатаны эзэмшил дор зовж буйгаа огт мэддэггүй байж. Бурхан бидэнд мэдэгдэх үед л, алдар нэр, эд хөрөнгө хөөцөлдсөний үр дүнд ирдэг хамаг зовлонг Сатан бий болгодгийг бид харсан. Тэгэхэд л Бурханы ариун байдал нь хүн төрөлхтний жинхэнэ аврал гэдгийг бид мэдэрсэн.) Үүн дээр нэмж ярих хүн байна уу? (Завхарсан хүн төрөлхтөнд Бурханы тухай жинхэнэ мэдлэг, Бурханыг гэсэн хайр дутмаг байдаг. Бид Бурханы ариун байдлын мөн чанарыг ойлгодоггүй болохоор Түүнийг шүтэн мөргөхөөр нүүрээрээ газар унан мөргөж, өвдөг сөгдөж байгаа маань ариун бус бодолтой, далд сэдэлтэй, зорилготой байдаг учраас Бурхан баярладаггүй. Бурхан Сатанаас өөр гэдгийг бид хардаг; Сатан өөрийг нь хүмүүс биширч, долигонон, шүтэж мөргөх гээд нүүрээрээ газар унаж, өвдөг сөгдөхийг нь хүсдэг. Сатанд зарчим байдаггүй. Үүнээс би бас Бурханы ариун байдлыг ойлгодог.) Маш сайн байна! Бид Бурханы ариун байдлын тухай нөхөрлөсөн болохоор та нар Бурханы төгс байдлыг харж байна уу? Бурхан бол бүх эерэг зүйлийн эх сурвалж гэдгийг хардаг уу? Бурхан бол үнэн ба шударга ёсны биелэл гэдгийг харж чаддаг уу? Бурхан хайрын эх сурвалж гэдгийг хардаг уу? Бурханы хийдэг бүхэн, Түүний илэрхийлдэг бүхэн, Түүний илчилдэг бүхэн өө сэвгүй гэдгийг хардаг уу? (Хардаг.) Эдгээр нь бүгд Бурханы ариун байдлын талаар Миний ярьсны гол санаа юм. Өнөөдөр энэ үг та нарт зүгээр л нэг сургаал шиг санагдах байх, гэхдээ нэг л өдөр чи үг болон ажлаас нь жинхэнэ Бурханыг Өөрийг нь мэдэрч, үзэх үедээ Бурхан бол ариун, Бурхан бол хүн төрөлхтнөөс өөр, Түүний зүрх сэтгэл,

зан чанар, мөн чанар бүгд ариун гэж сэтгэлийнхээ угаас хэлнэ. Энэ ариун байдал Бурханы төгс байдлыг хүнд харуулдаг, бас Бурханы ариун байдлын мөн чанар өө сэвгүй гэдгийг харуулдаг. Түүний ариун байдлын мөн чанар нь Тэр бол цор ганц Бурхан Өөрөө гэдгийг тодорхойлж, Тэр бол цор ганц Бурхан Өөрөө гэдгийг хүнд харуулж, бас баталдаг. Гол санаа нь энэ мөн үү? (Мөн.)

Өнөөдөр бид өмнөх цуглаанууд дээр ярьсан агуулгын зарим хэсгийг тоймлон өгүүллээ. Өнөөдрийн тоймоо ингээд дуусгая. Та нар бүгдээрээ бүлэг, сэдэв бүрийн гол санааг нухацтай авч үзнэ гэж Би найдаж байна. Эднийг ердөө нэг сургаал гэж бүү бод; цаг завтай үедээ тэдгээрийг илүү анхааралтай уншиж, эргэцүүлэх гэж хичээ. Эдгээрийг зүрх сэтгэлдээ санаж, амьдралдаа хэрэгжүүл, тэгвэл Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохын жинхэнэ илчлэлийн тухай Миний хэлсэн бүхнийг чи үнэхээр мэдэж авна. Гэхдээ чи эдгээрийг зүгээр л тэмдэглэлийн дэвтэртээ бичиж авчихаад ерөөсөө уншихгүй, эргэцүүлж бодохгүй бол хэзээ ч өөрийн болгож авахгүй. Чи одоо ойлгосон, тийм үү? Энэ гурван сэдвээр ярилцсаны дараа Бурханы ялгамж чанар, мөн чанар болон зан чанарын талаар хүмүүс ерөнхий, эсвэл бүр нарийн ойлголт олж авна, тэд Бурханы талаар бүрэн гүйцэд ойлголттой болох уу? (Үгүй.) Тэгвэл Бурханы талаарх өөрсдийн ойлголтыг харвал илүү гүнзгий ойлголт хэрэгтэй гэж санагдаж байгаа өөр талбар байна уу? Өөрөөр хэлбэл, одоо чи Бурханы эрх мэдэл, зөвт зан чанар, ариун байдлын тухай ойлголттой болчихлоо, чиний оюун санаанд Бурханы цор ганц ялгамж чанар, байр суурийн талаарх мэдлэг бий болсон байх; гэвч Бурханы үйлдэл, Бурханы хүч чадал, Бурханы мөн чанарыг туршлагаараа харж, ойлгож, гүнзгийрүүлэх ажил чамд үлддэг. Одоо та нар энэ нөхөрлөлүүдийг сонссон болохоор итгэлийн тухай энэ сэдвийг зүрх сэтгэлдээ хадгалж чадахаар боллоо: Бурхан үнэхээр оршин байдаг, бүх зүйлийг захирдаг нь бодит үнэн. Нэг ч хүн Түүний зөвт зан чанарт халдах ёсгүй; Түүний ариун байдал нь ямар ч хүн эргэлзэхийн аргагүй тодорхой зүйл юм. Эдгээр нь бодит баримт. Энэ нөхөрлөлүүд нь Бурханы байр суурь, ялгамж чанарыг хүмүүсийн зүрх сэтгэлд суурилуулж өгдөг. Энэ суурь тавигдсан байхад хүмүүс илүү ихийг ойлгох гэж хичээх ёстой.

I Түүх: Үр, газар, мод, нарны гэрэл, шувууд ба хүн

Өнөөдөр Би та нартай шинэ сэдвийн талаар нөхөрлөнө. Энэ ямар сэдэв бэ? Сэдвийн нэр нь “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж.” Арай л томдсон сэдэв юм шиг санагдаж байна уу? Энэ нь та нарт арай л хүрэхийн аргагүй санагдаж байна уу? “Бурхан бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдэг энэ сэдэв хүнд нэг л хамаагүй мэт санагдаж болох юм, гэвч Бурханыг дагадаг хүмүүс бүгд үүнийг ойлгох ёстой. Яагаад гэвэл, хүн бүр Бурханыг мэдэж, Түүнийг хангалуун байлгаж, Түүнийг хүндэлж чаддаг байхад энэ сэдэв салшгүй холбоотой. Тийм учраас Би энэ сэдвийн талаар нөхөрлөх гэж байна. Хүмүүс энэ сэдвийн талаар энгийн, урьд нь ойлголттой байсан, эсвэл үүнийг ямар нэг хэмжээгээр гадарладаг байсан байж тун болзошгүй. Оюун ухаандаа

тэд энэ тухай хэтэрхий энгийн мэдлэгтэй, эсвэл өнгөцхөн ойлголттой байж болох юм. Бусад нь энэ тухай зарим нэг онцгой туршлагатай байдаг; өөрсдийн өвөрмөц туршлагын улмаас зүрх сэтгэлдээ тэд энэ тухай гүнзгий ойлголттой болсон байдаг. Гэхдээ ийм урьдын мэдлэг гүн ч бай, өнгөцхөн ч бай, өрөөсгөл бөгөөд хангалттай тодорхой биш. Ийм учраас Би энэ сэдвийг нөхөрлөхөөр сонгосон нь та нарт илүү тодорхой, гүн гүнзгий ойлголт өгөхийн төлөө юм. Энэ сэдвийн талаар та нартай нөхөрлөхдөө Би нэгэн онцгой арга буюу өмнө нь хэрэглэж байгаагүй, та нарт жаахан сонин, эсвэл бага зэрэг таагүй санагдаж магадгүй аргыг ашиглана. Дараа нь та нар юу хэлээд байгааг минь мэдэх болно. Та нар түүх сонсох дуртай юу? (Дуртай.) За, та нар бүгдээрээ түүх сонсох их дуртайгаас хойш түүх ярих арга сонгосон минь зөв бололтой. Тэгвэл эхэлцгээе. Та нар тэмдэглэж авах шаардлагагүй. Ийш тийш сатааралгүй тайван суухыг та нараас хүсье. Хэрэв эргэн тойрны чинь зүйл, эсвэл хүмүүс сатааруулж магадгүй гэж санагдвал нүдээ аньж болно. Би та бүхэнд нэгэн гайхалтай бяцхан түүх ярьж өгье. Энэ нь нэг үр, газар, мод, нарны гэрэл, шувууд, хүний тухай түүх. Уг түүхийн гол дүрүүд юу билээ? (Үр, газар, мод, нарны гэрэл, шувууд, хүн.) Нэг нь Бурхан уу? (Үгүй.) Гэхдээ л энэ түүхийг сонсоод та нар сэргэж, сэтгэл ханана гэдэгт Би итгэлтэй байна. За, чимээгүйхэн сонсоорой.

Нэг бяцхан үр газарт унажээ. Ширүүн бороо орж, өнөөх үр соёолон үндэс нь аажмаар хөрсийг ухан оржээ. Сар нэг битүүрч, нэг хавиргалахын хэрээр цаг улирал ээлжлэхийг харж, ширүүн салхи, аадар бороог даван туулсаар өчүүхэн нахиа аяндаа ургалаа. Зун болоход газрын ус хишгээ хайрлаж, улирлын аагим халууныг давахад нь тусалжээ. Газрын ачаар нахиа халуунд нэрвэгдээгүй ба тийнхүү зуны хамгийн бэрх халууныг мэнд өнгөрөв. Өвөл болоход газар түүнийг дулаан энгэртээ тэвэрч, тэд бие биедээ чанга наалджээ. Газар өнөөх нахиаг дулаацуулсны ачаар жихүүн салхи, цасан хуйг ажралгүй, өвлийн хахир хүйтэнд тэсэж үлдэв. Газрын нөмөр нөөлгөөр нахиа зоримог, аз жаргалтай болжээ; газрын харамгүй бойжуулан тэжээсэн нахиа эрүүл, чийрэг ургажээ. Нахиа бороонд дуугаа дуулж, салхинд найган бүжиж, баяр баясалтай ургалаа. Нахиа, газар хоёр бие биеэ түшиглэдэг…

Он жил өнгөрөхөд тэр нахиа сүглэгэр мод боллоо. Тоймгүй олон навчаар хучигдсан бахим олон салаа мөчиртэй болж, газар дээр бат байрлав. Үндэс нь урьдын адил газарт мөн л шигдсээр, хөрсний гүнд бөх зоогджээ. Нэгэн цагт өчүүхэн нахиаг хамгаалж байсан газар одоо аварга модны суурь болжээ.

Нарны цацраг модон дээр тусав. Мод биеэ ганхуулж, мөчрөө алдлан дэлгээд нар туссан агаарыг гүнээ амьсгалдаг байв. Доорх газар нь модтой нэгэн хэмнэлээр амьсгалж, шинэ болсон мэт санагддаг байв. Яг тэр үед модны мөчир дундаас сэвшээ салхи үлээж, мод баярлан намилзаж, эрч хүчээр оргилдог байлаа. Мод ба нарны гэрэл бие биеэ түшиглэдэг…

Хүмүүс модны сэрүүн сүүдэрт суугаад анхилуун цэнгэг агаарт баясжээ. Агаар тэдний зүрх, уушгийг цэвэрлэж, цусыг нь цэвэршүүлж, тэдний бие алжаал ядаргааг мэдрэхээ болив. Хүмүүс ба мод бие биеэ түшиглэдэг…

Удалгүй модны мөчрүүд дээр бяцхан шувууд жиргэн эргэлдэх боллоо. Зарим нь махчдаас зугтаж, зарим нь ангаахайгаа бойжуулах гэж, харин зарим нь түрхэн зуур амсхийх гэж буусан байх. Шувуу ба мод бие биеэ түшиглэдэг…

Модны үндэс мушгирч, зангиран газарт гүн шигдэв. Модны их бие нь газрыг салхи, бороноос нөмөрлөн мөчрүүдээ дэлгэн доорх газраа хамгаалдаг байлаа. Газар өөрийнх нь эх байсан учраас мод ингэдэг байжээ. Тэд бие биеэ хүчирхэгжүүлж, бие биеэ түшиглэдэг бөгөөд хэзээ ч салж хагацахгүй…

Ингээд энэ түүх дууслаа. Миний ярьсан түүх бол үр, газар, мод, нарны гэрэл, шувууд болон хүний тухай байлаа. Энэ түүх хэдхэн хэсэгтэй. Энэ түүх та нарт юу бодогдуулав? Ийм маягаар ярихад Миний юу хэлээд байгааг та нар ойлгож байна уу? (Ойлгож байна.) Та нар юу бодсоноо ярь даа. Энэ түүхийг сонсоод ямар санагдав? Энэ түүхэнд гарсан бүх зүйлийг харж, хүрч болно гэдгийг Би эхлээд та нарт хэлье; тэдгээр нь зүйрлэл биш, бодит юмс. Та бүхэн Миний ярьсныг бодоосой гэж Би хүсэж байна. Миний өгүүлсэн түүхэнд далд утгатай юм ер байхгүй бөгөөд гол санаа нь уг түүхийн хэдхэн өгүүлбэрээр илэрч болно. (Саяын сонссон түүх маш сайхан зураглал дүрсэлж байна. Нэг үр амьтай болж, ургах явцдаа хавар, зун, намар, өвөл гээд жилийн дөрвөн улирлыг туулдаг. Соёолон буй үрийг газар түүнийг эх юм шиг нь бойжуулдаг. Газар тэр нахиаг өвөл дулаацуулж, нахиа хүйтнийг давж гарсан. Нахиа ургаж мод болоход нарны гэрэл мөчрүүдэд нь хүрч, модонд их баяр хөөр авчирдаг. Бурханы бүтээлийн олон зүйлийн дунд газар бас амьд бөгөөд мод тэр хоёр бие биеэ түшиглэдэг гэдгийг би харсан. Бас нарны гэрэл модонд их дулаан илч хайрладгийг би ойлгосон, шувууд хэдийгээр ердийн амьтад боловч тэд мод, хүнтэй хамт төгс зохицолддог гэдгийг би ойлгосон. Энэ түүхийг сонсож байхад миний зүрх сэтгэлд ийм мэдрэмж төрж байлаа; эдгээр зүйл бүгд үнэхээр амьд гэдгийг ухаарч байна.) Сайхан хэллээ! Өөр юм нэмж хэлэх хүн байна уу? (Үр соёолж, сүглэгэр мод болж ургадаг энэ түүхээс би Бурханы бүтээлийн гайхамшгийг харж байна. Бурхан, бүх зүйлийг бие биеэ батжуулж, түшиглэдэг болгосон ба бүх зүйл бие биетэйгээ холбоотой, бие биедээ үйлчилдэг болгосныг ойлголоо. Би Бурханы мэргэн ухаан болон гайхамшгийг харж, Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж мөн гэдгийг харсан.)

Миний дөнгөж сая ярьсан бүх зүйлийг та нар урьд нь харсан. Жишээ нь үр байна, үр ургаад мод болдог үйл явцыг чи нарийн мэдэхгүй байж болно, гэхдээ тэгдэг гэдгийг мэднэ, тийм биз дээ? Чи газрыг, нарны гэрлийг бас мэднэ. Шувууд модон дээр суусан байх нь хүн бүрийн харсан зүйл, тийм үү? Хүмүүс модны сүүдэрт сэрүүцэхийг та нар бүгдээрээ харж байсан биз дээ? (Харсан.) Тэгэхээр энэ бүх жишээг нэг дүр зурагт багтаахад тийм зураг ямар мэдрэмж төрүүлэх вэ? (Эв зохицол.) Ийм дүр зургийн зүйлс бүгд Бурханаас ирдэг үү? (Тийм.) Тэд Бурханаас ирдэг тул энэ өөр өөр зүйлийн газар дээр оршин буйн үнэ цэн, ач холбогдлыг Бурхан мэддэг. Бурхан бүх зүйлийг төлөвлөж, бүтээхдээ санаа зорилготой хийсэн; Бурхан бүх зүйлийг бүтээхдээ тэдэнд амь шингээсэн. Хүн төрөлхтний оршин

тогтноход зориулан Түүний бүтээсэн орчин нь яг л саяын түүхэнд өгүүлсэн үр ба газар бие биеэ түшиглэдэг, газар үрийг тэтгэж, үр газартай холбогддог тэр орчин юм. Энэ харилцааг Бурхан бүтээлийнхээ бүр эхэнд урьдчилан тогтоосон. Мод, нарны гэрэл, шувууд, хүмүүсийн дүрслэл бол хүн төрөлхтөнд зориулан Бурханы бүтээсэн амьдрах орчны зураглал юм. Нэгдүгээрт, мод газрыг орхиж чадахгүй, нарны гэрэлгүйгээр ч байж чадахгүй. Тэгэхээр Бурхан модыг бүтээсний зорилго нь юу юм бэ? Зөвхөн газрын төлөө бүтээсэн гэж хэлж болох уу? Зөвхөн шувуудын төлөө бүтээсэн гэж хэлж болох уу? Зөвхөн хүмүүсийн төлөө бүтээсэн гэж хэлж болох уу? (Болохгүй.) Тэдний хоорондох харилцаа юу вэ? Тэдний хоорондын харилцаа нь бие биеэ батжуулах, салж болшгүй харилцан хамаарал юм. Өөрөөр хэлбэл, газар, мод, нарны гэрэл, шувууд болон хүмүүс оршин байхын тулд бие биеэ тулж түшдэг бөгөөд нэг нь нөгөөгөө тэтгэдэг. Мод газрыг хамгаалдаг байхад газар модыг тэжээдэг; нарны гэрэл модонд шим өгөхөд мод нарны гэрлээс цэвэр агаар бий болгож, газарт тусах нарны төөнөм халууныг багасгадаг. Эцэст нь хэнд ашигтай байна? Хүн төрөлхтөнд ашигтай байгаа биз? Энэ бол хүн төрөлхтний амьдардаг, Бурханы бүтээсэн орчны үндэс болсон зарчмуудын нэг юм; Бурхан үүнийг анхнаасаа ямар байлгахаар зорьсон нь энэ юм. Хэдий энэ нь жирийн нэг дүрслэл боловч бид Бурханы мэргэн ухаан, санаа зорилгыг харж чаддаг. Хүн төрөлхтөн газаргүйгээр, модгүйгээр, бас шувуугүйгээр, нарны гэрэлгүйгээр амьдарч чадахгүй. Тийм биш үү? Энэ нь ердөө л нэг түүх боловч Бурханы бүтээсэн тэнгэр, газар ба бүх зүйл, мөн хүн төрөлхтөнд өгсөн Түүний бэлэг болох амьдрах орчны бичил ертөнцийг дүрслэн харуулдаг.

Бурхан тэнгэр, газар, бүх зүйлийг хүн төрөлхтөнд зориулж бүтээсэн бөгөөд бас амьдрах орчныг ч бүтээсэн. Нэгдүгээрт, энэ түүх бүх зүйл бие биеэ хүчирхэгжүүлдэг, харилцан хамаардаг ба зэрэгцэн оршдогийг гол зүйл болгон авч үздэг. Энэ зарчмын дор хүн төрөлхтний амьдрах орчин хамгаалагддаг; энэ нь цаашид оршин тогтож чадах ба байсаар байна. Үүний үрээр хүн төрөлхтөн цэцэглэн хөгжиж, өсөн үржиж чадна. Бидний үзсэн дүр зураг бол мод, газар, нар, шувууд, бас хүмүүсийн дүр зураг байсан. Энэ дүр зурагт Бурхан байсан уу? Хүн тэндээс Бурханыг олж хараагүй. Гэхдээ хүн энэ үйл явдалд гарсан зүйлсийн хоорондын бие биеэ хүчирхэгжүүлэх ба харилцан хамаарах зүй тогтлыг харсан; энэ зүй тогтлоор дамжуулан хүмүүс Бурхан оршин буйг, Бурханы дээд эрхийг харж чаддаг. Бурхан эдгээр зарчим болон зүй тогтлыг ашиглаад бүх зүйлийг амьд байлгаж, оршин тогтнуулдаг. Ийм замаар Тэр бүх зүйлийг хангаж, хүн төрөлхтнийг тэтгэж байдаг. Энэ түүх бидний гол сэдэвтэй холбоотой юу? Өнгөн талдаа холбоогүй юм шиг харагддаг боловч бодит байдал дээр Бурхан бүх зүйлийг бүтээсэн зүй тогтол болон бүх зүйлийг ноёрхох Түүний ноёрхол нь, Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж гэдэгтэй нь шууд уялдсан байдаг. Та нар жаахан юм сурч эхэлж байна!

Бүх зүйлийн үйл ажиллагааг удирддаг зүй тогтлыг Бурхан захирдаг; Тэрээр бүх зүйлийн амьдралыг удирддаг зүй тогтлыг захирдаг; Тэр бүх зүйлийг хянаж, бие

биедээ хүч нэмж, түшиглэдэг болгосноор тэд мөхдөггүй, алга болдоггүй. Зөвхөн ингэснээр хүн төрөлхтөн амьдарсаар байж чадна; зөвхөн ингэснээр Бурханы удирдлага дор ийм орчинд амьдарч чаддаг. Бурхан бол үйл ажиллагааны эдгээр зүй тогтлын эзэн бөгөөд хэн ч хөндлөнгөөс оролцож, тэдгээрийг өөрчилж чадахгүй; Бурхан Өөрөө л энэ зүй тогтлуудыг мэддэг, бас Бурхан Өөрөө л удирддаг. Модод хэдийд нахиалах; бороо хэдийд орох; газраас ургамал ногоонд газар хэр их ус, хэр зэрэг шим тэжээл өгөх; ямар улиралд навчис унах; ямар улиралд мод жимслэх; нарны гэрэл модонд хэр их шим тэжээл өгөх; нарны гэрлээс шим тэжээл аваад мод юу ялгаруулах—энэ бүхнийг Бурхан бүх зүйлийг бүтээхдээ урьдчилан зохицуулсан бөгөөд хэн ч зөрчиж чадахгүй зүй тогтлууд юм. Бурханы бүтээсэн зүйлс амьд ч бай, эсвэл хүний нүдэнд амьгүй гэж харагддаг ч бай, бүгдээрээ Бурханы гарт, Түүний ноёрхол дор байдаг. Хэн ч энэ зүй тогтлыг өөрчилж, эсвэл зөрчиж чадахгүй. Өөрөөр хэлбэл, Бурхан бүх зүйлийг бүтээхдээ ямар байхыг буюу газар байхгүйгээр мод үндэслэж, соёолж, ургаж чадахгүй байсан; хэрвээ газарт ямар ч мод байгаагүй бол газар хатах байсан; мод бол шувуудын орон гэр бөгөөд салхинаас хоргодох нөмөр нь болно гэдгийг урьдаас тогтоочихсон. Мод хөрсгүйгээр ургаж чадах уу? Яавч үгүй. Энэ нь нар, бороогүйгээр байж чадах уу? Бас л чадахгүй. Энэ бүхэн хүн төрөлхтний төлөө, хүн төрөлхтний оршин тогтнолын төлөө байдаг. Хүн модноос цэвэр агаар авдаг ба модоор хамгаалагдсан газар дээр амьдардаг. Хүн нарны гэрэл болон бусад янз бүрийн амьд зүйлгүйгээр амьдарч чадахгүй. Хэдий эдгээр зүйлийн хамаарал нарийн төвөгтэй боловч Бурхан бүх зүйлийг захирах зүй тогтлуудыг бүтээсэн, ингэснээр бүх зүйл харилцан хамааралтай, уялдаа холбоотой байдлаар оршиж болох юм гэдгийг чи санах ёстой; Өөрөөр хэлбэл, Бурханы бүтээсэн зүйл нэг бүр үнэ цэн, ач холбогдолтой. Хэрвээ Бурхан ач холбогдолгүй зүйл бүтээсэн бол Бурхан үүнийг алга болгох байсан. Энэ бол бүх зүйлийн хэрэгцээг хангахдаа Бурханы ашигладаг аргуудын нэг. Энэ түүхэнд “хангах” гэдэг үг юуг хэлж байна вэ? Бурхан тэр модыг өдөр бүр усалж байсан уу? Амьсгалахын тулд модонд Бурханы тусламж хэрэгтэй байна уу? (Үгүй.) Энд “хангах” гэдэг нь бүтээснийхээ дараа Бурхан бүх зүйлийг удирдахыг хэлдэг; тэдгээрийг захирах зүй тогтлыг бий болгосны дараа удирдах нь Бурханд хангалттай юм. Модны үрийг газарт тарьчихвал өөрөө ургадаг. Харин модны ургах нөхцөлийг бүгдийг нь Бурхан бүтээсэн. Бурхан нарны гэрэл, ус, хөрс, агаар болон хүрээлэн буй орчныг бүтээсэн; салхи, жавар, цас, бороо, дөрвөн улирлыг Бурхан бүтээсэн. Эдгээр нь мод ургахад хэрэгтэй нөхцөлүүд бөгөөд Бурханы бэлдсэн зүйл юм. Тэгэхээр Бурхан энэхүү амьдрах орчны эх сурвалж мөн үү? (Мөн.) Бурхан модны навч нэг бүрийг өдөр бүр тоолох шаардлагатай уу? Үгүй! Бурхан бас модыг амьсгалахад туслах хэрэг ч байхгүй, эсвэл өдөр бүр “Модон дээр тусах цаг чинь боллоо” гэж хэлээд нарны гэрлийг сэрээх ч шаардлагагүй. Тэр тэгэх шаардлагагүй. Нарны гэрэл зүй тогтлын дагуу гийх цаг нь болоход аяндаа гийнэ; гарч ирээд гэрлээ модон дээр тусгаж, хэрэгтэй үедээ мод нарны гэрлийг шингээдэг бөгөөд хэрэггүй үед мод мөн л зүй

тогтлоор амьдардаг. Та нар энэ үзэгдлийг тодорхой тайлбарлаж чадахгүй байж магадгүй, гэвч энэ нь хүн бүрийн харж, хүлээн зөвшөөрдөг бодит баримт юм. Хийх ёстой ганц зүйл чинь бүх зүйлийн оршин тогтнолын зүй тогтол Бурханаас ирдэг гэдгийг танин мэдэж, тэдний өсөлт болон оршин тогтнол Бурханы ноёрхолд байдаг гэдгийг мэдэх явдал юм.

Энэ түүхэнд “зүйрлэл” гэж хэлэхээр зүйл байна уу? Энэ нь хүнчлэл үү? (Үгүй.) Би та нарт үнэн түүх ярьсан. Бүх төрлийн амьд юмс, амьтай бүхэн Бурханд захирагддаг. Амьд зүйл бүрийг бүтээснийхээ дараа Бурхан амь өгсөн; амьтан нэг бүрийн амийг Бурхан өгсөн бөгөөд тэд өөрсдийг нь удирддаг замнал болон хуулийг мөрддөг. Хүн үүнийг өөрчлөх хэрэг байхгүй, мөн үүнд хүний тусламж хэрэггүй; энэ бол бүх зүйлийг хангадаг Бурханы арга замын нэг юм. Та нар ойлгосон биз дээ? Хүмүүс үүнийг мэдэх хэрэгтэй гэж та нар бодож байна уу? (Тийм.) Тэгвэл энэ түүх биологитой ямар нэгэн холбоотой юу? Үүнд ямар нэг мэдлэг, эсвэл судалгааны салбарт холбоотой юм байна уу? Бид энд биологи яриагүй, лав л биологийн судалгаа хийгээгүй байна. Бидний ярианы гол санаа юу вэ? (Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж.) Бүтээлийн дотроос та нар юу харсан бэ? Та нар мод харсан уу? Газар харсан уу? (Харсан.) Нарны гэрлийг бас харсан, тийм биз дээ? Модон дээр суусан шувуудыг харсан уу? (Харсан.) Хүн төрөлхтөн ийм орчинд амьдрахдаа аз жаргалтай байдаг уу? (Тийм.) Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний амьдрах орон гэрийг оршин тогтнуулж, хүн төрөлхтний гэрийг хамгаалахын тулд Бурхан бүх зүйлийг—Өөрийн бүтээсэн бүх зүйлийг ашигладаг. Ингэж Тэр хүнийг болон бүх зүйлийг хангадаг.

Энэ ярианы маяг, ийм янзаар нөхөрлөж байгаа маань та нарт ямар санагдаж байна? (Ойлгоход хялбархан, бас бодитой жишээ олон байна.) Би дэмий хоосон үг хэлэхгүй байгаа биз дээ? Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж гэдгийг хүмүүст ойлгуулахад саяын түүх хэрэгтэй юу? (Тийм.) Хэрвээ тийм бол дахиад нэг түүх ярья. Дараагийн түүх агуулгаараа жаахан өөр, гол санаа нь бас жаахан өөр. Уг түүхэнд гарах зүйлс нь Бурханы бүтээлээс хүмүүсийн харж чаддаг зүйл юм. За, Би дараагийн яриагаа эхэлье. Та нар чимээгүй сонсоод Миний үгийн учрыг ухаарч чадах эсэхээ хараарай. Ярьж дуусчихаад хэр зэрэг ойлгосныг чинь харахын тулд хэдэн асуулт асууна. Энэ түүхийн гол дүрүүд нь өндөр уул, жаахан горхи, хүчит салхи, аварга давлагаа юм.

II Түүх: Өндөр уул, жаахан горхи, хүчит салхи ба аварга давлагаа

Нэгэн жаахан горхи мурилзан мушгирч урссаар эцэст нь өндөр уулын бэлд ирэв. Уул бяцхан горхины замыг хааж байсан учир горхи доройхон, нарийхан дуугаараа “Намайг явуулаач, чи миний зам дээр зогсоод урагшлах замыг минь хаагаад байна” гэжээ. “Чи хаашаа явж байгаа юм бэ?” гэж уул асуув. “Би гэрээ хайж байгаа юм аа” гэж горхи хариулав. Уул: “За, яв, яв, миний дээгүүр давж урсаад яв!” гэлээ. Гэвч бяцхан горхи дэндүү дорой, бас хэтэрхий залуу учир өндөр уулыг давж

урсах ямар ч арга байсангүй. Тиймээс зөвхөн уулын бэл даган урсаж чадах байлаа…

Хүчит салхи нөгөө уулын байгаа газраар элс шороо татуулсаар шуурав. Салхи уул руу хуугиж, “Намайг явуул!” гэсэнд уул “Чи хаашаа явж байна вэ?” гэв. “Би уулын нөгөө талд гармаар байна” гэж салхи улин хариулав. Уул: “За, за. Миний дундуур хуваагаад гарч чадвал явж болно!” гэв. Хүчит салхи ийшээ тийшээ ульж, хэчнээн ууртай үлээсэн боловч уулыг дундуур нь хувааж чадсангүй. Салхи хүчээ барж, амрах гээд намджээ. Харин уулын нөгөө талд сэвшээ салхи үлээх болж, хүмүүсийг баярлуулж байв. Уул ингэж хүмүүстэй мэндчилж байлаа…

Далайн эрэгт далайн хаялга хадат эргийг зөөлөн цохилон эргэдэг байжээ. Гэтэл нэгэн аварга давлагаа гарч ирээд уулын зүг шуугин чиглэв. “Замаас холд!” хэмээн аварга давлагаа хашхирав. “Чи хаашаа явж байгаа юм бэ?” гэж уул асуулаа. Их давлагаа давшилтаа зогсоож чадахгүй хүрхрэн “Би нутаг дэвсгэрээ тэлж байна! Гараа сунгамаар байна!” гэв. Уул: “За, за. Миний оройг давж чадвал чамд би зам тавьж өгнө” гэлээ. Их давлагаа хойш жаахан ухраад, уул өөд дахин нэг давлагаалав. Гэвч хэчнээн их хичээсэн ч уулын оргилд хүрч чадсангүй. Давлагаа далайдаа аажуухан буцахаас өөр аргагүйджээ…

Хэдэн мянган жилийн турш бяцхан горхи уулын бэлээр зөөлхөн хоржигнон урсжээ. Бяцхан горхи уулын заасан замыг даган явсаар гэртээ ирж, голд нийлж, гол нь далайд цутгав. Уулын халамж дор бяцхан горхи хэзээ ч төөрсөнгүй. Горхи, уул хоёр бие биедээ хүч нэмж, бие биеэ түшиглэжээ; тэд бие биеэ хүчирхэгжүүлж, бие биеэ хязгаарлаж, хамт оршиж байлаа.

Хэдэн мянган жилийн турш хүчит салхи зуршлаараа ульж байлаа. Хүчит салхи мөн л ууланд “зочлохоор” байнга элс шороо хуйлруулсаар ирдэг байв. Уулыг сүрдүүлэвч дундуур нь гарч хэзээ ч чадсангүй. Салхи, уул хоёр бие биедээ хүч нэмж, бие биедээ түшиглэсэн; тэд бие биеэ хүчирхэгжүүлж, бие биеэ хязгаарлаж, хамт оршиж байлаа.

Хэдэн мянган жилийн турш аварга давлагаа огт амарч намжсангүй, нутаг дэвсгэрээ тасралтгүй тэлэн хайр найргүй давшсаар байлаа. Давлагаа байсхийгээд л уулын өөдөөс хүрхрэн түрэх боловч уул ямхын төдий ч хөдөлсөнгүй. Уул далайг харж хандаж, ийм маягаар далайн амьтад үржиж олшрон, өсөн нэмэгджээ. Давлагаа, уул хоёр бие биедээ хүч нэмж, бие биедээ түшиглэсэн; тэд бие биеэ хүчирхэгжүүлж, бие биеэ хязгаарлаж, хамт оршиж байлаа.

Энэ түүх маань дууслаа. Эхлээд, энэ түүх юуны тухай байсныг Надад хэл дээ. Юуны өмнө нэг өндөр уул, бяцхан горхи, хүчит салхи, аварга давлагаа байсан. Бяцхан горхи ба өндөр уултай эхний хэсэгт юу болсон бэ? Би яагаад өндөр уул, бяцхан горхины талаар ярьж байна вэ? (Уулын халамж дор горхи хэзээ ч төөрөөгүй. Тэд бие биедээ түшиглэсэн.) Уул бяцхан горхийг хамгаалсан уу, саад болсон уу? (Хамгаалсан.) Гэхдээ саад болоогүй гэж үү? Уул, горхи хоёр бие биедээ анхаарч байсан; уул горхийг хамгаалж, бас саад болсон. Голд нийлж байсан

болохоор уул горхийг хамгаалсан, гэхдээ бас хүмүүст үер усны аюул учруулж болзошгүй газраар урсгахгүйн тулд уул замыг нь хааж байсан. Уг хэсгийн санаа энэ мөн үү? Горхийг хамгаалж, мөн саатуулснаар уул хүмүүсийн орон гэрийг хамгаалсан. Дараа нь бяцхан горхи уулын бэлд гол мөрөнтэй нийлж, эцэст нь далайд цутгасан. Энэ нь горхины оршин тогтнолыг захирдаг зүй тогтол биш гэж үү? Горхи голд нийлж, дараа нь далайд цутгах боломжийг юу өгсөн бэ? Уул биш гэж үү? Тэр горхи уулын хамгаалалт болон саадад түшиглэсэн. Тэгэхээр энэ гол санаа нь мөн үү? Энд усны хувьд уул хэр чухал болохыг чи харж байна уу? Бурхан өндөр, нам уул бүрийг бүтээхдээ зорилготой байсан уу? (Тийм.) Нэг бяцхан горхи, өндөр уулаас өөр юм гардаггүй энэ богинохон хэсэг нь Бурханы бүтээлийн энэ хоёр зүйлийн үнэ цэн, ач холбогдлыг бидэнд харуулдаг; Бурхан энэ хоёр зүйлийг захирч байгаагаас бид Түүний мэргэн ухаан болон зорилгыг бас харж чаддаг. Тийм биш гэж үү?

Уг түүхийн хоёр дахь хэсэг юуны тухай байсан бэ? (Ширүүн салхи ба өндөр уул.) Салхи сайн зүйл мөн үү? (Мөн.) Заавал сайн биш, заримдаа салхи хэт ширүүсвэл гай гамшиг учруулдаг. Хэрвээ чамайг ширүүн салхинд зогсоовол чамд ямар санагдах вэ? Салхины хүчээс хамаарна. 3–4 дүгээр түвшний хүчтэй салхинд бол тэсээд байж чадна. Хамгийн ихдээ л нүдээ нээхэд хэцүү байна байх. Харин салхи ширүүсэж, хар салхи дэгдвэл чи тэсэж чадах уу? Чи чадахгүй. Тэгэхээр хүмүүс салхийг үргэлж сайн, эсвэл үргэлж муу гэж хэлэх нь буруу, учир нь салхи хэр хүчтэйгээс энэ нь шалтгаалдаг. Тэгвэл уул энд ямар үүрэгтэй байсан бэ? Салхины шүүлтүүр байсан биш гэж үү? Уул ширүүн салхийг юу болгож бууруулсан бэ? (Сэвшээ салхи.) Тэгвэл, хүмүүсийн суудаг орчинд дийлэнх хүмүүсийн хүрч, мэдэрч чаддаг салхи нь хүчтэй салхи байсан уу, эсвэл сэвшээ салхи байдаг уу? (Сэвшээ салхи.) Энэ нь Бурханы нэг зорилго, уулсыг бүтээхдээ агуулсан санаа зорилгынх нь нэг биш гэж үү? Салхинд элс нүүр нүдгүй хийсэж, хааж, шүүх юмгүй орчинд амьдарвал хүмүүст ямар байх бол? Хаа сайгүй элс, шороо боссон газар амьдрах аргагүй болох биш үү? Зарим хүн чулуунд цохиулж магадгүй, эсвэл элс орж нүдийг нь сохолж болзошгүй. Хүмүүс салхинд унах юм уу дээш хийсэж ч магадгүй. Барилга байшин нурж, бүх төрлийн гай гамшиг нүүрлэж болно. Гэхдээ хүчтэй салхинд үнэ цэн бий юу? Би салхи муу гэсэн болохоор салхи ямар ч үнэ цэнгүй юм гэж санагдах байх, гэхдээ тийм гэж үү? Сэвшээ салхи болж хувирмагцаа үнэ цэнтэй болдог бус уу? Чийгтэй, бүгчим үед хүмүүст юу хамгийн хэрэгтэй байдаг вэ? Тэднийг зөөлөн илбэх, сэргээж, толгойг нь амраах, ухааныг нь хурцлах, сэтгэл санааг нь засаж, сайжруулах зөөлөн сэвшээ салхи хэрэгтэй. Жишээ нь, та нар олон хүнтэй, бүгчим агаартай өрөөнд сууж байвал юу хамгийн их хэрэгтэй вэ? (Зөөлөн салхи.) Агаар нь бүгчим, бохир газар очиход хүний бодож сэтгэх нь удааширч, цусны эргэлт буурч, ухаан санаа нь муудаж болно. Харин агаар жаахан эргэлт хөдөлгөөнд орвол цэнгэг болж, цэнгэг агаарт хүмүүсийн байдал ч дээрддэг. Хэдий бяцхан горхи, хүчтэй салхи гамшиг учруулж болох байсан ч уул байгаа цагт тэр аюулыг хүмүүст ашиг тустай зүйл болгон хувиргана. Тийм биш гэж үү?

Түүхийн маань гурав дахь хэсэг юуны тухай байсан бэ? (Өндөр уул ба аварга давлагаа.) Өндөр уул ба аварга давлагаа. Энэ хэсэгт уулын бэлийн далайн эргийг дүрсэлжээ. Бид уул, далайн хаялга, аварга давлагааг харж болно. Энэ тохиолдолд аварга давлагааны хувьд уул юу байсан бэ? (Хамгаалагч, бас хаалт.) Хамгаалагч, бас хаалт. Хамгаалагчийн хувьд далайг үгүй болголгүй байлгадаг, ингэснээр дотор нь амьдардаг амьтад үржиж олширч чадна. Хаалт болохын хувьд гэвэл, далайн ус хальж урсан гамшиг тарихаас, хүмүүсийн гэр орныг эвдэж сүйтгэхээс хамгаалдаг. Тэгэхээр уулыг бид хаалт, бас хамгаалагч гэж хэлж болох юм.

Энэ бол өндөр уул ба бяцхан горхи, өндөр уул ба ширүүн салхи, өндөр уул ба аварга давлагааны хоорондох холбооны ач холбогдол юм; энэ бол тэдний бие биедээ хүч нэмж, бие биеэ хязгаарлаж, зэрэгцэн оршдогийн ач холбогдол юм. Бурханы бүтээсэн эдгээр зүйл оршин тогтноxдоо зүй тогтол, хуульд захирагддаг. Энэ түүхээс та нар Бурханы ямар үйл хэргийг харсан бэ? Бурхан бүх зүйлийг бүтээснийхээ дараа зөнд нь орхисон уу? Бурхан тэднийг зүй тогтолтой болгож, чиг үүргийг нь тогтоосныхоо дараа юу л болбол болог гээд зөнд нь хаясан уу? Ийм зүйл болсон гэж үү? (Үгүй.) Тэгвэл яасан бэ? Бурхан бас л хяналтдаа байлгадаг. Бурхан ус, салхи, давлагааг хянадаг. Тэднийг эмх замбараагаа алдаж, эсвэл хүмүүсийн гэр орныг эвдэж, сүйдлэхийг Бурхан зөвшөөрдөггүй. Тийм болохоор хүмүүс энэ газар нутагт амьдарч, өсөж үржиж чаддаг. Энэ нь Бурхан бүх зүйлийг бүтээхдээ тэдний оршин тогтнолын зүй тогтлыг аль хэдийнээ төлөвлөчихсөн байсан гэсэн үг юм. Бурхан бүх зүйлийг бүтээхдээ хүнд өгөх ашиг тусыг нь бодсон бөгөөд Тэр бас тэдгээрийг хянаж байдаг, ингэснээр энэ нь хүн төрөлхтөнд төвөг, гамшиг учруулахгүй юм. Хэрвээ Бурханы удирдлага байгаагүй бол ус замбараагүй урсах байсан биш үү? Салхи замбараагүй шуурах байсан биш үү? Ус, салхи зүй тогтлыг дагадаг уу? Хэрвээ Бурхан тэднийг удирдаагүй бол тэднийг захирах ямар ч зүй тогтол байхгүй байх байсан бөгөөд салхи ульж, ус задарч, үер ус нэрвэх байсан. Хэрвээ давлагаа уулнаас өндөр байсан бол далай оршиж чадах байсан уу? Чадахгүй байсан. Уул хэрвээ давлагаа шиг өндөр байдаггүй бол далай оршихгүй байсан бөгөөд уул үнэ цэн, ач холбогдлоо алдах байв.

Энэ хоёр түүхээс та нар Бурханы мэргэн ухааныг харж байна уу? Бурхан оршин буй бүх зүйлийг бүтээсэн бөгөөд Тэр оршин буй бүхнийг захирдаг; Тэр бүхнийг удирдаж, хангаж, оршин буй бүхний үг, үйлдэл бүрийг нь харж, гярхай ажигладаг. Тэр бас хүний амьдралын булан тохой бүрийг харж, гярхай ажигладаг. Иймээс Бурхан бүтээлд нь багтдаг юм бүрийн чиг үүрэг, шинж чанар, оршин тогтнох зүй тогтлоос нь эхлээд амьдралынх нь ач холбогдол, оршин тогтнолынх нь үнэ цэнийг нэгд нэггүй тодорхой мэддэг. Бурхан бүх зүйлийг бүтээсэн, тэдгээрийг захирдаг зүй тогтлыг Бурхан судлах хэрэгтэй гэж та нар бодож байна уу? Энэ тухай судалж, ойлгохын тулд Бурхан хүний мэдлэг, эсвэл шинжлэх ухааныг сурах хэрэгтэй юу? (Үгүй.) Тэгвэл хүн төрөлхтний дотор бүх зүйлийг Бурханы адил ойлгодог уудам ухаантай, өргөн мэдлэгтэй хүн байгаа юу? Байхгүй, тийм үү? Бүх зүйл хэрхэн

амьдарч, өсдөгийг үнэхээр ойлгодог одон оронч, биологич байдаг уу? Юм бүхний оршин тогтнолын үнэ цэнийг тэд үнэхээр ойлгож чадна гэж үү? (Чадахгүй.) Яагаад гэвэл, бүх зүйлийг Бурхан бүтээсэн болохоор хүн хэчнээн их, хэчнээн гүнзгий судалсан ч, хэчнээн жил чармайсан ч, Бурхан бүх зүйлийг бүтээсний нууц болон зорилгыг хэзээ ч ухан ойлгож чадахгүй. Тийм биш гэж үү? Энэ хүртэл хэлэлцсэн болохоор “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэсэн үгийн жинхэнэ утгыг та нар бага ч атугай ойлгож чадав уу? (Тийм.) Намайг “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдэг энэ сэдвийг ярихад олон хүн шууд л “Бурхан бол үнэн, биднийг хангахын тулд Бурхан үгээ ашигладаг” гэх өөр үгийн тухай бодохоос биш тэр сэдвийн учир утгын түвшнээс цааш бодохгүй гэдгийг Би мэдэж байсан. “Бурхан хүний амьдралыг хангаж, өдөр тутмын хоол унд, хэрэгцээг хангадаг нь хүнийг хангаж байгаад тооцогдохгүй” хэмээн боддог хүмүүс ч бий. Зарим хүнд ингэж санагддаггүй гэж үү? Хүн төрөлхтнийг хэвийн оршин тогтнуулж, амьдруулахын тулд бүх зүйлийг бүтээсэн Бурханы санаа зорилго тун тодорхой биш байна гэж үү? Бурхан хүмүүсийн амьдардаг хүрээлэн буй орчныг хэвээр хадгалж, хүн төрөлхтний оршин тогтнолд хэрэгтэй бүхнээр хангадаг. Түүнчлэн бүх зүйлийг удирдаж, ноёрхдог. Энэ бүхэн нь хэвийн байдлаар амьдарч, хөгжиж, үржих боломжийг хүн төрөлхтөнд олгодог; Бурхан ийм арга барилаар бүх зүйл болон хүн төрөлхтнийг хангадаг. Ийм юмыг хүмүүс танин мэдэж, ойлгох хэрэгтэй биш гэж үү? Зарим хүн: “Энэ сэдэв жинхэнэ Бурханы Өөрийнх нь тухай бидний мэдлэгээс дэндүү хол юм. Хүн зөвхөн талхаар биш, харин Бурханы үгээр амьдардаг учраас бид үүнийг мэдэхийг хүсэхгүй байна” гэж хэлж магадгүй. Ингэж ойлгох нь зөв үү? (Үгүй.) Яагаад буруу вэ? Бурханы хэлсэн зүйлийг л мэдлээ гээд Бурханы талаар бүрэн гүйцэд ойлголттой болж чадах уу? Хэрвээ та нар Бурханы ажил, шүүлт, гэсгээлтийг л хүлээн зөвшөөрвөл Бурханы талаар бүрэн гүйцэд ойлголттой болж чадах уу? Хэрвээ та нар Бурханы зан чанарын жаахан хэсгийг, Бурханы эрх мэдлийн багахан хэсгийг л мэддэг бол Бурханы тухай ойлголттой болоход тэр нь хангалттай гэж үзэх үү? (Үгүй.) Бурханы үйлдэл бүх зүйлийг бүтээхээс эхэлдэг ба өнөөдөр ч үргэлжилдэг—Бурханы үйлдлүүд цаг үргэлж, хором бүрд илэрхий байдаг. Бурхан нэг бүлэг хүмүүсийг сонгож аваад тэр хүмүүсийг аврахаар тэдэн дээр ажилладаг учраас л Бурхан оршдог болохоос биш өөр юу ч Бурханы эрх мэдэл, ялгамж чанарт ч, үйлдэлд ч хамаагүй гэж итгэдэг бол ийм хүнийг Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй гэж үзэж болох уу? “Бурханы тухай мэдлэг” гэгчтэй хүмүүс өрөөсгөл ойлголттой байдаг бөгөөд үүнийхээ дагуу Түүний үйл хэргийг зөвхөн нэг бүлэг хүмүүсээр хязгаарладаг. Энэ нь Бурханы тухай жинхэнэ мэдлэг мөн үү? Бурханы талаар иймэрхүү мэдлэгтэй хүмүүс, Бурхан бүх зүйлийг бүтээсэн гэдгийг, бас Бурхан бүх зүйлийг ноёрхдог гэдгийг үгүйсгэж байгаа биш гэж үү? Зарим хүн үүнд анхаарал хандуулахыг хүсдэггүй, харин “Бурхан бүх зүйлийг ноёрхдогийг би хараагүй. Энэ санаа надаас хэтэрхий хол зүйл, би ойлгох гэж оролдох ч үгүй. Бурхан юу хүссэнээ хийдэг, энэ нь надад огт хамаагүй. Би зөвхөн Бурханы

удирдлагыг болон Бурханы үгийг хүлээн авахад анхаарна, ингэснээр би Бурханаар аврууллж, төгс болгуулж чадна. Надад өөр юу ч хамаагүй. Бурхан бүх зүйлийг бүтээхдээ ямар зүй тогтол тогтоосон ч бай, бүх зүйл болон хүн төрөлхтнийг хангахдаа юу ч хийдэг бай, надад огт хамаагүй" гэж боддог. Энэ ямар гээчийн яриа вэ? Энэ тэрслүү үйлдэл биш гэж үү? Та нарын дотор ийм бодолтой хүн байна уу? Та нар өөрсдөө хэлэхгүй ч гэсэн та нараас олон хүн ингэж боддогийг Би мэднэ. Дүрэм журмыг ягштал баримталдаг ийм хүмүүс аливаа юмыг өөрсдийн "сүнслэг" үзэл бодлын үүднээс хардаг. Тэд Бурханыг Библиэр хязгаарлаж, Өөрийнх нь хэлсэн үгээр Бурханыг хязгаарлаж, бичигдсэн үгийн үгчилсэн утгаар Бурханыг хязгаарлахыг л хүсдэг. Тэд Бурханы талаар илүү ихийг мэдэхийг хүсдэггүй, мөн Бурхан өөр зүйл хийхэд анхаарлаа хандуулаасай гэж хүсдэггүй. Ийм төрлийн бодол гэнэн бөгөөд дэндүү шашинлаг. Ийм үзэл бодол баримталдаг хүмүүс Бурханыг мэдэж чадах уу? Бурханыг мэдэхэд тэдэнд тун хэцүү байх болно. Өнөөдөр Би дор бүрнээ өөр өөр талыг хөндсөн хоёр түүх ярилаа. Эдгээрийг дөнгөж сонсоход та нарт гүнзгий утгатай, эсвэл жаахан хийсвэр ч юм шиг, ухаарч ойлгоход хэцүү ч юм шиг санагдаж болох юм. Тэдгээрийг Бурханы үйлдэлтэй болон Бурхантай Өөртэй нь холбоход хэцүү байж магад. Гэхдээ Бурханы бүх үйлдлийг, бүтээлд болон хүн төрөлхтний дунд Бурханы хийсэн бүхнийг хүн бүр, Бурханыг мэдэхээр эрж хайдаг хүн бүхэн тодорхой, үнэн зөв мэдэх ёстой. Энэхүү мэдлэг Бурхан үнэхээр оршдог гэдэг итгэлд чинь баталгаа өгнө. Энэ нь бас чамд Бурханы мэргэн ухаан, хүч чадлын талаар, мөн Бурхан бүх зүйлийг хэрхэн хангадаг талаар үнэн зөв мэдлэг өгнө. Энэ нь чамд Бурханы жинхэнэ оршин тогтнол бол зохиомол биш, үлгэр домог биш, тодорхойгүй биш, онол биш бөгөөд нэг төрлийн шашны тайтгаруулах зүйл яавч биш, харин жинхэнэ оршин байдаг гэдгийг тодорхой ойлгуулна. Түүнчлэн Бурхан бүх зүйл болон хүн төрөлхтнийг үргэлж хангаж байдаг; Бурхан үүнийг Өөрийнхөө арга замаар, Өөрийнхөө хэмнэлээр хийдэг гэдгийг мэдэх боломжийг хүнд олгодог. Тэгэхээр, Бурхан бүх зүйлийг бүтээгээд тэдэнд зүй тогтол өгсөн болохоор Түүний урьдчилан тогтоосноор тэд тус бүрдээ өөрсдөд нь ноогдсон ажлыг хийж, хариуцлагаа биелүүлж, үүргээ гүйцэтгэх чаддаг; Бурханы урьдчилан тогтоосноор юм бүхэн хүн төрөлхтний төлөө, хүн төрөлхтний оршин амьдардаг орон зай, хүрээлэн буй орчны төлөө байдаг. Хэрвээ Бурхан ингэж хийгээгүй бол, хүн төрөлхтний амьдрах орчин ийм байгаагүй бол Бурханд итгэж, Түүнийг дагах нь хүн төрөлхтөнд боломжгүй байх байсан; энэ нь ердөө л хий дэмий яриа болох байсан. Тийм биш гэж үү?

Өндөр уул ба жижиг горхины тухай түүхийг дахиад нэг авч үзье. Уулын үүрэг юу вэ? Уулан дээр амьтай юмс цэцэглэн үрждэг, тэгэхээр уулын оршин тогтнол чухал үнэ цэнтэй бөгөөд бас жижиг горхийг хаан, дурааараа урсаж, хүмүүст гай гамшиг учруулахыг нь болиулсан. Тийм биш гэж үү? Уул, өөрийнхөө дээр амьдардаг үй түмэн зүйл—мод, өвс, бусад бүх төрлийн ургамал, амьтанд цэцэглэн үржих боломж олгон мөрөөрөө оршдог. Тэр бас жижиг горхины урсгах замыг чиглүүлсэн—уул,

горхины усыг цуглуулаад бэлээрээ хэвийн урсгаж, голд нийлүүлэн, яваандаа далайд цутгуулсан. Эдгээр зүй тогтол аяндаа бий болоогүй, харин бүтээлийн үед Бурхан онцгойлон зохицуулсан юм. Өндөр уул ба ширүүн салхины тухайд, ууланд ч гэсэн салхи хэрэгтэй. Өөрийнхөө дээр амьдардаг амьд бүхнийг илбэн таалахын тулд ууланд салхи хэрэгтэй, үүний зэрэгцээ салхийг дур зоргоор нь шуурууулахгүйн тулд хүчийг нь хязгаарладаг. Нэг талаараа энэ зүй тогтол бол их уулын үүрэг юм; гэхдээ уулын үүрэг болсон энэ зүй тогтол өөрөө үүсчихсэн үү? (Үгүй.) Үүнийг Бурхан бий болгосон юм. Өндөр уул өөрийн үүрэгтэй байдаг шиг ширүүн салхи ч бас өөрийн үүрэгтэй. Тэгвэл, өндөр уул ба аварга давлагааны тухай ярилцъя. Уул байгаагүй бол ус өөрөө чиглэлээ олоод урсах байсан уу? (Үгүй.) Ус үерлэх байсан. Уул нь уул гэдгээрээ өөрийн оршин тогтнолын үнэ цэнтэй, далай нь далай гэдгээрээ өөрийн оршин тогтнолын үнэ цэнтэй; гэвч хамтдаа зүгээр оршиж чаддаг, бие биедээ саад болдоггүй нөхцөлд тэд бас бие биеэ хязгаарладаг—өндөр уул далайг хязгаарласнаар далай эс үерлэж, тэгснээрээ хүмүүсийн орон гэрийг хамгаалдаг бөгөөд далайг хязгаарласнаар бас далайд амьдардаг амьтай зүйлсийг тэжээн тэтгэх боломжтой болдог. Энэ газрын гадаргуу өөрөө үүсчихсэн үү? (Үгүй.) Үүнийг бас л Бурхан бүтээсэн. Бурхан бүх зүйлийг бүтээхдээ уул хаана байхыг, горхи хаагуур урсахыг, ширүүн салхи хаанаас гарч хаашаа үлээхийг, аварга давлагаа хэр өндөр байхыг урьдаас тогтоосон гэдгийг бид энэ зураглалаас хардаг. Энэ бүх зүйл Бурханы санаархал, зорилгыг агуулсан бөгөөд тэдгээр нь Түүний үйл хэрэг билээ. Одоо та нар Бурханы үйл хэрэг бүх зүйлд байдгийг харж чадав уу? (Чадлаа.)

Бид эдгээрийг ярилцах нь ямар зорилготой вэ? Бүх зүйлийг бүтээхдээ Бурханы баримталсан зүй тогтлыг хүмүүсээр судлуулах гэж тэр үү? Аль эсвэл, одон орон, газар зүй сонирхохыг нь дэмжих гэж тэр үү? (Үгүй.) Тэгвэл ямар зорилготой юм бэ? Хүмүүст Бурханы үйл хэргийг ойлгуулах зорилготой. Бурханы үйлдлүүдээс хүмүүс, Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж мөн гэдгийг нотолж, баталж чадна. Хэрвээ чи энэ зүйлийг ойлгож чадвал өөрийн зүрх сэтгэл дэх Бурханы байр суурийг үнэхээр баталж, Бурхан бол тэнгэр, газар, бүх зүйлийг Бүтээсэн цор ганц Бурхан Өөрөө мөн гэдгийг баталж чадна. Тэгэхээр бүх зүйлийн зүй тогтлыг мэдэж, Бурханы үйл хэргийг мэдэх нь Бурханы талаарх ойлголтод чинь ашиг тустай юу? (Тийм.) Хэр ашиг тустай вэ? Юуны өмнө, Бурханы үйл хэргийг ойлгочихоод чи одон орон ба газар зүй сонирхсон хэвээр байж болох уу? Бурхан бол бүх зүйлийн Бүтээгч гэдэгт эргэлзэж, тээнэгэлзсэн зүрх сэтгэлтэй байсаар байж болох уу? Чи судлах хандлагатай байж, Бурхан бол бүх зүйлийн Бүтээгч мөн гэдэгт эргэлзсээр байж болох уу? (Үгүй.) Чи Бурхан бүх зүйлийг бүтээсэн гэдгийг баталж, Бурхан бүх зүйлийг бүтээсэн зарим зүй тогтлыг ойлгоод Бурхан бүх зүйлийг хангадаг гэдэгт үнэн сэтгэлээсээ итгэх үү? (Тийм.) Энд “хангах” гэдэг нь ямар нэгэн тодорхой утгатай юу, эсвэл онцгой нөхцөл байдлын талаар хэлж байна уу? “Бурхан бүх зүйлийг хангадаг” гэдэг үг маш өргөн утга учир, цар хүрээтэй. Бурхан хүмүүсийг

өдөр тутмын хоол ундаар л хангадаг юм биш; харин хүмүүсийн хардаг болон харж эс чадах зүйлийг бүгдийг нь оролцуулаад хэрэгтэй бүхнээр нь хүн төрөлхтнийг хангадаг. Бурхан хүн төрөлхтөнд маш чухал амьдрах орчныг нь тогтоон барьж, удирдаж, захирдаг. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөнд ямар улиралд ямар орчин хэрэгтэй байна, Бурхан түүнийг бэлдсэн. Хүн төрөлхтөн оршин тогтноход зохистой уур амьсгал, дулааны хэмийг Бурхан бас удирддаг. Эдгээр зүйлийг захирдаг зүй тогтол өөрөө санаандгүй үүсдэггүй; тэдгээр нь Бурханы дээд эрх ба үйл хэргийн үр дүн юм. Бурхан Өөрөө энэ бүх зүй тогтлын эх сурвалж бөгөөд бүх зүйлийн амийн эх сурвалж билээ. Чи үүнд итгэдэг ч бай, үгүй ч бай, үүнийг хардаг ч бай, үгүй ч бай, ойлгодог ч бай, үгүй ч бай, энэ бол маргашгүй баттай үнэн хэвээр үлдэнэ.

Хүмүүсийн дийлэнх олонх нь Библид агуулагддаг Бурханы үг, ажилд л итгэдэг гэдгийг Би мэднэ. Цөөхөн хүмүүст л Бурхан үйл хэргээ илчилсэн ба Өөрийн оршин тогтнолын үнэ цэнийг хүмүүст харуулсан. Тэр бас тэдэнд Өөрийн ялгамж чанарыг бага зэрэг ойлгуулж, Өөрийн оршин тогтнолын баримтыг баталгаажуулсан юм. Гэхдээ Бурхан бүх зүйлийг бүтээж, бүх зүйлийг удирдаж, хангадаг гэх бодит үнэн олон хүнд бүрхэг, эсвэл тодорхой бус санагддаг; ийм хүмүүс бүр эргэлзсэн хандлага баримталдаг ч байж болно. Ийм хандлага нь, байгаль ертөнцийн хууль өөрөө аяндаа бий болсон, мөн байгалийн өөрчлөлт, хувирал, үзэгдлүүд, эдгээрийг захирдаг тэрхүү хуулиуд нь байгалиас үүссэн гэж туйлбартай итгэхэд хүмүүсийг хүргэдэг. Бурхан бүх зүйлийг хэрхэн бүтээснийг болон тэдгээрийг хэрхэн захирдгийг хүмүүс сэтгэлдээ ухаарч чаддаггүй; Бурхан бүх зүйлийг хэрхэн удирдаж, хангадгийг ойлгож чаддаггүй. Ийм нөхцөлд хязгаарлагдаад Бурхан бүх зүйлийг бүтээж, захирч, бүх зүйлийг хангадаг гэдэгт хүмүүс итгэж чаддаггүй; итгэдэг хүмүүс хүртэл зөвхөн Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе болон Хаанчлалын эрин үеэр хязгаарлагддаг: Тэд Бурханы үйл хэрэг болон хүн төрөлхтнийг хангадаг нь гагцхүү Түүний сонгосон хүмүүст л зориулагдсан гэж итгэдэг. Энэ бол Миний хамгийн жигшдэг зүйл бөгөөд маш их шаналал авчирдаг зүйл юм. Яагаад гэвэл, хүн төрөлхтөн Бурханаас ирсэн бүхнийг эдэлдэг атлаа Бурханы хийдэг бүхнийг, өөрсдөд нь өгдөг бүхнийг үгүйсгэдэг. Тэгээд тэнгэр, газар, бүх зүйл байгалийн зүй тогтолдоо болон оршин тогтнох байгалийн хуульдаа захирагддаг, тэдгээрийг удирддаг ямар ч захирагч байхгүй, эсвэл тэднийг хангадаг, хамгаалдаг ямар ч захирагч байхгүй гэж л хүмүүс итгэдэг. Чи Бурханд итгэдэг ч гэсэн, энэ бүхэн нь Бурханы үйл хэрэг гэдэгт итгэдэггүй байж магадгүй; үнэндээ, энэ нь Бурханд итгэдэг бүхэн, Бурханы үгийг хүлээн авдаг бүхэн, Бурханыг дагадаг болгоны хамгийн их орхигдуулдаг зүйлийн нэг юм. Тийм болохоор, Намайг Библитэй, эсвэл сүнслэг нэр томьёо гэгчтэй хамаагүй юм яриад эхлэнгүүт зарим хүн уйдаж, залхаж, бүр тавгүйтдэг. Миний үг сүнслэг хүмүүс болон сүнслэг юмсаас хөндийрсөн мэт тэдэнд санагддаг. Тэр их муу зүйл. Бурханы үйл хэргийг мэдэх тухайд бол бид хэдийгээр одон орны талаар дурддаггүй, мөн газар зүй, биологи судалдаггүй ч гэсэн, Бурхан бүх зүйлийг захирдгийг ойлгох ёстой, Тэр бүх зүйлийг хангадгийг

болон Тэр бол бүх зүйлийн эх сурвалж гэдгийг мэдэх ёстой. Энэ бол заавал байх ёстой, заавал сурах ёстой хичээл юм. Миний үгийг ойлгов уу?

Миний дөнгөж сая ярьсан хоёр түүх та нарын хувьд хэдийгээр агуулга, илэрхийлэх маягаараа жаахан жирийн бус боловч бага зэрэг өвөрмөц байдлаар ярьсан нь та нарт илүү гүнзгий зүйл ухаарч, хүлээн зөвшөөрөхөд чинь туслахын тулд хялбар үг хэллэг, энгийн арга ашиглах гэсэн Миний оролдлого байлаа. Энэ бол Миний цор ганц зорилго байсан. Эдгээр богино түүх болон зураглалаас та нар, Бурхан бол бүх зүйлийг Захирагч гэснийг харж, итгээсэй гэж Би хүссэн билээ. Эдгээр түүхийг ярих зорилго бол түүхийн хязгаарлагдмал хүрээн дотроос Бурханы хязгааргүй үйл хэргийг харж, мэдэх боломжийг та нарт олгохын төлөө юм. Харин та нар өөрсдөө энэ үр дүнд хэзээ бүрэн хүрэх нь хувийн туршлага, эрэл хайгуулаас чинь хамаарна. Чи үнэнийг эрэлхийлж, Бурханыг мэдэхээр эрмэлздэг бол эдгээр зүйл чамд бүр илүү хүчтэй сануулга болох болно; эдгээр нь ухамсрыг чинь гүнзгийрүүлж, ойлголтыг чинь тодорхой болгож, Бурханы бодит үйл хэрэгт ойртох бөгөөд зай завсаргүй, алдаа мадаггүй ойр дотно болно. Гэхдээ чи Бурханыг мэдэхээр эрж хайдаггүй бол чиний сонссон эдгээр түүх чамд ямар ч хохирол учруулж чадахгүй. Зүгээр л үнэн түүх гэж бод.

Энэ хоёр түүхээс та нар ямар нэг зүйл ойлгож авав уу? Нэгдүгээрт, энэ хоёр түүх үүний өмнө Бурхан хүн төрөлхтөнд санаа тавьдаг тухай бидний хийсэн хэлэлцүүлгээс салангид байна уу? Ямар нэг холбоо хамаарал байна уу? Энэ хоёр түүхээс бид Бурханы үйл хэргийг болон Бурхан хүн төрөлхтөнд зориулан төлөвлөхдөө бүх зүйлийг сайтар тунгаан бодсоныг хардаг гэж үнэн үү? Бурханы хийдэг бүхэн болон Түүний боддог бүхэн хүн төрөлхтний оршин тогтнолын төлөө байдаг уу? (Тийм.) Бурхан хүн төрөлхтний төлөө нарийвчлан бодож, нягталсан нь маш тодорхой байгаа бус уу? Хүн төрөлхтөн юу ч хийх шаардлагагүй. Бурхан хүмүүст агаар бэлдсэн, тэд амьсгалахаас өөр юм хийх хэрэггүй. Тэдний иддэг ногоо, жимс бэлэн байж байдаг. Умардаас өмнөд, зүүнээс баруун хүртэл бүс нутаг бүрд байгалийн баялаг байдаг. Янз бүрийн бүсийн тариа будаа, жимс ногоог бүгдийг Бурхан бэлдсэн. Өргөн хүрээнд яривал, Бурхан бүх зүйлийг харилцан холбоотой, харилцан уялдаатай, зэрэгцэн оршихоор бүтээжээ. Тэр энэ арга зам, зүй тогтлыг ашиглан бүх зүйлийг мэнд байлгаж, оршин тогтнуулдаг; ийм маягаар хүн төрөлхтөн энэхүү хүрээлэн буй орчинд амар жимэр, энх тунх амьдарч, өнөөг хүртэл үеэс үед үржиж олширсоор иржээ. Өөрөөр хэлбэл, Бурхан байгаль орчинд тэнцвэр авчирдаг. Хэрвээ Бурханы дээд эрх, хяналт байгаагүй бол, Бурхан бүтээсэн ч гэсэн хүрээлэн буй орчны тэнцвэрийг барьж, хадгалах явдал ямар ч хүний хэрээс хэтрэх байсан юм. Зарим газар агаар байдаггүй, хүн тийм газар амьдарч чадахгүй. Бурхан чамайг тийш явуулахгүй. Тиймээс зохистой хил хязгаарыг бүү дав. Энэ нь хүн төрөлхтнийг хамгаалахын төлөө бөгөөд энд нууцлаг зүйл бий. Хүрээлэн буй орчны өнцөг булан бүрийг, газар дэлхийн урт, өргөнийг, дэлхий дээрх амьтан бүрийг—амьд, үхсэн хоёуланг—урьдаас Бурхан бодож,

бэлтгэсэн. Энэ зүйл яагаад хэрэгтэй вэ? Тэр зүйл яагаад хэрэггүй вэ? Энэ зүйлийг энд байлгах зорилго юу вэ, тэр зүйл яагаад тэнд байх ёстой вэ? Бурхан энэ бүх асуултыг хэдийн сайтар бодсон, хүмүүст тэрийг бодох шаардлага байхгүй. Уул нүүлгэх тухай үргэлж боддог зарим мунхаг хүн байдаг, тэгэхийн оронд яагаад тал газар луу нүүдэггүй юм бэ? Хэрвээ чи ууланд дургүй бол яагаад уулын ойролцоо амьдардаг юм бэ? Энэ чинь мунхаг биш гэж үү? Хэрвээ чи тэр уулыг нүүлгэвэл юу болох вэ? Хар салхи гарч, аварга давлагаа ирж, хүмүүсийн орон гэр сүйднэ. Энэ мунхаг хэрэг байх бус уу? Хүмүүс зөвхөн сүйтгэж л чаддаг. Тэд өөрсдийн оршин амьдрах орчныг ч хадгалж хамгаалж чадахгүй байж, бас бүх зүйлийг хангахыг хүсдэг. Энэ боломжгүй.

Бүх зүйлийг удирдаж, тэдний эзэн болохыг Бурхан хүн төрөлхтөнд зөвшөөрдөг боловч хүн үүнийг сайн хийдэг үү? Хүн чадах бүхнээ сүйтгэдэг. Хүн төрөлхтөн Бурханы бүтээсэн бүх зүйлийг анхны байдлаар нь хадгалж ер нь чаддаггүй, харин ч эсрэг юм хийж, Бурханы бүтээлийг сүйтгэсэн. Хүн төрөлхтөн уул нүүлгэж, далай байсан газрыг хагалж, тал хээрийг хэн ч амьдрах аргагүй цөл болгосон. Тэгчихээд цөлд үйлдвэр барьж, цөмийн бааз байгуулж, хамаг газарт сүйрэл тарьсан. Одоо голууд нь гол байхаа больж, далай нь далай биш болсон… Хүн төрөлхтөн байгалийн тэнцвэр болон зүй тогтлыг нь нэгэнт алдагдуулсан, гамшиг, мөхлийнх нь өдөр холгүй бөгөөд энэ нь гарцаагүй. Гамшиг ирэхэд хүн төрөлхтний төлөө Бурханы бүтээсэн бүх зүйл хэчнээн эрхэм нандин болохыг, хүн төрөлхтөнд хэчнээн чухал болохыг тэд мэдэх болно. Хүний хувьд, салхи үлээх цагтаа үлээж, хур бороо орох цагтаа ордог орчинд амьдрах нь диваажинд байгаатай адилхан. Үүнийг ерөөл мөнгэдгийг хүмүүс ойлгодоггүй, харин энэ бүхнийг алдмагцаа ямар ховор нандин зүйл байсныг нь харна. Нэгэнт үгүй болчихвол хүн үүнийг яаж буцаан авах вэ? Бурхан үүнийг дахин бүтээхийг хүсэхгүй бол хүмүүс юу хийж чадах вэ? Та нарт хийж чадах юм бий юу? Үнэндээ, та нарын хийж чадах нэг юм бий. Энэ маш энгийн бөгөөд Намайг хэлэхээр та нар тэр боломжтой болохыг шууд ойлгоно. Хүн одоогийн ийм байдалд амьдрах болсны шалтгаан нь юу вэ? Хүний шунал ба сүйтгэлээс болоогүй гэж үү? Хүн ингэж сүйтгэхээ больчихвол амьдрах орчин нь өөрөө аажмаар засрахгүй гэж үү? Хэрвээ Бурхан юу ч хийхгүй бол, хүн төрөлхтний төлөө ямар нэг юм хийхийг хүсэхээ боливол—өөрөөр хэлбэл, Тэр энэ асуудалд хөндлөнгөөс оролцохыг хүсдэггүй бол—ингэж сүйтгэхээ больж, амьдарч буй орчноо анхны байдалд буцаж орох боломж олгох нь хүн төрөлхтний хувьд хамгийн шилдэг шийдэл болох юм. Энэ бүх сүйрлийг цэглэнэ гэдэг нь Бурханы бүтээсэн бүхнийг тонож, хөнөөхөө болино гэсэн үг. Ингэх аваас хүний амьдардаг хүрээлэн буй орчин аажмаар сайжирна, харин ингэж чадахгүй бол хүрээлэн буй орчин амьдрахад улам найгүй болж, сүйрэл нь цаг тутам түргэснэ. Миний шийдэл энгийн байна уу? Энгийн агаад боломжтой байгаа биз? Зарим хүнд үнэхээр энгийн бөгөөд зарим хүний хувьд боломжтой, гэхдээ газар дээрх ихэнх хүний хувьд боломжтой юу? (Үгүй.) Ядаж та нарын хувьд боломжтой юу? (Тийм.) Тэгвэл, та нар яагаад

“тийм” гэж хэлж байна? Бурханы үйл хэргийн тухай ойлголтын суурин дээр үүнийг хэлсэн гэж болох уу? Бурханы эрх мэдэл, төлөвлөгөөнд дуулгавартай дагах нь үүний нөхцөл гэж болох уу? (Болно.) Энэ бүхнийг өөрчлөх арга зам бий, гэхдээ өнөөдөр бид энэ сэдвээр ярихгүй. Бурхан хүн нэг бүрийн амьдралыг хариуцдаг ба эцсийг нь хүртэл хариуцдаг. Чи Сатаны сүйтгэсэн энэ орчноос болж өвчилсөн ч, бохирдолд нэрвэгдсэн, эсвэл хохирол амссан байсан ч хамаагүй, Бурхан чамайг хангаж, чамайг амьдруулна. Чи үүнд итгэх ёстой. Бурхан хүнийг амархан үхүүлэхгүй.

Одоо та нар “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдгийг ойлгохын чухлыг бага зэрэг мэдэрсэн үү? (Тийм ээ, тэгсэн.) Юу мэдэрсэн бэ? Надад хэл дээ. (Урьд нь бид уул, далай, нуурыг Бурханы үйлдэлтэй хэзээ ч холбон бодож байсангүй. Өнөөдөр харин Бурханы нөхөрлөлийг сонсоод эдгээр зүйл дотроо Бурханы үйлдэл, Бурханы мэргэн ухааныг агуулж байдгийг ойлголоо; Бурхан бүх зүйлийг бүтээж эхлэхдээ л юм дор бүрд нь хувь тавилан, Өөрийн сайн хүслийг шингээснийг харлаа. Бүх зүйл харилцан хүч нэмж, харилцан түшиглэдэг ба эцсийн дүндээ хүн төрөлхтөнд ашиг тустай байдаг. Өнөөдрийн бидний сонссон зүйл цоо шинэ, ер бишийн санагдаж, Бурханы үйлдэл хэчнээн бодит болохыг бид мэдэрлээ. Бодит байдал дээр, өдөр тутмын амьдралдаа, бүх зүйлтэй тулгарахдаа ийм гэдгийг нь хардаг.) Үнэхээр харсан биз дээ? Бурхан хүн төрөлхтнийг баттай суурьгүйгээр хангадаггүй; Түүний хангалт хэдхэн богино үг биш. Бурхан маш ихийг хийсэн бөгөөд чиний хардаггүй зүйл хүртэл чамд ашиг тустай байдаг. Хүн өөрийнх нь төлөө Бурханы бүтээсэн бүх зүйлийн дунд, хүмүүс болон бусад зүйлс бие биеэ түшиглэдэг энэ орчинд амьдардаг. Жишээлбэл, ургамлаас гардаг хий агаарыг цэвэршүүлж, хүмүүс цэвэр агаар амьсгалан ашиг тусыг нь хүртдэг; гэхдээ зарим ургамал хүнд хортой байхад хортой ургамлын ерөндөг өөр ургамлуудад байдаг. Энэ бол Бурханы бүтээлийн гайхамшиг мөн! Харин одоохондоо энэ сэдвийг орхиё; өнөөдөр бид голдуу хүн ба бусад зүйлс зэрэгцэн орших тухай, хүн үүнгүйгээр амьдарч чадахгүй тухай хэлэлцлээ. Бурхан бүх зүйлийг бүтээсний ач холбогдол юу вэ? Амьдрахын тулд хүнд агаар зайлшгүй хэрэгтэй ба хэрвээ чамайг агааргүй орчинд байлгавал удахгүй үхэхийн адилаар хүн бусад зүйлгүйгээр амьдарч чадахгүй. Энэ бол хүн бүтээлийн бусад зүйлээс тусдаа оршин тогтнож чадахгүйг харуулах тун энгийн зарчим. Тэгвэл хүн бүх зүйлд ямар хандлага баримтлах ёстой вэ? Тэднийг нандигнан хайрлаж, хамгаалж, үр дүнтэй ашиглах ёстой, харин сүйтгэж, үрэн таран хийж, дураараа өөрчилж болохгүй, учир нь бүх зүйл Бурханаас ирдэг, бүх зүйл бол хүнд өгдөг Түүний хангалт бөгөөд хүн төрөлхтөн тэдэнд ухамсартай хандах ёстой. Өнөөдөр бид энэ хоёр сэдвийг хэлэлцлээ. Та нар сайтар эргэцүүлж, сайн тунгааж бодоорой. Дараагийн удаа бид зарим зүйлийг илүү дэлгэрэнгүй ярилцана. Үүгээр өнөөдрийн нөхөрлөл дуусаж байна. Баяртай!

2014 оны 1 дүгээр сарын 18

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ VIII
БУРХАН БОЛ БҮХ ЗҮЙЛИЙН АМИЙН ЭХ СУРВАЛЖ (II)

Бид өмнөх сэдвийн талаар үргэлжлүүлэн нөхөрлөнө. Өнгөрсөн удаа бид ямар сэдвээр нөхөрлөснийг санаж байна уу? (Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж.) “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэсэн энэ сэдэв та нарт их хол санагдаж байна уу? Эсвэл та нар зүрх сэтгэлдээ аль хэдийн бүдүүн тоймын ойлголттой болсон байгаа юу? Энэ сэдвийн талаарх өмнөх нөхөрлөлийн маань гол санаа юу байсныг товчхон ярьж чадах хүн байна уу? (Бурхан бүх зүйлийг бүтээсний улмаас Бурхан бүх зүйл болон хүн төрөлхтнийг тэтгэдгийг би хардаг. Өмнө нь би, Бурхан хүнд зориулан хангалт хийхдээ зөвхөн Өөрийн сонгосон хүмүүсийг үгээрээ хангадаг гэж үргэлж боддог байсан; бүх зүйлийг захирдаг хуулиар дамжуулан Бурхан бүх хүн төрөлхтнийг тэтгэж байгааг би хэзээ ч харж байгаагүй. Тэр бол бүх зүйлийн эх сурвалж, Тэр бүх зүйлийн амийг хангадаг, Бурхан эдгээр хуулийг зохицуулж, бүх зүйлийг тэтгэдэг гэдгийг үнэний тухай Бурханы яриагаар л дамжуулан би мэддэг болсон. Бүх зүйлийг бүтээснээс нь би Бурханы хайрыг хардаг.) Өнгөрсөн удаа бид, Бурхан бүх зүйлийг бүтээсэн талаар, мөн тэдгээрт зориулж хууль, зарчмыг Тэр хэрхэн тогтоосон талаар голчлон нөхөрлөсөн. Ийм хууль, ийм зарчмын дор бүх зүйл хүнтэй хамт Бурханы ноёрхол дор, Бурханы нүдэнд амьдарч, үхэж, зэрэгцэн оршдог. Бурхан бүх зүйлийг бүтээж, мөн бүх зүйлийн өсөж үржих хууль, түүнчлэн тэдгээрийн өсөлт үржилтийн график, хэв маягийг тогтооход Өөрийн арга барилыг ашигладаг тухай бид эхлээд ярилцсан. Тэрээр энэ газар нутагт бүх зүйлийн амьдрах арга замыг бас тогтоож өгсөн, ингэснээр тэд үргэлжлүүлэн өсөж үржин, бие биеэсээ харилцан хамааралтай амьдарч болно. Ийм арга зам, хуулиуд байснаар бүх зүйл энэ газар нутаг дээр төвөггүй, амар тайван оршиж, өсөж үржиж чаддаг, ийм л орчинд хүн тогтвортой гэр орон, тогтвортой амьдрах нөхцөлтэй болж, түүндээ Бурханы удирдамж дор хэзээд урагшаа, үргэлж урагшлан амьдарч болно.

Өнгөрсөн удаа бид Бурхан бүх зүйлийг хангадаг тухай үндсэн ухагдахууныг хэлэлцсэн: Бүх зүйл хүн төрөлхтний тусын тулд оршиж, амьдраасай гэсэндээ Бурхан ийм маягаар бүх зүйлийг хангадаг. Өөрөөр хэлбэл, Бурханы тогтоосон хуулиудаас болж ийм орчин нөхцөл оршин байдаг. Бурхан эдгээр хуулийг сахиулж, захирдаг болохоор л одоогийн амьдрах орчин нөхцөл нь хүн төрөлхтөнд байгаа билээ. Өнгөрсөн удаа бидний ярилцсан зүйл болон өмнө нь бидний ярьсан Бурханы талаарх мэдлэгийн хоорондтомоохон үсрэлт байна. Ийм үсрэлт байгаагийн шалтгаан юу вэ? Учир нь, урьд нь бид Бурханыг мэдэх тухай ярилцахдаа Бурхан хүн төрөлхтнийг аварч, удирдах хүрээнд—өөрөөр хэлбэл, Бурханы сонгосон хүмүүсийг аврах, удирдах тухай ярилцаж байсан—мөн тэрхүү цар хүрээнд бид Бурхан, Бурханы үйл хэрэг, Түүний зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох, Түүний хүсэл, Тэр хүнийг үнэн болон амиар хэрхэн хангадаг тухай ярилцсан.

Гэхдээ өнгөрсөн удаа эхлүүлсэн сэдэв маань Библийн агуулга, мөн Бурхан Өөрийнх нь сонгосон хүмүүсийг аврах хүрээнд хязгаарлагддаггүй. Харин ч сэдэв нь энэхүү цар хүрээнээс хэтэрч, Библи, мөн Өөрийн сонгосон хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын гурван үе шатны хүрээнээс хальж Бурханыг Өөрийг нь хэлэлцдэг. Тиймээс Миний нөхөрлөлийн энэ хэсгийг чи сонсохдоо Бурханы талаарх мэдлэгээ Библи болон Бурханы ажлын гурван үе шатаар хязгаарлах ёсгүй. Харин харах өнцгөө нээлттэй байлгах хэрэгтэй; бүх зүйлийн дотроос Бурханы үйл хэрэг болон Түүнд юу байгаа, Тэр юу болох, мөн Бурхан бүх зүйлийг хэрхэн захирч, удирдаж байдгийг харах ёстой. Энэ аргаар, энэ суурин дээрээс чи Бурхан бүх зүйлийг хэрхэн хангадгийг харж чадна. Бурхан бол бүх зүйлийн амийн жинхэнэ сурвалж бөгөөд энэ бол үнэндээ Бурханы Өөрийнх нь жинхэнэ ялгамж чанар гэдгийг ойлгох боломжийг энэ нь хүн төрөлхтөнд олгодог. Өөрөөр хэлбэл, Бурханы ялгамж чанар, байр суурь, эрх мэдэл хийгээд Түүний бүх зүйл Өөрийг нь одоо дагаж байгаа хүмүүст зөвхөн зориулагдаагүй—зөвхөн энэ бүлэг хүн та нарт зориулагдаагүй—харин бүх зүйлд зориулагдсан билээ. Тэгэхээр бүх зүйлийн цар хүрээ маш өргөн юм. Юм бүхнийг захирдаг Бурханы захиргааны цар хүрээг тайлбарлахын тулд Би “бүх зүйл” гэдэг нэр томьёог ашигладаг, учир нь Бурханы захирдаг зүйлс зөвхөн та нарын нүдээрээ харж чадах зүйлс биш юм, үүнд бүгдийн харж чаддаг материаллаг ертөнц төдийгүй, материаллаг ертөнцөөс чанагш, хүний нүдэнд үл үзэгдэх өөр ертөнц, бүр цаашилбал, хүн төрөлхтний амьдран суух боломжгүй гараг эрхэс, сансар огторгуй багтдаг. Энэ бол бүх зүйлийг ноёрхдог Бурханы ноёрхлын цар хүрээ юм. Түүний ноёрхлын цар хүрээ маш өргөн; та нар юу ойлгож, юу харах, ямар зүйлийн талаар мэдлэгтэй байх ёстойгоо хүн нэг бүр ойлгож, харж, тодорхой мэдэх шаардлагатай, бас ёстой. Хэдийгээр “бүх зүйл” гэдэг нэр томьёоны цар хүрээ яах аргагүй маш өргөн ч гэсэн тэрхүү цар хүрээн доторх та нарын харах аргагүй буюу биечлэн хүрэх боломжгүй зүйлийн талаар Би та нарт ярихгүй. Хүмүүсийн хүрч, ойлгож, ухаарч ойлгож чадах тэрхүү цар хүрээн доторх зүйлийн талаар л Би та нарт ярина, тэгснээр хүн бүр “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдэг хэллэгийн жинхэнэ утгыг мэддэг болж чадах юм. Ингэснээр та нарт Миний нөхөрлөсөн үгийн аль нь ч дэмий хоосон үг болохгүй.

Бурхан хэрхэн бүх зүйлийг хангадаг тухай үндсэн ойлголтыг хүмүүс олж авах болов уу гэж “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдэг сэдвийн талаар энгийн ерөнхий тойм өгөхөөр түүх өгүүлэх аргыг өнгөрсөн удаа бид хэрэглэсэн. Энэхүү үндсэн ухагдахууныг та нарт заасны зорилго юу вэ? Бурханы ажил бол Библи болон Түүний ажлын гурван үе шатнаас ч илүү гэдгийг хүмүүст ойлгуулах билээ. Тэрээр хүний харж, хүрч чадахгүй маш их ажлыг хийж байдаг, энэ ажилд Тэр биечлэн анхаарал тавьдаг. Хэрвээ Бурхан өөр бусад ажлыг хийхгүйгээр гагцхүү Өөрийн удирдлага болон Өөрийн сонгосон хүмүүсийг урагшаа хөтлөх тал дээр л ажиллаж байсан бол та бүгдийг оролцуулаад энэ хүн төрөлхтний хувьд үргэлжлүүлэн урагшлахад маш хэцүү байх байсан. Энэ хүн төрөлхтөн, энэ дэлхий

ертөнц үргэлжлүүлэн хөгжиж чадахгүй байх байв. Өнөөдөр Би та нартай хийж буй нөхөрлөлийн сэдэв болох “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” хэмээх хэллэгийн ач холбогдол энд оршиж байна.

Хүн төрөлхтөнд зориулан Бурханы бүтээсэн амьдралын үндсэн орчин

Бид “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” хэмээх үгтэй холбоотой олон сэдэв, нэлээд агуулгыг хэлэлцсэн, гэхдээ Бурхан та нарыг Өөрийн үгээр хангаж, та нар дээр Өөрийн гэсгээлт, шүүлтийн ажлыг гүйцэтгэхээс гадна хүн төрөлхтөнд ямар зүйлс хайрладгийг та нар зүрх сэтгэлдээ мэддэг үү? Зарим хүн “Бурхан надад нигүүлсэл, ерөөл хайрладаг; Тэр надад сахилгажуулалт, тайтгарал өгч, намайг бүхий л байдлаар халамжилж, хамгаалдаг” гэж хэлж магад. Нөгөө хэсэг нь “Бурхан надад өдөр бүр хоол, унд хайрладаг” гэж хэлдэг бол зарим нь бүр “Бурхан надад бүхнийг хайрласан” гэж хэлнэ. Хүмүүсийн өдөр тутмын амьдралд тулгардаг тэдгээр асуудалд та нар, өөрсдийн махан биеийн амьд туршлагын цар хүрээтэй холбоотой байдлаар хариу үйлдэл үзүүлж болох юм. Бурхан хүн бүрд олон зүйлийг хайрладаг, гэхдээ энд бидний хэлэлцэж байгаа зүйл зөвхөн хүмүүсийн өдөр тутмын хэрэгцээний хүрээнд хязгаарлагдахгүй, харин хүн бүрийн харах өнцгийг тэлж, аливааг томоор харах боломж олгох зорилготой юм. Бурхан бүх зүйлийн амийн эх сурвалж тул Тэр бүх зүйлийн амийг хэрхэн тэтгэдэг вэ? Өөрөөр хэлбэл, бүх зүйлийг оршин тогтнуулахын тулд тэдний оршин тогтнол болон оршин тогтнолынх нь хуулийг хадгалах гэж Бурхан Өөрийн бүтээсэн бүх зүйлд юу өгдөг вэ? Энэ бол бидний өнөөдрийн хэлэлцүүлгийн гол санаа юм. Та нар Миний хэлснийг ойлгож байна уу? Энэ сэдэв та нарт тун танил биш байж магад боловч Би хэт гүн гүнзгий хоосон сургаалын талаар ярихгүй. Би үгээ та нарт сонсгож, ойлгуулах гэж хичээнэ. Та нар тээршээх хэрэггүй—анхааралтай сонсоход л болно. Гэхдээ, энэ мөчид Би дахин нэгэнтээ онцлох ёстой: Би ямар сэдвээр ярьж байгаа билээ? Надад хэлээч. (Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж.) Тэгэхээр Бурхан бүх зүйлийг хэрхэн хангадаг вэ? Тэр бүх зүйлийг юугаар хангадаг болохоор “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэж хэлдэг байж болох вэ? Та нарт энэ талаар ойлголт, төсөөлөл байна уу? Та нарын бараг огт мэдэхгүй, зүрх сэтгэл, оюун ухааны чинь бараг үл таних сэдвийн талаар Би ярилцаад байх шиг байна. Гэхдээ та нар энэ сэдэв болон Миний ярих зүйлсийг аливаа мэдлэг, хүмүүний соёл, судалгаатай биш харин Бурханы үйл хэрэгтэй холбож ойлгож чадна гэж Би найдаж байна. Би зөвхөн Бурхан болон Бурханы Өөрийнх нь талаар ярьж байна. Энэ бол Миний та нарт өгөх санаа юм. Та нар ойлгож байгаа, тийм үү?

Бурхан хүн төрөлхтөнд олон зүйл хайрласан. Би хүмүүсийн харж чадах зүйл, өөрөөр хэлбэл, тэдний мэдэрч чадах зүйлийн талаар яриагаа эхэлнэ. Эдгээр нь хүмүүсийн зүрх сэтгэлдээ хүлээн зөвшөөрч, ойлгож чадах зүйлс юм. Иймд Бурхан хүн төрөлхтнийг юугаар хангасан талаар ярихдаа эхлээд материаллаг ертөнцийн талаарх хэлэлцүүлгээс эхэлцгээе.

а. Агаар

Эхлээд Бурхан хүнийг амьсгалаг гэж агаарыг бүтээсэн. Агаар бол өдөр тутмын амьдралдаа хүмүүсийн хүрэлцэж болдог бодис бөгөөд хором бүрд, бүр унтаж байхдаа ч гэсэн хүмүүсийн хамааралтай байдаг зүйл юм. Бурханы бүтээсэн агаар бол хүн төрөлхтөнд асар чухал: Энэ нь амьсгалах бүрд, амьдрахад нэн чухал юм. Зөвхөн мэдэрч л болохоос харж болохгүй энэхүү бодис нь Өөрийн бүтээсэн бүх зүйлд Бурханы өгсөн хамгийн анхны бэлэг байсан юм. Гэвч агаарыг бүтээснийхээ дараа Бурхан ажлаа дууссан гэж үзээд больсон уу? Эсвэл Тэр агаарын нягтшил ямар байхыг бодолцсон уу? Тэр агаарын агууламжид юу байхыг бодолцсон уу? Бурхан агаарыг бүтээж байхдаа юу бодож байсан бэ? Бурхан яагаад агаарыг бүтээсэн бэ, үүнийг бүтээсэн шалтгаан нь юу вэ? Хүмүүст агаар хэрэгтэй, тэд амьсгалах хэрэгтэй. Юуны өмнө агаарын нягтшил хүний уушгинд тохирох ёстой. Агаарын нягтшилыг мэддэг хүн байна уу? Үнэндээ энэ асуултын тоо эсвэл мэдээлэлтэй холбоотой хариултыг хүмүүс мэдэх гойд хэрэгцээ байхгүй, хариултыг нь мэдэх бараг шаардлагагүй—ерөнхий ойлголттой байхад яг л хангалттай. Бурхан, хүний уушги амьсгалахад хамгийн тохиромжтой нягтшил бүхий агаарыг бүтээсэн. Өөрөөр хэлбэл, Тэрээр, амьсгалаар нь дамжин хүний биед амархан орж болохоор, амьсгалах үед биед нь хор хөнөөл учруулахааргүй байхаар агаарыг бүтээсэн. Бурхан агаарыг бүтээхдээ эдгээрийг бодолцсон. Дараагийн бидний ярилцах зүйл бол агаар юу агуулдаг тухай юм. Агаарын агууламж хүмүүст хоргүй, уушги, биеийн аль нэг эд эрхтнийг гэмтээхгүй. Бурхан энэ бүхнийг бодолцож үзэх хэрэгтэй байсан. Хүний амьсгалдаг агаар биед саадгүй орж, гарч байх хэрэгтэй, мөн амьсгалсны дараа агаар доторх бодисын шинж чанар, тоо хэмжээ нь цус, түүнчлэн уушги болон бие дэх хэрэггүй агаар бүхэлдээ зохих ёсоор бодисын солилцоонд орохуйц байхыг бодолцох ёстой болсон. Түүнчлэн агаарт ямар ч хортой бодис агуулагдах ёсгүй байхыг Тэр бодолцох ёстой байлаа. Агаарын энэхүү хоёр стандартын талаар Би та нарт хэлж байгаа нь тодорхой нэг мэдлэгээр хангах гэсэн юм биш, харин Бурхан Өөрийн бүтээл дэх юм болгоныг бүтээхдээ бодсоныхоо дагуу бүтээсэн, Түүний бүтээсэн бүхэн нь байж болох хамгийн сайн нь гэдгийг та нарт харуулахыг зорьсон юм. Түүнээс гадна, агаар дахь тоосны хэмжээ; газар дээрх тоос, элс, шорооны хэмжээ; түүнчлэн тэнгэрээс газар луу туугдан ирдэг тоосны хэмжээний тухайд гэвэл, тэдгээрийг арилгах, задлах арга зам гээд эдгээр зүйлийг удирдах Өөрийн гэсэн арга зам ч бас Бурханд байдаг. Тодорхой хэмжээний тоос байдаг ч гэсэн Бурхан, тоос бие махбод, хүний амьсгалд хор хөнөөл учруулахааргүй, тоосны өчүүхэн ширхгүүд нь бие махбодод аюулгүй байхуйц хэмжээтэйгээр бүтээсэн. Бурхан агаарыг бүтээсэн нь нууцлаг байгаа бус уу? Энэ нь амнаасаа жаахан агаар үлээхтэй адил энгийн байсан уу? (Үгүй.) Түүний бүтээсэн хамгийн энгийн зүйлд ч Бурханы нууцлаг байдал, Түүний оюун ухааны ажиллаж байгаа байдал, Түүний сэтгэлгээний арга барил, Түүний мэргэн ухаан цөм илэрхий

байдаг. Бурхан бодитой бус уу? (Тийм ээ, Тэр бодитой.) Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл Бурхан эгэл зүйлийг бүтээхдээ ч хүн төрөлхтнийг бодож байсан юм. Юуны өмнө, хүний амьсгалдаг агаар цэвэр, агууламж нь хүн амьсгалахад зохимжтой, хоргүй, хүнд хор хөнөөл учруулдаггүй; агаарын нягтшил нь мөн л ижилхэн хүн амьсгалахад тохирсон байдаг. Хүмүүсийн тогтмол амьсгалж, гаргаж байдаг энэхүү агаар хүний биед, хүний махан биед нэн чухал юм. Иймээс хүмүүс саадгүй, санаа зоволгүйгээр чөлөөтэй амьсгалж болно. Тэд ийнхүү хэвийн амьсгалж болно. Агаар бол Бурханы эхэнд нь бүтээсэн зүйл бөгөөд хүн амьсгалахад зайлшгүй шаардлагатай билээ.

б. Температур

Бидний хэлэлцэх хоёр дахь зүйл нь температур юм. Хүн бүр температур гэж юу болохыг мэднэ. Температур бол хүн амьдрахад зохимжтой орчинд нэн чухал зүйл билээ. Жишээ нь, хэрвээ температур хэт өндөр, цельсийн 40 хэмээс дээш температуртай байлаа гэж бодоход хүмүүсийг маш ихээр туйлдуулах байсан бус уу? Тийм нөхцөлд амьдрахад хүмүүст хэцүү бэрх байх байсан бус уу? Хэрэв температур хэт бага байсан бол бас яах вэ? Температур цельсийн хасах 40 хэм хүрдэг байлаа гэж бодоход хүмүүс ийм нөхцөл байдлыг ч бас тэвчиж чадахгүй. Тиймээс Бурхан хүний биеийн дасан зохицож чадах температурын хэлбэлзлийн хязгаар болох ойролцоогоор цельсийн хасах 30 хэмээс 40 хэм байх энэ температурын хязгаарыг тогтоохдоо үнэндээ маш нарийн хандсан байдаг. Хойд зүгээс өмнө зүг хүртэлх газар нутаг дахь температур үндсэндээ энэ хязгаарын дотор байдаг. Хүйтэн бүс нутагт температур магадгүй цельсийн хасах тавь, жаран хэм хүртэл буурч болно. Бурхан ийм бүс нутагт хүмүүсийг амьдруулахгүй байсан. Тэгвэл яагаад ийм тэсгэм хүйтэн бүс нутаг байдаг вэ? Үүнд зориулсан Өөрийнх нь мэргэн ухаан, санаа зорилго Бурханд бий. Тэр чамайг тийм газруудын ойр явуулахгүй. Бурхан хэт хүйтэн болон хэт халуун газрыг хамгаалдаг нь хүнийг тэнд амьдруулахаар төлөвлөөгүй гэсэн үг юм. Эдгээр газар нь хүн төрөлхтөнд зориулагдаагүй. Гэхдээ Бурхан яагаад ийм газруудыг дэлхий дээр байлгадаг юм бэ? Хэрвээ энэ газруудад хүн суурьшиж, бүр амьд үлдэхийг Бурхан зөвшөөрөхгүй юм бол Бурхан тэдгээрийг яах гэж бүтээсэн юм бэ? Бурханы мэргэн ухаан энд оршдог. Өөрөөр хэлбэл, хүний амьдрах орчны температурын хязгаарыг Бурхан ул суурьтайгаар тохируулсан. Энд ч бас байгалийн хууль үйлчилж байдаг. Температурыг хадгалж, барихын тулд зарим нэг зүйлийг Бурхан бүтээсэн. Тэдгээр нь юу вэ? Юуны өмнө, нар хүмүүст дулаан илчийг авчирдаг боловч энэхүү дулаан илч нь хэтэрхий их бол хүмүүс тэвчиж чадах уу? Наранд ойртож зүрхлэх хүн бий юу? Наранд дөхөж очиж чадах ямар нэгэн шинжлэх ухааны төхөөрөмж дэлхий дээр бий юу? (Үгүй.) Яагаад чадахгүй вэ? Нар хэт халуун. Хэтэрхий ойртсон ямар ч зүйл хайлна. Тиймээс Бурхан, хүн төрөлхтний дээр байх нарны өндөр, нар хүн хоёрын хоорондох зайг Өөрийн нарийн тооцоо, стандартын дагуу тогтоох гэж тусгайлан ажилласан. Мөн дэлхийн Өмнөд ба Хойд гэсэн хоёр туйл бий. Энэхүү бүс нутгууд

тэр чигээрээ хөлдсөн, мөнх цэвдэгтэй. Хүн төрөлхтөн мөнх цэвдэгтэй бүс нутагт амьдарч чадах уу? Ийм газар нутаг хүн амьдрахад тохиромжтой юу? Үгүй, тиймээс хүмүүс ийм газрууд руу явдаггүй. Хүмүүс Хойд ба Өмнөд туйл руу явдаггүй болохоор мөнх цэвдэг нь хэвээр хадгалагдаж, температурыг барих үүргээ гүйцэтгэж чаддаг. Ойлгов уу? Хэрвээ Хойд, Өмнөд туйл гэж байхгүй байсан бол нарны байнгын халуун дэлхий дээрх хүмүүсийг мөхөхөд хүргэнэ. Гэвч Бурхан гагцхүү энэ хоёр зүйлээр л температурыг хүн амьдрахад тохирсон хязгаарт байлгадаг уу? Үгүй, нарны халууныг шингээн авч, ингэснээрээ, хүн төрөлхтний амьдардаг орчны температурыг тохируулахаар нарны дулааны эрчим хүчийг саармагжуулдаг төрөл бүрийн амьд зүйлс, тухайлбал хээр талын өвс ногоо, ойн янз бүрийн мод, бүх төрлийн ургамал бий. Мөн гол мөрөн, нуур гэх мэт усны эх үүсвэр байдаг. Гол мөрөн, нуур бүрхэх талбайг хэн ч шийдэж чадахгүй. Дэлхий дээр хэр зэрэг их ус байх, тэр ус хаашаа урсах, урсах чиглэл, усны хэмжээ, урсгалын хурдыг хэн ч хянаж чадахгүй. Зөвхөн Бурхан л мэднэ. Газрын гүний уснаас эхлээд газар дээрх нүдэнд үзэгдэх гол мөрөн, нуур зэрэг эдгээр янз бүрийн усны эх үүсвэр нь хүний амьдардаг орчны температурыг мөн зохицуулж чаддаг. Усны эх үүсвэрээс гадна, уул, тал, хавцал, намгархаг газар гээд бүгд газар зүйн цар хүрээ, талбайтайгаа тэнцүү хэмжээгээр температурыг зохицуулдаг бүх төрлийн газар зүйн тогтоц бас бий. Жишээлбэл, хэрвээ уул 100 километрийн тойрогтой бол тэрхүү 100 километр нь 100 километрийн хэмжээний ашиг тус өгнө. Бурхан, ийм уул, хавцал хэр олныг газар дээр бүтээсэн тухайд гэвэл, энэ тоог Бурхан бодолцсон байгаа. Өөрөөр хэлбэл, Бурханы бүтээсэн зүйл болгоны оршин тогтнолын ард түүх байдаг, юм болгон Бурханы мэргэн ухаан, төлөвлөгөөг агуулдаг. Жишээлбэл, ой мод, төрөл бүрийн ургамал ногоог аваад үзье—тэдгээрийн оршин тогтнож, ургадаг талбайн хэмжээ, цар хүрээг ямар ч хүн хянах аргагүй бөгөөд эдгээр зүйлийг шийдэх эрх хэнд ч байхгүй. Үүнтэй ижил тэдгээр нь хэр их ус шингээх, нарнаас хэр их дулааны эрчим хүч шингээж авах зэргийг бас ямар ч хүн хянаж чадахгүй. Энэ бүхэн нь бүх зүйлийг бүтээхдээ Бурханы гаргасан төлөвлөгөөний хүрээнд байдаг.

Бурхан бүх талаар хичээнгүйлэн төлөвлөж, бодолцож, зохицуулсан учраас л хүн ийм зохимжтой температуртай орчинд амьдарч чаддаг юм. Тиймээс хүний нүдээрээ хардаг нар гэх мэт юм бүхэн, хүмүүсийн байнга сонсдог хойд ба өмнөд туйл, түүнчлэн газар дээр, доор болон усан дахь янз бүрийн амьд зүйл, ой болон бусад төрлийн ургамал ногоо, усны эх үүсвэрийн эзлэх талбай, янз бүрийн хэлбэр хэмжээтэй ус, далайн ус ба цэвэр усны хэмжээ, газар зүйн өөр өөр орчин гээд энэ бүх зүйлийг Бурхан ашиглаж хүний амьдрах хэвийн температурыг хадгалдаг. Энэ бол маргаангүй. Бурхан энэ бүхний талаар гүнзгий бодсон учраас л хүн ийм зохимжтой температуртай орчинд амьдарч чаддаг. Хэт халуун ч биш, хэт хүйтэн ч биш байх ёстой: Хүний биеийн дасан зохицож чадах температураас хэтэрсэн дэндүү халуун газруудыг Бурхан чамд зориулж бэлдээгүй нь мэдээж. Температур

нь хэт бага, хэтэрхий хүйтэн, хүн тэнд ирснийхээ дараа хэдхэн минутад ярьж чадахгүй болж, тархи нь царцаж, бодож чадахаа болж, амьсгаа нь боогдож бүрэн хөлдөх ийм газруудыг Бурхан бас хүн төрөлхтөнд зориулж бэлдээгүй. Хүмүүс ямар төрлийн судалгаа явуулахыг хүсэх нь хамаагүй, ийм хязгаарлалтыг давж гарах шинэ санаачилга гаргахыг хүсэх эсэх нь ч бас хамаагүй—хүмүүс юу бодох нь хамаагүй, тэд хүний биеийн дасан зохицох хязгаарыг хэзээ ч давж чадахгүй. Хүний төлөө Бурханы бүтээсэн эдгээр хязгаарлалтаас тэд хэзээ ч салж чадахгүй. Учир нь Бурхан хүнийг бүтээсэн бөгөөд ямар температурт хүний бие дасан зохицож чадахыг Бурхан хамгийн сайн мэднэ. Харин хүмүүс өөрсдөө мэдэхгүй. Яагаад Би хүмүүс мэдэхгүй гэж хэлдэг вэ? Хүмүүс ямар мунхаг зүйл хийсэн бэ? Олон хүн хойд ба өмнөд туйлтай үзэлцэхээр байнга оролдож байсан бус уу? Тэр хүмүүс тийм газарт очиж, газар нутгийг нь эзэлж, улмаар тэндээ суурьшихыг үргэлж хүсдэг байсан. Ингэх нь мунхаглал болно. Чи хоёр туйлыг бүрэн дүүрэн судалсан ч гэсэн, тэгээд юу гэж? Чи температурт нь дасан зохицож, тэнд амьдарч чадсан ч гэсэн, хойд, өмнөд туйлын одоогийн амьдрах орчныг “сайжрууллаа” гээд хүн төрөлхтөнд ямар нэгэн байдлаар ашиг тус болох уу? Хүн төрөлхтөнд амьдарч чадах орчин байсаар атал хүмүүс чимээгүйхэн, дуулгавартайгаар тэндээ үлдэхгүй, харин ч амьд үлдэж чадахааргүй газрууд руу явж аз туршихаар зүтгэдэг. Яагаад ингэдэг юм бэ? Тэд ийм зохимжтой температурт амьдрахаасаа уйдаж тэсэхээ байдаг бөгөөд хэтэрхий их ерөөл эдэлсэн. Үүнээс гадна, хүн төрөлхтөн энэхүү амьдрах ердийн орчноо бараг бүрэн устгасан, иймээс одоо тэд илүү их сүйтгэх гэж, эсвэл ямар нэг “гал цогтой шинэ зам харгуй” олж чадна хэмээн ямар нэг “үйл хэргийг” эрэлхийлэхээр хойд, өмнөд туйл руу явсан нь дээр байх гэж боддог. Энэ чинь тэнэг хэрэг бус уу? Өөрөөр хэлбэл, энэ хүн төрөлхтөн өөрсдийн өвөг дээдэс Сатаны удирдлага дор утгагүй зүйлсийг ээлж дараалан хийж, тэдэнд зориулан Бурханы бүтээсэн сайхан орон гэрийг хайр найргүй, дур зоргоороо устгасаар байна. Энэ бол Сатаны хийж буй хэрэг. Улмаар дэлхий дээрх хүн төрөлхтний амьд байх нь тодорхой хэмжээгээр аюулд орсныг хараад олон хүн саран дээр очих арга замыг эрж хайж, тэнд амьдрах арга замыг бий болгохыг хүсдэг. Гэвч эцсийн эцэст, саран дээр хүчилтөрөгч байхгүй. Хүмүүс хүчилтөрөгчгүйгээр амьдарч чадах уу? Саран дээр хүчилтөрөгч байхгүй тул хүн байж чадах газар энэ биш, гэсэн ч хүн тийшээ очихыг хүссээр байдаг. Ийм зан авирыг юу гэж нэрлэх ёстой вэ? Энэ нь мөн өөрийгөө хорлож буй хэрэг. Сар бол агааргүй газар, температур нь хүн амьдрахад тохиромжгүй учраас энэ бол Бурханы хүнд зориулж бэлдсэн газар биш.

Бидний дөнгөж сая ярьсан сэдэв болох температур бол хүмүүсийн өдөр тутмын амьдралд тааралддаг зүйл юм. Температур бол бүх хүний бие мэдэрч чадах зүйл боловч температур хэрхэн бий болсон, хүн амьдрахад тохиромжтой энэ температурыг хэн хариуцаж, удирддаг талаар хэн ч боддоггүй. Энэ бол бидний одоо мэдэж авах зүйл юм. Үүнд Бурханы мэргэн ухаан байна уу? Үүнд Бурханы үйлдэл бий юу? (Тийм.) Бурхан, хүн амьдрахад тохиромжтой температур бүхий

орчныг бүтээснийг бодож үзвэл, бүх зүйлийг хангадаг Бурханы арга замуудын нэг нь энэ мөн үү? Мөн.

в. Дуу чимээ

Гурав дахь зүйл нь юу вэ? Энэ нь бас хүн оршин байх хэвийн орчны нэн чухал хэсэг болсон, бүх зүйлийг бүтээхдээ Бурханы зохицуулалт хийх ёстой болсон зүйл юм. Энэ нь Бурханд болон хүн болгонд маш чухал. Хэрвээ Бурхан үүнийг зохицуулаагүй байсан бол хүн төрөлхтний амьд байхад маш ихээр саад болох байв, өөрөөр хэлбэл, энэ нь хүний амьдрал болон махан биед ноцтой нөлөө үзүүлж ийм орчинд хүн төрөлхтөн амьдарч чадахгүйд хүрэх байсан. Ийм орчинд ямар ч амьд зүйл амьд үлдэж чадахгүй байсан гэж хэлж болно. Тэгэхээр Миний ярьж буй энэ зүйл юу вэ? Би дуу чимээний талаар ярьж байна. Бурхан бүх зүйлийг бүтээсэн, бүх зүйл Бурханы гарт амьдардаг. Бурханы бүтээсэн бүх зүйл Түүний нүдэнд амьдарч, байнгын хөдөлгөөнд эргэлдэж байдаг. Үүгээр Би юу хэлэх гээд байна вэ гэвэл, Бурханы бүтээсэн зүйл нэг бүр оршин тогтнох өөрийн гэсэн үнэ цэн, утга учиртай; өөрөөр хэлбэл юм бүрд оршин тогтнох ямар нэг зайлшгүй хэрэгцээ бий. Бурханы нүдэнд юм бүхэн амьтай, нэгэнт бүх юм амьтай учраас тус бүр нь дуу чимээ гаргадаг. Жишээ нь, дэлхий байнга эргэж байдаг, нар байнга эргэж байдаг, сар ч бас байнга эргэж байдаг. Бүх зүйл үржиж, хөгжиж, хөдлөхдөө дуу чимээ байнга гаргаж байдаг. Дэлхий дээр орших Бурханы бүтээсэн бүх зүйл байнга өсөн үржиж, хөгжиж, хөдөлж байна. Жишээлбэл, уулсын суурь хөдөлж, нүүж, далай тэнгисийн гүн дэх амьд зүйл цөм сэлж, нааш цааш хөдөлж байдаг. Энэ нь эдгээр амьд зүйл, Бурханы нүдэн дэх бүх зүйл тогтсон хэв маягийн дагуу тасралтгүй, жигд хөдөлгөөнд байдаг гэсэн үг юм. Тэгэхээр харанхуйд үржиж, хөгжин, нууцаар хөдөлж байдаг энэ бүх зүйл юу бүтээдэг вэ? Дуу чимээ—асар их, хүчирхэг дуу чимээ. Дэлхийгээс гадна төрөл бүрийн гараг ч бас байнгын хөдөлгөөнд байдаг бөгөөд эдгээр гараг дээрх амьд зүйлс, организмууд мөн байнга үржиж, хөгжин, хөдөлж байдаг. Өөрөөр хэлбэл, амьтай, амьгүй бүх зүйл Бурханы нүдэнд байнга урагшаа хөдөлж байдаг ба ингэхдээ тэд дор бүрнээ бас дуу чимээ гаргаж байдаг. Бурхан эдгээр дуу чимээнд бас зохицуулалт хийсэн бөгөөд Түүний ингэсэн шалтгааныг та нар хэдийнээ мэддэг гэдэгт Би итгэлтэй байна, тийм биз дээ? Нисэх онгоцонд ойртоход хөдөлгүүрийнх нь нүргээнтэй чимээ чамд ямар нөлөө үзүүлдэг вэ? Хажууд нь хэтэрхий удаан байвал чих чинь дүлийрнэ. Зүрх чинь яах вэ—ийм хүнд сорилтыг тэсэж чадах уу? Зүрх муутай зарим хүн тэсэж чадахгүй. Мэдээж, эрүүл чийрэг зүрхтэй хүмүүс ч гэсэн үүнийг хэтэрхий удаан тэсэж чадахгүй. Өөрөөр хэлбэл, чих ч бай, зүрх ч бай, хүний биед үзүүлэх дуу чимээний нөлөөлөл нь хүн нэг бүрд туйлын ноцтой бөгөөд хэт чанга дуу чимээ хүмүүст хор хөнөөл учруулна. Тиймээс бүх зүйлийг бүтээхдээ, тэдгээр нь хэвийн ажиллаж эхэлсний дараа Бурхан эдгээр дуу чимээ—хөдөлгөөнд буй бүх зүйлийн дуу чимээнд тохирох зохицуулалтыг хийсэн юм. Энэ нь бас хүн төрөлхтөнд зориулсан орчныг бүтээхдээ Бурханы бодолцож үзэх ёстой болсон асуудлын нэг байсан билээ.

Юун түрүүнд, дэлхийн гадаргаас дээшээ агаар мандал хүртэлх өндөр нь дуу чимээнд нөлөөлнө. Түүнчлэн хөрсөн дэх завсрын хэмжээ бас дуу чимээг гуйвуулж, түүнд нөлөөлнө. Үүнээс гадна янз бүрийн газар зүйн орчин уулзаж нийлэхдээ мөн л дуу чимээнд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, Бурхан зарим дуу чимээг арилгахын тулд тодорхой аргуудыг ашигладаг ба ингэснээр чих болон зүрх нь тэсвэрлэж чадах орчинд хүмүүс амьдарч чадах юм. Эс бөгөөс хүн төрөлхтний оршин тогтноход дуу чимээ асар том саад учруулж; амьдралд нь асар их тээр болж, тэдний хувьд том асуудал болно. Энэ нь Бурхан газар, агаар мандал, янз бүрийн газар зүйн орчныг бүтээхдээ маш нарийн хандсан бөгөөд энэ бүхэнд Бурханы мэргэн ухаан агуулагддаг гэсэн үг юм. Хүн төрөлхтөн үүнийг хэтэрхий нарийн ойлгох шаардлагагүй—хүмүүс Бурханы үйлдэл энд агуулагддаг гэдгийг мэдэхэд хангалттай. Одоо та нар Надад хэлээч, Бурханы хийсэн энэ ажил—хүн төрөлхтний амьдрах орчин, тэдний хэвийн амьдралыг хадгалахын тулд дуу чимээг нарийн тохируулах шаардлагатай байсан уу? (Тийм.) Энэхүү ажил чухал байсан юм бол, энэ өнцгөөс нь Бурхан бүх зүйлийг хангах нэг арга болгож энэ ажлыг ашигласан гэж хэлж болох уу? Бурхан хүн төрөлхтнийг хангахад зориулан ийм нам гүм орчныг бүтээсэн, ингэснээр хүний бие ийм орчинд ямар ч саад бэрхшээл учрахгүйгээр, тун хэвийн амьдарч, ингэснээр хүн төрөлхтөн хэвийн оршин байж, амьдарч чадна. Тэгэхээр хүн төрөлхтнийг хангадаг Бурханы арга замын нэг энэ бус уу? Бурханы хийсэн энэ зүйл маш чухал байсан бус уу? (Тийм.) Энэ маш чухал хэрэгтэй байсан. Тэгэхээр та нар үүнийг хэрхэн ойлгож байна вэ? Хэдийгээр энэ нь Бурханы үйлдэл байсан гэж та нарт санагдахгүй, мөн Бурхан тухайн үед энэ үйлдлийг хэрхэн хийснийг мэдэхгүй ч гэсэн, Бурхан энэ зүйлийг хийх шаардлагатай байсан гэж одоо ч гэсэн та нарт санагддаг уу? Та нар үүнд шингэсэн Бурханы мэргэн ухаан, хайр халамж, сэтгэлийг мэдэрч чадаж байна уу? (Тийм ээ, мэдэрч байна.) Та нар үүнийг мэдэрч чаддаг байхад хангалттай. Хүмүүсийн мэдэрч, харж чаддаггүй олон үйлдлийг Өөрийн бүтээсэн бүх зүйлийн дунд Бурхан гүйцэтгэсэн. Та нарыг Бурханыг мэдэж аваасай гэсэндээ Бурханы үйлдлийн талаар мэдээлэл өгөх л гэж Би үүнийг хөндөж байна. Бурханыг илүү сайн мэдэж, ойлгоход эдгээр сэжүүр та нарт тусалж чадна.

г. Гэрэл

Дөрөв дэх зүйл нь хүмүүсийн нүдэнд хамаатай: гэрэл. Энэ ч бас маш чухал. Чамайг тод гэрэл харж байхад, гэрлийн хүч тодорхой хэмжээнд хүрээд хүний нүдийг сохлох боломжтой. Эцсийн эцэст хүний нүд бол махан биеийн нүд. Нүд цочролыг тэвчиж чадахгүй. Нар луу шууд ширтэж зүрхлэх хүн бий юу? Зарим хүн оролдож үзсэн, хэрвээ тэд нарны шил зүүж байвал яах ч үгүй—гэхдээ үүнд багаж хэрэгсэл ашиглах шаардлагатай болдог. Хүний энгийн нүд багаж хэрэгсэлгүйгээр нар луу шууд эгцэлж хараад, шууд ширтэх ямар ч боломжгүй. Гэхдээ Бурхан хүн төрөлхтөнд гэрэл гэгээ авчрах гэж нарыг бүтээсэн бөгөөд энэхүү гэрэл ч бас Түүний

анхаарал тавьсан зүйл юм. Бурхан зүгээр нэг нарыг бүтээж дуусаад, хаа нэгтээ тавиад орхичхоогүй; Бурхан юмыг тэгж хийдэггүй. Тэрээр үйлдэлдээ тун анхааралтай байж, нэгд нэггүй боддог. Бурхан хүн төрөлхтөнд хар гэж нүд заяасан, бас хүн юмыг харж чадах гэрлийн үзүүлэлтийг ч урьдчилан тогтоосон юм. Гэрэл хэтэрхий бүдэг байсан бол хэрэггүй байх байв. Өмнөө байгаа хуруугаа ч харж чадахааргүй маш харанхуй байх үед хүмүүсийн нүд чиг үүргээ алдаж, ямар ч хэрэггүй болдог. Гэхдээ хурц гэрэл тэвчихийн аргагүй байдаг учраас хэтэрхий тод гэрэл мөн адил хүний нүдийг юм харж чадахгүй болгодог. Иймээс хүн төрөлхтний оршин тогтнож буй орчинд Бурхан, хүний нүдэнд тохирох—хүмүүсийн нүдний ажиллагааг алдагдуулах нь байтугай өвтгөж гэмтээхээргүй хэмжээний гэрлээр хангасан. Ийм учраас Бурхан нар болон дэлхийн эргэн тойронд хэдэн давхар үүл нэмсэн бөгөөд мөн хүмүүсийн нүд, арьсыг гэмтээж болох гэрлийг агаарын нягтшил зохих ёсоор шүүж авч чаддаг. Эдгээр нь харилцан уялдаатай. Түүнчлэн, Бурханы бүтээсэн газар дэлхийн өнгө нарны гэрэл болон бусад бүх төрлийн гэрлийг ойлгодгийн дээр хүний нүд дасан зохицоход хэтэрхий хурц гэрлийг устгаж чаддаг. Иймээс хүмүүс гадуур алхаж, байнга тас хар нарны шил зүүх шаардлагагүйгээр амьдарч болдог. Хэвийн нөхцөлд хүний нүд гэрэл саад болохгүйгээр үзэгдэх орчиндоо юм харж чаддаг. Өөрөөр хэлбэл, гэрэл хэт хурц юм уу, хэт бүдэг байж болохгүй. Хэрвээ хэт бүдэг байвал хүмүүсийн нүд гэмтэж, удалгүй харж чадахаа болино; хэт хурц байвал хүмүүсийн нүд тэсвэрлэж чадахгүй. Хүмүүст байдаг яг энэ гэрэл нь хүний нүд харахад тохиромжтой байх ёстой бөгөөд гэрлээс болж хүний нүдэнд учрах хор хөнөөлийг Бурхан янз бүрийн аргаар хамгийн бага болгожээ; энэхүү гэрэл хүний нүдэнд тустай, эсвэл халгаатай байж болох ч хүмүүс амьдралынхаа төгсгөл хүртэл нүдээрээ харахад хангалттай байдаг. Бурхан үүнийг сайтар бодолцсон бус уу? Харин диавол Сатан иймэрхүү зүйлийг хэзээ ч бодолцож үзэлгүйгээр үйлддэг. Сатан байхад, гэрэл үргэлж нэг бол хэт хурц, эсвэл хэт бүдэг байдаг. Сатан ингэж л үйлддэг.

Бурхан хүн төрөлхтний дасан зохицож амьдрах чадварыг дээд цэгт нь хүргэхийн тулд харах, сонсох, амтлах, амьсгалах, мэдрэх гээд эдгээр зүйлийг хүний биеийн бүх талд хийсэн, ингэснээр тэд хэвийн амьдарч, үргэлжлүүлж чадах юм. Өөрөөр хэлбэл, Бурханы бүтээсэн одоогийн амьдрах орчин нь хүн төрөлхтөн амьдрахад хамгийн тохиромжтой, ашиг тустай орчин мөн. Зарим хүн үүнийг нэг их чухал биш, бүгд тун энгийн зүйл гэж бодож магадгүй. Төрсөн мөчөөсөө эдэлж ирсэн дуу чимээ, гэрэл, агаарыг төрөхөөс олгогдсон эрх гэж хүмүүс боддог. Гэхдээ чиний эдлэх боломжтой байгаа эдгээр зүйлийн цаана Бурхан ажиллаж байсан гэдгийг хүмүүс мэдэж, ойлгох хэрэгтэй. Эдгээр зүйлийг ойлгох, мэдэх хэрэггүй гэж чамд санагддаг ч байсан гэсэн, товчхондоо Бурхан эдгээрийг бүтээхдээ сайтар бодолцож, төлөвлөгөөтэй, тодорхой бодол санаатай байсан. Тэр хэрэг явдлыг сайтар бодож үзэлгүйгээр хүн төрөлхтнийг зүгээр нэг, дэмий ийм амьдрах орчинд тавьчхаагүй. Та нар Намайг энэ жаахан зүйлсийг тус бүрээр нь дэндүү дэвэргэн

ярьж байна гэж бодож магад, гэхдээ Миний үзэл бодлоор бол Бурханы хангасан юм болгон хүн төрөлхтөн амьдрахад зайлшгүй шаардлагатай. Бурханы үйлдэл үүнд байдаг.

д. Агаарын урсгал

Тав дахь зүйл нь юу вэ? Энэ зүйл хүн бүрийн өдөр тутмын амьдралд маш ойр байдаг. Энэ материаллаг ертөнцөд хүний бие үүнгүйгээр амьдарч чадахааргүй тийм хэмжээнд хүний амьдралд ойр холбоотой байдаг. Энэ зүйл бол агаарын урсгал. “Агаарын урсгал” гэдэг нэр үгийг сонсоод хэн ч ойлгож чадах байх. Тэгэхээр агаарын урсгал гэж юу вэ? “Агаарын урсгал” гэдэг нь ердөө л урсаж буй агаарын хөдөлгөөн гэж хэлж болно. Агаарын урсгал бол хүний нүд харж чадахгүй салхи юм. Энэ нь бас хий шилжин хөдлөх нэг арга зам билээ. Гэхдээ ямар “агаарын урсгалын” талаар энд голчлон ярьж байна вэ? Та нар Намайг хэлмэгц ойлгоно. Дэлхий эргэхдээ уулс, далай тэнгис хийгээд бүх зүйлийг тээж явдаг бөгөөд тийнхүү эргэхдээ хурдтай эргэдэг. Ийнхүү эргэлдэж байгааг нь чи огт мэдэрдэггүй ч гэсэн, эргэж л байдаг. Энэхүү эргэлт юу үүсгэдэг вэ? Чамайг гүйхэд салхи үүсэж чихний чинь хажуугаар өнгөрдөг бус уу? Хэрвээ чамайг гүйхэд салхи үүсэж болж байгаа юм бол дэлхий эргэх үед салхи байхгүй байж яаж болох билээ? Дэлхий эргэх үед бүх зүйл хөдөлгөөнд оршдог. Дэлхий өөрөө хөдөлгөөнд оршиж, тодорхой хурдтай эргэж байхад түүн дээрх бүх зүйл ч бас байнга өсөж үржин, хөгжиж байдаг. Тиймээс тодорхой хурдтай хөдөлгөөн аяндаа агаарын урсгалыг бий болгоно. Үүнийг Би “агаарын урсгал” гээд байгаа юм. Энэхүү агаарын урсгал хүний биед тодорхой хэмжээгээр нөлөөлдөг үү? Хар салхийг аваад үзье: Энгийн хар салхи тийм ч хүчтэй биш боловч хар салхи ирэх үед хүмүүс тогтвортой зогсож ч чаддаггүй, салхинд алхахад хэцүү байдаг. Ганц алхахад ч бэрх байдаг, зарим хүн бүр салхинд юм руу шахагдаад, хөдөлж чаддаггүй. Энэ бол агаарын урсгалын хүн төрөлхтөнд нөлөөлж болох хэлбэрийн нэг юм. Хэрвээ газар дэлхий бүхэлдээ тал газраар дүүрэн байсан бол дэлхий болон бүх зүйл эргэхэд түүнээс үүсэх агаарын урсгалыг хүний бие тэсвэрлэх огт боломжгүй байх байлаа. Тийм нөхцөлд хариу үйлдэл үзүүлэхэд туйлын хэцүү байх байсан. Үнэхээр тийм байсан бол тэрхүү агаарын урсгал хүн төрөлхтөнд зөвхөн хор хохирол учруулаад зогсохгүй бүрэн сүйрүүлэх байлаа. Ийм орчинд хүмүүс амьд үлдэж чадахгүй байх байсан. Ийм учраас тэрхүү агаарын урсгалыг шийдвэрлэхийн тулд Бурхан өөр өөр газарзүйн орчныг бий болгосон—өөр өөр орчинд агаарын урсгал сулран, чиглэл, хурд, хүчээ өөрчилдөг. Тийм учраас хүмүүс уулс, их уулсын нуруу, хээр тал, толгод, голын сав газар, хөндий, өндөрлөг газар, их мөрнүүд гээд янз бүрийн газарзүйн орчныг хардаг билээ. Бурхан эдгээр янз бүрийн газар зүйн орчноор агаарын урсгалын хурд, чиглэл, хүчийг өөрчилдөг. Тэрээр энэ арга барилыг ашиглан агаарын урсгалыг сааруулж, салхины хурд, чиглэл, хүчийг нь тохиромжтой болгосноор хүмүүс хэвийн амьдрах орчинтой болно. Ингэх шаардлагатай юу? (Тийм ээ.) Ийм зүйл хийнэ гэдэг хүмүүст хэцүү мэт

санагдавч харин Бурханд бол амархан, учир нь Тэр бүх зүйлийг ажиглаж байдаг. Хүн төрөлхтөнд тохирсон агаарын урсгал бүхий орчныг бүтээх нь Түүний хувьд үнэхээр энгийн, хялбар юм. Тиймээс Бурханы бүтээсэн ийм орчинд, Түүний бүтээсэн бүх зүйлийн доторх юм нэг бүр зайлшгүй чухал билээ. Юм нэг бүрийн оршин тогтнолд үнэ цэнэ, хэрэгцээ шаардлага гэж бий. Гэсэн хэдий ч Сатан болон завхарсан хүн төрөлхтөн энэ зарчмыг ойлгодоггүй. Тэд уулсыг тэгшилж, хавцлыг дүүргэж, тэгш газар дээр тэнгэр баганадсан барилга барьж бетонон ширэнгэ бүтээх хоосон мөрөөдөлтэйгөөр зогсолтгүй сүйтгэж, хөгжүүлж, олборлож байдаг. Өөрийнх нь тэдэнд зориулан бэлдсэн хамгийн зохимжтой орчинд хүн төрөлхтөн аз жаргалтай амьдарч, өсөж үржин, өдөр бүрийг баяр баясалтайгаар өнгөрүүлж чадна гэж Бурхан найддаг. Тийм ч учраас хүн төрөлхтний амьдрах орчинд Бурхан хэзээ ч хайнга хандаж байгаагүй. Температураас агаар, дуу чимээнээс гэрэл хүртэл Бурхан нарийн төлөвлөгөө, зохицуулалт хийсэн, ингэснээр хүмүүсийн бие махбод болон амьдрах орчинд байгалийн нөхцөл байдал саад болохгүй, харин ч хүн төрөлхтөн хэвийн амьдарч, өсөж үржин, бүх зүйлтэй хамт эв найртайгаар зэрэгцэн оршиж, хэвийн амьдарч чадна. Бүх зүйл болон хүн төрөлхтнийг Бурхан энэ бүхнээр хангадаг.

Хүн амьдрах энэхүү таван үндсэн нөхцөлийг зохицуулж байгаа байдлаас нь Бурхан хүн төрөлхтнийг хангаж байгааг харж болохоор байгаа биз? (Тийм.) Өөрөөр хэлбэл, Бурхан бол хүн амьдрах хамгийн үндсэн бүх нөхцөлийн Бүтээгч бөгөөд Бурхан эдгээр зүйлийг бас удирдаж, хянаж байгаа; хүн хэдэн мянган жил оршин тогтносны дараа, одоо ч гэсэн Бурхан тэдний амьдрах орчныг байнга өөрчлөн, хэвийн амьдарч болохуйц хамгийн сайн, хамгийн тохиромжтой амьдрах орчноор тэднийг хангасаар байна. Ийм нөхцөл байдлыг хэр удаан хадгалж болох вэ? Өөрөөр хэлбэл, Бурхан биднийг хэр удаан ийм орчноор хангасаар байх вэ? Бурхан Өөрийн удирдлагын ажлыг бүрэн дуусгах хүртэл үргэлжилнэ. Дараа нь Бурхан, хүн төрөлхтний амьдрах орчныг өөрчилнө. Үүнийгээ Тэр адилхан аргаар, эсвэл өөр аргаар хийж магадгүй. Гэхдээ одоо хүмүүсийн мэдэх ёстой зүйл гэвэл, Бурхан хүн төрөлхтний хэрэгцээг байнга хангаж, хүн төрөлхтний амьдрах орчныг удирдаж, тэрхүү орчныг тэтгэж, хамгаалж, хадгалсаар байгаа билээ. Ийм орчин байгаа болохоор Бурханы сонгосон хүмүүс хэвийн амьдарч, Бурханы аврал, гэсгээлт, шүүлтийг хүлээн авч чаддаг билээ. Бурханы дээд эрхийн улмаас бүх зүйл амьдарсаар байдаг, Бурхан ийнхүү хангаж байгаа болохоор бүх хүн төрөлхтөн урагшилсаар байна.

Бидний нөхөрлөсөн энэхүү сүүлийн хэсэг та нарт ямар нэг шинэ бодол санаа өгсөн үү? Та нар одоо Бурхан, хүн төрөлхтөн хоёрын хоорондох хамгийн том ялгааг мэдэж авав уу? Эцсийн эцэст хэн бүх зүйлийн эзэн бэ? Хүн үү? (Үгүй.) Тэгвэл Бурхан болон хүмүүсийн бүх бүтээлд хэрхэн ханддагийн ялгаа нь юу вэ? (Бурхан бүх зүйлийг захирч, зохицуулдаг байхад хүн тэдгээрийг эдэлдэг.) Та нар үүнтэй санал нийлж байна уу? Бурхан, хүн төрөлхтөн хоёрын хоорондох хамгийн том

ялгаа нь Бурхан бүх бүтээлийг захирч, хангадаг. Бурхан бол бүх зүйлийн эх сурвалж, Бурхан бүх зүйлийг хангадаг байхад хүн төрөлхтөн түүнийг нь эдэлдэг. Өөрөөр хэлбэл, Бурханы бүх зүйлд хайрласан амийг хүн хүлээн авахдаа бүтээгдсэн бүх зүйлийг эдэлдэг. Бурхан бол Эзэн, Бурхан бүх зүйлийг бүтээсний үр шимийг хүн төрөлхтөн эдэлдэг. Тэгвэл Бурханы бүтээсэн бүх зүйлийн өнцгөөс авч үзвэл, Бурхан болон хүн төрөлхтний хоорондох ялгаа юу вэ? Бурхан бүх зүйлийн өсөн үржих хуулийг тодорхой харж чаддагийн дээр эдгээр хуулийг хянаж, захирдаг. Өөрөөр хэлбэл, бүх зүйл Бурханы нүдэнд, Түүний шинжих хүрээн дотор байдаг. Хүн төрөлхтөн бүх зүйлийг харж чадах уу? Хүн төрөлхтний харж чадах зүйл нүднийх яг урд байгаа зүйлээр хязгаарлагддаг. Хэрвээ чи энэ ууланд авирвал чиний харах зүйл зөвхөн тэр уул л байна. Уулын нөгөө талд юу байгааг чи харж чадахгүй. Хэрвээ далайн эрэгт очвол чи далайн нэг талыг л харна, далайн нөгөө тал ямар болохыг мэдэж чадахгүй. Хэрвээ ой модонд очвол эргэн тойронд чинь, урьд чинь байгаа ургамлуудыг харахаас бус, түүнээс цаашаа юу байгааг чи харж чадахгүй. Хүмүүс илүү өндөр, илүү хол, илүү гүн газруудыг харж чадахгүй. Тэд өөрсдийнх нь чанх урд, үзэгдэх орчинд нь буй зүйлийг л хардаг. Хүмүүс жилийн дөрвөн улирлын зүй тогтлыг болон бүх зүйлийн өсөж үржих зүй тогтлыг мэддэг байлаа ч гэсэн, бүх зүйлийг удирдаж, эсвэл захирч чаддаггүй. Харин Бурхан бүтээгдсэн бүх зүйлийг харахдаа Өөрөө биечлэн бүтээсэн машиныг харж байгаа юм шиг л хардаг. Тэрээр эд анги, холболт бүрийг нь, ямар зарчимтай, ямар зүй тогтолтой, ямар зориулалттайг нь тун сайн мэднэ—Бурхан энэ бүхнийг хамгийн тодорхой мэднэ. Тиймээс Бурхан бол Бурхан, хүн бол хүн билээ! Хүн бүх зүйлийг захирдаг хууль, шинжлэх ухааныг гүнзгий судалж болох ч тэрхүү судалгаа нь цар хүрээний хувьд хязгаарлагдмал байдаг, харин Бурхан бүх зүйлийг хянадаг бөгөөд хүний хувьд энэ нь хязгааргүй билээ. Хүн Бурханы хийсэн өчүүхэн зүйлийг судлахад бүхий л амьдралаа зориулаад ч ямар ч жинхэнэ үр дүнд хүрэхгүй байж мэднэ. Тийм учраас мэдлэг болон сурсан зүйлээ ашиглаад Бурханыг судлах аваас чи хэзээ ч Бурханыг мэдэж, ойлгож чадахгүй. Гэхдээ хэрвээ чи үнэнийг эрж хайх, Бурханыг эрж хайх замыг сонгож, Бурханыг мэдэж авах гэсэн өнцгөөс Түүнийг харах аваас нэг л өдөр Бурханы үйлдэл, мэргэн ухаан хаа сайгүй, нэгэн зэрэг байгааг танин мэдэж, Бурханыг чухам яагаад бүх зүйлийн Эзэн, бүх зүйлийн амийн эх сурвалж гэж нэрлэдгийг мэдэх болно. Чи ийм ойлголттой болох тусмаа Бурханыг бүх зүйлийн Эзэн гэж яагаад нэрлэдгийг, чамайг оролцуулаад бүх зүйл, юм болгон Бурханы тасралтгүй урсах хангалтыг байнга хүлээн авч байгааг улам их ойлгоно. Энэ дэлхий дээр, энэ хүн төрөлхтөн дунд бүх зүйлийн оршин тогтнолыг захирч, удирдан, хадгалах тийм чадвар, мөн чанар Бурханаас өөр хэнд ч байх боломжгүй гэдгийг чи бас тодорхой мэдэрч чадна. Ийм ойлголтод хүрэхдээ чи Бурхан бол чиний Бурхан гэдгийг үнэхээр танина. Энэ хэмжээнд хүрэхдээ чи Бурханыг үнэхээр хүлээн зөвшөөрч, Түүнийг өөрийн Бурхан, өөрийн Эзэн болгосон байх болно. Ийм ойлголттой болж, амь чинь ийм хэмжээнд хүрэхэд чи нэгэнт Бурханыг ойлгож,

Түүний зүрх сэтгэлийг мэдэж, зүрх сэтгэлдээ Бурханыг үнэн голоосоо хүлээн зөвшөөрсөн байх учраас Бурхан чамайг шалгаж, шүүхээ больж, бас чамд ямар нэгэн шаардлага тавихаа ч болино. Бурхан бүх зүйлийг захирч, удирддаг тухай эдгээр сэдвээр нөхөрлөх нэг чухал шалтгаан энэ билээ. Ингэх нь хүмүүст илүү их мэдлэг, ойлголт өгөх зорилготой байдаг—чамаар зүгээр нэг хүлээн зөвшөөрүүлэх гэж биш, харин Бурханы үйлдлийг чамд илүү бодитойгоор мэдүүлж, ойлгуулахын төлөө юм.

Хүн төрөлхтөнд зориулан Бурханы бэлддэг өдөр тутмын хоол, унд

Дэлхийг бүтээхдээ Бурханы бэлдсэн хүрээлэн буй орчны нэг хэсгийн талаар ерөнхийд нь, ялангуяа хүн төрөлхтөн амьд үлдэхэд нэн шаардлагатай орчин нөхцөлийн талаар бид дөнгөж сая ярилцлаа. Бид таван зүйлийн талаар, хүрээлэн буй орчны таван элементийн талаар ярилцсан. Бидний дараагийн сэдэв бол хүн бүрийн биет амьдралтай нягт холбоотой, тэрхүү амьдралд илүү нийцдэг бөгөөд чухал шаардлагатай нөхцөлөө өмнөх таваасаа үлэмж сайн биелүүлдэг билээ. Чухамхүү энэ бол хүмүүсийн иддэг хоол хүнс юм. Бурхан хүнийг бүтээж, тохиромжтой амьдрах орчинд тавьсан; дараа нь хүнд хүнс, ус хэрэгтэй болсон. Хүнд ийм хэрэгцээ байсан болохоор Бурхан түүнд зориулж зохих бэлтгэлийг хийсэн юм. Тиймээс Бурханы ажлын алхам бүр, Түүний хийдэг юм болгон нь зүгээр нэг хэлсэн хоосон үг биш, харин бодитоор хийгддэг жинхэнэ үйлдэл юм. Хүмүүсийн өдөр тутмын амьдралд хоол хүнс зайлшгүй шаардлагатай бус уу? Хоол хүнс агаараас илүү чухал уу? Хоёулаа адилхан чухал. Хоёулаа л хүн төрөлхтөн амьд үлдэхэд, хүн үргэлжлүүлэн амьдрахад шаардлагатай нөхцөл байдал, зүйлс юм. Аль нь илүү чухал вэ—агаар уу, ус уу? Температур уу, хоол хүнс уу? Бүгд л адилхан чухал. Хүмүүс эдгээрийн алингүйгээр ч байж чадахгүй учраас аль нэгийг нь сонгож чадахгүй. Энэ бол жинхэнэ, бодит асуудал бөгөөд чиний сонгох зүйл биш. Чи мэдэхгүй, харин Бурхан мэднэ. Чи хоол хараад “Би хоолгүй байж чадахгүй!” гэж боддог. Гэхдээ дөнгөж бүтээгдсэнийхээ дараа чамд хоол хүнс хэрэгтэй гэдгийг чи мэдэж байсан уу? Чи мэдээгүй, харин Бурхан мэдэж байсан. Чи өлсөөд, идэх жимс модон дээр, үр тариа газар байхыг хараад л чамд хоол хэрэгтэй гэдгийг ухаарсан. Чи цангаж, булгийн усыг хараад, түүнээс уухдаа л чамд ус хэрэгтэйг ухаарна. Усыг Бурхан хүн төрөлхтөнд зориулан урьдаас бэлдсэн. Хүн өдөрт хоёр, гурван удаа, эсвэл түүнээс ч олон хооллох нь хамаагүй, товчхондоо, хоол хүнс бол хүмүүсийн өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай зүйл юм. Хүний биеийн хэвийн амьдралыг тэтгэхэд хэрэгтэй зүйлсийн нэг энэ билээ. Тэгвэл ихэнх хоол хүнс хаанаас гардаг вэ? Нэгдүгээрт, энэ нь хөрснөөс гардаг. Хөрсийг Бурхан хүн төрөлхтөнд зориулан урьдаас бэлдсэн бөгөөд хөрс нь зөвхөн мод, өвс бус янз бүрийн ургамал амьдрахад тохиромжтой байдаг. Бурхан хүн төрөлхтөнд зориулан бүх төрлийн үр тариа, өөр бусад янз бүрийн хоол хүнсний үр бэлдэж, тариалахад тохиромжтой хөрс, газрыг хүн төрөлхтөнд өгсөн бөгөөд эдгээр зүйлээс хүн

төрөлхтөн хоол хүнс олж авдаг. Төрөл бүрийн хоол хүнс нь юу вэ? Та нар хэдийнээ мэдэж байгаа байх. Нэгдүгээрт, төрөл бүрийн үр тариа байдаг. Ямар өөр өөр төрлийн үр тариа байдаг вэ? Улаан буудай, хоног будаа, шар будаа, бог будаа болон бусад төрлийн хальстай үр тариа. Амуу тариа мөн л бүхий л сортоор, арвай, буудай, овьёос, сагаг гээд олон төрөл зүйлээр урдаас хойшоо байдаг. Өөр өөр төрөл зүйл нь өөр өөр бүс нутагт тариалахад тохиромжтой. Мөн өөр өөр төрлийн тутарга байдаг. Өмнөдөд өөрийн гэсэн төрөл зүйл байдаг, өмнөдөд илүү халуун байдаг учраас урт мөхлөгтэй, тэндхийн хүмүүст тохирсон байдаг нь нутгийн хүмүүс ази тутарга гэх мэт хэт цавуулаг биш төрлийг нь идэх ёстой гэсэн үг юм. Тутарга нь хэт цавуулаг байж болохгүй, эс бөгөөс тэд үүнийг боловсруулж чадахгүй бөгөөд хоолны дуршлаа алдана. Хойд нутаг үргэлж хүйтэн байдаг болохоор тэндхийн хүмүүс илүү цавуулаг ихтэй зүйл идэх ёстой байдаг учраас хойд нутгийнхан илүү цавуулаг тутарга иддэг. Түүнээс гадна мөн газар дээр ургадаг төрөл бүрийн шош, газар доор ургадаг төмс, амтлаг төмс, таро гэх мэт үндэст ногоо бий. Төмс хойд зүгт ургадаг, чанар нь тун сайн. Хүмүүст идэх үр тариа байхгүй үед өдөрт гурван удаа хооллоход нь төмс тэдний үндсэн хоол хүнс болж чаддаг. Төмсийг мөн хүнсний нөөц болгон хэрэглэж болно. Амтлаг төмсний чанар төмснөөс арай муу ч гэсэн өдрийн гурван хоолны нэг үндсэн хоол болгож болно. Үр тариа олдоц багатай үед хүмүүс амтлаг төмсөөр өлсөхөө дарж болно. Өмнөд нутгийн хүмүүсийн дандаа иддэг тарог ч бас ийм маягаар хэрэглэж болох бөгөөд мөн л үндсэн хоолны үүрэг гүйцэтгэж чадна. Хүмүүсийн өдөр тутмын хоол хүнс, ундны зайлшгүй хэсэг болсон янз бүрийн ургац ийм байдаг. Хүмүүс янз бүрийн үр тариа ашиглан талх, мантуу, гоймон, будаа, пүнтүүз болон бусад зүйлсийг хийдэг. Бурхан эдгээр төрөл бүрийн үр тариаг хүн төрөлхтөнд элбэг ихээр хайрласан. Яагаад ийм олон төрөл зүйл байна вэ гэдэг нь Бурханы хүслийн хэрэг билээ: Тэдгээр нь хойд, өмнөд, зүүн, баруун зүгийн өөр өөр хөрс, уур амьсгалд ургахад тохирсон байдаг бол тэдгээрийн янз бүрийн найрлага, агууламж нь хүний биеийн янз бүрийн найрлага, агууламжид таарсан байдаг. Хүмүүс эдгээр үр тариаг идэж байж л өөрсдийн биед шаардлагатай янз бүрийн шим тэжээл, бодисыг хадгалж чадна. Хойд болон өмнөд нутгийн хоол хүнс ялгаатай боловч ялгаатай гэхээсээ илүү төстэй байдал нь их юм. Тэдгээрийн аль аль нь хүний биеийн ердийн хэрэгцээг хангаж, хэвийн амьдралыг тэтгэж чадна. Тиймээс бүс нутаг бүрд ургадаг төрөл зүйл маш их байдгийн шалтгаан нь эдгээр өөр өөр хоол хүнсний хангадаг зүйл хүний бие махбодод хэрэгтэй. Биеийн хэвийн оршин тогтнолыг хадгалж, хэвийн хүний амьдралаар амьдрахын тулд хөрсөнд ургасан янз бүрийн хоол хүнснээс хангадаг зүйлс тэдэнд хэрэгтэй байдаг. Товчоор хэлбэл, Бурхан хүн төрөлхтөнд маш их анхаарал тавьсан. Хүмүүст Бурханы хайрласан янз бүрийн хоол хүнс нь нэгэн хэвийн биш—эсрэгээрээ маш олон янз байдаг. Хүмүүс овьёос идмээр байвал овьёос идэж болно. Зарим хүн улаан буудайнаас илүү цагаан будаанд дуртай байдаг, улаан буудайд дургүй болохоор тэд цагаан будаа идэж болно. Урт, богино гээд бүх төрлийн цагаан будаа байдаг ба хүмүүс нэг бүрийг нь

амтархан идэж болно. Тиймээс хүмүүс эдгээр үр тариаг идвэл—дэндүү их хоол хүнс голж шилдэг биш л бол—шим тэжээлээр дутагдахгүй, үхэх хүртлээ эрүүл амьдрах нь баталгаатай. Хүн төрөлхтөнд хоол хүнс хайрлахдаа Бурханы зорьж байсан санаа энэ байсан. Хүний бие эдгээр зүйлгүйгээр байж чадахгүй—энэ нь бодит байдал бус уу? Хүн төрөлхтөн эдгээр бодит асуудлыг өөрсдөө шийдвэрлэж чадаагүй, харин Бурхан үүнийг тэдэнд зориулж бэлдсэн: Тэр урьдаас бодож, хүн төрөлхтөнд зориулж эдгээр зүйлийг бэлдсэн.

Гэвч хүн төрөлхтөнд Бурханы өгсөн зүйл үүгээр тогтохгүй—мөн Тэр хүн төрөлхтөнд хүнсний ногоо өгсөн! Цагаан будаа байхад чи цагаан будаанаас өөр юу ч идэхгүй бол хангалттай шим тэжээл авч чадахгүй байж магадгүй. Нөгөө талаар хэрвээ чи жаахан ногоо шарах буюу салат хутгаад хоолтойгоо идвэл хүнсний ногоонд агуулагдах витамин, янз бүрийн микро элемент, бусад шим тэжээл нь мэдээжийн хэрэг чиний биеийн хэрэгцээг хангаж чадна. Мөн хүмүүс хоолны дундуур бага зэрэг жимс бас идэж болно. Заримдаа хүмүүст илүү их шингэн, эсвэл өөр шим тэжээл, өөр амт хэрэгтэй болдог бөгөөд жимс, хүнсний ногоо энэ хэрэгцээг хангахын тулд байдаг. Өмнөд, хойд, зүүн, баруун нутгийн цаг агаар болон хөрс өөр өөр байдаг болохоор өөр өөр төрлийн жимс, хүнсний ногоо ургадаг. Өмнөд нутгийн цаг агаар дэндүү халуун болохоор тэндхийн жимс, хүнсний ногооны дийлэнх нь идмэгц хүний биеийн халуун, хүйтнийг тэнцвэржүүлж чадахуйц сэрүүн чанарын байдаг. Эсрэгээрээ хойд нутагт илүү цөөн төрлийн жимс, хүнсний ногоо байдаг ч нутгийн хүмүүс идэхэд хангалттай. Гэвч сүүлийн жилүүдэд нийгмийн хөгжил болон нийгмийн дэвшил гэгчийн улмаас, түүнчлэн хойд, өмнөд, зүүн, барууныг холбосон тээвэр, харилцаа холбоо сайжирсны улмаас хойд нутгийн хүмүүс ч бас өмнөдийн зарим жимс, хүнсний ногоо, өмнө зүгийн бүс нутгийн бүтээгдэхүүнийг идэхдээ жилийн дөрвөн улиралд идэж чаддаг болсон. Хэдийгээр энэ нь хүмүүсийн идэх дур, материаллаг хүслийг хангаж чаддаг ч, биед нь өөрийн мэдэлгүй янз бүрийн хэмжээгээр хор хөнөөл учирч байдаг. Учир нь хүн төрөлхтөнд зориулан Бурханы бэлдсэн хоол хүнс дунд өмнөдийн хүмүүст зохимжтой хоол хүнс, жимс, хүнсний ногоо гэж байхаас гадна, хойд нутгийн хүмүүст зохимжтой хоол хүнс, жимс, хүнсний ногоо гэж бий. Өөрөөр хэлбэл, хэрвээ чи өмнөдөд төрсөн бол өмнөдийн юм идэх нь чамд зохистой. Өмнөд нутаг онцлог цаг агаартай учир Бурхан, эдгээр хүнс, жимс, хүнсний ногоог тусгайлан бэлтгэсэн. Хойд нутагт, хойд нутгийн хүмүүсийн биед хэрэгтэй хоол хүнс байдаг. Гэвч хүмүүс ханаж цадахгүй дуршилтай учраас тэд нийгмийн шинэ чиг хандлагын давлагаанд өөрийн мэдэлгүй татагдан орж, эдгээр хуулийг ухамсаргүйгээр зөрчиж байна. Хэдийгээр хүмүүс амьдрал нь өнгөрсөн үеэс илүү дээрдсэн гэж бодож байгаа ч, ийм нийгмийн дэвшил нь маш олон хүний биед далдуур хор хөнөөл учруулж байдаг. Энэ бол Бурханы харахыг хүсдэг зүйл биш, мөн хүн төрөлхтнийг эдгээр хоол хүнс, жимс, хүнсний ногоогоор хангахдаа Түүний зорьж байсан зүйл биш. Хүмүүс Бурханы хуулийг зөрчсөнөөр одоогийн нөхцөл байдлыг бий болгосон юм.

Тэр бүхнээр ч барахгүй, хүн төрөлхтөнд Бурханы хайрласан хишиг нь үнэхээрийн элбэг баян агаад газар нутаг бүрд орон нутгийн бүтээгдэхүүн байдаг. Жишээлбэл, зарим газар улаан хасарваань (мөн улаан чавга гэж нэрлэдэг) элбэг байхад, заримд нь хушга, газрын самар, өөр бусад олон янзын самар элбэг байдаг. Эдгээр материаллаг зүйл бүгд хүний биеийг хэрэгтэй шим тэжээлээр нь хангадаг. Гэхдээ Бурхан жилийн улирал, цаг үеийн дагуу аливаа зүйлээр зөв цагт нь таарсан хэмжээгээр хүн төрөлхтнийг хангадаг. Хүн төрөлхтөн бие махбодын таашаалд шунадаг, ховдог хомхой учраас хүн төрөлхтнийг бүтээхдээ Түүний тогтоосон хүний өсөж үржих байгалийн хуулийг зөрчиж, сүйтгэхэд хялбар байдаг. Интоорыг жишээ болгон авч үзье. Интоор ойролцоогоор зургаадугаар сард боловсордог. Хэвийн нөхцөлд наймдугаар сар гэхэд интоор байхгүй болсон байна. Интоорыг хоёрхон сар л шинэхэн байлгаж болно, гэвч хүмүүс тэр хугацааг одоо шинжлэх ухааны аргаар 12 сар, тэр ч бүү хэл, интоорын дараагийн ургац хүртэл сунгаж чадаж байна. Энэ нь бүтэн жилийн турш интоор байна гэсэн үг. Энэ үзэгдэл хэвийн үү? (Үгүй.) Тэгвэл интоор идэх хамгийн тохиромжтой улирал хэзээ вэ? Зургаадугаар сараас наймдугаар сар. Энэ хугацаанаас хойш бол чи яаж ч шинэхнээр нь хадгалаад адилхан амтагдахгүй, хүний биед хэрэгтэй зүйлийг нь ч өгөхгүй. Хугацаа нь дуусмагц ямар ч химийн бодис хэрэглэсэн гэсэн, байгальд ургасан шиг бүх зүйлийг нь шингээж өгч чадахгүй. Дээрээс нь, тэдгээр химийн бодисын хүмүүст учруулах хор хөнөөлийг хэн ч, яаж ч оролдоод арилгаж, эсвэл өөрчилж чадахгүй. Тэгэхээр одоогийн зах зээлийн эдийн засаг хүмүүст юу авчирдаг вэ? Хүмүүсийн амьдрал илүү дээрдсэн мэт санагдаж, бүс нутгуудын хоорондох зам тээвэр ихээхэн тав тухтай болж, хүмүүс бүх төрлийн жимсийг дөрвөн улирлын хэдийд ч идэж чадахаар болсон. Хойд нутгийн хүмүүс гадилаас гадна бүс нутгийн ямар ч амттан, жимс, өмнөдийн бусад хүнсийг байнга идэж чадахаар болсон. Гэхдээ хүн төрөлхтөнд Бурханы өгөхийг хүссэн амьдрал энэ биш юм. Ийм зах зээлийн эдийн засаг хүмүүсийн амьдралд зарим нэг ашиг тус авчирч болох ч бас хор хөнөөл авчирч чадна. Зах зээл дээр элбэг дэлбэг байдгаас нь болж олон хүн амандаа юу хийж байгаагаа бодолгүйгээр иддэг. Ийм зан авир байгалийн хуулийг зөрчиж байгаа бөгөөд хүмүүсийн эрүүл мэндэд хор хөнөөлтэй. Иймээс зах зээлийн эдийн засаг хүмүүст жинхэнэ аз жаргалыг авчирч чадахгүй. Өөрсдөө харцгаа. Зах зээл дээр жилийн дөрвөн улирлын турш усан үзэм зардаг бус уу? Усан үзэм үнэндээ түүсний дараа тун богино хугацаанд л шинэхнээрээ байдаг. Хэрвээ дараа жилийн зургаадугаар сар хүртэл хадгалбал тэдгээрийг усан үзэм гэж нэрлэж болох уу? Эсвэл “хог” гэх нь илүү дээр нэр болов уу? Тэдгээр нь зүгээр нэг шинэхэн усан үзэмд байх ёстой бодис нь байхгүй болсон юм биш илүү их химийн бодистой болсон байдаг. Жилийн дараа шинэхэн байхаа больж, шим тэжээл нь хэдийн үгүй болсон байдаг. Хүмүүс усан үзэм идэхдээ: “Бид ямар азтай юм бэ! Бид 30 жилийн өмнө энэ улиралд усан үзэм идэж чаддаг байл уу? Хүссэн ч идэж чадахгүй байсан. Одоо амьдрал үнэхээр сайхан байна!” гэж санагддаг. Энэ үнэхээр аз жаргал мөн

үү? Хэрвээ чи сонирхож байвал химийн бодисын тусламжтайгаар хадгалдаг усан үзмийг өөрөө судалж үзээд, яг юунаас бүтдэг, тэрхүү бодис нь хүнд ашиг тус өгч чадах эсэхийг харж болно. Хуулийн эрин үед израильчууд Египетийг орхиж гараад явж байхад нь Бурхан тэдэнд бөднө шувуу болон манна өгсөн. Гэвч Бурхан тэдгээр хүнсийг хадгалахыг хүнд зөвшөөрсөн үү? Тэдний зарим нь алсын хараагүй байсан бөгөөд маргааш дахиж өгөхгүй байх гэж айгаад заримыг нь дараа хэрэглэхээр хадгалсан. Гэтэл юу болсон бэ? Дараагийн өдөр тэр нь ялзарсан байсан. Үлдээж, нөөцлөхийг Бурхан чамд зөвшөөрөхгүй, учир нь Тэр чамайг баталгаатай өлсгөлөн явуулахгүйгээр бэлдсэн. Гэвч хүн төрөлхтөнд тийм найдвар ч, Бурханд итгэх жинхэнэ итгэл ч байхгүй. Тэд арга мэх сүвэгчлэх боломж өөртөө гаргахыг үргэлж хүсдэгийн дээр хүн төрөлхтөнд зориулж Бурханы бэлдсэн зүйлийн цаана байгаа тэр бүх халамж, сэтгэлийг хэзээ ч харж чаддаггүй. Тэд үүнийг мэдэрч чаддаггүй учраас Бурханд бүрэн итгэж чадахгүй, үргэлж: “Бурханы үйлдэл найдваргүй! Бурхан бидэнд хэрэгтэй зүйлийг өгөх эсэхийг, эсвэл хэзээ өгөхийг хэн мэдэх юм! Хэрвээ намайг өлсөж үхэх гэж байхад Бурхан хангахгүй бол би өлбөрч үхэх бус уу? Би хоол тэжээлийн дутагдалд орох бус уу?” хэмээн бодож байдаг. Хүний итгэл хэчнээн үхээнц болохыг харж байна уу!

Үр тариа, жимс, хүнсний ногоо, бүх төрлийн самар гээд энэ бүгд нь ургамлын гаралтай хоол юм. Хэдийгээр ургамлын гаралтай хоол боловч хүний биеийн хэрэгцээг хангахуйц хангалттай шим тэжээлтэй. Гэсэн хэдий ч Бурхан: “Эдгээр хоолыг л Би хүн төрөлхтөнд өгнө. Тэдэнд эдгээр зүйлийг л идүүл!” гэж хэлээгүй. Бурхан тэгээд зогсчхоогүй, харин ч хүн төрөлхтөнд бүр их амттай илүү их хоолыг бэлдсээр байсан. Эдгээр хоол нь юу вэ? Энэ нь та нарын ихэнх нь харж, идэж чаддаг төрөл бүрийн мах, загас юм. Тэрээр хүнд зориулан маш олон төрлийн мах, загас бэлдсэн. Загас усанд амьдардгийн дээр усны загасны махных нь бүтэц хуурай газар дээр амьдардаг амьтдын махнаас өөр байдаг ба хүнд өөр өөр шим тэжээл өгч чадна. Загас мөн хүний бие дэх халуун, хүйтнийг зохицуулж чадах шинж чанартай байдаг нь хүнд ихээхэн ашиг тустай юм. Гэхдээ сайхан амттай хоолыг хэтрүүлж идэж болохгүй. Аль хэдийн Миний хэлсэнчлэн, Бурхан хүн төрөлхтөнд зөв цагт нь, таарсан хэмжээгээр нь хайрладаг, ингэснээр хүмүүс Түүний хайрласныг улирал, цагийн дагуу хэвийн байдлаар, зүй зохистойгоор эдэлж чаддаг. Тэгэхээр шувууны махны ангилалд ямар төрлийн хүнс багтдаг вэ? Тахиа, бөднө, тагтаа гэх мэт. Олон хүн бас нугас, галуу иддэг. Бурхан энэ бүх махаар хангасан хэдий ч Өөрийн сонгосон хүмүүст тодорхой шаардлага тавьж, Хуулийн эрин үед хоол хүнсэнд нь тодорхой хязгаарлалт тавьсан. Өнөө үед энэхүү хязгаарлалт нь хувь хүний дур сонирхол, өөрөө хэрхэн ойлгох дээр тулгуурладаг. Энэхүү янз бүрийн мах нь хүний биеийг янз бүрийн шим тэжээлээр хангаж, уураг, төмөр нөхөж, цус төлжүүлж, булчин, яс бэхжүүлэн, тамир тэнхээ суулгадаг. Хүмүүс ямар аргаар болгож идэхээс үл хамааран, эдгээр мах нь хоолны амт сайжруулж, хүмүүсийн хоолны дуршлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ мөн ходоодыг нь дүүргэхэд тусалж

байдаг. Хамгийн чухал нь эдгээр хоол хүнс хүний биеийн өдөр тутмын шим тэжээлийн хэрэгцээг хангаж чадна. Бурхан хүн төрөлхтөнд зориулан хүнс хоол бэлдэхдээ үүнийг бодолцож үзсэн. Ногоо ч, мах ч байдаг нь элбэг баян байгаа бус уу? Гэвч Бурхан хүн төрөлхтөнд зориулж бүх хоол хүнсийг бэлдэж өгөхдөө ямар санаа зорилготой байсныг хүмүүс ойлгох хэрэгтэй. Энэ хоол хүнсийг хүн төрөлхтөн хэтрүүлэн хэрэглэг гэсэн үү? Хүн эдгээр материаллаг хүслээ хангахаар оролддогоо болихгүй болчихвол юу болох вэ? Тэр хоол тэжээлийн илүүдэлтэй болох бус уу? Хоол тэжээлийн хэт илүүдэлтэй байх нь хүний биеийг олон янзаар зовоодог бус уу? (Тийм.) Тийм учраас Бурхан таарсан хэмжээгээр зөв цагт хуваарилан өгч, өөр өөр цаг үе, улиралд нийцүүлэн хүмүүст янз бүрийн хоол хүнс хэрэглүүлдэг билээ. Жишээлбэл, маш халуун зуны дараа хүмүүсийн биед нэлээд их халуунаас гадна эмгэг хуурайшилт, чийг хуримтлагдана. Намар болоход, олон төрлийн жимс боловсордог бөгөөд хүмүүс эдгээр жимсийг идэхэд бие дэх чийгийг нь хөөнө. Энэ үед үхэр, хонь мөн тарга тэвээрэг авсан байх тул хүмүүс тэжээл болгож илүү их мах идэх хэрэгтэй. Төрөл бүрийн мах идсэнээр хүмүүсийн бие өвлийн хүйтнийг давах эрч хүч, дулааныг олж авч, үүний үр дүнд өвлийг аюулгүй, эсэн мэнд давч чадна. Бурхан хүн төрөлхтнийг хэдийд, юугаар хангах, мөн өөр өөр зүйлс хэдийд ургаж, үр жимсээ өгч, боловсрохыг маш нарийн бодож, тооцоолон хянаж, зохицуулдаг. Энэ нь “Хүний өдөр тутмын амьдралд хэрэгтэй хоол хүнсийг Бурхан хэрхэн бэлддэг”-т хамаарна. Олон төрлийн хоол хүнснээс гадна, Бурхан хүн төрөлхтнийг усны эх үүсвэрээр бас хангадаг. Хүмүүс юм идсэний дараа ус уух хэрэгтэй. Жимс дангаараа хангалттай юу? Хүмүүс дан ганц жимсээр амьдарч чадахгүй, үүнээс гадна зарим улиралд жимс байдаггүй. Тэгэхээр хүн төрөлхтний усны асуудлыг хэрхэн шийдэж болох вэ? Бурхан нуур, гол, булаг гээд газар дээр болон газар доор усны олон эх үүсвэр бэлдэж үүнийг шийдвэрлэсэн. Ямар нэгэн байдлаар бохирдуулаагүй, хүмүүс өөрчилж, сүйтгээгүй л бол эдгээр усны эх үүсвэрээс ууж болно. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн амьдралыг баян, элбэг дэлбэг, юугаар ч дутахгүй байлгах гэж Бурхан, хүн төрөлхтний бие махбодын амьдралыг тэтгэх хоол хүнсний эх үүсвэрийн тухайд маш чамбай, маш нарийн, тун зохимжтой бэлтгэл хийсэн. Энэ бол хүмүүсийн харж, мэдэрч болох зүйл юм.

Түүнчлэн, бүх зүйлийн дундаас Бурхан хүний биеийн гэмтлийг эдгээх, өвчнийг анагаахад онцгойлон зориулсан зарим ургамал, амьтан, төрөл бүрийн өвс ногоог бүтээсэн. Жишээлбэл, хэрвээ хүн түлэгдэх юм уу, санамсаргүй шалзлагдвал юу хийх хэрэгтэй вэ? Түлэгдлээ усаар зайлаад л болох уу? Чи зүгээр нэг даавууны өөдсөөр боогоод л болох уу? Тэгвэл шарх идээ бээрээр дүүрэх буюу халдвар авч магадгүй юм. Жишээлбэл, хүн халуурах буюу ханиад хүрч, ажиллаж байхдаа гэмтэж бэртэн, буруу зүйл идсэнээс болж ходоодны эмгэгтэй болох буюу амьдралын хэв маягийн хүчин зүйл юм уу сэтгэл хөдлөлийн асуудлаас үүдсэн зүрх судасны өвчин, сэтгэцийн эмгэг, дотор эрхтний өвчин гэх мэт тодорхой нэг өвчинтэй болбол эдгээр өвчнийг эмчлэхэд таарах ургамлууд байдаг. Цусны эргэлт

сайжруулан бүлэгнэлийг арилгаж, өвчин намдаан, цус алдалт зогсоож, мэдээ алдуулан, арьсыг сэргээн хэвийн байдалд нь оруулахад тусалж, цусны бүлэгнэл арилган, биеэс хор гадагшлуулдаг ургамлууд бий. Товчоор хэлбэл, энэ ургамлууд өдөр тутмын амьдралд хэрэгтэй. Тэдгээрийг хүмүүс хэрэглэж болно, Бурхан хүний биед хэрэг болно гэж бэлдсэн. Тэдгээрийн заримыг санаандгүй олж илрүүлэх боломжийг Бурхан хүнд олгосон бол үүнийг хийлгэхээр Бурханы сонгосон хүмүүс, эсвэл Бурханы зохион байгуулсан онцгой үзэгдлийн үр дүнд бусдыг нь олж илрүүлсэн. Эдгээр ургамлыг олж нээснийхээ дараа хүн төрөлхтөн өвлүүлэн дамжуулж, олон хүн энэ тухай мэдэж авдаг. Ийнхүү Бурхан эдгээр ургамлыг бүтээсэн нь үнэ цэн, утга учиртай юм. Дүгнэж хэлбэл, эдгээр зүйл бүгд Бурханаас улбаатай бөгөөд хүн төрөлхтөнд амьдрах орчин бүтээхдээ Түүний бэлдэж, тарьсан зүйлс юм. Эдгээр нь маш чухал. Бурхан бодож боловсруулахдаа хүн төрөлхтнөөс илүү нягт нямбай байдаг уу? Чи Бурханы хийсэн бүхнийг хараад Бурханы бодитой талыг мэдэрдэг үү? Бурхан нууцаар ажилладаг. Хүн энэ дэлхийд хараахан ирээгүй байхад, хүн төрөлхтөнтэй харилцахаасаа өмнө Бурхан энэ бүхнийг бүтээсэн. Хүн төрөлхтөнд зориулан Өөрийнх нь бэлдэж өгсөн энэ баян, элбэг дэлбэг материаллаг дэлхийд тэд хоол, хувцасны талаар санаа зоволгүй, дутагдах зүйлгүйгээр аз жаргалтай амьдраасай гэсэндээ Бурхан хүн төрөлхтнийг бодож, хүний оршин тогтнолын төлөө, тэднийг амьд байлгахыг бодолцож юм болгоныг хийсэн. Хүн төрөлхтөн ийм орчинд үргэлжлүүлэн өсөн үржиж, амьдарч чадна.

Бурханы том, жижиг бүх үйлс дотроос ямар ч үнэ цэн, учир утгагүй зүйл бий юу? Түүний хийдэг юм болгон үнэ цэн, утга учиртай байдаг. Хэлэлцүүлгээ түгээмэл сэдвээр эхэлцгээе. Хүмүүс: “Тахиа, өндөг хоёрын аль нь анхдагч вэ?” гэж үргэлж асуудаг. (Тахиа.) Тахиа анхдагч гэдэг нь эргэлзээгүй! Тахиа яагаад анхдагч вэ? Өндөг яагаад анхдагч байж болохгүй гэж? Тахиа өндөгнөөс гардаг бус уу? 21 хоногийн дараа тахиа өндөгнөөс гарч ирдэг. Тэр тахиа дараа нь олон өндөг гаргаж, тэр өндөгнүүдээс нь илүү олон тахиа гарна. Тэгэхээр тахиа, өндөг хоёрын аль нь түрүүлж гарсан бэ? Та нар туйлын итгэлтэйгээр “тахиа” гэж хариулдаг. Гэвч яагаад ингэж хариулдаг юм бэ? (Шувууд болон араатан амьтдыг Бурхан бүтээсэн гэж Библид өгүүлдэг.) Тэгэхээр та нарын хариулт Библид үндэслэсэн юм байна. Гэхдээ Бурханы үйлдлийн тухай ямар нэгэн бодит мэдлэг та нарт бий эсэхийг харах болов уу гэсэндээ өөрсдийнхөө ойлголтын талаар яриасай гэж Би хүсэж байна. Одоо та нар хариултдаа итгэлтэй байна уу, үгүй юу? (Бурхан тахиаг бүтээгээд түүнд үржих чадвар буюу өндөг дарах чадвар өгсөн.) Энэ тайлбар бараг л зөв. Эхлээд тахиа, дараа нь өндөг гарсан. Энэ бол гарцаагүй. Энд нэг их сүрхий нууц саад байх юм үгүй боловч дэлхийн хүмүүс үүнийг их сүрхий юм болгож, гүн ухааны онолоор шийдвэрлэх гэж оролддог ч хэзээ ч дүгнэлтэд хүрдэггүй. Тэднийг Бурхан бүтээсэн гэдгийг хүмүүс мэддэггүйтэй энэ нь яг адил. Тэд энэ суурь зарчмыг мэддэггүй, мөн өндөг анхдагч уу, эсвэл тахиа анхдагч уу гэдэг талаар ч тодорхой ойлголт байхгүй. Тэд аль нь анхдагч байх ёстой вэ гэдгийг мэдэхгүй тул хэзээ ч хариуг нь олж

чаддаггүй. Тахиа эхлээд бий болсон нь тун хэвийн юм. Хэрвээ тахианаас өмнө өндөг байсан бол энэ нь хэвийн бус байх байсан! Энэ бол их энгийн зүйл—тахиа эхлээд бий болсон нь мадаггүй. Энэ бол их мэдлэгтэй байхыг шаарддаг асуулт биш. Бурхан юм бүхнийг хүнд эдлүүлэх зорилготойгоор бүтээсэн. Нэгэнт тахиа оршин байгаа цагт өндөг жамаараа гарна. Энэ нь бэлээхэн шийдэл бус уу? Хэрвээ өндөг эхлээд бүтээгдсэн бол үүнийг дарах тахиа мөн л хэрэгтэй болох байсан бус уу? Шууд тахиа бүтээх нь хавьгүй дөт шийдэл юм. Ингэснээр тахиа өндөглөж, өндгөн дотроо ангаахай дарж чадах бөгөөд хүмүүс тахианы мах идэж болно. Хэчнээн амар вэ! Аливааг хийх Бурханы арга зам аятайхан, цэвэрхэн, огтхон ч төвөгтэй биш байдаг. Өндөг хаанаас гардаг вэ? Тахианаас гардаг. Тахиа байхгүй бол өндөг байхгүй. Бурханы бүтээсэн юм нь амьд зүйл байсан! Хүн төрөлхтөн хөгийн, инээд хүрмээр, үргэлж ийм энгийн зүйлд будилж, эцэстээ өчнөөн олон утгагүй төөрөгдлийг гаргаж ирдэг. Хүн ямар гэнэн юм бэ! Өндөг, тахиа хоёрын хоорондын харилцаа тодорхой байдаг: Тахиа эхлээд бий болсон. Энэ бол хамгийн үнэн зөв тайлбар, үүнийг ойлгох хамгийн үнэн зөв арга, хамгийн үнэн зөв хариулт юм. Энэ бол зөв.

Бид дөнгөж сая ямар сэдвээр ярилцсан бэ? Бид хүн төрөлхтний амьдардаг орчин, энэ орчны төлөө Бурхан юу юу хийж, бэлдсэн талаар, эхлээд ярилцсан. Тэр юуг зохицуулсан; хүн төрөлхтөнд зориулж Бурханы бэлдсэн бүх зүйлийн хоорондын харилцаа; мөн Түүний бүтээсэн зүйлс хүн төрөлхтөнд хор хөнөөл учруулахаас сэргийлэхийн тулд эдгээр харилцааг Бурхан хэрхэн зохицуулсан талаар бид ярилцлаа. Бурхан бас хүн төрөлхтний хүрээлэн буй орчинд олон өөр өөр хүчин зүйлийн учруулж болзошгүй хор хөнөөлийг багасгаж, бүх зүйлд үүргээ хамгийн сайн гүйцэтгэх боломж олгож, хүн төрөлхтөнд ач тустай элемент бүхий ашиг тустай орчныг бүрдүүлснээрээ ийм орчинд дасан зохицож, амьдрал, үржлийн мөчлөгийг тасралтгүй үргэлжлүүлэх боломжийг хүн төрөлхтөнд олгосон. Дараа нь бид хүний биед хэрэгтэй хоол хүнс—хүн төрөлхтний өдөр тутмын хоол ундны талаар ярилцсан. Энэ нь ч бас хүн төрөлхтөн амьд оршиход зайлшгүй чухал нөхцөл билээ. Өөрөөр хэлбэл, хүний бие дан ганц амьсгалаад, зөвхөн нарны гэрлээр тэтгүүлээд, салхи, эсвэл тохирсон температуртай байгаад амьдарч чадахгүй. Хүмүүс бас ходоодоо дүүргэх хэрэгтэй бөгөөд Бурхан хүн төрөлхтөнд зориулан тэдний ходоодоо дүүргэх хүнсний эх үүсвэрийг юуг нь ч орхигдуулалгүйгээр бэлдсэн. Хүн төрөлхтний хоол ундны эх үүсвэр болох эдгээр элбэг баян бүтээгдэхүүнийг хараад, Бурхан бол хүн төрөлхтөн болон Түүний бүтээсэн бүх зүйлийг тэтгэх эх сурвалж мөн хэмээн чи хэлж чадах уу? Хэрвээ бүтээлийн цаг үед Бурхан зөвхөн мод, өвс ургамал юм уу олон тооны бусад амьд зүйлийг бүтээсэн бол, энэхүү янз бүрийн амьд зүйл, ургамал нь бүгд үхэр, хонь, эсвэл эрээн тахь, буга зэрэг өөр бусад янз бүрийн амьтанд зориулагдсан, жишээлбэл, эрээн тахь, буга зэргийг арслан иддэг, хонь, гахай зэргийг бар иддэг, харин хүн идэхэд тохиромжтой ганц ч зүйл байхгүй байсан бол болох байсан уу?

Болохгүй. Хүн төрөлхтөн удаан амьдарч чадахгүй байсан. Хүн зөвхөн навч иддэг байсан бол яах вэ? Тэгж болох байсан уу? Хонинд зориулагдсан өвсийг хүмүүс идэж чадах байсан уу? Жаахан идэж үзвэл зүгээр байж магадгүй боловч удаан хугацаанд тийм зүйл идвэл ходоод нь боловсруулж чадахгүй бөгөөд хүмүүс удаан амьд явахгүй. Амьтад идэж болдог ч хүнд хортой зүйл ч байдаг. Амьтад идээд яах ч үгүй боловч хүмүүсийн хувьд тийм биш. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг бүтээсэн болохоор хүний биеийн бүтэц, зүй тогтол болон хүнд юу хэрэгтэйг Бурхан хамгийн сайн мэддэг. Биеийн найрлага, агууламж, хэрэгцээ, дотор эрхтнүүдийн үйл ажиллагаа, тэдгээр нь янз бүрийн бодисыг хэрхэн шингээж, задалж, боловсруулдгийг Бурхан маш сайн мэддэг. Хүмүүс үүнийг мэдэхгүй; заримдаа тэд ухаангүй идэж, өөртөө огт санаа тавихгүй, хэтэрхий их ийм байх нь тэнцвэр алдагдахад хүргэдэг. Хэрвээ та нарт зориулж Бурханы бэлдсэн зүйлсийг хэвийн байдлаар идэж, эдэлбэл чамд ямар ч эрүүл мэндийн асуудал үүсэхгүй. Заримдаа сэтгэл санаа тавгүй, цусны бүлэгнэлтэй байсан ч гэсэн ямар ч асуудалгүй. Чи тодорхой нэг төрлийн ургамал идэхэд л цусны бүлэгнэл арилна. Бурхан энэ бүх зүйлийг бэлдчихсэн. Иймээс, Бурханы нүдэнд хүн төрөлхтөн ямар ч амьд зүйлээс хамаагүй дээгүүрт байдаг. Бурхан ургамлын төрөл зүйл бүрд зориулсан орчин, амьтны төрөл зүйл бүрд зориулсан хоол, амьдрах орчин бэлдсэн, харин хүн төрөлхтний хүрээлэн буй орчны хэрэгцээ шаардлага л хамгийн нарийн бөгөөд энэхүү хэрэгцээ шаардлагыг үл тоомсорлож өчүүхэн ч болохгүй. Эс бөгөөс, хүн төрөлхтөн хэвийн байдлаар үргэлжлүүлэн хөгжиж, амьдарч, үржиж чадахгүй байх байлаа. Бурхан үүнийг зүрх сэтгэлдээ маш сайн мэддэг. Бурхан үүнийг хийхдээ юу юунаас ч илүү чухал ач холбогдол өгсөн юм. Чи амьдралдаа харж, эдэлж чаддаг зарим энгийн зүйл, эсвэл төрсөн цагаас чинь чамд байсан харж, эдэлж болох зүйлийн ач холбогдлыг мэдэрч чаддаггүй байж магадгүй боловч Бурхан чамд зориулаад үүнийг аль эрт, нууцаар бэлдчихсэн байдаг. Бурхан, хүн төрөлхтөнд таатай бус, хүний биед хор хохирол учруулж болох бүх сөрөг элементийг боломжит дээд хэмжээгээр арилгаж, багасгасан. Энэ нь юуг харуулж байна вэ? Хүн төрөлхтнийг бүтээхдээ тэдэнд хандаж байсан Бурханы хандлагыг энэ удаад харуулж байна уу? Тэрхүү хандлага нь ямар байсан бэ? Бурхан хянамгай бөгөөд хичээнгүй хандаж байсан бөгөөд Өөрөөс нь өөр ямарваа хүчин зүйл, нөхцөл байдал, эсвэл дайсны ямар ч хүч хөндлөнгөөс оролцохыг Тэр тэвчихгүй байсан. Хүн төрөлхтнийг бүтээж, удирдахдаа гаргадаг Бурхан хандлагыг үүнээс энэ удаад харж болно. Бурханы хандлага ямар байдаг вэ? Хүнийг бүтээснээс хойш тэдэнд хандах Бурхны хариуцлагатай хандлага, түүнчлэн энэ удаад хүн төрөлхтнийг аврах гэсэн Бурханы шийдэмгий байдлыг бид, хүн төрөлхтний амьдрах орчин, эдэлдэг амьдрал, түүнчлэн тэдний өдөр тутмын хоол унд, хэрэгцээнээс харж болно. Эдгээр зүйлээс Бурханы бодит байдал харагддаг уу? Түүний гайхалтай байдал харагддаг уу? Бурханы ойлгошгүй байдал харагддаг уу? Түүний бүхнийг чадагч байдал харагддаг уу? Бүх хүн төрөлхтнийг хангаж, түүнчлэн Өөрийн бүтээсэн бүх зүйлийг хангахын тулд Бурхан Өөрийн мэргэн

бөгөөд төгс хүчит арга замыг ашигладаг. Би маш их зүйлийг та нарт хэлсэн болохоор Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж гэж та нар хэлж чадах уу? (Тийм.) Гарцаагүй тийм шүү. Та нарт эргэлзээ байна уу? (Үгүй.) Бурхан бүх зүйлийг хангадаг нь Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж гэдгийг харуулахад хангалттай, учир нь Тэр бол бүх зүйлд орших, амьдрах, өсөж үржих, үргэлжлэх боломжийг олгосон хангалтын эх сурвалж бөгөөд Бурханаас Өөрөөс нь өөр ямар ч эх сурвалж үгүй. Хүмүүсийн хүрээлэн бус орчны хамгийн үндсэн хэрэгцээ ч бай, өдөр тутмын амьдралынх нь хэрэгцээ ч бай, эсвэл хүмүүсийн сүнсийг хангадаг үнэний хэрэгцээ ч бай, Бурхан бүх зүйлийн хэрэгцээг бүгдийг нь, хүн төрөлхтний бүх хэрэгцээг хангадаг. Бурханы ялгамж чанар, байр суурь бүх талаар хүн төрөлхтөнд асар их ач холбогдолтой байдаг; зөвхөн Бурхан Өөрөө л бүх зүйлийн амийн эх сурвалж юм. Өөрөөр хэлбэл, Бурхан бол хүмүүсийн харж, мэдэрч чаддаг энэхүү ертөнцийн Захирагч, Эзэн, Хангагч юм. Хүн төрөлхтний хувьд энэ нь Бурханы ялгамж чанар бус уу? Үүнд ямар ч худал зүйл үгүй. Иймээс чи тэнгэрт нисэж буй шувууг харахдаа Бурхан нисэж чаддаг бүх зүйлийг бүтээсэн гэдгийг мэдэх ёстой. Усанд сэлдэг амьд зүйл байдаг бөгөөд тэдгээр нь өөрийн гэсэн амьдрах арга замтай. Хөрсөнд амьдардаг мод, ургамал хавар соёлж, нахиалан, намар үр жимсээ өгч, навчсаа гөвж, өвөл болоход бүх навчис нь унаж тэдгээр ургамал өвлийг давж гарахад бэлддэг. Энэ бол тэдний амьд үлдэх арга зам юм. Бурхан бүх зүйлийг бүтээсэн, эдгээр нь тус бүрдээ өөр өөр хэлбэрээр, өөр өөр арга замаар амьдарч, өөрийн амийн хүч чадал, амьдардаг хэлбэрийг үзүүлэхдээ өөр өөр арга хэрэглэдэг. Тэд хэрхэн амьдрахаас үл хамааран бүгд Бурханы захиргаан дор байдаг. Бүх төрлийн амьдралын хэлбэр болон амьд биесийг Бурхан захирдгийн зорилго юу вэ? Хүн төрөлхтнийг амьд байлгахын төлөө юу? Тэрээр амийн бүх хуулийг хянадаг нь бүгд хүн төрөлхтнийг амьд байлгахын төлөө байдаг. Хүн төрөлхтөн амьд байх Бурханд хэчнээн чухал болохыг энэ нь харуулдаг.

Хүн төрөлхтөн хэвийн амьдарч, өсөж үржих чадвартай байх нь Бурханд нэн чухал юм. Тиймээс Бурхан хүн төрөлхтөн болон Өөрийн бүтээсэн бүх зүйлийг байнга хангаж байдаг. Тэр бүх зүйлийг өөр өөр арга замаар хангадаг бөгөөд бүх зүйлийг амьд байлгаснаар Тэр хүн төрөлхтнийг үргэлжлүүлэн урагш ахиулж, хүн төрөлхтний хэвийн амьдралыг хадгалдаг. Бидний өнөөдөр нөхөрлөж байгаа хоёр тал энэ юм. Энэ хоёр тал нь юу вэ? (Том өнцгөөс харвал, Бурхан хүн төрөлхтний амьдрах орчныг бүтээсэн. Энэ нь нэг дэх тал. Мөн Бурхан, хүн төрөлхтөнд хэрэгтэй бөгөөд харж, хүрч болох материаллаг зүйлсийг бэлдсэн.) Бид үндсэн сэдвээ энэ хоёр талаас нь нөхөрлөсөн. Үндсэн сэдэв маань юу вэ? (Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж.) Миний нөхөрлөсөн энэ сэдэв яагаад ийм агуулгатай байсан талаар та нар одоо зарим нэг ойлголттой болсон байх ёстой. Үндсэн сэдэвтэй холбогдолгүй хэлэлцүүлэг байсан уу? Огт байгаагүй! Магадгүй эдгээр зүйлийг сонсоод та нарын зарим нь ямар нэг ойлголт авч, эдгээр үг нөлөөтэй, маш чухал гэдгийг одоо мэдэрсэн боловч бусад нь зөвхөн шууд утгаар нь ойлгож, эдгээр үг нь

өөрөө чухал биш гэж боддог. Одоогоор та бүхэн үүнийг хэрхэн ойлгож байгаагаас үл хамааран, туршлага тодорхой хэмжээнд хүрч, та нарын ойлголт тодорхой хэмжээнд хүрэхэд, өөрөөр хэлбэл, Бурханы үйлдэл болон Бурханы Өөрийнх нь тухай мэдлэг чинь тодорхой түвшинд хүрэхэд та нар Бурханы үйлдлийн талаар гүн гүнзгий, жинхэнэ гэрчлэл хийхийн тулд өөрсдийн бодитой үгийг ашиглана.

Та нарын одоогийн ойлголт нэлээд өнгөц, баригдмал хэвээр байгаа гэж Би боддог боловч Миний нөхөрлөлийн энэ хоёр талыг сонсоод хүн төрөлхтнийг хангахдаа Бурхан ямар арга барил хэрэглэдэг, эсвэл Бурхан хүн төрөлхтнийг юугаар хангадгийг ядаж танин мэдэж чадсан уу? Та нарт үндсэн ухагдахуун, үндсэн ойлголт байна уу? (Тийм.) Гэхдээ Миний нөхөрлөсөн энэ хоёр тал Библитэй холбоотой юу? Тэдгээр нь Хаанчлалын эрин үе дэх Бурханы шүүлт, гэсгээлтэй холбоотой юу? (Үгүй.) Тэгвэл Би яагаад тэдгээрийн талаар нөхөрлөсөн бэ? Хүмүүс Бурханыг мэдэхийн тулд тэдгээрийг ойлгох ёстой учраас тэр үү? (Тийм.) Эдгээр зүйлийг мэдэх нь маш чухал, бас эдгээрийг ойлгох нь маш чухал. Бурханыг бүхэлд нь ойлгохоор эрж хайхдаа өөрийгөө Библиэр бүү хязгаарла, зөвхөн Бурхан хүнийг шүүж, гэсгээдгээр өөрийгөө бүү хязгаарла. Энийг хэлж байгаагийн минь зорилго юу вэ? Бурхан бол зөвхөн Өөрийн сонгосон ард түмний Бурхан төдий биш гэдгийг хүмүүст мэдүүлэхийн тулд юм. Чи одоогоор Бурханыг дагадаг, Тэр чиний Бурхан, харин Өөрийг нь дагадаггүй хүмүүсийн Бурхан Тэр мөн үү? Бурхан Өөрийг нь дагадаггүй бүх хүний Бурхан мөн үү? Бурхан бүх зүйлийн Бурхан мөн үү? (Мөн.) Тэгвэл Бурханы ажил, үйлдлийн цар хүрээ ердөө л Өөрийг нь дагадаг хүмүүсээр хязгаарлагддаг уу? (Үгүй.) Түүний ажил болон үйлдлийн цар хүрээ юу вэ? Түүний ажил болон үйлдлийн хамрах хүрээ нь хамгийн багадаа бүх хүн төрөлхтөн болон бүтээгдсэн бүх зүйлийг хамардаг. Хамгийн ихдээ энэ нь хүмүүсийн харж чаддаггүй бүхэл бүтэн орчлон ертөнцийг хамардаг. Тиймээс Бурхан бүх хүн төрөлхтний дунд Өөрийн ажлыг хийж, Өөрийн үйлдлийг гүйцэтгэдэг гэж хэлж болох бөгөөд Бурханыг Өөрийг нь бүхэлд нь мэдэж авах боломжийг хүмүүст олгоход энэ хангалттай. Хэрвээ чи Бурханыг мэдэж, үнэхээр Түүнийг мэдэж, ойлгож авахыг хүсэж байвал зөвхөн Бурханы ажлын гурван үе шат болон Бурханы урьд нь гүйцэтгэсэн ажлын тухай түүх төдийхнөөр өөрийгөө бүү хязгаарла. Хэрвээ чи Түүнийг тийм маягаар мэдэх гэж оролдвол Бурханд хязгаар тавьж, Түүнийг хязгаарлаж байна. Чи Бурханыг маш өчүүхэн зүйл гэж харж байна. Ингэх нь хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ? Чи Бурханы гайхалтай байдал болон эрхэм дээд чанарыг ч тэр, бас Бурханы хүч чадал, бүхнийг чадагч байдал, Түүний эрх мэдлийн хүрээг хэзээ ч мэдэж чадахгүй байх байсан. Бурхан бол бүх зүйлийн Захирагч гэсэн үнэнийг хүлээн зөвшөөрөх чиний чадвар, түүнчлэн Бурханы жинхэнэ ялгамж чанар, байр суурийн тухай мэдлэгт чинь ийм ойлголт нөлөөлөх байсан. Өөрөөр хэлбэл, Бурханы талаарх ойлголт чинь хязгаарлагдмал цар хүрээтэй бол хүлээн авч чадах зүйл чинь ч бас хязгаарлагдмал байна. Ийм учраас чи цар хүрээгээ өргөжүүлж, мэдлэгээ тэлэх ёстой. Бурханы ажил, Бурханы удирдлага, Бурханы захиргааны цар хүрээ, Түүний

удирдаж, захирдаг бүх зүйл гээд энэ бүхнийг чи ойлгохоор эрж хайх ёстой. Ийм зүйлээр дамжуулан чи Бурханы бүх үйлдлийг ойлгож авах ёстой. Ийм ойлголттой байхад Бурхан бүх зүйлийн дундаас бүх зүйлийг захирч, удирдаж, хангаж байдгийг өөрийн мэдэлгүй мэдэрч, бас чи бүх зүйлийн нэг хэсэг, нэг гишүүн гэдгээ үнэхээр мэдэрнэ. Бурхан бүх зүйлийг хангадаг болохоор чи ч бас Бурханы захиралт болон хангалтыг хүлээн авдаг. Энэ бол хэн ч үгүйсгэж чадахгүй баримт юм. Бүх зүйл Бурханы захиргаан дор өөрсдийн хуульд захирагддаг, бүх зүйл Бурханы захиргаан дор өөрийн гэсэн оршин тогтнох дүрэмтэй. Хүн төрөлхтний хувь заяа болон хэрэгцээ нь мөн Бурханы захиргаа, хангалттай холбоотой байдаг. Тийм учраас Бурханы ноёрхол болон захиргаан дор хүн төрөлхтөн, бүх зүйл өөр хоорондоо холбоотой, харилцан хамааралтай, сүлжилдсэн байдаг. Бурхан бүх зүйлийг бүтээсний зорилго, үнэ цэн энэ билээ.

2014 оны 2 дугаар сарын 2

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ IX
БУРХАН БОЛ БҮХ ЗҮЙЛИЙН АМИЙН ЭХ СУРВАЛЖ (III)

Энэ хугацаанд бид Бурханыг мэдэхтэй холбоотой олон зүйлийг ярьсан бөгөөд саяхан бид үүнтэй холбоотой маш чухал сэдвээр ярилцсан. Сэдэв нь юу вэ? (Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж.) Миний ярьсан зүйлс болон сэдэв хүн бүрд тод сэтгэгдэл төрүүлсэн юм шиг байна. Өнгөрсөн удаа бид, хүн төрөлхтөнд зориулан Бурханы бүтээсэн амьд орших орчин нөхцөлийн цөөн хэдэн талын тухай болон хүн төрөлхтөнд зориулан Бурханы бэлтгэсэн хүмүүс амьдрахад шаардлагатай олон төрлийн хоол тэжээлийн тухай ярилцсан. Үнэн хэрэгтээ, Бурханы хийдэг зүйл бол зөвхөн хүмүүсийн амьд орших орчин нөхцөлийг бэлтгэхээр хязгаарлагддаггүй, тэдний өдөр тутмын хоол тэжээлийг бэлтгэхээр ч бас хязгаарлагддаггүй. Харин хүмүүсийн амьд орших болон хүн төрөлхтний амийн олон өөр талтай хамаатай асар их хэмжээний нууцлаг, зайлшгүй ажлыг гүйцэлдүүлэхээс бүрдэнэ. Эдгээр нь бүгд Бурханы үйлс юм. Бурханы эдгээр үйлс нь зөвхөн хүмүүсийн амьд орших орчин нөхцөл болон өдөр тутмын хоол тэжээлийг бэлтгэхээр хязгаарлагддаггүй—үүнээс хавьгүй илүү өргөн цар хүрээтэй. Энэ хоёр төрлийн ажлаас гадна Тэр бас хүн амьдрахад шаардлагатай, амьдрах олон орчин, нөхцөл байдлыг бэлтгэдэг. Энэ бол өнөөдөр бидний ярих гэж буй сэдэв юм. Энэ нь бас Бурханы үйлстэй холбоотой; эс бөгөөс, үүнийг энд ярих нь ямар ч утгагүй байх байлаа. Хүмүүс Бурханыг мэдэхийг хүсдэг боловч “Бурхан” гэх үгийн талаар, эсвэл Бурханд юу байгаа болон Тэр юу болохын янз бүрийн талын тухайд зөвхөн үгчилсэн ойлголттой байдаг бол тэр нь жинхэнэ ойлголт биш юм. Тэгвэл Бурханы тухай мэдлэгийн зам гэж юу вэ? Энэ нь Түүний үйлсээр дамжуулан Түүнийг мэдэх, Түүнийг олон талаас нь мэдэх явдал юм. Тиймээс бид Бурхан бүх зүйлийг бүтээсэн үеийн Түүний үйлсийн талаарх сэдвээр цааш нь нөхөрлөх ёстой.

Бурхан бүх зүйлийг бүтээсэн цаг мөчөөс хойш Түүний тогтоосон хуулиудын дагуу бүх зүйл дэг журамтайгаар ажиллаж, тасралтгүй ахиж хөгжсөөр ирсэн. Түүний харц, Түүний захиргаан дор хүн төрөлхтөн амьд оршихтой зэрэгцэн бүх зүйл дэг журамтайгаар хөгжсөөр ирсэн. Эдгээр хуулийг өөрчлөх юм уу устгаж чадах зүйл юу ч үгүй. Бурханы захиралтаас болж бүх зүйл үржиж чаддаг, Түүний захиралт болон удирдлагаас болж бүх зүйл амьд оршиж чаддаг. Өөрөөр хэлбэл, Бурханы захиргаан дор бүх зүйл дэг журамтайгаар оршин тогтнож, өсөж бойжоод, алга болж, дахин төрдөг. Хавар болоход шиврээ бороо шинэхэн улирлын мэдрэмжийг авчирч, газар дэлхийг чийглэнэ. Газар шороо гэсэж, өвс ногоо газрын хөрсийг түрэн гарч ирээд, нахиалж эхлэхэд, модод аажмаар ногоордог. Энэ бүх амьд зүйл газар дэлхийд шинэхэн эрч хүч авчирдаг. Бүх зүйл бий болж, өсөж ургахдаа ингэж харагддаг. Бүх төрлийн амьтад ичээнээсээ гарч, хаврын дулаан илчийг мэдэрч, шинэ жилийг эхлүүлдэг. Бүх зүйл зундаа халуунд нарлаж, улирлаа даган ирсэн дулааныг таашаадаг. Тэд хурдан ургадаг. Мод, өвс ногоо гээд бүх төрлийн ургамал

маш хурдан ургаж, эцэст нь цэцэглэж, жимсэлдэг. Хүмүүсийг оролцуулаад бүх зүйл зундаа завгүй байдаг. Намрын улиралд бороо намар цагийн сэрүүнийг авчирч, төрөл бүрийн амьтад ургац хураалтын улирал ирснийг мэдэрч эхэлдэг. Бүх оршихуй үр жимсээ өгч, хүмүүс өвлийн хоол хүнсээ бэлтгэхийн тулд эдгээр янз бүрийн жимсийг хурааж эхэлдэг. Өвөл ирэхэд хүйтэнд бүх зүйл аажмаар амарч, нам гүм болж эхэлдэг бөгөөд хүмүүс ч бас энэ улиралд амарч авдаг. Улирлаас улиралд, хавраас зун, намар, өвөл рүү шилжих эдгээр өөрчлөлт нь бүгд Бурханы тогтоосон хуулийн дагуу явагддаг. Тэр эдгээр хуулийг ашиглан бүх зүйл болон хүн төрөлхтнийг залж чиглүүлдэг бөгөөд хүн төрөлхтөнд зориулан баялаг, өнгөлөг амьдралын замыг бүтээж өгч, өөр өөр температур, улиралтай амьд орших орчныг бэлтгэсэн. Тиймээс амьд орших иймэрхүү дэг журамтай орчинд хүмүүс амьд оршиж, дэг журамтайгаар өсөж үрждэг. Хүмүүс эдгээр хуулийг өөрчилж чадахгүй, хэн ч, юу ч үүнийг эвдэж чадахгүй. Тоо томшгүй олон өөрчлөлт гарч—далай тэнгис тал газар болж, тал газар далай тэнгис болсон ч—энэ хуулиуд оршсоор байгаа. Тэдгээр нь Бурхан оршдог учраас, Түүний захиралт, удирдлагаас болж оршдог. Ийм дэг журамтай, томоохон орчинд хүмүүсийн амьдрал эдгээр хууль, зүй тогтлын дагуу үргэлжилдэг. Эдгээр хуулийн дор хүмүүс үеэс үед өсөн хүмүүжиж, үеэс үед амьд үлдсэн. Энэхүү дэг журамтай амьдрах орчныг болон Бурханы үеэс үед бүтээсэн олон зүйлийг бүгдийг нь хүмүүс эдэлсэн. Хэдийгээр хүмүүст иймэрхүү хуулиуд угаасаа л байдаг зүйл мэт санагдаж, эдгээрийг байх л ёстой зүйл мэт үл тоомсорлож, Бурхан эдгээр хуулийг зохион байгуулж, Бурхан эдгээр хуулийг захирч байгааг мэдэрч чаддаггүй хэдий ч, ямартай ч Бурхан энэ хувиршгүй ажлыг үргэлж хийдэг. Энэхүү хувиршгүй ажил дахь Түүний зорилго нь хүн төрөлхтнийг амьд үлдээхийн төлөө байдаг бөгөөд ингэснээр хүн төрөлхтөн үргэлжлүүлэн амьдарч болох юм.

Бурхан бүх хүн төрөлхтнийг тэжээн тэтгэхийн тулд бүх зүйлд хил хязгаар тогтоодог

Өнөөдөр Би, бүх зүйлд Бурханы авчирсан иймэрхүү хууль бүх хүн төрөлхтнийг хэрхэн тэжээн тэтгэдэг тухай сэдвээр ярих гэж байна. Энэ маш том сэдэв учраас бид үүнийг хэд хэдэн хэсэг болгон хуваагаад нэг нэгээр нь хэлэлцвэл та нарт үүнийг тодорхой дүрслэн харуулж болно. Ингэвэл та нарт үүнийг ухаарахад илүү амархан байх бөгөөд та нар үүнийг аажмаар ойлгож чадна.

Нэгдүгээр хэсэг: Бурхан янз бүрийн нутаг дэвсгэрт хил хязгаар тогтоосон

Тэгэхээр, нэгдүгээр хэсгээс эхэлцгээе. Бурхан бүх зүйлийг бүтээх үедээ уул, тал, цөл, толгод, гол, нууруудад хил хязгаар тогтоосон. Газар дэлхий дээр уул, тал, цөл, толгод болон төрөл бүрийн хэмжээтэй ус бий. Тэдгээр нь өөр өөр төрлийн газарзүйн тогтцыг бий болгодог, тийм биз дээ? Бурхан тэдгээрийн хооронд хил

хязгаар тогтоосон. Хил хязгаар тогтооно гэж хэлээд байгаа маань, уулс өөрийн гэсэн хэлбэр дүрстэй, тал газар өөрийн гэсэн хэлбэр дүрстэй, элсэн цөл тодорхой хил хязгаартай, толгод тогтсон газартай гэсэн үг юм. Мөн гол мөрөн, нуур зэрэг усны ундаргад тогтсон хэмжээ гэж бий. Өөрөөр хэлбэл, Бурхан бүх зүйлийг бүтээхдээ бүх зүйлийг маш тодорхой хуваасан. Аливаа уулын радиус хэдэн километр байх, хамрах хүрээ нь ямар байхыг Бурхан аль хэдийн тодорхойлсон. Тэр бас аливаа тал газрын радиус хэдэн километр байх, хамрах хүрээ нь ямар байхыг тодорхойлсон юм. Бүх зүйлийг бүтээхдээ Тэр элсэн цөлийн хил хязгаар, мөн толгодын хүрээ, эзлэх хувь хэмжээ, тэд юутай хиллэх вэ гэдгийг ч бас тодорхойлсон—энэ бүгдийг Тэр тодорхойлсон юм. Тэр гол мөрөн, нуурыг бүтээхдээ тэдгээрийн цар хүрээг тогтоосон—тэдгээр нь бүгд өөр өөрийн гэсэн хил хязгаартай. Тэгэхээр “хил хязгаар”-ын тухай ярихад үүнийг юу гэж ойлгож байна вэ? Бурхан бүх зүйлд зориулсан хууль тогтоосноор хэрхэн бүх зүйлийг захирдаг тухай бид дөнгөж сая ярилцлаа. Өөрөөр хэлбэл, уулсын цар хүрээ, хил хязгаар нь дэлхийн бөмбөрцгийн эргэлт, эсвэл цаг хугацаа өнгөрч буйгаас шалтгаалан тэлэх юм уу багасна гэж байхгүй. Тэдгээр нь байнгын, өөрчлөгддөггүй бөгөөд өөрчлөгдөшгүй байдлыг нь Бурхан тушаадаг. Харин тал газрын талбай, цар хүрээ нь ямар байх, юутай хиллэдэг вэ гэдгийг Бурхан тогтоосон байдаг. Тэдгээр нь өөрийн гэсэн хил хязгаартай учраас тал газрын дунд нэг овгор шороо санаандгүй гараад ирэхгүй. Тал газар гэнэт уул болж хувирах боломжгүй—ингэх боломжгүй. Бидний дөнгөж сая ярьсан хууль, хил хязгаар гэдэг нь үүнийг хэлж байгаа юм. Элсэн цөлийн тухайд бол бид элсэн цөл юм уу өөр бусад газарзүйн тогтоц, эсвэл газарзүйн байршлын чиг үүргийг энд ярихгүй, харин хил хязгаарыг нь л ярина. Бурханы захиралт дор элсэн цөлийн хил хязгаар ч мөн тэлэхгүй. Учир нь Бурхан үүнд хууль болон хил хязгаарыг нь өгсөн. Талбай хэр том байх, үүрэг нь юу болох, юутай хиллэх, хаана байрлах зэргийг Бурхан аль хэдийн тогтоосон байдаг. Энэ нь хил хязгаараасаа хэтэрч гарахгүй, байрлалаа солихгүй, дур зоргоороо талбайгаа тэлэхгүй. Хэдийгээр гол, нуурууд зэрэг усны урсгал бүгд дэг журамтай, зогсолтгүй урсдаг боловч хэзээ ч цар хүрээнээсээ гарах юм уу хил хязгаарыг давна гэж байхгүй. Бүгд нэг чиглэлд, урсах ёстой чиглэл рүүгээ дэг журамтайгаар урсдаг. Тиймээс Бурханы захиралтын хуулийн дор ямар ч гол, нуур дэлхийн эргэлт, цаг хугацааны урсгалаас шалтгаалан дур зоргоороо хатаж ширгэдэггүй, эсвэл урсгалын чиглэл, хэмжээгээ дур зоргоороо өөрчилдөггүй. Энэ бүгд Бурханы хяналтад байдаг. Өөрөөр хэлбэл, энэ хүн төрөлхтний дунд Бурханы бүтээсэн бүх зүйл өөрсдийн гэсэн тогтсон байршил, талбай, хил хязгаартай байдаг. Бурхан бүх зүйлийг бүтээх үед тэдгээрийн хил хязгаар тогтоогдсон бөгөөд тэдгээрийг дур зоргоороо өөрчилж, шинэчилж, хувиргаж болохгүй гэсэн үг. “Дур зоргоороо” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь, тэдний анхны хэлбэр дэлхийн цаг агаар, температур, эргэлтийн хурднаас шалтгаалан санамсаргүй шилжиж, тэлж, өөрчлөгдөхгүй гэсэн үг. Тухайлбал, уул гэхэд өөрийн гэсэн тодорхой өндөртэй, суурь нь тодорхой

талбайг эзэлж, далайн түвшнээс дээш тодорхой өндөрт, тодорхой хэмжээний ургамалтай байдаг. Энэ бүгдийг Бурхан төлөвлөж, тооцоолсон бөгөөд үүнийг дур зоргоороо өөрчлөхгүй. Тал газрын хувьд гэвэл, хүмүүсийн дийлэнх нь тал газар дээр амьдардаг бөгөөд цаг агаарын ямар ч өөрчлөлт тэдний оршин буй гадаргын талбай, эсвэл оршин тогтнолын үнэ цэнд нөлөөлөхгүй. Бурханы бүтээсэн энэхүү төрөл бүрийн газрын тогтоц болон газарзүйн орчинд агуулагдаж байгаа зүйлс хүртэл дур зоргоороо өөрчлөгдөхгүй. Жишээлбэл, цөлийн найрлага, газар доорх эрдэс баялгийн ордуудын төрөл, цөлд агуулагдаж байгаа элсний хэмжээ, элсний өнгө, зузаан, эдгээр нь дур зоргоороо өөрчлөгдөхгүй. Яагаад дур зоргоороо өөрчлөгдөхгүй вэ? Бурханы захиралт, Түүний удирдлагаас болж байгаа юм. Өөрийн бүтээсэн энэхүү өөр өөр газрын тогтоц, газарзүйн орчин дотор Бурхан, бүх зүйлийг төлөвлөсний дагуу, дэг журамтайгаар удирдаж байдаг. Тиймээс ч энэ бүх газарзүйн орчин Бурханыг бүтээснээс хойш хэдэн мянган жил, хэдэн арван мянган жил оршсоор, өөрсдийн үүргийг гүйцэтгэсээр байгаа. Хэдийгээр галт уулс дэлбэрдэг, газар хөдлөлт болох тодорхой цаг хугацаа байдаг, газар шороонд томоохон шилжилт гардаг ч, Бурхан ямар ч төрлийн газарзүйн тогтцын анхны чиг үүргийг огтоос алдагдуулахгүй. Зөвхөн Бурханы энэхүү удирдлага болон эдгээр хуулийг барьж байгаа Түүний захиралт, хяналтаас болж энэ бүх зүйл—хүн төрөлхтний эдэлж, харж байгаа энэ бүх зүйл газар дээр дэг журамтайгаар амьд оршиж чаддаг. Тэгвэл газар дэлхий дээр оршдог энэ бүх янз бүрийн газарзүйн тогтцыг Бурхан яагаад ийм байдлаар удирддаг юм бэ? Янз бүрийн газарзүйн орчинд амьд оршдог амьд зүйлс бүгд тогтвортой орчинтой байгаасай, тэдгээр нь тухайн тогтвортой орчинд үргэлжлүүлэн амьдарч, өсөн үржих боломжтой байгаасай гэж Тэрээр зорьдог. Энэ бүх зүйл—хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй, хамрын нүхээрээ амьсгалдаг хийгээд амьсгалдаггүй—энэ бүхэн нь хүн төрөлхтний амьд орших ер бусын орчныг бүрдүүлдэг. Зөвхөн ийм төрлийн орчин л хүмүүсийг үеэс үед тэжээн тэтгэж, зөвхөн ийм орчин л хүмүүст үеэс үед амар тайван амьд оршсоор байх боломжийг өгч чаддаг.

Миний дөнгөж сая ярьсан зүйл бол жаахан том сэдэв учраас амьдралаас чинь бага зэрэг хол хөндий санагдаж магадгүй боловч та нар бүгд ойлгож чадна гэж Би итгэж байна. Өөрөөр хэлбэл, бүх зүйлийг захирах Бурханы ноёрхлын хууль бол чухал—үнэхээр маш чухал шүү! Бүх зүйл эдгээр хуулийн дагуу өсөж ургахын урьдчилсан нөхцөл юу вэ? Энэ нь Бурханы захиралтаас болдог. Бурханы захиралтаас болж бүх зүйл Түүний захиралтын хүрээнд өөрсдийн чиг үүргийг гүйцэтгэдэг. Тухайлбал, уулс ой модыг тэжээн тэтгэдэг бол ой мод нь эргээд дотор нь амьдардаг янз бүрийн шувуу, араатан амьтныг тэжээн тэтгэж, хамгаалдаг. Тал газар бол хүмүүс ургац тариалахад, мөн шувууд болон араатан амьтдад зориулан бэлдсэн газар. Тал газар нь хүн төрөлхтний ихэнх хэсгийг тэгш газар дээр амьдрах боломж олгож, хүмүүсийн амьдралд тав тухыг өгдөг. Тал газарт мөн өвст тал, асар их хадлангийн талбай багтана. Өвст тал бол дэлхийн ургамлын бүрхэвч юм.

Тэдгээр нь хөрсийг хамгаалж, өвст талд амьдарч байгаа үхэр, хонь, адууг тэжээдэг. Элсэн цөл ч бас өөрийн гэсэн үүрэгтэй. Энэ бол хүмүүс амьдрахад зориулсан газар биш; үүний үүрэг нь чийгтэй цаг агаарыг хуурай болгох юм. Гол, нуурын урсгал нь хүмүүст ундны усыг эвтэйхэн байдлаар авчирдаг. Урсаж байгаа газар бүрд нь хүмүүс уух устай байж, бүх зүйлийн усны хэрэгцээ таатайяа хангагдана. Энэ бол янз бүрийн газарзүйн тогтцод зориулан Бурханы тогтоосон хил хязгаар юм.

Хоёрдугаар хэсэг: Бурхан бүх амьд зүйлд хил хязгаар тогтоосон

Бурханы тогтоосон эдгээр хил хязгаараас болж төрөл бүрийн газарзүйн тогтоц нь амьдрах өөр өөр орчныг бий болгож, амьдрах эдгээр орчин нь төрөл бүрийн шувуу, араатан амьтанд тав тухтай байх бөгөөд түүнчлэн амьд орших орон зайг өгсөн. Үүнээс үүдэн төрөл бүрийн амьд зүйлийн амьдрах орчны хил хязгаарууд гарч ирсэн. Бидний дараа нь ярих гэж буй хоёр дахь хэсэг энэ юм. Юуны түрүүнд, жигүүртэн шувууд, араатан амьтад, шавж хорхойнууд хаана амьдардаг вэ? Тэд ой мод болон төгөлд амьдардаг уу? Энэ нь тэдний гэр орон. Иймээс, газарзүйн өөр өөр орчинд хил хязгаар тогтоохоос гадна Бурхан бас төрөл бүрийн жигүүртэн шувуу, араатан амьтан, загас жараахай, хорхой шавж болон бүх ургамалд хил хязгаар, хууль тогтоосон. Газарзүйн өөр өөр орчны хоорондын ялгаа, мөн янз бүрийн газарзүйн орчин байдгаас болж өөр өөр төрлийн жигүүртэн шувуу, араатан амьтан, загас жараахай, хорхой шавж болон ургамлын амьдрах орчин нь ялгаатай байдаг. Жигүүртэн шувууд, араатан амьтад, хорхой шавж янз бүрийн ургамлын дунд амьдардаг, загас усанд амьдардаг, ургамал газар дээр ургадаг. Газарт уулс, тал газар, толгод гэх мэт янз бүрийн бүс нутаг багтана. Жигүүртэн шувууд, араатан амьтад өөрийн гэсэн тогтсон гэр оронтой болмогцоо хаа сайгүй хэсэн тэнүүчилж, аль нэг тийшээ явахгүй. Тэдний гэр орон бол ой мод, уулс. Хэрэв нэг өдөр тэдний гэр орон сүйдвэл дэг журам эмх замбараагүй болно. Дэг журам эмх замбараагүй болмогц үр дагавар нь юу байх вэ? Хэн хамгийн түрүүнд хохирох вэ? Тэгэлгүй яах вэ, хүн төрөлхтөн. Бурханы тогтоосон энэ хууль, хил хязгаарын дотор та нар ямар нэгэн жигтэй үзэгдэл олж харсан уу? Жишээлбэл, заан элсэн цөлд алхаж байхыг та нар харж байсан уу? Хэрэв ийм зүйл үнэхээр тохиолдвол маш хачин үзэгдэл байх байлаа. Учир нь заан ой модонд амьдардаг бөгөөд энэ нь Бурханы тэдэнд зориулан бэлтгэсэн амьдрах орчин юм. Тэдэнд өөрсдийн гэсэн амьдрах орчин, өөрсдийн гэсэн тогтсон гэр орон байхад яах гэж хаа хамаагүй хэсүүчлэх билээ? Арслан, эсвэл бар далайн эргээр алхаж явахыг харсан хүн байна уу? Байхгүй, хараагүй. Арслан, барын гэр нь ой шугуй болоод уулс. Далай тэнгисийн халим, аварга загас элсэн цөлд сэлж байхыг харсан хүн байна уу? Байхгүй, хараагүй. Халим, аварга загас далай тэнгисийг гэрээ болгодог. Хүний амьдрах орчинд хүрэн баавгайтай зэрэгцэн амьдардаг хүмүүс байдаг уу? Гэрийнхээ гадна, доторгүй тогос юм уу өөр бусад жигүүртэн шувуугаар байнга хүрээлүүлсэн хүмүүс байдаг уу? Бүргэд, эсвэл зэрлэг галуу сармагчинтай тоглож байхыг харсан хүн байна уу?

(Үгүй.) Эдгээр нь бүгд жигтэй үзэгдэл байх байсан юм. Та нарт сонсоход тун жигтэй сонин үзэгдэл шиг санагдах эдгээр зүйлийг ярьж байгаагийн минь шалтгаан нь Бурханы бүтээсэн бүх зүйл—нэг газар тогтсон байршилтай, эсвэл хамраараа амьсгалж чадах эсэхээс үл хамааран—бүгд өөрсдийн гэсэн амьдралын хуультай гэдгийг та нарт ойлгуулахын төлөө юм. Бурхан эдгээр амьд зүйлийг бүтээхээсээ хамаагүй өмнө тэдэнд зориулсан гэр орон, амьдрах орчныг нь аль хэдийн бэлтгэсэн. Эдгээр амьд зүйл нь өөрсдийн гэсэн тогтсон амьдрах орчин, хоол хүнс, тогтсон гэр орон, амьдрахад тохиромжтой, амьд оршиход нь тохирсон цаг агаар бүхий тогтсон газартай байдаг. Тиймээс тэд хаа хамаагүй хэсүүчлэх юм уу хүн төрөлхтнийг амьд оршиход нь хор хөнөөл учруулж, амьдралд нь нөлөөлөхгүй. Бурхан ингэж бүх зүйлийг удирдан, хүн төрөлхтнийг амьдрах хамгийн сайхан орчноор хангадаг. Бүх зүйлийн дунд орших бүх амьд зүйл өөрсдийн гэсэн амьдрах орчинд амийг тэтгэх хоол хүнстэй байдаг. Тийм хоолтой болохоор тэд амьдрах уугуул орчноосоо салж чадахгүй. Тийм орчинд тэд Бурханы өөрсдөд нь зориулан тогтоосон хуулийн дагуу амьд оршсоор, өсөж үржсээр, урагшилсаар байдаг. Ийм хууль байгаа учраас, Бурхан урьдаас тогтоосон учраас бүх зүйл хүн төрөлхтөнтэй эв зохицолтой амьдардаг бөгөөд хүн төрөлхтөн бүх зүйлтэй харилцан хамааралтайгаар зэрэгцэн оршдог.

Гуравдугаар хэсэг: Бурхан хүн төрөлхтнийг тэтгэх байгаль орчин, экологийг хадгалсан

Бурхан бүх зүйлийг бүтээж, тэдгээрийн хил хязгаарыг тогтоосон; тэдгээрийн дунд Тэрээр бүх төрлийн амьтай зүйлсийг тэжээн тэтгэдэг. Үүний зэрэгцээ Тэр бас хүн төрөлхтөнд зориулан амьдрах өөр өөр арга замыг бэлдсэн, иймээс л хүмүүст амьд орших ганцхан арга зам байдаггүй, мөн амьд орших ганцхан төрлийн орчин байдаггүй гэдгийг чи харж болно. Бид өмнө нь, Бурхан хүмүүст зориулан өөр өөр төрлийн хоол хүнс болон усны эх үүсвэрийг бэлддэг тухай ярьсан, энэ нь хүн төрөлхтний махан биеийн амь үргэлжлэн орших боломжийг олгоход шийдвэрлэх чухал зүйл юм. Гэхдээ, энэ хүн төрөлхтний дундаас бүх хүн үр тариагаар амь зуудаг юм биш. Хүмүүс газарзүйн орчин болон газрын тогтцын ялгаанаас хамааран өөр өөр амьдрах арга барилтай байдаг. Бурхан энэ бүх амьдрах аргыг бэлтгэсэн. Тиймээс бүх хүн газар тариалан голчлон эрхлээд байдаггүй. Өөрөөр хэлбэл, бүх хүн тариа будаа ургуулж хоол хүнсээ авдаггүй. Энэ бол бидний ярих гурав дахь хэсэг: Хил хязгаар нь хүн төрөлхтний амьдралын өөр өөр хэв маягаас улбаалан бий болсон. Тэгвэл хүмүүст өөр ямар төрлийн амьдралын хэв маяг байдаг вэ? Өөр өөр хоол хүнсний эх үүсвэрийн тухайд гэвэл, өөр ямар төрлийн хүмүүс байдаг вэ? Хэд хэдэн үндсэн төрөл бий.

Эхнийх нь ан хийх амьдралын хэв маяг. Хүн бүр үүнийг юу болохыг мэднэ. Ан хийж амьдардаг хүмүүс юу иддэг вэ? (Ангийн мах.) Тэд ойн шувууд, араатан амьтдыг иддэг. “Ангийн мах” гэдэг бол орчин цагийн үг. Анчид үүнийг ангийн мах

гэж боддоггүй; тэд үүнийг хоол хүнс, өдөр тутмын хоол тэжээл гэж боддог. Жишээ нь, тэд буга агналаа. Тухайн бугыг авлаж байгаа нь яг л тариачин хөрс шорооноос хоол хүнсээ авч байгаатай адил байдаг. Тариачин хоол хүнсээ хөрснөөс авдаг бөгөөд энэхүү хүнсээ хараад баяр хөөртэй болж, санаа нь амардаг. Гэр бүл нь идэх тариа будаатай болсон тул өлсөхгүй. Тариачны санаа нь амарч, сэтгэл хангалуун болдог. Анчин ч бас хийсэн ангаа харахдаа санаа амарч, сэтгэл хангалуун болдог, учир нь тэр хоолны талаар санаа зовох шаардлагагүй болдог. Дараагийн хоолондоо идэх юмтай болж, өлсгөлөн явах шаардлагагүй болдог. Энэ бол амин зуулгынхаа төлөө ан хийдэг хүн юм. Ан хийж амь зуудаг хүмүүсийн ихэнх нь уулын ой модонд амьдардаг. Тэд газар тариалан эрхэлдэггүй. Тэнд тариалангийн газар олоход хялбар биш учраас тэд олон төрлийн амьд зүйл, янз бүрийн ангийн олзоор амьдардаг. Энэ бол ердийн хүмүүсийнхээс өөр амьдралын эхний хэв маяг юм.

Хоёр дахь төрөл нь мал маллах амьдралын хэв маяг. Мал маллаж амьдардаг хүмүүс бас газар тариалан эрхэлдэг үү? (Үгүй.) Тэгвэл тэд юу хийдэг вэ? Яаж амьдардаг вэ? (Ихэвчлэн тэд амьдрахын төлөө үхэр, хонь хариулж, өвөл нь малаа нядалж, иддэг. Тэдний үндсэн хоол хүнс үхэр, хонины мах бөгөөд тэд сүүтэй цай уудаг. Малчид хэдийгээр жилийн дөрвөн улиралд завгүй байдаг ч сайн хооллодог. Тэдэнд сүү, сүүн бүтээгдэхүүн, мах элбэг байдаг.) Мал маллаж амьдардаг хүмүүс гол төлөв үхэр, хонины мах идэж, хонь болон үнээний сүү ууж, морь мал унаж, хээр талд малаа хариулан, гадаа гандаж, хөдөө хөхөрч явдаг. Тэд орчин цагийн амьдралын стресстэй нүүр тулдаггүй. Бүхэл өдөржингөө өргөн уудам хөх тэнгэр, ногоон талыг л ширтдэг. Амь зуухын тулд мал маллаж байгаа хүмүүсийн дийлэнх нь өвст талд амьдарч, нүүдэлчин хэв маягаа үеийн үед үргэлжлүүлж чаддаг. Өвст тал дээр амьдрах нь бага зэргийн ганцаардмал байж болох ч бас маш аз жаргалтай амьдрал. Энэ бол амьдралын тийм ч муу хэв маяг биш!

Гурав дахь төрөл нь загасчлах амьдралын хэв маяг. Хүн төрөлхтний цөөн хэсэг нь далай тэнгисийн ойролцоо юм уу жижиг арал дээр амьдардаг. Тэд далай тэнгисийг харж, усаар хүрээлэгдсэн байдаг. Энэ хүмүүс амь зуухын тулд загасчилдаг. Загасчилж амь зуудаг хүмүүсийн хоол хүнсний эх үүсвэр юу вэ? Тэдний хоол хүнсний эх үүсвэрт бүх төрлийн загас, далайн хоол, бусад далайн бүтээгдэхүүн багтана. Загасчилж амь зуудаг хүмүүс газар тариалан эрхэлдэггүй, харин оронд нь өдөр бүрийг загасчилж өнгөрөөдөг. Тэдний гол хоол хүнс нь янз бүрийн загас, далайн бүтээгдэхүүнээс бүрддэг. Тэд хаяа эдгээр зүйлийг будаа, гурил болон өдөр тутмын хэрэгцээт зүйлээр сольж арилжаалдаг. Энэ бол усны дэргэд амьдардаг хүмүүсийн амьдралын өөр нэг хэв маяг юм. Усны ойр амьдардаг хүмүүс хоол хүнсээ усанд түшиглэдэг бөгөөд загасчлах нь тэдний амин зуулга билээ. Загасчлах нь тэдний хоол хүнсний эх үүсвэр төдийгүй, мөн амьжиргааны арга хэрэгсэл юм.

Хүн төрөлхтөн газар тариалан эрхлэхээс гадна дээр дурдсан гурван төрлийн амьдралын хэв маягаар ихэнхдээ амьдардаг. Гэхдээ хүмүүсийн дийлэнх олонх нь

газар тариалан эрхэлж амь зуудаг бол цөөн тооны хүн л мал маллаж, загасчилж, ан агнаж амьдардаг. Тэгвэл газар тариалан эрхэлж амь зуудаг хүмүүст юу хэрэгтэй байдаг вэ? Тэдэнд газар хэрэгтэй. Тэд үеэс үед газарт тариа тарьж амь зуудаг бөгөөд хүнсний ногоо, жимс жимсгэнэ, үр тариа гээд юу ч тарьсан бай, хүнс болон өдөр тутмын хэрэгцээт зүйлсээ газар шорооноос авдаг.

Хүний энэхүү өөр өөр амьдралын хэв маягийн суурь болж буй үндсэн нөхцөлүүд нь юу вэ? Тэдний амьдарч болох орчныг хамгийн анхдагч хэмжээнд нь хадгалах зайлшгүй шаардлагатай бус уу? Өөрөөр хэлбэл, хэрвээ ан хийж амьдардаг хүмүүс уулын ой мод, жигүүртэн шувууд, араатан амьтад үгүй болбол амин зуулгынх нь эх сурвалж байхгүй болно. Тэгээд энэ угсаатан, ийм төрлийн хүмүүсийн явах зүг чиг тодорхойгүй болж, тэд бүр устан үгүй болж ч магад. Тэгвэл мал маллаж амь зуудаг хүмүүсийн тухайд яадаг вэ? Тэд юунд найддаг вэ? Тэд үнэндээ малд биш, харин мал сүргийн амьдарч чадах орчин буюу бэлчээрийн тал газарт түшиглэдэг. Хэрэв бэлчээр байгаагүй бол малчид мал сүргээ хаана бэлчээх байсан бэ? Үхэр, хонь нь юу идэх байсан бэ? Мал байхгүй бол энэхүү нүүдэлчин ард түмэн амин зуулгагүй болно. Амьжиргааны эх үүсвэр үгүй бол энэ хүмүүс хаашаа явах билээ? Тэдэнд үргэлжлүүлэн амьд үлдэнэ гэдэг маш хэцүү болж, ирээдүй нь үгүй болно. Усны эх үүсвэр үгүй болж, гол нуурууд хатаж ширгэвэл, уснаас хамааралтай амьдардаг тэр бүх загас оршин тогтносоор байх уу? Оршин тогтнохгүй. Ус, загасанд найдаж амь зуудаг энэ хүмүүс цаашид амьд орших уу? Тэдэнд хоол хүнс, амьжиргааны эх үүсвэр байхгүй болох үед энэ хүмүүс цаашид амьдрах боломжгүй болно. Өөрөөр хэлбэл, амин зуулга, амьд орших чадварт нь асуудал гарсан даруйд тухайн угсаатан үргэлжлүүлэн оршихоо больж, дэлхийн хөрснөөс арчигдан, мөхөж үгүй болно. Газар тариалан эрхэлж амь зуудаг хүмүүс газраа алдаж, бүх төрлийн ургамал тарьж ургуулж, тэдгээр ургамлаас хоол хүнсээ гаргаж авч чадахгүй бол үр дүн нь ямар байх вэ? Хоол хүнс үгүй бол хүмүүс өлбөрч үхэх бус уу? Хэрвээ хүмүүс өлбөрч үхвэл тухайн үндэстний хүмүүс устах бус уу? Тиймээс л Бурхан төрөл бүрийн орчныг хадгалж үлдэх зорилготой байдаг. Бурхан төрөл бүрийн орчин, эко системийг хадгалж, тэдгээрийн доторх бүх өөр өөр амьд зүйлсийг хадгалж байдаг нь—бүх төрлийн хүмүүсийг тэжээн тэтгэж, газарзүйн өөр өөр орчинд амьдардаг хүмүүсийг тэжээн тэтгэх ганц зорилготой.

Хэрвээ бүтээлийн бүх зүйлийн өөрийн гэсэн зүй тогтол нь алдагдвал цаашид оршин тогтнож чадахаа болино; хэрвээ бүх зүйлийн зүй тогтол алдагдвал бүх зүйлийн дотор орших амьд зүйлс үргэлжлүүлэн оршиж чадахгүй. Хүн төрөлхтөн ч бас амьд оршихын тулд түшиглэн амьдардаг орчноо алдана. Хэрвээ хүн төрөлхтөн энэ бүхнийг алдвал цаашид амьдарч, үеэс үе дамжин өсөн үржиж, хөгжих боломжгүй болно. Хүмүүс өдийг хүртэл амьд оршиж байгаагийн шалтгаан нь Бурхан янз бүрийн арга замаар хүн төрөлхтнийг тэжээн тэтгэхийн тулд бүтээлийн бүх зүйлээр тэднийг хангасаар ирсэнд оршдог. Бурхан хүн төрөлхтнийг янз бүрийн арга замаар тэжээн тэтгэж ирсэн учраас л тэд өдийг хүртэл амьд оршиж, өнөөдрийг

хүртэл амьд үлдсэн юм. Тааламжтай бөгөөд байгалийн хууль нь дэг журамтай ийм тогтсон орчин байгаа болохоор дэлхийн өөр өөр төрлийн бүх хүн, өөр өөр төрлийн бүх үндэстэн тогтсон орон зайдаа амьд оршиж чаддаг. Хэн ч энэ орон зай, эдгээрийн хоорондох хил хязгаараас давж гарч чадахгүй, учир нь Бурхан тэднийг тогтоосон юм. Яагаад Бурхан хил хязгаарыг ийм байдлаар тогтоох болсон бэ? Энэ бол бүх хүн төрөлхтөнд маш чухал—үнэхээр маш чухал! Бурхан амьд зүйл бүрд хязгаар тогтоож, төрөл бүрийн хүний амьдрах арга хэрэгслийг тогтоосон. Тэрээр мөн дэлхий дээрх өөр өөр төрлийн хүн, өөр өөр арьстнуудыг хувааж, тэдгээрийн хязгаарыг тогтоосон. Энэ талаар бид дараагийн ээлжид ярилцах болно.

Дөрөвдүгээр хэсэг: Бурхан өөр өөр арьс өнгөний хүмүүсийн дунд хил хязгаар татсан

Дөрөвт, Бурхан өөр өөр үндэстний хооронд хил хязгаар бий болгосон. Дэлхий дээр цагаан, хар, бор, шар арьстай хүмүүс байдаг. Энэ бол хүний янз бүрийн төрлүүд юм. Бурхан бас энэ өөр өөр төрлийн хүмүүсийн амьдралд цар хүрээ тогтоосон бөгөөд үүнийг мэдэлгүйгээр хүмүүс Бурханы удирдлага дор өөрсдөөө тохирсон амьдрах орчиндоо амьдардаг. Хэн ч үүнийг давж чадахгүй. Жишээлбэл, цагаан арьстай хүмүүсийг аваад үзье. Тэдний ихэнх нь амьдардаг газар зүйн бүс ямар байдаг вэ? Ихэнх нь Европ болон Америкт амьдардаг. Хар арьстай хүмүүсийн голчлон амьдардаг газарзүйн бүс нь Африк тив юм. Бор арьстай хүмүүс голчлон Зүүн Өмнөд Ази болон Өмнөд Азид, Тайланд, Энэтхэг, Мьянмар, Вьетнам, Лаос зэрэг улс оронд амьдардаг. Шар арьстай хүмүүс үндсэндээ Ази тивд буюу Хятад, Япон, Өмнөд Солонгос гэх мэт орнуудад амьдардаг. Бурхан энэ бүх өөр өөр төрлийн үндэстнийг зохих ёсоор хуваан байрлуулж, ингэснээр энэхүү өөр өөр үндэстнүүд дэлхийн янз бүрийн хэсгүүдэд тархан байрласан байдаг. Дэлхийн энэхүү янз бүрийн хэсгүүдэд Бурхан төрөл бүрийн үндэстэн нэг бүрд таарч тохирсон амьдрах орчныг хэзээний бэлтгэсэн. Эдгээр амьдрах орчинд Бурхан тэдэнд зориулан янз бүрийн өнгө, найрлагатай хөрсийг бэлдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, цагаан арьстай хүмүүсийн биеийн найрлага бүтэц хар арьстай хүмүүсийнхтэй адилгүй бөгөөд бусад үндэстний хүмүүсийн биеийн найрлага бүтцээс бас өөр байдаг. Бурхан бүх зүйлийг бүтээх үедээ тухайн үндэстний амьдрах орчныг аль хэдийн бэлтгэсэн байсан. Ингэж хийсэн Түүний зорилго бол тухайн төрлийн хүмүүс өсөж үржин, тоо хэмжээ нь нэмэгдэх үедээ тодорхой бүс нутагтаа суурьшиж чадахын төлөө байсан юм. Бурхан хүн төрөлхтнийг бүтээхээсээ өмнө аль хэдийнээ энэ бүгдийг бодсон—Тэр цагаан арьстай хүмүүст Европ болон Америкийг хадгалж, тэднийг хөгжиж, амьд орших боломжоор хангасан. Тиймээс Бурхан дэлхийг бүтээж байх үедээ аль хэдийн төлөвлөгөөтэй байсан бөгөөд тухайн хэсэг газарт юу тавих, тухайн хэсэг газар дээр юу тэжээж тэтгэх талаар зорилго, зорилттой байсан. Жишээлбэл, тухайн газар нутагт ямар уулс, хэр их тал газар, хэр олон усны ундарга, ямар шувууд, араатан амьтад, ямар загас жараахай, ямар

ургамал байхыг Бурхан хэзээний зэхэж бэлтгэсэн байдаг. Тодорхой нэг төрлийн хүмүүс, үндэстний амьд орших орчныг зэхэж байх үедээ Бурхан олон асуудлыг бүхий л өнцгөөс нь бодолцож үзэх шаардлагатай байсан: газарзүйн орчин, хөрсний найрлага, өөр өөр төрлийн жигүүртэн шувуу, араатан амьтан, өөр өөр төрлийн загас жараахайн хэмжээ, загас жараахайн биеийн бүтэц, усны чанарын ялгаа, түүнчлэн бүх төрлийн ургамал гэх мэт… Бурхан энэ бүгдийг аль эртнээс бэлдсэн. Тийм орчин нь цагаан арьстай хүмүүст зориулан Бурханы бэлтгэж, бүтээсэн амьдрах орчин бөгөөд угаас тэд нарынх юм. Бурхан бүх зүйлийг бүтээх үедээ үүнийг маш их бодож тунгааж, төлөвлөгөөтэй үйлдсэн гэдгийг та нар харав уу? (Тэглээ, Бурхан төрөл бүрийн хүмүүсийн талаар маш анхааралтай бодож тунгаасныг бид харлаа. Өөр өөр төрлийн хүмүүст зориулан Түүний бүтээсэн амьдрах орчны хувьд ямар төрлийн жигүүртэн шувуу, араатан амьтан, загас жараахай, хэчнээн уул, хэр их тал газар байхыг бэлтгэхийг Тэр маш сайн тунгааж, нарийвчлан бодож гаргасан.) Жишээ нь, цагаан арьстай хүмүүсийг аваад үзье. Цагаан арьстай хүмүүс голчлон ямар хоол иддэг вэ? Цагаан арьстай хүмүүсийн иддэг хоол хүнс ази хүмүүсийн иддэг хоол хүнснээс маш өөр байдаг. Цагаан арьстай хүмүүсийн иддэг үндсэн хүнс нь гол төлөв мах, өндөг, сүү, шувууны махнаас бүрддэг. Талх, будаа зэрэг үр тариа нь ерөнхийдөө хоолны хажууд тавьдаг нэмэлт хүнс юм. Ногооны салат идэж байхдаа ч гэсэн тэд хэдэн ширхэг шарсан үхрийн мах юм уу тахианы мах дотор нь хийдэг, улаан буудайн гаралтай хоол хүнс идэж байхдаа ч гэсэн бяслаг, өндөг эсвэл мах нэмэх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, тэдний гол хүнс үндсэндээ улаан буудайн гаралтай хүнс юм уу цагаан будаанаас бүрддэггүй; тэд их хэмжээний мах, бяслаг иддэг. Идэж байгаа хүнс нь маш өндөр илчлэгтэй учраас тэд үргэлж мөстэй ус уудаг. Тиймээс цагаан арьстай хүмүүс маш биерхүү бадируун байдаг. Тэдэнд зориулан Бурханы бэлтгэсэн амьжиргааны эх үүсвэр, амьдрах орчин нь ийм бөгөөд өөр үндэстний хүмүүсийн амьдралын хэв маягаас өөр, ийм амьдралын хэв маягтай байх боломжийг тэдэнд олгодог. Энэхүү амьдралын хэв маягт сайн, муу гэсэн юм байхгүй, үүнийг Бурхан урьдчилан тогтоож, заяасан, энэ нь Бурханы тушаал, зохицуулалтаас гардаг. Энэхүү үндэстэн нь өөрийн үндэс угсаа, Бурханы тэдэнд зориулан бэлтгэсэн амьдрах орчноос болж ийм амьдралын хэв маяг, амьжиргааны эх үүсвэртэй байгаа юм. Та нар, цагаан арьстнуудад зориулан Бурханы бэлтгэсэн амьдрах орчин, тухайн орчноос гардаг өдөр тутмын хангамж тэжээл нь баялаг, элбэг дэлбэг гэж хэлж болно.

Бурхан бусад арьстнуудад бас амьд оршиход шаардлагатай орчныг бэлтгэсэн. Хар арьстай хүмүүс байдаг—хар арьстай хүмүүс хаана байдаг вэ? Тэд голчлон Африкийн төв болон өмнөд хэсгээр байдаг. Бурхан ийм төрлийн орчинд тэдэнд зориулан, амь зуух юу бэлдсэн бэ? Халуун орны ширэнгэн ой, хүмүүстэй зэрэгцэн амьдрах бүх төрлийн жигүүртэн шувуу, араатан амьтан, мөн элсэн цөл, бүх төрлийн ургамал. Тэдэнд усны, амьжиргааны, хоол хүнсний эх үүсвэр бий. Бурхан

тэднийг алагчилж үзээгүй. Тэд юу хийснээс үл хамааран амьд орших нь хэзээ ч асуудал болж байгаагүй. Тэд бас дэлхийн нэг хэсэгт тодорхой байршил, тодорхой газар нутгийг эзэлдэг.

Одоо, шар арьстай хүмүүсийн талаар ярилцъя. Шар арьстай хүмүүс голчлон дэлхийн дорно зүгт байрладаг. Өрнө, дорнын газарзүйн байрлал, орчны хооронд ямар ялгаа байдаг вэ? Дорнодод эх газрын ихэнх хэсэг нь үржил шимтэй, түүхий эд болон ашигт малтмалын нөөцөөр баялаг. Өөрөөр хэлбэл, газрын дээр ч, газрын доор ч бүх төрлийн нөөц баялаг маш элбэг байдаг. Энэ бүлэг хүн, энэ үндэстэнд Бурхан бас таарч тохирсон зохих хөрс шороо, цаг агаар, янз бүрийн газарзүйн орчныг бэлдсэн. Хэдийгээр тэрхүү газарзүйн орчин болон Өрнөдийн орчны хооронд маш том ялгаа байгаа ч Бурхан, хүмүүс амьд оршиход шаардлагатай хоол хүнс, амьжиргаа, эх үүсвэрийг бэлдсэн. Өрнөдөд байгаа цагаан арьстай хүмүүсээс амьдрах орчин нь л ялгаатай. Гэхдээ та нарт хэлэх хэрэгтэй нэг зүйл юу вэ? Дорнын үндэстний хүмүүсийн тоо харьцангуй их учраас Бурхан дэлхийн тухайн хэсэгт Өрнөдөөс ялгаатай маш олон элемент нэмсэн. Тэнд Тэрээр олон төрлийн байгаль, бүх төрлийн элбэг дэлбэг түүхий эд нэмж өгсөн. Тэндхийн байгалийн нөөц маш элбэг дэлбэг; газарзүйн тогтоц нь бас янз бүр, олон төрөл бөгөөд Дорнын үндэстний асар олон тооны хүнийг тэжээхэд хүрэлцээтэй байдаг. Дорныг Өрнөдөөс ялгадаг зүйл нь Дорнодод урдаасаа хойшоо, зүүнээс баруун зүгт цаг уур нь Өрнөдөөс дээр. Дөрвөн улирал нь тодорхой ялгаатай, температур нь тохиромжтой, байгалийн нөөц элбэг дэлбэг, байгалийн үзэмж хийгээд газарзүйн тогтцын төрөл зүйл нь Өрнөдөөс хавьгүй илүү дээр байдаг. Бурхан яагаад ингэсэн бэ? Бурхан цагаан болон шар арьстай хүмүүсийн хооронд маш ухаалаг тэнцвэрийг бий болгосон. Энэ юу гэсэн үг вэ? Цагаан арьст хүмүүсийн хоол хүнс, эдэлж хэрэглэдэг зүйл, таашаахад нь зориулан хангасан зүйлс нь бүх талаараа шар арьстай хүмүүсийн эдэлж чадах зүйлээс хавьгүй илүү байдаг гэсэн үг юм. Гэхдээ Бурхан ямар ч үндэстнийг алагчилж үздэггүй. Бурхан шар арьстай хүмүүст амьдрах илүү үзэсгэлэнтэй, илүү сайхан орчныг өгсөн. Энэ бол тэнцвэр юм.

Бурхан дэлхийн аль хэсэгт ямар төрлийн хүмүүс амьдрах ёстойг урьдчилан тогтоосон; хүмүүс энэ хязгаараас гарч чадах уу? (Үгүй, тэд чадахгүй.) Ямар гайхамшигтай юм бэ! Хэдий өөр өөр эрин үе, онцгой цаг үед дайн, түрэмгийлэл гарсан ч эдгээр дайн, түрэмгийлэл нь үндэстэн бүрд зориулан Бурханы урьдчилан тогтоосон амьдрах орчныг үгүй хийж огт чадахгүй. Өөрөөр хэлбэл, Бурхан дэлхийн тодорхой хэсэгт тодорхой төрлийн хүмүүсийг байлгахаар тогтоосон бөгөөд тэд тухайн хил хязгаараас давж гарч чадахгүй. Хүмүүс Бурханы зөвшөөрөлгүйгээр өөрсдийн нутаг дэвсгэрийг өөрчлөх юм уу тэлэх санаархалтай байсан ч гэсэн үүнийг биелүүлэхэд маш хэцүү байх болно. Үүнийг биелүүлэхэд тэдэнд тун хэцүү байх болно. Жишээ нь, цагаан арьстай хүмүүс газар нутгаа тэлэхийг хүсэж, зарим нэг өөр улс орныг колоничилж байсан. Германчууд зарим улс орныг эзлэн түрэмгийлж, Британи нэгэн цагт Энэтхэгийг эзэлж байсан. Үр дүн нь юу байсан бэ?

Эцсийн эцэст тэд бүтэлгүйтсэн. Бид тэдний бүтэлгүйтлээс юу харж байна вэ? Бурханы урьдчилан тогтоосон зүйлийг эвдэлж сүйтгэхийг зөвшөөрдөггүй. Тиймээс Британийн түрэмгийллээс хэчнээн агуу хүч харагдаж байсан нь хамаагүй эцэстээ тэд ухарч, Энэтхэгийн газар нутгийг орхисон. Тэрхүү газар нутагт амьдардаг хүмүүс британичууд биш, харин энэтхэгчүүд хэвээр үлдсэн, учир нь Бурхан үүнийг зөвшөөрөхгүй. Түүх юм уу улс төр судалдаг зарим хүн энэ талаар таамаг гаргасан байдаг. Тэд Британи улс яагаад бүтэлгүйтсэн шалтгааныг хэлж, зарим үндэстэн эзлэгдэшгүй, эсвэл хүний өөр бусад шалтгаанаас болсон байж болно гэж хэлдэг… Эдгээр нь жинхэнэ шалтгаан биш юм. Жинхэнэ шалтгаан нь Бурханд байгаа юм—Тэр үүнийг зөвшөөрөхгүй! Бурхан тодорхой хэсэг газар дээр нэг угсаатныг амьдруулж, тэнд суурьшуулдаг бөгөөд хэрвээ Бурхан тэдэнд тэр газраас нүүхийг зөвшөөрөхгүй бол тэд хэзээ ч нүүж чадахгүй. Хэрвээ Бурхан тэдэнд зориулж тодорхой газар хуваарилж өгсөн бол тэд тухайн газар дотроо л амьдрах болно. Хүн төрөлхтөн энэхүү тогтсон газраас гарч явж, эсвэл ангижирч чадахгүй. Тэр бол гарцаагүй. Түрэмгийлэгчийн хүч хэр агуу байх, эсвэл түрэмгийлэлд өртөж байгаа хүмүүс хэр сул дорой байх нь хамаагүй эцсийн дүнд эзлэн түрэмгийлэгчдийн амжилтыг Бурхан шийддэг. Тэр үүнийг аль хэдийн урьдчилан тогтоосон бөгөөд хэн ч үүнийг өөрчилж чадахгүй.

Бурхан дээрх байдлаар янз бүрийн арьстнуудыг тараан байршуулсан. Арьстнуудыг тараан байршуулахын тулд Бурхан ямар ажил хийсэн бэ? Эхлээд Тэр томоохон хэмжээний газарзүйн орчныг бэлтгэж, хүмүүсийг өөр өөр байршилд хуваарилж, тэгээд тэд үеэс үед тэрхүү газартаа амьдардаг. Ингэж л тогтсон—тэдний амьдрах тодорхой газар нутгийг тогтоосон. Тэдний амьдрал, юу идэх, юу уух, тэдний амин зуулга—энэ бүгдийг Бурхан хэзээний тогтоочихсон. Бурхан бүх зүйлийг бүтээж байх үедээ өөр өөр төрлийн хүмүүст зориулан өөр өөр бэлтгэл хийсэн: Янз бүрийн хөрсний бүтэц, өөр өөр цаг уур, өөр өөр ургамал, янз бүрийн газарзүйн орчин байдаг. Өөр өөр газруудад өөр өөр жигүүртэн шувууд, араатан амьтад, өөр өөр усанд тухайн усных нь онцгой төрлийн загас, далайн бүтээгдэхүүн байдаг. Шавж хорхойн төрлийг хүртэл Бурхан тодорхойлдог. Тухайлбал, Америк тивд ургадаг зүйлс бүгд маш том, маш өндөр, маш бадируун байдаг. Уулан дахь ой шугуйн моддын үндэс бүгд тийм гүн биш атлаа маш өндөр ургадаг. Бүр зуун метр буюу түүнээс өндөр ургадаг байхад Азийн ой шугуйд байгаа модод ихэвчлэн тийм ч өндөр байдаггүй. Жишээ нь, зуун наст ургамлыг аваад үзье. Японы зуун настууд маш нарийн, нимгэн байдаг бол АНУ дахь зуун наст ургамал маш том. Энд ялгаа нь байна. Ижил нэртэй, ижил төрлийн ургамал боловч Америк тивийнх онцгой том болж ургадаг. Эдгээр янз бүрийн талуудын ялгааг хүмүүс олж харахгүй, мэдрэхгүй байж магад боловч Бурхан бүх зүйлийг бүтээх үедээ тэдгээрийг тодорхойлж, өөр өөр үндэстэнд зориулан өөр өөр газарзүйн орчин, өөр өөр газарзүйн тогтоц, өөр өөр амьд зүйлс бэлдсэн. Учир нь Бурхан өөр өөр төрлийн хүмүүсийг бүтээсэн бөгөөд хэнд нь юу хэрэгтэйг, мөн амьдралын хэв маяг нь ямар байхыг мэддэг.

Бүхнийг захирч, бүгдийг хангадаг Бурхан бол бүх зүйлийн Бурхан юм

Эдгээр зүйлийн заримыг нь ярьсны дараа дөнгөж сая бидний ярилцсан гол сэдвийн талаар одоо та нар зарим нэг зүйл мэдэж авсан юм шиг санагдаж байна уу? Үүнийг ойлгож эхэлж байгаа юм шиг санагдаж байна уу? Илүү өргөн сэдэв доторх энэ талуудын талаар Би яагаад ярихаар сонгосон талаар та нар бүдүүн тоймын ойлголт авсан байх гэж Би итгэж байна. Тийм үү? Та нар үүнээс хэр ихийг ойлгосноо багахан ярьж болох юм. (Хүн төрөлхтөн бүхэлдээ бүх зүйлд зориулж Бурханы тогтоосон хуулиар тэжээн тэтгэгддэг. Бурхан эдгээр хуулийг тодорхойлж байхдаа өөр өөр үндэстнийг өөр өөр орчин, өөр өөр амьдралын хэв маяг, өөр өөр хоол хүнс, өөр өөр цаг уур, температураар хангасан. Ингэснээр бүх хүн төрөлхтөн газар дэлхий дээр сууршиж, амьд оршиж чадах юм. Хүнийг амьд үлдээх Бурханы төлөвлөгөө маш нарийн нямбай болохыг би үүнээс харж чаддаг, мөн Түүний мэргэн ухаан, төгс байдал, хүмүүс биднийг гэх Түүний хайрыг харж чаддаг.) (Бурханы тодорхойлсон хууль, цар хүрээг ямар ч хүн, үйл явдал, зүйл өөрчилж чадахгүй. Энэ бүхэн Түүний захиралт дор байдаг.) Бүх зүйлийн өсөлтөд зориулан Бурханы тодорхойлсон хуулийн өнцгөөс харвал бүх хүн төрөлхтнийг, бүх төрлөөр нь Бурхан хангаж, тэжээн тэтгэдэг бус уу? Хэрвээ эдгээр хууль сүйдэх юм уу Бурхан хүн төрөлхтөнд зориулж ийм хууль тогтоогоогүй бол хүн төрөлхтний хэтийн ирээдүй ямар байх байсан бэ? Хүмүүс амьд орших үндсэн орчноо алдсаны дараа хоол хүнсний эх үүсвэртэй байх байсан уу? Хоол хүнсний эх үүсвэр асуудал болох магадлалтай. Хэрвээ хүмүүс хоол хүнсний эх үүсвэрээ алдсан бол, өөрөөр хэлбэл, тэд ямар ч идэх зүйл олж авч чадахгүй бол хэд хоног тэсэж чадах вэ? Магадгүй, тэд ганц ч сар тэсэж чадахгүй бөгөөд тэдний амьд орших эсэх нь асуудал болно. Тиймээс хүмүүсийг амьд үлдээхийн төлөө, тэдний оршин тогтнох, өсөж үржих, амин зуулгыг үргэлжлүүлэхийн төлөө Бурханы хийдэг юм бүхэн маш чухал. Өөрийнх нь бүтээсэн зүйлийн дундаас Бурханы хийдэг юм бүхэн хүмүүсийн амьд оршихтой нарийн холбоотой, салшгүй байдаг. Хэрвээ хүн төрөлхтний амьд орших эсэх нь асуудалтай болбол Бурханы удирдлага цаашид үргэлжилж чадах уу? Бурханы удирдлага оршин тогтносоор байх уу? Бурханы удирдлага Өөрийнх нь тэжээн тэтгэдэг бүх хүн төрөлхтний амьд оршихтой зэрэгцэн оршдог, иймээс Бурхан Өөрийн бүтээсэн бүх зүйлд юу бэлддэг, хүмүүсийн төлөө юу хийдэг байх нь хамаагүй энэ бүгд Түүний хувьд зайлшгүй шаардлагатай, хүн төрөлхтний амьд оршиход шийдвэрлэх чухал зүйл юм. Хэрвээ бүх зүйлд зориулан Бурханы тогтоосон эдгээр хууль устаж, нурж, саатвал бүх зүйл оршин тогтнож чадахаа больж, хүн төрөлхтний амьдрах орчин ч тэр, тэдний өдөр тутмын амин зуулга, мөн тэд өөрсдөө ч тэр цаашид оршиж чадахгүй. Энэ шалтгааны улмаас хүн төрөлхтний авралын талаарх Бурханы удирдлага ч мөн оршихоо болино.

Бидний ярьсан бүх зүйл, нэг бүр нь, зүйл бүр нь хүн бүрийн амьд оршихтой нарийн холбогдсон байдаг. “Таны ярьж байгаа зүйл хэтэрхий том байна, бидний

харж чадах зүйл энэ биш” гэж та нар хэлж магадгүй, мөн “Таны ярьж байгаа зүйл надад ямар ч хамаагүй” гэж хэлэх хүмүүс ч байж магадгүй. Гэхдээ чи бүх зүйлийн ердөө л нэг хэсэг болон амьдарч байгаа гэдгээ бүү март; чи бол Бурханы захиралт дор байгаа бүх бүтээгдсэн зүйлийн дундах нэгэн зүйл. Бурханы бүтээсэн зүйлсийг Түүний захиралтаас салгаж болохгүй, нэг ч хүн өөрийгөө Түүний захиралтаас салгаж чадахгүй. Түүний захиралтыг, Түүний хангалтыг алдана гэдэг нь хүмүүсийн амь, хүмүүсийн махан биеийн амь алга болно гэсэн үг. Энэ бол Бурхан хүн төрөлхтний амьдрах орчныг бий болгосны ач холбогдол. Чи ямар үндэстэнд хамаардаг, ямар газар дээр амьдардаг, Өрнөдөд байна уу, Дорнодод байна уу хамаагүй—хүн төрөлхтөнд зориулан Бурханы тогтоосон амьдрах орчноос өөрийгөө тусгаарлаж чадахгүй бөгөөд хүмүүст зориулан Бурханы тогтоосон амьдрах орчин тэжээн тэтгэж, хангахаас өөрийгөө салгаж чадахгүй. Амин зуулга чинь юу болох, амьдрахын тулд юунд найддаг, махан биеийн амиа тэтгэхийн тулд юунд найддаг чинь хамаагүй, чи Бурханы захиралт болон Түүний удирдлагаас өөрийгөө салгаж чадахгүй. Зарим хүн: “Би тариачин биш, би амин зуулгынхаа төлөө тариа буудай тариалдаггүй. Миний хоол хүнс тэнгэрээс хамааралгүй учраас би Бурханы тогтоосон амьдрах орчинд амьдарч байгаа биш. Иймэрхүү орчин надад юу ч өгөөгүй” гэж хэлдэг. Энэ зөв үү? Чи тариа буудай тариалж амь зуудаггүй гэлээ, үр тариа иддэггүй юү? Чи мах, өндөг иддэггүй гэж үү? Хүнсний ногоо, жимс иддэггүй гэж үү? Чиний иддэг бүхэн, чамд хэрэгтэй энэ бүх зүйл нь хүн төрөлхтөнд зориулан Бурханы бий болгосон амьдрах орчноос салшгүй юм. Хүн төрөлхтөнд шаардлагатай бүх зүйлийн эх үүсвэрийг бүхэлдээ амьдрах орчныг чинь бүрдүүлдэг Бурханы бүтээсэн бүх зүйлээс салгах боломжгүй. Ууж байгаа ус, өмсөж байгаа хувцас, хэрэглэж байгаа бүх зүйл—эдгээрээс алийг нь Бурханы бүтээсэн зүйлийн дундаас авдаггүй вэ? Зарим хүн: “Бурханы бүтээсэн зүйлээс гаргаж аваагүй зарим нэг юм бий. Хуванцар л гэхэд тийм зүйлийн нэг. Энэ бол химийн гаралтай, хүний хийсэн зүйл” гэж хэлдэг. Энэ зөв үү? Хуванцрыг үнэхээр хүн хийсэн, химийн гаралтай зүйл, гэхдээ хуванцрын анхдагч бүрэлдэхүүн хэсгүүд хаанаас гаралтай вэ? Анхдагч бүрэлдэхүүн хэсгүүдийг Бурханы бүтээсэн материалаас гаргаж авсан. Эдэлж байгаа, харж байгаа зүйлсийг чинь, ашиглаж байгаа юм бүхнийг чинь бүгдийг нь Бурханы бүтээсэн зүйлээс гаргаж авсан. Өөрөөр хэлбэл, ямар үндэстэн байх, ямар амин зуулгатай байх, эсвэл ямар төрлийн амьдрах орчинд амьдардаг болох нь хамаагүй хүмүүс өөрсдийгөө Бурханы хангалтаас салгаж чадахгүй. Тэгэхээр, бидний өнөөдрийн ярьсан зүйл “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэсэн сэдэвтэй маань холбоотой юу? Бидний өнөөдрийн ярилцсан зүйлс энэхүү томоохон сэдэвт хамаарч байна уу? (Тийм ээ.) Магадгүй Миний өнөөдөр ярьсан зүйлийн зарим нь жаахан хийсвэр, ярилцахад жаахан хэцүү байж магадгүй. Гэхдээ та нар одоо энэ талаар арай дээр ойлголттой болсон байх гэж Би бодож байна.

Сүүлийн хэдэн удаагийн нөхөрлөл дээр бидний нөхөрлөсөн сэдвүүд арай өргөн хүрээтэй, өргөн цар хүрээг хамарсан байсан учраас энэ бүгдийг ойлгож авахад та

нарт бага зэрэг хүчин чармайлт шаарддаг. Учир нь энэ сэдвүүд бол Бурханд итгэх итгэлдээ хүмүүс өмнө нь хэзээ ч хөндөж байгаагүй зүйлс юм. Зарим хүн эдгээрийг учир битүүлэг зүйл гэж сонсдог, зарим нь үүнийг түүх гэж сонсдог—аль өнцөг нь зөв бэ? Та нар энэ бүгдийг ямар өнцгөөс сонсдог вэ? (Бурхан Өөрийн бүтээсэн бүх зүйлийг хэрхэн системтэйгээр зохицуулсан болохыг, бүх зүйл хуультай гэдгийг бид харсан бөгөөд эдгээр үгээр дамжуулан бид хүн төрөлхтнийг аврах Бурханы үйлс болон Түүний нягт нямбай зохицуулалтыг илүү ойлгож чаддаг.) Эдгээр нөхөрлөлөөр дамжуулан та нар бүх зүйлийг удирдах Бурханы удирдлагын цар хүрээ хэр хол хүрдгийг харсан уу? (Бүх хүн төрөлхтөн, бүх зүйлд хүрдэг.) Бурхан зөвхөн нэг үндэстний Бурхан уу? Тэр нэг төрлийн хүмүүсийн Бурхан уу? Тэр хүн төрөлхтний цөөнхийн Бурхан уу? (Үгүй ээ, тийм биш.) Тийм биш юм бол, Бурханы тухай та нарын мэдлэгээр бол, хэрвээ Тэр зөвхөн хүн төрөлхтний цөөнхийн Бурхан, эсвэл Тэр зөвхөн та нарын Бурхан бол энэ өнцөг зөв үү? Бурхан бүх зүйлийг удирдаж, захирдаг учраас бүх зүйлийг захирах захиралтаар нь илчлэгддэг Түүний үйлс, мэргэн ухаан, төгс хүчийг хүмүүс харах ёстой. Энэ бол хүмүүсийн мэдэх ёстой зүйл. Хэрвээ чи, Бурхан бүх зүйлийг удирддаг, бүх зүйлийг захирдаг, бүх хүн төрөлхтнийг захирдаг гэж хэлдэг боловч хүн төрөлхтнийг захирах Түүний захиралтын талаар ямар ч ойлголт, мэдлэг ухаан байхгүй бол Тэр бүх зүйлийг захирдаг гэдгийг үнэхээр чи хүлээн зөвшөөрч чадна гэж үү? Зүрх сэтгэлдээ чи, “Би чадна, яагаад гэвэл миний амьдралыг Бурхан бүхэлд нь захирч байгааг би хардаг” гэж бодож магадгүй. Гэхдээ Бурхан үнэхээр тийм өчүүхэн гэж үү? Үгүй, тийм биш! Чи зөвхөн чиний төлөөх Бурханы аврал, чиний доторх Түүний ажлыг л хардаг бөгөөд зөвхөн эдгээр зүйлээс л Түүний захиралтыг хардаг. Энэ бол хэтэрхий өчүүхэн цар хүрээ бөгөөд Бурханы тухай жинхэнэ ойлголтын хэтийн төлөвт чинь хортойгоор нөлөөлдөг. Хэрвээ чи, Бурханы чамайг хангаж байгаа зүйлийн цар хүрээ, чамайг гэсэн авралаар Бурханы тухай мэдлэгээ хязгаарлавал Тэр юм бүхнийг, бүх зүйлийг, бүх хүн төрөлхтнийг захирдаг гэдгийг хэзээ ч танин мэдэж чадахгүй. Энэ бүгдийг танин мэдэж чадахгүй бол Бурхан хувь заяаг чинь захирдаг гэдгийг чи үнэхээр танин мэдэж чадна гэж үү? Үгүй ээ, чи чадахгүй. Зүрх сэтгэлдээ чи тэр талыг хэзээ ч танин мэдэж чадахгүй—чи хэзээ ч тийм өндөр түвшний ойлголтод хүрч чадахгүй. Чи Миний юу хэлээд байгааг ойлгож байгаа биз дээ? Үнэндээ, та нар эдгээр сэдвийг, Миний ярьж байгаа агуулгыг ямар түвшинд ойлгож чадах вэ гэдгийг Би мэднэ, гэсэн атлаа Би яагаад энэ талаар ярьсаар байна вэ? Учир нь эдгээр сэдэв бол Бурханыг дагагч хүн нэг бүр, Бурханы авралд багтахыг хүсэж буй хүн нэг бүрийн таашаах ёстой зүйл—энэ сэдвүүдийг ойлгох нь нэн чухал. Хэдий энэ мөчид чи эдгээрийг ойлгохгүй байгаа ч нэг л өдөр чиний амь болон үнэний талаарх туршлага чинь тодорхой түвшинд хүрч, амь зан чанарын өөрчлөлт чинь тодорхой түвшинд хүрч, тодорхой хэмжээний биеийн хэмжээнд хүрэх үед, тэр цагт л та нартай нөхөрлөлөөр ярилцаж байгаа эдгээр сэдэв Бурханы тухай мэдлэгийн эрэл хайгуулыг чинь үнэхээр биелүүлж, хангах болно. Иймээс эдгээр үг

нь Бурхан бүх зүйлийг захирдаг хэмээх та нарын ирээдүйн ойлголт болон Бурханы Өөрийнх нь тухай ойлголтод чинь зориулан та нарыг бэлтгэж, суурь тавихын төлөө юм.

Хүмүүсийн зүрх сэтгэлд Бурханы тухай ойлголт хэчнээн их байна, зүрх сэтгэлд нь Түүний эзлэх байр суурь мөн төдий чинээ байна. Тэдний зүрх сэтгэл дэх Бурханы тухай мэдлэгийн хэмжээ хэдий чинээ их байна, тэдний зүрх сэтгэлд Бурхан төдий чинээ агуу байдаг. Хэрвээ чиний мэддэг Бурхан хоосон, тодорхойгүй байгаа бол чиний итгэдэг Бурхан мөн л хоосон агаад тодорхойгүй байна. Чиний мэддэг Бурхан чиний өөрийн амийн цар хүрээнд хязгаарлагддаг бөгөөд жинхэнэ Бурхантай Өөртэй нь ямар ч хамаагүй. Тиймээс Бурханы бодит үйлдлийг, Бурханы бодит байдал болон Түүний төгс хүчийг, Бурханы Өөрийн жинхэнэ ялгамж чанарыг, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг, Өөрийн бүтээсэн бүх зүйлийн дунд Түүний харуулсан үйлдлийг мэдэх—эдгээр нь Бурханы талаарх мэдлэгийг эрэлхийлж буй хүн нэг бүрд маш чухал юм. Эдгээр нь хүмүүс үнэн-бодит байдалд орж чадах эсэхэд шууд нөлөөлдөг. Хэрвээ чи Бурханы тухай ойлголтоо ердөө үгээр хязгаарлавал, өөрийн өчүүхэн туршлагаар, Бурханы нигүүлсэл гэж ойлгодог зүйлээр, Бурханд хийх өчүүхэн гэрчлэлээрээ хязгаарладаг бол чиний итгэдэг Бурхан яавч жинхэнэ Бурхан Өөрөө биш гэж Би хэлнэ. Түүгээр ч барахгүй, чиний итгэдэг Бурхан бол жинхэнэ Бурхан биш, харин төсөөллийн Бурхан гэж хэлж бас болно. Яагаад гэвэл, жинхэнэ Бурхан бол бүх зүйлийг захирдаг, бүх зүйлийн дунд алхдаг, бүх зүйлийг удирддаг Нэгэн юм. Тэр бол бүх хүн төрөлхтний, гартаа байгаа бүх зүйлийн хувь заяаг атгадаг Нэгэн билээ. Миний ярьж байгаа Бурханы ажил хийгээд үйлдэл нь цөөн тооны хүнээр хязгаарлагддаггүй. Өөрөөр хэлбэл, Түүнийг одоо дагаж байгаа хүмүүсээр хязгаарлагддаггүй. Түүний үйлс, бүх зүйлийн дунд, бүх зүйлийн оршин тогтнол, бүх зүйлийн өөрчлөлтийн хуулиас илэрдэг. Хэрвээ чи Бурханы аливаа үйлсийг Түүний бүтээсэн бүх зүйлийн дундаас харж, таньж чаддаггүй бол Түүний ямар ч үйлсийг гэрчилж чадахгүй. Хэрвээ чи Бурханд гэрчлэл хийж чадахгүй бол, хэрвээ чи өөрийн мэддэг тэр өчүүхэн “Бурхан” гэгч, үзэл санаанд чинь хязгаарлагдаж, оюун санааны чинь явцуу хязгаар дотор оршдог Бурханы талаар ярьсаар байгаа бол, хэрвээ чи тийм Бурханы талаар ярьсаар байгаа бол Бурхан итгэлийг чинь хэзээ ч сайшаахгүй. Чи Бурханд гэрчлэл хийх үедээ зөвхөн Бурханы нигүүлслийг хэрхэн эдэлдэг, Бурханы сахилгажуулалт болон цээрлүүлэлтийг хэрхэн хүлээн авдаг, Түүнийг гэрчлэхдээ Түүний ерөөлийг хэрхэн эдэлдэг тухайгаа гэрчлэх аваас энэ нь маш хангалтгүй бөгөөд Түүнийг огтоос сэтгэл хангалуун болгохгүй. Хэрвээ чи Бурханы хүсэлд нийцсэн байдлаар Түүнд гэрчлэл хийхийг, жинхэнэ Бурханыг Өөрийг нь гэрчлэхийг хүсэж байгаа бол Бурханы үйлдлээс Тэр юу болох, Түүнд юу байгааг харах ёстой. Бүх зүйлийг хянах Бурханы хяналтаас чи Түүний эрх мэдлийг харж, Тэр бүх хүн төрөлхтнийг хэрхэн хангадаг тухай бодит үнэнийг харах ёстой. Хэрвээ чи зөвхөн өдөр тутмын хоол, унд, амьдралын шаардлагатай зүйлс чинь Бурханаас ирдэг гэдгийг л хүлээн

зөвшөөрч байгаа боловч Бурхан Өөрийн бүтээсэн бүх зүйлээр бүх хүн төрөлхтнийг хангадаг, мөн бүх зүйлийг захирснаараа Тэр бүх хүн төрөлхтнийг залж чиглүүлдэг гэсэн бодит үнэнийг харж чаддаггүй бол чи хэзээ ч Бурханд гэрчлэл хийж чадахгүй. Би энэ бүгдийг хэлж байгаа нь ямар зорилготой вэ? Та нар үүнд хөнгөн хуумгай бүү хандаасай, Миний ярьсан эдгээр сэдэв та нарын амийн оролттой хамаагүй гэж бүү бодоосой, эдгээр сэдвийг зүгээр нэг төрлийн мэдлэг, сургаал гэж бүү хүлээн аваасай гэсэндээ тэр юм. Хэрвээ та нар Миний хэлж байгааг тийм хандлагаар сонсох аваас ганц ч зүйл олж авахгүй. Та нар Бурханыг мэдэх энэхүү агуу боломжийг алдах болно.

Энэ бүхнийг ярьж байгаа Миний зорилго юу вэ? Миний зорилго бол хүмүүст Бурханыг мэдүүлж, Бурханы бодит үйлсийг ойлгуулах явдал юм. Бурханыг ойлгодог, Түүний үйлсийг мэддэг болмогц, тэр үед л чи Түүнийг мэдэх боломж, бололцоотой болно. Тухайлбал, хэрвээ чи нэг хүнийг ойлгохыг хүсвэл хэрхэн ойлгож авах вэ? Тэдний гадаад төрхийг харснаар уу? Юу өмсөж, хэрхэн хувцасласныг нь харснаар уу? Яаж алхаж байгааг нь харснаар уу? Тэдний мэдлэгийн цар хүрээг харснаар уу? (Үгүй.) Тэгвэл хүнийг хэрхэн ойлгодог вэ? Чи тухайн хүний яриа, зан авир, бодол санаа, өөрийнхөө талаар илэрхийлж, илчилж байгаа зүйл дээр нь үндэслэж шүүдэг. Ингэж чи тэр хүнийг мэдэж, ойлгодог. Үүний адилаар, хэрвээ Бурханыг мэдэхийг хүсвэл, Түүний бодитой тал, Түүний жинхэнэ талыг ойлгохыг хүсвэл та нар Түүний үйлдэл, хийдэг бодитой зүйл бүрээр нь дамжуулан Түүнийг мэдэх ёстой. Энэ бол хамгийн шилдэг, мөн цорын ганц арга.

Хүн төрөлхтөнд амьдрах тогтвортой орчныг өгөхийн тулд Бурхан бүх зүйлийн хоорондох харилцааг тэнцвэржүүлдэг

Бурхан Өөрийн үйлсийг бүх зүйлийн дунд харуулдаг бөгөөд Тэр бүх зүйлийн дундаас бүх зүйлийн хуулийг захирч, хянадаг. Бурхан бүх зүйлийн хуулийг хэрхэн захирдаг, мөн түүнчлэн тэдгээр хуулийн дор бүх хүн төрөлхтнийг хэрхэн тэтгэж, хангадаг тухай бид дөнгөж сая ярьсан. Энэ бол нэг тал нь. Одоо бид өөр нэг талын тухай ярих гэж байгаа ба энэ бол Бурхан бүх зүйлийг хянахдаа хэрэглэдэг нэг арга юм. Бурхан бүх зүйлийг бүтээснийхээ дараа тэдгээрийн хоорондох харилцааг хэрхэн тэнцвэржүүлсэн талаар Би ярьж байна. Энэ бол та нарын хувьд бас нэлээд том сэдэв. Бүх зүйлийн хоорондох харилцааг тэнцвэржүүлэх—энэ нь хүмүүсийн хийж чадах зүйл мөн үү? Үгүй, хүмүүст тийм чадвар байхгүй. Хүмүүс зөвхөн сүйтгэж л чаддаг. Тэд бүх зүйлийн хоорондох харилцааг тэнцвэржүүлж чадахгүй; тэд тэдгээрийг удирдаж чадахгүй, тийм агуу эрх мэдэл, хүч чадлыг хүн төрөлхтөн авч чадахгүй. Зөвхөн Бурхан Өөрөө ийм зүйл хийх хүч чадалтай. Гэхдээ ийм зүйл хийх Бурханы зорилго нь юу вэ—юуны төлөө байдаг вэ? Энэ ч бас хүн төрөлхтний амьд оршихтой нарийн холбоотой. Бурханы хийхийг хүсдэг юм бүхэн зайлшгүй шаардлагатай—Түүний хийж магадгүй, эсвэл хийхгүй байж магадгүй зүйл гэж үгүй. Хүн төрөлхтний оршин тогтнолыг хамгаалж, хүмүүст амьдрах таатай орчныг өгөхийн тулд Түүний зайлшгүй хийх ёстой, нэн чухал зүйлс байдаг.

“Бурхан бүх зүйлийг тэнцвэржүүлдэг” гэсэн хэллэгийн үгчилсэн утгаас харвал энэ нь маш далайцтай сэдэв юм шиг байна. Нэгдүгээрт энэ нь, “бүх зүйлийг тэнцвэржүүлэх” гэдэг нь бүх зүйлийг Бурхан ноёрхдог гэдгийг мөн хэлж байгаа гэсэн ухагдахууныг хүмүүст өгдөг. “Тэнцвэр” гэдэг үг нь ямар утгатай вэ? Нэгдүгээрт, “тэнцвэр” гэдэг нь аливаа зүйлийг тэнцвэргүй болгохгүй байхыг хэлдэг. Аливааг жинлэхдээ жин хэрэглэдэгтэй адилхан. Жинг тэнцүүлэхийн тулд хоёр талынх нь жин ижил байх ёстой. Бурхан олон өөр төрлийн зүйлийг бүтээсэн: байрнаасаа хөдөлдөггүй зүйлс, хөдөлдөг зүйлс, амьд зүйлс, амьсгалдаг хийгээд амьсгалдаггүй зүйлс. Энэ бүх зүйл хоорондоо харилцан хамааралтай, харилцан холбоотой болж, аль аль нь бие биеэ бэхжүүлж, хянадаг байх нь амархан уу? Энэ бүгдийн дотор зарчим байгаа нь дамжиггүй боловч маш ээдрээтэй байдаг, үгүй гэж үү? Бурханд энэ нь хэцүү биш боловч хүмүүсийн хувьд судалж шинжлэхэд маш ээдрээтэй асуудал юм. “Тэнцвэр” гэдэг маш энгийн үг. Гэвч, хэрвээ хүмүүс үүнийг судлах аваас, хэрвээ хүмүүс өөрсдөө тэнцвэр бий болгох шаардлагатай болбол, биологич, одон орон судлаач, физикч, химич, бүр түүхч гээд бүх төрлийн эрдэмтэн үүн дээр ажилласан ч гэсэн энэхүү судалгааны эцсийн үр дүн нь ямар байх вэ? Үүнээс ямар ч үр дүн гарахгүй. Учир нь, Бурхан бүх зүйлийг хэтэрхий гайхамшигтай бүтээсэн бөгөөд хүн төрөлхтөн хэзээ ч үүний нууцыг тайлж чадахгүй. Бурхан бүх зүйлийг бүтээхдээ тэдгээрийн хоорондох зарчмыг тогтоож, харилцан хязгаарлаж, нэг нэгнийгээ нөхөж, харилцан тэтгэн амьд орших өөр өөр арга замыг тогтоосон. Төрөл бүрийн эдгээр арга барил маш ээдрээтэй, тэдгээр нь энгийн эсвэл нэг чиглэлийн гарцаагүй биш юм. Бурхан бүх зүйлийг хянаж байгаагийн цаад зарчмыг судалж, батлахын тулд хүмүүс өөрсдийн оюун санаа, олж авсан мэдлэг, ажигласан үзэгдлийг ашиглах үед эдгээр зүйлийг олж илрүүлэх туйлын хэцүү, ямар нэгэн үр дүнд хүрэхэд ч туйлын хэцүү. Хүмүүсийн хувьд үр дүнд хүрнэ гэдэг маш хэцүү; Бурханы бүтээсэн бүх зүйлийг захирахын тулд хүний сэтгэлгээ, мэдлэгт найдаж байгаа үед тэнцвэрийг нь хадгална гэдэг хүмүүст маш хэцүү. Яагаад гэвэл, хэрвээ хүмүүс бүх зүйлийн амьдрах зарчмыг мэддэггүй бол ийм тэнцвэрийг хэрхэн хамгаалахыг мэдэхгүй. Тиймээс хэрвээ хүмүүс бүх зүйлийг удирдаж, захирдаг байсан бол энэ тэнцвэрийг алдагдуулах маш өндөр магадлалтай. Тэнцвэр алдагдмагц хүн төрөлхтний амьд орших орчин сүйрч, тийм зүйл болоход үүнийг дагаад хүн төрөлхтөн амьд үлдэх эсэх түгшүүртэй болно. Энэ нь гай гамшгийг авчирна. Хүн төрөлхтөн гамшиг дунд амьдарвал ирээдүй нь юу болох вэ? Үр дүнг нь дүгнэж цэгнэхэд маш хэцүү, итгэлтэйгээр таамаглах боломжгүй юм.

Тэгвэл, бүх зүйлийн хоорондох харилцааг Бурхан хэрхэн тэнцвэржүүлдэг вэ? Нэгдүгээрт, дэлхий дээр жилийн турш мөс, цасаар хучигдсан газрууд байдаг байхад зарим газарт дөрвөн улирлын турш хавар шиг байж, хэзээ ч өвөл болдоггүй бөгөөд иймэрхүү газруудад хэсэг мөс, эсвэл цасан ширхгийг хэзээ ч олж харахгүй. Энд бид томоохон уур амьсгалын талаар ярьж байгаа бөгөөд энэхүү жишээ нь бүх зүйлийн хоорондох харилцааг тэнцвэржүүлдэг Бурханы арга замуудын нэг юм.

Хоёр дахь арга зам нь гэвэл: Сахлаг өвс ургамал бүрхэж, төрөл бүрийн ургамал ногоо газраар ширдэглэсэн уул нурууд, мөн дундуур нь алхахад дээр буй нарыг ч олж харж чадахааргүй өтгөн шигүү ойн зурвасууд. Гэтэл өөр нэг уул нурууг харахад ганц ч хадуур өвс ургаагүй, дээр дээрээсээ давхарласан нүцгэн арзгар уулс байдаг. Гаднаас нь харвал аль аль нь үндсэндээ асар их овоорсон шорооноос тогтсон уулс боловч нэгийг нь шигүү ой мод бүрхсэн байхад нөгөөх нь ургамалгүй, ганц хадуур өвс ч байхгүй. Энэ бол Бурхан бүх зүйлийн хоорондох харилцааг тэнцвэржүүлдэг хоёр дахь арга зам юм. Гурав дахь арга зам нь гэвэл: Нэг тийшээ харвал хязгааргүй уудам өвст тал, өвс ногоо халиурсан тал газрыг харж магадгүй. Нөгөө тийшээ харвал нүдний хараа ч хүрэхээргүй хол үргэлжлэх хоосон, исгэрэх салхи үлээсэн элсэн дунд ганц ч амьд зүйл үгүй цөл газрыг харж магадгүй. Дөрөв дэх арга зам нь гэвэл: Нэг тийшээ харахад бүх зүйл асар их хэмжээний ус болох далайн дор живсэн байхад нөгөө тийшээ харахад ганц дусал цэнгэг булгийн ус ч олоход хэцүү байдаг. Тав дахь арга зам нь гэвэл: Энэ газарт шиврээ бороо байнга ордог, цаг уур нь манантай, чийглэг байхад тэнд байгаа газарт тэнгэрт нь үргэлж нар төөнөж, дусал бороо орох ч ховор үзэгдэл байдаг. Зургаа дахь арга зам нь гэвэл: Нэг газарт агаар нь сийрэг, хүн амьсгалахад хэцүү өндөрлөг газар байдаг бол өөр нэг газарт төрөл бүрийн нүүдлийн шувуудын амьдрах газар болдог нам дор, намаг байдаг. Эдгээр нь өөр өөр төрлийн уур амьсгал, өөр өөр газарзүйн орчинд тохирох уур амьсгал, эсвэл орчин юм. Өөрөөр хэлбэл, Бурхан хүмүүсийн амьд орших орчны агаар, температур, чийгшлийг тэнцвэртэй байлгахын тулд уур амьсгалаас эхлээд газарзүйн орчин, төрөл бүрийн хөрсний бүтцээс эхлээд усны ундаргын тоо хүртэл хүн төрөлхтний амьдрах үндсэн орчныг том хэмжээний орчны хувьд тэнцвэртэй байлгадаг. Эдгээр газарзүйн эсрэг, тэсрэг орчны улмаас хүмүүс тогтвортой агаартай, өөр өөр улиралд температур, чийгшил нь тогтвортой байдаг. Энэ нь тухайн амьдрах орчиндоо үргэлж амьдарч байсан шигээ үргэлжлүүлэн амьдрах боломжийг хүмүүст өгдөг. Нэгдүгээрт, том хэмжээний орчныг тэнцвэртэй байлгах ёстой. Бурханы хүсдэг, хүн төрөлхтөнд шаардлагатай тэнцвэрийг бий болгохын тулд харилцан хязгаарлаж, хянах боломж олгодог өөр өөр газарзүйн байршил, тогтоц, мөн өөр өөр уур амьсгалын хоорондох өөрчлөлтийг ашиглан үүнийг хийдэг. Үүнийг том хэмжээний орчны өнцгөөс ярьж байна.

Одоо бид ургамал гэх мэт илүү нарийн ширийн зүйлийн талаар ярилцана. Тэдгээрийн тэнцвэрийг хэрхэн бий болгодог вэ? Өөрөөр хэлбэл, амьдрах тэнцвэртэй орчин дотор үргэлжлүүлэн амьд орших боломжийг ургамалд яаж олгож болох вэ? Хариулт нь, төрөл бүрийн ургамлын амьдрах хугацаа, өсөлтийн хурд, нөхөн үржих хурдыг удирдсанаар тэдний амьдрах орчныг хамгаалах юм. Бяцхан өвсийг жишээ болгон авч үзье—хавар нахиалж, зун цэцэглэж, намар үр жимсээ өгдөг. Үр жимс нь газар унадаг. Дараа жил нь жимснээс гарсан үр соёолж, нөгөө л хуулийн дагуу үргэлжилдэг. Өвсний амьдрах хугацаа маш богино; үр бүхэн газарт унаж, үндэс нахиа нь ургаж, цэцэглэж, үр жимсээ өгдөг бөгөөд энэ үйл явц бүхэлдээ хавар, зун, намар

гэсэн гуравхан улирлын дараа дуусдаг. Төрөл бүрийн мод ч бас өөрийн гэсэн амьдрах хугацаатай, нахиалж, үр жимсээ өгөх үе нь өөр өөр байдаг. Зарим мод ердөө 30-аас 50 жилийн дараа үхдэг бөгөөд энэ нь тэдний амьдрах хугацаа юм. Гэхдээ үр жимс нь газарт унаж, түүнээс үндэс ургаж, нахиалаад, цэцэглэж, үр жимс нь гарч, дахин 30-аас 50 жил амьдардаг. Энэ бол үүний давтамжийн хурд юм. Хөгшин мод үхэж, залуу мод ургадаг; ийм учраас ой шугуйд байнга л модод ургаж байгааг чи хардаг. Гэхдээ тэд ч бас өөрийн гэсэн хэвийн мөчлөг, төрөх, үхэх үйл явцтай. Зарим мод мянга гаруй жил амьдарч чаддаг бол зарим нь бүр гурван мянган жил амьдардаг. Ямар төрлийн ургамал байх, эсвэл амьдрах хугацаа нь хэр урт байх нь хамаагүй хэр удаан амьдардаг, нөхөн үржих чадвар, нөхөн үржих хурд, давтамж, үр төл гаргах хэмжээн дээр нь тулгуурлан Бурхан тэнцвэрийг нь зохицуулдаг. Энэ нь өвснөөс мод хүртэл ургамалд тэнцвэртэй экологийн орчинд үргэлжлүүлэн өсөж, ургах чадвартай байх боломжийг олгодог. Тиймээс дэлхий дээр байгаа ой модыг харахад дотор байгаа юм бүхэн, өвс, модны аль аль нь өөрийн гэсэн зүй тогтлын дагуу тасралтгүй үржиж, өсдөг. Үүнд хүн төрөлхтнөөс нэмэлт хөдөлмөр, тусламж хэрэггүй. Ийм тэнцвэр байдаг учраас л тэд амьдрах орчноо хадгалан үлдэж чаддаг. Амьдрах тохиромжтой орчин байгаа учраас л дэлхийн ой мод, өвст тал газар дэлхий дээр үргэлжлэн оршсоор байгаа юм. Тэдний оршин тогтнол нь хүмүүс, мөн түүнчлэн ой мод хийгээд өвст талд амьдардаг жигүүртэн шувуу, араатан амьтад, шавж хорхой, бүх төрлийн бичил биет зэрэг бүх төрлийн амьд зүйлийг үеэс үед тэжээн тэтгэдэг.

Бурхан бас бүх төрлийн амьтдын хоорондох тэнцвэртэй байдлыг хянадаг. Энэхүү тэнцвэртэй байдлыг Тэр хэрхэн хянадаг вэ? Энэ нь ургамалтай төстэй— Тэр тэдний нөхөн үржих чадвар, нөхөн үржих тоо хэмжээ ба давтамж, амьтны ертөнцөд гүйцэтгэх үүрэгт нь үндэслэн тэнцвэртэй байдлыг нь удирдаж, тоо толгойг тодорхойлдог. Жишээ нь, арслан алаг тахийг иддэг, иймээс хэрвээ арслангийн тоо алаг тахийн тооноос хэтэрвэл алаг тахийн хувь заяа яах вэ? Тэд устгаж үгүй болно. Хэрвээ алаг тахь арслангаас хавьгүй цөөн үр төл гаргадаг байвал тэдний хувь заяа яах вэ? Тэд мөн л устаж үгүй болно. Тиймээс алаг тахийн тоо арслангийн тооноос хамаагүй их байх ёстой. Учир нь, алаг тахь зөвхөн өөрийнхөө төлөө оршин тогтнодоггүй, тэд бас арслангийн төлөө оршин тогтнодог. Түүнчлэн, алаг тахь болгон нийт алаг тахийн нэг хэсэг боловч мөн арслангийн аманд орох хоол хүнс гэж бас хэлж болно. Арслангийн нөхөн үржих хурд алаг тахийнхаас хэзээ ч давж гарч болохгүй, тиймээс тэдний тоо хэмжээ хэзээ ч алаг тахийн тоо хэмжээнээс их байж болохгүй. Зөвхөн ийм маягаар л арслангийн хоол хүнсний эх үүсвэр баталгаатай байна. Иймээс, хэдийгээр арслан алаг тахийн төрөлхийн дайсан боловч энэ хоёр төрөл зүйлийн амьтан нэг газарт амар тайвнаар амарч байхыг хүмүүс олонтоо хардаг. Арслан алаг тахийг агнаж, иддэгээс болж алаг тахийн тоо хэзээ ч багасах юм уу устаж үгүй болохгүй бөгөөд “хаан” гэсэн зиндаанаас болж арслангийн тоо хэзээ ч өсөхгүй. Энэхүү тэнцвэртэй байдал бол Бурханы аль эртнээс тогтоосон зүйл юм. Өөрөөр хэлбэл, Бурхан бүх амьтны хоорондох тэнцвэртэй байдлын хуулийг

тогтоож, ингэснээр тэд ийм тэнцвэрийг хадгалж чаддаг бөгөөд энэ бол хүмүүсийн үргэлж хардаг зүйл юм. Зөвхөн арслан л алаг тахийн төрөлхийн дайсан уу? Үгүй, матар ч бас алаг тахийг иддэг. Алаг тахь маш биеэ хамгаалах чадваргүй амьтан мэт харагддаг. Тэдэнд арслангийн догшин авир байхгүй бөгөөд энэхүү догшин ширүүн дайсан арслантай нүүр тулах үедээ зугтаж л чаддаг. Тэд эсэргүүцэх ч тэнхээгүй байдаг. Арслангаас зугтаж чадахгүй болох үедээ тэд идүүлэхээс өөр аргагүй болдог. Үүнийг амьтны ертөнцөөс байнга харж болно. Иймэрхүү зүйл харах үед та нарт ямар мэдрэмж, бодол төрдөг вэ? Та нар алаг тахийг өрөвддөг үү? Арсланг жигшдэг үү? Алаг тахь маш үзэсгэлэнтэй харагддаг! Харин арслан үргэлж л тэднийг ховдог шунахайгаар ажиглаж байдаг. Гэвч тэнэг юм шиг алаг тахь хол гэгч зугтаадаггүй. Тэд модны доор сэрүүн сүүдэрт өөрсдийг нь хүлээж байгаа арсланг хардаг. Арслан тэднийг хэдийд ч ирээд идэж магадгүй. Тэд зүрх сэтгэлдээ үүнийг мэддэг ч гэсэн тухайн газраас явахгүй. Энэ бол гайхамшигтай зүйл, Бурханы урьдчилан төлөвлөлт, Түүний захиралтыг харуулдаг гайхамшигтай зүйл. Чи алаг тахийг өрөвддөг боловч түүнийг аварч чадахгүй бөгөөд арсланг жигшин зэвүүцэх боловч устгаж чадахгүй. Алаг тахь бол арсланд зориулан Бурханы бэлдсэн хоол хүнс боловч арслан хэчнээн олныг идсэн ч гэсэн алаг тахь устаж үгүй болно гэж байхгүй. Арслангийн гаргадаг үр төл маш цөөн бөгөөд тэд маш удаан үрждэг учраас хэр олон алаг тахь идэх нь хамаагүй тэдний тоо алаг тахийн тооноос хэзээ ч илүү гарахгүй. Энэ бол нэг төрлийн тэнцвэртэй байдал юм.

Ийм тэнцвэртэй байдлыг хадгалах Бурханы зорилго юу вэ? Энэ нь хүмүүсийн амьдрах орчин болон хүн төрөлхтний амьд оршихтой холбоотой. Хэрвээ алаг тахь, эсвэл буга зэрэг бусад ижил төстэй арслангийн идэш болох амьтан хэтэрхий удаан үржиж, арслангийн тоо огцом өсвөл хүнд ямар аюул учрах вэ? Арслан олзоо идэх нь хэвийн үзэгдэл боловч арслан хүн идэх нь эмгэнэлт явдал юм. Энэ эмгэнэлт явдлыг Бурхан урьдчилан тогтоогоогүй, энэ нь Түүний захиргаан дор болдог зүйл биш, хүн төрөлхтөнд Түүний авчирсан зүйл бүр ч биш. Харин ч, энэ нь хүмүүсээс өөрсдөөс нь болдог зүйл юм. Тиймээс Бурханы харж байгаачлан, бүх зүйлийн хооронд тэнцвэр байх нь хүн төрөлхтөн амьд оршиход амин чухал билээ. Ургамал ч бай, амьтан ч бай, юу ч зүй ёсны тэнцвэрээ алдаж болохгүй. Ургамал, амьтад, уулс, гол нуурууд нь—хүн төрөлхтөнд зориулан Бурханы бэлдсэн ердийн экологийн орчин юм. Хүмүүс ийм экологийн орчин—тэнцвэртэй орчинтой байсан үед л оршин тогтнол нь аюулгүй байна. Хэрвээ мод, эсвэл өвс ногоо нөхөн үржих чадвар муутай, эсвэл нөхөн үржих хурд нь маш удаан байсан бол хөрс чийгшлээ алдахгүй гэж үү? Хэрэв хөрс чийгшлээ алдвал эрүүл байх уу? Хэрвээ хөрс, ургамал болон чийгшлээ алдвал маш хурдан элэгдэлд орж, оронд нь элс бий болно. Хөрс муудсанаар хүмүүсийн амьдрах орчин ч бас сүйрнэ. Энэ сүйрлийг даган олон гамшиг ирэх болно. Ийм экологийн тэнцвэр байхгүйгээр, ийм экологийн орчин байхгүйгээр бүх зүйлийн хооронд тэнцвэргүй байдал бий болсноор хүмүүс байнгын гамшигт зовох болно. Жишээ нь, орчны тэнцвэр алдагдаж, мэлхийн экологийн орчин

сүйрэхэд хүрэх үед бүгд бөөгнөрөн цугларч, тоо хэмжээ нь огцом өсөх бөгөөд тэр ч байтугай хот дотор зам хөндлөн гарах олон тооны мэлхийг хүмүүс харна. Хэрвээ олон тооны мэлхий хүмүүсийн амьдрах орчныг эзэгнэх аваас үүнийг юу гэж нэрлэх вэ? Гамшиг гэнэ. Яагаад үүнийг гамшиг гэж нэрлэж байна вэ? Хүн төрөлхтөнд ашиг тустай энэ жижигхэн амьтад өөрсдөд нь тохирсон газартаа байх аваас хүмүүст хэрэгтэй; тэд хүмүүсийн амьдрах орчны тэнцвэрийг хадгалж чаддаг. Гэвч хэрвээ тэд гамшиг болбол хүмүүсийн амьдралын эмх цэгцтэй байдалд нөлөөлөх болно. Мэлхийний авчрах бүх зүйл, бие дээрээ авчрах бүх элемент хүмүүсийн амьдралын чанарт нөлөөлж болно. Хүмүүсийн бие эрхтэн хүртэл дайралтад өртөхөд хүргэж болно—энэ бол нэг төрлийн гамшиг юм. Хүмүүсийн олонтоо туулсан өөр нэгэн төрлийн гамшиг бол их хэмжээний царцаа гарч ирэх үзэгдэл юм. Энэ гамшиг биш гэж үү? Тийм ээ, энэ бол үнэхээр аймшигтай гамшиг. Хүмүүс хэр чадвартай байх нь хамаагүй—хүмүүс нисэх онгоц, их буу, атомын бөмбөг хийж чаддаг ч царцаа хүн төрөлхтөн рүү дайрах үед тэдэнд ямар шийдэл байдаг вэ? Тэд царцааны эсрэг их буу ашиглаж чадах уу? Автомат буугаар тэднийг шүршиж чадах уу? Үгүй, чадахгүй. Тэгээд тэднийг үлдэн хөөхийн тулд шавжны хор цацаж чадах уу? Тэр ч бас амар ажил биш. Тэр өчүүхэн царцаанууд яах гэж гарч ирдэг вэ? Тэд онцгойлон үр тариа иддэг. Царцааны явсан газар бүрд ургац тэр чигтээ сүйддэг. Царцааны дайралт болох үед тариачдын бүтэн нэг жилийн бүх хоол хүнсийг царцаанууд нүд ирмэх зуур, тэр чигт нь идэх боломжтой. Хүмүүсийн хувьд, царцаа ирэх нь зүгээр нэг бухимдал төрүүлэх зүйл бус, харин гамшиг юм. Тэгэхээр асар их хэмжээний царцаа гарч ирэх нь нэг төрлийн гамшиг гэдгийг бид мэдэх боловч оготнын тухайд ямар вэ? Хэрвээ оготно идэх ямар ч махчин шувуу байдаггүй бол тэд маш хурдан, төсөөлж чадахаас чинь ч илүү хурдан үржих болно. Тэгээд хэрвээ оготно саадгүй тархвал хүмүүс сайхан амьдарч чадах уу? Хүмүүс ямар нөхцөл байдалтай тулгарах вэ? (Тахалтай.) Гэхдээ тахал цорын ганц үр дагавар нь байна гэж бодож байна уу? Оготно юуг ч мэрнэ, бүр модыг ч гэсэн мэрэх болно. Нэг айлд хоёр оготно байхад л тэнд амьдардаг хүн болгоныг залхаана. Заримдаа тэд тос хулгайлж иддэг, заримдаа талх, үр тариа иддэг. Тэд иддэггүй зүйлээ зүгээр л мэрээд, ямар ч хэрэггүй хог новш болгож орхидог. Хувцас, гутал, тавилга гээд бүгдийг мэрдэг. Заримдаа аяга тавагны тавиур луу авирна—дээгүүр нь оготно гүйсний дараа тэр аяга тавгийг ашиглаж болох уу? Чи тэдгээрийг халдваргүйжүүлсэн ч санаа амар байж чадахгүй тул тэдгээрийг хаядаг. Энэ бол оготнын хүмүүст учруулдаг ярших төвөг юм. Оготно хэдийгээр өчүүхэн жижиг амьтан боловч хүмүүс тэдгээрийг зохицуулах арга байдаггүй, хайр найргүй устгахыг нь тэвчих л ёстой болдог. Асар их сүрэг оготно байтугай ердөө хоёрхон оготно байхад л эвдэж сүйтгэхэд хангалттай. Тоо толгой нь огцом өсвөл гамшиг болж, үр дагаврыг нь төсөөлөхийн аргагүй. Шоргоолж шиг өчүүхэн жижиг амьтан хүртэл гамшиг болж болно. Тийм зүйл болбол хүн төрөлхтөнд учруулах хохирлыг нь хайхрахгүй орхихын аргагүй. Шоргоолж байшин барилгад маш их хохирол учруулж, нурж унахад хүргэж болно. Тэдний хүчийг хайхралгүй орхиж

болохгүй. Төрөл бүрийн шувууд гамшиг үүсгэвэл аймшигтай зүйл болохгүй гэж үү? (Тэгнэ.) Өөрөөр хэлэх юм бол, ямар төрлийн амьтан, эсвэл амьд зүйлс байх нь хамаагүй тэнцвэр нь алдагдах болгонд хэвийн бус, эмх замбараагүй цар хүрээнд өсөж, үржиж, амьдрах болно. Энэ нь хүн төрөлхтөнд төсөөлөхийн аргагүй үр дагавар авчирна. Энэ нь хүмүүсийн оршин тогтнох болон амьдрахад нөлөөлөөд зогсохгүй мөн хүн төрөлхтөнд гамшиг авчирч, хүмүүс бүрмөсөн устаж үгүй болох, мөхөх хувь заяатай тулгарах хэмжээнд хүрнэ.

Бурхан бүх зүйлийг бүтээх үедээ тэдгээрийг тэнцвэртэй байлгаж, уулс болон нуурууд, ургамал болон бүх төрлийн амьтад, шувууд, шавж хорхойн амьдрах нөхцөлийг тэнцвэртэй байлгахын тулд бүх төрлийн арга, замыг ашигласан. Түүний зорилго бол бүх төрлийн амьд зүйлийг Өөрийн тогтоосон хуулийн дор амьдарч, үржих боломж олгох явдал байсан. Бүтээгдсэн нэг ч зүйл эдгээр хуулийн хүрээнээс давж гарч чадахгүй, хуулийг зөрчиж чадахгүй. Зөвхөн ийм үндсэн орчинд л хүмүүс үеэс үед аюулгүй амьд оршиж, үржиж чадна. Хэрвээ аливаа амьд амьтан Бурханы тогтоосон тоо хэмжээ, цар хүрээнээс давж гарвал, Түүний тушаасан өсөлтийн хурд, үржлийн давтамж, тоо хэмжээнээс хэтэрвэл, хүн төрөлхтний амьдрах орчин янз бүрийн хэмжээгээр сүйрэлд өртөнө. Үүний зэрэгцээ, хүн төрөлхтний амьд орших эсэхэд заналхийлнэ. Хэрвээ нэг төрлийн амьтан хэт их тоотой байвал хүмүүсийн хоол хүнсийг булаан авч, усны эх үүсвэрийг сүйтгэж, төрөлх нутгийг нь үгүй хийх болно. Ийм маягаар хүн төрөлхтний нөхөн үржих, амьд орших байдалд шууд нөлөөлнө. Жишээ нь, бүх зүйлд ус маш чухал. Хэрэв хэтэрхий олон тооны оготно, шоргоолж, царцаа, мэлхий юм уу өөр бусад төрлийн амьтан байвал тэдгээр нь илүү их ус уух болно. Тэдний уух усны хэмжээ нэмэгдэхийн хэрээр тогтсон цар хүрээтэй ундны усны эх үүсвэр болон устай газар дахь хүмүүсийн уух ус, усны эх үүсвэр багасаж, усны дутагдалд орно. Бүх төрлийн амьтдын тоо хэмжээ ихэссэнээс шалтгаалан хүмүүсийн уух ус тасарч, бохирдож, үгүй болбол амьдрах тийм хатуу ширүүн орчинд хүн төрөлхтөн амьд орших эсэхэд ноцтой заналхийлнэ. Зохих ёсны тоо хэмжээнээсээ хэтэрсэн нэг юм уу хэд хэдэн төрлийн амьд амьтан л байхад хүн төрөлхтний амьдрах орон зай дахь агаар, температур, чийгшил, тэр ч бүү хэл агаарын найрлага хүртэл хордож, янз бүрийн түвшинд сүйдэх болно. Ийм нөхцөл байдалд хүмүүсийн оршин тогтнол хийгээд хувь заяанд мөн эдгээр экологийн хүчин зүйл заналхийлнэ. Тэгэхээр, хэрвээ эдгээр тэнцвэр алдагдвал хүмүүсийн амьсгалах агаар сүйдэж, уух ус нь бохирдож, шаардагдах температур нь ч бас янз бүрийн түвшинд өөрчлөгдөж, нөлөөлөлд өртөх болно. Тийм зүйл тохиолдвол, хүн төрөлхтөнд угаас байсан амьдрах орчин нь асар их нөлөөлөлд өртөж, бэрхшээл учрах болно. Хүмүүсийн амьдрах үндсэн орчин сүйтгэгдсэн ийм нөхцөлд хүн төрөлхтний хувь заяа, ирээдүй ямар болох вэ? Энэ бол маш ноцтой асуудал! Бүтээгдсэн зүйлс хүн төрөлхтний төлөө ямар шалтгаанаар оршин байдгийг, Өөрийнх нь бүтээсэн төрөл зүйл бүрийн үүрэг юу болохыг, хүн төрөлхтөнд ямар нөлөө үзүүлдгийг, хүн төрөлхтөнд ямар хэмжээний ашиг тус авчирдгийг Бурхан

мэддэг учраас, мөн энэ бүгдэд зориулсан төлөвлөгөө Бурханы зүрх сэтгэлд байдаг бөгөөд Тэр бүтээсэн бүх зүйлийнхээ тал бүрийг удирддаг учраас Түүний хийдэг юм бүхэн хүн төрөлхтөнд маш чухал, шаардлагатай байдаг. Тиймээс одоогоос эхлэн, чи Бурханы бүтээсэн зүйлсийн дундаас зарим нэг экологийн үзэгдэл харахдаа, эсвэл Бурханы бүтээсэн зүйл дундаас зарим нэг байгалийн хууль хэрэгжиж байгааг харах болгондоо Бурханы бүтээсэн юм бүхэн байх шаардлагатай эсэхэд эргэлзэхээ болино. Чи, бүх зүйлийг зохицуулж байгаа Бурханы зохицуулалт, хүн төрөлхтнийг хангаж байгаа Түүний янз бүрийн арга замыг дур зоргоороо шүүмжилж, увайгүй үг хэрэглэхээ болино. Чи мөн бүтээсэн бүх зүйлдээ зориулсан Бурханы хуулийн талаар дур зоргоороо дүгнэлт гаргахаа болино. Тийм биш гэж үү?

Бидний дөнгөж сая ярилцаж байсан энэ бүх зүйл юуны тухай вэ? Энэ талаар нэг бодоод үз. Бурханы хийдэг юм бүхэнд Түүний санаа зорилго бий. Хэдийгээр хүмүүс Түүний санаа зорилгыг ухаарч чадахгүй ч хүн төрөлхтний амьд оршихтой үргэлж ээдрээтэй бөгөөд салшгүй холбоотой байдаг. Энэ бол зайлшгүй шаардлагатай. Учир нь, Бурхан хэзээ ч хий дэмий зүйл хийж байгаагүй. Түүний хийдэг юм бүхний цаад зарчимд Түүний төлөвлөгөө, мэргэн ухаан шингэсэн байдаг. Тэрхүү төлөвлөгөөний цаад зорилго, санаа нь хүн төрөлхтнийг хамгаалж, гамшгийг зайлуулж, аливаа амьд зүйлийн дайралтаас, Бурханы бүтээсэн аливаа зүйлийн хүнд учруулах аливаа хор хохирлоос сэргийлэхэд хүн төрөлхтөнд туслахын төлөө байдаг. Тиймээс энэ сэдвийн хүрээнд бидний харсан Бурханы үйлс Бурхан хүн төрөлхтнийг хангах өөр арга замыг бүрдүүлдэг гэж хэлж болох уу? Эдгээр үйлсээр дамжуулан Бурхан хүн төрөлхтнийг тэжээж, хариулж байгаа гэж бид хэлж болох уу? (Болно.) Энэхүү сэдэв болон “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэсэн бидний нөхөрлөлийн гарчгийн хооронд нягт холбоо байна уу? (Тийм ээ.) Маш нягт холбоо байгаа бөгөөд энэ сэдэв бол үүний нэг тал нь юм. Эдгээр сэдвийг ярихаас өмнө хүмүүс Бурхан, Бурхан Өөрөө, Түүний үйл хэргийн талаар зарим нэг бүдэг бадаг төсөөлөлтэй л байсан—тэдэнд жинхэнэ ойлголт байгаагүй. Харин, Түүний үйл хэрэг, Түүний хийсэн зүйлсийн тухай хүмүүст хэлэхэд тэд Бурханы хийдэг зүйлийн зарчмуудыг ойлгож, ухаарч, тэдгээрийн талаар ойлголттой болж, тэдгээрт дөхөж очдог. Бурхан бүх зүйлийг бүтээх, захирах гээд аливааг хийх болгонд, Түүний зүрх сэтгэлд бүх төрлийн маш ээдрээтэй онол, зарчим, дүрэм байдаг ч гэсэн, нөхөрлөлөөр та нарт ганцхан зүйлийн талаар мэдэх боломж олголоо гээд эдгээр нь Бурханы үйлс бөгөөд маш бодитой гэдгийг та нар зүрх сэтгэлдээ ойлгож чадахгүй гэж үү? (Чадна.) Тэгвэл Бурханы тухай одоогийн ойлголт чинь өмнөхөөсөө юугаараа ялгаатай юм бэ? Гол чанараараа ялгаатай. Өмнө нь ойлголт чинь хэтэрхий хоосон, хэтэрхий тодорхойгүй байсан бол одоо ойлголт чинь Бурханы үйлстэй нийцэх, Бурханд юу байгаа болон Бурхан юу болохтой нийцэх нэлээд их баттай нотолгоог агуулдаг. Иймээс, Миний хэлсэн бүх зүйл Бурханы талаарх ойлголтод чинь гайхалтай сургалтын материал болдог.

2014 оны 2 дугаар сарын 9

ЦОР ГАНЦ БУРХАН ӨӨРӨӨ Х
БУРХАН БОЛ БҮХ ЗҮЙЛИЙН АМИЙН ЭХ СУРВАЛЖ (IV)

Бид өнөөдөр онцгой сэдвээр ярилцаж байна. Итгэгч бүрийн мэдэж, туулж, ойлгох хэрэгтэй хоёр л гол зүйл бий. Энэхүү хоёр зүйл нь юу вэ? Эхнийх нь хувь хүний амийн оролт, хоёр дахь нь Бурханыг мэдэхтэй холбоотой. Бурханыг мэдэх тухай асуудлаар бидний саяхан ярилцсан сэдвийн тухайд, үүнд хүрэх боломжтой гэж та нар бодож байна уу? Ихэнх хүний хувьд энэ нь хүрч чадахгүй зүйл гэдгийг хэлэх нь зүйтэй. Та нар Миний үгэнд итгэхгүй байж магадгүй боловч Би яагаад ингэж хэлж байна вэ? Өмнө нь Миний хэлж байгааг та нар сонсож байхдаа яаж, ямар үгээр хэлснээс үл хамааран, эдгээр үг нь ямар учиртайг шууд утгаар нь болон онолын хувьд мэдэж чаддаг байсан учраас Би ингэж хэлж байна. Гэвч та бүгдийн хувьд, яагаад ийм зүйл хэлж, ийм сэдвээр ярьсныг минь ойлгоогүй нь маш ноцтой асуудал байсан юм. Энэ бол асуудлын гол нь. Иймээс, та нар эдгээр зүйлийг сонссоноороо Бурхан, Түүний үйл хэргийн талаарх ойлголтоо бага зэрэг нэмэгдүүлж, баяжуулсан хэдий ч Бурханыг мэдэхэд шаргуу хүчин чармайлт шаарддаг гэж та нарт санагдсан хэвээр байдаг. Өөрөөр хэлбэл, Миний хэлэхийг сонссоныхоо дараа та нарын ихэнх нь Би яагаад үүнийг хэлсэн, Бурханыг мэдэхтэй энэ нь ямар холбоотойг ойлгодоггүй. Бурханыг мэдэхтэй энэ нь хэрхэн холбогддогийг та нар ойлгож чаддаггүйн шалтгаан нь амийн туршлага чинь хэтэрхий өнгөц байдгийнх юм. Хэрвээ Бурханы үгийн талаарх хүмүүсийн мэдлэг, туршлага маш өнгөц түвшинд үлдвэл Түүний талаарх ихэнх мэдлэг нь тодорхой бус, хийсвэр байна; бүгд ерөнхий, ягшмал, онолынх байна. Онолын хувьд, энэ нь зүй ёсны, үндэслэлтэй харагдаж, сонсогдож магадгүй боловч ихэнх хүний амнаас гардаг Бурханы талаарх мэдлэг үнэндээ хоосон байдаг. Би яагаад үүнийг хоосон гэж хэлдэг вэ? Яагаад гэвэл, Бурханыг мэдэх тухайд хэлж буй зүйлийнхээ үнэн зөв, яг таг эсэх талаар чамд үнэндээ тодорхой ойлголт байхгүй. Иймээс ихэнх хүн Бурханыг мэдэх талаар маш их мэдээлэл, сэдэв сонссон боловч Бурханы талаарх мэдлэг нь онол болон тодорхой бус, хийсвэр хоосон сургаалаас хараахан хэтрээгүй байдаг. Тэгвэл энэ асуудлыг хэрхэн шийдэж болох вэ? Та нар энэ талаар ер нь бодож байсан уу? Хүн үнэнийг эрэлхийлдэггүй бол бодит байдалтай болж чадах уу? Хэрвээ хүн үнэнийг эрэлхийлдэггүй бол, түүнд бодит байдал байхгүй нь маргаангүй учраас Бурханы үгийн талаар мэдлэг, туршлага ч үгүй байх нь гарцаагүй. Тэгвэл Бурханы үгийн талаар ойлголтгүй хүмүүс Бурханыг мэдэж чадах уу? Огт чадахгүй; энэ хоёр нь хоорондоо холбоотой. Иймд ихэнх хүн “Бурханыг мэдэхэд яагаад ийм хэцүү байдаг юм бэ? Би өөрийгөө мэдэх тухай бол хэдэн цагаар ч ярьж чадах боловч Бурханыг мэдэх тухай ярих гэхээр хэлэх үггүй болдог. Би энэ сэдвээр бага зэрэг ярьж чадлаа ч гэсэн үг минь хүчилсэн бөгөөд үлбэгэр сонсогддог. Өөрийнхөө ярьж байгааг сонсоход хүртэл болхи сонсогддог” гэж хэлдэг. Энэ бол эх сурвалж. Хэрвээ Бурханыг мэдэхэд хэтэрхий хэцүү, маш их хүчин чармайлт шаарддаг, чамд

ярилцах сэдэв байхгүй, бусадтай болон өөртэйгөө ярилцаж, хангах ямар ч бодитой зүйл байхгүй санагдаж байвал Бурханы үгийг туулсан нэгэн биш гэдгийг чинь энэ нь баталдаг. Бурханы үг гэж юу вэ? Бурханы үг нь Түүнд юу байгаа, Тэр юу болохын илэрхийлэл бус уу? Хэрвээ чи Бурханы үгийг туулаагүй бол Түүнд юу байгаа, Тэр юу болох талаар ямар нэгэн мэдлэгтэй байж чадах байсан уу? Мэдээж үгүй. Эдгээр зүйл нь бүгд хоорондоо холбоотой. Хэрвээ чамд Бурханы үгийн талаар ямар ч туршлага байхгүй бол чи Бурханы хүслийг ухаарч чадахгүй, Түүний зан чанар юу болох, Тэр юунд дуртай, Тэр юуг жигшдэг, хүмүүст тавьдаг Түүний шаардлага юу болох, сайн болон муу хүмүүст ханддаг Түүний хандлага ямар байдгийг ч бас мэдэхгүй; энэ бүхэн нь чамд мэдээж ойлгомжгүй, бүрхэг байна. Хэрвээ чи ийм тодорхойгүй байдлын дунд Бурханд итгэдэг бол өөрийгөө үнэнийг эрэлхийлж, Бурханыг дагадаг хүмүүсийн нэг гэж хэлэхэд тэр үг чинь бодитой байна гэж үү? Бодитой биш! Тиймээс Бурханыг мэдэх талаар яриагаа үргэлжлүүлцгээе.

Та нар бүгд өнөөдрийн нөхөрлөлийн сэдвийг сонсохоор тэсэн ядаж байгаа байх, тийм үү? Энэхүү сэдэв нь бас бидний саяхан ярилцаж байсан “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдэг сэдэвтэй холбоотой. Бурхан хэрхэн бүгдийг захирч, Тэр ямар аргаар барилаар ийнхүү захирч, Бурханы бүтээсэн энэхүү гараг дээр тэдгээрийг оршин байлгахын тулд Тэр ямар зарчмаар бүх зүйлийг удирддаг тухай хүмүүст мэдүүлэх гэж өөр өөр арга барил, харах өнцөг ашиглаж ямар учраас “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” болох талаар бид ихээхэн ярьсан. Бурхан, хүн төрөлхтнийг хэрхэн хангадаг, Тэр ямар арга барилаар тийнхүү хангадаг, хүмүүсийг ямар төрлийн амьдрах орчноор хангадаг, хүний тогтвортой амьдрах орчныг ямар арга барилаар, ямар эхлэлийн цэгээс хангадаг талаар бид бас нэлээд ярьсан. Хэдийгээр бүх зүйлийг захирах Бурханы ноёрхол, захиргаа болон Түүний удирдлагын хоорондох харилцааны талаар Би шууд яриагүй боловч Тэр яагаад бүх зүйлийг ингэж удирддаг, түүнчлэн Тэр яагаад хүн төрөлхтнийг ийм маягаар хангаж, тэжээн тэтгэдэг талаар шууд бусаар ярьж байсан. Энэ бүхэн Түүний удирдлагатай холбоотой. Бидний ярилцсан агуулга, макро орчноос эхлээд хүмүүсийн үндсэн хэрэгцээ, хоол хүнс гэх мэт хавьгүй жижиг зүйлс хүртэл; Бурхан бүх зүйлийг хэрхэн захирч, тэднийг эмх цэгцтэй байлгадгаас эхлээд бүхий л угсаа язгуурын хүмүүст зориулан Түүний бүтээсэн зөв, зохистой амьдрах орчин хүртэл маш өргөн цар хүрээтэй байсан. Энэхүү өргөн цар хүрээтэй агуулга нь бүгд, хүмүүс махан биед хэрхэн амьдрахтай холбоотой. Өөрөөр хэлбэл, энэ бүхэн нь уулс, гол горхи, далай тэнгис, тал газар гэх мэт энгийн нүдэнд харагддаг, хүмүүсийн мэдэрч чаддаг материаллаг ертөнцийн юмстай холбоотой. Эдгээр нь бүгд харж, хүрч болдог зүйлс юм. Намайг агаар, температурын тухай ярихад, та нар амьсгалснаараа агаар оршин байгааг шууд мэдэрч, температурын их, багыг биеэрээ мэдэрч чадна. Мод, өвс ногоо, ойд байдаг шувуу, араатан амьтад, тэнгэрт нисдэг, газарт явдаг зүйлс, нүхнээсээ гарч ирдэг янз бүрийн бяцхан амьтдыг бүгдийг нь хүмүүс нүдээрээ харж, чихээрээ сонсож чаддаг. Хэдийгээр энэ бүх зүйлсийн хамрах цар хүрээ маш

өргөн боловч Бурханы бүтээсэн бүх зүйлээс тэдгээр нь зөвхөн материаллаг ертөнцийг төлөөлдөг. Материаллаг зүйлс гэдэг бол хүмүүсийн харж, мэдэрч чаддаг зүйлс, өөрөөр хэлбэл, хүрэхээрээ чи тэдгээрийг мэдэрч, нүд чинь тэднийг харахад тархи чинь дүрс, зураг чамд үзүүлдэг. Тэдгээр нь бодит, биет зүйлс; тэдгээр нь чамд бол хийсвэр бус, харин хэлбэртэй юм. Тэдгээр нь дөрвөлжин, дугуй, өндөр, нам байж болно, мөн юмс бүр өөр өөр мэдрэмж төрүүлдэг. Энэ бүх зүйл нь бүтээлийн материаллаг талыг төлөөлдөг. Тэгэхээр Бурханы хувьд “бүх зүйлийг Бурхан захирдаг” гэдгийн “бүх зүйл”-д юу багтдаг вэ? Тэдгээрт дан ганц хүмүүсийн харж, хүрч чадах зүйлс багтдаггүй; үүний зэрэгцээ, үл үзэгдэх, үл мэдрэгдэх бүх зүйл багтдаг. Бурхан бүх зүйлийг ноёрхдогийн жинхэнэ утга учрын нэг нь энэ юм. Ийм зүйлс хүмүүст үл үзэгдэж, үл мэдрэгддэг хэдий ч Бурханы хувьд Тэр нүдээрээ ажиглаж болж байгаа, Түүний дээд эрхийн цар хүрээнд байгаа л цагт тэдгээр нь үнэхээр оршин байдаг. Хэдийгээр хүний хувьд тэдгээр нь хийсвэр, төсөөлшгүй, тэр ч байтугай үл үзэгдэж, үл мэдрэгддэг нь бодит үнэн хэдий ч Бурханы хувьд үнэхээр, бодитоор оршин байдаг. Энэ бол Бурханы захирдаг бүх зүйлийн дундах өөр нэгэн ертөнц, Түүний ноёрхдог бүх зүйлийн цар хүрээний өөр нэг хэсэг юм. Энэ бол бидний өнөөдөр нөхөрлөх сэдэв, Бурхан сүнсний ертөнцийг хэрхэн захирч, удирддаг тухай юм. Энэхүү сэдэв нь, Бурхан бүх зүйлийг хэрхэн захирч, удирддаг тухай авч үзэх учраас материаллаг ертөнцийн гаднах ертөнц—сүнсний ертөнцөд хамаатай, тиймээс үүнийг ойлгох нь бидэнд нэн чухал. Энэхүү агуулгын талаар ярилцаж, ойлгосны дараа л хүмүүс “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдэг үгийн жинхэнэ утга учрыг жинхэнээсээ ойлгож чадна. Бид энэ сэдвээр ярилцах гэж байгаагийн шалтгаан нь энэ; “Бурхан бүх зүйлийг захирч, бүх зүйлийг удирддаг” хэмээх сэдвийг гүйцээх зорилготой юм. Магадгүй энэ сэдвийг сонсоод та нарт хачин, ойлгошгүй санагдаж болох ч та нарт ямар санагдах нь хамаагүй, сүнсний ертөнц нь Бурханы захирдаг бүх зүйлийн нэг хэсэг учир энэхүү сэдвийн талаар зарим ойлголтыг та нар олж авах ёстой. Ингэснийхээ дараа та нар “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэдэг хэллэгийн талаар илүү гүнзгий мэдлэг, ойлголт, ухаарлыг олж авах болно.

Бурхан сүнсний ертөнцийг хэрхэн захирч, удирддаг вэ

Материаллаг ертөнцийн хувьд, хүмүүс тодорхой нэг зүйл, үзэгдлийг ойлгохгүй байх болгондоо тэдгээр зүйлийн гарал үүсэл, цаад шалтгааныг олж мэдэхийн тулд янз бүрийн суваг ашиглаж, холбогдох мэдээллийг хайж болно. Харин өнөөдрийн бидний ярьж байгаа нөгөө ертөнц буюу материаллаг ертөнцийн гадна орших сүнсний ертөнцийн тухайд бол, энэ талаар ямар нэг зүйл олж мэдэх арга зам, суваг хүмүүст огт байхгүй. Би яагаад ингэж хэлж байна вэ? Яагаад гэвэл, хүн төрөлхтний ертөнцөд, материаллаг ертөнцийн бүх зүйл хүний биет оршин тогтнолтой салшгүй холбоотой бөгөөд материаллаг ертөнцийн бүх зүйл өөрсдийнх нь бие махбодын амьдрал болоод амьтай салшгүй холбоотой гэж хүмүүст санагддаг учраас ихэнх

хүн өөрсдөд нь харагддаг, нүднийх нь өмнөх материаллаг зүйлсийг л мэддэг, хардаг. Гэвч сүнсний ертөнц, өөрөөр хэлбэл, нөгөө ертөнцийн бүх зүйлийн тухайд ихэнх хүн үүнд итгэдэггүй гэж хэлэхэд болно. Хүмүүс үүнийг харж чаддаггүй, сүнсний ертөнц нь материаллаг ертөнцөөс юугаараа тэс өөр болох талаар бүү хэл, үүнийг ойлгох, энэ талаар юу ч мэдэх хэрэггүй гэж боддогийн дээр Бурханы хувьд нээлттэй, харин хүмүүсийн хувьд нууцлаг, хаалттай байдаг учраас энэхүү ертөнцийн янз бүрийн талыг ойлгох замыг олоход хүмүүст маш хэцүү байдаг. Сүнсний ертөнцийн талаар Миний ярих гэж буй өөр өөр талууд бол зөвхөн Бурханы захиргаа, дээд эрхтэй хамаатай; Би ямар нэгэн нууцыг ил болгох гээгүй, мөн та нарын олж мэдэхийг хүсдэг нууцлаг зүйлээс алийг нь ч хэлж өгөх гээгүй. Энэ нь Бурханы дээд эрх, Бурханы захиргаа, Бурханы хангалттай хамаатай учраас Би та нарын мэдэх шаардлагатай хэсгийг л ярина.

Эхлээд Би та нараас нэг асуулт асууя: Та нарын бодлоор сүнсний ертөнц гэж юу вэ? Ерөнхийд нь хэлбэл энэ нь хүмүүсийн нүдэнд харагддаггүй, гарт баригддаггүй, материаллаг ертөнцийн гаднах ертөнц юм. Гэхдээ, та нар сүнсний ертөнцийг ямар ертөнц байх учиртай гэж төсөөлж байна вэ? Харж чадахгүй байгаагийн улмаас та нар энэ талаар бодож чадахгүй байж магад. Гэхдээ ямар нэг домог сонсохоороо та нар бодсоор л, энэ тухай бодохоо больж чаддаггүй. Би яагаад ингэж хэлж байна вэ? Хүүхэд байхад нь олон хүнд тохиолддог нэг ийм зүйл бий: Хий үзэгдэл, сүнсний талаар хэн нэг нь аймшгийн түүх ярихад тэд ухаан алдталаа айдаг. Яг яагаад тэд айдаг вэ? Учир нь тэд ийм зүйлийг төсөөлж байдаг; харж чадахгүй ч өрөөнийх нь хаа сайгүй, ямар нэг далд, харанхуй буланд тэдгээр нь байгаа санагдаж, маш их айсандаа унтаж ч зүрхэлдэггүй. Ялангуяа шөнө өрөөндөө ганцаараа байх, хашаандаа ганцаараа зориглон гарахаас дэндүү их айдаг. Энэ бол та нарын төсөөлдөг сүнсний ертөнц, хүмүүсийн аймшигтай гэж боддог ертөнц юм. Үнэн хэрэгтээ, хүн бүр үүнийг тодорхой хэмжээгээр төсөөлдөг, хүн бүр бага зэрэг мэдэрч чадна.

Сүнсний ертөнцийн талаар яриагаа эхэлье. Энэ юу вэ? Би та нарт энгийн бөгөөд товчхон тайлбарлаж өгье: Сүнсний ертөнц бол материаллаг ертөнцөөс өөр, чухал газар юм. Би яагаад үүнийг чухал гэж хэлж байна вэ? Бид энэ талаар дэлгэрэнгүй ярилцах болно. Сүнсний ертөнцийн оршин тогтнол нь хүн төрөлхтний материаллаг ертөнцтэй салшгүй холбоотой. Бүх зүйлийг захирах Бурханы ноёрхол дахь хүний амьдрал, үхлийн мөчлөгт энэ нь чухал үүрэг гүйцэтгэдэг; энэ бол сүнсний ертөнцийн үүрэг бөгөөд оршин тогтнол нь чухал байдгийн нэг шалтгаан юм. Энэ нь таван мэдрэхүйгээр ялган таних аргагүй газар учраас сүнсний ертөнц оршин байдаг эсэхийг хэн ч үнэн зөв магадалж чаддаггүй. Сүнсний ертөнцийн янз бүрийн хөдөлгөөн нь хүний оршин тогтнолтой нягт холбоотой байдгийн улмаас хүн төрөлхтний амьдралын дэг жаягт ч бас сүнсний ертөнц асар их нөлөөлдөг. Үүнд Бурханы дээд эрх хамаатай юу, үгүй юу? Хамаатай. Намайг ингэж хэлэхээр та нар яагаад энэ сэдвээр ярилцаж байгааг минь ойлгоно: Учир нь, Бурханы дээд эрхээс гадна, Түүний захиргаа үүнд хамаатай. Хүмүүст үл үзэгдэх ийм ертөнцийн бүх

тэнгэрлэг тушаал, зарлиг, захиргааны тогтолцоо нь материаллаг ертөнцийн аль ч улсын хууль, тогтолцооноос хавьгүй дээгүүр байдгийн дээр энэ ертөнцөд амьдардаг ямар ч зүйл эдгээрийг зөрчиж, халдаж зүрхлэхгүй. Энэ нь Бурханы дээд эрх, захиргаатай холбоотой юу? Сүнсний ертөнцөд тодорхой захиргааны зарлиг, тэнгэрлэг тушаал, хууль тогтоомж бий. Өөр өөр түвшин, янз бүрийн талбарт харгалзагч нар үүргээ чанд баримталж, дүрэм журмыг мөрддөг, учир нь тэд тэнгэрлэг тушаалыг зөрчихийн үр дагавар юу болохыг мэддэг; Бурхан хэрхэн мууг шийтгэж, сайныг шагнадаг, Тэр бүх зүйлийг хэрхэн удирдаж, захирдгийг тодорхой мэддэг. Түүнчлэн, Тэр тэнгэрлэг тушаал, хууль тогтоомжоо хэрхэн хэрэгжүүлдгийг тэд тодорхой хардаг. Эдгээр нь хүн төрөлхтний оршин суудаг материаллаг ертөнцөөс ялгаатай юу? Үнэндээ асар их ялгаатай. Сүнсний ертөнц нь материаллаг ертөнцөөс огт өөр ертөнц юм. Тэнгэрлэг тушаал, хууль тогтоомж байдаг болохоор Бурханы дээд эрх, захиргаа, мөн түүнчлэн Бурханы зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохтой энэ нь хамаатай. Та нар үүнийг сонсоод Миний хувьд энэ сэдвийн талаар ярих нэн шаардлагатай гэж бодохгүй байна уу? Та нар салшгүй нууцыг нь мэдмээргүй байна уу? (Тийм ээ, бид мэдмээр байна.) Сүнсний ертөнцийн ухагдахуун ийм билээ. Хэдийгээр энэ нь материаллаг ертөнцтэй зэрэгцэн оршиж, Бурханы захиргаа, дээд эрхэд нэгэн зэрэг захирагддаг ч энэ ертөнцийг захирдаг Бурханы захиргаа, дээд эрх нь материаллаг ертөнцийнхөөс хавьгүй хатуу чанд байдаг. Нарийн ширийний тухайд гэвэл, сүнсний ертөнц хүн төрөлхтний амьдрал, үхлийн мөчлөгийн ажлыг хэрхэн хариуцдагаас бид эхлэх хэрэгтэй, учир нь энэ бол сүнсний ертөнцийн оршихуйнуудын ажлын томоохон хэсэг юм.

Хүн төрөлхтөн дундаас бүх хүнийг Би гурван төрөлд ангилдаг. Эхнийх нь шашны итгэл үнэмшилгүй үл итгэгчид. Тэднийг үл итгэгчид гэж нэрлэдэг. Үл итгэгчдийн дийлэнх олонх нь мөнгөнд л итгэдэг; тэд өөрсдийнхөө ашиг сонирхлыг л хөөцөлддөг, эдийн шуналтай бөгөөд амьдрал, үхлийн мөчлөг, шүтээн, хий үзэгдлийн тухай ямар ч яриандитгэдэггүй, харин материаллаг ертөнцөд л итгэдэг. Би ийм хүмүүсийг үл итгэгчид гэж ангилдаг, тэд бол эхний төрлийн хүмүүс юм. Хоёр дахь төрөлд нь үл итгэгчдээс бусад итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүс багтдаг. Хүн төрөлхтөн дундаас эдгээр итгэл бишрэлтэй хүмүүсийг Би хэд хэдэн томоохон бүлэгт хуваадаг: Эхнийх нь Иудейн шашинтан, хоёр дахь нь Католик шашинтан, гурав дахь нь Христийн шашинтан, дөрөв дэх нь Лалын шашинтан, тавь дахь нь Буддын шашинтан гэсэн таван төрөл юм. Эдгээр нь итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүс юм. Гурав дахь төрөл нь Бурханд итгэдэг хүмүүс, үүнд та нар хамаарна. Ийм итгэгчид нь өнөөдөр Бурханыг дагадаг хүмүүс юм. Энэ хүмүүсийг Бурханы сонгосон хүмүүс болон үйлчлэл үзүүлэгчид гэх хоёр төрөлд хуваадаг. Эдгээр үндсэн төрлийг маш тодорхой ялгасан. Иймээс та нар одоо, бодол санаандаа хүмүүсийн төрөл, зэрэглэлийг хооронд нь тодорхой ялгаж чадна, тийм үү? Эхний төрөл нь үл итгэгчдээс бүрдэнэ, тэд юу болохыг Би хэлсэн. Тэнгэр Эцэгт итгэдэг

хүмүүсийг үл итгэгчид гэж тооцох уу? Олон үл итгэгч Тэнгэр Эцэгт л итгэдэг; тариа тарьж, ургац хураахдаа өөрсдийнх нь найддаг энэхүү оршихуй салхи, бороо, аянга гэх мэтийг бүгдийг нь удирддаг гэж тэд итгэдэг атлаа Бурханд итгэх итгэлийн талаар дурдмагц Түүнд итгэхийг хүсдэггүй. Үүнийг итгэл байгаа гэж нэрлэж болох уу? Ийм хүмүүс үл итгэгчдэд хамаарна. Үүнийг ойлгосон биз дээ? Эдгээр ангиллыг бүү андуур. Хоёр дахь төрөлд нь итгэл бишрэлтэй хүмүүс багтдаг, гурав дахь төрөл нь яг одоо Бурханыг дагаж байгаа хүмүүс юм. Тэгвэл Би яагаад бүх хүнийг эдгээр төрөлд хуваасан бэ? (Учир нь төрөл бүрийн хүмүүс өөр өөр төгсгөл, хүрэх газартай байдаг.) Энэ бол нэг тал нь. Өөр өөр яс үндэс, төрлийн энэ хүмүүс сүнсний ертөнцөд эргэн очихдоо өөр өөр газар луу явж, амьдрал, үхлийн мөчлөгийн өөр өөр хуульд захирагдана, тийм учраас Би хүмүүсийг эдгээр үндсэн төрөлд ангилсан юм.

а. Үл итгэгчдийн амьдрал, үхлийн мөчлөг

Үл итгэгчдийн амьдрал, үхлийн мөчлөгийг эхлээд авч үзье. Хүнийг үхсэнийх нь дараа сүнсний ертөнцийн харгалзагч авч явдаг. Хүний яг юуг нь авч явдаг вэ? Махан биеийг нь бус, сүнсийг нь авч явдаг. Сүнсийг нь авч явахад, дөнгөж нас барсан хүмүүсийн сүнсийг тусгайлан хүлээн авдаг газар болох сүнсний ертөнцийн товчоо хэмээх газарт очдог. Тэр нь үхсэнийхээ дараа хүний очдог эхний газар бөгөөд сүнсний хувьд энэ нь танил бус байдаг. Тэднийг энэ газарт аваачих үед албан тушаалтан эхний үзлэг хийж, нэр, хаяг, нас, бүх туршлагыг нь баталгаажуулдаг. Амьд байхдаа хийсэн бүхнийх нь талаар бүртгэл хөтөлж, үнэн зөвийг нь магадалдаг. Энэ бүгдийг шалгасны дараа тухайн хүний насан туршийн үйлдэл, зан авирыг үндэслэн шийтгэгдэх үү, хүний төрлийг дахин олох уу гэдгийг нь тодорхойлдог ба энэ нь эхний шат юм. Энэ эхний шат аймшигтай байна уу? Хүн харанхуй, үл таних газарт ирснээс өөр зүйл тохиогоогүй учраас энэ тийм ч аймшигтай биш.

Хоёр дахь шатанд, тухайн хүн насан туршдаа олон муу зүйл хийж, олон хорон муу үйл үйлдсэн бол үүнийгээ шийдүүлэхээр шийтгэлийн газарт хүргэгдэнэ. Тэр нь тусгайлан хүмүүсийг шийтгэхэд ашигладаг газар байх болно. Түүний хэрхэн шийтгэгдэхийн нарийн ширийн нь үйлдсэн нүгэл, мөн үхэхээсээ өмнө хэчнээн олон хорон муу зүйл хийснээс нь хамаардаг, энэ нь хоёр дахь шатанд тохиодог эхний нөхцөл байдал юм. Үхэхээсээ өмнө хийсэн муу зүйл, үйлдсэн ёрын муу үйлийнхээ улмаас шийтгэлийнхээ дараа дахин төрлийг олохдоо, материаллаг ертөнцөд дахин нэг удаа төрөхдөө, зарим нь хүн хэвээр үлдэж, зарим нь амьтад болдог. Өөрөөр хэлбэл, хүн сүнсний ертөнцөд эргэн очсоныхоо дараа, үйлдсэн ёрын муу үйлээсээ болж шийтгүүлдэг; түүнчлэн, хийсэн хорон муу зүйлээсээ болж дараа төрөлдөө хүн биш, амьтан болж магадгүй. Тэд үхэр, адуу, гахай, нохой зэрэг амьтад болж магад. Зарим хүн дахин төрөхдөө шувуу, нугас, галуу болж болно… Тэд амьтны төрлийг олж дахин төрснийхөө дараа дахин үхэхдээ сүнсний ертөнцөд эргэж ирнэ. Тэнд урьдын адилаар үхэхийнх нь өмнөх зан авирт үндэслэн хүний

төрлийг дахин олох эсэхийг нь сүнсний ертөнц шийднэ. Ихэнх хүн хэтэрхий их ёрын мууг үйлдэж, нүгэл нь дэндүү их байдаг учраас долоогоос арван хоёр удаа амьтны төрлийг олж төрдөг. Долоогоос арван хоёр удаа гэдэг аймшигтай бус уу? (Аймшигтай.) Та нарт юу нь аймшигтай байна вэ? Хүн, амьтан болно гэдэг аймшигтай. Хүний хувьд амьтан болохын хамгийн зовлонтой зүйл нь юу вэ? Хэл яриагүй, зөвхөн энгийн бодолтой, амьтдын хийж чадах зүйлсийг л хийж, амьтдын иддэгийг л идэж чаддаг байх, мөн амьтдын энгийн сэтгэлгээ, үйл хөдлөлтэй байж, босоогоороо явж чадахгүй, хүмүүстэй харилцаж чадахгүй байх бөгөөд хүмүүсийн зан авир, үйлдлийн аль нь ч амьтадтай огт хамааралгүй байдаг бодит үнэн юм. Өөрөөр хэлбэл, бүх зүйлийн дундаас амьтан байна гэдэг бүх амьд зүйлээс хамгийн дорд болж, хүн байхаас илүү их зовлон зүдүүр туулах болдог. Маш их мууг хийж, асар их нүгэл үйлдсэн хүмүүсийг шийтгэх сүнсний ертөнцийн шийтгэлийн нэг тал нь энэ юм. Шийтгэл хэр хүнд байх нь ямар төрлийн амьтан болохоос хамааран шийдэгддэг. Жишээ нь, гахай байх нь нохой байхаас дээр үү? Гахай нохойноос дээр амьдардаг уу, дор амьдардаг уу? Дор амьдардаг биз дээ? Хүмүүс үхэр, адуу болбол гахай байснаас дээр амьдрах уу, дор амьдрах уу? (Дээр амьдарна.) Хүн муур болж дахин төрснөөр илүү тухтай байх уу? Тэр адилхан л амьтан байх бөгөөд муур байх нь морь, үхэр байхаас хавьгүй илүү амар, учир нь муур ихэнх цагаа нойрмоглон залхуурч өнгөрүүлдэг. Үхэр, морь болбол илүү их хөдөлмөрлөдөг. Тиймээс хэрвээ хүн үхэр, адууны төрлийг олж төрвөл шаргуу ажиллах ёстой, энэ нь хатуу шийтгэлтэй адилхан. Нохой эзэнтэйгээ илүү ойр дотно харилцаатай байдаг тул нохой болох нь үхэр, морь болохоос арай дээр байх болно. Зарим нохойг хэдэн жил тэжээсний дараа эздийнхээ хэлдэг үгээс нэлээдийг ойлгож чаддаг. Заримдаа нохой эзнийхээ сэтгэл санааны байдал болон шаардлагад зохицож чаддаг, тэгээд эзэн нь нохойдоо илүү сайн хандаж, нохойгоо илүү сайн хооллож ундалж, өвдөх үед нь илүү сайн асардаг. Тэгэхээр нохой аз жаргалтай амьдардаг бус уу? Тиймээс нохой байна гэдэг нь үхэр, морь байснаас дээр. Үүгээр, хүний шийтгэлийн хатуу ширүүн байдал нь хэдэн удаа, ямар амьтны төрлийг олж төрөхийг нь тодорхойлдог.

Амьд байхдаа маш олон нүгэл үйлдсэнээсээ болоод зарим хүн долоогоос арван хоёр удаа амьтны төрлийг олж төрөхөөр шийтгүүлдэг. Хангалттай олон шийтгүүлээд сүнсний ертөнцөд эргэн очих үед нь түүнийг өөр газар луу, янз бүрийн сүнснүүд аль хэдийн шийтгүүлчхээд, хүний төрлийг олохоор бэлдэж байгаа төрлийн сүнснүүд байдаг газарт аваачдаг. Энэ газарт, ямар гэр бүлд төрөх, дахин төрөөд ямар үүрэг гүйцэтгэх гэх мэтийнх нь дагуу сүнс тус бүрийг төрөл болгон ангилдаг. Жишээ нь, зарим хүн энэ хорвоод ирээд дуучин болох учраас түүнийг дуучдын дунд оруулдаг; зарим нь энэ хорвоод ирээд бизнес эрхлэгч болох учраас түүнийг бизнес эрхлэгчдийн дунд оруулдаг; хэн нэгэн нь хүн болсныхоо дараа шинжлэх ухааны судлаач болох бол шинжлэх ухааны судлаачдын дунд оруулдаг. Тэднийг ангилсны дараа, яг л өнөөдөр хүмүүс э-мэйл илгээдэг шиг тус бүрийг нь

өөр өөр цаг, товлосон өдөрт илгээдэг. Үүгээр амьдрал, үхлийн нэг мөчлөг дуусна. Хүн сүнсний ертөнцөд ирсэн өдрөөс эхлээд шийтгэл нь дуусах хүртэл буюу олон удаа амьтны төрлийг олж төрөөд, хүний төрлийг олж төрөхөөр бэлдэх хүртэл энэхүү үйл явц нь бүрэн төгс болдог.

Шийтгэгдэж дуусаад дахин амьтан болж төрөхгүй хүмүүс даруй материаллаг ертөнц рүү илгээгдэж хүн болж төрөх үү? Эсвэл, тэд хүмүүсийн дунд ирэх хүртлээ хэр удах вэ? Ийм зүйл тохиолдож болох давтамж нь ямар байдаг вэ? Үүнд цаг хугацааны хязгаарлалт байдаг. Сүнсний ертөнцөд болдог бүх зүйл цаг хугацааны нарийн хязгаарлалт, дүрэмд захирагддаг, үүнийг Би тоогоор тайлбарлавал та нар ойлгоно. Богино хугацаанд дахин төрлийг олсон хүмүүсийн хувьд гэвэл үхэх үед нь дахин хүн болж төрөх бэлтгэлийг аль хэдийн хийсэн байна. Ийм зүйл болж болох хамгийн богино хугацаа нь гурван өдөр байдаг. Зарим хүнд энэ нь гурван сар, заримынх нь хувьд гурван жил, заримд нь гучин жил, заримд нь гурван зуун жил гэх мэт болдог. Тэгвэл энэхүү цаг хугацааны дүрмийн талаар юу хэлж болох вэ, нарийн ширийн нь юу вэ? Сүнснээс материаллаг ертөнц буюу хүний ертөнцийн шаарддаг зүйл, энэхүү ертөнцөд сүнсний гүйцэтгэх учиртай үүрэг дээр эдгээр нь үндэслэдэг. Хүний ертөнцөд эгэл хүмүүсийн хэрэгцээ маш их байдаг учраас хүмүүс ийм эгэл хүний төрлийг дахин олж төрөхдөө ихэнх нь маш хурдан төрлөө олж дахин төрдөг, иймээс тэд гурван өдрийн дараа, нас барахаасаа өмнө байсан гэр бүлээс огт өөр гэр бүлд дахин илгээгддэг. Гэхдээ энэ дэлхийд онцгой үүрэг гүйцэтгэдэг зарим хүн бий. “Онцгой” гэдэг нь хүний ертөнцөд ийм хүмүүсийн хэрэгцээ нэг их байдаггүй гэсэн үг юм; ийм үүрэг гүйцэтгэхэд олон хүн шаардлагагүй учир гурван зуун жил ч болж болно. Өөрөөр хэлбэл, энэхүү сүнс нь гурван зуун жилд, эсвэл бүр гурван мянган жилд л нэг удаа ирнэ. Яагаад тэр вэ? Гурван зуу, эсвэл гурван мянган жилийн турш тухайн үүрэг хүний ертөнцөд шаардагдахгүй гэх баримтаас үүдэн түүнийг сүнсний ертөнцийн хаа нэгтээ байлгадаг. Күнзийг жишээ болгон авч үзье: Тэрээр Хятадын уламжлалт соёлд гүн гүнзгий нөлөөлж, тэр ирснээр тухайн үеийн хүмүүсийн соёл, мэдлэг, уламжлал, үзэл санаанд гүнзгий нөлөө үзүүлсэн. Гэхдээ ийм хүн эрин бүрд шаардлагагүй учраас сүнсний ертөнцөд үлдэж, дахин төрөх хүртлээ гурван зуу, эсвэл гурван мянган жил хүлээх ёстой болсон. Хүний ертөнцөд иймэрхүү хүн шаардлагагүй учраас тэр зүгээр хүлээх хэрэгтэй болсон юм, учир нь түүнийх шиг үүрэг маш цөөн, түүнд хийх зүйл маш бага байсан. Тиймээс хүний ертөнцөд хэрэгтэй болонгуут нь илгээхээр түүнийг ихэнх хугацаанд сүнсний ертөнцийн хаа нэгтээ дэмий байлгах ёстой болсон. Ихэнх хүний дахин төрөх давтамжид зориулсан сүнсний ертөнцийн цаг хугацааны дүрэм ийм байдаг. Хүмүүс энгийн, эсвэл онцгой ч бай, төрлөө дахин олох явцыг нь боловсруулахад үйлчилдэг зохих дүрэм, зөв хэрэгжүүлэлт сүнсний ертөнцөд байдаг бөгөөд эдгээр дүрэм болон хэрэгжүүлэлтийг сүнсний ертөнцийн аливаа харгалзагч юм уу оршихуй шийдэж хянадаггүй, харин Бурхан илгээдэг. Одоо та нар үүнийг ойлгож байгаа биз дээ?

Ямар ч сүнсний хувьд, дахин төрөх, энэ амьдралд ямар үүрэгтэй байх, ямар гэр бүлд төрөх, амьдрал нь ямар байх вэ гэдэг нь урьд төрөлтэй нь нягт холбоотой. Бүх төрлийн хүмүүс хүний ертөнцөд ирдэг бөгөөд гүйцэтгэх үүрэг, биелүүлэх даалгавар нь өөр өөр байдаг. Тэдгээр нь ямар үүрэг даалгавар байдаг вэ? Зарим хүн өрөө төлөхөөр ирдэг: Хэрвээ тэд урьд төрөлдөө бусдад дэндүү их хэмжээний мөнгөний өртэй байсан бол энэ төрөлдөө тэд өрөө төлөхөөр ирдэг. Гэтэл зарим хүн өрөө авахаар ирсэн байдаг: Тэр урьд төрөлдөө дэндүү их зүйл, дэндүү их хөрөнгө мөнгө залилуулсан байдаг; тийм болохоор сүнсний ертөнцөд ирснийх нь дараа тэдэнд шударга хандаж, энэ төрөлдөө өрөө авахыг нь зөвшөөрдөг. Зарим хүн ач хариулахаар ирсэн байдаг: Өмнөх амьдралд нь, өөрөөр хэлбэл урьд төрөлд нь тэдэнд хэн нэгэн сайн ханддаг байсан бөгөөд энэ төрөлд дахин төрөх маш сайхан боломж олдсон учраас тэд ачийг нь хариулахаар дахин төрдөг. Харин нөгөө хэсэг нь хүмүүсийн амийг авахаар энэ амьдралд дахин төрсөн байдаг. Тэгээд тэд хэний амийг авдаг вэ? Урьд төрөлд нь өөрийг нь хөнөөсөн хүмүүсийн амийг авдаг. Дүгнэж хэлбэл, хүн бүрийн одоогийн амьдрал урьд төрөлтэй нь бат, салшгүй холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, хүн бүрийн одоогийн амьдралд урьд төрөл нь асар их нөлөөлдөг. Жишээ нь, Жан нас барахынхаа өмнө Лигээс их хэмжээний мөнгө луйвардсан байж. Тэгвэл Жан, Лид өртэй юу? Өртэй, тэгэхээр Ли, Жангаас өрөө авах ёстой гэдэг нь зүй ёсны зүйл үү? Ийм болохоор нас барсных нь дараа тэдний хооронд төлөх учиртай өр үлддэг. Тэд дахин төрлийг олж, Жан хүн болох үед Ли өрөө хэрхэн авах вэ? Нэг арга зам нь Ли, Жангийн хүү болж дахин төрөх юм; Жан их мөнгө олж, дараа нь Ли түүнийг нь үрэн таран хийнэ. Жан хэчнээн их мөнгө оллоо ч хүү Ли нь үрэн таран хийж байдаг. Жан хэчнээн ч их мөнгө оллоо гэсэн хэзээ ч хүрэлцэхгүй; харин хүү нь яагаад ч юм бэ, янз бүрийн арга замаар эцгийнхээ мөнгийг дандаа үрж дуусгана. Жан “Яагаад миний энэ хүү үргэлж азгүй явдал авчирч байдаг юм бэ? Яагаад хүний хөвгүүд ийм сайхан биеэ авч явдаг юм бэ? Яагаад манай хүү ямар ч хүсэл эрмэлзэлгүй, ийм арчаагүй, ямар ч мөнгө олох чадваргүй байна вэ, яагаад би түүнийг байнга тэжээх ёстой юм бэ? Би түүнийг тэжээх ёстой юм хойно тэжээнэ ээ, гэхдээ хэчнээн их мөнгө өгсөн ч яагаад үргэлж хангалтгүй байдаг юм бэ? Яагаад тэр минь шударгаар хөдөлмөрлөж чадахгүй, харин биеэ оторлож, идэж ууж, завхайрч, мөрий тавих зэргийг хийдэг юм бэ? Юу л болоод байна даа?” хэмээн гайхшаа барна. Жан дараа нь “Би урьд төрөлдөө түүнд өртэй байсан байж болох юм. За яах вэ, өрөө барагдуулъя! Намайг өрөө төлж дуустал энэ дуусахгүй!” хэмээн хэсэг зуур бодно. Ли өрөө суутган авч дуусах өдөр ирж, тавин нас хүрээд гэнэтхэн сэхээ орж “Би амьдралынхаа эхний тэн хагаст нэг ч сайн зүйл хийсэнгүй! Эцгийнхээ олсон бүх мөнгийг үрэн таран хийлээ, тиймээс би сайн хүн болж эхлэх ёстой! Би өөрийгөө хатуужуулна; шударга, зөв зохистой амьдрагч нэгэн болж, эцэгтээ дахин хэзээ ч зовлон шаналал авчрахгүй!” хэмээн ухаарах өдөр ирж болно. Яагаад тэр ингэж бодов? Яагаад тэр гэнэт сайн тал руугаа өөрчлөгдөв? Үүнд шалтгаан байна уу? Шалтгаан нь юу вэ? (Учир нь Ли өрөө авсан;

Жан өрөө төлсөн.) Үүнд шалтгаан, үр дагавар байдаг. Энэ түүх тэр хоёрын энэ амьдралаас нь өмнө аль эрт эхэлсэн; тэдний урьд төрлийн амьдралын энэхүү түүх өнөөг хүртэл үргэлжилсэн бөгөөд хэн нь ч хэнийгээ буруутгаж чадахгүй. Жан хүүдээ юу ч гэж сургасан, хүү нь хэзээ ч сонсоогүй, хэзээ ч шударгаар хөдөлмөрлөж үзээгүй. Гэтэл өр барагдсан өдөр хүүгээ сургамжлах ямар ч шаардлага байгаагүй, хүү нь аяндаа ойлгосон. Энэ бол энгийн жишээ. Ийм жишээ өөр олон байдаг уу? (Тийм ээ, байдаг.) Энэ нь хүмүүст юуг хэлж байна вэ? (Сайн байж, ёрын мууг үйлдэх ёсгүй гэдгийг.) Тэд ёрын мууг хийх ёсгүй, муу үйлд цээрлүүлэлт байх болно гэдгийг хэлж байна! Ихэнх үл итгэгч маш их мууг үйлддэг, тэгээд муу үйл нь цээрлүүлэлт хүртдэг, зөв үү? Гэвч ийм цээрлүүлэлт тохиолдлынх байдаг уу? Үйлдэл болгонд цээрлүүлэлтийнх нь ард үндэслэл, шалтгаан байдаг. Чи хүнээс мөнгө залилчхаад зүгээр өнгөрнө гэж боддог уу? Тэрхүү мөнгийг луйвардаж авсны дараа чи ямар ч үр дагавартай нүүр тулахгүй гэж боддог уу? Ингэх боломжгүй; үнэхээр үр дагавар байх болно! Тэд хэн байх, Бурхан байдаг гэдэгт итгэдэг, үгүй нь хамаагүй, хувь хүн бүр үйлдэлдээ хариуцлага хүлээж, хийсэн үйлдлийнхээ үр дагаврыг үүрэх ёстой. Энэхүү энгийн жишээний тухайд Жан шийтгүүлж, Лигийн өр төлөгдсөн нь шударга бус уу? Хүмүүс иймэрхүү зүйл хийх үед ийм л үр дүн гардаг. Энэ нь сүнсний ертөнцийн захиргаатай салшгүй холбоотой юм. Бурханд итгэдэггүй үл итгэгч байсан ч гэсэн оршин тогтнол нь иймэрхүү тэнгэрлэг тушаал, зарлигт захирагддаг. Хэн ч үүнээс зайлж чадахгүй, мөн хэн ч энэ бодит байдлаас зайлсхийж чадахгүй.

Хүнд харагддаг бүхэн оршдог, харин харж болдоггүй юм бүхэн буюу хүмүүсээс маш холын зүйл оршин байдаггүй гэж итгэл бишрэлгүй хүмүүс дандаа итгэдэг. Тэд “амьдрал, үхлийн мөчлөг”, “шийтгэл” гэж байдаггүй гэдэгт итгэхийг илүүд үздэг учраас эрээ цээргүй нүгэл үйлдэж, мууг хийдэг. Үүний дараа тэд шийтгүүлж, эсвэл амьтны төрлийг олж төрдөг. Үл итгэгчдийн дундаас янз бүрийн хүмүүсийн ихэнх нь энэхүү аюулт тойрог руу унадаг. Тэд сүнсний ертөнц бүх амьд зүйлийг захирах захиргаандаа хатуу чанд байдгийг мэддэггүй учраас тэр юм. Чи итгэдэг ч бай, үгүй ч бай энэхүү бодит үнэн орших л болно, учир нь ганц ч хүн, эсвэл зүйл Бурханы нүдээрээ ажигладаг зүйлийн цар хүрээнээс зугтаж, Бурханы тэнгэрлэг тушаал, зарлигийн дүрэм, хязгаарлалтаас зугтаж чадахгүй. Тэгэхээр Бурханд итгэх эсэхээс үл хамааран нүгэл үйлдэж, мууг хийх чинь зөвшөөрөхийн аргагүй бөгөөд бүхий л үйлдэл үр дагавартай гэдгийг энэхүү энгийн жишээ хүн бүхэнд хэлж өгдөг. Хэн нэгэн өөр нэгний мөнгийг луйвардвал шийтгүүлдэг бөгөөд тэрхүү шийтгэл нь шударга юм. Иймэрхүү түгээмэл үзэгддэг зан авирыг сүнсний ертөнцөд шийтгэдэг, тэрхүү шийтгэлийг Бурханы зарлиг, тэнгэрлэг тушаалаар биелүүлдэг. Иймээс хүчин, тонуул, залилах, хууран мэхлэх, хулгай, дээрэм, хүн алах, галдан шатаах гэх мэт аймшигт гэмт хэрэг, хорон муу үйлдэл нь хүнд хөнгөний хувьд янз бүр, маш олон шийтгэлд улам бүр өртдөг. Хүнд хөнгөн нь янз бүр эдгээр шийтгэлд юу багтдаг вэ? Зарим нь цаг хугацаагаар хатуу чангын түвшнийг тогтоодог бол, зарим нь өөр

өөр аргачлалаар үүнийг тогтоодог; гэвч зарим нь дараагийн төрлөө олох үедээ хүмүүсийн хаашаа явахыг нь шийдсэнээр тогтоодог. Жишээ нь зарим хүн бүдүүлэг үг яриатай байдаг. “Бүдүүлэг яриатай” гэж юуг хэлдэг вэ? Энэ нь бусдыг байнга харааж загнадаг, хорон үгээр бусдыг харааж зүхдэг гэсэн үг юм. Хорон үг хэл юуг илтгэн харуулдаг вэ? Энэ нь тэр хүн хорон санаатай гэдгийг илтгэдэг. Бусдыг харааж зүхсэн бүдүүлэг үг хэл тийм хүмүүсийн амнаас байнга гардаг бөгөөд ийм хорон үг хэл нь ноцтой үр дагавар авчирдаг. Ийм хүмүүс үхээд тохирох шийтгэлээ хүртсэний дараа хэлгүй болж дахин төрж болно. Зарим хүн амьд байхдаа маш тооцоотой, бусдыг байнга завшдаг, бяцхан явуулгаа нэн сайн төлөвлөдөг, хүмүүст маш их хор хохирол учруулдаг. Тэд дахин төрөхдөө ухаан муутай, оюуны хомсдолтой нэгэн болж болох юм. Зарим хүн бусдын хувийн амьдрал руу үргэлж өнгийдөг; нүд нь харах ёсгүй хувийн нууцыг харж, мэдэх учиргүй зүйл ихийг мэддэг. Тиймээс дахин төрөхдөө тэд сохор болж магадгүй. Зарим хүн амьд байхдаа маш овсгоо сүйхээтэй байдаг; байнга тэмцэлдэж, муу зүйл их хийдэг. Үүний улмаас дахин төрөхдөө эрэмдэг зэрэмдэг, доголон, гаргүй төрж магадгүй; эсвэл тэд дахин төрөхдөө бөгтөр, гилжгий болох юм уу хазганаж явдаг, эсвэл нэг хөл нь нөгөөгөөсөө богино гэх мэт болж ч магадгүй. Ийнхүү амьд байхдаа үйлдсэн ёрын муугийнх нь хэмжээнд үндэслэн тэдэнд янз бүрийн шийтгэл оноодог. Зарим хүн яагаад хялар байдаг гэж та нар бодож байна? Ийм хүмүүс их байдаг уу? Өнөө үед олон байдаг болсон. Зарим хүн урьд төрөлдөө нүдээ хэт их хэрэглэж, дэндүү олон муу зүйл хийсэн байдаг учир энэ төрөлдөө хялар нүдтэй болж төрдөг, ноцтой тохиолдолд сохор ч байдаг. Энэ бол цээрлүүлэлт билээ! Зарим хүн нас барахаасаа өмнө бусадтай сайхан харьцдаг; тэд төрөл садан, найз нөхөд, хамт ажиллагсад, өөрсөдтэй нь холбоотой хүмүүст олон сайн зүйл хийдэг. Тэд бусдад буян үйлдэж, асарч халамжилж, санхүүгийн дэмжлэг үзүүлж, хүмүүс тэднийг маш өндрөөр үнэлдэг. Ийм хүмүүс сүнсний ертөнцөд эргэн ирэхдээ шийтгүүлдэггүй. Үл итгэгч ямар нэг байдлаар шийтгүүлэхгүй байна гэдэг бол маш сайн хүн байсан гэсэн үг юм. Бурханы оршин тогтнолд итгэхийн оронд тэд зөвхөн Тэнгэр Эцэгт итгэдэг. Ийм хүн өөрийнх нь хийж байгаа бүхнийг дээрээс хардаг сүнс байдаг гэж л итгэдэг—түүний итгэдэг зүйл ердөө л энэ. Үр дүнд нь, энэ хүн биеэ хавьгүй дээр авч явдаг. Ийм хүмүүс сайхан сэтгэлтэй, өглөгч байдгийн дээр эцэстээ сүнсний ертөнцөд эргэж очиход нь тэдэнд маш сайн хандаж, тэд удалгүй дахин төрлийг олж төрнө. Тэд дахин төрөхдөө ямар айлд ирэх вэ? Энэхүү айл нь хэдий баян биш ч зовлон шаналалгүй, гэр бүлийн гишүүд нь хоорондоо эвтэй найртай байна; энэхүү дахин төрлийг олсон хүмүүс энд амар амгалан, жаргалтай өдрүүдийг өнгөрөөж, хүн бүр баяр хөөртэй, сайхан амьдарна. Энэ хүмүүс насанд хүрээд өнөр өтгөн гэр бүлтэй болж, хүүхдүүд нь авьяастай, амжилттай байж, гэр бүл нь аз жаргалтай байна, ийм төгсгөл энэ хүмүүсийн урьд төрөлтэй асар их холбоотой. Өөрөөр хэлбэл, хүн үхээд дахин төрлийг олохдоо хаашаа явах, эрэгтэй, эмэгтэй байх эсэх, үүрэг даалгавар нь юу байх, амьдралдаа юу туулах, ямар бүтэлгүйтэл туулж, ямар ерөөл хүртэх,

хэнтэй уулзах, түүнд юу тохиолдох гээд эдгээр зүйлийг хэн ч урьдчилан хэлж, үүнээс зайлсхийж, эсвэл нуугдаж чадахгүй. Өөрөөр хэлбэл, амьдралыг чинь тодорхойлсны дараа чамд юу ч тохиолдсон, чи үүнээс зайлсхийхийг хэчнээн хичээж, ямар ч аргаар оролдсон байсан, сүнсний ертөнцөд чамд зориулж Бурханы төлөвлөсөн амьдралын замналыг зөрчих ямар ч аргагүй. Учир нь, чамайг дахин төрлийг олоход амьдралын чинь хувь заяа аль хэдийн тогтоогдсон байдаг. Сайн ч бай, муу ч бай хүн бүр үүнийг хүлээн зөвшөөрч, урагшаа ахисаар байх ёстой. Энэ хорвоод амьдардаг хэн ч энэ асуудлаас зайлсхийж чадахгүй, үүнээс илүү бодитой асуудал гэж үгүй. Миний хэлж байсан бүхнийг та бүгд ойлгосон, тийм үү?

Ийм зүйлийг ойлгосон болохоор, үл итгэгчдийн амьдрал, үхлийн мөчлөгийг Бурхан маш нарийн, хатуу хянаж, захирдаг гэдгийг та нар одоо харж байна уу? Эхлээд, Бурхан сүнсний ертөнцөд олон төрлийн тэнгэрлэг тушаал, зарлиг, тогтолцоо бий болгосон бөгөөд эдгээрийг тунхагласны дараа сүнсний ертөнцөд янз бүрийн албан тушаалын оршихуйнууд, Бурханы тогтоосны дагуу тэдгээрийг маш чанд мөрддөг, хэн ч үүнийг зөрчиж зүрхэлдэггүй. Иймээс хүний ертөнц дэх хүн төрөлхтний амьдрал, үхлийн мөчлөгт амьтны, эсвэл хүний төрлийн алийг нь ч хүн олсон бай, хоёуланд нь хууль дүрэм бий. Эдгээр хууль дүрэм Бурханаас ирдэг учир хэн ч зөрчиж зүрхэлдэггүй, зөрчиж ч чадахгүй. Бурханы энэхүү дээд эрхийн улмаас, мөн ийм хууль дүрэм байдаг учраас л хүмүүсийн хардаг материаллаг ертөнц нэгэн жигд, эмх цэгцтэй байдаг; Бурханы энэхүү дээд эрхийн улмаас л хүн төрөлхтөн өөрсдөд нь огт үл үзэгдэх өөр ертөнцтэй амар тайван зэрэгцэн оршиж, зохицон амьдарч чаддаг—энэ бүгд нь Бурханы дээд эрхээс салгахын аргагүй юм. Хүний махан биеийн амь үхсэний дараа сүнс нь амьд хэвээр байдаг учраас хэрвээ Бурханы захиргаа байдаггүй байсан бол юу болох байсан бэ? Сүнс нь хаа сайгүй хэрэн тэнүүчилж, энд тэндгүй үймүүлж, хүний ертөнц дэх амьд зүйлсийг хүртэл хорлох байсан юм. Ийм хор хохирол зөвхөн хүн төрөлхтөнд төдийгүй, мөн ургамал, амьтанд ч учрах байсан, гэвч хамгийн түрүүнд хүмүүс хорлогдох байлаа. Ийм зүйл болсон бол, ийм сүнс захиргаагүй байж, хүнийг үнэхээр хорлож, үнэхээр хорон муу зүйл хийсэн бол, сүнсний ертөнцөд авбал зохих арга хэмжээг энэхүү сүнсэнд мөн авах байв. Хэрвээ асуудал ноцтой байвал тэрхүү сүнс удалгүй оршин тогтнохоо больж, устгагдах болно. Хэрвээ боломжтой бол хаа нэг газар байрлуулж, дараа нь дахин төрлийг олуулах байв. Өөрөөр хэлбэл, янз бүрийн сүнсийг захирах сүнсний ертөнцийн захиргаа дэг журамтай байдаг, үе шат, дүрэм журмын дагуу хэрэгждэг. Тийм захиргаа байдаг учраас л хүн төрөлхтний материаллаг ертөнц эмх замбараагүй байдалд ороогүй бөгөөд материаллаг ертөнцийн хүмүүс хэвийн сэтгэхүй, хэвийн эрүүл ухаантай, махан биеийн дэг журамтай амьдралтай байдаг. Хүн төрөлхтөн ийм хэвийн амьдралтай байсны дараа л махан биед амьдардаг хүмүүс үеэс үед хөгжиж, өсөн үржсээр байж чадна.

Та нар дөнгөж сая сонссон үгийн талаар юу гэж бодож байна вэ? Эдгээр нь та нарт шинэ зүйл үү? Нөхөрлөлийн өнөөдрийн сэдэв та нарт ямар сэтгэгдэл

төрүүлсэн бэ? Шинэлэг байдлаас нь өөр зүйл мэдэрч байна уу? (Хүмүүс биеэ зөв авч явах хэрэгтэй бөгөөд Бурхан агуу агаад Түүнийг хүндэтгэх ёстой гэдгийг бид харж болно.) (Бурхан янз бүрийн хүмүүсийн төгсгөлийг хэрхэн зохицуулдаг талаар Бурханы яриаг дөнгөж сая сонсоод нэг талаар, Бурханы зан чанар халдахыг тэвчдэггүй; би Түүнийг хүндэтгэх ёстой гэж надад санагдаж байна; нөгөө талаар, Бурхан ямар хүмүүст дуртай, ямарт нь дургүй байдгийг мэддэг болсон учраас би Бурханы дуртай хүмүүсийн нэг болохыг хүсэж байна.) Энэ тал дээр Бурхан үйлдэлдээ зарчимч байдгийг та нар харж байна уу? Тэр ямар зарчмаар үйлддэг вэ? (Тэрээр хийдэг бүхнээс нь хамаарч хүмүүсийн төгсгөлийг тогтоодог.) Энэ бол бидний дөнгөж сая ярилцсан үл итгэгчдийн янз бүрийн төгсгөлийн тухай юм. Үл итгэгчдийн тухайд, Бурханы үйлдлийн цаад зарчмуудын нэг нь сайныг шагнаж, мууг шийтгэх мөн үү? Өөр ангид зүйл байдаг уу? (Үгүй.) Бурханы үйлдлийн цаана зарчим байдгийг та нар харж байна уу? Үл итгэгчид үнэндээ Бурханд итгэдэггүй, Бурханы зохион байгуулалтад ч бас дуулгавартай захирагддаггүй. Түүнчлэн тэд Бурханы дээд эрхийг мэддэггүй, тэр ч бүү хэл, Түүнийг хүлээн зөвшөөрдөггүй. Үүнээс ч ноцтой нь тэд Бурханыг гутаан доромжилж, Түүнийг хараан зүхэж, Бурханд итгэдэг хүмүүст дайсагнадаг. Тэд Бурханд ингэж ханддаг хэдий ч тэднийг захирах Бурханы захиргаа зарчмаасаа хазайдаггүй; Тэр Өөрийн зарчим, зан чанарын дагуу тэднийг эмх цэгцтэй захирдаг. Тэдний дайсагналыг Тэр юу гэж үздэг вэ? Мэдлэггүй байдал гэж үздэг! Иймээс Тэр энэ хүмүүсийг, өөрөөр хэлбэл үл итгэгчдийн дийлэнх олонхыг өнгөрсөнд амьтан болж төрөхөд хүргэсэн. Тэгэхээр Бурханы нүдээр бол үл итгэгчид гэж яг юу вэ? Тэд бүгд адгуус амьтан. Бурхан адгуус амьтан болон хүн төрөлхтний аль алиныг нь захирдгийн дээр ийм хүмүүст Тэр адил зарчмаар ханддаг. Энэ хүмүүсийг захирах Түүний захиргаанаас хүртэл Түүний зан чанарыг харж болдгийн адил бүх зүйлийг ноёрхох Түүний ноёрхлын цаад хуулийг ч харж болно. Иймээс Миний дөнгөж сая дурдсан үл итгэгчдийг захирдаг Түүний зарчмаас Бурханы дээд эрхийг та нар харж байна уу? Бурханы зөвт зан чанарыг харж байна уу? (Харж байна.) Өөрөөр хэлбэл, Бурхан бүх зүйлээс алинтай нь ч харьцсан байсан, Өөрийн зарчим, зан чанарын дагуу үйлддэг. Энэ бол Бурханы мөн чанар; ийм хүмүүсийг адгуус амьтан гэж үздэг байлаа гээд Тэр Өөрийн тогтоосон зарлиг, тэнгэрлэг тушаалыг хэзээ ч тоомжиргүй зөрчихгүй. Бурхан өчүүхэн ч болчимгүй үйлдэл хийхгүй, зарчмын дагуу үйлддэг, Түүний үйлдлүүдэд ямар ч хүчин зүйл огт нөлөөлдөггүй. Түүний хийдэг бүхэн Өөрийнх нь зарчмыг баримталдаг. Учир нь, Бурханд Бурханы Өөрийнх нь мөн чанар байдаг; ямар ч бүтээгдсэн зүйлд байдаггүй Түүний мөн чанарын нэг тал нь энэ юм. Бурхан Өөрийн бүтээсэн бүх зүйлийн дундаас юм, хүн, амьд зүйл бүртэй харьцаж, хандаж, удирдаж, эрхэлж, захирахдаа махруу, хариуцлагатай байдаг бөгөөд Тэр үүнд хэзээ ч хайхрамжгүй байгаагүй. Сайн хүмүүст Тэр нигүүлсэнгүй, сайхан ханддаг; хорон муу хүмүүст Тэр энэрэлгүй шийтгэл ноогдуулдаг; Тэр, өөр өөр цаг үед, хүний ертөнцийн өөр өөр шаардлагын дагуу, янз бүрийн амьд зүйлд, цаг тухайд нь, тохирох зохицуулалтыг

тогтмол хийдэг, тэгснээр энэхүү янз бүрийн амьд зүйл, гүйцэтгэх үүргийнхээ дагуу, эмх цэгцтэйгээр дахин төрлийг олж, материаллаг ертөнц болон сүнсний ертөнцийн хооронд системтэйгээр шилждэг.

Амьд зүйлсийн үхэл буюу бие махбодын амь төгсөх нь амьд зүйл, материаллаг ертөнцөөс сүнсний ертөнц рүү одсоныг илтгэдэг бол, шинэ бие махбодын амь төрөх нь амьд зүйл сүнсний ертөнцөөс материаллаг ертөнцөд ирж, үүргээ хүлээн авч, гүйцэтгэж эхэлснийг илтгэдэг. Оршихуйн явах ч бай, ирэх ч бай, аль аль нь сүнсний ертөнцийн ажилтай салшгүй холбоотой. Хүн материаллаг ертөнцөд ирэх үед түүний очих гэр бүл, төрөх эрин үе, ирэх цаг, гүйцэтгэх үүрэгт нь тохирох зохицуулалт, тодорхойлолтыг Бурхан сүнсний ертөнцөд аль хэдийн бий болгосон байдаг. Иймээс энэ хүний бүхий л амьдрал—түүний хийдэг зүйлс, сонгодог зам—сүнсний ертөнцөд хийсэн зохицуулалтын дагуу өчүүхэн ч хазайлгүйгээр явагддаг. Түүнчлэн, бие махбодын амь төгсөх цаг, төгсөх байдал, газар сүнсний ертөнцөд тодорхой, ойлгомжтой байдаг. Бурхан материаллаг ертөнцийг, мөн сүнсний ертөнцийг захирдаг, Тэр сүнсний амьдрал, үхлийн хэвийн мөчлөгийг саатуулахгүй, мөн тэрхүү мөчлөгийн зохицуулалтад ямар ч алдаа гаргаж чадахгүй. Сүнсний ертөнцийн албан тушаалд байгаа харгалзагчид дор бүрнээ Бурханы заавар, дүрэм журмын дагуу өөрсдийн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, хийх ёстой зүйлээ хийдэг. Иймээс хүн төрөлхтний ертөнцөд хүний харж буй материаллаг үзэгдэл болгон дэг журамтай, эмх цэгцтэй байдаг. Энэ бүхэн нь Бурхан бүх зүйлийг эмх цэгцтэй захирдаг, мөн түүнчлэн Түүний эрх мэдэл бүх зүйлийг захирдаг гэсэн бодит үнэнээс болдог бөгөөд Түүний ноёрхолд хүний амьдардаг материаллаг ертөнц, түүнчлэн хүн төрөлхтний цаана байгаа үл үзэгдэх сүнсний ертөнц багтдаг. Иймээс хэрвээ хүмүүс сайхан амьдралтай байхыг хүсэж, сайхан орчинд амьдарна гэж найдаж байвал нүдэнд харагддаг бүхий л материаллаг ертөнцөөр хангагдахаас гадна хэний ч харж чадахгүй, хүн төрөлхтний өмнөөс бүх амьд зүйлийг захирч, эмх цэгцтэй байдаг сүнсний ертөнцөөр мөн хангагдах ёстой. Тиймээс Бурхан бүх зүйлийн амийн эх сурвалж гэж хэлсэн болохоор бид “бүх зүйлийн” талаарх мэдлэг, ойлголтоо нэмсэн бус уу? (Тийм шүү.)

б. Итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүсийн амьдрал, үхлийн мөчлөг

Бид үл итгэгчид хэмээх нэг дэх төрлийн хүмүүсийн амьдрал, үхлийн мөчлөгийн талаар сая хэлэлцлээ. Одоо, хоёр дахь төрөл болох итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүсийн талаар ярилцацгаая. “Итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүсийн амьдрал, үхлийн мөчлөг” нь бас нэг маш чухал сэдэв бөгөөд та нар үүний талаар зарим нэг ойлголттой болох нь нэн чухал юм. Эхлээд, “итгэл бишрэлтэй хүмүүс” гэдгийн “итгэл бишрэл” гэдэг нь ямар итгэл бишрэлийг хэлж байгааг бүгдээрээ ярилцъя: Иудейн шашин, Христийн шашин, Католик шашин, Лалын шашин, Буддын шашин гэсэн таван томоохон шашин байдаг. Үл итгэгчдээс гадна энэ таван шашинд итгэдэг хүмүүс дэлхийн хүн амын томоохон хэсгийг эзэлдэг. Энэ таван шашин

дундаас өөрсдийн итгэлийг ажил мэргэжлээ болгосон хүмүүс цөөн хэдий ч эдгээр шашин олон дагагчидтай. Тэдгээр нь нас барахдаа өөр газар луу явна. Хэнээс “өөр” гэж? Үл итгэгчид буюу бидний дөнгөж сая ярьж байсан итгэл бишрэлгүй хүмүүсээс. Энэ таван шашны итгэгчид нас барсныхаа дараа өөр тийшээ, үл итгэгчдийнхээс өөр газар луу явдаг. Гэхдээ үйл явц нь адилхан; үхэхээсээ өмнө хийсэн бүхэнд нь үндэслэн сүнсний ертөнц адилхан л тэднийг шүүх болно, дараа нь тэднийг зохих ёсоор боловсруулна. Гэхдээ энэ хүмүүсийг боловсруулахын тулд яагаад өөр байршил руу явуулдаг юм бэ? Үүнд нэг чухал шалтгаан бий. Тэр нь юу вэ? Би жишээгээр үүнийг та нарт тайлбарлая. Гэхдээ Намайг тайлбарлахаас өмнө та нар дотроо: “Магадгүй тэдний Бурханд итгэх итгэл нь бага учраас тэр байх! Тэд огт итгэдэггүй хүмүүс биш” хэмээн бодож байгаа байх. Гэвч энэ бол шалтгаан нь биш. Тэднийг бусдаас тусад нь байлгадагт тун чухал шалтгаан бий.

Жишээ нь, Буддын шашныг аваад үзье. Би та нарт нэг баримт хэлье. Буддын шашинтан бол юуны өмнө, Буддын шашинд орсон хүн, өөрийнх нь итгэл юу болохыг мэддэг хүн юм. Буддын шашинтан үсээ авч, лам эсвэл гэлэнмаа болдог нь өөрийгөө шашны бус ертөнцөөс тусгаарлаж, хүний ертөнцийн дуу шуугианыг ардаа орхисон гэсэн үг юм. Тэд өдөр бүр ном хурж, бурхдын нэрсийг уянгалуулан уншиж, зөвхөн ногоон хоол идэж, даяанч амьдралаар амьдарч, зулын зэвүүн, бүдэг гэрэлд л өдөр хоногоо өнгөрөөдөг. Тэд бүх насаа ингэж өнгөрөөдөг. Буддын шашинтны бие махбодынх нь амь дуусах үед амьдралдаа дүгнэлт хийх боловч үхсэнийхээ дараа хаашаа явах, хэнтэй уулзах, ямар үр дүнд хүрэхээ зүрх сэтгэлдээ мэдэхгүй: Зүрх сэтгэлийнх нь гүнд ийм зүйлсийн талаар тодорхой төсөөлөл байхгүй. Бүхий л амьдралынхаа туршид нэг төрлийн итгэл бишрэлийг сохроор тээхээс өөр зүйл хийхгүй байсны эцэст харалган хүсэл, туйлын зорилготойгоо хүний ертөнцөөс явдаг. Амьдын ертөнцийг орхиход Буддын шашинтны бие махбодын амь ингэж төгсдөг; үүний дараа сүнсний ертөнцөд анх байсан байрандаа буцдаг. Энэ хүн газар дээр эргэн ирэхээр дахин төрлийг олж, өөрийгөө үргэлжлүүлэн боловсруулах эсэх нь нас барахынх нь өмнөх зан авир, хэрэгжүүлэлтээс нь хамаардаг. Хэрвээ амьдарч байх хугацаандаа ямар ч буруу зүйл хийгээгүй бол дахин төрлийг хурдан олж, газар луу дахин илгээгдэж, дахин нэгэнтээ лам, эсвэл хандмаа болно. Өөрөөр хэлбэл, эхний удаад өөрийгөө хэрхэн боловсруулж байсны дагуу бие махбодын амьдралын явцад өөрийгөө боловсруулсны дараа бие махбодын амьдрал нь дуусахад сүнсний ертөнц рүү эргэн ирээд шалгуулдаг. Үүний дараа, хэрвээ ямар ч асуудал байхгүй бол, хүний ертөнцөд дахин нэг удаа эргэн ирж, дахин нэг удаа Буддын шашинд орж, ийнхүү хэрэгжүүлэлтээ үргэлжлүүлдэг. Гурваас долоон удаа дахин төрлийг олсны дараа тэр, бие махбодын амь дуусах бүрд очдог сүнсний ертөнц рүү дахин нэг удаа буцна. Хэрвээ хүний ертөнц дэх янз бүрийн чадвар, зан авир нь сүнсний ертөнцийн тэнгэрлэг тушаалтай нийцэж байвал тэр мөчөөс эхлэн тэд тэндээ үлдэнэ; тэд цаашид дахин хүний төрлийг олж төрөхгүй, бас газар дээрх муу үйлийнхээ төлөө

шийтгүүлэх ямар ч эрсдэл үгүй болно. Тэд энэ үйл явцыг дахин хэзээ ч туулахгүй. Харин ч нөхцөл байдлаасаа хамаарч сүнсний ертөнцөд албан тушаал олж авна. Энэ бол Буддын шашинтнуудын “гэгээрэлд хүрэх” гэж хэлдэг зүйл юм. Гэгээрэлд хүрэх гэдэг нь үндсэндээ сүнсний ертөнцөд албан тушаалтан болох зам мөрд хүрч, цаашид дахин төрлийг олохоо болих, шийтгүүлэх эрсдэлгүй болох гэсэн үг юм. Түүнчлэн, дахин төрлийг олсны дараа хүн байхын зовлон шаналлыг цаашид амсахгүй гэсэн үг билээ. Тэгвэл амьтны төрлийг олох боломж бас бий юу? (Үгүй.) Тэд сүнсний ертөнцөд үүрэг хүлээхээр үлдэж, дахин төрлийг олохоо болино гэсэн үг юм. Энэ бол Буддын шашинд байдаг гэгээрлийн зам мөрд хүрэх тухай нэг жишээ юм. Зам мөрд хүрээгүй хүмүүсийн тухайд гэвэл, сүнсний ертөнц рүү эргэн ирэхэд нь тэднийг холбогдох албан тушаалтан шалгаж, магадлаад амьд байхдаа Буддын шашинд зааснаар хичээнгүйлэн өөрийгөө боловсруулаагүй, мэрийн ном хурж, бурхдын нэрийг уянгалуулан уншаагүй, харин ч олон ёрын муу үйл үйлдэж, ихээхэн хорон муу авир гаргасныг нь олж мэддэг. Тэгээд сүнсний ертөнцөд тэдний муу үйлийг шүүгээд, дараа нь заавал шийтгэдэг. Хэн ч үүнээс ангид бус. Тийм болохоор ийм хүн хэзээ зам мөрд хүрч чадах вэ? Тэд амьдралдаа ямар ч ёрын мууг хийгээгүй үед, сүнсний ертөнцөд эргэж ирснийх нь дараа үхэхээсээ өмнө ямар ч буруу зүйл хийгээгүй гэдэг нь харагдах үед. Тэд тэгээд үргэлжлүүлэн дахин төрлийг олж үргэлжлүүлэн ном хурж, бурхдын нэрийг уянгалуулан уншиж, зулын хүйтэн, бүдэг гэрэлд өдөр хоногоо өнгөрүүлж, аливаа амьд зүйлийг хөнөөх, мах идэхийг тэвчдэг. Тэд хүний ертөнцийн хэрэг явдалд оролцолгүй, төвөг бэрхшээлийг ардаа хол орхиж, бусадтай маргалдаж мэтгэлцдэггүй. Энэ үйл явцын үеэр хэрвээ тэд ёрын мууг үйлдээгүй бол, сүнсний ертөнц рүү буцаж ирээд, бүх үйлдэл, зан авираа шалгуулсныхаа дараа гурваас долоон удаа үргэлжилдэг мөчлөгөөр хүний ертөнц рүү дахин нэг удаа илгээгддэг. Хэрвээ энэ хугацаанд ямар ч буруу зүйл хийгээгүй бол гэгээрэлд хүрэхэд нь нөлөөлж, саад болохгүй. Энэ бол итгэл бишрэлтэй бүх хүний амьдрал, үхлийн мөчлөгийн онцлог юм: Тэд “зам мөрд хүрч”, сүнсний ертөнцөд албан тушаалтай болж чаддаг; тэднийг үл итгэгчдээс ялгадаг зүйл нь энэ юм. Юуны өмнө, сүнсний ертөнцөд албан тушаал олж авч чаддаг хүмүүс газар дээр амьд байхдаа биеэ хэрхэн авч явдаг вэ? Тэд ямар ч ёрын мууг огт үйлдэхгүй байх ёстой: Тэд хүн алж, галдан шатааж, хүчиндэж, дээрэм хийх ёсгүй; хэрвээ тэд залилан, мэхэлж, хулгай, дээрэм үйлдвэл зам мөрд хүрч чадахгүй. Өөрөөр хэлбэл, хэрвээ тэд муу үйлтэй ямар нэгэн байдлаар холбогдох буюу хамсаатан болбол сүнсний ертөнцийн оноодог шийтгэлээс зайлж чадахгүй. Сүнсний ертөнц нь гэгээрсэн Буддын шашинтнуудад тохирох зохицуулалтыг хийдэг: Тэд Буддын шашин болон Тэнгэр Эцэгт итгэдэг хүмүүсийг удирдахаар томилогдож магадгүй, тэдэнд хамаарах газар нутаг хуваарилж өгч магадгүй. Тэд бас зөвхөн үл итгэгчдийг л хариуцдаг, маш бага үүрэгтэй албан тушаалтай болж ч болох юм. Ийм хуваарилалт сүснийх нь янз бүрийн уг чанараас хамаардаг. Энэ бол Буддын шашны жишээ юм.

Бидний ярилцсан таван шашнаас Христийн шашин хавьгүй онцгой. Христийн шашин юугаараа онцгой вэ? Тэд бол жинхэнэ Бурханд итгэдэг хүмүүс юм. Жинхэнэ Бурханд итгэдэг хүмүүсийг энд яахан жагсааж болох юм бэ? Христийн шашин нь итгэл бишрэлийн нэг төрөл гэж хэлбэл, ямар ч маргаангүйгээр итгэл бишрэлтэй л холбоотой; ердөө л нэг төрлийн зан үйл, нэг төрлийн шашин бөгөөд Бурханыг жинхэнээсээ дагадаг хүмүүсийн итгэл бишрэлээс огт өөр зүйл байх байсан. Би, Христийн шашныг таван том шашны дунд жагсаасны шалтгаан нь Христийн шашин нь Иудейн шашин, Буддын шашин, Лалын шашинтай адил түвшинд очих хүртлээ доройтсон. Энд байгаа ихэнх хүн Бурхан байдаг, Тэр бүх зүйлийг захирдаг гэдэгт итгэдэггүй; Түүний оршин тогтнолд бүр ч итгэдэггүй. Үүний оронд тэд шашны номлолын талаар ярилцахдаа, Судар ашигладаг төдий бөгөөд шашны номлол ашиглан сайхан сэтгэлтэй байж, зовлонг тэвчиж, сайн үйл хий гэж хүмүүст сургадаг. Христийн шашин ийм л шашин болсон: Зөвхөн шашны номлолын онолд анхаарч, хүнийг удирдаж, аврах Бурханы ажилтай огтхон ч холбоогүй болсон. Бурханыг дагадаг боловч үнэндээ Бурханд хүлээн зөвшөөрөгдөөгүй хүмүүсийн шашин болсон юм. Гэвч ийм хүмүүст хандах Өөрийн гэсэн зарчим Бурханд бас бий. Тэр тэдэнтэй үл итгэгчидтэй харьцдаг шиг хүссэнээрээ, хааш яаш зохицуулж, харьцдаггүй. Тэр Буддын шашинтнуудад ханддаг шигээ л тэдэнд ханддаг: Хэрвээ Христэд итгэгч амьд байхдаа өөрөө сахилга баттай байж, Арван Тушаалыг чанд сахиж, хууль болон тушаалуудын дагуу зан авиртаа шаардлага тавьж, насан туршдаа тэрийгээ баримталж чадвал тэд мөн адил хугацааг амьдрал, үхлийн мөчлөг туулахад зарцуулж байж л “өргөгдөх” гэгчид үнэхээр хүрч чадна. Ийнхүү өргөгдсөний дараа сүнсний ертөнцөд үлдэж, нэг албан тушаалд очиж, ажилтнуудын нэг болдог. Үүний нэгэн адил, хэрвээ тэд газар дээр ёрын мууг үйлдвэл, хэрвээ тэд дэндүү нүгэлтэй агаад хэтэрхий их нүгэл үйлдвэл, тэд хүнд хөнгөн янз бүрийн хэмжээгээр шийтгүүлж, сахилгажуулагдах нь зайлшгүй. Буддын шашинд зам мөрд хүрэх гэдэг нь Диваажингийн ариун газарт очих гэсэн үг байдаг бол Христийн шашинд үүнийг юу гэж нэрлэдэг вэ? Үүнийг “тэнгэрт орох”, “өргөгдөх” гэж нэрлэдэг. Үнэхээр өргөгдсөн хүмүүс мөн л амьдрал, үхлийн мөчлөгийг гурваас долоон удаа туулсныхаа дараа нас барахаараа нойрсож буй мэт сүнсний ертөнцөд ирдэг. Хэрвээ тэд стандартад нийцэж байвал албан тушаал олж аван үлдэж болно, газар дээрх хүмүүсээс ялгаатай нь тэд энгийн байдлаар, тогтсон журмын дагуу дахин төрлийг олохгүй.

Энэ бүх шашин дундаас тэдний ярьдаг, хүрэхийг эрмэлздэг төгсгөл нь Буддын шашны зам мөрд хүрэхтэй адил; ердөө л энэхүү “зам мөрд” өөр өөр аргаар хүрдэг. Тэд бүгд нэгэн адил. Зан авиртаа шашны сургаалыг чанд дагаж мөрддөг, эдгээр шашны энэ хэсэг дагагчдыг Бурхан тохиромжтой хүрэх газар, очих газраар хангаж, тэднийг зохих ёсоор зохицуулдаг. Энэ бүгд нь үндэслэлтэй боловч хүмүүсийн төсөөлдөг шиг биш. Одоо Христийн шашны хүмүүст юу тохиолддогийг сонсоод та нарт ямар санагдаж байна вэ? Тэдний золгүй нөхцөл байдал шударга бус санагдаж байна уу? Тэднийг өрөвдөж байна уу? (Бага зэрэг.) Үүнийг яах ч аргагүй; тэд өөрсдөө

л үүнд буруутай. Би яагаад ингэж хэлж байна вэ? Бурханы ажил бол жинхэнэ; Тэр бол амьд, бодитой, Түүний ажил бүх хүн төрөлхтөн, хувь хүн бүрд чиглэж байдаг. Тэгвэл яагаад тэд үүнийг хүлээн зөвшөөрдөггүй юм бэ? Яагаад тэд Бурханыг улайран эсэргүүцэж, хавчдаг вэ? Тэд ядаж л ийм төгсгөлтэй байгаагаа азтайд тооцох хэрэгтэй, тиймээс яагаад та нар тэдний төлөө харамсана вэ? Тэднийг ийм маягаар зохицуулах нь маш их хүлээцтэй байдлыг харуулдаг. Бурханыг ямар их эсэргүүцдэгийг нь бодож үзвэл тэднийг устгах ёстой хэдий ч Бурхан тэгдэггүй; харин Тэр Христийн шашныг бусад ердийн шашнуудтай л адил зохицуулдаг. Тиймээс бусад шашны тухай нарийвчлан ярих хэрэг байна уу? Энэ бүх шашны үзэл санаа нь, хүмүүсийг илүү их зовлон зүдүүр амсаж, мууг үйлдэхгүй, сайн үйл хийж, бусдыг харааж зүхэхгүй, бусдыг шүүмжлэхгүй, хэрүүл маргаанаас зайлсхийж, сайн хүмүүс болохын төлөө юм—ихэнх шашны сургаал иймэрхүү байдаг. Тиймээс, итгэл бишрэлтэй энэ хүмүүс, янз бүрийн шашин, урсгалын энэхүү дагагчид, шашныхаа сургаалыг чанд баримталж чадвал газар дээр байх хугацаандаа том алдаа гаргаж, нүгэл үйлдэхгүй; гурваас долоон удаа дараа төрлийг олсныхоо дараа шашны сургаалыг чанд баримталж чаддаг энэ хүмүүс ерөнхийдөө сүнсний ертөнцөд албан тушаалтай болж үлдэнэ. Ийм хүн олон байдаг уу? (Үгүй, олон биш.) Та нар хариултаа юунд үндэслэж байна вэ? Сайныг хийж, шашны дүрэм журам, хууль баримтлах амаргүй. Буддын шашин хүмүүст мах идэхийг зөвшөөрдөггүй—чи тэгж чадах байсан уу? Хэрвээ саарал өмсгөл өмсөж, Буддын шашны хийдэд бүхэл өдөржингөө ном хурж, бурхдын нэрийг уянгалуулан унших хэрэгтэй болбол чи тэгж чадах байсан уу? Энэ тийм ч амархан байхгүй байсан. Христийн шашинд Арван Тушаал, бусад тушаал, хууль байдаг; тэдгээрийг мөрдөхөд хялбар уу? Хялбар биш, тийм биз дээ? Жишээлбэл, бусдыг харааж зүхэхгүй байхыг аваад үзье: Хүмүүс зүгээр л энэ дүрэм журмыг баримтлах чадваргүй байдаг. Тэд биеэ барьж чадалгүй харааж зүхдэг, харааснихаа дараа үгээ буцааж болохгүй болохоор юу хийдэг вэ? Шөнөдөө тэд нүглээ улайдаг. Заримдаа бусдыг харааж зүхсэнийхээ дараа ч зүрх сэтгэлд нь үзэн ядалт байсаар байдаг бөгөөд бүр цаашлаад тэр хүмүүст улам их хор хүргэх цагаа хүртэл төлөвлөдөг. Товчоор хэлбэл, энэхүү үхмэл хоосон сургаал дунд амьдардаг хүмүүсийн хувьд нүгэл хийхгүй, мууг үйлдэхгүй байх нь амар биш. Тиймээс шашин бүрд маш цөөн тооны хүмүүс л үнэндээ зам мөрд хүрч чаддаг. Эдгээр шашныг маш олон хүн дагадаг учраас нэлээд олон хүн сүнсний ертөнцөд үүрэг хүлээхээр үлдэж чадна гэж чи боддог уу? Тийм ч олон байдаггүй; үнэндээ цөөн тооны хүн л үүнд хүрч чаддаг. Итгэл бишрэлтэй хүмүүсийн амьдрал, үхлийн мөчлөг, ерөнхийдөө ийм л байдаг. Тэд зам мөрд хүрч чаддагаараа ялгардаг, тэдний үл итгэгчдээс ялгарах зүйл нь энэ билээ.

в. Бурханыг дагагчдын амьдрал, үхлийн мөчлөг

Одоо, Бурханыг дагадаг хүмүүсийн амьдрал, үхлийн мөчлөгийн талаар ярилцацгаая. Энэ нь та нарт хамаатай учир анхаарал хандуулаарай: Эхлээд,

Бурханыг дагагчдыг хэрхэн ангилж болох талаар бод. (Бурханы сонгосон хүмүүс болон үйлчлэл үзүүлэгчид.) Бурханы сонгосон хүмүүс болон үйлчлэл үзүүлэгчид гэсэн хоёр төрөл үнэхээр байдаг. Эхлээд, бид цөөхөн байдаг Бурханы сонгосон хүмүүсийн талаар ярилцацгаая. “Бурханы сонгосон хүмүүс” гэж хэнийг хэлдэг вэ? Бурхан бүх зүйлийг бүтээж, хүн төрөлхтөн бий болсны дараа Өөрийг нь дагах бүлэг хүнийг сонгосон; тэднийг зүгээр л “Бурханы сонгосон хүмүүс” гэж нэрлэдэг. Бурхан энэ хүмүүсийг сонгосонд онцгой цар хүрээ, ач холбогдол байсан. Түүнийг чухал ажил хийх үед нь ирэх ёстой шилмэл цөөн хэдэн хүнээр хязгаарлагддаг тул цар хүрээ нь онцгой юм. Тэгвэл ач холбогдол нь юу вэ? Тэд Бурханы сонгосон бүлэг байсан болохоор ач холбогдол нь асар их юм. Өөрөөр хэлбэл, Бурхан энэ хүмүүсийг бүрэн гүйцэд, төгс болгохыг хүсдэг бөгөөд удирдлагын ажил нь дуусмагц Тэр энэ хүмүүсийг олж авна. Энэхүү ач холбогдол нь асар их бус уу? Иймээс энэ сонгогдсон хүмүүс Бурханд асар чухал, учир нь тэд бол Бурханы олж авахаар зорьдог хүмүүс билээ. Харин үйлчлэл үзүүлэгчдийн тухайд гэвэл, Бурханы урьдчилан тогтоодог тухай сэдвийг түр орхиод, тэдний гарал үүслээс эхэлж ярья. “Үйлчлэл үзүүлэгч” гэдэг нь чухамдаа үйлчилдэг нэгэн юм. Үйлчилдэг хүмүүс түр зуурынх байдаг; тэд урт хугацаагаар, эсвэл үүрд үйлчилдэггүй, харин тэднийг түр хөлсөлж, элсүүлдэг. Тэдний ихэнх нь анх үл итгэгчдийн дундаас сонгогдсон байдаг. Тэд газар дээр ирэхдээ Бурханы ажилд үйлчлэл үзүүлэгчийн үүрэг хүлээх тушаалтай байдаг. Тэд урьд төрөлдөө амьтан байсан байж болох боловч бас үл итгэгчид байсан байж болно. Үйлчлэл үзүүлэгчдийн гарал үүсэл ийм билээ.

Бурханы сонгосон хүмүүсийн талаар цааш нь ярья. Тэд үхэхдээ үл итгэгчид, итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүсээс огт өөр газар очдог. Энэ нь, тэнгэр элч нар, Бурханы элч нар тэднийг дагалддаг газар; Бурханы биечлэн удирддаг газар юм. Бурханы сонгосон хүмүүс энэ газарт Бурханыг нүдээрээ харж чадахгүй ч гэсэн энэ бол сүнсний ертөнцийн өөр хаана ч байдаггүй газар; энэ хэсэг хүний нас барсныхаа дараа очдог газар нь энэ юм. Нас барахдаа тэд ч бас Бурханы элч нарын хатуу чанд байцаалтад ордог. Тэгээд юуг нь байцаадаг вэ? Бурханд итгэж амьдарсан амьдралынхаа туршид энэ хүмүүсийн туулсан зам, энэ хугацаанд хэзээ нэгэн цагт тэд Бурханыг эсэргүүцэж, Түүнийг харааж байсан эсэх, аймшигт нүгэл, ёрын мууг үйлдсэн эсэхийг нь Бурханы элч нар шалгаж байцаадаг. Энэ байцаалтаар тухайн хүн явах уу, эсвэл үлдэх үү гэдгийг шийддэг. “Явах” гэж юуг хэлдэг вэ? “Үлдэх” гэж юуг хэлдэг вэ? “Явах” гэдэг нь зан авирт нь үндэслэн Бурханы сонгосон хүмүүс дунд үлдээх эсэх гэсэн үг юм; “үлдэж” болно гэдэг нь тэд эцсийн өдрүүдэд Бурханы бүрэн төгс болгох хүмүүсийн дунд үлдэж чадна гэсэн үг юм. Үлдэж байгаа хүмүүст зориулсан онцгой зохицуулалт Бурханд байдаг. Өөрийн ажлын үе бүрийн туршид Бурхан, элчийн үүрэг гүйцэтгэх, чуулгануудыг сэргээх, харж хандах ажил хийлгэхээр ийм хүмүүсийг илгээнэ. Гэвч ийм ажил хийх чадвартай хүмүүс нь үеийн үед эргэн төрдөг үл итгэгчид шиг дахин төрлийг байнга олдоггүй; харин тэднийг Бурханы ажлын хэрэгцээ, алхмуудаас хамаарч газар руу буцаадаг бөгөөд тэд

дахин төрлийг байнга олдоггүй. Тэгэхээр тэд хэзээ дахин төрлийг олох тухайд ямар нэгэн дүрэм байдаг уу? Тэд хэдэн жилд нэг удаа ирдэг үү? Тэд ийм давтамжтайгаар ирдэг үү? Тэгдэггүй. Энэ бүгд нь Бурханы ажил, Түүний ажлын үе шат, Түүний хэрэгцээнд үндэслэдгийн дээр тогтсон дүрэм байдаггүй. Цорын ганц дүрэм нь Бурхан эцсийн өдрүүдэд Өөрийн ажлын сүүлчийн үе шатыг хийх үед энэ сонгогдсон хүмүүс бүгд ирнэ, ийнхүү ирэхдээ тэд сүүлчийн удаа дахин төрлийг олох болно. Яагаад тэр вэ? Энэ нь Бурханы ажлын сүүлчийн үе шатанд хүрэх үр дүнд үндэслэдэг—учир нь ажлын энэхүү сүүлчийн үе шатанд Бурхан энэ сонгосон хүмүүсийг бүрэн төгс болгоно. Энэ нь юу гэсэн үг вэ? Хэрвээ энэхүү сүүлчийн үе шатанд энэ хүмүүс бүрэн, төгс болгуулбал урьдынх шигээ дахин төрлийг олохгүй; хүн байх үйл явц нь бүрэн дуусаж, дахин төрлийг олох үйл явц нь ч мөн адил дуусна. Энэ нь үлдэх хүмүүст хамаатай. Тэгвэл үлдэж чадахгүй хүмүүс хаашаа явдаг вэ? Үлдэж болохгүй хүмүүст очвол зохих газар байдаг. Юуны түрүүнд, муу үйл, хийсэн алдаа, үйлдсэн нүглийнхээ улмаас тэд ч бас шийтгүүлнэ. Шийтгүүлснийх нь дараа, Бурхан нөхцөл байдалд тааруулан тэднийг үл итгэгчдийн дунд илгээхээр зохицуулалт хийнэ, эсвэл итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүсийн дунд очуулахаар зохицуулна. Өөрөөр хэлбэл, тэдэнд боломжит хоёр үр дүн бий: Нэг нь, магадгүй шийтгүүлж дахин төрлийг олсныхоо дараа магадгүй тодорхой нэг шашны дунд амьдрах, нөгөө нь, үл итгэгч болох юм. Хэрвээ тэд үл итгэгч болбол бүх боломжоо алдана; харин итгэл бишрэлтэй хүн болбол—жишээ нь, Христэд итгэгч болбол—Бурханы сонгосон хүмүүсийн эгнээнд эргэн орох боломж байсаар байна; үүнд маш нарийн төвөгтэй харилцаа байдаг. Товчхондоо, хэрвээ Бурханы сонгосон хүмүүс Бурханыг гомдоох ямар нэг зүйл хийвэл бусад хүмүүсийн нэгэн адил шийтгүүлнэ. Жишээлбэл, бидний өмнө нь ярьж байсан Паулыг аваад үзье. Паул бол шийтгүүлдэг хүний жишээ юм. Та нар Миний юу яриад байгааг ойлгож байна уу? Бурханы сонгосон хүмүүсийн цар хүрээ тогтсон байдаг уу? (Ихэнхдээ тийм.) Ихэнх нь тогтсон байдаг боловч багахан хэсэг нь тогтоогүй байдаг. Яагаад тэр вэ? Энд Би хамгийн ойлгомжтой шалтгаан буюу мууг үйлдэх талаар хэлсэн. Хүмүүс мууг үйлдэхэд Бурхан тэднийг хүсдэггүй, Бурхан тэднийг хүсэхгүй байх үедээ янз бүрийн үндэстний, олон төрлийн хүмүүсийн дунд хаядаг. Энэ нь тэднийг итгэл найдваргүй болгож, эргэж ирэхэд бэрх болгодог. Энэ бүхэн нь Бурханы сонгосон хүмүүсийн амьдрал, үхлийн мөчлөгтэй холбоотой.

Энэхүү дараагийн сэдэв нь үйлчлэл үзүүлэгчдийн амьдрал, үхлийн мөчлөгтэй холбоотой. Бид дөнгөж сая үйлчлэл үзүүлэгчдийн гарал үүслийн талаар; өөрөөр хэлбэл урьд төрөлдөө үл итгэгч, амьтан байсныхаа дараа дахин төрлийг олсон бодит үнэний талаар ярьсан. Ажлын сүүлчийн үе шат ирэхэд Бурхан үл итгэгчдээс ийм бүлэг хүнийг сонгосон, энэ бол онцгой бүлэг билээ. Энэ хүмүүсийг сонгосон Бурханы зорилго нь Өөрийнхөө ажилд үйлчлүүлэх явдал юм. “Үйлчлэл” гэдэг нь нэг их гоё сонсогддог үг биш, хүн бүрийн хүсэлд ч нийцдэггүй боловч энэ нь хэнд чиглэдгийг бид харах хэрэгтэй. Бурханы үйлчлэл үзүүлэгчийн оршин тогтнол

онцгой ач холбогдолтой. Тэднийг Бурхан сонгосон учраас өөр хэн ч тэдний үүргийг гүйцэтгэж чадахгүй. Эдгээр үйлчлэл үзүүлэгчийн үүрэг юу вэ? Бурханы сонгосон хүмүүст үйлчлэх юм. Ихэнхдээ тэд Бурханы ажилд үйлчилж, хамтран ажиллаж, сонгосон хүмүүсээ бүрэн төгс болгоход нь Бурханд туслах үүрэгтэй. Хөдөлмөрлөж, ажлын зарим нэг талыг хэрэгжүүлж, тодорхой даалгавар биелүүлж байгаа эсэхээс үл хамааран эдгээр үйлчлэл үзүүлэгчид тавьдаг Бурханы шаардлага юу вэ? Тэдэнд тавьдаг шаардлагадаа Тэр хэт хатуу байдаг уу? (Үгүй, Бурхан тэднээс үнэнч байхыг л шаарддаг.) Үйлчлэл үзүүлэгчид ч бас үнэнч байх ёстой. Чиний гарал үүсэл, эсвэл Бурхан яагаад чамайг сонгосноос үл хамааран, чи Бурханд, Бурханы чамд өгсөн даалгаварт, түүнчлэн хариуцсан ажилдаа, гүйцэтгэдэг үүрэгтээ үнэнч байх ёстой. Үнэнч байж, Бурханыг сэтгэл хангалуун байлгах чадвартай үйлчлэл үзүүлэгчдийн хувьд үр дүн нь ямар байх вэ? Тэд үлдэж чадна. Үйлчлэл үзүүлэгчийн хувьд үлдэх нь ерөөл мөн үү? Үлдэх гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэхүү ерөөлийн ач холбогдол нь юу вэ? Байр сууриараа, тэд Бурханы сонгосон хүмүүстэй адилгүй юм шиг; өөр юм шиг санагддаг. Гэвч үнэндээ, энэ төрөлдөө тэдний эдэлдэг зүйлс нь Бурханы сонгосон хүмүүсийнхтэй адил бус уу? Ядаж л энэ төрөлдөө адилхан. Та нар үүнийг үгүйсгэхгүй биз дээ? Бурханы айлдвар, Бурханы нигүүлсэл, Бурханы хангалт, Бурханы ерөөлийг эдэлдэггүй хэн байна вэ? Хүн бүр ийм элбэг дэлбэг байдлыг эдэлдэг. Үйлчлэл үзүүлэгчийн ялгамж чанар бол үйлчлэл үзүүлдэг хүн, харин Бурханы хувьд тэд бол ердөө л Түүний бүтээсэн бүх зүйлийн нэг; зүгээр л тэд үйлчлэл үзүүлэгчийн үүрэгтэй юм. Хоёулаа л Бурханы бүтээл болохын хувьд, үйлчлэл үзүүлэгч болон Бурханы сонгосон хүмүүсийн хооронд ялгаа байдаг уу? Үнэндээ байдаггүй. Нэрийн хувьд ялгаатай; мөн чанар болон гүйцэтгэх үүргийн хувьд ялгаатай боловч Бурхан энэ бүлэг хүнд шударга бус ханддаггүй. Тэгвэл яагаад энэ хүмүүсийг үйлчлэл үзүүлэгчид гэж тодорхойлдог вэ? Та нар энэ талаар зарим нэг ойлголттой болох ёстой! Үйлчлэл үзүүлэгчид үл итгэгчдийн дундаас гардаг. Тэднийг үл итгэгчдийн дундаас гардаг гэж дурдангуут тэд ижилхэн муу гарал үүсэлтэй нь илэрхий байдаг: Тэд бүгд бурхангүй үзэлтнүүд бөгөөд өмнө нь ч бас тийм байсан; тэд Бурханд итгэдэггүй, Бурханд, үнэнд, бүх эерэг зүйлд дайсагнадаг байсан. Тэд Бурханд, Түүний оршин тогтнолд итгэдэггүй байсан. Тэгэхээр тэд Бурханы үгийг ойлгох чадвартай юу? Тэд бараг л ойлгох чадваргүй гэж хэлж болно. Амьтад хүний үгийг ойлгох чадваргүй байдгийн адилаар үйлчлэл үзүүлэгчид Бурханы юу хэлж байгаа, Түүний шаардлага юу болох, яагаад Тэр ийм шаардлага тавьдгийг ойлгож чаддаггүй. Тэд ойлгодоггүй, ийм зүйлс тэдэнд ойлгомжгүй байх бөгөөд тэд гэгээрээгүй хэвээр үлддэг. Энэ шалтгааны улмаас бидний ярьсан шиг амь энэ хүмүүст байдаггүй. Амьгүйгээр хүмүүс үнэнийг ойлгож чадах уу? Тэд үнэнээр зэвсэглэдэг үү? Тэдэнд Бурханы үгийн туршлага, мэдлэг байдаг уу? (Үгүй.) Үйлчлэл үзүүлэгчдийн гарал үүсэл ийм билээ. Гэхдээ Бурхан энэ хүмүүсийг үйлчлэл үзүүлэгчид болгодог тул тэдэнд тавих Түүний шаардлагад стандарт байсаар байдаг; Тэр тэднийг дорд үздэггүй, бас тэдэнд хайхрамжгүй

ханддаггүй. Хэдийгээр тэд Түүний үгийг ойлгодоггүй, амь байхгүй боловч Бурхан тэдэнд сайхан ханддаг, тэдэнд тавих Түүний шаардлагад стандарт байсаар байдаг. Бурханд үнэнч байж, Түүний хэлснийг хийх гэсэн эдгээр стандартын талаар та нар дөнгөж сая ярьсан. Чи үйлчлэл хийхдээ хэрэгтэй газар нь эцсээ хүртэл үйлчлэх ёстой. Хэрвээ чи үнэнч үйлчлэл үзүүлэгч байж, бүр эцсээ хүртэл үйлчилж, чамд Бурханы даалгасан даалгаврыг биелүүлж чадвал үнэ цэнтэй амьдралаар амьдарна. Ингэж чадвал чи үлдэж чадна. Хэрвээ чи арай илүү хичээл зүтгэл гаргаж, арай илүү чармайж, Бурханыг мэдэх хүчин чармайлтаа нэмэгдүүлж чаддаг, Бурханыг мэдэх тухай бага ч гэсэн ярьж чаддаг бол, Бурханд гэрчлэл хийж чадвал, түүнчлэн Бурханы хүслээс зарим зүйлийг ойлгож, Бурханы ажилд хамтран ажиллаж, Бурханы санаа зорилгод бага ч гэсэн санаа тавьж чадвал үйлчлэл үзүүлэгч хэмээх чиний хувь тавилан өөрчлөгдөнө. Тэгээд энэхүү хувь тавилангийн өөрчлөлт нь юу байх вэ? Чи зүгээр нэг үлдэж чадахаа болино. Биеэ авч яваа байдал, хувийн хүсэл тэмүүлэл, эрэлхийлэлд чинь үндэслэн Бурхан чамайг сонгогдсон хүмүүсийн нэг болгоно. Хувь тавилангийн чинь өөрчлөлт энэ байх болно. Үйлчлэл үзүүлэгчдийн хувьд үүнээс хамгийн сайхан зүйл нь юу вэ? Бурханы сонгосон хүмүүсийн нэг болж чадах нь юм. Хэрвээ тэд ингэвэл үл итгэгчид шиг дахиж амьтны төрлийг олохгүй гэсэн үг юм. Энэ нь сайн зүйл үү? Тийм ээ, энэ бас сайн мэдээ: Энэ нь үйлчлэл үзүүлэгчийг төлөвшүүлж болно гэсэн үг юм. Үйлчлэл үзүүлэгчийн хувьд, Бурхан түүгээр үйлчлүүлэхээр урьдчилан тогтоомогц тэр мөнхөд үйлчилнэ гэсэн үг биш; заавал ийм байх албагүй. Энэ хүний хувь хүнийх нь биеэ авч явах байдалд нь тааруулан Бурхан түүнийг зохицуулж, хариу өгнө.

Гэхдээ, эцсийг нь хүртэл үйлчилж чаддаггүй үйлчлэл үзүүлэгчид байдаг; үйлчлэх хугацаандаа замын дундаас бууж өгч, Бурханыг хаядаг хүмүүс, мөн түүнчлэн олон муу зүйл хийдэг хүмүүс байдаг. Тэр ч бүү хэл, Бурханы ажилд асар их хор, хохирол учруулдаг хүмүүс, Бурханыг хараадаг үйлчлэл үзүүлэгчид хүртэл байдаг. Эдгээр засахын аргагүй үр дагавар нь юуг илтгэж байна вэ? Аливаа иймэрхүү муу үйл нь тэдний үйлчлэл эцэс болсныг илтгэнэ. Үйлчлэлийн хугацаанд биеэ авч явах байдал чинь хэтэрхий муу байсан, хэрээ мэдэхгүй даварсан учраас Бурхан үйлчлэлийг чинь шаардлага хангаагүй гэж үзвэл үйлчлэх эрхийг чинь хасна. Тэр үйлчлэхийг чинь зөвшөөрөхөө болино; Тэр чамайг нүднийхээ өмнөөс, Бурханы гэрээс зайлуулна. Чи үйлчлэхийг хүсэхгүй байгаа болохоор тэр үү? Чи үргэлж мууг үйлдэхийг хүсдэг бус уу? Чи үргэлж үнэнч бус байдаг бус уу? Тэгвэл, үүнийг шийдэх хялбар шийдэл байдаг нь чиний үйлчлэх эрхийг хасах юм. Бурханы хувьд, үйлчлэл үзүүлэгчийн үйлчлэх эрхийг хасна гэдэг нь тухайн үйлчлэл үзүүлэгчийн төгсгөлийг тунхагласан гэсэн үг бөгөөд тэр Бурханд үйлчлэх эрхгүй болно. Бурханд энэ хүний үйлчлэл цаашид хэрэггүй болж, тэр ямар ч сайхан зүйл хэлсэн тэр үг нь хий дэмий байх болно. Асуудал үүндээ хүрвэл нөхцөл байдлыг залруулахын аргагүй болно; ийм үйлчлэл үзүүлэгчдэд буцах зам байхгүй. Тэгээд Бурхан ийм үйлчлэл үзүүлэгчидтэй хэрхэн харьцдаг вэ? Үйлчлэхийг нь л болиулдаг уу? Үгүй. Түүний

үлдэхийг нь л хорьдог уу? Эсвэл түүнийг хайхралгүй орхиод эргэхийг нь хүлээдэг үү? Тэр тэгдэггүй. Бурхан үнэндээ үйлчлэл үзүүлэгчдийг тийм ч их хайрладаггүй. Хэрвээ хүн Бурханд үйлчлэхдээ ийм хандлагатай байвал Бурхан энэ хандлагаас нь болж түүний үйлчлэх эрхийг хасаж, түүнийг үл итгэгчдийн дунд дахин нэг удаа буцааж хаяна. Үл итгэгчдийн дунд буцааж хаягдсан үйлчлэл үзүүлэгчийн хувь заяа ямар байх вэ? Үл итгэгчдийнхтэй адилхан байна: Дахин амьтны төрлийг олж, сүнсний ертөнцөд үл итгэгчтэй адил шийтгэл хүлээнэ. Түүнчлэн энэ хүн Бурханы ажилтай ямар ч холбоогүй болох учир Бурхан тийм хүний шийтгэлийг биечлэн сонирхохгүй. Энэ нь зөвхөн Бурханд итгэх итгэлийн амьдралынх нь төгсгөл төдийгүй, бас түүний хувь заяаны төгсгөл, хувь заяаны тунхаглал юм. Иймээс хэрвээ үйлчлэл үзүүлэгч муу үйлчилбэл үр дагаврыг нь өөрөө үүрэх ёстой болно. Хэрвээ үйлчлэл үзүүлэгч эцсийг нь хүртэл үйлчилж чадахгүй бол, замын дундаас үйлчлэх эрхээ хасуулбал үл итгэгчдийн дунд хаягдана—хэрэв ийм зүйл болбол малтай харьцдаг шиг, эргүү, эрүүл ухаангүй хүмүүстэй харьцдагтай адилаар тэр хүнтэй харьцана. Намайг ингэж тайлбарлахаар та нар ойлгодог биз дээ?

Бурхан, Өөрийн сонгосон хүмүүс болон үйлчлэл үзүүлэгчдийн амьдрал, үхлийн мөчлөгийг хэрхэн зохицуулдгийг дээр дурдлаа. Үүнийг сонсоод та нарт ямар санагдаж байна вэ? Би энэ сэдвээр өмнө нь ярьж байл уу? Бурханы сонгосон хүмүүс болон үйлчлэл үзүүлэгчдийн тухай сэдвээр Би өмнө нь ярьж байл уу? Үнэндээ ярьсан, гэвч та нар санахгүй байна. Бурхан Өөрийн сонгосон хүмүүс болон үйлчлэл үзүүлэгчдэд хандахдаа зөвт байдаг. Тэр бүх талаараа зөвт. Чи эндээс хаанаас нь ч юм алдаа мадаг олж чадах уу? “Бурхан яагаад сонгогдсон хүмүүст маш хүлээцтэй ханддаг вэ? Тэгээд яагаад Тэр үйлчлэл үзүүлэгчдэд ердөө өчүүхэн тэвчээр гаргадаг юм бэ?” гэж хэлэх хүмүүс байхгүй гэж үү? Үйлчлэл үзүүлэгчдийг өмөөрмөөр байгаа хүн байна уу? “Бурхан үйлчлэл үзүүлэгчдэд илүү их хугацаа өгч, тэдэнд илүү тэвчээртэй, хүлээцтэй хандаж чадах уу?” Ийм асуулт асуух нь зөв үү? (Үгүй, буруу.) Яагаад буруу вэ? (Яагаад гэвэл, биднийг үйлчлэл үзүүлэгч болгосноороо л үнэндээ бидэнд ивээл үзүүлсэн.) Үйлчлэл үзүүлэхийг зөвшөөрсөн нь л үнэндээ үйлчлэл үзүүлэгчдэд ивээл үзүүлж буй хэрэг юм! “Үйлчлэл үзүүлэгч” гэдэг цолгүйгээр, үйлчлэл үзүүлэгчийн ажилгүйгээр энэ хүмүүс хаана байх байсан бэ? Тэд үл итгэгчдийн дунд, малтай хамт амьдарч, үхэх байсан. Бурханы өмнө, Бурханы гэрт ирэхийг тэдэнд зөвшөөрснөөр өнөөдөр тэд ямар их нигүүлслийг эдэлж байна вэ! Энэ бол асар их нигүүлсэл! Бурхан, үйлчлэл үзүүлэх боломж өгөөгүй бол Түүний өмнө очих боломж чамд хэзээ ч олдохгүй байх байсан. Шулуухан хэлэхэд, хэрвээ чи Буддын шашинтан байгаад зам мөрд хүрсэн байлаа ч гэсэн, хамгийн ихдээ л сүнсний ертөнцөд зарлага л болно; чи хэзээ ч Бурхантай уулзаж, Түүний дуу хоолой, үгийг сонсож, Түүний хайр, ерөөлийг мэдрэхгүй, Бурхантай нүүр тулан уулзаж хэрхэвч чадахгүй. Буддын шашинтнуудын өмнө байх ганц л зүйл нь энгийн даалгаврууд юм. Тэд Бурханыг мэдэж хэрхэвч чадахгүй, ердөө л захирагдаж, дуулгавартай дагадаг байхад үйлчлэл үзүүлэгчид ажлын энэ

үе шатанд маш ихийг олж авдаг! Юуны түрүүнд, тэд Бурхантай нүүр тулан уулзаж, Түүний дуу хоолой, Түүний үгийг сонсож, хүмүүст Түүний хайрладаг нигүүлсэл, ерөөлийг туулж чаддаг. Түүнчлэн, тэд Бурханы хайрласан үг болоод үнэнийг эдэлж чаддаг. Үйлчлэл үзүүлэгчид үнэхээр маш ихийг олж авдаг! Иймд үйлчлэл үзүүлэгчийн хувьд чи зохих ёсоор хичээл зүтгэл ч гаргаж чадахгүй бол Бурхан чамайг байлгасаар байж чадах уу? Тэр чамайг байлгаж чадахгүй. Тэр чамаас тийм ч ихийг шаарддаггүй, гэтэл чи Түүний шаарддаг зүйлээс юуг нь ч зохих ёсоор хийдэггүй; чи үүргээ баримтлаагүй. Иймд Бурхан чамайг байлгаж чадахгүй нь лавтай. Бурханы зөвт зан чанар ийм билээ. Бурхан чамайг эрхлүүлдэггүй боловч бас ялгаварлан гадуурхдаг ч үгүй. Бурханы үйлддэг зарчим ийм билээ. Бурхан бүх хүн, бүтээгдсэн зүйлд ингэж ханддаг.

Сүнсний ертөнцийн тухайд гэвэл, тэнд байдаг янз бүрийн оршихуй ямар нэгэн буруу зүйл хийх буюу ажлаа зөв хийхгүй бол тэдэнтэй харьцвал зохих тэнгэрлэг тушаал, зарлиг Бурханд бас байдаг; энэ нь гарцаагүй. Иймээс Бурханы хэдэн мянган жилийн удирдлагын ажлын үеэр буруу зүйл хийсэн зарим үүрэг гүйцэтгэгчийг устгасан бол зарим нь өнөөдөр ч хоригдож, шийтгүүлсээр байна. Энэ бол сүнсний ертөнц дэх оршихуй бүрд тулгарах ёстой зүйл юм. Хэрвээ тэд ямар нэгэн буруу зүйл хийж, мууг үйлдвэл шийтгүүлдэг—энэ нь Өөрийнх нь сонгосон хүмүүс болон үйлчлэл үзүүлэгчдэд хандах Бурханы хандлагатай адилхан. Иймээс сүнсний ертөнцөд ч бай, материаллаг ертөнцөд ч бай Бурханы үйлддэг зарчим өөрчлөгддөггүй. Бурханы үйлдлийг харж чаддаг эсэхээс чинь үл хамааран зарчим нь өөрчлөгддөггүй. Бүх зүйлд хандах хандлагадаа, бүх зүйлийг зохицуулахдаа Бурхан хаа сайгүй нэгэн адил зарчимтай байдаг. Энэ бол хувиршгүй. Бурхан үл итгэгчдийн дундаас харьцангуй зөв зохистой амьдардаг хүмүүст сайхан хандаж, шашин бүрийн биеэ зөв авч явдаг, мууг хийдэггүй хүмүүст боломж олгож, Бурханы удирддаг бүх зүйлд үүргээ гүйцэтгэж, хийх ёстойгоо хийхийг зөвшөөрнө. Үүний адилаар, Бурханыг дагадаг хүмүүс, Өөрийнх нь сонгосон хүмүүсийн дундаас Бурхан энэхүү зарчмынхаа дагуу ямар ч хүнийг ялгаварлан гадуурхдаггүй. Өөрийг нь чин сэтгэлээсээ дагаж чаддаг хүн бүхэнд Тэр сайн ханддаг, Өөрийг нь чин сэтгэлээсээ дагадаг хүн бүрийг Тэр хайрладаг. Үл итгэгчид, итгэл бишрэлтэй янз бүрийн хүмүүс, Бурханы сонгосон хүмүүс гээд энэ хэдэн төрлийн хүмүүст Түүний хайрладаг зүйл нь өөр өөр байдаг. Жишээ нь үл итгэгчдийг аваад үзье: Тэд Бурханд итгэдэггүй, Бурхан тэднийг адгуус амьтан гэж үздэг хэдий ч бүх зүйлийн дундаас тэд дор бүрнээ идэх хоолтой, өөрийн гэсэн орон гэртэй, амьдрал, үхлийн хэвийн мөчлөгтэй байдаг. Мууг хийдэг хүмүүс шийтгүүлж, сайныг хийдэг нь ерөөгдөж, Бурханы хайр энэрлийг хүртдэг. Ийм байдаг биш гэж үү? Итгэл бишрэлтэй хүмүүсийн хувьд, хэрвээ тэд ахин дахин эргэж төрөх замаар шашны сургаалаа чанд баримталж чадвал энэ бүх дахин төрлийг олсны дараа эцэст нь Бурхан тэдэнд тунхаглалаа зарлах болно. Үүнтэй адилаар, өнөөдөр та нарын хувьд Бурханы сонгосон хүмүүс, эсвэл үйлчлэл үзүүлэгчийн аль нь ч бай, Бурхан Өөрийн

тогтоосон захиргааны зарлиг, журмыг та нараар ч бас мөрдүүлж, төгсгөлийг чинь тодорхойлно. Энэ хэдэн төрлийн хүмүүсийн дундаас, итгэл бишрэлтэй өөр өөр төрлийн хүмүүс буюу олон янзын шашинд харьяалагддаг хүмүүст Бурхан амьдрах орон зай өгсөн үү? Иудейн шашинтнууд хаана байна вэ? Бурхан тэдний итгэл бишрэлд хөндлөнгөөс оролцсон уу? Тэгээгүй. Тэгвэл Христэд итгэгчийн тухайд ямар байна вэ? Тэр бас л хөндлөнгөөс оролцоогүй. Тэр тэдэнд өөрсдийнхөө ёс журмыг мөрдөхийг зөвшөөрдөг, тэдэнтэй ярьж, эсвэл гэгээрүүлдэггүй, түүнчлэн тэдэнд юу ч илчилдэггүй. Хэрвээ чи үүнийг зөв гэж бодож байгаа бол энэ маягаараа итгэ. Католик шашинтнууд Мариад итгэдэг, түүгээр дамжин Есүст мэдээ очсон гэж итгэдэг; тэдний итгэлийн хэлбэр ийм юм. Бурхан ер нь тэдний итгэлийг зассан уу? Тэр тэднийг дураар нь байлгадаг; Тэр тэднийг тоодоггүй, тэдэнд амьдрах тодорхой орон зай өгдөг. Лалын болон Буддын шашинтнуудын тухайд Тэр адилхан бус уу? Тэр тэдэнд ч мөн адил хил хязгаар тогтоосны дээр тус тусынх нь итгэл бишрэлд хөндлөнгөөс оролцохгүйгээр өөрийн гэсэн амьдрах орон зайтай байх боломж олгодог. Бүгд маш эмх цэгцтэй байдаг. Та нар энэ бүгдээс юу харж байна вэ? Бурханд эрх мэдэл байдаг ч Тэр Өөрийн эрх мэдлийг буруугаар ашигладаггүй. Бурхан бүх зүйлийг төгс эмх журамтай, цэгцтэй байдлаар зохицуулдаг, Түүний мэргэн ухаан, төгс хүчин үүнд оршдог.

Өнөөдөр бид Бурхан сүнсний ертөнцийг удирдаж, ноёрхож байдгийн нэг талыг илэрхийлдэг сүнсний ертөнцийн хэрэг явдалтай хамаатай нэгэн шинэ, онцгой сэдвийг хөндлөө. Та нар эдгээр зүйлийг ойлгохоосоо өмнө “Үүнтэй холбоотой юм бүхэн нууцлаг, амийн оролттой минь ямар ч хамаагүй; эдгээр зүйл нь хүмүүс үнэндээ хэрхэн амьдардгаас ангид бөгөөд үүнийг ойлгохын хэрэггүй, тэдгээрийн талаар сонсохыг ч хүсэхгүй байна. Тэдгээр нь Бурханыг мэдэхтэй огт холбоогүй” гэж хэлсэн байж болно. Одоо та нар, ийм сэтгэлгээнд асуудал байна гэж бодож байна уу? Энэ нь зөв үү? (Үгүй.) Ийм сэтгэлгээ буруу бөгөөд ноцтой асуудалтай. Үүний шалтгаан нь, хэрвээ чи Бурхан бүх зүйлийг хэрхэн захирдгийг ойлгохыг хүсэж байвал гагцхүү өөрийнхөө харж чадах, сэтгэлгээний арга барил чинь ухаарч чадах зүйлийг л ойлгож болохгүй; чамд харагддаггүй ч, чиний харж чадах энэ ертөнцтэй салшгүй холбоотой нөгөө ертөнцийн талаар бас ойлгох ёстой. Энэ нь Бурханы дээд эрх, “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж” гэсэн сэдэвт хамаатай. Тэр талаарх мэдээлэл нь энэ юм. Ийм мэдээлэлгүйгээр Бурхан хэрхэн бүх зүйлийн амийн эх сурвалж байдаг тухай хүмүүсийн мэдлэг дутуу дулимаг, алдаатай байх болно. Иймд бидний өмнөх сэдвүүд, мөн түүнчлэн “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж”-ийн талаарх агуулгыг өнөөдрийн ярьсан зүйл маань нэгтгэн дүгнэлээ гэж хэлж болох юм. Үүнийг ойлгосон болохоор одоо та нар энэхүү агуулгаар Бурханыг мэдэж чадах уу? Илүү чухал зүйл бол өнөөдөр Би та нарт үйлчлэл үзүүлэгчдэд хамаатай нэг маш чухал мэдээлэл өглөө. Та нар иймэрхүү сэдвийн талаар сонсох үнэхээр дуртай гэдгийг, иймэрхүү зүйлийг үнэхээр анхаардаг гэдгийг Би мэднэ. Тиймээс, та нар өнөөдөр Миний ярьсан зүйлд сэтгэл хангалуун байна

уу? (Тийм ээ, сэтгэл хангалуун байна.) Бусад зүйлсийн зарим нь та нарт нэг их хүчтэй сэтгэгдэл төрүүлээгүй байж магад боловч үйлчлэл үзүүлэгчдийн талаар Миний хэлсэн зүйл та нарт тун хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн, учир нь энэхүү сэдэв нь хүн нэг бүрийн сүнсний талаар хөнддөг.

Хүн төрөлхтөнд тавих Бурханы шаардлага

а. Бурханы Өөрийнх нь ялгамж чанар, байр суурь

Бид “Бурхан бол бүх зүйлийн амийн эх сурвалж”, мөн түүнчлэн “Бурхан бол цор ганц Бурхан Өөрөө” гэсэн сэдвүүдийг үзэж дууслаа. Тийм болохоор бид дүгнэлт хийх хэрэгтэй. Бид ямар дүгнэлт хийх ёстой вэ? Бурханы Өөрийнх нь тухай дүгнэлт. Ийм болохоор энэ нь Бурханы бүх тал, мөн түүнчлэн хүмүүс Бурханд хэрхэн итгэдэгтэй зайлшгүй холбоотой байх ёстой. Тиймээс эхлээд Би та нараас ингэж асуух ёстой: Эдгээр номлолыг сонссон болохоор та нарын төсөөлөл дэх Бурхан гэж хэн бэ? (Бүтээгч.) Та нарын төсөөлөл дэх Бурхан бол Бүтээгч юм. Өөр зүйл байна уу? Бурхан бол бүх зүйлийн Эзэн. Эдгээр үг нь тохиромжтой юу? (Тохиромжтой.) Бурхан бол бүх зүйлийг захирч, удирддаг Нэгэн. Тэр байгаа бүхнийг бүтээсэн, байгаа бүхнийг удирдаж, захирч, бас хангадаг. Энэ бол Бурханы байр суурь, Түүний ялгамж чанар юм. Бүх зүйл, байгаа бүхний хувьд Бурханы жинхэнэ ялгамж чанар нь бүх бүтээлийн Бүтээгч агаад Захирагч мөн. Бурханд байдаг ялгамж чанар нь ийм, Тэр бол бүх зүйлийн дунд цор ганц билээ. Хүн төрөлхтний дунд ч бай, сүнсний ертөнцөд ч бай, Бурханы бүтээлүүдийн нэг нь ч Бурханы ялгамж чанар, байр суурийг дуурайх юм уу орлох гэж ямар нэг арга, шалтаг хэрэглэж болохгүй, учир нь бүх зүйлийн дунд ийм ялгамж чанар, хүч чадал, эрх мэдэл, бүтээлийг захирах чадвартай цорын ганц Нэгэн байдаг нь бидний цор ганц Бурхан Өөрөө билээ. Тэр бүх зүйлийн дунд амьдарч, шилждэг; Тэр бүх зүйлийн дээр, хамгийн өндөр газар дээр гарч чадна. Тэр даруухнаар хүн болж, мах, цуснаас бүрддэг хүмүүсийн нэг болж, хүмүүстэй нүүр тулан уулзаж, тэдний баяр гунигийг хуваалцахын зэрэгцээ байгаа бүхнийг захирч бөгөөд байгаа бүхний хувь заяаг болон хаашаа явахыг нь шийддэг. Мөн түүнчлэн, Тэр бүх хүн төрөлхтний хувь заяаг замчилж, зүг чигийг нь залж чиглүүлдэг. Ийм Бурханд бүх амьд зүйл шүтэн мөргөж, дуулгавартай байж, Түүнийг мэдэх хэрэгтэй. Иймээс хүн төрөлхтний дунд чи ямар бүлэг, төрөлд багтаж байгаагаас үл хамааран Бурханд итгэж, Бурханыг дагаж, Бурханыг хүндэлж, Түүний захиргааг хүлээн зөвшөөрч, хувь заяаг чинь зохицуулах Бурханы зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх нь ямар ч хүн, аливаа бүх амьд зүйлийн хувьд цорын ганц, зайлшгүй сонголт юм. Бурханы цор ганц чанараас хүмүүс, Түүний эрх мэдэл, зөвт зан чанар, мөн чанар болон бүх зүйлийг хангаж буй арга зам нь бүгд тэр чигээрээ цор ганц болохыг хардаг; энэхүү цор ганц чанар нь Бурханы Өөрийнх нь жинхэнэ ялгамж чанарыг тодорхойлдгийн дээр, мөн Түүний байр суурийг тодорхойлдог. Иймд бүх бүтээгдсэн зүйлийн дотроос, сүнсний ертөнцөд, эсвэл хүн төрөлхтний дунд байдаг ямар нэгэн амьд зүйл Бурханы оронд зогсохыг хүссэн бол

амжилт олох боломжгүй, Бурханы дүрд тоглохыг оролдох нь мөн л боломжгүй хэрэг. Энэ бол бодит баримт. Бурханы Өөрийнх нь ялгамж чанар, хүч чадал, байр суурьтай ийм Бүтээгч, Захирагчийн хүн төрөлхтнөөс шаарддаг шаардлага юу вэ? Үүнийг хүн бүр ойлгож, санах ёстой; энэ нь Бурхан, хүн хоёрт хоёуланд нь маш чухал!

б. Бурханд хандах хүн төрөлхтний янз бүрийн хандлага

Хүмүүс Бурханд хэрхэн хандах нь тэдний хувь заяаг, мөн түүнчлэн Бурхан тэдэнд хэрхэн хандаж, харьцахыг шийддэг. Энэ мөчид Би, хүмүүс Бурханд хэрхэн ханддаг талаар зарим жишээ дурдах гэж байна. Бурханы өмнө тэдний биеэ авч явж буй байдал, хандлага зөв эсэхийг сонсож, үзье. Бүгдээрээ, доор дурдсан долоон төрлийн хүний биеэ авч явах байдлыг авч үзье.

1) Бурханд тун хөгийн ханддаг нэг төрлийн хүмүүс байдаг. Бурхан бол хүмүүний үлгэр домгийн ариун оршихуй, Бодьсадва шиг бөгөөд хүмүүс, уулзахдаа гурвантаа мөргөж, хоол болгоныхоо дараа хүж асаах хэрэгтэй байдаг энэ хүмүүс боддог. Тиймээс тэд нигүүлслийнх нь төлөө Бурханд туйлын их баярлаж, талархах болгондоо дандаа иймэрхүү сэтгэл хөдлөлтэй байдаг. Өнөөдөр өөрсдийнх нь итгэдэг Бурхан, зүрх сэтгэлдээ хүсэмжилдэг ариун оршихуйнх нь адилаар, уулзахдаа гурвантаа мөргөж, хоол болгоныхоо дараа хүж асаадаг байдлыг нь хүлээн зөвшөөрдөг болоосой гэж тэд ихэд хүсдэг.

2) Зарим хүн Бурханыг бүх амьд зүйлийг зовлонгоос ангижруулж, аварч чадах амьд Будда мэт үздэг; тэд Түүнийг зовлонгийн далайгаас холдуулж чадах амьд Будда гэж хардаг. Энэ хүмүүсийн Бурханд итгэх итгэл нь Түүнийг Будда мэт шүтэн мөргөх шалтгаан болдог. Хэдийгээр тэд хүж асааж, мэхийн ёсолж, тахил өргөдөггүй ч гэсэн зүрх сэтгэлийнхээ гүнд Бурхан бол яг л Буддагийн адил, сайхан сэтгэлтэй, өглөгч байж, ямар ч амьд зүйлийг хөнөөхгүй байх, бусдыг харааж зүхэхийг тэвчиж, үнэнч шударга харагдах амьдралаар амьдарч, ямар ч муу үйл хийхгүй байхыг л шаарддаг гэж боддог. Тэр ийм зүйлийг л өөрсдөөс нь шаарддаг гэж тэд итгэдэг; энэ бол тэдний зүрх сэтгэл дэх Бурхан юм.

3) Зарим хүн Бурханыг агуу, алдартай нэгэн мэт шүтэн мөргөдөг. Жишээлбэл, энэ агуу хүний ярих дуртай арга барил, ярьдаг аялга, хэрэглэдэг үг, хэллэг, дуу хоолойны өнгө, гарын дохио зангаа, санал бодол, үйлдэл, намба төрхийг бүгдийг нь тэд хуулбарладаг бөгөөд эдгээр нь Бурханд итгэх итгэлийн замналдаа бүрэн бий болгох ёстой зүйлс нь байдаг.

4) Зарим хүн Бурханыг эзэн хаан мэт үзэж, Тэр бүхнээс дээр байдаг, хэн ч Түүнд халдаж зүрхэлдэггүй, хэрвээ тэгвэл тэр хүн торгуулна гэж боддог. Эзэн хаан тэдний зүрх сэтгэлд тодорхой байр суурь эзэлдэг учир тэд тийм эзэн хааныг шүтэн мөргөдөг. Түүний бодол, ааш маяг, уг чанар—ашиг сонирхол, хувийн амьдрал нь хүртэл—бүгд энэ хүмүүсийн ойлгох ёстой гэж боддог зүйл нь болдог; тэдгээр нь тэдний анхаарах ёстой асуудал, хэрэг явдал болдог. Иймээс тэд Бурханыг эзэн хаан мэт шүтэн мөргөдөг. Итгэлийн ийм хэлбэр үнэхээр хөгийн.

5) Зарим хүн Бурханы оршин тогтнолд гойд итгэлтэй байдгийн дээр энэхүү итгэл нь гүн гүнзгий агаад гуйвшгүй. Гэхдээ, Бурханы талаарх мэдлэг нь маш өнгөц, Бурханы үгийн талаар нэг их туршлага байхгүй учраас Түүнийг шүтээн мэт шүтэн мөргөдөг. Энэхүү шүтээн нь тэдний зүрх сэтгэл дэх Бурхан; тэдний эмээж, бөхийн мөргөх ёстой, дагаж, дуурайх ёстой зүйл нь юм. Тэд Бурханыг бүхэл амьдралынхаа турш дагах ёстой шүтээн гэж үздэг. Тэр Бурханы ярианы өнгийг хуулбарлаж, Бурханд таалагддаг хүмүүсийг гаднаа дуурайдаг. Тэд гэнэн, цэвэр ариун, үнэнч шударга харагддаг зүйлсийг үргэлж хийж, тэр ч байтугай энэхүү шүтээнийг хэзээ ч хагацаж чадахгүй хамтрагч, хань нөхөр мэт дагадаг. Тэд ийм маягаар итгэдэг билээ.

6) Бурханы үгээс ихийг уншиж, зөндөө номлол сонссон хэдий ч Бурханд хандах цор ганц зарчим бол үргэлж долигонож, бялдуучилж, бодитой бус байдлаар Бурханыг магтаж, сайшаах ёстой гэж зүрх сэтгэлийнхээ гүнд боддог нэг төрлийн хүмүүс бий. Бурхан бол өөрсдийг нь ийм маягаар авирлахыг шаарддаг Бурхан гэж тэд итгэдэг. Тэр ч байтугай тэгэхгүй бол хэдийд ч Түүнийг хилэгнүүлж, өөрийн мэдэлгүй Түүний эсрэг нүгэл үйлдэж, ийнхүү нүгэл үйлдсэний улмаас Бурхан тэднийг шийтгэнэ гэж итгэдэг. Тэдний зүрх сэтгэлдээ хадгалдаг Бурхан ийм билээ.

7) Тэгээд мөн, Бурханаас сүнслэг тэжээл олж авдаг хүмүүс олонх байдаг. Учир нь, тэд энэ хорвоод амьдардаг, амар амгалан, аз жаргал үгүй, хаанаас ч тайтгарал олж авч чаддаггүй. Тэд Бурханыг олж аваад, Түүний үгийг сонсож, харсныхаа дараа зүрх сэтгэлдээ нууцхан баяр, хөөр тээж эхэлдэг. Яагаад гэвэл, тэд сүнсийг нь аз жаргалтай болгох газрыг, мөн өөрсдөд нь сүнслэг тэжээл өгөх Бурханыг эцэст нь оллоо гэж итгэдэг. Бурханыг хүлээн авч, дагаж эхэлснийхээ дараа тэд аз жаргалтай болж, амьдрал нь бүрэн дүүрэн болдог. Тэд амьдралаа амьтан шиг ухамсаргүйгээр өнгөрүүлдэг үл итгэгчидтэй адил байхаа больж, амьдрал нь хүсэл эрмэлзэлтэй болсон санагддаг. Тиймээс, энэ Бурхан өөрсдийнх нь сүнслэг хэрэгцээг хангаж, оюун санаа болон сүнсний аль алинд нь асар их аз жаргал авчирч чадна гэж тэд боддог. Өөрсдөө ч мэдэлгүйгээр тэд, өөрсдөд нь сүнслэг хангалт өгч, сүнсэнд нь болон гэр бүлийнх нь бүх гишүүдэд аз жаргал авчирдаг Бурханыг орхиж чадахгүй болдог. Бурханд итгэх итгэл өөрсдөд нь сүнслэг түшиг тулгуураас өөр юу ч авчрах хэрэггүй гэж тэд боддог.

Бурханд хандах дээр дурдсан эдгээр олон төрлийн хандлагатай хүн та нарын дунд байна уу? (Байна.) Хэрвээ Бурханд итгэхдээ хүн эдгээр хандлагын аль нэгийг зүрх сэтгэлдээ тээдэг бол Бурханы өмнө үнэхээр очиж чадах уу? Хэрвээ хэн нэгний зүрх сэтгэлд эдгээр хандлагын аль нэг нь байдаг бол тэр хүн Бурханд итгэдэг үү? Ийм хүн цор ганц Бурханд Өөрт нь итгэдэг үү? (Үгүй.) Чи цор ганц Бурханд Өөрт нь итгэдэггүй юм бол хэнд итгэдэг юм бэ? Хэрвээ чиний итгэдэг зүйл цор ганц Бурхан Өөрөө биш бол чи шүтээн, агуу хүн, эсвэл Бодьсадвад итгэдэг, зүрх сэтгэлдээ байгаа Буддаг шүтэн мөргөдөг байж болзошгүй юм. Түүнчлэн, чи жирийн нэг хүнд итгэдэг байж болзошгүй. Товчоор хэлбэл, Бурханд итгэх итгэл, хандлага нь янз

бүрийн хэлбэрээр байдаг учраас хүмүүс өөрсдийн мэддэг Бурханыг зүрх сэтгэлдээ байлгаж, өөрсдийн төсөөллийг Бурханд тулгаж, Бурханы талаарх хандлага, төсөөллөө цор ганц Бурхантай Өөртэй нь эн зэрэгцүүлэн тавьсныхаа дараа тэдгээрийг өндөрт өргөж тахидаг. Хүмүүс Бурханд ийм зүй зохисгүй хандлагатай байгаа нь юу гэсэн үг вэ? Энэ нь тэд жинхэнэ Бурханыг Өөрийг нь голж, хуурамч бурханыг шүтэн мөргөж байна гэсэн үг юм; энэ нь тэд Бурханд итгэхийн зэрэгцээ Түүнийг голж, эсэргүүцэж, жинхэнэ Бурханы оршин тогтнолыг үгүйсгэдгийг нь илтгэдэг. Хэрвээ хүмүүс ийм хэлбэрийн итгэлтэй зууралдсаар байвал тэд ямар үр дагавартай нүүр тулах вэ? Итгэлийн ийм хэлбэртэй байснаараа тэд Бурханы шаардлагыг биелүүлэхэд илүү ойртож ер нь чадах уу? (Үгүй, чадахгүй.) Эсрэгээрээ, өөрсдийн үзэл, төсөөллөөс болж тэд Бурханы замаас улам л холдоно, учир нь тэдний эрж хайдаг чиглэл Бурхан тэднээс явахыг шаарддаг чиглэлээс эсрэг зүгт байдаг. Та нар “сүйх тэргээ хойд зүг рүү жолоодоод, урд зүг рүү явах нь” гэдэг түүхийг ер нь сонсож байсан уу? Энэ нь ёстой л сүйх тэргээ хойд зүг рүү жолоодож, урд зүгт явж буй хэрэг байж болох юм. Хэрвээ хүмүүс ийм утгагүй байдлаар Бурханд итгэвэл хичээх тусмаа чи Бурханаас улам их холдоно. Тиймээс Би та нарт ийнхүү сургамжилж байна: Та нар явахаасаа өмнө эхлээд үнэхээр зөв чиглэлд явж байгаа эсэхээ эхлээд ялгаж салгах ёстой. Хүчин чармайлт гаргахдаа анхааралтай байж, “Миний итгэдэг Бурхан бүх зүйлийг Захирагч мөн үү? Миний итгэдэг Бурхан ердөө л надад сүнслэг тэжээл өгдөг хэн нэгэн үү? Тэр зүгээр нэг миний шүтээн үү? Миний итгэдэг энэ Бурхан надаас юу шаарддаг вэ? Бурхан миний хийдэг бүхнийг сайшаадаг уу? Миний бүх үйлдэл, эрэл хайгуул Бурханыг мэдэхээр эрж хайхтай нийцдэг үү? Түүний надаас шаарддаг зүйлтэй тэдгээр нь нийцэж байна уу? Миний алхдаг замыг Бурхан хүлээн зөвшөөрч, сайшаадаг уу? Миний итгэлд Тэр сэтгэл хангалуун байдаг уу?” гэж өөрсдөөсөө заавал асуу. Чи эдгээр асуултыг өөрөөсөө байнга, ахин дахин асууж байх хэрэгтэй. Хэрвээ чи Бурханы талаарх мэдлэгийг эрж хайхыг хүсэж байвал Бурханыг сэтгэл хангалуун болгож чадахаасаа өмнө ухаан чинь саруул, зорилго чинь тодорхой байх ёстой.

Дөнгөж сая Миний ярьсан энэ зүй зохисгүй хандлагыг Бурхан хүлээцтэй байдлынхаа улмаас дуртай дургүй хүлээн зөвшөөрөх боломжтой юу? Бурхан энэ хүмүүсийн хандлагыг сайшааж чадах болов уу? (Үгүй.) Хүмүүст болон Өөрийг нь дагадаг хүмүүст тавих Бурханы шаардлага юу вэ? Тэрээр хүмүүсээс ямархуу хандлагатай байхыг шаарддаг вэ? Та нарт тодорхой санаа бодол байна уу? Энэ мөчид Би маш ихийг ярьсан; Бурханы Өөрийнх нь тухай сэдвээр, мөн түүнчлэн Түүний үйлс, Түүнд юу байдаг, Тэр юу болох талаар Би ихээхэн ярилаа. Бурхан хүмүүсээс юу олж авахыг хүсдэгийг одоо та нар мэдэх үү? Бурхан чамаас юу хүсдэгийг мэдэх үү? Санал бодлоо хэл. Туршлага, хэрэгжүүлэлтээс олж авсан мэдлэг чинь бас л дутуу дулимаг, маш өнгөц хэвээр байвал та нар эдгээр үгийн талаар зарим нэг мэддэг зүйлээ ярьж болно. Та нарт хураангуй мэдлэг байна уу? Бурхан хүнээс юу шаарддаг вэ? (Энэ хэдэн ярианы үеэр Өөрийг нь, Өөрийнх нь

үйл хэргийг, Тэр бол бүх зүйлийн амийн эх сурвалж гэдгийг нь, Өөрийнх нь байр суурь, ялгамж чанарыг мэдэхийг биднээс шаарддаг гэдгээ Бурхан онцоллоо.) Тэгэхээр Бурхан Өөрийг нь мэд гэж хүмүүсээс шаардахад эцсийн үр дүн нь юу байдаг вэ? (Бурхан бол Бүтээгч, хүн бол бүтээгдсэн зүйл гэдгийг тэд ойлгодог.) Хүмүүс ийм мэдлэгтэй болох үед Бурханд хандах тэдний хандлага, үүргийн гүйцэтгэл, амь зан чанарт нь ямар өөрчлөлт гардаг вэ? Та нар энэ тухай ер нь бодож үзсэн үү? Бурханыг мэдэж, Түүнийг ойлгосноороо тэд сайн хүн болдог гэж хэлж болох уу? (Бурханд итгэх итгэлд сайн хүн болохоор эрж хайх явдал ордоггүй. Харин энэ бол Бурханы шаардлага хангасан бүтээл болох гэж, мөн үнэнч шударга хүн байхаар эрэлхийлэх явдал байдаг.) Өөр хэлэх зүйл байна уу? (Бурханыг үнэхээр, зөвөөр мэдсэний дараа бид Түүнд Бурхан гэж хандаж чаддаг; Бурхан бол үргэлж Бурхан, бид бол бүтээгдсэн зүйлс, Бурханыг шүтэн мөргөх, зүй ёсны байр сууриндаа зогсох ёстой гэдгээ бид мэддэг.) Тун сайн байна! Өөр хүмүүсийн ярихыг сонсъё. (Бид Бурханыг мэддэг, эцсийн дүндээ Бурханд үнэхээр захирагддаг, Бурханыг хүндэлж, муугаас зайлдаг хүмүүс байж чаддаг.) Яг зөв!

в. Хүн төрөлхтнөөс Бурханы шаарддаг Өөрт нь хандвал зохих хандлага

Үнэндээ, Бурхан хүн төрөлхтнөөс нэг их зүйл шаарддаггүй—ядаж л хүмүүсийн төсөөлдөг шиг шахаж шаарддаггүй. Бурхан нэг ч үг айлдаагүй, зан чанар, аливаа үйлсээ илэрхийлээгүй бол Бурханыг мэдэх нь та нарын хувьд туйлын хэцүү байх байлаа, учир нь хүмүүс Түүний санаа зорилго, Түүний хүслийг таах хэрэгтэй болох байсан; үүнийг хийхэд тун хэцүү байх байсан. Гэхдээ Өөрийн ажлын сүүлийн үе шатанд, Бурхан олон үг айлдаж, асар их ажил хийж, хүнд олон шаардлага тавьсан. Үгээрээ болон асар их хэмжээний ажлаараа Тэр, Өөрийгөө юунд дуртай, юуг жигшдэг, мөн өөрсдийг нь ямар байх ёстойг хүмүүст мэдэгдсэн. Эдгээр зүйлийг ойлгосны дараа хүмүүс зүрх сэтгэлдээ Бурханы шаардлагын талаар нарийн зөв ухагдахуунтай болох ёстой, учир нь тэд тодорхойгүй байдлаар Бурханд итгэдэггүй, тодорхойгүй Бурханд итгэхээ больж, бас тодорхойгүй, хоосон байдал дунд Бурханд итгэдэг байхаа больсон. Харин ч тэд Түүний айлдваруудыг сонсож, Түүний шаардлагуудын стандартыг ойлгож, үүнд хүрч чаддагийн дээр мэдэж, ойлгох ёстой бүхнийг нь хэлэхийн тулд Бурхан хүн төрөлхтний хэлийг ашигладаг. Өнөөдөр, хүмүүс Бурхан юу болох, Тэр өөрсдөөс нь юу шаарддагийг мэдэхгүй хэвээр байвал; яагаад Бурханд итгэх ёстойгоо, Түүнд хэрхэн итгэж, хэрхэн хандах ёстойгоо ч мэдэхгүй байвал үүнд асуудал байна. Саяхан, та нар дор бүрнээ тодорхой нэг талбарын талаар ярилаа; тэдгээр зүйл нь тодорхой ч бай, ерөнхий ч бай, та нар зарим зүйлийг мэдэж байгаа. Гэхдээ Би, хүн төрөлхтөнд Бурханы тавьдаг зөв, бүрэн, тодорхой шаардлагыг та нарт хэлмээр байна. Эдгээр нь ердөө л хэдхэн үг бөгөөд маш энгийн; та нар эдгээрийг аль хэдийн мэддэг байж магадгүй. Хүн төрөлхтнөөс болон Өөрийг нь дагадаг хүмүүсээс Бурхан дараах зөв шаардлагуудыг

шаарддаг. Бурхан Өөрийг нь дагадаг хүмүүсээс таван зүйл шаарддаг: жинхэнэ итгэл, үнэнчээр дагах, туйлын дуулгавартай байдал, жинхэнэ мэдлэг, чин сэтгэлийн хүндэтгэл.

Энэхүү таван зүйлээр Бурхан, Өөрт нь эргэлзэхээ больж, өөрсдийн төсөөлөл, тодорхойгүй, хийсвэр үзэл бодлыг ашиглан Өөрийг нь дагахаа болихыг хүмүүсээс шаарддаг; тэд ямар нэг төсөөлөл, үзэл дээр үндэслэж Бурханыг дагах ёсгүй. Бурхан, Өөрийг нь дагадаг хүн бүрээс хайнга, хоёрдмол сэтгэлээр бус үнэнчээр дагахыг шаарддаг. Бурхан чамд ямар нэгэн шаардлага тавьж, чамайг туршиж, шүүж, чамтай харьцаж, чамайг засаж, сахилгажуулж, цохих үед чи Түүнд бүрэн дүүрэн захирагдах ёстой. Чи учир шалтгааныг нь асууж, болзол тавих ёсгүй, тэр ч байтугай, шалтаг хэлэх ёсгүй. Дуулгавартай байдал чинь туйлын байх ёстой. Бурханы талаарх мэдлэг бол хүмүүсийн хамгийн дутуу дулимаг байдаг талбар юм. Тэд Бурханд хамааралгүй хэллэг, айлдвар, үгсийг дандаа Түүнд тулгаж, эдгээр үг нь Бурханы талаарх мэдлэгийн хамгийн үнэн зөв тодорхойлолт гэж итгэдэг. Хүний төсөөлөл, дүгнэлт, мэдлэгээс гарсан зарим хэллэг нь Бурханы мөн чанарт өчүүхэн ч хамааралгүй гэдгийг тэд огт мэддэггүй. Ийм учраас хүмүүсийг олж аваасай гэж Бурханы хүсдэг мэдлэгийн тухайд, Бурхан чамаас зүгээр нэг Өөрийг нь, Өөрийнх нь үгийг танин мэдэхийг шаарддаггүй, харин Түүний талаарх мэдлэг чинь зөв байхыг шаарддаг гэдгийг Би та нарт хэлмээр байна. Хэдийгээр чи ганцхан өгүүлбэр хэлж чаддаг, өчүүхэн багыг л мэддэг ч гэсэн, энэхүү өчүүхэн бага мэдлэг чинь үнэн зөв, жинхэнэ бөгөөд Бурханы Өөрийнх нь мөн чанартай нийцдэг. Учир нь, Өөрийг нь бодитой бус, бодлогогүйгээр магтаж, сайшаахыг Бурхан жигшдэг. Түүнээс ч илүүтэйгээр, хүмүүс Түүнд агаар шиг хандахыг Тэр үзэн яддаг. Бурханы талаарх сэдвээр ярилцах үеэр хүмүүс ямар ч баримтгүйгээр, дураараа, тээнэгэлзэлгүй, зоргоороо ярихыг Тэр үзэн яддаг; түүнчлэн, Бурханыг мэддэг гэж итгэдэг, Түүний талаарх мэдлэгээрээ бардамнадаг, Түүний талаарх сэдвээр огт биеэ барилгүй, эрээ цээргүй ярилцдаг хүмүүсийг Тэр үзэн яддаг. Дээр дурдсан тэрхүү таван шаардлагын хамгийн сүүлийнх нь чин сэтгэлийн хүндэтгэл юм: Энэ бол Өөрийг нь дагадаг бүх хүнд тавих Бурханы эцсийн шаардлага билээ. Хүн Бурханы талаар үнэн, зөв мэдлэгтэй байвал Бурханыг үнэхээр хүндэтгэж, муугаас зайлж чаддаг. Энэхүү хүндэтгэл нь тэдний зүрх сэтгэлийн гүнээс гардаг; Бурханы шахалтын улмаас бус, харин сайн дураараа ийнхүү хүндэлдэг. Бурхан чамаас ямар нэгэн сайхан хандлага, биеэ авч явах байдал, гаднах зан авираар бэлэг барь гэж шаарддаггүй; харин зүрх сэтгэлийнхээ гүнд Өөрийг нь хүндэтгэж, Өөрөөс нь эмээхийг Тэр чамаас шаарддаг. Амь зан чанар чинь өөрчлөгдөж, Бурханы талаар мэдлэгтэй, Бурханы үйлсийн талаар ойлголттой болж, Бурханы мөн чанарын талаар ойлгож авч, мөн өөрийгөө Бурханы бүтээлийн нэг гэдэг бодит үнэнийг хүлээн зөвшөөрсний улмаас ингэж хүндэлдэг болдог. Иймд энд хүндэтгэлийг тодорхойлохдоо “чин сэтгэлийн” гэдэг үгийг хэрэглэсэн Миний зорилго бол Бурханыг хүндлэх хүндэтгэл нь зүрх сэтгэлийнх нь гүнээс гарах ёстой гэдгийг хүмүүст ойлгуулахын төлөө юм.

Одоо тэрхүү таван шаардлагыг авч үзье: Эхний гуравт нь хүрч чадах хүн та нарын дунд байна уу? Үүгээр Би жинхэнэ итгэл, үнэнчээр дагах, туйлын дуулгавартай байхыг хэлж байна. Эдгээр зүйлийг хийх чадвартай хүн та нарын дунд байна уу? Хэрвээ Би бүх таван шаардлагыг гэж хэлсэн бол та нарын дундаас нэг нь ч гарахгүй байсан гэдэг нь маргаагүй, гэхдээ Би тоог нь гурав болгож багасгасан. Та нар эдгээр зүйлд хүрсэн эсэхээ нэг бодоод үз. “Жинхэнэ итгэлд” хүрэхэд амархан уу? (Үгүй, амархан биш.) Хүмүүс Бурханд байнга эргэлздэг учраас амархан биш. Тэгвэл “Үнэнчээр дагах” тухайд ямар вэ? “Үнэнчээр” гэж юуг хэлдэг вэ? (Хоёрдмол сэтгэлтэй биш, харин үнэн сэтгэлээсээ байх.) Хоёрдмол сэтгэлтэй биш, харин үнэн сэтгэлээсээ байх. Та нар голыг нь олж хэллээ! Тэгэхээр та нар энэ шаардлагад хүрч чадах уу? Та нар илүү их хичээх хэрэгтэй, тийм үү? Одоохондоо та нар энэ шаардлагад хүрч хараахан чадаагүй байгаа. “Туйлын дуулгавартай байдлын” тухайд та нар үүнд хүрсэн үү? (Үгүй.) Та нар үүнд ч бас хүрээгүй. Та нар байнга дуулгаваргүй, тэрслүү байдаг; дандаа сонсдоггүй, дуулгавартай байхыг хүсдэггүй, сонсохыг хүсдэггүй. Эдгээр нь амийн оролтод хүрснийхээ дараа хүмүүсийн биелүүлдэг хамгийн үндсэн гурван шаардлага боловч та нар тэдгээрт хараахан хүрээгүй байна. Иймд одоогоор та нарт асар их чадамж байна уу? Өнөөдөр, Намайг эдгээр үгийг хэлэхийг сонсоод та нарын сэтгэл зовниж байна уу? (Тийм.) Та нарын сэтгэл зовних нь зөв. Сэтгэл зовнихоос зайлсхийх гэж бүү хичээ. Би та нарын өмнөөс сэтгэл зовниж байна. Би нөгөө хоёр шаардлагын талаар ярихгүй; энд байгаа хэн ч тэдгээрт хүрч чадваргүй гэдэг нь эргэлзээгүй. Та нарын сэтгэл зовниж байна. Тэгэхээр та нар зорилгоо тодорхойлсон уу? Ямар зорилготойгоор, ямар чиглэлд эрэлхийлж, хичээл зүтгэлээ зориулах ёстой вэ? Та нарт зорилго бий юу? Би илэн далангүй ярья: Энэ таван шаардлагад хүрмэгц та нар Бурханыг сэтгэл хангалуун болгоно. Эдгээр нь дор бүрнээ хүний амийн оролт боловсорч гүйцсэний үзүүлэлт, мөн түүнчлэн эцсийн зорилго нь юм. Хэрвээ Би эдгээр шаардлагаас зөвхөн нэгийг нь л сонгоод дэлгэрэнгүй ярьж, та нараас биелүүлэхийг шаардсан ч гэсэн үүнд хүрэхэд амаргүй байх болно; тодорхой хэмжээний зовлон бэрхшээл туулж, хүчин чармайлт гаргах ёстой. Та нар ямар сэтгэлгээтэй байх хэрэгтэй вэ? Мэс заслын орон дээр гарахаар хүлээж буй хорт хавдартай өвчтөнийхтэй адил байх ёстой. Би яагаад ингэж хэлж байна вэ? Хэрвээ чи Бурханд итгэхийг, Бурханыг олж авч, Түүнийг сэтгэл хангалуун байлгахыг хүсвэл, тодорхой хэмжээний зовлон шаналал туулж, тодорхой хэмжээний хүчин чармайлт гаргахгүйгээр эдгээр зүйлд хүрч чадахгүй. Та нар маш их номлол сонссон боловч сонслоо гээд энэ номлол чинийх болсон гэсэн үг биш; чи үүнийг ойлгож авч, өөрийн болгож авах ёстой. Үүнийг өөрийн аминд шингээж, оршин тогтнолдоо оруулж, эдгээр үг, номлол хэрхэн амьдрахыг чинь залж чиглүүлж, чиний аминд оршин тогтнолын үнэ цэн, утга учир авчрахыг зөвшөөрөх ёстой. Ингэх үед эдгээр үгийг сонссоны чинь ашиг гарна. Хэрвээ Миний хэлдэг үг амьдралд чинь ямар нэгэн эргэлт авчирч, оршин тогтнолд чинь ямар нэг үнэ цэн нэмээгүй бол үүнийг сонсох

нь чамд ямар ч хэрэггүй. Та нар үүнийг ойлгож байгаа биз дээ? Үүнийг ойлгосон бол үлдсэн хэсэг нь та нараас шалтгаална. Та нар хүчин чармайлт гаргах ёстой! Та нар бүх зүйлд чин сэтгэлээсээ хандах ёстой! Төөрөлдөж бүү бай; цаг хугацаа нисэн өнгөрч байна! Та нарын дундаас ихэнх нь Бурханд аль хэдийн арав гаруй жил итгэсэн. Энэ өнгөрсөн арван жилээ эргээд хар: Та нар хэр ихийг олж авсан бэ? Мөн энэ төрөлдөө амьдрах хэдэн арван жил үлдсэн бэ? Тийм ч их үлдээгүй. Бурханы ажил чамайг хүлээдэг эсэх, Тэр чамд боломж үлдээсэн эсэх, Тэр нэг ажлаа дахин хийх эсэх тухай март; ийм зүйлийн талаар бүү ярь. Чи амьдралынхаа өнгөрсөн арван жилийн замналаа ухрааж чадах уу? Өдөр өнгөрөх бүрд, алхах бүрд өдөр хоногууд чинь нэгээр хорогддог. Цаг хугацаа хэнийг ч хүлээдэггүй! Хэрвээ чи үүнд амьдралынхаа хамгийн агуу зүйл, хоол, хувцас, өөр юунаас ч илүү чухал гэж хандвал Бурханд итгэх итгэлээс ашиг тус л хүртэнэ. Хэрвээ чи зөвхөн завтай үедээ итгэж, итгэлдээ бүх анхаарлаа хандуулж чадахгүй бол, чи үргэлж төөрөгдөлд автаж байдаг бол юу ч олж авахгүй. Та нар үүнийг ойлгож байгаа биз дээ? Өнөөдөртөө яриагаа ингээд дуусгая. Дараа дахин уулзъя!

2014 оны 2 дугаар сарын 15

Сайн мэдээний вэб сайт
QR Код

Төгс Хүчит Бурханы
Чуулганы Апп

Сайн мэдээний вэб сайт

https://mn.kingdomsalvation.org

YouTube: https://l.kingdomsalvation.org/mn/video

E-mail: contact.mn@kingdomsalvation.org